ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ
ХҮРЭЭЛЭН

СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ЭМХЭТГЭЛ

(2016-2017)

V

Улаанбаатар хот
2018 он

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ
ХҮРЭЭЛЭН

СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ЭМХЭТГЭЛ

(2016-2017 он)

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

Улаанбаатар хот
2018

ДАА 340
НҺА 67
С-701

Судалгааны баг:

Удирдсан:

С.Энхцэцэг	Захирал
Ж.Амарсанаа	Зөвлөх, Академич
Д.Зүмбэрэллхам	Хууль зүйн ухааны доктор /Ph.D/
Х.Эрдэм-Ундрах	Хууль зүйн ухааны доктор /Dr.jur/

Судалгааны багийн гишүүд:

Б.Алтангэрэл
Ж.Алтансүх
Ж.Ариунцэцэг
Л.Банзрагч
С.Батбаяр
Ч.Бат-Уянга
Ж.Бариаширсүрэн
У.Буянтогтох
Л.Галбаатар
Б.Гончигсумлаа
Б.Доржпагма
Н.Мичидмаа
Д.Мөнхжаргал
Д.Нямбаяр
Ц.Одгэрэл
Э.Өлзийлхам
Б.Сүнжидмаа
М.Төрбаяр
А.Түвшинтулга
Б.Ундрах
Э.Уянга
Г.Халиунаа
Г.Цагаанбаяр
М.Цэдэвсүрэн
Б.Энх-Амгалан
У.Эрдэнэзаяа

© Хууль зүйн үндэсний хүрээлэн

Хянасан: Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн ухааны доктор /Ph.D/ П.Амаржаргал
Эмхэтгэсэн: Эрдэм шинжилгээний ахлах ажилтан Г.Халиунаа
Эрдэм шинжилгээний ажилтан Х.Ариунсүрэн
Хэвлэлийн эх бэлтгэсэн: Д.Мөнхжаргал
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.
Хэвлэсэн хугацаа: 2018 оны 12 дугаар сар

ISBN-978-99978-788-0-9

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.legal.gov.mn

ГАРЧИГ

НЭГ. ЗАСГИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ 59 ДҮГЭЭР ТОГТООЛД ЗААСАН АРГАЧЛАЛЫН ДАГУУ ГҮЙЦЭТГЭСЭН СУДАЛГАА

1. Архивын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ....11
2. Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ 32
3. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ....57
4. Патентийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ 90
5. Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн хэрэгцээ, шаардлагын урьдчилан тандан судалгаа 126
6. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх үнэлгээ 170
7. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн төсөлд хийсэн зардлын тооцоо 208
8. Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ....255
9. Эрүүгийн хуулийн /шинэчилсэн найруулга/ зарим зүйл, заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах эдийн засгийн үр нөлөөний судалгаа....302

ХОЁР. ЗАСГИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ 249 ДҮГЭЭР ТОГТООЛД ЗААСАН АРГАЧЛАЛЫН ДАГУУ ГҮЙЦЭТГЭСЭН СУДАЛГАА

1. Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөрийн нөлөөллийн үрьдчилсан үнэлгээ 330
2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн нөхцөл байдлын дүн шинжилгээ.345

ГУРАВ. ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

1. ХЗҮХ-ийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомжуудын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах нийцлийн мониторинг 354

ДӨРӨВ. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

1. Аж ахуйн нэгжийн дампуурал ба дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа 398
2. Гаалийн байгууллага, гаалийн улсын байцаагчийн эрх зүйн байдлын зарим асуудал....432
3. Гаалийн тухай хууль, гаалийн тухай хуулийн төсөл, гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай конвенцийн нэмэлт протоколын харьцуулалт 475
4. Эрүүгийн ял оногдуулах талаарх онол, практикийн асуудал 669
5. Эрх зүйн боловсрол олгох, мэдээлэл түгээх үр нөлөөтэй арга хэлбэр 677
6. Шүүхээс эрүүгийн хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцаах нь.... 734

ТАВ. ЛАВЛАГАА

1. Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон сонгуулийн тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулиудын зөрчил, хийдэл, давхардал болон уялдаа холбоо 746
2. Гадаадын зарим орнуудын хуулийн этгээдийн төрөл....761
3. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа....783
4. Түрээслэгчийн эрх ашгийг хамгаалсан хууль эрх зүйн орчин....803

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nji.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж
АЕГ	Архивын ерөнхий газар
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АТГ	Авлигатай тэмцэх газар
АТХ	Архивын тухай хууль
АҮӨЭГ	Аж үйлдвэрийн өмчийн эрхийн газар
АҮӨЗЭГ	Аж үйлдвэрийн өмчийн захиргааны эрхийн газар
АҮӨХ	Аж үйлдвэрийн өмчийн хэлтэс
ББСҮА	Банк бус санхүүгийн үйл ажиллагаа
БНКУ	Бүгд Найрамдах Казахстан Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БТГЗЗтХ	Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль
ГХО	Гадаадын хөрөнгө оруулалт
ГХОААН	Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж
ДОӨБ	Дэлхийн оюуны өмчийн байгууллага
ДХБ	Дэлхийн худалдааны байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЕХ	Европын холбоо
ЗЭБТХЭтХ	Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль
МУ	Монгол Улс
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
ОӨГ	Оюуны өмчийн газар
ОӨУБЕГ	Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар
ОУЗХ	Олон улсын зохицуулах хороо
ОХУ	Оросын Холбооны Улс
ӨМНС	Өрхийн мэдээллийн нэгдсэн сан
СХБ	Солонгосын хуулийн байгууллага
СХД	Сонгино хайрхан дүүрэг
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ТРИПС	Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр
УБТЗ	Улаанбаатар төмөр зам
ҮТА	Үндэсний Татварын алба
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УДШ	Улсын дээд шүүх
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
УИХ	Улсын Их Хурал
ҮТА	Үндэсний төв архив
ҮТГА	Үндэсний татвар, гаалийн алба
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЗБХ	Хууль зүйн байнгын хороо
ХЗСТ	Хууль зүйн судалгааны төв

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.legal.gov.mn

ХЗҮХ	Хууль зүйн үндэсний хүрээлэн
ХЭ	Хуулийн этгээд
ХЭБГ	Хуулийн этгээдийн бүртгэлийн газар
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ХЭҮБ	Хүний эрхийн үндэсний байгууллага
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ХЭҮКтХ	Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ХЭҮБ	Хүний эрхийн үндэсний байгууллага
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ХЭҮКтХ	Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШГА	Шийдвэр гүйцэтгэх алба
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ШСМСХ	Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ЭША	Эрдэм шинжилгээний ажилтан
ЭБШХ	Эрүүгийн байцаан шийтгэх хууль
ЭХТА	Эрүүгийн хуулийн тусгай анги
ЭХЕА	Эрүүгийн хуулийн ерөнхий анги
ЭЗМНС	Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем
ЮНЕСКО	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллага
AMS	Archive Management System
EASTICA	Зүүн Азийн орнуудын архивын салбар зөвлөл
KOICA	БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага
WIPO CASE	Олон улсын хайлт шүүлтийн төвлөрсөн хандалтын систем

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.legal.gov.mn

ӨМНӨХ ҮГ

Хууль зүйн үндэсний хүрээлэн нь хууль зүйн салбарт хоёр томоохон чиглэлээр ажил үүрэг гүйцэтгэдэг байгууллага юм. Тус хүрээлэн нь салбарын албан хаагч, эрдэмтэн, судлаач, иргэдэд эрх зүйн сургалт, мэдээ, мэдээллийг түгээх, сурталчлах чиг үүргийг хэрэгжүүлэхээс гадна Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чиглэсэн судалгааг шинжлэх ухааны арга зүйгээр явуулах, хууль зүйн нийтлэг бодлогын асуудлаар бодлогын болон хавсарга судалгааг эрх зүйн суурь судалгаанд тулгуурлан хийх, төрийн захиргааны төв байгууллагуудад хуулийн хэрэгжилт болон хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, бусад лавлагаа, мэдээллээр хангах, эрх зүйн харьцуулсан судалгаа хийж, үндэсний хууль тогтоомжийн хөгжил, онцлогийг тандан судлах зэрэг ажил үүргийг гүйцэтгэж байна.

Энэ ч утгаараа судалгааны үр дүнгээ эргэлтэд оруулах, олон нийтийн хүртээл болгох зорилгоор 2003 оноос хойш гүйцэтгэсэн судалгааны бүтээлээ эмхэтгэл болгон хэвлүүлсээр өдгөө тав дахь цуврал бүтээлээ гаргаж Та бүхэнд толилуулж байна.

Тус хүрээлэнгийн 2003-2015 онд гүйцэтгэсэн судалгааны ажлын тайлангууд “Судалгааны тайлангийн эмхэтгэл I, II, III, IV боть” болон хэвлэгдэж хэдийн уншигчдын хүртээл болж, олны талархлыг хүлээсэн бол энэ удаа бид 2016-2017 онд гүйцэтгэсэн төлөвлөгөөт болон захиалгат эрдэм шинжилгээ, судалгааны тайлангаа “Судалгааны тайлангийн эмхэтгэл V боть” болгон хэвлүүлж уншигч Таны мэлмий, оюунд тань хүргэхэд бэлэн болоод байна.

Энэ удаагийн бүтээлд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолд заасан аргачлалын дагуу гүйцэтгэсэн есөн судалгаа, Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолд заасан аргачлалын дагуу гүйцэтгэсэн хоёр судалгаа, хяналт, шинжилгээ, үнэлгээний нэг тайлан, харьцуулсан зургаан судалгаа, дөрвөн лавлагаа, мэдээллийг тус тус нийтэллээ.

Уг бүтээл маань хууль зүйн шинжлэх ухааныг шимтэн судалдаг уншигч Танд өчүүхэн ч болтугай хувь нэмэр болно гэдэгт итгэлтэй байна.

Мэргэн уншигч Та болгооно уу.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ С.ЭНХЦЭЦЭГ

Хуулийн үндэсний хүрээлэн
www.nlrc.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nli.gov.mn

НЭГ. ЗАСГИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ 59 ДҮГЭЭР ТОГТООЛД ЗААСАН АРГАЧЛАЛЫН ДАГУУ ГҮЙЦЭТГЭСЭН СУДАЛГАА

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nli.gov.mn

АРХИВЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН[1]

УДИРТГАЛ

1998 онд батлагдсан Архивын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийв.

Үнэлгээ хийх ажлын зорилт нь Архивын тухай хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хуулийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлоход оршино.

Үнэлгээг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Гончигсумлаа, Д.Нямбаяр нар 2017 оны 6 дугаар сарын 22-ний өдрөөс 2017 оны 7 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэн, тус хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Х.Эрдэм-Ундрахаар хянуулсан болно.

Тус үнэлгээ нь төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шатаас бүрдэнэ.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Төлөвлөх шатны зорилго нь үнэлгээ хийх хүрээг тогтоож түүнд тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход чиглэгдэнэ. Энэ үе шатанд дараах алхмуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

- Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
- Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
- Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
- Харьцуулах хэлбэрийг сонгох;
- Шалгуур үзүүлэлтийг томьёолох;
- Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

1.1. Үнэлгээ хийх шалтгаан

Хууль тогтоомж нь тухайн харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх болон нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх зорилгоор үнэлгээний ажлын эхэнд үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлно. Ингэхдээ “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 3.2-т заасан нөхцөл байдлыг үндэслэв.

Архивын тухай хууль 1998 онд батлагдсан бөгөөд түүнээс хойш 8 удаа нэмэлт, өөрчлөлт орсон. Ингэхдээ зарчмын шинжтэй томоохон өөрчлөлт хийгдээгүй байна.

Дэлхийн улс орнуудад төдийгүй Монгол улсад архив, албан хэрэг хөтлөлтийн харилцаа шинэчлэгдэн хөгжиж байна. Харин 1998 онд батлагдсан Архивын тухай хууль нь энэхүү өөрчлөлт, хөгжлөөс хоцрох хандлагатай болсон, мөн хуулийн зарим заалтын хэрэгжилт хангалтгүй байгаа нь хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх зайлшгүй шаардлагатайг илтгэнэ.

Архивын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны явцад ярилцлагын судалгаанд оролцсон хууль хэрэгжүүлэгч субьект болон

[1] Тус судалгааг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Х.Эрдэм-Ундрах удирдан, эрдэм шинжилгээний ажилтан Б.Гончигсумлаа, Д.Нямбаяр нар хамтран гүйцэтгэв.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

эрдэмтэн, судлаачид уг хуулийг шинэчлэх хэрэгцээ, шаардлага байгааг онцлон тэмдэглэж байлаа.*(График 1-ийг үзнэ үү)*

Дээрхээс үзэхэд Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3 дугаар зүйлийн 3.2.2 дахь хэсэгт заасан шалтгаан, үндэслэлийг хангасан гэж дүгнэж болохоор байна. Иймд тус үнэлгээг үргэлжлүүлэн хийв.

График 1. Архивын тухай хуулийг шинэчлэх хэрэгцээ, шаардлага бий юу?



1.2. Үнэлгээ хийх хүрээ

Үнэлгээ хийх хүрээ нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад хамгийн гол нөлөөлөл үзүүлэх зохицуулалтыг тодорхойлоход чиглэгдэнэ. Өөрөөр хэлбэл үнэлгээ хийх шалтгаантай холбогдсон байдаг.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт бүхэлд нь үнэлгээ хийхэд ихээхэн цаг хугацаа, хөдөлмөр, зардал шаардагдана. Мөн хүрэх үр дүн ч ач холбогдолгүй байх тохиолдол бий. Иймд хуулийн зорилгыг хэрэгжүүлэхэд чухал нөлөөлөл үзүүлэх зарим зохицуулалтыг тусгайлан сонгож үнэлгээ хийх нь илүү үр дүнтэй байдаг тул уг аргачлалын дагуу тусгайлан сонголт хийлээ.

Архивын тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээг гүйцэтгэх хүрээг тогтоохдоо судалгааны баг хууль тогтоомжийг судалж, холбогдох тайлан, үнэлгээнүүдийг ашиглахын зэрэгцээ хуулийг хэрэгжүүлэгч зарим субьектээс ярилцлагын судалгаа авсан. Тус судалгааны явцад *Архивын баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлэх, цахим үйлчилгээг нэвтрүүлэхэд чиглэсэн хуулийн зохицуулалтын хэрэгжилт удаашралтай, мөн төрөлжсөн архивууд архивын бариmтаа хуульд заасан хугацаа дуусахад улсын архивт хүлээлгэн өгөх зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй байгаа зэрэг нөхцөл байдал тулгамдсан шинжтэй ажиглагдаж байна. Дээрх хүндрэл, бэрхшээл нь Архивын тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг бууруулж буй голлох шалтгаан байж болохоор байна.*

Иймээс дээрх үндэслэлийг харгалзан судалгааны баг Архивын тухай хуулийн дараах заалтуудыг сонгон авч үнэлгээ хийх хүрээг тодорхойлов. Үүнд:

Гурав дугаар бүлэг

15 дугаар зүйлийн 15.1.12.“Архивын баримтыг тусгай тээгч буюу цахим тооцоолуурын санамжид буулгаж, хадгалах”,

23 дугаар зүйлийн 23.1.12.“Архивын баримтыг байгууллагын архивт тэдгээрийг зохион бүрдүүлсэн оны дараа жилийн 1 дүгээр сарын 1-нээс эхлэн тооцож дор дурдсан хугацаагаар хадгалан уг хугацаа дууссаны дараа түүх, эрдэм шинжилгээний ач холбогдолтой хэсгийг нь төрийн архивт шилжүүлнэ: 23.1.12. байгууллагын төрөлжсөн архивт-40 жил”

Дээр дурдсанаар үнэлгээний хүрээг нарийвчлан тогтоох нь судалгаа товч, ойлгомжтой болоход ач холбогдолтой байдаг.

1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт

Үнэлгээний ажлыг төлөвлөх шатанд тухайн үнэлгээг хийх шалгуур үзүүлэлтийг тогтооно. Ингэхдээ дараах зургаан үндсэн шалгуур үзүүлэлт болон бусад үзүүлэлтээс үнэлгээний хүрээтэй тохирохыг нь сонголоо. Шалгуур үзүүлэлтүүдийг дурдвал:

- зорилгод хүрсэн түвшин;
- зардлын өсөлт, бууралт;
- зардал-үр өгөөжийн харьцаа;
- хүлээн зөвшөөрөгдсөн байдал;
- практикт нийцэж байгаа байдал;
- бусад үр дагавар.

Шалгуур үзүүлэлтийг сонгохын тулд шалгуур үзүүлэлт тус бүрийн ойлголт, онцлог, хоорондын ялгааг харгалзан үзэх ба сонгосон шалгуур үзүүлэлт нь Архивын тухай хуулийн холбогдох хэсэгт үнэлгээ хийх болсон шалтгаантай уялдсан байх, хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байх шаардлагатай.

Манай судалгааны хувьд дараах хоёр шалгуур үзүүлэлтийг сонгох нь тохиромжтой гэж үзлээ. Үүнд:

- практикт нийцэж байгаа байдал;
- зорилгод хүрсэн түвшин;

Шалгуур үзүүлэлт тус бүрийн ялгаа, онцлогийг дурдвал:

д/д	Шалгуур үзүүлэлт	Ойлголт, онцлог	Жишээ тайлбар
1	Зорилгодхүрсэн түвшин	Тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтооно.	Архивын тухай хууль нь 1998 оноос эхлэн хэрэгжсэн. Хууль тогтоогчийн зүгээс хуулийн зорилтыг Монгол Улс дахь үндэсний архивын сан хөмрөг, түүний бүрэлдэхүүн, төрийн архивын үйл ажиллагааны зарчим, удирдлага, архивын баримтын хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт, ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулахаар тодорхойлсон байна. Харин тус хуулиас сонгон авсан зохицуулалт болох 15.1.2 дугаар зүйлийн хүрээнд архивын бүхий л баримтыг эх хувиас нь гадна тусгай тээгч буюу цахим тооцоолуурын санамжид буулгаж, хадгалсан байхыг зорилго болгон дэвшүүлсэн байна. Мөн хуулиас сонгон авсан 23.1 дүгээр зохицуулалтын хувьд төрөлжсөн архивын байгууллагууд Архивын баримтыг хадгалах хуульд заасан 40 жилийн хугацаа дуусмагц Төрийн архивт шилжүүлсэн байх нөхцөлийг зорилго болгосон гэж ойлгож болно.
5	Практикт нийцэж байгаа байдал	Хуулийг хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.	Архивын тухай хуулиас сонгон авсан дээрх заалтууд нь хэрэглэхэд ойлгомжтой эсэх, цаашид хэрэгжүүлэх боломж бололцоо практикт байгаа эсэхийг тодорхойлно.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.jri.gov.mn

1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрүүдээс сонгоно. Үүнд:

- Байх ёстой болон одоо байгаа;
- Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших;
- Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших;
- Тохиолдол судлах.

Харьцуулах хэлбэр тус бүрийн онцлогийг дурдвал:

д/д	Харьцуулах хэлбэр	Ойлголт, онцлог
1	Байх ёстой болон одоо байгаа	Хуулиар тогтоосон “байх ёстой” үзүүлэлт практикт хэр байгааг илрүүлэх зорилготой. Үнэлгээ хийх хуульд байвал зохих тодорхой абсолют үзүүлэлтийг зааж өгсөн тохиолдолд одоо бодит байгаа үзүүлэлттэй харьцуулна.
2	Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш	Хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль хүчин төгөлдөр хэрэгжсэний дараахтай буюу хуулийн хэрэгжилтийн явцад гарч буй үр дагавартай харьцуулна.
3	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дараалаар тогтоон харьцуулна.
4	Тохиолдол судлах	Хууль, эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоогдсон зүйл, заалт өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх зэрэг) хэрхэн хэрэгжиж буй байдлыг харьцуулна.

Судалгааны явцад Архивын тухай хуулиас сонгон авсан зохицуулалтын өнөөгийн хэрэгжилтийг **байх ёстой буюу бүрэн хэрэгжсэн тохиолдолд хэрхэн авч үзэх** тухай харьцуулалтын хэлбэрийг ашиглана. Энэ хүрээнд Төрийн архивын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс өмнөх нөхцөл болон хөтөлбөрийн дараах үр дүнг харьцуулах, ялангуяа сүүлийн жилүүдэд зохицуулалтын хэрэгжилтийг сайжруулах талаар хийгдсэн үйл ажиллагааг судална.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох

Шалгуур үзүүлэлтийг томьёолох хүрээнд шалгуур үзүүлэлт тус бүрээр Архивын тухай хуулийн сонгон авсан хэсэгт тохируулан дараах таамаглал дэвшүүлж, асуулт боловсруулав.

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

1. Хуулийн 3 дугаар бүлэг.

15 дугаар зүйл. Төрийн архивын эрх, үүрэг

- Хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дахь заалт буюу архивын баримтыг тусгай тээгч буюу цахим тооцоолуурын санамжид буулгаж, хадгалах талаарх зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх?

23 дугаар зүйл. Төрийн архивын сан хөмрөгийн бариmтыг байгууллагын архивт хадгалах хугацаа

- Хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.12 дахь заалтад тусгасан архивын баримтыг байгууллагын төрөлжсөн архивт 40 жил хадгалах бөгөөд уг хугацаа дууссаны дараа түүх, эрдэм шинжилгээний ач холбогдолтой хэсгийг нь төрийн архивт шилжүүлэх тухай зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх?

ХУУЛЬ ЗҮЙН УНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.legal.mn

Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

15 дүгээр зүйл. Төрийн архивын эрх, үүрэг

- Хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дахь заалт буюу архивын баримтыг тусгай тээгч буюу цахим тооцоолуурын санамжид буулгаж, хадгалах талаарх зохицуулалт практикт хэрхэн хэрэгжсэн бэ?

23 дугаар зүйл. Төрийн архивын сан хөмрөгийн баримтыг байгууллагын архивт хадгалах хугацаа

- Хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.12 дахь заалтад тусгасан Архивын баримтыг байгууллагын төрөлжсөн архивт 40 жил хадгалах бөгөөд уг хугацаа дууссаны дараа түүх, эрдэм шинжилгээний ач холбогдолтой хэсгийг нь төрийн архивт шилжүүлэх тухай зохицуулалт практикт хэрхэн нийцэж байна вэ? Хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл, түүнээс үүдэн гарах үр дагавар юу вэ? гэдгийг тодорхойлов.

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Архивын ерөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээнд үнэлгээ хийх хүрээ, шалгуур үзүүлэлтийг харгалзан дараах байдлаар дурдсан мэдээллийг бүрдүүлнэ. Үүнд:

- **Холбогдох эх сурвалжийг ашиглах:** Архив, албан хэрэг хөтлөлт болон цахим архив, төрөлжсөн архивын талаарх хууль тогтоомж, мэргэжлийн ном, товхимол, гарын авлага, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, статистикийн тоо баримт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн эх сурвалжийг ашиглана;
- **Холбогдох субьектээс судалгаа авах:** Тухайн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулж байгаа Архивын ерөнхий газрын мэргэжилтнүүд болон төрөлжсөн архивын ажилтнуудтай ярилцлага зохион байгуулна. Мөн холбогдох байгууллагуудаас үйл ажиллагааны болон шалгалтын тайлан, судалгаа, бусад мэдээлэл (тухайн байдлын чанарын үзүүлэлт)-ийг гаргуулна;
- **Биечлэн судалгаа хийх**: Архивын ерөнхий хуулиас сонгон авсан хэсгийн хэрэгжилтийг үнэлэх хүрээнд биечлэн судлах, ажиглалт хийх, эсхүл дээр дурдсаны дагуу ярилцлагын аргыг ашиглан мэдээлэл цуглуулна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Төлөвлөх үе шатанд хийгдсэн ажлыг хүснэгтээр харуулбал:

ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ				
Үнэлгээний хүрээ	**Шалгуур үзүүлэлт**	**Харьцуулах хэлбэр**	**Шалгуур үзүүлэлтийн томьёолол**	**Мэдээлэл цуглуулах арга**
Хуулийн 3 дугаар бүлэг. Төрийн архивын эрх үүрэг **15.1.** 15 дугаар зүйл. Төрийн архив дараах эрх, үүрэгтэй байна. **15.1.12.** Архивын баримтыг тусгай тээгч буюу цахим тооцоолуурын санамжид буулгаж, хадгалах	· Зорилгод хүрсэн түвшин · Практикт нийцэж байгаа байдал	· Байх ёстой буюу бүрэн хэрэгжсэн тохиолдолд хэрхэн авч үзэх	Зорилгод хүрсэн түвшин · Хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дахь хэсэгт заасан архивын баримтыг тусгай тээгч буюу цахим тооцоолуурын санамжид буулгаж, хадгалах талаарх зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ? Практикт нийцэж байгаа байдал · Хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дахь хэсэгт буюу архивын баримтыг тусгай тээгч буюу цахим тооцоолуурын санамжид буулгаж, хадгалах талаарх зохицуулалт практикт хэр хэрэгжсэн бэ?	· Холбогдох эх сурвалжийг ашиглах · Холбогдох субьектээс судалгаа авах · Биечлэн судалгаа хийх.
Хуулийн 3 дугаар бүлэг. Төрийн архивын сан хөмрөгийн баримтыг байгууллагын архивт хадгалах хугацаа **23.1.** Архивын баримтыг байгууллагын архивт тэдгээрийг зохион бүрдүүлсэн оны дараа жилийн 1 дүгээр сарын 1-нээс эхлэн тооцож дор дурдсан хугацаагаар хадгалан уг хугацаа дууссаны дараа түүх, эрдэм шинжилгээний ач холбогдолтой хэсгийг нь төрийн архивт шилжүүлнэ: **23.1.12**.байгууллагын төрөлжсөн архивт-40 жил.	· Зорилгод хүрсэн түвшин; · Практикт нийцэж байгаа байдал.	· Байх ёстой буюу бүрэн хэрэгжсэн тохиолдолд хэрхэн авч үзэх	**Зорилгод хүрсэн түвшин** · Хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.12 дахь хэсэгт Архивын баримтыг байгууллагын төрөлжсөн архивт 40 жил хадгалах бөгөөд уг хугацаа дууссаны дараа түүх, эрдэм шинжилгээний ач холбогдолтой хэсгийг нь төрийн архивт шилжүүлэх тухай зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ? **Практикт нийцэж байгаа байдал** · Хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.12 дүгээр зүйлд Архивын баримтыг байгууллагын төрөлжсөн архивт 40 жил хадгалах бөгөөд уг хугацаа дууссаны дараа түүх, эрдэм шинжилгээний ач холбогдолтой хэсгийг нь төрийн архивт шилжүүлэх тухай зохицуулалт практикт нийцэж байна вэ? Хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл түүнээс үүдэн гарах үр дагавар юу вэ? гэдгийг тодорхойлов.	· Холбогдох эх сурвалжийг ашиглах · Холбогдох субьектээс судалгаа авах · Биечлэн судалгаа хийх.

ХҮЧЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nii.gov.mn

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Архивын тухай хуулийн сонгон авсан хэсгийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд тохиромжтой аргаар мэдээллээ цуглуулна. Ингэхдээ холбогдох материал ашиглах болон эрх бүхий субьекттэй ярилцлага хийх, судалгаа авах аргыг ашиглав.

Архив, албан хэрэг хөтлөлт болон цахим архив, төрөлжсөн архивын талаарх хууль тогтоомж, мэргэжлийн ном, товхимол, гарын авлага, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, статистикийн тоо баримт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн эх сурвалжийг ашиглана.

Уг хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх явцад хуулийг хэрэгжүүлэгч субьект болох Архивын ерөнхий газрын Мэргэжил арга зүйн удирдлагын газрын дарга, Хяналт, шинжилгээ-үнэлгээ дотоод аудитын хэлтсийн дарга болон мэргэжилтэн, Мэдээлэл технологийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Цахим сангийн төвийн арга зүйч, Гадаад харилцааны яамны Гадаад харилцааны төв архивын эрхлэгч, Тагнуулын ерөнхий газрын тусгай архив эрхлэгч, архивч, УБТЗ-ын төв архивын архивч зэргийг ярилцлагад хамруулав.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Архивын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2 болон 23 дугаар зүйлийн 23.1.12 дахь хэсэгт сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийхэд дараах байдалтай байна.

3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Архивын тухай хуулийн үндсэн зорилтыг “Монгол Улс дахь үндэсний архивын сан хөмрөг, түүний бүрэлдэхүүн, төрийн архивын үйл ажиллагааны зарчим, удирдлага, архивын баримтын хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт, ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” хэмээн хуулийн нэгдүгээр зүйлд заасан байна. Иймд уг хуулийн бүхий л зохицуулалт энэхүү үндсэн зорилтыг хангахад чиглэн үйлчлэх учиртай.

Энэхүү зорилгыг хангах хүрээнд Архивын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 болон 23 дугаар зүйлийн 23.1.12 дахь хэсгийн зохицуулалтыг хуульчилсан байна.

<u>Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1.</u> Хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дахь хэсэгт заасан архивын баримтыг тусгай тээгч буюу цахим тооцоолуурын санамжид буулгаж, хадгалах тухай зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх?

15 дугаар зүйл. Төрийн архивын эрх, үүрэг

15.1. Төрийн архив дараах эрх, үүрэгтэй байна:

15.1.1.түүх, эрдэм шинжилгээний ач холбогдолтой архивын баримтыг цуглуулах, тэдгээрт сонголт, нягтлан шалгалт хийх;

15.1.2. сан хөмрөгөө нөхөн бүрдүүлэх;

15.1.3. архивын баримтыг зориулалтын байранд, зохих горимын дагуу хадгалах;

15.1.4. архивын баримтыг сэлбэн засах, сэргээн шинэтгэх;

15.1.5. хосгүй үнэт, үнэт баримтын нөөц хувьтай болох;

15.1.6. архивт хүлээн авсан баримтыг ангилах, төрөлжүүлэх, тэдгээрээр архивын хөмрөг байгуулах;

15.1.7. архивын баримтын тоо бүртгэл хөтлөх;

15.1.8 .архивын баримтын агуулга, бүрэлдэхүүнийг нээн харуулсан мэдээлэл-лавлагааны сан бүрдүүлэх;

15.1.9. архивын баримтыг судлах, сурталчлах, хэвлэн нийтлэх;

15.1.10. архивын баримтыг ашиглуулах;

15.1.11. архивын хөмрөг үүсгэгч байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, архивын хууль тогтоомжийн биелэлтийг шалгах;

15.1.12. архивын баримтыг тусгай тээгч буюу цахим тооцоолуурын санамжид буулгаж, хадгалах

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.mi.gov.mn

Монгол Улсын Засгийн газар 2006 онд “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхээр батлсан. Хөтөлбөрийн нэгдүгээр үе шат 2006-2008 онд /ойрын хугацаа/, Хоёрдугаар үе шат 2009-2012 онд /дунд хугацаа/, гуравдугаар үе шат 2014-2016 онд хэрэгжсэн байна.

Хөтөлбөрийн 1 дүгээр үе шатанд Архивын ерөнхий газраас төрийн архивуудад хадгалагдаж буй баримтын тоо хэмжээ, онцлог, ашиглалтын байдал, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, боловсон хүчний байдалд судалгаа явуулах, шаардлагатай тогтоол, шийдвэрийг гаргуулах, арга зүйн баримт бичгийг боловсруулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн бол 2, 3 дугаар үе шатанд төрийн архивын мэдээлэл, эрэлт хайлтын автоматжуулсан сан байгуулах, төрийн архивын цахим мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, байгууллагын үйл ажиллагаанд цахим бичиг хэргийн тогтолцоог нэвтрүүлэх зорилтын хүрээнд төрийн болон байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг ажилтнуудыг сургаж мэргэшүүлэх, шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангахад анхаарал хандуулан ажилласан бөгөөд Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор төрийн архивуудад цахим мэдээллийн сан үүсгэх гэрээт ажилтнуудыг ажиллуулж эхэлсэн[2] байна.

Засгийн газрын 2017 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 4 дүгээр тогтоолоор үндэсний хөтөлбөрийн 4 дүгээр үе шатыг 2017-2020 онд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна. Уг хөтөлбөрийн 5 дахь хэсэгт “4. Дөрөвдүгээр үе шат (2017-2020 он /дунд хугацаа/)” гэж, мөн хэсэгт “5.4. Дөрөвдүгээр үе шат (2017-2020)-нд Үндэсний төв архив, төрийн архивуудад хадгалагдаж байгаа цаасан суурьтай баримт, кино, гэрэл зураг, дуу авианы баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх, цахим архив үүсгэх ажлыг зохион байгуулна.”[3] гэж нэмсэн байна.

Архивын тухай хууль 1998 онд батлагдсанаас хойш дунд хугацаанд архивын салбарт төрийн архивын ажлын арга зүй, зохион байгуулалт сайжирсан, байгууллагын архивын баримтын эмх цэгц, хадгалалт хамгаалалт сайжирч, архивын өрөөтэй, тавиур, шүүгээ, компьютертой болсон, зарим архивууд тоо бүртгэлийн баримт, хүн амын тооллогоо компьютерт оруулж, мэдээллийн сангаа бүрдүүлж эхэлсэн, баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, архивыг техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангахад шаардагдах хөрөнгийг тодорхой хэмжээгээр төсөвт тусгаж байгаа, Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн ажилд ахиц гарсан зэрэг олоултууд гарсан байна[4] гэж 2004 онд хийгдсэн Архивын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх дүгнэлтэд дурджээ. Гэвч шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгон авсан хуулийн зохицуулалтын хэрэгжилтийн талаар дурьдаагүй байна. Энэ нь Архивын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дахь хэсгийн зохицуулалт 1998-2004 оны хооронд хангалтгүй байсантай холбоотой.

Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 1 дүгээр зүйлд “Өнөөдрийн байдлаар төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үйл явц эхлэл төдий, урсгал шинж байдалтай, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтгүй, энэ талаар олон улсын архивын байгууллагаас төдийгүй өөрийн орны бусад салбараас үлэмж хоцрогдонгуй байна” хэмээн тодорхойлсноос үзэхэд шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон хуулийн зохицуулалт буюу архивын баримтыг цахим хэлбэрт буулгах, хадгалах ажлыг эрчимжүүлэх нь тухайн үеийн хэрэгцээ шаардлагын хувьд цаг үеийн шинжтэй зайлшгүй асуудал байжээ.

---

[2] Архивын тухай мэдээлэл. Архивын ерөнхий газрын цахим хуудас. http://zasag.mn/m/general-archival-authority/view/15927 /Сүүлд зочилсон 2017.7.30-ний өдөр/

[3] Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай. Засгийн газрын 2017 оны 4 дүгээр тогтоол

[4] Үндэсний төв архив. Архивын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх дүгнэлт. УБ., 2004 он

Баримт бичиг, мэдээллийн урсгал нэмэгдэж байгаатай уялдан баримт, мэдээллийг цахим хэлбэрээр хөтөлж, тэдгээрийг зөв зохистой журамлах, зохицуулах, архивлан хадгалах асуудал нь тулгамдсан зорилт болж байна. Ардчилал, зах зээлийн нөхцөлд төрийн үйлчилгээ, бизнесийн үйл ажиллагаа зохион байгуулалттай, шуурхай явагдах ёстой бөгөөд түүний угтвар нөхцөл нь байгууллагын албан хэрэг хөтлөлтийг автоматжуулах, удирдлагын үйл ажиллагааны мэдээллийн орчинг боловсронгуй болгох явдал юм.[5]

Архивын үйл ажиллагааг цахимжуулах, цахим архив үүсгэх харилцааны талаар зохицуулалт нь Архивын тухай хуульд 15 дугаар зүйлийн 15.1.12 дахь хэсэгт зааснаас өөр газар тус хуульд байхгүй юм. Энэ нь цахим архивтай холбогдох харилцааг зөвхөн 15 дугаар зүйлийн 15.1.12 дахь хэсэгт зааснаар ерөнхий байдлаар зохицуулж байна гэсэн агуулгаар ойлгож болохоор байна. Гэвч баримтыг цахим хэлбэрт оруулах, хадгалах, цахим архив үүсгэх ойлголт нь 15 дугаар зүйлийн 15.1.12 дахь хэсэгт заасан тусгай тээгч буюу цахим тооцоолуурт хадгалах, буулгах гэсэнтэй агуулгын хувьд ялгаатай байж болох юм. Учир нь хуульд тусгай тээгч буюу цахим тооцоолуур гэж ямар эд зүйл, технологийг хэлж байгаа нь тодорхойгүй байгаагаас үүдэж нэгдсэн ойлголт стандарт өнөөдрийг хүртэл бий болоогүй байна.

Тухайн зохицуулалтыг практикт ялгаатай ойлгох хандлага байгааг тодотгох нь зүйтэй. Шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон хуулийн зохицуулалтыг зөвхөн цахим мэдээллийг хадгалах хөдөлгөөнт төхөөрөмжөөр хязгаарлаж уян диск, зөөврийн хатуу диск, флаш, гэх мэтийг хамруулан ойлгож болохоор байна. Эсхүл нөгөө талаас тусгай тээгч буюу цахим тооцоолуур гэж хөдөлгөөнт техник хэрэгсэл, төхөөрөмжийг ойлгох эсэх, тусгайлан бэлтгэсэн сервер байж болно. Хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дахь хэсгийн заалт нь агуулгын хувьд бүрэн ойлгогдохоор бичигдээгүй нь Архивын тухай хууль батлагдах үед техник, технологийн шинэчлэлийн талаар ойлголт бага байсантай холбоотой байх талтай. Тухайн үед техник, технологийн хөгжлийн түвшинг үнэлэх бололцоо бага байсныг мөн харж болно.

ШИГТГЭЭ 1

Хуулийн 15.2.12-дахь заалт бол тун учир дутагдалтай заалт. Хэрэв яг хуулиа баримталбал бүх материалаа CD, флаш, зөөврийн хард гэх мэт заавал зөөж явдаг төхөөрөмжид хадгалах шаардлагатай болно. Гэтэл энэ нь хоцрогдсон. Иймээс архивууд найдвартай ажиллагааны үүднээс цахим мэдээллээ серверт хадгалаад явж байгаа.

Гадаад харилцааны яамны Гадаад харилцааны төв архив

Архивын баримтыг цахим хэлбэрт буулгаж, хадгалах үйл ажиллагааг дүгнэж[6] Засгийн Газрын 2006 онд баталсан Үндэсний үзэл баримтлалын хүрээнд бол шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон хуулийн зохицуулалтад тусгагдсан цахим тооцоолуур гэдэгт цахим серверийг адилтган ойлгож болох дүр зураг харагдана. Мөн тухайн серверт архивын баримтыг 100 хувь цахим хэлбэрт шилжүүлж, цахим архив бий болгох зорилтыг хуулийн зохицуулалтаас харж болно.

Иймд судалгаагаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон хуулийн зохицуулалтыг агуулгаар нь архивын бүхий л баримтыг цахим хэлбэрт буулгаж серверт хадгалах ажиллагааг хамруулан авч үзлээ.

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажил 2006 оноос эхэлсэн бөгөөд 2016 оны 12 сар хүртэл хугацаанд улсын хэмжээнд нийт архивын баримт

[5] Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт. Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр. Нэг, Хөтөлбөр боловсруулах хэрэгцээ, шаардлага

[6] Архивын ерөнхий газрын Мэдээллийн технологийн хэлтсийн үйл ажиллагаанд хийсэн процессын үнэлгээний тайланд Мэдээлэл технологи нэвтрүүлэх ажлын эрх зүйн үндэслэлд АтХ-ийн 15.1.12 дахь хэсгийг удирдлага болгосон байна.

18 хувийн[7] гүйцэтгэлтэй байна. Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд нийт архивын баримтын 30 хувийг цахим хэлбэрт шилжүүлэх зорилт тавьсан байна[8].

Хүснэгт 1. Орон нутагт дахь цахим баримт бүрдүүлэлтийн явц

ЦАХИМ ХЭЛБЭРТ ШИЛЖҮҮЛСЭН БАРИМТЫН ТОО 2016 ОН /3 ГЭРЭЭТ АРХИВЧ-ОПЕРАТОР/		
д/д	Төрийн архивын нэр	Нийт хуудасны тоо
1	Баянхонгор	143576
2	Дорнод	102265
3	Хөвсгөл	81976
4	Архангай	76294
5	Сүхбаатар	70041
6	Төв	59985
7	Ховд	59246
8	Завхан	58813
9	Өвөрхангай	43287
10	Хэнтий	41853
11	Баян-Өлгий	2995
12	Увс	2680

ЦАХИМ ХОЛБОЛТ ХИЙСЭН БАРИМТЫН ТОО 2016 ОН /3 ГЭРЭЭТ АРХИВЧ-ОПЕРАТОР/		
д/д	Төрийн архивын нэр	Нийт хуудасны тоо
1	Баянхонгор	157821
2	Дорнод	102265
3	Хөвсгөл	81454
4	Ховд	59249
5	Төв	59058
6	Увс	56618
7	Завхан	49843
8	Сүхбаатар	49045
9	Хэнтий	47165
10	Өвөрхангай	45000
11	Баян-Өлгий	30571
12	Архангай	10830

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

[7] Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан. Архивын ерөнхий газар, Мэдээлэл технолгийн хэлтэс. Статистик мэдээ 2016 оны 12 дугаар сарын байдлаар.

[8] Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.4.11. “Архивын баримт бичгийн 30 хувийг цахим хэлбэрт шилжүүлж, төрийн албан хэрэг хөтлөлтөд тоон гарын үсэг нэвтрүүлэх, мэдээллийн нэгдсэн систем бүрдүүлэх замаар төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг сайжруулна.” гэсэн байна.

ШИГТГЭЭ 2

Архивын баримтыг цахим хэлбэрт оруулах ажлыг зохих түвшинд гүйцэтгэж байна. 2006-2016 оны хооронд нийтдээ 18 хувийг цахим хэлбэрт оруулсан. Гэтэл 2016-2020 он хүртэл 4 жилийн хугацаанд 30%-ийг цахим хэлбэрт оруулна гэдэг маш том зорилт. Өнөөдрийн ажиллаж буй хүчин чадлаар бол зорилтыг биелүүлэхэд хүндрэл ихтэй гэж бодож байна.

Архивын ерөнхий газрын Хяналт, шинжилгээ -үнэлгээ, дотоод аудитын хэлтэс

Дээрхээс үзэхэд архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажил хийгдэж байгаа хэдий ч хангалтгүй, удаашралтай байна. Үүнд нөлөөлж буй гол хүчин зүйл бол цаг хугацаа ихээхэн шаардагддаг, боловсон хүчин, хүний нөөцийн тогтвортой байдал, программ хангамжийн байнгын хөгжүүлэлт шаардагддаг, орчин үеийн техник, тоног төхөөрөмжийн хэрэгцээ шаардлага[9] зэргээс хамаардаг.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. Хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.12 дахь хэсэгт Архивын баримтыг байгууллагын төрөлжсөн архивт 40 жил хадгалах бөгөөд уг хугацаа дууссаны дараа түүх, эрдэм шинжилгээний ач холбогдолтой хэсгийг төрийн архивт шилжүүлэх тухай зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ?

23 дугаар зүйл. Төрийн архивын сан хөмрөгийн баримтыг байгууллагын архивт хадгалах хугацаа

23.1. Архивын баримтыг байгууллагын архивт тэдгээрийг зохион бүрдүүлсэн оны дараа жилийн 1 дүгээр сарын 1-нээс эхлэн тооцож дор дурдсан хугацаагаар хадгалан уг хугацаа дууссаны дараа түүх, эрдэм шинжилгээний ач холбогдолтой хэсгийг нь төрийн архивт шилжүүлнэ:

23.1.1. Ерөнхийлөгч, түүний Тамгын газарт-20 жил;

23.1.2. Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлд-30 жил;

23.1.3. Улсын Их Хурал, түүний Тамгын газарт-20 жил;

23.1.4. Үндсэн хуулийн Цэцэд-20 жил;

23.1.5. Монгол Улсын Засгийн газар, түүний Хэрэг эрхлэх газарт-20 жил;

23.1.6. Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагуудад-15 жил;

23.1.7. яам, агентлагт-15 жил;

23.1.8.төрийн өмчийн болон төрийн өмч оролцсон хуулийн этгээд, улсын төсөвт байгууллагад -10 жил;

23.1.9. нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагад-8 жил;

23.1.10. зураг төслийн баримтыг үндсэн байгууллагад-20 жил;

23.1.11.шинжлэх ухаан, технологи, патентын холбогдолтой баримтыг үндсэн байгууллагад-15 жил;

23.1.12. байгууллагын төрөлжсөн архивт-40 жил

Монгол улсад Үндэсний төв архивын эх үүсвэр анх 1927 онд тавигдсан гэж үздэг. Харин Архивын ерөнхий газар 1948 онд байгуулагдаж байжээ. Үүний дараа 1960 онд төв, төрөлжсөн архив, салбар архивууд байгуулагдсан байна.[10]

[9] Архивын ерөнхий газрын мэргэжилтнүүд болон Төрөлжсөн архивын мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагаас онцлов.

[10] Архивын ерөнхий газрын цахим хуудас. https://www.archives.gov.mn/index.php?option=com_content&view =article&id=107&Itemid=84. Сүүлд зочилсон: 2017.7.30-ний өдөр.

Монгол Улсад 2017 оны байдлаар Үндэсний төв архив 1, Аймаг, нийслэлийн 22 архив, төрөлжсөн 10, салбар архив 4 нийтдээ төрийн архивын гэрчилгээ бүхий 37 архив үйл ажиллагаагаа явуулж байна.[11]

Хүснэгт 2. Төрийн архивын тогтолцоо



Архивын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д Үйл ажиллагааны онцлог, баримт бичгийн ач холбогдол, хэмжээ, бүрэлдэхүүнээс хамаарч, байгууллагын архив нь төрөлжсөн ба анхан шатны гэсэн зэрэглэлтэй байхаар тусгажээ.

Шүүх, прокурор, гадаад харилцаа, батлан хамгаалах, улсын аюулгүй байдлыг хангах болон цагдаагийн төв байгууллага нь шүүн таслах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдалд холбогдох баримт бичиг, гэрээ, хэлэлцээрийн эхийг төвлөрүүлж хадгалах архивыг төрөлжсөн архив гэнэ.[12] Харин байгууллагын анхан шатны архив гэдэгт зөвхөн тухайн байгууллагын бичиг баримтыг хадгалж буй архивыг хэлнэ.[13]

1998 онд Архивын тухай хууль батлагдахаас өмнө төрөлжсөн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг архивууд баримтаа байгууллага дээрээ хадгалдаг байсан. Үүнийг төвлөрүүлэх, нэгдсэн сан бий болгох зорилгоор тус 23 дугаар зүйлийн 23.1.12 дахь хэсгийн зохицуулалтыг шинээр хуульчилжээ.

Гэвч тус зохицуулалт хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш хэрэгжээгүй байна. Өөрөөр хэлбэл тус хуулийн заалтын хүрээнд төрөлжсөн архивууд ҮТА-т баримт шилжүүлсэн тохиолдол байхгүй байна.

Иймд тус зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй байгаа шалтгаан, нөхцөлийг тогтоох хүрээнд Үндэсний төв архивын болон Гадаад харилцааны яамны Гадаад харилцааны төв архив, УБТЗ-ын төв архив, Тагнуулын ерөнхий газрын тусгай архивуудын үйл ажиллагааг судалсан болно.

Архивын ерөнхий газар нь төрөлжсөн архивуудад хадгалагдаж буй баримтыг Үндэсний төв архив руу шилжүүлэх ажлыг зохион байгуулаагүй. Учир нь их хэмжээний баримтыг хадгалах байрны багтаамж байхгүй, зардал шаардлагатай гэж тайлбарлаж байна.

[11] http://www.archives.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=135&Itemid=89, Төрийн архивуудын 2016 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан.

[12] Архивын тухай хууль 1998 он. 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэг

[13] С.Туяа, И.Саруул. Архивч. УБ.,2015 он, 36 дахь тал.

Хуулийн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

ШИГТГЭЭ 3

Үндэсний төв архив Төрөлжсөн архивын баримтыг хүлээн авах боломж одоогоор байхгүй байна. Учир нь ТЕГ, ЦЕГ, Гадаад харилцааны яам гэх мэт олон жилийн түүхтэй байгууллагуудын архивын хөмрөг их хэмжээтэй байдаг. Хэрэв энэхүү заалтыг хэрэгжүүлье гэвэл санхүүжилт шаардлагатай болно. Төрөлжсөн архив нь тухайн байгууллага дээрээ байрлах нь тохиромжтой гэж үзэж байна. Ерөнхийд нь тус хуулийн 23.1.12 дахь хэсгийг харахад ач холбогдол нь төдийлөн харагддаггүй. Цаашид энэ зохицуулалт байх шаардлагатай эсэх нь эргэлзээтэй санагддаг.

Архивын ерөнхий газрын Хяналт, шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын газар хөрөнгө мөнгө төрөлжсөн архивууд

Төрөлжсөн архивын зүгээс хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн ажил мөн байхгүй байна. Тэд ерөнхийдөө төв газраас өгөх чиглэлийг хүлээх хандлагатай байдаг.

ШИГТГЭЭ 4

Манай архивт архивын баримтыг авах талаар өмнө нь мэдэгдэж байгаагүй. Бидний хувьд 40 жил өнгөрсөн баримтаа хуулийн дагуу шилжүүлэн өгөхөд татгалзах зүйл огт байхгүй. АЕГ Архивын тухай хуульд заасны дагуу хадгалах хугацаа дууссан архивын баримтыг хүлээн авья гэхэд тэдэнд өнөөдрийн байдлаар хүлээн авах, хадгалах боломж байхгүй байна. Ийм учраас баримт авах тухай дээрээс ч ярьдаггүй, бид шилжүүлье ч гэж ханддаггүй.

Гадаад харилцааны яамны
Гадаад харилцааны төв архив

Архивын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт тус “ ...хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх” талаар заасан байна. Гэвч хууль хэрэгжиж эхэлсэн 1998 оноос хойш дээрх хуулийн хэсгээр хариуцлага хүлээсэн тохиолдол байхгүй[14] байгаа нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байсныг харуулж байна.

3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дахь хэсэгт архивын баримтыг тусгай тээгч буюу цахим тооцоолуурын санамжид буулгаж, хадгалах талаарх зохицуулалт практикт хэрхэн хэрэгжсэн бэ?

Монгол Улсын Засгийн газар 2006 онд “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхээр батлсан. Хөтөлбөрийн нэгдүгээр үе шат 2006-2008 онд /ойрын хугацаа/, Хоёрдугаар үе шат 2009-2012 онд /дунд хугацаа/, гуравдугаар үе шат 2014-2016 онд хэрэгжсэн байна.

Засгийн газрын 2017 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор үндэсний хөтөлбөрийн 4 дүгээр үе шатыг 2017-2020 онд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна. Уг хөтөлбөрийн 5 дахь хэсэгт “4. Дөрөвдүгээр үе шат (2017-2020 он /дунд хугацаа/)” гэж, мөн хэсэгт “5.4. Дөрөвдүгээр үе шат (2017-2020)-нд Үндэсний төв архив, төрийн архивуудад хадгалагдаж байгаа цаасан суурьтай баримт, кино, гэрэл зураг, дуу авианы баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх, цахим архив үүсгэх ажлыг зохион байгуулна.”[15] гэж нэмсэн байна.

[14] Монгол Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн статистик мэдээ 2005-2016, Архивын ерөнхий газрын мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл.

[15] Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай.

Энэ хүрээнд хийгдсэн ажлын нэг нь төрийн архивын AMS (Archive Management System) программ бөгөөд архивын баримт мэдээллийг цахим хэлбэрээр хадгалан, архивын мэдээллийн нэгдсэн цахим сан үүсгэх, эрэлт хайлтыг автоматжуулах үндсэн дээр архивын үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилготой.[16] Тус программ нь төрийн архивын программын анхны хувилбар бөгөөд 2008 онд боловсруулагдаж байжээ. Үүнээс өмнө хүн, амын тооллогын цахим санд зориулагдсан “E-one” программыг боловсруулан ажиллаж байжээ.[17]

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 5.1.4 дүгээр зүйлийн 2-т “Төрийн архивуудын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх” арга хэмжээнд 4 жилийн хугацаанд 2,773.6 сая төгрөг, 3-т “Цахим архив үүсгэж хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах” арга хэмжээнд 648.8 сая төгрөг зарцуулахаар төсөвлөсөн байна.

Аймгийн хэмжээнд төрийн архивуудын сан хөмрөг дараах байдалтай байна. Үүнд:

График 2. 2006-2016 оны хугацаанд Аймгуудын төрийн архивын нийт баримт, үүнээс цахимжуулсан бариmтын тоо
/ хуудасны тоог 1 сая тоогоор илэрхийлэв/



Архивын ерөнхий газраас архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх талаар төрийн архивын удирдах ажилтнуудын нэгдсэн зөвлөгөөнийг хэд хэдэн удаа[18] зохион байгуулсан, Үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлэх хүрээнд улсын хэмжээнд 175 гэрээт ажилтныг цалинжуулан архивын баримтыг цахим хэлбэрт

[16] Д.Золбоо. УТА-ын баримтыг ангилан тодорхойлон бичих, цахим хэлбэрт оруулж буй талаарх ажлын туршлага. УБ., 2012. Зүүн Азийн орнуудын архивын салбар зөвлөл /EASTICA/ семинарын материал. Монгол талын илтгэл.

[17] Үндэсний архивын газрын 2007 оны үйл ажиллагааны тайлан. 8 дахь тал.

[18] Төрийн архивын удирдах ажилтны зөвлөгөөн. 2012 оны 05 дугаар сарын 24-25-ны өдрүүд

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

оруулах ажиллагааг хийлгэж байна.[19]

Архивын баримтыг цахим хэлбэрт оруулахад архивын байгууллагын хэрэглэж буй программ чухал үүрэгтэй. Өнөөдрийн байдлаар архивын үйл ажиллагаанд 102 байгууллага буюу 78.4% нь программ ашиглаж байна. Үүнд: Orm-Ams /ARMS/ программыг 25 байгууллага /19.2/, “Гурусофт” ХХК-ийн архивын программыг 7 байгууллага /5.3%/, бусад 70 байгууллага албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаанд өөрсдийн боловсруулсан программ хангамжуудыг ашиглаж байгаа нь төсвийн үр ашиггүй, давхар зардал гаргадаг, мэдээллийн санг нэгтгэхэд хүндрэл учруулдаг, албан хэрэг хөтлөлт, архивын арга зүйн шаардлагыг тэр бүр хангахгүй байгаа учир албан хэргийг цахим хэлбэрээр хөтлөх, цахим архив байгуулах талаар төрийн байгууллагын хэмжээнд нэгдсэн журам, стандарт гаргаж, мөрдүүлэх, шаардагдах дэд, техник технологи, программ хангамжийн асуудлыг нэгдсэн бодлогын хүрээнд шийдвэрлэх, цахим баримт бичгийг хадгалах, ашиглах, аюулгүй байдлыг хангах талаар хуульд тусгайлан тусгах шаардлагатай байна.[20]

Архивын ерөнхий газраас цахим хэлбэрт шилжүүлсэн баримтын тайлан, мэдээг сар бүр авч нэгдсэн мэдээ, тайлан гаргаж үр дүнг тооцон ажилласан нь гэрээт ажилтны ажлын төлөвлөгөө гарган биелэлтийг харгалзан үр дүнг нь тооцон ажилласан нь энэ ажлын гүйцэтгэл сайжирсан байна[21] гэж дүгнэсэн байна.

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, удирдлага зохион байгуулалтаар хангах зорилгоор ХЗДХ-ийн сайдын 2007 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 18 дугаар тушаалаар Архивын ерөнхий газарт “Мэдээлэл технологийн хэлтэс”-ийг байгуулсан. Мөн 2009 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 28 дугаар тушаалаар “Цахим сангийн төв”-ийг байгуулсан ба үндсэн 7 ажилтан, гэрээт 37 архивч-операторын бүрэлдэхүүнтэйгээр үндэсний архивт хадгалагдаж байгаа цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааг гүйцэтгэж байна. Харин орон нутагт 1-5 хүртэл хүнийг гэрээгээр ажиллуулж цахим мэдээллийн сан үүсгэх болон архивын баримтыг цахим хэлбэрт оруулах ажлыг гүйцэтгэж байна.

Монгол Улсын хэмжээнд архивт хадгалагдаж буй цаасан суурьтай болон тусгай төрлийн баримтын 18 хувийг цахим хэлбэрт шилжүүлснээр тухайн хэмжээнд баримтыг эрэлт, хайлтын систем үүсгэх байгууллага, иргэдэд архивын үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй үзүүлэх нөхцөл бүрдэхээс гадна архивын эх баримтыг ашиглалтаас чөлөөлж, баримтын насжилтын хугацааг уртасгаж байгаа давуу талтай юм.

Архивын баримтыг хадгалж буй Серверыг гадны цахим халдлагаас хамгаалах системийг тогтмол сайжруулан, хөгжүүлэлтийг хийж байх шаардлагатай. Учир нь цахим халдлагад өртсөн тохиолдолд Монгол Улсын Архивын мэдээлэл алдагдах аюултай бөгөөд энэ нь цаашлаад Монгол Улсын Үндэсний аюулгүй байдалд аюул учруулах эрсдэлтэй юм.

Шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон хуулийн зохицуулалт хэргэжихэд гарч буй хүндрэл бэрхшээл бол Төрийн архивуудын техник хэрэгсэл хоцрогдсон, үзүүлэлт нь хангалтгүй[22] байдаг. Орчин үеийн техник, тоног төхөөрөмж, хэрэгслээр Төрийн архивуудыг нэн даруй хангах шаардлагатай байна. Мөн архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажил нь цаг хугацаа ихээхэн шаардагддаг бөгөөд архивын баримтыг цахим хэлбэрт буулгах ажиллагаа харилцан адилгүй байдаг

[19] Архивын ерөнхий газрын 2012 оны үйл ажиллагааны тайлан. 4 дэх тал.

[20] Хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлан. Архивын ерөнхий газар. УБ., 2017 он, 9 дэх тал.

[21] Төрийн архивуудын 2016 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан. 2016 он. 9 дэх тал.

[22] Архивын ерөнхий газрын мэргэжилтнүүд болон Төрөлжсөн архивын мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагаас онцлов. /Архивын ерөнхий газрын Мэдээллийн технологийн хэлтэс болон Цахим сангийн төвд ашиглагдаж байгаа техник хэрэгсэл нь актлагдсан буюу ашиглалтын хугацаа дуусаад багагүй хугацаа өнгөрсөн байгааг мэргэжилтнүүд хэлж байсан/

байна. Ажиллах боловсон хүчнийг тогтмол чадавхжуулах, архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж буй гэрээт ажилтны тоог нэмэгдүүлэх шаардлага байгаа боловч Монгол Улсын эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалж дээрх асуудлыг цогцоор шийдвэрлэж чадахгүй байна.

Хүснэгт 3



Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. Хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.12 дахь хэсэгт Архивын баримтыг байгууллагын төрөлжсөн архивт 40 жил хадгалах бөгөөд уг хугацаа дууссаны дараа түүх, эрдэм шинжилгээний ач холбогдолтой хэсгийг нь төрийн архивт шилжүүлэх тухай зохицуулалт практикт нийцэж байна уу? Хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл түүнээс үүдэн гарах үр дагавар юу вэ?

Төрөлжсөн архивууд хадгалах хугацаа дууссан архивын баримтыг Үндэсний төв архивт шилжүүлэн өгөх зохицуулалт хэрэгжихгүй байгаад нөлөөлж буй гол шалтгаан, хүчин зүйлсийг дараах байдлаар бүлэглэн авч үзлээ. Үүнд:

1. Үндэсний төв архивт төрөлжсөн архивын баримтыг 40 жил хадгалах боломж хомс;
2. Баримтыг шилжүүлэхэд зардал ихээхэн шаардлагатай;
3. Хуульд төрөлжсөн архивын статус, чиг үүргийг ойлгомжгүй зохицуулсан;
4. Зарим архивын үйл ажиллагааны онцлогтой холбоотой шалтгаан;
5. Хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн хариуцлага тодорхой бус.

Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрөлжсөн архивуудын олонх нь 50 дээш жилийн хугацаанд үйл ажиллагаагаа явуулаад байна. Иймээс хадгалагдаж буй архивын нийт баримтын хэмжээ харьцангуй өндөр байна. Төрөлжсөн архив баримтаа 40 жил хадгалсны дараа Үндэсний архивын газар шилжүүлэхэд 1/ тээврийн зардал, 2/байршуулах заалт, зориулалтын шүүгээ, 3/бүртгэлд холбох, 4/ ажилтнуудын зардал гэх мэт шаардагдахаар байна.

Архивын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.12 дахь хэсэгт хадгалах хугацаа дууссан баримтыг төрийн архивт шилжүүлэх зохицуулалтыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй нэг бэрхшээл бол төрөлжсөн архивын статус тодорхойгүй, хуулийн зохицуулалтууд хоорондоо зөрчилдөөнтэй байгаатай холбоотой.

Архивын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэгт дурдсан зорилгын хүрээнд[23] төрөлжсөн архивтай байж болох тухай заасан ч түүний эрх, үүргийг тодорхойлолгүй орхигдуулсан байна.

Хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д “Төрөлжсөн архивт тухайн салбарын баримтыг 23.1.12-т заасан хугацаагаар хадгална. Төрөлжсөн архив нь төрийн

[23] Архивын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6. 20.6. Шүүх, прокурор, гадаад харилцаа, батлан хамгаалах, улсын аюулгүй байдлыг хангах болон цагдаагийн төв байгууллага нь шүүн таслах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдалд холбогдох баримт бичиг, гэрээ, хэлэлцээрийн эхийг төвлөрүүлж хадгалах зорилгоор төрөлжсөн архивтай байж болно.

архивын статустай байна.” гэж заасан нь төрөлжсөн архивийг төрийн архив мөн гэж ойлгохоор байна. Гэтэл хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-д “Төрийн архивын сан хөмрөгийн баримтыг зөвхөн Үндэсний төв архив болон аймаг, нийслэлийн архив байнга хадгалах эрхтэй байна.” гэж зааснаараа төрөлжсөн архивын статусыг ойлгомжгүй байдалд хүргэсэн. Төрөлжсөн архив баримтаа 40 жил хадгалсны дараа хаана шилжүүлэх нь тодорхойгүй үлджээ.

Хуулийн 12 дугаар зүйлд төрийн архивын тогтолцоог хуульчлахдаа түүнд төрөлжсөн архивыг оруулаагүй, хууль тогтоогчийн зүгээс нэгдсэн архивын сан хөмрөгийг бий болгохыг зорилго болгосон зэргээс үзэхэд төрөлжсөн архив баримтаа Үндэсний төв архивт шилжүүлэхээс өөр хууль зүйн гарц харагдахгүй байна.

Гэвч практикт төрөлжсөн архивуудад төрийн архивын “Батламж” олгох замаар төрийн архивд хамааруулан үздэг.

Мөн төрөлжсөн архивын байгууллагууд үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад хүний нөөцийн тогтворгүй байдал сөргөөр нөлөөлдөг байна. Мэргэшсэн ажилтнаа хөгжүүлэхэд бага анхаардаг, орон тооны цомхотгол хийхэд архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтан хамрагдах магадлал өндөр байдаг байна.

ШИГТГЭЭ

Төрөлжсөн архивуудын статус болон орон тоо зэрэг нь хоорондоо харилцан адилгүй байгааг нэг мөр хуульчлан зохицуулах хэрэгтэй. Жишээлбэл Батлан хамгаалахын төв архив нь Батлан хамгаалах яамны харьяанд бие даан үйл ажиллагаагаа явуулж байдаг. Гэтэл манайх болон зарим архивууд тухайн чиглэлийн байгууллагынхаа бүтцэд багтдаг. Манай архив гэхэд л Гадаад харилцааны яамны Тамгын газарт харьяалагдана. Статус тодорхой бус, харилцан өөр байгаа нь Архивын үйл ажиллагааг тогтвортой явуулахад их нөлөөлдөг. Хамгийн эхний жишээ бол орон тооны цомхотгол хийхдээ байгууллагууд хамгийн түрүүнд архивын ажилчдыг хөдөлгөөнд оруулдаг.

Гадаад харилцааны яамны
Гадаад харилцааны төв архив

Архивын баримтыг шилжүүлэн авахад баримтын онцлогийг харгалзан үзэх шаардлага тавигдаж байна. Хууль, хяналтын байгууллагын архивын хувьд хадгалагдаж байгаа баримтууд нь нууц зэрэглэлтэй мэдээлэл тул Үндэсний архивын газарт шилжүүлэхэд ихээхэн хяналттай хандах шаардлагатай.

ШИГТГЭЭ

Хууль, хяналтын байгууллагын хувьд баримтыг цахим хэлбэрт оруулах тал дээр ихээхэн анхааралтай хандах талаар удирдлагаас чиглэл өгдөг. Цахим архивын хувьд удирдлага, захирамжлалын баримт бичгийг цахим хэлбэрт оруулах ажил хийгдэж байна. Үүнд даргын тушаал гэх мэт тагнуулын байгууллагад хамаарах лавлагааг гаргах зэрэг ордог. Ялангуяа өмнө ажиллаж байсан хүмүүс лавлагаа авахаар ихэвчлэн ирдэг. Удирдлага, захирамжлалын баримт бичгээс өөр баримтыг цахим хэлбэрт оруулах ажлыг манайх түр хойшлуулаад байгаа. Учир нь тагнуулын байгууллагаас гарч буй баримт бичгүүд нь Төрийн нууцын тухай хуулиар хамгаалагдсан тул зөвхөн Архивын тухай хууль, тогтоомжийг баримтлах зөрчилтэй байдлыг үүсгэх талтай байдаг. Мөн 2017 онд Төрийн болон албаны нууцын тухай хууль шинээр батлагдсантай холбогдуулан тус хуульд үйл ажиллагаагаа нийцүүлэх зэрэг бусад олон журмыг цогцоор нь харж, хандахыг хичээж байна

Хууль, хяналтын байгууллагын архив

www.nli.gov.mn

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу Архивын тухай хуулин дахь сонгосон заалтад үнэлгээ хийж гүйцэтгэв. Үнэлгээний төгсгөлд үнэлгээг илэрхийлсэн дүгнэлт болон үнэлгээнд тулгуурлан хууль тогтоомжийн хүртээмжтэй, үр нөлөөтэй байдлыг нэмэгдүүлэх талаар зөвлөмж гаргасан болно.

4.1. Үнэлгээний дүгнэлт

Архивын тухай хуулийн Гурав дугаар бүлгийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дахь хэсгийн хэрэгжилтийн үр дагаварт “Зорилгод хүрсэн түвшин”, “Практикт хэрэгжсэн байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийв.

Үнэлгээний үр дүнг дүгнэхэд дараах байдалтай байна:

Зорилгод хүрсэн түвшин:

Улсын хэмжээнд 37 төрийн архивт хадгалагдаж байгаа архивын бүх баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх нь багагүй цаг хугацаа, санхүүжилт, хүний нөөц шаардсан, тодорхой үе шатны дагуу гүйцэтгэх ажил юм. Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх хуулийн зохицуулалт нь архивын баримтын эх хувилбарыг ашиглалтаас чөлөөлж, баримтын механик элэгдлээс хамгаалах зорилгыг агуулдаг.

Иймд тухайн заалтын хэрэгжилтийг дүгнэхдээ архивын баримтыг тусгай тээгч буюу цахим тооцоолуурын санамжид буулгах, хадгалах ажлын гүйцэтгэл, үр дүн авч үзэх ач холбогдолтой.

Хуулийн зохицуулалт томьёоллын хувьд оновчтой бус байгаа нь практикт ялгаатай ойлгогдоход хүргэдэг байна. Энэ нь 1998 онд тус хууль батлагдан гарахад техник, технологийн хөгжил өнөөгийн түвшинд хүрээгүй байсантай холбоотой гэж салбарын мэргэжилтнүүд үздэг байна.

2006-2016 оны хугацаанд нийт Монгол Улсын архивт хадгалагдаж байгаа баримтын 18%-ийг цахим хэлбэрт оруулсан нь хангалттай үзүүлэлт биш юм. Гэхдээ архивын программ зохион бүтээх, хэрэглээнд нэвтрүүлэх зэрэг ажилд ихээхэн анхаарал хандуулсныг харгалзах хэрэгтэй. Цахим архив үүсгэх ажлын хүрээнд Засгийн газраас 2006 онд Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээлэл технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр баталж, өнөөг хүртэл хэрэгжүүлж байгаа нь хэрэгжилтийн үр нөлөөг хангахад голлох үүргийг гүйцэтгэсэн байна.

Тус зохицуулалтыг зорилгод хүрсэн түвшин гэсэн шалгуур үзүүлэлтээр шалгахад архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх үе шаттай үйл ажиллагааг хэрэгжүүлж зохих түвшинд хүрсэн нь харагдаж байгаа боловч шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон хуулийн зохицуулалтын хэрэгжилт хангалттай гэж үзэх боломжгүй. Цахим архив үүсгэх ажил удаашралтай байгааг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Практикт хэрэгжсэн байдал:

Архивын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дахь хэсгийг хэрэглэх явцад хэд хэдэн бэрхшээл тулгамдаж байна.

Дээр дурьдаж буй асуудлын хувьд архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажил нь цаг хугацаа ихээхэн шаардагддаг, боловсон хүчин, хүний нөөцийн орон тоо дутмаг, архивын баримтыг цахим хэлбэрт буулгах ажиллагаа харилцан адилгүй, программ хангамжийн байнгын хөгжүүлэлт шаардагддаг, орчин үеийн техник, тоног төхөөрөмжийн хэрэгцээ шаардлага зэрэг санхүүжилтын асуудлыг цогцоор шийдвэрлээгүй нь тус хуулийн зохицуулалтыг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй байгаагийн шалтгаан болж байна.

Нөгөө талаас цахим архив үүсгэх, хадгалах ажил хийгдэж эхлээд багагүй хугацаа өнгөрсөн боловч эрх зүйн зохицуулалт хангалтгүй байсан бөгөөд зарим төрлийн журмаар зохицуулж байжээ. Хуульд зөвхөн 15.1.12-р зүйл уг харилцаанд хамаарч байгаа нь зохицуулалтын түвшинд хангалтгүй байсантай холбоотой.

Архивын тухай хуулийн Гурав дугаар бүлгийн 23 дугаар зүйлийн 23.1.12 дахь хэсгийн хэрэгжилтийн үр дагаварт "Зорилгод хүрсэн түвшин", "Практикт хэрэгжсэн байдал" шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийв.

Үнэлгээний үр дүнг дүгнэхэд дараах байдалтай байна:

Зорилгод хүрсэн түвшин:

Шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон хуулийн зохицуулалтын зорилго нь түүхийн болон эрдэм шинжилгээний ач холбогдол бүхий баримтыг Төрийн архивт төвлөрүүлж нэгдсэн судалгаа, шинжилгээний архивын сан хөмрөг үүсгэх гэсэн агуулгатай байна.

Архивын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.12 дахь хэсэгт заасны дагуу төрөлжсөн архивууд хадгалах хугацаа дууссан баримтаа төрийн архив /Үндэсний төв архив/-т шилжүүлсэн тохиолдол байхгүй байна. Архивын ерөнхий газар болон төрөлжсөн архивын үйл ажиллагаанд хийсэн ярилцлагын судалгаанаас үзэхэд хоёр талаас хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх тал дээр аливаа арга хэмжээг зохион байгуулсан тохиолдол байхгүй байна. Үүнээс үзэхэд Төрийн архив нь төрөлжсөн архивын түүхийн болон эрдэм шинжилгээний ач холбогдол бүхий баримтаар баяжигдаагүй байна.

Тус зохицуулалтыг зорилгод хүрсэн түвшин гэсэн шалгуур үзүүлэлтээр шалгахад зорилгодоо хүрээгүй гэж дүгнэж болохоор байна.

Практикт хэрэгжсэн байдал:

Архивын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.12 дахь хэсэг нь батлагдсанаас хойш хэрэгжсэн тохиолдол байхгүй байна. Үүнд нөлөөлж буй нэг шалтгаан нь Үндэсний төв архивт төрөлжсөн архивын баримтыг хадгалах боломж бага, баримтыг шилжүүлэхэд багагүй зардал гарахтай холбоотой байдаг. Мөн хуульд төрөлжсөн архивын статус, чиг үүргийг ойлгомжгүй зохицуулсан нь тус зохицуулалтын хэрэгжилт хангагдахгүй байх нөхцөлийг бүрдүүлжээ.

Хууль, хяналтын байгууллагын төрөлжсөн архив уг зохицуулалтыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагааны төрөл нь хязгаарлалт болох хандлагатай байдаг. Жишээлбэл: Зарим Хууль, хяналтын байгууллагын архив нь удирдлага, захирамжлалын баримтаас бусад баримтыг Төрийн нууцын тухай хуулийн дагуу төрийн нууцад хамаарах тул төрөлжсөн архивдаа хадгалагдах нь зүйтэй гэж үздэг байна.

Нөгөө талаас Төрийн архивын санаачилгаар авах уу эсхүл төрөлжсөн архивын хүсэлтээр архивын баримтыг хүлээлгэн өгөх үү, мөн тухайн баримтыг хүлээлгэн өгөх, авахтай холбоотой санхүүгийн зардлыг аль тал нь хариуцах, төсөвт тусгагдсан эсэх нь тодорхойгүй байдгаас ямар албан тушаалтан хариуцлага хүлээх эсэх нь тодорхойгүй байдагтай холбоотой гэж үзэж байна.

Шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон хуулийн зохицуулалт нь практикт огт хэрэгжээгүй байна.

Иймд тус зохицуулалт цаашид шаардлагатай эсэхийг эргэн харах, эсхүл бодит байдалд нийцүүлэн сайжруулан томьёолох нь зүйтэй байна.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.legal.gov.mn

4.2. Зөвлөмж

Үнэлгээний үр дүнд буюу үнэлгээг илэрхийлсэн дүгнэлтэд тулгуурлан хууль тогтоомжийн хэрэгжилтийг илүү хүртээмжтэй, үр нөлөөтэй болгох талаар дараах санал, зөвлөмж гаргаж байна.

Архивын тухай хуулийн үнэлгээ хийсэн холбогдох заалтуудын дүгнэлт, бусад холбогдох судалгаануудад үндэслэн Архивын тухай хуулийг шинэчлэн найруулах/нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргаж байна. Ингэхдээ дараах зохицуулалтуудыг тусгах нь цаашид ач холбогдолтой байна. Үүнд:

- Архивын баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлэх, цахим архив үүсгэхэд чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, ялангуяа энэ төрлийн суурь харилцааг хуулиар зохицуулах;
- Цахим архив үүсгэх ажлын явц удаашралтай байгааг эрчимжүүлэх, санхүүгийн тогтвортой байдлаар хангахад анхаарах;
- Төрөлжсөн архив болон төрийн архивын статусыг тодорхой хуульчлах, тэдгээрийн эрх үүргийг хуулиар эсхүл бусад баримт бичгээр нарийвчлан тодорхойлох;
- Төрөлжсөн архивын байгууллагын үйл ажиллагааг тогтворжуулах;
- Архивын баримтыг төрийн архивт шилжүүлэх зардлыг харгалзан цахим хэлбэрээр шилжүүлэх боломжийг нэвтрүүлэх;
- Архивын баримтыг төрийн архивт шилжүүлэн өгөх ажиллагаанд оролцогчдын эрх үүргийг тодорхойлох, хуулийг хэрэгжүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг нарийвчлан тусгах;
- Архивын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.12 дугаар хэсгийн зохицуулалт шаардлагатай эсэхийг эргэн харах, шаардлагатай гэж үзвэл сайжруулан томьёолох.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. Эрх зүйн баримт бичиг

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992
2. Архивын тухай хууль,1998
3. Төрийн нууцын тухай хууль, 1995
4. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоол.
5. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
6. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай. 2017 оны 4 дүгээр тогтоол.
7. Архивын ерөнхий газраас 2017 онд хэрэгжүүлэх нийтлэг арга хэмжээ
8. Мэдээлэл аюулгүй ажиллагааны журам. Архивын ерөнхий газрын даргын 2012 оны 04/2858 тоот тушаал

Хоёр. Статистик мэдээ, судалгааны тайлан,

9. Төрийн албан хэрэг хөтлөлтийн эрх зүйн зохицуулалт. ХЗҮХ-ийн судалгааны төв, 2014
10. Архивын ерөнхий газрын мэдээллийн мэдээллийн технологийн хэлтсийн үйл ажиллагаанд хийсэн процессын үнэлгээний тайлан, 2016
11. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал, Архивын ерөнхий газар, 2014
12. Архивын ерөнхий газрын төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээний биелэлтийн тайлан, 2016 он
13. "Архивын ерөнхий газраас үзүүлж буй төрийн үйлчилгээ ба хэрэглэгчийн сэтгэл ханамж" мониторингийн судалгаа, 2014 он
14. Архивын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх дүгнэлт, Архивын ерөнхий газар, 2004 он
15. Төрийн архивуудын 2016 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, Архивын ерөнхий газар, 2017 он
16. Архивын ерөнхий газрын үйл ажиллагааны тайлан /2007-2016/
17. Архивын ерөнхий газрын мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл.
18. Төрөлжсөн архивын эрхлэгч, архивчтай хийсэн ярилцлагын тэмдэглэл.

Гурав. Мэргэжлийн ном, сурах бичиг, өгүүлэл

19. Хууль тогтоомжийн тухай /Аргачлал, гарын авлага/. ХЗДХЯ. УБ.,2015
20. С.Туяа, И.Саруул. Архивч. УБ.,2005
21. Архивын салбарын хөгжлийн стратеги /2016-2025 он/. ХЗДХЯ, Архивын ерөнхий газар, 2016
22. Д.Золбоо. Үндэсний төв архивыг ангилан тодорхойлох, бичих, цахим хэлбэрт оруулж буй талаарх ажлын туршлага.

----o0o----

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

БАРААНЫ ТЭМДЭГ, ГАЗАР ЗҮЙН ЗААЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ (Шинэчилсэн найруулга)-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН [1]

УДИРТГАЛ

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар “Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль” (шинэчилсэн найруулга)-ийн хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийв.

БТГЗЗтХ-ийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх судалгаа нь хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгахын зэрэгцээ хуулийг хэрэгжүүлснээр гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг байдлыг илрүүлэн, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж дүгнэлт, зөвлөмж өгөх зорилготой.

Тус үнэлгээг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвөөс 2017 оны 6 дугаар сарын 26-ны өдрөөс 2017 оны 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн болно.

Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ нь төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шатаас бүрдсэн.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Төлөвлөх шатны зорилго үнэлгээ хийх хүрээг тогтоож, түүнд тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход чиглэгдэнэ. Энэ үе шатанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
- Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
- Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
- Харьцуулах хэлбэрийг сонгох;
- Шалгуур үзүүлэлтийг томъёолох;
- Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

1.1.Үнэлгээ хийх шалтгаан

2010 онд БТГЗЗтХ-ийг баталж, хэрэгжүүлж эхэлснээс хойш 7 жил өнгөрсөн. Энэ хугацаанд хуулийг хэрэгжүүлэх явцад зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх, хэрэглэхэд хүндрэл гарах болсон төдийгүй уг харилцаанд оролцогчид, эрдэмтэн судлаачдын зүгээс хуулийн хэрэгжилттэй холбоотой тодорхой асуудлаар нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл бүхий санал гаргасан тул хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх зайлшгүй шаардлагатай гэж үзсэн болно.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” 11 дүгээр тогтоолын хавсралтын 142-т заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамны 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.1.14-т “Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийн үзэл баримтлалыг батлуулж, 2018 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгажээ. Улмаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 4-т Оюуны

[1] Тус судалгааг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Х.Эрдэм-Ундрах удирдан, эрдэм шинжилгээний ажилтан Н.Мичидмаа, У.Эрдэнэзаяа, Б.Сүнжидмаа нар хамтран гүйцэтгэв.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.zhi.gov.mn

өмч улсын бүртгэлийн тухай багц хуулиудад судалгаа хийхээр тус тус тусгасан байна. Дээрх баримт бичгүүдийг үндэслэн Засгийн газрын 2016 оны 59-р тогтоолын 6-р хавсралтаар баталсан аргачлалыг баримтлан БТГЗЗтХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийв.

1.2. Үнэлгээ хийх хүрээ

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг.

БТГЗЗтХ нь барааны тэмдэгтэй холбогдсон харилцаа, газар зүйн заалттай холбогдсон харилцаа гэсэн тус тусын агуулга бүхий хоёр харилцааг нэг хуулиар зохицуулдаг.[2] Гэсэн хэдий ч барааны тэмдэг, газар зүйн заалтыг эрх зүйн хувьд баталгаажуулах, уг харилцаанд оролцогчдын хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой бүхий л асуудлыг төрийн захиргааны нэг байгууллагын нэг нэгж хариуцан ажиллаж байна. Үүний зэрэгцээ оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч оюуны өмчийн эрхийг хамгаалахад багагүй үүрэг гүйцэтгэдэг байна. Үүнийг харгалзан үзэж уг хуулийн 6 дугаар бүлгийн 29 дүгээр зүйл. Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг; 31 дүгээр зүйл. Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч гэсэн зүйл, заалтыг сонгон авсан болно.

1.3.Үнэлгээний шалгуур үзүүлэлт

БТГЗЗтХ-ийн хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараах хоёр шалгуур үзүүлэлтийг сонгон авлаа. Үүнд:

- зорилгод хүрсэн төвшин ;
- практикт нийцэж байгаа байдал.

Зорилгод хүрсэн төвшин шалгуур үзүүлэлтээр БТГЗЗтХ-ийн 29, 31 дүгээр зүйл хуулийн зорилгодоо хүрсэн эсэхийг үнэллээ.

Ер нь хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг судалдаг хамгийн чухал шалгуур үзүүлэлт нь “зорилгод хүрсэн төвшин ” шалгуур үзүүлэлт юм. Иймд БТГЗЗтХ-ийн 1 дүгээр зүйлээр тодорхойлсон “*бараа, үйлчилгээний тэмдэг (цаашид “барааны тэмдэг” гэх), газар зүйн заалтыг эрх зүйн хувьд баталгаажуулах, түүнийг эзэмшигч, хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах болон барааны тэмдэг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, газар зүйн заалтыг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино*” гэх хуулийн зорилтыг хэрэгжүүлэхэд энэ хуулийн 29, 31 дүгээр зүйл хангалттай үйлчилж чадаж байгаа эсэхийг тодруулахад чиглэсэн.

Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгон авсан хуулийн зүйл хэрхэн хэрэгжиж байгаа, хэрэгжүүлэхэд гарч байгаа хүндрэл, бэрхшээл байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно.

1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр

БТГЗЗтХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших гэсэн хэлбэрийг сонгож үнэлгээг хийлээ.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох

Шалгуур үзүүлэлтийг томъёолохдоо сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах асуултыг боловсруулсан.

[2] Зарим улс оронд дээрх хоёр харилцааг 2 эрх зүйн баримт бичгээр зохицуулдаг. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 1, 2-оос харна уу.

Зорилгод хүрсэн төвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн зургаадугаар бүлэг. Оюуны өмчийн байгууллага

- 29 дүгээр зүйл. Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг зохицуулсан зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ?
- 31 дүгээр зүйл. Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн асуудлыг зохицуулсан зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ?

Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн зургадугаар бүлэг. Оюуны өмчийн байгууллага

- 29 дүгээр зүйл. Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тогтоосон зохицуулалт практикт нийцэж байна уу, хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байна уу?
- 31 дүгээр зүйл. Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх зүйн зохицуулалт практикт нийцэж байна уу, хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байна уу?

1.6.Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн төвшин , практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор баримт бичиг, судалгааны ажил уншиж, судлах, харьцуулалт хийх, мэргэжилтнүүдтэй уулзаж, ярилцах, санал солилцох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд мэдээлэл цуглуулах дараах аргуудыг ашигласан болно. Үүнд:

- **Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах:** Барааны тэмдэг, газар зүйн заалтад холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенци, бусад эрх зүйн баримт бичиг, ном сурах бичиг, нэг сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайлан, статистик мэдээнд дүн шинжилгээ хийсэн;
- **Холбогдох субьектээс судалгаа авах**: БТГЗЗтХ-ийн үйлчлэлд хамаарах төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, албан хаагч, эрх эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хуульч, судлаачдаас фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын аргаар судалгаа авсан.

Хүснэгт 1. Төлөвлөх үе шатанд хийгдсэн ажил

ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ				
Үнэлгээний хүрээ	**Шалгуур үзүүлэлт**	**Харьцуулах хэлбэр**	**Шалгуур үзүүлэлтийн томъёолол**	**Мэдээлэл цуглуулах арга**
Хуулийн зургадугаар бүлэг. **· 29 дүгээр зүйл.** Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага **· 31 дүгээр зүйл.** Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч	· Зорилгод хүрсэн төвшин ; · Практикт нийцэж байгаа байдал.	· Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш.	**Зорилгод хүрсэн төвшин** · 29 дүгээр зүйл. Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг зохицуулсан зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ? · 31 дүгээр зүйл. Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн асуудлыг зохицуулсан зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ? **Практикт нийцэж байгаа байдал** · 29 дүгээр зүйл. Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тогтоосон зохицуулалт практикт нийцэж байна уу, хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байна уу? · 31 дүгээр зүйл. Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх зүйн зохицуулалт практикт нийцэж байна уу, хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байна уу?	**· Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах:** Барааны тэмдэг, газар зүйн заалтад холбогдох хууль тогтоомж, Олон улсын гэрээ, конвенци, БТГЗЗтХ-ийн хэрэгжилттэй холбогдон гарсан ном сурах бичиг, мэргэжлийн өгүүлэл, илтгэл, судалгааны тайлан, статистик мэдээнд дүн шинжилгээ хийх; **·Холбогдох субьектээс судалгаа авах:** БТГЗЗтХ -ийн үйлчлэлд хамаарах төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, албан хаагч, эрх эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хуульч, судлаачдаас фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын аргыг ашиглан судалгаа авах;

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

БТГЗЗтХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ бэлэн байгаа мэдээллийг цуглуулах, холбогдох субьектээс судалгаа авах аргаар холбогдох материалыг цуглуулан үнэлгээг хийсэн болно.

- *Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах*

Хууль, эрх зүйн акт

1. Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль, 2010.
2. Аж үйлдвэрийг хамгаалах өмчийг хамгаалах тухай Парисийн конвенци.
3. Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээр.
4. Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээрийн протокол.
5. Барааны тэмдгийг бүртгэх зорилгоор бараа үйлчилгээний олон улсын ангилал тогтоох Ниццийн ангилал.
6. Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр.
7. Trademarks Act, the Statutes of the Republic of Singapore, 2005.
8. Geographical Indications Act, the Statutes of the Republic of Singapore, 1999.
9. Civil Code of the Russian Federation, Part IV, Section VII, Rights to the Results of Intellectual Activity and Means of Individualization, 2007.
10. The Lanham Act. 15 US.C. Chapter 22, 1947.
11.Provisions for the Protection of Products of Geographical Indication Promulgated by the General Administration of Quality Supervision, Inspection and Quarantine of the People's Republic of China on May 16 2005.
12. Trademark Law of the People's Republic of China, 2013.
13. "Оюуны өмчийн улсын хяналтын дүрэм", Засгийн газрын 1999 оны 220 дугаар тогтоол.
14. "Оюуны өмчийн тогтолцоог хөгжүүлэх үндэсний стратеги", Засгийн газрын 2015 оны 298 дугаар тогтоол.
15. "Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц", Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны А/16 тоот тушаал.
16. "Барааны тэмдгийг бүртгэх, улсын бүртгэл хөтлөх тэдгээрт өөрчлөлт оруулах тухай журам", Оюуны өмчийн газрын даргын 2011 оны 112 тоот тушаал.
17. "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай", Оюуны өмчийн газрын даргын 2015 оны 179 тоот тушаал.
18. "Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах журам", Оюуны өмчийн газрын даргын 2002 оны 1/120 тоот тушаалын хавсралт.

Ном, сурах бичиг

19. Мягмардорж.Э, Оюуны өмчийн эрх зүйн үндсэн асуудлууд, УБ., 2003.
20. Цолмон.Д, Оюуны өмчийн эрх зүй, УБ., 2016.

Эрдэм шинжилгээний өгүүлэл

21. Тэмүүлэн.Б, Барааны тэмдгийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал, "Эрх зүйн онол, практик, арга зүй, мэдээллийн цуврал", №6-7, УБ., 2001.
22. Эрдэнэчимэг.Д, Барааны тэмдэг, газар зүйн заалт, түүний учир холбогдол, "Монголын төр, эрх зүй", №3, УБ., 2003.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

Цахим эх сурвалж

23. http://www.mfa.gov.mn/wp-content/uploads/2016/06/Int-Treaty-List-24-Dec-2015-2.pdf
24. www.legalinfo.mn
25. www.wipo.int
26. www.ipom.mn
27. Burtgel.mn зэрэг хоёрдогч эх сурвалжуудыг ашигласан.

· *Холбогдох субьектээс судалгаа авах арга*

БТГЗЗтХ-ийн хэрэгжилтийн талаар фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын аргаар мэдээллийг цуглуулсан.

Тус хуулийг хэрэгжүүлэгч субьект болох салбарын мэргэжилтнүүд, хуулиар эрх, ашиг сонирхол нь хөндөгддөг бүлгийн төлөөлөл болох итгэмжлэгдсэн төлөөлөгч, барааны тэмдэг эзэмшигч, газар зүйн заалт хэрэглэгчид болон эрдэмтэн, судлаач, хуульч зэрэг нийт 19 хүнээс фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага авсан. Судалгаанд оролцогчдын мэдээллийг хувиар харуулбал. (Зураг 1).

Зураг 1. Судалгаанд оролцогчдын мэдээлэл (хувиар)



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭНГ www.nli.gov.mn

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлтийн томъёоллын дагуу БТГЗЗтХ-ийн 29 дүгээр зүйлд үнэлгээ хийхэд дараах байдалтай байв:

3.1. “Зорилгод хүрсэн төвшин ” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

БТГЗЗтХ-ийн үндсэн зорилтыг *“бараа, үйлчилгээний тэмдэг (цаашид “барааны тэмдэг” гэх), газар зүйн заалтыг эрх зүйн хувьд баталгаажуулах, түүнийг эзэмшигч, хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, барааны тэмдэг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, газар зүйн заалтыг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино”*[3] хэмээн уг хуулийн нэгдүгээр зүйлд заажээ. Энэхүү зорилтыг хуулийн бүхий л зохицуулалт хангаж байх учиртай гэж үзэж байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Хуулийн 29 дүгээр зүйл буюу Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгтэй холбоотой зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ?

[3] Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/, “Төрийн мэдээлэл” сэтгүүл №26/647/, УБ., 2010.

29 дүгээр зүйл.Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага

29.1.Монгол Улсад барааны тэмдэг, газар зүйн заалттай холбогдсон асуудлыг төрийн захиргааны байгууллага хариуцах бөгөөд төрийн захиргааны байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

29.1.1.барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

29.1.2.барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал боловсруулах;

29.1.3.барааны тэмдэг, газар зүйн заалтыг бүртгэх, улсын бүртгэл хөтлөх, тэдгээрт өөрчлөлт оруулах, барааны тэмдгийг нийтэд түгээмэл болсонд тооцохтой холбоотой журам, дүрмийг боловсруулж, батлах;

29.1.4.барааны тэмдэг, газар зүйн заалтыг бүртгүүлэх тухай өргөдлийн маягт болон барааны тэмдэг, газар зүйн заалтын гэрчилгээний загварыг тогтоох;

29.1.5.барааны тэмдэг, газар зүйн заалтын мэдүүлгийг хүлээн авч, хянах;

29.1.6.барааны тэмдэг, газар зүйн заалтыг бүртгэж, гэрчилгээ олгох;

29.1.7.барааны тэмдэг, газар зүйн заалтын улсын нэгдсэн бүртгэл хөтлөх;

29.1.8.барааны тэмдэг, газар зүйн заалтын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;

29.1.9.барааны тэмдэг, газар зүйн заалтын бүртгэлтэй холбогдсон мэдээллийг нийтэд мэдээлэх зорилгоор энэ хуулийн 3.1.14-т заасан албан ёсны тогтмол хэвлэлд нийтлэх;

29.1.10.хуульд заасан үндэслэл, журмын дагуу барааны тэмдэг, газар зүйн заалтыг хүчингүй болсонд тооцох;

29.1.11.барааны тэмдгийн олон улсын бүртгэлтэй холбоотой үйл ажиллагаа явуулах;

29.1.12.Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн биелэлтэд тавих улсын хяналтыг хэрэгжүүлэх, оюуны өмчийн улсын байцаагч ажиллуулах;

29.1.13.барааны тэмдэг, газар зүйн заалтын талаархи сургалт, судалгааны ажлыг нэгдсэн арга зүйгээр хангаж, зохион байгуулах;

29.1.14.барааны тэмдэг, газар зүйн заалтын үнэлгээг эзэмшигч, хэрэглэгчийн хүсэлтээр баталгаажуулах;

29.1.15.оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах этгээдийг шалгаруулах, тусгай зөвшөөрөл олгох;

29.1.16.хуулиар харьяалуулсан гомдол, маргааныг хянан шийдвэрлэх;

29.1.17.хуульд заасан бусад чиг үүрэг.

29.2.Энэ хуулийн 6.4.2, 9.4, 17.3, 25.4-т заасан үйлчилгээний хураамжийн хэмжээг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

31 дүгээр зүйл. Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч

31.1.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь дээд боловсролтой, оюуны өмчийн салбарт гурваас доошгүй жил ажилласан, 25 насанд хүрсэн, Монгол Улсад байнга оршин суудаг Монгол Улсын иргэн, эсхүл Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан, үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд байна.

31.2.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу тусгай зөвшөөрөл авна.

31.3.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах журмыг төрийн захиргааны байгууллага батална.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ КҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Монгол Улсад Оюуны өмчийн эрхийн асуудлыг анх 1952 оны Иргэний хуулийн арван найм, арван есдүгээр бүлэгт хуульчилж, 1963 оны Иргэний хуулиар агуулга, цар хүрээг нь улам баяжуулсан байна. Улмаар 1967 онд "Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай дүрэм" батлагдаж, 1987 онд шинэчлэгдэж байжээ.

Монгол Улс Дэлхийн оюуны өмчийн байгууллагад 1979 онд элссэн, 1992 оны "Үндсэн хууль" батлагдсан, 1997 онд Венийн конвенцид нэгдэн орсон. Эдийн засгийн харилцаанд "*brand*" гэх ойлголтыг бататгаж төрөлжүүлсэн анхны хууль болох "Барааны тэмдэг, аж ахуйн нэрийн тухай хууль" 1996 онд батлагдсан байна.

Барааны тэмдэг, газар зүйн заалтын харилцааг хамтад нь хуульчилсан анхны хууль 2003 оны 5 сарын 2-ны өдөр батлагдсан бөгөөд 2010 онд шинэчлэн найруулсан БТГЗЗтХ хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Ингээд барааны тэмдэг, газар зүйн заалттай холбогдсон асуудлыг хариуцах байгууллагын нэр, статусыг урьд батлан хэрэгжүүлж байсан 1996, 2003 оны хуулийн холбогдох заалттай харьцуулан үзэж онцлог шинжийг нь хүснэгтээр харуулъя.

Хүснэгт 2. Барааны тэмдэг, газар зүйн заалттай холбоотой асуудлыг хариуцах байгууллага

Хуулийн нэр	**Хариуцах байгууллага, чиг үүрэг**	**Онцлог шинж**
"Барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийн тухай хууль" (1996 -12-19)	6.1 **Оюуны өмчийн газар нь барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийг бүртгэхтэй** холбогдсон дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:	· Хуулийг хэрэгжүүлэх байгууллагыг шууд нэрлэн зааж хуульчилсан. · Барааны тэмдэгээс гадна ААН-ийн нэрийг бүртгэх асуудлыг тус хуулиар зохицуулж байв. · Газар зүйн заалттай холбоотой харилцаа үүнд хамаарахгүй. · Барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийг зөвхөн "**бүртгэх"-**тэй холбогдсон харилцааг Оюуны өмчийн газар хэрэгжүүлэхээр заасан.
"Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль" (2003-05-02)	4.1 **Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага** / цаашид "байгууллага" гэх/ нь барааны тэмдэг, газар зүйн заалтыг **бүртгэхтэй** холбогдсон дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:	· **"*Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага*"** гэж хуульчилсан нь уг хуулийн хэрэгжилтийг хариуцсан байгууллагын оноосон нэр өөрчлөгдөж "тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" уг асуудлыг хэрэгжүүлэхээр заасан. · ААНэгжийн нэр гэдгийг хасч, газар зүйн заалт гэдэг нэр томъёо, ойлголтыг хуулинд тусгаснаар тухайн байгууллагын эрхлэх асуудлын хүрээ өөрчлөгдсөн. · Өмнөх хуультай адил, чиг үүргийн хүрээг зөвхөн "бүртгэх" үйл ажиллагаа байхаар хязгаарласан.
"Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль" /Шинэчилсэн найруулга/ (2010-06-10)	29.1.Монгол Улсад барааны тэмдэг, газар зүйн заалттай холбогдсон асуудлыг **төрийн захиргааны байгууллага хариуцах** бөгөөд төрийн захиргааны байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:	· "...бүртгэх"-ээс гадна бусад чиг үүргийг нэмж хуульчилж өгсөн.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.legal.gov.mn

БТГЗЗтХ-ийн хэрэгжилтийг хангах төрийн захиргааны байгууллагын бүтэц, орон тоо

Дээрх хүснэгтээс харвал барааны тэмдэг, газар зүйн заалт эзэмшигч, хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхлэн гүйцэтгэхээр заасан байна. Харин 1996 он хүртэлх хугацаанд БТГЗЗтХ-ийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах чиг үүргийг Патент, барааны тэмдгийн газар болон Соёлын яамны Зохиогчийн эрхийн асуудал хариуцсан газар хэрэгжүүлж ирсэн байдаг. Ингээд 1996 онд Улсын Их Хурлын 40 дүгээр тогтоолоор Оюуны өмчийн газрыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн статустай байгуулснаар тус улс зохиогчийн эрхийг хамгаалах төрийн бодлогыг хэрэгжүүлэх бие даасан байгууллагатай болсон байна.

1996-2010 онуудад ОӨГ-ын Барааны тэмдэгт хамаарах үйл ажиллагааг эрхлэн хэрэгжүүлдэг хэлтэс нь Патентийн хэлтэс нэртэй болсон ба Патентийн хэлтсийн нийт орон тоо 11 байсан. (Зураг 2).

Зураг 2. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Оюуны өмчийн газрын Патентийн хэлтсийн бүтэц орон тоо (1996-2010 он)



2010 онд бүтцийн өөрчлөлт хийж Патентийн хэлтэс, Зохиогчийн эрхийн хэлтсийг нэгтгэж “Аж үйлдвэрийн өмч, зохиогчийн эрхийн хэлтэс” болгосон бөгөөд нийт 14 хүний орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулах болжээ. Зураг 3-ыг үзнэ үү.

Зураг 3. ОӨГ-ын Аж үйлдвэрийн өмч, зохиогчийн эрхийн хэлтсийн бүтэц орон тоо (2010-2015 он)



Монгол Улсын Шадар сайдын 2015 оны 10 тоот тушаалаар дахин бүтцийн өөрчлөлт хийгдэж, Аж үйлдвэрийн өмч, зохиогчийн эрхийн хэлтсийг “Аж үйлдвэрийн өмчийн хэлтэс”, “Зохиогчийн эрхийн хэлтэс” гэж хоёр салгаж, 2016 оны 7 дугаар

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

сарын 21-ний өдөр хүртэлх хугацаанд барааны тэмдэгт хамаарах үйл ажиллагааг Аж үйлдвэрийн өмчийн хэлтэст хамааруулж 14 хүний орон тоотой үйл ажиллагаа явуулах болсон. (Зураг 4).

Зураг 4. ОӨГ-ын Аж үйлдвэрийн өмчийн хэлтсийн бүтэц, орон тоо (2015.06-2016.07 сар)



Сүүлд 2016 оны 7 дугаар сард Монгол Улсын Их Хурлын 12 дугаар тогтоолоор Оюуны өмчийн газрын чиг үүрэг шилжсэнтэй холбогдуулан Агентлагийн статустай байсан Оюуны өмчийн газрыг УБЕГ-тай нэгтгэж “ОӨУБЕГ” болгосон. Бүтэц, зохион байгуулалтыг дахин өөрчилж Барааны тэмдэгт хамаарах үйл ажиллагааг “Аж үйлдвэрийн өмчийн эрхийн газар”-т хамааруулж тус газрын (хэлтсийн биш) орон тоог 9 болгон цомхотгосон байна. Бүртгэлийн мэргэжилтний орон тоог 2-оор, Олон улсын барааны тэмдгийн шинжээчийн орон тоог 1-ээр, Бүтээгдэхүүний загварын шинжээчийн орон тоог 1-ээр тус тус хорогдуулж, цахимжуулалтын мэргэжилтэнгүй болгосон. Зураг 5-аас харна уу.

Зураг 5. ОӨУБЕГ-ын Аж үйлдвэрийн өмчийн эрхийн газрын бүтэц, орон тоо (2017 оны байдлаар)



Ийнхүү 2010 онд шинэчлэн найруулсан БТГЗЗтХ хэрэгжиж эхэлснээс хойш долоохон жилийн дотор 3 удаа бүтцийн өөрчлөлт хийж, 2 удаа өөр чиг үүргийн төрийн захиргааны байгууллагатай нийлүүлж, салгаж, орон тоог 1/3 хувиар цөөрүүлсэн дүр зураг гарч байна.

Энэ байдал нь байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнийг тогтвортой бус болгож, мэргэшсэн боловсон хүчин дутагдах, улмаар ажлын ачааллын тэнцвэртэй байдлыг алдагдуулж ажлын чанарт нөлөөлж болзошгүй үр дагаварт хүргэж буй нь анхаарал татаж байна.

Сүүлийн 20 жилийн хугацаанд тус нэгжийн хүлээн авсан барааны тэмдгийн мэдүүлгийн тооноос харвал тухайн байгууллагад хандаж гаргасан мэдүүлгийн тоо жилээс жилд өсөх хандлагатай болж байна. Тухайлбал, Анх 1997 онд 1767 барааны

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ КҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

тэмдгийн мэдүүлэг хүлээн авч байсан бол, 2016 оны байдлаар энэ тоо 3312-т хүрч даруй 2 дахин өссөн үзүүлэлттэй байна. (Зураг 6). Энэ тоон үзүүлэлт цаашид эдийн засаг, нийгмийн харилцаа хөгжихийн хэрээр улам өсөх боломжтой юм.

Зураг 6. Барааны тэмдгийн мэдүүлгийн тоо (1997-2016 он)



Дээрх тоо бүртгэлээс харахад нэгжийн ажлын ачаалал хоёр дахин нэмэгдсэн байна.

Энэ нь БТГЗЗтХ-ийн 29 дүгээр зүйлд заасан чиг үүргийг улсын хэмжээнд бүхэлд нь хариуцаж хэрэгжүүлэхэд тус нэгж 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллах нь хүндрэлтэй байгааг харуулж байна.

ШИГТГЭЭ 1.

АҮӨЭГ нь 9 хүнтэй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд орон тоо хасагдсанаас мэдүүлэг хүлээн авч цахимжуулах, тэдгээрийн бүрдлийн шүүлт хийх, хэвлэх эрхийн хамгаалалт барааны тэмдэг, газар зүйн заалт, шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварт улсын бүртгэл хийх, патент, гэрчилгээ олгох, бүртгэлийн дараах өөрчлөлт хийх ажлыг **нэг** мэргэжилтэн хариуцан хийж байна. Өмнө нь 3 мэргэжилтэн байсан.

АҮӨЭГ-ын мэргэжилтнүүд.

Хуулийн 29.1.2-т заасан “барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал боловсруулах” чиг үүргийг 2010 оны шинэчилсэн найруулгаар уг хуулинд нэмж тусгасан байна. Үүгээр БТГЗЗтХ-ийг ДОӨБ-аас тавьж буй зорилготой уялдуулах, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцитэй нийцүүлэн хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах эрхийг нээж өгсөн нь хуулийн үндсэн зорилгодоо хүрэхэд эерэг зохицуулалт болсон гэж дүгнэж болохоор байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. Хуулийн 31 дүгээр зүйл буюу Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх зүйн зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ?

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.legal.gov.mn

31 дүгээр зүйл. Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч
31.1.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь дээд боловсролтой, оюуны өмчийн салбарт гурваас доошгүй жил ажилласан, 25 насанд хүрсэн, Монгол Улсад байнга оршин суудаг Монгол Улсын иргэн, эсхүл Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан, үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд байна.
31.2.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу тусгай зөвшөөрөл авна.
31.3.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах журмыг төрийн захиргааны байгууллага батална.

Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь оюуны өмчийн эрхийг хамгаалахад онцгой үүрэгтэй оролцдог байна. Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч оюуны өмчийн хуулийн хүрээнд иргэд, хуулийн этгээдийг итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлж, оюуны өмчийн эрхэд хамаарах бүтээлд эрхийн хамгаалалт хийлгэх үйл ажиллагааг зуучлан гүйцэтгэх, түүнчлэн төрийн захиргааны болон бусад байгууллагын өмнө өмгөөлөгчийн эрхтэй бол хуулийн байгууллагын өмнө өөрийн үйлчлүүлэгчээ төлөөлөх эрхтэй оролцдог байна.

Ингэж итгэмжлэгдсэн төлөөлөгч үйлчлэгчийн эрх ашгийг хамгаалах эрх, үүрэгтэй оролцдог учраас үйл ажиллагаа нь хариуцлагатай байх ёстой. Одоогийн мөрдөж байгаа БТГЗЗтХ-д итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйл ажиллагааг бүрэн зохицуулсан байдал, хариуцлагын тогтолцоо нь хангалттай бус байна.

ШИГТГЭЭ 2.

Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь сураг байдаггүй, алга болчихлоо гэх тохиолдлууд гардаг. Гэтэл тэдэнд хүлээлгэх хариуцлага байхгүй. Оюуны өмчийн бүтээлийг дагаж бизнесийн үйл ажиллагаа явагдаж байдаг учир итгэмжлэгдсэн төлөөлөгч ажилдаа хариуцлагагүй хандахад л бизнес эрхлэгчдийн эрх ашиг хохирч байдаг. Энэ байдал нь хуулийн зохицуулалт болон хариуцлагын асуудал сул байгаатай холбоотой.

Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид, эрдэмтэн судлаачид.

Барааны тэмдэг, газар зүйн заалтаар мэргэшсэн итгэмжлэгдсэн төлөөлөгчид ховор байдаг. Оюуны өмчийн чиглэлийн эрх зүйн орчноо бүрэн судлаагүй, амандаа орсон хэт өндөр үнийн дүн хэлж үйлчлүүлэгчдийг төөрөгдүүлдэг, мөнгөө авчихаад үйлчилгээ үзүүлдэггүй итгэмжлэгдсэн төлөөлөгчид олширсон, тэдэнд хариуцлага тооцдог механизм байдаггүй.

Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид.

БТГЗЗтХ болон журамд итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах эрх, үүргийн зохицуулалт, хариуцлага тооцох механизм нь дутуу байгаа учраас хэрэглэгч, эзэмшигчийн эрхийг хохироох байдал нь хуулийн зорилгод сөргөөр нөлөөлж байна гэж үзэж байна.

Уг хуулийн 31.1-т “Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь дээд боловсролтой, оюуны өмчийн салбарт гурваас доошгүй жил ажилласан, 25 насанд хүрсэн” байх гэсэн болзлыг тавьсан байна. Ингэж хуулинд хязгаар тавьсан нь зарим талаараа итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах боломжийг хязгаарлах үндэслэл болж буй талаар ярилцлагын судалгаанд оролцогчид онцолж байсан.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

ШИГТГЭЭ 3.

“оюуны өмчийн салбарт гурваас доошгүй жил ажилласан, 25 насанд хүрсэн” гэж хуулинд заасан байдаг. Үүнийг яагаад ингэж оруулсаныг мэдэхгүй юм. Үүний оронд эрх зүйн бүрэн чадамжтай, мэргэжлээрээ эсвэл оюуны өмчийн салбарт 2 жил ажилласан бакалавр зэрэгтэй байх гэж заавал илүү оновчтой байх болов уу.

Оюуны өмчийн итгэжлэгдсэн төлөөлөгчид.

ШИГТГЭЭ 4.

Одоо мөрдөж байгаа хуулинд итгэмжлэгдсэн төлөөлөгчид дээд боловсрол, 3 жил, 25 насанд хүрсэн гэж заасан мөртөө шинжээчид ингэж заагаагүй. Энэ хэсэг нь мэргэжлээрээ 2 жил ажилласан боловч 25 нас хүрээгүй болохоор энэ салбарт ажиллах боломжгүйд хүрдэг. Шинэ итгэмжлэгдсэн төлөөлөгчид энэ салбарт орж ирэх боломжийг нь илүү нээлттэй, таатай нөхцөлийг нь бүрдүүлж өгөх талаар хууль, журмаар зохицуулж өгвөл зүгээр санагддаг.

Оюуны өмчийн итгэжлэгдсэн төлөөлөгчид.

Иймд дээрх заалтын шалгуурыг эргэн харах хэрэгтэй.

Хуулийн 31.3-т Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах журмыг төрийн захиргааны байгууллага батална гэж заасан байна.

ОӨГ-ын даргын 2002 оны 1/120 дугаар тушаалаар Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах журмыг баталжээ. Уг журмаар оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулсан. Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлсэн тохиолдолд итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх, үүргийг зааж өгөхөөс гадна хариуцлага давхар явагдаж байх ёстой. Журамд оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх, үүргийг зааж өгсөн хэдий ч хариуцлагын асуудал орхигдсон байна.

Үүнээс гадна “Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах журам”-д “оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь үйлчилгээний орлогын мэдээг жил тутам гаргаж, ашгийн 10 хувийг оюуны өмчийн газарт шилжүүлсэн байна” гэж заасан нь үндэслэлгүй бөгөөд хуулиас давсан журам тогтоосон байна. Энэ зохицуулалт нь өөрөө ойлгомжгүй байдлыг үүсгэж байна. Яагаад оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид үйлчилгээний хөлсний 10 хувийг оюуны өмчийн газарт төлж байгаа юм бэ? гэсэн асуулт гарч байна. Учир нь тэд холбогдох татварын хуулийн дагуу татвараа төлдөг бөгөөд БТГЗЗтХ-д болон холбогдох бусад хуульд оюуны өмчийн газарт итгэмжлэгдсэн төлөөлөгч татвар төлөх тухай зохицуулалт байхгүй байна.

3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. БТГЗЗтХ-ийн 29 дүгээр зүйл. Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зохицуулалт практикт нийцэж байна уу, хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байна уу?

хуулийн судалгааны хүрээлэн
www.mnlaw.edu.mn

29 дүгээр зүйл.Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага

29.1.Монгол Улсад барааны тэмдэг, газар зүйн заалттай холбогдсон асуудлыг төрийн захиргааны байгууллага хариуцах бөгөөд төрийн захиргааны байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

29.1.1.барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

29.1.2.барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал боловсруулах;

29.1.3.барааны тэмдэг, газар зүйн заалтыг бүртгэх, улсын бүртгэл хөтлөх, тэдгээрт өөрчлөлт оруулах, барааны тэмдгийг нийтэд түгээмэл болсонд тооцохтой холбоотой журам, дүрмийг боловсруулж, батлах;

29.1.4.барааны тэмдэг, газар зүйн заалтыг бүртгүүлэх тухай өргөдлийн маягт болон барааны тэмдэг, газар зүйн заалтын гэрчилгээний загварыг тогтоох;

29.1.5.барааны тэмдэг, газар зүйн заалтын мэдүүлгийг хүлээн авч, хянах;

29.1.6.барааны тэмдэг, газар зүйн заалтыг бүртгэж, гэрчилгээ олгох;

29.1.7.барааны тэмдэг, газар зүйн заалтын улсын нэгдсэн бүртгэл хөтлөх;

29.1.8.барааны тэмдэг, газар зүйн заалтын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;

29.1.9.барааны тэмдэг, газар зүйн заалтын бүртгэлтэй холбогдсон мэдээллийг нийтэд мэдээлэх зорилгоор энэ хуулийн 3.1.14-т заасан албан ёсны тогтмол хэвлэлд нийтлэх;

29.1.10.хуульд заасан үндэслэл, журмын дагуу барааны тэмдэг, газар зүйн заалтыг хүчингүй болсонд тооцох;

29.1.11.барааны тэмдгийн олон улсын бүртгэлтэй холбоотой үйл ажиллагаа явуулах;

29.1.12.Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн биелэлтэд тавих улсын хяналтыг хэрэгжүүлэх, оюуны өмчийн улсын байцаагч ажиллуулах;

29.1.13.барааны тэмдэг, газар зүйн заалтын талаархи сургалт, судалгааны ажлыг нэгдсэн арга зүйгээр хангаж, зохион байгуулах;

29.1.14.барааны тэмдэг, газар зүйн заалтын үнэлгээг эзэмшигч, хэрэглэгчийн хүсэлтээр баталгаажуулах;

29.1.15.оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах этгээдийг шалгаруулах, тусгай зөвшөөрөл олгох;

29.1.16.хуулиар харьяалуулсан гомдол, маргааныг хянан шийдвэрлэх;

29.1.17.хуульд заасан бусад чиг үүрэг.

29.2.Энэ хуулийн 6.4.2, 9.4, 17.3, 25.4-т заасан үйлчилгээний хураамжийн хэмжээг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

Уг хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-т заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд тодорхой ахиц дэвшил гарсан хэдий ч зарим зохицуулалтыг хэрэгжүүлэхэд зохих хүндрэл гарч байна. Үүнд:

Одоогийн байдлаар АҮӨЭГ нь 9 хүний орон тоотой ажиллаж байгаа нь барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулахад хүндрэлтэй байна.

Судалгааны явцад 29 дүгээр зүйлийн 29.1-т заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд орон тооны хувьд хүндрэл гардаг эсэх талаар АҮӨЭГ-ын ажилтнуудаас тодруулахад 2015 оныг хүртэл тус газар нь ОӨГ нь 14 хүний орон тоотой үйл ажиллагаа явуулж байсан боловч 2017 онд бүтцийн өөрчлөлт хийж 9 хүний орон тоотой болгож цөөрүүлсэний улмаас хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах ажил төдийлөн хангалттай бус, түүнчлэн бараа үйлчилгээний тэмдэг, газар зүйн заалт эзэмшигч, хэрэглэгчийн эрхийг хамгаалахад учир дутагдалтай байдаг гэж үзэж байсан.

Түүнчлэн энэ талаар судалгаанд оролцогчдын байр суурийг дэлгэрэнгүй байдлаар авч үзвэл:

хуулийн төслийн судалгаа
www.nli.gov.mn

Оюуны өмчийн байгууллагыг Улсын бүртгэлийн газартай нийлүүлж бүтэц өөрчлөгдсөн нь дотоод зохион байгуулалтын асуудлаас гадна олон улсын төвшин д нэр хүнд нь буурах шалтгаан болсон байна. Учир нь ОӨГ нь олон улсын төвшин д аж үйлдвэрийн өмчийн хайлт, шүүлт хийдэг, олон улсын гэрээний заалтад хуулийн заалт нийцэж байгаа эсэхийг тодруулдаг онцлогтой байгууллага бол, УБЕГ нь зөвхөн дотооддоо бүртгэл хийдэг.

Иймд оюуны өмчийг хамгаалах чиглэлээр гадны ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг орнууд Монгол орныг олон улсын төвшин д хайлт, шүүлт хийхээ зогсоож, зөвхөн дотооддоо бүртгэдэг орон гэх хандлагатай болж байна.

Олон улсын төвшин д оюуны өмчийн эрхийг хамгаалахдаа энэ үзүүлэлтийг л чухалчилж үздэг байна. Өөрөөр хэлбэл, олон улсын төвшин д оюуны өмчийн эрхийг хамгаалахад зөвхөн бүртгэл хийснээр хамгаалалт болдоггүй байна.

Одоогоор дэлхийн улс орноос гадагшаа буюу олон улсад хандалт хийдэггүй дотооддоо бүртгэдэг 20 орон байдаг байна. Эдгээрт нэн буурай хөгжилтэй орнууд багтдаг ба манай орон энэ төвшин рүү ухарсан үзүүлэлттэй болж байна гэж дүгнэж болохоор байна.

Мөн байгууллагын статус, бүтэц, зохион байгуулалт нь зөв байж, тухайн байгууллагын үйл ажиллагаа зөв гольдролоор явагддаг гэдгийг судалгааны үр дүн давхар харуулж байна.

Хуулийн 29.1.2-т “барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал боловсруулах” чиг үүрэг нь практикт цаг үеэ олсон чухал заалт болсон байна. Тухайлбал, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа БТГЗЗтХ-ийг Сингапурын гэрээ, Мадридын хэлэлцээр, протоколыг баримталж хийсэн учир олон улсын стандартад нилээн дөхөж очсон хэмээн судалгаанд оролцогчид дүгнэж байна. Уг хуулийн төслийг АҮӨЭГ боловсруулсан байна. Гэхдээ хууль хэрэгжүүлэх явцад зарим зүйлийн зохицуулалтыг дутуу орхигдуулсан, зарим дотоодын хууль тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээрт нэмж нийцүүлэх шаардлага байгаа нь судалгааны явцад тогтоогдлоо. Тухайлбал, БТГЗЗтХ-иар эрх эзэмшигчид зарим талаар “шударга бус давуу эрх” эдлэх тохиолдол гардаг байна:

- Бүтээгдэхүүн үйлдвэрлэдэггүй хэрнээ бусдын бизнесийг хаах, бизнес эрхлэгчдийг дарамтлах зорилгоор эсхүл санаатайгаар бусдын барааны тэмдгийг өөрийн нэр дээр түрүүлж бүртгүүлээд шударга бус давуу эрх эдлэх тохиолдол гардаг. Энэ үзэгдэл нь чөлөөт, шударга өрсөлдөөнийг дэмжих барааны тэмдгийн эрх зүйн зохицуулалт нь Өрсөлдөөний тухай хуультай зөрчилдөх болсон байна.

Ер нь Оюуны өмчийн эрхийн зохицуулалт тэр дундаа барааны тэмдэг, газар зүйн заалтын эрхийн зохицуулалт нь Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Өрсөлдөөний тухай хуулиудтай уялдаатай хөгжих ёстой. Гэтэл дээрх хуулиудад барааны тэмдэг, газар зүйн заалтын харилцаанд оролцогчдын эрхийг хэрхэн хамгаалах талаар зохицуулалт байдаггүй. Тиймээс Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Өрсөлдөөний тухай хуулиудад барааны тэмдэг, газар зүйн заалтын харилцаанд оролцогчдын эрхийн хамгаалалтыг баталгаажуулж уялдуулж өгөх шаардлага практикт бий болсон.

ШИГТГЭЭ 5.

БТГЗЗтХ-д заасан эрхийн хамгаалалтын хэрэгжилт тааруу байгаагаас гадна зарим талаараа эрх эзэмшигчид “давуу эрх” олгох байдлаар зохицуулж өгсөн. Энэ байдлыг Өрсөлдөөний тухай хуультай уялдуулж өгөхгүй бол Өрсөлдөөний тухай хуультай зөрчилддөг.

Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид, эрдэмтэн судлаачид.

ШИГТГЭЭ 6.

БТГЗЗтХ-ийг Сингапурын гэрээ, Мадридын хэлэлцээр, протоколыг баримталж хийсэн гэж үздэг. Гэхдээ Локарнийн хэлэлцээр, Ниццийн хэлэлцээр, ТРИПС-ийн зохицуулалтыг уг хуультай уялдуулах хэрэгцээ, шаардлага гарч байгаа.

Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид, АҮӨЭГ-ын ажилтнууд.

Иймд БТГЗЗтХ-ийг Монгол Улсын нэгдэн орсон гэрээ, хэлэлцээрт нийцүүлэх, өөрийн орны онцлог, нийгэм, эдийн засгийн байдалд тохируулах шаардлага, хэрэгцээ байна гэж үнэллээ.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. Хуулийн 31 дүгээр зүйл буюу Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн зохицуулалт практикт нийцэж байна уу, хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байна уу?

31 дүгээр зүйл. Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч

31.1.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь дээд боловсролтой, оюуны өмчийн салбарт гурваас доошгүй жил ажилласан, 25 насанд хүрсэн, Монгол Улсад байнга оршин суудаг Монгол Улсын иргэн, эсхүл Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан, үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд байна.

31.2.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу тусгай зөвшөөрөл авна.

31.3.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах журмыг төрийн захиргааны байгууллага батална.

Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлж мэдүүлэг гаргагч, эрх эзэмшигчийн эрхийг хамгаалах процесс явагддаг. Гэвч тэдний эрх, үүрэг, хариуцлагын механизм тодорхой бус байгаа нь мэдүүлэг гаргагч, эрх эзэмшигчийн эрх зөрчигдөхөд хүрч байна.

ШИГТГЭЭ 7.

Зарим чадваргүй итгэмжлэгдсэн төлөөлөгчид чанаргүй үйлчилгээ үзүүлэх, хэт өндөр үнийн дүн санал болгох гэх мэт сөрөг үйл ажиллагаа явуулж байгаа нь итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн нэр хүндийг унагаж байна. Цаашид энэ байдлыг газар авахуулж болохгүй. Тиймээс тэдэнд хариуцлага тооцдог механизмыг хууль, журамдаа зохицуулж өгөх шаардлагтай байна.

Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид.

Иймд оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйл ажиллагааг уг хууль, журмаар бүрэн зохицуулаагүйн улмаас эрх, үүрэг, хариуцлага нь орхигдох хандлагатай болж байна.

“Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах журам”-д заасанчлан ...ашгийн 10 хувийг оюуны өмчийн газарт өгч байгаа нь энэ салбарт үйл ажиллагаа явуулж байгаа оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдөд “давхар татвар”-ын дарамт болдог байна.

ДӨРӨВ. БТГЗЗтХ-ийн зохицуулалт Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцитэй нийцэж байгаа эсэх тухай

Оюуны өмчийг хамгаалах олон улсын гэрээ нь олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх гол хэрэгсэл болж, оюуны өмчийн эрхийг хамгаалах салбарт чухал

үүрэг гүйцэтгэдэг байна. Оюуны өмч нь орчин үеийн эдийн засгийн тогтолцоонд бизнесийг хамгаалах зайлшгүй байх өгөгдөл болж байна. Үүнийг аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисийн конвенци, Дэлхийн худалдааны байгууллагын оюуны өмчийн худалдаанд хамаарах хэлэлцээр (ТРИПС) гэсэн 160, 170 гаруй тооны улсыг багтаасан олон улсын олон талт хэлэлцээрүүд харуулж байна[4].

Иймд БТГЗЗтХ-ийн зохицуулалт энэ чиглэлээр нэгдэн орсон олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх талаар тодруулахыг зорьсон болно.

ДОӨБ-аас 2016 оны 10 сард ОӨУБЕГ-ын барааны тэмдгийн эрхийн хамгаалалтын үйл ажиллагаанд үнэлгээ хийж БТГЗЗтХ-ийг олон улсын гэрээ, конвенцитой нийцүүлэх талаар дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан байна.

Энэхүү судалгаанд ДОӨБ-ын боловсруулсан дүгнэлт, зөвлөмжийг эх сурвалж болгон ашигласан болно. Ингэхдээ барааны тэмдэг, газар зүйн заалттай холбогдох хэсгийг түүвэрлэн авч БТГЗЗтХ-ийн заалт тус бүрээр харьцуулан авч үзсэн.

Практикт уг хуулийг хэрэгжүүлэх явцад зарим нэр томъёог[5], нэг мөр ойлгож хэрэгжүүлэх, хуулийн зүйл, заалтыг олон улсын гэрээ, конвенцитэй уялдуулан нийцүүлэх шаардлагатай байна.

4.1. Хуулийн нэр томъёоны тодорхойлолттой холбоотой санал, зөвлөмж

БТГЗЗтХ-ийн 3.1.1.“барааны тэмдэг” гэж иргэн, хуулийн этгээд өөрийн бараа, үйлчилгээг бусад этгээдийн бараа, үйлчилгээнээс ялгах зорилгоор хэрэглэх ялгагдах чадвартай илэрхийллийг ойлгоно гэж тодорхойлжээ. Уг хуулийн нэр томъёог **Худалдаанд хамаарах Оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр (ТРИПС)-ийн** 2 дугаар анги: Барааны тэмдэг, 15 дугаар зүйл, хамгаалагдвал зохих зүйлд дараах байдлаар дэлгэрүүлэн тодорхойлсон байна: 1. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг нэг этгээдийн бараа буюу үйлчилгээг бусад этгээдийнхээс ялгаж буй тэмдэг, тэмдгийн хослолыг барааны тэмдэгт тооцож болно. Хувь хүний нэр, үсэг, тоо, дүрс, өнгөний хослолыг багтаасан үг бүхий тэмдэг, тэмдгийн хослолыг барааны тэмдгээр бүртгэж болно. Хэрэв тэмдэг нь шинж чанарын хувьд холбогдох бараа буюу үйлчилгээг ялгах чадваргүй бол гишүүд тэмдгийн бүртгэлийг ашиглалтын явцад бий болсон ялгагдах чадвараас хамааруулж болно. Гишүүд тэмдгийн ялгагдах шинжийг бүртгэх нөхцөл болгон шаардаж болно.

4.2.Барааны тэмдгийн мэдүүлгийн бүрдлийг хянах, анхдагч огноог тогтоохтой холбоотой зохицуулалтын талаарх санал, зөвлөмж

БТГЗЗтХ-ийн 7 дугаар зүйлд барааны тэмдгийн мэдүүлгийн бүрдлийг хянах анхдагч огноог тогтоожээ. Хэдий тийм боловч эдгээр зохицуулалтыг Барааны тэмдгийн хуулийн тухай Сингапурын гэрээ 5 дугаар зүйл, Барааны тэмдгийн хуулийн тухай Сингапурын гэрээний журам[6], Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцитэй нийцүүлж хуулиндаа тусгаж өгөх шаардлагатай. Үүнд: 1. Хуулийн 7.1, 7.2, 7.3 дахь хэсгийг **Барааны тэмдгийн хуулийн тухай Сингапурын гэрээний 5 дугаар зүйлд** нийцүүлэх.

Сингапурын гэрээний 5 дугаар зүйлд дараах байдлаар зохицуулсан байдаг:

Анхдагч огноо. Зөвшөөрөгдөх шаардлагууд (b) дэд хэсэг болон (2) дугаар заалтад заасныг харгалзан Хэлэлцэн тохирогч тал нь мэдүүлгийн анхдагч огноог заалт болон бүрдэл хэсгийг Алба хүлээн авсан өдрөөр тогтооно. Дээрх заалт болон

[4] Уянга.Д, Монгол Улсын оюуны өмчийн хамгааллын тогтолцооны тойм, хууль зүйн бодлогын асуудлын тухай эргэцүүлэл, нийтлэл, 2016.

[5] Хавсралт 1, Гадаад орнуудын хуульд барааны тэмдэгтийг тодорхойлсон заалтыг харьцуулсан хүснэгтээс харна уу.

[6] http://www.wipo.int/edocs/lexdocs/treaties/en/singapore/trt_singapore_002en.pdf

бүрдэл хэсэгт дараах зүйлүүд орох бөгөөд эдгээрийг 8(2) дугаар зүйлд заасан хэлээр үйлдэнэ:

(i) Тэмдэг бүртгүүлэхийг хүссэн тухай илэрхий буюу илэрхий бус заалт

(ii) Мэдүүлэг гаргагчийг тодорхойлох боломж бүхий заалт

(iii) Алба нь мэдүүлэг гаргагч эсхүл хэрэв байгаа бол түүний төлөөлөгчтэй харилцах боломж бүхий заалт

(iv) Бүртгүүлэхийг хүсч буй тэмдгийн хангалттай тод дүрслэл

(v) Бүртгүүлэхийг хүсч буй бараа, үйлчилгээний жагсаалт

(vi) 3(1)(a)(xvi) дугаар зүйл эсхүл (b) хэсэг хамаарах бол Хэлэлцэн тохирогч талын хууль тогтоомжийн дагуу шаардлагатай 3(1)(a)(xvi) дугаар зүйлд заасан мэдэгдэл эсхүл 3 (1)(b) дугаар зүйлд заасан мэдэгдэл болон нотолгоо.

(a) Хэлэлцэн тохирогч аливаа тал анхдагч огноог (a) дэд хэсэгт заасан заалт болон бүрдэл хэсгийн бүгдийг бус заримыг нь эсхүл тэдгээрийг 8(2) дугаар зүйлд зааснаас өөр хэлээр үйлдсэнийг Алба хүлээн авсан огноогоор тогтоож болно.

(1) [Зөвшөөрөгдөх нэмэлт шаардлага]

(a) Хэлэлцэн тохирогч тал шаардлагатай хураамж төлөгдөх хүртэл анхдагч огноог тогтоохгүй байхаар зааж болно.

(b) Хэлэлцэн тохирогч тал (a)дэд хэсэгт заасан шаардлагыг зөвхөн тухайн Тал энэхүү Гэрээнд нэгдэж орох үед тавьж байсан тохиолдолд хэрэглэж болно.

(2) [Залруулга ба хугацаа] (1),(2) дугаар заалтад заасан залруулга хийх нөхцөл болон хугацааг Журмаар тогтооно.

[Бусад шаардлагуудыг хориглох] Хэлэлцэн аливаа тал мэдүүлгийн анхдагч огноогийн хувьд: (1),(2) дугаар хэсэгт зааснаас өөр зүйл шаардахгүй.

2. БТГЗЗтХ-ийн 7.4. Мэдүүлэг гаргагч нь зохих засварыг энэ хуулийн 7.3-т заасан хугацаанд хийж ирүүлсэн бол төрийн захиргааны байгууллага мэдүүлгийн анхдагч огноог түүнийг анх хүлээн авсан өдрөөр тогтоож, энэ тухай мэдүүлэг гаргагчид бичгээр мэдэгдэнэ гэх хэсгийг **Барааны тэмдгийн хуулийн тухай Сингапурын гэрээний журам[7]-д** нийцүүлэх шаардлагтай. Тус журмын 5(2) дүрэм. Анхдагч огнооны талаар дэлгэрэнгүй мэдээлэл, (2) [Анхдагч огноонд залруулга хийх Case[8]]. Хэрэв урилгад хугацааны хязгаар заасан бол мэдүүлэг гаргагч нь 1 дүгээр параграфт дурдсан урилгыг дагаж мөрдөх, бусад шаардлагатай тусгай хураамжийг төлөх, хуулийн 5(1)(а)-д дурдсаны дагуу анхдагч огноог заалт болон бүрдэл хэсгийг Алба хүлээн авсан өдрөөр тооцох, хуулийн 5(2)(а)-д заасан шаардлагатай хураамжийг Албад төлсөн мэдэгдэл.

Хэрэв боломжтой бол 5 дугаар зүйлийн (2) дахь хэсгийн (а) дэд хэсэгт заасан шаардагдах хөлсийг Албанд төлсөн байх. Өөрөөр хэлбэл, хэрвээ эдгээрийг бүрдүүлээгүй бол мэдүүлгийг мэдүүлээд тооцно гэсэнтэй нийцүүлэх;

БТГЗЗтХ-ийн 7.6. Энэ хуулийн 6.6-д заасан зүйлийг мэдүүлгийн анхдагч огнооноос хойш хоёр сарын дотор төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ. Мөн 7.7.Энэ хуулийн 6.6-д заасан зүйлийг энэ хуулийн 7.6-д заасан хугацаанд ирүүлээгүй бол төрийн захиргааны байгууллага мэдүүлэг гаргагчийг тухайн мэдүүлгээсээ татгалзсанд тооцож, энэ тухай мэдүүлэг гаргагчид бичгээр мэдэгдэнэ гэх хэсгийг **Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцийн** 4 дүгээр зүйл. D(3)-д нийцүүлэх. Холбооны гишүүн орнууд давамгайлах эрхийн тухай мэдэгдэл гаргасан этгээдээс түүний урьд нь гаргасан мэдэгдлийн хуулбарыг (тодорхойлолт, зураглал г.м) ирүүлэхийг шаардаж болно. Энэ мэдэгдлийг хүлээн авсан байгууллага хуулбар үнэн зөв гэж баталгаажуулсан хуулбарт хуулийн ямар нэгэн баталгаажилт шаардахгүй бөгөөд ямар ч тохиолдолд түүнийг дараачийн мэдэгдэл гаргасан

[7] http://www.wipo.int/edocs/lexdocs/treaties/en/singapore/trt_singapore_002en.pdf

өдрөөс хойш гурван сарын дотор ямар нэгэн хураамжгүйгээр ирүүлж болно. Харин мэдүүлэг анх гаргасан өдрийн тухай уг байгууллагаас авсан магадлагаа болон орчуулгыг хавсаргаж ирүүлэхийг шаардах эрхтэй байна. (4) Мэдэгдэл гаргах үед нь давамгайллын тухай мэдэгдэлд зориулсан өөр ямар нэгэн албан ёсны шаардлага тавьж болохгүй. Холбооны гишүүн орон бүр давамгайлах эрхийг алдахаас илүү, энэхүү зүйлд дурдсан албан ёсны шаардлагыг мөрдөхгүйгээс үүсгэх үр дагаврыг тодорхойлно гэж заасныг тус тус баримталж нийцүүлэх шаардлагатай.

4.3. Барааны тэмдэг, газар зүйн заалтын бүртгэлийг хүчингүй болгохтой холбоотой санал, зөвлөмж

2010 оны БТГЗЗтХ-нд барааны тэмдэг, газар зүйн заалтын бүртгэлийг хүчингүй болгохдоо барааны тэмдэг ашиглагдахгүй байгаатай холбогдуулан тус барааны тэмдгийн бүртгэлийг хүчингүй болгох хүсэлт гаргах эрхийг тусгаж өгөөгүй байна. Гэтэл 2003 оны Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн “барааны тэмдэг эзэмшигч, газар зүйн заалт хэрэглэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр барааны тэмдгийг 5 жилийн турш ашиглаагүй” тохиолдолд хүчингүй болгох заалтыг хуульчилсан байжээ. Энэ заалтыг сэргээж хуулинд тусгаж өгөх шаардлагатай байна. Эсхүл **Худалдаанд хамаарах Оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр (ТРИПС)-ийн** 19 дүгээр зүйлд нийцүүлэх шаардлагатай. Уг хэлэлцээрт зааснаар Ашиглалтын шаардлагад:

1. Хэрэв ашиглалт нь бүртгэлийг хүчинтэй хадгалахад шаардлагатай болж байвал тэмдэг нь наад зах нь тасралтгүй 3 жилийн хугацаанд ашиглагдаагүй бөгөөд барааны тэмдгийн эзэмшигч нь тийнхүү хэрэглэхэд саад болсон бодит шалтгааныг нотлоогүй бол бүртгэлийг хүчингүй болгож болно. Барааны тэмдгээр хамгаалагдсан бараа буюу үйлчилгээнд импортын хязгаарлалт эсхүл засгийн газраас бусад шаардлага тавьсан зэргээр барааны тэмдэг хэрэглэхэд саад учруулж буй барааны тэмдэг эзэмшигчийн хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлыг барааны тэмдэг ашиглаагүйн бодит шалтгаан болно.

2. Барааны тэмдгийн эзэмшигчийн хяналтан дор өөр этгээд барааны тэмдгийг ашигласныг барааны тэмдгийн бүртгэлийг хүчинтэй байлгах зорилгоор ашиглаж байна гэж үзнэ.

Мөн **Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцийн** 5 дугаар зүйлийн С-д Барааны тэмдэг: ашиглахгүй байх, хэлбэрийн ялгаа,хамтран эзэмшигчийн ашиглалтын талаар

(1) Хэрэв бүртгэгдсэн тэмдгийг аль нэг оронд заавал ашиглах ёстой нөхцөлд ашиглагдаагүйг нь үнэмшилтэй шалтгаанаар сонирхогч этгээдийн зүгээс нотлоогүй тохиолдолд, мөн боломжит хугацаа дууссан тохиолдолд л түүний бүртгэлийг хүчингүй болгож болно.

(2) Холбооны гишүүн аль нэг оронд бүртгэгдсэн тэмдгийн ялгагдах үндсэн шинжийг өөрчлөөгүй бөгөөд зөвхөн зарим нэг өөр бүрдэлтэй хэлбэрээр тэмдгийг эзэмшигч нь ашигласан нь тэмдэгт олгосон эрхийн хамгаалалтыг хязгаарлахгүй бөгөөд бүртгэлийг хүчингүй болгохгүй.

(3) Эрхийн хамгаалалт хүсч байгаа тухайн орны дотоодын хуулийн дагуу тэмдгийн хамтран эзэмшигчид болох үйлдвэрлэл, худалдааны байгууллагууд адил төрлийн буюу ижил үүслийн бүтээгдэхүүний тэмдгийг зэрэг ашиглах нь хэрэв тэмдгийн тийм ашиглалт нь олон нийтэд буруу ойлголт өгөхгүй, олон нийтийн сонирхолтой зөрчилдөхгүй байвал эрхийн хамгаалалт хүсэж байгаа холбооны гишүүн аль нэг орны тэмдгийн бүртгэлд саад болохгүй бөгөөд ямар нэгэн байдлаар

эрхийн хамгаалалтыг хязгаарлахгүй гэж заасныг баримталж дээрх олон улсын хэлэлцээр, ковенцитэй уг хуулийн зохицуулалтыг нийцүүлэх нь зүйтэй юм.

ТАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Үнэлэх үе шатны төгсгөлд томъёолсон шалгуур үзүүлэлтэд тулгуурлан дараах байдлаар дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулаа:

5.1. ДҮГНЭЛТ

БТГЗЗтХ-ийн зургадугаар бүлгийн 29, 31 дүгээр зүйлийн хэрэгжилтийн үр дагаварт “Зорилгод хүрсэн төвшин ”, “Практикт хэрэгжсэн байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийв.

Зорилгод хүрсэн төвшин :

Уг хуулийн зорилт нь “бараа, үйлчилгээний тэмдэг, газар зүйн заалт эзэмшигч, хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах”-д чиглэгдсэн. Энэ зорилгод хүрэхийн тулд нэн тэргүүнд ОӨГ хариуцан гүйцэтгэвэл зохих чиг үүргийг тодорхой хуульчилж өгсөн болно. Гэвч ОӨГ энэхүү чиг үүргийг гүйцэтгэхэд тодорхой хэмжээний хүндрэл, бэрхшээл гардаг байна.

Оюуны өмчийн байгууллагын эрхлэх ажил үүрэг нь нилээд онцлогтой тул уг ажилтнаас нарийн мэргэжил эзэмшсэн, мэргэшсэн, ур чадвар эзэмшсэн, тогтвортой байх зарчмыг шаардаж байдаг. Гэтэл 2017 онд УБЕГ-тай нийлүүлж ОӨГ-ын хэрэгжүүлэх чиг үүрэг нь хасагдаагүй байхад орон тоог бууруулсан байна. 2010 онд хууль хэрэгжиж эхэлснээс хойш ердөө 7 жилийн дотор 3 удаа бүтцийн өөрчлөлт хийж, 2 удаа өөр чиг үүргийн төрийн захиргааны байгууллагатай нийлүүлж, салгаж орон тоог цөөрүүлсэн байдлаас үүнийг харж болно. Ингэж байгууллагын бүтэц, тогтолцоо ойр ойрхон өөрчлөгдөх нь чиг үүргийн хуваарилалт, оновчтой байдалд сөргөөр нөлөөлж, улмаар эзэмшигч, хэрэглэгчийн эрхийг хамгаалж, түргэн шуурхай, чанартай үйлчилгээ үзүүлэх зорилго удаашрах нөхцөл үүсч байна.

Практикт хэрэгжсэн байдал:

Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тухайд үндсэн чиг үүргээ зохих төвшин д хэрэгжүүлж ирсэн бөгөөд эерэг үр дүн багагүй гарсан хэдий ч зарим нэг талаар хүндрэл гарч байна.

Практик дээр Монгол Улсад барааны тэмдэг, газар зүйн заалттай холбогдсон асуудлыг төрийн захиргааны байгууллага буюу ОӨГ хариуцахаар чиг үүргийг нь хуульчилж өгсөн байна. ОӨГ-т энэхүү чиг үүргийг гүйцэтгэх явцад бүтэц, орон тоог хэт цөөлснөөс болж мэргэшсэн хүний нөөц асуудал дагуулах болсон байна.

АҮӨЭГ-ын ажилтнуудыг мэргэшсэн байхыг шаардаж байгаа нь түүнийг тухайн ажилд гаршуулан дадлагажуулах, ийнхүү дадаж туршлагажсаны хэрээр түүнийг илүү хариуцлагатай ажилд шат ахиулан ажиллуулах явдал чухал байгаа нь судалгааны үр дүнгээс тодорхой харагдаж байна. Ийнхүү байгууллагын бүтэц, орон тоо, ажилтны ажлын ачааллын тэнцвэрт байдал алдагдвал байгууллагын хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг байна. Тухайлбал, ОӨГ нь 2016 он хүртэл бүтэц, орон тоо нь 14 байсныг 2017 онд 9 хүний орон тоотой болгож цөөлөхдөө байх ёстой хэд хэдэн орон тоог (шинжээч, бүртгэлийн мэргэжилтэн) хассаны нэг нь цахимжуулалтын мэргэжилтэн юм. Гэтэл ДОӨБ-ын зүгээс мэдээлэл технологийн мэргэжилтнийг солихгүй байх гэсэн үндсэн шаардлагыг тавьдаг байна. Учир нь барааны тэмдэг, газар зүйн заалтын бүртгэлтэй холбоотой үйл ажиллагаа нь мэдээлэл технологийн мэргэжилтэнтэй нягт холбоотой байдаг тул мэдээлэл

технологийн мэргэжилтнийг ДОӨБ-аас тусгайлан сургаж, мэргэшүүлж байжээ. Хэрэв мэдээлэл технологийн мэргэжилтэн байхгүй бол бүртгэл зогсох эрсдэлтэй болдог байна.

БТГЗЗтХ-ийг Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Өрсөлдөөний тухай хуулиудтай уялдуулах шаардлага практик хэрэгцээнээс гарч байна.

Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал боловсруулах тухайд:

Монгол Улс олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орсон бол гэрээгээр хүлээсэн үүргээ даган биелүүлэх учиртай. ДОӨБ-аас тавьж буй зорилготой уялдуулах, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенци болон дотоодын хууль тогтоомжтой нийцүүлэн боловсронгуй болгох эрхийг ОӨГ-ын чиг үүрэгт багтаан 2010 онд шинэлэн баталсан БТГЗЗтХ-иар зохицуулж өгсөн нь эерэг зохицуулалт болсон. Уг чиг үүргийнхээ дагуу АҮӨЭГ-нь БТГЗЗтХ-ийг олон улсын чиг хандлага болон өөрийн орны онцлог, нөхцөл байдалтай уялдуулан боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулж байгаа нь цаашдаа барааны тэмдэг, газар зүйн заалтын эрхийг эзэмшигч, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад томоохон түлхэц болсон зохицуулалт болсон гэж үзэж байна.

Одоогийн байдлаар энэхүү чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл төдийлөн гараагүй байна.

БТГЗЗтХ-ийн 31 дүгээр зүйл. Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч

Зорилгод хүрсэн төвшин :

Монгол Улсад болон олон улсын төвшин д оюуны өмчийг хамгаалахад итгэмжлэгдсэн төлөөлөгчийг татан оролцуулдаг учраас тэдний үйл ажиллагаа хариуцлагатай байх ёстой юм. Гэтэл одоогийн мөрдөж байгаа хууль, журамд хариуцлагын механизмыг бүрэн тусгаж өгөөгүй байна. Ийнхүү хариуцлагын тогтолцоо сул байгаагаас барааны тэмдэг, газар зүйн заалт эзэмшигч, хэрэглэгчийн эрх хохирох нь хуулийн зорилгод хүрэх байдалд сөргөөр нөлөөлж байна гэж үзэж байна.

Практикт хэрэгжсэн байдал:

Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлж мэдүүлэг гаргагч, эрх эзэмшигчийн эрхийг хамгаалах процесс явагддаг байна. Гэтэл тэдний эрх, үүрэг, хариуцлагын механизм тодорхой бус байгаа нь мэдүүлэг гаргагч, эрх эзэмшигчийн эрх зөрчигдөхөд хүрч байна. Мөн итгэмжлэгдсэн төлөөлөгчдөд тавих шалгуурыг эргэн харах шаардлагтай байна.

Захиалагчаас ирүүлсэн албан хүсэлтийн дагуу тус хуулийн зохицуулалт нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцид нийцэж буй эсэх талаар тусгайлан судалж үзсэн бөгөөд дараах дүгнэлтэнд хүрлээ:

- БТГЗЗтХ-ийг Сингапурын гэрээ, Парисын конвенци, Локарнийн хэлэлцээр, Ниццийн хэлэлцээр, ТРИПС-ийн зохицуулалттай уялдуулах хэрэгцээ, шаардлага гарах болсон байна.
- ДОӨБ-аас ОӨУБЕГ-ын барааны тэмдгийн газрын үйл ажиллагаанд хийсэн үнэлгээний үр дүнд БТГЗЗтХ-ийг олон улсын гэрээ, конвенцитой нийцүүлэх талаарх дүгнэлт, зөвлөмж гаргаснаас холбогдох хэсгийг түүвэрлэж тусгалаа.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Үүнд:

- Уг хуулийн 7.1, 7.2, 7.3 дахь хэсэг болон “Барааны тэмдгийг бүртгэх, улсын бүртгэл хөтлөх, тэдгээрт өөрчлөлт оруулах журам”-ын 3.2-ыг Сингапурын гэрээний 5 дугаар зүйлтэй нийцүүлэн өөрчлөх. Албан шалгалтын хэлтсийг тусад нь оруулж өгөх талаар хуульчилж өгөх;
- Хуулийн 7.4 дэх заалтыг Сингапурын гэрээний 5(2) дүрэмтэй нийцүүлж өөрчлөх;
- Хуулийн 7.6, 7.7 дахь заалтыг Парисын конвенцийн 4D(3) болон (4)-тэй нийцүүлж өөрчлөх;
- Хэрэглэгдэхгүй байгаа барааны тэмдгийн бүртгэлийг хүчингүй болгох, уг барааны тэмдгийг гуравдагч этгээд бүртгүүлж болох талаар Парисын Конвенцийн 5С болон ТРИПС-ийн гэрээний 19 дүгээр зүйлд тус тус заасныг БТГЗЗтХ-д тусгах;
- Хуулийн 5 дугаар зүйлд заасан “**Барааны тэмдэгт тавих шаардлага**”-ыг дутуу боловсруулсан, мөн олон талаараа тодорхой бус байна. Үүнийг дахин боловсруулж, давхардсан агуулгыг хасах;
- Хуулийн 3.1.1-д заасан “**Барааны тэмдэг**”-ийн тодорхойлолт нь ТРИПС-ийн гэрээний 15.1 дүгээр заалттай нийцэхгүй байгааг анхаарах.

5.2. Зөвлөмж

БТГЗЗтХ-ийн 29, 31 дүгээр зүйлийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний дүгнэлтэд үндэслэн дараах санал, зөвлөмж гаргаж байна:

- АҮӨЭГ-ын бүтэц, тогтолцоо ойр ойрхон өөрчлөгдөх нь чиг үүргийн хуваарилалтын оновчтой байдалд сөргөөр нөлөөлж байгаа тул тус байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахуйц зохицуулалтыг хуулийн төсөлд тусгах зайлшгүй шаардлагатай. Цаашид БТГЗЗтХ-тай холбогдох асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүтцэд өөрчлөлт оруулах болбол заавал чиг үүргийн шинжилгээнд үндэслэж, нарийн тооцоо, судалгаатай хийх талаар хуулинд тодорхой зохицуулалт тусгаж өгч болох юм.
- БТГЗЗтХ-д “Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь Итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн холбооны гишүүн байх” тухай зохицуулалтыг нэмж оруулах шаардлагатай байна.
- Ингэснээр “Итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн холбоо” нь өөрийн дотоод журмаараа гишүүддээ хариуцлага тооцох механизм бүрдүүлж ажиллах боломжтой.
- “Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах журам”-д “оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь үйлчилгээний орлогын мэдээг жил тутам гаргаж, ашгийн 10 хувийг оюуны өмчийн газарт шилжүүлсэн байх”-аар зохицуулсан. Гэтэл итгэмжлэгдсэн төлөөлөгч нь холбогдох татварын хуулийн дагуу албан татвараа төлж байдаг. Хэрвээ Оюуны өмчийн газарт ашгийн татварыг төлж байгаа тохиолдолд алдагдалтай ажиллавал алдагдалыг нь нөхөж өгөх үү? гэсэн асуулт гарч байна. Иймд уг журмын 8.3 дахь хэсэг итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн эрх ашигт нийцэхгүй байгаа тул хасах.
- Судалгааны хүрээнд томъёолоогүй боловч үнэлгээ хийх явцад судалгаанд оролцогчдын зүгээс БТГЗЗтХ-нд тусгахуйц асуудлуудыг цөөнгүй хөндөж байсан тул тэдгээр саналыг нэгтгэн боловсруулсан болно. Үүнд:
- БТГЗЗтХ-д барааны тэмдэг, газар зүйн заалтыг хүчингүй болгох хугацааг зааж өгөөгүй нь бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд саад болох, хохиролтой байдаг. Иймд Парисын понвенцийн 5С болон ТРИПС-ийн хэлэлцээрийн дагуу 19 дүгээр зүйлийг тус тус үндэслэн, 2003 онд үйлчилж байсан Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн “барааны тэмдэг эзэмшигч, газар зүйн заалт хэрэглэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр барааны тэмдгийг 5 жилийн турш ашиглаагүй” гэх заалтыг сэргээн хуульчилж өгөх нь чухал байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

- БТГЗЗтХ-ийн 29.2-т энэ хуулийн 6.4.2, 9.4, 17.3, 25.4-т заасан үйлчилгээний хураамжийн хэмжээг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоохоор заасан байдаг. Хэдийгээр Барааны тэмдгийг нийтэд түгээмэл болсонд тооцохтой холбоотой журам батлагдсан боловч энэ үйлчилгээг үзүүлэхэд үйлчилгээний хураамж авах асуудал хуульд тусгагдаагүйгээс өнөөг хүртэл энэхүү хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх боломжгүй байна. Нийтэд түгээмэл болсонд тооцсон барааны тэмдгийн хувьд хугацаагүй эрхийн хамгаалалт олгогдддог тул ямар нэг үйлчилгээний хураамжгүйгээр хамгаалалт олгох боломжгүй байдгийг харгалзаж үзэх.
- БТГЗЗтХ-ийг хүн бүр өөр өөрөөр ойлгож хэрэглэж байгаа тул хуулинд нэр томъёог зөв тодорхойлж өгөх, улмаар аль ч шатандаа нэг мөр ойлгож, мөрдөж, хэрэгжүүлэхэд анхаарах хэрэгтэй байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭЛ
www.nli.gov.mn

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Нэг.Хууль, эрх зүйн акт

1. Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль, 2010.
2. Аж үйлдвэрийг хамгаалах өмчийг хамгаалах тухай Парисийн конвенци, 1983.
3. Барааны тэмдгийн олон улсын буртгэлийн тухай Мадридын хэлэлцээр, 1985.
4. Барааны тэмдгийн олон улсын буртгэлийн тухай Мадридын хэлэлцээрийн протокол, 2001.
5. Барааны тэмдгийг бүртгэх зорилгоор бараа үйлчилгээний олон улсын ангилал тогтоох Ниццийн ангилал, 2001.
6. Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр, 1997.
7. Trademarks Act, the Statutes of the Republic of Singapore, 2005.
8. Geographical Indications Act, the Statutes of the Republic of Singapore, 1999.
9. Civil Code of the Russian Federation, Part IV, Section VII, Rights to the Results of Intellectual Activity and Means of Individualization, 2007.
10. The Lanham Act. 15 US.C. Chapter 22, 1947.
11. Provisions for the Protection of Products of Geographical Indication Promulgated by the General Administration of Quality Supervision, Inspection and Quarantine of the People's Republic of China on May 16 2005.
12. Trademark Law of the People's Republic of China, 2013.
13. "Оюуны өмчийн улсын хяналтын дүрэм", Засгийн газрын 220 дугаар тогтоол, 1999.
14. "Оюуны өмчийн тогтолцоог хөгжүүлэх үндэсний стратеги", Засгийн газрын 298 дугаар тогтоол, 2015.
15. "Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц", Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/16 дугаар тушаал, 2016.
16. "Барааны тэмдгийг бүртгэх, улсын бүртгэл хөтлөх тэдгээрт өөрчлөлт оруулах тухай журам", Оюуны өмчийн газрын даргын 112 дугаар тушаал, 2011.
17. "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай", Оюуны өмчийн газрын даргын 179 дүгээр тушаал, 2015.
18. "Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах журам", Оюуны өмчийн газрын даргын 1/120 дугаар тушаалын хавсралт, 2002.

Хоёр. Ном, сурах бичиг:

19. Мягмардорж.Э, Оюуны өмчийн эрх зүйн үндсэн асуудлууд, УБ., 2003.
20. Цолмон.Д, Оюуны өмчийн эрх зүй, УБ., 2016.

Гурав. Эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл

21. Уянга.Д, Монгол Улсын оюуны өмчийн хамгааллын тогтолцооны тойм, хууль зүйн бодлогын асуудлын тухай эргэцүүлэл, нийтлэл, УБ., 2016.
22. Тэмүүлэн.Б, Барааны тэмдгийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал, "Эрх зүй онол, практик, арга зүй, мэдээллийн цуврал", №6-7, УБ., 2001.
23. Эрдэнэчимэг.Д, Барааны тэмдэг, газар зүйн заалт, түүний учир холбогдол, "Монголын төр, эрх зүй", №3, УБ., 2003.

Дөрөв. Цахим эх сурвалж

24. http://www.mfa.gov.mn/wp-content/uploads/2016/06/Int-Treaty-List-24-Dec-2015-2.pdf
25. www.legalinfo.mn
26. www.wipo.int
27. www.ipom.mn
28. burtgel.mn

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.jli.gov.mn

Хавсралт 1

ГАДААД ОРНУУДЫН ХУУЛЬД БАРААНЫ ТЭМДЭГТИЙГ ТОДОРХОЙЛСОН ЗААЛТЫГ ХАРЬЦУУЛСАН ХҮСНЭГТ

Монгол улс[9]	Сингапур[10]	ОХУ[11]	АНУ[12]	БНХАУ[13]
Барааны тэмдгийн тухай анхны бие даасан хууль 1996 онд “Барааны тэмдэг аж ахуйн нэгжийн нэрийн тухай хууль” нэртэйгээр батлагдсан бөгөөд 2003, 2010 онд “Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль” нэртэйгээр шинэчлэгдсэн. 3.1.1.**“барааны тэмдэг”** гэж иргэн, хуулийн этгээд өөрийн бараа, үйлчилгээг бусад этгээдийн бараа, үйлчилгээнээс ялгах зорилгоор хэрэглэх ялгагдах чадвартай илэрхийллийг;	“Барааны тэмдгийн тухай хууль” 1998 оны 46 дугаар Акт. Уг хуулийг 1999 он болон 2005 онд шинэчлэн найруулсан. **“Барааны тэмдэг”** гэдэг нь бараа, үйлчилгээгээр үйлчилж буй этгээдийн худалдаа арилжааны явцад эсвэл бусад этгээдийн үзүүлж буй бараа эсвэл үйлчилгээг ялгах чадвартай график дүрслэлээр илэрхийлэгдэх боломжтой аливаа тэмдгийг хэлдэг.	Оросын Холбооны Улсын Барааны тэмдгийн тухай хууль нь 1992 онд батлагдаж 2002 онд шинэчлэгдсэн байна. Хуулийн 1 дүгээр зүйл. Барааны тэмдэг болон үйлчилгээний тэмдэг. **Барааны тэмдэг, үйлчилгээний тэмдэг** (цаашид “барааны тэмдэг” гэх) нь хувь хүн, хуулийн этгээдийн ажил болон үйлчилгээ, барааг бусдаас ялгах чадвартай тэмдгийг хэлнэ. Мөн ОХУ-ын “Иргэний хууль”-ийн 4 дүгээр бүлгээр Барааны тэмдгийг бас зохицуулдаг. **77 дүгээр зүйл. Барааны тэмдгийн ба Үйлчилгээний Тэмдэг**[14] 1. Барааны тэмдгийн гэрчилгээ (1481-р зүйл)-ээр баталгаажуулсан онцгой эрхийг барааны тэмдгээр хүлээн зөвшөөрөх, өөрөөр хэлбэл, аж ахуйн нэгж эсвэл хувиараа аж ахуй эрхэлдэг этгээдийн бараа бүтээгдэхүүнийг онцлог болгох чадвартай тэмдгээр хүлээн зөвшөөрнө. 2. Барааны тэмдэгтэй холбоотой энэхүү дүрмийн заалтуудыг үйлчилгээний тэмдэг, өөрөөр хэлбэл, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгч хувь хүмүүсийн гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээг онцлог болгож чадах шинж тэмдгүүдэд хэрэглэнэ.	Ланхамын Акт, 15 U.S.C §§ 1051 -ийг Худалдааны заалтаар олгосон эрх мэдэлд үндэслэн 1946 онд Конгрессоор баталсан. “**Барааны тэмдэг”** гэсэн нэр томъёонд /1/ аливаа этгээдийн ашиглаж буй эсвэл /2/ худалдаанд аливаа этгээд зөв шударгаар хэрэглэх зорилготой эзэмшиж буй болон тус бүлэгт тодорхойлсон үндсэн бүртгэлд бүртгүүлэхэд ашигладаг, өөрийн барааг бусад үйлдвэрлэгчийн эсвэл бусад этгээдийн худалдаж буй бараанаас ялгахын тулд, бас хэдийгээр эх сурвалж нь мэдэгдэхгүй байсан ч тухайн худалдааны эх сурвалжийг заахын тулд ашиглаж буй үг, нэр, билэг тэмдэг буюу төхөөрөмж зэрэг багтана.	БНХАУ-ын Барааны тэмдгийн хуулийг Тавдугаар Ардын Их Хурлын Байнгын комиссын 24-р хурлаар 1982 онд баталсан. **3 дугаар зүйл. Бүртгэгдсэн барааны тэмдэг нь** бараа, үйлчилгээний барааны тэмдэг, хамтын барааны тэмдэг, баталгаажуулалтын тэмдэг зэргийг оруулаад барааны тэмдгийн албаны баталгаатайгаар бүртгэгдсэн барааны тэмдгийг илэрхийлж байгаа болно. Бүртгэгдсэн барааны тэмдгийг эзэмшигч нь хуулиар хамгаалагдсан барааны тэмдгийг ашиглах онцгой эрхтэй байдаг. Энэхүү хуулийн зорилгоор, хамтын барааны тэмдэг нь гишүүнчлэлийг илэрхийлэхийн тулд гишүүддээ бизнест нь ашиглуулах зорилгоор групп, нийгэмлэг, болон аливаа бусад байгууллагуудын нэр дээр бүртгэсэн барааны тэмдгүүдийг хэлнэ. Энэ хуулийн зорилгын дагуу **баталгаажуулалтын барааны тэмдэг гэдэг** нь тодорхой төрлийн бараа, үйлчилгээнд хяналт тавих чадвартай байгууллагаар хянагдсан бөгөөд байгууллагаас өөр нэгж эсвэл хувь хүмүүс өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээнд хэрэглэгддэг, дурдсан бараа, үйлчилгээний гарал үүслийн газар, түүхий эд материал, үйлдвэрлэлийн хэлбэр, чанар, эсвэл бусад тодорхой шинж чанарыг баталгаажуулахад зориулагдсан болно. Хамтын барааны тэмдэг, баталгаажуулалтын барааны тэмдгийг бүртгэх, захиран зарцуулахтай холбогдсон тодорхой мэдээллүүдийг Төрийн Зөвлөлийн дэргэдэх үйлдвэр, худалдааны захиргааны хэлтэс боловсруулна.

[9] Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль.2010. http://www.legalinfo.mn/law/details/111?lawid=111

[10] Singapore: Trade Marks Act. 2005. http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=187981

[11] Russian Trademark Law. 2002. http://www.wipo.int/edocs/lexdocs/laws/en/ru/ru056en.pdf

[12] The Lanham Act. 15 US.C.Chapter 22. http://www.bitlaw.com/source/15usc/index.html

[13] Trademark Law of the People’s Republic of China. 2013. http://www.wipo.int/edocs/lexdocs/laws/en/cn/cn195en.pdf

[14] Civil Code of the Russian Federation. Part Four.2006

ХУУЛЬ ЗҮЙН УНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Хавсралт 2

ГАДААД ОРНУУДЫН ГАЗАР ЗҮЙН ЗААЛТЫГ ТОДОРХОЙЛСОН ЗААЛТЫН ХАРЬЦУУЛСАН ХҮСНЭГТ

Монгол улс[15]	Сингапур[16]	ОХУ[17]	АНУ[18]	БНХАУ[19]
3.1.4.**“газар зүйн заалт”** гэж тухайн газар нутгийн байгаль, цаг уурын нөхцөл, эсхүл тухайн газар нутгийн хүмүүсийн дадал заншил зэрэг хүчин зүйлээр тодорхойлогдсон чанар, нэр хүнд, бусад онцлог шинж чанар бүхий бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн улс, бүс, газар нутгийн газар зүйн тодорхойлолтыг;	**“Газар зүйн заалт” гэдэг нь** тухайн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн газрыг заахад ашигладаг заалтыг хэлдэг. Үүнд: /А/ шаардлага хангасан улс эсвэл тухайн шаардлага хангасан улс дахь бүс нутаг буюу орон нутаг болон /Б/ Барааны чанар, нэр хүнд болон бусад онцлог шинж чанар нь хамааралтай газар орно.	1516. дугаар зүйл. **Гарал үүслийн тодорхойлолт/нэр** Хууль эрх зүйн хамгаалалт олгосон гарал үүслийн нэр нь улс орон, хот эсвэл хөдөөгийн суурин, орон нутгийн эсвэл бусад газарзүйн обьектууд, мөн тийм нэрний үүсмэл нэрний орчин үеийн эсвэл түүхийн, албан ёсны эсвэл албан бус, бүрэн эсвэл товчилсон хэлбэрийг илэрхийлсэн эсвэл агуулсан шинж тэмдэг ба асуудалд/анхаарлын төвд байгаа газар зүйн биетэд онцгой байдаг байгалийн нөхцөл байдал буюу хүний хүчин зүйлээр онцгойлон эсвэл гол төлөв тодорхойлогддог 1. Бараа бүтээгдэхүүний онцгой шинж чанарыг тогтоохоод ашигласны үр дүнд мэдэгддэг болсон шинж тэмдэг байна. Ийм худалдааны үйлдвэрлэгчнь энэхүү нэр оноох явдлыг ашиглахын тулд онцгой эрх эдэлнэ (1229 ба 1519-р зүйл). 2. Газар зүйн объектын нэрийг илэрхийлсэн эсвэл агуулж буй боловч үйлдвэрлэлийнх нь газартай холбогдоогүй тодорхой төрлийн бүтээгдэхүүнийг тодорхойлох байдлаар ОХУ-д нийтийн эзэмшлийн газарт хамаарах нэр томъёо буюу тэмдэглэгээг/оноолтыг гарал үүслийн нэрийг тодорхойлсон нэрлэсэн гэж үзэхгүй.	Газар зүйн заалтыг тодорхойлсон заалт Ланхамын Акт тусгагдаагүй байна.	**2 дугаар зүйл.** Энэхүү Заалтуудад дурдсан газарзүйн заалтын бүтээгдэхүүнь байгалийн ба хүний хүчин зүйлд бодитойгоор хамаарах чанартай, нэр хүндтэй буюу бусад шинж чанар бүхий тодорхой бүс нутгаас гаралтай бүтээгдэхүүнийг илэрхийлэх бөгөөд шалгаж, батлах үед бүс нутгийн нэрээр нэрлэгдсэн болно. Газар зүйн заалтын бүтээгдэхүүнүүд нь: (1) тухайн бүс нутагт үргуулж, тариалсан; (2) тухайн бүсийн түүхий эдээр бүхэлд нь буюу хэсэгчлэн бүтээсэн бөгөөд тухайн бүсийн тодорхой техникээр боловсруулж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнүүдийг хамруулна;

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭНГ www.legal.mn

[15] Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль. 2010.

[16] Geographical Indications Act. Chapter 117B. the Statutes of the Republic of Singapore. 1999.

[17] The Civil Code of the Russian Federation. Part 4. The Right to the Appellation of Origin of Goods.

[18] The Lanham Act. 15 US.C.Chapter 22. http://www.bitlaw.com/source/15usc/index.html

[19] Provisions for the Protection of Products of Geographical Indication Promulgated by the General Administration of Quality Supervision, Inspection and Quarantine of the People’s Republic of China.2005 http://www.wipo.int/edocs/lexdocs/laws/en/cn/cn041en.pdf

ЗОХИОГЧИЙН ЭРХ БОЛОН ТҮҮНД ХАМААРАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН[1]

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн (цаашид ЗЭБТХЭтХ гэх) хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу “жишиг үнэлгээ” хийв.

Энэхүү жишиг үнэлгээг нэгэнт батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажилд жишиг болгон ашиглах боломжтой.

Үнэлгээ хийх ажил *төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх* гэсэн гурван үе шатаас бүрддэг. Зарим тохиолдолд уг асуудлын онцлогоос хамааран энэ дарааллыг баримтлахгүй байж болно.

Төлөвлөх үе шат нь үнэлгээ хийх ажлын суурь бөгөөд үүнд хамаарах алхамуудыг амжилттай гүйцэтгэж чадвал “хэрэгжүүлэх” болон “үнэлэх” үе шатанд хийх ажил илүү тодорхой болно.

Төлөвлөх шатны зорилго нь үнэлгээ хийх хүрээг тогтоож түүнд тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход чиглэгдэнэ. Энэ үе шатанд дараах алхамуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
- Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
- Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
- Харьцуулах хэлбэрийг сонгох;
- Шалгуур үзүүлэлтийг томьёолох;
- Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

Гэхдээ үнэлгээ хийх асуудлын онцлогоос шалтгаалан эдгээр алхамуудыг бүгдийг гүйцэтгэх буюу дээр дурдсан дарааллыг ягштал баримтлах шаардлагагүй байж болно.

1.1. Үнэлгээ хийх шалтгаан

Уг хууль нь тухайн төрлийн харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх болон уг хууль тогтоомжийн нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэхийн тулд үнэлгээний ажил эхлэхээс өмнө үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох шаардлагатай. Ингэхдээ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 3.2.-т заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд үнэлгээ хийж болно. Өөрөөр хэлбэл, энд заасан нөхцөл байдлаас өөр үндэслэл, шалтгаанаар хууль болгоны хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шаардлагагүй гэсэн үг юм.

Жишиг үнэлгээ хийхээр сонгосон “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулийн хувьд: Уг хууль 2006 онд батлагдсан бөгөөд өнгөрсөн хугацаанд энэхүү хуулиар зохицуулах харилцаа багагүй өөрчлөгдөж, энэ төрлийн *харилцааны өөрчлөлт, хөгжлөөс хоцрох хандлага ажиглагдаж, түүнээс улбаалсан сөрөг үр дагавар гарах болсон тул* хэрэгжилтийн үр дагаварт нь үнэлгээ хийх шаардлагатай гэж үзсэн болно.

[1] Тус судалгааг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Зүмбэрэллхам удирдан, эрдэм шинжилгээний ажилтан М.Төрбаяр, У.Эрдэнэзаяа, хуульч, судлаач Ч.Бат-Уянга нар хамтран гүйцэтгэв.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.jri.gov.mn

Уг хууль зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхээр хамгаалагдах бүтээлийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилготой ба үнэлгээ хийх ажлын явцад уг хуулийн үйлчлэлд хамаарах этгээдүүдтэй хийсэн анкетын болон ярилцлагын судалгаанд (цаашид "судалгаа" гэх) оролцогчдын 47 хүн буюу 95.9 хувь нь энэхүү хуулийг "шинэчлэх шаардлагатай" гэж үзсэн байна.

Зураг 1. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийг шинэчлэх хэрэгцээ, шаардлага (судалгаанд оролцогчдын дүнд эзлэх хувиар)



1.1.Үнэлгээ хийх хүрээ

Үнэлгээ хийх хүрээг тогтоох ажиллагаа нь агуулгын хувьд чухал ач холбогдолтой бөгөөд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэгдэнэ. Түүнчлэн энэхүү алхам нь үнэлгээ хийх шалтгаантай шууд уялдаатай байх шаардлагатай.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт бүхэлд нь үнэлгээ хийх ажлын зардал нилээд өндөр байдаг ба бүхэлд нь үнэлгээ хийлээ гэхэд хүрэх үр дүн нь төдийлөн ач холбогдолтой биш байх тохиолдол гардаг. Иймээс хуулийн зорилгыг хэрэгжүүлэхэд хамгийн их нөлөөлөл үзүүлэх зарим зохицуулалт (бүлэг, зүйл, заалт)-ыг тусгаарлан сонгож үнэлгээ хийх нь илүү үр дүнтэй.

Үнэлгээ хийх хүрээг тогтоох зорилгоор судалгааны баг ЗЭБТХЭтХ-ийн үйлчлэлд хамаардаг зарим субьектээс анкетын судалгаа авсан ба оролцогчид 100 хувь уг хууль *"зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг бүрэн хамгаалж чаддаггүй"* гэж, 97 хувь нь *"Зохиогчийн эрхийг хамгаалах байгууллага зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг хамгаалах талаар хангалттай ажилладаггүй" гэж,* 99 хувь нь *"Зохиогчийн эрхийг хамгаалах, зохиогчийн эрх зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагатай холбогдох зохицуулалт зорилгодоо бүрэн хүрч үйлчилдэггүй"* гэж тус тус хариулсан байна.

Үүнийг харгалзан судалгааны баг уг хуулийн 7, 8 дугаар бүлгийн зохицуулалт *"нийгмийн харилцааны өөрчлөлт, хөгжлөөс хоцрох хандлагатай болж, түүнээс улбаалан сөрөг үр дагавар гарах болсон" байж болзошгүй* гэж таамаглан үнэлгээ хийх хүрээг тодорхойлсон болно. Эдгээр бүлгийн бүтцийг харуулбал:

- 7 дугаар бүлэг. Зохиогчийн эрхийг хамгаалах байгууллага

√ 26 дугаар зүйл. Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны

байгууллага

- √ 27 дугаар зүйл. Хамтын удирдлагын байгууллага
- √ 28 дугаар зүйл. Хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаа
- √ 29 дүгээр зүйл. Хамтын удирдлагын байгууллагын үүрэг

8 дугаар бүлэг. Зохиогчийн эрхийг хамгаалах, зохиогчийн эрх зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

- √ 31 дүгээр зүйл. Зохиогчийн эрх ба түүнд хамаарах эрхийн тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага.

Ийнхүү урьдчилан тогтоосон үнэлгээний хүрээг өргөжүүлэх, эсхүл багасгах нөхцөл байдал үнэлгээ хийх явцад үүсч болдог. Үнэлгээ хийх хүрээг урьдчилан тогтоосноор зарим зохицуулалт орхигдох эсхүл буруу тодорхойлогдох нөхцөл байдал үүсч болзошгүй бөгөөд ийм байдал ажиглагдвал дахин шалгаж, залруулах боломжтой. Өөрөөр хэлбэл, уг асуудалд аль болох уян хатан хандах нь зүйтэй.

1.2. Үнэлгээний шалгуур үзүүлэлт

Үнэлгээний ажлыг төлөвлөх шатны гол тулгуур хэсэг нь тухайн үнэлгээг хийх шалгуур үзүүлэлтийг тогтоох алхам юм. Ингэхдээ дараах зургаан үндсэн шалгуур үзүүлэлтээс үнэлгээний хүрээтэй аль тохирохыг нь сонгож тогтооно. Үүнд:

- зорилгод хүрсэн түвшин;
- зардлын өсөлт, бууралт;
- зардал-үр өгөөжийн харьцаа;
- хүлээн зөвшөөрөгдсөн байдал;
- практикт нийцэж байгаа байдал;
- бусад үр дагавар.

Шалгуур үзүүлэлтийг сонгохын тулд шалгуур үзүүлэлт тус бүрийн ойлголт, онцлог, хоорондын ялгааг харгалзан үзэх нь чухал ба сонгосон шалгуур үзүүлэлт нь үнэлгээ хийх болсон шалтгаантай уялдсан байхаас гадна хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байх шаардлагатай.

Хүснэгт 1. Шалгуур үзүүлэлт тус бүрийн ялгаа, онцлог

Д/д	Шалгуур үзүүлэлт	Ойлголт, онцлог	Жишээ тайлбар
1	Зорилгод хүрсэн түвшин	Тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтооно.	ЗЭБТХЭтХ нь 2006.01.19-өөс эхлэн үйлчилсэн. Хууль тогтоогч хуулийн үндсэн зорилгыг "зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхээр хамгаалагдах бүтээлийг зөвшөөрөлгүй, ашиглах, захиран зарцуулах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэж тодорхойлсон. Энэ тохиолдолд ЗЭБТХЭтХ бүхэлдээ болон сонгосон зохицуулалт энэ зорилгодоо хүрч чадсан эсэхийг үнэлэх ёстой. Хуульд үндсэн зорилгоос гадна бүлэг, хэсэг, зүйл бүрт тодорхойлсон дагалдах зорилго байж болох бөгөөд үүнийг давхар шалгаж болно.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

2	Зардлын өсөлт, бууралт	Хууль хэрэгжсэнээр үүсч байгаа зардлын өсөлт, бууралтыг тодорхойлно.	ЗЭБТХЭтХ хэрэгжсэнээр иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага болон үлсын төсөвт үүссэн зардлын өсөлт, бууралтыг тодорхойлно. Үүнд, санхүүгийн, боловсон хүчний, техникийн г.м олон зардал хамаарна. Гэхдээ энэ хэсгийг үналэхдээ эвхэн тухайн үналгээнд хамааралтай, анхаарал татсан зардлыг авч үзэгг.
3	Зардал-үр өгөөжийн харьцаа	Хуулийг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгө, гарсан үр өгөөжийн харьцааг тооцон гаргана.	ЗЭБТХЭтХ хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгө, хүрсэн үр өгөөжийн харьцааг тооцон гаргана. Хуулийг хэрэгжүүлэхэд гарсан зардал нь, бий болсон үр өгөөжөөсөө хавьгүй өндөр бөгөөд ийм зардал гаргаснаар хуулийн зорилтодоо хүрээгүй, нийгэмд эерэг үр нөлөө үзүүлээгүй тохиолдолд хуулийг цаашид хэрэгжүүлэх эсэх дээр эргэлээ үүсэнэ.
4	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	Иргэд, хуулийн этгээдээс хуулийг хүлээн авч буй байдал, хэрэгжүүлж байгаа эсэхийг тодорхойлно.	ЗЭБТХЭтХ-ийн үр нөлөөг шууд хүртэж буй буюу хуулийн үйлчлэлд хамаарч буй этгээдүүдэд (зохиогч, эрх эзэмшигч, уран бүтээлч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч гэх зэрэг) тус хууль хүлээн зөвшөөрөгдсөн эсэхийгтодорхойлно.
5	Практикт нийцэж байгаа байдал	Хуулийг хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэгболон сөрөг үрдагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийгтодорхойлно.	ЗЭБТХЭтХ-ийн сийлгомжтой байдал, хэрэгжүүлэх боломж бололцоо практикт байгаа эсэх зэргийг тодорхойлно.
6	Бусад үр дагавар	Урьдчилан тооцоогүй болон шинээр гарч болзошгүй ямар үр дагавар байж болохыг тооцоолно.	ЗЭБТХЭтХ-ийн хэрэгжилтэд тооцох аргагүй, сөрөг үр дагавар үүссэн эсэхийг тодорхойлно.

Үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран эдгээр шалгуур үзүүлэлтээс нэг буюу хэд хэдийг сонгож болох ба манай тохиолдолд дараах хоёр шалгуур үзүүлэлтийг сонгосон. Үүнд:

1. Зорилгод хүрсэн түвшин;

2. Практикт нийцэж байгаа байдал.

Зорилгод хүрсэн төвшин шалгуур үзүүлэлтээр ЗЭБТХЭтХ-ийн 7, 8 дугаар бүлгийн зохицуулалтын зорилго болон зорилтдоо хүрсэн түвшинг үнэлнэ.

Ер нь хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг судалдаг хамгийн чухал шалгуур үзүүлэлт нь “зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлт юм. Манай тохиолдолд ЗЭБТХЭтХ-ийн 1 дүгээр зүйлээр тодорхойлсон “зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхээр хамгаалагдах бүтээлийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэх зорилтыг хэрэгжүүлэхэд энэ хуулийн 7, 8 дугаар бүлгийн зохицуулалт хангалттай үйлчилж чадаж байна уу, үгүй юу гэдгийг тодорхойлоход чиглэгдэнэ.

Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтээр уг хуулийн 7, 8 дугаар бүлгийн хэрэгжилт, хэрэгжих явцад үүсч буй эерэг, сөрөг үр дагавар, хүндрэл бэрхшээл, ер нь хэрэгжүүлэх боломж, бололцоо практикт байгаа эсэхийг тодорхойлоход чиглэгдэнэ.

Хуулийн зүйлчлэлийн ажлын хэсэг www.mn.gov.mn

Энэхүү шалгуур үзүүлэлтийг: тухайн хуулийг хэрэгжүүлэх эрх, үүрэг бүхий байгууллага, албан тушаалтантай холбогдох зохицуулалт практикт хэрэгжиж байгаа эсэхийг болон хэрэгжих боломжтой эсэхийг тогтооход түлхүү ашигладаг.

Иймээс манай тохиолдолд зохиогчийн эрхийг хамгаалах эрх үүрэг бүхий байгууллага (төрийн болон төрийн бус байгууллага)-д энэхүү хуулийг хэрэгжүүлэхэд ямар хүндрэл бэрхшээл учирч байна, чиг үүргээ хэрэгжүүлэхэд эрх хэмжээ нь хүрэлцэж байна уу, үүнтэй холбогдох эрх зүйн зохицуулалт хэр ойлгомжтой, ер нь уг хууль хэрэгжих бодит боломж, бололцоо практикт байгаа эсэхийг тодруулах зорилготой.

Манай тохиолдолд хүлээн зөвшөөрөгдсөн байдал, зардлын өсөлт бууралт, зардал-үр өгөөжийн харьцаа зэрэг бусад шалгуур үзүүлэлтийг сонгоогүй ба эдгээр шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл боловсруулахаас өмнө болон төслийн хувилбаруудын үр нөлөөг урьдчилан тандан судлах үеэр зардлыг тооцсон тохиолдолд сонгох нь илүү оновчтой.

1.3. Үнэлгээний харьцуулах хэлбэр

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрүүдээс сонгоно. Үүнд:

- Байх ёстой болон одоо байгаа;
- Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших;
- Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших;
- Тохиолдол судлах.

Хүснэгт 2. Харьцуулах хэлбэр тус бүрийн онцлог

Д/д	Харьцуулах хэлбэр	Ойлголт, онцлог
1	Байх ёстой болон одоо байгаа	Хуулиар тогтоосон “байх ёстой” үзүүлэлт практикт хэр байгааг илрүүлэх зорилготой. Үнэлгээ хийх хуульд байвал зохих тодорхой абсолют үзүүлэлтийг зааж өгсөн тохиолдолд одоо бодит байгаа үзүүлэлттэй харьцуулна.
2	Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш	Хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль хүчин төгөлдөр хэрэгжсэний дараахтай буюу хуулийн хэрэгжилтийн явцад гарч буй үр дагавартай харьцуулна.
3	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдснийг он дараалаар тогтоон харьцуулна.
4	Тохиолдол судлах	Хууль, эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоогдсон зүйл, заалт өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх зэрэг) хэрхэн хэрэгжиж буй байдлыг харьцуулна.

Манай тохиолдолд ЗЭБТХЭтХ-ийн 7, 8 дугаар бүлгийг *хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс* хойш болон *тохиолдол судлах* хэлбэрээр харьцуулан үнэлнэ. *Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш* харьцуулах хэлбэрийн хүрээнд ЗЭБТХЭтХ-ийн шинэчилсэн найруулга үйлчилж эхэлснээс хойш (2006 оноос) зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөн, ялангуяа эрх зүйн хамгаалалт

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.mn.gov.mn

сайжирсан эсэхийг судалж тогтоох бол **тохиолдол судлах** хэлбэрийн **хүрээнд** сонгон авсан зохицуулалт гадаад улс оронд ямар байдлаар хэрэгждэг талаар тодруулах юм.

1.4.Шалгуур үзүүлэлтийг томьёолох

Шалгуур үзүүлэлтийг томьёолох гэдэг нь тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамаглал дэвшүүлэх буюу асуулт тавихыг хэлнэ. Таамаглал дэвшүүлэх болон асуулт тавихдаа аль болох товч, тодорхой томьёолох зарчим баримтлах нь зүйтэй. Манай тохиолдолд сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрийг дараах байдлаар томьёолон үнэлнэ.

Зорилгод хүрсэн төвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

1. Хуулийн 7 дугаар бүлэг. Зохиогчийн эрхийн хамгаалах байгууллага

- Хуулийн 26 дугаар зүйл буюу оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ гэдгийг тодорхойлно.
- Хуулийн 27, 28, 29 дүгээр зүйл буюу зохиогчийн эрхийг хамгаалах Хамтын удирдлагын байгууллагын зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ гэдгийг тодорхойлно.

2.Хуулийн 8 дугаар бүлэг. Зохиогчийн эрхийг хамгаалах, зохиогчийн эрх зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

- Хуулийн 31 дүгээр зүйл зохиогчийн эрх ба зохиогчийн эрхэд хамаарах эрхийн тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлох эрх зүйн үндсийг бүрэн тавьж чадаж байгаа болон хүлээлгэж буй хариуцлага нь хуулийн зорилгыг хангаж байгаа эсэхийг тодруулахад оршино.

Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

1.Хуулийн 7 дугаар бүлэг. Зохиогчийн эрхийн хамгаалах байгууллага

- Хуулийн 26 дугаар зүйл буюу оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зохицуулалт практикт нийцэж байна уу, хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл, түүнээс үүдэн гарсан үр дагавар юу вэ гэдгийг тодорхойлно.
- Хуулийн 27, 28, 29 дүгээр зүйл буюу зохиогчийн эрхийг хамгаалах Хамтын удирдлагын байгууллагын зохицуулалт практикт нийцэж байна уу, хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл, түүнээс үүдэн гарсан үр дагавар юу вэ, зорилгодоо хэр хүрсэн бэ гэдгийг тодорхойлно.

2.Хуулийн 8 дугаар бүлэг. Зохиогчийн эрхийг хамгаалах, зохиогчийн эрх зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

- Хуулийн 31 дүгээр зүйл хэрэгжиж байна уу, хэрэгжилтэд тулгарч буй бэрхшээл, түүнээс үүдэн гарсан үр дагавар юу вэ, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэж буй хариуцлага хэр бодитой байна вэ гэдгийг тодорхойлно.

1.5. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Үнэлгээ хийх шалтгаан, үнэлгээ хийх хүрээ, шалгуур үзүүлэлт, сонгосон харьцуулах хэлбэр, томьёолсон шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан ямар мэдээлэл олж авахаа тодорхойлж, уг мэдээллийг ямар аргаар хэзээ, хаанаас цуглуулахаа сонгох ба шаардлагатай материалыг дараах аргаар цуглуулж болно. Үүнд:

хуулийн хүрээнээс хүрээлэн www.legal.mn

- **Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах:** Шүүхийн шийдвэр буюу шүүхийн практик, тухайн сэдвээр гарсан мэргэжлийн ном, товхимол, гарын авлага, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, статистикийн тоо баримт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн эх сурвалжийг ашиглана.
- **Холбогдох субьектээс судалгаа авах:** Тухайн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулж байгаа болон чиг үүргээрээ түүнтэй холбоотой төрийн байгууллага, албан хаагч, хуулийн хэрэгжилтэд өртөж байгаа иргэн, хуулийн этгээдээс мэдээлэл цуглуулахын тулд анкетын болон ярилцлагын аргыг ашиглах, хэлэлцүүлэг хийж болно. Мөн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар холбогдох байгууллагаас албан ёсоор тайлан, судалгаа, бусад мэдээлэл (тухайн байдлын чанарын үзүүлэлт)-ийг гаргуулж болно.
- **Шинжээчдийн зөвлөгөөн зохион байгуулах:** Цуглуулсан мэдээлэл, судалгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлж, дүгнэхэд хангалттай бус, эсхүл эргэлзээтэй бол илүү тодорхой мэдээлэл авах зорилгоор тодорхой салбар, чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүд, эсхүл хууль тогтоомж хэрэгжүүлж байгаа буюу түүний хэрэгжилтэд хамаарах бусад субьектийг оролцуулсан уулзалт, ярилцлага зөвлөгөөнийг зохион байгуулан хэрэгцээтэй мэдээллээ олж авна.
- **Биечлэн судалгаа хийх:** Тухайн хууль тогтоомж хэрэгжиж байгаа орчин нөхцөлд биечлэн очиж, ажиглалт хийх, эсхүл дээр дурдсаны дагуу анкетын болон ярилцлагын аргыг ашиглан мэдээлэл цуглуулж болно.
- Эдгээр аргуудаас нэг буюу хэд хэдийг сонгож болох ба манай тохиолдолд дараах аргуудыг сонгож, ашигласан болно. Тодруулбал:
- **Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах:** Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг хамгаалахтай холбогдох хууль тогтоомж, ЗЭБТХЭтХ- ийн хэрэгжилттэй холбогдон гарсан шүүхийн шийдвэр, мэргэжлийн өгүүлэл, илтгэл, судалгааны тайлан, статистик мэдээнд дүн шинжилгээ хийх;
- **Холбогдох субьектээс судалгаа авах:** ЗЭБТХЭтХ-ийн үйлчлэлд хамаарах төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, албан хаагч, зохиогч, уран бүтээлч, эрх эзэмшигч, хуульч, судлаачдаас анкетын болон ярилцлагын аргыг ашиглан судалгаа авах зэрэг.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nlt.gov.mn

ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ				
Үнэлгээний хүрээ	Шалгуур үзүүлэлт	Харьцуулах хэлбэр	Шалгуур үзүүлэлтийн томьёолол	Мэдээлэл цуглуулах арга
Хуулийн 7 дугаар бүлэг. Зохиогчийн эрхийг хамгаалах байгууллага ✓ 26 дугаар зүйл. Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ✓ 27 дугаар зүйл. Хамтын удирдлагын байгууллага ✓ 28 дугаар зүйл. Хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаа ✓ 29 дүгээр зүйл. Хамтын удирдлагын байгууллагын үүрэг	Зорилгод хүрсэн түвшин; Практикт нийцэж байгаа байдал.	Тохиолдол судлах; Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш.	Зорилгод хүрсэн түвшин Хуулийн 26 дугаар зүйл буюу оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ? • Хуулийн 27, 28, 29 дүгээр зүйл буюу зохиогчийн эрхийг хамгаалах Хамтын удирдлагын байгууллагын зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ? Практикт нийцэж байгаа байдал Хуулийн 26 дугаар зүйл буюу оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зохицуулалт практикт нийцэж байна уу, хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл, түүнээс үүдэн гарсан үр дагавар юу вэ? Хуулийн 27, 28, 29 дүгээр зүйл буюу зохиогчийн эрхийг хамгаалах Хамтын удирдлагын байгууллагын зохицуулалт практикт нийцэж байна уу, хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл, түүнээс үүдэн гарсан үр дагавар юу вэ?	Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах: Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зохицуулж буй холбогдох хууль тогтоомж, ЗЭБТХЭтХ-ийн хэрэгжилттэй холбогдон гарсан шүүхийн шийдвэр, мэргэжлийн өгүүлэл, илтгэл, судалгааны тайлан, статистик мэдээнд дүн шинжилгээ хийх; Холбогдох субьектээс судалгаа авах: ЗЗБТХЗтХ-ийн үйлчлэлд хамаарах төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, судлаачдаас анкетын болон ярилцлагын аргыг ашиглан судалгаа авах.
Хуулийн 8 дугаар бүлэг. Зохиогчийн эрхийг хамгаалах, зохиогчийн эрх зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага ✓ 31 дүгээр зүйл. Зохиогчийн эрх ба түүнд зохиогчийн эрхэд хамаарах эрхийн тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх	• Зорилгод хүрсэн түвшин; • Практикт нийцэж байгаа байдал.	охиолдол судлах; Хууль	Зорилгод хүрсэн түвшин улийн 31 дүгээр зүйл нь зохиогчийн эрх ба зохиогчийн эрхэд хамаарах эрхийн тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлох эрх зүйн үндсийг бүрэн тавьж чадаж байна уу, хүлээлгэж буй хариуцлага нь хуулийн зорилгыг хангаж байна уу? Практикт нийцэж байгаа байдал • Хуулийн 31 дүгээр заалт хэрэгжиж	Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах: Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зохицуулж буй холбогдох хууль тогтоомж, ЗЭБТХЭтХ-ийн хэрэгжилттэй холбогдон гарсан шүүхийн шийдвэр, мэргэжлийн өгүүлэл, илтгэл, судалгааны тайлан, статистик мэдээнд дүн шинжилгээ хийх; Холбогдох субьектээс

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.ilbsv.mn

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Төлөвлөх үе шатанд сонгосон аргын дагуу холбогдох мэдээлэл цуглуулах, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг энэ үе шатанд гүйцэтгэнэ. Ингэхдээ тухайн хууль, эсхүл түүний бүлэг, зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхэд ямар арга хэрэглэж мэдээллээ цуглуулахаа сонгоно.

Манай тохиолдолд бэлэн байгаа мэдээллийг цуглуулах болон холбогдох субьектээс судалгаа авах аргаар шаардлагатай мэдээллийг цуглуулсан.

Нэг. Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах **Эрх зүйн баримт бичиг**

Монгол Улсын Үндсэн хууль, 1992, (8 дугаар зүйл, хоёр дугаар бүлэг); Монгол Улсын Иргэний хууль, 2002, (10, 54-59 дүгээр бүлэг);

Зохиогчийн эрхийн тухай хууль, 1993[2];

Патентийн тухай хууль, 2006;

“Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллага байгуулах тухай” конвенц, 1978;

“Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай” Бернийн конвенц, 1997; “Зохиогчийн эрхийн тухай” ДОӨБ-ын гэрээ, 2002;

“Тоглолт, дуу авиа, дүрс бичлэг бүтээгчдийн эрхийг хамгаалах тухай” ДОӨБ-ын гэрээ, 2002;

“Хараагүй, харааны бэрхшээлтэй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүст зориулан хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хүртээмжтэй болгох тухай” Марракешийн гэрээ, 2015;

“Оюуны өмчийн улсын хяналтын дүрэм”, Засгийн газрын 1999 оны 220 дугаар тогтоол;

“Оюуны өмчийн бүтээлийн үнэлгээ тогтоох, баталгаажуулах журам”, Оюуны өмчийн газрын даргын 2011 оны 65 дугаар тушаал;

“Оюуны өмчийн газрын зохион байгуулалтын бүтэц”, Монгол Улсын шадар сайдын 2015 оны 10 дугаар тушаал;

“Оюуны өмчийн газрын бүтцийн нэгжийн стратеги, орон тоо”, Оюуны өмчийн газрын даргын 2015 оны 90 дүгээр тушаал;

“Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны А/16 дугаар тушаал;

“Оюуны өмчийн тогтолцоог хөгжүүлэх үндэсний стратеги”, Засгийн газрын 2015 оны 298 дугаар тогтоол.

Статистик мэдээ, судалгааны тайлан, ном, сурах бичиг, өгүүлэл

Тамоцу Хозуми, “Ази дахь зохиогчийн эрхийн гарын авлага”, УБ., 2007;

Э.Цэндмаа, “Зохиогчийн эрх-Таны бүтээл”, УБ., 2009;

Ц.Шинэбаяр, “Оюуны өмчийн асуудал”, УБ., 2010;

Ц.Шинэбаяр, “Олон улсын гэрээ, хэлэлцээрийн тойм”, УБ., 2011;

Б.Батбаяр, Д.Дэлгэрцоо, Д.Зүмбэрэллхам, Ц.Энхгэрэл, “Оюуны үнэт зүйлийг ашиглах гэрээний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь” сэдэвт төслийн ажлын тайлан (төсөл), УБ., 2012;

Оюуны өмчийн газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, “Зохиогчийн эрхийн ойлголт, контент үйлдвэрлэл-телевизийн салбарт” илтгэл, УБ., 2016;

[2] Хүчингүй болсон.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.jri.gov.mn

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар, “Зохиогчийн эрх болон түүнд холбогдох эрхийн тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулга, үзэл баримтлалын төсөл”, УБ., 2017;

Шүүхийн ерөнхий зөвлөл, “2006-2017 онуудад шүүхээр шийдэгдсэн зохиогчийн эрхтэй холбогдох иргэн, эрүүгийн хэргийн статистик”.

Хоёр. Судалгааны аргаар цуглуулсан мэдээлэл

ЗЭБТХЭтХ-ийн хэрэгжилтийн талаар хийсэн анкетын болон ярилцлагын судалгаа.

Уг хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх явцад ЗЭБТХЭтХ-ийн үйлчлэлд хамаарах төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, албан хаагч, зохиогч, уран бүтээлч, эрх эзэмшигч, хуульч, судлаач нийт 49 оролцогчоос анкетын болон ярилцлагын аргыг ашиглан судалгаа авсан ба оролцогчдын бүтцийг харуулбал:

Зураг 2. Судалгаанд оролцогчдын мэдээлэл (хувиар)



ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд үнэлгээ хийх ажлыг эцэслэн, тайлан бичих, үнэлгээний үр дүнг нэгтгэн, зөвлөмж боловсруулах ажил хийгдэх ба манай тохиолдолд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу ЗЭБТХЭтХ-ийн 7, 8 дугаар бүлэгт үнэлгээ хийхэд дараах байдалтай байв.

3.1.“Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

ЗЭБТХЭтХ-ийн үндсэн зорилтыг *“зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхээр хамгаалагдах бүтээлийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино”* хэмээн уг хуулийн нэгдүгээр зүйлд заасан байна. Иймд уг хуулийн бүхий л зохицуулалт энэхүү үндсэн зорилтыг хангахад чиглэн үйлчлэх учиртай.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэх ялангуяа зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг хамгаалах тусгай зорилгыг хангах үүднээс хуулийн 7 дугаар бүлгийн 26, 27, 28, 29 дүгээр зүйлээр оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Хамтын удирдлагын байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээг тодорхойлсон байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДСНИЙ ХҮРЭЭЛЭЛ www.nli.gov.mn

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Хуулийн 26 дугаар зүйл буюу оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ?

26 дугаар зүйл. Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага

26.1.Зохиогчийн эрхийг хамгаалах төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхлэн дараах чиг үүргийг гүйцэтгэнэ:

26.1.1.зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

26.1.2.зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжийг сурталчлах, боловсронгуй болгох, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах;

26.1.3.зохиогч, зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах, тэдний бүтээн туурвих үйл ажиллагааг дэмжих, зохиогчийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах;

26.1.4.энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан хамтын удирдлагын байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хамтран ажиллах;

26.1.5.зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчийн хүсэлтээр зохиогчийн эрх, түүнд хамаарах эрхийн бүтээлийг бүртгэх, гэрчилгээ олгох, бүртгүүлсэн бүтээлийн сан байгуулах;

26.1.6.оюуны өмчийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих улсын хяналтыг хэрэгжүүлэх, оюуны өмчийн улсын байцаагч ажиллуулах;

26.1.7.зохиогчийн эрхийн зөрчлийг арилгахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах, зохиогчийн эрхтэй холбоотой маргааныг шийдвэрлэхэд лавлагаа гаргаж өгөх;

26.1.8.зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийн үнэлгээ тогтоох, баталгаажуулах;

26.1.9.ардын урлагийн бүтээлийг хамгаалах чиглэлээр иргэд, байгууллагуудтай хамтран ажиллах.

26.2.Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага үйл ажиллагааныхаа орлогоор санхүүжих бөгөөд үйл ажиллагааны хөлсний хэмжээг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

26.3.Оюуны өмчийн улсын хяналтын дүрмийг Засгийн газар батална.

26.1.хэсэг хуулийн зорилтыг хангахад нийцэж байна. Зохиогчийн эрхийн тухай анхны бие даасан хууль 1993 онд батлагдсан ба 2006 онд уг хуулийг шинэчлэн найруулж баталсан байна. Эдгээр хуульд зохиогчийн эрхийг хамгаалах төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхлэн гүйцэтгэхээр заасан бөгөөд 1996 он хүртэл энэхүү чиг үүргийг Патент, барааны тэмдгийн газар болон Соёлын яамны Зохиогчийн эрхийн асуудал хариуцсан газар хэрэгжүүлж ирсэн байдаг.

Харин 1996 онд Улсын Их Хурлын 40 дүгээр тогтоолоор Оюуны өмчийн газрыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн статустай байгуулснаар тус улс зохиогчийн эрхийг хамгаалах төрийн бодлогыг хэрэгжүүлэх бие даасан байгууллагатай болсон байна.

Оюуны өмчийн газар 20 жил бие даан дээрх чиг үүргийг хэрэгжүүлж ирсэн ба 2016 онд тус газрыг Улсын бүртгэлийн ерөнхий газартай нэгтгэн Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрыг (цаашид “ОӨУБЕГ” гэх) байгуулснаар одоо уг байгууллагын бүтэц дэх “Зохиогчийн эрхийн газар” энэхүү чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Хуулийн 26 дугаар зүйлээр оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад олгосон эрх хэмжээ, чиг үүрэг уг хуулийн үндсэн зорилтыг хангахад нийцэж байгаа ба хуулиар олгогдсон чиг үүргээ зохих түвшинд хэрэгжүүлж ирсэн байна. Гэхдээ цаашид анхаарах шаардлагатай асуудлууд байгаа нь үнэлгээний явцад ажиглагдлаа.

26.1.1.зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

Хуулийн 26.1.1.-д заасан “зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах” эрх хэмжээ нь хуулийн үндсэн зорилтыг хэрэгжүүлэхэд нөлөө үзүүлэх хамгийн чухал зохицуулалт боловч бодит байдал дээр хэрэгжилт муутай байна.

2017 оны гуравдугаар сарын байдлаар ОӨУБЕГ-ын Зохиогчийн эрхийн газар нь дарга, ахлах мэргэжилтэн нэг, шинжээч хоёр, мэргэжилтэн дөрөв нийт найман хүний орон тоотой ажиллаж байна[3]. Эдгээр найман ажилтан зохиогчийн эрхийг хамгаалах төрийн бодлого хэрэгжүүлэх ажлыг үндсэнд нь хариуцаж байгаа ба 26 дугаар зүйлд заасан чиг үүргийг бүхэлд нь хэрэгжүүлэхэд бүтэц, орон тооны хувьд учир дутагдалтай.

Шигтгээ 1.

...Зохиогчийн эрхийн газар нь хөдөө, орон нутагт салбар төлөөлөгчгүй. Энэ чиглэлийн улсын байцаагч орон нутагт байдаггүй. Ер нь “зохиогчийн эрх” гэдэг асуудлыг хотын асуудал гэж үзэж буй мэт байдаг...

1 Судалгаанд оролцогчид

26.1.2.зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжийг сурталчлах, боловсронгуй болгох, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах;

2006 онд уг хуулийг шинэчилэн найруулж баталснаас хойш зарчмын шинжтэй нэмэлт, өөрчлөлт ороогүй ба харин одоо ОӨУБЕГ-ын Зохиогчийн эрхийн газраас уг хуулийг хэрэгжүүлэх явцад цуглуулсан туршлага болон сүүлд нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрт нийцүүлэн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж байна.Төслийн үзэл баримтлалд “Монгол Улсын зохиогчийн эрхийн хамгаалалтын өнөөгийн тогтолцоо орчин цаг үеэс хоцорч байгаа нь зохиогчийн эрхийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагыг бий болгож байна” хэмээн дурджээ. Үүнээс дүгнэвэл оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад энэхүү заалтаар олгосон эрх хэмжээний хүрээнд “зохиогчийн эрхийг хамгаалах” үндсэн зорилгоо хэрэгжүүлэхэд илүү анхаарах хүсэл эрмэлзэл бүрэн байна гэж үзэж байна.

[3] “Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны А/16 дугаар тушаал.
Оюуны өмчийн мэдээллийн сан: Бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох Үндэсний хөтөлбөрийнтайлан,2012.

Гэхдээ уг хэсгийн *“...зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжийг сурталчлах...”* чиг үүрэг хангалттай хэрэгжихгүй байгаа нь судалгаанд оролцогчдын санал бодол, уг харилцаанаас үүссэн эрх зүйн зөрчлүүдээс ажиглагдаж байгааг дурдах нь зүйтэй юм.

26.1.3.зохиогч, зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах, тэдний бүтээн туурвих үйл ажиллагааг дэмжих, зохиогчийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах;

Энэ зүйлээр зохиогч, зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчийг хамгаалах, дэмжих, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тавьжээ. Уг заалт нь хэрэгжилтийг хангах холбогдох зохицуулалтаар “амь орох” бөгөөд энэ түвшинд нь авч үзвэл зорилгодоо хүрэхүйц байна.

26.1.4.энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан хамтын удирдлагын байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хамтран ажиллах

ЗЭБТХЭтХ-ийн нэг онцлог нь зохиогчийн эрхийн харилцааг зохицуулах чиг үүргийг төрийн болон төрийн бус байгууллагад хуваарилснаараа энэхүү харилцааг зохицуулах үүргийг хэсэгчлэн мэргэжлийн өөрөө удирдах байгууллагын эрх мэдэлрүү шилжүүлэх оролдлого хийсэнд оршино. Дээрх заалтад *“мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хамтран ажиллах”* зохицуулалт тусгагдсан боловч ямар төрлийн удирдлага, хамтын ажиллагаа болох нь хуульд тодорхой тусгагдаагүй байна.

Түүнчлэн 27.4.-д тусгагдсан “Хамтын удирдлагын байгууллага нь зохиогчийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулахдаа оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай *хамтран ажиллах гэрээ* байгуулж ажиллана.” гэх заалт дээрх асуудлыг илүү тодорхой болгож чадахгүй байна. Үүнийг ойлгомжтой болгож нарийвчлан тусгаснаар уг заалт хуулийн үндсэн зорилгодоо нийцэх ба энэ хэвээр байвал “тунхагийн шинжтэй” үлдэх магадлалтай.

26.1.5.зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчийн хүсэлтээр зохиогчийн эрх, түүнд хамаарах эрхийн бүтээлийг бүртгэх, гэрчилгээ олгох, бүртгүүлсэн бүтээлийн сан байгуулах;

Уг хэсгийн зохицуулалт хуулийн зорилтыг хангахад хүрэлцэхүйц бөгөөд дараах хүснэгтээс хэрэгжилтийн байдлыг нь шинжлэх боломжтой.

Хүснэгт 4. Монгол Улсад хамгаалагдсан оюуны өмчийн бүтээлийн патент, гэрчилгээний тоон үзүүлэлт[3]

Он	Шинэ бүтээлийн Патент		Бүтээгдэхүүний загварын Патент		Барааны тэмдгийн Гэрчилгээ		Ашигтай загварын Гэрчилгээ	Зохиогчийн эрхийн Гэрчилгээ
	Үндэсний	Олон улсын PCT гэрээний дагуу	Үндэсний	Олон улсын Гаагийн хэлэлцээрийн	Үндэсний	Олон улсын Мадридын хэлэлцээрийн дагуу		
1983-1989	500				704	4160	Онцлогтой санал	
1990	38		20		55	1416		
1991	122		75		147	1336		
1992	119		77		128	1254		
1993	99		125		168	1324		
1994	104		134		214	1351		195
1995	118		131		281	958	24152	309
1996	113		122		297	1044		168
1997	116		82	174	322	2871		139
1998	173		107	282	523	1530		204
1999	160		32	252	360	750		125
2000	106		60	292	332	2096	280	169
2001	176		75	310	376	1646	208	179
2002	183		74	371	392	1954	187	133
2003	213		101	353	447	1206	164	233
2004	185		113	232	500	1115	235	239
2005	197		138	222	601	1523	214	240
2006	95	79	139	218	607	1708	145	301
2007	77	122	91	284	614	1820	127	359
2008	58	101	98	384	638	1626	154	351
2009	62	70	60	152	548	1475	108	407
2010	47	49	83	151	672	1546	105	298
2011	37	80	74	154	846	1547	71	456
2012	31	84	65	122	1046	1542	84	431
Нийт	3091	585	2074	3933	10796	38664	26212	4936

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nlf.gov.mn

26.1.9.ардын урлагийн бүтээлийг хамгаалах чиглэлээр иргэд, байгууллагуудтай хамтран ажиллах.

Уг хэсэгт ямар хэлбэрийн хамтын ажиллагаа байх хийгээд бусад зохиогчийн эрхээс зохицуулалт нь ямар ялгаатай байх нь тодорхойгүй байна.

26.1.6.оюуны өмчийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих улсын хяналтыг хэрэгжүүлэх, оюуны өмчийн улсын байцаагч ажиллуулах;

26.3.Оюуны өмчийн улсын хяналтын дүрмийг Засгийн газар батална.

Засгийн газрын 1999 оны 220 дугаар тогтоолоор баталсан “Оюуны өмчийн улсын хяналтын дүрэм”-ээр Оюуны өмчийн улсын байцаагчийн эрх, хэмжээг тодорхойлсон байна. Уг дүрмийн 7 дахь хэсэгт зааснаар “оюуны өмчийн улсын хяналт” нь дараах хоёр чиглэлтэй байна. Үүнд:

- Монгол Улсын нэгдэн орсон оюуны өмчийн талаарх олон улсын гэрээ, конвенц, эрх зүйн бусад баримт бичгийн биелэлтийг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдийн үйл ажиллагаанд шалгах;
- Оюуны өмчийн талаарх хууль тогтоомж, Засгийн газар болон эрх бүхий бусад байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих.

Энэ хүрээнд оюуны өмчийн улсын байцаагч нь дараах эрх, үүрэгтэй.

Үүнд:

Эрх	Үүрэг
• Хяналт шалгалтын ажилд шаардлагатай бичиг, баримт, мэдээ, судалгаа, тодорхойлолтыг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдээс гаргуулж авах; • Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа ажлын байр, талбайд нэвтрэн орох; • Байгууллагын удирдлагатай нь тохиролцсоны үндсэн дээр хяналт шалгалтын ажилд зохих мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулах, шинжээчийг томилон ажиллуулах; • Шаардлагатай гэж үзвэл шалгалтын материалыг хуулийн холбогдох байгууллагад шилжүүлэх; • Оюуны өмчийн эрх зөрчсөн үйлдлийг зогсоох, эрх зөрчсөн бараа, бүтээгдэхүүн, хууль бус орлогыг хураан авч улсын орлого болгох буюу эрх эзэмшигчид олгох, эсвэл акт үйлдэж устгах арга хэмжээ авах; • Хууль тогтоомж, дүрэм журам зөрчсөн болон илэрсэн зөрчлийг арилгах талаар өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн заалтыг үндэслэн хариуцлага хүлээлгэх.	• Оюуны өмчийн хууль тогтоомжийн дагуу байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдийн үйл ажиллагаанд оюуны өмчийн улсын хяналтыг хэрэгжүүлж, оюуны өмчийн эрх зөрчигдөхөөс сэргийлэх, илэрсэн зөрчлийг шуурхай арилгах арга хэмжээ авах, хяналтын үр дүнг мэдээлэх, сурталчлах; • Оюуны өмчийн эрхэд хохирол учруулсан гэж тодорхойлогдсон үйлдвэрлэл, үйлчилгээг зөрчлийг арилгах хүртэл хугацаагаар бүхэлд нь буюу хэсэгчлэн зогсоож, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх; • Зөрчил, дутагдлын шалтгааныг судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээний чиглэл, бодлогын төслийг боловсруулж холбогдох газарт оруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих; • Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдэд акт, мэдэгдэл бичиж, хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах; • Хуурамчаар үйлдвэрлэсэн бараа, үзүүлсэн үйлчилгээний талаар олон нийтэд мэдээлэх.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Үүнээс харахад уг хэсгийн зохицуулалт зорилгодоо хүрэхүйц байна. Гэхдээ “илэрсэн зөрчлийг арилгах талаар өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн заалтыг үндэслэн хариуцлага хүлээлгэх”-ээр заасныг эргэн нягтлах шаардлагатай.

“Холбогдох хууль тогтоомжийн заалт” гэдэг нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2. дахь хэсэг бөгөөд үүнд “улсын байцаагчийн албан даалгавар, шаардлага, акт, дүгнэлтийг эсэргүүцсэн, тогтоосон хугацаанд биелүүлээгүй, шаардлагын биелэлтийг гаргаж ирүүлээгүй иргэнийг *хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, эсхүл түүнийг хоёроос гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох”-оор заасан байна.*

Гэвч энд тогтоосон торгуулийн хэмжээ хууль хэрэгжүүлэх хөшүүрэг болж чадах хэмжээнд байгаа эсэхийг эргэн нягтлах шаардлагатай ба энэхүү заалт бүрэн хэрэгжсэн ч зохиогчийн эрхийг хамгаалах зорилго хангалттай хэрэгжиж чадахгүй юм.

26.1.8.зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийн үнэлгээ тогтоох, баталгаажуулах;

Зохиогчийн эрх хэмээх ойлголт нь өөртөө “эдийн засгийн болон ёс суртахууны эрх”-ийг агуулдаг. Ёс суртахууны эрх гэдэгт зохиогчийн эд хөрөнгийн бус хувийн эрх, тэр дундаа “зохиогч мөн болох эрх”-ийн ойлголт юм. Харин эдийн засгийн эрх гэдэгт эд хөрөнгийн эрх буюу бүтээлээсээ ашиглах, үнэлүүлэх зэрэг агуулгууд багтана.[4] Оюуны өмчийн үнэлгээ нь тодорхой оюуны өмчийн мөнгөн өртгийг тодорхойлох явцыг хэлнэ.

Иймд энэ заалт бүтээлийн үнэлгээ тогтоох харилцааны эрх зүйн үндсийг тавьснаараа зохиогчийн эд хөрөнгийн эрхийг хамгаалах ач холбогдолтой бөгөөд хуулийн үндсэн зорилгод нийцэхүйц байна.

26.2. Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага үйл ажиллагааныхаа орлогоор санхүүжих бөгөөд үйл ажиллагааны хөлсний хэмжээг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

Энэ хэсгийн агуулга оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төсвөөс ямар нэг санхүүжилт авалгүй, цэвэр өөрсдийн үйл ажиллагааны орлогоор санхүүжих агуулгатай байна. Энэ нь холбогдох хууль (Төсвийн удирдлага, санхүүжилтийн тухай зэрэг)-тай зөрчилдөхөөс гадна хуулийн хэрэгжилтэд сайнгүй үр дагавар үүсгэж болзошгүй юм.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. Хуулийн 27, 28, 29 дүгээр зүйл буюу зохиогчийн эрхийг хамгаалах Хамтын удирдлагын байгууллагын зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ?

27 дугаар зүйл. Хамтын удирдлагын байгууллага

27.1.Зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчид эрхээ хамгаалуулах зорилгоор, хамтын удирдлагын байгууллагыг байгуулан ажиллуулж болно.

27.2.Хамтын удирдлагын байгууллагыг зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчдийн санаачлагаар байгуулна.

27.3.Хамтын удирдлагын байгууллагыг зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийн төрөл, ангиллаар дагнасан буюу хэд хэдэн төрлийг хамарсан үйл ажиллагаа явуулахаар байгуулж болно.

[4] Jefferson Community College, “Copyright Handbook”, 2015.

27.4.Хамтын удирдлагын байгууллага нь зохиогчийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулахдаа оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллана.

Хамтын удирдлагын байгууллага *(Collective management organisations)*- тай холбогдох энэхүү хэсэг нь тус салбарт мэргэжлийн өөрөө удирдах байгууллага үүсэх эрх зүйн үндсийг тавьсан чухал зохицуулалт бөгөөд хуулийн үндсэн зорилтыг хангахад нийцэж байна. Гэвч судалгааны явцад уг заалтын хэрэгжилт учир дутагдалтай байгаа байдал ажиглагдсан.

28 дугаар зүйл. Хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаа

28.4.Хамтын удирдлагын байгууллага нь зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчдийг төлөөлж, тэдний нэрийн өмнөөс, тэднээс олгосон бүрэн эрхийн хүрээнд дараах үйл ажиллагаа явуулна.

28.4.1. бүтээлийг нь ашиглуулах талаар гишүүн зохиогч болон эрх эзэмшигчтэй гэрээ байгуулах;

28.1.2.бүтээл ашиглах лиценз авсан этгээдтэй төлбөрийн хэмжээ, бусад нөхцөлийг тохиролцох, төлбөр авах;

28.1.3.авсан төлбөрөөс зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчид хуваарилан олгох;

28.1.4.гишүүн зохиогчийн бүтээлийг хууль бусаар ашигласан тухай мэдээллийн дагуу оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх, хуульд заасан арга хэмжээ авахуулах.

Уг зүйлийн нэр “Хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаа” гэж байгаа боловч доторх заалтуудын нь агуулга зүйлийнхээ нэртэй нийцэхгүй байна. Өөрөөр хэлбэл, тухайн байгууллагын эрх хэмжээ, чиг үүргийг заасан зохицуулалт уу, эсвэл үйл ажиллагаа явуулах журам уу, аль нь болох нь ойлгомжгүй байна. Иймээс зүйлийн нь нэрийг эргэж нягтлах шаардлагатай. Гэхдээ Хамтын удирдлагын байгууллагын гол чиг үүрэг болох зарим асуудлыг тусгасан нь ололттой бөгөөд хуулийн үндсэн зорилтыг хангахад нэмэр тус болох магадлалтай. Үүнд:

- Зохиогч, эрх эзэмшигчтэй бүтээлийг нь ашиглуулах талаар тохиролцох;
- Тохиролцсоны дагуу бүтээлийг нь ашиглах этгээдтэй тохиролцох, ашиглуулсны төлбөр авах;
- Авсан төлбөрөөс зохиогч, эрх эзэмшигчдэд хуваарилах зэрэг.

29 дүгээр зүйл. Хамтын удирдлагын байгууллагын үүрэг

29.5.Хамтын удирдлагын байгууллага нь зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчийн эрх ашигт нийцсэн үйл ажиллагаа явуулах талаар дараах үүрэг хүлээнэ:

29.1.1.зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчид бүтээл ашигласны шагналыг олгохдоо тухайн бүтээлийг ашигласантай холбогдолтой мэдээллийг танилцуулах;

29.1.2.лицензийн дагуу хураан авсан бүтээл ашигласны төлбөрийг зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчид хуваарилан олгох;

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГ www.legal.gov.mn

29.1.3.бүтээл ашигласантай холбогдуулан хураан авсан төлбөрөөс үйл ажиллагааны зардлыг хасч зохиогч, эрх эзэмшигчдэд тогтмол хугацаанд бүтээлийн ашиглалтын хэмжээгээр хувь тэнцүүлэн хуваарилах.

ОӨУБЕГ-ын Зохиогчийн эрхийн газраас авсан мэдээллээр манай улсын хэмжээнд 10 гаруй Хамтын удирдлагын байгууллага ажиллаж байгаа ба эдгээрийн зарим нь нилээд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг байна.

Тэдгээрийн нэг нь 2011 онд байгуулагдсан “Монголын зохиолч, хөгжмийн зохиолч, нийтлэгчдийн нийгэмлэг” (MOSCAP) бөгөөд уг байгууллагыг хөгжмийн чиглэлээр байгуулагдсан 10 орчим хамтын удирдлагын байгууллагыг нэгтгэн байгуулсан байна. Эдгээр байгууллагуудыг нэгтгэн зохион байгуулахад Зохиогчийн эрхийн газар нилээд хүчин чармайлт гаргасан бөгөөд түүний үйл ажиллагааг олон улсын гэрээ, конвенц, бусад улсын жишигт нийцүүлэх зорилго тавин ажиллаж байгаа аж. Иймээс Хамтын удирдлагын байгууллагуудыг төлөөлүүлэн энэхүү байгууллагыг сонгож, судалгаанд хамруулсан болно.

Үнэлгээ хийх явцад тус байгууллагын дүрмийг судлах боломж олдоогүй бөгөөд тусгайлсан бүтэцгүй, гүйцэтгэх захирал болон хоёр менежерийн орон тоотой ажилладаг. Мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хамтран ажиллах чиг үүрэгтэйн хувьд Зохиогчийн эрхийн газрын удирдлагын түвшинд уг байгууллагыг өөрийн чиг үүргийг *“хангалттай хэрэгжүүлдэг”* гэсэн дүгнэлт өгсөн юм.

ШИГТГЭЭ 2.

...Зохиогчийн эрхийн нэг гол онцлог нь хүнд байгалиасаа заяасан унаган эрх юм. Ийм учраас заавал гэрээ, патент авахгүйгээр үүсдэг эрх. Олон улсын гэрээнд ч энэ талаар заагаад өгсөн. Энэ эрхээ хэрэгжүүлэх гол байгууллага нь хамтын удирдлагын байгууллага. Олон улсын тогтолцоо нь ийм байдаг, бусад улс орнуудад ч гэсэн ийм. Хамтын удирдлагын байгууллага бол зохиогчийн эрхийнх нь зөвшөөрлийг өмнөөс нь өгдөг, ашиглалтаас орж буй мөнгийг хурааж, буцаагаад гишүүддээ тэр ашгийг нь хуваарилдаг ашгийн төлөө бус байгууллага юм. Энэ нь анх Францад бий болж, Японд нилээн сайн хөгжсөн байдаг. Хамтын удирдлагын байгууллага нь Монголд бэхжээд өгвөл зохиогчийн эрхийн зөвшөөрөл авах байдал жигдрэнэ. Бид зүтгэж “хөгжмийнх”-ийг байгуулсан. Хөгжмийн 10-аад хамтын удирдлагын байгууллага байсныг 2011 онд нэгтгээд нэг болгосон юм. Одоо тэр байгууллага маань их сайн ажиллаж байгаа. Жилд 100 сая төгрөгний хуваарилалт гишүүддээ хийж байна...

Зохиогчийн эрхийн газрын ажилтнуудтай хийсэн ярилцлага

Гэхдээ 2006 оноос хойш Иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн зохиогчийн эрхтэй холбогдох маргааны цөөнгүй хэсэгт Монголын зохиолч, хөгжмийн зохиолч, нийтлэгчдийн нийгэмлэг хариуцагчаар оролцсон байдаг.

Түүнчлэн 28, 29 дүгээр зүйлийн зохицуулалтын агуулга давхардсаныг дурдах нь зүйтэй.

ШИГТГЭЭ 3.

Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.3., Иргэний хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.2., 9.4.4.-т заасныг баримтлан Монголын зохиолч, Хөгжмийн зохиолч нийтлэгчдийн нийгэмлэг “Н” хамтлагийн ахлагч, ая зохиогч, дуучин Б.Б-ны бүтээл ашиглах онцгой эрхийг зөрчиж, “Н” хамтлагийн “Н” цомгийг АНУ-ын APPLE компанийн ITUNES store сайтад байршуулсан гэм буруутай болохыг тогтоож...

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН www.nli.gov.mn

Сүхбаатар дүүргийн анхан шатны шүүхийн 2013-07-01-ний өдрийн 1361 дугаартай шийдвэр

Тохиолдол судлах хэлбэрээр харьцуулах зорилгоор Хамтын удирдлагын байгууллагын зохицуулалт бусад улс оронд ямар байдалтай байгааг судлав. Олон улсын жишгээр зохиогчийн эрхийн харилцаанд оролцогч хоёр үндсэн зохион байгуулалтын бүтэц байна. Үүнд:

- Зохиогчийн эрхийг хамгаалах чиг үүрэгтэй төрийн байгууллага;
- Зохиогчийн эрхийг хамгаалах чиг үүрэгтэй хамтын удирдлагын байгууллага.

Зарим улс оронд энэ хоёр бүтэц хоёулаа байдаг бөгөөд зарим оронд зөвхөн Хамтын удирдлагын байгууллага хэлбэрээр оршиж байна. Аль ч хэлбэрээр байсан хууль тогтоомжоор тэдгээр байгууллагад холбогдох бүх эрхийг олгож, түүндээ нийцсэн стандарт тогтоодог байна.

Зохиогчийн эрхийг хамгаалах төрийн байгууллага нь ихэнх улсад бодлого төлөвлөх, хууль тогтоомж хэрэгжүүлэх, хариуцлага тооцох, соён гэгээрүүлэх чиг үүрэгтэй. Зарим улсад уг байгууллага оюуны өмчийн бүх л асуудлыг (зохиогчийн эрх болон аж үйлдвэрийн өмч) хариуцдаг байна. Зарим улсад энэ чиг үүрэг дээр нэмээд хууль тогтоомж зөрчигчдөд хариуцлага хүлээлгэх эрх мэдэл олгосон байдаг.

Гэхдээ цөөнгүй улс оронд зохиогчийн эрхийн байгууллага нь дангаараа ажиллахаас илүү тодорхой чиг үүргээ Хамтын удирдлагын байгууллагатай хуваалцах, ингэхдээ Хамтын удирдлагын байгууллагад үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, олгосон зөвшөөрлийнхөө хүрээнд хяналт тавих байдлаар ажиллахаар зохицуулжээ.[5]

Хамтын удирдлагын байгууллагын эрх хэмжээг бусад улс орон холбогдох хууль тогтоомждоо ямар байдлаар тусгасныг судалж үзэхэд дараах байдал харагдаж байна. Үүнд:

- Бүтэц, зохион байгуулалтын асуудлыг өөрсдийн нь мэдэлд үлдээдэг ч дотоод хяналт шалгалт хийх, тайлагнах, гишүүддээ ил тод байх зэрэг үүргийг оноож, эдгээрийг хариуцсан бүтэц байхыг үүрэг болгон, тайлан, мэдээллийн бүтцийг тусгаж өгсөн (Словени, Япон);
- Гишүүдтэйгээ зааваал гэрээ хийхийг үүрэг болгож, гэрээний стандарт нөхцөлийг хуульдаа тусгасан;
- Ашгийн бус байгууллага болохыг нь хуулиар зааж, үйлчилгээний хураамж, хүртэх ашгийн хувийг төрийн байгууллагаас тогтоож өгсөн (БНХАУ);
- Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг зохиогчийн эрхийн байгууллагаас өгсөн зэрэг (БНХАУ).

Судалгаанд оролцогчдоос “гишүүдийн бүтээлтэй холбоотой эд хөрөнгийн эрхийг хамгаалах асуудлыг илүү тодорхой хуульчилж, Хамтын удирдлагын байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааг аль болох тийш нь чиглүүлэх шаардлагатай” гэсэн санал ирж байсныг дурдах нь зүйтэй.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 3. Хуулийн 31 дүгээр зүйл нь зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлох эрх зүйн үндсийг бүрэн тавьж чадаж байна уу, хүлээлгэж буй хариуцлага нь хуулийн зорилгыг хангаж байна уу?

[5] Дэлхийн оюуны өмчийн байгууллага, “Educational Material on Collective Management of Copyright and Related Rights”, сургалтын материал, 2012.

31 дүгээр зүйл. Зохиогчийн эрх ба түүнд зохиогчийн эрхэд хамаарах эрхийн тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

31.1.Зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, улсын байцаагч иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос зургаа дахин, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорин тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гэм буруутай иргэн, албан тушаалтныг шүүгч 7-14 хоногоор баривчлах шийтгэл ногдуулж, улсын байцаагч, шүүгч нь зөрчилтэй бараа бүтээгдэхүүн, эд зүйлсийг хураан авч, хууль бусаар олсон орлогыг улсын орлого болгох буюу зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчид олгож, тухайн үйл ажиллагааг зогсооно.”

31.2.Эрх эзэмшигчийн таних тэмдгийг хуурамчаар үйлдэж хэрэглэсэн, уг таних тэмдгийн хамт бичигдсэн зүйлийг өөрчилсөн, устгасан, хууль бусаар өөрчилсөн, устгасныг мэдсэн болон мэдэх боломжтой байсан ч түүнийг нэвтрүүлсэн, тараасан, тараах зорилгоор хилээр нэвтрүүлсэн, нийтэд түгээсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч зөрчил гаргасан иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос зургаа дахин, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорин тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох шийтгэл ногдуулна.

31.3. Бүтээл ашиглах онцгой эрхийг зөрчсөнөөс учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг Монгол Улсын Иргэний хуулийн дагуу шийдвэрлэнэ.

31.4.Хэрэв эрх нь зөрчигдсөн зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигч хүсэлт гаргавал, түүнд зөрчилтэй бүтээгдэхүүнийг хохирлынх нь төлбөрт тооцож шилжүүлэн өгч болох бөгөөд хүсэлт гаргаагүй бол зөрчилтэй бараа, бүтээгдэхүүнийг устгах арга хэмжээг шүүгч, улсын байцаагч авна.

31.5.Зохиогчийн эрх зөрчиж, зохиогчийн эрхийн бүтээл, зохиогчийн эрхэд хамаарах эрхийн бүтээлийг хуулбарлахад ашигласан техник хэрэгслийг шүүх, эрх бүхий байгууллагын шийдвэрээр хураан авч улсын орлого болгоно.

Уг зүйлээр зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсон ба хуулийн үндсэн зорилтод ерөнхийдөө нийцсэн байна. Гэхдээ 31 дүгээр зүйлийн 31.1.-ийн “Зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, улсын байцаагч...” гэх заалтад ямар төрлийн зөрчилд шүүгч, ямар төрлийн зөрчилд улсын байцаагч хариуцлага хүлээлгэх нь тодорхой биш байна.

Мөн уг зүйлийн 31.1., 31.2.-т “...эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол...”, 31.3.-т “Бүтээл ашиглах онцгой эрхийг зөрчсөнөөс учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг Монгол Улсын Иргэний хуулийн дагуу шийдвэрлэх”-ээр тус тус заасан нь хэрэг, маргааны харьяаллыг тогтоосон сайн талтай.

3.1.“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Хуулийн 26 дугаар зүйл буюу оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зохицуулалт практикт нийцэж байна уу, хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл, түүнээс үүдэн гарсан үр дагавар юу вэ?

26 дугаар зүйл. Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага

26.1.Зохиогчийн эрхийг хамгаалах төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхлэн дараах чиг үүргийг гүйцэтгэнэ:

26.1.1.зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

26.1.2.зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжийг сурталчлах, боловсронгуй болгох, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах;

26.1.3.зохиогч, зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах, тэдний бүтээн туурвих үйл ажиллагааг дэмжих, зохиогчийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах;

26.1.4.энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан хамтын удирдлагын байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хамтран ажиллах;

26.1.5.зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчийн хүсэлтээр зохиогчийн эрх, түүнд хамаарах эрхийн бүтээлийг бүртгэх, гэрчилгээ олгох, бүртгүүлсэн бүтээлийн сан байгуулах;

26.1.6.оюуны өмчийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих улсын хяналтыг хэрэгжүүлэх, оюуны өмчийн улсын байцаагч ажиллуулах;

26.1.7.зохиогчийн эрхийн зөрчлийг арилгахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах, зохиогчийн эрхтэй холбоотой маргааныг шийдвэрлэхэд лавлагаа гаргаж өгөх;

26.1.8.зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийн үнэлгээ тогтоох, баталгаажуулах;

26.1.9.ардын урлагийн бүтээлийг хамгаалах чиглэлээр иргэд, байгууллагуудтай хамтран ажиллах.

26.2.Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага үйл ажиллагааныхаа орлогоор санхүүжих бөгөөд үйл ажиллагааны хөлсний хэмжээг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

26.3.Оюуны өмчийн улсын хяналтын дүрмийг Засгийн газар батална.

Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгтэй холбоотой зохицуулалтын тухайд: Уг хуулийн 26.1. болон

26.1.2.-т заасан “төрийн бодлого хэрэгжүүлэх”, “зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжийг сурталчлах, боловсронгуй болгох, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах” зохицуулалтын хүрээнд багагүй ахиц дэвшил гарсан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийнх нь өмч, Монгол Улсын үндэсний баялаг мөн”, 16 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт “Монгол Улсын иргэн соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална” гэж тус тус заасан ба 1994 онд баталсан Иргэний хууль нь зохиогчийн эрхийн одоогийн эрх зүйн тогтолцоо бий болох үндэс суурь болсон байдаг.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Түүнчлэн Монгол Улс 1979 онд НҮБ-ын төрөлжсөн байгууллага болох Дэлхийн Оюуны Өмчийн байгууллага (ДОӨБ)-ын гишүүн орон болсон бөгөөд энэ салбарын 14 гэрээ, конвенцид тус улс нэгдэн орсны тав нь зохиогчийн эрхийг хамгаалахтай холбоотой байна. Тодруулбал:

-1997 онд “Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай” Бернийн конвенц;

-2002 онд “Зохиогчийн эрхийн тухай” ДОӨБ-ын гэрээ;

-2002 онд “Тоглолт, дуу авиа, дүрс бичлэг бүтээгчдийн эрхийг хамгаалах тухай” ДОӨБ-ын гэрээ;

-2015 онд “Хараагүй, харааны бэрхшээлтэй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүст зориулан хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хүртээмжтэй болгох тухай Марракешийн гэрээ”-нд тус тус нэгдэн орсон.

Гэхдээ энэхүү зүйлийн зарим зохицуулалтыг хэрэгжүүлэхэд зохих хүндрэл тулгарч байна. Үүнд:

1.ОӨУБЕГ-ын Зохиогчийн эрхийн газар нь 2017 оны 3 дугаар сарын байдлаар дарга, ахлах мэргэжилтэн нэг, шинжээч хоёр, мэргэжилтэн дөрөв нийт найман хүний орон тоотой ажиллаж байна[6]. Эдгээр найман ажилтан уг зүйлийн

26.1.26.1.1.-д заасан зохиогчийн эрхийг хамгаалах төрийн бодлогыг хэрэгжүүлэх, энэ чиглэлийн хууль тогтоомжийг улсын хэмжээнд зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа ба ийм бүтэц, орон тоогоор ийм өргөн хүрээтэй, эрх хэмжээ, чиг үүргийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй.

Ийм ч учраас судалгаанд оролцогчдын зүгээс *“зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах ажил хангалтгүй, зөвхөн Улаанбаатарын хэмжээнд хэрэгжиж ирсэн”, “Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг хамгаалж чаддаггүй”* гэх зэргээр хариулжээ. Зураг 3-аас үзнэ үү.

Зураг 3. Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн хамгаалалтын хэрэгжилт (хувиар)



Цаашлаад зохиогчийн эрхийг хамгаалж чадахгүй байгаагийн шалтгааныг “уг байгууллагын бүтэц, орон тоо, хариуцлага ногдуулах эрх хэмжээ хангалтгүй” байгаатай холбон үзсэн байна.

-26.2.-т “Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага үйл ажиллагааныхаа орлогоор санхүүжих бөгөөд үйл ажиллагааны хөлсний хэмжээг

[6] “Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны А/16 дугаар тушаал.

Оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно” хэмээн заасан байна.

Гэтэл уг байгууллага нь байгуулагдсан цагаасаа эхлэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн статустай ажиллаж, улсын төсвөөс санхүүжиж ирсэн ба одоо ийм байдлаар санхүүжиж, үйл ажиллагаагаа явуулна гэвэл үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүйд хүрэх эрсдэлтэй.

2.Оюуны өмчийн үнэлгээ нь тодорхой оюуны өмчийн мөнгөн өртгийг тодорхойлох явцыг хэлнэ. Иймд уг хуулийн 26.1.8.-д бүтээлийн үнэлгээ тогтоох харилцааны эрх зүйн үндсийг тавьснаараа зохиогчийн эд хөрөнгийн эрхийг хамгаалах чухал ач холбогдолтой.

Оюуны өмчийн газрын даргын 2011 оны 65 дугаар тушаалаар “Оюуны өмчийн бүтээлийн үнэлгээ тогтоох, баталгаажуулах журам” батлагдсан байна.

Гэтэл уг байгууллагад хуулиар ийм эрх олгоогүйн гадна тухайн харилцааг бүрэн, дүүрэн зохицуулж чадахгүй байгааг салбарын судлаачид дурдсаар байна. Тухайлбал, Монгол Улсын их сургуулиас хийсэн “Оюуны өмчийн хөрөнгийн үнэлгээ” сэдэвт судалгаанд Монгол Улс дахь оюуны өмчийн хөрөнгийн үнэлгээний давуу болон сул талыг дурдахдаа: Оюуны өмчийн үнэлгээ хийх эрх зүйн орчин, тогтолцоо боловсронгуй бус байгаа тул Оюуны өмчийн газрын мөрддөг оюуны өмчийн үнэлгээний журам, үнэлгээний үйл явцыг нарийвчлах, илүү боловсронгуй, ил тод болгох шаардлагатай гэж дүгнэсэн байна. Өөрөөр хэлбэл энэхүү дүрэм, журам боловсронгуй биш байгаа нь зохиогчийн эд хөрөнгөтэй холбоотой эрхийг хамгаалах уг хуулийн нэн чухал зорилт хэрэгжихэд зохих хүндрэл учруулж байна гэсэн үг юм.

3.ЗЭБТХЭтХ-ийн 26.3.-т Оюуны өмчийн улсын хяналтын дүрмийг Засгийн газар батлахаар заасан. Энэхүү заалт 1993 оны хуульд ч байсан бөгөөд энэ дагуу 1999 оны 220 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналтын дүрэм” өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байна. Зүй нь 2006 онд шинэчлэн найруулж батлагдсан хуульд нийцүүлэн уг дүрмийг шинээр батлах ёстой байсан байна.

Өөрөөр хэлбэл 2006 оны хууль батлагдахаас 7 жилийн өмнө батлагдсан энэхүү дүрэм (13 заалт бүхий)-ийг 20 шахам жил мөрджээ. Оюуны өмчийн улсын байцаагч нь энэхүү дүрмийн дагуу гадагш болон дотогш чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд уг дүрмээр энэхүү өргөн хүрээний харилцааг зохицуулахад хүндрэлтэй билээ. Одоо улсын байцаагчийн эрхтэй ажилтан 10 гаруй *байгаагийн дотор зохиогчийн эрхийг хамгаалах чиглэлээр дөрөв байна. Товчхондоо маш хуучирсан дүрмээр маш цөөн улсын байцаагч үйл ажиллагаа явуулж байна гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Судалгааны явцад улсын байцаагчийн эрх хэмжээ, чиг үүрэг, үйл ажиллагаа хангалттай биш байгааг оролцогчид дурдаж байв.*

ШИГТГЭЭ 4.

...Оюуны өмчийн улсын байцаагчдын орон тоо дутагдалтай, ажил үүргийн хуваарь тэгш бус байдаг. ЗЭБТХЭтХ-ийн хувьд ерөнхийдөө эрхийг хамгаалах боломжтой ч тэрхүү хуулиа хамгаалдаг байцаагчдын зохицуулалт сул байгаагаас хэрэгждэггүй..

...Оюуны өмчийн улсын байцаагчдын эрх мэдлийг өргөжүүлэх, тоог нэмэх, Цагдаагийн байгууллагатай уялдаатай ажиллах тогтолцоо бүрдүүлэх хэрэгтэй...

Ярилцлагын судалгаанд оролцогчид

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. Хуулийн 27, 28, 29 дүгээр зүйл буюу зохиогчийн эрхийг хамгаалах Хамтын удирдлагын байгууллагын зохицуулалт

практикт нийцэж байна уу, хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл, түүнээс үүдэн гарсан үр дагавар юу вэ?

28 дугаар зүйл. Хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаа

28.1. Хамтын удирдлагын байгууллага нь зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчдийг төлөөлж, тэдний нэрийн өмнөөс, тэднээс олгосон бүрэн эрхийн хүрээнд дараах үйл ажиллагаа явуулна:

28.1.1. бүтээлийг нь ашиглуулах талаар гишүүн зохиогч болон эрх эзэмшигчтэй гэрээ байгуулах;

28.1.2.бүтээл ашиглах лиценз авсан этгээдтэй төлбөрийн хэмжээ, бусад нөхцөлийг тохиролцох, төлбөр авах;

28.1.3. авсан төлбөрөөс зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчид хуваарилан олгох;

28.1.4. гишүүн зохиогчийн бүтээлийг хууль бусаар ашигласан тухай мэдээллийн дагуу оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх, хуульд заасан арга хэмжээ авахуулах.

29 дүгээр зүйл. Хамтын удирдлагын байгууллагын үүрэг

29.2. Хамтын удирдлагын байгууллага нь зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчийн эрх ашигт нийцсэн үйл ажиллагаа явуулах талаар дараах үүрэг хүлээнэ:

29.2.2. зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчид бүтээл ашигласны шагналыг олгохдоо тухайн бүтээлийг ашигласантай холбогдолтой мэдээллийг танилцуулах;

29.1.2. лицензийн дагуу хураан авсан бүтээл ашигласны төлбөрийг зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчид хуваарилан олгох;

29.1.3. бүтээл ашигласантай холбогдуулан хураан авсан төлбөрөөс үйл ажиллагааны зардлыг хасч зохиогч, эрх эзэмшигчдэд тогтмол хугацаанд бүтээлийн ашиглалтын хэмжээгээр хувь тэнцүүлэн хуваарилах.

Хамтын удирдлагын байгууллагатай холбоотой зохицуулалтын тухайд: Уг байгууллагын статус, эрх хэмжээ, санхүүжүүлэх зарчим, чиг үүрэг, үйл ажиллагаа явуулах журам зэрэгтэй холбоотой зохицуулалт тодорхой хуульчлагдаагүйгээс энэ төрлийн байгууллагууд үндсэндээ 3 үүргийн хүрээнд л үйл ажиллагаа явуулж байна.

Цаашид эрх зүйн зохицуулалтыг нь дэлгэрүүлэхгүй бол ийм төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд олноор үүсч, үйл ажиллагаа нь жигдрэх үйл явц удааширч улмаар хуулийн зорилго биелэгдэхгүйд хүрч болзошгүй юм. Ийм чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага 10 гаруй байгаа тухай дээр дурдсан ба энэ нь улсын бүртгэлд бүртгэгдсэн нийт төрийн бус байгууллагын өчүүхэн бага хувийг эзэлж байна.

Түүнчлэн 2006 оноос хойш иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэсэн зохиогчийн эрхэд холбогдох хэрэг, маргааны цөөнгүй хувьд нь Хамтын удирдлагын байгууллага хариуцагчаар татагдсан байв. Энэ нь эргээд Хамтын удирдлагын байгууллага зохиогчдын эрхийг хамгаалах биш зөрчих, хуулийн ерөнхий зохицуулалтаас үүдэн зөвхөн хувь хүртэгч байдлаар ажилладаг ашгийн байгууллага болгон хувиргах эрсдэлтэйг анхаарах шаардлагатай.

Хэдийгээр төрийн байгууллагын зүгээс Хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагааг эерэгээр үнэлэх хандлага байсан ч зохиогч, уран бүтээлч, эрх эзэмшигч

болон Хамтын удирдлагын байгууллагын ажилтнууд өөрсдөө “Хамтын удирдлагын байгууллагын эрх үүрэг, хариуцлагыг илүү тодорхой болгох шаардлагатай. Одоогийн нөхцөлд уг байгууллага “зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг хамгаалах чадамжгүй байна” гэх хариулт өгч байв.

Зураг 4. Хамтын удирдлагын байгууллагын зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн хамгаалалтын байдал (хувиар)



Шалгуур узуулэлтийн томьёолол 3. Хуулийн 31 дүгээр зүйл хэрэгжиж байна уу, хэрэгжилтэд тулгарч буй бэрхшээл, түүнээс үүдэн гарсан үр дагавар юу вэ, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэж буй хариуцлага хэр бодитой вэ?

31 дүгээр зүйл. Зохиогчийн эрх ба түүнд зохиогчийн эрхэд хамаарах эрхийн тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

31.1.Зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, улсын байцаагч иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос зургаа дахин, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорин тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гэм буруутай иргэн, албан тушаалтныг шүүгч 7-14 хоногоор баривчлах шийтгэл ногдуулж, улсын байцаагч, шүүгч нь зөрчилтэй бараа бүтээгдэхүүн, эд зүйлсийг хураан авч, хууль бусаар олсон орлогыг улсын орлого болгох буюу зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчид олгож, тухайн үйл ажиллагааг зогсооно.

31.2.Эрх эзэмшигчийн таних тэмдгийг хуурамчаар үйлдэж хэрэглэсэн, уг таних тэмдгийн хамт бичигдсэн зүйлийг өөрчилсөн, устгасан, хууль бусаар өөрчилсөн, устгасныг мэдсэн болон мэдэх боломжтой байсан ч түүнийг нэвтрүүлсэн, тараасан, тараах зорилгоор хилээр нэвтрүүлсэн, нийтэд түгээсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч зөрчил гаргасан иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос зургаа дахин, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорин тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох шийтгэл ногдуулна.

31.3. Бүтээл ашиглах онцгой эрхийг зөрчсөнөөс учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг Монгол Улсын Иргэний хуулийн дагуу шийдвэрлэнэ.

31.4.Хэрэв эрх нь зөрчигдсөн зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигч хүсэлт гаргавал, түүнд зөрчилтэй бүтээгдэхүүнийг хохирлынх нь төлбөрт тооцож шилжүүлэн өгч болох бөгөөд хүсэлт гаргаагүй бол зөрчилтэй бараа, бүтээгдэхүүнийг устгах арга хэмжээг шүүгч, улсын байцаагч авна.

ХУУЛЬ ЗҮЙН УНШЛАГЫН ХҮРЭЭЛЭН
www.lib.ugy.mn

31.5.Зохиогчийн эрх зөрчиж, зохиогчийн эрхийн бүтээл, зохиогчийн эрхэд хамаарах эрхийн бүтээлийг хуулбарлахад ашигласан техник хэрэгслийг шүүх, эрх бүхий байгууллагын шийдвэрээр хураан авч улсын орлого болгоно.

Зохиогчийн эрхийн салбарт гарч буй зөрчлийг сүүлийн 7 жилээр авч үзэхэд 2010 онд хийсэн 132 хяналт, шалгалтаар 86 зөрчил, 2011 онд хийсэн 266 шалгалтаар 236 зөрчил, 2012 онд хийсэн 74 шалгалтаар 69 зөрчил, 2013 онд хийсэн 198 шалгалтаар 154 зөрчил, 2014 онд хийсэн 270 шалгалтаар 266 зөрчил, 2015 онд хийсэн 242 шалгалтаар 234 зөрчил, 2016 онд хийсэн 275 шалгалтаар 263 зөрчил тус тус илрүүлсэн байна. Зохиогчийн эрхийн зөрчлийн төрлийг “шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл”-ийн болон “цахим орчин” дахь гэх хоёр бүлэгт ангилан авч үзэж болох ба зургаар харуулбал:

Зураг 5. Зохиогчийн эрхийн салбарт гарсан зөрчлийн тоон үзүүлэлт (2010-2017 он)[7]



Судалгаанаас харахад эхний багц үзүүлэлт болох шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээлийн зөрчлийн (2010-2016 он хүртэлх) хэлбэлзэл нь харилцан адилгүй байхад, цахим орчин дахь эрхийн зөрчлийн давтамж жил ирэх тусам нэмэгдэх хандлагатай байна. Түүнчлэн ОӨУБЕГ-ын Зохиогчийн эрхийн газрын улсын байцаагчийн эрх бүхий ажилтнуудаас авсан судалгаанаас харахад *“зохиогчийн эрхийг хамгаалах, зохиогчийн эрх зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагатай холбогдох одоогийн зохицуулалт практикт хэрэгжихгүй байгаа бөгөөд энэ нь хууль зүйн хүчин чадал муутайгаас болдог”* хэмээн тайлбарласан байна.

Сүүлийн жилүүдэд зохиогчийн эрхийн салбарт гарч буй зөрчлийн дийлэнх нь цахим орчинд гарах болсон тул үүнд чиглэсэн хариуцлагын зохицуулалт шинээр нэмэх шаардлагатай байна. Цахим орчин дахь зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зөрчлийн асуудал түгээмэл байгаа хэдий ч манай тохиолдолд үнэлгээний хүрээнд хамааруулагүй тул дэлгэрүүлэн авч үзээгүй болно.

Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуультай холбогдох маргааныг иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэсэн статистик тоон мэдээллээс харахад 2006-2016 онд нийт 22 маргаан шийдвэрлэжээ.

[7] Оюуны өмчийн газраас зохиогчийн эрхийн салбарт хийсэн хяналт шалгалтын дүн.

Хүснэгт 5. Шүүхээр шийдвэрлэсэн зохиогчийн эрхтэй холбогдох иргэний хэрэг[8]

Он	Шийдвэрлэсэн хэрэг
2006	3
2007	3
2008	1
2009	2
2010	0
2011	4
2012	1
2013	4
2014	0
2015	3
2016	1
Дүн	22

Дээрх тоон мэдээнээс харахад иргэний хэргийн шүүх жилд дунджаар зохиогчийн эрхтэй холбоотой хоёр маргаан шийдвэрлэсэн байна. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдлын дийлэнх нь Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хүрээнд шийдвэрлэгддэг байна. Үүний шалтгааныг судалгаанд оролцогчид янз бүрээр тайлбарлаж байв.

ШИГТГЭЭ 5.

...Иргэний шүүхээр явъя гэхээр тэр хулгайлсан хүний үнэн бодит орлогыг тогтоох боломж ; байдаггүй. Учир нь эрүү үүсэхгүй учраас хэдэн хувийг, хэдэн жил хэвлээд зарж борлуулсанаа тэр хүн хэлэхгүй шүү дээ. Тэгэхээр би нэхэж байгаа мөнгөө үндэслэлтэй болгож, шүүхээр ; тогтоолгох боломжгүй...

...Бүтээсэн киногоо удаа дараа алдсан. Хуулбарыг сайт, пэйжид тавих, youtube-д байршуулах, DVD-д хуулж хар зах дээр зарах гэх зэрэг олон хэлбэрээр хулгайлсан. Кино алдагдахдаа IPTV-д шилжсэн үед айлын зурагтнаас хуулах аргаар алдагддаг. Мөн бичсэн, орчуулсан ; ; номны файлыг интернетэд тавих, хулгайгаар хэвлээд номын худалдаагаар зарах зэргээр зохиогчийн эрхээ зөрчүүлсээр байна...

...Иргэн, эрүүгийн шүүхээр явах гэвч хуулийн байгууллагууд тоохгүй, мөн хэдий хэр хохирол ; учирснаа бодитой нотолж чаддаггүй зэрэг бэрхшээл гардаг...

Зохиолч, уран бүтээлч, эрх эзэмшигчидтэй хийсэн ярилцлага

ЗЭБТХЭтХ батлагдан гарснаас хойших зохиогчийн эрхтэй холбогдох иргэн, эрүү болон зохиогчийн эрхийг хамгаалах байгууллагаар шийдвэрлэсэн зөрчил, маргааны тоон үзүүлэлт, агуулгыг харахад “зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн хамгаалалт” хангалттай ахисан байдал харагдахгүй байна. Судалгаанд

[8] Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн мэдээ, 2017.02 сар.
СХД-ийн эрүүгийн хэргийн шүүхээр 2015 онд нэг хэрэг шийдэгдсэн ч давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон гэх тул судалгаанд ашигласангүй.

оролцогчид *“техник технологийн хурдтай уялдан нөхцөл байдал улам хүндэрсэн, гэтэл хүлээлгэх хариуцлага сул хэвээр”* байна гэж үнэлсэн байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн дүн мэдээгээр 2006 оноос хойш зохиогчийн эрхийг зөрчсөний улмаас шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэрэг

байхгүй байна.[9] Энэ нь зохиогчийн эрхийг зөрчсөн гэмт хэрэг гараагүй гэхээсээ илүү гарч байгаа хэрэг маргааны үнийн дүн Эрүүгийн хуулийн 140 дүгээр зүйлд заасан “их хэмжээ” гэх тоо хэмжээнд хүрэхгүй байгаатай холбоотой байна.

140 дүгээр зүйл. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг зөрчих

140.1.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн бүтээлийг зөвшөөрөлгүй хуулбарлан нийтлүүлсэн, түгээсэн, борлуулсан, тэдгээрийн улмаас их хэмжээний орлого олсон бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Эрүүгийн хуульд зааснаар “их хэмжээний хохирол” гэдэг нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 125-200 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээ юм. 2017 оны байдлаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ Улаанбаатар хотод 240 мянган төгрөг байгаа бөгөөд энэ дагуу тооцоход

30.0.000-48.000.000 (гучин саяас дөчин найман сая) төгрөг байна. Энэхүү хэмжээ нь практикт нийцэхгүй байгааг талууд дурдсаар байгаа ба 2015 оны 12 дугаар сард батлагдсан ч 2016 онд эргүүлэн татсан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад “их хэмжээ” хэмээх ойлголт хэвээр тусч эрүүгийн хэрэг үүсгэх хэмжээ нь 50.000.000 (тавин сая) төгрөг болон нэмэгдсэн байна.

ШИГТГЭЭ 6.

...Эрүүгийн хуулийн 140 дүгээр зүйлд “их хэмжээ” гэдгийг тайлбараас нь хараад мөнгөн дүнгээр нь бодоход 50 сая төгрөгний хохирол юм байна. Хөөрхий дөө, миний номыг нэг удаа; 2000 төгрөгөөр 300 хувь хэвлэхэд 600,000 төгрөг болно. 3000 зарахад 900,000 төгрөг болно. Тэр хүн миний номыг 55 удаа буюу 15 жил хэвлэх эрхтэй болж байгаа юм. Нэг удаа барилаа гэхэд өмнөх орлого нь тогтоогдохгүй, боломжгүй, учир нь эрүү үүсдэггүй болохоор. Ер нь бол ; тэр хүн бүх насаараа миний номыг зэрэгцээд хэвлэх, ашиг олох эрхтэй болж байгаа юм. ; Тиймээс ядаж 5 сая болгоод буулгамаар байна...

Зохиолч Ш

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Үнэлэх үе шатны төгсгөлд томьёолсон шалгуур үзүүлэлтэд тулгуурлан дараах байдлаар дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулна. Үүнд:

- Үнэлгээг илэрхийлсэн дүгнэлт гаргах;
- Үнэлгээний үр дүнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг илүү хүртээмжтэй, үр нөлөөтэй болгох зөвлөмж гаргах.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

4.1.Үнэлэлт, дүгнэлт

ЗЭБТХЭтХ-ийн 7 дугаар бүлгийн 26, 27, 28, 29 дүгээр зүйл болон 8 дугаар бүлгийн 31 дүгээр зүйлийн хэрэгжилтийн үр дагаварт “Зорилгод хүрсэн түвшин”, “Практикт хэрэгжсэн байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийв.

Үнэлгээний үр дүнг зүйл, заалт бүрээр дүгнэхэд дараах байдалтай байна:

26 дугаар зүйл. Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага:

Зорилгод хүрсэн түвшин:

Хуулийн 26 дугаар зүйлээр оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад олгосон чиг үүрэг нь хуулийн үндсэн зорилгод нийцэж байгаа ба уг байгууллага нь хуулиар олгогдсон чиг үүргээ зохих түвшинд хэрэгжүүлж ирсэн ч цаашид анхаарах зүйл байгаа нь үнэлгээний явцад ажиглагдлаа. Үүнд:

- ОӨУБЕГ-ын Зохиогчийн эрхийн газар нь нийт найман хүний орон тоотой ажиллаж байгаа нь хуулиар олгосон чиг үүргийг бүхэлд нь хэрэгжүүлэхэд учир дутагдалтай. Ялангуяа “зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах, зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжийг сурталчлах, боловсронгуй болгох, зохиогч, зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах, тэдний бүтээн туурвих үйл ажиллагааг дэмжих, зохиогчийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллага явуулах” зэрэг тус зүйлээр олгосон зарим чиг үүргийг хэрэгжүүлэх, улмаар *“зохиогчийн эрхийг хамгаалах”* үндсэн зорилгод хүрэх явцыг удаашруулжээ.
- ЗЭБТХЭтХ-иар зохиогчийн эрхийн харилцааг зохицуулах, хамгаалах чиг үүргийг төрийн болон төрийн бус байгууллагад (оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон хамтын удирдлагын байгууллага) хуваарилсан ба энэхүү харилцааг зохицуулах үүргийг хэсэгчлэн мэргэжлийн өөрөө удирдах байгууллагын эрх мэдэлрүү шилжүүлэх оролдлого хийсэн нь ололттой. Гэхдээ *“хамтын удирдлагын байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хамтран ажиллах”* зохицуулалт нь тодорхойгүй байна. Энэхүү зохицуулалтыг илүү ойлгомжтой, дэлгэрэнгүй болгож нарийвчлан тусгаснаар уг зүйл хуулийн үндсэн зорилгодоо нийцэх ба энэ хэвээр байвал “тунхагийн шинжтэй” үлдэх юм.
- *“Зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийн үнэлгээ тогтоох, баталгаажуулах”* чиг үүрэг нь хуулийн үндсэн зорилгод бүрэн нийцсэн боловч хэрэгжилтийг хангах зорилгоор батлагдсан журмын ерөнхий зохицуулалт нь зорилгод хүрэх байдлыг бууруулжээ.
- *“Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага үйл ажиллагааныхаа орлогоор санхүүжих...”* тухай заалт нь хуулийн үндсэн зорилгод нийцэхгүй байна. Уг заалт холбогдох хууль тогтоомжтой зөрчилдөхөөс гадна Зохиогчийн эрхийг хамгаалах төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагыг үйл ажиллагааны чадамжгүй болгох эрсдэлтэй.

Практикт хэрэгжсэн байдал:

Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тухайд үндсэн чиг үүргээ зохих түвшинд хэрэгжүүлж ирсэн бөгөөд эерэг үр дүн багагүй гарсан байна.

Гэвч энэхүү “зохих түвшин” гэдэг нь хангалттай, сайн гэсэн үнэлэлт биш бөгөөд тус үнэлгээний хүрээнд хийгдсэн судалгаанд оролцогчид “Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг хамгаалж чаддаггүй” гэж үзсэн юм. Тухайлбал: хуулийн

26 дугаар зүйлийн 26.1.1., 26.1.3., 26.1.6. зэрэг заалтууд хангалттай түвшинд хэрэгжээгүй нь зохиогчийн эрхийн хамгаалалт муу байгаагаас харагдана.

Энэ нь хууль тогтоомжийн тодорхойгүй байдал, хууль хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байгууллагын бүтэц, орон тооны хүрэлцээнээс ихээхэн хамаарчээ. Тухайлбал, хуулийн 26 дугаар зүйлийн 26.3. дахь хэсэгт Оюуны өмчийн улсын хяналтын дүрмийг Засгийн газар батлахаар заасан. Энэ дагуу хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.6. дахь заалт хэрэгжинэ. Гэтэл өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй Оюуны өмчийн улсын хяналтын дүрэм нь Засгийн газрын 1999 оны 220 дугаар тогтоолоор батлагдсан бөгөөд 2006 онд хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн шинээр батлаагүй байна. Өөрөөр хэлбэл шинэ хууль батлагдахаас 7 жилийн өмнө батлагдсан энэхүү дүрэм (13 заалт бүхий)-ийг 20 шахам жил мөрдэжээ.

Оюуны өмчийн улсын байцаагч нь энэхүү дүрмийн дагуу гадагш болон дотогш чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд улсын байцаагчийн эрхтэй цөөн тооны ажилтнууд Монгол Улсын 21 аймаг болон нийслэлд оюуны өмчийн улсын хяналт явуулж байгаа нь тухайн заалтын хэрэгжилт ямар түвшинд байгааг харуулж байна.

27 дугаар зүйл. Хамтын удирдлагын байгууллага

Зорилгод хүрсэн түвшин:

Хуулийн зорилгод нийцэж байна. Гэхдээ *"Хамтын удирдлагын байгууллага нь зохиогчийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулахдаа оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллана."* гэсэн заалтын хамтран ажиллах гэрээний зохицуулалт, хэрхэн яаж байгуулах зэрэг нь тодорхойгүй байна.

Практикт хэрэгжсэн байдал:

Хамтын удирдлагын байгууллагуудыг судлах явцад хамгийн идэвхтэй ажиллаж байгаа нь "Монголын зохиолч, хөгжмийн зохиолч, нийтлэгчдийн нийгэмлэг" (MOSCAP) гэх боловч 2006 оноос хойш иргэний хэргийн шүүхээр шийдэгдсэн зохиогчийн эрхэд холбогдох хэрэг, маргааны цөөнгүй хэсэгт тус байгууллага хариуцагчаар татагдсан байв.

Одоогийн хуулийн зохицуулалтад байгаа "зөвхөн хувь хүртэгч"-ийн шинжтэй эрх, үүргийг нарийвчлан зохиогчийн эрхийн хамгаалал, төлөөллийн байгууллага болгох талд нь зохицуулалт хийхгүй бол Хамтын удирдлагын байгууллага зохиогчийн эрхийг хамгаалах биш зөрчих, зөвхөн хувь хүртэгч байдлаар ажилладаг ашгийн байгууллага болгон хувиргах эрсдэлтэйг анхаарах шаардлагатай.

28 дугаар зүйл. Хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаа

Зорилгод хүрсэн түвшин:

Хуулийн зорилгод нийцэж байна. Гэхдээ хуулийн 28, 29 дүгээр зүйлийг нэгтгэн, зохицуулалтыг нь дэлгэрүүлж илүү тодорхой болгох шаардлагатай. Одоогийн зохицуулалтаар аль заалт нь үйл ажиллагааны журам, аль нь эрх хэмжээ олгосон, зохицуулалт хоорондын хувьд ямар ялгаа байгаа зэрэг нь ойлгомж муутай байна.

Практикт хэрэгжсэн байдал:

Хамтын удирдлагын байгууллагын статус, эрх хэмжээ, санхүүжүүлэх зарчим, чиг үүрэг, үйл ажиллагаа явуулах журам зэрэг нь тодорхой хуульчлагдаагүйгээс хязгаарлагдмал хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

29 дүгээр зүйл. Хамтын удирдлагын байгууллагын үүрэг

Зорилгод хүрсэн түвшин:

Хуулийн 28 дугаар зүйлтэй адил байна.

Практикт хэрэгжсэн байдал:

Хуулийн 28 дугаар зүйлийн дүгнэлттэй мөн адил.

31 дүгээр зүйл. Зохиогчийн эрх ба зохиогчийн эрхэд хамаарах эрхийн тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

Зорилгод хүрсэн түвшин:

Хуулийн зорилгод нийцсэн байна. Гэхдээ 31 дүгээр зүйлийн 31.1. дэх хэсгийн "Зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, улсын байцаагч..." гэсэн заалт ямар зөрчилд шүүгч, ямар зөрчилд улсын байцаагч хариуцлага хүлээлгэх нь тодорхой биш байна.

Практикт хэрэгжсэн байдал:

ЗЭБТХЭтХ батлагдан гарснаас хойших зохиогчийн эрхтэй холбогдох иргэн, эрүү болон Зохиогчийн эрхийн газраар шийдэгдсэн зөрчил, маргааны тоон үзүүлэлт, түүний агуулгыг харахад "зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн хамгаалалт" хангалттай ахисан нь харагдахгүй байна. Судалгаанд оролцогчид хуулийн үйлчлэлд хамаардаг субьектүүд *"техник технологийн хурдтай уялдан нөхцөл байдал улам хүндэрсэн, гэтэл хүлээлгэх хариуцлага сул хэвээр"* гэж үнэлж байна.

2006 оноос хойш зохиогчийн эрхийг зөрчсөн гэмт хэрэг, шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэрэг байхгүй байна. [9] Энэ нь зохиогчийн эрхийг зөрчсөн гэмт хэрэг гараагүй гэхээсээ илүү Эрүүгийн хуулийн 140 дүгээр зүйлд заасан "их хэмжээ" гэх тоонд хэрэг маргааны үнийн дүн хүрэхгүй байгаатай холбоотой байна.

Эрүүгийн хуулиар гэмт хэрэг гэж үзэх хохирлын хэмжээнд хүрдэггүй, иргэний журмаар шийдвэрлүүлэх шатанд шүүхийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх процесс ажиллагаанаас хамаарч хэрэг, маргаан удааширдаг, хуулийн байгууллагын энэ талаарх хандлага сул зэргээс үүдэн тухайн асуудлыг хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэхээс төвөгшөөх хандлага оролцогчдод илэрч байв.

Түүнчлэн уг зүйлийг хэрэглэн маргааныг шийдвэрлэх шүүгч, улсын байцаагчийн шийдвэрлэх маргааны харьяалал давхардсан зэрэг зөрчил илрэв.

4.2.Зөвлөмж

Үнэлгээний үр дүнд буюу үнэлгээг илэрхийлсэн дүгнэлтэд тулгуурлан хууль тогтоомжийн хэрэгжилтийг илүү хүртээмжтэй, үр нөлөөтэй болгох талаар дараах санал, зөвлөмж гаргаж байна.

ЗЭБТХЭтХ-ийн холбогдох бүлэг, зүйл, заалтад хийсэн дээр дурдсан дүгнэлтэд үндэслэн, багийн зүгээс ЗЭБТХЭтХ-ийг шинэчлэн найруулах санал гаргаж байна. Түүнчлэн уг хуулийг шинэчлэн найруулахдаа дараах зохицуулалтуудыг тусгахыг мөн санал болгож байна. Үүнд:

- Зохиогчийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагын хяналт, шалгалт хийх, хяналт шалгалтын мөрөөр хариуцлага ногдуулах эрх хэмжээг эргэн нягтлах (өргөтгөх);
- Зохиогчийн эрхийг хамгаалах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг хүртээмжтэй байлгах үүднээс аймаг, сумын Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Мэргэжлийн хяналтын газар, хэлтэстэй хамтран ажиллах эрх зүйн үндсийг бүрдүүлэх;

[9] СХД-ийн эрүүгийн хэргийн шүүхээр 2015 онд нэг хэрэг шийдэгдсэн ч давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон гэх тул судалгаанд ашигласангүй.

• Зохиогчийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, Хамтын удирдлагын байгууллага хоорондын харилцааны эрх зүйн зохицуулалтыг илүү тодорхой болгох. Тухайлбал:

√ Хамтын удирдлагын байгууллага ямар төрлийн үйл ажиллагаандаа тухайн төрийн байгууллагаас зөвшөөрөл авах, ямар тохиолдолд авахгүй байх зэргийг нарийвчлан тусгах;

√ Одоогийн хуульд байгаа *"оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллана."* гэсэн заалтыг илүү тодорхой болгох. Хамтран ажиллах гэрээний стандарт нөхцөлийг тусгах;

√ Зохиогчийн эрхийн бүртгэл, оюуны өмчийн үнэлгээ хийх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэхдээ Хамтын удирдлагын байгууллагын оролцоог ашиглах, нэмэгдүүлэх.

√ Хамтын удирдлагын байгууллагын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож олон улсын гэрээ хэлэлцээр, бусад орны энэ төрлийн харилцааны зохицуулалтад ойртуулах. Тухайлбал:

√ Үйл ажиллагааны хүрээ, дотоод хяналт шалгалт, үйл ажиллагаа болон санхүүгээ тайлагнах журам гишүүддээ ил тод байх зэрэг үүргийг хуульчлах;

√ Байгууллага, гишүүд өөр хоорондоо гэрээ байгуулахыг үүрэг болгож, тэрхүү гэрээнд заавал тусгах стандарт нөхцөлийг заах.

• ЗЭБТХЭтХ зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын механизмыг боловсронгуй болгох, ингэхдээ хууль бус үйл ажиллагаанаас олсон орлогыг зохиогчийн эрх эзэмшигчдэд нөхөн төлүүлэх ажиллагааны хэрэгжилтийг дээшлүүлэхэд Зохиогчийн эрхийг хамгаалах төрийн захиргааны байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах талаар тусгах;

• Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуультай уялдуулах, одоогийн ЗЭБТХЭтХ-д ямар зөрчилд шүүгч, ямар зөрчилд улсын байцаагч хариуцлага тооцох нь тодорхойгүй, давхардсан зэргийг жигдлэх;

• Эрүүгийн хуулийн 140 дүгээр зүйлд заасан "их хэмжээ" гэх ойлголтыг эргэн нягтлах;

• Уг хуулийг дагаж гарах хуучирсан дүрэм, журмыг төсөл боловсруулах явцад зэрэгцүүлэн хийх.

Хуулийн мэдээллийн хүрээлэн www.legal.mn

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Нэг. Хууль тогтоомж, олон улсын гэрээ, бусад эрх зүйн акт

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Зохиогчийн эрхийн тухай хууль, 1993.
3. Монгол Улсын Иргэний хууль, 2002.
4. Патентийн тухай хууль, 2006.
5. “Оюуны өмчийн тогтолцоог хөгжүүлэх үндэсний стратеги”, Засгийн газрын 2015 оны 298 дугаар тогтоол.
6. “Оюуны өмчийн улсын хяналтын дүрэм”, Засгийн газрын 1999 оны 220 дугаар тогтоол.
7. “Оюуны өмчийн бүтээлийн үнэлгээ тогтоох, баталгаажуулах журам”, Оюуны өмчийн газрын даргын 2011 оны 65 дугаар тушаал.
8. “Оюуны өмчийн газрын зохион байгуулалтын бүтэц”, Монгол Улсын шадар сайдын 2015 оны 10 дугаар тушаал.
9. “Оюуны өмчийн газрын бүтцийн нэгжийн стратеги, орон тоо”, Оюуны өмчийн газрын даргын 2015 оны 90 дүгээр тушаал.
10. “Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны А/16 дугаар тушаал.
11. “Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллага байгуулах тухай” конвенц, 1978.
12. “Зохиогчийн эрхийн тухай” ДОӨБ-ын гэрээ, 2002.
13. “Тоглолт, дуу авиа, дүрс бичлэг бүтээгчдийн эрхийг хамгаалах тухай” ДОӨБ-ын гэрээ, 2002.
14. “Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай” Бернийн конвенц,1997.
15. “Хараагүй, харааны бэрхшээлтэй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүст зориулан хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хүртээмжтэй болгох тухай” Марракешийн гэрээ, 2015.

Хоёр. Судалгаа, тайлан, төсөл, илтгэл, эмхэтгэл

16. Батбаяр.Б, Дэлгэрцоо.Д, Зүмбэрэллхам.Д., Ц.Энхгэрэл, “Оюуны үнэт зүйлийг ашиглах гэрээний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь” сэдэвт төслийн ажлын тайлан (төсөл), УБ., 2012.
17. Оюуны өмчийн газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, “Зохиогчийн эрхийн ойлголт, контент үйлдвэрлэл-телевизийн салбарт” илтгэл, УБ., 2016.
18. Оюуны өмчийн газр, “Бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох Үндэсний хөтөлбөрийн тайлан”, 2012.
19. Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар, “Зохиогчийн эрх болон түүнд холбогдох эрхийн тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулга, үзэл баримтлалын төсөл”, УБ., 2017.
20. Шинэбаяр.Ц., “Олон улсын гэрээ, хэлэлцээрийн тойм”, УБ., 2011.
21. Шүүхийн ерөнхий зөвлөл, “2006-2017 онуудад шүүхээр шийдэгдсэн зохиогчийн эрхтэй холбогдох иргэн, эрүүгийн хэргийн статистик”, УБ., 2017.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

Гурав. Ном, сэтгүүл, гарын авлага

22.Тамоцу Хозуми “Ази дахь зохиогчийн эрхийн гарын авлага”, УБ., 2007.

23.Цэндмаа.Э., “Зохиогчийн эрх-Таны бүтээл”, УБ., 2009.

24.Шинэбаяр. Ц., “Оюуны өмчийн асуудал”, УБ., 2010.

Дөрөв. Г адаад хэл дээрх эх сурвалж

25.Jefferson Community College, “Copyright Handbook”, 2015.

26.World intellectual property organization, “Educational Material on Collective Management of Copyright and Related Rights”, module, 2012.

----o0o----

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ПАТЕНТИЙН ТУХАЙ ХУУЛЬ (Шинэчилсэн найруулга)-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН[1]

УДИРТГАЛ

Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар Патентийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийв.

Үнэлгээ хийх ажлын зорилт нь Патентийн тухай хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа өөрэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хуулийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлоход оршино.

Тус үнэлгээ нь төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шатаас бүрдэнэ.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

1.1. Үнэлгээ хийх шалтгаан

Манай оронд сүүлийн жилүүдэд шинжлэх ухаан, инноваци, техник технологи хурдацтай хөгжихийн хэрээр эдийн засаг, бизнес, үйлдвэрлэлийн хөгжил ч түргэсч, өөрчлөгдөх болсон. Энэхүү нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийн үйл явцын шалтгаан нь олон хүчин зүйлтэй холбоотой болох ч түүний нэг учиг нь шинээр сэдсэн бүтээлийг эдийн засаг, бизнесийн эргэлтэд оруулж буй харилцаа мөн. Өөрөөр хэлбэл, аж үйлдвэрийн үндсэн объект болох бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын шинэ бүтээлийг илүүтэй бизнест нэвтрүүлж байгаатай холбогдох харилцаа юм. Иймд эдгээр бүтээлүүдийг хуулиар хамгаалах, ашиглахтай холбоотой асуудлыг зохицуулсан хууль тогтоомжийг ч эргэн харах зайлшгүй шаардлага урган гарч байна.

Оюуны бүтээлийг хамгаалах, ашиглахтай холбоотой суурь хууль болох Патентийн тухай хууль 2006 онд шинэчлэгдэн батлагдсан. Патентийн тухай хуулиар аж үйлдвэрийн үндсэн объект болох шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг бүртгэх, өмчлөх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулсан байдаг. Гэтэл эдгээр объектуудад хамааруулах асуудлууд нь хуулийн нэг зүйлд хамтаар орсон тул анх удаа мэдүүлэг гаргагч нэр, объект хоорондын ялгааг ойлгохгүй, объектоо тодорхойлж чадахгүйгээс болж мэдүүлгийг сольж өгөх, улмаар мэдүүлэг гаргагчид бухимдал үүсэх, олон дахин буцах асуудал удаа дараа гарах болсон. Нөгөөтэйгүүр мэдүүлэг гаргах, хайлт, шүүлт хийх процедурыг тодорхой нарийвчилж өгөөгүйгээс гадна эдгээртэй холбоотой хугацааны асуудал маргаан дагуулах болсон.[2]

Мөн судалгаагаар, Патентийн тухай хуулиар суурь ойлголтуудыг зохицуулсан хэдий ч хуулийн гол амин зохицуулалт болох шинэ бүтээлийн техникийн төвшин тогтоох процедур нь алдаатай, мөн энэ төрлийн хуулийн зохицуулалт дутмаг байдгаас үүдэж мэдүүлэг гаргагч олон дахин буцах, ойлгомжгүй байдал үүсдэг болох нь тогтоогдсон.

---

[1] Тус үнэлгээг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Х.Эрдэм-Ундрах удирдаж, эрдэм шинжилгээний ажилтан М.Төрбаяр, У.Эрдэнэзаяа, Б.Алтангэрэл нар хамтран гүйцэтгэв.

[2] ОӨУБЕГ-ын Аж үйлдвэрийн өмчийн эрхийн газрын ажилтнууд болон Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчидтэй хийсэн ярилцлага.

Иймд эрх зүйн асуудлыг улам боловсронгуй болгож, хуулиар зохицуулах ёстой харилцааг нөхцөл байдалдаа тохируулан суулгаж өгөх, олон улсын жишиг стандарт, өнөөгийн түвшинд нийцүүлэх шаардлагатай байна.

1.2. Үнэлгээ хийх хүрээ

Манай улсад одоогийн байдлаар шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах, түүнд шүүлт хийх процедур болон процессын хугацаа нь практикт төдийлөн нийцэхгүй байгаа байдал нь шинжлэх ухаан, техник технологийн дэвшил, зохион бүтээгчдийн шинээр сэдэх санааг хөхиүлэн дэмжих, худалдаа, бизнесийг дэмжих энэхүү үйл ажиллагаа нь орхигдох төлөвтэй болсон байна.

Иймд үнэлгээ хийх хүрээг тогтоохдоо дээрх шалтгаан, нөлөөллийг харгалзан үзэж Патентийн тухай хуулийн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах, түүнд шүүлт хийх гэсэн бүлэг, зүйл, заалтыг сонгон авсан болно. Үүнд:

- Хоёрдугаар бүлэг. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах, түүнд шүүлт хийх
  - √ 7 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах
  - √ 8 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийг цахим хэлбэрээр гаргах
  - √ 9 дүгээр зүйл. Патентийн хамтын ажиллагааны гэрээний дагуу олон улсын мэдүүлэг гаргах
  - √ 10 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийн анхдагч огноог тогтоох
  - √ 11 дүгээр зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлэгт шүүлт хийх
  - √ 12 дугаар зүйл. Ашигтай загварын мэдүүлэгт магадлан шүүлт хийх гэсэн зүйл, заалтыг авч үзлээ.

1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу дараах үндэслэлээр шалгуур үзүүлэлтүүдийг сонгосон болно. Үүнд:

а) зорилгод хүрсэн түвшин. Патентийн тухай хууль 2006 онд батлагдсан бөгөөд өнгөрсөн хугацаанд энэхүү хуулиар зохицуулах харилцаа багагүй өөрчлөгдөж байна. Ийнхүү шинэчлэгдэн өөрчлөгдөж байгаа өнөө цаг үед хуулийн зорилго, зорилтдоо хүрч чадаж байгаа эсэх;

б) практикт нийцэж байгаа байдал. Уг хуулийн зохицуулалт практикт хэрхэн нийцэж байгаа болон хэрэгжилтэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно.

Зорилгод хүрсэн төвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

1). Хуулийн 2 дугаар бүлэг. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах, түүнд шүүлт хийх

- Хуулийн 7, 8, 9, 10, 11, 12 дугаар зүйл буюу шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах, анхдагч огноог тогтоох, шүүлт хийх зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ гэдгийг тодорхойлно.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

2). Хуулийн 2 дугаар бүлэг. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах, түүнд шүүлт хийх

- Хуулийн 7, 8, 9, 10, 11, 12 дугаар зүйл буюу шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах, анхдагч огноог тогтоох, шүүлт хийх зохицуулалт практикт нийцэж байна уу, хуулийн хэрэгжилтэд тулгарч байгаа хүндрэл, түүний үр дагавар юу вэ гэдгийг тодорхойлов.

1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр

Патентийн тухай хууль (шинэчилсэн найруулга) батлагдаж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс өнөөг хүртэлх 10 гаруй жилийн хугацаанд шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын хамгаалалттай холбогдсон харилцаа, ялангуяа шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах, түүнд шүүлт хийх процессын ажиллагаатай холбоотой өөрчлөлтийг судалсан болно.

Судалгаагаар сонгон авсан зохицуулалт болох шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах, түүнд шүүлт хийх үйл ажиллагаа олон улсын гэрээ, конвенци, жишиг стандартад хэр зэрэг нийцтэй байгааг харьцуулж үзсэн болно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Судалгааны мэдээллийг цуглуулахдаа баримт бичгийн судалгаа, ярилцлагын болон фокус бүлгийн ярилцлагын арга, статистик тоо баримтад тулгуурлаж хийсэн.

Баримт бичгийн судалгаа: Патентийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ дор дурдсан хууль тогтоомж, дүрэм журам, гэрээ, конвенци, эрдэмтэн судлаачдын эрдэм шинжилгээний бүтээлүүд, тайлан, статистик мэдээллийг судалж, ашигласан болно. Үүнд:

а) Хууль тогтоомж, олон улсын гэрээ, бусад эрх зүйн акт

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
- Патентийн тухай хууль, 2006.
- Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах, бүртгэх журам батлах тухай, Шадар сайдын 2006 оны 57 тоот тушаал.
- Дэлхийн оюуны өмчийн байгууллага байгуулах тухай конвенци, 1978.
- Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенци, 1983.
- Бүтээгдэхүүний загварын олон улсын хадгалалтын тухай Гаагийн хэлэлцээр, 1999.
- Патентийн хамтын ажиллагааны гэрээ, 1970.
- Бүтээгдэхүүний загварын олон улсын ангилал тогтоох тухай Локарногийн хэлэлцээр, 1968.
- Дэлхийн худалдааны байгууллагын Оюуны өмчийн эрхийн худалдаанд хамаарах хэлэлцээр, 1994.
- Патентный закон Российской Федерации, 1992.

б) Судалгаа, тайлан, эмхэтгэл

- “ОӨУБЕГ-ын аж үйлдвэрийн өмчийн эрхийн газрын үйл ажиллагааны тайлан, 2010-2016 он.

хууль зүйн ухаарын сайдын www.mn.gov.mn

- Оюуны өмч улсын бүргэлийн ерөнхий газрын Аж үйлдвэрийн өмчийн эрхийн газар, “Патентийн сангийн мэдээлэл (1963-1999, 2000-2016 он)”, УБ., 2016.
- ОӨУБЕГ-ын Аж үйлдвэрийн өмчийн эрхийн газар, “Патентийн хамтын ажиллагааны гэрээний дагуу мэдүүлсэн шинэ бүтээлийн статистик”, УБ., 2016.

в) Ном, сэтгүүл, гарын авлага

- Батбаяр, Б., Мөнхжаргал, Т. Бүгд найрамдах хятад ард улсын оюуны өмчид холбогдох хууль тогтоомжийн эмхэтгэл, УБ., 2012.
- Намжил, З. Патент-эрх зүйн оньс, УБ., 2000.

г) Цахим эх сурвалж

- http://chinalawinfo.ru/civil_law/law_patent/law_patent_ch1
- https://ru.wikipedia.org/wiki/%D0%9F%D0%B0%D1%82%D0%B5%D0%BD%D1%82
- http://www.consultant.ru/document/Cons_doc_LAW_979/a75ec5ec4892bac64bbb1b5246d09cf5a8c2f31f/
- http://www.consultant.ru/document/Cons_doc_LAW_979/5b89bee4ebb4f1a10ba2412012a14bf4c8ec02c6/

Ярилцлагын арга: Патентийн тухай хуулийн хэрэгжилтийн бодит байдал, тулгамдаж буй бэрхшээл, нийгэмд үзүүлж буй эерэг болон сөрөг нөлөөллийн асуудлыг тодруулахаар патент эзэмшигчид, эрдэмтэн судлаачид, Оюуны өмч улсын бүртгэлийн ерөнхий газар (цаашид ОӨУБЕГ гэх)-ын Аж үйлдвэрийн өмчийн эрхийн газрын ажилтнууд, компанийн төлөөлөл, бие даасан итгэмжлэгдсэн төлөөлөгчидтэй тус тус ганцаарчилсан ярилцлага хийсэн.

Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах, шүүлт хэрхэн хийгддэг тухай баримт мэдээлэл авахаар Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид болон ОӨУБЕГ-ын Аж үйлдвэрийн өмчийн эрхийн газрын ажилтнуудын төлөөлөлтэй бүлгийн ярилцлагыг хийсэн. Судалгаанд оролцогчдыг зургаар дүрслэн харуулбал:

Зураг 1. Судалгаанд оролцогчдын байдал (хувиар)



Судалгааны анхдагч мэдээллийг тухайн салбарт ажилладаг болон компанийн төлөөлөл, энэ чиглэлээр өмгөөлөл, судалгаа, шинжилгээний ажил хийдэг эрдэмтэн, судлаачид, патент эзэмшигч, салбарын мэргэжилтнүүдээс авсан тул илүү бодитой, найдвартай байдлыг хангаж чадна гэж үзсэн болно.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Судалгааны баг үнэлэх үе шатны ажлыг дараах дарааллаар хийж гүйцэтгэв. Үүнд:

1.Хэрэгжүүлэх үе шатанд **цуглуулсан мэдээллийг** холбогдох аргачлалын 5.1.1, 5.2-т заасны дагуу үнэлэх;

2. Уг аргачлалын 5.3-т заасны дагуу сонгосон **шалгуур үзүүлэлт** болон **харьцуулах** (тохиолдол) хэлбэрийг ашиглан хуулийн Хоёрдугаар бүлэгт үнэлгээ хийх.

Хэрэгжүүлэх үе шатанд 5 ангилалд хамаарах 19 төрлийн мэдээлэл цуглуулсан ба тэдгээр материал (Судалгааны эх сурвалжийн жагсаалтаас харна уу)-ыг үнэлгээний хүрээнд “хамааралтай” бөгөөд “шаардлагатай” гэж үзсэн болно.

Үнэлгээг сонгосон шалгуур үзүүлэлтийг ашиглан хийсэн ба судалгааны хүрээнд хамаарсан Хоёрдугаар бүлгийн хэрэгжилт дараах байдалтай байна.

3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

<u>Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1.</u> **7 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ?**

7 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах

7.1.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийг зохиогч, түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн, хуулийн этгээд оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.

/*<u>Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан</u>*/

7.2.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар бүрд тусдаа мэдүүлэг гаргах бөгөөд нэг зориулалттай, нэгдмэл байдлаар ашиглагдах шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварт нэг мэдүүлэг гаргаж болно.

7.3.Шинэ бүтээлийн мэдүүлэг нь өргөдөл болон дараах агуулга бүхий шинэ бүтээлийн тодорхойлолт, томъёолол, товч тайлбараас бүрдэх бөгөөд шаардлагатай бол өргөдөлд холбогдох зураг, болон эрх бүхий байгууллагын магадлагааг хавсаргана:

7.3.1.шинэ бүтээлийн тодорхойлолт нь шинэ бүтээлээр дэвшүүлсэн зорилгод хүрэхэд тухайн шийдлийн өмнөх техник, технологийн түвшингээс онцгой ялгарах шинж чанар, хамаарах салбарын мэргэжлийн хэрэглэгчдэд түүний давуу байдал болон шинэ бүтээлийг ашиглах хамгийн тохиромжтой аргыг хангалттай, бүрэн ойлгомжтой гаргасан цогц мэдээллийг агуулна;

7.3.2.шинэ бүтээлийн томъёолол нь тухайн шинэ бүтээлийн онцгой ялгарах шинж чанар, эрхийн хамгаалалтын хүрээг тогтоосон, ойлгомжтой, товч, тодорхой байх бөгөөд нэг шинэ бүтээл нь нэг буюу хэд хэдэн томъёололтой байж болно;

7.3.3.тодорхойлолт, зураг нь томъёоллын агуулгыг дэлгэрэнгүй тайлбарлана;

7.3.4.товч тайлбар нь тухайн шинэ бүтээлийн талаар мэдээлэл өгөх зорилготой бөгөөд түүнийг шинэ бүтээлийн эрхийн хамгаалалтын хүрээг тогтооход ашиглахгүй.

7.4.Бүтээгдэхүүний загварын мэдүүлэг нь өргөдөл, бүтээгдэхүүний загварын зураг, тодорхойлолтоос бүрдэх бөгөөд шаардлагатай бол зураг, тодорхойлолтод холбогдох бусад материалыг хавсаргана.

7.5.Ашигтай загварын мэдүүлэг нь өргөдөл, тодорхойлолт, томъёолол, тайлбар, зургаас бүрдэх бөгөөд ашигтай загварын томъёолол нь уг шийдлийн ялгарах шинжийг тодорхойлж, эрхийн хамгаалалтын хүрээг тогтооно.

7.6.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын өргөдөлд шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар зохиогч, мэдүүлэг гаргагч, тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр, хаяг, патент авах хүсэлт, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын нэрийг тусгана.

7.7.Зохиогч бус этгээд мэдүүлэг гаргах бол патент, гэрчилгээ авах эрхээ нотолсон баримтыг хавсаргана.

7.8.Хүн амын хүнсний хангамж, эрүүл ахуйтай холбогдсон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын тухайд хүний эрүүл мэнд, биед хохирол учруулахгүйг нотолсон эрүүл ахуй, халдвар судлалын байгууллагын магадлагаа, тодорхойлолтыг хавсаргана.

Хуулиар зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

7.9.Мэдүүлэг гаргагч өргөдөлдөө үндэсний, бүсийн, олон улсын мэдүүлгийн огноог давамгайлах огноогоор тогтоолгох тухай хүсэлтээ илэрхийлж болох бөгөөд энэ тохиолдолд давамгайлах огноо хүсэж гаргасан мэдүүлгийн хуулбарыг хавсаргана.

7.10.Давамгайлах огноо тогтоолгох хүсэлт гаргахад шинэ бүтээл, ашигтай загварын мэдүүлэгт олон улсын хайлт, урьдчилсан шүүлтийн дүгнэлтийг хавсаргана.

7.11.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэгт үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

7.12.Мэдүүлэг гаргагч нь итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлж болно.

7.13.Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх, үүргийг Иргэний хуульд заасан шаардлага хангасан итгэмжлэлээр тодорхойлно.

7.14.Мэдүүлгийг монгол хэлээр үйлдэх бөгөөд өөр хэлээр үйлдсэн тохиолдолд мэдүүлэг гаргагч оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад уг мэдүүлгийг ирүүлсэн өдрөөс хойш 2 сарын дотор монгол хэлнээ хөрвүүлж өгнө.

/*Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан*/

7.15.Энэ хуулийн 7.14-т заасан хугацаанд мэдүүлгийг хөрвүүлж өгөөгүй бол мэдүүлэг гаргаагүй гэж үзнэ.

7.16.Олон улсын нэг ангилалд хамаарах адил төстэй 50 хүртэл бүтээгдэхүүний загварыг нэг мэдүүлгээр мэдүүлж болно.

7.17.Мэдүүлэг гаргагч мэдүүлгийн талаар эцсийн шийдвэр гарах хүртэлх хугацаанд мэдүүлгээ буцаан авч болно.

Үнэлгээ:

Тус хуулийн 7 дугаар зүйлээр шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах харилцааг зохицуулсан. Энэ зорилгыг хэрэгжүүлснээр зохион бүтээгч бүтээлээ хамгаалуулах эхний үе шат бүрдэж байгаа юм.

Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах, бүртгэхэд тавигдах шаардлагыг журмаар[3] зохицуулж өгсөн байдаг. Мэдүүлэг гаргагчийн бүрдлийн шаардлагад тавигдах нөхцөл нь бүрхэг, ойлгомжгүй байдаг учраас хуульд заасан хугацаа хэтэрсэн тохиолдолд мэдүүлэг гаргаагүй гэж үздэг байна. Тухайлбал, 2016 онд шинэ бүтээлийн 93 мэдүүлэгт нэмэлт засвар хийж ирүүлэх мэдэгдэл хүргүүлж, **үүнээс мэдүүлэг гаргаагүйд тооцсон 19 мэдүүлэг байна. Ө.х. нийт мэдүүлгийн 40 гаруй хувьд засвар хийж ирүүлэх мэдэгдэл хүргүүлсэн ба эдгээр мэдүүлэг нь бүгд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулаагүй шууд мэдүүлсэн дотоодын мэдүүлэг байна. Сүүлийн таван жилийн байдлыг судалж үзэхэд нэмэлт засвар хийж ирүүлэх мэдэгдлийг шинэ бүтээл болон ашигтай загварын мэдүүлгийн 40-45 хувьд хүргүүлж байна.**[4]

Хууль, журамд мэдүүлгийг ямар үндэслэлээр татгалзаж байгаа нь мөн тодорхой бус байна.

Дээрх тохиолдолд эрхээ хамгаалуулах гэхээр гол баримтлах зүйл, процедур нь хуулинд бус журамд тусгасан байдаг учраас зохион бүтээгч хохирох эрсдэлтэй болж зохион бүтээгч, бизнес эрхлэгчид эрхээ хамгаалахад хүндрэлтэй болж байгаа нь хуулийн зорилгодоо нийцэхүйц байж чадахгүйд хүрч байна.

ШИГТГЭЭ 1.

2006 оны Патентийн тухай хууль нь техникийн төвшин тогтоосон зүйлийг хуулинд биш журамдаа оруулчихдаг.

Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчидтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас.

[3] Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах, бүртгэх журам батлах тухай, Шадар сайдын 2006 оны 57 тоот тушаал.

[4] ОӨУБЕГ-ын Аж үйлдвэрийн өмчийн эрхийн газрын статистик мэдээ.

Хуулийн 7.1 дэх хэсэгт шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварыг хуулийн нэг зүйл, заалтад оруулж мэдүүлэг гаргахаар зохицуулсан байна. Гэтэл бүтээгдэхүүний загварын зохицуулалт нь мөн чанараараа шинэ бүтээл, ашигтай загвараас өөр байдаг учраас зохицуулах зүйл нь ч уялддаггүй байна. Хуулиар шинэ бүтээл, ашигтай загвар гэсэн бие даасан гурван объектыг нэг зүйлд хамтатган зохицуулж байгаа нь, мөн түүнчлэн зохиогч, түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн хуулийн этгээд гэж нарийвчлан заах нь зарим талаар хязгаарлалт үүсгэж[5] байгаа нь энэ харилцааг зохицуулахад хүндрэлтэй байна.

Хуулийн 7.7 дахь хэсэг хоёрдмол утгыг агуулж байна. Нэг талаас мэдүүлэг гаргагч патент авах эрхтэй байх албагүй байдаг байна. Нөгөө талаас хэрэв патент эзэмших эрх шилжүүлэлт гэж үзвэл тусгай зүйлээр, объект бүр дээр тус тусдаа заалттай байх ёстой гэсэн утга санааг илэрхийлж байна.

Мөн хуулийн 7.8-д Оюуны Өмчийн газар нь мэдүүлэг гаргасан бүтээлийг үйлдвэрлэхэд зөвшөөрөл өгдөг, шинжилж судлаад хортой, хоргүй гэдгийг тогтоодог мэтээр төөрөгдөл үүсгэхээр зохицуулагдсан байна. Хуулиар бол Оюуны өмчийн газар шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар нь цоо шинэ болохыг тодорхойлдог.

Мөн түүнчлэн зохион бүтээгчээс үйлдвэрлэлд нэвтрээгүй байгаа бүтээлийн магадлагаа, тодорхойлолтыг түрүүлж гаргуулах боломжгүй юм. Иймд мэдүүлгийн бүрдэлд тавигдах шаардлагыг хангаж чадахуйц биш байгаа юм.

Хуулийн 7.10-т “Давамгайлах огноо тогтоолгох хүсэлт гаргахад шинэ бүтээл, ашигтай загварын мэдүүлэгт олон улсын хайлт, урьдчилсан шүүлтийн дүгнэлтийг хавсаргана.” гэж заасан байгаа. Аливаа улсын үндэсний байгууллагад гаргасан мэдүүлгийг олон улсын хайлт, шүүлтээр оруулдаггүй зөвхөн Патентийн хамтын ажиллагааны гэрээний дагуу гаргасан олон улсын мэдүүлэгт л олон улсын хайлт, шүүлт хийгддэг байна. Гэхдээ Патентийн хамтын ажиллагааны дагуу гаргасан мэдүүлэгт олон улсын хайлт, шүүлтийн тайлан хавсаргахыг шаардахыг Патентийн хамтын ажиллагааны гэрээгээр хоригложээ.

...Мэдүүлэг гаргагч хүсвэл хайлт, шүүлт хийлгэхгүй байж болдог. Тиймээс хийлгээгүй зүйлийг үндэсний байгууллагаас шаардаж болохгүй юм.[6]

Хуулийн 7.17-д “мэдүүлэг гаргагч мэдүүлгээ буцаан авч болно” гэж байгаа боловч хэзээ, хэрхэн, яаж буцаан авах тухай хуулийн зохицуулалт байхгүй байна. Түүнээс гадна уг заалтыг хоёр өөрөөр тайлбарлаж байна.

Жишээ нь: Өргөдлөө эргүүлэн татаж болно гэсэн үг юм. Тэрнээс биш материалаа авч болно гэсэн үг биш. Тухайлбал, тухайн хүн өргөдөл өгчихөөд батлуулахаа болилоо гэсэн тэр л хүсэлтийг хэлж байгаа юм.[7]

Өнөөгийн байдлаар мэдүүлэг гаргагч мэдүүлгээ буцаан авч болдоггүй, патентийн хайлт, шүүлтийг үргэлжлүүлээд хийдэг.[8]

[5] Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчидтэй хийсэн ярилцлага, 2017 оны 7 дугаар сар.

[6] Ярилцлагын судалгаа, 2017 оны 7 дугаар сар.

[7] Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй хийсэн ярилцлага, 2017 оны 7 дугаар сар.

[8] Фокус бүлгийн ярилцлагын судалгаа, 2017 оны 7 дугаар сар.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

ШИГТГЭЭ 2.

Эх материалыг буцааж өгдөггүй юм аа. Хэдийгээр патент хамгаалагдаагүй ч гэсэн дараа нь тухайн хүний хийсэн технологи магадгүй ямар нэгэн байдлаар материалаа дутуу өгснөөс болж авч чадаагүй байж болноо доо. Гэтэл дараагийн хүн ийм технологийг хаа нэг газар хэрэглэсэн байж болно. Тухайн хүн өөрийн зохион бүтээсэн технологио хамгаалах гэхээр эх материалыг буцааж өгөөгүй болохоор юу барьж зарга хийх билээ?

Итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй хийсэн ярилцлага

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. Хуулийн 8 дугаар зүйл буюу шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийг цахим хэлбэрээр гаргах зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ?

8 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийг цахим хэлбэрээр гаргах

8.1.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийг мэдүүлэг гаргагч цахим хэлбэрээр гаргаж болох бөгөөд энэ тохиолдолд мэдүүлэг нь энэ хуулийн 7 дугаар зүйл, оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан журамд заасан шаардлага хангасан байна.

/*Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан*/

8.2.Энэ хуулийн 8.1-д заасан мэдүүлгийг уян диск болон мэдээллийн цахим хэлбэрийн бусад хэрэгслээр ирүүлж болно.

8.3.Цахим хэлбэрээр ирүүлсэн мэдүүлгийн анхдагч огноог тухайн мэдүүлэг энэ хуульд заасан шаардлагыг хангасан бөгөөд шаардлагатай баримтуудыг хавсаргасан нөхцөлд хүлээн авсан холбогдох ажилтны гарын үсэг, дугаар бүхий баримтыг үндэслэн тогтооно.

8.4.Цахим хэлбэрээр ирүүлсэн мэдүүлэгтэй холбоотой шийдвэрийг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага цахим хэлбэрээр хүргүүлж, тус газрын дарга цахим гарын үсэг хэрэглэж болно.

/*Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан*/

Үнэлгээ:

Хуулиар энэ төрлийн үйлчилгээг зохион бүтээгч, мэдүүлэг гаргагчдад цаг хэмнэж шуурхай хүргэхийн тулд бүртгэлийн үйлчилгээнд нэвтрүүлэхээр зорьсон байна. Гэвч зохицуулалтад найруулгын алдаа гарсан, нөгөө талаар хэрэгжүүлэх дүрэм, журам байхгүй нь мэдүүлгийг цахим хэлбэрээр гаргах боломжгүй болоход хүргэж байна. Одоогоор энэхүү заалт хэрэгжсэнээс хойших хугацаанд ОӨУБЕГ-ын Аж үйлдвэрийн өмчийн эрхийн газарт цахим хандалт ирсэн тохиолдол нэг ч гараагүй байна.

Гэхдээ 8 дугаар зүйлийг шинэчлэн найруулснаар зорилгодоо хүрэх боломжтой.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 3. Хуулийн 9 дүгээр зүйл буюу Патентийн хамтын ажиллагааны гэрээний дагуу олон улсын мэдүүлэг гаргах зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ?

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

9 дүгээр зүйл. Патентийн хамтын ажиллагааны гэрээний дагуу олон улсын мэдүүлэг гаргах

9.1.Монгол Улсыг нэр зааж гаргасан шинэ бүтээл, ашигтай загварын олон улсын мэдүүлгийн анхдагч огноог энэ хуулиар, эсхүл Патентийн хамтын ажиллагааны гэрээний дагуу бүртгүүлсэн олон улсын байгууллагын бүртгэлийн огноогоор тогтооно.

9.2.Монгол Улсын иргэн болон Монгол Улсад оршин суудаг гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний гаргасан олон улсын мэдүүлгийн хувьд хүлээн авагч байгууллага нь оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллага байна.

/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

9.3.Мэдүүлэг гаргагч олон улсын мэдүүлгийг хүлээн авагч байгууллагад гэрээнд заасан хэл дээр гаргаж, хураамж төлнө.

9.4.Мэдүүлэг гаргагч нь олон улсын мэдүүлэгтээ Монгол Улсын нутаг дэвсгэр дээр шинэ бүтээлийн патент, ашигтай загварын гэрчилгээ авахаар Монгол Улсыг нэр заасан бол оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь нэр заагдсан байгууллага болно.

/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

9.5.Мэдүүлэг гаргагч нь олон улсын мэдүүлэгтээ олон улсын урьдчилсан магадлан шүүлт хийлгэхээр Монгол Улсыг сонгосон бол оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгогдсон байгууллага болно.

/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

9.6.Сонгогдсон байгууллага нь мэдүүлэгт хийх урьдчилсан магадлан шүүлтийн тайланг гэрээнд заасан хугацаанд хүлээж авна.

9.7.Монгол Улсыг сонгосон олон улсын мэдүүлгийн хувьд мэдүүлэг гаргагч Патентийн хамтын ажиллагааны гэрээнд заасны дагуу урьдчилсан магадлан шүүлт хийж эхлэхээс өмнө хураамж төлнө.

9.8. оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олон улсын мэдүүлэгт хийх бүх үйл ажиллагааг холбогдох хууль, гэрээ, журмын дагуу гүйцэтгэнэ.

/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

Үнэлгээ:

Хуулийн 9 дүгээр зүйлд “Патентийн хамтын ажиллагааны гэрээний дагуу олон улсын мэдүүлэг гаргах зохицуулалт нь нэгдэн орсон Патентийн хамтын ажиллагааны гэрээ (PCT)-гээ зөрчиж байна гэж хэлж болохоор байна. Иймд уг зохицуулалт нь энэ найруулгаар зорилгодоо хүрэх байдлыг бууруулж байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 4. Хуулийн 10 дугаар зүйл буюу “шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийн анхдагч огноо тогтоохтой холбоотой зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ?

Уг зүйл 5 хэсэгтэй (10.1-10.5) бөгөөд эдгээрт шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийн **анхдагч огноог** тогтоохтой холбоотой зохицуулалтууд тусгагдсан байна. Үүнд:

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nlrc.gov.mn

10 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийн анхдагч огноог тогтоох

10.1. оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлэг хүлээн авсан өдрөөс хойш 2О, ашигтай загварын мэдүүлэг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор түүний бүрдлийг хянаж, энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан шаардлагад нийцсэн бөгөөд **мэдүүлгийн бүрдэл хангасан** гэж үзвэл анхдагч огноог мэдүүлэг хүлээн авсан өдрөөр тооцно.

10.2. оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мэдүүлгийг энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй гэж үзвэл түүнд нэмэлт, засвар хийх шаардлагатайг мэдүүлэг гаргагчид мэдэгдэнэ.

10.3.Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 10.2-т заасан мэдэгдлийг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүлээн авсан өдрөөс хойш шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлэгт 3 сар, ашигтай загварын мэдүүлэгт 1 сарын дотор нэмэлт, засвар хийж ирүүлсэн тохиолдолд тухайн мэдүүлгийн анхдагч огноог мэдүүлгийг анх хүлээн авсан өдрөөр тооцно.

10.4.Энэ хуулийн 10.3-т заасан хугацааны дотор нэмэлт, засвар хийж ирүүлээгүй бол тухайн мэдүүлгийг гаргаагүй гэж үзнэ.

10.5.Мэдүүлэг гаргагч давамгайлах огнооны эрх хүсэж байгаа бол мэдүүлгийг бүртгэснээс хойш 2 сарын дотор энэ тухайгаа бичгээр мэдэгдэж, анхны мэдүүлгийн хуулбарыг ирүүлнэ.

Үнэлгээ:

Патентийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд хуулийн **үндсэн зорилтыг** “шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар зохиогч болон патент, гэрчилгээ эзэмшигчийн өмчлөх эрхийг баталгаажуулах, шинэ бүтээл бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг **ашиглахтай** холбогдсон харилцааг зохицуулахад оршино” хэмээн томъёолсон байна. Иймээс 10 дугаар зүйлийн зохицуулалт бүхэлдээ энэхүү зорилтыг хангахад чиглэсэн байх учиртай.

Энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан **шаардлагад** нийцсэн бөгөөд **мэдүүлгийн бүрдэл** хангасан гэж үзвэл **анхдагч огноог мэдүүлэг хүлээн авсан өдрөөр тооцно** хэмээн тус хуулийн 10.1-д заасан. Уг заалт нь Олон улсын гэрээтэй нийцэж байгаа бөгөөд хуулийн үндсэн зорилтыг хангахад чиглэсэн нилээд чухал зохицуулалт юм.

Мэдүүлгийн **анхдагч огноог үндэслэлтэй тогтоох нь** аж үйлдвэрийн өмчийн эрхийн хамгаалалт эхлэх хугацааг тодорхойлж байна гэсэн үг бөгөөд энэ хуульд зааснаар шинэ бүтээлд 20 жил, бүтээгдэхүүний загварт 10 жил, ашигтай загварт 7 жилийн хугацаатайгаар патент олгодог.

Түүнчлэн энэхүү зүйлийн 10.2, 10.3-т мэдүүлэг хүлээн авагч байгууллага тухайн мэдүүлгийг энэ хуульд заасан шаардлага (7 дугаар зүйл)-ыг хангаагүй гэж үзвэл мэдүүлэг гаргагчид энэ тухай мэдэгдэж, нэмэлт засвар хийх хугацаа олгохоор тусгасан, 10.5-д давамгайлах огноо хүсэх хугацааг заасан зэрэг нь уг хуулийн зорилтыг хангахад зайлшгүй шаардлагатай зохицуулалтууд болсон байна. Иймд эдгээр зохицуулалтууд хуулийн хэрэгжилтэд бүхэлдээ **эерэг** нөлөө үзүүлж байна гэж үнэлэх үндэслэлтэй байна.

<u>Шалгуур үзүүлэлтийн томъёолол 5.</u> Хуулийн 11 дүгээр зүйл буюу “шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлэгт шүүлт хийхтэй холбоотой зохицуулалт” зорилгодоо хэр хүрсэн бэ?

Уг зүйл 12 хэсэг (11.1-11.12)-тэй бөгөөд эдгээрт шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлэгт **шүүлт** хийхтэй холбоотой зохицуулалтууд тусгагдсан байна. Үүнд:

11 дүгээр зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлэгт шүүлт хийх

11.1.Мэдүүлгийн анхдагч огноог тогтоосны дараа оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шинжээч тухайн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар энэ хуулийн 4, 5 дугаар зүйлд заасан шалгуурыг хангасан эсэхэд мөн чанарын шүүлт хийнэ.

11.2.Мэдүүлэг гаргагч мэдүүлсэн шинэ бүтээл, эсхүл түүнтэй мөн чанараараа ижил бүтээлд патент буюу өөр ямар нэг эрхийн баримт авахаар гадаадын улс, олон улсын байгууллагад мэдүүлэг гаргасан тухайгаа оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

11.3.Шүүлт хийх явцад буюу эцсийн шийдвэр гарахаас өмнө мэдүүлэг гаргагч анхныхаа ирүүлсэн тодорхойлолтын агуулгын хүрээнээс халихгүйгээр, мэдүүлэгтээ нэмэлт, өөрчлөлт хийж болно.

11.4.Нэмэлт, өөрчлөлт нь мэдүүлж байгаа шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мөн чанарыг өөрчлөх бол шинээр мэдүүлэг гаргана.

11.5.Мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр шүүлт хийхийг хойшлуулж болох боловч шүүлт хийхийг хойшлуулах хугацаа нь энэ хуулийн 11.9, 11.10-т заасан хугацаагаар хязгаарлагдана.

11.6.Шүүлт хийх явцад мэдүүлэг гаргагч анхныхаа ирүүлсэн тодорхойлолтын агуулгын хүрээнээс халихгүйгээр мэдүүлгээ 2 буюу түүнээс олон мэдүүлэг болгон салгах, эсхүл хамтаар ашиглагдах шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын хэд хэдэн мэдүүлгийг нэгтгэж болно.

11.7.Энэ хуулийн 11.6-д заасан тохиолдолд мэдүүлгийн анхдагч огноо буюу давамгайлах огноог анхны мэдүүлгээр тогтооно.

11.8.Шинэ бүтээлээр дэвшүүлсэн шийдлийн зохиогч мэдүүлгийг эцсийн шийдвэр гарахаас өмнө ашигтай загварын мэдүүлэг болгон, ашигтай загварын гэрчилгээ хүссэн мэдүүлгийг шинэ бүтээлийн мэдүүлэг болгон тус тус өөрчилж болох бөгөөд энэ тохиолдолд анхдагч огноог анхны мэдүүлгээр тогтооно.

11.9. оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мэдүүлгийн анхдагч огнооноос хойш 9 сарын дотор шүүлтийн дүгнэлтийг үндэслэн патент олгох эсэх талаар шийдвэр гаргана.

11.10.оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 11.9-д заасан хугацааг 12 сар хүртэл хугацаагаар сунгаж болно.

11.11.Патент олгохоор шийдвэрлэсэн шинэ бүтээлийн ном зүй, томъёолол, бүтээгдэхүүний загварын зургийг патентийн хэвлэлд нийтэлж зарлана.

11.12.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар болох нь нотлогдоогүй, хамгаалах боломжгүй бол патент олгохоос татгалзсан шийдвэр гаргах бөгөөд шүүлтийн дүгнэлтийн хуулбарыг уг дүгнэлт гарсан өдрөөс хойш ЗО хоногийн дотор мэдүүлэг гаргагчид хүргүүлж, мэдүүлгийг патентийн санд хадгална.

Үнэлгээ:

Патентийн хуулийн зорилт нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварт эрхийн хамгаалалт хийж, ашиглалтыг нь дэмжихэд оршдог бөгөөд энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд 11 дүгээр зүйлийн зохицуулалт чухал нөлөөтэй. Учир нь мэдүүлгийн анхдагч огноог тогтоосны дараа тухайн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар хуульд заасан шалгуурыг хангаж буй эсэхэд шинжээч мөн чанарын шүүлт хийдэг ба үүнийг нилээд чухал ажиллагаа гэж үздэг байна.

Түүнчлэн уг зүйлийн 11.1-д шинжээч тухайн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар энэ хуулийн 4 болон 5 дугаар зүйлд заасан шалгуурыг хангасан эсэхэд мөн чанарын шүүлт хийхээр, 11.3-т мэдүүлэг гаргагч шүүлт хийх явцад мэдүүлэгтээ өөрчлөлт (анхны тодорхойлолтын агуулгаас халихгүй) оруулж болохоор, 11.6-д мэдүүлэг гаргагч мэдүүлгээ салгаж эсхүл нэгтгэж болохоор, 11.8-д зохиогч дэвшүүлсэн шийдлийнхээ объектыг өөрчилж болохоор, 11.11-д патент олгох шийдвэрт холбогдох материалыг патентийн хэвлэлд нийтлэх талаар, 11.12-т патент олгохоос татгалзах үндэслэл болон мэдүүлэг гаргагчид энэ тухай мэдээлж

байхаар тус тус заасан байна. Эдгээрийг энэхүү хуулийн зорилтыг хангахад **эерэг нөлөө** үзүүлж буй чухал зохицуулалтууд гэж үнэлж болохоор байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 6. Хуулийн 12 дугаар зүйл буюу ашигтай загварын мэдүүлэгт магадлан шүүлт хийхтэй холбоотой зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ?

Уг зүйл 2 хэсэг (12.1-12.2)-тэй бөгөөд уг хэсэгт ашигтай загварт **магадлан шүүлт** хийхтэй холбоотой хоёр зохицуулалт тусгагдсан байна. Үүнд:

12 дугаар зүйл. Ашигтай загварын мэдүүлэгт магадлан шүүлт хийх

12.1.Мэдүүлгийн анхдагч огнооноос хойш 1 сарын дотор энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан эсэх, ашигтай загвараар бүртгэгдэх боломжтой эсэхэд шинжээч магадлан шүүлт хийж дүгнэлт гаргана.

12.2.Ашигтай загварын мэдүүлэгт шүүлт хийхэд энэ хуулийн 11.2, 11.3-т заасныг нэгэн адил мөрдөнө.

Үнэлгээ:

Уг зүйлийн 12.1-д ашигтай загварын мэдүүлэгт **магадлан шүүлт** хийх хугацааг тодорхойлсон нь хуулийн хэрэгжилтийг хангахад зайлшгүй шаардлагатай зохицуулалт боловч энэхүү хугацааг яагаад ийм богино (1сар) байхаар тогтоосон, хуулийн 11 дүгээр зүйлийн зохицуулалтад “ашигтай загвар”-ын мэдүүлэгт шүүлт хийх асуудал хамраагүй байтал уг зүйлийн 11.2, 11.3-ыг ишлэл болгосон зэрэг нь учир дутагдалтай байна. Иймээс энэхүү зүйл нь хуулийн хэрэгжилтийг хангахад эерэг нөлөө үзүүлэх магадлал муутай болжээ.

3.2.“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Хуулийн 7 дугаар зүйл буюу шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах зохицуулалт практикт нийцэж байна уу, хуулийн хэрэгжилтэд тулгарч байгаа хүндрэл, түүний үр дагавар юу вэ?

Хуулийн нэгдсэн хүрээлэн www.nli.gov.mn

7 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах

7.1.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийг зохиогч, түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн, хуулийн этгээд оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.

/*Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан*/

7.2.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар бүрд тусдаа мэдүүлэг гаргах бөгөөд нэг зориулалттай, нэгдмэл байдлаар ашиглагдах шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварт нэг мэдүүлэг гаргаж болно.

7.3.Шинэ бүтээлийн мэдүүлэг нь өргөдөл болон дараах агуулга бүхий шинэ бүтээлийн тодорхойлолт, томъёолол, товч тайлбараас бүрдэх бөгөөд шаардлагатай бол өргөдөлд холбогдох зураг, болон эрх бүхий байгууллагын магадлагааг хавсаргана:

7.3.1.шинэ бүтээлийн тодорхойлолт нь шинэ бүтээлээр дэвшүүлсэн зорилгод хүрэхэд тухайн шийдлийн өмнөх техник, технологийн түвшингээс онцгой ялгарах шинж чанар, хамаарах салбарын мэргэжлийн хэрэглэгчдэд түүний давуу байдал болон шинэ бүтээлийг ашиглах хамгийн тохиромжтой аргыг хангалттай, бүрэн ойлгомжтой гаргасан цогц мэдээллийг агуулна;

7.3.2.шинэ бүтээлийн томъёолол нь тухайн шинэ бүтээлийн онцгой ялгарах шинж чанар, эрхийн хамгаалалтын хүрээг тогтоосон, ойлгомжтой, товч, тодорхой байх бөгөөд нэг шинэ бүтээл нь нэг буюу хэд хэдэн томъёололтой байж болно;

7.3.3.тодорхойлолт, зураг нь томъёоллын агуулгыг дэлгэрэнгүй тайлбарлана;

7.3.4.товч тайлбар нь тухайн шинэ бүтээлийн талаар мэдээлэл өгөх зорилготой бөгөөд түүнийг шинэ бүтээлийн эрхийн хамгаалалтын хүрээг тогтооход ашиглахгүй.

7.4.Бүтээгдэхүүний загварын мэдүүлэг нь өргөдөл, бүтээгдэхүүний загварын зураг, тодорхойлолтоос бүрдэх бөгөөд шаардлагатай бол зураг, тодорхойлолтод холбогдох бусад материалыг хавсаргана.

7.5.Ашигтай загварын мэдүүлэг нь өргөдөл, тодорхойлолт, томъёолол, тайлбар, зургаас бүрдэх бөгөөд ашигтай загварын томъёолол нь уг шийдлийн ялгарах шинжийг тодорхойлж, эрхийн хамгаалалтын хүрээг тогтооно.

7.6.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын өргөдөлд шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар зохиогч, мэдүүлэг гаргагч, тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр, хаяг, патент авах хүсэлт, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын нэрийг тусгана.

7.7.Зохиогч бус этгээд мэдүүлэг гаргах бол патент, гэрчилгээ авах эрхээ нотолсон баримтыг хавсаргана.

7.8.Хүн амын хүнсний хангамж, эрүүл ахуйтай холбогдсон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын тухайд хүний эрүүл мэнд, биед хохирол учруулахгүйг нотолсон эрүүл ахуй, халдвар судлалын байгууллагын магадлагаа, тодорхойлолтыг хавсаргана.

7.9.Мэдүүлэг гаргагч өргөдөлдөө үндэсний, бүсийн, олон улсын мэдүүлгийн огноог давамгайлах огноогоор тогтоолгох тухай хүсэлтээ илэрхийлж болох бөгөөд энэ тохиолдолд давамгайлах огноо хүсэж гаргасан мэдүүлгийн хуулбарыг хавсаргана.

7.10.Давамгайлах огноо тогтоолгох хүсэлт гаргахад шинэ бүтээл, ашигтай загварын мэдүүлэгт олон улсын хайлт, урьдчилсан шүүлтийн дүгнэлтийг хавсаргана.

7.11.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэгт үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

7.12.Мэдүүлэг гаргагч нь итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлж болно.

7.13.Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх, үүргийг Иргэний хуульд заасан шаардлага хангасан итгэмжлэлээр тодорхойлно.

7.14.Мэдүүлгийг монгол хэлээр үйлдэх бөгөөд өөр хэлээр үйлдсэн тохиолдолд мэдүүлэг гаргагч оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад уг мэдүүлгийг ирүүлсэн өдрөөс хойш 2 сарын дотор монгол хэлнээ хөрвүүлж өгнө.

/*Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан*/

7.15.Энэ хуулийн 7.14-т заасан хугацаанд мэдүүлгийг хөрвүүлж өгөөгүй бол мэдүүлэг гаргаагүй гэж үзнэ.

7.16.Олон улсын нэг ангилалд хамаарах адил төстэй 50 хүртэл бүтээгдэхүүний загварыг нэг мэдүүлгээр мэдүүлж болно.

7.17.Мэдүүлэг гаргагч мэдүүлгийн талаар эцсийн шийдвэр гарах хүртэлх хугацаанд мэдүүлгээ буцаан авч болно.

Үнэлгээ:

Хуулийн 7 дугаар зүйл, заалт нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар гэх бие даасан гурван объектыг хуулийн нэг зүйл, заалтад оруулж мэдүүлэг гаргахаар зохицуулсан байгаа нь мэдүүлэг гаргагч уг нэр, объект хоорондын ялгааг тэр бүр ойлгохгүй, объектоо тодорхойлж чадахгүйгээс болж мэдүүлгийг сольж өгөх улмаар хугацаа алдах зэрэг асуудал, чирэгдэл дагуулж эхэлдэг байна.

Нөгөөтэйгүүр бүртгэлийн ажилтан мэдүүлгийн бүрдүүлэлтэд хэлбэрийн төдий шалгалт хийж анхдагч огноог тогтоогоод шинжээч рүү шилжүүлдэг байна. Ингэснээр шинжээч мэдүүлгийг стандарт шаардлагад (агуулга талаас) нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж тодорхой хугацаа алдсаны дараа (энэ хооронд хугацаа их зарцуулдаг) шаардлагын дагуу мэдүүлгээ бичиж ирүүлээгүй байна гэдэг дүгнэлт гаргаснаас үүдэж маргаан үүсэх нөхцөл болдог байна. Шинжээчийн үүрэг нь хайлт, шүүлт хийнэ, ижил төсөөтэй илэрцүүдийг гаргаж ирээд мөн чанарын шүүлтийг хийх ёстой байтал дүгнэлт нь хугацаа алдаж олон сарын дараа мэдүүлэг гаргагчид очдог. Энэ хооронд мөн л зөрчил, маргаан үүсдэг байна.

ШИГТГЭЭ 3.

Одоогийн байдлаар бол шинжээч нь бүртгэлийн ажилтны хийх ёстой ажлыг хийгээд байгаа юм. Агуулга дээр нь ажиллаж байгаа хэрэг. Мэдүүлэг гаргагч руу томъёололд чинь ийм юм алга байна, ийм шаардлага хангаагүй байна, тодорхойлолт чинь ийм юм дутуу байна гээд л хоорондоо бичилцээд байж байдаг. Шинжээч үндсэн ажлын хажуугаар бүрдлийн шаардлагыг давхар хянаж байгаа учраас хугацаа алдаж нилээн олон сарын дараа тэр мэдүүлэг гаргагч дээр очино. Энэ байдал нь үл ойлголцох байдалд хүргэдэг. Үүнийг зайлшгүй шийдэх ёстой асуудал мөн.

ОӨУБЕГ-ын Аж үйлдвэрийн өмчийн эрхийн газрын ажилтнуудтай хийсэн фокус бүлгийн ярилцлагаас.

Энэ ерөнхий дүр зургаас харвал бүрдлийн хяналт зохих шатандаа хийгдэхгүй байгаа нь бүрдлийн шинжээчийн орон зай орхигдоод байна гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, бүрдлийн шинжээч анхдагч огноо тогтоохоос өмнө тодорхойлолт томъёололоос нь хальсан эсвэл тодорхойлолтод байхгүй юмыг томъёолж уу, үгүй юу, нэр, орчуулга нь зөв хийгдэж үү... гэдгийг тогтоож бүрдлийг хянадаг байх ёстой юм. Энэ бүгд нь бүрдлийн шинжээчээс буцаж мэдүүлэг гаргагчиддаа эргэх холбоотой ажиллавал энэ дунд зөрчил гарахгүй байх бүрэн боломжтой. Ер нь тухайн хүнд өөрийнхөө мэдүүлгийг засах, хамгаалах боломж олгох ёстой юм. Гэтэл одоогийн хуулиар ямар ч боломжгүй, шууд татгалзахаар байгаа нь иргэн, зохион бүтээгч, бизнес эрхлэгчдэд хүндрэл, ойлгомжгүй байдлыг үүсгэх болсон байна.

Мөн хуулийн 7.1-д ...зохиогч, түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн, хуулийн этгээд гэж нарийвчилж өгсөн нь мэдүүлэг гаргагчийг төөрөгдөлд оруулдаг байна. Тухайлбал, анх ямар нэг зүйл сэдсэн зохион бүтээгч өөрийгөө зохиогч эсвэл зохион бүтээгч гэж ойлгодоггүй, ихэнхдээ “зохиогч, зохион бүтээгч нь тусгай мэргэшсэн мундаг инженер байна” гэж ойлгодог, үүний адилаар эрх шилжүүлэн авагч гэдгийг бүр ч ойлгодоггүй, ямар нэгэн байгууллагаас эрх авсны дараа мэдүүлэг гаргах хэрэгтэй юм байна гэж ойлгодог.[9] Хуульд хязгаарлалт тогтоосон нь бүртгэлийн ажиллагаанд мөн хүндрэл үүсгэдэг байна.

Хуулийн 7.8-д “Хүн амын хүнсний хангамж, эрүүл ахуйтай холбогдсон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын тухайд хүний эрүүл мэнд, биед хохирол учруулахгүйг нотолсон эрүүл ахуй, халдвар судлалын байгууллагын магадлагаа, тодорхойлолтыг хавсаргана.” гэсэн энэхүү хэсэг нь амьдрал дээр хэрэгжих боломж тааруу байдаг байна. Тухайлбал:

[9] Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчидтэй хийсэн ярилцлагын судалгаа, 2017 он.

ШИГТГЭЭ 4.

Үйлдвэрлэл эхлээгүй байгаа эмийн бодис эсвэл ундаа гэх мэтийн хувьд энэ магадлагаа тодорхойлолтыг гаргуулгах боломж байхгүй.

Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй хийсэн ярилцлагаас.

ШИГТГЭЭ 5.

Огт үйлдвэрлэгдээгүй ундааны тодорхойлолтыг хаанаас авах вэ? ...энэ тохиолдолд лабораторийн шинжилгээг аваад ирдэг.

Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй хийсэн ярилцлагаас.

Хуулиар техникийн түвшинг нь тогтоогоод зохион бүтээгч шинэ зүйл сэдсэн учраас эрхийг хамгаална. Харин бүтээл нь үйлдвэрлэгдсэн бол түүнийг шинжилдэг, судалдаг тусдаа мэргэжлийн байгууллагууд байдаг.

Хуулийн 7.17-д “мэдүүлэг гаргагч мэдүүлгээ буцаан авч болно” гэж байгаа. Харин амьдрал дээр хэрэгжихдээ нэгэнт мэдүүлэг гаргасан бол буцаан авч болдоггүй бөгөөд үргэлжлүүлээд хайлт, шүүлт хийдэг байна.

Практикт мэдүүлэг гаргагч мэдүүлгийн талаар эцсийн шийдвэр гарах хүртэлх хугацаанд мэдүүлгээсээ татгалзах тохиолдол гардагийг тооцон үзэж, уян хатан байдлаар хандах шаардлагатай байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. Хуулийн 8 дугаар зүйл буюу шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийг цахим хэлбэрээр гаргах зохицуулалт практикт нийцэж байна уу, хуулийн хэрэгжилтэд тулгарч байгаа хүндрэл, түүний үр дагавар юу вэ?

8 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийг цахим хэлбэрээр гаргах

8.1.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийг мэдүүлэг гаргагч цахим хэлбэрээр гаргаж болох бөгөөд энэ тохиолдолд мэдүүлэг нь энэ хуулийн 7 дугаар зүйл, оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан журамд заасан шаардлага хангасан байна.

/*Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан*/

8.2.Энэ хуулийн 8.1-д заасан мэдүүлгийг уян диск болон мэдээллийн цахим хэлбэрийн бусад хэрэгслээр ирүүлж болно.

8.3.Цахим хэлбэрээр ирүүлсэн мэдүүлгийн анхдагч огноог тухайн мэдүүлэг энэ хуульд заасан шаардлагыг хангасан бөгөөд шаардлагатай баримтуудыг хавсаргасан нөхцөлд хүлээн авсан холбогдох ажилтны гарын үсэг, дугаар бүхий баримтыг үндэслэн тогтооно.

8.4.Цахим хэлбэрээр ирүүлсэн мэдүүлэгтэй холбоотой шийдвэрийг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага цахим хэлбэрээр хүргүүлж, тус газрын дарга цахим гарын үсэг хэрэглэж болно.

/*Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан*/

Үнэлгээ:

Патентийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар мэдүүлгийг анх удаа цахим хэлбэрээр гаргаж болохоор тусгаж өгсөн нь зохион бүтээгч мэдүүлгээ ямар хэлбэрээр гаргах сонголтыг нээж өгсөн давуу талтай хэдий ч одоогоор практикт огт хэрэгжээгүй байна. Тухайлбал,

- 2016 онд нэмэлт, өөрчлөлт орсон боловч хуучин заалттайгаа уялдахгүй
- Цахим мэдүүлэг гаргахад бэлтгэл ажил хийгдээгүй
- Мэдүүлгийг цахим хэлбэрээр гаргахад баримтлах дүрэм, журам байдаггүй.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 3. Хуулийн 9 дүгээр зүйл буюу Патентийн хамтын ажиллагааны гэрээний дагуу олон улсын мэдүүлэг гаргах зохицуулалт практикт нийцэж байна уу, хуулийн хэрэгжилтэд тулгарч байгаа хүндрэл, түүний үр дагавар юу вэ?

9 дүгээр зүйл. Патентийн хамтын ажиллагааны гэрээний дагуу олон улсын мэдүүлэг гаргах

9.1.Монгол Улсыг нэр зааж гаргасан шинэ бүтээл, ашигтай загварын олон улсын мэдүүлгийн анхдагч огноог энэ хуулиар, эсхүл Патентийн хамтын ажиллагааны гэрээний дагуу бүртгүүлсэн олон улсын байгууллагын бүртгэлийн огноогоор тогтооно.

9.2.Монгол Улсын иргэн болон Монгол Улсад оршин суудаг гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний гаргасан олон улсын мэдүүлгийн хувьд хүлээн авагч байгууллага нь оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллага байна.

/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

9.3.Мэдүүлэг гаргагч олон улсын мэдүүлгийг хүлээн авагч байгууллагад гэрээнд заасан хэл дээр гаргаж, хураамж төлнө.

9.4.Мэдүүлэг гаргагч нь олон улсын мэдүүлэгтээ Монгол Улсын нутаг дэвсгэр дээр шинэ бүтээлийн патент, ашигтай загварын гэрчилгээ авахаар Монгол Улсыг нэр заасан бол оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь нэр заагдсан байгууллага болно.

/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

9.5.Мэдүүлэг гаргагч нь олон улсын мэдүүлэгтээ олон улсын урьдчилсан магадлан шүүлт хийлгэхээр Монгол Улсыг сонгосон бол оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгогдсон байгууллага болно.

/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

9.6.Сонгогдсон байгууллага нь мэдүүлэгт хийх урьдчилсан магадлан шүүлтийн тайланг гэрээнд заасан хугацаанд хүлээж авна.

9.7.Монгол Улсыг сонгосон олон улсын мэдүүлгийн хувьд мэдүүлэг гаргагч Патентийн хамтын ажиллагааны гэрээнд заасны дагуу урьдчилсан магадлан шүүлт хийж эхлэхээс өмнө хураамж төлнө.

9.8. оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олон улсын мэдүүлэгт хийх бүх үйл ажиллагааг холбогдох хууль, гэрээ, журмын дагуу гүйцэтгэнэ.

/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

Үнэлгээ:

Дээрх заалт нь амьдрал дээр буухдаа олон улсын мэдүүлгийг Оюуны өмчийн газар хийж байгаа мэт, нөгөө талаар олон улсын байгууллагад мэдүүлэг гаргаж болох ч юм шиг заалтууд хоорондоо холилдсон нь мэдүүлэг гаргагчид ойлгомжгүй байдал үүсэх, ойлголтын зөрүү гардаг байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

ШИГТГЭЭ 6.

9-р зүйлийг бүгдийг нь өөрчлөх хэрэгтэй. Жишээ нь: 9.3.Мэдүүлэг гаргагч олон улсын мэдүүлгийг хүлээн авагч байгууллагад гэрээнд заасан хэл дээр гаргаж, хураамж төлнө. ДОӨБ-д хураамж төлдөг. Харин Оюуны өмчийн газарт хураамж төлдөггүй.

Мөн уг зүйлийг гадны хуулиас орчуулахдаа буруу орчуулсан уу, эсвэл манайхан ингэж тусгасан уу утга нь тааруу болсон.

Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчидтэй х ийсэн ярилцлагын судалгааны үр дүн.

Патентийн хамтын ажиллагааны гэрээний дагуу олон улсын мэдүүлэг гаргах гэдгээр нь аваад дотроо бас хоёр задлах ёстой. Гадагшаа мэдүүлэх гээд олон улсын гэрээний дагуу олон улсын мэдүүлэг гаргах, манайд гаднаас ирж байгаа олон улсын мэдүүлэг гэх ч юм уу.

Аж үйлдвэрийн өмчийн эрхийн газрын ажилтантай хийсэн ярилцлагын судалгааны үр дүн.

Өнөөгийн байдлаар манай орны хувьд Патентийн хамтын ажиллагааны гэрээний дагуу олон улсад мэдүүлсэн шинэ бүтээл тэр бүр гарахгүй байна. Харин Патентийн хамтын ажиллагааны гэрээний дагуу ирсэн мэдүүлгийн 50-иас дээш хувийг[10] Монгол Улсыг нэр зааж ирүүлсэн шинэ бүтээлийн олон улсын мэдүүлэг эзэлж байна. Энэ хувь жилээс жилд өсөх төлөвтэй байна. Иймд энэ харилцааг зохицуулахад олон улсын гэрээний дагуу мэдүүлэг гаргах журам боловсруулах, мөн хуулийн зохицуулалтыг олон улсын холбогдох гэрээ хэлэлцээрийн стандарт, шаардлагад нийцүүлж өөрчлөн найруулвал практикт хэрэгжих боломжтой юм.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 4. Хуулийн 10 дугаар зүйл буюу шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийн **анхдагч огноо** тогтоохтой холбоотой зохицуулалт практикт нийцэж байна уу, хуулийн хэрэгжилтэд тулгарч байгаа хүндрэл, түүний үр дагавар юу вэ?

10 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийн анхдагч огноог тогтоох

10.1. оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлэг хүлээн авсан өдрөөс хойш 2О, ашигтай загварын мэдүүлэг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор түүний бүрдлийг хянаж, энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан шаардлагад нийцсэн бөгөөд **мэдүүлгийн бүрдэл хангасан** гэж үзвэл анхдагч огноог мэдүүлэг хүлээн авсан өдрөөр тооцно.

10.2. оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мэдүүлгийг энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй гэж үзвэл түүнд нэмэлт, засвар хийх шаардлагатайг мэдүүлэг гаргагчид мэдэгдэнэ.

10.3.Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 10.2-т заасан мэдэгдлийг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүлээн авсан өдрөөс хойш шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлэгт 3 сар, ашигтай загварын мэдүүлэгт 1 сарын дотор нэмэлт, засвар хийж ирүүлсэн тохиолдолд тухайн мэдүүлгийн анхдагч огноог мэдүүлгийг анх хүлээн авсан өдрөөр тооцно.

10.4.Энэ хуулийн 10.3-т заасан хугацааны дотор нэмэлт, засвар хийж ирүүлээгүй бол тухайн мэдүүлгийг гаргаагүй гэж үзнэ.

10.5.Мэдүүлэг гаргагч давамгайлах огнооны эрх хүсэж байгаа бол мэдүүлгийг бүртгэснээс хойш 2 сарын дотор энэ тухайгаа бичгээр мэдэгдэж, анхны мэдүүлгийн хуулбарыг ирүүлнэ.

[10] ОӨУБЕГ-ын Аж үйлдвэрийн эрхийн газрын 2016 оны статистик тоо баримт.

Үнэлгээ:

Хуулийн 10 дугаар зүйлд дээр дурдсан **эерэг** зохицуулалтууд байгаа хэдий ч хэрэглэхэд ойлгомж муутай, хэрэгжүүлэхэд хүндрэлтэй хуулийн хэрэгжилтэд **сөрөг** нөлөө үзүүлж болохоор зарим зохицуулалт байна гэж үзэв.

Үүнд:

1. Хуулийн 10.1-д **мэдүүлгийн бүрдлийг хянах** хугацааг хоёр өөрөөр тогтоосон (7 ба 20 хоног)-ыг эргэн нягталж, эдгээр хугацааг уртасгах боломжийг анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

Мэдүүлэг хүлээн авч **бүрдлийг хянах** чиг үүргийг Аж үйлдвэрийн өмчийн эрхийн газар (цаашид АҮӨЭГазар гэх) хэрэгжүүлдэг бөгөөд одоогоор уг чиг үүргийг улсын хэмжээнд ганц мэргэжилтэн хариуцан гүйцэтгэдэг байна. Энэ нь уг газрын бүтэц зохион байгуулалт, хүний нөөцийн боломжтой холбоотой бөгөөд түүний ачааллаас шалтгаалан практикт ихээхэн хүндрэл үүсч байгаа нь судалгаанд хамрагдсан ажилтнуудтай хийсэн фокус ярилцлага, уулзалт ярианаас ажиглагдаж байв. Хүлээн авч буй мэдүүлгийн тоо жил ирэх тутам өсөж байгаа ба 2012 онд 462 мэдүүлэг хүлээн авч байсан бол 2016 онд 559 болон өссөн дүнтэй байна.

Өөр нэг хүндрэлтэй зүйл нь **"**мэдүүлгийн бүрдлийн шаардлага" хангахтай холбоотой зохицуулалт энэ зүйлд маш бүдэг (бараг байхгүй) тусгагдсан байна. Мэдүүлгийн "бүрдлийг хянах" ажиллагаа нь өргөдөлд хавсаргах ёстой материалууд бүрэн эсэхийг шалгаж хүлээн авах ажиллагаа ба **"мэдүүлгийн бүрдлийн шаардлагад шүүлт"** хийх асуудал нь мэрэгшсэн шинжээчдийн хийдэг нилээд нарийн ажиллагаа болох нь олон улсын гэрээ, хэлэлцээр бусад эх сурвалжаас харагдаж байна. Гэтэл практикт бүртгэлийн мэргэжилтэн нь тухайн мэдүүлэгт зөвхөн "бүрдлийн хяналт" хийж (ачааллын хувьд шинжилгээ хийх ямар ч боломжгүй) шинжээчид шилжүүлдэг учраас шүүлт хийх шатанд **бүрдлийн шаардлага** хангаагүй материал олноор гардаг байна. Өөрөөр хэлбэл бүхэл бүтэн нэг шатны ажиллагаа ямар процедураар явагдах нь тодорхойгүй байгаагаас уг хуулийг хэрэгжүүлж буй төрийн байгууллагын ажилтнууд болон мэдүүлэг гаргагчдад ихээхэн хүндрэл үүсгэж, цаашлаад хуулийн хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлж болохоор байна. Жишээ нь: АҮӨЭГ-т 2016 онд зөвхөн шинэ бүтээлийн мэдүүлэг 220 ирсэн ба үүний 93-ыг нь нэмэлт засвар хийлгэхээр буцааж, 19-ийг нь мэдүүлэг гаргаагүйд тооцсон нь нийт ирсэн мэдүүлгийн 50 гаруй хувь болж байна. Иймээс үүнд дүгнэлт хийх шаардлагатай гэж үзэж байна.

ШИГТГЭЭ 7.

Манай газрын нэн тэргүүний асуудал бол хүний нөөцийн асуудал байдаг. Манайх бүтцээрээ бүртгэлийн 1 мэргэжилтэнтэй ба мэдүүлэг хүлээн авах, бүртгэлийн дараах өөрчлөлт хийх, цахимжуулах бүх ажлыг хариуцдаг. Гэтэл бусад оронд мэдүүлгийн бүрдлийн шүүлт хийдэг тусдаа орон тоо байдаг.

АҮӨЭГазрын төлөөлөл

ШИГТГЭЭ 8.

Хүний нөөцийн асуудал хүндрэлтэй байна. Одоо бүр шинжээчээ хүртэл бүртгэл дээр суулгаад хоёр хүн ажиллаж байна. Бусад улсад мэдүүлэг хүлээж авах, бүрдлийн шүүлт хийх хоёрыг тус тусдаа чиг үүрэг гэж үздэг. Хуулийн заалтад эдгээрийн зааг ялгааг нарийн тусгаж өгөх шаардлагатай. Учир нь мэдүүлэг хүлээн авахаас шийдвэр гарах хүртэл маш олон төрлийн ажлын нарийн процедур байдаг. Энэ нь цаанаа ажлын технологи юм. Үүнийг зөв гаргаад аль нь алинтайгаа уялдах вэ гэсэн ажлын зураглал гаргаад үүндээ тохируулаад хуульдаа тусгавал сайн байна. Хуулиа хараад байхаар маш их төөрөгдөлд оруулах заалтууд байдаг. Мэдүүлэг гаргагчид байтугай биднийг төөрөгдөлд оруулах заалт их байдаг. Хэн ч өөрийнхөөрөө тайлбар хийчих боломжтой. Дотроо заалтууд нь маш их зөрчилддөг. Процедураа хуульд маш сайн оруулах шаардлагатай байна.

АҮӨЭГ-ын төлөөлөл

2. Хуулийн 10.1-д энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан **шаардлагад** нийцсэн гэж үзвэл мэдүүлгийг хүлээн авч анхдагч огноог мэдүүлэг хүлээн авсан өдрөөр тооцохоор заасан. Гэтэл энэ нь дээр дурдсанчлан мөн энэ хэсгийн **“мэдүүлгийн бүрдлийг хянах** гэсэн ойлголттой давхардан будилаантай ойлголт үүсгэж байгаагийн гадна “шинэ бүтээл”, “бүтээгдэхүүний загвар”, “ашигтай загвар”-ын мэдүүлгийн бүрдэлд тавигдах шаардлагыг хуулийн 7 дугаар зүйлд нэг дор маш товч байдлаар тусгасан (7.3-7.5) нь энэ хуулийн амин сүнс гэж хэлж болох хамгийн нарийн төвөгтэй асуудлуудыг хэрэглэгчид нэг мөр ойлгож хэрэгжүүлэхэд ихээхэн хүндрэлтэй болсон байна.

ШИГТГЭЭ 9.

Патентийн тухай хуулиар аж үйлдвэрийн өмчийн үндсэн объект болох шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын эрхийн хамгаалалтын асуудал зохицуулагддаг. Эдгээр объектод хамаарах асуудлууд хуулийн нэг зүйлд хамтаар орсон байдаг тул мэдүүлэг гаргагч нар объект хоорондын ялгааг ойлгохгүй, объектоо тодорхойлж чадахгүйгээс болж мэдүүлгээ сольж өгөх зэрэг асуудал олноор үүсдэг. Иймд энэ гурван объектыг салгаж, тус тусд нь бүлэг, зүйл болгон оруулах шаардлагатай байна. Мэдүүлэг гаргаж байгаа мэдүүлэгч нарын зүгээс бид нарт хандаж байгаа зүйл бол процедурыг нь нарийн тусгаж өгөөгүйгээс болоод будилаад байна гэдэг. Өөрөөр хэлбэл хуулийн зохицуулалтыг дэлгэрүүлэх хэрэгтэй байна.

АҮӨЭГ-ын төлөөлөл

3. Уг хуулийн 10.3-т заасан хугацаанд багтаан мэдүүлэг гаргагч нэмэлт засвар хийсэн боловч тухайн мэдүүлэг дахиад бүрдлийн шаардлага хангаагүй хэвээр байвал яах вэ гэдэг асуудал **зохицуулагдаагүйн** гадна 10.4-т хуулиар тогтоосон хугацаанд мэдүүлэгт нэмэлт, засвар хийж ирүүлээгүй бол тухайн мэдүүлгийг **гаргаагүйд** тооцохоор заасан нь хэрэглэхэд ойлгомжгүй байна. Нэгэнт гаргасан мэдүүлгийг гаргаагүйд тооцох нь хууль зүйн үндэслэл багатай бөгөөд харин мэдүүлгийн шаардлага хангаагүй гэх үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж болох талтай. Гэвч ийм зохицуулалт уг хуульд байхгүй байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

ШИГТГЭЭ 10.

Мэдүүлэг хуульд заасан хэмжээнд бичигдээгүй орж ирдэг. Тэгэхээр хайлт, шүүлт хийх боломж байхгүй. Тиймд мэдүүлгийг хүлээн авахаас татгалзах, хүлээн авсанд тооцохгүй байх зэрэг хуулийн зохицуулалт хэрэгтэй байна. Анхдагч огноог өгөхийн тулд мэдүүлэг тодорхой шаардлага хангасан байх шаардлагатай. Практик дээр "мэдүүлэг бүртгэдэг" ажилтан мэдүүлэг хүлээж авдаг. Яг уншиж судлах ажлаа шинжээч хийдэг. Тэгэхээр шинжээчийн зүгээс мэдүүлэг гаргаагүйд тооцох, татгалзах заалт хуульд байхгүй. Тиймээс анхдагч огноог тогтоохоос өмнөх заалтыг ашиглаж мэдүүлэг гаргаагүйд тооцдог. Мэдүүлэг гаргаагүйд тооцох гэдэг нь эрх зүйн хувьд өөр асуудал. Патент олгохгүй гэсэн үг биш. Гаргасан мэдүүлэг нь шаардлагад нийцэхгүй байна гэсэн үг.

АҮӨЭГ-ын ажилтан

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 5. Хуулийн 11 дүгээр зүйл буюу шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлэгт шүүлт хийхтэй холбоотой зохицуулалт практикт нийцэж байна уу, хуулийн хэрэгжилтэд тулгарч байгаа хүндрэл, түүний үр дагавар юу вэ?

11 дүгээр зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлэгт шүүлт хийх

11.1.Мэдүүлгийн анхдагч огноог тогтоосны дараа оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шинжээч тухайн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар энэ хуулийн 4, 5 дугаар зүйлд заасан шалгуурыг хангасан эсэхэд мөн чанарын шүүлт хийнэ.

11.2.Мэдүүлэг гаргагч мэдүүлсэн шинэ бүтээл, эсхүл түүнтэй мөн чанараараа ижил бүтээлд патент буюу өөр ямар нэг эрхийн баримт авахаар гадаадын улс, олон улсын байгууллагад мэдүүлэг гаргасан тухайгаа оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

11.3.Шүүлт хийх явцад буюу эцсийн шийдвэр гарахаас өмнө мэдүүлэг гаргагч анхныхаа ирүүлсэн тодорхойлолтын агуулгын хүрээнээс халихгүйгээр, мэдүүлэгтээ нэмэлт, өөрчлөлт хийж болно.

11.4.Нэмэлт, өөрчлөлт нь мэдүүлж байгаа шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мөн чанарыг өөрчлөх бол шинээр мэдүүлэг гаргана.

11.5.Мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр шүүлт хийхийг хойшлуулж болох боловч шүүлт хийхийг хойшлуулах хугацаа нь энэ хуулийн 11.9, 11.10-т заасан хугацаагаар хязгаарлагдана.

11.6.Шүүлт хийх явцад мэдүүлэг гаргагч анхныхаа ирүүлсэн тодорхойлолтын агуулгын хүрээнээс халихгүйгээр мэдүүлгээ 2 буюу түүнээс олон мэдүүлэг болгон салгах, эсхүл хамтаар ашиглагдах шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын хэд хэдэн мэдүүлгийг нэгтгэж болно.

11.7.Энэ хуулийн 11.6-д заасан тохиолдолд мэдүүлгийн анхдагч огноо буюу давамгайлах огноог анхны мэдүүлгээр тогтооно.

11.8.Шинэ бүтээлээр дэвшүүлсэн шийдлийн зохиогч мэдүүлгийг эцсийн шийдвэр гарахаас өмнө ашигтай загварын мэдүүлэг болгон, ашигтай загварын гэрчилгээ хүссэн мэдүүлгийг шинэ бүтээлийн мэдүүлэг болгон тус тус өөрчилж болох бөгөөд энэ тохиолдолд анхдагч огноог анхны мэдүүлгээр тогтооно.

11.9. оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мэдүүлгийн анхдагч огнооноос хойш 9 сарын дотор шүүлтийн дүгнэлтийг үндэслэн патент олгох эсэх талаар шийдвэр гаргана.

11.10.оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 11.9-д заасан хугацааг 12 сар хүртэл хугацаагаар сунгаж болно.

11.11.Патент олгохоор шийдвэрлэсэн шинэ бүтээлийн ном зүй, томъёолол, бүтээгдэхүүний загварын зургийг патентийн хэвлэлд нийтэлж зарлана.

11.12.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар болох нь нотлогдоогүй, хамгаалах боломжгүй бол патент олгохоос татгалзсан шийдвэр гаргах бөгөөд шүүлтийн дүгнэлтийн хуулбарыг уг дүгнэлт гарсан өдрөөс хойш ЗО хоногийн дотор мэдүүлэг гаргагчид хүргүүлж, мэдүүлгийг патентийн санд хадгална.

Үнэлгээ:

Хуулийн 11 дүгээр зүйлд дээр дурдсан **эерэг** зохицуулалтууд байгаа хэдий ч хэрэглэхэд ойлгомж муутай, хэрэгжүүлэхэд хүндрэлтэй хуулийн хэрэгжилтэд **сөрөг** нөлөө үзүүлж болохоор зарим зохицуулалт байна гэж үнэлэв.Үүнд:

1. Уг зүйлийн 11.9-д оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мэдүүлгийн анхдагч огнооноос хойш 9 сарын дотор шүүлтийн дүгнэлтийг үндэслэн патент олгох эсэх талаар шийдвэр гаргахаар, 11.10-т патент олгох шийдвэр гаргах хугацааг **шаардлагатай гэж үзвэл** 12 хүртэл сарын хугацаагаар сунгаж болохоор тус тус заасан.

Гэтэл дээрх заалтууд практикт огт нийцдэггүй учраас хэрэгжих боломж муутайг судалгаанд хамрагдсан байгууллагуудын төлөөллүүд санал нэгтэй мэдээлж байснаас гадна “шаардлагатай гэж үзвэл” гэдэгт юуг хамааруулж ойлгох талаар хуульд тодорхой зохицуулалт тусгагдаагүй байна. Гэтэл олон улсын туршлагаас харахад энэ хугацаа 3-10 жил үргэлжилдэг байна.

ШИГТГЭЭ 11.

Мэдүүлэг хүлээн авснаас хойш патент олгох эцсийн шийдвэр гарах хүртэлх хугацаа хуульд зааснаар 9 сар ба энэ нь бусад оронтой харьцуулахад маш богино хугацаа юм. Иймээс WIPO CASE /ОУ-ын хайлт шүүлтийн төвлөрсөн хандалтын систем/-д хандах ажиллагаанд манай хуулийн хугацаанаас болж хүндрэл үүсээд байна.

Патентийн хуулийн хэрэгжилттэй холбоотой тулгамдсан асуудал материалаас ОӨУБЕГ-ын АҮӨЭГазраас ирүүлсэн мэдээ.

ШИГТГЭЭ 12.

Шинэ бүтээлд 9 сарын дотор шүүлтийн дүгнэлт гарна. 9 сарын дотор хайлт, шүүлтийн дүгнэлт гаргахад төвөгтэй болоод байна. Жишээ нь: Бусад улсын патентийн газар маш том бүтэцтэй байдаг. Хятад улсад шинжээч нь гэхэд 11000 хүн ажилладаг. Олон улсын ангилал бүрт нэг нэг шинжээч суудаг. Өөрөөр хэлбэл 11000 хүн тус бүр мэргэшээд суудаг. Бидэнд тийм боломж байхгүй. Техник, технологийн инновацилаг өндөр шийдлүүд ороод ирэхээр түүнд ажиллах хугацаа 9 сар байгаа нь ерөөсөө нийцэхгүй байгаа юм.

Ихэнх оронд мэдүүлэг хүлээн авч анхдагч огноог тавьлаа түүнээс хойш 16 сарын дараа мэдээлэл өгөх зорилгоор хэвлээд 3 жилийн дараа шүүлт хийлгэх үү гэдэг хүсэлтийг аваад хийлгэнэ гэвэл шүүлт эхлээд, шүүлт нь дунджаар 3-10 жил үргэлжилдэг. Тэгэхээр патентийн хугацаа маш урт байдаг. Манайх бол хүлээж аваад хайлт, шүүлтээ хийгээд 9 сарын дотор шийдвэр гаргахыг шаардаад байдаг.

Дэлхийн оюуны өмчийн байгууллагын хүн ирж хичээл заахдаа жижиг патентийн газрууд ямар байх вэ гэхээр бусад улсын нүсэр газруудын ажлын үр дүнг ашиглаад патентийн хайлт, шүүлтийн чанарыг сайжруулах шаардлагатай. Тэгэхээр танай патентийн процедурын хугацаа 9 сар бас дээр нь хуулиндаа 12 сар хүртэл хугацаанд сунгаж болно гэж заасан. Иймд нэг бол 12 сар хүртэл хугацаанд хайлт, шүүлтийн хугацааг ойлгоно, нэг бол 21 сар болгож ойлгодог ч маш богино хугацаа юм. Тэгэхээр Патентийн хуулийн процедурын хугацааг сунгаж өгөх шаардлагатай байна.

АҮӨЭГ-ын ажилтан

2. 11 дүгээр зүйлд **“хайлт”** хийхтэй холбоотой зохицуулалт **огт тусгагдаагүй** бөгөөд АҮӨЭГазар Монгол Улсын Олон Улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хүрээнд энэхүү чиг үүргийг хэрэгжүүлдэг байна. Өөрөөр хэлбэл дотоодын хуульд энэ тухай зохицуулалт байхгүй учраас олон улсын гэрээг дагаж мөрддөг бөгөөд хайлт шүүлт хийхтэй холбоотой хугацаа нь Патентийн тухай хуулийн 11.9, 11.10-д заасан

хугацаатай зөрчилдөж хуулийн хэрэгжилтэд нилээдгүй **сөрөг** үр дагавар үүсгэдэг байна. Мэдүүлэгт хайлт хийхтэй холбоотой харилцааг Патентийн тухай хуулиар зайлшгүй зохицуулах ёстой бөгөөд уг харилцааг зохицуулалтгүй орхигдуулсан гэж үнэлэх үндэслэлтэй байна.

ШИГТГЭЭ 13.

Мэдүүлэг гаргаснаас хойших процедурыг ялгаж өгөх хэрэгтэй. Мэдүүлэг гаргахад эхлээд өгөх ёстой юм бүрэн эсэхийг үздэг. /нэр, хаяг гэх мэт/ Энэ бүрэн байвал техникийн түвшинд ямар байна гэдгийг тогтоож өгнө. Тодруулбал, **хайлт** хийнэ. Техникийн түвшинд болно гэж үзвэл **шүүлт** хийнэ. Яг ийм 3 дамжлага байх ёстой байтал мэргэжлийн байгууллага нь өөрөө холиод 2 болгоод хаячихсан байгаа. Энэ бол процедурын алдаа. Үе шат болгон дээр буцаагаад алдаагаа засаад явах процесс байх ёстой. Энэ байхгүй. Хамгийн сүүлд патент авсаны дараа хаягаа өөрчилж болно, эзэмшигч өөрчилж болно, хүнд шилжүүлж болно. Энэ зүйлүүд байхгүй. Иймд одоо эдгээрийг маш сайн гаргаж өгөх шаардлагатай. 9 сарын дотор патент олгох шийдвэр гардаггүй. Зөвхөн шүүлтийн дүгнэлт гаргах гэж л хичээдэг.

Итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн төлөөлөл

Монгол Улсын нэгдэн орсон “Патентийн хамтын ажиллагааны гэрээ”-нд зааснаар хэлэлцэн тохиролцогч бүх орны мэдүүлэг гаргагч өөрийнхөө шинэ бүтээлийг бусад оронд хамгаалуулахаар нэр заан мэдүүлэг гаргах эрхтэй ба уг мэдүүлэг нь бусад оронд үндэсний байгууллагад өгсөн патентийн мэдүүлэгтэй нэгэн адил хүчинтэй байдаг. Энэхүү мэдүүлэг нь олон улсын **хайлт** хийх үндсэн баримт болдог бөгөөд патентийн хайлтыг олон улсын томоохон байгууллагуудын аль нэг нь гүйцэтгэдэг.

Мэдүүлгийг бүртгэх, хайлт, шүүлт хийх ажиллагаа дээр дурдсан гэрээний дагуу явагдах бөгөөд хэрэв тухайн бүтээгдэхүүнийг патентлаг чадваргүй гэж үзсэн тохиолдолд олон улсын хайлт хийж, шинэ бүтээлийн патентлаг чадварыг тогтоох боломжтой хамгийн олон патентийн баримтын жагсаалтыг багтаасан “Олон улсын хайлтын тайлан” үйлдэж мэдүүлэг гаргагчид хүргүүлдэг байна.

Мэдүүлэг гаргагч “Олон улсын хайлтын тайлан”-г зөвшөөрөхгүй тохиолдол гарч болдог ба ийм нөхцөл үүсвэл мэдүүлгээ уг тайлангийн хамт хэвлэж, бүх нэр заасан оронд илгээдэг. Эндээс патентийн хамтын ажиллагааны давуу тал харагдах ба Олон улсын хайлтын буюу урьдчилсан магадлан шүүлтийн тайлангууд нь патентийн байгууллагад хийгдэх х**айлт, шүүлтийн** ажлын хэмжээг эрс багасгадаг**.** Түүнчлэн мэдүүлэг нь Олон улсын хайлтын тайлантай хамт хэвлэгддэг учраас тухайн бүтээлийн патентлаг чадварын тухайд ихээхэн үндэслэл сайтай санал гаргах боломж бүрддэг байна.

Судалгааны үеэр хийсэн фокус ярилцлага, итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн төлөөлөлтэй хийсэн уулзалт болон энэ чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг хүмүүстэй хийсэн ярилцлагаас үзэхэд энэ хуулийн хамгийн чухал хэсэг болох мэдүүлэгт хайлт, шүүлт хийхтэй холбоотой зохицуулалт шаардлага хангахгүй байгаа нь ажиглагдсан ба үүнийг сайтар судалж, зохицуулалтыг нь илүү дэлгэрэнгүй, нарийн болгох шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрсэн болно.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

ШИГТГЭЭ 14.

Хайлт, шүүлтийн процедурыг хуульд нарийн тусгаагүйгээс мэдүүлэг гаргагч болон шинжээч нарын хооронд үл ойлголцол үүсдэг тул үүнийг Патентийн хамтын ажиллагааны гэрээнд тусгасан процедурт ойртуулж нарийвчлан заах шаардлагатай байна. 11 дүгээр зүйлд "шүүлт хийх" талаар заасан байдаг.

Шинэ бүтээлд **хайлт, шүүлт** хийнэ гэж үздэг. **"хайлт"** гэдэг үг Патентийн хуульд байхгүй. Гэтэл Патентийн системийн шинж чанар нь хайлт болон таслал шүүлтэн дээр явагддаг байгаа. Тэгэхээр бидэнд тийм заалт хэрэгтэй байгаа юм.

АҮӨЭГ-ын ажилтан

3. Уг зүйлийн 11.5-д заасан мэдүүлэг гаргагчийн шүүлт хийхийг хойшлуулах хүсэлт гаргах хугацааг патент олгох шийдвэр гаргах хугацаагаар хязгаарласны хууль зүйн үндэслэл ойлгомжгүйн гадна 11.6-д мэдүүлэг гаргагчийн мэдүүлгээ салгах эсхүл нэгтгэх хүсэлт гаргах хугацааг заагаагүй, 11.11-ийн томъёололд "бүтээгдэхүүний загварын ном зүй" тусгагдаагүй зэрэг нь хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэхэд тодорхойгүй байдал үүсгэдэг байна. Иймээс эдгээрийг анхаарах шаардлагатай.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 6. Хуулийн 12 дугаар зүйл буюу ашигтай загварын мэдүүлэгт магадлан шүүлт хийхтэй холбоотой зохицуулалт практикт нийцэж байна уу, хуулийн хэрэгжилтэд тулгарч байгаа хүндрэл, түүний үр дагавар юу вэ?

12 дугаар зүйл. Ашигтай загварын мэдүүлэгт магадлан шүүлт хийх

12.1.Мэдүүлгийн анхдагч огнооноос хойш 1 сарын дотор энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан эсэх, ашигтай загвараар бүртгэгдэх боломжтой эсэхэд шинжээч магадлан шүүлт хийж дүгнэлт гаргана.

12.2.Ашигтай загварын мэдүүлэгт шүүлт хийхэд энэ хуулийн 11.2, 11.3-т заасныг нэгэн адил мөрдөнө.

Үнэлгээ:

Уг зүйлийн 12.1-д ашигтай загварын мэдүүлэгт магадлан шүүлт хийх хугацааг 1 сар байхаар тогтоосон нь практикт нийцэхгүй байгаа тухай судалгааны үеэр болсон семинар, уулзалт, хэлэлцүүлгийн үеэр хууль хэрэглэгч байгууллага, иргэдийн төлөөлөл хэлж, шүүмжилж байсныг тэмдэглэх нь зүйтэй гэж үзэв.

Түүнчлэн хуулийн 11 дүгээр зүйлийн зохицуулалтад "ашигтай загвар"-ын мэдүүлэгт шүүлт хийх асуудал тусгагдаагүй байтал уг зүйлийн 11.2,11.3-ыг ишлэл болгосон нь учир дутагдалтай бөгөөд огт хэрэглэгдэхгүй заалт болсон байна. Иймээс энэхүү зүйл нь хуулийн хэрэгжилтийг хангахад эерэг нөлөө үзүүлэх магадлал муутай.

ШИГТГЭЭ 15.

Ашигтай загварын тухай хууль гэж оруулах эсхүл тусд нь нэг бүлэг болгож хуульд оруулах. Ашигтай загварын мэдүүлэгт магадлан шүүлт хийх хугацаа богино байна. Нэг сар ийм богино байж болохгүй. Яагаад ч ийм байж болохгүй. Ашигтай загвар гэж шинэ юм гарлаа. 1 сарын дотор энэ хуулиар шийдвэрийг нь гаргаад өгчихлөө. 3 сарын дотор ашигтай загварын гэрчилгээ авчихсан. Авснаас хойш 6 сарын дараа давамгайлах огноотой өргөдөл гараад ирдэг. Чинийхийг хүчингүй болголоо гэж хэлж болдоггүй юм. Шинэ бүтээл, ашигтай загвар хамт байж болно. Ойролцоо төрлийн харилцаа учраас. Харин бүтээгдэхүүний загвартай хамт байж болохгүй. Бүтээгдэхүүний загварын хуулийг тусд нь эсхүл энэ хуульд тусгай бүлгээр зохицуулбал зохимжтой.

Итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн төлөөлөл

Хууль зүйн асуудлын хүрээлэн www.nli.gov.mn

3.3. Тохиолдол судлах:

Судалгааны баг холбогдох аргачлалын 3.5.3-т заасан харьцуулах хэлбэрүүдээс “тохиолдол судлах хэлбэр”-ийг сонгож энэхүү үнэлгээг хийсэн ба ингэхдээ Бүгд Найрамдах Хятад Ард Улс (цаашид БНХАУ гэх) болон Оросын Холбооны Улс (цаашид ОХУ гэх)-ын энэ төрлийн харилцааг зохицуулж буй хуулийн холбогдох зүйл, заалтыг Монгол Улсын Патентийн тухай хуулийн судалгааны хүрээнд хамаарч буй бүлэг (Хоёрдугаар бүлэг)-ийн зохицуулалттай харьцуулах байдлаар хийв[11].

Ингэхдээ манай улсын Патентийн тухай хуулийн 7, 8, 9, 10, 11, 12 дугаар зүйлээр зохицуулсан харилцааг ОХУ, БНХАУ-ын Патентийн хуулиар хэрхэн зохицуулсан байдгийг харьцуулан судалж үзлээ.

ОХУ-ын хувьд Эдийн засгийн хөгжлийн яаманд харьяалагдах Холбооны улсын оюуны өмчийн байгууллага, БНХАУ-ын тухайд Төрийн Зөвлөлийн харьяа Патентийн газар нэртэй байгууллагууд Патентийн хуулийн хэрэгжилтийг хангаж ажилладаг байна.

ОХУ, БНХАУ-ын хуульд шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар гэсэн аж үйлдвэрийн гурван объектод гурвууланд нь патент олгохоор зохицуулсан байдаг бол манай улсад шинэ бүтээл, бүтгээгдэхүүний загварт патент, ашигтай загварт гэрчилгээ олгодог байна.

БНХАУ-ын Патентийн хуулийн 3 дугаар зүйлд Төрийн Зөвлөлийн харьяан дахь Патентийн газар нь нийт улсын хэмжээний патентийн ажлыг хариуцна. Муж, өөртөө засах орон болон шууд харьяа хотын удирдлагын харьяан дахь патентийн асуудал хариуцсан захиргааны байгууллага нь харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд патентийн асуудлыг эрхлэн хариуцдаг[12] байна. Өөрөөр хэлбэл орон нутагт салбартай гэсэн үг.

ОХУ-ын Патентийн хуулийн чиг үүргийг хэрэгжүүлэх харьяа байгууллага болон Патентийн байгууллагад Евразийн патентийн байгууллага, Европын холбооны патентийн байгууллага, Холбооны улсын оюуны өмчийн байгууллага, Дэлхийн оюуны өмчийн байгууллага зэрэг багтана гэдгийг хуулиндаа тусгаж өгсөн байна.[13] Түүнчлэн Патентийн мэдүүлэг гаргахтай холбогдсон харилцаан дахь зохицуулалтыг Шинэ бүтээл (16 дугаар зүйл), ашигтай загвар (17 дугаар зүйл), бүтээгдэхүүний загвар (18 дугаар зүйл)-ыг салгаж зохицуулсан байх тул хэрэглэхэд хялбар, ойлгомжтой байна.

Харин БНХАУ-д шинэ бүтээл, ашигтай загвар (26 дугаар зүйл), бүтээгдэхүүний загвар (27 дугаар зүйл)-ын мэдүүлэг гаргах нөхцлийг ОХУ-ын патентийн хуулийн мэдүүлэг гаргах томъёоллыг төсөөтэйгээр хуулиндаа тусгасан байна.

ОХУ-ын Патентийн хуулийн 21.7 дахь заалтад Мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр шинэ бүтээлийн мэдүүлэг гаргасан өдрөөс хойш 3 жилийн дотор Холбооны улсын оюуны өмчийн байгууллага хайлтын үр дүнг үндэслэн патент олгож болно гэж заасан.[14]

ОХУ-ын Патентийн хуулийн 23.1 дэх заалтад Ашигтай загварын мэдүүлгийн анхдагч огнооноос хойш хоёр сарын дотор энэ хуулийн 17 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг шинжээч магадлан шүүлт явуулна гэж хуульчилсан байна. Мэдүүлэг гаргагчийн санаачлагаар мэдүүлэг гаргасан өдрөөс хоёр сарын дотор нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд Патентийн татвар оногдуулахгүй.

[11] Харьцуулсан судалгааны дэлгэрэнгүйг хавсралтаас үзнэ үү.

[12] http://chinalawinfo.ru/civil_law/law_patent/law_patent_ch1

[13] https://ru.wikipedia.org/wiki/%D0%9F%D0%B0%D1%82%D0%B5%D0%BD%D1%82

[14] http://www.consultant.ru/document/Cons_doc_LAW_979/a75ec5ec4892bac64bbb1b5246d09cf5a8c2f31f/

Монголд ашигтай загвар (хуулийн 10.3 дахь заалт)-ын мэдүүлэгт 1 сарын дотор нэмэлт, засвар хийж ирүүлсэн тохиолдолд тухайн мэдүүлгийн анхдагч огноог мэдүүлгийг анх хүлээн авсан өдрөөр тооцно. Харин энэ харилцааг татвараар зохицуулсан зохицуулалт байхгүй байна.

ОХУ-ын Засгийн газар нь аж үйлдвэрийн гурван объектын мэдүүлэгт үйлчилгээний хураамж төлөх журмыг батлана гэж заасан.

БНХАУ-ын Патентийн хуулийн 28 дугаар зүйлд Төрийн Зөвлөлийн харьяа Патентийн байгууллагад патентийн өргөдөл материалыг хүлээж авсан өдрөөр мэдүүлэг гаргасан өдөрт тооцно. Мэдүүлгээ шуудангаар явуулсан бол шуудангийн дарсан тэмдгээр мэдүүлэг гаргасан хугацааг тооцно гэж зохицуулсан.

БНХАУ-ын Патентийн хуулийн 34 дэх зүйлд заасны дагуу Төрийн Зөвлөлийн харьяа патентийн газар нь шинэ бүтээлийн мэдүүлгийг хүлээж авсны дараа, урьдчилсан шүүлт хийсний дараа тус хуулийн шаардлагад нийцэж байна гэж үзвэл хүлээн авсан өдрөөс эхлэн 18 сарын дараа хэвлэлд нийтлэнэ. Төрийн зөвлөлийн харьяа патентийн газраас мэдүүлэг гаргагчийн хүсэлт шаардлагыг үндэслэж мэдүүлгийг нь урьдчилан нийтлэж болно.

Харин ОХУ-ын шинэ бүтээл, ашигтай загварын тухайд заасан хугацаанаас 12 сарын дотор, бүтээгдэхүүний загварт 6 сарын дотор мэдүүлгээ Холбооны улсын оюуны өмчийн байгууллагад гаргасан байвал шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын давуу эрхийг Үндэсний болон аж үйлдвэрийн өмчийг хамгаалах Парисын тунхаглалын гишүүн орнуудад анхны мэдүүлгээ өгсөн өдрөөр тогтоож болно.[15] Олон улсын давуу эрх хүссэн мэдүүлэг гаргагчаас үл шалтгаалан заасан хугацаанд мэдүүлгээ гаргаагүй бол энэ хугацаа нь хоёр сараас хэтрэхгүйгээр сунгагдаж болохоор зохицуулжээ.

ОХУ-ын Патентийн хуулийн 23.1 дэх заалтад заасанчлан Мэдүүлгийн анхдагч огнооноос хойш хоёр сарын дотор энэ хуулийн 17 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг шинжээч магадлан шүүлт явуулна. Ашигтай загварын мэдүүлэгт магадлан шүүлт явуулахдаа энэ хуулийн 21 дүгээр зүйлийн 2, 4, 5, 9, 11, 12 дугаар заалтыг баримтална.

ОХУ-ын Патентийн хуулийн 23.11 дэх зүйлд заасанчлан Мэдүүлэг гаргагч магадлан шүүлтийн шийдвэр, мэдээллийн шүүлтийн тайлангийн бүх материалтай танилцах эрхтэй. Мэдүүлэг гаргагчийн хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш нэг сарын дотор Холбооны улсын оюуны өмчийн байгууллага мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр патентийн баримт бичгийн хуулбарыг явуулна.

35 дугаар зүйлд зааснаар Улсын нууцын мэдээлэл агуулаагүй бол ОХУ-д бүтээгдсэн шинэ бүтээл, ашигтай загварын мэдүүлгийг Холбооны улсын оюуны өмчийн байгууллагад зохих мэдүүлэг гаргасан өдрөөс хойш 6 сарын дотор олон улсын байгууллага, гадаад улсад гаргаж болно[16] гэж тус тус тусгажээ.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

4.1. Дүгнэлт

Патентийн тухай хуулийн 2 дугаар бүлгийн хэрэгжилтийн үр нөлөөнд үнэлгээ хийсний үр дүнд дараах дүгнэлтэнд хүрч байна. Үүнийг сонгож авсан хуулийн зүйл тус бүрээр толилуулбал:

[15] ОХУ-ын Патентийн хуулийн 19.2 дахь заалт.

[16] http://www.consultant.ru/document/Cons_doc_LAW_979/5b89bee4ebb4f1a10ba2412012a14bf4c8ec02c6/

1) Хуулийн 7 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах

Зорилгод хүрсэн түвшин:

Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах процедур нь хуулийн зорилгод хүрэхэд хэд хэдэн хүндрэл үүссэн нь ажиглагдлаа. Үүнд:

- Хуулийн 7 дугаар зүйл, заалт нь шинэ бүтээл, ашигтай загвар гэсэн бие даасан гурван объектыг нэг зүйлд хамтатган зохицуулж байгаагаас мэдүүлэг гаргагч уг нэр, объект хоорондын ялгааг ойлгохгүй, объектоо тодорхойлж чадахгүйгээс болж мэдүүлгийг сольж өгөх, улмаар хугацаа алдах зэрэг асуудал, чирэгдэл дагуулж байна.
- Шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварыг хуулийн нэг зүйл, заалтад оруулж мэдүүлэг гаргахаар зохицуулсан нь бүтээгдэхүүний загварын зохицуулалт нь мөн чанараараа шинэ бүтээл, ашигтай загвараас өөр байдаг учраас зохицуулах зүйл нь уялддаггүй.
- Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах, бүртгэхэд тавигдах шаардлагыг журмаар зохицуулж өгсөн байдаг боловч бүрдлийн шаардлагад тавигдах шаардлага нь бүрхэг, ойлгомжгүй байдаг учраас хуульд заасан хугацаа хэтэрсэн тохиолдолд ихэнх мэдүүлгийг гаргаагүйд тооцдог.
- Шүүхээр зөрчигдсөн эрхээ хамгаалуулах тохиолдолд гол баримтлах зүйл, процедур нь хуулинд бус журамд тусгасан учир зохион бүтээгч, бизнес эрхлэгчид эрхээ хамгаалж чадахгүйд хүрдэг. Учир нь энэ харилцааг журмаар зохицуулах тухай хуулинд заагаагүй гэдэг үндэслэлээр шүүх уг журмыг хүчин төгөлдөр бус акт гэж үздэг байна.

Практикт хэрэгжсэн байдал:

- Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах үйл явцыг бүртгэлийн ажилтан мэдүүлгийн бүрдүүлэлтийг шалгаад бүрдлийн шинжээч анхдагч огноо тогтоохоос өмнө бүрдлийг хянадаг шинэ бүтээлийн шинжээч, ашигтай загварын шинжээч ажил үүргийнхээ дагуу хайлт, шүүлт хийх, ижил төсөөтэй илэрцүүдийг гаргаж ирэх, мөн чанарынхаа шүүлтийг хийх гэсэн процесс дутуу байна.
- Зохион бүтээгчид өөрийнхөө мэдүүлгийг засах, хамгаалах боломж олгох ёстой юм. Гэтэл одоогийн хуулиар ямар ч боломжгүй, шууд татгалзахаар байгаа нь иргэн, зохион бүтээгч, бизнес эрхлэгчдэд хүндрэл, ойлгомжгүй байдлыг үүсгэх болсон байна.
- Гадаад орны туршлагаас харахад мэдүүлэг гаргах ажиллагааг объект тус бүрээр нь бие даасан зүйл, заалтаар салгаж зохицуулсан байна.

2) Хуулийн 8 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийг цахим хэлбэрээр гаргах

Зорилгод хүрсэн түвшин:

Хуулийн зорилгод төдийлөн оновчтой нийцэхгүй байна. Уг зүйлийн заалтууд нь найруулгын алдаатай, баримтлах дүрэм, журам байхгүй нь мэдүүлгийг цахим хэлбэрээр гаргах боломжгүйд хүргэж байна. Хууль тогтоогчийн санаа нь мэдүүлэг гаргах процессыг цахим хэлбэрт шилжүүлэх байсан байх магадлалтай. Гэвч хуулиа харахаар бүрдүүлбэрээ файл хэлбэрээр уян дискэн дээр хадгалж авчрах мэт ойлгогдож байна. Гэхдээ 8 дугаар зүйлийг шинэчлэн найруулснаар зорилгодоо хүрэх боломжтой.

Практикт хэрэгжсэн байдал:

Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийг цахим хэлбэрээр гаргах харилцааг оновчтой зохицуулж чадаагүйн улмаас практикт хэрэгжихгүй байна. Уг харилцааг зохицуулахдаа цахим мэдүүлэг гаргахад бэлтгэл ажил хийгдээгүй, 2016 онд уг зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулсан хэдий ч хуучин заалттайгаа уялдаагүй зэрэг нь практикт хэрэгжих боломжгүй байдлыг бий болгодог байна.

3) Хуулийн 9 дүгээр зүйл. Патентийн хамтын ажиллагааны гэрээний дагуу олон улсын мэдүүлэг гаргах

Зорилгод хүрсэн түвшин:

Хуулийн зорилгод хүрч чадахгүй байна. Учир нь "Патентийн хамтын ажиллагааны гэрээний дагуу олон улсын мэдүүлэг гаргах" зүйлийн доторх заалтууд холилдсон гэж үзэж болохоор байна. Нэг талаас Монгол Улсын нэр зааж гадаадаас ирүүлж буй мэдүүлэг, нөгөө талаас Монгол Улсаас гадаад руу буюу олон улсад гаргаж буй мэдүүлэг хоёр нь тусдаа ойлголт тул тус тусын процессоор явагддаг харилцаа юм. Үүнийг ялгаатай зохицуулах шаардлагатай.

Практикт хэрэгжсэн байдал:

Уг хуулийн заалтаар Патентийн хамтын ажиллагааны гэрээний дагуу олон улсын мэдүүлэг гаргахад төвөгтэй байна. Уг харилцааг зохицуулахдаа олон улсын гэрээний дагуу мэдүүлэг гаргах журам боловсруулаагүй, мөн хуулийн зохицуулалтыг олон улсын холбогдох гэрээ хэлэлцээрийн стандарт, шаардлагад нийцүүлж зохицуулж чадаагүйгээс болж өнөөгийн практикт хэрэгжиж чадахгүй байна.

4) Хуулийн 10 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийн анхдагч огноо тогтоох

Зорилгод хүрсэн түвшин:

Уг зүйлд хуулийн хэрэгжилтэд **эерэг** нөлөө үзүүлэх зарим зохицуулалт байгаа хэдий ч зүйлийг бүхэлд нь авч үзвэл: зорилгодоо **хангалттай хүрсэн** гэж дүгнэх үндэслэл муутай байна.

Практикт хэрэгжсэн байдал:

Энэхүү зүйлд хэрэглэхэд ойлгомж муутай, хэрэгжүүлэхэд хүндрэлтэй зарим зохицуулалт байна гэж үнэлсэн ба эдгээр нь хуулийн зорилтыг хангахад **сөрөг** нөлөө үзүүлж байна гэсэн дүгнэлт хийж байна. Үүнд:

- "Шинэ бүтээл", "бүтээгдэхүүний загвар", "ашигтай загвар"-ын мэдүүлгийн бүрдэлд тавигдах шаардлагыг хуулийн 7 дугаар зүйлд тусгасан (7.3-7.5) бөгөөд уг шаардлагыг хангасан гэж үзвэл **анхдагч огноог мэдүүлэг хүлээж авсан өдрөөр тооцохоор энэ зүйлийн** 10.1- д заасан. Гэтэл хуулийн амин сүнс гэж хэлж болох эдгээр нарийн төвөгтэй асуудлуудыг хуулийн бичилтийн хувьд хамтад нь нэг дор маш товч байдлаар тусгасан нь хэрэглэгчдийг төөрөгдүүлж, уг хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэхэд ихээхэн хүндрэл үүсгэж байна.
- Уг зүйлийн 10.1-д "**мэдүүлгийн бүрдлийг хянах"** хугацааг хоёр өөрөөр тогтоосон (7 ба 20 хоног)-ы хууль зүйн үндэслэл ойлгомжгүйгээс гадна эдгээр хугацаа нь мэдүүлгийн бүрдлийг үндэслэлтэй хянахад хангалтгүй болох нь судалгаагаар тогтоогдож байна.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.lri.gov.mn

5) Хуулийн 11 дүгээр зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлэгт шүүлт хийх

Зорилгод хүрсэн түвшин:

Уг зүйлд хуулийн хэрэгжилтэд **эерэг** нөлөө үзүүлэх зарим зохицуулалт байгаа боловч энэхүү зүйлийг бүхэлд нь дүгнэж үзвэл зорилгодоо хүрээгүй гэж үзэх үндэслэлтэй байна.

Практикт хэрэгжсэн байдал:

Уг зүйлд практикт огт хэрэгждэггүй зарим заалт байгаагийн гадна огт тусгагдаагүй орхигдсон зохицуулалт байна гэж үнэлсэн ба эдгээр нь хуулийн зорилтыг хангахад **сөрөг** нөлөө үзүүлж байна гэсэн дүгнэлт хийв. Үүнд:

- Уг зүйлийн 11.9-д мэдүүлгийн анхдагч огнооноос хойш 9 сарын дотор шүүлтийн дүгнэлтийг үндэслэн патент олгох шийдвэр гаргахаар, 11.10-д патент олгох шийдвэр гаргах хугацааг **шаардлагатай гэж үзвэл** 12 сар хүртэл хугацаагаар сунгаж болохоор тус тус заасан нь практикт огт нийцдэггүй учраас бодит байдалд хэрэгждэггүй байна.
- Уг зүйлд **"хайлт"** хийхтэй холбоотой зохицуулалт огт тусгагдаагүй орхигдсон нь уг хуулийг хэрэглэхэд ихээхэн хүндрэл үүсгэж, цаашлаад Монгол Улсын нэгдэн орсон Олон Улсын гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтэд муугаар нөлөөлж байна.
- Уг зүйлийн 11.5-д мэдүүлэг гаргагчид шүүлт хийхийг хойшлуулах хүсэлт гаргах хугацаа олгосон боловч уг хугацааг патент олгох шийдвэр гаргах хугацаагаар хязгаарласан, 11.6-д мэдүүлэг гаргагчийн мэдүүлэгээ салгах, нэгтгэх хүсэлт гаргах хугацааг заагаагүй, 11.11-ийн томъёололд "бүтээгдэхүүний загварын ном зүйг" орхигдуулсан зэрэг нь хэрэглэгчдэд тодорхойгүй байдал үүсгэж байна.
- Уг зүйлд "**Мэдүүлгийн бүрдлийн шаардлагад шүүлт"** хийхтэй холбоотой зохицуулалт бараг тусгагдаагүй тул энэхүү чиг үүргийг хэрэгжүүлж буй төрийн захиргааны байгууллагын ажилтнууд болон мэдүүлэг гаргагчдад ихээхэн хүндрэл үүсгэж, цаашлаад энэхүү хууль олон улсын түвшинд хэрэгжих боломжтой эсэхэд эргэлзээ төрүүлэхэд хүргэж байна.

6) 12 дугаар зүйл. Ашигтай загварын мэдүүлэгт магадлан шүүлт хийх

Зорилгод хүрсэн түвшин:

Уг зүйл нь бүтцийн хувьд хоёрхон хэсэгтэй бөгөөд цаг хугацаа шаардсан энэхүү нарийн ажиллагааг эдгээр заалтаар зохицуулж, хуулийн зорилтод хүрэх боломжгүй гэсэн дүгнэлт хийж байна.

Практикт хэрэгжсэн байдал:

Түүнчлэн уг зүйлийн хоёр заалт нь практикт нийцэхгүй байна. Үүнд:

- Энэхүү зүйлийн 12.1-д ашигтай загварын мэдүүлэгт магадлан шүүлт хийх хугацааг 1 сар байхаар тогтоосон нь практикт огт нийцдэггүй тухай хууль хэрэглэгчдээс судалгааны үеэр цөөнгүй шүүмжлэл гарч байв.
- Хуулийн 11 дүгээр зүйлд "ашигтай загвар"-ын мэдүүлэгт шүүлт хийх тухай огт тусгагдаагүй байтал уг зүйлийн 11.2,11.3-ыг энэ зүйлд ишлэл болгосон нь учир дутагдалтай болсон байна.

4.2. Зөвлөмж

Судалгааны хүрээнд хамаарч буй хуулийн зүйл, заалтад хийсэн үнэлгээний дүнг харгалзан Патентийн тухай хуулинд 2 дугаар бүлэгт дараах зохицуулалтуудыг нэмж тусгах шаардлагатай гэсэн **Зөвлөмж** гаргаж байна.

Үүнд:

1) Аж үйлдвэрийн өмчийн эрхийн гурван үндсэн объект болох шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварт холбогдох хамгийн гол зохицуулалтууд (мэдүүлэг гаргах, хайлт шүүлт хийх)-ыг ганц бүлэгт багтаан цөөн хэдэн зүйл (7-12 дугаар зүйл) болгон нэг дор тусгаснаас мэдүүлэг гаргагчид хоорондын ялгааг нь ойлгохгүй, төөрөгдөл үүсгэх, улмаар мэдүүлгийг сольж өгөх зэрэг асуудал олноор гарч хэрэглэгчдэд хүндрэл учруулж байгаад дүгнэлт хийж, эдгээр гурван обектийн зохицуулалтыг салгаж, тус тусд нь бүлэг, зүйл болгон, зохицуулалтыг нь илүү нарийвчлан дэлгэрүүлэх;

2) Мэдүүлгийн бүрдлийг хянах хугацааг хоёр өөрөөр тогтоосныг эргэн нягталж нэг мөр болгох, эдгээр хугацааг уртасгах боломжийг судлах;

3) Хуульд заасан хугацаанд (10.3) багтаан мэдүүлэг гаргагч мэдүүлэгт нэмэлт засвар хийсэн боловч тухайн мэдүүлэг дахиад бүрдлийн шаардлага хангаагүй хэвээр байвал яах вэ гэдэг асуудлын зохицуулалтыг тодорхой болгох;

4) Хуулиар тогтоосон хугацаанд (10.4) мэдүүлэг гаргагч мэдүүлэгт нэмэлт, засвар хийж ирүүлээгүй бол тухайн мэдүүлгийг **гаргаагүйд** тооцохоор заасныг эргэн нягтлах. Уг заалтын агуулга Патентийн тухай хуулийн 3.1.7-той зөрчилдсөн шинжтэй байгаагаас гадна энэ тохиолдолд өөр байдлаар (татгалзах) шийдвэрлэх гарц, боломж бий эсэхийг судалж, зохих ёсоор хуулинд тусгах;

5) Мэдүүлгийн **“бүрдлийг хянах”** болон “**мэдүүлгийн бүрдлийн шаардлагад шүүлт”** хийх ажиллагааны ялгаа, зохицуулалт тодорхойгүйгээс хуулийг хэрэглэхэд ихээхэн хүндрэл үүсч байгааг онцгойлон анхаарч, тэдгээрийн зааг, ялгааг сайтар тодорхойлж, зохицуулалтыг нь илүү нарийвчлах, цаашлаад зарим улс орны мэдүүлгийн **бүрдүүлэлтэд шүүлт хийдэг шинжээч** ажиллуулдаг туршлагыг судалж, хэрэгжүүлбэл хуулийн хэрэгжилтэд илүү эерэг үр нөлөө үзүүлэх боломжтойг анхаарах;

6) Хуульд шүүлтийн дүгнэлтийг үндэслэн, патент олгох эсэх шийдвэрийг 9 сарын дотор (11.9) гаргахаар, **шаардлагатай гэж үзвэл** 12 сар хүртэл хугацаагаар сунгаж (11.10) болохоор заасан ба “шаардлагатай гэж үзвэл” гэдэгт юуг хамааруулж ойлгох нь тодорхойгүй, түүнчлэн эдгээр хугацаа практикт огт нийцдэггүй тухай судалгаанд хамрагдсан байгууллагуудын төлөөллүүд санал нэгтэй шүүмжилж байсан тул уг асуудлыг тусгайлан анхаарч Олон улсын гэрээ, хэлэлцээрийн агуулгад нийцүүлэн өөрчлөх; Олон улсын туршлагаас харахад энэ хугацаа 3-10 жил үргэлжилдэг байна.

7) Мэдүүлэгт шүүлт хийхтэй холбоотой зохицуулалт хуульд дутуу дулимаг тусгагдсаны дотор **“хайлт”** хийх ажиллагаа огт тусгагдаагүй орхигдсоныг анхаарч, холбогдох зохицуулалтыг Патентийн хамтын ажиллагааны гэрээнд заасан процедурт нийцүүлж боловсруулах;

8) Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийг цахим хэлбэрээр гаргах зохицуулалтыг бүхлээр нь өөрчилж, практикт хэрэгжүүлж болохуйц, цогц, оновчтой байдлаар шинэчлэн найруулах;

9) Патентийн хамтын ажиллагааны гэрээний дагуу олон улсын мэдүүлэг гаргах бүлгийг бүхэлд нь өөрчлөн, олон улсын гэрээний дагуу мэдүүлэг гаргах журмын төслийг хамтад нь зэрэгцүүлэн боловсруулж, мөн хуулийн зохицуулалтыг олон улсын холбогдох гэрээ, хэлэлцээрийн стандарт, шаардлагад нийцүүлж шинэчлэн найруулах;

10) Патентийн тухай хуулиар ”Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах, бүртгэх”-тэй холбоотой дүрэм, журам гаргах эрхийг аль нэг субъектэд олгоогүй тул Шадар сайдын 2006 оны 57 дугаар тушаалаар баталсан “журам” шүүхийн шатанд хууль зүйн хувьд хүчин төгөлдөр бусад тооцогддог болохыг анхаарах;

11) Хуульд ашигтай загварын мэдүүлэгт магадлан шүүлт хийх хугацааг хэтэрхий богино (12.1-д 1 сар) байхаар тусгасан нь бодит байдалд нийцэхгүй байгаа тухай хууль хэрэглэгчдээс гарсан шүүмжлэлийг анхаарч, хугацааг уртасгах боломжийг судалж тусгах. Бусад орны туршлагаас харахад уг хугацаа ОХУ-д хоёр сар, БНХАУ-д гурван жил байдаг байна.

12) УИХ-ын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2016-2020 онд боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 141-д, ХЗДХЯ-ны 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.1.21-д Патентийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгасан бөгөөд судалгааны хүрээнд хамрагдсан асуудлын тухайд энэхүү хуулиар зохицуулах харилцааны хамгийн гол хэсэг бөгөөд үүнийг дагаад бусад хэсэгт нь нилээд өөрчлөлт орж, хуулийн бүтэц бүхэлдээ хөдлөх магадлал байгаа тул **“шинэчилсэн найруулгын төсөл” боловсруулах шаардлага** гарч болзошгүйг анхаарах;

13) Эцэст нь судалгааны хүрээнд хамааралгүй боловч судалгааны үеэр зохион байгуулагдсан фокус ярилцлага, семинар, уулзалт, ярилцлагад оролцогчдын зүгээс цөөнгүй санал, мэдээлэл зарим шүүмжлэл гарч байсан гурван асуудлын талаар товч дурдах нь зүйтэй гэж үзэв. Үүнд:

- **“Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч”**-ийн эрх хэмжээ, чиг үүрэгтэй холбоотой зохицуулалт хуульд маш бүрхэг тусгагдсан (27.1-27.4)-ыг тодруулж, дэлгэрүүлэн хуульчлах;
- Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгт (26.1.12-т) шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын **үнэлгээг** зохиогчийн хүсэлтээр баталгаажуулахаар заасан нь ойлгомж муутайн гадна Патентийн тухай хуулиар тусгайлан эрх олгоогүй байхад Оюуны өмчийн газрын даргын 2011 оны 65 дугаар тушаалаар “Оюуны өмчийн бүтээлийн үнэлгээ тогтоох, баталгаажуулах журам”-ыг баталж мөрдсөн нь хууль зүйн хувьд хүчин төгөлдөр бус болохыг анхаарч, энэ төрлийн харилцааны зохицуулалтыг Олон Улсын гэрээ хэлэлцээрийн агуулгад нийцүүлэн хуульчлах, эсхүл хуульд уг асуудлаар эрх олгосон хэм хэмжээ тусгах байдлаар шийдвэрлэх;
- Судалгааны үеэр Патентийн тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага болон хариуцлага ногдуулдах эрх бүхий субъектийн чиг үүрэг, эрх хэмжээтэй холбоотой асуудал цөөнгүй хөндөгдсөн ба уг асуудлыг “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх үед судалж, судалгааны тайланд (25-28, 30-31 хуудас) тусгасан тул уг судалгааг ашиглах боломжтой болно.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Нэг. Хууль тогтоомж, олон улсын гэрээ, бусад эрх зүйн акт

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Патентийн тухай хууль, 2006.
3. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах, бүртгэх журам батлах тухай Шадар сайдын 2006 оны 57 тоот тушаал.
4. Дэлхийн оюуны өмчийн байгууллага байгуулах тухай конвенци, 1978.
5. Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенци, 1983.
6. Бүтээгдэхүүний загварын олон улсын хадгалалтын тухай Гаагийн хэлэлцээр, 1999.
7. Патентийн хамтын ажиллагааны гэрээ, 1970.
8. Бүтээгдэхүүний загварын олон улсын ангилал тогтоох тухай Локарногийн хэлэлцээр, 1968.
9. Дэлхийн худалдааны байгууллагын Оюуны өмчийн эрхийн худалдаанд хамаарах хэлэлцээр, 1994.

Хоёр. Судалгаа, тайлан, төсөл, илтгэл, эмхэтгэл

10.“ОӨУБЕГ-ын аж үйлдвэрийн өмчийн эрхийн газрын үйл ажиллагааны тайлан, 2010-2016 он.

11.Оюуны өмч улсын бүргэлийн ерөнхий газрын Аж үйлдвэрийн өмчийн эрхийн газар, “Патентийн сангийн мэдээлэл (1963-1999, 2000-2016 он)”, УБ., 2016.

12.ОӨУБЕГ-ын Аж үйлдвэрийн өмчийн эрхийн газар, “Патентийн хамтын ажиллагааны гэрээний дагуу мэдүүлсэн шинэ бүтээлийн статистик”, УБ., 2016.

Гурав. Ном, сэтгүүл, гарын авлага

13.Батбаяр, Б., Мөнхжаргал, Т. Бүгд найрамдах хятад ард улсын оюуны өмчид холбогдох хууль тогтоомжийн эмхэтгэл, УБ., 2012.

14.Намжил, З. Патент-эрх зүйн оньс, УБ., 2000.

Дөрөв. Гадаад эх сурвалж

15.Патентный закон Российской Федерации, 1992.

Тав. Цахим эх сурвалж

16.http://chinalawinfo.ru/civil_law/law_patent/law_patent_ch1

17.https://ru.wikipedia.org wiki/%D0%9F%D0%B0%D1%82%D0%B5%D0%BD%D1%82

18.http://www.consultant.ru/document/Cons_doc_LAW_979a75ec5ec4892bac64bbb1b5_246d09cf5a8c2f31f/

19.http://www.consultant.ru/document/Cons_doc_LAW_979/5b89bee4ebb4f1a10ba24120_12a14bf4c8ec02c6/

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nji.gov.mn

Хавсралт 1.

Гадаад орны Патентийн хуулийн харьцуулалт

№	Зохицуулалт	Монгол Улсын Патентийн хууль, 2006.1.19-өөс мөрдөж эхэлсэн, 6 бүлэг, 30 зүйл, 3 удаа нэмэлт, өөрчлөлт орсон	ОХУ-ын Патентийн хууль, 1992.9.23-аас мөрдөж эхэлсэн, 8 бүлэг, 37 зүйл 3 удаа нэмэлт, өөрчлөлт орсон	БНХАУ-ын Патентийн хууль, 1984.3.12-оос мөрдөж эхэлсэн, 8 бүлэг, 69 зүйл 3 удаа нэмэлт, өөрчлөлт орсон
1.	Патентийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах байгууллага	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, ОӨУБЕГ	Эдийн засгийн хөгжлийн яаманд харьяалагдах Холбооны улсын оюуны өмчийн байгууллага	Төрийн зөвлөлийн харьяа Патентийн газар
2.	Мэдүүлэг хүлээн авах байгууллага	7.1.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийг зохиогч, түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн, хуулийн этгээд оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.	2 дугаар зүйл. Холбооны оюуны өмчийн байгууллага нь энэхүү хуулиар заасан шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын эрх зүйн хамгаалалтын хүрээнд төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг хариуцна.	3 дугаар зүйл. Төрийн Зөвлөлийн харьяан дахь Патентийн газар нь нийт улсын хэмжээний патентийн ажлыг эрхлэн хариуцна. Муж, өөртөө засах орон болон шууд харьяа хотын удирдлагын харьяан дахь патентийн асуудал хариуцсан захиргааны байгууллага нь харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд патентийн асуудлыг эрхлэн хариуцна.
3.	Мэдүүлэг гаргахтай холбогдсон зохицуулалт	7.2.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар бүрд тусдаа мэдүүлэг гаргах бөгөөд нэг зориулалттай, нэгдмэл байдлаар ашиглагдах шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварт нэг мэдүүлэг гаргаж болно.	Шинэ бүтээл (§16), ашигтай загвар (§17), бүтээгдэхүүний загвар (§18) тусд нь зохицуулсан байх тул хэрэглэхэд хялбар, ойлгомжтой байна. Жишээ нь: 16.1-д нэг буюу хэдэн хэдэн шинэ бүтээлийн мэдүүлэг нь нэгдмэл шинэ бүтээлийн сэдлийг агуулсан, өөр хоорондоо холбоотой бол нэг патентийн мэдүүлэг гаргаж болно гэж заасан.	31 дүгээр зүйл. Шинэ бүтээл буюу ашигтай загварын патентийн нэг шинэ бүтээл буюу ашигтай загварт патент авахаар хүсэлт гаргана. Нэг санаа бүхий хоёроос дээш шинэ бүтээл буюу ашигтай загварт нэг мэдүүлэг гаргаж болно. Нэг төрлийн бүтээгдэхүүний загварт нэг мэдүүлэг гаргана. Адил төрлийн зүйлд хэрэглэх, иж бүрдүүлэн худалдах буюу хэрэглэх бүтээгдэхүүнийг хоёроос дээш бүтээгдэхүүний загварт нэг мэдүүлэг гаргаж болно.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ САН
www.legal.gov.mn

4.	Үйлчилгээний хураамж, татвартай холбоотой зохицуулалт	7.11.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэгт үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.	16.2 Шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын мэдүүлгийг нэг буюу хэд хэдэн мэдүүлэгт тогтоосон хэмжээгээр патентийн татвар төлснийг баталсан баримт бичиг эсвэл патентийн татвараас чөлөөлөх үндэслэл бүхий баримт бичиг, эсвэл татварын хэмжээг багасгасан, төлбөр төлөхийг хойшлуулсан баримт бичгийг хавсаргасан байх ба ОХУ-ын Засгийн газар тогтооно.	Энэхүү харилцааг зохицуулсан зохицуулалт байхгүй байна.
5.	Мэдүүлгийн хэл	7.14.Мэдүүлгийг монгол хэлээр үйлдэх бөгөөд өөр хэлээр үйлдсэн тохиолдолд мэдүүлэг гаргагч оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад уг мэдүүлгийг ирүүлсэн өдрөөс хойш 2 сарын дотор монгол хэлнээ хөрвүүлж өгнө. 7.15.Энэ хуулийн 7.14-т заасан хугацаанд мэдүүлгийг хөрвүүлж өгөөгүй бол мэдүүлэг гаргаагүй гэж үзнэ гэж заажээ.	15.3 Шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патентийн өргөдлийг орос хэл дээр байна. Мэдүүлгийн бусад баримт бичгүүд орос болон бусад хэл дээр гаргаж болно. Хэрвээ мэдүүлгийн баримт бичиг бусад хэл дээр байгаа тохиолдолд, орос хэл дээрх орчуулгыг мэдүүлэгт хавсаргана гэж зохицуулсан.	Энэхүү харилцааг зохицуулсан зохицуулалт байхгүй байна.
6.	Цахимаар мэдүүлэг гаргах боломж	8 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийг цахим хэлбэрээр гаргах		28 дугаар зүйл. Мэдүүлгээ шууданаар явуулсан бол шуудангийн дарсан тэмдгээр мэдүүлэг гаргасан хугацаагаар тооцно.
7.	Олон улсын мэдүүлэг гаргахтай холбогдсон зохицуулалт	9.1.Монгол Улсыг нэр зааж гаргасан шинэ бүтээл, ашигтай загварын олон улсын мэдүүлгийн анхдагч огноог энэ хуулиар, эсхүл Патентийн хамтын ажиллагааны гэрээний дагуу бүртгүүлсэн олон улсын байгууллагын бүртгэлийн огноогоор тогтооно.	Хэрвээ улсын нууцыг агуулсан мэдээлэл агуулаагүй бол ОХУ-д бүтээгдсэн шинэ бүтээл, ашигтай загварын мэдүүлгийг Холбооны улсын оюуны өмчийн байгууллагад зохих мэдүүлэг гаргасан өдрөөс 6 сарын дотор олон улсын байгууллага, гадаад улсад гаргаж болно. Олон улсын давуу эрх хүссэн мэдүүлэг гаргагчаас үл шалтгаалан заасан хугацаанд мэдүүлгээ гаргаагүй бол энэ хугацаа нь хоёр сараас хэтрэхгүйгээр сунгагдаж болно	29 дүгээр зүйл. Мэдүүлэг гаргагчаас шинэ бүтээл буюу ашигтай загварынхаа тухай гадаад улсад анх удаа патентийн мэдүүлэг гаргасан өдрөөс эхлээд арван хоёр сарын дотор, бүтээгдэхүүний загварынхаа тухай гадаад улсад анх удаа патентийн мэдүүлэг гаргасан өдрөөс эхлээд зургаан сарын дотор, БНХАУ-ын мөн адил патентийн мэдүүлэг гаргасан байвал, тухайн улсын БНХАУ-тай тогтоосон гэрээ хэлэлцээр буюу аль алиных нь нэгдэн орсон олон улсын гэрээний ёсоор, эсхүл давамгайлах эрхийг харилцан зөвшөөрөх зарчмын дагуу давамгайлах эрхийг хэрэглэж болно.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

8.	Анхдагч огноо	10.1. оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлэг хүлээн авсан өдрөөс хойш 2О, ашигтай загварын мэдүүлэг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор түүний бүрдлийг хянаж, энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан шаардлагад нийцсэн бөгөөд мэдүүлгийн бүрдэл хангасан гэж үзвэл анхдагч огноог мэдүүлэг хүлээн авсан өдрөөр тооцно.	19.2 Шинэ бүтээл, ашигтай загварын талаар заасан хугацаанаас 12 сарын дотор, бүтээгдэхүүний загварын талаар 6 сарын дотор мэдүүлгээ Холбооны улсын оюуны өмчийн байгууллагад гаргасан байвал шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын давуу эрхийг Үндэсний болон аж үйлдвэрийн өмчийг хамгаалах Парисын тунхаглалын гишүүн орнуудад анхны мэдүүлгээ өгсөн өдрөөр тогтоож болно. 21.1. Холбооны улсын оюуны өмчийн байгууллагад гаргасан шинэ бүтээл нь энэ хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь заалтад заасны дагуу баримт бичгийг шалган, албан ёсны шүүлт явуулна. 21.2. Шинэ бүтээлийн мэдүүлэгт нэмэлт материал мэдүүлэг гаргагчид олгосон тохиолдолд энэ хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу өргөдөл гаргасан шинэ бүтээлийн мөн чанарыг өөрчлөх эсэхийг шалгана. 21.3. Шинэ бүтээлийн мэдүүлэг гаргасан анхдагч өдрийг албан ёсны шүүлт дууссаны дараа даруй мэдэгдэнэ. Шинэ бүтээл (§21.4.), ашигтай загвар (§23.4.), бүтээгдэхүүний загвар (§24.4.)-т Патентийн мэдүүлэг гаргагч баримт бичгийн шаардлагыг зөрчиж мэдүүлэг гаргасан бол мэдүүлэг гаргагчид хүлээн авсан өдрөөс 2 сарын дотор засвар оруулах санал өгнө. Харин Патентийн мэдүүлэг гаргагчнь тогтоосон хугацаанд баримт бичгийн бүрдүүлбэр гаргаагүй эсвэл хугацаагаа сунгах хүсэлт гаргаагүй бол уг мэдүүлгийг гаргаагүйд тооцно. Холбооны улсын оюуны өмчийн байгууллагань 10 сараас хэтрэхгүй хугацаанд сунгаж болно.	34 дүгээр зүйл. Төрийн Зөвлөлийн харьяа Патентийн газар нь шинэ бүтээлийн мэдүүлгийг хүлээж авсны дараа, урьдчилсан шүүлт хийсний дараа тус хуулийн шаардлагад нийцэж байна гэж үзвэл хүлээн авсан өдрөөс эхлэн 18 сарын дараа хэвлэлд нийтлэнэ. Төрийн зөвлөлийн харьяа Патентийн газраас мэдүүлэг гаргагчийн хүсэлт шаардлагыг үндэслэж мэдүүлгийг нь урьдчилан нийтлэж болно.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ
www.nli.gov.mn

9.	Мэдүүлэгт шүүлт хийх	11.3.Шүүлт хийх явцад буюу эцсийн шийдвэр гарахаас өмнө мэдүүлэг гаргагч анхныхаа ирүүлсэн тодорхойлолтын агуулгын хүрээнээс халихгүйгээр, мэдүүлэгтээ нэмэлт, өөрчлөлт хийж болно.	20.1. Мэдүүлэг гаргагч шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварт өөрчлөлт оруулах эрхтэй. Патент олгох шийдвэр гарах, татгалзах хүртэл шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын мэдүүлгийн мөн чанарыг өөрчлөхгүйгээр засвар оруулах эрхтэй. 20.3. Мэдүүлэг гаргагчийн санаачлагаар мэдүүлэг гаргасан өдрөөс хоёр сарын дотор нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд Патентийн татвар оногдуулахгүй.	33 дугаар зүйл. Мэдүүлэг гаргагч нь Патентийн мэдүүлэгтээ нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэхдээ шинэ бүтээл, ашигтай загвараар Патентийн мэдүүлэг гаргасан баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа анхны ирүүлсэн өргөдөл, тодорхойлолтын хүрээнээс халихгүй байна. Бүтээгдэхүүний загварын Патентийн мэдүүлэгт хамаарал бүхий баримт бичгийн нэмэлт, өөрчлөлтөө анхны гэрэл зураг эсвэл дүрслэлийн хүрээнээс халихгүй байна.
		11.9. оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мэдүүлгийн анхдагч огнооноос хойш 9 сарын дотор шүүлтийн дүгнэлтийг үндэслэн патент олгох эсэх талаар шийдвэр гаргана.	21.7. Мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр шинэ бүтээлийн мэдүүлэг гаргасан өдрөөс 3 жилийн дотор Холбооны улсын оюуны өмчийн байгууллага хайлтын дүнг үндэслэн патент олгоно.	35 дугаар зүйл. Шинэ бүтээлийн Патентийн мэдүүлгийг гаргасан өдрөөс эхлээд гурван жилийн дотор Төрийн зөвлөлийн харьяа Патентийн газар мэдүүлэг гаргагчийг хүссэн үед нь мэдүүлэгт нь мөн чанарын шүүлт хийж болно. Мэдүүлэг гаргагч уг хугацааны дотор багтаан мөн чанарын шүүлт хийлгэхээр хүсэлт гаргахгүй бол тус мэдүүлгийг буцааж авсанд тооцно. Төрийн зөвлөлийн харьяа Патентийн газар шаардлагатай гэж үзвэл шинэ бүтээлийн мэдүүлэгт бие даан мөн чанарын шүүлт хийж болно.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

10.	Магадлан шүүлт хийх	12.1.Мэдүүлгийн анхдагч огнооноос хойш 1 сарын дотор энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан эсэх, ашигтай загвараар бүртгэгдэх боломжтой эсэхэд шинжээч магадлан шүүлт хийж дүгнэлт гаргана.	23.1. Мэдүүлгийн анхдагч огнооноос хойш 2 сарын дотор энэ хуулийн 17 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг шинжээч магадлан шүүлт явуулна. Ашигтай загварын мэдүүлэгт магадлан шүүлт явуулахдаа энэ хуулийн 21 дүгээр зүйлийн 2,4,5,9,11,12 дугаар заалтыг баримтална. 23.11. Мэдүүлэг гаргагч магадлан шүүлтийн шийдвэр, мэдээллийн шүүлтийн тайлангийн бүх материалтай танилцах эрхтэй. Мэдүүлэг гаргагчийн хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш нэг сарын дотор Холбооны улсын оюуны өмчийн байгууллага мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр Патентийн баримт бичгийн хуулбарыг явуулна.	40 дүгээр зүйл. Ашигтай загвар буюу бүтээгдэхүүний загварын Патентийн мэдүүлэгт урьдчилсан шүүлт хийхэд Патентийн эрх олгохоос татгалзах үндэслэл байхгүй байвал Төрийн зөвлөлийн харьяа Патентийн газар ашигтай загвар буюу бүтээгдэхүүний загварыг Патентийн эрх олгох шийдвэр гаргаж, холбогдох Патентийн гэрчилгээ өгөхийн хамт бүртгэн авч зарлан нийтлэнэ. Ашигтай загварын Патентийн эрх буюу бүтээгдэхүүний загварын Патентийн эрх зарлан нийтэлсэн өдрөөс эхэлж хүчинтэй болно.

----o0o----

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ САН
www.nli.gov.mn

ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ЯЛЛАГДАГЧИД ҮЗҮҮЛЭХ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ТУХАЙ ХУУЛЬ[1]
Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан

Ерөнхий мэдээлэл:

Манай улсад “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлсэн туршлага, хүний нөөц, материаллаг баазад түшиглэн төлбөрийн чадваргүй иргэнд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлын эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор 2013 оны 7 дугаар сарын 5-ны өдөр Улсын Их Хурлаас “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль”-ийг баталсан.

“Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль”-д заасны дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд 2014 онд Хууль зүйн туслалцааны төвийг байгуулан төлбөрийн чадваргүй яллагдагчид дээрх хуулийн дагуу үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг Улсын өмгөөлөгч хариуцах болсон.

Улсын өмгөөлөгчдийг ажиллуулснаар төлбөрийн чадваргүйн улмаас өмгөөлөгч авах боломжгүй, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад эрхээ хамгаалж чадахгүй байгаа, эрх нь зөрчигдөх магадлал бүхий иргэдэд Монгол Улсын Үндсэн хуульд заасан хууль зүйн туслалцаа авах, хууль шүүхийн өмнө эрх тэгш байх эрхээ хэрэгжүүлэх нөхцөл, бололцоог төрөөс бүрдүүлж өгсөн төдийгүй Хууль зүйн салбар анх удаа “Улсын өмгөөлөгч” гэдэг статус бүхий өмгөөлөгчтэй болж, төлбөрийн чадваргүй яллагдагчид төрөөс улсын өмгөөлөгчөөр дамжуулан үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлж байна.[2]

Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн орчин нь “Үндсэн хууль”, “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль”, “Эрүүгийн байцаан шийтгэх хууль”, “Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль”болон бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

Тухайлбал Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6-д “төлбөрийн чадваргүй этгээд өмгөөлөгч оролцуулах хүсэлт гаргасан” бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх уг хэрэгт өмгөөлөгч оролцуулах эрхийг хангах үүрэгтэй талаар заажээ.

“Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль”-д зааснаар улсын өмгөөлөгч зөвхөн гэмт хэрэгт буруутгагдан шалгагдаж байгаа яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх байдлаар хязгаарлагдаж байна.

“Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль” батлагдан, Хууль зүйн туслалцааны төв байгуулагдан ажилласнаас хойших мэдээнээс үзэхэд 2014 онд 1891 хэргийн 2102 хүнд, 2015 онд 2888 хэргийн 3145 хүнд, 2016 онд 2482 хэргийн 2749 хүнд туслалцаа үзүүлжээ.[3]

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45.1.11-т “... төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах” гэж заасан

---

[1] Тус судалгааг хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Зүмбэрэллхам удирдан, эрдэм шинжилгээний ажилтан Б.Гончигсумлаа, М.Цэдэвсүрэн, МУИС-ийн Хувийн эрх зүйн тэнхмийн багш С.Батбаяр нар хамтран гүйцэтгэв.

[2] “Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх хууль зүйн туслалцааны хүртээмж” судалгаа. Хууль зүйн туслалцааны төв. УБ.,2016 он. 4 дэх тал.

[3] Хууль зүйн туслалцаан төвийн салбаруудын 2014, 2015, 2016 оны тоон тайлан.

бөгөөд Монголын Хуульчдын холбооны “Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хороо” хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Энэхүү судалгаагаар “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль”-д тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төсөл боловсруулах шаардлагатай эсэхийг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу гүйцэтгэв.

Судалгааны аргачлал:

Тус судалгааг гүйцэтгэхдээ Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу дараах үе шатаар хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Асуудалд дүн шинжилгээ хийх;
2. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томьёолох;
3. Тухайн асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож тэдгээрийн эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах;
4. Зохицуулалтын хувилбарын үр нөлөөг тандан судлах;
5. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийх;
6. Тухайн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийх;
7. Зөвлөмж боловсруулах.

Дээрх дараалллын дагуу нэгдүгээрт “Хууль зүйн туслалцааны тухай хууль”-д үүсэж буй асуудлыг тодорхойлохыг зорьсон болно. Үүний тулд холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт, ярилцлага хийх, өмнө хийгдсэн социологийн судалгаа, бусад статистик мэдээллийг ашигласан бөгөөд асуудлын мөн чанар, түүний цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй нийгмийн бүлэг бусад этгээд болон тухайн асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөлийг тус тус тодорхойлов.

Асуудлыг тодорхойлсны дараагаар асуудлыг шийдвэрлэх ерөнхий зорилгоо томьёолж, тухайн зорилгод хүрэх хувилбарыг тогтоосон. Тухайн үе шатанд асуудлыг шийдвэрлэх хувилбаруудыг зорилгод хүрэх байдлаар нь харьцуулан дүгнэж хамгийн оновчтой хувилбарыг сонгон авч үр нөлөөг судалсан.

Эцэст нь тухайн судалгааны хувилбаруудаас сонгон авсан хувилбарт үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал[4] /цаашид Аргачлал гэх/-ын 2.1-д заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль батлагдан хэрэгжсэнээс хойш 3 жил болж байна. 2014 онд улсын хэмжээнд 6375

[4] Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол. Нэгдүгээр хавсралт.

эрүүгийн хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэнээс 1895 хэргийн 2102 холбогдогчид буюу 31.1 хувьд, 2015 онд 6576 эрүүгийн хэрэг шийдвэрлэгдсэнээс 1787 хэргийн 3145 холбогдогчид буюу 43.9 хувьд, 2016 онд 5762[5] хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэнээс 2339[6] хэргийн 2572 холбогдогчид буюу 40.5 хувьд улсын өмгөөлөгч үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлсэн байна.

Харин 2016 оны байдлаар улсын өмгөөлөгч нь нийт өмгөөлөгчдийн 2.5[7] хувийг эзэлж байгаа ба 2014-2016 оны дунджаар нийт шийдвэрлэгдэж буй эрүүгийн хэргийн 40.8 хувьд улсын өмгөөлөгч оролцсон байна.

Хууль зүйн туслалцааны төвөөс 2016 онд хийсэн "Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх хууль зүйн туслалцааны хүртээмж" судалгаанд "**Хууль зүйн туслалцааны хүртээмжтэй байдлын талаарх нөхцөл байдал**"-ыг судлах зорилгоор 3 бүлэг */90 иргэн, 111 шүүх болон цагдаагийн алба хаагч, мөн тус төвийн 30 салбарын 44 улсын өмгөөлөгчийг тус тус хамруулсан бөгөөд судалгааны дүнг бүлэг тус бүрээр нэгтгэн гаргасан*/-ээс санал асуулга авсан байна.

Тухайлбал, судалгаанд хамрагдсан улсын өмгөөлөгчдийн дунд явуулсан санал асуулгаар[8] дараах дүн гарчээ. Үүнд:

Үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа нэн тэргүүнд шаардлагатай төлбөрийн чадваргүй бүлгийн тухай асуултад 90.9 хувь нь "сэжигтэн, яллагдагч", 50 хувь нь "хөгжлийн бэрхшээлтэй иргэд", 43.1 хувь нь "хохирогч", 43.1 хувь нь "насанд хүрээгүй этгээд", 18.1 хувь нь "иргэн болон захиргааны хэргийн зохигчид" хамрах боломжтой гэж хариулсан бол Улсын өмгөөлөгчийн хууль зүйн туслалцаа үзүүлэх чиг үүрэгт хамрагдахгүй этгээд болох эрүүгийн хэргийн хохирогч, иргэн болон захиргааны хэргийн оролцогчдын зүгээс хууль зүйн үнэ төлбөргүй үйлчилгээ авах хүсэлт хэр их гардаг тухай асуултад 50 хувь нь "байнга", 38.6 хувь нь "хааяа", 6.8 хувь нь "огт үгүй" гэсэн байна.

Харин Хууль зүйн туслалцааны төвийн чиг үүрэгт хамаарахгүй чиглэлээр[9] хууль зүйн туслалцаа авахыг хүссэн иргэдийн хүсэлтийг хэрхэн шийдвэрлэдэг тухай асуултад 29.5 хувь нь "Монголын Хуульчдын холбооны Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хороонд хүсэлтийг шилжүүлдэг", 9 хувь нь "Монголын Өмгөөлөгчдийн холбоо болон хүний эрхийг хамгаалдаг олон нийтийн байгууллагууд руу хүсэлтийг шилжүүлдэг", 34 хувь нь "бусад" хэлбэрээр шийдвэрлэдэг байна.

Түүнчлэн Улсын өмгөөлөгчид хандан анхан шатны хууль зүйн зөвлөгөө авч буй иргэдийн 69 хувь нь "иргэний хэрэг", 68.1 хувь нь "эрүүгийн хэрэг", 50 хувь нь "гэр бүлийн", 13.6 хувь нь "захиргааны хэрэг", 18.1 хувь нь "бусад" асуудлаар хандсан байна. Үүнтэй холбогдуулан Хууль зүйн туслалцааны төвөөс төлбөрийн чадваргүй эрүүгийн хэргийн хохирогч, иргэн, захиргааны хэргийн оролцогчид үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх шаардлагатай юу гэсэн асуултад улсын өмгөөлөгчдийн 40.9 хувь нь "тийм", 40.9 хувь нь "зарим тохиолдолд", 15.9 хувь нь "үгүй", 11.3 хувь нь "бусад" гэж хариулсан байна.

---

[5] Монгол Улсын шүүхийн 2016 оны шүүн таслах ажиллагааны тайлан. УБ.,2016 он. 11 дэх тал.

[6] Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааны 2014, 2015, 2016 оны тайлан.

[7] Монголын хуульчдын холбооны цахим хуудас. Хуульчдын тоо, нэгдсэн статистик. https://www.mglbar.mn/?action=content&view=category&layout=detail&id=23. 2017.03.06-ны өдөр зочилсон.

[8] "Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх хууль зүйн туслалцааны хүртээмж" судалгаа. Хууль зүйн туслалцааны төв. УБ.,2016 он. 13-14 дэх тал. Судалгаанд хэд хэдэн хариулт сонгох боломжтой санал асуулга авагдсан тул дүн нь давхардсан тоогоор илэрхийлэгдсэн болно.

[9] Захиргааны болон иргэний эрх зүйн маргаан.

Өөрөөр хэлбэл дээрх судалгааны дүнгээс үзэхэд зөвхөн төлбөрийн чадваргүй яллагдагч бус гэмт хэргийн сэжигтэн, хохирогч, иргэний хэргийн зохигч болон захиргааны хэргийн нэхэмжлэгчид үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө өгөх, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ, шаардлага байгааг харж болох юм.

Манай улсад Үндэсний Статистикийн хорооноос 2 жил тутамд Монгол Улсын Ядуурлын түвшний судалгааг гаргадаг ба хамгийн сүүлийн[10] буюу 2014 оны судалгааг харахад ядуурлын төвшин 21.6 хувь буюу 2012 оны үзүүлэлттэй харьцуулахад 5.9 хувиар буурсан үзүүлэлт гарсан байна[11]. Үүнээс үзэхэд ядуурлын түвшинд байгаа бүх хүнийг хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа шаардлагатай бүлэг гэж үзэхгүй ч нийт хүн амын ¼ нь ядуу байгаа нь бусад улстай харьцуулахад өндөр хувьтай үзүүлэлт бөгөөд тэр хэмжээгээр хууль зүйн туслалцаа авах төлбөрийн чадваргүй иргэдийн тоо их байна.

Хууль зүйн туслалцааны төвийн тоон мэдээнээс[12]үзэхэд улсын өмгөөлөгчдөөс хэрэг, маргааны төрөл харгалзахгүйгээр 2014 онд төлбөрийн чадваргүй 7351 хүнд, 2015 онд 8363 хүнд, 2016 онд 6631 хүнд тус тус хууль зүйн зөвлөгөө өгч ажилласан байна. Энэ нь нэг талаас Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн 17.2.2-т заасан улсын өмгөөлөгчийн хориглох үйл ажиллагаанд хамаарах боловч нөгөө талаас Хууль зүйн туслалцааны төв байгуулагдахаас өмнө Эрх зүйн туслалцааны төв хэргийн төрөл хамаарахгүйгээр хууль зүйн зөвлөгөө өгч ажиллаж байсан, иргэдийн дунд хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах бодит хэрэгцээ, шаардлага байгаатай холбоотой.

Мөн “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль”-ийн хэрэгжилт болон хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлын талаар салбарын мэргэжилтнүүдийн саналыг дараах байдлаар оруулав.

> Хууль нь зөвхөн эрүүгийн хэргийн яллагдагч гэж гарсан боловч эрүүгийн хэргийн хохирогч, иргэн болон захиргааны хэрэгт зөвлөгөө туслалцаа авч байгаа иргэд их байна. Энэ нь эрэлт хэрэгцээ байгааг харуулж байна. Эрх зүйн туслалцааны төв байх үед эрүү, иргэн, захиргааны хэрэгт туслалцаа үзүүлж байсан. Гэхдээ эрүүгийн хэрэгm голлон анхаарч байсан. “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль” гарсны дараа зөвхөн эрүүгийн хэрэгт ажиллах болсон. Зөвлөгөө авч байгаа хүмүүс маш их байна. Гэтэл энэ эрэлт байхад нийлүүлэлт алга. Голчлон ямар хэрэг маргаанд зөвлөгөө авч байсан гэдгийг судлах хэрэгтэй байна. Захиргааны хэрэгт голчлон газрын маргаан, иргэний хэрэгт үндэслэлгүйгээр ажлаас халагдсан, нийгмийн даатгал төлөөгүй, гэр бүл салалт, тэтгэвэр тэтгэмжийн асуудал байж болно. Иргэд манайхаар үйлчлүүлээд маш их сэтгэл хангалуун байдаг. Мөн нөгөө талаас улсын өмгөөлөгч нарыг яагаад зөвхөн эрүүгийн хэрэгт туслалцаа үзүүлж байгааг лавласан асуулт байнга ирдэг.
>
> *Хууль зүйн туслалцааны төвийн захиралтай хийсэн ярилцлагаас*

[10] 2016 оны албан ёсны статистик нь 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар хараахан гараагүй талаар салбарын мэргэжилтнээс авсан мэдээлэлд үндэслэв.

[11] Статистикийн Үндэсний хороо, Дэлхийн банк “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа” 2014 он.

[12] Тус тайлан дахь Хууль зүйн зөвлөгөө өгсөн хүний тоо нь давхардсан тоо болохыг анхаарна уу.

Ерөнхийдөө иргэн, захиргааны хэрэг дээр хууль зүйн туслалцаа үзүүлэх нь жаахан асуудалтай бөгөөд нийтийг хавтгайруулан хамруулж болохгүй гэж боддог. Харин тодорхой хүрээнд туслалцаа үзүүлж болох юм. Жишээлбэл гэр бүлийн маргаан, гэр бүл салалт, хүүхдийн тэтгэмжтэй холбоотой маргаанд хууль зүйн зөвлөгөө өгөх шаардлага ихээхэн гардаг. Тэдгээр иргэд шүүхэд хандах гэхээр улсын тэмдэгтийн хураамжаа ч төлөх боломжгүй байдаг. Хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх тал дээр манайх цөөхөн өмгөөлөгчтэйгөөс шалтгаалж бэрхшээл үүсдэг. Улсын өмгөөлөгч хохирогчийн өмгөөлөгчөөр хэрэгт орчихоор яллагдагч маань өмгөөлөгчгүй болчих гээд байдаг. Хуулийн гол үзэл санаа бол яллагдагч руу чиглэсэн шүү дээ. Тиймээс би хохирогчид туслалцаа үзүүлэхэд тохиромжгүй гэж үздэг. Өөрөөр хэлбэл бүх хохирогчийг хамруулан авч үзэх боломжгүй бөгөөд зарим бүлэгт л туслалцаа үзүүлэх ёстой. Жишээлбэл насанд хүрээгүй бэлгийн хохирогчид туслалцаа үзүүлэх нь маш чухал асуудал юм.

Улсын өмгөөлөгчтэй хийсэн ярилцлагаас

Энэхүү нийгмийн хэрэгцээ шаардлагыг үндэслэн төлбөрийн чадваргүй яллагдагчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах, төрөөс хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоо, зохион байгуулалт, эрх зүйн байдлыг тогтоох[13], хууль зүйн туслалцааны үйлчилгээг сайжруулах зорилгын хүрээнд улсын өмгөөлөгчийн цалин хөлсийг нэмэгдүүлэх, урамшуулал болон бусад нийгмийн баталгаагаар хангах, Хууль зүйн туслалцааны төвийн материаллаг бааз, хүний нөөцийг бэхжүүлэх асуудлууд одоогийн тогтолцоонд хөндөгдөж болох юм.

Улсын өмгөөлөгчийн цалин бол маш бага гэж боддог. Тэтгэврийн насны хүнд шинээр орон байр авах хэрэгцээ бага болохоор энэ цалингаараа өдөр хоногоо өнгөрүүлээд байж болдог. Харин ирээдүйтэй залуу хүмүүсийн хувьд хаанаа ч хүрэхгүй. Хувийн өмгөөлөгчийн нэг хэрэг дээр авдаг цалингийн талд ч хүрэхгүй мөнгөөр бүтэн сар ажилладаг. Ийм бага цалинтай учир чадвартай, сайн өмгөөлөгчдийн тогтвортой ажиллах боломжийг хаадаг. Ялангуяа хөдөө орон нутагт улсын өмгөөлөгчөөр ажиллах сонирхолтой хуульч байдаггүй.

Улсын өмгөөлөгчтэй хийсэн ярилцлагаас

Улсын өмгөөлөгчийн эрх зүйн статус тодорхой биш, мөн цалин хэт бага байна. Өмгөөлөгчийн цалинг прокурортой дүйцүүлж болох юм. Учир нь цалингийн босгыг өндөр тавьж өгвөл манайд чадвартай хүмүүс ажиллахаар ирнэ. Чанар бас чухал. Дээрх шалтгаан нь улсын өмгөөлөгчийн үйлчилгээний хүртээмжид шууд нөлөөлдөг. Хүн амын гуравны нэг хувь буюу найман зуун мянга гаруй иргэд ядуу байна. Энэ хүмүүст хүрч үйлчлэхэд манай орон тоо бүтэц багадаад байна. Дүүргүүдэд доод тал нь 8-10 өмгөөлөгч, орон нутагт 3 өмгөөлөгч ажиллах хэрэгтэй байгаа. Тэгэхээр нийт орон тоо 200 өмгөөлөгч болохоор байгаа юм. Иймд нэгд, статусыг тодорхой болгох хэрэг байна. Хоёрт, цалингийн асуудал байна. Хуучин нэг жишиг байсан юм. Тухайлбал, онц хүнд гэмт хэрэгт дөчин хэдэн мянган төгрөг ч билүү тийм байсан. Одоо тийм жишиг тогтоовол нэлээд өндөр гарна. Цалин бага учраас чадвар муутай, дөнгөж сургууль төгссөн ч юм уу, гүйлгээ ухаан бага хүмүүс л ирээд байна. Өөр хүн олдохгүй байна. Одоо манайд ажиллах хүмүүс дандаа тэтгэврийн насны хүмүүс байна. Иймд боловсон хүчний асуудал бас байдаг.

Хууль зүйн туслалцааны төвийн захиралтай хийсэн ярилцлагаас

Өөр нэг асуудал нь “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль”-аар төлбөрийн чадваргүй гэдгийг хэрхэн тогтоох тухай юм. Төлбөрийн чадваргүй болохыг дараах байдлаар тогтоож байна. Үүнд:

- Эрх бүхий байгууллагын баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн сан /цаашид “ӨМНС” гэх/-д орсон, амьжиргааны төвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхийн гишүүн;

- ӨМНС-д бүртгэлгүй боловч ядуурлын шугамаас доогуур орлоготой болохоо өөрөө тодорхойлсон хүн;

[13] Төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг.

- “Хүүхэд хамгааллын тухай хууль”-д заасан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хууль зүйн туслалцаа үзүүлэхээр заасан.

Гэвч гадаадын иргэн, харьяалалгүй хүний хувьд Монгол Улсад гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд тэдгээрийг төлбөрийн чадваргүй эсэхийг тодорхойлох зохицуулалт байхгүй тул хууль зүйн туслалцаа үзүүлэх боломжгүй байгаа ч Хууль зүйн туслалцааны төвөөс 2014, 2015 онд тус бүр 5, 2016 онд 11 гадаадын иргэн, харьяалалгүй хүнд хууль зүйн туслалцаа үзүүлжээ.

“Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хороо нь 2014 онд байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш 2 жилийн хугацаанд нийт 238 иргэний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн бөгөөд үүний 124 нь иргэний хэргийн оролцогч, 107 нь эрүүгийн хэргийн хохирогч, 7 нь захиргааны хэргийн оролцогч байжээ.[14] Хууль зүйн туслалцааны төв болон тус хорооноос нийт төлбөрийн чадваргүй 5247[15] иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлснээс Хороо нь 238 хүнд буюу 4.5 хувьд туслалцаа үзүүлжээ.

Монголын Хуульчдын холбооноос ирүүлсэн мэдээллээс үзэхэд “Уг хороонд сайн дурын гишүүнчлэлтэй 97 өмгөөлөгч бүртгэлтэй бөгөөд төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх хууль зүйн туслалцааны зардлыг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т “... төлбөрийн чадваргүй иргэнд үзүүлэх өмгөөллийн үйлчилгээний зардлыг төр хариуцна” гэж заасан боловч уг санхүүжилтийг хаанаас, яаж олгох, хэдий хэмжээний санхүүжилтийг ямар журмаар гаргах зэрэг асуудал нь тодорхой тусгагдаагүй байна. Иймд сайн дурын гишүүнчлэлтэй өмгөөлөгчид төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэхэд урамшууллын тогтолцоо бүрдээгүйгээс пробоно үйл ажиллагаа явуулах идэвхийг бууруулах, үйл ажиллагааг огт явуулахгүй байх, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол тууштай хамгаалагдахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна”[16] гэж дурдсан байна. Төлбөрийн чадваргүй иргэдэд тус хорооноос хууль зүйн туслалцааг үзүүлэх нь үйлчлүүлэгч өмгөөлөгчөө өөрөө сонгох боломжийг илүү олгох бол туслалцааны төвөөс энэхүү үйлчилгээг үзүүлэх нь хүртээмжийн хувьд илүү байх талтай.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар зүйлийн 5.3.10-т “Нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ” гэсэн зорилт тусгагдсан бөгөөд энэхүү зорилтын хүрээнд 4 арга хэмжээг төлөвлөн, түүнийгээ 2020 он хүртэл үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгажээ.

Иймд Аргачлалын 3-т заасны дагуу асуудалд дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, түүний мөн чанар, цар хүрээ, шалтгаан, нөхцөлийг тогтоож, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийн эрхэд тухайн асуудал хэрхэн нөлөөлж буй талаар авч үзсэн болно.

1.1.Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал

Дээр дурдсан нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхэд дараах асуудлууд голлон анхаарал татаж байна. Үүнд:

---

[14] Монголын Хуульчдын холбооны 2016 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 2/170 тоот албан бичгээр ирүүлсэн мэдээлэл.

[15] Хууль зүйн туслалцааны төв болон Монголын Хуульчдын холбооны 2014-2015 онд хууль зүйн үйлчилгээ үзүүлсэн нийт иргэдийн тоон үзүүлэлт.

[16] “Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх хууль зүйн туслалцааны хүртээмж” судалгаа. Хууль зүйн туслалцааны төв. УБ., 2016 он. 7 дахь тал.

-Хуулийн үйлчлэх хүрээ нь төлбөрийн чадваргүй гэмт хэргийн сэжигтэн, хохирогч, иргэний хэргийн зохигч болон захиргааны хэргийн нэхэмжлэгч нарт хамаарахгүй байна;

-Хэргийн төрөл харгалзахгүйгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд, насанд хүрээгүй иргэд, иргэний хэргийн хувьд гэр бүл, тэтгэмж гаргуулах маргааны зохигч нар улсын өмгөөлөгчөөс хууль зүйн зөвлөгөө авах хэрэгцээ шаардлага их байдаг, мөн захиргааны хэрэгт газрын маргаанд холбогдуулан хууль зүйн зөвлөгөө авч байна;

-Тус төвөөр үйлчлүүлж буй иргэдийн тоо, улсын өмгөөлөгчийн ажлын ачааллыг орон тоотой харьцуулахад өмгөөлөгчийн хүрэлцээ хангалтгүй байна;

-Улсын өмгөөлөгчийн эрх зүйн байдал тодорхойгүй, эдийн засаг, нийгмийн баталгаа хангалтгүй,улсын өмгөөлөгчдийн орон тоо цөөрч, мэргэшсэн чадварлаг өмгөөлөгч улсын өмгөөлөгчөөр ажиллах нөхцөл бүрдэхгүй байна;

-Хууль зүйн туслалцааны төвийн материаллаг бааз, хүний нөөц бэхжээгүй байна;

-Төлбөрийн чадваргүй гадаадын иргэн, харьяалалгүй хүнд хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн зохицуулалт байхгүй.

Эдгээр асуудлуудын хүрээнд судалгааны цар хүрээг одоогийн байгаа тогтолцоог сайжруулах хүрээнд “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль”-ийн үйлчлэх хүрээг өргөжүүлэх, улсын өмгөөлөгчийн эрх зүйн байдлыг тодорхой болгож, төрөөс улсын өмгөөлөгчийг эдэлбэл зохих эдийн засаг, нийгмийн баталгаагаар хангах замаар Хууль зүйн туслалцааны төвийн материаллаг бааз болон хүний нөөцийг бэхжүүлж, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах” гэж тодорхойлов.

1.2.Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлох[17]

Дээр тодорхойлсон цар хүрээтэй холбоотойгоор дараах нийгмийн бүлэг, бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байна гэж үзлээ.

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг		Нөлөөлж буй хэлбэр
1	Гэмт хэргийн хохирогч	Гэмт хэргийн хохирогч нь төлбөрийн чадваргүй тохиолдолд өөрийн өмгөөлүүлэх эрхээ эдлэх боломжгүй байна. Бодит байдалд хууль зүйн туслалцаа хэрэгцээтэй байдаг бүлэг бол гэмт хэргийн хохирогчид байдаг.
2	Иргэний хэргийн зохигчид болон захиргааны хэргийн нэхэмжлэгч	Иргэний хэрэгт гэрлэлт цуцлалтаас үүдэн хүүхдийн тэтгэмж гаргуулахтай холбогдох маргаан, захиргааны хэрэгт төрийн байгууллагын шийдвэрээс эд хөрөнгө, газраа хураалгасан маргааны нэхэмжлэгч төлбөрийн чадваргүй эсэхээс үл хамааран хууль зүйн туслалцаа авах боломжгүй байна.
3	Гадаадын иргэн, харьяалалгүй хүн	Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэгт холбогдсон гадаадын иргэн, харьяалалгүй хүний хувьд төлбөрийн чадваргүй байдлыг тогтоох зохицуулалтгүйгээс хууль зүйн туслалцаа авах эрх нь зөрчигдөж байна.

[17] Аргачлалын 3.1.2-т зааснаар “эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд”-ийг тодорхойлохоор байгаа. Харин манай тохиолдол нь “аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд”-ийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөөгүй тул энэхүү судалгааны 1.2 дахь хэсгийн нэршлээс эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөхгүй бүлгийг хассан болно.

4	Улсын өмгөөлөгч	Улсын өмгөөлөгчийн хувьд ажлын ачаалал их байдаг ч хуулиар өөр ажил хавсран эрхлэхийг хориглосон тул зөвхөн цалингийн орлоготой байдаг. Түүнчлэн албан тушаалын статус тодорхойгүйгээс бусад нийгмийн баталгааг эдлэх боломж бүрддэггүй.
5	Төлбөрийн чадваргүй яллагдагч	Улсын өмгөөлөгчийн цалин хөлс бага, нийгмийн баталгаа муу байдгаас хамааран мэргэжлийн ёс зүй, ур чадвар өндөр, хариуцлагатай өмгөөлөгч нар улсын өмгөөлөгчөөр ажиллах нь ховор байдаг. Энэ нь улсын өмгөөлөгчийн үйл ажиллагааны чанарт тодорхой байдлаар нөлөөлж байгаа нь гарцаагүй.

Дээрх нөлөөллийн улмаас Монгол Улсын Үндсэн хуульд заасан шударга шүүхээр шүүлгэх, хууль зүйн туслалцаа авах эрхээ зөвхөн төлбөрийн чадваргүй яллагдагч эдлэх, цаана нь гэмт хэргийн хохирогч, иргэний болон захиргааны хэргийн төлбөрийн чадваргүй оролцогч боломжоор хангагдахгүй үлдэж байна.

Нөгөө талаас бодит байдалд улсын өмгөөлөгч нь зөвхөн төлбөрийн чадваргүй яллагдагчаас гадна гэмт хэргийн хохирогч, сэжигтэн, иргэний хэргийн зохигч, захиргааны хэргийн нэхэмжлэгчид үндсэн чиг үүргээс гадуур хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгч байгаа нь улсын өмгөөлөгчид ашиг сонирхлын зөрчил үүсгэх, хийж буй ажлаа бодитоор үнэлүүлж чадахгүй байх зэрэг үр дагаврыг үүсгэж байна.

1.3.Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл

“Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль”-д үүсэж буй зарим асуудлын шалтгаан нөхцөлийг дараах байдлаар багцлан авч үзэв.

Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Хууль зүйн туслалцаа авах эрх бүхий хүн нь төлбөрийн чадваргүй яллагдагч байна“ гэж заасан бол Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6-д “төлбөрийн чадваргүй этгээд өмгөөлөгч оролцуулах хүсэлт гаргасан бол заавал өмгөөлөгчтэй оролцуулах”-аар зохицуулсан нь гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, хохирогч, шүүгдэгч бүгдэд нь хамааралтай. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 19.1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”, Арван зургадугаар зүйлийн 16.14-т “... эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ... өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах ...” эрхийг иргэн бүр эдлэхээр заасан. Түүнчлэн дээр дурдагдсан судалгаанаас үзэхэд зөвхөн төлбөрийн чадваргүй яллагдагч бус гэмт хэргийн сэжигтэн, хохирогч, иргэний хэргийн зохигч болон захиргааны хэргийн нэхэмжлэгчид үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ, шаардлага байгааг тодорхой харж болох юм. Гэтэл Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль нь зөвхөн төлбөрийн чадваргүй нь тогтоогдсон яллагдагчид хамааралтай байхаар зохицуулсан нь энэхүү хуулийн зохицуулалтын хүрээг хязгаарлаж, яллагдагчаас бусад төлбөрийн чадваргүй иргэд хууль зүйн туслалцаа авах, өмгөөлүүлэх эрхээ эдлэх боломжгүй нөхцөлд хүргэж байна.

Хуулийн үйлчлэлийн хугацаа
www.zali.gov.mn

Эрүүгийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн этгээдэд энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан тул гадаадын иргэн, харьяалалгүй хүнд хууль зүйн туслалцаа үзүүлэх хэрэгцээ гардаг. Гэвч төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуульд гадаадын иргэн, харьяалалгүй хүний төлбөрийн чадваргүйг тодорхойлох талаар зохицуулаагүй тул хууль зүйн туслалцаа үзүүлэх боломжгүй байна. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх конвенцын 20 дугаар зүйлд “Иргэний болон худалдааны хэргийн талаар хэлэлцэн тохиролцогч улс бүрийн иргэд нь хэлэлцэн тохирогч бусад бүх улсад үнэ төлбөргүй эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хууль тогтоомжийнх нь дагуу эдгээр улсуудын иргэдийн адил үнэ төлбөргүй эрх зүйн туслалцаа авна” гээд захиргааны хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлж буй улсуудад тухайн хэргийг эрх бүхий шүүх хэлэлцэхэд иргэний хэргийн талаарх зохицуулалт мөн адил хэрэглэгдэхээр тус тус заасан нь манай улсын хувьд гадаадын иргэн, харьяалалгүй хүнд ч нэгэн адил үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх үүрэгтэй болохыг харуулж байна.

Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг төрийн албан хаагч гэнэ” гэсэн бол улсын өмгөөлөгч нь Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллахаар заасан ба ажлын байр нь байнгын, төрийн чиг үүргийг гүйцэтгэсний төлөө төрөөс тогтмол цалин авч, ажиллах нөхцөл нь төрөөс хангагддаг. Гэтэл улсын өмгөөлөгч төрийн албан хаагчийн статуст хамаарах, эвсэл төрийн байгууллагад гэрээгээр ажиллаж буй хуульч эсэхийг тодорхой заагаагүйгээс төрийн албан хаагчийн баталгаагаар хангагдах эсэх нь тодорхойгүй байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/133/437 тоот тушаалаар Хууль зүйн туслалцааны төвийн бүтэц, орон тоог шинэчлэн батлагдсан бөгөөд нийт 92 орон тоотой байсныг 52 орон тоотой болгож бууруулсан байна. Энэ нь жил бүр нэмэгдэж байгаа үйлчлүүлэгчийн эрэлтийг бүрэн хангахгүй, хууль зүйн туслалцааны чанарт нөлөөлөх, алслагдсан орон нутгийн иргэд хууль зүйн туслалцаа авах боломжийг хязгаарлах нөхцөл болж байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Хэдийгээр “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль” батлагдсанаар гэмт хэрэгт холбогдсон яллагдагчийн хувьд хууль зүйн туслалцаа авах эрхээ хэрэгжүүлэх, хамгаалуулах нөхцөл бүрдсэн ч дээр дурдсан эрх зүйн асуудал болон нийгмийн бодит хэрэгцээ шаардлага үүссээр байна.

Иймд аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

Зорилго: “Төлбөрийн чадваргүй нийгмийн зорилтот бүлгийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хүртээмжтэйгээр хангах”

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ КҮРЭЭЛЭНГ www.legalaid.mn

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу "Төлбөрийн чадваргүй нийгмийн зорилтот бүлгийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хүртээмжтэйгээр хангах" зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эрэг өөрчлөлтийг харьцуулан дараах дүгнэлтийг гаргалаа.

Асуудлыг зохицуулж болох хувилбаруудын эрэг болон сөрөг тал

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах	Өнөөгийн тулгамдаж буй бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй бөгөөд тулгамдсан асуудал хэвээр үргэлжилнэ.	Үр дүн сөрөг
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Өнөөгийн тулгамдаж буй бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд асуудлыг шийдвэрлэх боломжгүй.	Зардал зохих хэмжээнд шаардагдана. Асуудлыг үүсгэх гол шалтгааныг арилгаж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Хууль зүйн туслалцаа үзүүлэх хүрээ болон тулгамдсан харилцааг хуулиар тогтоосон тул зах зээлийн хэрэгслийг ашиглан төрөөс зохицуулалт хийх замаар шийдвэрлэх боломжгүй.	Зардал шаардагдана. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Иргэдийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангахад тодорхой санхүүжилт шаардлагатай ч хуулиар тогтоосон зохицуулах харилцааг өөрчлөх боломжгүй	Зардал шаардагдана. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУУЛЬ
www.legal.gov.mn

5	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх ажиллагааг мэргэжлийн холбоо /Монголын Хуульчдын холбооны Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хороо/-д төрөөс санхүүжилт олгох замаар шийдвэрлэж боломжтой. Мөн 1994 онд баталсан Өмгөөллийн тухай хуулиар өмгөөлөгч жилд 2 удаа төлбөрийн чадваргүй иргэнийг өмгөөлөхөөр зохицуулсныг агуулгаар нь сэргээх замаар өмгөөлөгчид төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үүргийг хүлээлгэх нь төрийн ачааллыг бууруулах төлөвтэй байна.	Мэргэжлийн холбооноос Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэхэд тодорхой хэмжээний зардал шаардагдана. 2007-2010 он хүртэл нийт 4982 иргэн өмгөөлөгч томилуулахаар хүсэлт гаргасан бөгөөд 5036 холбогдогчид 1718 өмгөөлөгч томилон ажиллажээ. Уг ажиллагаанаас үзэхэд өмгөөлөгчид тодорхой тооны иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үүрэг хүлээлгэх нь улсын төсөвт дарамт учруулахгүй байх давуу талтай байна. Төлбөрийн чадваргүй иргэд маргааны төрөл харгалзахгүйгээр мэргэжлийн чадварлаг олон өмгөөлөгчөөс сонгож хууль зүйн туслалцаа авах боломжтой.	Үр дүнтэй
6	Захиргааны шийдвэр гаргах	Гадаадын иргэн, харьяалалгүй хүний төлбөрийн чадваргүй байдлыг тодорхойлох журмыг захиргааны шийдвэрээр тогтоож болох ч хуулийн зохицуулалтын хүрээг өргөжүүлэх, албан тушаалын статусыг тодорхойлох боломжгүй.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
7	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуульд тулгамдаад байгаа бэрхшээл, асуудлыг шийдвэрлэх бөгөөд зорилгод хүрэх боломжтой.	Зардал гарах боловч энэ нь хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой.	Үр дүнтэй

Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх замаар иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

төрөөс зохицуулалт хийх, эсхүл төрөөс санхүүгийн интервенц хийх, захиргааны шийдвэр гаргаснаар тухайн асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэж, дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжгүй юм.

Иймд асуудлын мөн чанар, цар хүрээ болон нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хуулийн зохицуулах харилцааг өргөжүүлэх, хууль зүйн туслалцааны чанар, үр өгөөжийг дээшлүүлэх зорилтод хүрэхийн тулд одоо байгаа тогтолцооны хүрээнд "Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр хуулийн төслийг боловсруулах, эсхүл одоо байгаа тогтолцоог өөрчлөх, тус тогтолцоотой хамт бусад хэлбэрийн хууль зүйн үнэ төлбөргүй туслалцааны аргыг судалж хуулийн төсөл боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Ингэхдээ "Төлбөрийн чадваргүй нийгмийн зорилтот бүлгийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хүртээмжтэйгээр хангах" зорилгын хүрээнд дараах зохицуулалтын хувилбарыг дэвшүүлэв.

Хувилбар 1. Төлбөрийн чадваргүй иргэдийн үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах эрхийг хангахад одоогийн байгаа тогтолцооны хүрээнд хуулийн зохицуулалтын хүрээг өргөжүүлэх, улсын өмгөөлөгчийн орон тоог нэмэх, тэдний нийгэм, эдийн засгийн баталгааг хангах.

Хувилбар 2. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т "... төлбөрийн чадваргүй иргэнд үзүүлэх өмгөөллийн үйлчилгээний зардлыг төр хариуцна" гэж заасныг үндэс болгон хувийн өмгөөлөгчдийг оролцуулах замаар хууль зүйн туслалцааны хүртээмжийг нэмэгдүүлэх.

Хувилбар 3. 1994 оны Өмгөөллийн тухай хуульд[18] "Өмгөөлөгч жилд хоёр удаа төлбөрийн чадваргүй иргэнийг өмгөөлөх үүрэгтэй", "Хууль зүйн туслалцаа хүсэгч нь төлбөрийн чадвар болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар өмгөөлүүлэх эрхээ өөрөө хэрэгжүүлэх боломжгүй, түүнчлэн өмгөөлөгчөө сонгон авч чадаагүй тохиолдолд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах болон шүүх, прокурорын байгууллага энэ тухай Холбоо, түүний аймаг, нийслэлийн салбар зөвлөлд мэдэгдэн өмгөөлөгч томилуулах арга хэмжээ авах үүрэгтэй" гэсэн агуулгатай зохицуулалтыг хуульд дахин тусгах замаар төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх хууль зүйн туслалцааны хүртээмжийг нэмэгдүүлэх.

Нэгдүгээр хувилбарын хувьд төлбөрийн чадваргүй этгээдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллага байгуулагдаж, улсын өмгөөлөгчийг ажиллуулснаар зөвхөн төлбөрийн чадваргүй этгээдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээг түргэн, шуурхай явуулах боломжийг бүрдүүлнэ. Үүнийг иргэд болон шүүх, цагдаагийн ажилтнуудаас авсан судалгааны дүнгээс үзэхэд энэхүү тогтолцоо нь үр дүн сайтай, нийгмийн тодорхой бүлгийн эрэлт хэрэгцээг хангаж байгаа тул зохистой хувилбар байж болно.

Хоёрдугаар хувилбарын хувьд Монголын Хуульчдын холбоонд "Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хороо" байгуулагдан ажиллаж байгаа боловч хуульд заасны дагуу төрөөс өмгөөллийн зардлыг даахаар зохицуулсан хуулийн заалт хэрэгжихгүй байгаа тул төдийлөн үр дүнгээ өгөөгүй байна. Гэсэн ч энэхүү хувилбарын хувьд төрөөс өмгөөллийн зардлыг гаргаж, хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулбал үйлчлүүлэгч олон өмгөөлөгчөөс өмгөөлөгчөө сонгох боломжтой болно. Харин хууль зүйн туслалцаа үзүүлэх нэгдсэн байгууллага байхгүй болж өмгөөлөгчийн хууль зүйн туслалцааны үр дүнг үнэлэх, үйлчлүүлэгчид түргэн шуурхай хууль зүйн туслалцаа үзүүлэх ажилд хяналт тавих боломж сулрах талтай.

[18] 2012 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар хүчингүй болсон.

Гуравдугаар хувилбарын хувьд өмнө нь манай улсад хэрэгжиж байсан тогтолцоо бөгөөд өмгөөлөгч бүрд жилд тодорхой тооны төлбөрийн чадваргүй иргэнд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх үүргийг ногдуулах нь бага зардлаар асуудлыг шийдвэрлэх боловч өмгөөлөгч тухайн хэрэгт идэвх зүтгэлгүй хандах, өмгөөлөгчид хандсан төлбөрийн чадваргүй иргэдэд татгалзах, үүний улмаас төлбөрийн чадваргүй иргэд хууль зүйн туслалцааг хүртээмжтэй авах боломж хомсдох сул талтай.

Зохицуулалтын хувилбаруудад хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа авахыг хүссэн гадаадын иргэн, харьяалалгүй хүний төлбөрийн чадваргүй байдлыг тогтоох аргачлалыг судалж хуульчлах шаардлагатай .

Иймд дээрх гурван хувилбараас 1 болон 2 дугаар хувилбар судалгаагаар дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжтой гэж үзэж тус хоёр хувилбарын үр нөлөөг зорилгод хүрэх байдал болон зардал, үр өгөөжийн харьцаагаар харьцуулан авч үзье.

Зорилгод хүрэх байдал:

Хувилбар 1. Томьёолол: Төлбөрийн чадваргүй иргэдийн үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах эрхийг хангахад одоогийн байгаа тогтолцооны хүрээнд хуулийн зохицуулалтын хүрээг өргөжүүлэх, улсын өмгөөлөгчийн орон тоог нэмэх, тэдний нийгэм, эдийн засгийн баталгааг хангах.

Асуудлыг шийдвэрлэх зорилт нь төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны хүрээг өргөжүүлэх замаар нийгмийн зорилтот бүлгийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хүртээмжтэйгээр хангах явдал юм.

Хувилбар 1-ийн хүрээнд улсын өмгөөлөгчийн одоогийн ажлын ачаалал болон шинээр нэмэгдсэн чиг үүргийг харгалзан орон тоог нэмснээр төлбөрийн чадваргүй иргэдэд хүрч үйлчлэх, улмаар нийгэмд хууль зүйн туслалцааны хүртээмж нэмэгдэх зэрэг үр дүнд хүрэх боломжтой.

Хууль зүйн туслалцааны төв нь нийт 52 улсын өмгөөлөгчийн орон тоотойгоор ажиллаж байна. Өөрөөр хэлбэл улсын хэмжээнд төлбөрийн чадваргүй яллагдагч нарт 52 өмгөөлөгч хууль зүйн туслалцаа үзүүлж байна. Харин Хувилбар 2 нь дээрх цөөн тооны өмгөөлөгчдөөр хязгаарлах бус нийт өмгөөлөгчдөөс сонгон өмгөөлүүлэх боломжтой байгаа юм. Тус хувилбар нь зах зээлийн эдийн засгийн хувьд илүү тохиромжтой эсэхийг анхаарах хэрэгтэй байна.

Тухайлбал, Япон улсад эрүүгийн хэргийн холбогдогчид улсаас төлбөрийг гарган өмгөөлөгч томилдог тогтолцоотой байна. Улсаас өмгөөлөгч томилох ажлыг шүүхийн байгууллага гүйцэтгэдэг бөгөөд зардал, мөнгө нь ч шүүхээс гардаг ба шүүхээс аль өмгөөлөгч хэрэг дээр ажиллахыг нь зааж өгдөггүй байна. Шүүхээс өмгөөлөгчдийн холбоо руу хэргийн материалыг явуулан, түүнийг нь өмгөөлөгч нар үзээд өөрсдөө аль хэрэг дээр ажиллахаа сонгодог[19] туршлага байна.

Зардал, үр өгөөжийн харьцаа

Хувилбар 1-ийн хүрээнд одоо төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны зардлыг төр хариуцаж байгаа ч багагүй хэмжээний зардал гарч байгаа ба улс орны эдийн засгийн өнөөгийн нөхцөлд уялдуулан улсын өмгөөлөгч, Хууль зүйн туслалцааны төвийн ажлын албаны орон тоог цөөрүүлэх зэргээр зардлыг багасгах арга хэмжээ авч байна. Гэвч ийм нөхцөлд Хувилбар 1-д

[19] Мика Изка. Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх эрх зүйн туслалцаа. Өмгөөлөгч судлал. УБ.,2011 он, 290 дэх тал.

заасны дагуу хууль зүйн туслалцааны хүрээг өргөжүүлэх нь тус төвөөр үйлчлүүлэх иргэдийн тоо эрс нэмэгдэж, улсын өмгөөлөгчийн орон тоог нэмэгдүүлэх зэргээр улсын төсөвт багагүй ачаалал үүсгэх төлөвтэй байна. Хэрэв ачаалал болон эрэлт хэрэгцээнд захируулан орон тоо төсвийг нэмэгдүүлэх тохиолдолд төрөөс ихээхэн хэмжээний зардал гарахаар байна.

Тэгэхдээ одоогийн тогтолцоонд тус төвөөр үйлчлүүлэх төлбөрийн чадваргүй иргэдийн тоо нэмэгдэж тэр хэмжээгээр төлбөрийн чадваргүй иргэдийн зөрчигдсөн эрхээ сэргээх, хууль зүйн туслалцаа авч эрхээ эдлэх боломж нэмэгдэж буй тул гарах зардалтай харьцуулахад үр дүн сайтай хувилбар юм.

Зорилгод хүрэх байдал:

Хувилбар 2. Томьёолол: Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т "... төлбөрийн чадваргүй иргэнд үзүүлэх өмгөөллийн үйлчилгээний зардлыг төр хариуцна" гэж заасныг үндэс болгон хувийн өмгөөлөгчдийг оролцуулах замаар хууль зүйн туслалцааны хүртээмжийг нэмэгдүүлэх.

Энэхүү хувилбарын хүрээнд нэгэнт бий болсон Монголын Хуульчдын холбооны Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хороо болон иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлдэг төрийн бус байгууллага, өмгөөлөгч нарт төрөөс өмгөөллийн зардлыг олгох замаар иргэдийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хүртээмжтэй, сонголттойгоор хэрэгжүүлэх боломжтой. Гэхдээ төрөөс өмгөөллийн зардлыг гаргуулж аваад тухайн төлбөрийн чадваргүй иргэнд идэвхгүй, чанаргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх явдал гарахыг үгүйсгэхгүй ба өмнөх хувилбартай харьцуулахад хяналтын нэгдсэн тогтолцоо үгүй болно.

Зардал, үр өгөөжийн харьцаа

Хоёрдугаар хувилбар нь Нэгдүгээр хувилбартай харьцуулахад зардлын хувьд илүү хэмнэлттэй байх боломжтой. Тэгэхдээ төрөөс тухайн өмгөөлөгчид төлөх зардлын жишгийг сайтар тооцож тогтоохгүй бол төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэхдээ хэт өндөр төлбөр шаардах, бага үнийн дүнтэй хэрэгт үйлчилгээ үзүүлэхээс татгалзах зэргээр төлбөрийн чадваргүй иргэдийг хохироох эрсдэлтэй. Иймд энэ талын эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан зааж өгөх хэрэгтэй болно.

Түүнчлэн одоо байгаа тогтолцооны хувьд бага хэмжээний цалингаар мэргэжлийн өмгөөлөгчдийг өөр ажил хийх боломжгүйгээр зөвхөн төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулж байгаа нь зардлын хэмнэлтээс шалтгаалан үндсэн зорилго биелэгдэхэд сөрөг нөлөө үзүүлэх талтай байна. .

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу өмнөх үе шатанд сонгон авсан хуулийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Ингэхдээ "улс төрийн намын хатуу гишүүнчлэлээс татгалзах" болон Улс төрийн намыг төрөөс санхүүжүүлэх боломжийг нэмэгдүүлэх" хувилбаруудад хүснэгтийн дагуу хариулав.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг Хавсралт 1-ийн 1, 2, 3, 4 дүгээр хүснэгтээс үзнэ үү.

4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Хувилбар 1-ийн хувьд эрх нь зөрчигдсөн болон хууль зүйн үйлчилгээ авах боломжгүй төлбөрийн чадваргүй иргэдэд түргэн шуурхай хууль зүйн үйлчилгээ авах боломжийг бүрдүүлж Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан хүний эрх, эрх чөлөөг хангахад эерэг нөлөө үзүүлнэ.

Хувилбар 2-ийн хувьд төлбөрийн чадваргүй иргэн мэргэжлийн олон өмгөөлөгчөөс сонгож үйлчлүүлэх, түүнчлэн чанартай хууль зүйн туслалцаа авах боломжтой.

4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Хувилбар 1-ийн хувьд Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасны дагуу бүх санхүүжилтийг улсын төсвөөс гаргаж байна. Тус хуульд үүсэж буй асуудлыг шийдвэрлэж өөрчлөлт оруулах нь хууль зүйн туслалцааны хүртээмжийг нэмэгдүүлэх, улсын өмгөөлөгчийн орон тоог нэмэгдүүлэх, эдийн засаг, нийгмийн баталгааг хангахад чиглэгдэх тул багагүй хэмжээний нэмэлт зардал шаардагдах төлөвтэй юм. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 19.1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэсэн ба төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх, эрх, эрх чөлөөг хамгаалах нь төрийн үүрэг юм.

Хувилбар 2-ын хувьд байнгын орон тоо бүхий улсын өмгөөлөгчдийг ажиллуулж цалинжуулах шаардлага гарахгүйгээр төлбөрийн чадваргүй иргэн хууль зүйн туслалцаа авах хэрэгцээтэй үед улсаас сонгосон өмгөөлөгчид тогтоосон хэмжээний зардлыг санхүүжүүлэх нь улсын төсөвт үүсэх зардал бага байх боломжтой. Гэхдээ улсаас гаргах өмгөөлөгчийн зардлыг хэт багаар тогтоовол тухайн төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх өмгөөлөгчийн идэвх, сонирхлыг бууруулж болох талтай.

4.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосноор төлбөрийн чадваргүй иргэд хууль зүйн туслалцаа авах, хуулиар олгогдсон эрхээ эдлэх боломжийг бүрдүүлэх тул нийгэмд эерэг нөлөөтэй.

4.4.Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.5.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16.14-т “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах ...” Арван есдүгээр зүйлийн 19.1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.mli.gov.mn

зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна", НҮБ-ийн Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 7 дугаар зүйл "Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчлалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. Хүн бүр энэхүү Тунхаглалд харшлах аливаа алагчлалаас болон тийнхүү алагчлахыг өдөөсөн турхиралтаас адилхан хамгаалуулах эрхтэй", 11 дүгээр зүйлийн 11.1-д "Гэмт хэрэгт буруутгагдаж буй хэн боловч өмгөөлөх бүх боломжоор хангагдсан нээлттэй шүүх хурлаар гэм буруутайг нь хуулийн дагуу тогтоох хүртэл гэм буруугүй гэж тооцогдох эрхтэй" гэж тус тус заасан.

Иймд төлбөрийн чадваргүй иргэд ч шударга шүүхээр шүүлгэх, хууль зүйн туслалцаа авах, өмгөөлүүлэх эрхээр хангагдах эрхтэй ба Монгол Улсын Үндсэн хуулиар энэхүү үүргийг төр хариуцахаар заасан тул Монгол Улсын Үндсэн хууль болон Олон улсын гэрээ конвенцийн үзэл баримтлалтай нийцэж байна.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Судалгааны 3-р хэсэгт зардал үр өгөөжийн харьцааг зорилгод хүрэх боломжтой харьцуулан судалсны үндсэн дээр дээрх хоёр хувилбарын эерэг болон сөрөг талыг харьцуулан дүгнэлээ.

Гарч болох эерэг үр дагавар

Хувилбар 1-ийн хувьд иргэд хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх тусгай чиг үүрэг бүхий төрийн байгууллагаас түргэн, шуурхай үйлчилгээ авах боломж бүрдэж, хууль зүйн туслалцааны чанар, үр нөлөөг хянах нэгдсэн тогтолцоотой болно. Ингэснээр хууль зүйн туслалцааны чанар, хүртээмж сайжирч иргэдийн эрх зөрчигдөхөөс сэргийлэх, төрийн үйл ажиллагаанд итгэх нийгмийн итгэл дээшилнэ.

Хувилбар 2-ийн хувьд өмгөөлөгчийн жишиг зардлыг тогтоож, хууль зүйн үнэ төлбөргүй үйлчилгээнд өмгөөлөгчдийг идэвхтэй хамруулбал олон тооны мэргэжлийн өмгөөлөгчөөс сонгож үйлчлүүлэх, эрхээ хамгаалуулах боломж бүрдэнэ. Түүнчлэн улсын төсөвт үзүүлэх зардлын ачааллыг бага байлгах боломжтой.

Гарч болох сөрөг үр дагавар

Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээ конвенцийн үзэл баримтлалд хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдсөн эрхийг сэргээх, шударга шүүхээр шүүлгэх, хууль зүйн туслалцаа авах, өмгөөлүүлэх эрхээр хангагдах нь хүн бүрийн эдлэх эрх тул үүнийг хуулийн төсөл боловсруулах замаар шийдвэрлэх нь оновчтой хувилбар гэж дээр дүгнэсэн билээ.

Ингэхдээ төлбөрийн чадваргүй гэж тодорхойлогдсон бүх иргэн үнэ төлбөргүй хууль зүйн үйлчилгээ авах нь энэ төрлийн үйлчилгээ цаашид хавтгайрах, мэргэжлийн үйлчилгээ үзүүлж буй бусад хуульчдын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Иймд төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх хүрээг бодитойгоор тогтоох ёстой байна.

Хувилбар 1-ийн хувьд улсын өмгөөлөгчийн зардлыг улсад хариуцуулах нь төсөвт хэт их хэмжээний ачаалал үүсгэх эрсдэлтэй тул төлбөрийн чадваргүй иргэн ямар хэрэгт үнэ төлбөргүй хууль зүйн үйлчилгээ авах боломжтойг хязгаартайгаар тогтоох нь тохиромжтой. Өөрөөр хэлбэл дээрх зохицуулалтын 2 хувилбарын аль нь ч байсан хууль зүйн туслалцааны хүрээг хязгаартайгаар тогтоох нь зүйтэй байна.

Нөгөө талаас Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д "... төлбөрийн чадваргүй иргэнд үзүүлэх өмгөөллийн үйлчилгээний зардлыг төр хариуцна" гэж заасныг үндэс болгон төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэхэд хувийн өмгөөлөгчдийн оролцоог хангах арга замыг анхаарах хэрэгтэй юм.

Төлбөрийн чадваргүй иргэнд эрх зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх чиглэлээр тодорхой мэргэжлийн өмгөөлөгчдийн дунд тендер зарлах замаар төсөвлөсөн төсөвт багтаан уг үйлчилгээг зохион байгуулж чадах багийг сонгон шалгаруулж, тэр үүргийг үүрүүлэх ...[20] зэрэг хувилбарын үр нөлөөг тооцох, анхаарах нь ач холбогдолтой байна.

ЗУРГАА.ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Олон улсын эрх зүйн зохицуулалт

Олон улсын эрх зүйн зохицуулалтыг судлан үзэхэд эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай тусгайлан зохицуулсан олон талт “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх конвенц”, 2 талт “одоогийн байдлаар 20 оронтой эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ /иргэний, гэр бүлийн, хөдөлмөрийн, худалдааны, эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай/, 4 оронтой гэмт этгээдийг шилжүүлэх өгөх тухай гэрээ, 2 улстай ялтан шилжүүлэх тухай”[21] гэрээ байгуулжээ.

Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээнүүдийн агуулгаас харахад Иргэний хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэхэд гол төлөв нэхэмжлэл гаргах, шүүхийн зардлаас чөлөөлөгдөх, хэлэлцэн тохирогч нэг улсын нутаг дэвсгэр дээр нөгөө улсын тухайн асуудлаар гарсан шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх болон биелүүлэх журам ажиллагааг зохицуулдаг бол эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээгээр холбогдогч этгээдийн гэм буруугүйд тооцох зарчмын баталгаа, эрх зүйн туслалцаа авах эрх, гомдол гаргах эрх, эрх чөлөөг хангах[22] зэргийг голчлон зохицуулдаг байна.

Тухайлбал, манай улс Вьетнам[23] улстай байгуулсан гэрээний 18 дугаар зүйлд хууль зүйн үнэ төлбөргүй туслалцааг хэлэлцэн тохирогч тухайн талын иргэдийн нэгэн адил нөхцөл, хэмжээгээр авах бөгөөд энэ нь шийдвэрийг биелүүлэх ажиллагааг оролцуулаад тухайн хэргийн талаар явуулж байгаа байцаан шийтгэх бүх ажиллагаанд нэгэн адил хамаарахаар, Казахстан[24] улстай байгуулсан гэрээний 13 дугаар зүйлд шинжээч нарын үйлчилгээний хөлснөөс бусад тохиолдолд үнэ төлбөргүй эрх зүйн туслалцаа үзүүлэхээр, Энэтхэг[25] улстай байгуулсан гэрээний 15 дугаар зүйлд хэлэлцэн тохирогч нөгөө талын иргэний адил хэмжээ, нөхцөлөөр эрх зүйн үйлчилгээний төлбөрөөс чөлөөлөгдөхөөр тус тус заажээ.

Бусад орны эрх зүйн зохицуулалт

Гадаад орнуудын туршлагыг судлах хүрээнд манай улстай адил тогтолцоотой байсан шилжилт хийсэн орнуудаас Казахстан улс, хууль зүйн туслалцааг хүртээмжтэй хүргэж буй улсуудаас БНХАУ, Австрали улс, Украйн, АНУ, Канад, Молдав зэрэг улсын зохицуулалтыг авч үзлээ.

---

[20] Б.Пүрэвням. Төлбөрийн чадваргүй иргэдийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангахад өмгөөлөх байгууллагын гүйцэтгэх үүрэг. Өмгөөлөл судлал. УБ.,2011 он, 162 дахь тал.

[21] Хууль зүй, дотоод хэргийн яамны цахим хуудас. http://mojha.gov.mn/news/3d/Эрх_зүйн_туслалцаа_харилцан_үзүүлэх_нь.html.

[22] Хууль зүй, дотоод хэргийн яамны цахим хуудас. http://mojha.gov.mn/news/3d/Эрх_зүйн_туслалцаа_харилцан_үзүүлэх_нь.html.

[23] Хууль зүй, дотоод хэргийн яамны цахим хуудас. http://mojha.gov.mn/images/files/geree/Vietnam.pdf.

[24] Хууль зүй, дотоод хэргийн яамны цахим хуудас.http://mojha.gov.mn/images/files/geree/Kazakstan.pdf.

[25] Хууль зүй, дотоод хэргийн яамны цахим хуудас.http://mojha.gov.mn/images/files/geree/Kazakstan.pdf.

Бүгд найрамдах Казахстан улс

БНКУ-ын хувьд өмгөөллийн үйлчилгээг үнэ төлбөргүйгээр дараах бүлгүүдэд үзүүлж байна. Үүнд:

1)Тэжээгчээ алдсан хохирлын нөхөн төлбөр гаргуулах талаар гаргасан маргааны нэхэмжлэгч;

2) Эрүүгийн эрх зүйн зөрчил учруулсан эсхүл ажил хөдөлмөртэй холбоотой эрүүл мэндэд хохирол учирсны улмаас нөхөн төлбөр гаргуулах талаар гаргасан маргааны нэхэмжлэгч;

3) Эх орны дайнд оролцогчид, тэтгэврийн насныхан, 1, 2 дугаар группийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хугацаат цэргийн албан хаагчид, үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоогүй маргааны хариуцагч, нэхэмжлэгч;

4) Хуулийн дагуу цагаатгагдсан хохирлыг нөхөн төлбөр гаргуулах маргааны нэхэмжлэгч.

Бүгд найрамдах Хятад ард улс

БНХАУ нь тус үйлчилгээний хамрах хүрээг гаргахдаа эрүүгийн хэрэг болон иргэний хэрэг гэж зааглаад эрүүгийн хэрэгт хараагүй, хэлгүй, сонсголгүй, цаазаар авах ял шийтгэгдсэн этгээд, иргэний маргаанд засгийн газрын нөхөн олговор, нийгмийн хамгааллын болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр болон тэтгэмж, хүүхдийн тэтгэмжийн асуудал зэрэг хамаардаг.

Украйн

Украйн улс нь бага орлоготой иргэд, өнчин хүүхэд эсвэл гэр бүл нь салсан ахмад дайчин, иргэний чадвар, чадамж тодорхойлох, эрүүгийн хэргийн сэжигтэн, яллагдагч, цагдан хоригдож буй этгээд, эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу өмгөөлөгч томилуулах шаардлагатай тохиолдол, нийгмийн зорилтот бусад хүмүүст үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлдэг.

Австрали

Австрали улс нь Эрүүгийн гэмт хэрэгт холбогдогчид, гэр бүл салалт, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн этгээд, нийгмийн болон хүний эрхийн зарим маргаан /нийгмийн даатгал, зээл, сэтгэцийн эрүүл мэнд, гэмтэл, цагаачлал, дүрвэгч асран хамгаалалт болон ялгаварлан гадуурхалтын эсрэг асуудал/, замын хөдөлгөөний зөрчил болон их хэмжээний торгууль ногдуулсантай холбоотой асуудлаар үйлчилгээ үзүүлдэг.

Америк

АНУ-ын Хууль зүйн үйлчилгээний корпораци нь зөвхөн иргэний хэрэгт эмэгтэйчүүд, хүүхдүүд, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүмүүст үйлчилгээ үзүүлдэг.

Канад

Канад улсын Хууль зүйн туслалцааны төв нь эрүүгийн болон гэр бүлийн хэрэг, маргаанд хууль зүйн өмгөөлөл болон зөвлөгөө өгдөг. Мөн уугуул иргэд, цагаач иргэд, сэтгэцийн эмгэгтэй этгээдүүдэд хууль зүйн туслалцаа үзүүлдэг.

Бусад орны зохицуулалтаас харахад бие даасан Хууль зүйн туслалцааны тухай хуультай байх бөгөөд эрүүгийн хэргээс гадна зарим төрлийн хэрэг маргаанд хууль зүйн туслалцаа үзүүлэхээр хуульчилсан байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, сэтгэцийн эмгэгтэй иргэн, гэр бүлийн маргаан /гэр бүлийн хүчирхийлэл, тэтгэмж гаргуулах/ гэх мэт.

Молдав

Молдав улс нь хууль зүйн анхан шатны туслалцааг хэрэг маргааны төрөл, хөрөнгийн байдлыг харгалзахгүйгээр үзүүлж буй бол бусад улсын хувьд хууль зүйн туслалцаа үзүүлэхдээ ихэвчлэн орлогыг гол шалгуур болгож байна.

Хууль зүйн яаманд хамаарах эрх зүйн мэдээлэл www.legal.gov.mn

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль батлагдсанаар гэмт хэрэгт холбогдон шалгагдаж буй яллагдагч хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэх боломж нэмэгдсэн төдийгүй судалгааны дүнгээс харахад тус хуулийн хэрэгжилт зохих ёсоор явагдаж байна. Тэгэхдээ зөвхөн төлбөрийн чадваргүй яллагдагч бус үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах бусад иргэдийн бодитой эрэлт хэрэгцээ нийгэмд байна.

Монгол Улсын Үндсэн хууль болон Олон улсын гэрээ, конвенцид зааснаар төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцааг алагчлалгүйгээр үзүүлэх, иргэн хууль зүйн туслалцаа авах эрхтэй болохыг тусган бэхжүүлсэн байна. Хэдийгээр төлбөрийн чадваргүй иргэн бүрд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх нь эдийн засаг болоод хүний нөөцийн хувьд хүндрэлтэй асуудал боловч зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг төр иргэнийхээ өмнө хүлээдгийн хувьд хууль зүйн туслалцаа зайлшгүй шаардагдах зорилтот бүлэгт энэхүү туслалцаа үзүүлэх шаардлагатай.

Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль батлагдан, Хууль зүйн туслалцааны төв байгуулагдан ажилласнаас хойш жил бүр тус төвөөр үйлчлүүлэх иргэдийн тоо өсөж байгаа бөгөөд улсын өмгөөлөгчийн ажлын ачаалал эрс нэмэгдэж, өмгөөлөгчийн хүрэлцээ хангалтгүй болоод байна. Мөн улсын өмгөөлөгчийн албан тушаалын статус тодорхойгүйгээс эдийн засаг, нийгмийн баталгаа хангагдахгүй байгаа нь мэргэшсэн чадварлаг өмгөөлөгч тогтвортой ажиллах нөхцөлийг бууруулах болжээ. Түүнчлэн хууль зүйн үйлчилгээ үзүүлж буй улсын өмгөөлөгчийн цалин хангамж хангалтгүйгээс улсын өмгөөлөгчөөр ажиллах хүсэлтэй мэргэшсэн өмгөөлөгч цөөн, одоо ажиллаж буй улсын өмгөөлөгчдийн ачаалал их байгаа нь шуурхай, чанартай хууль зүйн туслалцааг үзүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.

Судалгааны үр дүнд зохицуулалтын хувилбаруудыг харьцуулан үзсэнээр одоогийн тулгарч буй асуудлыг шийдвэрлэх хамгийн оновчтой арга зам бол хуулийн төсөл боловсруулах явдал мөн гэж дүгнэв.

Хуулийн төсөлд одоогийн хуулиар зохицуулаагүй болон зохицуулалт гарцаагүй шаардаж байгаа дараах асуудлуудыг тусгах нь зүйтэй гэсэн саналтай байна. Үүнд:

Нэг. Хуулийн зохицуулах харилцааг зөвхөн төлбөрийн чадваргүй яллагдагчаар хязгаарлаж байгааг өргөжүүлэх, ингэхдээ бүх төрлийн маргаанд хууль зүйн туслалцаа үзүүлэх бус тодорхой хязгаартайгаар хамруулах нь зүйтэй. Тухайлбал: Төлбөрийн чадваргүй сэжигтэн, хохирогч, насанд хүрээгүй этгээд, тэтгэлэг гаргуулахтай холбогдсон иргэний хэргийн зохигч, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өмч хөрөнгөө хууль бусаар хураалгасан захиргааны хэргийн нэхэмжлэгч зэрэг маргаанд төлбөрийн чадваргүй шалтгаанаар хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэх боломжгүй байгаа нь хууль зүйн туслалцааны үйлчилгээ нийгмийн зорилтот бүлэгт бүрэн хүрэхгүй байгааг харуулж байна.

Гэхдээ төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх үүргийг зөвхөн төр дангаар хариуцах бус нэгэнт эрх зүйн зохицуулалт нь бий болоод буй мэргэжлийн холбоодыг татан оролцуулж, үйлчилгээнд шаардагдах зардлыг төрөөс хариуцах үүргээ хэрэгжүүлбэл асуудлыг зардал багатай, үр өгөөжтэйгөөр шийдвэрлэх боломжтой.

Ингэхдээ одоо байгаа тогтолцооны хүрээнд төлбөрийн чадваргүй яллагдагч дээр төлбөрийн чадваргүй сэжигтэн /шүүгдэгч, ялтан/, хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх чиг үүргийг нэмж, бусад маргааны оролцогчдод мэргэжлийн

холбоо, төрийн бус байгууллага, өмгөөлөгч нар хууль зүйн туслалцаа үзүүлдэг байж болох юм.

Хоёр. Төрөөс улсын өмгөөлөгчийн нийгэм, эдийн засгийн баталгааг хангах, түүний эрх зүйн байдлыг тодорхой болгох нь одоо мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хийдлийг арилгах, тус төвд чадварлаг өмгөөлөгчид ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж, хууль зүйн туслалцааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх дүр зураг харагдаж байна.

Гурав. Монгол Улс гэмт хэрэгт холбогдсон төлбөрийн чадваргүй гадаадын иргэн, харьяалалгүй хүнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үүргийг Монгол улсын хууль тогтоомжоос гадна олон улсын гэрээ, конвенциор хүлээдэг. Иймд дээр дурдсан этгээдэд хууль зүйн туслалцаа авах боломж бүхий эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Дөрөв. Эцэст нь энэхүү судалгаанд дурдагдсан асуудлуудаас үзэхэд төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх харилцааны эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх бодитой шаардлага байна. Энэ хэрэгцээ шаардлагыг дараах гурван хувилбараас илүү зохистойг сонгон шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.

А) Одоо хэрэгжиж буй “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах;

Б) “Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах замаар мэргэжлийн байгууллага, өмгөөлөгчдийн оролцоог хангах;

В) Өмгөөллийн тухай хуулийг шинээр боловсруулж, түүнд энэ харилцааны зохицуулалтыг шингээн тусгах

Эдгээр хувилбаруудын эерэг болон сөрөг үр нөлөөний талаар үндсэн хэсэгт тусгасан болно.

ХУУЛЬ ЗҮЙН УНДЭСНИЙ ХУРООЛЭН
www.nli.gov.mn

Хавсралт 1

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 1)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	**1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх**			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	**Үгүй**	Ялгаварлан гадуурхалтыг хориглож буй зохицуулалт агуулаагүй.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	**Тийм**	Үгүй	Зөвхөн төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх боловч энэ нь ялгаварлаж буй зохицуулалт биш болно.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	**Тийм**	Үгүй	Төлбөрийн чадваргүй иргэд хууль зүйн туслалцаа авах эрхийг эдлүүлэхэд чиглэсэн бөгөөд Монгол улсын үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.14 дэх хэсэгт тусгагдсан, мөн олон улсын гэрээнд тусгагдсан зарчим юм.
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	**Тийм**	Үгүй	ХЗДХЯ-ны холбогдох мэргэжилтэн, Хууль зүйн туслалцааны төвийн мэргэжилтнүүд, улсын өмгөөлөгчид, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны холбогдох мэргэжилтэн, судлаачдын саналыг тусгаж ажиллав.
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	**Тийм**	Үгүй	Гэмт хэргийн хохирогч, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, улсын өмгөөлөгч, төлбөрийн чадваргүй яллагдагч эрх ашиг зохих хэмжээнд хөндөгдөж байгаа бөгөөд хүснэгт 1-д тэдэнд үзүүлэх үр нөлөөг тооцов.
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	**Тийм**	Үгүй	Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор баталгаажуулсан иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх эрхийг хангах, дэмжлэг үзүүлэх тогтолцоо сайжирч, зорилтод бүлэгт хүрэх хүртээмж нэмэгдэнэ.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	**Тийм**	Үгүй	Шударга, тэгш эрх, үр өгөөжтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн. Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцид нийцсэн.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	**Тийм**	Үгүй	Хууль зүйн туслалцаа үзүүлэх харилцааны явцад хууль зөрчсөн тохиолдолд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцно.
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	**Тийм**	Үгүй	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	**Үгүй**	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй.

Хууль зүйн Үндэсний Хүрээлэн www.nhro.gov.mn

3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	**Тийм**	Үгүй	- Гэмт хэргийн хохирогч - Гадаадын иргэн, харьяалалгүй хүн - Улсын өмгөөлөгч, төлбөрийн чадваргүй яллагдагч
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	**Тийм**	Үгүй	Хуулийн төсөл нь төлбөрийн чадваргүй, хууль зүйн туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэдэд чиглэсэн
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	**Тийм**	Үгүй	Хуулийн төсөл нь төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангахад чиглэгдсэн
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх / хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	**Тийм**	Үгүй	Төлбөрийн чадваргүй гэмт хэргийн хохирогч, тэтгэлэг гаргуулахтай холбоотой иргэний хэргийн зохигч, эд хөрөнгөө хууль бусаар хураалгасан захиргааны хэргийн нэхэмжлэгч, насанд хүрээгүй хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бүхэлд нь хамруулахыг зорьсон хуулийн төсөл бөгөөд өөр ангилал тогтоогоогүй.
Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	**Тийм**	Үгүй	Хууль зүйн туслалцааны төв болон улсын өмгөөлөгчийн ажиллагаа нэмэгдэх чиглэлээр үүрэг хүлээнэ.
4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх 5.	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	**Тийм**	Үгүй	Иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон бүх харилцаанд жендерийн тэгш байдлыг бүрдүүлсэн байна.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	**Тийм**	Үгүй	Иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон бүх харилцаанд жендерийн тэгш байдлыг бүрдүүлсэн байна.

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 2)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Хууль зүйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй дотоодын хуулийн этгээдийн үйл ажиллагаа болон өрсөлдөөнд ямар нэг байдлаар нөлөөлөхгүй. Учир нь төлбөрийн чадваргүй иргэдэд чиглэсэн үйлчилгээ үзүүлнэ.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Энэ чиглэлээр зохицуулалт агуулаагүй.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэхгүй.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Нэмэлт зардал үүсэхгүй.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Инновации болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

Хууль зүйн яамны хэрэгжилтийн хяналтын мэдээлэл www.mojha.gov.mn

8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Хууль зүйн туслалцаа үзүүлэх хүрээг нэмэгдүүлэхийн тулд улсын өмгөөлөгчдийн орон тоог нэмэх шаардлагатай
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Хууль зүйн үйлчилгээг зөвхөн төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх тул ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Улсын өмгөөлөгчийн орон тоог нэмэгдүүлэх, цалин хөлсийг нэмэгдүүлэх, нийгмийн баталгааг сайжруулахад төсвөөс санхүүжүүлэх шаардлагатай.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Хууль зүйн туслалцаа үзүүлэх хүрээг өргөжүүлэхтэй холбогдуулан Хууль зүйн туслалцааны төвьд бүтцийн өөрчлөлт хийх боломжтой.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Хууль зүйн туслалцаа үзүүлэх хүрээг өргөжүүлэхтэй холбогдуулан шинээр чиг үүрэг бий болох боломжтой.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ажил эрхлэлтийн байдалд эерэг нөлөө үзүүлэх боловч, улсын төсөвт тодорхой хэмжээний зардал нэмэгдэнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 3)

Үзүүлэх үр нөлөө:	**Холбогдох асуултууд**	Хариулт		**Тайлбар**
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны хүрээг өргөжүүлэхтэй холбоотойгоор Улсын өмгөөлөгчийн орон тоо тодорхой хэмжээгээр нэмэгдэнэ.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

Хууль зүйн яаманд
www.mli.gov.mn

2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Улсын өмгөөлөгчийн нийгмийн баталгааг нэмэгдүүлснээр үйл ажиллагааны чанарт нөлөө үзүүлэх боломжтой.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Хууль зүйн туслалцааны хүрээг өргөжүүлж, улсын өмгөөлөгчдийн нийгмийн баталгааг нэмэгдүүлснээр тэдний эрх, үүрэгт зохих хэмжээний өөрчлөлт орно.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	**Үгүй**	Улсын өмгөөлөгчийн ажлын чанарыг үнэлэх, хүртээмжтэй байдлыг хангах талаар нэмэлт стандарт шаардлагатай.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	**Үгүй**	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх боломж бүрдэнэ.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Төлбөрийн чадваргүй гадаадын иргэн, харьяалалгүй этгээд хууль зүйн туслалцаа авах боломж бүрдэнэ.
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Хууль зүйн туслалцааны төвийн чиг үүрэг, үйл ажиллагаанд зохих өөрчлөлт орно.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Төлбөрийн чадваргүй иргэд шүүхэд хандаж эрхээ хамгаалуулах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх боломж бүрдэнэ.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Хууль зүйн туслалцаа үзүүлэх хүрээг өргөжүүлснээр үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, улсын өмгөөлөгчийн нийгмийн баталгааг нэмэгдүүлснээр үйлчилгээний чанар дээшлэх боломжтой.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэ н сөрөг нөлөө байхгүй.

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 4)

Үзүүлэх үр нөлөө:	**Холбогдох асуултууд**	**Хариулт**		**Тайлбар**
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

Хувилбар 2

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 2)

3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Төрийн санхүүжилтээр өмгөөллийн үйлчилгээнийхээ зохих хэсгийг бүрдүүлэх боломжтой.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Өмгөөлөгчийн үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс гаргах тул нөлөө үзүүлэхээр байна.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Хэргийг өмгөөлөгч нарт хуваарилах, санхжүүжилтийг олгох зэрэг асуудлаар зохих байгууллагын чиг үүрэг өөрчлөгдөх зэрэг бүтцийн өөрчлөлт орно.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 3)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Шинээр ажлын байр бий болохгүй.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Шинээр ажлын байр бий болж болно.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Хууль зүйн туслалцааны төвийн чиг үүрэг, үйл ажиллагаанд зохих өөрчлөлт орно.

Хувилбар 3

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 2)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Төлбөрийн чадваргүй иргэнд үзүүлсэн хууль зүйн туслалцааны тухай мэдээлэх үүрэг болон зардал бий болно.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх үүрэг бүх өмгөөлөгчдөд бий болно.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Улсын төсөвт нөлөө үзүүлэхгүй.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Хэргийг өмгөөлөгчдөд хуваарилах, бүртгэх зэрэг үйл ажиллагаатай холбогдсон чиг үүрэг нэмэгдэнэ.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ажил эрхлэлтийн байдалд эерэг нөлөө үзүүлнэ, улсын төсөвт тодорхой хэмжээний зардал үүсэхгүй.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 3)

Үзүүлэх үр нөлөө:	**Холбогдох асуултууд**	**Хариулт**		**Тайлбар**
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	**Тийм**	Үгүй	Тухайн улсын өмгөөлөгчийн туршлага, чадвараас шалтгаалан ажлын чанар харилцан адилгүй байх магадлалтай.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	**Тийм**	Үгүй	Хууль зүйн туслалцааны хүрээг өргөжүүлж, улсын өмгөөлөгчдийн нийгмийн баталгааг нэмэгдүүлснээр тэдний эрх, үүрэгт зохих хэмжээний өөрчлөлт орно.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	**Тийм**	Үгүй	Хууль зүйн туслалцаа үзүүлэх хүрээг өргөжүүлснээр үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН www.mn.gov.mn

Хавсралт 2

ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ХАРИЛЦААНД ХОЛБОГДОХ ХУУЛИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА

д/д	Хуулийн нэр	Холбогдох зүйл, заалт
1	Монгол Улсын Үндсэн хууль	14.1. Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. 14.2. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна. 16.14. Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм бурууташд тооцож үл болно. Гэм бурууты ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно. 19,1. Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГ www.nli.gov.mn

2	Эрүүгийн байцаан шийтгэх хууль	38 дугаар зүйл. Өмгөөлөгч 38.1. Хуульд заасан журмын дагуу сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, хууль зүйн туслалцаа үзүүлж байгаа этгээдийг өмгөөлөгч гэнэ. 38.2. Мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй бол байцаан шийтгэх ажиллагаанд оролцоход харшлах шалтгаангүй этгээдийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрөө өмгөөлөгчөөр сонгоно./Энэ хэсгийн “Мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй бол байцаан шийтгэх ажиллагаанд оролцоход харшлах шалтгаангүй этгээдийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрөө өмгөөлөгчөөр сонгоно.” гэснийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 03 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/ 38.3. Энэ хуулийн 172.3-т заасан хойшлуулшгүй ажиллагаа явуулж эхэлсэн, ийм ажиллагаа явуулаагүй бол гэмт хэрэгт сэжигтнээр тооцсон үеэс эхлэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох эрхтэй. 38.4. Хэргийн талаар харилцан эсрэг сонирхолтой хэд хэдэн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг нэг өмгөөлөгч өмгөөлж болохгүй. **39 дүгээр зүйл. Өмгөөлөгчийг сонгон авах, солих** 39.1. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч өмгөөлөгчөө өөрөө сонгоно. 39.2.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн зөвшөөрснөөр буюу хүссэнээр түүний хууль ёсны төлөөлөгч, гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн нь өмгөөлөгчийг сонгон авч болно. 39.3.Нэг этгээд хэд хэдэн өмгөөлөгчтэй байж болно. 39.4.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч өмгөөлөгчөө сонгон аваагүй бол түүний хүсэлтээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох боломжийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх хангах бөгөөд өмгөөлөгчөө сонгоход нь тодорхой хүний нэр зааж тулгаж болохгүй. 39.5.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн сонгож авсан өмгөөлөгч уг хэрэгт оролцох боломжгүй болсон, түүнчлэн өмгөөлөгчөөсөө татгалзсан бол өөр өмгөөлөгч сонгон авна. **40 дүгээр зүйл. Өмгөөлөгчийг заавал оролцуулах** 40.1.Дор дурдсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны ажиллагаанд өмгөөлөгчийг заавал оролцуулна: 40.1.1.хэлгүй, дүлий, хараагүй зэрэг эрхтэн дутуу буюу сэтгэцийн өвчний улмаас өөрийгөө өмгөөлөх болон өмгөөлүүлэх эрхээ эдэлж чадахгүй; 40.1.2. насанд хүрээгүй; 40.1.3. монгол хэл, бичиг мэддэггүй; 40.1.4. цаазаар авах ялаар шийтгэгдэж болох; 40.1.5. хэргийнхээ талаар харилцан эсрэг сонирхолтой сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн аль нэг нь өмгөөлөгчтэй байгаа бол бусад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч; 40.1.6.төлбөрийн чадваргүй этгээд өмгөөлөгч оролцуулах хүсэлт гаргасан.

ХУУЛЬ ЗҮЙН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
www.lawuni.edu.mn

		40.2. Энэ хуулийн 40.1-д заасан тохиолдолд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн, түүнчлэн түүний хүссэнээр буюу зөвшөөрснөөр бусад этгээд өмгөөлөгч сонгон аваагүй бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх уг хэрэгт өмгөөлөгч оролцуулах явдлыг хангах үүрэгтэй. **41 дүгээр зүйл. Өмгөөлөгчийн эрх, үүрэг** 41.1. Өмгөөлөгч нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, хууль зүйн туслалцаа үзүүлэх, хүндэтгэн үзэх шалтгаангүй бол хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага, шүүхээс товлосон хугацаанд ирж байцаан шийтгэх ажиллагаанд оролцох үүрэгтэй. 41.2. Хэрэгт оролцох талаар тохиролцсон буюу томилогдсон үеэс өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр өөрийн үүргээс татгалзах, хууль бусаар нотлох баримт цуглуулах эрхгүй. 41.3. Өмгөөлөгч нь дараах эрх эдэлнэ: 41.3.1. хэрэгт оролцох үеэс эхлэн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчтой ганцаарчлан уулзах, тэдгээрийг байцаахад байлцах, асуулт тавих; 41.3.2. энэ хуулийн 92 дугаар зүйлд заасны дагуу хууль зүйн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад нотлох баримтыг цуглуулах талаар хүсэлт тавих, гаргаж өгөх, түүнийгээ шалгуулан хавтаст хэрэгт тусгуулах; 41.3.3. хохирогч, гэрч, шинжээчийг байцаахад байлцаж, тэдгээрт асуулт тавих; 41.3.4. өмгөөлж байгаа этгээдийнхээ болон өөрийнхөө хүсэлтээр хийгдэж байгаа хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд байлцаж тухайн ажиллагаанд оролцож байгаа гэрч, шинжээч, бусад этгээдэд аль ч үед асуулт тавих; 41.3.5. өөрийн байлцсан байцаан шийтгэх ажиллагааны тэмдэглэлтэй танилцаж, засвар оруулах тухай саналаа бичгээр гаргах; 41.3.6. өөрсдийнх нь зөвшөөрснөөр иргэн, хуулийн этгээдээс тайлбар, баримт бичиг, тодорхойлолт гаргуулж авах; 41.3.7. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, орчуулагч, хэлмэрч, шүүгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах; 41.3.8. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дууссаны дараа хэргийн бүх материалтай танилцаж, төр, байгууллага, хувь хүний нууцад үл хамаарах нотлох баримтыг өөрийн зардлаар хувилах, хуулбарлан авах; 41.3.9. шүүх хуралдаанд оролцох; 41.3.10. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах; 41.3.11.өмгөөлж байгаа сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих асуудлыг шүүхэд шийдвэрлэхэд хүсэлтээрээ байлцаж, шүүхэд санал гаргах; 41.3.12.давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанд хүсэлтээрээ оролцох.

ХУУЛЬ ЗҮЙН УНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

3	Хуульчийн эрх зүйн байдлын тухай	**35 дугаар зүйл.Өмгөөллийн үйлчилгээний төрөл** 35.1.Өмгөөлөгч энэ хуулийн 24.1.5-д заасан хууль чийн мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд дараах хэлбэрийн үйлчилгээг үзүүлнэ: 35.1.1.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд үйлчлүүлэгчийг төлөөлөх; 35.1.2.иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үйлчлүүлэгчийг төлөөлөх, өмгөөлөгчөөр оролцох; 35.1.3.эрүүгийн байцаан шийтгэх болон захиргааны зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үйлчлүүлэгчийн төлөөлөгч, өмгөөлөгчөөр оролцох; 35.1.4.олон улсын шүүх, арбитрын ажиллагаа болон бусад байгууллагад үйлчлүүлэгчийг төлөөлөх; 35.1.5.шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд үйлчлүүлэгчийн төлөөлөгчөөр оролцох; 35.1.6.хууль тогтоомжоор хориглоогүй эрх зүйн бусад туслалцаа үзүүлэх. 35.2.Эрүү, иргэн, захиргааны хэрэг, маргааныг эрх бүхий байгууллага хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийн хэрэгжүүлэх бүрэн эрхийг холбогдох хуулиар тогтооно. **37 дугаар зүйл.Өмгөөллийн үйлчилгээгээр хангах** 37.1.Хууль зүйн туслалцаа хүсэгч нь өмгөөлөгчид шууд хандаж хэлцэл хийх, эсхүл Хуульчдын холбоонд хүсэлт гаргах ба Хуульчдын холбоо өмгөөлөгчдийн нэр, хаягийн лавлагаа өгөх үүрэгтэй. 37.2.Иргэн, хуулийн этгээдийн өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангахын тулд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нь өмгөөлөгч болон өмгөөллийн хуулийн этгээдийн нэр, хаягийн лавлагаа өгч болно. 37.3.Хууль зүйн туслалцаа хүсэгч нь эрүүл мэнд, төлбөрийн чадвар болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар өмгөөлөгчөө сонгон авч чадаагүй тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нь энэ тухай Хуульчдын холбоонд мэдэгдэн өмгөөлөгч томилуулах арга хэмжээ авна. 37.4.Энэ хуулийн 37.1-37.3-т заасан тохиолдолд хууль зүйн туслалцаа хүсэгчид өмгөөлөгчөө сонгоход нь тодорхой хүний нэр зааж, тулгахыг хориглоно. **38 дугаар зүйл.Өмгөөлөгчийн үүрэг** 38.1.Өмгөөлөгч энэ хуулийн 26 дугаар зүйлд зааснаас гадна дараах үүрэг хүлээнэ: 38.1.1.үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуульд үл харшлах арга, хэрэгслийг ашиглан бүрэн, тууштай хамгаалах; 38.1.2.үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын эсрэг аливаа үйлдэл хийхгүй байх; 38.1.3.хууль тогтоомжид заасан бусад үүрэг. **40 дүгээр зүйл.Өмгөөллийн үйлчилгээний баталгаа** 40.1.Өмгөөлөгчид хуулийн хүрээнд мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулахад нь дарамт, шахалт үзүүлэх буюу хөндлөнгөөс нөлөөлөх, саад учруулах, заналхийлэхийг хориглоно. 40.2.Мэргэжлийн үйл ажиллагаатай нь холбогдуулан өмгөөлөгчийн яриаг чагнах, албан байранд үзлэг, нэгжлэг хийх, баримт бичгийг гаргуулан авахыг хориглоно. 40.3.Өмгөөлөгч мэргэжлийн үүргээ гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, мэдээ сэлтийг гаргуулан авахын тулд шүүх, прокурор, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага, бусад байгууллага, түүний холбогдох албан тушаалтанд хүсэлт гаргах эрхтэй. 40.4.Энэ хуулийн 40.3-т заасны дагуу хүсэлт гаргасан тохиолдолд холбогдох байгууллага, албан тушаалтан өмгөөлөгчийн хүсэлтийг шийдвэрлэх үүрэгтэй. 40.5.Хуульчдын холбоогоор уламжлуулан хүсэлт гаргасан тохиолдолд цагдаагийн байгууллага өмгөөлөгч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, эд хөрөнгийг хамгаалах, мэргэжлийн үйл ажиллагаатай нь холбогдуулан үндэслэлгүйгээр мөрдөх, эрхийг нь хязгаарлахаас хамгаалах арга хэмжээ авна.
4	Прокурорын байгууллагын тухай хууль	**32 дугаар зүйл. Дээд шатны прокуророос доод шатны прокурорын шийдвэрийг заавал хянах** 32.1.Доод шатны прокурорын шийдвэрийг дараах тохиолдолд заавал хянана: 32.1.1.хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч гомдол, өмгөөлөгч хүсэлт гаргасан;

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ САН
WWW.LEGALINFO.MN

5	Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль	**10 дугаар зүйл. Хорих байрны ажилтан, түүний эрх, үүрэг** 10.1.Хорих байрны ажилтнууд нь хамгаалалтын болон үйлчилгээний ажилтнаас бүрдэнэ. 10.2.Хорих байрны офицер, ахлагч, түрүүч, байлдагчийг хамгаалалтын ажилтан гэх бөгөөд тэдгээр нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны эрх эдэлж, үүрэг хүлээнэ. 10.3.Хорих байрны ажилтнуудад дараах зүйл хийхийг хориглоно: 10.3.1.хорих байранд энэ хуульд зааснаас бусад гаднын хүмүүсийг нэвтрүүлэх; 10.3.2.хоригдсон этгээдтэй албаны бус зүйл ярих, уулзах, зохих зөвшөөрөл, хяналтгүйгээр хоол хүнс, хувцас, захидал болон бусад зүйл дамжуулах; 10.3.3.галт зэвсэг, тусгай хэрэгсэл, хорих өрөөний түлхүүрийг бусдад шилжүүлэх; 10.3.4.тухайн хэргийг шалган шийдвэрлэх үүрэг хүлээсэн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, өмгөөлөгч, прокурор, шүүгчээс бусад албан тушаалтан болон байгууллага, иргэнд хоригдсон этгээдийн талаар лавлагаа өгөх; 10.3.5.хоригдсон этгээдтэй хүнлэг бус харьцах; 10.3.6.ганцаараа байх үедээ хорих өрөөг онгойлгох, хорих өрөөнд орох. **11 дүгээр зүйл.Хорих байранд нэвтрэх** 11.1.Гаднын хүмүүс хорих байранд нэвтрэх, ажил байдалтай нь танилцах, засвар үйлчилгээ, ариутгал, эмчилгээ хийх зөвшөөрлийг цагдан хорих төвийн болон аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга олгоно. 11.2.Хоригдсон этгээдийн хэргийг шалгаж байгаа буюу хянан шийдвэрлэх гэж байгаа хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, өмгөөлөгч, прокурор, шүүгч түүнтэй уулзахаар хорих байранд үнэмлэхээ үзүүлж нэвтрэх эрхтэй. 11.3.Биеийн байцаалтгүй, галт болон хүйтэн зэвсэг, тусгай хэрэгсэл бүхий хүнийг хорих байранд нэвтрүүлэхийг хориглоно. **15 дугаар зүйл.Хоригдсон этгээдийн хувийн хэрэг** 15.1.Хоригдох этгээдийг хорих байранд хүлээн авахдаа хорих байрны захиргаа энэ хуулийн 9.1.3-т зааснаар хувийн хэрэг нээх бөгөөд түүнд дараах зүйлийг хавсаргана: 15.1.1.тухайн этгээдийг хорих тухай шийдвэр; 15.1.2.хоригдох этгээдийн гэрэл зураг; 15.1.3.хоригдох этгээдийн хуруугны хээний дарц (дактокарт); 15.1.4.эргэлт, уулзалт, хувцас сольсон талаарх тэмдэглэл; 15.1.5.хорих байранд ороход түр хураалгасан бичиг баримт, эд зүйлс, мөнгө, үнэт зүйл; 15.1.6.хоригдох этгээдийн хувийн байдлын талаарх мэдээлэл; 15.1.7.эрүүл мэндийн байдал, биеийн жингийн талаар мэдээлэл; 15.1.8.өлсгөлөн зарласан, эмчид үзүүлсэн, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч, өмгөөлөгчийг дуудуулсан зэрэг үйл явдлын талаарх тэмдэглэл; 15.1.9.хорих байранд ирсэн болон суллагдсан он, сар, өдөр, цагийн талаарх тэмдэглэл. 15.2.Хорих ял шийтгүүлсэн этгээдийн хувийн хэргийг хорих ял эдлүүлэх байгууллагад шилжүүлнэ.Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн бол хувийн хэргийг хорих байрны захиргаа гурван жилээс багагүй хугацаагаар хадгална. 34.1.5.хориглосон хүнсний болон бусад эд зүйлийг бэлтгэсэн, хадгалсан, хэрэглэсэн; 34.1.6.мөрийтэй тоглосон; 34.1.7.жижгээр танхайрсан. 34.2.Энэ хуулийн 34.1-д заасан зөрчил гаргасан этгээдийг хорих байрны даргын тогтоолыг үндэслэн сахилгын өрөөнд хорино. 34.3.Хоригдсон этгээдийн гаргасан нэг зөрчилд нэгээс илүү сахилгын шийтгэл ногдуулж болохгүй. 34.4.Сахилгын шийтгэлийг зөрчил илрүүлсэн өдрөөс, хэрэв зөрчлийн талаар шалгаж тогтоох шаардлагатай бол шалгалтыг дууссан өдрөөс гурав хоногийн дотор, гэхдээ зөрчил гарснаас хойш нэг сарын дотор ногдуулна. 34.5.Сахилгын шийтгэл ногдуулахад зөрчил гаргасан этгээдээс бичгээр тайлбар гаргуулах бөгөөд тайлбар өгөхөөс татгалзсан тохиолдолд энэ талаар тэмдэглэл үйлдэнэ. 34.6.Хоригдсон этгээд сахилгын шийтгэлийн талаар эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүхэд гомдол гаргах эрхтэй. Ийнхүү гомдол гаргасан тохиолдолд тухайн шийдвэрийн хэрэгжилтийг гурав хүртэл хоног түдгэлзүүлж болно.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ САН
WWW.LEGALINFO.MN

		34.7.Сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэрийг даруй хэрэгжүүлэх бөгөөд тухайн нөхцөл байдалд тийм бололцоогүй бол шийтгэл ногдуулсан өдрөөс хойш арав хоногийн дотор хэрэгжүүлнэ. 34.8.Хорих байрны дарга нь эмчийн магадлагаа болон бусад үндэслэлээр сахилгын өрөөнд хорих шийтгэлийг биелүүлэхийг хойшлуулах, эсхүл сахилгын өрөөнд хоригдож байгаа этгээдийг хугацаанаас нь өмнө суллах, хугацааг нь багасгаж болно. Хэрэв ийнхүү хойшлуулсан хугацаанд хоригдсон этгээд нь дахин зөрчил гаргаагүй бол шийтгэлийг нөхөж эдлүүлэхгүй. 34.9.Зөрчил гаргасан этгээдийг сахилгын өрөөнд ганцаарчлан хорино. Сахилгын өрөөнд шөнийн цагаар хучлага, дэвсгэр тавьж олгоно. Сахилгын өрөөнд хоригдсон этгээдэд сахилгын шийтгэлийг эдэлж дуустал захидал, цахилгаанаар харилцах, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч, өмгөөлөгчөөс бусад хүмүүстэй уулзах, хүнсний болон нэн хэрэгцээтэй зүйлийг худалдан авах, эргэлт авах, ном, сонин, сэтгүүл унших эрхийг нь хязгаарлана. Сахилгын өрөөнд хоригдож байхад нь ирүүлсэн эргэлтийг сахилгын өрөөнөөс суллагдсаны дараа олгоно. Сахилгын өрөөнд хоригдож байгаа этгээдийг өдөрт 15 минут салхинд гаргана. 34.10.Сахилгын өрөөнд хоригдсон этгээдийн эрхийг энэ хуульд зааснаас өөрөөр хязгаарлахыг хориглоно. Сахилгын өрөөнд хоригдсон этгээдээс гаргасан өргөдөл, санал, гомдлыг энэ хуулийн 22-т заасан журмын дагуу шийдвэрлэнэ. **36 дугаар зүйл.Өлсгөлөн зарлах** 36.1.Хоригдсон этгээд өлсгөлөн зарласнаа мэдэгдвэл хорих байрны дарга хэргийг нь шалгаж байгаа албан тушаалтан, прокурор, өмгөөлөгчид гурван цагийн дотор мэдэгдэж, бусад этгээдээс тусгаарлан эмчийн хяналтад авна. 36.2.Өлсгөлөн зарласан этгээдийн биеийн байдал, жин, өгсөн хоол, цай идэж уухыг татгалзсан тухай өдөр бүр тэмдэглэл үйлдэж, хувийн хэрэгт нь хавсаргана. 36.3.Өлсгөлөн зарласан этгээдийн амь насанд аюул учирч болох тохиолдолд эмчийн бичгээр гаргасан дүгнэлтийг үндэслэн түүний эрүүл мэндийг сайжруулах албадлагын арга хэмжээ авч болно. 36.4.Өлсгөлөн зарласан нь өөр хорих байранд шилжүүлэх болон мөрдөн байцаах ажиллагаа, шүүх хуралдаанд оролцуулахаар хуяглан авч явахад саад болохгүй. Шаардлагатай тохиолдолд ийнхүү хуяглан авч явахад эмнэлгийн ажилтанг байлцуулна. 36.5.Өлсгөлөн зарласан этгээдийн тавьсан шаардлага үндэслэлтэй бол хорих байрны захиргаа шаардлагыг биелүүлэх боломжтой бүх арга хэмжээг авах үүрэгтэй. 36.6.Хоол, цай идэж уусан үеэс эхлэн өлсгөлөнг зогссонд тооцно.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nlc.gov.mn

		17 дугаар зүйл.Хоригдсон этгээдийн эрх 17.1.Хоригдсон этгээд дараах эрх эдэлнэ: 17.1.1.өөрийн эрх, үүрэг, хорих байрны дотоод журам, өргөдөл, гомдол, хүсэлт гаргах эрхийн талаар мэдээлэл, тайлбар авах; 17.1.2.өөрийн хувийн аюулгүй байдлыг хангуулах; 17.1.3.хорих байрны дарга болон хорих байрны үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий албан тушаалтантай хорих байранд ажиллах үеэр нь хувиараа уулзах; 17.1.4.өмгөөлөгчтэй уулзах, хууль зүйн туслалцаа авах; 17.1.5.энэ хуулийн 19-д заасан хүмүүстэй уулзах; 17.1.6.улсын нууцтай холбоотой болон гэмт үйлдэлд холбогдолтой урвуулан ашиглаж болзошгүйгээс бусад, өөрийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах баримт бичиг, бичлэгийг биедээ хадгалах; 17.1.7.ном, сонин, сэтгүүл, ариун цэврийн хэрэгсэл өрөөндөө байлгах; 17.1.8.энэ хуулиар тогтоосон хэмжээний илчлэгтэй хоол, түүнчлэн унтах байр, дэвсгэр, хучлагаар хангагдах; 17.1.9.шөнийн цагт 8 цагаас багагүй хугацаагаар унтаж амрах; 17.1.10.эмнэлгийн тусламжийг Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд1 заасан журмын дагуу авах; 17.1.11.хорих байрны дотоод журамд заасны дагуу захидал, цахилгаанаар харилцах, бичгийн хэрэгсэл ашиглах; 17.1.12.хорих байрны дотоод журам зөрчихгүйгээр шашны зан үйл үйлдэх; 17.1.13.хорих байрны дотоод журамд заасан хугацаагаар салхинд гарах; 17.1.14.боловсрол, мэдлэгээ дээшлүүлэх, шаардлагатай сурах бичиг, ном ашиглах; 17.1.15.эргэлт авах; 17.1.16.иргэний эрх зүйн хэлцэлд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан оролцох; 17.1.17.өөрт холбогдох асуудлаар болон хорих байрны нөхцөл, журам, үйл ажиллагааны талаар аль ч байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол, хүсэлт гаргах. **19 дүгээр зүйл.Хоригдсон этгээд өмгөөлөгч болон төрөл садан, бусад хүмүүстэй уулзах** 19.1.Хоригдсон этгээд нь хорих байранд өөрийн өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзаж болно. 19.2.Хоригдсон этгээдийг хорих шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтны буюу түүний удирдах дээд албан тушаалтны бичгээр олгосон зөвшөөрлөөр төрөл садан болон бусад хүмүүстэй уулзуулж болно. 19.3.Хоригдсон гадаад улсын иргэн нь энэ хуулийн 19.2-т заасан албан тушаалтны зөвшөөрлөөр хорих байрны захиргаагаар дамжуулан өөрийн улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газрын ажилтантай уулзаж болно. 19.4.Хоригдсон этгээд төрөл садан болон бусад хүмүүстэй уулзахад хорих байрны харуул хамгаалалтын ажилтан байлцана. Хориглосон хүнсний болон бусад зүйл, эсхүл гэмт хэргийн бодит үнэнийг тогтооход саад учруулах буюу гэмт хэрэг үйлдэхэд хүргэх мэдээлэл дамжуулахыг оролдсон тохиолдолд уулзалтыг нэн даруй таслан зогсооно. **25 дугаар зүйл.Эмнэлэг, эрүүл ахуйн хангамж** 25.1.Хорих байранд өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, халдваргүйжүүлэх ажлыг эрүүл мэндийг хамгаалах холбогдох хууль тогтоомжид заасны дагуу явуулна. Хорих байрны захиргаа нь хоригдсон этгээдийн эрүүл мэндийг хамгаалахуйц ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангах үүрэгтэй. 25.2.Хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, түүнийг эмнэлгийн байгууллагад эмчлэх, хорих байранд эмнэлгийн ажилтан ирж, үйлчлэх журмыг эрүүл мэнд, нийгмийн хамгааллын болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. 25.3.Хоригдсон этгээд биедээ гэмтэл авсан тохиолдолд хорих байрны эмнэлгийн ажилтан эмнэлгийн үзлэг хийж, үзлэгийн дүнг гэмтэл авсан этгээдэд танилцуулж, энэ тухай хувийн хэрэгт тэмдэглэнэ. Хорих байрны даргын болон хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын санаачилгаар, эсхүл гэмтэл авсан этгээд, түүний өмгөөлөгчийн хүсэлтээр үзлэгийг эмнэлгийн ердийн байгууллагаар хийлгэж болно.

ХУУЛЬ ЗҮЙН УЛЬЗЫЙ ХҮРЭЭЛЭН
www.nlf.gov.mn

		25.4.Хоригдсон этгээд хүндээр өвчилсөн, эсхүл нас барсан тохиолдолд хорих байрны захиргаа нь түүний ойрын төрөл садан болон хорих шийдвэр гаргасан албан тушаалтан, прокурорт нэн даруй мэдэгдэнэ. 25.5.Хоригдсон этгээд нас барсан тохиолдолд цогцост шүүх эмнэлгийн задлан шинжилгээ хийсний дараа ар гэр, төрөл саднын хүмүүст шилжүүлнэ. Цогцсыг ирж авах хүнгүй бол тухайн хорих байрны зардлаар оршуулна. **33 дугаар зүйл.Хоригдсон этгээдийг хянах** 33.1.Хоригдсон этгээдийг байнгын хяналтад байлгах бөгөөд хорих өрөөнөөс гаргах, авч явахад хорих байрны хамгаалалтын ажилтан хуяглан дагалдана. Хорих байрны хяналтад аудио болон видео техник ашиглаж болно. 33.2.Хоригдсон этгээдийн бие болон эргэлтийн эд зүйлд үзлэг хийж, хорих өрөөнд нь өдөрт нэг ба түүнээс дээш удаа нэгжлэг хийнэ. 33.3. Үзлэг, нэгжлэгээр илэрсэн мөнгө, үнэт цаас, дотоод журмаар зөвшөөрснөөс бусад эд зүйлийг зохих албан тушаалтны шийдвэр гартал хувийн хэрэгт нь тэмдэглэж хадгална. Ингэж хадгалахдаа мөнгийг сери, дугаар, дэвсгэртээр нь бүртгэнэ. 33.4.Хураасан хориотой хүнсний болон бусад эд зүйлийг хорих байрны даргын үндэслэл бүхий тогтоолоор зохих акт үйлдэж устгана. 33.5.Хоригдсон этгээдийн биед хийх үзлэгийг түүнтэй ижил хүйсний хамгаалалтын ажилтан хийх бөгөөд үзлэгээр илэрсэн гэмтэл, шарх сорви болон биеийн жин, өндөр, онцлог, содон тэмдгийг бүртгэж, хувийн хэрэгт нь бүрэн тэмдэглэнэ. 33.6.Эмийн зүйлийг хоригдсон этгээдэд байлгах эсэхийг хорих байрны эмчийн саналыг үндэслэн шийдвэрлэнэ. 33.7.Хорих байранд нэвтэрч байгаа хорих байрны хамгаалалтын ба үйлчилгээний ажилтан болон бусад этгээд нь хорих байранд нэвтрүүлэхийг хориглосон эд зүйл авч яваа гэж үзэх тодорхой үндэслэл байвал тэдний бие, хувцас, эд зүйл, унаанд үзлэг хийж болно. Харин хорих шийдвэр гаргасан албан тушаалтан, өмгөөлөгч, прокурор, шүүгчийн бие, хувцас, эд зүйлд үзлэг хийхийг хориглоно. **34 дүгээр зүйл.Сахилгын шийтгэл ногдуулах, эдлүүлэх, чөлөөлөх** 34.1. Дараах зөрчил гаргасан сэжигтэн, яллагдагчийг сахилгын өрөөнд 15 хоног хүртэл, насанд хүрээгүй бол 7 хоног хүртэл хугацаагаар хорино: 34.1.1.хорих байрны ажилтны хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй; 34.1.2.хорих байрны ажилтныг доромжилсон, түүн рүү дайрч довтолсон; 34.1.3.хоригдсон бусад этгээдийг дарамталсан, доромжилсон; 34.1.4.согтууруулах болон мансууруулах ундааны зүйлийг бэлтгэсэн, хадгалсан, хэрэглэсэн;
6	Улсын бүртгэлийн ерөнхий хууль	15 дугаар зүйл.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас мэдээлэл өгөх 15.7.Эрүү, иргэний хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг хамгаалахад шаардлагатай лавлагаа, мэдээллийг бүртгэлийн байгууллагаас гаргуулах тухай хүсэлтээ уг хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж байгаа албан тушаалтнаар дамжуулан авна.
7	Зөрчлийн тухай хууль	**16.17 дугаар зүйл.Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль зөрчих** 1.Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа яллагдагч нь төлбөрийн чадваргүй болохоо худал тодорхойлсон бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХЭЛТЭС
www.legal.mn

Хавсралт 3

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Нэг. Хууль тогтоомж, бусад эрх зүйн акт

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.

2. Төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хууль, 2013 он.

3. Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 2002 он.

4. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, 2012 он.

5. Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 263 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр".

6. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал".

7. Хууль зүйн туслалцааны төвийн дүрэм, 2014 он.

8. Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн дугаар А/15 тоот тушаал. Босго шугам тогтоох тухай.

9. Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 404 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Өрхийн мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах журам".

10.Монгол Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын хооронд иргэн, гэр бүлийн болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ (2000 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр).

Хоёр. Гарын авлага, өгүүлэл, судалгааны ажил

11.Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгчийн гарын авлага. Хууль зүйн яам. УБ.,2014 он.

12.Мика Изка. Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх эрх зүйн туслалцаа. Өмгөөлөгч судлал. УБ.,2011 он, 290-297 дахь тал.

13.Б.Пүрэвням. Төлбөрийн чадваргүй иргэдийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангахад өмгөөлөх байгууллагын гүйцэтгэх үүрэг. Өмгөөлөл судлал. УБ.,2011 он, 162-166 дахь тал.

14."Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа" Статистикийн Үндэсний хороо, Дэлхийн банк. УБ.,2014 он.

15. Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн давхардал, хийдэл, зөрчлийн талаарх мэдээлэл. Хууль зүйн туслалцааны төв. 2016 он.

16.Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаанд тулгамдаж буй хүндрэл, бэрхшээл. Хууль зүйн туслалцааны төв. УБ.,2016 он.

17.Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх хууль зүйн туслалцааны хүртээмж судалгаа. Хууль зүйн туслалцааны төв. УБ.,2016 он.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Гурав. Ярилцлага, бусад баримт бичиг

18.Хууль зүйн туслалцааны төвийн захиралтай хийсэн ярилцлагын тэмдэглэл /2017 оны 2 дугаар сарын 17-ны өдөр/.

19.Хууль зүйн туслалцааны төвийн ажлын албаны мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл /2017 оны 2 дугаар сарын 11-ний өдөр/.

20.Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгчидтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл /2017 оны 2 дугаар сарын 20-ны өдөр/.

21.Хөдөлмөр, нийгэм хамгааллын яамны Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилт зохицуулах газрын Нийгмийн халамжийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл /2017 оны 2 дугаар сарын 16-ны өдөр/.

22.Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн төслийн үзэл баримтлал. 2013 он. /Монгол Улсын Их Хурлын цахим хуудас http://2012.parliament.mn/law/project/114/category/1 сүүлд зочилсон 2017 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр/.

23.Хууль зүйн мэдээлэл, туслалцааны нөхцөл байдал. Нээлттэй нийгэм форум.УБ.,2016 он /Нээлттэй нийгэм форумын цахим хуудас http://forum.mn/index.php?sel=resource&f=resone&obj_id=1040&menu_id=3&resmenu_id=2 сүүлд зочилсон 2017 оны 3 дугаар сарын 12-ны өдөр/.

24.Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх нь. Хууль зүй, дотоод хэргийн яамны цахим хуудас. /http://mojha.gov.mn/news/3d/Эрх_зүйн_туслалцаа%20_харилцан_үзүүлэх_нь.html. сүүлд зочилсон 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдөр/.

Дөрөв. Тайлан, тоон мэдээлэл

25.Монгол Улсын шүүхийн 2016 оны шүүн таслах ажиллагааны тайлан. УБ.,2016 он.

26.Хууль зүйн туслалцааны төвийн 2014, 2015, 2016 оны жилийн эцсийн ажлын тайлан.

27.Хууль зүйн туслалцааны төвийн салбаруудын 2014, 2015, 2016 оны тоон тайлан.

28.Хуульчдын тоо, нэгдсэн статистик мэдээлэл. Монголын Хуульчдын холбооны цахим хуудас / https://www.mglbar.mn/?action=content&view=category&layout=detail&id=23 сүүлд зочилсон 2017 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр/.

29.Хууль зүйн туслалцааны төв болон Монголын Хуульчдын холбооны 2014,2015 онд хууль зүйн үйлчилгээ үзүүлсэн иргэдийн статистик мэдээ.

30.Үндэсний статистикийн хороо, Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа. Хүн амын амьжиргааны доод түвшин, нэг хүнд сард ногдохоор, бүсээр /2001-2017 он/, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан /http://www.1212.mn/statHtml/_statHtml.do?orgId=976&tblId=DT_NSO_1900_010V1&conn_path=I3 сүүлд зочилсон 2017 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр/.

----o0o----

Хуулийн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

“ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ЯЛЛАГДАГЧИД ҮЗҮҮЛЭХ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ТУХАЙ ХУУЛЬ”-Д НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХОЛБОГДУУЛАН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО[26]

Өмнөтгөл

“Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэх “Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах” судалгааны тайланд үндэслэн хууль зүйн туслалцааны хүрээг өргөжүүлж, улсын өмгөөлөгчийн орон тоог нэмэх хувилбарт холбогдуулан төрийн байгууллагад үүсэх зардлыг тооцсон болно.

Тэгэхдээ энэхүү зардлын тооцоо нь хуулийн зохицуулалтын хүрээг өргөжүүлснээр төвөөр үйлчлүүлэгч иргэдийн тоо хэдээр нэмэгдэх тохиолдлын тоог тогтоох боломжгүй тул зөвхөн одоогийн улсын өмгөөлөгчийн цалингийн мэдээлэлд үндэслэн тохиолдлын тоог хийсвэрээр тооцож гаргасан болно.

Түүнчлэн зардлыг тооцох хуулийн төсөл байхгүй тул зардал гарах зохицуулалтыг түүвэрлэж стандарт үйл ажиллагааны зардлыг тооцох боломжгүй тул хуулийн төслийн нэг заалтыг хийсвэрээр тогтоож зардлын тооцоог тооцсон болохыг тэмдэглэх нь зүйтэй.

Хоёр. Тайлбар

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу захиргааны байгууллагад болон улсын төсөвт үүсэх зардлыг тооцохдоо дараах үе шатаар тооцдог.

1. Үүрэг хүлээх байгууллага болон тэдгээрээс гүйцэтгэх үүргийг тодорхойлох үе шат.

2. Зарцуулах хугацаа болон тоон үзүүлэлтийг тооцоолох

3. Гарах зардлыг урьдчилан тооцоолох

4. Нийт дүнг тооцоолох.

5. Хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийг шалгах.

Өмнө дурдсанчлан энэхүү тооцоог хийхэд шаардлагатай хуулийн төсөл байхгүй тул хуульд өөрчлөлт орж магадгүй гэж үзээд “Төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч /шүүгдэгч, ялтан/, хохирогч, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн тэтгэлэг гаргуулахтай холбоотой иргэний хэргийн нэхэмжлэгч, эд хөрөнгөө хууль бусаар хураалгасан захиргааны хэргийн нэхэмжлэгчид хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлнэ” гэсэн заалтыг хийсвэрлэж зардлыг тооцлоо.

Дээрх дарааллын дагуу захиргаанд үүсэх зардлыг тооцох ба зардлын тооцоо шууд мөнгөн дүнгээр гардаггүй. Учир нь хуулийн төслөөр төрийн байгууллагад шинээр бий болгож буй үүрэг нь тухайн төрийн байгууллагын ажилтнаас тухайн ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд зарцуулах цаг хугацааг баримжаалж тогтоох ба гарсан цаг хугацааг үндэслэж хуулиар хүлээсэн үүргийг нэг жилд хэдэн удаа гүйцэтгэх буюу тохиолдлын тоог тооцсоны үндсэн дээрх тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд төрийн байгууллагад нэг жилд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тооцоолж гаргана.

[26] Энэхүү зардлын тооцоог “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль”-ийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах тайлан”-гийн хавсралт байдлаар гүйцэтгэв.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Тухайн хуулиар ногдуулсан үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тооцсоны үндсэн дээр тухайн ажил үйлчилгээг гардан гүйцэтгэх ажилтны цалин, цаашлаад тухайн ажилтны ажлын байрны зардлуудаар үржүүлснээр бодит зардлыг тооцно. Иймд энэхүү судалгааг хийж гүйцэтгэхдээ төрийн байгууллагын ажилтны дундаж цалинг одоогийн улсын өмгөөлөгчийн дундаж цалингаар тооцож гаргасан болно.

Улсын өмгөөлөгч, түүний туслахын цалин хөлсний жишгийг Хууль зүйн сайд, Сангийн сайд нар хамтран батална гэсний дагуу Ахлах улсын өмгөөлөгч ТҮ-10 (төрийн үйлчилгээний албан тушаалын цалин), Улсын өмгөөлөгч ТҮ-9, Улсын өмгөөлөгчийн туслахын цалин хөлсийг ТҮ-4-тэй тус тус дүйцүүлэн тогтоосон бөгөөд энэ нь Ахлах Улсын өмгөөлөгчид 693,884 төгрөг, Улсын өмгөөлөгчид 641,091 төгрөг, Улсын өмгөөлөгчийн туслахад 427,360 төгрөгийн цалин олгогддог байна.

Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт төвийн ажлын албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан нь төрийн захиргааны албан хаагч байна, Засгийн газрын 2014 оны 332 дугаар тогтоолд тус тус заасны дагуу захирал ТЗ-12, захиргааны удирдлагын хэлтсийн дарга ТЗ-8, ахлах мэргэжилтэн ТЗ-6, мэргэжилтэн ТЗ-5, ахлах нягтлан бодогч ТҮ-8, нярав ТҮ-4 ангиллын цалин хөлсийг авч ажилладаг.

Зардал тооцох хуулийн заалт /хийсвэр байдлаар/

“Төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч /шүүгдэгч, ялтан/, гэмт хэргийн хохирогч, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн тэтгэлэг гаргуулахтай холбоотой иргэний хэргийн нэхэмжлэгч, эд хөрөнгөө хууль бусаар хураалгасан захиргааны хэргийн нэхэмжлэгчид хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлнэ”

Хоёр. Стандарт үйл ажиллагааны зардал

Хүний нөөцийн тооцоо[27]

№	Нэг жил	Ажлын өдөр /дундаж/	Ажлын цаг /нэг өдөр/	Нэг жилд ажиллах цаг	Минут	Нийт
1	1	250	8 цаг	2,000 цаг	60 мин	120,000 мин

Хүний нөөцийн дундаж зардал[28]

№	Зардлын нэр	Дүн
1	Үндсэн цалин	693,884[29]
2	Бүх төрлийн даатгал	144,411
3	Унаа хоолны нэмэгдэл	132,000/нэг өдрийн 6,000/
4	Нийт /нэг сард/	970,295
5	Нийт /нэг жилд/	11,643,540

[27] Төрийн байгууллагын ажилтны нэг жилд ажиллах дундаж хугацаа. Минутаар тооцов.

[28] 2012 оны Засгийн газрын 78 дугаар тогтоолын хавсралт

[29] Улсын ахлах өмгөөлөгчийн цалингаар үндсэн цалинг тооцов.

Материаллаг зардал[30]

№	Зардлын нэр	Дүн
1	Газрын төлбөр	22,253
2	Бичиг хэрэг	124,000
3	Гэрэл, цахилгаан	128,239
4	Түлш, халаалт	263,408
5	Тээвэр, шатахуун	300,191
6	Шуудан холбоо	306,812
7	Цэвэр, бохир ус	599,438
8	Ном хэвлэх, авах	54,745
9	Урсгал засвар	127,752
10	Хөрөнгө оруулалт	70,422
11	Нийт	1,698,448

Элэгдэл хорогдлын зардал[31]

№	Зардлын нэр	Хувь	дүн	Хорогдол тооцсон дүн
1	Техник, тоног төхөөрөмж	20%	800,000	160,000
2	Тавилга /ширээ сандал г.м/	10%	1,000,000	100,000
3	Ажлын өрөөний хэмжээ 8 м2	1,6%	4,364,179	69,826
4	Нийт			329,826

Нэг жилд төрийн байгууллагын нэг ажилтанд ногдох нийт зардал[32]

№	Зардлын нэр	Зардлын дүн
1	Хүний нөөцийн зардал	11,643,540
2	Материаллаг зардал	1,698,448
3	Элэгдэл хорогдлын зардал	329,826
	Нийт зардал	13,671,814

Цаашид энэхүү судалгаанд хийсвэрлэж авсан хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх улсын өмгөөлөгчид үүсэх ачаалал болон хүний нөөцийн хэрэгцээг тооцоолж гаргасны үр дүнд нэг өмгөөлөгчид жилд зарцуулах зардлыг үржүүлснээр төрийн байгууллагад үүсэх зардлыг тогтооно.

Гэхдээ улсын өмгөөлөгч хэргийн материалтай танилцах, шүүх хуралд бэлтгэх, шүүх хурал хойшлохгүйгээр шууд явагдах зэргээр бүх тохиолдлын тоог хамгийн бага буюу 1-ээр тооцсон болно.

[30] ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2010 оны 99 дүгээр тушаалын хавсралт 3

[31] ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2010 оны 99 дүгээр тушаалын хавсралт 3

[32] Энэхүү зардал нь Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх улсын өмгөөлөгчийн нэг жилд зарцуулах нийт зардал юм.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Төрийн байгууллагын үүрэг	Үүргийг хэрэгжүүлэх албан тушаалтнаас гүйцэтгэх үйлдэл	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	хүний нөөцийн хэрэгцээ /цаг/
Төлбөрийн чадваргүй иргэнд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх[33]				
Төлбөрийн чадваргүй иргэний тодорхойлолтыг шалгах	Хүсэлтийг хүлээн авах	3 мин	1	0,05 цаг
	хүсэлтийг шалгаж, бүртгэх	60 мин	1	1 цаг
Хэргийн материалтай танилцах	Шүүх явах	30 мин	1	0,5 цаг
	Хэргийн материалтай танилцах	120 мин	1	2 цаг
	Шаардлагатай баримт хуулбарлан авах	60 мин	1	1 цаг
Өмгөөлөлд бэлтгэх	Үйлчлүүлэгчтэй уулзах	60 мин	1	1 цаг
	Хууль тогтоомж судлах, өмгөөллийн үг бэлдэх	480 мин	1	8 цаг
Шүүх хуралд оролцох	Хуралд оролцох	240 мин	1	3 цаг
Нийт цаг				16,55 цаг
Ажлыг гүйцэтгэх хүний нөөцийн хэрэгцээ 16,55 цаг: 2000 цаг = 0,008275 цаг				

Төрийн байгууллагын үүрэг	Үүргийг хэрэгжүүлэх албан тушаалтнаас гүйцэтгэх үйлдэл	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	хүний нөөцийн хэрэгцээ /цаг/
Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн зөвлөгөө өгөх[34]				
Төлбөрийн чадваргүй иргэний тодорхойлолтыг шалгах	Хүсэлтийг хүлээн авах	3 мин	1	0,05 цаг
	хүсэлтийг шалгаж, бүртгэх	60 мин	1	1 цаг
Хууль зүйн зөвлөгөө өгөх	Хэргийн материалтай танилцах	30 мин	1	0,5 цаг
	Зөвлөгөө өгөх	120 мин	1	2 цаг
Нийт цаг				3,55 цаг
Ажлыг гүйцэтгэх хүний нөөцийн хэрэгцээ 35,5 цаг: 2000 цаг = 0,001775 цаг				

[33] Энэ хэсэгт заасан төлбөрийн чадваргүй иргэн гэдэг нь зардлыг тооцох гэж буй хийсвэр хуулийн заалтад хамаарах төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, гэмт хэргийн хохирогч, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн тэтгэлэг гаргуулахтай холбоотой иргэний хэргийн нэхэмжлэгч, эд хөрөнгөө хууль бусаар хураалгасан захиргааны хэргийн нэхэмжлэгч зэргийг хамааруулж байгаа болно.

[34] Энэ хэсэгт заасан төлбөрийн чадваргүй иргэн гэдэг нь зардлыг тооцох гэж буй хийсвэр хуулийн заалтад хамаарах төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, гэмт хэргийн хохирогч, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн тэтгэлэг гаргуулахтай холбоотой иргэний хэргийн нэхэмжлэгч, эд хөрөнгөө хууль бусаар хураалгасан захиргааны хэргийн нэхэмжлэгч зэргийг хамааруулж байгаа болно.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.legal.gov.mn

№	Зардал гарах хуулийн зүйл	Хүний нөөцийн хэрэгцээ	Нэг өмгөөлөгчийн зардал	Нэг өмгөөлөгчид гарах нийт зардал
1	Төлбөрийн чадваргүй иргэнд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх	0,008275 цаг	13,671,814	113,134
Нийт зардал		0,008275 цаг	13,671,814	113,134

№	Зардал гарах хуулийн зүйл	Хүний нөөцийн хэрэгцээ	Нэг өмгөөлөгчийн зардал	Нэг өмгөөлөгчид гарах нийт зардал
1	Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн зөвлөгөө өгөх	0,001775 цаг	13,671,814	24,267
Нийт зардал		0,001775 цаг	13,671,814	24,267

Энэ нь хамгийн багаар тооцоход нэг улсын өмгөөлөгч төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх зардал юм. Гэхдээ үүнд шүүх хуралдаан хойшлох, нотлох баримт гаргах, эрүүгийн хэрэгт цагдан хорих анги руу явах зэрэг цаг хугацаа их шаардагддаг үйл ажиллагааг тооцоогүй болохыг анхаарна уу.

Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгчид зөвхөн төлбөрийн чадваргүй 2482 хэргийн 2749 яллагдагчид өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн ба 6631 иргэнд хууль зүйн зөвлөгөө өгсөн байна.

Эдгээрийг тус бүрд нь авч үзвэл төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлсэн өмгөөллийн үйлчилгээний зардлын тооцоонд тохиолдлын тоог авахдаа нэг жилд 2749 яллагдагчийг жишиг тоогоор авч хуулийн зохицуулалтын хүрээ өргөжиж байгаа буюу зөвхөн төлбөрийн чадваргүй яллагдагч бус дээр дурдсан бусад хэргийн оролцогчдод туслалцаа үзүүлнэ гэж үзээд 6 дахин өснө гэж үзэв.

Түүнчлэн хууль зүйн зөвлөгөө авах иргэдийн хувьд одоо ч бусад төрлийн маргааны иргэдэд анхан шатны хууль зүйн туслалцаа үзүүлж байгааг харгалзан үзээд одоо байгаа дүнгээс 3 дахин өснө гэж үзсэн болно.

Ингэхэд нийт тус төвөөр үйлчлүүлэх иргэд буюу өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх тохиолдлын тоо 2749*6=16,494 байна.

Үүнийг нэг өмгөөлөгч өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх зардлыг тохиолдлын тоогоор үржүүлж зардлыг тооцно.

112,792*16,494=1,890,391,248 төгрөг буюу өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх зардал.

Хууль зүйн зөвлөгөө авах тохиолдлын тоо 6631*3=19,893

Үүнийг нэг өмгөөлөгчид хууль зүйн туслалцаа зөвлөгөө өгөх зардлыг тохиолдлын тоогоор үржүүлж зардлыг тооцно.

19,893*24,267=482,743,431 төгрөг буюу хууль зүйн зөвлөгөө өгөхөд гарах зардал.

Ингээд дээрх өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх болон хууль зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээнд шаардагдах нийт зардлыг дараах байдлаар үзүүлэв.

Утга	Зардал	Нийт
Өмгөөллийн үйлчилгээ	1,890,391,248	2,373,134,679
Хууль зүйн зөвлөгөө	482,743,431	

Энэхүү зардлын тооцоонд хийсвэрлэж авсан *“Төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч /шүүгдэгч, ялтан/, гэмт хэргийн хохирогч, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн тэтгэлэг гаргуулахтай холбоотой иргэний хэргийн нэхэмжлэгч, эд хөрөнгөө хууль бусаар хураалгасан захиргааны хэргийн нэхэмжлэгчид хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлнэ”* гэсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэхэд нийт 2,373,134,679 төгрөг шаардлагатай байна.

----o0o----

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН[1]

УДИРТГАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар зүйлийн 5.1.22 дахь хэсэгт “Хууль зүйн судалгааны чанарыг шинэ түвшинд гаргаж, хууль тогтоомжийн боловсруулалт, хэрэгжилтийг судалгаанд суурилан хөгжүүлэх боломжийг бүрдүүлнэ”. Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-т “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх” гэж тусгасан.

Энэ хүрээнд 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн “Хууль тогтоомжийн тухай” хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ыг баталсан.

Энэхүү судалгааны зорилго нь Засгийн газраас баталсан аргачлалыг баримтлан Хууль зүй, дотоод хэргийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн төсөлд “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу судалж хуулийн төслийг боловсронгуй болгох, нөгөө талаар хуулийн төсөл боловсруулагчид жишиг болохуйц гарын авлага боловсруулахад оршино.

Түүнчлэн энэхүү судалгаагаар Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, уг төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах замаар хуулийн этгээдийн улсын бүртгэлийн эрх зүйн орчныг сайжруулах боломжийг тодорхойлох, мөн хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад хууль санаачлагчид дэмжлэг үзүүлэх, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөхийг зорилоо.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

[1] Тус судалгааг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга /Ph.D/ Д.Зүмбэрэллхам удирдаж, Эрдэм шинжилгээний ажилтан Ж.Алтансүх, Д.Нямбаяр, Б.Сүнжидмаа, “Хууль эрх зүйн хөгжлийн хүрээлэн” ТББ-ын судлаач, өмгөөлөгч Г.Цагаанбаяр нар хамтран гүйцэтгэв.

НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Хуулийн төслийн үр нөлөөний судалгааг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлт тус бүрийг сонгож төслийн үр нөлөөг гүйцэтгэлээ. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих байдал
3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал
4. Ойлгомжтой байдал
5. Зардал[2]
6. Харилцан уялдаа зэрэг болно.

Эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараах үндэслэлийг харгалзан үзсэн. Үүнд:

1.Хуулийн төсөл нь 1/ хуулийн этгээд шинээр байгуулсан, өөрчлөн байгуулсан, татан буулгасныг болон түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх; 2/ иргэн, хуулийн этгээд болон тусгайлан эрх олгогдсон байгууллагад лавлагаа олгох; 3/ хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөхтэй холбогдон үүсэх харилцааг цогц байдлаар зохицуулах гэсэн зорилгодоо хүрсэн эсэх;

2.Хуулийн төсөлд тусгагдсан асуудлууд болох 1/ цахим хэлбэрээр бүртгэл хийх, цахимаар үзүүлэх үйлчилгээ; 2/ хуулийн этгээдийг бүртгэх хугацаа; 3/ Өргөдөл гаргагчийн хууль тогтоомжид заасан баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн эсэхийг тогтоох зэрэг зохицуулалт нь практикт хэрэгжих эсэх;

3.Хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтуудыг хэрэглэх, хэрэгжүүлэх субьектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан эсэх;

4.Хуулийн төсөлд тусгагдсан хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл, түүнд шаардлагатай мэдээлэл, мөн шинээр үүсгэн байгуулсан, өөрчлөн байгуулсан, татан буулгасныг болон түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэхэд шаардагдах баримт бичгийн бүрдлүүд хуулийн этгээдүүдийн эрх, ашиг сонирхлыг хөндөх эсэх, мөн эдгээр хуулийн этгээдүүд уг төсөлд шинээр тусгагдсан зохицуулалтыг хүлээн зөвшөөрөх эсэх;

5.Хуулийн төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэх зэргийг тус тусад нь шалгана.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ

Энэхүү хэсэгт уг хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно. Энэхүү зүйл заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авсан. Өөрөөр хэлбэл тухайн төслийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс хуулийн төсөлд шинээр нэмж орж буй, голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож, тухайн сонгож буй зүйл заалтын үр нөлөөг судална.

[2] Хуулийн төслийн “Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийг “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль”-ийн төслийн зардлын тооцоо гэсэн хэсэгт тусад нь тооцож, үр нөлөөг нь үнэлсэн болно. Дэлгэрэнгүйг уг тайлангаас үзнэ үү.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Түүнчлэн хуулийн төсөл батлагдсанаар тодорхой зардал үүсгэж болохуйц, эсхүл тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой, мөн тодорхой субъектэд үүрэг хүлээлгэсэн, тодорхой байгууллагад шинээр чиг үүрэг хүлээлгэж байгаа, мөн тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор шинээр хэлтэс, нэгж, байгууллага бий болгох шаардлагатай эсэх зэргийг харгалзан үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон.

Ингээд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдлыг шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу авч үзье.

2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:

“Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийн үндсэн зорилго нь 1/ хуулийн этгээд шинээр байгуулсан, өөрчлөн байгуулсан, татан буулгасныг болон түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх, 2/ иргэн, хуулийн этгээд болон тусгайлан эрх олгогдсон байгууллагад лавлагаа олгох 3/ хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөхтэй холбогдон үүсэх харилцааг цогц байдлаар зохицуулахад оршиж байна. Энэ зорилгод хүрэхийн тулд хуулийн төслөөр дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна.[3] Үүнд:

- Хуулийн этгээдийн төрөл хэлбэрээс үл хамааран хуулийн этгээдийг зөвхөн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэх;
- Бүртгэлийн цахим тогтолцоонд шилжих, бүртгэлийг цахимаар хийлгэх, цахим өргөдөл, цахим нэрийн баталгаажуулалт хийлгэх зэрэг хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг цахимаар хийх эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
- Бүртгэлийн байгууллага болон төрийн бусад байгууллагууд өөр хоорондоо мэдээлэл шуурхай солилцож, цаасгүй орчинд шилжих.

Иймд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөс дээрх зорилтуудтай холбогдсон, эдгээр зорилтуудыг хангах зорилгоор тусгагдсан зүйл заалтыг сонгон авч “зорилгод хүрэх байдал”-ийн үр нөлөөг нь тооцно. Үүнд:

№	Зорилгод хүрэх байдал/ дагалдах зорилтууд	Сонгосон зүйл заалт
1	Хуулийн этгээдийн төрөл хэлбэрээс үл хамааран хуулийн этгээдийг зөвхөн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэх	Хуулийн төслийн 1.1, 3.1.1, 4.1, 8.1
2	Бүртгэлийн цахим тогтолцоонд шилжих, бүртгэлийг цахимаар хийлгэх, цахим өргөдөл, цахим нэрийн баталгаажуулалт хийлгэх зэрэг хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг цахимаар хийх эрх зүйн зохицуулалтыг бий болгохыг зорьсон	Хуулийн төслийн 3.1.9, 3.1.10, 6.1, 13.1-4
3	Бүртгэлийн байгууллага болон төрийн бусад байгууллагууд өөр хоорондоо мэдээлэл шуурхай солилцож, цаасгүй орчинд шилжих	Хуулийн төслийн 9.1.6, 10.3,12.2.1

[3] Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалаас иш татав.

2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:

Практикт хэрэгжих байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд 1/ цахим хэлбэрээр бүртгэл хийх, цахимаар үзүүлэх үйлчилгээ; 2/ хуулийн этгээдийг бүртгэх хугацаа; 3/ Өргөдөл гаргагчийн хууль тогтоомжид заасан баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн эсэхийг тогтоох зэрэг зохицуулалтыг сонгон “Практикт хэрэгжих байдал”-ын үр нөлөөг нь тооцсон болно. Сонгосон зүйл заалтуудыг хүснэгтээр үзүүлвэл:

№	Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл заалт
1	Хуулийн төслийн цахимаар үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зүйл заалтууд	6.1. Улсын бүртгэлийн үйлчилгээг энэ хуульд заасны дагуу цахим, эсхүл бичгийн хэлбэрээр авч болно; 7.2.Энэ хуулийн 16.1-д заасан өргөдөл гаргагч улсын тэмдэгтийн хураамжийн төлбөрийг цахим хэлбэрээр төлж болно; 9.1.1.Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 8 дугаар зүйлд заасан улсын бүртгэл хөтлөх, энэ тухай хуульд заасны дагуу цахим хуудсаар нийтэд мэдээлэх; 9.6.Улсын бүртгэлийн байгууллага нууцын тухай хууль тогтоомжид зааснаас бусад улсын бүртгэлийн мэдээллийг өөрийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ. 10.3.Хуулийн этгээдийн хувийн хэргийг цахим болон бичгийн хэлбэрээр бүрдүүлэн улсын бүртгэлийн мэдээллийн санд давхар хөтөлнө; 12.2.Хуулийн этгээдийн хувийн хэргийн лавлагааг дараах хэлбэрээр олгоно: 12.2.1.бичгээр, эсхүл цахим хэлбэрээр; 13.2.Улсын бүртгэлийн байгууллага хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан тохиолдолд өргөдөл гаргагчид татгалзаж байгаа үндэслэл бүхий мэдэгдлийг бичгээр, цахим хэлбэрээр хүргүүлнэ. 13.3.Цахим хэлбэрээр өргөдөл гаргагч энэ хуулийн 13.1-д заасны дагуу улсын бүртгэлд бүртгэх тухай мэдэгдэл хүлээн авсан өдрөөс хойш энэ хуулийн 17.1-17.3-т заасан, эх хувь нь шаардлагатай баримт бичгийг өөрийн иргэний үнэмлэхийн хамт холбогдох улсын бүртгэлийн байгууллагад ажлын таван өдрийн дотор биечлэн авч ирснээр бүртгэл албан ёсоор баталгаажна. 13.4.Өргөдөл гаргагч энэ хуулийн 17.1-17.3-т заасан баримт бичгийг цахим хэлбэрээр ирүүлэхдээ гарын үсгээ Цахим гарын үсгийн тухай хуульд заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд энэ хуулийн 13.3 дахь хэсэг хамаарахгүй. 15.3.Энэ хуулийн 16.1-д заасан өргөдөл гаргагч энэ хуулийн 9.5-д заасан баталсан маягтын дагуу өргөдөл гаргаж, гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд өргөдлийг цахим хэлбэрээр гаргасан бол цахим гарын үсгээр баталгаажуулж болно. 17.6.Улсын бүртгэлийн байгууллага нь өргөдлийг бичгээр хүлээн авсан бол баримт бичгийн жагсаалт, хүлээн авсан он, сар, өдөр, цаг, минут бүхий мэдээллийг өргөдөл гаргагчид цахим хэлбэрээр, эсхүл бичгээр хүргүүлнэ; 18.2.Цахим хэлбэрээр өргөдөл гаргасан тохиолдолд улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 13.3-т заасны дагуу эх хувиар авч ирсэн баримт бичгийг цахим хэлбэрээр ирүүлсэн баримт бичигтэй тулган нягталсны дараа тухайн хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичгийн эхний хуудас дээр хуулийн этгээдийн хувийн хэргийн дугаар, он, сар, өдөр бүхий баталгааны тэмдэг, бусад хуудас дээр улсын бүртгэгчийн тэмдэг дарснаар хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэсэнд тооцно. 18.4.Улсын бүртгэлийн байгууллага нь хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэснийг нотолсон хуулийн этгээдийн хувийн хэргийн болон регистрийн дугаар бүхий улсын бүртгэлийн цахим гэрчилгээг өргөдөл гаргагч хэвлэн авах боломжтойгоор улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд байршуулж болно. 26.2.Улсын бүртгэлийн байгууллага хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хассан тухайгаа Иргэний хуулийн 32.11-д заасны дагуу цахим хуудсаар нийтэд тухай бүр мэдээлнэ.

2	Хуулийн төслийн хуулийн этгээдийн бүртгэх эсэх шийдвэр гаргах хугацаа	13.1.Хуульд өөрөөр заагаагүй бол улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 17.1-17.3-т заасан баримт бичгийг бүрэн гүйцэд хүлээн авснаас хойш гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг бүртгэх эсэх талаар ажлын 10 өдрийн дотор, бусад хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх эсэх талаар ажлын хоёр өдрийн дотор шийдвэр гаргаж, энэ тухай өргөдөл гаргагчид бичгээр, цахим хэлбэрээр мэдэгдэнэ;
3	Өргөдөл гаргагчийн хуульд заасан баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн эсэхийг тогтоох	19.1.3. Өргөдөл гаргагч хууль тогтоомжид заасан баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн;

2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн зүйл заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцно. /Хуулийн төсөл 8 бүлэг, 28 зүйлтэй. /

2.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төсөлд тусгагдсан хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл, түүнд шаардлагатай мэдээлэл, мөн шинээр үүсгэн байгуулсан, өөрчлөн байгуулсан, татан буулгасныг болон түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэхэд шаардагдах баримт бичгийн бүрдлүүд хуулийн этгээдүүдийн эрх, ашиг сонирхлыг хөндөж байгаа эсэх зэрэг зохицуулалтыг сонгож авсан.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар зүйлийн 5.2.7-д “Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хүнд суртлаас ангид байх эрх зүйн орчинг бүрдүүлж, иргэдийн эрхийг баталгаажуулна.” гэж тусгасан. Энэ хүрээнд хуулийн этгээдийн бүртгэлийн эрх зүйн орчныг сайжруулах, тэр дундаа Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн хэрэглэгч субъектүүд болох хуулийн этгээдийн бүртгэлийг түргэн, шуурхай хялбар болгох асуудалд хууль санаачлагч анхаарах шаардлагатай.

Монгол Улсын Их Хурлын 2015 онд баталсан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн төслийн дагалдах судалгаанаас үзэхэд “... хуулийн этгээдийн бүртгэлийг хялбаршуулж, цахимжуулах шаардлагатай бөгөөд …, хуулийн этгээдийг бүртгүүлэхэд бүрдүүлэх баримт бичгийг цөөрүүлэх, бүртгэлийг хурдан шуурхай болгох шаардлага байна.” гэж дурджээ.

Үүнтэй холбогдуулан энэ хуульд хамаарах хуулийн этгээдүүдийн төрлүүдийн бүртгэлтэй холбоотой эрх, ашиг сонирхол хөндөгдөж болохуйц заалтуудыг доор хүснэгтээр авч үзье:

Хуулийн хүрээлэн www.legal.gov.mn

№	Хүлээн зөвшөөрөгдөх байдал/сонгосон зүйл, заалт	Шаардагдах мэдээлэл, баримт бичгүүд
1	17 дугаар зүйлийн 17.1	**17.1.Өргөдөл гаргагч шинээр байгуулсан хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлэхдээ дараах баримт бичгийг бүрдүүлнэ:** 17.1.1.хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт; 17.1.2.баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл; 17.1.3.үүсгэн байгуулах баримт бичиг; 17.1.4.шаардлагатай тохиолдолд итгэмжлэл; 17.1.5.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт; 17.1.6.хувь нийлүүлсэн хөрөнгө болохыг нотолсон банкинд харилцах данс нээлгэсэн баримт; 17.1.7.үүсгэн байгуулагч, гүйцэтгэх удирдлагын цахим үнэмлэхийн хуулбар; 17.1.8.хуулийн этгээдийн хаягийн нотлох баримт;
2	21 дүгээр зүйлийн 21.1	**21.1.Өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ:** 21.1.1.хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт; 21.1.2.баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл; 21.1.3.үүсгэн байгуулах баримт бичиг буюу өөрчлөн байгуулсан тухай шийдвэр /тогтоол/, шинэчилсэн дүрэм, хуульд заасан бол гэрээ; 21.1.4.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт; 21.1.5.шаардлагатай тохиолдолд итгэмжлэл; 21.1.6.энэ хуулийн 11.1.7-д заасан эрх залгамжлалын талаарх өөрчлөлтийг оруулсан үүсгэн байгуулах баримт бичиг; 21.1.7.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 21.1-д заасны дагуу гадаадын хөрөнгө оруулахыг зөвшөөрсөн эрх бүхий байгууллагын шийдвэр; 21.1.8.өөрчлөн байгуулагдах үеийн санхүүгийн тайлан, тэнцэл; 21.1.9.улсын бүртгэлийн гэрчилгээ; 21.1.10.нэгдэх, нийлэх тохиолдолд Өрсөлдөөний тухай хуулийн 8.1-д заасны дагуу өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүгнэлт;
3	23 дугаар зүйлийн 23.1	**23.1.Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ:** 23.1.1.нэр өөрчлөх тохиолдолд шинээр олгосон нэрийн баталгаажуулалт, өдөр тутмын сонинд зарлуулсан зар; 23.1.2.баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл; 23.1.3.үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт оруулах тухай шийдвэр; 23.1.4.холбогдох өөрчлөлт оруулах тухай үүсгэн байгуулагч, эрх бүхий байгууллагын шийдвэр /тогтоол/, хурлын тэмдэглэл; 23.1.5.үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан өөрчлөлт; 23.1.6.шаардлагатай тохиолдолд итгэмжлэл; 23.1.7.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт. 23.1.8.дүрэмд өөрчлөлт оруулах тохиолдолд шинэчилсэн дүрэм, хуульд заасан тохиолдолд шинэчилсэн гэрээ эсхүл гэрээний нэмэлт, өөрчлөлт; 23.1.9.хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт оруулах тохиолдолд баталгаажсан санхүүгийн тайлан, тэнцэл; 23.1.10.хаяг өөрчлөх тохиолдолд үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ эсхүл түрээсийн гэрээ зэрэг нотлох баримт; 23.1.11.улсын бүртгэлийн гэрчилгээ.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЛЫН www.legal.mn

4	25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг.	25.1.Хуулийн этгээдийг татан буулгасныг улсын бүртгэлд бүртгүүлэхэд Иргэний хуулийн 32.2-т заасан татан буулгах комисс дараах баримт бичгийг бүрдүүлнэ: 25.1.1.баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл; 25.1.2.татан буулгах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр; 25.1.3.дуусгалтын тайлан; 25.1.4.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт; 25.1.5.татварын байцаагчийн акт, тодорхойлолт; 25.1.6.өртэй эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын лавлагаа; 25.1.7.татан буулгасан тухай өдөр тутмын сонинд зарлуулсан зар.
5	Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.6	9.6.Улсын бүртгэлийн байгууллага нууцын тухай хууль тогтоомжид зааснаас бусад улсын бүртгэлийн мэдээллийг өөрийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

2.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн зүйл заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцно. /Хуулийн төсөл 8 бүлэг, 28 зүйлтэй. /

ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав:

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 1.1, 3.1.1, 4.1, 8.1, Хуулийн төслийн 3.1.9, 3.1.10, 6.1, 12.2.1, 13.1-4 Хуулийн төслийн 9.1.6, Хуулийн төслийн 9.6	Зорилгод дүн шинжилгээ хийх
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 6.1, 7.2, 9.1.1, 9.6, 10.3, 12.2.1; Хуулийн төслийн 15.3, 17.6, 18.2, 18.4, 26.2; Хуулийн төслийн 13.1, 13.2, 13.3, 13.4 Хуулийн төслийн 19.1.3	Практикт туршилт хийх, практикт тухайн төрлийн харилцаа, чиг үүргийг хэрэгжүүлж буй этгээдээс ярилцлага авах, гарч болох хүндрэлийг судлах.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг бүхэлд нь тооцно	Ойлгомжтой байдлыг судлах, ингэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар хуулийн төслийг шалгах.
4	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	17 дугаар зүйлийн 17.1, 21 дүгээр зүйлийн 21.1, 23 дугаар зүйлийн 23.1, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг. Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.6	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх асуудлын хүрээнд, холбогдох байгууллагуудаас бичгээр санал авах, холбогдох мэргэжилтэнтэй фокус ярилцлага хийх

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

5	Зардал	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу тусад нь тооцно.	Зардлын тооцоо хийх
6	Харилцан уялдаа	Хуулийн төслийг бүхэлд нь тооцно	Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгуудаар шалгах

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ:

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал:

Хуулийн этгээдийн төрөл хэлбэрээс үл хамааран хуулийн этгээдийг зөвхөн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгэдэг болох зорилгын хүрээнд хуулийн төслийн 1.1, 3.1.1, 4.1, 8.1 дүгээр зүйл заалтад дүн шинжилгээ хийсэн байдал.

Хуулийн төслийн нэгдүгээр зүйлд “ Энэ хуулийн зорилт нь хуулийн этгээд шинээр үүсгэн байгуулсан, өөрчлөн байгуулсан, татан буулгасныг болон түүний мэдээлэлд өөрчлөлт оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх, иргэн хуулийн этгээд болон эрх бүхий байгууллага, албан тушаалтанд лавлагаа олгох, хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино” хэмээн ерөнхий зорилгыг тодорхойлж өгсөн байна.

Ерөнхий зорилгоос авч үзэхэд Хуулийн этгээдийн төрөл, хэлбэрээс үл хамааран хуулийн этгээдийг зөвхөн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэх, улсын бүртгэлийн байгууллагаас хуулийн этгээдтэй холбоотой бүртгэлийн цогц, нэгдмэл үйлчилгээг үзүүлэхээр хуулийн төслийн нэгдүгээр зүйлд тусгаж өгчээ.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэх үүднээс хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т “хуулийн этгээд” гэдгийг тодорхойлсон байх бөгөөд Иргэний хуульд заасан хуулийн этгээдийн ерөнхий тодорхойлолтыг иш татсан байгаа нь хуулийн этгээдийн төрөл, хэлбэрээс үл хамааран хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хуульд ямар ч хуулийн этгээд хамаарч болохоор өргөн хүрээтэй болж өгсөн нь хуулийн төслийн зорилгод нийцсэн байна.

Түүнчлэн хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.-т зааснаар “хуулийн этгээдийн төрөл, хэлбэрээс үл хамааран иргэний эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсч, хуульд заасан журмын дагуу татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болохтой холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна” гэж зааж өгсөн. Энэ нь хуулийн этгээд шинээр бүртгүүлэх харилцаа болон татан буугдах харилцааг л зөвхөн зохицуулах юм шиг явцуу хүрээнд ойлгогдож байна. Угтаа бол хуулийн төслөөр хуулийн этгээд шинээр үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулагдах, хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт орох, хуулийн этгээдийн хувийн хэрэг хөтлөх, лавлагаа авах, хуулийн этгээдийн мэдээллийг олон нийтэд ил болгох зэрэг олон төрлийн харилцааг энэ хуулиар зохицуулахаар хуулийн зорилгодоо тусгаж өгсөн. Иймд хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг нь хуулийн төслийн зорилгод бүрэн нийцэж чадаагүй байна.

Мөн хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Улсын бүртгэлийн байгууллага дараах хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрыг бүртгэнэ”: гээд

- Нөхөрлөл
- Компани
- Холбоо
- Сан
- Хоршоо
- Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар
- Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
- Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж
- Гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар гэсэн 9 хуулийн этгээдийн төрлийг бүртгэх юм шиг зохицуулалтыг хийж өгчээ.

Энэ нь хуулийн төслийн ерөнхий зорилго болох хуулийн этгээдийн бүртгэлийг төрөл, хэлбэр харгалзахгүйгээр бүртгэх, цогц бүртгэлийн тогтолцоог бий болгох зорилгод нийцэхгүй болжээ. Учир нь хуулийн этгээдийн төрөл, хэлбэр нь дээр дурдсан хуулийн этгээдийн 9 төрөл, хэлбэрээс олон байгаа. Тухайлбал, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т “хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллага” /цаашид “Хуульчдын холбоо” гэх/ гэж хуульчдын заавал гишүүнчлэлтэй, өөрийн удирдлагатай, нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг” хэмээн нийтийн эрх зүйн хуулийн этгээд гэсэн төрөл, хэлбэрийг хуулиар тодотгож өгсөн бөгөөд Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 26.3-т “нийтийн эрх зүйн хуулийн этгээд” гэсэн нэр томьёог ашигласан байдаг.

Түүнчлэн Төрийн бус байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т “төрийн бус байгууллага” гэж иргэд, төрийн байгууллагаас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллагыг хэлнэ” гэж тодорхойлж өгсөн нь Иргэний хуульд заасан холбоо, сангаас өөр төрөл хэлбэрийн хуулийн этгээд байхаар хуульчилжээ.

Үүнээс үзэхэд дээрх хуулийн заалтууд нь хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг үл харгалзан бүх хуулийн этгээдийн төрөл хэлбэрийг бүртгэх, нэгдмэл тогтолцоог бий болгох зорилгод хүрэх боломж багатай, хуулийн төслийн зорилгод бүрэн нийцэж чадаагүй байна.

> Бүртгэлийн цахим тогтолцоонд шилжих, бүртгэлийг цахимаар хийлгэх, цахим өргөдөл, цахим нэрийн баталгаажуулалт хийлгэх зэрэг хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг цахимаар хийх эрх зүйн зохицуулалтыг бий болгох зорилгын хүрээнд хуулийн төслийн 3.1.9, 3.1.10, 6.1, 13.3-4 дүгээр зүйл заалтад дүн шинжилгээ хийсэн байдал.

Хуулийн төслийн бас нэгэн зорилго бол бүртгэлийн цахим тогтолцоонд шилжих, бүртгэлийг цахимаар хийлгэх, цахим өргөдөл, цахим нэрийн баталгаажуулалт хийлгэх зэрэг хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг цахимаар хийх эрх зүйн зохицуулалтыг бий болгохыг зорьсон. Энэ хүрээнд хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.1.9-т “бүртгэлийн цахим хэлбэр гэж цахим сүлжээгээр дамжуулан улсын бүртгэлийн байгууллагын цахим хуудсанд хандаж улсын бүртгэл хийлгэхийг”, хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Улсын бүртгэлийн үйлчилгээг энэ хуульд заасны дагуу цахим, эсхүл бичгийн хэлбэрээр авч болно”, хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Хуулийн этгээдийн хувийн хэргийг цахим болон бичгийн хэлбэрээр бүрдүүлэн улсын бүртгэлийн мэдээллийн санд давхар хөтөлнө”, хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.3-т “ цахим хэлбэрээр өргөдөл гаргагч ….” гэх мэтээр

томьёолж өгсөн нь хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг цахимаар хийх эрх зүйн орчныг бий болгох зорилгодоо нийцэж байна.

Дээрх зохицуулалтуудаар цахим бүртгэлийн үйлчилгээг хэрэгжүүлэх боломжтой эсэх, зорилгод хүрэх байдлын дүн шинжилгээг дараах байдлаар хийлээ:

Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.3-т “цахим хэлбэрээр өргөдөл гаргагч … улсын бүртгэлд бүртгэх тухай мэдэгдэл хүлээн авсан өдрөөс хойш … эх хувь нь шаардлагатай баримт бичгийг өөрийн иргэний үнэмлэхийн хамт холбогдох улсын бүртгэлийн байгууллагад ажлын таван өдрийн дотор биечлэн авч ирснээр бүртгэл албан ёсоор баталгаажна” гэж заасан. Энэ заалт нь хуулийн этгээдийг шинээр үүсгэн байгуулах өргөдөл гаргах /хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.2/, өөрчлөн байгуулах замаар хуулийн этгээдийг бүртгүүлэх /хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.1/, хуулийн этгээдийн мэдээллийн санд өөрчлөлт оруулах /хуулийн төслийн 23.4/, хуулийн этгээдийг татан буулгасныг бүртгэхэд /хуулийн төслийн 25 дугаар зүйлийн 25.2/ нэгэн адил хамаарахаар зааж өгсөн байна. Үүний үр дүнд цахим байдлаар өргөдөл гаргасан этгээдийг дахин цаасан байдлаар бүх баримт бичгээ бүрдүүлж, эх хувиар нь авчрахыг шаардаж байгаа бөгөөд цахимаар бүртгэлийн үйлчилгээг авах зорилгодоо нийцэхгүй байна.

Хуулийн төслийг боловсруулсан ажлын хэсгийн гишүүдээс энэ талаар тодруулахад “хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь заалт нь өргөдөл гаргагчийн материалыг цахим байдлаар урьдчилж шалгаад, шаардлага хангаж буй эсэхийг нь нягталж үзэх, ингэснээр улсын бүртгэлийн байгууллагад өргөдөл гаргагчийг биечлэн ирэх тоог багасгах, өргөдөл буцах нөхцөл байдлыг бууруулах зорилготой” гэж тайлбар өгсөн. Үүнээс үзвэл хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь заалт нь цахим бүртгэл, цахим үйлчилгээг бий болгох гэхээс илүүтэйгээр өргөдлийн шаардлага хангуулах, материалын бүрдлийг урьдчилан хангуулах зорилготой заалт гэж үзэхээр байна.

Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.4-т “Өргөдөл гаргагч … баримт бичгийг цахим хэлбэрээр ирүүлэхдээ гарын үсгээ Цахим гарын үсгийн тухай хуульд заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд энэ хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг хамаарахгүй” гэж зааж өгсөнөөр цахимаар өргөдөл гаргасан этгээд нь цахим гарын үсгээр хуулиар шаардсан материалаа баталгаажуулж илгээсэн тохиолдолд шинээр бүртгүүлэх, хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт оруулах, өөрчлөн байгуулах замаар хуулийн этгээд бүртгүүлэх зэрэг өргөдлүүдийг цахимаар хүлээн авч бүртгэл хийх бүрэн боломжтой. Энэ нь цахим бүртгэлийн үйлчилгээг нэвтрүүлэх зорилгод нийцэж байна.

> Бүртгэлийн байгууллага болон төрийн бусад байгууллагууд өөр хоорондоо мэдээлэл шуурхай солилцож, цаасгүй орчинд шилжих гэсэн зорилгын хүрээнд хуулийн төслийн 9.1.6, 10.3 12.2.1 дугаар зүйл заалтад дүн шинжилгээ хийсэн байдал.

Хуулийн этгээдийн талаарх лавлагаа мэдээллийг төрийн байгууллага, иргэн, аж ахуйн нэгж цахим хэлбэрээр авах, цаасгүй орчинд шилжих зорилгыг хуулийн төсөлд тусгаж өгсөн. Энэ зорилгын хүрээнд хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.6-д “улсын бүртгэлийн асуудлаар төрийн болон бусад байгууллагатай харилцан мэдээлэл солилцох”, 12 дугаар зүйлийн 12.2.1-д “Хуулийн этгээдийн хувийн хэргийн лавлагааг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр олгоно” гэж хуульчилж өгсөн байна. Цахимаар цаасгүй хэлбэрээр лавлагаа, мэдээлэл солилцоход тухайн хуулийн этгээдийн хувийн хэрэг нь мөн цахим байдлаар хадгалагдаж байх шаардлагатай бөгөөд үүнийг хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.3-т “хуулийн этгээдийн хувийн хэргийг цахим болон бичгийн хэлбэрээр бүрдүүлэн улсын бүртгэлийн мэдээллийн

санд давхар хөтөлнө” гэж бүртгэлийн байгууллагад үүрэг болгосон байна.

Улсын бүртгэлийн байгууллагын холбогдох мэргэжилтнээс авсан ярилцлагад “хуулийн этгээдийн хувийн хэргийг цахим байдлаар буюу 2014 он хүртэл хуулийн этгээдийн хувийн хэргийг “сканердаж” хадгалсан байдаг. Үүнийг ямар нэгэн байдлаар ашиглаагүй байгаа.” гэж тайлбар өгсөн байсан. Өөрөөр хэлбэл хуулийн этгээдийн хувийн хэргээс мэдээлэл, лавлагааг цахимаар авах эрх зүйн зохицуулалт байгаа боловч үүнийг хэрхэн ашиглах, хэрэгжүүлэх, ямар тохиолдолд бичгээр эсхүл цахимаар лавлагаа мэдээлэл өгөх журам зохицуулалт нь тусгагдаагүй байна. Тухайлбал, шүүхэд бүртгэлийн байгууллагаас лавлагааг шүүхэд цахим байдлаар хүргүүлэхэд нотлох баримтын шаардлагыг хэрхэн хангах эсэх талаарх зохицуулалт нь байхгүй байгаа юм.

Түүнчлэн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын 2016 оны үйл ажиллагааны тайланд “хуулийн этгээдийн бүртгэлийн архивт 9786 хуулийн этгээдийн хувийн хэрэг, 15516 хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн баримт бичгийг хvлээлгэн өгч, 13712 хуулийн этгээдийн хувийн хэргийг улсын бүртгэгч нар архиваас хүлээн авч улсын бүртгэлийн лавлагаа, мэдээлэлд ашигласан байна.” гэх боловч дан цаасан хэлбэрээр хувийн хэргийг авч, цаасан хэлбэрээр лавлагаа мэдээлэл олгодог болох нь харагдаж байна. Үүнээс дүгнэж үзэхэд цахим хэлбэрээр лавлагаа, мэдээлэл олгох эрх зүйн зохицуулалт нь хуулийн төсөлд тусгагдсан боловч практикт үүнийг хэрэгжүүлэх нарийвчилсан, тодорхой болгосон зохицуулалтыг хуулийн төсөлд нэмж тусгах эсхүл тусгай журмаар зохицуулж байж эдгээр зүйл заалт нь зорилгодоо хүрэхээр байна.

3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

Судалгааны багийн зүгээс “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоохдоо хуулийн төслийг хэрэгжүүлэгч субъекттэй ярилцлага хийх, төсөлд санал авах, бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны тайлан, албан ёсны цахим хуудас дахь мэдээлэл, мэргэжлийн байгууллага, судлаачдын судалгаа, бүртгэх явцад үүсэх процесс ажиллагаа зэрэгт дүн шинжилгээ хийх замаар шалгасан.

Дээр дурдсанаар практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн 6.1, 7.2, 9.1.1, 9.6, 10.3, 12.2.1, 13.1, 13.2, 13.3, 13.4, 15.3, 17.6, 18.2, 19.1.3, 18.4, 26.2 зүйл заалтуудыг сонгон судлах болно.

Дээрх зүйл заалтуудын практикт хэрэгжих боломжтой эсэхийг судлахдаа одоо хэрэгжиж буй хуулийн этгээдийн бүртгэлийн процесс ажиллагааг жишиг болгон авч үзсэн. Практикт хэрэгжих боломжийн талаар судалж үзэхдээ цахимаар бүртгэл явагдаж байгаа эсэх, улсын бүртгэлд бүртгэх эсэхийг шийдвэрлэх хугацаа нь боломжит эсэх, хуурамч баримт бичгийг хэрхэн тогтоох гэсэн асуудалд үнэлэлт өгөхийг зорилоо. Ингэхдээ дараах асуултад хариулахыг эрмэлзлээ. Үүнд:

1. Хуулийн төслийг хэрэгжүүлэх субъект байгаа эсэх;
2. Хуулийн төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд боломж бололцоо байгаа эсэх.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

- Санхүү
- Хүний нөөц
- Техник, тоног төхөөрөмж, программ хангамж шаардлага хангаж байгаа эсэх.

Хуулийн төслийн цахим хэлбэрээр хэрэгжих боломжийн талаар хуулийн төслийн цахим бүртгэлтэй холбогдох зүйл, заалтын хэрэгжих боломж байгаа эсэх гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд 6.1, 7.2, 9.1.1, 9.6, 10.3, 12.2.1, 13.2-13.4, 15.3, 17.6, 18.2, 18.4, 26.2 зүйл, заалтуудыг сонгож, эдгээр заалтуудыг багцлан авч үзье.

1. Хэрэгжүүлэх субъект байгаа эсэх:

Уг хуулийн төсөлд тусгаснаар хэрэгжүүлэгч субъект нь Улсын бүртгэлийн байгууллага буюу Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын "Хуулийн этгээдийн бүртгэлийн газар" байхаар тусгасан /Төслийн 8, 9 дүгээр зүйл/. Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар нь нийтдээ 43 ажилтантай бөгөөд Газрын дарга 1, Улсын ахлах бүртгэгч 2, Улсын бүртгэгч 17, Орон нутгийн улсын бүртгэгч 21, Багануур дүүрэгт Хуулийн этгээдийн улсын бүртгэл хариуцсан улсын бүртгэгч 1, Гэрээт ажилтан 1 ажиллаж байна.[4] Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд одоогийн байдлаар дотоод зохион байгуулалтаар хуулийн этгээдийн оноосон нэрийн бүртгэл хариуцсан 1 бүртгэгч, гадаад хөрөнгө оруулалттай хуулийн этгээд болон ТББ-ын бүртгэл хариуцсан 2 бүртгэгч, тамга тэмдэг, баталгааны тэмдгийн бүртгэл, хяналт хариуцсан 1 бүртгэгч, материал хүлээн авалтыг хариуцсан 4 бүртгэгч, хуулийн этгээдийн бүртгэл хариуцсан 7 бүртгэгч, утсаар зөвлөгөө өгдөг 1 бүртгэгч, зөвлөх үйлчилгээ хариуцсан 1 бүртгэгч, татан буулгалтын бүртгэл, хуулийн байгууллагатай харилцах асуудал (шүүх дээр гарсан хэрэг маргаан) хариуцсан 1 бүртгэгч, 1 гэрээт ажилтан олголтыг хариуцаж ажиллаж[5] байна.

Эдгээр ажилтнууд өөрийн хариуцсан чиглэлийн бүртгэлийг хийх бөгөөд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас авсан мэдээллээр цахим бүртгэлийг дагнан хариуцсан ажилтан байхгүй байгаа талаар мэдээлсэн.[6] Өөрөөр хэлбэл Хуулийн этгээдийн цахим бүртгэлийг оноосон нэрийн бүртгэл хариуцсан бүртгэгч давхар хариуцаж байна. Тухайн ажилтан үндсэн ажлын хажуугаар уг цахим бүртгэлийг хавсран гүйцэтгэж байна. Энэ нь ажлын ачаалал нэмэгдэх, цахимаар бүртгэл хийх гэсэн гол зорилгыг хангахад учир дутагдалтай байдал үүсгэж болзошгүй. Иймд цаашид хуулийн этгээдийн цахим бүртгэл хариуцсан ажилтны орон тоог бий болгох, энэ чиглэлээр дагнан ажиллах ажилтныг ажиллуулах, мэргэшүүлэхэд анхаарах шаардлагатай.

2. Хуулийн төслийн зохицуулалт хэрэгжих боломж хэр байгааг судлах:

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.8-т "Улсын бүртгэлийн ажиллагааг онлайн горимд шилжүүлж үндэсний цахим баримт бичгийн хэрэглээг нэмэгдүүлнэ" гэсэн зорилт дэвшүүлсэн. Энэ зорилтын хүрээнд Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас хэрэгжүүлэх 2017-2020 оны ажлын төлөвлөгөөнд "Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах, шинээр байгуулагдсан хуулийн этгээд, түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын

[4] Хуулийн этгээдийн бүртгэлийн газар. (Сүүлд үзсэн: 2017.03.06) http://www.burtgel.gov.mn/index.php/about/departments-item/262-2015-12-09-11-47-3917.

[5] Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн улсын бүртгэгч нартай хийсэн ярилцлага.

[6] Мөн тэнд.

бүртгэлд бүртгэх үйлчилгээг онлайн горимд шилжүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх" төлөвлөгөөнд хоёр тэрбум төгрөгийн төсвийг улсын төсөв болон гадаад эх үүсвэрээс бүрдүүлэхээр тусгасан[7] байна.

Тухайн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудад 2018 онд хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээний 30 хувь, 2019 онд үйлчилгээний 50 хувь нь онлайн горимд тус тус шилжих, 2020 он гэхэд "улсын бүртгэлийн байгууллагаас хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг онлайн горимд бүрэн шилжүүлж, иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээ ил тод, нээлттэй шуурхай, хүртээмжтэй" болгохоор төлөвлөсөн байна. [8]

Дэлхийн улс орнууд төрийн үйл ажиллагаа, нийтийн албан дахь авилга, хүнд суртлыг халах, иргэдэд төрийн зүгээс үзүүлэх үйлчилгээг сайжруулах, ойртуулах, хялбар болгохыг зорьж бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж байна. Үүний нэг жишээ бол Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас 2003, 2005 онд хуралдсан "Мэдээлэлжсэн нийгэм" сэдэвт дэлхийн дээд хэмжээний чуулга уулзалтаар "Мэдээлэл, харилцаа холбооны технологийг 2020 он хүртэл хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг" дэлхийн 175 улс орны төлөөлөгчид" баталсан[9] байна.

Тухайлбал Бүгд Найрамдах Солонгос Улсын бүртгэлийн тогтолцоо болон бүртгэх процедур нь цахим бүртгэлд шилжсэн бол ХБНГУ-ын Засгийн газар 2003 оноос нийт улсыг хамарсан "цахим засаглал" хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд хуулийн этгээдийн бүртгэлийг цахимаар бүртгүүлэх боломжийг хангаж өгсөн. Герман улсад хуулийн этгээд бүртгэлийг аль нэг газар очих шаардлагагүйгээр интернетээр бүртгүүлж болох боломжтой бөгөөд баримт бичгийг үнэн, баталгаатай байдлыг нотариатаар баталгаажуулснаар бүртгүүлж болдог[10] байна.

Монгол Улсын хувьд Хуулийн этгээдийн бүртгэлийг цахим бүртгэлд шилжүүлэх ажил 2005 оноос эхэлж энэ зорилтыг хангахад холбогдох эрх бүхий байгууллагууд анхаарч ажилласаар ирсэн. Улсын бүртгэлийн ерөнхий газар, Бүгд найрамдах Солонгос Улсын олон улсын хамтын ажиллагааны агентлаг (KOICA)-тай хамтран ажиллах "Улсын бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах цахим архивын төсөл"-ийн санамж бичиг байгуулсан.[11] Уг санамж бичгийн хүрээнд улсын бүртгэлийн архивт хадгалагдаж байгаа хуулийн этгээдийн бүх цаасан материалыг цахим хэлбэрт шилжүүлэх зорилгоор хуулийн этгээдийн бүртгэлийг цахим архивын системтэй болгох[12] ажил эхлүүлсэн. Мөн МТШХХТГ-аас хэрэгжүүлж буй "Төрийн байгууллагуудын мэдээллийг нэгдсэн өгөгдлийн сантай холбох систем хөгжүүлэх" төслийн хүрээнд жишиг үйлчилгээнүүдийг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг "Инносолюшн" ХХК-тай хамтран хийсэн бөгөөд тус газраас иргэдэд үзүүлдэг хуулийн этгээдийн үйлчилгээний цахим порталыг нэвтрүүлсэн.[13]

Одоогийн байдлаар хуулийн этгээдийн цахим бүртгэлийн үйлчилгээний эхлэл тавигдсан гэж ойлгож болохоор байна. Учир нь оноосон нэрийг шинээр авах

[7] Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөний хүрээнд "Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө".

[8] Мөн тэнд.

[9] Бүртгэлийн тогтолцоо: Сайн туршлага, ХЗҮХ-ийн судалгааны тайлан, УБ, 2014 он. 8 дахь тал.

[10] Мөн тэнд.

[11] "Хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурлаа." (сүүлд үзсэн 2017.03.07) http://www.burtgel.gov.mn/index.php/component/content/article?id=1044:2015-12-21-07-55-17.

[12] "Улсын бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах Цахим архив төсөл хэрэгжиж эхэллээ." (сүүлд үзсэн 2017.03.07) http://www.burtgel.gov.mn/index.php/476-2015-12-10-08-41-54.

[13] http://les.burtgel.gov.mn/ubeg/citizen/article (сүүлд үзсэн 2017.03.07).

болон оноосон нэрийн баталгаажуулалтын лавлагаанд ашиглаж байна. Хуулийн этгээдийн илгээсэн нэрийг хуулийн этгээдийн цахим хуудсаар явуулж улсын бүртгэгчээр шалгуулж батлуулна. Гэхдээ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 болон 14.4-т зааснаар хуулийн этгээд 10 хоногийн дотор хуулийн этгээдийг бүртгүүлэх өргөдлийг авчраагүй тохиолдолд тухайн нэрийн баталгаажуулалт хүчингүй болно[14] гэж заасан байдаг. Үүнээс үзэхэд нэрийн баталгаажуулалтыг цахимаар баталгаажуулсан хэдий ч үйлчилгээний хураамжийг улсын бүртгэл дээр биеэр очиж төлж байгаа нь цахим бүртгэлийн нэрийн баталгаажуулалт бүрэн хэрэгжээгүй гэж үзэхээр байгаа бөгөөд цахим бүртгэл ач холбогдолгүй байна.

Хуулийн этгээдийн бусад цахим бүртгэлийг практик дээр хэрэгжүүлэхэд дараах хүндрэл, бэрхшээл тулгардаг талаар хэрэгжүүлэгч субъект болох улсын бүртгэгчтэй хийсэн ярилцлага, тайлан, судалгааны материалыг судлахад харагдаж байна. Үүнд:

● Хуулийн этгээдийн бүртгэлийн үндсэн программ болох программ хангамж нь анх туршилтын хэлбэрээр хэрэгжиж байсан бөгөөд одоог хүртэл энэ программд шинэчлэл хийгдээгүй. Мөн хуулийн этгээдийн бүртгэлийн газар нь энэхүү программын албан ёсны эрхийг хүлээж аваагүй. Программ хангамж шаардлага хангаагүйгээс үүдэн хуулийн этгээдийн цахим бүртгэлийг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй байна.

● Хуулийн этгээд бүртгэлийг цөөн тохиолдолд цахимаар илгээсэн сканердсан материалуудыг шалгуулж байсан. Харин хуулийн этгээдийг олноор бүртгэхэд программ хангамжийн хувьд хүчин чадал хангалтгүй байна.

● Цахим мэдээллийн сан болон цахим бүртгэлийн үйлчилгээ нь цахим халдлагад өртөж, гэмтэл доголдол үүссэн тохиолдолд үйл ажиллагааг цаашид хэвийн явуулахад нөөц сервер байхгүйгээс үүдэн үйлчлүүлэгч нар хохирох, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаа шууд зогсох эрсдэл бий.

● Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.3 болон 13.4-т зааснаар баримт бичгийг цахим бүртгэлээр хоёр байдлаар бүртгүүлэх боломжтой. Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.3-т эх хувь нь шаардлагатай баримт бичгийг өөрийн иргэний үнэмлэхийн хамт... биечлэн авч ирж баталгаажуулна. Эсхүл хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.4-т цахим хэлбэрээр ирүүлэхдээ Цахим гарын үсгээр баталгаажуулж болно. Гэвч цахим гарын үсэгтэй хуулийн этгээд цөөн байдаг гэж улсын бүртгэгч ярилцлагад мэдээлсэн.[15] Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан зүйл заалтыг хэрэгжүүлэхийн тулд цахим гарын үсгийн тухай хуулийг мөн адил хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2017 оны 2 сард зохион байгуулагдсан эрдэм шинжилгээний бага хурлын “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, цаашдын зорилт” сэдэвт илтгэлд бүртгэлийн программ дахь давхардал, зөрчил, хөрвүүлэлтийн явцад гарсан алдаа, программаас статистик мэдээ гаргах боломж учир дутагдалтай байдлаас үүдэн хуулийн этгээдийн өмнөх жилүүдийн тоо, мэдээ, бүртгэлийн программын дүн, Үндэсний Статистикийн Хорооны тайлан мэдээлэл зөрүүтэй гарсан гэж мэдээлсэн. Цаашид Мэдээллийн Технологийн Газартай хамтран бүртгэлийн программ дахь давхардал, зөрчлүүдийг арилгах, бүртгэлийн материалаас мэдээлэл статистик гаргах боломжийг сайжруулах шаардлагатай гэж

[14] Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, 19 дүгээр зүйлийн 19.1.3.

[15] Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн улсын бүртгэгч нартай хийсэн ярилцлага.

дүгнэсэн байна.[16]

Дээрхээс үзэхэд хуулийн этгээдийн цахим бүртгэлийн үйлчилгээний эхлэл тавигдсан ч бүрэн нэвтрээгүй, программ хангамжийн асуудал бүрэн шийдэгдээгүй байгаа зэрэг асуудал үүсч байгаа нь харагдаж байна. Үүнээс дүгнэхэд хуулийн этгээдийн цахим бүртгэлийг бүрэн хэрэгжүүлэх боломж дутмаг боловч программ хангамжийн асуудлыг шийдвэрлэвэл практикт хэрэгжих боломжтой байна.

Хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх эсэхийг шийдвэрлэх хугацааны практикт хэрэгжих боломжийн талаар хуулийн төслийн 13 дүгээр зүйлийн 13.1 дэх зүйл заалтад хэрэгжих боломж хэр байгааг судалсан байдал

1. Хэрэгжүүлэх субъект байгаа эсэх:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар нь нийтдээ 17 улсын бүртгэгч, орон нутгийн 21 бүртгэгчтэйгээр үйл ажиллагаа явуулж байна гэж дээр дурдсан билээ. Хуулийн этгээдийн улсын 17 бүртгэгчид нь Хуулийн этгээдийн оноосон нэрийн бүртгэл, тамга тэмдэг, баталгааны тэмдгийн бүртгэл, гадаадын хөрөнгө оруулалтай хуулийн этгээд болон ТББ-ын бүртгэл, татан буулгалтын бүртгэл, хуулийн байгууллагатай харилцах асуудал хариуцсан бүртгэл, бусад бүртгэл гэх зэрэг материал хүлээн авах, дараагийн сар бүртгэл хийх байдлаар ээлжлэн ажилладаг. *Эдгээрээс одоогоор 10 орчим бүртгэгч хуулийн этгээдийн улсын бүртгэл хийдэг бөгөөд үүнээс нэг цонхон дээр 2-3 бүртгэгч ээлжлэн суудаг талаар улсын бүртгэгч мэдээлсэн*.[17] Үүнээс үзэхэд энэхүү заалтыг хэрэгжүүлэх субъект байгаа болох нь харагдаж байна.

2. Хуулийн төслийн зохицуулалт хэрэгжих боломж хэр байгааг судлах:

Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.1-т хуулийн этгээдээр бүртгүүлэх баримт бичгийг бүрэн гүйцэд хүлээн авснаас хойш гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжээс бусад хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх эсэх талаар ажлын хоёр өдрийн дотор шийдвэр гаргаж, энэ тухай өргөдөл гаргагчид бичгээр, цахим хэлбэрээр мэдэгдэнэ гэж тусгагдсан байдаг.

Хуулийн этгээдийг бүртгэх эсэх талаар шийдвэр гаргах үйл ажиллагааг ажлын хоёр өдөрт багтаан шийдвэрлэхэд дараах хүндрэл, бэрхшээл гардаг талаар бүртгэгч нартай хийсэн ярилцлагад онцолсон байна. Үүнд:

- Хуулийн этгээдийн бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулахад улсын бүртгэгч нарт нэмэлт өөрчлөлт оруулахаар ирүүлсэн материалыг судлах, холбогдох судалгааг хийх зэрэг ажиллагаа ихтэй байдаг. Жишээ нь ХК-г ХХК болгож шилжүүлэх, хувьцаа нэмэх, хөрөнгө нэмэх зэргийг нягталж судлахад нэмэлт хугацаа шаарддаг.
- Нэг бүртгэгч өдөрт дунджаар 20-30 орчим бүртгэлийн материалыг бүртгэдэг[18] байна.
- Хуулийн этгээдийн бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулж байгаа тохиолдолд хувийн хэрэг хөтлөх журмын дагуу хувийн хэргийг архиваас аваад 8 цагийн дотор архивт буцааж өгөх шаардлагатай. Гэвч бүртгүүлэх материалаа бүрэн гүйцэт авчирч өгөөгүйгээс ажлын 8 цагт багтаан шалгахад хүндрэлтэй байдаг.

[16] Д.Болормаа, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, цаашдын зорилт, “Оюуны өмч, улсын бүртгэлийн өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага” Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл дотор, (2017) УБ., 73 дах тал.

[17] Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн улсын бүртгэгч нартай хийсэн ярилцлага.

[18] Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн төслийн зардлын тооцоо тайлангаас дэлгэрүүлэн үзнэ үү.

● Уг хуулийн төслийн 2015 онд батлагдсан шинэчилсэн найруулгын гол зорилго, агуулга нь цахим тогтолцоонд шилжих байсан бөгөөд хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх эсэхийг шийдвэрлэх хугацаа нь хуучин 5 хоногт бүрдүүлдэг байсныг 2 хоног болгон өөрчилж хурдан, шуурхай бүртгүүлэх тогтолцоо, боломжийг нээгдэнэ[19] гэсэн боловч цахим бүртгэлийн тогтолцоонд бүрэн шилжээгүй байгааг анхаарах хэрэгтэй.

● Улсын бүртгэгч ирүүлсэн материалыг бүрэн хяналт хийж чадаагүйн улмаас хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч болон хувьцаа эзэмшигчдийн хооронд ирээдүйд бий болж болзошгүй маргаан шүүхээр шийдвэрлүүлэхэд тухайн хуулийн этгээдийн нэмэлт өөрчлөлт оруулсан бүртгэлийг хүчингүйд тооцох зэрэг үр дагавар, эрсдэл байгаа бөгөөд энэ төрлийн маргаан практикт цөөнгүй ажиглагддаг.

● Хуулийн этгээдийн улсын бүртгэгч нартай хийсэн ярилцлагад тэрээр хуулийн этгээд шинээр бүртгэх эсэх талаар ажлын хоёр өдөрт багтааж шийдвэр гарах боломжтой гэхдээ хуулийн этгээдийн бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулахад хувийн хэргээс материалыг шалгах гэх зэрэгт цаг их зарцуулдаг учраас ажлын гурван өдөр болгох[20] саналтай байгаагаа онцолсон.

Үүнтэй холбогдуулан улсын бүртгэгч ирүүлсэн материалыг бүрэн нягталж чадаагүйн улмаас хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч болон хувьцаа эзэмшигчдийн хооронд маргаан үүсч болзошгүй байдал үүсдэг.

Дээрхээс үзэхэд хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх эсэх талаар ажлын хоёр өдрийн дотор шийдвэр гаргаж, энэ тухай өргөдөл гаргагчид бичгээр, цахим хэлбэрээр мэдэгдэх гэсэн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд зарим хүндрэл үүсч байгаа нь харагдаж байна. Үүнтэй холбогдуулан энэ хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэхийн тулд 1/ Шинээр хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд шийдвэр гаргах хугацааг ажлын 2 өдөрт багтаан бүртгүүлэх боломжтой боловч хуулийн этгээдийн бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийг ажлын 2 өдөрт багтаах гэснийг ажлын 3 өдөр болгон өөрчлөх; эсхүл 2/ бүртгэгч нарын тоог нэмэгдүүлэх; 3/ хуулийн этгээдийн бүртгэлийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж Улсын бүртгэлийн байгууллагын ачааллыг бууруулахад анхаарах шаардлагатай.

Хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.1.3 дахь заалтад тусгагдсан хуулийн этгээдийг бүртгүүлэхэд шаардагдах баримт бичгийг хуурамч эсэхийг тогтоох гэсэн эрх зүйн зохицуулалт практикт хэрэгжих боломжтой эсэхэд дүн шинжилгээ хийсэн байдал

1.Хэрэгжүүлэх субъект байгаа эсэх:

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулинд “хуулийн этгээдийн баримт бичгийн хуурамч эсэхийг эрх бүхий байгууллага тогтооно”[21] гэж заасан ба энэ хуулийн төслийн холбогдох заалттай жишиж үзвэл улсын бүртгэгч уг хяналтыг хэрэгжүүлэхээр болсон байна. Үүнээс үзэхэд хуулийн төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэгч субъект байна.

[19] Монгол Улсын Их Хурлын 2014 оны намрын ээлжит чуулганы 2015 оны 1 сарын 29-ний өдрийн хуралдааны тэмдэглэл.

[20] Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн улсын бүртгэгч нартай хийсэн ярилцлага.

[21] Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, 19 дүгээр зүйлийн 19.1.3.

2. Хуулийн төслийн зохицуулалт хэрэгжих боломж хэр байгааг судлах

Өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 19.1.3-т “өргөдөл гаргагч хууль тогтоомжид заасан баримт бичгийг хуурамчаар бүрдүүлснийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоосон” гэж тусгасан байсныг энэ хуулийн төсөлд “эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоосон” гэснийг хасчээ.

Дээрх заалтаас тухайн зохицуулалтыг[22] хуулийн төслийн зохицуулалтаар хассан нь тухайн бүртгүүлэх баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн эсэхийг тогтооход мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор бус улсын бүртгэгч хянаж шийдвэрлэхээр болсон гэж үзэхээр байна. Улсын бүртгэгч бүртгүүлэхээр ирүүлсэн материал бүрийг хуулийн 13.1-т зааснаар ажлын хоёр өдөрт багтаан бүртгэх шийдвэрийг гаргах шаардлагатай тул эрх бүхий байгууллага хуурамчаар бүрдүүлсэн баримт бичгийг хянаж шалгаад зохих шийдвэрийг улсын бүртгэгчид ажлын хоёр өдрийн дотор ирүүлэх боломж хомс байдаг. Тухайлбал, Баримт бичгийн хуурамч эсэхийг шалгахад хамгийн багадаа 3-аас доошгүй хоног шаардлагатай[23] байдаг.

Зарим тохиолдолд улсын бүртгэгч эргэлзээ бүхий баримт бичгийг хянуулахаар эрх бүхий байгууллагад хүргүүлдэг ба ихэнх тохиолдолд эрх бүхий байгууллагад хянуулалгүйгээр үзэмжээрээ хянаж, шалган бүртгэл хийх нь практикт хэвшиж тогтсон байна. Улсын бүртгэгч баримт бичгийг хуурамч эсэхийг мэргэжлийн түвшинд бус нүдэнд харагдах байдлаар шалгаснаас үүдэн хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчдийн хооронд бий болсон маргаан шүүхээр шийдвэрлэгдэх явдал гардаг. Жишээ нь: хуулийн этгээдийн нэг үүсгэн байгуулагч эсхүл хувьцаа эзэмшигчийн гарын үсгийг баримт бичигт дуурайлган зурах, бусдын өмнөөс зурж бүртгэл хийлгэх, хуурамч баримт бичгийг нотариатаар батлуулах[24] зэрэг олон асуудал үүсдэг.

Үүнээс үүдэн баримт бичгийн хуурамч эсэхийг шалгах нь нарийн ажиллагаатай, мэргэжлийн өндөр ур чадвар шаарддаг болох нь илэрхий байна. Тиймээс баримт бичгийн хуурамч эсэхийг тогтоох техник, тоног төхөөрөмжтэй болоход анхаарах шаардлагатай.

3.3. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

Хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд судалгаа хийхэд тухайн хуулийн төсөлд тодорхой этгээдэд үүрэг хүлээлгэсэн, аж ахуйн нэгж байгууллагад ачаалал, хүндрэл үүсгэх, эсхүл төрийн байгууллагад шинэ бүтэц бий болгох, шинээр чиг үүрэг нэмэгдэх зэрэг зохицуулалт байгаа тохиолдолд судалгаа хийхийг ойлгоно. Энэхүү шалгуур үзүүлэлтийн судалгааг гүйцэтгэхдээ уг хуулийн төслийн хэрэглэгч субъектүүдэд хандсан анкетын судалгаа авах, “фокус” бүлгийн ярилцлага хийх, хуулийн төсөлд санал авах, тухайн хуулийн төсөлтэй холбоотой эх сурвалжийн судалгаа хийх зэргээр хийж болдог.

Судалгааны багийн зүгээс “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” гэсэн энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоохдоо хуулийн төслийг хэрэгжүүлэгч субъектээс анкетын судалгаа авах нь үр дүнтэй байж чадахгүй гэж үзсэний үндсэн дээр бусад арга хэрэгслүүд болох “фокус” бүлгийн ярилцлага хийх, төсөлд санал авах, бүртгэлийн байгууллагын үйл

[22] Мөн тэнд.

[23] Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс авсан мэдээлэлд үндэслэв.

[24] Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн улсын бүртгэгч нартай хийсэн ярилцлага.

ажиллагааны тайлан, илтгэлийн эмхтгэл, бүртгэх явцад үүсэх процесс ажиллагаа зэрэгт дүн шинжилгээ хийх замаар шалгасан. Энэхүү шалгуур үзүүлэлтээр 1/ Хуулийн этгээдэд нэмэлт баримт бичиг бүрдүүлэхээр тусгасан зүйл заалтуудын дүн шинжилгээ; 2/ Улсын бүртгэлийн байгууллага нууцын тухай хууль тогтоомжид зааснаас бусад улсын бүртгэлийн мэдээллийг өөрийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлэх гэсэн зүйл заалтуудын үр нөлөөг судалсан. Үүнд:

17 дугаар зүйлийн 17.1, 21 дүгээр зүйлийн 21.1, 23 дугаар зүйлийн 23.1, 25 дугаар зүйлийн 25.1 дугаар зүйл заалтад дүн шинжилгээ хийсэн байдал.

Хуулийн төслөөс үзэхэд 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр батлагдан мөрдөж буй Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн холбогдох зүйл заалтуудтай харьцуулахад дараах өөрчлөлтүүд хийгджээ. Үүнд:

1. Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.6-д “хувь нийлүүлсэн хөрөнгө болохыг нотолсон банкинд харилцах данс нээлгэсэн баримт”, 17.1.7-д “үүсгэн байгуулагч, гүйцэтгэх удирдлагын цахим үнэмлэхийн хуулбар”, 17.1.8-д “хуулийн этгээдийн хаягийн нотлох баримт”-ыг тус тус нэмж бүртгүүлэхээр тусгасан;

2. Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1.8-д “өөрчлөн байгуулагдах үеийн санхүүгийн тайлан, тэнцэл”, 21.1.9-д “улсын бүртгэлийн гэрчилгээ”, 21.1.10-д “нэгдэх, нийлэх тохиолдолд Өрсөлдөөний тухай хуулийн 8.1-д заасны дагуу өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүгнэлт”-ыг тус тус нэмж бүртгүүлэхээр тусгасан;

3. Төслийн 23 дугаар зүйлийн 23.1.7-д “улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт”, 23.1.8-д “дүрэмд өөрчлөлт оруулах тохиолдолд шинэчилсэн дүрэм, хуульд заасан тохиолдолд шинэчилсэн гэрээ эсхүл гэрээний нэмэлт, өөрчлөлт” 23.1.9-д “хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт оруулах тохиолдолд баталгаажсан санхүүгийн тайлан, тэнцэл”, 23.1.10-д ”хаяг өөрчлөх тохиолдолд үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ эсхүл түрээсийн гэрээ зэрэг нотлох баримт”, 23.3.6-д “улсын бүртгэлийн гэрчилгээ” тус тус нэмж бүртгүүлэхээр тусгасан;

4. Төслийн 25 дугаар зүйлийн 25.1.7-д “татан буулгасан тухай өдөр тутмын сонинд зарлуулсан зар” зэрэг баримт бичгүүдийг шинээр нэмж бүрдүүлэхээр тусгажээ.

Эдгээр зүйл заалтуудад тусгагдсан баримт бичгүүдийг хуулийн этгээдүүд улсын бүртгэлд бүртгүүлэхдээ нэмж бүрдүүлэхээр тусгасан нь нэг талаас улсын бүртгэл үнэн зөв байх, бүртгэлтэй холбоотой хэрэг маргааны нотлох баримтын шаардлагыг хангуулах, нөгөө талаас Улсын бүртгэлтэй холбоотой үүсэх хэрэг маргааны тоог бууруулах ач холбогдолтой гэж хууль санаачлагч үзсэн нь харагдаж байна.

Ингээд эдгээр зүйл заалтуудаар нэмэлт, өөрчлөлт хийгдсэн хуулийн этгээдийн бүртгүүлэхэд нэмж шаардлагатай баримт бичгүүдийн төрлүүдийн хууль зүйн ач холбогдол болон зарим зүйл заалтын хууль зүйн техникийн асуудал, томьёолол зэрэгт дүн шинжилгээ хийж үзье.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар зүйлийн 5.2.7-д “Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хүнд суртлаас ангид байх эрх зүйн орчинг бүрдүүлж, иргэдийн эрхийг баталгаажуулна.” гэж тусгасан. Энэ хүрээнд хуулийн этгээдийн бүртгэлийн эрх зүйн орчныг сайжруулах, тэр дундаа Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн хэрэглэгч субъектүүд болох хуулийн этгээдийн төрлүүдийн бүртгэлийг түргэн шуурхай, хялбар болгох асуудалд хууль санаачлагч анхаарах шаардлагатай.

2015 онд батлагдсан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд “2012 онд хувийн хэвшлийн дунд хийсэн санал асуулгын дүнгээс үзэхэд хуулийн этгээдийн бүртгэлийг хялбаршуулж, цахимжуулах шаардлага байгаа бөгөөд одоогийн хууль, эрх зүйн орчинд хуулийн этгээдийг бүртгүүлэхийн тулд 12 төрлийн баримт бичиг бүрдүүлж 8 шат дамжлагаар 5 хоногт бүртгүүлж байгааг хялбаршуулж, хуулийн этгээдийг бүртгүүлэхэд бүрдүүлэх баримт бичгийг цөөрүүлэх, хурдан шуурхай, шат дамжлагыг багасгах, чирэгдэлгүй болгох шаардлага зүй ёсоор урган гарч байна.” гэжээ.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлсэн “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичигт дэмжлэг үзүүлэх нь” судалгааны Хавсралт тайлангийн 3-т буюу “Бизнесийн орчин дахь эрх зүйн шинэтгэл”-ийн хүрээнд хийсэн социологийн судалгаагаар аж ахуйн нэгж байгууллага тэр дундаа жижиг дунд эрхлэгчид улсын бүртгэлд бүртгүүлэхэд зарим талаар хүндрэлтэй асуудал гардаг талаар дурджээ. Тухайлбал, жижиг дунд бизнес эрхлэгч, аж ахуйн нэгж байгууллагуудад улсын бүртгэлд бүртгүүлээгүй шалтгаануудад 1/ тухайн бүртгүүлж буй субъектүүд бүртгүүлэхийн ач холбогдлыг сайн мэдэхгүй 2/ бүртгүүлэх үйл явц хүндрэлтэй 3/ цаг хугацаа их шаарддаг 4/ бүртгэлийн хураамж их, зардал өндөр 5/ хүнд сурталтай, үйлчилгээний чанар муу байдаг гэж тус тус хариулсан байна.[25] Түүнчлэн төрийн албан хаагчид бүртгэл, зөвшөөрөл болон бусад чиглэлийн мэдээлэл өгөхдөө хойрго, нэг хүнийг олон дахин явуулж чирэгдүүлэх хандлага байна гэжээ.[26]

Үүнээс үзэхэд хуулийн этгээдийн бүртгэлийг хэрэглэгчид түргэн, шуурхай хийх, аж ахуйн нэгж байгууллагыг шинээр үүсэн байгуулахад зардал чирэгдэл багатайгаар бүртгэх нь хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуулийн төслийн нэн тэргүүнд шийдвэрлэх зорилт болох нь харагдаж байна. Үүнтэй холбогдуулан дүгнэхэд дээрх хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.1, 21 дүгээр зүйлийн 21.1, 23 дугаар зүйлийн 23.1, 25 дугаар зүйлийн 25.1 дэх тус тус хэсэгт нэмэлт баримт бичиг, мэдээлэл шаардлагатай байхаар тусгасан нь хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн зорилт хангагдаагүй байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6-д дахь заалтад дүн шинжилгээ хийсэн байдал.

> “9.6.Улсын бүртгэлийн байгууллага нууцын тухай хууль тогтоомжид зааснаас бусад улсын бүртгэлийн мэдээллийг өөрийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ” гэсэн зүйл заалтад дүн шинжилгээ хийсэн байдал.

Хуулийн төслийн агуулгаас харахад Улсын бүртгэлийн байгууллага нь нууцын тухай хууль тогтоомжид зааснаас бусад улсын бүртгэлийн мэдээллийг нийтэд мэдээлэхээр тусгажээ.

Нийтэд мэдээлж болохуйц бүртгэлийн мэдээлэл гэдэгт хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол уг хуулийн төслийн 11 дүгээр зүйлд тусгагдсан Хуулийн этгээдийн хувийн хэрэгт хавсаргах мэдээллүүд болох дор дурдсан мэдээллүүд хамаарахаар тусгагдсан. Үүнд:

- Нэр
- Регистр
- Хаяг байршил, утас
- Бүртгүүлсэн огноо

[25] Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичигт дэмжлэг үзүүлэх нь тайлан, Хавсралт тайлан 3, Хууль зүйн үндэсний хүрээлэн, (2016), УБ., 6 дахь тал.

[26] Мөн тэнд.

- Хувьцаа эзэмшигч
- Эзэмшиж буй хувь хэмжээ
- Дүрмийн сан
- Үйл ажиллагааны чиглэл
- Гүйцэтгэх удирдлага, төлөөлөх этгээд
- Бүртгэлд орсон өөрчлөлтүүд гэх мэт ...

Эдгээр мэдээллүүдийг нийтэд ил болгохын ач холбогдлыг 1/ Бүртгэлийн байгууллагын ачаалал багасна; 2/ Иргэн, Хуулийн этгээдийн цаг завыг хэмнэх; 3/ Хуулийн этгээдийн ил тод байдал; 4/ Улсын төсвийн орлого бүрдэх; 5/ Хөрөнгө оруулалт, бизнесийн эрх зүйн орчин сайжрахад эерэг нөлөөтэй гэж зарим судлаачид үзжээ.[27]

Судалгааны багийн зүгээс хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой дээр дурдсан мэдээллийг олон нийтэд ил тод болгох нь зохистой эсэх талаар зарим нэгэн хуулийн этгээдийн төлөөллүүдтэй фокус ярилцлага хийсэн. Энэхүү ярилцлагаар хуулийн этгээдийн зарим төлөөллүүд нь тохиолдлын журмаар Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхээр ирсэн хүмүүс байсан. Эдгээр байгууллагын төлөөллүүд нийтлэг байдлаар дараах хариултыг өгсөн.

Хуулийн этгээдийн зарим төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас…

"Аж ахуйн нэгж байгууллагуудын бүртгэлтэй холбоотой зарим мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод болгох нь зохисгүй гэж бодож байна. Учир нь аж ахуйн нэгж байгууллагууд хоорондоо өрсөлдөгчид, өөрөөр хэлбэл зах зээлд бий болгосон давуу талыг алдаж магадгүй нөгөө талаар томоохон аж ахуйн нэгжүүд зах зээл дээр шударгаар өрсөлдөх боломжийг хязгаарлаж магадгүй" гэсэн бол өөр нэгэн аж ахуйн нэгж "хуулийн этгээдийн бүртгэлийн зарим мэдээллүүдийг олон нийтэд ил тод болгох нь зарим талаар сөрөг үр дагавартай байж магадгүй. Хэрвээ компанийн үйл ажиллагааны чиглэл, санхүүгийн тайлан, баланстай холбоотой мэдээлэл, хувь эзэмшигчийн мэдээлэл зэргийг ил тод байлгавал зарим хүмүүс буруугаар ашиглаж магадгүй" гэжээ.[28]

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагын бүртгэгчтэй хийсэн ярилцлагаас…

"Миний хувьд хуулийн этгээдийн мэдээллийг ил тод болгох нь цаашдаа их хэрэгтэй ажил гэж үзэж байна. Энэ нь бидний ажлыг хөнгөвчлөх, ажлын ачааллыг бууруулах, улмаар бизнесийн орчинд эерэг нөлөөтэй гэж бодож байна. Гэсэн хэдий ч хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой зарим мэдээллийг Улсын бүртгэлийн байгууллагын цахим хуудсаар нийтэд мэдээлэхээр төсөлд тусгавал зарим аж ахуйн нэгжүүд их дургүй хүлээж авах байх гэж бодож байна. Яагаад гэхээр миний ажигласнаар зарим байгууллагууд ялангуяа том аж ахуйн нэгжүүд бүртгэлтэй холбоотой үйлчилгээ авахдаа баримт бичгээ ихэд нууцалдаг. Энэ нь тэдгээр байгууллагууд бусад өрсөлдөгчид мэдээллийг нь буруугаар ашиглахвий гэхээс

[27] Д.Болормаа, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, цаашдын зорилт, "Оюуны өмч, улсын бүртгэлийн өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага" Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл дотор, (2017) УБ., 74 дэх тал.

[28] Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраар үйлчлүүлж байсан хуулийн этгээдийн зарим төлөөллүүдтэй хийсэн ярилцлага. /2017 оны 02 дугаар сарын 22-ний өдөр/

болгоомжилдог байх гэж бодож байна.” гэжээ.[29]

Дээрхээс үзэхэд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн зарим мэдээллийг нийтэд ил тод байх талаар хуулийн төсөлд тусгах нь хуулийн хэрэглэгч этгээдүүд зарим талаар хүлээн зөвшөөрөх боломжгүй болох нь харагдаж байна. Үүнтэй холбогдуулан дүгнэхэд хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой зарим мэдээллийг Улсын бүртгэлийн байгууллага цахим хуудсаараа нийтэд ил тод болгох нь бизнесийн эрх зүйн орчныг сайжруулахад чухал ач холбогдолтой боловч өнөөгийн нөхцөлд хэрэгжихэд хүндрэлтэй болов уу гэж үзэж байна.

3.4. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

Хуулийн төсөл нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой байдлаар томьёологдсон эсэхийг шалгах үүднээс хуулийн төсөлд санал авахаар Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас авсан санал болон судалгааны багийн зүгээс хуулийн төслийн ойлгомжтой байдалд дүн шинжилгээ хийсэн болно.

№	Ойлгомжгүй байгаа хуулийн төслийн зохицуулалт	Тайлбар	Санал
1	8.4.Улсын бүртгэлийн байгууллага хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэлийг “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал, тодорхойлолт”-д заасан салбарын ангилал, дэд салбараар бүртгэнэ.	Энэ хэсэгт “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал, тодорхойлолт”-д заасан салбарын ангилал, дэд салбараар бүртгэнэ гэдгийг хэрхэн ойлгох талаар ойлгомжгүй байна.	“Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал, тодорхойлолт”-д заасан салбарын ангилал, дэд салбараар бүртгэх гэснийг хуулийн төсөлд тодорхой болгон тусгах
2	10.2.Хуулийн этгээдийн хувийн хэргийг улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд хөтлөхдөө улсын хэмжээний бусад мэдээллийн систем, сүлжээтэй харилцан уялдаатай байх зарчмыг удирдлага болгон зохих арга зүйг ашиглана.	Энэ хэсгийн “зохих арга зүйг ашиглах” гэсэн нь ойлгомжгүй байна.	“зохих арга зүйг ашиглах” гэснийг хуулийн төсөлд ойлгомжтой байдлаар тусгах
3	13.3.Цахим хэлбэрээр өргөдөл гаргагч энэ хуулийн 13.1-д заасны дагуу улсын бүртгэлд бүртгэх тухай мэдэгдэл хүлээн авсан өдрөөс хойш энэ хуулийн 17.1-17.3-т заасан, эх хувь нь шаардлагатай баримт бичгийг өөрийн иргэний үнэмлэхийн хамт холбогдох улсын бүртгэлийн байгууллагад ажлын таван өдрийн дотор биечлэн авч ирснээр бүртгэл албан ёсоор баталгаажна.	Энэ хэсгийн агуулга нь хуулийн этгээдийн бүртгэлийг хялбаршуулах, цахим хэлбэрээр өргөдөл гаргагчийн ажлыг хөнгөвчлөх агуулгаар төсөлд тусгагдсан боловч бүртгэлийг албан ёсоор баталгаажуулахдаа биечлэн ирж баталгаажуулахаар тусгагдсан нь хуулийг хэрэглэгчид ойлгомжгүй, хүндрэлтэй байдал бий болгожээ. Өөрөөр хэлбэл энэхүү заалтын агуулгаас харахад хуулийн этгээдүүд бүртгүүлэхдээ эхлээд цахимаар хандаж дараа нь биечлэн материалаа авч ирсэнээр бүртгэл баталгаажихаар тусгагдсан нь шат дамжлагын хувьд хоёр шаттайгаар бүртгүүлэхээр тусгагдсан гэж ойлгогдохоор байна.	Энэхүү хэсгийн агуулгыг хуулийн төслийн үзэл баримтлал, зорилготой нийцүүлэн дахин өөрчлөн найруулах

[29] Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын улсын бүртгэгч нартай хийсэн ярилцлага. /2017 оны 02 дугаар сарын 15-ны өдөр/

4	14.2.3. Нийтийн зан суртахуунд сөргөөр нөлөөлөхөөргүй	Энэхүү заалтын нийтийн зан суртахуунд сөргөөр нөлөөлөхөөргүй гэснийг хэрхэн ойлгох талаар ойлгомжгүй байдал үүсгэж байна. Тухайлбал, хуулийн этгээдийн нэр олгох, баталгаажуулахдаа ямар үйлдлийг нийтийн зан суртахуун гэж ойлгох, нийтийн зан суртахуунд харшилсныг хэн тогтоох, нийтийн зан суртахуунд сөргөөр нөлөөлөөгүй гэдгийг хэрхэн ойлгох нь ойлгомжгүй болжээ.	Бүртгэлийн байгууллагаас нийтийн зан суртахуунд сөргөөр нөлөөлөх гэснийг тодорхой болгон төсөлд тусгах, эсхүл энэхүү заалтыг ойлгомжтой болгох үүднээс нарийвчилсан журам гаргах
5	17.2.4.гадаадын хөрөнгө оруулагч мөнгөн хөрөнгө, бэлэн мөнгө, хөдлөх эд хөрөнгө, оюуны өмчөөр хөрөнгө оруулалт хийж байгаа бол гадаад улсаас мөнгөн хөрөнгө шилжүүлснийг нотолсон банкны тодорхойлолт, дансны хуулга, гаалийн байгууллагын мэдүүлэг, эрх бүхий байгууллагаас олгосон гэрчлэх баримт бичиг.	Энэхүү хэсэгт гадаадын хөрөнгө оруулагч ..., оюуны өмчөөр хөрөнгө оруулалт хийж байгаа бол ямар баримт бичгийг бүрдүүлэх талаар ойлгомжгүй тусгасан байна.	Энэхүү заалтыг өөрчлөн найруулах
6	17.8.Улсын бүртгэлийн байгууллага нь гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн хүсэлтэд үндэслэн тухайн иргэн гадаадын хөрөнгө оруулагч, эсхүл гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, түүний салбар, төлөөлөгчийн газарт ажиллах удирдах албан тушаалтнаар бүртгэлтэй байгаа болон энэ хуулийн 17.7-д заасан үйл ажиллагаа явуулах хугацааны талаарх тодорхойлолтыг гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад батлагдсан маягтаар гарган өгнө.	Энэхүү хэсэгт Улсын бүртгэлийн байгууллагын гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдтэй холбогдох тодорхойлолтыг гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гарган өгөх гэсэн агуулгаар тусгасан гэж ойлгогдохоор байгаа боловч уг хэсэгт хууль хэрэглэгчийн зүгээс уншихад ойлгомжгүй байна.	Энэхүү хэсгийг дахин найруулж бичих шаардлагатай буюу уг заалтад тусгагдсан үйлдлүүдийг тус тусад нь заалт болгон ялгаж, энгийн, ойлгомжтой болгох
7	18.2.Цахим хэлбэрээр өргөдөл гаргасан тохиолдолд улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 13.3-т заасны дагуу эх хувиар авч ирсэн баримт бичгийг цахим хэлбэрээр ирүүлсэн баримт бичигтэй тулган нягталсны дараа тухайн хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичгийн эхний хуудас дээр хуулийн этгээдийн хувийн хэргийн дугаар, он, сар, өдөр бүхий баталгааны тэмдэг, бусад хуудас дээр улсын бүртгэгчийн тэмдэг дарснаар хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэсэнд тооцно.	Иргэн, хуулийн этгээд цахим хэлбэрээр өргөдөл гаргах нь бүртгэлийг хурдан шуурхай, шат дамжлагыг багасгах агуулгатай зохицуулалт болсон боловч энэхүү хэсэгт бүртгүүлэхээр өргөдөл гаргагч баримт бичгээ дахин биечлэн авч ирсний дараа бүртгэлийг хийхээр тусгасан агуулгын хувьд зөрчилтэй болжээ.	Энэхүү хэсгийг уг хуулийн зорилготой нийцүүлэх өөрчлөн найруулах

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nii.gov.mn

8	Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.11, 12 дугаар зүйлийн 12.5, 17 дугаар зүйлийн 17.2.1, 24 дүгээр зүйлийн 24.1-т тус тус заасан “эрх бүхий этгээд”, “эрх бүхий байгууллага” гэх зэргээр тусгасныг тодруулах	Энэхүү дурдсан зүйл заалтуудад “эрх бүхий этгээд”, “эрх бүхий байгууллага” гэх зэргээр тусгасан нь хуулийг хэрэглэгч субъектүүдэд ойлгомжгүй болжээ.	Төслийн зарим зүйл заалтуудад “эрх бүхий этгээд”, “эрх бүхий байгууллага” гэж томъёологдсон нь тодорхой бус болсон тул хууль хэрэглэгчийн зүгээс ойлгоход энгийн байдлаар уг зүйл заалтуудыг нарийвчлах, өөрчлөн найруулах
9	24.2.Иргэний хуулийн 32.3-т заасны дагуу татан буулгах комисс тухайн хуулийн этгээдийг татан буулгасан тухай нийтэд мэдээлснээс хойш хоёроос зургаан сарын дараа уг хуулийн этгээдийг татан буулгаж дууссан тухай холбогдох улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ.	Энэ хэсэгт “... татан буулгах комисс тухайн хуулийн этгээдийг татан буулгасан тухай нийтэд мэдээлснээс хойш хоёроос зургаан сарын дараа уг хуулийн этгээдийг татан буулгаж дууссан тухай холбогдох улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ.” гэсэн нь цаг хугацааны хувьд ойлгомжгүй болсон байна.	хуулийн этгээдийг татан буулгасан тухай нийтэд мэдээлснээс хойш хоёроос зургаан сарын дотор … улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ гэх агуулгаар өөрчлөх

Түүнчлэн энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг шалгасан. Үүнд:

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	-Хуулийн төслийн 1.1, 3.1.1, 4.1, 8.4 дүгээр зүйл, заалтуудын зорилго, агуулгыг авч үзэхэд Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д заасан бүх төрлийн хуулийн этгээдийг энэ хуулиар бүртгэхээр зааж өгсөн. Гэтэл хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дүгээр зүйлд 9 төрөл, хэлбэрийн хуулийн этгээдийг бүртгэнэ гэж заасан нь Төрийн бус байгууллагын тухай хууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан хуулийн этгээдийн төрөл, хэлбэр болох “төрийн бус байгууллага”, “нийтийн эрх зүйн хуулийн этгээд” гэсэн хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг бүртгэхгүй байх мэтээр зөрчилтэй болсон байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУУЛЬ
www.nlo.gov.mn

	-Хуулийн төсөлд хуулийн этгээд шинээр үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах замаар хуулийн этгээд байгуулах, хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт оруулах, хуулийн этгээд татан буугдсаныг бүртгүүлэх шаардлагатай баримт бичгийн жагсаалтыг бүлэг тус бүрт нь зааж өгсөн. Тухайлбал хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.5-д "хуульд өөрөөр заагаагүй бол улсын бүртгэлийн байгууллага өргөдөл гаргагчаас энэ хуулийн 17.1-3-т заасан бусад баримт бичгийг шаардахгүй" гэж заасан боловч Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5.1-т "улсын бүртгэлд бүртгүүлэх эрхийн үнэн зөвийг нотлох баримт, тайлбар, лавлагааг холбогдох албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдээс гаргуулан авах" гэсэн заалтыг үндэслэн хуулийн төсөлд зааснаас өөр, хуульд заагаагүй баримт бичгийг шаарддаг. Иймд Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 11.5.1 болон хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.5 дахь заалтын уялдаа холбоог сайжруулах, зөрчлийг арилгах. -Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.6-д "Улсын бүртгэлийн байгууллага нууцын тухай хууль тогтоомжид зааснаас бусад улсын бүртгэлийн мэдээллийг өөрийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ" гэж зааж өгсөн. Гэтэл Байгууллагын нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т "нууцын тухай хуулийн 3.2-т хамаарах нууцыг байгууллага өөрөө тогтооно" гэж заасан байх бөгөөд улсын бүртгэлийн байгууллага хуулийн этгээдийн өөрөө тогтоож нууцад хамааруулсан нууцыг тэр болгон мэдэх боломжгүй. Иймд хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь заалт болон Нууцын тухай хуулийн холбогдох зүйл заалтын уялдаа холбоог бий болгох, зөрчлийг арилгах.
29.1.2. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Хуулийн төсөлд Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-т заасан хуулийн этгээдийг хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг үл харгалзан бүх төрөл, хэлбэрийн хуулийн этгээдийг бүртгэх, мэдээлэлд нь өөрчлөлт оруулах, татан буулгасныг бүртгэх, нэрийн баталгаажуулалт олгох, лавлагаа өгөх зэрэг харилцааг зохицуулахаар тусгасан. Гэхдээ тухайн төрлийн харилцааг зохицуулах эрх зүйн нарийвчилсан зохицуулалт нь зарим талаар дутмаг байна. Уг судалгааны 15 дахь талаас дэлгэрүүлэн үзнэ үү.
29.1.3. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Хуулийн төсөл зохицуулах харилцаа, хүрээнээс хальсан зүйл судалгаагаар тогтоогдоогүй.
29.1.4. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХЭЛТЭС www.nlc.mn

29.1.5. Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1-т “энэ хуулийн зорилт нь хуулийн этгээд шинээр үүсгэн байгуулсан, өөрчлөн байгуулсан, татан буулгасныг болон түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх, иргэн, хуулийн этгээд болон эрх бүхий байгууллага, албан тушаалтанд лавлагаа олгох, хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино” гэж заасан бол хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1-т “ хуулийн этгээдийн төрөл хэлбэрээс үл хамааран иргэний эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсч, хуульд заасан журмын дагуу татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болохтой холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна” гэж хуулийн үйлчлэх хүрээг багасгаж, явцууруулсан байна. Өөрөөр хэлбэл зөвхөн хуулийн этгээд шинээр бүртгүүлэх болон татан буугдсаныг бүртгэх харилцааг л зохицуулах мэт ойлгогдож байна.
29.1.6. Хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.7. Бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг иш татах, энэ тохиолдолд ишлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Иргэний хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн ишэлсэн байх боловч хуулийг хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг зааж өгөөгүй. Түүнчлэн Байгууллагын нууцын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хуулийг ишэлсэн байх боловч аль заалтаас ишлэл хийж байгаа нь тодорхойгүй, нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг зааж өгөөгүй.
29.1.8. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Хуулийн төслийн 27 дугаар зүйлийн 27.1-т “... холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ” гэж тодорхойгүй байдлаар зааж өгснийг тодорхой болгох.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулаагүй байна.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

хуулийн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага.	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.2.нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.1, “... бичгээр, цахим хэлбэрээр мэдэгдэнэ”, 13.2-т “... мэдэгдлийг бичгээр, цахим хэлбэрээр хүргүүлнэ” гэсэн байх бөгөөд аль аль хэлбэрээр нь мэдэгдэнэ гэж ойлгох эсэх, эсвэл аль нэгээр нь хүргүүлж мэдэгдэхэд хангалттай эсэх нь ойлгомжгүй найруулга болсон байна.
30.1.4.хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

3.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

“Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” гэсэн шалгах хэрэгслээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судлан, хуулийн төслийн дотоод болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулах юм. Түүнчлэн хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан дараах асуудлуудыг тодорхойлох байдлаар хуулийн төслийн харилцан уялдаатай байдлыг үнэллээ.

Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
Хуулийн төслийн зохицуулалт нь тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	-Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дүгээр зүйлд заасан хуулийн этгээдүүдийг л бүртгэхээр зааж өгсөн байгаа нь хуулийн төслийн 1 дүгээр зүйлд заасан зорилттой бүрэн нийцэхгүй байна. -Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1-т заасан хуулийн үйлчлэх хүрээ нь хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх болон татан буугдсаныг бүртгэх харилцаагаар хязгаарлагдах мэтээр бичигдсэн нь хуулийн төслийн 1 дүгээр зүйлд заасан зорилтод нийцэхгүй байна.
Хуулийн төслийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх,	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nlic.gov.mn

Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	*Хуулийн төслийн зүйл заалт өөр хооронд нийцэж байгаа эсэх:* -Хуулийн төслийн 1.1, 3.1.1, 4.1, 8.4 дүгээр зүйлүүдийн зорилго, агуулгыг авч үзэхэд Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д заасан бүх төрлийн хуулийн этгээдүүдийг энэ хуулиар бүртгэхээр зааж өгсөн. Гэтэл хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1-т хуулийн этгээдийн 9 төрөл, хэлбэрийг бүртгэнэ гэж заасан нь Төрийн бус байгууллагын тухай хууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан хуулийн этгээдийн төрөл, хэлбэр болох “төрийн бус байгууллага”, “нийтийн эрх зүйн хуулийн этгээд” гэсэн хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг бүртгэхгүй байх мэтээр зөрчилтэй болсон байна. *Хуулийн төслийн зүйл заалт бусад хуультай нийцэж байгаа эсэх:* -Хуулийн төсөлд хуулийн этгээд шинээр үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах замаар хуулийн этгээд байгуулах, хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт оруулах, хуулийн этгээд татан буугдсаныг бүртгүүлэх шаардлагатай баримт бичгийн жагсаалтыг бүлэг тус бүрт нь зааж өгсөн. Тухайлбал хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.5-д “хуульд өөрөөр заагаагүй бол улсын бүртгэлийн байгууллага өргөдөл гаргагчаас энэ хуулийн 17.1-3-т заасан бусад баримт бичгийг шаардахгүй” гэж заасан боловч Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5.1-т “улсын бүртгэлд бүртгүүлэх эрхийн үнэн зөвийг нотлох баримт, тайлбар, лавлагааг холбогдох албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдээс гаргуулан авах” гэсэн заалтыг үндэслэн хуулийн төсөлд зааснаас өөр хуульд заагаагүй баримт бичгийг шаардагдахаар байна. Иймд Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 11.5.1 болон хуулийн төслийн 17.5 дахь заалтын уялдаа холбоог сайжруулах, зөрчлийг арилгах. -Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.6-д “Улсын бүртгэлийн байгууллага нууцын тухай хууль тогтоомжид зааснаас бусад улсын бүртгэлийн мэдээллийг өөрийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан нийтэд мэлээлнэ” гэж зааж өгсөн. Гэтэл Байгууллагын нууцын тухай хуулийн 4.2-т “нууцын тухай хуулийн 3.2-т хамаарах нууцыг байгууллага өөрөө тогтооно” гэж заасан байх бөгөөд улсын бүртгэлийн байгууллага хуулийн этгээдийн өөрөө тогтоож нууцад хамааруулсан нууцыг тэр болгон мэдэх боломжгүй. Иймд хуулийн төслийн 9.6 дахь заалт болон Нууцын тухай хуулийн холбогдох зүйл заалтын уялдаа холбоог бий болгох, зөрчлийг арилгах.
Хуулийн төслийн зүйл заалт нь тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	-Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1.9 -т “гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар”-ыг улсын бүртгэлийн байгууллага бүртгэнэ гэж зааж өгсөн бөгөөд мөн хуулийн төслийн 9.1.9-т “гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрыг холбогдох журмын дагуу шинээр бүртгэх, улсын бүртгэлд өөрчлөлт оруулах, улсын бүртгэлээс хасах гэж ижил агуулгатай давхардсан зохицуулалт болсон байна. Иймд 9.1.9 дэх заалтыг хасах.
Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Хуулийн төслөөр хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ САН
www.nlis.mn

Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	-Хуулийн төслөөр улсын бүртгэлийн үйлчилгээг цахим хэлбэрээр авч болохоор зохицуулж өгсөн ч цахим хэлбэрээр үйлчилгээ авах зохицуулалтуудыг хэрхэн хэрэгжүүлэх талаарх нарийвчилсан зохицуулалт тусгаагүй. Тухайлбал хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.3-т “хуулийн этгээдийн хувийн хэргийг цахим болон бичгийн хэлбэрээр давхар хөтөлнө” гэсэн байх боловч цахим хувийн хэргийг хэрхэн ашиглах, юунд ашиглах зэрэг нарийвчилсан зохицуулалт байхгүй, хэрэв хуулийн этгээд бичгийн хэлбэрээр хувийн хэргээ бүрдүүлж байгаа бол түүнийг хэрхэн цахим хувийн хэрэгт шилжүүлэх талаарх нарийвчилсан зохицуулалт байхгүй. -Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.8-д “Хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлийн гэрчилгээ болон тамга, тэмдгийн хяналтын дугаар дахин олгох тохиолдолд улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар өмнөх гэрчилгээ, хяналтын дугаарыг хүчингүйд тооцно” гэж заасан боловч хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлийн гэрчилгээ болон тамга тэмдгийн хяналтын дугаар дахин олгох тохиолдлыг тодорхой тусгаж өгөөгүй. Энэ зүйлд ямар тохиолдолд гэрчилгээ болон хяналтын дугаар дахин олгож болохыг тодорхой тусгаж нэмэлт зохицуулалт хийж өгөх шаардлагатай.
Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Хуулийн төслөөр төрийн байгууллагуудын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан, нэг чиг үүргийг хоёр өөр төрийн байгууллага хийж гүйцэтгэх, давхардуулан зохицуулсан заалт байхгүй.
Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр хураамж тогтоосон эсэх	Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.1-т “хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгүүлэхэд Улсын тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлс төлнө” гэж заасан байх бөгөөд улсын тэмдэгтийн хураамж болон үйлчилгээний хөлс гэсэн хоёр төлбөр төлөхөөр зааж өгсөн. Хуулийн этгээдийг бүртгүүлэхэд тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 15 дугаар зүйл зохицуулсан бол үйлчилгээний хөлсийг Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлд зааж өгсөн байна. Иймд уг хуулийн төсөл нь татвар, төлбөр хураамж шинээр тогтоосон зүйлгүй байна.
Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгаж байгаа эсэх	Энэ хуулийн төслөөр шинээр тусгай зөвшөөрөл бий болгох зохицуулалт байхгүй.
Хуулийн төслийн зүйл, заалт нь жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Хуулийн төслөөр хүйсийн ялгавартай байдал бий болгосон зүйл заалт байхгүй.
Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төслөөр шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн, бий болгосон заалт байхгүй.
Авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төслөөр хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг аль болох хурдан, шуурхай, нэгдсэн байдлаар үзүүлэх зорилтыг дэвшүүлж үүнд чиглэсэн зохицуулалтуудыг оруулсан.
Хуулийн төсөлд тусгасан хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Хуулийн төслийн 27 дугаар зүйлийн 27.1-т “... улсын бүртгэлийн байгууллагын ажилтан холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ” гэж хүлээлгэх хариуцлага нь тодорхойгүй.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

4.1. Үнэлэлт, дүгнэлт

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ шалгуур үзүүлэлт бүрээр дараах байдлаар үнэлж дүгнэлээ.

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төслийн зорилго, үзэл баримтлалаас гурван төрлийн зорилгыг тодорхойлж, эдгээр зорилгод хуулийн төслийн зүйл заалт хэрхэн нийцэж байгаад үнэлгээ хийсэн. Хуулийн этгээдийн төрөл хэлбэрээс үл хамааран хуулийн этгээдийг зөвхөн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэх, нэгдсэн тогтолцоог бий болгохоор зорьсон боловч Хуулийн төслийн 8.1 дүгээр зүйлд хуулийн этгээдийн 9 төрөл, хэлбэрийг л бүртгэхээр зааж өгсөн нь хязгаарлагдмал байх бөгөөд зарим хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг орхигдуулсан байна. Тухайлбал нийтийн эрх зүйн хуулийн этгээд, төрийн бус байгууллагын хэлбэрээр байгуулагдсан хуулийн этгээдийг орхигдуулжээ. Ингэснээр хуулийн этгээдийн төрөл хэлбэрээс үл хамааран улсын бүртгэлийг хийх зорилгодоо хүрч чадахааргүй байна гэж дүгнэлээ.

Хуулийн төслийн 4.1 дүгээр зүйлд хуулийн үйлчлэх хүрээг хумьж, хуулийн этгээдийн бүртгэл, хуулийн этгээдийн татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдахтай холбоотой харилцааг зохицуулахаар зааж өгсөн нь хуулийн төслийн зорилготой бүрэн нийцэж чадаагүй байна. Харин хуулийн төслийн 1.1 дүгээр зүйл болон 3.1.1 дүгээр зүйл заалт нь хуулийн төслийн үзэл баримтлалаар дэвшүүлж буй зорилгод нийцсэн, зорилгодоо хүрэх байдал нь эерэг байна.

Бүртгэлийн цахим тогтолцоонд шилжих, бүртгэлийг цахимаар хийлгэх, цахим өргөдөл, цахим нэрийн баталгаажуулалт хийлгэх зэрэг хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг цахимаар хийх эрх зүйн зохицуулалтыг бий болгохыг зорьсон байх бөгөөд үүнийг хуулийн төслийн 3.1.9, 6.1, 13.1-13.4 дүгээр зүйлүүдэд тус тус зохицуулж өгсөн нь улсын бүртгэлийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх зорилгодоо нийцсэн, зорилгод хүрэх байдал нь эерэг зохицуулалтууд гэж үзэж байна.

Бүртгэлийн байгууллага болон төрийн бусад байгууллагууд өөр хоорондоо мэдээлэл шуурхай солилцож, цаасгүй орчинд шилжих зорилгын хүрээнд хуулийн төслийн 9.1.6, 10.3, 12.2.1 дүгээр зүйлүүдэд үнэлгээ хийсэн. Цахим хэлбэрээр мэдээлэл, лавлагаа олгох эрх зүйн зохицуулалт боломжийг нь хуулийн төсөлд тусгаж өгсөн байх боловч цахим хувийн хэргийг хэрхэн яаж, ямар стандартаар бий болгох, цахим хэлбэрээр төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдэд лавлагаа, мэдээлэл олгоход нотлох баримтын шаардлага хэрхэн хангах зэрэг нарийвчилсан зохицуулалт дутмаг улмаас хуулийн төслийн дээрх заалтууд нь зорилгод хүрэх байдал нь хангалтгүй гэж дүгнэлээ.

Практикт хэрэгжих байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Уг хуулийн төслийн хүрээнд сонгож авсан цахим бүртгэл, бүртгэлийн хугацаа, хуурамч баримт бичгийг тогтоох зүйл заалтууд нь практикт хэрэгжих боломж байгаа эсэх талаар судлаад дараах дүгнэлтийг хийлээ. Үүнд:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн төсөл дээр дурдсан цахим бүртгэлтэй холбоотой зүйл заалтыг хэрэгжүүлэхэд Хуулийн этгээдийн цахим бүртгэлийг хийхэд программ хангамжийн хувьд шаардлага хангахгүй байна. Мөн хүний нөөцийн хувьд хангалттай бус байгаа зэргээс үүдэн бүрэн хэрэгжихэд хүндрэлтэй байна.

Хуулийн этгээдийг бүртгэлийг хийхэд ажлын 2 хоногийн дотор гэж заасан хугацаа нь хуулийн этгээдийг шинээр бүртгэх тал дээр практикт хэрэгжих боломжтой байна. Харин хуулийн этгээдийн бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд хүний нөөц хангалтай бус, судалж, шалгах материал ихтэй учир хугацааны хувьд тухайн зүйл заалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулдаг учраас үүнийг дахин анхаарах шаардлагатай.

Хуулийн этгээдийг бүртгэхэд шаардлагатай баримт бичгийг хуурамч эсэхийг ямар шалгуураар шалгах, тоног төхөөрөмж, арга зүй тодорхойгүй байна. Хуурамчаар бүрдүүлсэн баримт бичгийг бүртгэснээс үүдэн шүүхээр шийдвэрлүүлэх маргаан гарах магадлалтай. Иймд баримт бичгийн хуурамч эсэхийг тогтоох стандарт бий болгох, улсын бүртгэгчдийг сургалтад хамруулж арга зүйд сургах, техник тоног төхөөрөмж шаардагдах учир энэ тал дээр анхаарах хэрэгтэй.

Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.1, 21 дүгээр зүйлийн 21.1, 23 дугаар зүйлийн 23.1, 25 дугаар зүйлийн 25.1 дэх зүйл заалтуудад дүн шинжилгээ хийсэн байдал:

Хуулийн төслөөс үзэхэд 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр батлагдан мөрдөж буй Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн төслийн холбогдох зүйл заалтуудтай харьцуулахад зарим нэгэн баримт бичгүүдийг нэмж бүртгүүлэхээр тусгасан. Энэ нь уг хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан “хуулийн этгээдийн бүртгэлийг хялбаршуулах, хуулийн этгээдийг бүртгүүлэхэд бүрдүүлэх шаардлагатай баримт бичгийг цөөрүүлж, бүртгэлийг хурдан шуурхай болгох” гэсэн зорилтыг хангахад учир дутагдалтай болжээ. Үүнээс үзэхэд дээрх хуулийн төслийн холбогдох зүйл заалтуудаар нэмэлт баримт бичиг, мэдээлэл шаардлагатай байхаар тусгасан нь хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийг хангахад учир дутагдалтай болсон гэж байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6-д дахь заалтад дүн шинжилгээ хийсэн байдал:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн зарим мэдээллийг нийтэд ил тод байлгах талаар хуулийн төсөлд тусгах нь хуулийг хэрэглэгч субъектүүд зарим талаар хүлээн зөвшөөрөхгүй байх магадлал харагдаж байна. Үүнтэй холбогдуулан дүгнэхэд хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой зарим мэдээллийг Улсын бүртгэлийн байгууллага цахим хуудсаараа нийтэд ил тод болгох нь бизнесийн эрх зүйн орчныг сайжруулахад чухал ач холбогдолтой боловч өнөөгийн нөхцөлд хэрэгжихэд хүндрэлтэй болов уу гэж үзэж байна.

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төслийн ойлгомжтой байдлыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага, мөн Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг харгалзан үнэллээ.

Дээрх байдлаар хуулийн төслийн ойлгомжтой байдлыг үнэлэхэд хуулийн төсөл нь хуулийн төслийн эх бичвэрт тавигдах нийтлэг шаардлага, хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагыг зарим талаар хангаагүй, мөн Хууль

тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг зарим тохиолдолд баримтлаагүй байна гэж үзлээ. Үүнд:

Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.2, 10 дугаар зүйлийн 10.2, 13 дугаар зүйлийн 13.3, 14 дүгээр зүйлийн 14.2.3, 17 дугаар зүйлийн 17.2.4, 17.8, 18 дугаар зүйлийн 18.2, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь тус тус зүйл заалтууд ойлгомжгүй томьёологдсон;

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.11, 12 дугаар зүйлийн 12.5, 17 дугаар зүйлийн 17.2.1, 24 дүгээр зүйлийн 24.1-т тус тус заасан “эрх бүхий этгээд”, “эрх бүхий байгууллага” гэх зэргээр тусгасан нь хэрэгжүүлэх эрх бүхий субъектүүдийг ойлгомжгүй томьёолсон;

Уг хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлагын 29.1.3, 29.1.4, 29.1.6, 29.1.8, 29.1.11 дэх тус тус шаардлагыг хангасан боловч хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.2, 29.1.5, 29.1.7, 29.1.9, 29.1.10 дахь заалтуудад тавигдсан нийтлэг шаардлагуудыг хангаагүй байна.

Уг хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагын 30.1.1, 30.1.2, 30.1.4, 30.1.5 дахь заалтуудад тусгасан шаардлагыг хангасан боловч Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3-т заасан “үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих” гэсэн шалгуурыг зарим талаар хангаагүй байна.

Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь үнэлэхийг зорьж, хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуудлуудыг тодруулж, хуулийн төслийн дотоод болон бусад хууль тогтоомжтой хэрхэн уялдаж байгаа талаар үнэлэлт дүгнэлт өгөхийг зорьсон болно.

Хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлалын дагуу тодруулах шаардлагатай байх 14 төрлийн асуулгаас Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн төсөл нь 8 төрлийн асуулгын шаардлагыг хангасан, уялдаа холбоотой болсон байна гэж дүгнэлээ.

Үүнд, хуулийн төслийн “хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хуулиуд нь хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой харилцаанд хамааралтай, хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёонууд нь Иргэний хуулийн болон Улсын бүртгэлийн ерөнхий хуульд заасан нэр томьёотой нийцсэн, төрийн байгууллагуудын чиг үүргийг давхардуулсан зохицуулалт байхгүй, шинээр татвар, хураамж тогтоосон зүйлгүй, аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг шинээр бий болгоогүй, жендэрийн эрх тэгш байдлыг хангасан, шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн зохицуулалт хийгээгүй, авилга хүнд суртал бий болгоход чиглэсэн заалт тусгаагүй байна гэж дүгнэлээ.

Шалгуур үзүүлэлтэд заасан 6 асуулгын хүрээнд хуулийн төслийн зарим зүйл заалт уялдаа холбоотой байх шаардлага хангахгүй байна гэж үзлээ. Үүнд, хуулийн төслийн 4.1 болон 8.1 дүгээр зүйлүүд нь тухайн хуулийн зорилттой бүрэн нийцэж чадаагүй бөгөөд хуулийн төслийн 1.1, 3.1.1 дүгээр зүйлтэй зөрчилдөж байна. Хуулийн төслийн 17.5 дугаар зүйл нь Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 11.5.1 зүйлтэй; хуулийн төслийн 9.6 дугаар зүйл нь Байгууллагын нууцын тухай хуулийн

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

4.2 дугаар зүйлтэй зөрчилтэй, уялдаа муутай болжээ. Түүнчлэн хуулийн төслийн 8.1.9 дүгээр зүйл болон 9.1.9 дүгээр зүйлүүд нь хоорондоо ижил агуулгатай зүйлийг зохицуулсан, давхардсан зохицуулалт болсон байна.

Хуулийн төслийн 9.8 дугаар зүйлд гэрчилгээ болон тамга, тэмдгийн хяналтын дугаарыг ямар тохиолдолд дахин олгох тохиолдлуудыг хуульд тусгаж өгөөгүй, хуулийн төслийн 10.3 дугаар зүйлд заасан цахим хувийн хэргийг хэрхэн хөтлөх, хэрхэн ашиглах талаар нарийвчилсан зохицуулалтуудыг оруулж өгөөгүй байна гэж дүгнэлээ.

4.2. Зөвлөмж

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн төслийн үр нөлөөг тооцох ажиллагааны үр дүнд гарсан дүгнэлтэд тулгуурлан дараах зөвлөмжүүдийг гаргаж байна.

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

1. Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1-т 9 төрлийн хуулийн этгээдийг жагсааж өгсөн. Үүнд орхигдуулсан хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг нэмж оруулах, мөн түүнчлэн хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтад нийцүүлсэн ерөнхий зохицуулалтыг нэмж оруулах;

2. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн үйлчлэх хүрээг хуулийн төслийн 1.1 дүгээр зүйлд нийцүүлэн хуулийн үйлчлэх хүрээ, харилцааг өргөжүүлэн томьёолох;

3. Бүртгэлийн байгууллага болон төрийн бусад байгууллагууд өөр хоорондоо мэдээлэл шуурхай солилцож, цаасгүй орчинд шилжих, цахимаар лавлагаа өгөх зорилгод хүрэхийн тулд хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийг тууштай хэрэгжүүлэх; цахим хувийн хэргийг ашиглах эрх зүйн зохицуулалт, цахим хувийн хэргийг ашигласан тохиолдолд хэрхэн нотлох баримтын шаардлага хангуулах зэрэг нарийвчилсан зохицуулалтуудыг хуулийн төсөлд нэмж тусгаж өгөх шаардлагатай.

Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төслийн цахим хэлбэрийн бүртгэл, бүртгэлийн хугацаа, хуурамч баримт бичиг гэсэн зүйл заалтын хүрээнд судлахад практикт хэрэгжих боломжийн шалгуур үзүүлэлтэд гарсан бэрхшээл, асуудлыг дараах байдлаар шийдвэрлэх боломжтой талаар зөвлөж байна.

1. Хуулийн этгээдийн бүртгэлийн программыг шинэчилж боловсронгуй болгох;

2. Хуулийн этгээдийн цахим бүртгэлийг хариуцсан ажилтны орон тоог бий болгох, түүнийг тогтвортой ажлын байраар хангах;

3. Монгол Улсын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим хэлбэрийн бүртгэлийг хэрэгжүүлэхдээ нарийвчлан төлөвлөж хийх;

4. Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.4-т зааснаар баримт бичгийг цахим хэлбэрээр ирүүлэхдээ гарын үсгээ Цахим гарын үсгийн тухай хуульд заасны дагуу баталгаажуулна гэсэн заалтыг хэрэгжүүлэхийн тулд цахим гарын үсгийг хэрэгжүүлэх;

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

5. Хуулийн этгээдийн цахим бүртгэлийн талаар иргэдэд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр сурталчлах;

6. Хэрэглэгчдийг түргэн шуурхай мэдээллээр хангах, туслах зорилгоор онлайн зөвлөгөө өгдөг болгох;

7. Хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.4-т хуулийн этгээд улсын бүртгэлийн цахим гэрчилгээг хэвлэн авах боломжтойгоор өөрчлөх;

8. Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.1-т заасан хуулийн этгээдийг бүртгэх эсэх талаар шийдвэр гаргахдаа шинээр бүртгүүлж буй хуулийн этгээдийг ажлын хоёр хоногт, нэмэлт өөрчлөлт оруулах гэснийг ажлын гурван өдрийн дотор бүртгэх гэж өөрчлөх; эсхүл бүртгэгчийн ажлын ачааллыг бууруулахад анхаарах;

9. Хуулийн төслийн 23 дугаар зүйлийн 23.1.1-т нэрийн баталгаажуулалт, 25.1.7-т татан буулгасан тухай өдөр тутмын сонинд зарлуулах нь хэрэгтэй хүндээ хүрэх тал дээр дутагдалтай байдаг. Энэ талаарх мэдээллийг улсын бүртгэлийн цахим хуудсанд байршуулах;

10. Хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.1.3-т заасан хуулийн этгээдийг бүртгүүлэхэд шаардлагатай материалын баримт бичгийн хуурамч эсэхийг хэрхэн шалгах тал дээр стандарт тогтоох хэрэгтэй. Мөн улсын бүртгэгчийг баримт бичгийг хэрхэн шалгах, хуурамч эсэхийг тогтоох талаар сургалтад хамруулах;

11.Хуурамч баримт бичгийг тогтоох техник, тоног төхөөрөмжтэй болох, банкны лавлагааг асууж тодруулах, гарын үсгийг тухайн хуулийн этгээдээс утсаар тодруулж бүртгэлийг хийх.

Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.1, 21 дүгээр зүйлийн 21.1, 23 дугаар зүйлийн 23.1, 25 дугаар зүйлийн 25.1 дэх зүйл заалтуудаар хуулийн этгээдийг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхэд нэмэлт баримт бичиг, мэдээлэл шаардлагатай байхаар тусгасан.

Энэ нь уг хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан “хуулийн этгээдийн бүртгэлийг хялбаршуулах, хуулийн этгээдийг бүртгүүлэхэд бүрдүүлэхэд шаардагдах баримт бичгийг цөөрүүлж, бүртгэлийг хурдан шуурхай болгох” гэсэн зорилтыг хангахад учир дутагдалтай болжээ. Иймээс хууль санаачлагчид дээр дурдсан баримт бичгүүд бүртгэл хийлгэхэд заавал шаардлагатай эсэхийг нягталж, бүртгэлийн үйл ажиллагааг хялбаршуулах үүднээс бүртгэл хийлгэхэд шаардлагатай баримт бичгийн тоог багасгах талаар анхаарах хэрэгтэй.

2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6-д дахь заалтад Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн зарим мэдээллийг нийтэд ил тод байх талаар хуулийн төсөлд тусгасан. Энэ нь хуулийн хэрэглэгч субъектүүд зарим талаар хүлээн зөвшөөрөхгүй байдлыг үүсгэж болзошгүй байдлыг харгалзан хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой ямар төрлийн мэдээллийг Улсын бүртгэлийн байгууллага цахим хуудсаараа нийтэд ил тод болгох талаар судалж, уг хуулийн төсөлд тусгах шаардлагатай.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.4.-т “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал, тодорхойлолт”-д заасан салбарын ангилал, дэд салбараар бүртгэх гэснийг хуулийн төсөлд тодорхой болгон тусгах**;**

2. Хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.2-т “зохих арга зүйг ашиглах” гэж томьёолсныг хуулийн төсөлд ойлгомжтой байдлаар тусгах;

3. Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн агуулгыг хуулийн төслийн үзэл баримтлал, зорилготой нийцүүлэн дахин өөрчлөн найруулах;

4. Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтын “нийтийн зан суртахуунд сөргөөр нөлөөлөх” гэснийг тодорхой болгон төсөлд тусгах, эсхүл энэхүү заалтыг ойлгомжтой болгох үүднээс журамласан хэм хэмжээ тогтоох;

5. Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.2.4 дахь заалтын “гадаадын хөрөнгө оруулагчийн оюуны өмчөөр хөрөнгө оруулалт хийж байгаа бол ямар баримт бичгийг бүрдүүлэх талаар ойлгомжгүй тусгасан байдлыг харгалзан уг заалтыг өөрчлөн найруулах;

6. Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.8 дахь хэсгийг дахин найруулж бичих, мөн уг заалтад тусгагдсан агуулга тус бүрийг ялгаж, энгийн, ойлгомжтой болгох;

7. Хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийг уг хуулийн үзэл баримтлал, зорилготой нийцүүлэн өөрчлөн найруулах;

8. Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.11, 12 дугаар зүйлийн 12.5, 17 дугаар зүйлийн 17.2.1, 24 дүгээр зүйлийн 24.1-т тус тус заасан “эрх бүхий этгээд”, “эрх бүхий байгууллага” гэх зэргээр тусгасныг ойлгомжтой байдлаар төсөлд тусгах;

9. Хуулийн төслийн 24 дүгээр зүйлийн 24.2-т “Хуулийн этгээдийг татан буулгасан тухай нийтэд мэдээлснээс хойш хоёроос зургаан сарын дотор … улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ” гэх агуулгаар өөрчлөх шаардлагатай.

10.Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-т заасан “Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх” гэсэн нийтлэг шаардлагын тухайд:

Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1-т хуулийн этгээдийн 9 төрөл, хэлбэрийг бүртгэнэ гэж заасан нь Төрийн бус байгууллагын тухай хууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан хуулийн этгээдийн төрөл, хэлбэр болох “төрийн бус байгууллага”, “нийтийн эрх зүйн хуулийн этгээд” гэсэн хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг бүртгэхгүй байх мэтээр зөрчилтэй болсон. Энэхүү заалтыг өөрчлөн найруулах;

Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.5-д “хуульд өөрөөр заагаагүй бол улсын бүртгэлийн байгууллага өргөдөл гаргагчаас энэ хуулийн 17.1-3-т заасан бусад баримт бичгийг шаардахгүй” гэж заасан боловч Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 11.5.1-т “улсын бүртгэлд бүртгүүлэх эрхийн үнэн зөвийг нотлох баримт, тайлбар, лавлагааг холбогдох албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдээс гаргуулан авах” гэсэн заалтыг үндэслэн хуулийн төсөлд зааснаас өөр, хуульд заагаагүй баримт бичгийг шаарддаг. Иймд Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 11.5.1 болон хуулийн төслийн 17.5 дахь заалтын уялдаа холбоог сайжруулах, зөрчлийг арилгах;

Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.6-д “Улсын бүртгэлийн байгууллага нууцын тухай хууль тогтоомжид зааснаас бусад улсын бүртгэлийн мэдээллийг өөрийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан нийтэд мэлээлнэ” гэж зааж өгсөн. Гэтэл Байгууллагын нууцын тухай хуулийн 4.2-т “нууцын тухай хуулийн 3.2-т хамаарах нууцыг байгууллага өөрөө тогтооно” гэж заасан байх бөгөөд улсын бүртгэлийн байгууллага хуулийн этгээдийн өөрөө тогтоож нууцад хамааруулсан нууцыг тэр болгон мэдэх боломжгүй. Иймд хуулийн төслийн 9.6 дахь заалт болон Нууцын тухай хуулийн холбогдох зүйл заалтын уялдаа холбоог бий болгох, зөрчлийг арилгах;

11. Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-т заасан “тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх” гэсэн нийтлэг шаардлагын тухайд:

Хуулийн төсөлд Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-т заасан хуулийн этгээдийг хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг үл харгалзан бүх төрөл, хэлбэрийн хуулийн этгээдийг бүртгэх, мэдээлэлд нь өөрчлөлт оруулах, татан буулгасныг бүртгэх, нэрийн баталгаажуулалт олгох, лавлагаа өгөх зэрэг харилцааг зохицуулахаар тусгасан. Тухайн төрлийн харилцааг зохицуулах эрх зүйн зохицуулалт нь зарим талаар дутмаг байгаа байдалд анхаарах;

12. Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-д “зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх” гэсэн нийтлэг шаардлагын тухайд:

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1-т “энэ хуулийн зорилт нь хуулийн этгээд шинээр үүсгэн байгуулсан, өөрчлөн байгуулсан, татан буулгасныг болон түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх, иргэн, хуулийн этгээд болон эрх бүхий байгууллага, албан тушаалтанд лавлагаа олгох, хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино” гэж заасан. Хуулийн төслийн 4.1-т “хуулийн этгээдийн төрөл хэлбэрээс үл хамааран иргэний эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсч, хуульд заасан журмын дагуу татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болохтой холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна” гэж хуулийн үйлчлэх хүрээг багасгаж, явцууруулсан байна. Өөрөөр хэлбэл зөвхөн хуулийн этгээд шинээр бүртгүүлэх болон татан буугдсаныг бүртгэх харилцааг л зохицуулах мэт ойлгогдож байна. Эдгээр заалтуудыг хуулийн төсөлд тусгахдаа хоорондын уялдаатай тусгагдсан эсэхийг анхаарах;

13. Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.7-д “бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг иш татах, энэ тохиолдолд ишлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх” гэсэн нийтлэг шаардлагын тухайд:

Иргэний хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийг ишэлсэн байх боловч хуулийг хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг зааж өгөөгүй. Түүнчлэн Байгууллагын нууцын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хуулийг ишэлсэн байх боловч аль заалтаас ишлэл хийж байгаа нь тодорхойгүй, нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг зааж өгөөгүй байдалд анхаарах;

14. Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.9-д “шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт” гэсэн нийтлэг шаардлагын тухайд:

Хуулийн төслийн 27 дугаар зүйлийн 27.1-т “ ...холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ” гэж тодорхойгүй байдлаар зааж өгснийг тодорхой болгох;

Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дүгээр зүйлийг хасах;

15.Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.10-т “шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх” гэсэн нийтлэг шаардлагын тухайд:

Бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулаагүй байна.

16. Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3-т “үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих” гэсэн нийтлэг шаардлагын тухайд:

Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.1-т “... бичгээр, цахим хэлбэрээр мэдэгдэнэ”, 13.2-т “... мэдэгдлийг бичгээр, цахим хэлбэрээр хүргүүлнэ” гэсэн байх бөгөөд аль аль хэлбэрээр нь мэдэгдэнэ гэж ойлгох эсэх, эсвэл аль нэгээр нь хүргүүлж мэдэгдэхэд хангалттай эсэх ньнайруулгын хувьд ойлгомжгүй болсныг өөрчлөн найруулах.

Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

1. Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.8-д ямар ямар тохиолдолд гэрчилгээ болон тамга тэмдгийн хяналтын дугаар олгох тохиолдлуудыг нэмж тусгах;

2. Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.5 дугаар зүйл болон Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 11.5.1 дүгээр зүйлтэй уялдуулах, аль эсвэл Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн дээрх заалтад өөрчлөлт оруулах;

3. Хуулийн төслийн 9.6 дугаар зүйл болон Байгууллагын нууцын тухай хуулийн 3.2 дугаар зүйлтэй уялдуулан “Байгууллагын нууцын тухай хуулийн 3.2-т зааснаас бусад улсын бүртгэлийн мэдээллийг” гэсэн агуулгыг нэмэх;

4. Хуулийн төслийн 9.4, 14.5, 18.6 дугаар зүйлд заасан журмуудыг “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас боловсруулж” гэсэн агуулгыг нэмж оруулах.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн төслийн үр нөлөөг сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэхдээ дараах эх сурвалжийг ашигласан болно. Үүнд:

1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, 2015 он

2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал. 2017 он

3. “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль”-ийн төслийг боловсруулсан ажлын хэсгийн гишүүдтэй хийсэн ярилцлага. /2017 оны 02 дугаар сарын 9-ны өдөр/

4. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын улсын бүртгэгч нартай хийсэн ярилцлага. /2017 оны 02 дугаар сарын 15-ны өдөр/

5. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраар үйлчлүүлж байсан хуулийн этгээдийн зарим төлөөллүүдтэй хийсэн ярилцлага. /2017 оны 02 дугаар сарын 22-ний өдөр/

6. Д.Болормаа, “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, цаашдын зорилт”, “Оюуны өмч, улсын бүртгэлийн өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага” эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл, УБ: 2017

7. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан. 2017 он

8. “Хуулийн этгээдийн онлайн бүртгэлийн үйлчилгээ”, Жишиг үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх төсөл

9. Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын 2016 оны үйл ажиллагааны тайлан

10. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөний хүрээнд “Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”

11.Бүртгэлийн тогтолцоо: Сайн туршлага/Харьцуулсан судалгаа/, Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2014 он

12. Маягт, индекс, баталгааны тэмдгийн загварыг шинэчлэн батлах тухай, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаал, дугаар 334, 2015 оны 02 дугаар сарын 27

13. Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам, Хууль зүйн сайдын 2015 оны А/39 дүгээр тушаалын хавсралт

14. Гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэх журам, Хууль зүйн сайдын 2015 оны А/40 дугаар тушаалын хавсралт

15. Хуулийн этгээдийн нэр олгох, баталгаажуулах журам, Хууль зүйн сайдын 2015 оны А/41 дүгээр тушаалын хавсралт

16. Иргэн, хуулийн этгээдийн тамга, тэмдэг, баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам, Хууль зүйн сайдын 2015 оны А/42 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

17. Журам батлах тухай, дугаар 335, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2015 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн тушаал

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

18. Хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбогдон үүссэн маргаантай асуудлуудын нэгдсэн танилцуулга, судалгаа, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газар, 2016 он

19. Хууль тогтоомжийн тухай хууль, аргачлал, гарын авлага, Хууль зүй, дотоод хэргийн яам, 2016 он

20. Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал" Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт

21. Хуулийн этгээдийн бүртгэлийн газар. (Сүүлд үзсэн: 2017.03.06) http://www.burtgel.gov.mn/index.php/about/departments-item/262-2015-12-09-11-47-3917

22. "Хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурлаа." (сүүлд үзсэн 2017.03.07) http://www.burtgel.gov.mn/index.php/component/content/article?id=1044:2015-12-21-07-55-17

23. "Улсын бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах Цахим архив төсөл хэрэгжиж эхэллээ." (сүүлд үзсэн 2017.03.07) http://www.burtgel.gov.mn/index.php/476-2015-12-10-08-41-54

24.http://les.burtgel.gov.mn/ubeg/citizen/article (сүүлд үзсэн 2017.03.07)

25.Монгол Улсын Их Хурлын 2014 оны намрын ээлжит чуулганы 2015 оны 1 сарын 29-ний өдрийн хуралдааны тэмдэглэл

---oOo---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ САН ЭЛ
www.nli.gov.mn

“ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ”-Д ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦОО[1]

УДИРТГАЛ

УИХ-аас 2015 онд баталж, 2017 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж буй “Хууль тогтоомжийн тухай хууль” болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-ыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог урьдчилсан байдлаар хийлээ.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хуулийн төслийн үр нөлөөг урьдчилан тандан судлах явцад, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх явцад болон хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг тандан судлах явцад тус тус гүйцэтгэнэ. Энэ нь тодорхой харилцааг зохицуулах зорилгоор шинээр боловсруулж буй хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээр төрийн байгууллага, хуулийн этгээд болон хувь хүнд хэр хэмжээний зардал, ачаалал үүсгэх магадлалыг урьдчилан гаргах зорилготой.

“Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл” дэх зохицуулалтууд нь иргэнд зардал үүсгэхгүй, харин төрийн байгууллага болон хуулийн этгээдэд зардал үүсгэж байна. Иймд хуулийн төслийн зардлыг урьдчилан тооцохдоо түүнийг хэрэгжүүлэх төрийн байгууллага болон хуулийн этгээдэд үүсэх зардлыг тоймлон гаргах, мөн эдгээр байгууллагад үүсэх зардал, ачааллыг бууруулах боломжтой эсэхийг судлан, боломжит хувилбарыг дэвшүүлэхийг зорьсон. Мөн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон шинэчилсэн найруулгын төсөлд өмнө нь зардлыг тооцоо хийгдэж байгаагүй тул энэ удаа хуулийн төсөл дэх зардал үүсгэх боломжтой зүйл, заалтыг бүхэлд нь авч үзэн зардлыг тус тус тооцсон болно.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Хуулийн этгээдийн бүртгэлийн байгууллага буюу төрд үүсэх зардал

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газар нь улсын хэмжээнд нийслэл хот болон орон нутагт хуулийн этгээдийн бүртгэлтэй холбогдох үйл ажиллагаа явуулдаг ба албан хаагчид нь төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээний ТЗ-6 зэрэглэлээр цалинждаг[2]. Нийслэл дэх бүртгэлийн газар 2 ахлах улсын бүртгэгч, 17 улсын бүртгэгчтэй бол орон нутагт 21 улсын бүртгэгч ажилладаг байна.

2016 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд 170 мянга орчим хуулийн этгээд бүртгэлтэй байгаагаас нийслэлд бүртгэлтэй 132704, орон нутагт бүртгэлтэй 36958 хуулийн этгээд байна[3]. Энэ нь улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт хуулийн этгээдийн 73% нь нийслэлд, 27% нь орон нутагт бүртгэлтэй байна.

[1] Тус судалгааг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Зүмбэрэллхам удирдан эрдэм шинжилгээний ажилтан Ж.Бариаширсүрэн,Б.Алтангэрэл, “Хууль, эрх зүйн хөгжлийн хүрээлэн”-ийн судлаач Б.Доржпагма нар хамтран гүйцэтгэв.

[2] Хуулийн этгээдийн бүртгэл газрын улсын бүртгэгчийн цалингийн зэрэглэлийн болох ТЗ-6-ийн дундаж хэмжээг жишиг болгон ашигласан болно. ХЭБГ-ийн дарга ТЗ-10, ахлах улсын бүртгэгч ТЗ-7 зэрэглэлээр цалинждаг.

[3] Оюуны өмч, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас 2017 оны 1 сарын 20-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгаланд хүргүүлсэн 1-4/173 тоот “Мэдээлэл хүргүүлэх тухай” албан тоотын хавсралтаас.

Хуулийн төслөөс харахад ХЭБГ-ын улсын бүртгэгчид хуулийн этгээдийг шинээр бүртгэх, хуулийн этгээдийн хувийн хэргийг хөтлөх, хуулийн этгээдэд нэр, тамга, тэмдэг, баталгааны тэмдгийн хяналтын дугаарыг олгох, хүчингүй болгох, лавлагаа олгох, хуулийн этгээдийн нэрийн сан хөтлөх, түүнээс лавлагаа олгох, хуулийн этгээдийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулах, хуулийн этгээдийн улсын бүртгэлээс хасах, цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлэх зэрэг хэд хэдэн үүргийг хүлээлгэсэн байна. Дээрх үүргийн хүрээнд нэг жилд дунджаар шинээр байгуулагдсан **15463.5** хуулийн этгээдийг бүртгэж**, 2460** хуулийн этгээдийг бүртгэхээс татгалзсан шийдвэр гаргаж, **18854.5** хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэж, **187280** Хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт хийдэг байна.

Дээр дурдсан тоо мэдээлэлд үндэслэн нэг улсын бүртгэгчийн ажлын ачааллыг баримжаалахад дараах тоо, хэмжээ гарч байна. Байгууллагын дотоод зохион байгуулалтын дагуу нэг улсын бүртгэгч хүснэгт дэх 4 төрлийн ажил үйлчилгээг зэрэг хийдэггүй, тодорхой нэг асуудлыг дагнах, зарим ажил үйлчилгээтэй хавсарсан байдлаар гүйцэтгэдэг.

Ажил үйлчилгээний төрөл	Нийслэл	Орон нутаг
Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийг бүртгэх	663	198
Хуулийн этгээдийг бүртгэхээс татгалзсан шийдвэр гаргах	105	31
Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэх	809	42
Хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт хийх	8042	2407
Нийт	**9619**	**2678**

Хүснэгтээс харахад нийслэл дэх нэг улсын бүртгэгч нэг жилд дунджаар **9619** ажил үйлчилгээ үзүүлдэг бол орон нутаг дахь нэг улсын бүртгэгч нэг жилд дунджаар **2678** ажил үйлчилгээ үзүүлж байгаа нь тэдний ажлын ачаалал тэнцвэргүй байгааг харуулж байна.

Бүртгэлийн байгууллагын ажлын ачааллыг нэмэгдүүлж буй бас нэг хүчин зүйл бол сүүлийн жилүүдэд ХЭ шинээр байгуулах, ХЭ-ийн мэдээлэлд өөрчлөлт оруулах болон бусад үүнтэй холбоотой ХЭ-ээс гаргаж буй хүсэлтийн хэмжээ эрс нэмэгдсэнтэй холбоотой. Тухайлбал, ХЭБГ-аас гаргасан статистик мэдээнээс харахад тус байгууллага 2008 онд 3192 ХЭ шинээр бүртгэж, 5390 ХЭ-ийн мэдээлэлд өөрчлөлт оруулж, 8838 ХЭ-д нэр олгож байсан бол 2016 онд 14000 ХЭ шинээр бүртгэж, 17287 ХЭ-ийн мэдээлэлд өөрчлөлт оруулж, 32118 ХЭ-д нэр олгосон байна. Энэ нөхцөл байдал улсын бүргэгчийн ажлын ачааллыг даруй 3,5-4 дахин нэмэгдсэн үзүүлэлт гарч байна.

Дээр дурдсан мэдээллүүдээс харахад ХЭБГ-ын улсын бүртгэгчийн ажлын ачаалал өндөр байгаа нь ажил үйлчилгээний чанар, хүртээмжид сөргөөр нөлөөлөхөөс гадна, хуулийн төслийн үндсэн зорилгын нэг болох иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх төрийн үйлчилгээг түргэн, шуурхай, чирэгдэлгүй болгоход шаардлагатай хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ байгааг харуулж байна. Энэ дүгнэлтийг “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-д хийсэн зардлын тооцооны үр дүнд тус хуулийн төслийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд урьдчилсан байдлаар нэг жилд дунджаар **53,2 хүний нөөцийн** хэрэгцээ үүсэх магадлалтай байна гэх тооцоо гарсан нь үндэслэж байна. Иймд хүний нөөцийн хэрэгцээг ажлын ачаалалтай уялдуулан нэмэх шаардлага байна гэж үзлээ.

2013-2016 оны статистик, тоо мэдээллээс харахад хуулийн этгээдийн мэдээллийн сан хөтлөх ажлын хүрээнд жилд дунджаар 15463.5 хуулийн этгээдийн

хувийн хэрэг шинээр үүсгэдэг бөгөөд 2016 оны жилийн эцсийн байдлаар нийт **170 мянга орчим** хуулийн этгээдийн хувийн хэрэг бүхий мэдээллийн санг хөтөлж, түүнээс мэдээлэл, лавлагаа олгодог. Хуулийн этгээдийн мэдээллийн санд жил бүр шинээр нэмэгдэж байгаа мэдээллийн хэмжээ улам өсөх хандлага байна. Иймд хуулиар хүлээсэн үүргээ /татвар, санхүүгийн тайлан гаргах/ удаан хугацаагаар биелүүлээгүй, идэвхитэй үйл ажиллагаа эрхлээгүй хуулийн этгээдийг тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу бүртгэлийн мэдээллийн сангаас хасах, мөн хуулийн этгээдийн гэрчилгээг дахин олгох тохиолдолд хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэдэг зохицуулалт бий болгосноор бүртгэлийн байгууллагын ачаалал, зардалд тодорхой хэмжээний хэмнэлт үүсэх боломжтой нь судалгааны явцад илэрч байлаа.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбогдох үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжээгүй. Иймд зардлын тооцоо хийхдээ энэ төрлийн ажил үйлчилгээг гүйцэтгэх хугацааг тодорхойлох боломжгүй байлаа. Гэхдээ ХЭ-ийн бүртгэлийг цахим болон цаасан хэлбэрээр зэрэг хөтлөх хуулийн зохицуулалт хэрэгжиж эхэлснээр улсын бүртгэгчийн зүгээс үзүүлж буй ажил үйлчилгээнд шаардагдах цаг хугацаа нэмэгдэх үндэслэлтэйг анхаарах шаардлагатай.

Одоогийн байдлаар нэрийн баталгаажуулалт, хуулийн этгээдийн бүртгэл, лавлагаа өгөх ажлыг цахим хэлбэрт шилжүүлэх ажил хийгдэж байгаа боловч эдгээр програм хангамж нь бүрэн цахимжаагүй, зөвхөн “сайжруулсан емэйл” хэлбэрээр ажилладаг. Тухайлбал цахимаар ирүүлсэн нэрийн баталгаажуулалтын хүсэлтийг улсын бүртгэгч хянаж үзээд тухайн нэрийг баталгаажуулж болох, эс болох талаар хариу өгдөг, мөн хуулийн этгээдийн цахим бүртгэлийн “LES” програмын ойлгомжгүй байдал, иргэд хуулийн этгээдийн цахим бүртгэлийн талаар мэдээлэлгүй, нэгэнт цахим хэлбэрээр илгээсэн баримт бичгийг эх хувиар нь заавал өгөх шаардлагатай зэрэг асуудлууд нь цахим хэлбэрийг сонгохоос цааргалах гол шалтгаан болж байна. Үүнийг тод харуулах жишээ бол “*ХЭБГ 2015.03.01-ээс http://les.burtgel.gov.mn/ubeg/citizen/services/ цахим хуудсаар дамжуулан шинээр байгуулагдсан хуулийн этгээдийг цахим хэлбэрээр бүртгэх үйл ажиллагааг эхлүүлсэн. Тус цахим хуудаст 2015 оны сүүлийн хагас жилд шинээр бүртгүүлэх 113 хүсэлт ирснээс 25.7% буюу 29 хүсэлт зөвшөөрөгдөж, 69.9% буюу 79 хүсэлт цуцлагдсан бол 2016 оны байдлаар нийт 146 хүсэлт ирснээс 17.1% буюу 25 хүсэлт зөвшөөрөгдөж, 65.8% буюу 96 хүсэлт цуцлагдсан. Мөн 2017 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 03 дугаар сарын 09-ны өдрийн байдлаар тус цахим хуудаст нийт 36 хүсэлт ирснээс 2.8% буюу 1 хүсэлт зөвшөөрөгдсөнөөр цахим бүртгэл дийлэнх тохиолдолд цуцлагдсан үзүүлэлттэй байна.*[4] *Мөн тухайн онд Улсын бүртгэлд шинээр бүртгүүлсэн нийт хуулийн этгээдийн дүнтэй харьцуулвал 2015 онд 0.2%, 2016 онд 0.2% нь цахим хэлбэрээр бүртгэл хийлгэжээ*.” гэх мэдээллээс харж болох юм. Иймд хуулийн этгээдийг бүртгэл хийх, бүртгүүлэх боломжийг бүрэн шийдсэн програм хангамжийг шинээр болон шинэчлэн боловсруулах шаардлагатай.

Харин 2005 оноос хөтөлж эхэлсэн хуулийн этгээдийн бүртгэлтэй холбогдох 3,2 сая баримт материалыг 2014 онд БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /КОЙКА/-ын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлсэн “Бүртгэл мэдээллийн цахим архив” төслийн хүрээнд цахимжсан байна. Одоо 2014 оноос хойш шинээр бүртгүүлсэн болон нэмэлт өөрчлөлт оруулсан 1,7 сая баримт цахимжаагүй хүлээгдэж байна. Иймд дээр дурдсан төслийн хүрээнд цаасан нотлох эх баримтыг цахимжуулах ажлын ихэнх хэсэг хийгдсэн. Гэвч эдгээр цахим мэдээллийг удирдах

[4] Хүсэлт цуцлагдсан үндсэн шалтгаан нь баримт бичгийн бүрдэл дутуу байх явдал байна. Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын мэргэжилтэнтэй хийсэн ярилцлага.

буюу хэрэглээнд нэвтрүүлэх, онлайн байршуулах гэсэн дараагийн 2 үе шат хүлээгдэж байна.

Тус байгууллага хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг онлайн горимд шилжүүлж, иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээг ил тод, нээлттэй, шуурхай, хүртээмжтэй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулахаар төлөвлөсөн байх бөгөөд 2020 он гэхэд хуулийн этгээдийн бүртгэлийг цахимжуулах ажлыг бүхэлд нь 2 тэрбум төгрөгөөр[5] хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Хуулийн этгээдийн бүртгэл, түүнд холбогдох материалуудыг цахим горимд шилжүүлэхэд их урт хугацаа шаардлагагүй, ойролцоогоор 3 – 4 сарын хугацаанд гүйцэтгэх боломжтой гэх тооцоо гаргасан байна.[6] Учир нь энэ төрлийн мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх туршлага, ажлын даалгавар гээд бүх зүйл тодорхой, хийх мэргэжилтэн, хэрэглэх материал гээд суурь нь бэлэн байгаа юм. Энд зөвхөн санхүүжилтийн асуудал тулгарч байна.

Судалгаагаар “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл” –ийн 8, 9, 10, 12, 14, 17, 18, 22, 24, 26 дугаар зүйл, заалт дахь зохицуулалтын дагуу төрийн байгууллага буюу төрд хүлээлгэсэн үүргийг /ажил үйлчилгээг/ хэрэгжүүлэхэд нийт **832,313,425.6 төгрөгийн зардал** үүсэх урьдчилсан тооцоо гарсан бөгөөд үүнийг дэлгэрэнгүй байдлаар судалгааны ажлын “Төрийн захиргааны байгууллагын захиргааны зардлыг стандарт зардлын загвараар тооцоолох” хэсгээс үзнэ үү.

ХЭБГ-аас хуулийн этгээдийн бүртгэл, лавлагаатай холбоотой үзүүлж буй ажил үйлчилгээ нь төлбөртэй, тодорхой хэмжээний улсын тэмдэгтийн хураамж төлсөн байх шаардлага тавигддаг. Иймд тус байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах, сайжруулах, хэвийн ажиллуулахад шаардагдах төсөв, санхүүжилт улсын төсөвт их хэмжээний ачаалал үүсгэхээргүй байна. Тухайлбал ХЭБГ-аас улсын тэмдэгтийн хураамжаар улсын төсөвт 2015 онд 991,155.0 сая төгрөг, 2016 онд 782,348.4 сая төгрөгийн орлого оруулсан байх бөгөөд үүнээс 2015 онд 224,882 сая төгрөгийг, 2016 онд 139,768.9 сая төгрөгийг албан хаагчдын цалин хангамж, бичиг хэргийн зардалд зарцуулсан үзүүлэлт байна[7]. Үүнээс харахад улсын төсөвт оруулсан орлогын хэмжээ сүүлийн 2 жилийн байдлаар нэг жилд дунджаар 704,426.1 сая төгрөг байгаа нь тус байгууллагад оруулах хөрөнгө оруулалтууд улсын төсөвт их хэмжээний дарамт үүсгэхгүй гэх дүгнэлтийг бататгаж байна.

Ерөнхийдөө хуулийн төсөлд тусгагдсан хуулийн этгээдийн цахим бүртгэлийн тогтолцоог бүрдүүлэх нийгэм, эдийн засгийн хэрэгцээ шаардлага нэгэнт үүссэн байна. Цахим бүртгэлийн тогтолцоонд шилжихэд ОӨУБЕГ –ын ХЭБГ нь хүний нөөцийн ур чадвар, цахим сан бүрдүүлэх баримт мэдээллээр хангагдсан байгаа нь цахим бүртгэлийг шуурхай нэвтрүүлэхэд давуу тал болж байна. Иймд цахим бүртгэлийг хэрэгжүүлэхэд шаардлагатай програм хангамж, тоног төхөөрөмжийн санхүүжилтийг шийдвэрлэснээр хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт заасан цаасан болон цахим хэлбэрээр бүрдүүлэх, бүртгэлийн цахим сан хөтлөх, лавлагаа, мэдээлэл олгох зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх бүрэн боломжтой.

Харин төрөөс шаардлагатай санхүүжилт хийгдээгүй тохиолдолд буюу одоо хэрэглэж буй програм хангамж, тоног төхөөрөмжийн нөөцөөр хуулийн төсөлд тусгагдсан цахим бүртгэл, мэдээлэл олгох үйл ажиллагаа хэрэгжих боломжгүй гэж дүгнэв.

---

[5] Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөний хүрээнд Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас хэрэгжүүлэх төлөвлөгөө Зорилт 4-ийн 9 дэх арга хэмжээ.

[6] ОӨУБЕГ-ын дэд дарга Д.Дэлгэрсайхантай хийсэн ярилцлагаас.

[7] ХЭБГ-аас авсан мэдээлэл.

Иймд “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга”-д тусгасан цахим хэлбэрээр хөтлөх, бүртгэх, мэдээлэл оруулах, лавлагаа мэдээлэл олгох ажил үйлчилгээг хэрэгжүүлэх үүргийг ХЭБГ-т хуулиар хүлээлгэхээс өмнө түүнийг хэрэгжүүлэх суурь болсон програм хангамж, тоног төхөөрөмжийн санхүүжилтийн асуудлыг нэгмөр шийдвэрлэх шаардлагатай байна.

Хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардал

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-ийн 15, 20, 23, 24 дүгээр зүйл дэх зохицуулалтууд хуулийн этгээдэд мэдээлэх үүрэг хүлээлгэсэн байна. Үүний дагуу хуулийн этгээд нь шинээр үүсгэн байгуулагдсан, эсхүл өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан тохиолдолд шинээр бүртгүүлэх, Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэх, татан буугдсан, өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан тохиолдолд хуулийн этгээдийн бүртгэлээс хасуулах үүрэг хүлээнэ.

Хуулийн этгээдэд хүлээлгэсэн эдгээр мэдээлэх үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан үүсэх захиргааны зардлын тооцоог дэлгэрэнгүй байдлаар судалгааны ажлын “Хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардлыг стандарт зардлын загвараар тооцох нь” хэсгээс үзэж танилцна уу.

Хуулийн этгээдэд үүсэх зардлыг тооцохдоо хуулийн этгээдийн зүгээс тухайн үүргийг хэрэгжүүлэх хүрээнд хийх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг[8] тодорхойлж, тэдгээрийн тус бүрт зарцуулах хугацаа болон ажлын хөлсийг тогтооно. Хуулийн этгээдэд үүсэх зардлын хэмжээг зөвхөн мөнгөн дүнгээр урьдчилан тооцож гаргасан.

Хуулийн этгээдийн нэг ажилтны цалинг аж ахуй нэгж байгууллагад ажиллагчдын сарын дундаж цалин сүүлийн гурван жилийн /2014-2016 он/ дундаж цалингийн хэмжээ болох 865,600 төгрөгөөр, ажлын 1 минутын хөлсийг 82 төгрөг байхаар тооцсон бөгөөд хуулийн этгээдийн мэдээлэх үүрэг тус бүрээр нь зардлын тооцоог задлан боловсруулласа. Мэдээлэх үүрэг хүлээлгэсэн үйл ажиллагаа тус бүрийн тохиолдлын тоог ХЭБГ-аас гаргасан, 2013-2016 оны статистик, тоо мэдээний дундаж хэмжээгээр тооцолсон болно. Үүнээс харахад

- Хуулийн этгээдийг шинээр бүртгүүлэх тохиолдлын тоог хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн хуулийн этгээдийн тоогоор буюу 15463 байхаар тооцож, энэ үүргийг хэрэгжүүлэхэд нэг жилд дунджаар 238709872 төгрөгийн зардал үүсгэх урьдчилсан тооцоо гаргасан бөгөөд энэ ажиллагааг хялбарчлах, гарах зардлаас хэмнэх боломжгүй,
- Нэг жилд дунджаар өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан 150 хуулийн этгээдийг **бүртгүүлэхэд** 1955700 төгрөгийн зардал үүсгэх урьдчилсан тооцоо гаргасан бөгөөд энэ ажиллагааг хялбарчлах, гарах зардлаас хэмнэх боломжгүй,
- **Нэг жилд дунджаар** 18854 тохиолдолд х**уулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэхэд үүсэх захиргааны зардлын хэмжээг** 408151392 төгрөг байх урьдчилсан тооцоог гаргасан бөгөөд энэ ажиллагааг хялбарчлах, гарах зардлаас хэмнэх тухайд Хуулийн төслийн 23.1.8, 23.1.9 хэсэгт заасан мэдээллээс тухайн хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтөөс шалтгаалан баримт бичгийн аль нэгийг бүрдүүлэх боломж олгосноор хэмнэх боломжтой, мөн хуулийн төслийн 23.1.3 дахь хэсэгт өөрчлөлт оруулах шийдвэр,

[8] Үүрэг тус бүрийн гүйцэтгэхэд зайлшгүй хийгдэх үйлдлийг стандарт үйл ажиллагаа гэнэ. Хуулийн этгээдийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн хугацааг тооцох загварыг ЗГ-ын 2006 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтын Хүснэгт 1-ээс үзэх боломжтой.

23.1.4 дэх хэсэгт үүсгэн байгуулагч, эрх бүхий байгууллагын шийдвэр /тогтоол/ гэж оруулж өгсөн нь мэдээллийн агуулга давхацсан утгыг илэрхийлж байна;

- **Нэг жилд дунджаар** 2164 х**уулийн этгээдийг татан буулгасан тухай улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэх үүрэг үүсдэг бөгөөд үүнтэй холбоотой хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардлын хэмжээ** 408151392 төгрөг байх урьдчилсан тооцоо гаргасан бөгөөд энэ ажиллагааг хялбарчлах, гарах зардлаас хэмнэх боломжгүй гэх саналыг тус тус гаргасан байна.

Эцэст нь дүгнэхэд “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-ийг хэрэгжүүлэхэд хуулийн этгээд үүсэх зардлын хэмжээнд их хэмжээний өөрчлөлт ороогүй, ойролцоогоор 100000 төгрөг байгаа бол харин гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн хувьд үүсэх зардлын хэмжээ нэмэгдэж байна. Мөн хуулийн этгээдийн бүртгэлийг цахим болон цаасан хэлбэрээр давхар бүртгэх буюу цахимаар илгээсэн эх нотлох баримтыг цаасан хэлбэрээр нь өгөх шаардлага тавьж байгаа нь хуулийн этгээдэд нэмэлт ачаалал үүсгэж байна.

Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт үүсэх зардлын дийлэнхийг хуулийн этгээдийн бүртгэлийг цахим хэлбэрт давхар шилжүүлэхтэй холбоотой програм хангамж, техник, тоног төхөөрөмжтэй холбоотой үүсэх зардал эзэлж байгаа бол бүртгэлийн газрын улсын бүртгэгчийн ажлын ачааллыг бууруулах үүднээс хүний нөөцийг нэмэгдүүлэхтэй холбоотой тодорхой зардал үүсэх магадлалтай. Иймд хуулийн төслийг хэрэгжүүлэхийн тулд юуны өмнө хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим тогтолцоог /програм хангамж, техник, тоног төхөөрөмж/ бий болгох шаардлагатай байгаа тул хуулийн төслийг батлах тохиолдолд цахим горимд шилжүүлэхтэй холбоотой судалгаанд дурдсан санхүүжилт болон техникийн нөхцөлийг хангахтай холбоотой үүсэх зардлыг төр хүлээх юм.

НЭГ. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫГ СТАНДАРТ ЗАРДЛЫН ЗАГВАРААР ТООЦОХ НЬ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх хэсэгт заасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу алхам тус бүрийн хүрээнд мэдээлэл цуглуулан, стандарт үйл ажиллагааны жагсаалтад үндэслэн дараах тооцооллыг хийлээ.

Зардлын тооцоог дараах алхмын хүрээнд хийнэ. Үүнд:

1. Хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох
2. Зардал тооцох
3. Тоон үзүүлэлтийг тооцох
4. Зардлын дүнг тооцож гаргах
5. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах
6. Нэмэлт зардал тооцох

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.legal.gov.mn

1.1.Хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн дараах зохицуулалт байна.

Хүснэгт 1. Хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн заалт

Хуулийн төсөл дэх холбогдох зохицуулалт	Үүрэг
15 дугаар зүйл. Шинээр байгуулсан хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл гаргана.	15.1.Өргөдөл гаргагч шинээр байгуулсан хуулийн этгээдийг бүртгүүлэх өргөдлийг улсын бүртгэлийн байгууллагад гаргана.
20.1.Хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээд нь энэ хуулийн 13.3, 15.1, 16.1-д заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл гаргана.	20 дугаар зүйл. Өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээдийг бүртгүүлэх өргөдөл гаргах
11.3.Энэ хуулийн 11.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулсан бол тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор энэ талаар улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэх ба эрх бүхий төрийн байгууллагаас зөвшөөрөл авдаг өөрчлөлтийн хувьд тухайн байгууллагын зөвшөөрөл олгосон шийдвэр гарсан өдрөөс хойш энэхүү хугацааг тооцно.	23 дугаар зүйл. Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэх
24 дүгээр зүйл.Хуулийн этгээдийг татан буулгасан тухай улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэх	24.1.Хуулийн этгээдийг татан буулгах тухай шийдвэр гаргасан эрх бүхий этгээд ажлын гурван өдрийн дотор холбогдох улсын бүртгэлийн байгууллагад бичгээр мэдэгдэж, татан буулгах тухай шийдвэрийн эх хувийг мэдэгдэлд хавсаргана.
	24.2.Иргэний хуулийн 32.3-т заасны дагуу татан буулгах комисс тухайн хуулийн этгээдийг татан буулгасан тухай нийтэд мэдээлснээс хойш хоёроос зургаан сарын дараа уг хуулийн этгээдийг татан буулгаж дууссан тухай холбогдох улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ.

Дээрх заалтуудад тусгагдсан үүргүүд нь мэдээллийн хэд хэдэн агуулгатай байж болно. Өөрөөр хэлбэл хууль тогтоомжид заасан, тухайн үүргийг гүйцэтгэхэд бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт түүнчлэн үүрэг, үүргийн агуулга хоорондоо нягт уялдаатай байх шаардлагатай. Тухайлбал хуулийн 20 дугаар зүйлд заасан “Өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээдийг бүртгүүлэх өргөдөл гаргах” үүрэг нь хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт, баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл, үүсгэн байгуулсан баримт бичиг, улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, өөрчлөн байгуулагдах үеийн санхүүгийн тайлан тэнцэл зэрэг хэд хэдэн агуулгыг багтааж байна.

1.2 Зардлыг тооцох

Энэ хэсэгт хуулийн төсөлд тусгасан үүргийг хэрэгжүүлснээр хуулийн этгээдэд үүсэх зардлын хэмжээг мөнгөн дүнгээр урьдчилан тооцож гаргана. Хуулийн этгээдийн зүгээс үүргийг хэрэгжүүлэх хүрээнд хийх үйлдэл буюу стандарт үйл ажиллагаа[9] тодорхойлж, тус бүрт зарцуулах хугацаа болон ажлын хөлсийг тогтоох шаардлагатай.

[9] Үүрэг тус бүрийн гүйцэтгэхэд зайлшгүй хийгдэх үйлдлийг стандарт үйл ажиллагаа гэнэ. Хуулийн этгээдийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн хугацааг тооцох загварыг ЗГ-ын 2006 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтын Хүснэгт 1-ээс үзэх боломжтой.

Зардлыг тооцохдоо дараах хүчин зүйлийг тооцов. Үүнд:

1.Үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлох;

2.Тухайн үйлдэлд зарцуулагдах хугацааг тогтоох;

3.Тухайн үйлдлийг хийх ажилтны ажлын хөлсийг тодорхойлох.

Хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардлыг тооцохдоо стандарт үйл ажиллагааны жагсаалтад үндэслэнэ. Мөн тус жагсаалтад багтахгүй үйл ажиллагаанд жагсаалт гаргаж, ажиглалт хийх, ярилцлага хийх зэрэг судалгааны арга ашиглан тухайн үүргийг гүйцэтгэх хугацааг тодорхойлно. Цаг хугацааг тооцохдоо зарцуулах хугацааг минутаар тооцож гаргана.

Ажлын хөлсийг тооцох

Ажлын хөлсийг тогтоохдоо аж ахуйн нэгжид ажиллаж буй нэг ажилтны сарын дундаж цалин хөлсийг баримжаалан тооцох бөгөөд зарим тохиолдолд тусгай мэдлэг, мэргэжил, ур чадвар шаардсан үйл ажиллагаанд өндөр цалин, хангамж олгож буй тохиолдлыг анхаарч авч үздэг. Мөн нэг сард ажиллах хугацааг тооцож гарган үндсэн цалинг ажиллах хугацаанд хуваасаар тухайн ажилтанд ногдох ажлын хөлсийг тооцож гаргана.

Хүснэгт 2. Аж ахуйн нэгж байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин[10]

Он	2014 онд	2015 онд	2016 онд	Дундаж дүн
Улсын дундаж цалин	844,000	868,500	884,300	**865,600**

Аж ахуй нэгж байгууллагад ажиллагчдын сарын дундаж цалин сүүлийн гурван жилийн хугацаанд тогтмол өссөн үзүүлэлтэй байна. Сүүлийн гурван жилийн дундаж цалинд үндэслэн ажилтны нэг сарын ажлын хөлсийг **856,000** төгрөг байхаар, ажиллах хугацааг хөдөлмөрийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомжид заасан ажлын хоног, ажиллах цагт үндэслэлээ.

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 70 дугаар зүйлд ердийн нөхцөлд ажлын цагийг 7 хоногт 40 цагаас, нэг өдрийн ажлын цаг 8 цагаас илүүгүй байхаар зохицуулсан байдаг. Үүнээс харахад нэг ажилтан нэг сард ажлын 22 өдөр /22*8=176 цаг, 176*60=10560 минут/ ажилладаг байна.

Хүснэгт 3. Аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхэлж буй ажилтны ажлын хөлсийг цаг, минутаар

Үндсэн цалин	/	Ажиллах хугацаа	=	Ажлын хөлс /төгрөг/
865,600	/	176 цаг	=	4,918 төг /цагт/
865,600	/	10560 минут	=	**82**[11] төг /минут/

1.2.1 Шинээр үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийг бүртгүүлэхэд гарах захиргааны зардал

Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийг бүртгүүлэхэд “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-ийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасны дагуу өргөдөл гаргах үүрэг хүлээлгэсэн байх бөгөөд энэ нь 17.1, 17.2, 17.3 дахь хэсэгт заасан мэдээллийг тусгасан байх шаардлага тавьж байна.

[10] http://1212.mn/statHtml/statHtml.do -сүүлд нэвтэрсэн 2017 оны 03 дугаар сарын 02-ны өдөр. Аж ахуй нэгж байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин, өмчийн хэлбэр, хүйс, улирал, жилээр.

[11] Аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхэлж буй ажилтны 1 цагийн хөлс 81,96 төгрөг байгаа бөгөөд энэ тохиолдолд 82 төгрөг болгон тэгшитгэсэн болно.

Хүснэгт 4. Зардал. Хугацаа х Ажлын хөлс =
Үйл ажиллагаа тус бүрийн зардал

Үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа (мин)	Ажлын хөлс (төг)	Зардал (төг)
Шинээр бүртгүүлэх өргөдөл гаргах	Хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт /17.1.1/	Нэр баталгаажуулах	5	82	410
	Баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл /17.1.2/	Өргөдөл бичих	7	82	574
	Үүсгэн байгуулах баримт бичиг /17.1.3/	Дотоод хуралдаан	30	82	2460
	Шаардлагатай тохиолдолд итгэмжлэл /17.1.4/	Итгэмжлэл гаргах	20	82	1640
		Нотариатаар баталгаажуулах	20	82	1640
	Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт /17.1.5/	Мөнгө шилжүүлэх	8	82	656
	Хувь нийлүүлсэн хөрөнгө болохыг нотолсон банкинд харилцах данс нээлгэсэн баримт /17.1.5/	Данс нээлгэх	30	82	2460
		Банкны тодорхойлолт гаргуулах[12]	5	82	410
		Мэдээллийн өгөгдөхүүнийг нягтлах	5	82	410
	Үүсгэн байгуулагч, гүйцэтгэх удирдлагын цахим үнэмлэхийн хуулбар /17.1.6/	Олшруулах, архивлах, тараах	5	82	1,230
	хуулийн этгээдийн хаягийн нотлох баримт /17.1.7/	Хаягын тодорхойлолт авах/ түрээсийн гэрээг хуулбарлах	5	82	410
Шинээр бүртгүүлэх өргөдөл гаргах / ГХОААН/	ГХ оруулахыг зөвшөөрсөн эрх бүхий байгууллагын шийдвэр /17.2.1/	Олшруулах, архивлах, тараах	5	82	410
	2 буюу түүнээс дээш этгээд хамтран байгуулж байгаа бол хувьцаа эзэмшигчдийн хооронд байгуулсан гэрээ /17.2.2/	Гэрээний төсөл гаргуулах	100	82	8200
		Нотариатаар баталгаажуулах	20	82	820
	Хөрөнгө оруулагч нь гадаадын иргэн бол биеийн байцаалт, хуулийн этгээд бол гадаадын хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээний хуулбар /17.2.3/	Олшруулах, архивлах, тараах	5	82	410
	Гадаадын хөрөнгө оруулагчтай бол гадаад улсаас мөнгөн хөрөнгө шилжүүлснийг нотолсон банкны тодорхойлолт, дансны хуулга, гаалийн байгууллагын мэдүүлэг, эрх бүхий байгууллагаас олгосон гэрчлэх баримт бичиг /17.2.4/	Банкны тодорхойлолт гаргуулах	20	82	1640
		Дансны хуулга авах	10	82	820
		Гаалийн байгууллагын мэдүүлэг авах	15	82	1230
		Олшруулах, архивлах, тараах	5	82	410

[12] Стандарт үйл ажиллагааны жагсаалтад үндэслэв. Эрх бүхий байгууллагаас нэмэлт лавлагаа шаардвал гаргаж өгөх.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Шинээр бүртгүүлэх өргөдөл гаргах / ГХОХХ-тай нөхөрлөл/	нөхөрлөлийн гишүүн тус бүрд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон бүртгэлийн гэрчилгээ /17.3.1/	Олшруулах, архивлах, тараах	5	82	410
	Гадаад улс дахь хуулийн этгээдийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах бол тухайн байгууллагын зөвшөөрөл болон өргөдөл гаргагч нь тус байгуул- лагын гишүүн бөгөөд эрх олгосон болохыг нотолсон тодорхойлолт /17.3.2/	Зөвшөөрөл гаргуулах	15	82	1230
		Тодорхойлолт гаргуулах	15	82	1230
	энэ хуулийн 17.3-т заасан хуулийн этгээд нь тухайн улсдаа хууль тогтоомжийн хүрээнд байгуулагдан үйл ажиллагаа явуулдаг тухай эрх бүхий байгууллагын тодорхойлолт, эсхүл[13] хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээний хуулбар /17.3.3/	Тодорхойлолт гаргуулах	15	82	1230
		Олшруулах, архивлах, тараах	5	82	410
	Энэ хуулийн 17.1-17.3-т заасан баримт бичгийг гадаад хэлээр үйлдсэн бол орчуулж, хавсаргана. /17.4/	Баталгаат орчуулга хийлгэх[14]	15	82	1230
		Мэдээлэл шилжүүлэх ба нийтүүлэх	2	82	164

Тоон үзүүлэлтийг тооцох

Тоон үзүүлэлт нь хуулийн төсөлд тусгасан үүрэг хичнээн хуулийн этгээдэд, нэг жилд хэдэн удаагийн давтамжтайгаар үүрэг хүлээлгэж байгааг илэрхийлнэ. Тоон үзүүлэлтийг тооцохдоо тохиолдлыг тоог давтамжийн тоогоор үржүүлнэ.

Тоон үзүүлэлтийг тооцохдоо дараах хүчин зүйлийг тооцов. Үүнд:

1. Тухайн үүргийг хүлээх хуулийн этгээдийн тоо (Тохиолдлын тоо);
2. Тухайн үүргийг жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо (Давтамжийн тоо);

Тохиолдлын тоо: Хуулийн төслийн 15 дугаар зүйлд шинээр байгуулсан хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл гаргахаар үүрэгжүүлж өгсөн. Тохиолдлын тоог тогтоохдоо хуулиар үүрэг хүлээж байгаа хуулийн этгээдийн том, жижгийг харгалзаж үзэх шаардлагатай. Хэрэв тухайн зохицуулалт хуулийн этгээдийн хэд хэдэн төрлийг хамарч байвал тэдгээр төрөл тус бүрийн оролцогчийн тоог гаргана.[15] Түүнчлэн Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ГХОААН, ГХО-тай нөхөрлөлийг шинээр бүртгэхэд нэмэлт материал бүрдүүлэх үүрэг оноосон байна. Хөрөнгө оруулалт, хуулийн этгээдийн бүртгэлийн газрын статистик мэдээнээс Монгол Улсын хэмжээнд 2013-2016 оны хооронд шинээр бүртгүүлсэн, бүртгэлд өөрчлөлт оруулсан болон татан буугдсан хуулийн этгээдийн талаарх статистик тоо мэдээллээс тохиолдлын тоог гаргаж авлаа.

[13] Хуулийн төслийн 17.3.3 дахь хэсэгт хоёр баримт бичгийн аль нэгийг бүрдүүлэхийг шаардсан байна. Зардлын тооцоо хийхдээ хоёр төрлийн баримт бичиг тус бүрийг бүрдүүлэхэд шаардагдах захиргааны зардлыг тооцож илүү хэмнэлттэй хувилбарыг санал болгохыг зорьсон.

[14] Баталгаат орчуулгын товчоонд орчуулах баримт бичгийг хүлээлгэн өгөх болон хүлээн авахад зарцуулах хугацааг тооцов.

[15] Хууль тогтоомжийн тухай хууль аргачлал, гарын авлага. Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн "Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах" төсөл. Улаанбаатар хот. 2016 он.

Хүснэгт 5. Улсын бүртгэлд бүртгүүлсэн хуулийн этгээдийн тоо[16]

	Хуулийн этгээдийн тоо		2013 онд	2014 онд	2015 онд	2016 онд	Тохиолдлын тоо
1.	Улсын бүртгэлд бүртгэгдсэн нийт хуулийн этгээд		15998	17323	14532	14001	15463
2.	Хязгаарлагдмал хариуцлагатай компани		12335	13003	10934	10140	11603
3.	Үүнээс	Гадаадын хөрөнгө оруулалттай	-	8924	287	268	3160
4.	Нөхөрлөл		343	311	349	287	322
5.	Үүнээс	Гадаадын хөрөнгө оруулалттай	-	2	2	4	3

Хүснэгт 5-аас үзэхэд улсын хэмжээнд жилд дунджаар 15463 хуулийн этгээд шинээр бүртгүүлж, 2164 хуулийн этгээд татан буугдан улсын бүртгэлээс хасагдаж, 18854 хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэж, 935 хуулийн этгээдийн бүртгэлд хориг тавьж, цуцласан байна. Мөн сүүлийн 2 жилийн хугацаанд хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэгчдийн тоо буурсан үзүүлэлт гарчээ.

Давтамжийн тоо: Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хуулийн этгээдийн зүгээс мэдээлэл хүргүүлж байх хугацааг заагаагүй, харин тухай бүр гаргаж байхаар зохицуулсан тул давтамжийг 1 гэж авсан болно.

Хүснэгт 6. Тоон үзүүлэлт = Тохиолдлын тоо х Давтамж

Үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Тохиолдлын тоо	Давтамж	Тоон үзүүлэлт
Өргөдөл гаргах	Хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт /17.1.1/	15463	1	15463
	Баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл /17.1.2/	15463	1	15463
	Үүсгэн байгуулах баримт бичиг /17.1.3/	15463	1	15463
	Шаардлагатай тохиолдолд итгэмжлэл /17.1.4/	15463	1	15463
	улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт /17.1.5/	15463	1	15463
	Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт /17.1.6/	15463	1	15463
	Хувь нийлүүлсэн хөрөнгө болохыг нотолсон банкинд харилцах данс нээлгэсэн баримт /17.1.7/	15463	1	15463
	ХЭ-ийн хаягийн нотлох баримт /17.1.8/	15463	1	15463
Өргөдөл гаргах /ГХОААН/[17]	ГХ оруулахыг зөвшөөрсөн эрх бүхий байгууллагын шийдвэр /17.2.1/	3163	1	3163
	2 буюу түүнээс дээш этгээд хамтран байгуулж байгаа бол хувьцаа эзэмшигчдийн хооронд байгуулсан гэрээ /17.2.2/	3163	1	3163
	Хөрөнгө оруулагч нь гадаадын иргэн бол биеийн байцаалт, хуулийн этгээд бол гадаадын хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээний хуулбар /17.2.3/	3163	1	3163
	ГХ оруулагчтай бол гадаад улсаас мөнгөн хөрөнгө шилжүүлснийг нотолсон банкны тодорхойлолт, дансны хуулга, гаалийн байгууллагын мэдүүлэг, эрх бүхий байгууллагаас олгосон гэрчлэх баримт бичиг /17.2.4/	3163	1	3163

[16] ОӨУБЕГ, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын 2012-2016 оны статистик мэдээ.

[17] 2013-2016 онуудын статистик мэдээнээс үзвэл жилд дундажаар ГХОААН 3160, ГХО-тай нөхөрлөл 3 тус тус шинээр байгуулагдаж байна.

Өргөдөл гаргах / ГХОХХ-тай нөхөрлөл/	Нөхөрлөлийн гишүүн тус бүрд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон бүртгэлийн гэрчилгээ /17.3.1/	3	1	3
	Гадаад улс дахь хуулийн этгээдийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах бол тухайн байгууллагын зөвшөөрөл болон өргөдөл гаргагч нь тус байгууллагын гишүүн бөгөөд эрх олгосон болохыг нотолсон тодорхойлолт /17.3.2/	3	1	3
	энэ хуулийн 17.3-т заасан хуулийн этгээд нь тухайн улсдаа хууль тогтоомжийн хүрээнд байгуулагдан үйл ажиллагаа явуулдаг тухай эрх бүхий байгууллагын тодорхойлолт, эсхүл[18] хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээний хуулбар /17.3.3/	3	1	3
	Энэ хуулийн 17.1-17.3-т заасан баримт бичгийг гадаад хэлээр үйлдсэн бол орчуулж, хавсаргана. /17.4/	3163	1	3163

Хуулийн этгээдэд үүсэх нийт захиргааны зардлын дүнг тооцох

Энэ хэсэгт өмнөх шатанд тооцож гаргасан стандарт үйл ажиллагаа тус бүрийг гүйцэтгэхтэй холбогдон гарах зардлын тооцоо болон тоон үзүүлэлтийг хооронд нь үржүүлж нийт захиргааны зардлын дүнг гаргана.

Хүснэгт 7. Нийт зардал =
Стандарт үйл ажиллагааны зардал х Тоон үзүүлэлт

Үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зардал (төг)	Тоон үзүүлэлт	Нийт зардал
Өргөдөл гаргах	Хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт /17.1.1/	Нэр баталгаажуулах	410	15463	6339830
	Баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл /17.1.2/	Өргөдөл бичих	574	15463	8875762
	Үүсгэн байгуулах баримт бичиг /17.1.3/	Дотоод хуралдаан	2460	15463	38038980
	Шаардлагатай тохиолдолд итгэмжлэл /17.1.4/	Итгэмжлэл гаргах	1640	15463	25359320
		Нотариатаар баталгаажуулах	1640	15463	25359320
	Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт /17.1.5/	Мөнгө шилжүүлэх	656	15463	10143728
	Хувь нийлүүлсэн хөрөнгө болохыг нотолсон банкинд харилцах данс нээлгэсэн баримт /17.1.6/	Данс нээлгэх	2460	15463	38038980
		Банкны тодорхойлолт гаргуулах[19]	410	15463	6339830
		Мэдээллийн өгөгдөхүүнийг нягтлах	410	15463	6339830
	Үүсгэн байгуулагч, гүйцэтгэх удирдлагын цахим үнэмлэхийн хуулбар /17.1.7/	Олшруулах, архивлах, тараах	1,230	15463	19019490
	Хуулийн этгээдийн хаягийн нотлох баримт /17.1.8/	Хаягын тодорхойлолт авах/ түрээсийн гэрээг хуулбарлах	410	15463	6339830

[18] Хуулийн төслийн 17.3.4 дахь хэсэгт хоёр баримт бичгийн аль нэгийг бүрдүүлэхийг шаардсан байна. Зардлын тооцоо хийхдээ хоёр төрлийн баримт бичиг тус бүрийг бүрдүүлэхэд шаардагдах захиргааны зардлыг тооцож илүү хэмнэлттэй хувилбарыг санал болгохыг зорьсон.

[19] Стандарт үйл ажиллагааны жагсаалтаас эрх бүхий байгууллагаас нэмэлт лавлагаа шаардвал гаргаж өгөхөд зарцуулах хугацааг сонгов.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nlf.gov.mn

Өргөдөл гаргах / ГХОААН/	ГХ оруулахыг зөвшөөрсөн эрх бүхий байгууллагын шийдвэр /17.2.1/	Олшруулах, архивлах, тараах	410	3163	1296830
	2 буюу түүнээс дээш этгээд хамтран байгуулж байгаа бол хувьцаа эзэмшигчдийн хооронд байгуулсан гэрээ /17.2.2/	Гэрээний төсөл боловсруулах	8200	3163	25936600
		Нотариатаар баталгаажуулах	820	3163	2593660
	ХО нь гадаадын иргэн бол биеийн байцаалт, хуулийн этгээд бол гадаадын хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээний хуулбар /17.2.3/	Олшруулах, архивлах, тараах	410	3163	1296830
	ГХ оруулагчтай бол гадаад улсаас мөнгөн хөрөнгө шилжүүлснийг нотолсон банкны тодорхойлолт, дансны хуулга, гаалийн байгууллагын мэдүүлэг, эрх бүхий байгууллагаас олгосон гэрчлэх баримт бичиг /17.2.4/	Банкны тодорхойлолт гаргуулах	1640	3163	5187320
		Дансны хуулга авах	820	3163	2593660
		Гаалийн байгууллагын мэдүүлэг авах	1230	3163	3890490
		Олшруулах, архивлах, тараах	410	3163	1296830
Өргөдөл гаргах / ГХОХХ-тай нөхөрлөл/	Нөхөрлөлийн гишүүн тус бүрд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон бүртгэлийн гэрчилгээ /17.3.1/	Олшруулах, архивлах, тараах	410	3	1230
	Гадаад улс дахь хуулийн этгээдийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах бол тухайн байгууллагын зөвшөөрөл болон өргөдөл гаргагч нь тус байгууллагын гишүүн бөгөөд эрх олгосон болохыг нотолсон тодорхойлолт /17.3.2/	Зөвшөөрөл гаргуулах	1230	3	3690
		Тодорхойлолт гаргуулах	1230	3	3690
	Энэ хуулийн 17.3-т заасан ХЭ нь тухайн улсдаа хууль тогтоомжийн хүрээнд байгуулагдан үйл ажиллагаа явуулдаг тухай эрх бүхий байгууллагын тодорхойлолт, эсхүл ХЭ-ийн гэрчилгээний хуулбар /17.3.3/	Тодорхойлолт гаргуулах	1230	3	3690
		Олшруулах, архивлах, тараах	410	3	1230
	Энэ хуулийн 17.1-17.3-т заасан баримт бичиг нь монгол хэлээр байх бөгөөд гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийг орчуулж, хавсаргана.	Баталгаат орчуулга хийлгэх	1230	3163	3890490
		Мэдээлэл шилжүүлэх ба нийтлүүлэх	164	3163	518732
Нийт зардал					**238709872**

Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах

Энэ хэсэгт тодорхой шалгах асуултын дагуу зардлыг нь тооцсон үүрэг нэг бүрийн зардлыг бууруулах, аж ахуйн салбарт үүсгэх дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгалаа. Шалгуурууд:

- *Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх:* Хуулийн төсөлд шинээр байгуулагдсан хуулийн этгээд цахим хэлбэрээр бүртгүүлэх боломжтой талаар зохицуулалт туссан. Тус зохицуулалтын хэрэгжиж буй байдал, хэрэгжих боломж,

Хуулийн төслийн хүрээлэн www.ri.gov.mn

бололцоог авч үзье. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар 2015 оны 03 дугаар сарын 01-ээс http://les.burtgel.gov.mn/ubeg/citizen/services/ цахим хуудсаар дамжуулан шинээр байгуулагдсан хуулийн этгээдийг цахим хэлбэрээр бүртгэх үйл ажиллагааг эхлүүлсэн байна. Тус цахим хуудаст 2015 оны сүүлийн хагас жилд хуулийн этгээд шинээр бүртгүүлэх 113 хүсэлт ирснээс 25.7% буюу 29 хүсэлт зөвшөөрөгдөж, 69.9% буюу 79 хүсэлт цуцлагдсан бол 2016 оны байдлаар нийт 146 хүсэлт ирснээс 17.1% буюу 25 хүсэлт зөвшөөрөгдөж, 65.8% буюу 96 хүсэлт цуцлагдсан байна. Мөн 2017 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 03 дугаар сарын 09-ны өдрийн байдлаар тус цахим хуудаст нийт 36 хүсэлт ирснээс 2.8% буюу 1 хүсэлт зөвшөөрөгдсөнөөр цахим бүртгэл дийлэнх тохиолдолд цуцлагдсан үзүүлэлттэй байна.[20] Мөн тухайн онд улсын бүртгэлд шинээр бүртгүүлсэн нийт хуулийн этгээдийн дүнтэй харьцуулвал 2015 онд 0.2%, 2016 онд 0.2% нь цахим хэлбэрээр бүртгэл хийлгэжээ. Шинээр байгуулагдсан хуулийн этгээд цахим хэлбэрээр бүртгүүлэх үзүүлэлт харьцангуй бага байгаа шалтгааныг тодруулвал:

- Хуулийн этгээдийн цахим бүртгэлийн талаар мэдээлэлгүй;
- Цахим бүртгэлийн програм хангамжийн ойлгомжгүй байдал;
- Баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлэн илгээхдээ материалын бүрдэл дутуу илгээснээр цуцлагдаж буй байдал;
- Бүрэн цахим хэлбэрт шилжээгүй байдал: Баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлэн илгээх нь зөвшөөрөгдсөн боловч эх нотлох баримт бичгийг Улсын бүртгэлийн газарт цаасан хэлбэрээр биеэр авчирч өгснөөр хуулийн этгээдийн бүртгэл баталгаажиж байгаа нь хуулийн этгээдэд давхар дамжлага бий болгохоор байна. /13.3/ Тухайлбал цаасан хэлбэрээр баримт бичгийг авчирсан тохиолдолд бүртгэлийн ажилтан баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлдэг бол цахим хэлбэрээр бүртгүүлэх тохиолдолд хуулийн этгээд баримт бичгээ цахим хэлбэрт шилжүүлж илгээсний дараа цаасан хэлбэрээр хүргүүлдэг. Энэ нь баримт бичиг хүргүүлэх дарааллын хувьд ялгаа гарснаас хуулийн этгээдийг цахимаар бүртгэж байгаа гэж хэлэхэд тохиромжгүй тул хуулийн этгээдийн зүгээс бүртгэлийн цахим хэлбэрийг сонгох нь бага байхаар байна;
- Цахим бүртгэлийн програм хангамж нь сайжруулсан цахим шуудан хэлбэртэй байгаа явдал: Хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийг улсын бүртгэгч шалгаад хариу захидал бичдэг нь автоматжаагүй, механик ажиллагаатай байна.

• *<u>Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх</u>:* Энэ тохиолдолд хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломжгүй бөгөөд хуулийн этгээдийн бүртгэл, мэдээлэлд орсон өөрчлөлтийг зайлшгүй хөтлөх шаардлагатай.

• *<u>Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж бий эсэх</u>:* Хуулийн этгээд шинээр бүртгүүлэхдээ цаасан болон цахим хэлбэр харгалзахгүй улсын бүртгэлийн байгууллагад нэг удаа биечлэн очиж баримт бичгийн эх нотлох баримтыг хүлээлгэн өгч байна. Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийг бүртгэх тохиолдолд мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломжгүй.

• *<u>Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх</u>:* Хуулийн төслийн 17.3.3. дахь хэсэгт ГХО-тай нөхөрлөл нь гадаад улсдаа хууль тогтоомжийн хүрээнд байгуулагдан үйл ажиллагаа явуулдаг тухай эрх бүхий байгууллагын тодорхойлолт, эсхүл хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг бүрдүүлэхээр заасан. Тус хоёр баримт бичгийн аль нэгийг бүрдүүлэхийг шаардсан байна. Зардлын тооцоо хийхдээ хоёр төрлийн баримт бичиг тус бүрийг бүрдүүлэхэд шаардагдах <u>захиргааны зардлыг</u> тооцож үзэхэд хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээний

[20] Хүсэлт цуцлагдсан үндсэн шалтгаан нь баримт бичгийн бүрдэл дутуу байх явдал байна. Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас.

хуулбарыг өгөх нь хуулийн этгээдийн хувьд илүү хэмнэлттэй хувилбар байна. Иймд эрх бүхий байгууллагын тодорхойлолт гэсэн агуулгыг хасах боломжтой гэж үзэж байна.

- *Мэдээллийн зарим агуулгаас татгалзаж болох эсэх*: ХЭБГ-ын албан хаагчдын зүгээс шинээр байгуулагдсан ХЭ-г бүртгэхэд шаардаж буй баримт бичиг нь эх нотлох баримтын хувьд шүүхэд төлөөлөх хэмжээний олон талын мэдээллийг багтаасан байх шаардлагатай гэсэн байр суурийг илэрхийлсэн. Мөн мэдээллийн агуулгаас хасах боломжгүй бөгөөд боломжит хувилбараар орсон гэж үзсэн.

Нэмэлт зардлыг тооцох

Энэ хэсэгт Хуулийн төсөлд тусгагдсан үүргийн улмаас хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардал, ачааллыг тооцоолох явцад гарч болох бусад зардлыг тооцоолно.

Хүснэгт 8. Бусад зардал

Хуулийн этгээдэд үүсэх нэмэлт зардал: Нэрийн баталгаажуулалт хийлгэсэн төлбөр : 500 x 187280 = 93640000 Итгэмжлэл гаргуулах нотариатын төлбөр: 5000 x 773[21]= 3865000 Тэмдэгтийн хураамж: 44000 x 15463= 680372000 Баталгаат орчуулгын төлбөр: 500000[22] x 3163[23]= 1187000000 Нэмэлт зардал 93640000+ 3865000+680372000+1187000000= 1980337000 төгрөг байна.					
Нэгж	Нийт зардал	+	Нэмэлт зардал	=	Бүгд
Хуулийн этгээд	238709872	+	1964877000	=	2203586872

Үр дүн, санал

Хуулийн төсөлд тусгасан шинээр байгуулагдсан хуулийн этгээдийг бүртгүүлэх хуулийн этгээдээс шаардах баримт бичгийг бүрдүүлэхэд улсын хэмжээнд шинээр бүртгүүлж буй 15463 хуулийн этгээдийн хувьд нэг жилд дунджаар 2,203,586,872 төгрөгийн зардал гарах төлөвтэй байна.

Үүнээс харахад нэг хуулийн этгээдэд 142,507 төгрөгийн зардал үүсгэнэ гэх тооцоо гарах /2,203,586,872 төгрөг / 15463 хуулийн этгээд = 142,507 төгрөг/хуулийн этгээд/ бөгөөд энэ нь шинээр бүртгүүлж буй хуулийн этгээдэд дарамт учруулах хэмжээнд хүрэхгүй байна. Ялангуяа дотоодын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн тухайд орчуулгын, баталгаажуулалтын зэрэг зардал гарахгүй тул энэ хэмжээ ойролцоогоор 100,000 төгрөг байна.

1.2.2.Өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээдийг бүртгүүлэхэд гарах захиргааны зардал

Хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээдийг бүртгүүлэхэд “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-ийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасны дагуу өргөдөл гаргах үүрэг хүлээлгэсэн байх бөгөөд энэ нь 21.1 дахь хэсэгт заасан мэдээллийг тусгасан байх шаардлага тавигдаж байна.

[21] Хуулийн төслийн 17.1.4-т шаардлагатай тохиолдолд итгэмлэл гэж заасныг нийт бүртгүүлсэн хуулийн этгээдийн 5 хувьд нь итгэмжлэл шаардлагатай болсон гэж баримжаалан тооцов.

[22] Баталгаат орчуулга 1 нүүр материалыг 20000-25000 орчуулахаар тооцов. Хуулийн этгээдийн бүрдүүлсэн бичиг баримтын хуудасны тоо дундажаар 25 хуудас байдаг гэж үзвэл нийт 500000 төгрөг орчуулгын зардалд зарцуулах юм.

[23] 2013-2016 онуудад ГХОААН, ГХО нөхөрлөлийн бүртгүүлсэн дундаж тоонд үндэслэв.

Хүснэгт 9. Зардал. Хугацаа х Ажлын хөлс = Үйл ажиллагаа тус бүрийн зардал

Үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа (мин)	Ажлын хөлс (төг)[24]	Зардал (төг)
Өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагд сан хуулийн этгээдийг бүртгүүлэх өргөдөл гаргах	ХЭ-ийн нэрийн баталгаажуулалт /21.1.1/	Нэр баталгаажуулах	5	82	410
	Баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл /21.1.2/	Өргөдөл бичих	7	82	574
	Үүсгэн байгуулах баримт би-чиг буюу өөрчлөн байгуулсан тухай шийдвэр /тогтоол/, шинэчилсэн дүрэм, хуульд заасан бол гэрээ /21.1.3/	Дотоод хуралдаан	30	82	2460
		Мэдээлэл шилжүүлэх, нийтлэх	2	82	164
	Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт /21.1.4/	Мөнгө шилжүүлэх	8	82	656
	Шаардлагатай тохиолдолд итгэмжлэл /21.1.5/	Итгэмжлэл гаргах	20	82	1640
		Нотариатаар баталгаажуулах	20	82	1640
	Энэ хуулийн 11.1.7-д заасан эрх залгамжлалын талаарх өөрчлөлтийг оруулсан үүсгэн байгуулах баримт бичиг /21.1.6./	Дотоод хуралдаан	30	82	2460
		Мэдээлэл шилжүүлэх, нийтлэх	2	82	164
	ГХ оруулахыг зөвшөөрсөн эрх бүхий байгууллагын шийдвэр /21.1.7/	Олшруулах, архивлах, тараах	5	82	410
	Өөрчлөн байгуулагдах үеийн санхүүгийн тайлан, тэнцэл /21.1.8/	Олшруулах, архивлах, тараах	5	82	410
	улсын бүртгэлийн гэрчилгээ /21.1.9/	Мэдээлэл шил-жүүлэх, нийтлэх	2	82	410
	Нэгдэх, нийлэх тохиолдолд Өрсөлдөөний тухай хуулийн 8.1-д заасны дагуу өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүгнэлт /21.1.10/	Дүгнэлт гаргуулах	15	82	1230
		Мэдээлэл шилжүүлэх, нийтлэх	2	82	410

Тоон үзүүлэлтийг тооцох

Тоон үзүүлэлт нь хуулийн төсөлд тусгасан үүрэг хичнээн хуулийн этгээдэд, нэг жилд хэдэн удаагийн давтамжтайгаар үүрэг хүлээлгэж байгааг илэрхийлнэ. Тоон үзүүлэлтийг тооцохдоо тохиолдлыг тоог давтамжийн тоогоор үржүүлнэ.

Тоон үзүүлэлтийг тооцохдоо дараах хүчин зүйлийг тооцов. Үүнд:

1. Тухайн үүргийг хүлээх хуулийн этгээдийн тоо (Тохиолдлын тоо);
2. Тухайн үүргийг жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо (Давтамжийн тоо);

Хүснэгт 10. Өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээд[25]

	Хуулийн этгээд	2015 онд	2016 онд	Тохиоллын тоо
1.	Шинэчилсэн бүртгэлд хамрагдаж улсын бүртгэлийн гэрчилгээгээ солиулсан хуулийн этгээд	156	144	**150**

Давтамжийн тоо: Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн

[24] Өмнөх хэсэгт тооцсон цалингийн зардлыг ашиглав.

[25] ОӨУБЕГ, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын 2016 оны үйл ажиллагааны тайлан.

Хуульч үйлчлэгчийн хураэлэн www.ihuljch.mn

шинэчилсэн найруулгын төсөлд хуулийн этгээдийн зүгээс мэдээлэл хүргүүлж байх хугацааг заагаагүй, харин тухай бүр гаргаж байхаар зохицуулсан тул давтамжийг 1 гэж авсан болно.

Хүснэгт 11. Тоон үзүүлэлт = Тохиолдлын тоо х Давтамж

Үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Тохиолд-лын тоо	Давтамж	Тоон үзүүлэлт
Өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээдийг бүртгүүлэх өргөдөл гаргах	ХЭ-ийн нэрийн баталгаажуулалт /21.1.1/	150	1	150
	Баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл /21.1.2/	150	1	150
	Үүсгэн байгуулах баримт бичиг буюу өөрчлөн байгуулсан тухай шийдвэр /тогтоол/, шинэчилсэн дүрэм, хуульд заасан бол гэрээ /21.1.3/	150	1	150
	Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт /21.1.4/	150	1	150
	Шаардлагатай тохиолдолд итгэмжлэл /21.1.5/	150	1	150
	Энэ хуулийн төслийн 11.1.7-д заасан эрх залгамжлалын талаарх өөрчлөлтийг оруулсан үүсгэн байгуулах баримт бичиг /21.1.6./	150	1	150
	ГХ оруулахыг зөвшөөрсөн эрх бүхий байгууллагын шийдвэр /21.1.7/	150	1	150
	Өөрчлөн байгуулагдах үеийн санхүүгийн тайлан, тэнцэл /21.1.8/	150	1	150
	Улсын бүртгэлийн гэрчилгээ /21.1.9/	150	1	150
	Нэгдэх, нийлэх тохиолдолд Өрсөлдөөний тухай хуулийн 8.1-д заасны дагуу өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүгнэлт /21.1.10/	150	1	150

Хуулийн этгээдэд үүсэх нийт захиргааны зардлын дүнг тооцох

Энэ хэсэгт өмнөх шатанд тооцож гаргасан стандарт үйл ажиллагаа тус бүрийг гүйцэтгэхтэй холбогдон гарах зардлын тооцоо болон тоон үзүүлэлтийг хооронд нь үржүүлж нийт захиргааны зардлын дүнг гаргана.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Хүснэгт 12. Нийт зардал =
Стандарт үйл ажиллагааны зардал х Тоон үзүүлэлт

Үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зардал (төг)	Тоон үзүүлэлт	Нийт зардал
Өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагд сан хуулийн этгээдийг бүртгүүлэх өргөдөл гаргах	ХЭ-ийн нэрийн баталгаажуулалт /21.1.1/	Нэр баталгаажуулах	410	150	61500
	Баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл /21.1.2/	Өргөдөл бичих	574	150	86100
	Үүсгэн байгуулах баримт бичиг буюу өөрчлөн байгуулсан тухай шийдвэр /тогтоол/, шинэчилсэн дүрэм, хуульд заасан бол гэрээ /21.1.3/	Дотоод хуралдаан	2460	150	369000
		Мэдээлэл шилжүүлэх, нийтлэх	164	150	24600
	Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт /21.1.4/	Мөнгө шилжүүлэх	656	150	98400
	Шаардлагатай тохиолдолд итгэмжлэл /21.1.5/	Итгэмжлэл гаргах	1640	150	246000
		Нотариатаар баталгаажуулах	1640	150	246000
	энэ хуулийн 11.1.7-д заасан эрх залгамжлалын талаарх өөрчлөлтийг оруулсан үүсгэн байгуулах баримт бичиг /21.1.6./	Дотоод хуралдаан	2460	150	369000
		Мэдээлэл шилжүүлэх, нийтлэх	164	150	24600
	ХО тухай хуулийн 21.1-д заасны дагуу ГХ оруулахыг зөвшөөрсөн эрх бүхий байгууллагын шийдвэр /21.1.7/	Олшруулах, архивлах, тараах	410	150	61500
	өөрчлөн байгуулагдах үеийн санхүүгийн тайлан, тэнцэл /21.1.8/	Олшруулах, архивлах, тараах	410	150	61500
	улсын бүртгэлийн гэрчилгээ /21.1.9/	Мэдээлэл шил жүүлэх, нийтлэх	410	150	61500
	нэгдэх, нийлэх тохиолдолд Өрсөлдөөний тухай хуулийн 8.1-д заасны дагуу өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүгнэлт /21.1.10/	Дүгнэлт гаргуулах	1230	150	184500
		Мэдээлэл шилжүүлэх, нийтлэх	410	150	61500
Нийт зардал					**1955700**

Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах

Энэ хэсэгт тодорхой шалгах асуултын дагуу зардал тооцсон үүрэг нэг бүрийн зардлыг бууруулах, аж ахуйн салбарт үүсгэх дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгалаа. Шалгуурууд:

- Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх: Хуулийн этгээдийн бүртгэлийн цахим системд өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээдийг бүртгүүлэх цэс байршаагүй байна. Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн мэдээллийг цахим хэлбэрээр хүлээн авсны дараа баримт бичгийг цаасан хэлбэрээр биечлэн хүргүүлж байгаа нь мэдээллийг цахим болон цаасан хэлбэрээр хүргэх 2 үе шатыг бий болгож буй талаар өмнөх хэсэгт дурдсан.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Иймд хуулийн этгээдийн бүртгэлийн цахим системийг боловсронгуй болгох хүрээнд өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээдийг бүртгүүлэх мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой юм.

- Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх: Тухайн жилд өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн тоо тогтмол биш байх тул тохиолдлын тоог сүүлийн 2 жилийн дундаж тоонд түшиглэн гаргасан. Энэ тохиолдолд хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломжгүй юм.
- Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж бий эсэх: Өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээд нь улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй байна. Энэ үүрэг нь өөрчлөн байгуулагдсанаар бүртгүүлэх буюу 1 удаа хийгдэх үйл ажиллагаа юм. Энэ тохиолдолд мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломжгүй юм.
- Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх: Хэрэв өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээдийг нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах замаар, эсхүл хуулийн этгээдийн хэлбэр өөрчлөгдсөн тохиолдолд өмнөх хуулийн этгээдийн үйл ажиллагааг дуусгавар болсонд тооцож, бүртгэлээс хасан шинээр байгуулагдсанаар хуулийн этгээдийн мэдээллийг бүртгэж байна. Хуулийн төслийн 20.2 дахь хэсэгт заасны дагуу өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээд болон шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгүүлэх адил ажиллагаанд 1 стандарт шаардлага тавигдаж байна.
- Хуулийн төсөл болон судалгаа мэдээллээс харахад итгэмжлэл болон Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 21.1-д заасны дагуу гадаадын хөрөнгө оруулахыг зөвшөөрсөн эрх бүхий байгууллагын шийдвэр гэх мэдээллийн агуулгыг “шаардлагатай тохиолдолд бүрдүүлэх” тул үүний тохиолдлын тоо нь тухайн жилээс хамааран хэлбэлзэх боломжтой.
- Мэдээллийн зарим агуулгаас татгалзаж болох эсэх: Баримт бичгийн бүрдлийг хангах, хуулийн этгээдийн хувийн хэрэг хөтлөх хүрээнд мэдээллийн зарим агуулгаас татгалзах боломжгүй.

Нэмэлт зардлыг тооцох

Энэ хэсэгт хуулийн төсөлд тусгасан үүргийн улмаас хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардал, ачааллыг тооцоолох явцад гарч болох бусад зардлыг тооцоолно.

Хүснэгт 12. Нэмэлт зардал

Хуулийн этгээдэд үүсэх нэмэлт зардал: Нэрийн баталгаажуулалт хийлгэсэн төлбөр : 500 x 150 = 75000 Нотариатын төлбөр: 5000 x 7.5[26]= 37500 Тэмдэгтийн хураамж: 44000[27] x 150= 6600000 Нэмэлт зардал байна. 75000+37500+6600000 = 6712500 төгрөг					
Нэгж	**Нийт зардал**	**+**	**Нэмэлт зардал**	**=**	**Бүгд**
Хуулийн этгээд	**1955700**	**+**	**6712500**	**=**	**8668200**

[26] Хуулийн төслийн 21.1.5-д шаардлагатай тохиолдолд итгэмлэл гэж заасныг нийт бүртгүүлсэн хуулийн этгээдийн 5 хувьд нь итгэмжлэл шаардлагатай болсон гэж баримжаалан тооцов.

[27] Өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээд нь шинэ гэрчилгээ авах бол улсын тэмдэгтийн хураамж 44000 төгрөг , нэмэлтээр бичүүлэх бол улсын тэмдэгтийн хураамж 10000 төгрөгийн үнэтэй байна. Энэ тохиолдолдөөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээд шинэ гэрчилгээ авахаар тооцов.

Үр дүн, санал

Хуулийн төсөлд тусгасан өөрчлөн байгуулагдах замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээдийг бүртгүүлэх хуулийн этгээдээс шаардах баримт бичгийг бүрдүүлэхэд улсын хэмжээнд дунджаар шинээр бүртгүүлж буй 150 хуулийн этгээдийн хувьд нэг жилд дунджаар **8,668,200** төгрөгийн зардал гарах төлөвтэй байна.

Үүнээс харахад нэг хуулийн этгээдэд **57,788** төгрөгийн зардал үүсгэнэ гэх тооцоо гарах бөгөөд энэ нь шинээр бүртгүүлж буй хуулийн этгээдэд дарамт учруулах хэмжээнд хүрэхгүй байна.

1.2.3 Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэхэд шаардах захиргааны зардал

Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэхэд “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-ийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасны дагуу өргөдөл гаргах үүрэг хүлээлгэсэн байна.

Хүснэгт 13. Хугацаа х Ажлын хөлс = Үйл ажиллагаа тус бүрийн зардал

Үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа (мин)	Ажлын хөлс (төг)	Зардал (төг)
Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэх	нэр өөрчлөх тохиолдолд шинээр олгосон нэрийн баталгаажуулалт, өдөр тутмын сонинд зарлуулсан зар /23.1.1/	Нэр баталгаажуулах	5	82	410
		Зар захиалах	10	82	820
	баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл /23.1.2/	Өргөдөл бичих	7	82	574
	үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт оруулах тухай шийдвэр /23.1.3/	Мэдээлэл шилжүүлэх, нийтлэх	30	82	2460
	холбогдох өөрчлөлт оруулах тухай үүсгэн байгуулагч, эрх бүхий байгууллагын шийдвэр /тогтоол/, хурлын тэмдэглэл /23.1.4/	Дотоод хуралдаан	20	82	1640
		Олшруулах, архивлах, тараах	5	82	410
	үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан өөрчлөлт /23.1.5/	Мэдээлэл шилжүүлэх, нийтлэх	2	82	164
	шаардлагатай тохиол долд итгэмжлэл /23.1.6/	Итгэмжлэл гаргах	20	82	1640
		Нотариатаар баталгаажуулах	20	82	1640
	улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт /23.1.7/	Мөнгө шилжүүлэх	8	82	656
	дүрэмд өөрчлөлт оруулах тохиолдолд шинэчилсэн дүрэм, хуульд заасан тохиолдолд шинэчилсэн гэрээ эсхүл гэрээний нэмэлт, өөрчлөлт /23.1.8/	Мэдээлэл шилжүүлэх, нийтлэх	2		164
	хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт оруулах тохиолдолд баталгаажсан санхүүгийн тайлан, тэнцэл /23.1.9/	Олшруулах, архивлах, тараах	5	82	410
	хаяг өөрчлөх тохиолдолд үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ эсхүл түрээсийн гэрээ зэрэг нотлох баримт /23.1.10/	Хаягын тодорхойлолт авах/ түрээсийн гэрээг хуулбарлах	5	82	410

Хуульчийн дэлгэрэнгүй мэдээлэл www.legal.gov.mn

	улсын бүртгэлийн гэрчилгээ /23.1.11/	Мэдээлэл шилжүүлэх, нийтлэх	5	82	410
	Иргэний хуульд заасан холбогдох гэрээ эсхүл өв залгамжлах эрхийн гэрчилгээ /нотариатаар гэрчлүүлсэн/ /23.3.4/	Гэрээний төсөл гаргуулах	100	82	8200
		Нотариатаар баталгаажуулах	20	82	1640

Тоон үзүүлэлтийг тооцох

Тоон үзүүлэлт нь хуулийн төсөлд тусгасан үүрэг хичнээн хуулийн этгээдэд, нэг жилд хэдэн удаагийн давтамжтайгаар үүрэг хүлээлгэж байгааг илэрхийлнэ. Тоон үзүүлэлтийг тооцохдоо тохиолдлыг тоог давтамжийн тоогоор үржүүлнэ.

Тоон үзүүлэлтийг тооцохдоо дараах хүчин зүйлийг тооцов. Үүнд:

1. Тухайн үүргийг хүлээх хуулийн этгээдийн тоо (Тохиолдлын тоо);
2. Тухайн үүргийг жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо (Давтамжийн тоо);

Хүснэгт 14. Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн тоо[28]

Тохиолдол	2013 онд	2014 онд	2015 онд	2016 онд	Тохиолдлын тоо
Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэсэн	20979	20655	16506	17278	18854.5

Давтамжийн тоо: Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хуулийн этгээдийн зүгээс мэдээлэл хүргүүлж байх хугацааг заагаагүй, харин тухай бүр гаргаж байхаар зохицуулсан тул давтамжийг 1 гэж авсан болно.

Хүснэгт 15. Тоон үзүүлэлт = Тохиолдлын тоо х Давтамж

	Стандарт үйл ажиллагаа	Тохиолдлын тоо	Давтамж	Тоон үзүүлэлт
Үүрэг	нэр өөрчлөх тохиолдолд шинээр олгосон нэрийн баталгаажуулалт, өдөр тутмын сонинд зарлуулсан зар /23.1.1/	18854	1	18854
	Баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл /23.1.2/	18854	1	18854
	үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт оруулах тухай шийдвэр /23.1.3/	18854	1	18854
	холбогдох өөрчлөлт оруулах тухай үүсгэн байгуулагч, эрх бүхий байгууллагын шийдвэр /тогтоол/, хурлын тэмдэглэл /23.1.4/	18854	1	18854
	үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан өөрчлөлт /23.1.5/	18854	1	18854
	шаардлагатай тохиолдолд итгэмжлэл /23.1.6/	18854	1	18854
	улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт /23.1.7/	18854	1	18854
	дүрэмд өөрчлөлт оруулах тохиолдолд шинэчилсэн дүрэм, хуульд заасан тохиолдолд шинэчилсэн гэрээ эсхүл гэрээний нэмэлт, өөрчлөлт /23.1.8/	18854	1	18854

[28] ОӨУБЕГ, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын 2012-2016 оны статистик мэдээ.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

	хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт оруулах тохиолдолд баталгаажсан санхүүгийн тайлан, тэнцэл /23.1.9/	18854	1	18854
	хаяг өөрчлөх тохиолдолд үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ эсхүл түрээсийн гэрээ зэрэг нотлох баримт /23.1.10/	18854	1	18854
	улсын бүртгэлийн гэрчилгээ /23.1.11/	18854	1	18854
	Иргэний хуульд заасан холбогдох гэрээ эсхүл өв залгамжлах эрхийн гэрчилгээ / нотариатаар гэрчлүүлсэн/ /23.3.4/	18854	1	18854

Хуулийн этгээдэд үүсэх нийт захиргааны зардлын дүнг тооцох

Энэ хэсэгт өмнөх шатанд тооцож гаргасан стандарт үйл ажиллагаа тус бүрийг гүйцэтгэхтэй холбогдон гарах зардлын тооцоо болон тоон үзүүлэлтийг хооронд нь үржүүлж нийт захиргааны зардлын дүнг гаргана.

Хүснэгт 16. Нийт зардал = Стандарт үйл ажиллагааны зардал х Тоон үзүүлэлт

Үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зардал (төг)	Тоон үзүүлэлт	Нийт зардал
Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөл тийг бүртгүүлэх	нэр өөрчлөх тохиолдолд шинээр олгосон нэрийн баталгаажуулалт, өдөр тутмын сонинд зарлуулсан зар /23.1.1/	Нэр баталгаажуулах	410	18854	7730140
		Зар захиалах	820	18854	15460280
	баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл /23.1.2/	Өргөдөл бичих	574	18854	10822196
	үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт оруулах тухай шийдвэр /23.1.3/	Мэдээлэл шилжүүлэх, нийтлэх	2460	18854	46380840
	холбогдох өөрчлөлт оруулах тухай үүсгэн байгуулагч, эрх бүхий байгууллагын шийдвэр /тогтоол/, хурлын тэмдэглэл /23.1.4/	Дотоод хуралдаан	1640	18854	30920560
		Олшруулах, архивлах, тараах	410	18854	7730140
	үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан өөрчлөлт /23.1.5/	Мэдээлэл шилжүүлэх, нийтлэх	164	18854	3092056
	шаардлагатай тохиолдолд итгэмжлэл /23.1.6/	Итгэмжлэл гаргах	1640	18854	30920560
		Нотариатаар баталгаажуулах	1640	18854	30920560
	улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт /23.1.7/	Мөнгө шилжүүлэх	656	18854	12368224
	дүрэмд өөрчлөлт оруулах тохиолдолд шинэчилсэн дүрэм, хуульд заасан тохиолдолд шинэчилсэн гэрээ эсхүл гэрээний нэмэлт, өөрчлөлт /23.1.8/	Мэдээлэл шил жүүлэх, нийтлэх	164	18854	3092056
	хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт оруулах тохиолдолд баталгаажсан санхүүгийн тайлан, тэнцэл /23.1.9/	Олшруулах, архивлах, тараах	410	18854	7730140

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ МЭДЭЭЛЭЛ www.mojha.gov.mn

	хаяг өөрчлөх тохиолдолд үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ эсхүл түрээсийн гэрээ зэрэг нотлох баримт /23.1.10/	Хаягын тодорхойлолт авах/ түрээсийн гэрээг хуулбарлах	410	18854	7730140
	улсын бүртгэлийн гэрчилгээ /23.1.11/	Мэдээлэл шил жүүлэх, нийтлэх	410	18854	7730140
	Иргэний хуульд заасан холбогдох гэрээ эсхүл өв залгамжлах эрхийн гэрчилгээ /нотариатаар гэрчлүүлсэн/ /23.3.4/	Гэрээний төсөл гаргуулах	8200	18854	154602800
		Нотариатаар баталгаажуулах	1640	18854	30920560
Нийт зардал					**408151392**

Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах

Энэ хэсэгт тодорхой шалгах асуултын дагуу зардлыг нь тооцсон үүрэг нэг бүрийн зардлыг бууруулах, аж ахуйн салбарт үүсгэх дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгалаа. Шалгуурууд:

- *Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх:* Хуулийн этгээдийн цахим бүртгэлийн систем нь хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг цахим хэлбэрээр хүлээн авах ажлыг 2015 оны 03 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлсэн. Энэ хүрээнд 2015 онд 3 хүсэлт ирснээс 100% цуцлагдсан, 2016 онд 2 хүсэлт ирснээс 100% зөвшөөрөгдсөн, 2017 оны 03 дугаар сарын 09-ний байдлаар бүртгүүлэх хүсэлт ирээгүй байна. Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэхээр жилд дундажаар 18854 хуулийн этгээд хандаж буй тоотой харьцуулбал цахим хэлбэрээр бүртгүүлсэн хуулийн этгээд 0.01%-ийг эзэлж байна. Мэдээллийг цахим хэлбэрээр хүргүүлэх боломж бүрдсэн боловч улсын бүртгэлийн байгууллагаас зөвшөөрөгдсөний дараа цаасан хэлбэрээр биечлэн хүргүүлж баталгааждаг нь хуулийн этгээдийн талд давхар үе шат нэмэхээр байна. Мэдээллийг 100% цахим хэлбэрээр хүргүүлэх, бичиг баримтын үнэн зөв байдлыг цахим хэлбэрээр шалгах боломжийг судлах шаардлагатай байна.
- *Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх:* Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд Хуулийн этгээдийн хувийн хэргийн агуулгад байх шаардлагатай мэдээллийн бүрдүүлбэрийг оруулж өгсөн. Мөн Хуулийн төслийн 11.1. дэх хэсэгт заасан мэдээлэлд өөрчлөлт оруулсан бол хуулийн этгээд ажлын 15 хоногийн дотор улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй байна. Хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт оруулсан хуулийн этгээдийн тоо тогтмол биш бөгөөд жилд дундажаар 18854 хуулийн этгээд өөрчлөлт хийсэн тооцоолол гаргасан. Энэ тохиолдолд хамрагдах хуулийн этгээдийн тоо тухайн жилээс хамааран багасах эсхүл нэмэгдэх боломжтой.
- *Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж бий эсэх:* Хуулийн этгээд нь хуулийн төслийн 11.1 дэх хэсэгт заасан мэдээллийг өөрчилсөн тохиолдолд улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй байна. Энэ үүрэг нь өөрчлөлт оруулсан мэдээллээ бүртгүүлэх буюу 1 удаа хийгдэх үйл ажиллагаа юм. Энэ тохиолдолд мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломжгүй.
- *Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх:* Хуулийн төсөлд шаардлагатай тохиолдолд бүрдүүлэх баримт бичгийг зааж өгсөн байна. Үүнд: итгэмжлэл, дүрэмд өөрчлөлт оруулах тохиолдолд шинэчилсэн дүрэм, хуульд заасан тохиолдолд шинэчилсэн гэрээ эсхүл гэрээний нэмэлт, өөрчлөлт, хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт оруулах тохиолдолд баталгаажсан санхүүгийн тайлан, тэнцэл,

хаяг өөрчлөх тохиолдолд үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ эсхүл түрээсийн гэрээ зэрэг нотлох баримт бүрдүүлэх шаардлага тавьжээ. Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтөөс шалтгаалан дээрх 3 төрлийн баримт бичгийн аль нэгийг бүрдүүлэх боломжтой байна.

- *Мэдээллийн зарим агуулгаас татгалзаж болох эсэх*: Хуулийн төслийн 23.1.3 дахь хэсэгт үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт оруулах тухай шийдвэр, 23.1.4 дэх хэсэгт холбогдох өөрчлөлт оруулах тухай үүсгэн байгуулагч, эрх бүхий байгууллагын шийдвэр /тогтоол/, хурлын тэмдэглэл, 23.1.5 дахь хэсэгт үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан өөрчлөлтийн баримт бичгийг бүрдүүлэх шаардлага тавигдсан. Баримт бичгийн жагсаалтад 23.1.3 дахь хэсэгт өөрчлөлт оруулах шийдвэр, 23.1.4 дэх хэсэгт үүсгэн байгуулагч, эрх бүхий байгууллагын шийдвэр /тогтоол/ гэж оруулж өгсөн нь мэдээллийн агуулга давхацсан утгыг илэрхийлж байна. Иймд тус мэдээллийн агуулгын ялгаа заагийг тодорхой болгох шаардлагатай.

Нэмэлт зардлыг тооцох

Энэ хэсэгт Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дэх үүргийн улмаас хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардал, ачааллыг тооцоолох явцад гарч болох бусад зардлыг тооцоолно.

Хүснэгт 17. Нэмэлт зардал

Хуулийн этгээдэд үүсэх нэмэлт зардал: Нэрийн баталгаажуулалт хийлгэсэн төлбөр : 500 x 18854 = 9427000 Итгэмжлэл гаргуулсан нотариатын төлбөр: 5000 x 943[29]= 4715000 Өв залгамжлах эрхийн гэрчилгээ нотариатын төлбөр: 5000 x 18854 = 94270000 Тэмдэгтийн хураамж: 10000 x 18854= 188540000 Зар байршуулах: 1000[30]*18854= 18854000 Нэмэлт зардал 9427000+4715000+94270000+188540000+18854000= 315806000 төгрөг байна.					
Нэгж	**Нийт зардал**	**+**	**Нэмэлт зардал**	**=**	**Бүгд**
Хуулийн этгээд	**408151392**	**+**	**315806000**	**=**	**723957392**

Үр дүн, санал

Хуулийн төсөлд тусгасан хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг нэг жилд дунджаар **18854** хуулийн этгээд бүртгүүлж, **723957392** төгрөгийн зардал гаргах төлөвтэй байна. Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулсныг бүртгүүлж буй нэг хуулийн этгээдийн хувьд нэг жилд дунджаар **38,398** төгрөгийн зардал үүсгэх урьдчилсан тооцоо гарч байна.

1.2.3 Хуулийн этгээдийг татан буулгасан тухай улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэхэд үүсэх захиргааны зардал

Хуулийн этгээдийг татан буулгасан тухай улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэхэд үүргийг "Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл"-ийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт заасны дагуу өргөдөл гаргах үүрэг хүлээлгэсэн байна.

[29] Хуулийн төслийн 23.1.6-т шаардлагатай тохиолдолд итгэмжлэл гэж заасныг нийт бүртгүүлсэн хуулийн этгээдийн 5 хувьд нь итгэмжлэл шаардлагатай болсон гэж баримжаалан тооцов.

[30] Өдөр тутмын сонинд үгэн зар байршуулах дундаж ханш 1 үг 100 төгрөгний үнэтэй байна. Зар байршуулахад дундажаар 10 үг орохоор тооцов.

Хүснэгт 18. Хугацаа х Ажлын хөлс = Үйл ажиллагаа тус бүрийн зардал

Үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа (мин)	Ажлын хөлс (төг)	Зардал (төг)
Хуулийн этгээдийг татан буулгах	Хуулийн этгээдийг татан буулгах тухай шийдвэрийг бичгээр мэдэгдэж, татан буулгах тухай шийдвэрийн эх хувийг мэдэгдэлд хавсаргах /24.1/	Албан бичиг боловсруулах	10	82	820
		Мэдээлэл шил жүүлэх нийтлэх	2	82	164
		Шууданд хийх	5	82	410
	баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл /25.1.1/	Өргөдөл бичих	7	82	574
	татан буулгах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр /25.1.2/	Мэдээлэл шилжүүлэх, нийтлэх	2	82	164
	дуусгалтын тайлан /25.1.3/	Мэдээлэл цуглуулах	30	82	2460
	улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт /25.1.4/	Мөнгө шилжүүлэх	8	82	656
	татварын байцаагчийн акт, тодорхойлолт /25.1.5/	Мэдээлэл шилжүүлэх, нийтлэх	2	82	164
	өртэй эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын лавлагаа /25.1.6./	Мэдээлэл шилжүүлэх, нийтлэх	15	82	1230
	татан буулгасан тухай өдөр тутмын сонинд зарлуулсан зар /25.1.7/	Зар захиалах	10	82	820
	ХЭ-ийг дампуурсанд тооцсон, хуулийг удаа дараа буюу ноцтой зөрчсөн, эсхүл хуульд заасан бусад үндэслэлээр татан буулгасан тухай шүүхийн шийдвэрийг энэ хуулийн 24.1-д заасан хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад ирүүлнэ. /25.3/	Мэдээлэл шилжүүлэх нийтлэх	2	82	1640
		Шууданд хийх	5	82	1640

Тоон үзүүлэлтийг тооцох

Тоон үзүүлэлт нь хуулийн төсөлд тусгасан үүрэг хичнээн хуулийн этгээдэд, нэг жилд хэдэн удаагийн давтамжтайгаар үүрэг хүлээлгэж байгааг илэрхийлнэ. Тоон үзүүлэлтийг тооцохдоо тохиолдлыг тоог давтамжийн тоогоор үржүүлнэ.

Тоон үзүүлэлтийг тооцохдоо дараах хүчин зүйлийг тооцов. Үүнд:

3. Тухайн үүргийг хүлээх хуулийн этгээдийн тоо (Тохиолдлын тоо);
4. Тухайн үүргийг жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо (Давтамжийн тоо);

Хүснэгт 19 . Татан буугдсан хуулийн этгээдийн тоо[31]

	Тохиолдол	2013 онд	2014 онд	2015 онд	2016 онд	Тохиолдлын тоо
1.	Татан буугдаж улсын бүртгэлээс хасагдсан	426	583	4595	3052	2164

Давтамжийн тоо: Хуулийн төсөлд хуулийн этгээдийн зүгээс мэдээлэл хүргүүлж байх хугацааг заагаагүй, харин тухай бүр гаргаж байхаар зохицуулсан тул давтамжийг 1 гэж авсан болно.

[31] ОӨУБЕГ, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын 2012-2016 оны статистик мэдээ.

Хүснэгт 20 . Тоон үзүүлэлт = Тохиолдлын тоо х Давтамж

Үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Тохиолдлын тоо	Давтамж	Тоон үзүүлэлт
Хуулийн этгээдийг татан буулгасан тухай улсын бүртгэлийн байгуул лагад мэдэгдэх	Хуулийн этгээдийг татан буулгах тухай шийдвэрийг бичгээр мэдэгдэж, татан буулгах тухай шийдвэрийн эх хувийг мэдэгдэлд хавсаргах /24.1/	2164	1	2164
	баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл /25.1.1/	2164	1	2164
	татан буулгах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр /25.1.2/	2164	1	2164
	дуусгалтын тайлан /25.1.3/	2164	1	2164
	улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт /25.1.4/	2164	1	2164
	татварын байцаагчийн акт, тодорхойлолт /25.1.5/	2164	1	2164
	25.1.6.өртэй эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын лавлагаа	2164	1	2164
	татан буулгасан тухай өдөр тутмын сонинд зарлуулсан зар /25.1.7/	2164	1	2164
	Хуулийн этгээдийг дампуурсанд тооцсон, хуулийг удаа дараа буюу ноцтой зөрчсөн, эсхүл хуульд заасан бусад үндэслэлээр татан буулгасан тухай шүүхийн шийдвэрийг энэ хуулийн 24.1-д заасан хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад ирүүлнэ. /25.3/	2164	1	2164

Хуулийн этгээдэд үүсэх нийт захиргааны зардлын дүнг тооцох

Энэ хэсэгт өмнөх шатанд тооцож гаргасан стандарт үйл ажиллагаа тус бүрийг гүйцэтгэхтэй холбогдон гарах зардлын тооцоо болон тоон үзүүлэлтийг хооронд нь үржүүлж нийт захиргааны зардлын дүнг гаргана.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Хүснэгт 21 . Нийт зардал =
Стандарт үйл ажиллагааны зардал х Тоон үзүүлэлт

Үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зардал (төг)	Тоон үзүүлэлт	Нийт зардал
Хуулийн этгээ-дийг татан буулгах	Хуулийн этгээдийг татан буулгах тухай шийдвэрийг бичгээр мэдэгдэж, татан буулгах тухай шийдвэрийн эх хувийг мэдэгдэлд хавсаргах /24.1/	Албан бичиг боловсруулах	820	2164	1774480
		Мэдээлэл шил жүүлэх нийтлэх	164	2164	354896
		Шууданд хийх	410	2164	887240
	баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл /25.1.1/	Өргөдөл бичих	574	2164	887240
	татан буулгах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр /25.1.2/	Мэдээлэл шилжүүлэх нийтлэх	164	2164	1242136
	дуусгалтын тайлан /25.1.3/	Мэдээлэл цуглуулах	2460	2164	5323440
	улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт /25.1.4/	Мөнгө шилжүүлэх	656	2164	1419584
	татварын байцаагчийн акт, тодорхойлолт /25.1.5/	Мэдээлэл шил жүүлэх, нийтлэх	164	2164	354896
	өртэй эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын лавлагаа /25.1.6/	Мэдээлэл шилжүүлэх, нийтлэх	1230	2164	2661720
	татан буулгасан тухай өдөр тутмын сонинд зарлуулсан зар /25.1.7/	Зар захиалах	820	2164	1774480
	Хуулийн этгээдийг дампуурсанд тооцсон, хуулийг удаа дараа буюу ноцтой зөрчсөн, эсхүл хуульд заасан бусад үндэслэлээр татан буулгасан тухай шүүхийн шийдвэрийг энэ хуулийн 24.1-д заасан хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад ирүүлнэ. /25.3/	Мэдээлэл шилжүүлэх нийтлэх	1640	2164	3548960
		Шууданд хийх	1640	2164	3548960
Нийт зардал					**408151392**

Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах

Энэ хэсэгт тодорхой шалгах асуултын дагуу зардлыг нь тооцсон үүрэг нэг бүрийн зардлыг бууруулах, аж ахуйн салбарт үүсгэх дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгалаа. Шалгуурууд:

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

- *Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх:* Хуулийн этгээдийн цахим бүртгэлийн системд татан буугдсан хуулийн этгээдийн мэдээллийг хүлээн авах цэс байршаагүй байна. Хуулийн төслийн 24.1 дэх хэсэгт Хуулийн этгээдийг татан буулгах тухай шийдвэрийг бичгээр мэдэгдэж, татан буулгах тухай шийдвэрийн эх хувийг мэдэгдэлд хавсаргах үүргийг хуулийн этгээдэд хүлээлгэсэн тул мэдээллийг цахим хэлбэрээр хүргүүлэх боломжгүй.
- *Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх:* Татан буугдсан хуулийн этгээд бүр улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэх үүрэгтэй байна. 1 жилд татан буугдах хуулийн этгээдийн тоо тогтмол биш бөгөөд жилд дундажаар 2164 хуулийн этгээд татан буугддаг байна. Энэ тохиолдолд хамрагдах хуулийн этгээдийн тоо тухайн жилээс хамааран тооцоололд ашигласан дундажаас багасах эсвэл нэмэгдэх боломжтой.
- *Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж бий эсэх:* Хуулийн төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт заасны дагуу хуулийн этгээдийг татан буулгах тухай шийдвэр гаргасан эрх бүхий этгээд ажлын гурван өдрийн дотор холбогдох улсын бүртгэлийн байгууллагад бичгээр мэдэгдэж, татан буулгах тухай шийдвэрийн эх хувийг мэдэгдэлд хавсаргах үүрэгтэй. Энэ үүрэг нь татан буугдсан тухай мэдэгдэх буюу 1 удаа хийгдэх үйл ажиллагаа юм. Энэ тохиолдолд мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломжгүй юм.
- *Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх:* Хуулийн этгээд татан буугдсан тухай мэдэгдэхдээ төрийн бусад байгууллагаас дараах мэдээллийг бүрдүүлэх шаардлагатай байна. Үүнд: татварын байцаагчийн акт, тодорхойлолт /25.1.5/, өртэй эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын лавлагаа /25.1.6/ зэрэг болно. Төрийн мэдээллийн нэгдсэн санд ОӨУБЕГ, ТЕГ, ШШГЕГ цахим үйлчилгээний хүрээнд байгууллагууд нэгдэж мэдээллийг хурдан шуурхай солилцох боломжийг судлах шаардлагатай. Энэ нь бусад төрийн байгууллагатай харилцахад шаардагдах зардлыг багасгах боломжтой.
- *Мэдээллийн зарим агуулгаас татгалзаж болох эсэх*: Хуулийн этгээдийг татан буулгах тухай мэдэгдэхдээ хуулийн этгээдийн зүгээс 6 мэдээллийн агуулгаар баримт бичиг бүрдүүлэх үүрэгтэй байна. Мөн энэ тохиолдолд татан буугдсан хуулийн этгээдийн бүрдүүлэх мэдээллийн агуулгад татгалзах мэдээлэл тусгагдаагүй гэж үзлээ.

Нэмэлт зардлыг тооцох

Энэ хэсэгт Хуулийн төсөлд заасан үүргийн улмаас хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардал, ачааллыг тооцоолох явцад гарч болох бусад зардлыг тооцоолно.

Хүснэгт 21 . Нэмэлт зардал

Хуулийн этгээдэд үүсэх нэмэлт зардал:					
Улсын эмдэгтийн хураамж:		10000 х 1640= 16400000			
Зар байршуулах:		1000*1640= 8200000			
Нэмэлт зардал		16400000+8200000= 24600000 төгрөг байна.			
Нэгж	**Нийт зардал**	**+**	**Нэмэлт зардал**	**=**	**Бүгд**
Хуулийн этгээд	**408151392**	**+**	**24600000**	**=**	**432751392**

Үр дүн, санал

Хуулийн төсөлд тусгасан хуулийн этгээдийг татан буулгасан тухай улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэх үүргийг нэг жилд дунджаар 2164 хуулийн этгээд хэрэгжүүлж , нийт **432751392** төгрөгийн зардал гаргах төлөвтэй байна. Үүнээс харахад хуулийн этгээдийг татан буулгасан тухай улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэж буй тохиолдол тус бүр дунджаар **199977** төгрөгийн зардал үүсгэх урьдчилсан тооцоо гарч байна.

ХОЁР. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫГ СТАНДАРТ ЗАРДЛЫН ЗАГВАРААР ТООЦООЛОХ

Энэ бүлэгт “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-ийн төрийн захиргааны байгууллагад үүрэг оногдуулсан зохицуулалтууд нь тухайн байгууллагад буюу төрд хэдий хэр ачаалал, зардал үүсгэх магадлалтайг баримжаалан тооцоолох зорилготой. Захиргааны байгууллагад үүсэх ачаалал, зардлын хэмжээг урьдчилан тооцох нь тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх төсөв, санхүүжилтийн хэмжээ, хэрэгцээ, шаардлагыг тогтоох, мөн хуулийн зохицуулалтын хэрэгжих боломжийг тодорхойлоход нөлөөлөх хүчин зүйлийн нэг юм.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийг хөтлөх төрийн захиргааны байгууллагад буюу улсын төсөвт үүсэх зардлыг урьдчилсан байдлаар тооцоолох ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан аргачлалын дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ. Үүнд:

1. Улсын бүртгэлийн байгууллагад хүлээлгэсэн үүрэг буюу ажил үйлчилгээг тодорхойлох;
2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;
3. Гарах зардлыг урьдчилан тооцоолох;
4. Зардлыг нэгтгэн тооцох;
5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

2.1 Улсын бүртгэлийн байгууллагад хүлээлгэсэн үүрэг буюу ажил үйлчилгээг тодорхойлох

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 8, 9, 10, 12, 14, 17, 18, 22, 24, 26 дугаар зүйлд Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, төрийн захиргааны байгууллагын дарга болон улсын бүртгэлийн байгууллагад үүрэг оногдуулсан зохицуулалт орсон байна./ Хавсралт №1/. Үүнээс харахад энэ чиг үүргийг хэрэгжүүлэх явцад Хууль зүй, дотоод хэргийн яам, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар /цаашид ОӨУБЕГ гэх/ болон Хуулийн этгээдийн бүртгэлийн газар /цаашид ХЭБГ гэх/ хуулиар тогтоосон үүрэг хүлээж байна. /Хавсралт №2/

Иймд хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой гол үйл ажиллагаа явуулах төрийн захиргааны байгууллага буюу ХЭБГ-т үүрэг хүлээлгэсэн зохицуулалттай холбогдон үүсэх магадлалтай зардлыг урьдчилан тооцох болно.

Уг хуулийн төсөлд тусгаснаар хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагад:

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nji.gov.mn

- Хуулийн этгээдийг шинээр бүртгэх;
- Хуулийн этгээдийн хувийн хэргийг хөтлөх;
- Хуулийн этгээдэд нэр, тамга, тэмдэг, баталгааны тэмдгийн хяналтын дугаарыг олгох, хүчингүй болгох, лавлагаа олгох;
- Хуулийн этгээдийн нэрийн сан хөтлөх, түүнээс лавлагаа олгох;
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулах;
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлээс хасах;
- Цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлэх зэрэг хэд хэдэн үүргийг хүлээлгэсэн байна.

2.2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;

"Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл"-д бүртгэлийн байгууллагад хүлээлгэсэн үүрэг тус бүрийг гүйцэтгэхэд зайлшгүй явуулах шаардлагатай үйл ажиллагаа буюу ажил үйлчилгээ тус бүрийг стандарт үйл ажиллагааны загварын дагуу тооцож эдгээрт ямар цаг хугацаа зарцуулах хэрэгцээтэй болохыг тогтоох юм. Хугацааг тодорхойлсноор тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох бөгөөд улмаар улсын төсөвт хүний нөөцтэй холбоотой ямар хэмжээний зардал үүсэхийг урьдчилан тооцох боломжтой.

Хүний нөөцийн хэрэгцээг тооцохдоо тухайн ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хугацаа болон 1 жилд гүйцэтгэх тохиолдлын тоогоор баримжаална.

Ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хугацааг тогтохдоо стандарт үйл ажиллагаанд зарцуулах хугацааг тогтоосон загварт үндэслэх, хэрэв ийм загвар байхгүй бол өөрсдийн судалгаа, туршлагад тулгуурлан шинээр боловсруулах боломжтой. Одоогоор манай улс өөрийн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа, ачааллын онцлог нөхцөл байдалд тохирсон стандарт үйл ажиллагаа болон түүнд шаардагдах хугацааг нэгдсэн байдлаар тогтоогоогүй байна. Иймд судалгааны ажлын хүрээнд ОӨУБЕГ –ыг Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын улсын бүртгэгч нараас авсан мэдээлэл болон ажлын байрны ажиглалтад түшиглэн стандарт үйл ажиллагааны хугацааг тогтоосон болно.

ХЭБГ-аас үзүүлж буй үйлчилгээний төрөл, тоо өндөр байгаатай холбогдуулан үйлчилгээний төрөл тус бүрээр нь хугацааг тооцох нь зүйтэй гэж үзлээ.

2.2.1 Шинээр үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийг бүртгэх

"Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл"-ийн 4 дүгээр бүлэгт шинээр байгуулсан хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэхтэй холбоотой зохицуулалт орсон байна.

Хүснэгт №1 Шинээр бүртгэсэн хуулийн этгээдийн тохиолдлын тоо

Тохиолдол		2013 онд	2014 онд	2015 онд	2016 онд	Жилийн дундаж
Улсын бүртгэлд бүртгэгдсэн нийт хуулийн этгээд		**15998**	**17323**	**14532**	**14001**	**15463.5**
Хувьцаат компани		2	4	1	3	**2.5**
Хязгаарлагдмал хариуцлагатай компани		12335	13003	10934	10140	**11603**
Үүнээс	Гадаадын хөрөнгө оруулалттай	-	8924	287	268	**2369.75**
Төрийн бус байгууллага		2051	2487	2304	2393	**2308.75**

Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар		8	3	9	3	**5.75**
Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар		32	65	22	16	**33.75**
Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар		172	166	142	220	**175**
Нөхөрлөл		343	311	349	287	**322.5**
Үүнээс	Гадаадын хөрөнгө оруулалттай	-	2	2	2	
Хоршоо		644	336	234	103	**329.25**
Хадгаламж, зээлийн хоршоо		-	411	30	42	**161**
Сан		129	153	183	153	**120.75**
Үйлдвэрчний эвлэлийн байгууллага		138	219	178	147	**170.5**
Шашны байгууллага		19	26	39	50	**33.5**
Хэвлэл мэдээллийн байгууллага		125	139	107	93	**116**
Боловсрол, сургалтын байгууллага		-	-	-	349	**349**
Эрдэм шинжилгээний байгууллага		-	-	-	2	**2**

Дээрх хүснэгтээс харахад жилд дунджаар **15463.5** хуулийн этгээд шинээр бүртгүүлдэг бөгөөд үүнийг тохиолдлын тоо болгон авлаа. Стандарт үйл ажиллагаанд зарцуулах хугацааг тохиолдлын тоогоор үржүүлэх замаар тухайн үйл ажиллгааг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тогтоодог.

Хуулийн этгээдийг бүртгэх үйл ажиллагаанд хуулийн этгээдийн төрлөөс хамааран бүрдүүлэх, хянах шаардлагатай баримт бичгийн тоо харилцан адилгүй байгаа нь бүртгэлийн байгууллагын албан хаагчийн ажлын ачаалал, зарцуулах цаг хугацаанд нөлөөлөх нь зүйн хэрэг юм. Гэхдээ энэхүү загвар зардлын тооцоонд хуулийн этгээдийн төрөл түс бүрийн бүртгэлд зарцуулах хугацааг нэгдмэл байдлаар тооцож, стандарт ажиллагаанд шаардагдах хугацааг дундажлан тогтоосон болно.

Хүснэгт №2 Хуулийн этгээдийг шинээр бүртгэх стандарт үйл ажиллагаа, хугацаа

Бүртгэлийн байгууллагын гүйцэтгэх үүрэг	**Стандарт үйл ажиллагаа**	**Зарцуулах хугацаа /Минут/**	**Тохиолдлын тоо**	**Хүний нөөцийн хэрэгцээ/ минут**
Хуулийн этгээдийг шинээр бүртгэх	Материал хүлээж авах	5	15463.5	77317.5
	Мэдээллийг хянах, шаардлагатай баримт бичгийн бүрдлийг хянах[32]	10	15463.5	154635
	Материал хүлээн авах эсэхийг шийдвэрлэх	3	15463.5	46390.5
	Зөвлөгөө өгөх[33]	10	15463.5	154635
	Бүртгэх эсэх талаар шийдвэр гаргах[34]	30	15463.5	463905
	Цахим санд оруулах	30	15463.5	463905
	Бүртгэлийн баримт олгох	3	15463.5	46390.5
	Хуулийн этгээдийг бүртгэсэн, эсхүл бүртгэхээс татгалзсан талаар мэдээлэх /бичгээр+цахимаар	6	15463.5	92781
Нийт		**97**	**15463.5**	**1499960**

Үүнээс харахад хуулийн этгээдийг шинээр бүртгэхэд жилд дунджаар **1499960** минут буюу **24999.33 ажлын цаг** шаардагдах байна.

Хуулийн этгээдийг шинээр бүртгэхэд нэг жилд дунджаар **24999.33 ажлын цаг** шаардлагатай бөгөөд нэг албан хаагч 200 ажлын өдөр буюу 1600 цаг ажилладаг

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

гэж үзвэл: 24999.33 ажлын цаг / 1600 цаг = **15.6 хүний нөөцийн хэрэгцээ** буюу орон тоо шаардлагатай.

2.2.2 Хуулийн этгээдийг бүртгэхээс татгалзах

Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг болон 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзах тухай зохицуулалт байна.

ОӨУБЕГ-аас хуулийн этгээдийг бүртгэхээс болон мэдээлэлд өөрчлөлт оруулахаас татгалзсан тохиолдлын тооны тухайд тусгайлсан статистик мэдээ гаргадаггүй. Харин ХЭБГ журнал хөтөлдөг бөгөөд үүнээс харахад 1 улсын бүртгэгч 1 сард дунджаар 20 орчим татгалзсан хариу гаргаж, түүнд холбогдох хууль тогтоомжийг судалсны үндсэн дээр үндэслэл хэсгийг боловсруулдаг байна. Иймд 1 улсын бүртгэгч 1 сард дунджаар 20 татгалзсан хариу өгдөг гэж үзэн түүнийгээ 12 сар болон 10-н улсын бүртгэгчийн тоогоор үржүүлснээр 1 жилд дунджаар 2460 татгалзсан хариу өгдөг гэсэн тохиолдлын тоог гаргаж авлаа.

Хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзах тохиолдолд бүртгэлийн байгууллага дараах стандарт үйл ажиллагааг хийдэг байна:

Хүснэгт №3. Хуулийн этгээдийг бүртгэхээс татгалзах стандарт үйл ажиллагаа, хугацаа

Бүртгэлийн байгууллагын гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /Минут/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ/ минут
Хуулийн этгээдийг шинээр бүртгэх	Материал хүлээж авах	2	2460	4920
	Мэдээллийг хянах, шаардлагатай баримт бичгийн бүрдлийг хянах[35]	10	2460	24600
	Материал хүлээн авах эсэхийг шийдвэрлэх	3	2460	7380
	Бүртгэх эсэх талаар шийдвэр гаргах[36]	30	2460	73800
	Бүртгэлийн баримт олгох	3	2460	7380
	Хуулийн этгээдийг бүртгэхээс татгалзсан хариуг үндэслэлийн хамт мэдээлэх	60	2460	147600
	Хуулбарлах	**3**	2460	7380
	Нийт	**111**		**273060**

Үүнээс харахад хуулийн этгээдийг бүртгэхээс татгалзах хариу өгөхөд жилд дунджаар **273060** минут буюу **4551 ажлын цаг** шаардагдах ба энэ нь **2,8 хүний нөөцийн хэрэгцээг** илэрхийлж байна

2.2.3 Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэх

Хуулийн төслийн 10 дугаар зүйл, 11 дүгээр зүйл болон 23 дугаар зүйлд хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэх тухай зохицуулалт орсон.

Хуулийн этгээдийн бүртгэлийн газар нь 2013-2016 оны статистик мэдээнээс харахад нэг жилд дунджаар 18854,5 өөрчлөлт оруулсан байна. Иймд хуулийн этгээдийн хувийн хэрэгт буй мэдээлэлд өөрчлөлт оруулсан тохиолдлын тоог дунджаар 18854,5 гэж авсан болно.

Хууль зүйн яамны Нийгэм эдийн засгийн хөгжлийн судалгааны төв www.nisec.mn

Хүснэгт №4. Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэсэн тохиолдлын тоо

Тохиолдол	2013 онд	2014 онд	2015 онд	2016 онд	Жилийн дундаж тохиолдлын тоо
Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэсэн	20979	20655	16506	17278	**18854.5**

Мэдээлэлд өөрчлөлт оруулахад шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг дараах байдлаар тооцлоо:

Хүснэгт №5. ХЭ-ийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэх стандарт үйл ажиллагаа, хугацаа

Бүртгэлийн байгууллагын гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /Минут/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /минут
Хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт оруулах	Материал хүлээж авах	2	18854.5	37709
	Хуулийн этгээдийн хувийн хэргийг архиваас захиалж авах	30	18854.5	565635
	Өөрчлөлтийг хянах, шалгах	10	18854.5	188545
	Гэрчилгээнд тэмдэглэгээ хийх	10	18854.5	188545
	Цахим санд оруулах[39]	10	18854.5	188545
	Өргөдөл гаргагчид өөрчлөлтийг бүртгэсэн бүртгэлийн баримт олгох	3	18854.5	56563.5
	Нийт	**65**		**1225543**

Үүнээс харахад хуулийн этгээдийн хувийн хэрэг дэх мэдээлэлд 18854,5 тохиолдолд өөрчлөлт оруулахад 1225543 минут буюу 20425.71 цаг шаардлагатай байна. Энэ нь 12.7 хүний нөөцийн хэрэгцээг байгааг харуулж байна.

2.2.4 Хуулийн этгээдийн хувийн хэрэг хөтлөх, Хуулийн этгээдэд нэр, тамга, тэмдэг, баталгааны тэмдгийн хяналтын дугаарыг олгох, хүчингүй болгох, лавлагаа олгох болон Хуулийн этгээдийн нэрийн сан хөтлөх, түүнээс лавлагаа олгох

Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.3, 9.1.4[32], 9.1.5, 9.1.8 дахь хэсэг болон 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт, 12 дугаар зүйлийн 12.2 , 12.2.1, 12.3 дахь хэсэг болон 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэгт хуулийн этгээдийн бүртгэл, лавлагаатай холбоотой зохицуулалт орсон.

Монгол Улсын Статистикийн мэдээллийн нэгдсэн санд байршуулсан мэдээллээс харахад 2016 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 166134 хуулийн этгээд бүртгэлтэй байна.[33] Үүнийг тохиолдлын тоо болгон авав.

Хүснэгт №6. Хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт хийсэн тохиолдлын тоо

Тохиолдол	2013 онд	2014 онд	2015 онд	2016 онд	Жилийн дундаж тохиолдлын тоо
Хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт хийсэн	-	-	-	187280	**187280**
Тамга, тэмдгийн хяналт, лавлагаа	-	-	16964	19270	**18117**

Хуулийн этгээдийн хувийн хэрэг хөтлөх тохиолдлын тоог улсын хэмжээнд

[32] Хуулийн этгээдийн хувийн хэргээс лавлагаа олгох ажил үйлчилгээг Хуулийн этгээдийн бүртгэлийн газар хариуцдаагүй, харин Улсын бүртгэлийн төв архив хариуцдаг тул энэ ажил үйлчилгээтэй холбоотой зардлыг тусгаагүй болно.

[33] ОӨУБЕГ-ын захиргааны статистикийн мэдээлэл /2016 оны 10 дугаар сар/. Эх сурвалж: http://burtgel.gov.mn/index.php/news/statistical-rating-item. Сүүлд нэвтэрсэн 2017.03.10

[34] Хүснэгт №5. ХЭ-ийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэх стандарт үйл ажиллагаа, хугацаа

шинээр бүртгүүлж буй хуулийн этгээдийн тоогоор буюу **15463.5** байхаар, хуулийн этгээдэд нэр, тамга, тэмдэг, баталгааны тэмдгийн хяналтын дугаарыг олгох, хүчингүй болгох, лавлагаа олгосон тохиолдлын тоог дунджаар **18117** байхаар, хуулийн этгээдийн нэрийн сан хөтлөх тоог улсын хэмжээнд бүртгэлтэй хуулийн этгээдийн тоогоор **166134** байхаар, түүнээс лавлагаа олгох үйл ажиллагааны тохиолдлын тоог давхардсан тоогоор, дунджаар 187280 байхаар тус тус тооцов.

Хүснэгт №7. ХЭ-ийн мэдээллийн сан хөтлөх, лавлагаа олгох стандарт үйл ажиллагаа, хугацаа

Бүртгэлийн байгууллагын гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /Минут/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /минут/
Хуулийн этгээдийн хувийн хэрэг хөтлөх	Хуулийн этгээдийн хувийн хэрэгт орох материалыг хянах	15	15463.5	231952.5
	Хуулбарлах	2	15463.5	30927
	Цахим санд оруулах[39]	20	15463.5	309270
	Бичгийн хэлбэрээр хадгалах	10	15463.5	154635
	Нийт	**47**		**726784.5**
Тамга, тэмдэг, баталгааны тэмдгийн хяналтын дугаарыг олгох, хүчингүй болгох, лавлагаа олгох	Хүсэлттэй танилцах	1	18117	18117
	Програмаас хайлт хийх[22]	2	18117	36234
	Лавлагаа олгосныг бүртгэх	2	18117	36234
	Нийт	**5**		**90585**
Хуулийн этгээдийн нэрийн сан хөтлөх	Хүсэлттэй танилцах	1	15463.5	15463.5
	Хуулийн этгээдийн нэрийн санд мэдээлэл оруулах	5	15463.5	77317.5
	Нэрийн баталгаажуулалтын хуудас олгох	2	15463.5	30927
	Цахим санд оруулах	2	15463.5	30927
	Нийт	**10**		**154635**
Нэрийн сангаас лавлагаа олгох	Хүсэлт хүлээж авах	1	187280	187280
	Хураамж авах	2	187280	374560
	Лавлагаа олгох	2	187280	374560
	Нийт	**5**		**936400**

Үүнээс харахад хуулийн этгээдийн хувийн хэрэг хөтлөх, хуулийн этгээдэд нэр, тамга, тэмдэг, баталгааны тэмдгийн хяналтын дугаарыг олгох, хүчингүй болгох, лавлагаа олгох болон хуулийн этгээдийн нэрийн сан хөтлөх, түүнээс лавлагаа олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нийт **1908405 минут буюу 31806.74** цаг шаардлагатай. Энэ нь **19.8** х**үний нөөцийн хэрэгцээ** бий болохыг илэрхийлж байна.

2.2.5 Хуулийн этгээдийн улсын бүртгэлээс хасах, хуулийн этгээдийн бүртгэлд хориг тавих, цуцлах үйл ажиллагаа

Хуулийн төслийн 22 дугаар зүйлд хуулийн этгээдийг бүртгэлээс хасах тухай зохицуулалт орсон байна. ХЭБГ-ын статистик мэдээнд үндэслэн дараах тохиолдлын тоог тоймлон авч болох байна.

[35] Одоо цахим санд оруулдаггүй. Шинэ зохицуулалтаар нэмэгдэх ажил үйлчилгээний төрөл.

Хүснэгт №8. ХЭ-ийг бүртгэлээс хасах, хориг тавих, цуцлах үйл ажиллагааны тохиолдлын тоо

Тохиолдол	2013 онд	2014 онд	2015 онд	2016 онд	Жилийн дундаж тохиолдлын тоо
Хуулийн этгээдийн бүртгэлд хориг тавих, цуцлах	561	600	873	1708	**935.5**
Татан буугдаж улсын бүртгэлээс хасагдсан	426	583	4595	3052	**2164**
Улсын бүртгэлээс хасагдсан гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар	98	10	7	-	**28.75**

Хуулийн этгээдийн улсын бүртгэлээс хасах, хуулийн этгээдийн бүртгэлд хориг тавих, цуцлах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацааг дараах байдлаар тооцов.

Хүснэгт №9. ХЭ-ийг бүртгэлээс хасах, хориг тавих, цуцлах стандарт үйл ажиллагаа, хугацаа

Бүртгэлийн байгууллагын гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /Минут/	Тохиолд-лын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ/ минут
Хуулийн этгээдийн улсын бүртгэлээс хасах	Материал хүлээж авах	2	2192.75	4385.5
	Хуулийн этгээдийн хувийн хэрэгт орох материалыг хянах	15	2192.75	32891.25
	Хувийн хэргийг архиваас захиалах	30	2192.75	65782.5
	Цахим санд оруулах	10	2192.75	21927.5
	Бичгийн хэлбэрээр хадгалах/архивт	20	2192.75	43855
	Эрх бүхий этгээдэд мэдээлэх	5	2192.75	10963.75
	Нийт	**82**		**179805.5**
Хуулийн этгээдийн бүртгэлд хориг тавих, цуцлах	Хүсэлттэй танилцах	1	935.5	935.5
	Хувийн хэргийг архиваас захиалах	30	935.5	28065
	Хуулийн этгээдийн хувийн хэрэгт оруулах мэдээллийг хянах	5	935.5	4677.5
	Хуулийн этгээдийн бүртгэлд мэдээлэл оруулах, тэмдэглэгээ хийх	5	935.5	4677.5
	Хориг тавих/хориг цуцлах тухай эрх бүхий этгээдэд мэдээлэх	5	935.5	4677.5
	Нийт	**46**		**43033**

Үүнээс харахад хуулийн этгээдийн улсын бүртгэлээс хасах, хуулийн этгээдийн бүртгэлд хориг тавих, цуцлах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ажил үйлчилгээнд **222838.5 минут буюу 3713.975 цаг** шаардлагатай байна. Энэ нь **2.3 хүний нөөцийн** хэрэгцээ байгааг харуулж байна.

2.2.6 Нийт хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох

Хуулийн төсөлд тусгасан зохицуулалтаар ХЭБГ-т хүлээлгэсэн үүргийг хэрэгжүүлэхэд тухайн байгууллагад хэдий хэр хүний нөөцийн хэрэгцээ үүсэх магадлалтайг ажил үйлчилгээний төрөл тус бүрээр урьдчилан тооцож үзлээ.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Хүснэгт №10 Хүний нөөцийн нийт хэрэгцээ

Ажил үйлчилгээ	Хүний нөөцийн хэрэгцээ
Хуулийн этгээдийг шинээр бүртгэх	15,6
Хуулийн этгээдийг бүртгэхээс татгалзах	2,8
Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэх	12,7
Хуулийн этгээдийн мэдээллийн сан хөтлөх, лавлагаа олгох	19,8
Хуулийн этгээдийг бүртгэлээс хасах, бүртгэлд хориг тавих,цуцлах	2,3
Нийт хүний нөөцийн хэрэгцээ	**53.2**

ОӨУБЕГ-ын ХЭБГ нь 2017 оны 3 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд нийт 42 албан хаагчтай үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс газрын дарга 1, ахлах улсын бүртгэгч 2, улсын бүртгэгч 17, орон нутгийн улсын бүртгэгч 21, гэрээт ажилтан 1 тус тус байна. Улсын хэмжээнд нэг жилд дунджаар 15463 гаруй хуулийн этгээд шинээр бүртгүүлэх, 18850 гаруй өөрчлөлт оруулах хүсэлт хүлээж авч, шийдвэрлэж байгаагийн 70 гаруй %-ийг нийслэл дэх бүртгэлийн газрын улсын бүртгэгчид гүйцэтгэж байгаа нь албан хаагчдын ажлын ачаалал харилцан адилгүй байгааг харуулж байна.

Хуулийн төслөөр тус байгууллагад шинээр үүрэг болгож буй хуулийн этгээдийн талаарх мэдээллийг цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлэх үйл ажиллагаа, цахим хэлбэрээр хуулийн этгээдийг бүртгэх үйл ажиллагаа нь одоогоор бүрэн хэрэгжиж эхлээгүй байна. Энэ нь уг үйл ажиллагааг гүйцэтгэх програм хангамж байхгүйтэй холбоотой юм.

2.3 Гарах зардлыг урьдчилан тооцох

Төрийн захиргааны байгууллагад буюу төрөөс гарах зардлыг урьдчилан тооцох үе шатанд:

- Хүний нөөцийн зардал /төрийн албан хаагчтай холбоотой шууд болон шууд бусаар үүсэх зардал/
- Материаллаг зардал /төрийн албан хаагчийн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардал/
- Бусад зардал /тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд дагалдан гарах зардал/-ыг тооцож гаргана.

2.3.1 Хүний нөөцийн зардал

Хүний нөөцийн зардлыг тооцохдоо тухайн ажил үйлчилгээ буюу үүргийг гүйцэтгэх төрийн захиргааны байгууллагын албан хаагчид зарцуулах цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал зэрэг төрөөс даадаг бүх зардлыг нэгтгэн авч үзэх ба эдгээрийн дундаж хэмжээгээр тооцож тогтооно.

ОӨУБЕГ-ын ХЭБГ нь улсын хэмжээнд нийт 42 албан хаагчтай үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Төрийн захиргааны алба хаагчийн ТЗ10-6 зэрэглэлээр цалинждаг байна. Үүнд:

Хүснэгт №11 Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын албан хаагчдын цалингийн зэрэглэл

№	Албан тушаал	Хариуцах чиглэл	Албан тушаалын зэрэглэл	Албан тушаал эрхлэгчийн тоо
1.	Газрын дарга		ТЗ-10	1
2.	Улсын ахлах бүртгэгч	Бүртгэлийн зохион байгуулалт, хяналт хариуцсан	ТЗ-7	2

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

3.	Улсын бүртгэгч	Хуулийн этгээдийн бүртгэл хариуцсан	ТЗ-6	17[41]
4.	Орон нутгийн бүртгэгч		ТЗ-6	21
5.	Гэрээт ажилтан	Хуулийн этгээдийн бүртгэл хариуцсан	ТЗ-6	1

Хуулийн этгээдийн улсын бүртгэгч нь төрийн захиргааны алба хаагчийн цалингийн ТЗ-6 зэрэглэлд хамаардаг тул “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2014 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 332 дугаар тогтоолийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ”-ний ТЗ-6 зэрэглэлээр дундаж цалингийн хэмжээг тооцож гаргав.

Хүснэгт №12 Цалингийн зэрэглэл. хэмжээ[37]

Албан тушаалын зэрэглэл	1	2	3	4	5	Сарын дундаж цалин
ТЗ-6	547759	580710	613669	645556	677436	613,023 төгрөг

ХЭБГ-ын нэг улсын бүртгэгчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүний үндсэн цалингаас гадна 1/ бүх төрлийн даатгал, 2/ хоол, унааны нэмэгдэл, 3/ ажилласан жилийн нэмэгдэл, 4/ зэрэг дэвийн нэмэгдэл, 5/ буцалтгүй тусламж, 6/ шагнал, урамшуулал[38] зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Эдгээрийн хэмжээг тодорхой тогтоох боломжгүй тохиолдолд нэг албан хаагчийн цалингийн дундаж хэмжээний 15%-иар нийтлэг зардлыг, 10%-иар дагалдах зардлыг, 30%-иар нэмэгдэл, урамшууллын зардлыг тооцох боломжтой юм.

Хүснэгт №13 Нэг албан хаагчид ногдох цалингийн зардал

Зардлын нэр	Цалингийн дундаж хэмжээ	Хувь	Хэмжээ /төгрөг/
Үндсэн цалингийн дундаж хэмжээ	613,023		613,023
Нийтлэг зардал	613,023	15%	91,954
Дагалдах зардал	613,023	10%	61,302
Нэмэгдэл, урамшууллын зардал	613,023	30%	183,908
Нийт			**950,191**

2.3.2 Материаллаг зардал

Материаллаг зардалд тухайн үүргийг гүйцэтгэж буй нэг албан хаагчийг ажиллах нөхцөлөөр хангахад зарцуулж буй зардлыг ойлгоно. Тухайлбал албан хаагчийн ажлын байр, өрөө тасалгаа, техник хэрэгсэл, шаардлагатай бусад зардлыг энд тооцох хэрэгтэй.

ОӨУБЕГ нь улсын хэмжээнд иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээд, оюуны өмчийг бүртгэх, улсын бүртгэлийн төв архивын үйлчилгээ үзүүлэх үндсэн чиг үүргээ нийсэлийн 9 дүүрэг, 152 хороо, 21 аймаг, 330 сум болон гадаад улс дахь 77

[36] Хүснэгт №5. ХЭ-ийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэх стандарт үйл ажиллагаа, хугацаа

[37] Эх сурвалж: http://cita.gov.mn/wp-content/uploads/2015/04/%D0...B9.pdf Сүүлд нэвтэрсэн: 2017.03.10

[38] Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2015 оны үйл ажиллагааны тайланд дурдсанаар “УБЕГ-ын улирлын шилдэг ажилтан шалгаруулах журам”-д заасны дагуу 10 албан хаагчийг шалгаруулж батламж, мөнгөн шагнал, УБЕГ-ын даргын 2015 оны 700, 867, 868 дугаар тушаалаар бүртгэлийн байгууллагын зарим албан хаагчдад зэрэг дэв олгох, цалингийн шатлал ахиулах, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох асуудлыг шийдвэрлэсэн, Улсын их баяр наадмыг тохиолдуулан тус газрын 24 албан хаагчийг төрийн дээд шагналаар, 8 албан хаагчийг “Хууль зүйн албаны тэргүүний ажилтан тэмдэг”-ээр, 12 албан хаагчийг “Улсын бүртгэлийн тэргүүний ажилтан тэмдэг”-ээр, 35 албан хаагчийг “ХЗДХЯ-ны хүндэт жуух бичиг”-ээр 148 албан хаагчийг “Мөнгөн шагнал”-аар шагнахаар тус тус шийдвэрлэсэн байна. Эх сурвалж: http://www.burtgel.gov.mn/images/document/tailan/final_2015. Сүүлд нэвтэрсэн: 2017.03.10

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН www.nli.gov.mn

дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан хэрэгжүүлдэг. Иймд дээрх зардлуудын дийлэнхийг, тухайлбал урсгал зардлыг /халаалт, цэвэр, бохир ус, цахилгаан, урсгал засвар гэх зэрэг/ үйлчилгээний байр тус бүрээр ерөнхий байдлаар гаргадаг тул ХЭБГ-ын 1 бүртгэгчид зарцуулах материаллаг зардлыг нарийвчлан тооцож гаргах боломжгүй байна. Иймд “Хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал”-д жишээ болгон авсан ХЗДХЯ-ны нэг ажилтны материаллаг зардлыг ашиглав.

Хүснэгт №14 Нэг албан хаагчид гарах материаллаг зардал

Зардлын нэр	Зардлын төрөл	Хэмжээ /төгрөг/
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	124,000
	Ном, хэвлэл авах	54,745
	Шуудан холбоо	306,812
	Нийт	**485,557**
Барилга, байгууламж, өрөө тасалгааны зардал	Түлш, халаалт	263,408
	Гэрэл, цахилгаан	128,239
	Цэвэр, бохир ус	599,438
	Урсгал засвар	127,752
	Газрын төлбөр	22,253
	Нийт	**1,141,090**
Элэгдэл, хорогдлын зардал	Техник, тоног төхөөрөмж[44]	160,000
	Тавилга, эд хогшил[45]	100,000
	Барилга, байгууламж[46]	65,670
	Нийт	**325,670**

Дээр тооцсон бүх зардал нийтдээ нэг албан хаагчийн “ажлын байрны дундаж материаллаг зардал”-ыг бүрдүүлэх юм.

Хүснэгт №15 Ажлын байртай холбоотой үүсэх дундаж материаллаг зардал

Материаллаг зардал	Зардлын хэмжээ /төгрөг
Урсгал зардал	485,557
Барилга, байгууламж, өрөө тасалгааны зардал	1,141,090
Элэгдэл, хорогдлын зардал	325,670
Нийт	**1,952,317**

Үүнээс харахад ХЭБГ-ын нэг улсын бүртгэгчид гарах материаллаг зардлын хэмжээ дунджаар **1,952,317** /нэг сая есөн зуун тавин хоёр гурван зуун арван долоо/ төгрөг байна.

2.3.3 Бусад зардал

Бусад зардалд төрийн байгууллагаас тухайн ажил үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой дагалдан гарах зардлыг авч үзнэ. Тухайлбал байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хөндлөнгийн хяналт, шалгалт хийлгэх, тусгайлсан програм хангамж боловсруулах, тендер зарлах гэх зэрэг зардлыг дурдаж болох юм.

Хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг “Хуулийн этгээдийн хувийн хэргийг цахим болон бичгийн хэлбэрээр бүрдүүлэн улсын бүртгэлийн мэдээллийн санд давхар хөтөлнө.” үүргийг хэрэгжүүлэхэд цахим болон цаасан материалыг

[39] Нэг албан хаагчид хэрэглэгдэж буй техник, тоног төхөөрөмжийн үнийг дунджаар 800,000 төгрөгөөр тооцож, түүний элэгдэл хорогдлын хэмжээг ЗГ-ын 2005 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан “Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол тооцох журам, Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлыг тооцоход баримтлах хугацаа”-нд тусгасаар 20% -иар тооцов.

[40] Тавилга, эд хогшлын үнийг дунджаар 1,000,000 төгрөгөөр тооцож, түүний элэгдэл, хорогдлыг ЗГ-ын 2005 оны 233 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад тусгасаар 10%-иар тооцов.

[41] 2013 онд ХЗЯ-наас хийсэн “Хөдлөх эд хөрөнгийн болон түүнтэй холбоотой эрхийн барьцааны тухай хуулийн төслийн үр нөлөөг тооцох судалгааны тайлан”-д дурдсан мэдээллийг ашиглав.

агуулах, түүнийг удирдах програм болон бусад тоног төхөөрөмж, хэрэгсэл нэн даруй шаардлагатай байгаа тухай мэдээллийг ОӨУБЕГ-ын дэд дарга Д.Дэлгэрсайханаас авсан. Мэдээллээс үзэхэд дараах бусад зардал шаардлагатай байна гэж үзлээ.

Програм хангамж, технологийн шинэчлэл хийх тухайд

ОӨУБЕГ-ын 2015 оны ажлын тайланд “Хуулийн этгээдийн бүртгэлийн систем”, “Улсын бүртгэл, мэдээллийг сайжруулах цахим архив” зэрэг төсөл, хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулах, шаардлагатай програмыг шинээр боловсруулах[42] зэрэг ажил хийгдэж байгаа тухай дурдсан ба одоо “Үндэсний ой санамж I. II. III” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа нь дээрх хуулийн заалтыг хэрэгжүүлэх үндэс гэж үзэх боломжтой байна.

Урьдчилсан байдлаар ОӨУБЕГ-ын үйл ажиллагааны төвшинд бүх бүртгэлийг цахим горимд бүрэн шилжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэхэд нийт 9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа бөгөөд үүний 4,5 сая нь програм хангамж, 4,5 тэр бум нь сервер, техник хэрэгсэл авахад шаардлагатай гэсэн урьдчилсан судалгаа гаргасан байдаг.

Өнөөдөр ОӨУБЕГ-ын хэмжээнд нийт 42 програм хэрэглэгддэг. Эдгээрийн ихэнх нь иргэний бүртгэлтэй холбоотой. Хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой тамга, тэмдгийн програм, хуулийн этгээдийн бүртгэлийн програм, нэрийн баталгаажуулалтын програм гэсэн 3 програм хэрэглэж байна. Лицензийн төлбөрийн асуудал хуулийн этгээдийн бүртгэлийн програмын хувьд гардаггүй. Харин ерөнхий газрын хэмжээнд програм хангамжийг ашиглах орчин болж буй үйлдлийн систем, өгөгдлийн сангийн хувьд өртөг өндөртэй лицензийн төлбөр төлдөг.

Хуулийн этгээдийн бүртгэлийг 2005 оноос хөтөлж эхэлсэн бөгөөд 2014 онд БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /КОЙКА/-ын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлсэн “Бүртгэл мэдээллийн цахим архив” төслийн хүрээнд 3,2 сая баримт цахимжсан байна. Одоо 2014 оноос хойш шинээр бүртгүүлсэн болон нэмэлт өөрчлөлт оруулсан 1,7 сая баримт цахимжаагүй хүлээгдэж байна. Иймд дээр дурдсан төслийн хүрээнд цаасан нотлох эх баримтыг цахимжуулах ажлын ихэнх хэсэг хийгдсэн. Харин эдгээр цахим мэдээллийг удирдах буюу хэрэглээнд нэвтрүүлэх, онлайн байршуулах гэсэн дараагийн 2 үе шат хүлээгдэж байна.

Тус байгууллага хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг онлайн горимд шилжүүлж, иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээг ил тод, нээлттэй, шуурхай, хүртээмжтэй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулах бөгөөд 2020 он гэхэд хуулийн этгээдийн бүртгэлийг цахимжуулах ажлыг бүхэлд нь 2 тэрбум төгрөгөөр[43] хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Хуулийн этгээдийн бүртгэл, түүнд холбогдох материалуудыг цахим горимд шилжүүлэхэд их урт хугацаа шаардлагагүй, ойролцоогоор 3 – 4 сарын хугацаанд гүйцэтгэх боломжтой гэх тооцоо гаргасан байна. Учир нь энэ төрлийн мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх туршлага байна, ажлын даалгавар гээд бүх зүйл тодорхой, хийх мэргэжилтэн, хэрэглэх материал гээд суурь нь бэлэн байгаа юм. Зөвхөн санхүүжилтийн асуудал тулгарч байна.

[42] ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2015 оны үйл ажиллагааны тайлан. 27 дугаар нүүр. Эх сурвалж: http://www.burtgel.gov.mn/images/document/tailan/final_2015

[43] Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөний хүрээнд Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас хэрэгцүүлэх төлөвлөгөө Зорилт 4-ийн 9 дэх арга хэмжээ

Өнөөгийн байдлаар улсын бүртгэлийн байгууллага хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой нийт 9 төрлийн лавлагаа мэдээдэл олгож байгаагаас ТҮЦ машинаар "хуулийн этгээдийн лавлагаа" болон "хуулийн этгээдгүй" гэсэн 2 төрлийн лавлагаа өгдөг. 2016 оны байдлаар 5000 гаруй лавлагааг ТҮЦ машинаар авсан байна. Иймд үлдсэн 7 төрлийн лавлагааг цахимаар өгдөг байхын тулд цахим хэлбэрт шилжих шаардлага зайлшгүй тулгарч байна.

Цаасан архивын барилга байгууламжыг сайжруулах тухайд

"Үндэсний ой санамж II" хөтөлбөрийн хүрээнд эх нотлох баримтын хадгалалт, хамгаалалт, байршуулалт, түүнд холбогдох тоног төхөөрөмж, програмыг сайжруулахад 2,8 тэрбум төгрөг шаардлагатай гэсэн судалгаа гаргасан. Өнөөдөр улсын бүртгэлийн архивын барилга 97%-ийн дүүргэлттэй байна. Үлдсэн 3 % нь 3 жилийн нөөц болохоор байгаа нь энэ асуудлыг шуурхай шийдвэрлэх шаардлага байгааг харуулж байна.

Өнөөдөр улсын бүртгэлийн нэгдсэн архивт 90 сая баримт бичиг зориулалтын бус, хадгалалтын горимд нийцэхгүй орчин, нөхцөлд хадгалагдаж байна. Энэ 90 гаруй сая материал бүхий архив нь бүртгэл үүссэн цаг хугацаанаас /иргэний бүртгэл 1940 он, хуулийн этгээдийн бүртгэл 2005 он, эд хөрөнгийн бүртгэл 1997 он, оюуны өмчийн бүртгэл 1990 он/ эхэлж үүссэн баримт бичгийн "амьд архив" буюу байнгын хэрэглээнд байдаг архив юм.

Хөндлөнгийн хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлгэх тухайд

Төрийн байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны цар хүрээнээс хамааран Хөндлөнгийн хяналт, шалгалт хийлгэхэд[44] дунджаар 10 сая төгрөг зарцуулдаг. ОӨБЕГ нь улсын хэмжээнд иргэний, эд хөрөнгийн эрхийн, хуулийн этгээдийн болон оюуны өмчийн гэсэн үндсэн 4 төрлийн бүртгэл хөтөлдөг. Хөндлөнгийн хяналт, шинжилгээ хийлгэх зардлыг бүртгэлийн 4 төрөлд хуваасnаар Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт оногдох зардлыг гаргах боломжтой гэж үзлээ. Үүнээс харахад ХЭБГ-ын үйл ажиллагаанд хийж буй хяналт, шинжилгээнд нэг жилд дунджаар **2,9 сая төгрөг** зарцуулдаг гэж үзэх боломжтой байна.

Дээрх мэдээллүүдээс харахад ХЭБГ "Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл"-д тусгагдсан үүрэг буюу ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд дараах бусад зардал гарах төлөвтэй байна. Үүнд:

Хүснэгт №16 Бусад зардлын хэмжээ

Зардлын нэр	**Зардлын хэмжээ 1 жил/төгрөг**
Хөндлөнгийн хяналт, шинжилгээ, үнэлгээ	2,900,000
Програм хангамж, технологийн шинэчлэл хийх	500,000,000[50]
Цаасан архивын барилга байгууламжыг сайжруулах	175,000,000[51]
Нийт	**677,900,000**

[44] ЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан "Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам", Хууль зүйн сайдын 2014 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан "Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ үнэлгээний аргачлал", Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2011 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу жил бүр байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэх үүрэгтэй.

[45] 2016-2020 онд 2 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа гэх тооцоо гарсан бөгөөд энэ нь 1 жилд 500,000 төгрөгийн санхүүжилт шаардахаар байна.

[46] ОӨУБЕГ-ын архивын барилга, байгууламжийг нөхцөлийг сайжруулахад нийт 2,8 тэрбум төгрөг шөөрдлөгөтэй байгаа бөгөөд үүнийг бүртгэлийн үндсэн 4 төрөлд хуваах үзвэл бүртгэлийн 1 төрөл болох хуулийн этгээдийн бүртгэлийн архивт 700,000,000 төгрөг ногдож байна. Хэрэв үүнийг 4 жилийн хугацаанд санхүүжүүлнэ гэж үзвэл 1 жилд 175,000,000 төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай болохоор байна.

2.3.4 Зардлыг нэгтгэн тооцох

Энэ үе шатанд төрийн захиргааны байгууллагаас буюу төрд үүсэх нийт зардлыг тооцож гаргана. Ингэхдээ хүний нөөцийн зардал, материаллаг зардлын нийлбэрийг хүний нөөцийн хэрэгцээнд үржүүлэн тооцох ба үүн дээр бусад зардлыг нэмснээр нийт зардлын хэмжээ гарах юм.

Хүснэгт №17 Нийт зардлын хэмжээ

Зардлын төрөл	Зардлын хэмжээ	Хүний нөөцийн хэрэгцээ	Нийт зардал
Хүний нөөцийн зардал	950,191	53,2	50,550,161.2
Материаллаг зардал	1,952,317	53,2	103,863,264.4
Бусад зардал	677,900,000	1	677,900,000
Нийт зардал			**832313425.6**

Дээрх хүснэгтээс харахад “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-д тусгасан ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага буюу ОӨУБЕГ-ын ХЭБГ-т нэг жилд дунджаар **832,313,425.6** /найман зуун гучин хоёр сая гурван зуун арван гурван мянга дөрвөн зуун хорин таван/ төгрөгийн зардал үүсэхээр байна. Гэхдээ бусад зардалд хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах, дөрвөн жилийн хугацаанд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн хүрээнд үүсэх зардал буюу програм хангамж боловсруулах, техник, тоног төхөөрөмж худалдан авах зэрэг зардал багтсан байгаа тул хуулийн төслийн зардлын үр нөлөөний судалгааг 4 жилийн дараа дахин хийх шаардлагатай юм.

2.4 Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

Хувилбарыг нягтлах шатанд хуулийн төсөлд шинээр нэмэгдэж байгаа буюу өөрчлөгдөж буй зохицуулалттай холбоотой төрд үүсэх зардлыг хэрхэн багасгах, эдийн засагт дарамт багатай өөр хувилбар боломж байгаа эсэхийг нягталж үзнэ.

Хувилбарыг нягтлах ажлыг дараах шалгуур үзүүлэлтүүдийн дагуу гүйцэтгэнэ:

1. Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх:
2. Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх:
3. Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж бий эсэх:
4. Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх:
5. Мэдээллийн зарим агуулгаас татгалзаж болох эсэх:

- *Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх*: Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд шинээр байгуулагдсан хуулийн этгээдийг бүртгэх, хуулийн этгээдийн бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах болон лавлагаа мэдээлэл олгох үйл ажиллагааг цаасан эх баримтаар олгохын зэрэгцээ цахим хэлбэрээр давхар бүртгэх /хуулийн төслийн 10 дугаар зүйл/ тухай зохицуулалт шинээр нэмэгдэж орсон. Өнөөдрийн байдлаар ХЭБГ-т хэрэгжиж буй цахим хэлбэрээр мэдээлэл олгох ажиллагаа нь “сайжруулсан емэйл” хэлбэрээр буюу үйлчлүүлэгчээс цахимаар ирүүлсэн хүсэлтийг улсын байцаагч нягталж үзсэний дараа хариуг цахимаар хүргүүлэх байдлаар хэрэгжиж байна. Цахим хэлбэрээр хариу олгож буй улсын байцаагч бүртгэлийн байгууллага дээр биеэр ирж үйлчлүүлж буй иргэдэд үйлчилгээ үзүүлэх, бүртгэл хөтлөх ажлын “завсар зай”-гаар цахимаар ирүүлсэн хүсэлтэд хариулж байгаа нь “энэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлснээр үйлчилгээ шуурхай болно” гэх үндсэн зорилгыг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Хуулийн этгээдийн төдийгүй аливаа бүртгэл нь хувь хүний болон албан байгууллагын эд хөрөнгө, эрх ашигтай шууд холбогддог, хэрэг маргаан үүсэх тохиолдолд нотлох баримтаар ашиглагдах зэрэг эрх зүйн чухал ач холбогдолтой нотлох эх баримт бичиг юм. Иймд тэдгээрийг нягтлах, үнэн, бодит байдлыг шалгах зэрэг ажиллагаанд улсын бүртгэгчийн үйл ажиллагаа зайлшгүй шаардлагатай. Учир нь баримт бичгийг хуурамчаар үйлдэх үйлдэл цөөнгүй гардаг тул эдгээр баримт бичгийг албан ёсны эх сурвалжтай тулгах, нягтлах шаардлага үүсдэг.

Харин бүртгэлээс лавлагаа мэдээлэл хүсэх, мэдээлэлд өөрчлөлт оруулах, хуулийн этгээд үүсгэн байгуулах хүсэлт ирүүлэх, тэдгээрт хариу олгох замаар баримт бичгийн бүрдүүлэлтийг бүрэн, зөв, гүйцэт болгох зэрэг ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх нь бүртгэлийн газрын очер дараалал, ажлын ачааллыг бууруулах, хуулийн этгээд байгуулах этгээд шаардлагатай мэдээллээ бүрэн авснаар бүртгэлийн газар олон дахин очихгүй байх зэрэг давуу далууд үүсэх юм.

Өнөөгийн байдлаар ХЭБГ 3 төрлийн бүртгэлийн програм хангамж хэрэглэдэг бөгөөд эдгээр нь бүрэн ашиглагдах боломжгүй байна. Тухайлбал хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтын програм ашиглан ирүүлсэн хүсэлтэд улсын байцаагч тухай бүр харин өгөх боломжгүй бөгөөд дунджаар 1 ажлын өдөрт багтаан хариулдаг. Энэ удаашралтай байдал нь улсын байцаагч “цонх”-оор үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ цахимаар ирүүлсэн хүсэлтэд хариулдагтай, энэ асуудлыг зөвхөн 1 улсын байцаагч хариуцдагтай шууд холбож ойлгож болно. Мөн хуулийн этгээдийн цахим бүртгэлийн “LES програм”[47] ашиглахад хүндрэлтэй, ойлгомжгүй байгаа нь тус програм хангамжийг сайжруулах шаардлагтайг харуулж байна.

Үүнээс гадна хуулийн этгээдийн бүртгэлийн програм хангамжийг боловсруулах, мэдээллийн санг байршуулах, мэдээллийг баяжилт хийхэд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл байхгүй байгаа зэрэг нь хуулийн төслийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй байгааг илэрхийлж байна.

ОӨУБЕГ-ын хэмжээнд бүртгэлийг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг хэрэгжүүлэх төсөв, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлээгүй тохиолдолд хуулийн төслийн энэ заалт хэрэгжих боломжгүй. Харин санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэсэн тохиолдолд ойролцоогоор хагас жилийн дотор цахим хэлбэрт шилжих боломжтой гэсэн дүгнэлтийг судалгааны явцад цуглуулсан мэдээ, мэдээллээс харж болно.

- *Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх*: Хуулийн этгээдийн бүртгэлд хамрагдах этгээдийн тоог багасгах боломжгүй. Хуулийн төслийн 8 дугаар зүйлд улсын бүртгэлд бүртгүүлэх шаардлагатай хуулий этгээдийн төрлийг тодорхойлсон байна. Нийгмийн харилцаа улам өргөжиж, хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэл, төрөл улам нарийвчилсан хэлбэрт шилжиж байгаа энэ цаг үед тэдгээрийг бүртгэх хэлбэр, төрөл, тэднээс шаардах эх баримт бичгийн төрлийг үйл ажиллагааны чиглэлээр нь ангилах хэрэгцээ шаардлага бий. Ингэснээр хуулийн этгээдийн эрх, үүрэг тодорхой болохын зэрэгцээ хуулийн этгээд үүсгэн байгуулагч, гишүүд хоорондын харилцаа, төрөөс үзүүлэх хөнгөлөлт, хүлээлгэх хариуцлага зэрэг асуудлыг тодорхой болгох давуу талтай.
- *Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж бий эсэх*: Хуулийн төсөлд зааснаар хуулийн этгээд шинээр байгуулах, хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт оруулах, хуулийн этгээдийн бүртгэлээс хасах зэрэг хуулийн дагуу хэрэгжүүлж буй үйл ажиллагааны давтамжийг бууруулах боломжгүй.
- *Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх*: Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуульд шинээр байгуулагдсан хуулийн этгээдийг бүртгэх, хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэх, хуулийн этгээдийн бүртгэлээс хасах хүсэлт гаргах тохиолдолд бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг

[47] Цахим хуудас: http://les.burtgel.gov.mn/ubeg/citizen

нэмж оруулсан нь түүнийг бүртгэх, өөрчлөлт оруулах улсын байцаагчийн ажил үйлчилгээний хэмжээг нэмэгдүүлсэн байна. Гэхдээ хуулийн этгээдийн хувийн хэрэгт хавсаргаж буй баримт бичгүүд нь эх нотлох баримт болдог. Хуулийн этгээдийн төрөл бүр өөрийн онцлогтой байх тул түүнд нь тохирсон тодорхой баримт бичгийг бүрдүүлэх нь хуулийн этгээд төдийгүй төрийн байгууллагын үйл ажиллагаанд "үл маргах" нотлох баримт болох нөхцөлийг бүрдүүлэх тул мэдээллийн агуулгыг багасгах шаардлагагүй.

- *Мэдээллийн зарим агуулгаас татгалзаж болох эсэх:* Хуулийн төсөлд хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааны наад захын шаардлагыг тогтоосон зохицуулалт орсон байх тул энэ тохиолдолд агуулгаас татгалзах асуудал хөндөгдөхгүй.

2.5 Үр дүн, санал

Хуулийн төслийг хэрэгжүүлэхэд гарах зардалд хуулийн этгээдийн бүртгэлийг 2020 он хүртэл[48] цахим хэлбэрт бүрэн шилжүүлэхэд шаардлагтай техник, тоног төхөөрөмж, програм хангамж болон цаасан эх баримтын архивын нөхцөл байдлыг сайжруулахад зарцуулах шаардлагатай байгаа санхүүжилтийн хэмжээг 4 жилд багтаан хэрэгжүүлнэ гэх төсөөллөөр боловсруулаа.

Судалгааны дүнгээс харахад хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хийсэн зардлын тооцооны үр дүнг нэгтгэн үзэхэд тус хуулийн төслийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд урьдчилсан байдлаар нэг жилд дунджаар **832313425.6 төгрөгийн зардал, 53,2 хүний нөөцийн** хэрэгцээ үүсэх магадлалтай байна.

ОӨУБЕГ-ын ХЭБГ нь улсын хэмжээнд нийт 42 албан хаагчтай үйл ажиллагаа явуулж байна. улсын хэмжээнд нэг жилд дунджаар 15463 гаруй хуулийн этгээд шинээр бүртгүүлэх, 18850 гаруй өөрчлөлт оруулах хүсэлт хүлээж авч, шийдвэрлэж байгаагийн 70 гаруй %-ийг нийслэл дэх бүртгэлийн газрын улсын бүртгэгчид гүйцэтгэж байгаа нь албан хаагчдын ажлын ачаалал харилцан адилгүй байгааг харуулж байна. Иймд хүний нөөцийн хэрэгцээг ажлын ачаалалтай уялдуулан нэмэх шаардлага байна гэж үзлээ.

Хуулийн төсөлд тусгагдсан хуулийн этгээдийн цахим бүртгэлийн тогтолцоог бүрдүүлэх нийгэм, эдийн засгийн хэрэгцээ шаардлага нэгэнт үүссэн байна. Цахим бүртгэлийн тогтолцоонд шилжихэд ОӨУБЕГ –ын ХЭБГ нь хүний нөөцийн ур чадвар, цахим сан бүрдүүлэх баримт мэдээллээр хангагдсан байгаа нь цахим бүртгэлийг шуурхай нэвтрүүлэхэд давуу тал болж байна. Иймд цахим бүртгэлийг хэрэгжүүлэхэд шаардлагатай програм хангамж, тоног төхөөрөмжийн санхүүжилтийг шийдвэрлэснээр хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт заасан цаасан болон цахим хэлбэрээр бүрдүүлэх, бүртгэлийн цахим сан хөтлөх, лавлагаа, мэдээлэл олгох зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх бүрэн боломжтой.

Харин төрөөс шаардлагатай санхүүжилт хийгдээгүй тохиолдолд буюу одоо хэрэглэж буй програм хангамж, тоног төхөөрөмжийн нөөцөөр хуулийн төсөлд тусгагдсан цахим бүртгэл, мэдээлэл олгох үйл ажиллагаа хэрэгжих боломжгүй гэж дүгнэв.

Иймд "Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга"-д тусгасан хуулийн этгээдийн бүртгэлийг цахим хэлбэрээр хөтлөх, бүртгэх, мэдээлэл оруулах, лавлагаа мэдээлэл олгох ажил үйлчилгээг хэрэгжүүлэх үүргийг ХЭБГ-т хуулиар хүлээлгэхээс өмнө түүнийг хэрэгжүүлэх суурь болсон програм хангамж, тоног төхөөрөмжийн асуудлыг нэгмөр шийдвэрлэх шаардлагатай байна.

[48] ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөнд тусгагдсан байдлаар хугацааг тогтоосон.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

6. Улсын бүртгэлийн ерөнхий хууль. 2009 он.

7. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль. 2015 он.

8. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл. 2017 он

9. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга. 2015 он

10.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал. 2017 он

11.Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын 2016 оны үйл ажиллагааны тайлан

12.Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөний хүрээнд “Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”

13.Маягт, индекс, баталгааны тэмдгийн загварыг шинэчлэн батлах тухай, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаал, дугаар 334, 2015 он.

14.Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам, Хууль зүйн сайдын 2015 оны А/39 дүгээр тушаалын хавсралт

15.Гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэх журам, Хууль зүйн сайдын 2015 оны А/40 дугаар тушаалын хавсралт

16.Хуулийн этгээдийн нэр олгох, баталгаажуулах журам, Хууль зүйн сайдын 2015 оны А/41 дүгээр тушаалын хавсралт

17.Иргэн, хуулийн этгээдийн тамга, тэмдэг, баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам, Хууль зүйн сайдын 2015 оны А/42 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

18.Журам батлах тухай, дугаар 335, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2015 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн тушаал

19.Оюуны өмч, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас 2017 оны 1 сарын 20-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгаланд хүргүүлсэн 1-4/173 тоот “Мэдээлэл хүргүүлэх тухай” албан тоотын хавсралтаас.

20.Хууль, хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал. 2013 он. ХЗДХЯ, ГОУХАН

21.Хууль тогтоомжийн тухай хууль, аргачлал, гарын авлага. 2016 он. ХЗДХЯ 2016 он

22.ОӨУБЕГ-ын захиргааны статистикийн мэдээлэл /2016 оны 10 дугаар сар/. Эх сурвалж: http://burtgel.gov.mn/index.php/news/statistical-rating-item. Сүүлд нэвтэрсэн 2017.03.10

23.ОӨУБЕГ, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын 2012-2016 оны статистик мэдээ

24.ОӨУБЕГ, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын 2016 оны үйл ажиллагааны тайлан

25.ОӨУБЕГ-ын дэд дарга Д.Дэлгэрсайхантай хийсэн ярилцлага

26.“Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-ийг боловсруулсан ажлын хэсгийн гишүүдтэй хийсэн ярилцлага

27.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын улсын бүртгэгч нартай хийсэн ярилцлага

28.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраар үйлчлүүлж байсан хуулийн этгээдийн зарим төлөөллүүдтэй хийсэн ярилцлага

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Хавсралт №1: Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт хууль тогтоомжийн төслийн хүрээнд хүлээлгэсэн үүрэг

Хуулийн зүйл, заалт		Хуулийн зохицуулалт
8 дугаар зүйл **Улсын бүртгэлийн байгууллага**	8.1 дэх хэсэгт	Улсын бүртгэлийн байгууллага хуулийн этгээд, түүний салбар төлөөлөгчийн газрыг бүртгэнэ.
9 дүгээр зүйл **Улсын бүртгэлийн байгууллагын эрх, үүрэг**	9.3 дахь хэсэгт	Улсын бүртгэлийн байгууллага нь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хөрөнгө оруулагч, гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрын тоо, тэдгээрийн эзэмшиж байгаа хувь, хэмжээ, үйл ажиллагааны чиглэлийн талаар нэгдсэн бүртгэл хөтөлж, энэ талаарх мэдээллийг хагас болон бүтэн жилээр гаргаж, хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдээлнэ.
	9.6 дахь хэсэгт	9.6.Улсын бүртгэлийн байгууллага нууцын тухай хууль тогтоомжид зааснаас бусад улсын бүртгэлийн мэдээллийг өөрийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.
10 дугаар зүйл **Хуулийн этгээдийн хувийн хэрэг бүрдүүлэх зарчим, хэлбэр**	10.3 дахь хэсэг	Хуулийн этгээдийн хувийн хэргийг цахим болон бичгийн хэлбэрээр бүрдүүлэн улсын бүртгэлийн мэдээллийн санд давхар хөтөлнө.
12 дугаар зүйл **Хуулийн этгээдийн хувийн хэргээс лавлагаа олгох**	12.1 дэх хэсэг	Улсын бүртгэлийн байгууллага нь ... хуулийн этгээдийн регистерийн дугаарын мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгч болно.
	13.1 дэх хэсэг	Хууль өөрөөр заагаагүй бол улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 17.1-17.3-т заасан баримт бичгийг бүрэн гүйцэт хүлээж авснаас хойш гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг бүртгэх эсэх талаар ажлын 10 өдрийн дотор, бусад хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх эсэх талаар ажлын 2 өдрийн дотор шийдвэр гаргаж, энэ тухай өргөдөл гаргагчид бичгээр цахим хэлбэрээр мэдэгдэнэ.
13 дугаар зүйл **Шинээр байгуулсан хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх**	14.2 дахь хэсэг	Улсын бүртгэлийн байгууллага Иргэний хуулийн 27 дугаар зүйлд зааснаас гадна дараах ерөнхий шаардлагыг хангасан хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулна.
17 дугаар зүйл **Улсын бүртгэлд бүртгүүлэхэд шаардах баримт бичиг**	17.6 дахь хэсэг	Улсын бүртгэлийн байгууллага нь өргөдлийг бичгээр хүлээн авсан бол баримт бичгийн жагсаалт, хүлээн авсан он, сар, өдөр, цаг, минут бүхий мэдээллийг өргөдөл гаргагчид цахим хэлбэрээр, эсхүл бичгээр хүргүүлнэ.
	17.7 дахь хэсэг	Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн санхүүгийн баталгаажсан тайланг үндэслэн үйл ажиллагаа явуулах хугацаа 2 жил тутамд сунгана.
	17.8 дахь хэсэг	Улсын бүртгэлийн байгууллага нь гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн хүсэлтэд үндэслэн тухайн иргэн гадаадын хөрөнгө оруулагч, эсхүл гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, түүний салбар, төлөөлөгчийн газарт ажиллах удирдах албан тушаалтнаар бүртгэлтэй байгаа болон энэ хуулийн 17.7-д заасан үйл ажиллагаа явуулах хугацааны талаарх тодорхойлолтыг гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад батлагдсан маягтаар гарган өгнө.

18 дугаар зүйл **Хуулийн этгээдийг шинээр бүртгэх**	18.2 дахь хэсэг	Цахим хэлбэрээр өргөдөл гаргасан тохиолдолд улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 13.3-т заасны дагуу эх хувиар авч ирсэн баримт бичгийг цахим хэлбэрээр ирүүлсэн баримт бичигтэй тулган нягталсны дараа тухайн хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичгийн эхний хуудас дээр хуулийн этгээдийн хувийн хэргийн дугаар, он, сар, өдөр бүхий баталгааны тэмдэг, бусад хуудас дээр улсын бүртгэгчийн тэмдэг дарснаар хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэсэнд тооцно.
	18.3 дахь хэсэг	Өргөдлийг бичгээр гаргасан тохиолдолд улсын бүртгэлийн байгууллага эх баримтыг улсын бүртгэлийн мэдээллийн санд оруулж тухайн хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичгийн эхний хуудас дээр хуулийн этгээдийн хувийн хэргийн дугаар, он, сар, өдөр бүхий баталгааны тэмдэг, бусад хуудас дээр улсын бүртгэгчийн тэмдэг дарснаар хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэсэнд тооцно.
	18.4 дэх хэсэг	Улсын бүртгэлийн байгууллага нь хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэснийг нотолсон хуулийн этгээдийн хувийн хэргийн болон регистрийн дугаар бүхий улсын бүртгэлийн цахим гэрчилгээг өргөдөл гаргагч хэвлэн авах боломжтойгоор улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд байршуулж болно.
	18.5 дахь хэсэг	Улсын бүртгэлийн байгууллага нь өргөдөл гаргагчийн хүсэлтээр улсын бүртгэлийн гэрчилгээг үнэт цаасан дээр хэвлэж, баталгаажуулан олгож болно.
19 дүгээр зүйл. **Бүртгэхээс татгалзах**	19.1 дэх хэсэг	Улсын бүртгэлийн байгууллага хуулийн этгээд шинээр байгуулсан, өөрчлөн байгуулсан, татан буулгасныг болон түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг дараах тохиолдолд улсын бүртгэлд бүртгэхээс татгалзана:
22 дугаар зүйл. **Өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх**	22.1 дэх хэсэг	Хуулийн этгээдийг нийлүүлэх замаар өөрчлөн байгуулах тохиолдолд нийлсэн хуулийн этгээд тус бүрийн үйл ажиллагааг дуусгавар болсонд тооцож улсын бүртгэлээс хасах бөгөөд шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн мэдээллийг улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэнэ.
	22.2 дахь хэсэг	Нэгтгэх замаар өөрчлөн байгуулах тохиолдолд нэгдэж байгаа хуулийн этгээд тус бүрийн үйл ажиллагааг дуусгавар болсонд тооцож улсын бүртгэлээс хасах бөгөөд нэгтгэж байгаа хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэнэ
	22.3 дахь хэсэг	Хуваах замаар өөрчлөн байгуулах тохиолдолд хуваагдаж байгаа хуулийн этгээдийн үйл ажиллагаа дуусгавар болсонд тооцож улсын бүртгэлээс хасах бөгөөд шинээр байгуулагдсан хуулийн этгээд тус бүрийн мэдээллийг улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэнэ.
	22.4 дэх хэсэг	Тусгаарлах замаар өөрчлөн байгуулах тохиолдолд шинээр байгуулагдсан хуулийн этгээд тус бүрийн бүртгэлийг улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэнэ
	22.5 дахь хэсэг	Хуулийн этгээдийн хэлбэр өөрчлөгдөх тохиолдолд тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааг дуусгавар болсонд тооцож, шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн мэдээллийг улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэнэ.
24 дүгээр зүйл. **Хуулийн этгээдийг татан буулгасан тухай улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэх**	24.3 дахь хэсэг	Энэ хуулийн 24.1-д заасан баримт бичгийг үндэслэн улсын бүртгэлийн байгууллага тухайн хуулийн этгээдийг татан буулгасныг улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэнэ.

Хуулийн үндэсний хүрээлэн www.nlt.gov.mn

26 дугаар зүйл. **Хуулийн этгээдийг татан буулгасныг бүртгэх**	26.1 дэх хэсэг	Улсын бүртгэлийн байгууллага нь татан буугдсан хуулийн этгээдийн тухай мэдээллийг улсын бүртгэлийн мэдээллийн санд оруулснаар тухайн хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хассанд тооцно.
	26.2 дахь хэсэг	Улсын бүртгэлийн байгууллага хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хассан тухайгаа Иргэний хуулийн *32.11*-д заасны дагуу цахим хуудсаар нийтэд тухай бүр мэдээлнэ.

Хавсралт №2. Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын бүтцийн ерөнхий тогтолцоо

---oOo---

Хууль зүйн үндэсний хүрээлэн
www.nli.gov.mn

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ[1]

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлэгт Монгол улсад оршин суугаа хүн бүр тэгш эдлэх хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулж өгсөн байх ба эдгээр эрх, эрх чөлөөг хууль тогтоомж боловсруулах, батлах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд эрхэмлэх, хүний эрхийг зөрчихгүй байх, мөн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж заасан нь Олон улсын хүний эрхийн гэрээ, хэлэлцээрт тунхагласан дэлхий нийтийн жишигт нийцжээ.

Монгол Улс 1961 онд НҮБ-ын гишүүнээр элссэн бөгөөд Хүний эрхийн түгээмэл тунхаглалын үзэл санааг дэмжиж улмаар Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад 1974 онд нэгдэн орсноос хойш хүний эрхийн талаарх 40 гаруй олон улсын гэрээ, конвенц, тэдгээрийн нэмэлт протоколд нэгдэн орж, соёрхон батлсан байна.[2] 2016 оны 1 дүгээр сарын байдлаар 273 олон улсын олон талт гэрээ, 1500 хоёр талт гэрээнд нэгдэн орсон байна. Ялангуяа шилжилтийн үеэс эхлэн Монгол Улсад хүний эрхийг хууль тогтоомжоор дамжуулан баталгаажуулах арга хэмжээг хэрэгжүүлж ирснийг үүнээс харж болох юм.

Монгол Улсад хүний эрхийг хамгаалах үндэсний байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бий болгосон "Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай" хуулийг УИХ-аас 2000 оны 12 дугаар сарын 7-ны өдөр баталсан бөгөөд эдүгээ 17 дахь жилдээ дорвитой өөрчлөлт оролгүйгээр хэрэгжиж байгаа хуулиудын нэг болжээ.. Тус хуульд 2002, 2003, 2011, 2015 онд нийт 5 удаа нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд эдгээр нь гол төлөв бусад хууль тогтоомж батлагдан гарсантай холбоотой нэмэлт, өөрчлөлтүүд юм.

Олон улсын түвшинд гарч буй нийгэм, эдийн засаг, улс төрийн орчны хувьсал, өөрчлөлт манай улсад ч мөн адил нөлөөлж байна. Ардчилал улам бүр хөгжиж, иргэдийн эрх зүйн соёл ухамсар, мэдлэг төлөвшихийн хэрээр хүний эрх, эрх чөлөөний талаарх ойлголт бэхжиж, улмаар хөндөгдсөн эрх ашгаа сэргээлгэх тогтолцооны бүхий л үе шатыг ашиглах чадвар, боломж нэмэгдэж байна. Үүнд хууль тогтоомжоор олгогдсон эрхээ эдлэх мэдлэг, мэдээллийг түгээж буй техник, технологийн дэвшилтэт бүтээгдэхүүний хэрэглээ нэмэгдсэн, цахим орчинд холбогдох боломж өргөжсөнөөс гадна хүний эрхийн байгууллагуудын үйл ажиллагаа идэвхжиж байгаа зэрэг нь шууд нөлөөлж байна.

Манай улсад хүний эрхийг хамгаалах үндэсний байгууллагаас хэрэгжүүлж буй арга хэмжээ, гаргаж буй шийдвэр, тэдгээрийг хүчгүйдүүлж буй сул орон зай, хариуцлагын тогтолцооны хангалтгүй байдал зэрэг шийдвэр хэрэгжүүлэх явцад гарч буй хүндрэл бэрхшээлийг хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх замаар илрүүлэх нь цаашид шинэчлэн боловсруулах хуулийн төсөлд нэмж зохицуулах, засч сайжруулах шаардлагатай асуудлыг тодорхойлоход чухал үр нөлөөтэй гэж үзсэний үндсэн дээр 2000 онд батлагдсан "Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай" хуульд хэрэгжилтийг үр дагаврын үнэлгээ хийх

[1] Тус үнэлгээг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор Х.Эрдэм-Ундрах удирдаж, эрдэм шинжилгээний ажилтан Ж.Бариаширсүрэн, Д.Нямбаяр нар хамтран гүйцэтгэв.

[2] "Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь: Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн 2008 оноос хойших хэрэгжилт. Хавсралт тайлан ". ХЗҮХ. 2016 он. Уб хот. 125 дахь тал.

шаардлага бий гэж үзлээ.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээний зорилго нь өнгөрсөн хугацаанд хуулийг хэрэгжүүлэх явцад гарч буй хүндрэл бэрхшээлийг илрүүлэх, нийгэмд үзүүлж буй эерэг болон сөрөг нөлөөг тогтоох замаар цаашид уг хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд ашиглаж болохуйц шийдлийн хувилбаруудыг дэвшүүлэхэд оршино.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу гүйцэтгэлээ.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Төлөвлөх үе шатанд хууль тогтоомжид үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох, үнэлгээ хийх хүрээг тогтоох, шалгуур үзүүлэлтийг сонгох, харьцуулах хэлбэрийг сонгох, шалгуур үзүүлэлтийг томъёолох, мэдээлэл цуглуулах аргыг сонгох ажиллагаа хийгдсэн.

1.1. Хууль тогтоомжид үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

2000 онд батлагдсан Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль эдүгээ 17 дахь жилдээ хэрэгжиж байгаа бөгөөд өнгөрсөн хугацаанд 2002, 2003, 2011, 2015 онд нийт 5 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд нь Жендэрийн тухай, Хууль тогтоомжийн тухай, Эрүүгийн болон Зөрчлийн тухай хууль тогтоомжууд батлагдсантай холбоотой орсон байдаг.

Монгол Улсын үндэсний хэмжээнд болон гадаад харилцаандаа баримтлах бодлого, олон улсын өмнө хүлээх хариуцлага, харилцааны төвшин 2000 онтой харьцуулахад шинэ шатанд гарч, өөрчлөгдөж байна. Мөн улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил, иргэдийн мэдлэг, ухамсрын төвшин дээшилж, иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаа өргөжиж, идэвхжиж буй энэ үед үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулах эрх бүхий ХЭҮК-ын үйл ажиллагааны эрх зүйн үндэс болсон “Хүний эрхийн үндэсний комиссын тухай” хууль нийгэм, олон нийтийн хэрэгцээ шаардлагыг хангаж буй эсэхэд үнэлгээ хийх, мөн хуулийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний үр дүнд тулгуурласан шинэчлэл, өөрчлөлтийг хийх нь цаг үеэ олсон асуудлын нэг юм.

Иймээс Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Засаглалын бодлого бүлгийн 5.3.11 дэх хэсэгт “Хүний эрхийг хамгаалах үндэсний төлтолцоог сайжруулж, хүний эрхийн стандартыг нэвтрүүлэх” зорилт тавин ажиллаж байна.

Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийг цаг үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх ажлыг хэд хэдэн удаа санаачлан эхлүүлсэн байх боловч боловсруулагдсан хуулийн төслүүд батлагдаагүй байна. Тухайлбал судалгааны явцад цугларсан мэдээллээс харахад дөрвөн хуулийн төсөл боловсруулсан байх ба эдгээрийг Монгол Улсын Ерөнхийлөгч, ХЭҮК зэрэг эрх бүхий этгээдүүд санаачлан боловсруулж байсан нь тус хуулийг шинэчлэх шаардлага буйг илтгэж байна. Гэхдээ зөвхөн дотоодын нийгэм, эдийн засгийн хөгжлийн төвшин гэхээсээ илүүтэй Монгол Улсын олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагад нийцүүлэх, ялангуяа 1993 онд батлагдсан Хүний эрхийн тухай үндэсний байгууллагуудын тухай Парисын зарчимд нийцүүлэх шаардлага тулгамдаж байна.[3] 1991 онд НҮБ-ын Хүний эрхийн комиссоос зохион байгуулсан хурлаар “Хүний эрхийн үндэсний байгууллагуудын талаарх зарчмууд”-ыг батлагдсан бөгөөд Парисын зарчим гэгдэх энэхүү баримт бичгийг 1993 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1993/48/134 тоот тогтоолоор батламжилсан байдаг. Үүнд тодорхойлсноор “Хүний эрхийн Үндэсний байгууллага нь бие даасан, тодорхой эрх

[3] Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачилсан Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалаас

мэдэлтэй, байнгын ажиллагаатай, олон ургальч төлөөллийг хангах зарчмаар бий болсон бүрэлдэхүүнтэй, олон нийтэд ойр, өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулах санхүүгийн чадвартай байх ёстой. Мөн хуулийг дээдэлж, хараат бус, бие даасан байж, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсыг тууштай хамгаалж, ил тод, шударга ажиллах үүрэгтэй" байна. Эдгээр үзүүлэлтүүд нь Хүний эрхийн Үндэсний байгууллагын үр нөлөөтэй эсэхийг хэмжих шалгуур болдог.

Хүний эрхийг байгууллагын үйл ажиллагаа, эрх зүйн байдалтай холбогдох хууль тогтоомжийг шинэчлэх ажлын явцад Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж, *Монгол Улсын Их Хурлын 2016 оны "*Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" тухай 45 дугаар тогтоолоор баталсан хавсралтын 5.2.11-т "Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоог сайжруулж, хүний эрхийн стандартыг нэвтрүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлэх чадавхтай бүтцийг бий болгох шаардлагатай байна.

Батлагдсанаас хойш зарчмын хувьд нэмэлт, өөрчлөлт, ямар нэгэн засваргүйгээр хэрэгжүүлж ирсэн Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийг «НҮБ-ын Парисын зарчмуудаар баталгаажуулсан наад захын зарим хэм хэмжээг хуульчлаагүй" хэмээн олон улсын зүгээс одоог хүртэл шүүмжлэлтэй хандаж ирсэн. Хэдийгээр дээрх зарчмын дагуу Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс байгуулагдсан гэж үздэг ч өнөөдөр хэрэгжиж буй хуулийн зохицуулалт нь бусад хууль тогтоомжтой уялдаа холбоо муутай, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох, иргэдийн гомдлыг бүрэн дүүрэн шийдвэрлэхэд учир дутагдалтай, гомдол шийдвэрлэх ажиллагааг хуульчлаагүй зэрэг асуудлууд оршсоор байгаа юм.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн Засаглалын бодлого бүлгийн 5.3.11 дэх хэсэгт "Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоог сайжруулж, хүний эрхийн стандартыг нэвтрүүлнэ" гэсэн зорилтын хүрээнд Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийж үр дүнг танилцуулах зорилгоор энэхүү үнэлгээ хийгдэж байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу 2000 онд баталснаас хойш 17 дахь жилдээ хэрэгжиж буй Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн хэрэгжилтийн бодит нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, нийгэмд үзүүлж буй эерэг сөрөг байдлыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад гарсан ололтыг бататгах, хүндрэл бэрхшээлийг тодорхойлох зорилгоор хийгдэж буй үнэлгээний үр дүн хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулахад нөлөөлөхүйц нэмэлт өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд хуулийг шинэчлэн боловсруулах үндэс болох юм.

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ын 3 дугаар зүйлийн 3.2.2 дахь хэсэгт "хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад ... нийгмийн харилцааны өөрчлөлт, хөгжлөөс хоцорсон, зайлшгүй зохицуулах ёстой харилцааг хамарч зохицуулаагүй..." тохиолдолд тодорхой хууль тогтоомжид хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийхээр тусгасан зэрэг нь Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх үндэслэл болж, хэрэгцээ шаардлагыг тодорхойлж өгч байна.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх хүрээг тогтоохдоо Хүний эрхийн үндэсний комиссын тухай" хуулийг хэрэгжүүлэхэд агуулгын хувьд чухал ач холбогдолтой гэж үзсэн Комисс, түүний гишүүний бүрэн эрх, Комисст гомдол гаргахтай холбогдох зүйл заалтын хүрээнд тус тус үнэлгээ хийхээр хүрээг тогтоож өгсөн. Үүнд.

-Комисс, түүний гишүүний бүрэн эрхтэй холбогдох асуудлын хүрээнд:

Хуулийн 2 дугаар бүлгийн 5 дугаар зүйлийн 5.1., 5.2., 5.4., 5.6 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт,

Хуулийн 4 дүгээр бүлгийн 13 дугаар зүйл, 15 дугаар зүйл, 16 дугаар зүйлийн 16.1.1-16.1.8 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.1.1-17.1.5 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.1.-18.6 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.1-19.6 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалт, 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалт

- Комисст гомдол гаргах асуудлын хүрээнд:

Хуулийн 3 дугаар бүлгийн 9 дүгээр зүйлийн 9.1-9.4 дэх заалт, 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1-12.3 дахь заалт,

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгох

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.1.3-т заасан шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох ажлын хүрээнд зорилгод хүрсэн түвшин, практикт нийцэж байгаа байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхээр сонгосон.

Аргачлалын 3.4.1 дэх хэсэгт заасан “зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгон авсан хуулийн зүйл, заалтуудын хэрэгжилтэд хийсэн үнэлгээгээр уг хуулийн зохицуулалт хуулийн “Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын үйл ажиллагааны зарчим, эрх зүйн үндсийг тодорхойлж, түүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах” гэх үндсэн зорилгодоо хүрч байгаа эсэхэд үнэлэлт өгөх, аргачлалын 3.4.5-д заасан “практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтээр хуулийн зохицуулалт ойлгомжтой, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэх, хуулийг хэрэгжүүлэхэд ямар хүндрэл гарч байгаа зэрэг асуудлыг тодорхойлох зорилгоор сонгосон болно.

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль батлагдан гарснаар нийгмийн харилцаанд гарсан өөрчлөлтүүдийг олж тогтоох үүднээс аргачлалын 3.5.3.3-т заасан харьцуулалтын “хууль тогтоомж хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойш” аргыг сонгосон. Энэ нь дээрх хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөж буйг он дараалаар судлах, улмаар хуулийн хэрэгжилт хэрхэн хангагдаж буйг харуулах боломж бүрдүүлнэ гэж үзсэн.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох

Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийхэд сонгосон шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар томъёолсон. Үүнд:

- зорилгод хүрсэн төвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулиас сонгон судалсан зохицуулалтууд зорилгодоо хүрсэн түвшинг тодорхойлох,

- практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд хүний эрхийн зөрчилтэй холбоотой гомдол шийдвэрлэх ажиллагаа, комиссоос гаргаж буй зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлж буй байдал болон бусад холбогдох үйл ажиллагаа практикт хэрхэн нийцэж байгааг, эдгээр зохицуулалт хуулийн үндсэн зорилгыг хэрэгжүүлэхэд хангалттай байгаа эсэх, мөн хэрэгжилтийн явцад ямар хүндрэл бэрхшээл тулгарч байгааг тодруулах зэрэг асуудлыг хөндөн судална.

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээллийг аргачлалын 3.7.3.1-т заасан бэлэн байгаа мэдээлэл цуглуулах арга буюу холбогдох ном, товхимол, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, ХЭҮК-оос гаргасан статистик тоон мэдээ зэргээс, мөн аргачлалын 3.7.3.2-т заасан холбогдох субъектээс судалгаа авах аргын дагуу тухайн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулж буй Хүний эрхийн үндэсний комиссын ажлын албанаас шаардлагатай мэдээ, мэдээллийг нарийвчлан гаргуулах зэргээр бүрдүүлсэн болно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Хэрэгжүүлэх үе шатанд төлөвлөлтийн үе шатанд тодорхойлсон үнэлгээ хийх хүрээнд багтсан зүйл заалтын хэрэгжилтэд дүн шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээ, мэдээлэл буюу хууль тогтоомж, илтгэл, нийтлэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, ном, эмхэтгэл зэрэг олон нийтийн хүртээл болгосон бүтээлүүд болон ХЭҮК-оос ирүүлсэн мэдээлэлд үндэслэн Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн зорилгыг хэрэгжүүлэх, Комисс ба түүний гишүүдийн бүрэн эрхтэй холбоотой асуудал, Комисст гомдол гаргах асуудал болон хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагатай холбоотой асуудлыг хангалттай зохицуулж чадаж байгаа эсэх, хэрэв хангалтгүй бол ямар шалтгаан байгааг тодорхойлох ажиллагаа хийгдсэн.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

3.1. Үнэлэх хүрээ: Комисс, түүний гишүүний бүрэн эрхтэй холбогдох асуудал

5.1. Комиссын гишүүнд нэр дэвшигчийн нэрийг Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Улсын дээд шүүхийн саналыг үндэслэн Улсын Их Хурлын дарга Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. 5.2. Улсын Их Хурал нэр дэвшигчийг Комиссын гишүүнд томилохоос татгалзсан бол Улсын Их Хурлын дарга арван дөрвөн хоногийн дотор энэ хуулийн 5.1-д заасан журмын дагуу өөр хүний нэрийг дэвшүүлнэ. 5.4. Нэр дэвшигчийн нэрийг өргөн мэдүүлснээс хойш гуч хоногийн дотор Улсын Их Хурал уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. 5.5. Комиссын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанаас өмнө хуульд заасан үндэслэлээр албан тушаалаасаа чөлөөлөгдсөн, огцорсон, нас барсан тохиолдолд Улсын Их Хурал жар хоногийн дотор энэ хуульд заасны дагуу Комиссын гишүүнийг нөхөн томилно.

3.1.1 Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2, 5.4, 5.5 дахь заалтын зорилгод хүрсэн төвшин ба практикт нийцэж буй байдал

А. Шалгуур үзүүлэлтийн томъёолол:

Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн Комиссын гишүүнд нэр дэвшүүлэх, томилохтой холбогдох заалт хараат бус, бие даасан үйл ажиллагаа явуулах чадавхтай гишүүдийг сонгон, нэр дэвшүүлэх боломж бүрдүүлж байгаа эсэх?

Б. Судалсан байдал:

Монгол Улсын УИХ 2000 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийг баталж, 2001 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 1 тоот тогтоолоор ХЭҮК-ын гишүүдийг томилсноор Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхүүлэн дэмжих чиг үүрэгтэй Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс 3 гишүүнтэйгээр байгуулагдсан.

НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос 2000 онд өгсөн Ерөнхий зөвлөмждөө Монгол Улсын хүний эрхийг хамгаалах үндэсний механизм бий болгох тухайд Хүний эрхийн Дээд Комиссарын газартай хамтран ажиллаж буйг сайшаахын зэрэгцээ тус байгууллагыг Парисын зарчимд нийцүүлэн байгуулахыг уриалж байсан[4] боловч өнөөг хүртэл Парисын зарчимд бүрэн нийцээгүй гэх шүүмжлэл хэвээр байна.

Хүний эрхийн Үндэсний Комисс /цаашид ХЭҮК гэх/ 2001 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш нийт 6 хүнийг гишүүнээр сонгон томилсон бөгөөд томилогдсон гишүүдээс Комиссын даргыг сонгодог тогтолцоотой.

[4] Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх МУ-ын ээлжит илтгэлүүд, НҮБ-ын холбогдох хороодоос МУ-ын ЗГ-т өгсөн зөвлөмжийн эмхэтгэл /1977-2014/ ХЭҮК, UNDP. 2014 он. Уб хот.223 дахь тал.

Судалгааны үр дүнгээс харахад ХЭҮК-ын гишүүдийг томилох үйл ажиллагаатай холбогдуулан дараах 2 асуудлын хүрээнд санал, зөвлөмж, шүүмж хүргүүлсэн байна.

Нэгдүгээрт, гишүүдийг сонгон шалгаруулах процесстой холбогдох асуудлын хүрээнд: одоо хэрэгжиж буй эрх зүйн зохицуулалт Парисын зарчмын В.1 заалт болон ХЭҮБ-уудын шийдвэр гаргах байгууллагын томилгооны талаарх ОУЗХ-ны МИДХ-ны Ерөнхий зөвлөмжийн 1.8 дахь хэсэгт заасан стандартуудад нийцэхгүй хэвээр байна. Дээрх зөвлөмжид ХЭҮК-ын гишүүдийг сонгон шалгаруулах, томилох журамд сул орон тооны талаар нээлттэй хэлэлцүүлэх, сурталчлах ажиллагааны талаар заалт байхгүй, улмаар тодорхой, ил тод, олон нийт, иргэний нийгмийн оролцоог хангахгүй байна гэж үзсэн.

Олон улсын стандартад зааснаар 1/ гишүүний сул орон тоо гарч байгааг олон нийтэд ил зарлах, 2/ нийгмийн олон янзын бүлгүүдээс нэр дэвших боломжтой нэр дэвшигчдийн тоог нэмэгдүүлэх, 3/ нэр дэвших иргэнийг урьдаас тодорхой болсон, бодитой, нийтэд ил тод шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлдэг байх, 4/ нэр дэвшигчийг төлөөлж буй байгууллагынхаа нэрийн өмнөөс гэхээс илүүтэй хувь хүний өөрийн мэдлэг, чадавхаар ажиллах хүнийг сонгон шалгаруулдаг байхыг чухалчлан үздэг.

Хүний эрхийн үндэсний байгууллагуудын үйл ажиллагааны үндсэн зарчмуудыг агуулсан Парисын зарчим болон Хүний эрхийн үндэсний байгууллагуудад тавигддаг олон улсын стандартуудын дундаас тухайн байгууллагын хараат бус байдлыг илэрхийлэх гол шалгуур үзүүлэлтийн нэг бол “Бие даасан хараат бус гишүүд”-тэй байх явдал юм.

Манай улсын хувьд ХЭҮК-ын гишүүдийг сонгон шалгаруулж, нэр дэвшүүлж буй процесс гишүүдийн хараат бус, бие даасан байх нөхцөлийг бүрдүүлж байгаа эсэх нь эргэлзээ төрүүлсээр ирсэн. Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын их хурал, Улсын дээд шүүхээс нэр дэвшүүлэгчийн талаарх мэдээлэл олон нийтэд ил болдоггүй, эрх бүхий субъект зөвхөн нэг хүний нэр дэвшүүлдэг, нэр дэвшүүлсэн этгээд гишүүнээр сонгогдоогүй тохиолдолд байхгүй, УИХ нэр дэвшигчийг гишүүнд томилохоос татгалзаж байсан удаагүй, иргэний нийгмийн байгууллагуудаас нэр дэвшүүлсэн этгээдтэй холбоотой санал авч байгаагүй зэрэг нь энэхүү зохицуулалт олон улсын стандартад нийцэхгүй байгааг харуулж байна. Үүнээс харахад ХЭҮК-ын гишүүнд нэр дэвшүүлэх асуудал МУ-ын Ерөнхийлөгч, УИХ, УДШ-ийн хүрээнд хаалттай орчинд зохион байгуулагддаг байдал ажиглагдаж байна.

Гишүүдийн хараат бус байдлыг хангах асуудалд анхаарал хандуулах шаардлагатайг холбогдох олон улсын болон дотоодын байгууллагуудаас удаа дараа сануулж байжээ. Тухайлбал, “Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Зохицуулах Хорооноос манай улсад Гишүүдийн хараат бус байдлыг хангах асуудалд анхаарал хандуулах шаардлагатайг холбогдох олон улсын болон дотоодын байгууллагуудаас удаа дараа сануулж Гишүүдийн хараат бус байдлыг хангах асуудалд анхаарал хандуулах шаардлагатайг холбогдох олон улсын болон дотоодын байгууллагуудаас удаа дараа сануулж Хүний эрхийн Үндэсний байгууллага нь өөрийн байртай байх, тус байгууллагын төсвийг Засгийн газраас хараат бус байдлаар, УИХ-д тайлан өргөн барьж хэлэлцүүлдэг байх, ХЭҮК-ын гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох үйл явцыг ил тод, нээлттэй болгох (Комиссын гишүүний шаардлага хангасан хэн боловч өрсөлдөх боломжийг бүрдүүлэх)”-ыг зөвлөж байсан бол НҮБ-ын Эрүү шүүлтийн эсрэг хорооны CAT/C/MNG/CO/1/CPR.1 дүгнэлтэд ХЭҮК-ын удирдлагыг томилох үйл явц ил тод, зөвшилцөөн нээлттэй, өргөн хүрээтэй, ялангуяа иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангасан байх явдлыг баталгаажуулах, түүнчлэн ХЭҮК-ын хараат бус байдал, чадавхыг бэхжүүлж, үйл ажиллагаанд нь ямар нэг хязгаарлалт, саад учруулахгүй байх нь зүйтэй” зэрэг асуудлыг хэд хэдэн удаа зөвлөсөн байна.[5]

[5] Хүний эрхийн Үндэсний комисс 10 жилд 2001-2011” ХЭҮК, 2011 он. Уб хот. 160 дахь тал.

Үүнээс гадна НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхий төлөв байдлын ээлжит дүгнэлт, хэлэлцүүлэг /UPR/ -т Монгол Улсын Төрийн бус байгууллагуудын Форумын үйл ажиллагааны хүрээнд 2014 оны 9 сард бэлтгэсэн “Эрх зүйн шинэтгэл” сэдэвт тайлангийн 15-д “ХЭҮК-ын үйл ажиллагааг Парисын зарчимд нийцүүлэх Олон улсын Зөвлөх хорооны зөвлөмж биелээгүй. Комиссын бие даасан, хараат бус үйл ажиллагааг хангахад Комиссын гишүүдийг ил тод, нээлттэй, олон нийтийн оролцоотой томилох ... эрх зүйн орчинг бүрдүүлж чадаагүй байна. Комиссын хуульд өөрчлөлт ороогүй. Комиссын санхүүжилтийг Сангийн яамнаас хасдаг практик хэвээр байна. Комисс хүний эрхийн ноцтой хэрэг дээр бие даасан байр сууриа илэрхийлэх, хөгжлийн бодлого, төлөвлөгөөнд хүний эрхийн байр сууринаас дүгнэлт хийх, шүүмжлэх боломжгүй, засах залруулах зөвлөмж өгөх чадавхаа бүрдүүлж чадахгүй байна.”[6] гэж дүгнэжээ. Мөн “Хүний эрхийг бэхжүүлэх” талаар гаргасан зөвлөмждөө “Хүний эрхийн байгууллагын хараат бус, бие даан ажиллах чадавхыг бүрдүүлж, хүний эрхийг хамгаалах бүрэн эрхийг өргөжүүлэх зорилгоор ХЭҮК-ын тухай хуулийг Парисын зарчимд нийцүүлэх, ХЭҮК-ын гишүүний шалгуурт хүний эрхийн мэдлэг туршлагыг чухалчлах”-ыг зөвлөсөн байна.[7]

Хоёрдугаарт, ХЭҮК-ын гишүүнд нэр дэвшиж буй этгээдэд тавигдах мэргэжил, туршлагатай холбоотой асуудлыг хөндсөн санал, зөвлөмж, шүүмж гардаг.

Хууль тогтоомжид заасан тодорхой болзол хангасан хүнийг Хүний эрхийн үндэсний байгууллагын гишүүнээр тодорхой хугацаагаар сонгох буюу томилох ба тэднийг зөвхөн хуульд заасан үндэслэлээр чөлөөлөх нь Хүний эрхийн үндэсний байгууллагын амин чухал хэсэг. Хүний эрхийн үндэсний байгууллага /цаашид ХЭҮБ гэх/ нь хүний эрхийн онолын үүднээс төр засаг ба иргэдийн хооронд байршиж, төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, хүний эрхийн үүднээс иргэдийг хөхүүлэн дэмждэг байгууллага. Иймд Засгийн газар, эрх баригч хүчний байр суурь, төрийн албан хаагчдын үзэл бодлоос үл хамааран, хүний эрхийн асуудлаар хяналт шалгалт явуулж чаддаг, тухайн асуудалд хүний эрхийн зарчим, байр сууринаас үнэлэлт, дүгнэлт өгдөг, илтгэл, зөвлөмж, саналаа гаргадаг байх нь тухайн ХЭҮБ-ыг үнэлэх хамгийн чухал шалгуур үзүүлэлт болдог.[8] Мөн Олон улсын стандартаас харахад ХЭҮБ-ыг жендэрийн тэгш оролцоог хангасан бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажиллахыг чухалчилдаг. Зарим улсад, тухайлбал Непал, БНСУ-д энэ асуудлыг хуулиар зохицуулсан байдаг. Манай улсын хувьд жендэрийн асуудлыг хуулиар зохицуулаагүй ч гишүүнээр томилох явцад үүнийг анхааралдаа авч иржээ. Түүхэн замналаас харахад ХЭҮК-ын 3 гишүүн бүгд эрэгтэй байсан тохиолдол нэг удаа байсан бөгөөд бусад тохиолдолд гишүүдийн нэг нь эмэгтэй байсан байна.

Үүнтэй холбогдуулан манай улсад өгсөн зөвлөмжүүдээс харахад, НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны 2005 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн CRC/C/1/Add.264 дугаарт дүгнэлтэд МУ 2001 онд ХЭҮК байгуулж, 3 гишүүний нэг нь хүүхдийн эрхийн асуудлыг тусгайлан хариуцах болсныг сайшаасан бол Эмэгтэйчүүдийн эсрэг алагчлалыг устгах хорооны 2008 оны 11 сарын 7-ны өдрийн CEDAW/C/MNG/CO/7 дугаарт дүгнэлтэд МУ-ын ХЭҮК-ын бүрэлдэхүүн дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаар оролцогч улсын төлөөлөл хангалттай мэдээлэл өгч чадахгүй байгаад харамсаж байгаагаа илэрхийлсэн байдаг.[9]

В. Үнэлсэн байдал.

Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн Комиссын гишүүнд нэр дэвшүүлэх, томилохтой холбогдох заалтын хэрэгжилттэй холбоотой маргаан,

[6] НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхий төлөв байдлын ээлжит дүгнэлт, хэлэлцүүлэг /UPR/ -т бэлтгэсэн “Эрх зүйн шинэчлэл” тайлан. Монгол Улсын төрийн бус байгууллагуудын Форум, 2014 он. 5 дахь тал.

[7] Мөн тэнд 7 дахь тал

[8] “Хүний эрхийн үндэсний байгууллага: тавигдах шаардлага” С.Цэрэндорж. Хууль зүйн ухааны доктор. Хүний эрх” онол, арга зүйн сэтгүүл. 2016/01 дугаар 42 дахь тал

[9] “Хүний эрхийн Үндэсний комисс 10 жилд 2001-2011” ХЭҮК, 2011 он. Уб хот. 159 дэх тал.

асуудал өнгөрсөн хугацаанд төдийлөн гараагүй. Гэвч олон улсын болон дотоодын иргэний нийгмийн байгууллагуудаас гаргаж буй зарчмын шинжтэй санал зөвлөмжүүдэд гишүүдийн хараат бус, бие даасан үйл ажиллагаа явуулах нөхцөлийг хангах талаар арга хэмжээ авах шаардлагатай байгаа тухай цөөнгүй удаа анхааруулжээ. Ялангуяа гишүүнээр нэр дэвшүүлж буй этгээдийн хүний эрхийн мэдлэг, туршлагыг шалгуур үзүүлэлт болгох, Комиссын гишүүдийг Парисын зарчимд нийцүүлэн ил тод, нээлттэй, олон нийтийн оролцоотой томилох эрх зүйн орчинг бүрдүүлэх асуудлууд өнөөг хүртэл шийдвэрлэгдээгүй нь уг хуулийн зохицуулалт зорилгод хүрэх хангалттай түвшинд хүрэхгүй байна.

Мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1. дэх хэсэгт “Комиссын гишүүнд нэр дэвшигчийн нэрийг Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Улсын дээд шүүхийн саналыг үндэслэн Улсын Их Хурлын дарга Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж томъёолсон нь найруулгын хувьд ХЭҮК-ын гишүүнд нэр дэвшигчийн талаар Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Улсын дээд шүүхээс санал авахаар ойлгогдож байна. Гэвч Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Улсын Дээд Шүүхээс нэр дэвшүүлэхээр санал болгосон 3 хүний нэрийг Улсын Их Хурлын дарга Улсын Их Хуралд өргөн мэдүүлдэг бөгөөд сонгон шалгаруулалт 2-3 хоногийн дотор зохион байгуулагдан, нэр дэвшигчдийг шууд сонгодог, тэдний дундаас УИХ-аас нэр дэвшүүлсэн гишүүнийг ХЭҮК-ын даргаар сонгодог бөгөөд урьдчилан олон нийтэд танилцуулах, санал авах арга хэмжээ авдаггүй практик тогтсон байна.

ХЭҮК-ын гишүүдийг томилох үед жендэрийн тэгш байдлыг хангах асуудлыг хуульд тусгаагүй. Гэхдээ өнгөрсөн хугацаанд томилогдон ажилласан гишүүдийн дунд жендэрийн харьцаа харьцангуй сайн хангагдсан гэж үзэх боломжтой байна. Хамгийн эхний бүрэлдэхүүнд багтсан 3 гишүүн бүгд эрэгтэй байснаас бусад тохиолдолд 3 гишүүний аль нэг нь эмэгтэй, зарим тохиолдолд 2 эмэгтэй гишүүнтэй байсан байна. Ерөнхийдөө гишүүнд санал болгох эрх бүхий субъектээс 1 хүний нэр дэвшүүлдэг бөгөөд жендэрийн тэгш байдлыг хангаж байгаа явдал нь тохиолдлын журмаар хэрэгжиж байгаа гэж үзэж болохоор байна. Иймд гишүүнд нэр дэвшүүлэх эрх бүхий субъектээс хамгийн багадаа 1 эрэгтэй, 1 эмэгтэй гишүүний нэр дэвшүүлдэг болох, түүнийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх асуудлыг судлах шаардлагатай байна. Гишүүнийг нөхөн томилохтой холбоотой тогтоосон хугацаатай холбоотой үүссэн маргаан гараагүй тул энэ зохицуулалт хэрэгжих боломжтой гэж үнэллээ.

Г. Санал зөвлөмж

- Хуулийн зааltыг Парисын зарчимд нийцүүлэн шинэчлэх,
- ХЭҮК-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах ажиллагааг Парисын зарчимд нийцүүлэн олон нийтийн оролцоотойгоор ил тод, нээлттэй зохион байгуулах,
- Гишүүнд нэр дэвшиж буй этгээдийн хүний эрхийн талаарх мэдлэг, туршлагын талаар бусад эрх бүхий байгууллагаас авч буй саналд тусгуулдаг байх,
- Жендэрийн тэгш байдлыг хангах тухай зохицуулалтыг хуульд нэмж тусгах.

> 5.7. Комиссын гишүүн сургалт, эрдэм шинжилгээний ажил хийхээс бусад энэ хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, алба н тушаал хавсарч болохгүй. Хэрэв гишүүн томилогдохоосоо өмнө өөр ажил, албан тушаал эрхэлж байгаа бол тангараг өргөсөн өдрөөсөө эхлэн уул үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөнө.

3.1.2 Хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь заалтын зорилгод хүрсэн төвшин ба практикт нийцэж буй байдал

А. Шалгуур үзүүлэлтийн томъёолол:

Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн Комиссын гишүүнд нэр дэвшүүлэх, томилохтой холбогдох энэхүү заалт гишүүн хараат бус, бие даасан үйл ажиллагаа явуулах бүрдүүлж байгаа эсэх?

В. Үнэлсэн байдал.

ХЭҮК-ын гишүүн төрийн өндөр, дээд албан тушаал хашиж байгаа бөгөөд түүнийг хараат бус, бие даасан үйл ажиллагаа хэрэгжүүлэх явцад ашиг сонирхол, эдийн засаг, улс төрийн хараат байдал үүсгэхгүй байх зорилгодоо хүрсэн, практикт бүрэн нийцсэн зохицуулалт юм.

5.6. Комиссын даргыг Улсын Их Хурлын даргын санал болгосноор Комиссын гишүүдээс Улсын Их Хурал гурван жилийн хугацаагаар томилно.

3.1.3. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь заалтын зорилгод хүрсэн төвшин ба практикт нийцэж буй байдал

А. Шалгуур үзүүлэлтийн томъёолол:

Хүний эрхийн үндэсний комиссын даргыг томилох тухай энэ заалт зорилгодоо хүрч байгаа эсэх?

Б. Судалсан байдал

Хүний эрхийн үндэсний комиссын даргыг томилж буй нөхцөл байдлыг судлан үзэхэд эх сурвалжийн судалгааны явцад тодорхой баримт мэдээлэл олдоогүй бөгөөд ажлын албанаас авсан мэдээлэл, ярилцлагын судалгаанд тулгуурлан энэхүү заалтын хэрэгжилтийг үнэлсэн болно. Үүнээс үзэхэд ХЭҮК-ын даргыг УИХ сонгож байгаа тохиолдолд УИХ өөрийн нэр дэвшүүлсэн гишүүнийг сонгох нөхцөлийг бүрдүүлж байна. Энэ нь улс төрийн нөлөөллөөс ангид байх, хараат бус байдлыг хангах асуудалд хөндлөнгийн буюу улс төрийн нөлөөлөл орох эрсдэлийг үүсгэж байна.

Өнөөгийн байдлаар ХЭҮК-ын 3 гишүүн дотроосоо дарга сонгох боломжгүй. Энэ нь нэг талаас гишүүдийн тоо цөөн буюу 3 байгаа нь гишүүд өөрсдөө дотроосоо даргаа сонгох боломжийг хаадаг. Иймд бүрэлдэхүүний тоог нэмэгдүүлэх, тухайлбал 5 гишүүнтэй болгох замаар гишүүд даргаа сонгох боломжийг бүрдүүлэх боломжтой.

Комиссын даргыг 6 жилийн хугацаатай сонгогдсон гишүүдийн дундаас 3 жилийн хугацаагаар сонгон ажиллуулж байгаа боловч өнөөгийн байдлаар 3 жил тутам дахин сонгосон тохиолдол байхгүй буюу нэгэнт сонгогдсон дарга үргэлжлүүлэн ажилладаг, зарим тохиолдолд түүнийг дахин болон улираан томилох тухай шийдвэрийг тухайлан гаргадаггүй байна.

В. Үнэлсэн байдал

ХЭҮК-ын даргыг УИХ-ын даргын санал болгосноор УИХ сонгох энэхүү тогтолцоо нь ХЭҮК-ын үйл ажиллагаа, удирдлага улс төрийн нөлөөнд автах, хараат байдлыг бий болгох боломжийг бүрдүүлж байгаа бөгөөд энэхүү заалт хэрэгжсэнээр хуулийн үндсэн зорилгын нэг болох хараат бус, бие даасан хүний эрхийн үндэсний байгууллага байх асуудлыг гажуудуулах эрсдэлийг үүсгэж байна.

ХУНИЙ ЭРХИЙН ХҮРЭЭЛЭН www.legal.mn

Мөн Комиссын даргыг 3 жилийн хугацаатай томилох тухай энэхүү заалт хэрэгждэггүй болох нь судалгаанаас харагдаж байна.

Г. Санал зөвлөмж

Комиссын даргыг сонгох процессыг олон нийтийн саналд суурилсан, ил тод, нээлттэй болгох,

13.1.1. Монгол Улс дахь хүний эрхтэй холбоотой аливаа асуудлаар санал гаргах;
13.1.2. хууль тогтоомж, захиргааны шийдвэр хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар зөвлөмж, санал гаргах;
18 дугаар зүйл. Комиссын гишүүний хүний эрх , эрх чөлөөг хангах талаарх бусад бүрэн эрх
18.1. Комиссын гишүүн нь Улсын Их Хурлын чуулган, Засгийн газрын хуралдаанаар хүний эрхтэй холбогдсон асуудал хэлэлцэхэд Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын хүсэлтээр зөвлөх эрхтэй оролцож болно.
18.5. Комиссын гишүүн нь хүний эрхийн асуудлаар төрийн байгууллагын хүсэлтээр зөвлөгөө өгнө.

3.1.5 Хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1., 13.1.2 дахь заалт болон 18 дугаар зүйлийн 18.1., 18.5 дахь заалтын зорилгод хүрсэн түвшин

А. Шалгуур үзүүлэлтийн томъёолол:

Хүний эрхийн үндэсний комиссоос Монгол Улс дахь хүний эрхтэй холбоотой аливаа асуудлаар санал, зөвлөмж гаргах тухай зохицуулалт зорилгодоо хүрч байгаа эсэх?

Б. Судалсан байдал.

ХЭҮК, түүний гишүүдийн бүрэн эрхэд хамаарах үндсэн асуудлын нэг бол хяналт шалгалт, мониторинг, судалгаа хийх явдал юм. Энэ эрхийнхээ хүрээнд хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн, зөрчиж байгаа талаарх гомдол болон тухайн үеийн нөхцөл байдал зэрэгт дүн шинжилгээ хийж, төлөвлөгөөт болон гэнэтийн хяналт шалгалт, мониторинг, судалгааг тодорхой субъектүүдийг хамруулан дангаар болон холбогдох төр, иргэний нийгмийн байгууллагатай хамтран хийдэг. Судалгаанаас харахад ХЭҮК 2002-2016 он хүртэл 15 жилийн хугацаанд 457 удаагийн хяналт шалгалт хийсэн бөгөөд хүний эрх, эрх чөлөөг сэргээх, зөрчлийг арилгуулах зорилгоор 200 шаардлага, хүний эрх, эрх чөлөөг зөрчиж болзошгүй тохиолдол шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар өөрийн эрх хэмжээний хүрээнд 204 зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.[10]

ХЭҮК нь олон улсад дагаж мөрдөж буй хүний эрхийн зарчим, бусад хууль тогтоомжид тусгасан хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой хэм хэмжээ болон дангаар болон бусад байгууллагатай хамтран гүйцэтгэсэн судалгаа шинжилгээ, хяналт шалгалтын үр дүнд суурилсан санал, зөвлөмж боловсруулж хууль санаачлагч болон бусад эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх ажлыг тогтмол гүйцэтгэж байна. Тухайлбал, УИХ-аар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн хуулийн заалт хүний эрхийн зарчимд хэрхэн нийцэж байгаа талаар ХЭҮК-оос санал авдаг болсны дагуу “Хууль тогтоомж, бодлого шийдвэрийн төсөлд хүний эрхийн үүднээс дүн шинжилгээ хийх” ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг УИХ-аар хэлэлцэх хууль тогтоомжийн төслүүдтэй тухай бүр танилцан санал өгч байгаа бөгөөд 2013-2015 онд нийт 58 хууль, түүнтэй уялдан гарах журмын төслүүдэд дүн шинжилгээ хийж, холбогдох саналыг хууль санаачлагчдад хүргүүлсэн байна.[11]

[10] Хүний эрхийн төлөө хамтдаа зүтгэсэн 15 жил” Ж.Бямбадорж, ХЭҮК-ын дарга, Хууль зүйн ухааны доктор, профессор, Монгол Улсын гавьяат хуульч. “Хүний эрх” онол, арга зүйн сэтгүүл. 2016/01 дугаар 8 дахь тал.

[11] Хүний эрхийн төлөө хамтдаа зүтгэсэн 15 жил” Ж.Бямбадорж, ХЭҮК-ын дарга, Хууль зүйн ухааны доктор, профессор, Монгол Улсын гавьяат хуульч. “Хүний эрх” онол, арга зүйн сэтгүүл. 2016/01 дугаар 8 дахь тал.

В. Үнэлсэн байдал

ХЭҮК Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой аливаа асуудлаар санал, зөвлөмж гаргах, аливаа хууль тогтоомж, захиргааны шийдвэр хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар зөвлөмж, санал гаргах, мөн УИХ-ын чуулган, ЗГ-ын хуралдаан, төрийн байгууллагын хүсэлтээр зөвлөх эрхтэй оролцох, зөвлөгөө өгөх эрх хуулиар олгогдсон нь хуулийн зорилгод нийцсэн байна. Гэвч практик хэрэгждэггүй буюу УИХ, ЗГ, төрийн байгууллагын зүгээс зөвлөмж, зөвлөгөө авах хүсэлт гаргасан тохиолдол ховор байна. Иймд ХЭҮК-ын гишүүн өөрийн санаачлагаар оролцох эрхийг олгох шаардлага байна.

Практикт нийцэж буй байдал

А. Шалгуур үзүүлэлтийн томъёолол:

Хүний эрхийн үндэсний комиссоос Монгол Улс дахь хүний эрхтэй холбоотой аливаа асуудлаар гаргасан саналыг хэрэгжүүлэх асуудал практикт нийцэж байгаа эсэх?

Б. Судалсан байдал.

1998 онд батлагдсан “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийн 1.1.3.2.3-т “Улсын их хурал, байнгын хороод, Засгийн газрын хуралдаанаар хүний эрх, эрх чөлөөнд шууд холбогдох асуудлыг хэлэлцэхэд ХЭҮК-ын гишүүд өөрийн санаачлагаар оролцож, санал дүгнэлтээ мэдэгдэх эрхтэй болгоно” гэж заасан боловч энэ зорилт өнөөг хүртэл хэрэгжээгүй, Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуульд энэхүү эрхийг олгосон зохицуулалт ороогүй байна.[12] Иймд ХЭҮК-ын гишүүд бичгээр санал хүргүүлэхээс гадна УИХ-ын чуулган, ЗГ-ын хуралдаанд оролцож хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой асуудлаар санал, дүгнэлтээ шууд хэлэх эрх зүйн үндэс бүрдээгүй гэж үзэж байна.

Түүнчлэн ХЭҮК-оос өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжихгүй байх нь элбэг байна. Тухайлбал “Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 11 дэх илтгэлийн хавсралтад дурдсанаар өмнөх 10 дахь илтгэлд тусгасан санал зөвлөмжийн биелэлтийг харахад санал, зөвлөмжийн 5 биелээгүй, 2 хагас хэрэгжсэн, 1 бүрэн хэрэгжсэн гэх үзүүлэлт гарсан бол ХЭҮК-оос өмнөх 9 илтгэлд нийт 143 санал зөвлөмж өгсөн бөгөөд үүний хэрэгжилтийг тооцож үзэхэд зөвлөмжийн 41 нь буюу 28,6% бүрэн, 45 буюу 31,4% хагас хэрэгжиж 57 нь буюу 39,6% нь хэрэгжээгүй гэсэн судалгаа гаргасан байна.[13]

Үүнээс гадна ХЭҮК-оос гаргасан саналыг хууль тогтоомжийн төсөлд хэрхэн тусгаж буй талаар мэдээлэл байхгүй байгаа нь ХЭҮК өөрийн гаргасан саналыг хэрхэн хүлээн авсан, ямар үр дүнд хүрч байгаад тодийлон анхаарал хандуулахгүй байгаатай холбоотой байх магадлалтай. Зөвхөн ХЭҮК-оос гаргасан санал зөвлөмж тодийгүй тэдгээрийг хэлэлцэн, хэрэгжилтийг хангах үүднээс Хууль зүйн байнгын хорооноос гаргасан тогтоолын хэрэгжилт мөн адил хангалтгүй байгаа нь судалгаанаас харагдаж байна.

В. Үнэлсэн байдал

ХЭҮК-оос гаргасан зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, УИХ, ЗГ болон төрийн байгууллага тус комиссоос зөвлөмж, зөвлөгөө авах талаар хүсэлт гаргасан тохиолдлын тоо цөөн байгаа, Комиссын гишүүн өөрийн санаачлагаар дээрх байгууллагуудад зөвлөгөө өгөх эрх зүйн орчин бүрдээгүй зэргээс харахад энэ заалт практикт хэрэгжих байдал нь хангалтгүй гэх дүгнэлтэд хүргэж байна.

[12] “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь: Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн 2008 оноос хойших хэрэгжилт. Хавсралт тайлан ”. ХЗҮХ. 2016 он. Уб хот. 205 дахь тал.

[13] Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 11 дэх илтгэл. ХЭҮК. 2012 он. Уб хот.

13.1.3. Олон улсын хүний эрхийн гэрээний биелэлт, энэ тухай Засгийн газрын илтгэлийг боловсруулахад санал өгөх;

18.6.Энэ хуулийн 3.2-т заасан гишүүдээс нэг нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг хариуцна.

3.1.6 Хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь болон 18.6 дахь заалтын зорилгод хүрсэн төвшин ба практикт хэрэгжих байдал

А. Шалгуур үзүүлэлтийн томъёолол:

Хүний эрхийн үндэсний комисс Олон улсын хүний эрхийн гэрээний биелэлт, энэ тухай Засгийн газрын илтгэлийг боловсруулахад санал өгөх тухай зохицуулалт зорилгод хүрдэг эсэх?

Б. Судалсан байдал.

Монгол Улс НҮБ, түүний төрөлжсөн байгууллагуудаас батлан гаргасан хүний эрхийн гэрээнд нэгдэн орох, соёрхон батлах, хэрэгжүүлэх, тайлагнах журмын талаар Монгол Улсын Их хурлын дэгийн тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, Олон улсын гэрээний тухай хууль үйлчилж байна.[14] Мөн МУ нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилтийн тухай үндэсний илтгэл бэлтгэхтэй холбогдуулан Засгийн газраас 2009 онд "Журам батлах тухай /Үндэсний илтгэл бэлтгэх/" 362 дугаар тогтоолыг баталснаар үндэсний илтгэл бэлтгэж, хүргүүлэх үүргээ цаг хугацаанд нь биелүүлэх, хэлэлцүүлэх асуудалд ахиц гарсан байна.

Хүний эрхийн талаар гаргасан олон улсын баримт бичигт заасны дагуу хүний эрхийн үндэсний байгууллагад нэмэлт үүрэг ногдуулахдаа хүний нөөц, төсөв санхүүгийн асуудлыг хамтад нь шийдвэрлэж байх зарчимтай.

Гэвч ХЭҮК-т хуулиар хэд хэдэн нэмэлт үүрэг хариуцуулсан боловч шаардагдах эх үүсвэрийг өнөөг хүртэл шийдвэрлээгүй байна. Тухайлбал, 2011 онд УИХ-аас баталсан "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай" хуулийн 23, 24, 26 дахь заалтуудад ХЭҮК-ын гүйцэтгэх чиг үүргийг тусгасан. Энэ чиг үүргийн хүрээнд жендэрийн эрх тэгш байдлыг зөрчсөн тухай гомдол хүлээж авч шийдвэрлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавьж, энэ тухай 2 жил тутамд УИХ-д илтгэж байх үүрэг хүлээлгэсэн. Мөн МУ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 57 дугаар чуулганы 2002 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн A/Res/57/199 дүгээр тогтоолоор баталсан "Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протокол"-ыг 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдөр соёрхон баталсан. Тус конвенцид нэгдэн орсон гишүүн улс бүр протокол хүчин төгөлдөр болсноос, эсхүл соёрхон баталснаас хойш 1 жилийн дотор үндэсний түвшинд нэг болон түүнээс дээш урьдчилан сэргийлэх байгууллагыг байгуулах, томилох үүрэг хүлээдэг. Үүний дагуу манай улсад ХЭҮК хуулиар тогтоосон хүний эрхийг хамгаалах, хөхүүлэн дэмжих үндсэн үйл ажиллагаанаас гадна нэмэлт чиг үүргийг шинээр хэрэгжүүлэхээр болсон. Гэвч дээрх хуулиудаар хүлээлгэсэн нэмэлт үүргийг хэрэгжүүлэх мэргэшсэн боловсон хүчин болон нэмэлт чиг үүрэгтэй холбогдох хяналт шалгалтын үйл ажиллагааг тасралтгүй явуулах хангалттай санхүүгийн чадавхтай байх шаардлагыг хангаагүй буюу шаардлагатай төсөв санхүүжилт олгоогүй нь бэрхшээл үүсгэдэг байна.

Аливаа эрх зүйн баримт бичгийн биелэлтийг тодорхойлоход шаардлагатай мэдээлэл, санал бэлтгэх ажилд бодит нөхцөл байдлыг илрүүлэхэд чиглэсэн судалгаа шинжилгээний, үнэлгээний ажил зайлшгүй шаардагддаг. Гэтэл төсөв санхүүжилт хүрэлцээгүйн улмаас өргөн уудам нутаг дэвсгэрт хүн ам тархан суурьшсан манай улсад хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтоох, улмаар Олон улсын хүний эрхийн гэрээний биелэлт, энэ тухай Засгийн газрын илтгэлийг

[14] "Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь: Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн 2008 оноос хойших хэрэгжилт. Хавсралт тайлан ". ХЗҮХ. 2016 он. Уб хот. 126 дахь тал.

боловсруулахад хэрэглэгдэхүйц, бүрэн төгс мэдээлэл, санал боловсруулах ажил хүндрэлтэй хэвээр байна.

В. Үнэлсэн байдал

ХЭҮК МУ-ын Олон улсын хүний эрхийн гэрээний биелэлт, энэ тухай Засгийн газрын илтгэлийг боловсруулахад санал өгөх үүргээ өөрийн нөөц бололцооны хүрээнд тогтмол хэрэгжүүлж ирсэн байна. Үүнээс харахад хуулийн энэ заалт уг хуулийн "ХЭҮК-ын үйл ажиллагааны зарчим, эрх зүйн үндсийг тодорхойлох, түүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах" үндсэн зорилттой нийцэж байгаа боловч үндэсний хэмжээний илтгэлд санал боловсруулах ажлын суурь болсон судалгаа, шинжилгээний ажилд шаардлагатай боловсон хүчин, төсөв санхүүгийн хүрэлцээ хангалтгүй байгаа зэргээс үүдэн хуулийн заалт практикт бүрэн хэрэгжиж чадахгүй байх магадлалтай.

Г. Санал зөвлөмж

ХЭҮК хуулиар олгогдсон эрхийн дагуу Олон улсын хүний эрхийн гэрээний биелэлт, энэ тухай Засгийн газрын илтгэлийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, бодит нөхцөл байдалд нийцсэн санал боловсруулахад шаардлагатай судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд хүрэлцэхүйц мэргэшсэн боловсон хүчин, төсөв санхүүгийн баталгаат байдлыг хангах талаар анхаарах шаардлагатай байна.

13.2.1. хүний эрхийн асуудлаар судалгаа явуулж, шаардлагатай мэдээллээр хангах;

3.1.7 Хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1 дэх заалтын зорилгод хүрсэн төвшин ба практикт хэрэгжих байдал

А. Шалгуур үзүүлэлтийн томъёолол:

Хүний эрхийн үндэсний комисс хүний эрхийн асуудлаар судалгаа явуулж, шаардлагатай мэдээллээр хангах хуулийн зохицуулалт зорилгод хүрдэг эсэх?

Б. Судалсан байдал.

ХЭҮК-оос гүйцэтгэж буй судалгааны ажлууд гол төлөв цаг үеийн шинжтэй, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, тэднээс ирж буй санал, тулгамдаж буй асуудалд үндэслэдэг жишиг тогтсон байна.

ХЭҮК 2001-2012 оны хооронд хүний эрх, эрх чөлөөг хөхүүлэн дэмжихтэй холбоотой 30 төсөл хэрэгжүүлсэн бөгөөд эдгээрийн дийлэнх хувийг НҮБ-ын аль нэг Олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөр, гадаад орны санхүүжилттэйгээр гүйцэтгэсэн байна.[15]

Судалгааны ажлын чиглэлээр Улаанбаатар хотод шилжин ирсэн бүртгэлгүй иргэдийн эрх, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалт, Хүний эрхийн боловсрол, Цаатан иргэд, үндэсний цөөнхийн эрх, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд, Ахмад настны эрх, Уул уурхайн үйлдвэрлэлээс хүний эрхэд үзүүлж буй нөлөө зэрэг өргөн хүрээний сэдэв, агуулгыг хамарсан 56 судалгааны ажлыг 2016 он хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн байна. Хүний эрхийн тулгамдаж буй асуудлаар судалгаа хийхдээ хөндлөнгийн үнэлгээ, бодлогын дүн шинжилгээ, хяналт шалгалт зэргээр цогц байдлаар хэрэгжүүлж, эдгээрт Засгийн газрын агентлаг, албад, иргэний нийгмийн байгууллагууд болон хараат бус судлаач, шинжээч зэргийг оролцуулан зохион байгуулж, үр дүнг үндэслэн зохих санал, зөвлөмжүүд боловсруулан Хүний эрхийн төлөв байдлын илтгэлд тусган ажилладаг байна. Мөн ХЭҮК-ын 2015-2020 оны Стратеги төлөвлөгөөнд Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах, чадваржуулах, Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хүний

[15] "Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь: Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн 2008 оноос хойших хэрэгжилт. Хавсралт тайлан ". ХЗҮХ. 2016 он. Уб хот. 201 дэх тал.

эрхийн үнэлгээ, шинжилгээ, нөлөөллийн үйл ажиллагаа хийхээр тусгасан байна.[16]

ХЭҮК-оос зохион байгуулах ажлын цар хүрээг хууль тогтоомжоор өргөн тодорхойлж өгсөн боловч түүнд тохирсон үйл ажиллагааны төсөв санхүүг хангалттай олгодоггүй тухай тус комиссын тайлангуудад байнга дурдахын зэрэгцээ УИХ, ЗГ-т зөвлөмж хүргүүлж байсан байна.

Хэдийгээр ХЭҮК-т улсын төсвөөс олгож буй санхүүжилт хангалтгүй байгаа ч комиссын тайлангаас харахад үйл ажиллагааны зардал болон хүний нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр төрөөс анхаарч ирсэн гэж үзэж байна. Тухайлбал, 2006 онд 12 орон тоотой, 80,431,500 төгрөгийн төсөвтэй байсан бол 2012-2014 он хүртэл тогтмол өсөж 954 орчим сая төгрөгийн төсөвтэй байгууллага болж өргөжсөн байна.[17] Харин 2015 оноос эхлэн улсын төсвөөс олгох санхүүжилтийн хэмжээ буурчээ. Энэ нь хэд хэдэн чиг үүрэг шинээр нэмэгдэж буй ХЭҮК-ын үйл ажиллагааг сааруулах, үр дүнг бууруулах эрсдэл үүсгэж байна. 2016 онд Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс гаргасан “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь: Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн 2008 оноос хойших хэрэгжилт. Хавсралт тайлан ”-д дээрх дүгнэлтийг бататгахын зэрэгцээ “ХЭҮК төсөв, санхүүгийн нөөц бололцооноос хамааран үндсэн чиг үүргээ бүрэн гүйцэд хэрэгжүүлж чадахгүй байна. Хэрэгжүүлэгч субъектүүдийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаа харьцангуй бие даасан шинжтэй, тэдгээрийн хоорондын харилцаа уялдаа холбоо сул, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд богино хугацаатай зэрэг асуудлаас үүдэн нийгэмд үзүүлж буй үр нөлөө, хүрч буй үр дүн сул байна.” гэсэн дүгнэлт гаргасан байна.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэлүүд дэх ХЭҮК-оос хийсэн судалгааны ажлуудад дүн шинжилгээ хийхэд гол төлөв нийгэм, улс төрийн төвшинд тухайн цаг үед ямар нэгэн байдлаар анхаарал татаж буй асуудлуудын хүрээнд судалгаа, нөхцөл байдлын дүн шинжилгээ хийдэг гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Тухайлбал МУ Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид нэгдсэн 2004 он, түүний нэмэлт протоколыг соёрхон батлсан 2014 онуудад эрүү шүүлтийн чиглэлээр, 2011 оноос жендэрийн тэгш эрх, хүйсийн ялгаатай байдлын талаар, сонгуулийн жилүүдэд сонгогчийн болон хэвлэн нийтлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хүрээнд гол анхаарлаа хандуулан судалгааны ажил гүйцэтгэсэн байна.

В. Үнэлсэн байдал

Тус зааллтай холбогдох асуудлыг судалж үзсэний үндсэн дээр энэхүү зааллтын зорилгодоо хүрэх болон практикт хэрэгжих боломж төсөв санхүүгийн улмаас хязгаарлагдмал байна. Улсын төсвөөс олгогдож буй санхүүжилтийн хэмжээ албан хаагчдын цалингийн зардлын хэмжээтэй дүйцэж байгаа нь улсын хэмжээнд судалгаа шинжилгээний ажил хийх, хүний эрхийн хэрэгжилтийн талаарх бодит нөхцөл байдлыг улсын хэмжээнд тогтоох үйл ажиллагаа явуулахад хангалтгүй байна. Тиймээс зөвхөн нийгэм, улс төр, олон нийтийн анхаарал төвлөрсөн асуудлын хүрээнд судалгаа хийж, судалгааны үр дүнд суурилсан мэдээллээр хангах боломж бүрдсэн гэж үнэлж байна.

Комисс нь УИХ-аас байгуулагддаг бие даасан, хараат бус байгууллага боловч уг байгууллагын төсвийн хэмжээг Сангийн яам танах, хасах зэргээр тогтоож байгаа нь улсын хэмжээнд тогтвортой үйл ажиллагаа явуулахад хүндрэл учруулдаг байна.

[16] Хүний эрхийн төлөө хамтдаа зүтгэсэн 15 жил” Ж.Бямбадорж, ХЭҮК-ын дарга, Хууль зүйн ухааны доктор, профессор, Монгол Улсын гавьяат хуульч. “Хүний эрх” онол, арга зүйн сэтгүүл. 2016/01 дугаар 8 дахь тал.

[17] Мөн тэнд.

Г. Санал

Комисст хүний эрхийн нөхцөл байдлыг улсын хэмжээнд тодорхойлох, хууль тогтоомж, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд хангалттай санхүүжилт олгох асуудлыг судлах;

Комиссын төсвийг УИХ-аас баталдаг байх

13.2.2. олон улсын, бүсийн, хүний эрхийн бусад үндэсний байгууллагатай хамтран ажиллах;

3.1.8. Хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.2 дахь заалтын зорилгод хүрсэн төвшин ба практикт хэрэгжих байдал

А. Шалгуур үзүүлэлтийн томъёолол:

Хүний эрхийн үндэсний комисс олон улсын, бүсийн, хүний эрхийн бусад үндэсний байгууллагатай хамтран ажиллах тухай зохицуулалт зорилгод хүрдэг эсэх?

Б. Судалсан байдал.

ХЭҮК байгуулагдсан цагаасаа олон улсын болон бүс нутгийн хүний эрхийг хамгаалах тогтолцооны хүрээнд амжилттай ажиллаж байна. Тухайлбал, 2002 онд Ази, Номхон Далайн бүс нутгийн Хүний эрхийн үндэсний байгууллагуудын чуулганы 10 дахь гишүүнээр элсэн орсон.

Хүний эрхийн үндэсний байгууллагуудыг Олон улсын зохицуулах хорооноос дэлхийн улс орнуудын хүний эрхийн үндэсний байгууллагуудыг магадлан итгэмжилж, Парисын зарчимд нийцсэн эсэхийг үнэлж “А”,”В”, “С” статус олгодог бөгөөд МУ-ын ХЭҮК 2003, 2008, 2014 онуудад нийт 3 удаа “А” статустай магадлан итгэмжлэгдсэн байна. Мөн 2015 онд Олон улсын зохицуулах хорооны шийдвэр гаргах үндсэн бүтэц болох Товчооны гишүүнээр сонгогдсон, 2015 оны 8 дугаар сараас Ази Номхон далайн бүс нутгийн Хүний эрхийн үндэсний байгууллагуудын чуулганыг даргалж байна.

Үүнээс гадна ХЭҮК-ын гишүүн П.Оюунчимэг Ази Номхон далайн бүс нутгийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын чуулганы бага хурлаар Хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хамгаалах үндэсний байгууллагуудын Олон улсын зохицуулах хорооны Бизнес ба хүний эрхийн асуудлаарх Ажлын хэсгийн гишүүнээр, мөн Ази Номхон далайн бүс нутаг дахь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Элчин сайд хөтөлбөрт ХЭҮК-ын Бодлого, дүн шинжилгээ, хүний эрхийн боловсролын хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнийн хамт сонгогдон ажиллаж байна.[18]

Дээрхээс харахад гадаад харилцааг хөгжүүлэх, хамтран ажиллах цар хүрээг нэмэгдүүлэх чиглэлээр чамлахааргүй ахицтай ажиллаж байна. 2015 оны байдлаар Шинэ Зеланд, БНСУ, Мьянмар Улсын хүний эрхийн байгууллага, Данийн хүний эрхийн хүрээлэнтэй хүний эрхийн чиглэлээр хамтран ажиллах санамж бичиг байгуулсан ба эдгээр байгууллагуудын төлөөлөл манай ХЭҮК-т айлчилж сургалт хийх, туршлага судлах ажлууд хийгдсэн байна.

Үүнээс гадна гадаад хамтын ажиллагаанд тулгуурлан Ази Номхон далайн бүс нутгийн Хүний эрхийн байгууллагуудын чуулганы Х, ХХ хуралдаан, “Монгол Улс дахь уул уурхайн бизнес ба хүний эрх” олон улсын бага хурал, Азийн хүүхдийн эрхийн чуулга уулзалт зэрэг олон улсын хурал, зөвлөгөөнийг эх орондоо зохион байгуулжээ.[19]

ХЭҮК бие даасан, хараат бус байгууллагын хувьд төрийн, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах талаар тодорхой ажлууд

[18] Хүний эрхийн төлөө хамтдаа зүтгэсэн 15 жил” Ж.Бямбадорж, ХЭҮК-ын дарга, Хууль зүйн ухааны доктор, профессор, Монгол Улсын гавьяат хуульч. “Хүний эрх” онол, арга зүйн сэтгүүл. 2016/01 дугаар 11 дэх тал.

[19] Хүний эрхийн төлөө хамтдаа зүтгэсэн 15 жил” Ж.Бямбадорж, ХЭҮК-ын дарга, Хууль зүйн ухааны доктор, профессор, Монгол Улсын гавьяат хуульч. “Хүний эрх” онол, арга зүйн сэтгүүл. 2016/01 дугаар 11 дэх тал.

зохион байгуулдаг. Хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хүний эрхийг хязгаарладаг эрх мэдэлтэй, хөндлөнгийн хяналтгүй тохиолдолд хүний эрхийн зөрчил гаргах эрсдэлтэй гэж үздэг төрийн тусгай чиг үүргийн байгууллагуудтай, тухайлбал УЕПГ, ЦЕГ, АТГ, ШШГЕГ, ТЕГ, ХХЕГ, Зэвсэгт хүчний жанжин штаб зэрэг газруудтай "Хамтран ажиллах санамж бичиг" байгуулан ажилладаг. Үүний үр дүн эрүүдэн шүүх аливаа хэлбэрийг гаргуулахгүй байх, дүрмийн бус харилцааг таслан зогсооход чухал ач холбогдолтой гэж үзжээ.

ХЭҮК хүний эрхийн талаар үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудтай олон талт хамтын ажиллагаа явуулж байна. Гадаад улсын Засгийн газар, хөгжлийн агентлаг, НҮБ-ын болон бусад олон улсын байгууллагын санхүүжилтээр судалгаа хийлгэх, хамтарсан хяналт шалгалт, мониторинг хийх, тэднээс төрийн байгууллага, нийгэмд хандсан хүсэлт, шаардлагыг дэмжих, санамж бичиг байгуулах зэргээр ажиллаж, хагас, бүтэн жилээр уулзалт хийж харилцан мэдээлэл солилцдог байна. Мөн ХЭҮК-ын тухай хуульд зааснчлан, ХЭҮК-ын дэргэд Орон тооны бус зөвлөлийг 2002 оноос хүний эрхийн чиглэлээр ажилладаг ТББ-ын төлөөллийн оролцоотойгоор байгуулан ажиллуулдаг байна.

Иргэний нийгмийн байгууллага ба Хүний эрхийн үндэсний байгууллагын хамтын ажиллагаа мөн Парисын зарчимд үндэслэгдэх бөгөөд зарчмын хэрэгжилтийн үр нөлөөг сайжруулахад Ази Номхон далайн Бүсийн чуулган, Хүний эрхийг хамгаалах, хөхүүлэн дэмжих хороо /ICC/ Хүний эрх, хөгжлийн төлөөх Азийн Форум зэрэг бүтцүүд ажилладаг. Форумын үйл ажиллагааны үндсэн гол чиглэлийн нэг бол Азийн төрийн бус байгууллагуудын сүлжээ /АННИ/ юм. 2006 онд Бангкок хотноо үүсгэн байгуулагдсан энэ сүлжээ нь хүний эрхийн үндэсний байгууллагуудыг ил тод, үр дүнтэй, бие даасан, хариуцлагатай хөгжүүлэх, бий болгоход дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах зорилготой. Сүлжээний гишүүн орнууд өөрийн орны хүний эрхийн үндэсний байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ хийж, жил бүр тайлан бэлтгэн хүргүүлдэг байна. Монгол Улсын хувьд уг тайланг "Хүний эрх, хөгжил төв" удирдан боловсруулдаг бөгөөд 2015 оны байдлаар нийт 9 удаагийн хөндлөнгийн тайлан бэлтгэж хүргүүлсэн байдаг. Эдгээр тайлангуудын хүрээнд нийт 39 зөвлөмж өгсөн бөгөөд гол агуулга нь ХЭҮК-ын бүтцийг олон талын төлөөллийг оролцуулах зарчимд нийцүүлэх, гишүүний томилгоо, түүнд тавигдах шаардлага, ил тод байдал, чиг үүргээ хэрэгжүүлэхэд хангалттай санхүүжилт авах, ТББ-тай хамтын ажиллагааг сайжруулах, гаргасан шийдвэрээ хэрэгжүүлэхэд анхаарах, хэрэгжилтэд мониторинг хийх, Комиссын тухай хуулийг Парисын зарчимд нийцүүлэх зэрэг асуудлыг хөндсөн байна. Харин зарим зөвлөмжийн хэрэгжилт хангагдаж байгаа ч зарим зөвлөмж удаа дараа өгөгдөж байгааг анхаарах, олон улсын гэрээ, конвенцийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, хууль тогтоомжоо шуурхай батлуулах зэрэг санал өгсөн байна.[20]

В. Үнэлсэн байдал

ХЭҮК олон улсын, бүсийн, хүний эрхийн бусад үндэсний байгууллагатай хамтран ажиллах тухай зохицуулалт нь хүний эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулах, хөхүүлэн дэмжих зорилгод нийцсэн байна. ХЭҮК-ын хэрэгжүүлж буй үйл ажиллагаа энэ заалтын зорилгод хангалттай сайн нийцэж байх бөгөөд практикт нийцэх байдал нь мөн адил хангалттай сайн гэж үнэлж байна.

Энэхүү заалтын хэрэгжилт сайн байхад гадаадын хүний эрхийн байгууллагуудын идэвхи санаачлага, манай байгууллагыг дэмжих хүсэлт их байдаг нь голлох нөлөө үзүүлдэг байна. Комисс нь одоогоор зөвхөн олон улсын байгууллагын гишүүнчлэлийн төлбөрөө төлдөг бөгөөд бусад зардал гадаадад Монгол Улсыг төлөөлөн оролцоход хүрэлцдэггүй байна. Тухайлбал ХЭҮК-ын төсөвт

[20] "Иргэний нийгмийн байгууллага ба хүний эрхийн үндэсний байгууллагын хамтын ажиллагааны үр нөлөө, түүнийг сайжруулах нь: олон улсын туршлага" Г.Уранцоож. Хүний эрх, хөгжлийн төлөөх Азийн Форум болон Хүний эрх хөгжил төвийн тэргүүн. Хүний эрх" онол, арга зүйн сэтгүүл. 2016/01 дугаар 38 дахь тал

гадаад зардалд сард 500,000 төгрөг тусгагддаг бөгөөд энэ нь гадаад томилолт болон замын зардалд хүрэлцдэггүй.

> 13.2.3. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар илтгэл бичих;
> **20 дугаар зүйл. Комиссын илтгэл**
> 20.1. Комисс нь Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар жил бүрийн эхний улиралд багтаан Улсын Их Хуралд илтгэнэ.

3.1.9 Хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.3 дахь заалт болон 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалтын зорилгод хүрсэн төвшин ба практикт хэрэгжих байдал

А. Шалгуур үзүүлэлтийн томъёолол:

Хүний эрхийн үндэсний комисс Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар илтгэл бэлтгэж, түүнийгээ жил бүрийн эхний улиралд багтаан Улсын Их Хуралд илтгэх тухай зохицуулалт зорилгод хүрдэг эсэх?

Б. Судалсан байдал.

Монгол Улс дахь хүний эрх чөлөөний толь бол жил бүр УИХ-д өргөн барьдаг “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл” юм. ХЭҮК 2002 оноос эхлэн өөрийн болон төрийн, иргэний нийгмийн, судалгааны зэрэг байгууллагуудаас хийсэн судалгаа, хяналт шалгалт, хянан шийдвэрлэсэн гомдлын байдалд, тэдгээрийн үр дүнд үндэслэн МУ дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар 16 илтгэл боловсруулж, УИХ-д өргөн барьсан байна. Эдгээр илтгэлүүдэд хүний эрх, эрх чөлөөний талаарх өргөн цар хүрээтэй асуудлыг хамруулсан төдийгүй зарим асуудлыг тухайн үеийн нөхцөл байдал, шаардлагыг харгалзан хэд хэдэн удаа тусгажээ. УИХ-д өргөн барьсан нийт 16 илтгэлээс 1,3,4 дэх илтгэлийг огт хэлэлцээгүй, 5 дахь илтгэлийг УИХ-ын нэгдсэн хуралдаанаар, бусдыг Хууль зүйн байнгын хороогоор, гэхдээ 13,14 дэх илтгэлийг нэгтгэн хэлэлцэж байжээ. Эдгээр илтгэлд 2016 оны байдлаар хүний эрхийн тулгамдсан асуудлаар УИХ-аас шийдвэр гаргуулахаар нийт 278 санал, зөвлөмж хүргүүлсэн байна. Сүүлийн жилүүдэд УИХ-ын Хууль зүйн байнгын хороогоор илтгэлийг хэлэлцэж, зайлшгүй шаардлагатай зарим асуудлаар олон заалт бүхий тогтоол гаргадаг болсон нь сайн талтай боловч ЗГ, төрийн холбогдох байгууллага тэдгээрийг бүрэн хэрэгжүүлэхгүй байна. Тухайлбал, илтгэлүүдийг УИХ болон байнгын, дэд хороодын зүгээс хэлэлцсэн байдлаас товч харахад 2013 оны 12 сарын 31-ний өдөр УИХ-ын ХЗБХ “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл”-ийг хэлэлцэн 15 дугаар тогтоолыг, 11 дүгээр илтгэлийг УИХ-ын Байнгын хороогоор хэлэлцэж 2013 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 02 дугаар тогтоолыг[21], 12 дахь илтгэлийг УИХ-ын ХЗБХ-ны 2013 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж 3 дугаар тогтоолыг, 13 дахь болон 14 дэх илтгэлийг УИХ-ын ХЗБХ, Хүний эрхийн дэд хороо 2015 оны 10 сарын 1-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд 28, 29 дүгээр тогтоолыг тус тус гаргасан. Дээрх тогтоолуудаар тодорхой арга хэмжээ авч ажиллахыг даалгасан ажлуудын дийлэнх нь өнөөг хүртэл хэрэгжээгүй, харин хууль тогтоомж болон холбогдох дүрэм, журмыг өөрчлөх талаар гаргасан шийдвэрүүд харьцангуй сайн хэрэгжсэн байна. Тухайлбал, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизм байгуулах, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцтой холбоотой зөвлөмжүүдээс бусад зөвлөмжийн хэрэгжилт харьцангуй сайн байна гэж дүгнэсэн байна.[22]

В. Үнэлсэн байдал

Дээр дурдсан нөхцөл байдлыг дүгнэж үзвэл ХЭҮК Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл бэлтгэж, УИХ-д илтгэх зорилгоо хангалттай хэрэгжүүлж байгаа боловч түүний практик ач холбогдол нь хангалттай биш байна. Иймээс ч ХЭҮК-ын дарга Ж.Бямбадорж УИХ Монгол Улс дахь хүний эрх, эрх

[21] УИХ-ын Байнгын хорооны 2013 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний комиссын 11 дэх илтгэлийг хэлэлцсэн тухай” 02 дугаар тогтоол. “Хүний эрх” онол, арга зүйн сэтгүүл. 2013/01 дугаар 84 дэх тал.

[22] Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл. ХЭҮК. 2015 он.Уб хот

чөлөөний байдлын талаарх илтгэлийг хэлэлцэхдээ түүнд тусгагдсан асуудлуудад онцгой анхаарч, хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулах бодлого, эрх зүйн орчинг сайжруулах талаар тодорхой арга хэмжээ авах цаг болсон гэж үзсэн байна.[23]

Түүнчлэн Комисс хүний эрх, эрх чөлөөний талаарх илтгэлээ УИХ-д илтгэнэ гэж зохицуулсан нь энэхүү илтгэх процессыг хэрхэн хэрэгжүүлэх тухайд ойлгомжгүй байдал үүсгэдэг байна. Иймд энэхүү асуудалд хуулийн тайлбар хийх, нарийвчлан зохицуулах шаардлагатай гэж үзэж байна. Тухайлбал, илтгэнэ гэдэгт УИХ-ын даргад илтгэлийг өргөн барих, эсхүл УИХ-ын чуулганаар илтгэх үйл явцын алиныг ойлгохыг тайлбарлах шаардлага тулгамдаж байна. Учир нь практикт аль нэг улс төрийн амьдралд гарч буй өөрчлөлтийн, тухайлбал сонгуулийн дараа шинээр бүрдэж буй бүтэц бүр дээрх зохицуулалтыг өөр өөрөөр тайлбарлах явдал байнга гардаг. Хамгийн сүүлд 2016 оны илтгэлийг цахим хэлбэрээр авах нь “илтгэх” гэсэн ойлголтод багтана гэж үзэж байна.

Г.Санал зөвлөмж

ХЭҮК–оос хуулийн хугацаанд бэлтгэсэн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг тогтмол хэлэлцүүлэх, санал, зөвлөмжтэй холбоотой гаргасан Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийг хангуулах тухайд дорвитой арга хэмжээ авах шаардлага байна.

Мөн Комиссын илтгэлийг хэлэлцэх асуудлыг тодорхой болгох, тухайлбал УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг гаргадаг байх, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаар Комисст мэдэгддэг байх асуудлыг хуульчлах шаардлагатай гэж үзэж байна. Ингэснээр үндэсний хэмжээнд хүний эрхийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг зөвхөн Хууль зүйн байнгын хороогоор хэлэлцүүлж, тогтоол гаргаж байгаад өөрчлөлт хийх боломжтой юм.

Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг “илтгэнэ” гэх ойлголтыг нэг мөр болгох, процессыг зохистой байдлаар хуульчлах шаардлагатай.

13.2.4. хүний эрхийн талаарх хууль тогтоомж, олон улсын гэрээг олон нийтэд сурталчлах;

3.1.10 Хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.4 дэх заалтын зорилгод хүрсэн төвшин ба практикт хэрэгжих байдал

А. Шалгуур үзүүлэлтийн томъёолол:

ХЭҮК хүний эрхийн талаарх хууль тогтоомж, олон улсын гэрээг олон нийтэд сурталчлах тухай зохицуулалт зорилгод хүрдэг эсэх? Мөн энэ зохицуулалтыг практикт хэрэгжүүлэх боломж бүрдсэн эсэх?

Б. Судалсан байдал.

Комиссоос хуулиар хүлээлгэсэн энэхүү чиг үүргийн хүрээнд хүний эрхийн товхимол, эвхмэл хуудас хэвлүүлж түгээхийн зэрэгцээ телевиз, радиогийн цуврал нэвтрүүлэг, шторк, хүүхдэд зориулсан радио жүжиг, гар, фото зургийн уралдаан, мэтгэлцээн, олон нийтийн лекц, өглөөний уулзалт, хэлэлцүүлэг зэрэг олон талт үйл ажиллагааг зохион байгуулж, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийг ашиглан сурталчилгааны ажил явуулж, “Хүний эрх” сэтгүүл гаргаж байна. Өдөр тутмын зарим сонинд “Хүний эрхийн булан” хөтөлж, 7 хоног бүр хүний эрхийн асуудлаар нийтлэл, ярилцлага, мэдээлэл бэлтгэн иргэдэд хүргэж байна. Өнгөрсөн хугацаанд Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх МУ-ын ээлжит илтгэлүүд, НҮБ-ын холбогдох хороодоос МУ-ын ЗГ-т өгсөн зөвлөмжүүдийн эмхэтгэл, Хүний эрхийн товч тайлбар, Хүний эрхийн олон улсын Билл зэрэг 197 төрлийн ном товхимол, гарын авлага хэвлэн гаргажээ. Мөн 2001 оноос хойш хэвлүүлсэн монгол, англи

[23] “Хүний эрхийн төлөө хамтдаа зүтгэсэн 15 жил” Ж.Бямбадорж, ХЭҮК-ын дарга, Хууль зүйн ухааны доктор, профессор, Монгол Улсын гавьяат хуульч. “Хүний эрх” онол, арга зүйн сэтгүүл. 2016/01 дугаар 8 дахь тал.

хэл дээрх бүх ном товхимол, судалгааны тайлан, “Хүний эрх” эрдэм шинжилгээ, онол, практикийн сэтгүүл, “Хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын илтгэл”-үүдийг багтаасан “Хүний эрхийн цахим номын сан”-г 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн ажиллуулж байна.[24]

ХЭҮК зөвхөн Улаанбаатар хот төдийгүй хөдөө орон нутагт хүрч ажиллах чиглэл баримтлан ажилладаг бөгөөд үүний нэг гол арга хэмжээ бол “Хүний эрхийн нээлттэй өдөрлөг” арга хэмжээ юм. Энэ хүрээнд улсын хэмжээнд нийт 80 удаа, нэг аймагт дунджаар 3-4 удаа ажиллажээ.[25] Үүнээс гадна Хүний эрхийн олон улсын өдрийг угтсан үйл ажиллагааны хүрээнд хэвлэл мэдээллийн хэрэгслээр тодорхой сэдэвт ажлыг зохион байгуулах, сэтгүүлчдийн дунд уралдаан зарлах, чиглэсэн сургалт хийх зэрэг ажил хийдэг.

Комиссын дэргэд “Хүний эрхийн төлөө сэтгүүлчид клуб”-ыг 2012 оноос байгуулан ажиллуулсан бөгөөд 2016 оны байдлаар 18 сэтгүүлч нэгдээд байна. Тус клуб нь хүний эрхийн мэргэшсэн сэтгүүлч бэлтгэх бодлого барьж ажилладгаараа онцлог юм.

УИХ-аас 2011 оноос эхлэн ХЭҮК-ын орон тоо, төсвийг нэмэгдүүлсэн, 2014 оноос эхлэн аймаг бүрт хүний эрхийн ахлах мэргэжилтэн ажиллуулах шийдвэрийг хэрэгжүүлж байгаа боловч 2016 онд тус комиссын төсвийг танаснаар эдгээр үйл ажиллагааны үр дүн, хүртээмжид сөрөг үр дагавар үзүүлэх эрсдэл бий болгож байна.

В. Үнэлсэн байдал

ХЭҮК хүний эрхийн талаарх хууль тогтоомж, олон улсын гэрээг олон нийтэд сурталчлах зорилгод хүрч ажилласан бөгөөд практикт хэрэгжүүлж буй байдал тус байгууллагын үйл ажиллагаанд зарцуулагдахаар олгогдсон санхүүжилтийн хүрээнд харьцангуй сайн хийгддэг гэж үнэлж болохоор байна.

ХЭҮК-ын иргэд олон нийтийн хүний эрхийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хүний эрхийн боловсрол олгох, хүний эрхийн соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны үр дүнд иргэдийн хүний эрхийн холбогдолтой хууль тогтоомжийн мэдлэг дээшилсэн гэж дүгнэж байна.

Үүнээс гадна олон улсын гэрээ, конвенцийг сурталчлах ажлыг уялдуулах шаардлага байна. Тухайлбал, хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн дагуу тухайн асуудлыг хариуцсан яам олон улсын гэрээг орчуулах, сурталчлах ажлыг зохион байгуулах үүрэг хүлээсэн байдаг. Үүний зэрэгцээ Комисс болон бусад хууль сурталчлах чиг үүрэг бүхий байгууллагуудад мөн адил энэ үүргийг хүлээлгэсэн байдаг. Гэтэл эдгээр байгууллагуудын хоорондын уялдаа холбоог сайжруулах арга хэмжээ дутагдаж байна. Ялангуяа олон улсын гэрээ, конвенцийн орчуулгын асуудал, тэдгээрийг хууль, хяналтын байгууллагууд хэрэглэх асуудлыг нэн даруй шийдвэрлэх асуудалд Засгийн газрын зүгээс онцгой анхаарах шаардлага байна.

Г. Санал зөвлөмж

ХЭҮК-оос хүний эрхийн талаарх хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенцийн талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, тэдний мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг олгох, хүний эрхийн мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх, тэдгээрийг тогтвор суурьшилтай ажиллуулах зэрэг асуудалд анхаарах шаардлага байна.

Олон улсын гэрээ, конвенцийг сурталчлах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах шаардлагатай.

---

[24] “Хүний эрхийн төлөө хамтдаа зүтгэсэн 15 жил” Ж.Бямбадорж, ХЭҮК-ын дарга, Хууль зүйн ухааны доктор, профессор, Монгол Улсын гавьяат хуульч. “Хүний эрх” онол, арга зүйн сэтгүүл. 2016/01 дугаар 8 дахь тал.

[25] Хүний эрхийн төлөө хамтдаа зүтгэсэн 15 жил” Ж.Бямбадорж, ХЭҮК-ын дарга, Хууль зүйн ухааны доктор, профессор, Монгол Улсын гавьяат хуульч. “Хүний эрх” онол, арга зүйн сэтгүүл. 2016/01 дугаар 8 дахь тал.

13.2.5. хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих

3.1.11 Хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.5 дахь заалтын зорилгод хүрсэн төвшин ба практикт хэрэгжих байдал

А. Шалгуур үзүүлэлтийн томъёолол:

Хүний эрхийн үндэсний комисс хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих тухай зохицуулалт зорилгод хүрдэг эсэх? Мөн уг заалтыг практикт хэрэгжүүлэх боломж бүрдсэн эсэх?

Б. Судалсан байдал.

ХЭҮБ-ын үйл ажиллагааны үндсэн 2 чиглэлийн нэг бол “Хүний эрхийг хөхүүлэн дэмжих үйл ажиллагаа” юм. Энэ чиг үүргийн хүрээнд хүний эрхийн боловсрол олгохтой холбогдох үйл ажиллагаанууд бүхэлдээ багтана. Энэ хүрээнд хүний эрхийн тухай мэдээллээр хангах, хүний эрхийг хүндэтгэхэд чиглэсэн үнэт зүйлс хандлагыг дэмжих, хүний эрхийн зөрчлөөс хамгаалахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжин хэрэгжүүлэх гэсэн үндсэн гурван зорилго, үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Эдгээр зорилгуудын Парисын зарчмуудад нийцсэн байдал нь хүний эрхийн үндэсний байгууллагыг НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл болон олон улсын хүний эрхийн бусад тогтолцоо, механизмын хэлэлцүүлэгт оролцох зэрэг эрх бүхий магадлан итгэмжлэлийн үндсэн шалгуур болж өгдөг.[26]

Олон улсын баримт бичгүүдэд тусгаснаар “Хүний эрхийн боловсрол гэдэгт хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн харьцах, өв тэгш хөгжүүлж, түүний эрхэм зэргийг дээдлэх, чөлөөт нийгэмд үр ашигтайгаар оролцох зэрэг мэдлэг чадвар, хандлагуудыг төлөвшүүлэх, хүний эрхийн түгээмэл соёл бүрдүүлэхэд чиглэсэн сургалт, мэдээлэл, түгээн дэлгэрүүлэх бүхий л үйл ажиллагааг ойлгоно” гэж заасан байдаг. Энэ нь хүний эрхийн боловсрол олгох асуудлыг их өргөн хүрээнд авч үздэгийн илрэл юм.

ХЭҮБ-ууд нь боловсролын хөтөлбөр болон бусад үйл ажиллагаагаараа хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг дэмждэг. Энэхүү үйл ажиллагаа нь албан болон албан бус сургалтын хэлбэрээр хүний эрхийн суурь мэдлэг олгохоос эхлээд эрх зүйн зарим асуудлыг тайлбарлах хүртэл өргөн цар хүрээг хамардаг бөгөөд хүний эрхийн үндэсний байгууллагын үйл ажиллагааны дийлэнх хувийг эзэлдэг байна. Боловсрол олгох ажиллагааг хэрэгжүүлэхэд төлөвлөгөө, стратеги, зохих хүний нөөц бүхий хүний эрхийн боловсрол олгох хөтөлбөртэй байхыг шаарддаг. Аливаа улсын хүний эрхийн үндэсний байгууллага тухайн орны хүний эрхийн боловсролын хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахуйц санхүүгийн нөөцтэй байх боломжгүй байж болно. Гэхдээ хүний эрхийн боловсролын тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох, хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд удирдлага болохуйц онол, арга зүйн туслалцаа үзүүлэх, практикт нэвтрүүлэх болон бусад байгууллагуудтай түншлэх, хүний эрхийн сургагч нарыг бэлтгэх зэрэг чиглэлээр ажилладаг байна. Энэ хүрээнд эрх эдлэгчдийн эрхээ шаардах чадавхыг дэмжих, үүрэг хүлээгчдэд хүний эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах үүргийг сануулах чиглэлээр ажилладаг хандлага олон улсад тогтсон байна. Хүн эрх, эрх чөлөөгөө бодитоор эдлэхэд хүний эрхийн боловсрол зайлшгүй чухал. Энэ хүрээнд НҮБ-аас Хүний эрхийн боловсролын 10 жил /1995-2004/, Бүх нийтийн боловсролын Дакарын тунхаглал /2002/, Хүний эрхийн боловсрол, сургалтын тунхаглал /2011/ зэрэг олон улсын бодлогын баримт бичгүүдийг баталсан байдаг.

Монгол Улсын хувьд 2003 онд “Монгол Улсад Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр”-ийг баталсан нь хүний эрхийг хангахад чиглэсэн чухал ажил байсан. Гэвч хөтөлбөрийг хэрэгжүүлэх Хорооны үйл ажиллагааг 2012 онд зогсоосон нь МУ дахь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах нэгдсэн бодлого, механизмыг тодорхойлох,

[26] “Хүний эрхийн боловсрол” Хүний эрхийн үндэсний байгууллагуудын гарын авлага. 2013 он. 21 дэх тал

үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулах эрх бүхий бүтцийг бий болгох шаардлагыг үүсгэсэн.

ХЭҮК-оос олон нийтэд хүний эрхийн боловсрол олгох, энэ чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд ихээхэн анхаарч ирсэн бөгөөд 2005 онд ЮНЕСКО-гийн дэмжлэгтэйгээр "Хүний эрхийн боловсрол-Ерөнхий боловсролын сургуульд" төслийг хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд ЕБС-д орж буй "Хүний эрх" хичээлийн чанар, үр нөлөө, агуулга, заах арга зүй, багшлах боловсон хүчний байдал, сургуулийн хүний эрхийн орчинд үнэлэлт дүгнэлт өгөх үндэсний хэмжээний судалгааны ажлыг зохион байгуулжээ. Мөн 2012-2014 онд хэрэгжүүлэх стратегийн зорилгодоо "Бүх нийтэд хүний эрхийн боловсрол олгох үндэсний тогтолцоог бэхжүүлэх"-ээр тусгасан бөгөөд энэ хүрээнд албан боловсролын тогтолцоогоор олгож буй хүний эрхийн боловсролын чанар, үр нөлөөг дээшлүүлэх, албан бус сургалт явуулах чадавхыг дээшлүүлэх, хүний эрхийн онолын судалгааг хөгжүүлэхэд нэмэр оруулах, олон нийтийн хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх зэрэг зорилт тавьж байсан.

ХЭҮК хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтад 2001-2013 оны байдлаар 2340 хүнийг танхимын сургалтад хамруулсан байна. Харин алслагдсан орон нутгийн иргэдэд 2013 оноос эхлэн цахим сургалт явуулах боломжийг бүрдүүлээд байна.[27]

ХЭҮК-оос жил бүр гаргадаг "МУ дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл"-ийн 2007 оны илтгэлд анх удаа хүний эрхийн боловсролын төлөв байдлын тухай бүлэг оруулсан. Мөн илтгэлүүддээ НҮБ-ын Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөр, түүний төлөвлөгөөтэй уялдсан төрөөс хүний эрхийн талаар баримтлах бодлого, хөтөлбөрийг боловсруулах, бүх шатны боловсролын сургуулиудын сургалтын хөтөлбөрт хүний эрхийн хичээлийг ерөнхий мэдлэгийн суурь хичээл болгох стандарт батлуулах, хууль зүйн их, дээд сургуулийн суурь хичээлийн жагсаалтад "Хүний эрх" хичээлийг заавал оруулах, сургалтын хөтөлбөрийг хүний эрхэд суурилсан хандлагад нийцүүлэн шинэчлэх зэрэг санал зөвлөмж дэвшүүлсээр ирсэн[28]. Үүний үр дүнд 2017 онд "Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөр"-ийн төслийг боловсруулаад байгаа билээ.

ХЭҮК-оос хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх үүднээс юуны өмнө нөхцөл байдлын ерөнхий зураглалыг үндэсний хэмжээнд гаргах, нийгэмд хүний эрхийг төлөвшүүлэх талаар үндэсний хэмжээний хөтөлбөр боловсруулах, хүний эрхийн цахим сургалтыг түгээн дэлгэрүүлэх, хүний эрхийн боловсролын нөөц, эх сурвалж, хэрэглэгдэхүүнийг боловсруулах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах асуудал тулгамдсан хэвээр байна. Үүнд зөвхөн ХЭҮК төдийгүй бусад төрийн болон иргэний нийгэм, сургалтын байгууллагуудын хамтын ажиллагаа, оролцоо чухал юм.

В. Үнэлсэн байдал

Хүний эрхийн үндэсний байгууллага хүний эрхийн боловсролыг дэмжих үйл ажиллагааныхаа хүрээнд хийж гүйцэтгэсэн ажилдаа хяналт шинжилгээ, үнэлгээ хийх шаардлагатай. Энэ нь хүссэн үр дүндээ хүрэхэд хангалттай агуулга, арга, хэрэгслээр хийгдэж байгааг тогтооход чухал үүрэгтэй бөгөөд үүнийг эрх агуулагчид, үүрэг хүлээгчид болон нөлөөлөгчдийн оролцоотойгоор тодорхой шалгууруудын дагуу гүйцэтгэдэг. Манай улсын хувьд хүний эрхийн боловсролыг дэмжих ажиллагаанд хэвлэл мэдээллийг татан оруулах, сургуулийн өмнөх боловсролын төв, сургуулиуд дахь хүний эрхийн боловсролын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд илүүтэй анхаарах шаардлагатай байгаа нь ажиглагдаж байна.

ХЭҮК-оос хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх, дэмжих талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зохих түвшинд амжилттай хэрэгжиж байна гэж дүгнэж

[27] Хүний эрхийн боловсролыг түгээж буй МУ-ын ХЭҮК-ын туршлага, цаашдын чиг хандлага" Н.Ганбаяр МУХЭҮК-ын гишүүн. "Хүний эрх" онол, арга зүйн сэтгүүл. 2014/01 дугаар 7 дахь тал

[28] Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэл. ХЭҮК. 2015 он.Уб хот

болох юм. Учир нь энэ чиглэлээр хийсэн ажлын үр дүнд Комисст хүний эрхийн зөрчилтэй холбогдох гомдол гаргасан иргэдийн тоо сүүлийн жилүүдэд эрс нэмэгдсэн үзүүлэлттэй гарчээ. Энэ нь хүний эрхийн боловсрол олгох зорилго практикт хангалттай хэрэгжиж буйг гэрчилж байна. Иймд энэ заалт хангалттай сайн хэрэгжиж байна гэж үнэлж болох байна.

3.2 ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

ГУРАВДУГААР БҮЛЭГ Комисст гомдол гаргах, 9 дүгээр зүйл. Гомдол гаргах эрх

9.1. Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан эрх, эрх чөлөөг нь аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн зөрчсөн гэж үзвэл Монгол Улсын иргэн дангаар буюу хамтарч энэ хуульд заасны дагуу Комисст гомдол гаргах эрхтэй.

9.3. Иргэний эрхийн бүрэн чадамжгүй, зарим буюу хэсэгчилсэн чадамжтай хүнийг түүний хууль ёсны төлөөлөгч-эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь, түүнчлэн сураггүй алга болсонд тооцогдсон, нас барсан гэж зарлагдсан хүнийг хуульд заасан төлөөлөгч нь төлөөлж гомдол гаргаж болно

9.4. Төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэлийн байгууллага энэ хуулийн 9.1-д заасан эрхийг мөн адил эдлэх бөгөөд төлөөлөгчөөрөө дамжуулан гомдол гаргана

3.2.12 Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1., 9.3., 9.4 дэх заалтын зорилгод хүрсэн төвшин ба практикт хэрэгжих байдал

А. Шалгуур үзүүлэлтийн томъёолол:

Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан эрх, эрх чөлөөг нь аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн зөрчсөн гэж үзвэл Монгол Улсын иргэн дангаар буюу хамтарч, эсхүл төлөөлөгчөөрөө дамжуулан Комисст гомдол гаргах эрх хүний эрх, эрх чөлөөг хангах тухай хуулийн зохицуулалт зорилгод нийцэж байгаа эсэх? Уг заалтыг практикт хэрэгжүүлэх боломж бүрдсэн эсэх?

Б. Судалсан байдал

ХЭҮК 2001-2016 оны байдлаар иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 5300 гаруй гомдол хүлээн авч шийдвэрлэсэн байх бөгөөд сүүлийн жилүүдэд буюу 2014 оноос хойш хүлээн авч шийдвэрлэсэн гомдлын тоо 2012 онтой харьцуулахад 2 дахин өссөн үзүүлэлттэй байна. Иргэд гомдлоо зөвхөн өөрийн биеэр болон төлөөлөгчөөрөө дамжуулан гаргаж байгаа ба утсаар болон цахим хэлбэрээр гаргасан гомдол байхгүй, энэ боломжийг олгосон эрх зүйн орчин бүрдээгүй байна.

ХЭҮК-т сүүлийн 3 жилийн байдлаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гомдлыг агуулгын хувьд авч үзвэл шударга шүүхээр шүүлгэх эрх буюу хилс хэрэгт ял шийтгүүлсэн болон хэргийг үнэн зөвөөр шийдвэрлүүлж өгөхийг хүссэн гомдол дийлэнх хувийг эзэлж байна.

Үүнээс иргэд дангаараа гаргасан 4665, хамтарч гаргасан 213 гомдол байна. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

он	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	Нийт
Дангаар	55	145	144	142	142	208	247	264	164	211	314	297	671	671	616	502	**4665**

Хамтарч	18	19	5	9	13	15	12	6	3	4	18	14	17	15	27	21	**216**

Иргэдээс хүний эрх, эрх чөлөөний зөрчилтэй холбогдуулан 2011-2016 оны хооронд гаргасан гомдлыг агуулгын хувьд авч үзвэл 3 жилийн дунджаар хамгийн олон гомдол буюу нийт гомдлын 37%-ийг Эрүү шүүлтээс ангид байх эрх, 24%-ийг Шударга шүүхээр шүүлгэх эрх, 10орчим %-ийг хөдөлмөрлөх эрх, 10 орчим хувийг халдашгүй чөлөөтэй байх эрх, 7%-ийг Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхийн зөрчилтэй холбоотой гаргасан байна. Тодруулбал:

№	Гомдлын агуулга	Гомдлын тоон үзүүлэлт /оноор/		
		2014	2015	2016
1	Шударга шүүхээр шүүлгэх эрх /Хилс хэрэгт ял шийтгүүлсэн болон хэргийг үнэн зөвөөр шийдвэрлүүлэхийг хүссэн/	143	134	106
2	Хууль зүйн туслалцаа авах эрх	175	7	5
3	Халдашгүй чөлөөтэй байх эрх	31	77	47
4	Өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрх	48	11	8
5	Өмчлөх эрх	16	20	7
6	Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрх	63	37	15
7	Зорчих эрх	11	4	5
8	Хүүхдийн эрх зөрчигдсөн талаар	18	6	6
9	Хөдөлмөрлөх эрх	55	27	73
10	Ажлын байрны дарамт болон ялгаварлан гадуурхагдсан талаар	6	12	7
11	Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх	24	9	11
12	Тэтгэвэр, тэтгэмж авах, нийгмийн халамж хүртэх эрх	14	6	9
13	Эрүү шүүлтээс ангид байх эрх	54	92	67
14	Хохирол нөхөн төлүүлэх тухай	21	10	6
15	Эд мөнгөний тусламж авах эрх	16	12	17
17	Гэр бүлийн хүчирхийллийн талаар	9	3	3
18	Сурч боловсрох эрх	6	3	5
19	Сонгох, сонгогдох эрх	-	-	15
20	Соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрх	-	-	2
	НИЙТ	**710**	**470**	**414**

Комиссын тухай хуулийн 9 дүгээр зүйлд Комисст гомдол гаргах эрх бүхий субъектүүдийг өргөн хүрээнд тодорхойлж өгсөн. Харин хүүхэд өөрөө гомдол гаргах эрхийг олгоогүй. Энэ асуудлыг НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороо хөндөж, 2010 оны 1 сарын 29-ний өдрийн CRC/C/OPSC/MNG/CO/1 дугаарт тогтоолдоо хүүхдүүд ХЭҮК-д биечлэн гомдол гаргах эрхгүй байгаа нь анхаарал татаж байгаа тухай дурдаад "эрх нь зөрчигдсөн тохиолдолд гомдлоо ХЭҮК-д гаргах боломжийг хялбарчлах арга хэмжээ авч бэхжүүлэхийг зөвлөсөн, мөн хүүхдүүд биечлэн гаргасан гомдлыг ХЭҮК хүлээн авч, шалгаж шийдвэрлэх бүрэн эрх, чадвартай байх явдлыг баталгаажуулахыг зөвлөжээ.[29]

Хэдийгээр хуулийн заалтад хүүхдээс гаргасан гомдлыг хүлээж авах тухай зохицуулалт ороогүй боловч Комисс хүүхдээс гаргасан гомдлыг шууд хүлээн авч шийдвэрлэдэг байна.

Хуулийн 10 болон 11 дүгээр зүйлд заасан гомдолд тавигдах хэлбэрийн шаардлагыг хангасан тохиолдолд шалгах ажиллагаа явагддаг. Хэрэв хэн нэгэн хууль тогтоомжоор баталгаажсан эрх нь зөрчигдсөн гэж үзсэн бол ХЭҮК-д өргөдөл

[29] Хүний эрхийн Үндэсний комисс 10 жилд 2001-2011" ХЭҮК, 2011 он. Уб хот. 159 дэх тал.

гаргах ба тодорхой шаардлагуудыг хангасан байх хуулийн зохицуулалттай.

Тухайлбал хуулийн 10 дугаар зүйлд, “Гомдлыг монгол хэлээр, бичгээр эсхүл амаар биечлэн гаргана. Монгол хэл мэдэхгүй хүн эх хэлээрээ гомдол гаргаж болох бөгөөд гомдлоо монгол хэлнээ орчуулж, зохих журмаар баталгаажуулсан байх”-аар заасан байдаг. Энэхүү заалтын дагуу гомдол гаргагч хэрэв бичиг үсэг мэддэггүй, эсхүл харааны бэрхшээлтэй байх зарим тохиолдолд гомдол гаргах эрхээ бүрэн эдэлж чадахгүй байх, монгол хэлнээс бусад хэлээр гомдол гаргаж буй иргэнд орчуулгын, хэлмэрчийн хөлс зэрэг нэмэлт зардал шаардах байдлаар хүндрэл, чирэгдэл үүсгэх магадлалтай байна.

Мөн ХЭҮК-ын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх хэсэгт гомдол гаргагч иргэн гомдлоо захиргааны журмаар шийдвэрлүүлсэн байх буюу гомдол гаргахын өмнө тухайн асуудлаар өөрийг нь хохироосон байгууллага, албан тушаалтны талаар холбогдох дээд шатны байгууллага, албан тушаалтанд гомдол гаргаж, албан ёсны хариу авсан байх шаардлага тавьж байна. Энэ нь нэг талаас тухайн гомдлыг Комисс хүлээн авч шийдвэрлэхэд тус дөхөмтэйгөөс гадна төрийн байгууллагын холбогдох албан тушаалтны бүрэн эрхэд халдахгүйгээр зөрчлийг арилгуулах боломжийг олгож байгаа сайн тал байгаа боловч нөгөө талаар энэ нь иргэдийн зүгээс зөрчигдсөн эрхийнхээ талаар ХЭҮК-д шууд хандах боломжийг хязгаарлах, хугацаа алдах нөхцөлийг бүрдүүлэх магадлалтай юм.

Комиссоос өгсөн тайлбараас харахад энэхүү зохицуулалтыг үйл ажиллагааны явцад түгээмэл ашигладаг бөгөөд ялангуяа Комиссын тухай хуулийн хамрах хүрээнээс хэтэрсэн, өөр байгууллагын чиг үүрэгт хамаарах, эсхүл бусад байгууллагаас явуулах үйл ажиллагааны үр дүнд тухайн асуудлыг богино хугацаанд шийдвэрлэх боломжтой гэж үзсэн тохиолдолд энэхүү заалтыг үндэслэн гомдлыг хүлээж авахаас татгалздаг байна.

Цаашлаад ХЭҮК-ын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь хэсэгт зааснаар гомдол гаргагч гомдолдоо “Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж болон олон улсын гэрээгээр баталгаажуулсан ямар эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн болохыг заах” тухай тусгасан байна. Гомдол гаргагч иргэн тэр бүр хууль эрх зүйн ойлголт, мэдлэгтэй байдаггүй тул уг шаардлагыг хангаагүй гомдол гаргах нь элбэг. Ерөнхийдөө нийгмийн янз бүрийн бүлэг, давхаргад хамаарах иргэд хувь хүний хувийн мэдлэг, боловсролын түвшнээс хамааралд гомдолдоо зөрчигдсөн эрхийнхээ талаар тодорхой, нэг бүрчлэн бичих эсхүл энэ талаар тусгах чадваргүй байдаг. Гэтэл иргэдийн гомдлыг чухам энэ шаардлагыг хангаагүй гэсэн үндэслэлээр буцаах боломжийг бүрдүүлсэн зохицуулалт байна.

Гэвч Комисс гомдолд тавих хэлбэрийн шаардлага болох бичгээр болон амаар гомдол гаргана гэх энэ заалтаас гадна утсаар, цахимаар гомдол хүлээж авч байна. Гэхдээ хуульд заасан хэлбэрийн шаардлагаас өөр хэлбэрээр авсан гомдлыг шаардлагатай тохиолдолд бичгээр бичүүлж авдаг. Учир нь бичгийн хэлбэрээр үйлдсэн гомдол нотлох баримт болдог учраас үүнийг чухалчилж үздэг. Гадаадын иргэдээс гаргасан гомдлын орчуулгыг өөрсдийн нөөц бололцоондоо тулгуурлан орчуулан хавсаргадаг байна. Үүнээс гадна гомдол гаргах ажиллагаанд нутаг дэвсгэрийн хязгаар тогтоох асуудлыг хөндөн судлах шаардлагатай байна. Тухайлбал, Комисс Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах эрхтэй бөгөөд гадаад улсаас ирсэн гомдлын дагуу тухайн оронд хяналт шалгалт явуулах, гомдол шийдвэрлэх боломжгүй. Харин иргэдийн зүгээс гадаад улсад байх хугацаанд эрх нь зөрчигдсөн үед Хүний Эрхийн Үндэсний комисс тэднийг хамгаалах үйл ажиллагаа явуулахгүй байна гэсэн гомдол гаргадаг байна. Комисс энэ асуудлын хүрээнд тухайн улсын хүний эрхийн байгууллагуудтай холбогдон тодорхой арга хэмжээ авахыг санал болгох л боломжтой байдаг.

В. Үнэлсэн байдал

ХЭҮК-ын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.14 дэх хэсэгт заасан гомдол гаргах эрх хүний эрх, эрх чөлөөг хамгаалах хуулийн зорилготой нийцэж байна.

Харин практикт хэрэгжих байдал нь тус хуулийн 10 болон 11 дүгээр зүйлд заасан шаардлагад нийцүүлэхтэй холбоотойгоор зарим тохиолдолд хүндрэлтэй байх талтай. Учир нь нэгдүгээрт гомдол гаргагч асуудлаа захиргааны журмаар шийдвэрлүүлсэн байх шаардлага хангасан байх хэрэгтэй. Гэтэл бодит амьдралд иргэний болон захиргааны эрх зүйн маргаан шийдвэрлэх ажиллагаа олон жил үргэлжилж байгаа бөгөөд энэ тохиолдолд хүний эрхийн зөрчил удаан хугацаагаар үргэлжлэх боломжийг бүрдүүлж байна.

Хоёрдугаарт гомдол гаргах эрх бүхий субъектүүдийг өргөн хүрээнд тодорхойлж өгсөн боловч үүнд хүүхэд өөрөө шууд ХЭҮК-д хандаж гомдол гаргах эрх зүйн орчин бүрдээгүй байна. Сүүлийн жилүүдэд нийгэмд ядуурал, гэр бүлийн хүчирхийлэл, согтууруулах ундаа, мансуурах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хэрэглээ газар авч байгаа зэрэг нь хүүхдийн эрхийг зөрчих орчин нөхцөлийг бий болгосоор байна. Иймд дээр дурдсан орчин, гэр бүлд өсөж буй хүүхэд эрхээ хамгаалуулахдаа заавал асран хамгаалагч, төлөөлөгчөөр дамжуулан ХЭҮК-т хандах нь зохистой эсэхийг судлах хэрэгтэй юм. Мөн Комисс хүүхдээс гаргасан гомдлыг хүлээн авч шийдвэрлэж хэвшсэн энэ үйл ажиллагааг хуульд тусгаж өгөх хэрэгцээтэй юм.

Гуравдугаарт бичиг үсэг тайлагдаагүй болон үндэстний цөөнхийн эсхүл гадаад хэл дээр гомдол гаргах процесс чирэгдэлтэй, зардалтай байгаатай холбогдуулан тус ажиллагааг хялбаршуулах боломжийг судлах шаардлага байна.

15.1.1. гомдлыг хүлээн авч, хянан үзэх

3.2.1 Хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтын зорилгод хүрсэн төвшин ба практикт хэрэгжих байдал

А. Шалгуур үзүүлэлтийн томъёолол:

Хүний эрхийн үндэсний комиссын гишүүний хүний эрхийн зөрчилтэй холбогдох гомдол хүлээн авах, хянаж үзэх бүрэн эрх хүний эрх, эрх чөлөөг хамгаалах тухай зохицуулалт зорилгод хүрч байгаа эсэх? Мөн практикт хэрэгжүүлэх боломж бүрдсэн эсэх?

Б. Судалсан байдал

ХЭҮК-т зөрчигдсөн эрх, эрх чөлөөгөө сэргээлгэх зорилгоор гомдол гаргасан иргэдийн тоо 2001 оноос 2017 оны 6 сар хүртэлх хугацаанд нийт 5353 хүрсэн байна. Хамгийн бага буюу 55 гомдлыг 2001 онд гаргаж байсан бол хамгийн их буюу 671 гомдлыг 2013, 2014 онуудад гаргаж байсан байна.[30]

Анх 2001 онд үүсгэн байгуулагдсан ХЭҮК-т 2017 он хүртэлх хугацаанд нийт 7 гишүүн ажилласан байна. Гишүүдэд гомдлыг тэгш хуваарилдаг. Комисст ирүүлсэн гомдлыг Комиссын дарга өөртөө болон бусад гишүүддээ тодорхой хариуцсан чиглэлийг харгалзан хуваарилдаг бөгөөд шийдвэрлэхэд шаардлагатай үйл ажиллагааг ажлын алба гүйцэтгэдэг байна. Комисст нэг жилд дунджаар 700 орчим гомдол ирдэг бөгөөд нэг гишүүн жилд дунджаар 200 гаруй хэрэг шийдвэрлэдэг байна. Комисст ирж буй гомдлын тоо 2014 оноос эхлэн эрс өссөн нь тус байгууллага орон нутагт салбар ажиллуулж эхэлсэнтэй холбон үзэж болох юм.

ХЭҮК-т гаргаж буй гомдлын 50 орчим хувь нь хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой байна. Тухайлбал, ХЭҮК–ын 2004 оны тайлангаас харахад тус комисс 162 гомдол хүлээж авснаас 79 гомдол буюу 48,8% нь хууль хяналтын байгууллагатай, 19 нь буюу 11,7% нь хөдөлмөр эрхлэхтэй, 10 буюу 6,2% нь нөхөн олговор тэтгэмжтэй, 11 буюу 8,6% газар эзэмших эрхтэй холбоотой гомдол байсан байна.[31]

[30] ХЭҮК-оос авсан статистик мэдээллээс. 2017.06.20

[31] Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай 4 дэх илтгэл. 2005 он. ХЭҮК. 2005 он. Уб хот.

В. Үнэлсэн байдал

ХЭҮК-ын гишүүн гомдол хүлээн авч, хянан үзэх зохицуулалт зорилгодоо нийцэж, практикт хэрэгжих бүрэн боломжтой байна.

15.1.2. энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаагүй гомдлыг хүлээн авахаас татгалзах; 17.1.5. гомдол үндэслэлгүй гэж үзвэл гомдол гаргагчид буцаах. 12.2. Комисс нэр, хаяггүй гомдол хүлээн авахгүй.

3.2.2 Хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.1.2 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.1.5 дахь заалтын зорилгод хүрсэн төвшин ба практикт хэрэгжих байдал

А. Шалгуур үзүүлэлтийн томъёолол:

Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн шаардлага хангаагүй, эсхүл үндэслэлгүй гэх үндэслэлээр гомдол буцаах нь энэ хуулийн зорилгод нийцэх эсэх? Мөн практикт хэрэгжүүлэх боломж бүрдсэн эсэх?

Б. Судалсан байдал

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 11 дүгээр зүйлд гомдолд тавих шаардлагыг тодорхойлсон байна. Үүнд зааснаар гомдол гаргагч гомдлоо захиргааны журмаар шийдвэрлүүлсэн байх, ямар эрх, эрх чөлөө зөрчигдсөн болохыг заах, өөрийн нэр, оршин суугаа газрын буюу шуудангийн хаягаа бичиж гарын үсэг зурсан байх, холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүний нэр, хаяг, утасны дугаар болон холбогдох бусад баримтыг хавсаргасан байх шаардлага тавьсан.

Дээрх шаардлагыг хангаагүй гэж үзсэний улмаас 2001-2016 онд нийт 179 гомдол буцаасан байна. Үүнийг дэлгэрэнгүй байдлаар үзвэл:[32]

он	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	Нийт
тоо		8	2		17	9	11	2	5	1	13	24	30	25	18	14	**179**

Буцаасан гомдол нь нийт хүлээж авсан гомдлын 3,35% байх бөгөөд энэ хэмжээ иргэдийн эрх ашигт болон ХЭҮК-ын гишүүний гомдол хүлээн авах, хянан шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлөхүйц хэмжээнд хүрэхгүй гэж дүгнэлээ.

Харин хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5 дахь хэсэгт заасан “гомдол үндэслэлгүй гэж үзвэл гомдол гаргагчид буцаах” эрх зүйн зохицуулалтын дагуу мөн хугацаанд нийт 236 гомдлыг буцаасан байна.

он	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	Нийт
тоо	22	42	8	12	22	1		7	12	3	3	6	59	7	22	9	**236**

Нийт гомдол гаргагчдын 4,42% буюу 236 гомдлыг хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн үндэслэлгүй гэсэн үндэслэлээр гомдол гаргагчид буцаасан байна.

Тодруулбал 2014-2016 оны байдлаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас Комисст ирүүлсэн гомдлуудаас гомдолд тавигдах хуульд заасан шаардлага хангаагүй, гомдол гаргагч гомдлоосоо татгалзсан, үндэслэлгүй гомдлыг буцаасан талаарх мэдээллийг харахад үндэслэлгүй гомдлын хэмжээ давамгайлж байна.

[32] ХЭҮК-оос авсан статистик мэдээллээс. 2017.06.20

Он	Гомдолд тавигдах шаардлага хангаагүй	Үндэслэлгүй гомдлыг буцаасан	Гомдлоосоо татгалзсан
2014	3	24	12
2015	15	29	9
2016	4	15	7
Нийт	22	68	28

В. Үнэлсэн байдал

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан гомдолд тавьсан шаардлагыг хангаагүй гэж үзэн иргэний зүгээс гаргасан гомдлыг буцаасан тохиолдлын тоо нийт гомдлын 3 гаруй хувийг, харин үндэслэлгүй гомдол гаргасан үндэслэлээр буцаасан гомдол 4,42 хувийг эзэлж байгаа нь хуулийн эдгээр заалтын зорилгод хүрэх байдалд нөлөөлөх хэмжээнд хүрэхгүй байна. Иймд тус хуулийн заалт хэрэгжих боломжтой гэж үзлээ.

Г. Санал зөвлөмж

ХЭҮК-т гаргасан, үндэслэлгүй болон хууль тогтоомжид заасан шаардлага хангаагүй шалтгаанаар буцаагдсан гомдлуудад дүн шинжилгээ хийж, хамгийн их давтамжтай гомдлын төрлүүдэд чиглэсэн сургалт зохион байгуулах, мэдээлэх, сурталчлах ажиллагаа зохион байгуулах боломжтой юм.

15.1.3. эрүүгийн хэрэг, эрх зүйн маргааны талаарх гомдлыг харьяаллын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх;
15.1.4. гомдол гаргагчид зөрчигдсөн эрхээ сэргээлгэх талаар ямар эрх, үүрэгтэй болохыг тайлбарлах
16.1.6. гомдлыг хянан үзэх явцад уул гомдол нь эрүү, иргэний хэрэг маргааны шинжтэй гэж үзвэл түүнийг холбогдох байгууллага, албан тушаалтанд харьяаллын дагуу шилжүүлэх;

3.2.3 Хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.4 болон 16 дугаар зүйлийн 16.1.6 дахь заалтын зорилгод хүрсэн төвшин ба практикт хэрэгжих байдал

А. Шалгуур үзүүлэлтийн томъёолол:

Хүний эрхийн үндэсний комисс иргэдээс гаргасан эрүүгийн хэрэг, иргэний болон эрх зүйн маргааны талаарх гомдлыг харьяаллын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх үйл ажиллагааны талаарх зохицуулалт хуулийн зорилгод нийцэж байгаа эсэх? Мөн практикт хэрэгжүүлэх боломж бүрдсэн эсэх?

Б. Судалсан байдал.

Хүний эрхийн үндэсний комисс тухай хуулийн дээрх 2 заалтын хүрээнд иргэдээс гаргасан гомдол эрүүгийн болон иргэний эрх зүйн маргааны шинжтэй байх тохиолдолд уг гомдлыг тухай хэрэг маргааныг харьяаллын дагуу шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлдэг. Иймхүү хэрэг маргааныг харьяаллын дагуу шилжүүлсэн статистик мэдээнээс харахад 2001-2016 онд нийт 179 гомдлыг холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлсэн байна.[33]

Он	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	Нийт
Тоо		35	3		76	50	32	26	18	16	63	49	165	193	75	142	**179**

Дээрх тоон мэдээллээс харахад ХЭҮК-т хандаж гаргасан гомдлыг харьяаллын дагуу шилжүүлсэн тохиолдлын тоо сонгуулийн болон сонгуулийн дараах жилд харьцангуй өндөр байна. Энэ нь УИХ, аймаг, нийслэл, сум дүүргийн сонгуулийн

[33] ХЭҮК-оос авсан статистик мэдээллээс. 2017.06.20

дараах төрийн албаны албан хаагчдын халаа сэлгээтэй холбоотой байх магадлалтай юм.

Мөн хуулийн 16.1.6 дахь хэсэгт гомдлыг хянан үзэх явцад уул гомдол нь эрүү, иргэний хэрэг маргааны шинжтэй гэж үзвэл түүнийг холбогдох байгууллага, албан тушаалтанд харьяаллын дагуу шилжүүлэх тухай зохицуулсан байна. Энэхүү зохицуулалтад захиргааны хэрэг маргааныг нэмж оруулах шаардлагатай юм. Хүний эрхийн комиссын тухай хуулийг батлах үед Монгол Улсад захиргааны хэрэг маргааныг бие даан шийдвэрлэдэг эрх зүйн орчин, бүтэц байгаагүй тул энэ зохицуулалт ороогүй. Гэвч шүүх эрх мэдлийн хүрээнд бие даасан үйл ажиллагаа явуулаад 10 гаруй жил болж буй захиргааны хэргийн шүүхийн харьяалалд хамаарах хэрэг маргааныг шилжүүлэх боломжийг хуулиар олгох нь зүйтэй юм.

В. Үнэлсэн байдал

ХЭҮК нь төрийн эрх мэдлийн хуваарилалтын дагуу шүүх эрх мэдлийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлдэггүй. Иймд эрүүгийн болон иргэний эрх зүйн шинжтэй маргааныг харьяаллын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх тухай хуулийн энэ зохицуулалт зорилгодоо нийцсэн, практикт хэрэгжих боломжтой гэж үзэж байна. Харин энэ заалтын хүрээнд гомдлыг захиргааны хэргийн шүүхэд харьяаллын дагуу шилжүүлэх асуудлыг нэмж тусгах шаардлагатай юм.

16.1.2. гомдол гаргагч, холбогдох хүмүүсийг дуудан ирүүлэх;

16.1.3. гомдолтой холбогдолтой асуудлаар аль ч аж ахуйн нэгж, байгууллагад саадгүй нэвтрэн орж, түүний хурал, зөвлөгөөнд оролцох, холбогдох албан тушаалтантай биечлэн уулзах;

16.1.4. шаардлагатай нотлох баримт, албан бичиг, мэдээллийг байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах, газар дээр нь танилцах;

16.1.8. бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай гэж үзсэн тохиолдолд холбогдох хуульд заасан журмын дагуу төр, байгууллага, хувь хүний нууцтай танилцах.

18.3. Комиссын гишүүн нь хүний эрхийн асуудлаар судалгаа хийх зорилгоор эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан, хэрэгсэхгүй болгосон, шүүхээр шийдвэрлэгдсэн эрүү, иргэний хэргийн материалтай танилцаж болно.

23 дугаар зүйл. Хууль зүйн баталгаа

23.4. Комиссын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн албан тушаалтан, иргэд бүх талын туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

3.2.5 Хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2, 16.1.3, 16.1.4 болон 16.1.8, 18 дугаар зүйлийн 18.3 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалтын зорилгод хүрсэн төвшин ба практикт хэрэгжих байдал

А. Шалгуур үзүүлэлтийн томъёолол:

Хүний эрхийн үндэсний комисс иргэдээс хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн байдалтай холбоотой гаргасан гомдлыг шалгах ажиллагааны явцад шаардлагатай мэдээлэл гаргуулж авах, газар дээр нь танилцах болон холбогдох этгээдүүдтэй биечлэн уулзах тухай хуулийн зохицуулалт зорилгод нийцэж байгаа эсэх? Мөн практикт хэрэгжүүлэх боломж бүрдсэн эсэх?

Б.Судалсан байдал

Комиссын тухай хуулийн 16 дугаар зүйлд гомдлын мөрөөр шалгалт хийх бүрэн эрхийг заасан байдаг. Олон улсын практикт гомдлыг шалгах үндсэн бүрэн эрхүүдийн нэг нь гомдол гаргагч болон хохирогч, гэрчээс нотлох баримт гаргуулах, гэрчээс тайлбар мэдүүлэг авах, баримт, мэдээлэл олж авах, бусдын өмчийн объектуудад нэвтрэх, хяналт шалгалт явуулах зэргийг хамааруулдаг. Гомдлыг шалгах ажиллагаанд албан журмаар, эсвэл сайн дурааараа оролцсон эсэхээс үл хамааран түүнд хувь нэмрээ оруулсан хэнийг ч хамгаалалтад авах асуудлыг энэхүү бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх ёстой. Тийм боломжгүй нөхцөлд, хэрэв эцэст нь өөрсдөө бусдын зүгээс ирэх аюулын хохирогч болно гэж үзвэл хохирогч, гэрч нар гомдлын талаар тайлбар мэдээлэл өгөхөөс татгалздаг. Тухайлбал,

хөдөлмөрлөх эрхийн зөрчлийн нэг талд ажил олгогч, нөгөө талд ажилтан гэсэн хоёр тэнцвэргүй талын хооронд үүсдэг зөрчил. Гомдол гаргагч хөдөлмөрийн харилцаанд хөдөлмөрлөх эрх нь зөрчигдсөн асуудлаар холбогдох байгууллагад хандаж хөдөлмөрлөх эрхийн зөрчлийг таслан зогсоох, гомдлоо шийдвэрлүүлснээрээ эргээд ажил олгогчийн зүгээс дарамтад өртөх, эсвэл тухайн байгууллагын ажилтнуудын Хүний эрхийн үндэсний байгууллагаас хийж байгаа гомдол шалгах ажиллагаанд оролцон мэдээлэл, тайлбар өгөхөөс айх, эргээд өөрт нь ирэх сөрөг нөлөөлөл, дарамт шахалт үүсэхээс болгоомжлох хандлага байдаг. Энэ байдал манай улсын хувьд харьцангуй өндөр байна.

ХЭҮК өнгөрсөн хугацаанд нийт 175 тохиолдолд шаардлагатай нотлох баримт, албан бичиг, мэдээллийг байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах арга хэмжээ авсан байна.

он	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	Нийт
тоо	3	2	5	7	4	2	3	1	2	6	12	8	40	34	10	43	**175**

Хүний эрхийн зөрчилтэй холбоотой гомдол шалгах ажиллагааны явцад мэдээлэл цуглуулах ажиллагаанд хамгийн их хүндрэл учирдаг байна. Тухайлбал гэрч, хохирогч мэдээлэл өгөхөөс айдаг, нэр, хаягаа буюу өөрийг нь тодорхойлж болохуйц мэдээлэл өгөхөөсөө татгалзах явдал элбэг тохиолддог. Энэ тухай ХЭҮК-ын гишүүн П.Оюунчимэг "...Мөн нөгөө талаас бидэнд учирдаг зарим хүндрэлүүдийн нэг нь зарим төрлийн эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон, цагаатгасан хэргийн материалуудтай танилцах, төлөөлөн нэхэмжлэл гаргахад шаардлагатай материал хувилж авахад хуулийн байгууллагуудын зүгээс шалтаг, шалтгаан тоочсон хүндрэлүүд ихээр гарч байна." гэж тайлбарласан байдаг. Иймээс Комиссоос гаргаж буй эрх зүйн актуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, хууль тогтоомжид Комиссын оролцоо, эрх үүргийн талаар нэмэлт, өөрчлөлт оруулах, төлөөлөн нэхэмжлэлийн хүрээг газар эзэмших, байгаль орчны зэрэг асуудалтай холбоотой тэлэх зэрэг санал боловсруулах шаардлага бий гэж үзсэн байна.[34]

В. Үнэлсэн байдал

Хүний эрхийн үндэсний комисс иргэдээс хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн байдалтай холбоотой гаргасан гомдлыг шалгах ажиллагааны явцад шаардлагатай мэдээлэл гаргуулж авах, газар дээр нь танилцах болон холбогдох этгээдүүдтэй биечлэн уулзах тухай хуулийн зохицуулалтын хэрэгжилт хүндрэлтэй байна. Үүнийг нэгдүгээрт, холбогдох байгууллага, этгээдүүд мэдээ, баримт сэлтийг гаргаж өгөхдөө хойрго, ямар нэгэн шалтгаанаар удаашруулах, саатуулах оролдлого гаргах нь түгээмэл байдаг бол иргэдийн зүгээс өөртэй нь болон шалгагдаж буй гомдолтой холбогдох мэдээллийг нуух, мэдээлэл өгснөөр өөрт нь ямар нэг сөрөг үр дагавар учрахаас эмээх байдал их тохиолддог байна. Эдгээр шалтгааны улмаас хуулийн энэ заалтын хэрэгжилт практикт хэрэгжих байдал нь хүнд, мөн хүний эрхийн зөрчлийг илрүүлэх ажиллагааг удаашруулах нэг хүчин зүйл болж байна.

Комиссын зүгээс хэрэгжүүлж буй гомдол хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ заалтыг голлон ашиглаж шаардлагатай баримт мэдээллийг шаардаж авдаг. Гэвч энэ эрх нь зөвхөн гишүүний бүрэн эрхийн хүрээнд авч болох арга хэмжээ байхаар зохицуулагдсан бөгөөд ажлын албаны албан хаагчдад хамаарахгүй байгаа нь хүндрэл учруулдаг байна. Тухайлбал комиссын гишүүн зөвхөн өөрийн биеэр ирсэн

[34] Хүний эрхийн үндэсний байгууллагаас шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргаж байгаа өнөөгийн нөхцөл болон гарч буй хүндрэлүүд" П.Оюунчимэг. ХЭҮК-ын гишүүн, Хууль зүйн ухааны доктор. Хүний эрх" онол, арга зүйн сэтгүүл. 2012/02 дугаар 16 дахь тал

тохиолдолд мэдээлэл өгөх асуудал тогтмол хөндөгддөг бөгөөд үйл ажиллагаагаа хэвийн явуулах үүднээс хууль хяналтын байгууллагуудын удирдлагын төвшинд харилцан тохиролцсоны үндсэн дээр тухайн хэргийг хариуцсан мэргэжилтэнд гишүүний зүгээс итгэмжлэл олгох байдлаар дээрх хуулийн заалтын хэрэгжилтийг хангаж байгаа бол хувийн хэвшлийн байгууллагуудыг шалгах, тэдгээрээс баримт, мэдээ авах нөхцөлд энэ заалтыг хэрэгжүүлэхэд ихээхэн хүндрэл учирдаг байна. Гэтэл ямар нэгэн тохиолдлоор Комиссын 3 гишүүний аль нь ч итгэмжлэл өгөх боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд хүний эрхийн зөрчил гаргасан байгууллагад хяналт, шалгалт хийх боломжгүй болох магадлалтай юм. Хэдийгээр ийм тохиолдолд гарч байгаагүй боловч энэ асуудлыг тодорхой зохицуулах, шаардлагатай тохиолдолд тухайн хэргийг хариуцсан Комиссын мэргэжилтэн орон байранд нэвтрэх, мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх шаардлага бий.

Г.Санал зөвлөмж

Комисст гаргасан гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эдлэх гишүүний бүрэн эрхийг зохицуулсан дээрх заалтуудыг бүрэн хэрэгжүүлэх ажиллагааг сайжруулах үүднээс гишүүнийг төлөөлөн ажиллаж буй тухайн чиг үүргийг хэрэгжүүлж буй Комиссын ажлын албаны мэргэжилтний мэдээлэл цуглуулах ажиллагааны явцад эдлэх эрхийг хууль тогтоомжоор баталгаажуулах, эрх зүйн хамгаалалтад авах асуудлыг судлах шаардлагатай байна.

16.1.5. тусгай мэдлэг шаардагдсан тохиолдолд зохих байгууллагын шинжээчийг томилж, дүгнэлт гаргуулах;

3.2.6 Хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5 дахь заалтын зорилгод хүрсэн төвшин ба практикт хэрэгжих байдал

А. Шалгуур үзүүлэлтийн томъёолол:

Хүний эрхийн үндэсний комисс иргэдээс хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн байдалтай холбоотой гаргасан гомдлыг шалгах ажиллагааны явцад тусгай мэдлэг шаардагдсан тохиолдолд зохих байгууллагын шинжээчийг томилж, дүгнэлт гаргуулах үйл ажиллагааны тухай зохицуулалт зорилгод нийцэж байгаа эсэх? Мөн практикт хэрэгжүүлэх боломж бүрдсэн эсэх?

Б. Судалсан байдал

ХЭҮК-оос хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн талаар гаргасан гомдол шийдвэрлэх ажиллагааны явцад баримт бичиг, нөхцөл байдалд дүн шинжилгээ, үнэлгээ хийлгэх зэрэг ажиллагаа хийхдээ шаардлагатай тохиолдолд тусгай мэдлэг бүхий мэргэжлийн шинжээч томилох боломж хуулиар олгогдсон байдаг. Энэ эрхийн хүрээнд ХЭҮК 2005, 2015, 2016 онуудад нийт 4 удаа мэргэжлийн байгууллага, шинжээчээр дүгнэлт гаргуулсан байна.[35]

В. Үнэлсэн байдал

Хүний эрхийн комисст ирүүлж буй гомдлыг шийдвэрлэх ажиллагаанд нарийн мэдлэг шаардсан, шинжээч томилуулах хэрэгцээ шаардлага бүхий гомдол бага ирдэг. Харин сүүлийн жилүүдэд шинжээч томилуулах хэрэгцээ шаардлага ялангуяа хүүхдийн эрхийн асуудалтай холбоотой өсөх хандлагатай байна. Гэвч энэ чиглэлээр мэргэшсэн, үнэлгээ хийх чадвартай сэтгэл зүйч, шинжээч манай улсад байхгүй байгаа нь хүндрэл үүсгэдэг байна.

Үүнээс гадна шинжээч томилсон тохиолдолд үүсэх зардлыг хэн хариуцах, хаанаас гаргах нь тодорхойгүй байдаг байна.

[35] ХЭҮК-оос авсан статистик мэдээллээс. 2017.06.20

Г. Санал зөвлөмж

Хүний эрхийн үндэсний комисст ирүүлж буй гомдлыг шалгах ажиллагааны хүрээнд нарийн мэдлэг шаардсан тохиолдолд шинжээч томилуулах, ялангуяа хүүхдийн эрх зөрчигдсөн үед тэдний сэтгэлзүйн байдалд үнэлгээ хийх чадвартай гадаад, дотоодын шинжээчийг томилон ажиллуулах зардлыг төсөвт тусгадаг байх, ажлын албаны мэргэжилтнүүдийг анхан шатны болон ахисан төвшний сургалтад хамруулах шаардлага байна.

16.1.7. аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд дангаар буюу төрийн эрх бүхий байгууллага, тэдгээрийн албан тушаалтанд санал болгосны үндсэн дээр хамтран шалгалт явуулах;

18.2. Комиссын гишүүн нь хүний эрх, эрх чөлөөг зөрчиж байгаа талаарх мэдээллийг үндэслэн өөрийн санаачлагаар, эсхүл аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүсэлтээр шалгалт хийж болно.

3.2.7 Хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.7 дахь заалт болон 1 дугаар зүйлийн 18.2 дахь заалтын зорилгод хүрсэн төвшин ба практикт хэрэгжих байдал

А. Шалгуур үзүүлэлтийн томъёолол:

ХЭҮК аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд дангаар буюу төрийн эрх бүхий байгууллага, тэдгээрийн албан тушаалтанд санал болгосны үндсэн дээр хамтран шалгалт явуулах үйл ажиллагааны талаарх зохицуулалт зорилгод нийцэж байгаа эсэх? Мөн практикт хэрэгжүүлэх боломж бүрдсэн эсэх?

Б. Судалсан байдал

ХЭҮК-оос 2001-2016 оны хооронд дангаар буюу бусад байгууллагатай хамтарч хийсэн шалгалтын тоо жил тутам өссөн үзүүлэлттэй байна. ХЭҮК өнгөрсөн хугацаанд нийт 745 шалгалт хийснээс 673-ыг дангаар, 72-ыг бусад байгууллагатай хамтран гүйцэтгэсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Дангаар хийсэн шалгалтын тоо:

Он	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	Нийт
Тоо	1	41	10	7	96	22	13	6	29	10	26	69	59	131	27	126	**673**

Бусад байгууллагатай хамтарч хийсэн шалгалтын тоо

Он	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	Нийт
Тоо	0	0	0	0	25	6	0	0	0	0	0	6	8	8	19	0	**72**

В. Үнэлсэн байдал

Комисс аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд дангаар буюу төрийн эрх бүхий байгууллага, тэдгээрийн албан тушаалтанд санал болгосны үндсэн дээр хамтран шалгалт хийх эрх зүйн зохицуулалтын хүрээнд дангаар, эсхүл бусад байгууллагатай буюу мэргэжлийн хяналт, прокурор, шүүхийн шийдвэр гүтйцэтгэх байгууллага, үйлдвэрчний эвлэл, төрийн бус байгууллага зэрэг байгууллагатай хамтран шалгалт хийж буй шалгалтын хувьд ямар нэг асуудал гардаггүй хэрэгжих боломжтой байна.

Харин хуулийн 18.2 дахь хэсэгт заасан байгууллагын хүсэлт, захиалгаар шалгалт хийсэн тохиолдол одоогоор байхгүй байна. Байгууллагууд өөрийн

Хүний эрхийн үндэсний комиссын мэдээллийн сан www.nhrc.gov.mn

хүсэлтээр үйл ажиллагаандаа шалгалт, үнэлгээ хийлгэх хүсэлгүй байдагтай үүнийг холбож болох юм. Гэхдээ энэ заалтаар дамжуулан дээрх боломжийг нээж өгсөн гэж үзэж болно. Өнөөгийн практикаас харахад аль нэг байгууллага өөр нэг байгууллагын үйл ажиллагаа хүний эрх зөрчиж байгааг шалгуулах тухай хүсэлтээ шууд гаргаагүй боловч байгууллага, иргэдийн зүгээс хүний эрхийн зөрчлийн талаар мэдээлэл өгөх тохиолдол гардаг. Эдгээр мэдээллийн мөрөөр Комиссоос тухайн байгууллагын үйл ажиллагаанд шалгалт хийдэг байна.

17.1.1. аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах, шүүх хуралдаанд хуулиар тогтоосон журмын дагуу биечлэн болон төлөөлөгчөө оролцуулах;

3.2.8 Хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтын зорилгод хүрсэн төвшин ба практикт хэрэгжих байдал

А. Шалгуур үзүүлэлтийн томъёолол:

Хүний эрхийн үндэсний комисс аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах, шүүх хуралдаанд хуулиар тогтоосон журмын дагуу биечлэн болон төлөөлөгчөө оролцуулах эрхийн тухай зохицуулалт хуулийн зорилгод нийцэж байгаа эсэх? Мөн практикт хэрэгжүүлэх боломж бүрдсэн эсэх?

Б. Судалсан байдал.

ХЭҮК-оос шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргахдаа Үндсэн хууль, МУ-ын олон улсын гэрээ, Шүүхийн тухай хууль, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулиудад заасан хүний эрх, эрх чөлөө, тэр дундаа хүүхдийн эрхийг зөрчсөн асуудлаар нэлээдгүй нэхэмжлэлийг шүүхэд гаргаж шийдвэрлүүлсний зарим нь шүүхийн практикт анх удаа шийдэгдэж байсан байна. Иймээс ХЭҮК нийтийн эрх ашгийг, хүний эрхийг төлөөлөн шүүхэд хандах хуулиар олгогдсон эрхээ хангалттай сайн хэрэгжүүлдэг гэж дүгнэсэн байна.[36] Тухайлбал, ХЭҮК 2001-2012 онд шүүхийн цагаатгах тогтоол болон прокурорын хэрэгсэхгүй болгосон тогтоолууд, мөн олон улсын гэрээний заалтыг зөрчсөн гэх үндэслэлээр 19 хүнд холбогдох 1,022,374,846 төгрөгийн хохирол нөхөн төлүүлэх талаар 15 төлөөлөн нэхэмжлэлийг харьяаллын дагуух шүүхүүдэд гаргаснаас шүүх 14 нэхэмжлэлийн 160,245,113,000 төгрөгийг ЗГ-ын нөөц хөрөнгөөс гаргаж 16 хохирогчид олгохоор шийдвэрлэсэн.[37] 2016 он хүртэлх хугацаанд эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн 25 иргэнийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргасан бөгөөд шүүхээс нийт 441,753,172 төгрөгийн гэм хорын хохирлыг хангаж шийдвэрлэсэн байна. Ийнхүү хилс хэргийн улмаас нэр төр, сэтгэл санаа, эрүүл мэнд зэрэгт учирсан гэм хорын асуудлаар шүүхэд хандаж эрхийг нь сэргээх практик тогтоосон нь хүний эрхийг хамгаалахад чухал дэвшил болсон гэж үздэг. Иймээс ч ХЭҮК-ын энэхүү эрхийг улам бататгаж Захиргааны процессын хуульд илүү дэлгэрүүлэн оруулсан байна.

ХЭҮК-ын иргэнийг шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргасан тоог харвал:

он	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	Нийт
тоо	0	0	1	1	1	2	0	0	1	3	7	3	3	3	1	3	**29**

[36] "Хүний эрх, эрх чөлөөг хангах эрх зүйн шинэтгэлийн бодлого, түүний хэрэгжилт" Ж.Баярцэцэг. ХЗЯ-ны ТНБД. "Хүний эрх" онол, арга зүйн сэтгүүл. 2016/01 дугаар 26 дахь тал.

[37] "Хүний эрхийн үндэсний байгууллагаас шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргаж байгаа өнөөгийн нөхцөл болон гарч буй хүндрэлүүд" П.Оюунчимэг. ХЭҮК-ын гишүүн, Хууль зүйн ухааны доктор. Хүний эрх" онол, арга зүйн сэтгүүл. 2012/02 дугаар 13 дахь тал

ХЭҮК-оос гаргасан төлөөлөн нэхэмжлэлийн үнийн дүнгийн маш бага хэсгийг шүүх ханган шийдвэрлэдэг, Улсын дээд шүүхийн 2008 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 09 тоот тогтоолоор батлагдсан “Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай” тайлбарыг шүүгч практикт хэрэглэж хэвшээгүй, ойлголт муутай байгаагаас хэрэг маргаан гүйцэд шийдэгдэхгүй байна гэж ХЭҮК-ын гишүүн, хууль зүйн доктор П.Оюунчимэг дүгнэсэн байна.

ХЭҮК төлөөлөн нэхэмжлэлийн үнийн дүнг тогтоохдоо хохирогчийн хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын болон прокурор, шүүхийн шатанд хоригдож байсан хугацаанд олох байсан орлого[38], өмгөөлөл болон хуулийн зөвлөгөө авахад зарцуулсан төлбөр, сэтгэл санаа, эрүүл мэнд, нэр төр, алдар хүндээрээ хохирсон хохирлыг цугларсан нотлох баримтын хэмжээнд тогтоодог. Эдгээрээс сэтгэл санаа, эрүүл мэндийн хохирлыг тооцож гаргах нь хамгийн хүндрэлтэй байдаг байна.

В. Үнэлсэн байдал

ХЭҮК-оос гаргаж буй төлөөлөн нэхэмжлэлийг шүүхээр шийдвэрлэж хохирогчдын эрх ашгийг хамгаалах, хохирлыг тодорхой хэмжээнд барагдуулах талаар хэрэгжүүлсэн ажиллагаа өнгөрсөн хугацаанд амжилттай хэрэгжиж, шүүхийн практикт анх удаа шийдэгдсэн тохиолдол цөөнгүй байна. Энэ нь хүний эрхийг хангахад чухал үр дүнтэй ажил болж байна. Харин шүүхээс нэхэмжлэлийн үнийн дүнгийн маш бага хэсгийг хүлээн зөвшөөрдөг нь хохирогчийн зүгээс гарсан бодит зардлыг нөхөж чадахгүй байна. Энэ нь хохирлын хэмжээг тооцох аргачлал байхгүй, ялангуяа эрүүл мэнд, сэтгэл санаа, нэр хүнд, олох байсан орлоготой холбоотой хохирлын хэмжээг тооцохтой холбоотой хүндрэлээс үүдэлтэй гэж үзэж болох байна.

17.1.2. хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн гэж үзсэн албан тушаалтанд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага ногдуулах тухай хүсэлтээ эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавих;

17.1.3. хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн, зөрчих нөхцөл бүрдүүлсэн үйл ажиллагаагаа зогсоохыг байгууллага, албан тушаалтнаас шаардах.

18.4. Комиссын гишүүн нь хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбогдсон хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай саналаа хууль санаачлах эрх бүхий албан тушаалтан, байгууллагад уламжилна.

19 дүгээр зүйл. Комиссын гишүүний шаардлага, зөвлөмж

19.1. Комиссын гишүүн нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шаардлага, зөвлөмж гаргана.

19.2. Комиссын гишүүн нь аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн гэж үзвэл тухайн хүний эрх, эрх чөлөөг сэргээж, зөрчлийг арилгуулахаар холбогдох байгууллагад шаардлага бичиж хүргүүлнэ.

19.3. Комиссын гишүүн нь аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөөг зөрчиж болзошгүй тохиолдолд шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар өөрийн эрх хэмжээний хүрээнд зөвлөмж гаргаж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

19.4. Комиссын гишүүний шаардлагыг хүлээн авсан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан долоо хоногийн дотор, зөвлөмжийг хүлээн авсан бол гуч хоногийн дотор авсан арга хэмжээнийхээ тухай бичгээр хариу мэдэгдэнэ.

19.5. Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авахаас татгалзсан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны талаар хуульд заасан журмын дагуу шүүхэд хандаж болно.

19.6. Комиссын гишүүн нь гаргасан шаардлага, зөвлөмжөө хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэвлэн нийтлэх, мэдээлэх эрхтэй.

[38] Хохирогчийн олж болох бодит орлогын хэмжээг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцдог.

3.2.9 Хуулийн **17 дугаар зүйлийн 17.1.2., 17.1.3, 18 дугаар зүйлийн 18.4 болон 19 дүгээр зүйл дэх заалтын зорилгод хүрсэн төвшин ба практикт хэрэгжих байдал**

А. Шалгуур үзүүлэлтийн томъёолол:

Хүний эрхийн үндэсний комиссоос хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн гэж үзсэн албан тушаалтанд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага ногдуулах тухай хүсэлтийг шийдвэрлэх асуудал болон уг комиссоос эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн шаардлагын хэрэгжилтийг зохицуулж буй хуулийн заалтын зорилгод хүрсэн төвшин хэр байна вэ? Мөн практикт хэрэгжүүлэх боломж бүрдсэн эсэх?

Б. Судалсан байдал

ХЭҮК 2001-2016 оны хооронд хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн албан тушаалтанд захиргааны шийтгэл ногдуулах тухай нийт 103 тохиолдолд хүсэлтээ эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

он	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	Нийт
тоо	0	3	0	0	5	5	1	0	1	0	5	6	5	41		32	**103**

Дээрх хугацаанд хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн, зөрчих нөхцөл бүрдүүлсэн үйл ажиллагаагаа зогсоох талаар байгууллага, албан тушаалтанд ХЭҮК-оос 229 удаа шаардлага хүргүүлсэн байна.

он	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	Нийт
тоо	11	18	14	5	10	5	18	2	6	6	18	14	19	19	35	31	**229**

Харин ХЭҮК-оос хүргүүлсэн шаардлагыг холбогдох байгууллага, албан тушаалтан хүлээж авахаас татгалзсан, эсхүл хариу өгөөгүй байх тохиолдол цөөнгүй байдаг байна. Энэ нь ХЭҮК-оос гаргасан зөвлөмж, хүргүүлсэн шаардлага заавал биелэх зарчимтай зөрчилдөх магадлалтай юм.

Өнгөрсөн 16 жилийн хугацаанд холбогдох байгууллага, албан тушаалтан ХЭҮК-оос өгсөн шаардлагыг хүлээж авахаас татгалзсан, эсхүл хариу ирүүлээгүй 19 тохиолдол бүртгэгдсэн байна.

он	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	Нийт
тоо	2	0	3	1	1	1	2	0	0	0	2	0	1	1	3	2	**19**

Харин ХЭҮК-оос хүргүүлсэн шаардлагыг үндэслэлгүй гэж үзсэн тохиолдол хүлээж авахаас татгалзсан, эсхүл хариу ирүүлээгүй байгууллага, албан тушаалтны тооноос даруй 2 дахин илүү буюу 31 тохиолдол бүртгэгдсэн байна. Үүнд:

Хүний эрхийн үндэсний Хэрэгсэл www.nhrc.gov.mn

он	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	Нийт
тоо	0	0	0	0	1	0	0	0	0	3	6	2	7	3	3	6	**31**

Манай улсын хувьд Комиссын гишүүний гаргасан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг чангатгах, биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагын хэмжээг нэмэгдүүлэх ажил хийгдэхгүй байна. Энэ нь шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байх гол хүчин зүйлийн нэг юм. Дэлхийн бусад орны хүний эрхийн үндэсний байгууллага, омбудсмены чиг үүрэг нь гомдол гаргагчийн эрхийг хамгаалахын тулд ялангуяа түүнд тохиолдсон бэрхшээлийн шалтгаан болж буй хууль тогтоомж, нийгмийн хэв журам, захиргааны практикийг өөрчлөх, засч залруулах шаардлага, зөвлөмжийг эрх бүхий байгууллагуудад хүргүүлэх, тухайн шаардлага, зөвлөмжийг хүлээж авсан этгээд биелүүлэх талаар арга хэмжээ авах үүрэг хүлээх явдал байдаг.

Одоогоор Комиссын гишүүний гаргасан шаардлага, зөвлөмжийг биелүүлээгүй, хугацаанд нь хариу өгөөгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх тогтолцоо байхгүй бөгөөд ийм тогтолцоог бий болгохгүйгээр хүний эрх зөрчигдөх явдалтай тэмцэхэд хүндрэл учрахаар байна.

Комиссын тухай хуулийн 19 дүгээр зүйлд Комиссын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шаардлага, зөвлөмж гаргана. Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт “Комиссын гишүүн нь аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн гэж үзвэл тухайн хүний эрх, эрх чөлөөг сэргээж, зөрчлийг арилгуулахаар холбогдох байгууллагад шаардлага хүргүүлнэ”, 19.2 дахь хэсэгт “Комиссын гишүүн нь аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөөг зөрчиж болзошгүй тохиолдолд шалтгаан нөхцөлийг арилгуулахаар өөрийнхөө эрх хэмжээний хүрээнд зөвлөмж гаргаж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ”, 19.4 дэх хэсэгт “Комиссын гишүүний шаардлагыг хүлээн авсан аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтан долоо хоногийн дотор, харин зөвлөмжийг хүлээн авсан бол 30 хоногийн дотор авсан арга хэмжээнийхээ тухай бичгээр хариу мэдэгдэнэ” гэж тус тус заажээ.

Гэтэл практикт Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн хариу хуулиар тогтоосон хугацаанд ирдэггүй. Комиссын ажилтан өөрөө шаардлага, зөвлөмж хүлээн авсан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтантай утсаар холбогдон, албан бичгээр хариу ирүүлэхийг шаардан ажилладаг. Шаардлага, зөвлөмжийн хариу ирүүлэх хуулиар тогтоосон хугацааг нарийвчлан тооцож үзэх зарчим ч тодорхой бус байгаа нь хүндрэл учруулдаг. Тухайлбал, аймаг, сумдад явуулсан шаардлага, зөвлөмжийг тухайн байгууллага, албан тушаалтан хүлээн авсан өдрөөс нь хугацааг тооцож эхлэх үү, эсвэл Комиссоос явуулсан шаардлага, зөвлөмж дээрх сар, өдрөөр хугацааг тооцох уу гэдэг асуудал тодорхойгүй байна.

Түүнээс гадна шаардлага, зөвлөмж хүлээн авсан байгууллага, албан тушаалтнууд түүнийг хүлээн аваад, холбогдох ажилтан руугаа шилжүүлсэн байх хэдий ч хариуг буцааж хүргүүлэх талаар удирдах албан тушаалтан ч, хариуцсан ажилтнууд ч анхаарал тавихгүй байгаагаас хугацаа алдаж, байнга шаардуулж байж ирүүлэх хандлага түгээмэл байдаг байна.

Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг хүлээн авсан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнуудаас өгсөн хариуг судлан үзэхэд тэдгээрийн дотор шаардлага, зөвлөмжид дурдсан асуудлаас өөр асуудлыг хөндсөн, тойруу утгатай, биелүүлэхээс зайлсхийсэн шинжтэй, газар дээр нь очиж танилцалгүйгээр тухайн шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг дүгнэх боломжгүй, хүндрэлтэй нөхцөл байдлыг үүсгэдэг үзэгдэл багагүй байна.

2001-2017 оны 4 дүгээр сарын байдлаар Комиссын гишүүн аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай гомдол мэдээллийг хүлээн авч зөрчлийг арилгуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтанд нийт 241 шаардлага, хүний эрх, эрх чөлөөг зөрчиж болзошгүй тохиолдол шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар Комиссын гишүүний бүрэн эрхийн хүрээнд нийт 238 зөвлөмжийг холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, шаардлага зөвлөмжийн биелэлтийг хангуулан ажиллажээ.

2014-2017 оны 4 дүгээр сарын байдлаар Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн байдал:

Он	Шаардлага/ зөвлөмж	Нийт тоо	Огт хариу өгөөгүй	Хариу ирүүлсэн боловч биелэлт хангалтгүй
2014 он	Шаардлага	19	2	1
	Зөвлөмж	25	5	-
2015 он	Шаардлага	37	3	4
	Зөвлөмж	40	-	4
2016 он	Шаардлага	31	2	-
	Зөвлөмж	28	7	-
2017 он	Шаардлага	10	1	-
	Зөвлөмж	6	-	-

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5 дахь хэсэгт заасны дагуу Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авахаас татгалзсан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны талаар хуульд заасан журмын дагуу шүүхэд хандсан 3 тохиолдол байдаг байна.

В. Үнэлсэн байдал

ХЭҮК 2001- 2016 оны хооронд хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн гэж үзсэн албан тушаалтанд хариуцлага ногдуулах тухай нийт 229 хүсэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьсан бөгөөд эдгээр шаардлагын дагуу хэрэгжүүлж буй арга хэмжээний хэрэгжилт удаан, зарим тохиолдолд зөрчлийн хэмжээтэй харьцуулахад харьцангуй бага хариуцлага ногдуулдаг болон зөрчил шалгах ажиллагаа шударга явагдаж байгаа зэрэгт иргэд, олон нийтийн зүгээс өгөх үнэлгээ, итгэл зэргээс хамааран зохицуулалтын хэрэгжилт зохистой түвшинд хүрэхгүй, үр дүн сул байна. Энэ нь ялангуяа хууль сахиулах байгууллагын ажилтан, албан хаагчдын гаргасан зөрчлийг тухайн байгууллага өөрөө шалгаж байгаатай холбоотой үүсэж байна.

ХЭҮК-оос хүргүүлсэн шаардлагыг хүлээж авахгүй байх, шаардлагын хариуг ирүүлэхгүй байх, эсхүл үндэслэлгүй гэх шалтгаанаар буцаах асуудалд хариуцлага тооцох тогтолцоо, шийдвэрлэх арга, зохицуулалт байхгүй байна.

Комиссоос хүргүүлсэн шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх асуудал хүндрэлтэй байдаг. Тухайлбал, шаардлага хүргүүлсэн байгууллагуудаас ирүүлж буй мэдээлэлд хүний эрхийг зөрчсөн тодорхой үйлдлийг таслан зогсоосон гэхээс илүүтэй таслан зогсоохын тулд ямар нэг үйл ажиллагаа хийх, арга хэмжээ авах тухай төлөвлөж, хичээж байгаа, тухайн зөрчил дотоод хяналт, шалгалтын хүрээнд тогтоогдоогүй тул арга хэмжээ авах боломжгүй тухай ирүүлсэн мэдээллийг хэрхэн үнэлэх нь үзэмжээр шийдэж болох нөхцөлийг үүсгэж, хүний эрхийн зөрчлийг даамжруулах боломжийг бүрдүүлж байна.

Комиссын шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар хариу ирүүлээгүй тохиолдолд “хариу ирүүлээгүй” гэх үндэслэлээр хуулийн 19.1 дэх хэсэгт заасны дагуу шүүхэд хандах боломж олгосон эрх зүйн зохицуулалт л энэ зүйл заалтын хувьд хариуцлагын арга хэмжээ болж байгаа нь Комиссыг “шүдгүй арслан” болгож байна. Иймд Комиссоос хүргүүлсэн шаардлага, зөвлөмжийг биелүүлэх үүргийг байгууллага, албан тушаалтанд хүлээлгэдэг гадаад орнуудын туршлагыг үндэсний

хууль тогтоомжид нийцүүлэн нутагшуулах асуудлыг судлах, нэвтрүүлэх шаардлага байна.

Г. Санал

Комиссоос хүргүүлж буй шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах үүднээс шаардлага, зөвлөмж хүлээж авсан байгууллагын хэрэгжүүлсэн арга хэмжээг үнэлэх аргачлал боловсруулах, мөн шаардлага, зөвлөмжийг биелүүлэхгүй удаашруулах, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох талаар шуурхай, тодорхой арга хэмжээ авахгүй байгаа нь илэрхий байгаа тохиолдолд хүлээлгэх хариуцлагын шатлал, төрлийг нэг мөр тодорхой болгох шаардлагатай байна.

17.1.4. талуудыг эвлэрүүлэх замаар асуудлыг шийдвэрлэх;

3.2.11 Хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалтын зорилгод хүрсэн төвшин ба практикт хэрэгжих байдал

А. Шалгуур үзүүлэлтийн томъёолол:

Хүний эрхийн үндэсний комиссын талуудыг эвлэрүүлэх замаар асуудлыг шийдвэрлэх ажиллагааны зорилгод хүрсэн түвшинг тодорхойлох боломж бий эсэх? Практикт хэрэгжүүлэх боломж бүрдсэн эсэх?

Б. Судалсан байдал

Комиссын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх хэсэгт талуудыг эвлэрүүлэх замаар гомдол шийдвэрлэх гэсэн тодорхойгүй заалт байдаг боловч хүний эрхийн ямар зөрчлийг эвлэрүүлэх замаар шийдвэрлэх, эвлэрлийн үйл ажиллагаанд комиссын ажилтнууд ямар статустай оролцох (эвлэрүүлэн зуучлагч), ямар бүрэн эрх, чиг үүрэгтэй байх, уг ажиллагааг ямар арга хэлбэрээр явуулах нь тодорхойгүй байна. Үүний улмаас Комиссын ажилтнууд ХЭҮК-т гаргасан гомдлыг шийдвэрлэх гарын авлагад дурдсаны дагуу талуудын хооронд эвлэрлийн гэрээг хийж, гарын үсэг зуруулан гомдлыг хаадаг. Гэтэл энэ эвлэрлийн гэрээ нь Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд зааснаас гадуур хийгддэг ажиллагаа тул талууд эвлэрлээсээ татгалзсан тохиолдолд яах вэ гэдэг асуудал тодорхойгүй байна. ХЭҮК 2014 онд 8, 2015 онд 9, 2016 онд 9 гомдолд дурдсан асуудлыг тус тус эвлэрүүлэх замаар шийдвэрлэсэн байна

Г. Үнэлсэн байдал

ХЭҮК-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх хэсэгт заасан эвлэрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрэн бүрэлдээгүй, эвлэрүүлэх үйл ажиллагааны үр дүн болох эвлэрлийн гэрээг хэрхэн үнэлэх, гэрээг зөрчсөн эсхүл гэрээнээс татгалзсан тохиолдолд ямар эрх зүйн үр дагавар үүсэх нь тодорхойгүй, 2012 онд батлагдсан Эвлэрүүлэн зуучлалын тухай хуультай хэрхэн уялдуулах талаар тодорхой арга хэмжээг аваагүй зэрэг асуудлууд өнөөг хүртэл байсаар байна. Иймд хуулийн энэ зохицуулалтын зорилгод хүрэх төвшин хангалтгүй, практикт хэрэгжих боломж бүрдээгүй байна.

Тухайлбал, Комиссын үйл ажиллагааны явцад талууд эвлэрсэн тохиолдолд тэдний эвлэрлийн гэрээг баталгаажуулах эрх Комисст байхгүй, иймээс хэрэв талууд эвлэрлийн гэрээнээс буцсан тохиолдолд хүлээлгэх хариуцлага тодорхойгүй байгаа нь энэ зохицуулалтын хүрээнд хийгдэж буй үйл ажиллагаа зөвхөн итгэлцлийн үндсэн дээр хэрэгжих боломжтойг харуулж байна.

Эвлэрүүлэн зуучлах асуудлыг зохицуулж буй хуулийн энэ заалтын хэрэгжилтийг бодитой болгох үүднээс Комиссын эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааны процессыг тодорхой болгох, эвлэрлийн гэрээг баталгаажуулах эвлэрлийн гэрээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын асуудлыг тодорхой болгох шаардлагатай. Эдгээр асуудлуудыг тодорхой шийдээгүй тохиолдолд хуулийн энэ заалт хэрэгжих боломжгүй байна.

9.2. Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын иргэний адил Комисст гомдол гаргах эрх эдэлнэ.

10.1. Гомдлыг монгол хэлээр бичгээр, эсхүл амаар биечлэн гаргана. Монгол хэл мэдэхгүй хүн эх хэлээрээ гомдол гаргаж болох бөгөөд гомдлоо монгол хэлнээ орчуулж, зохих журмаар баталгаажуулсан байна.:

3.2.12 Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалт болон 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтын зорилгод хүрсэн төвшин ба практикт хэрэгжих байдал

А. Шалгуур үзүүлэлтийн томъёолол:

Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын иргэний адил Комисст гомдол гаргах эрх эдлэх тухай зохицуулалтын зорилгод хүрсэн төвшин хир байна? Мөн практикт хэрэгжүүлэх боломж бүрдсэн эсэх?

Б. Судалсан байдал

Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын иргэний адил Комисст гомдол гаргах эрх эдлэх эрх зүйн орчин, нөхцөл бүрдсэн боловч гомдол гаргахад тавигдах шаардлагад өргөдлийг заавал монгол хэл рүү хөрвүүлэх, түүнийг баталгаажуулах дотоодын болон олон улсын эрх зүйн баримт бичигт заасан ямар эрх нь зөрчигдсөн тухай заавал дурдах зэрэг шаардлагууд нь бэрхшээл үүсгэх боломжтой. Учир нь өнөөдөр манай улсын хууль тогтоомжууд гадаад хэл дээр албан ёсоор орчуулагддаггүй, орчуулгын үйлчилгээний өртөг өндөр байдаг.

ХЭҮК-оос гаргасан судалгаанаас харахад 2001-2016 онд нийт 41 гадаадын, эсхүл харьяалалгүй иргэн гомдол гаргасан байна. Үүнээс хамгийн олон гомдлыг 2015 онд гаргаж байсан бол 2001, 2002 онд огт гомдол гаргаагүй байна. 16 жилийн дунджийг харвал ХЭҮК нэг жилд ойролцоогоор 2,5 гадаадын, эсхүл харьяалалгүй иргэнээс гаргасан гомдол хүлээж авсан байна.

В. Үнэлсэн байдал

Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын иргэний адил Комисст гомдол гаргах эрх эдлэх эрх зүйн орчин бүрдсэн боловч түүнийг хэрэгжүүлэх ажиллагаа хүндрэлтэй байна. Ялангуяа зөвхөн монгол хэл дээр гомдол гаргах, мөн аль хууль тогтоомжид тусгасан ямар эрх, эрх чөлөөгөө зөрчигдсөн гэж үзэж байгаагаа тэмдэглэх зэрэг нь хуулийн заалтын зорилгод хүрсэн түвшинг бууруулах шалтгаан болох магадлалтай байна.

Г. Санал зөвлөмж

Гадаадын, эсхүл харьяалалгүй иргэн ХЭҮК-т гомдол гаргах ажиллагааг хөнгөвчлөх боломжийг судлах, ялангуяа эх хэлээрээ, эсхүл НҮБ-ын албан ёсны хэлний аль нэгээр гомдол гаргах,мэдээлэл авах асуудалд анхаарах

ДҮГНЭЛТ

2000 онд батлагдсан Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль 17 дахь жилдээ хэрэгжиж байгаа бөгөөд өнгөрсөн хугацаанд 2002, 2003, 2011, 2015 онд нийт 5 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд нь Жендэрийн тухай, Хууль тогтоомжийн тухай, Эрүүгийн болон Зөрчлийн тухай хууль зэрэг бусад хууль тогтоомжууд батлагдсантай холбоотой орсон байдаг.

1991 онд НҮБ-ын Хүний эрхийн комиссоос Хүний эрхийн үндэсний байгууллагуудын талаарх зарчмуудыг баталсан. Үүнд тодорхойлсноор “Хүний эрхийн Үндэсний байгууллага нь бие даасан, тодорхой эрх мэдэлтэй, байнгын ажиллагаатай, олон ургальч төлөөллийг хангах зарчмаар бий болсон бүрэлдэхүүнтэй, олон нийтэд ойр, өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулах санхүүгийн чадвартай байх ёстой. Мөн хуулийг дээдэлж, хараат бус, бие даасан байж, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсыг тууштай хамгаалж, ил тод, шударга ажиллах үүрэгтэй”

байна. Эдгээр үзүүлэлтүүд нь Хүний эрхийн Үндэсний байгууллагын үр нөлөөтэй эсэхийг хэмжих шалгуур болдог.

Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний үр дүнд тогтоогдсон хүндрэл бэрхшээл, зөрчил, хийдэл, давхардлыг арилгах, тэдгээрийг шийдвэрлэхтэй холбоотой асуудлын хүрээнд гаргасан судалгааны багийн саналыг хуулийг боловсронгуй болгох ажлын хүрээнд ашиглах боломжтой юм.

Комиссын гишүүнд нэр дэвшүүлэх, томилох, нөхөн томилох асуудлын хүрээнд ХЭҮКтХ-ийн 5.1, 5.2, 5.4, 5.5, 5.6 дахь заалтыг тус тус сонгон судалж дараах дүгнэлтэд хүрсэн байна. Үүнд:

Судалгааны дүнгээс харахад манай улсын хүний эрхийн үндэсний байгууллагын гишүүдийг томилох, сонгон шалгаруулах үйл ажиллагаа Парисын зарчимд тусгалаа олсон олон улсын стандартад нийцэхгүй байна.

Олон улсын стандартад зааснаар 1/ гишүүний сул орон тоо гарч байгааг олон нийтэд ил зарлах, 2/ нийгмийн олон янзын бүлгүүдээс нэр дэвших боломжтой нэр дэвшигчдийн тоог нэмэгдүүлэх, 3/ нэр дэвших иргэнийг урьдаас тодорхой болсон, бодитой, нийтэд ил тод шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлдэг байх, 4/ нэр дэвшигчийг төлөөлж буй байгууллагынхаа нэрийн өмнөөс гэхээс илүүтэй хувь хүний өөрийн мэдлэг, чадавхаар ажиллах хүнийг сонгон шалгаруулдаг байхыг чухалчлан үздэг. Манай улсын хувьд ХЭҮК-ын гишүүдийг сонгон шалгаруулж, нэр дэвшүүлж буй процесс гишүүдийн хараат бус, бие даасан байх нөхцөлийг бүрдүүлж байгаа эсэх нь тодорхойгүй байна. Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын их хурал, Улсын дээд шүүхээс нэр дэвшүүлэгчийн талаарх мэдээлэл олон нийтэд ил болдоггүй, эрх бүхий субъект зөвхөн нэг хүний нэр дэвшүүлдэг, үүнээс шалтгаалан сонгон шалгаруулалт явуулах боломжгүй байдал үүсдэг, нэр дэвшүүлсэн этгээд гишүүнээр сонгогдоогүй тохиолдол байхгүй, гишүүнд нэр дэвшүүлэх, томилох ажиллагаа 2-3 хоногийн хугацаанд явагддаг, УИХ нэр дэвшигчийг гишүүнд томилохоос татгалзаж байсан удаагүй, олон нийт, иргэний нийгмийн байгууллагуудаас нэр дэвшүүлсэн этгээдтэй холбоотой санал авч байгаагүй зэрэг нь энэхүү зохицуулалт олон улсын стандартад нийцэхгүй байгааг харуулж байна. Үүнээс харахад ХЭҮК-ын гишүүнд нэр дэвшүүлэх асуудал МУ-ын Ерөнхийлөгч, УИХ, УДШ-ийн хүрээнд хаалттай орчинд зохион байгуулагддаг, УИХ-аас нэр дэвшиж сонгогдсон Комиссын гишүүн Комиссын даргаар сонгогддог практик тогтсон байна.

ХЭҮК-ын даргыг УИХ-ын даргын санал болгосноор УИХ-аас 3 жилийн хугацаатай сонгох энэхүү тогтолцоо нь ХЭҮК-ын үйл ажиллагаа, удирдлага улс төрийн нөлөөнд автах, хараат байдлыг бий болгох боломжийг бүрдүүлж байгаа бөгөөд энэхүү заалт хэрэгжсэнээр хуулийн үндсэн зорилгын нэг болох хараат бус, бие даасан хүний эрхийн үндэсний байгууллага байх асуудлыг гажуудуулах эрсдэлийг үүсгэж байна.

Мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1. дэх хэсэгт “Комиссын гишүүнд нэр дэвшигчийн нэрийг Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Улсын дээд шүүхийн саналыг үндэслэн Улсын Их Хурлын дарга Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж томъёолсон нь найруулгын хувьд ХЭҮК-ын гишүүнд нэр дэвшигчийн талаар Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Улсын дээд шүүхээс санал авахаар ойлгогдож байна.

ХЭҮК-ын гишүүдийг томилох үед жендэрийн тэгш байдлыг хангах асуудлыг хуульд тусгаагүй боловч өнгөрсөн хугацаанд томилогдон ажилласан гишүүдийн дунд жендэрийн харьцаа харьцангуй сайн хангагдаж байсан байна. Гэвч Комиссын гишүүнд санал болгох эрх бүхий субъектээс зөвхөн 1 хүний нэр дэвшүүлдэг бөгөөд жендэрийн тэгш байдлыг хангаж байгаа явдал нь тохиолдлын журмаар хэрэгжиж байгаа гэж үзэж болохоор байна. Иймд гишүүнд нэр дэвшүүлэх эрх бүхий субъектээс хамгийн багадаа 1 эрэгтэй, 1 эмэгтэй гишүүний нэр дэвшүүлдэг болох, түүнийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх асуудлыг судлах шаардлагатай байна.

Комиссын гишүүний санал, зөвлөмж өгөх, зөвлөх эрхийн хэрэгжилтийн хүрээнд ХЭҮКтХ-ийн 13.1.1., 13.1.2, 13.1.3., 18.1., 18.5.,18.6 дахь заалтыг тус тус сонгон судалсан бөгөөд дараах дүгнэлтэд хүрсэн байна.

Комиссын гишүүн бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой аливаа асуудлаар санал, зөвлөмж гаргах, аливаа хууль тогтоомж, захиргааны шийдвэр хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар зөвлөмж, санал гаргах, мөн УИХ-ын чуулган, ЗГ-ын хуралдаан, төрийн байгууллагын хүсэлтээр зөвлөх эрхтэй оролцох, зөвлөгөө өгөх эрх хуулиар олгогдсон нь хуулийн зорилгод нийцсэн боловч үүнээс УИХ-ын чуулган, ЗГ-ын хуралдаан, төрийн байгууллагын хүсэлтээр зөвлөх эрхтэй оролцох, зөвлөгөө өгөх эрх практикт хэрэгждэггүй буюу УИХ, ЗГ, төрийн байгууллагын зүгээс зөвлөмж, зөвлөгөө авах хүсэлт гаргасан тохиолдол ховор байна. Иймд ХЭҮК-ын гишүүн өөрийн санаачлагаар оролцох эрхийг олгох шаардлага байна.

1998 онд батлагдсан “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийн 1.1.3.2.3-т “Улсын их хурал, байнгын хороод, Засгийн газрын хуралдаанаар хүний эрх, эрх чөлөөнд шууд холбогдох асуудлыг хэлэлцэхэд ХЭҮК-ын гишүүд өөрийн санаачлагаар оролцож, санал дүгнэлтээ мэдэгдэх эрхтэй болгоно” гэж заасан боловч энэ зорилт өнөөг хүртэл хэрэгжээгүй, Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуульд энэхүү эрхийг олгосон зохицуулалт ороогүй байна.[39] Иймд ХЭҮК-ын гишүүд бичгээр санал хүргүүлэхээс гадна УИХ-ын чуулган, ЗГ-ын хуралдаанд өөрийн санаачлагаар оролцож хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой асуудлаар санал, дүгнэлтээ хэлэх эрх олгосон эрх зүйн зохицуулалт дутагдаж байна.

Үүнээс гадна Комиссоос хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой асуудлаар гаргасан саналыг хууль тогтоомжийн төсөлд хэрхэн тусгаж буй талаар мэдээлэл байхгүй, мөн тэдгээрийг хэлэлцэн, хэрэгжилтийг хангах үүднээс Хууль зүйн байнгын хорооноос гаргасан тогтоолын хэрэгжилт мөн адил хангалтгүй байгаа нь Комиссын гишүүдийн санал, зөвлөмжийн үр нөлөөг бууруулж байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Комиссоос МУ-ын Олон улсын хүний эрхийн гэрээний биелэлт, энэ тухай Засгийн газрын илтгэлийг боловсруулахад санал өгөх үүргээ өөрийн нөөц бололцооны хүрээнд тогтмол хэрэгжүүлж ирсэн байна. Гэвч үндэсний хэмжээний илтгэлд санал боловсруулах ажлын суурь болсон судалгаа, шинжилгээний ажилд шаардлагатай боловсон хүчин, төсөв санхүүгийн хүрэлцээ хангалтгүй байгаа зэргээс үүдэн хуулийн заалт практикт бүрэн хэрэгжих чадахгүй байх магадлалтай. Комиссын үйл ажиллагаанд улсын төсвөөс олгогдож буй санхүүжилтийн хэмжээ албан хаагчдын цалингийн зардлын хэмжээтэй дүйцэж байгаа нь улсын хэмжээнд судалгаа шинжилгээний ажил хийх, хүний эрхийн хэрэгжилтийн талаарх бодит нөхцөл байдлыг улсын хэмжээнд тогтоох үйл ажиллагаа явуулахад хангалтгүй байна. Тиймээс зөвхөн нийгэм, улс төр, олон нийтийн анхаарал төвлөрсөн асуудлын хүрээнд судалгаа хийж, судалгааны үр дүнд суурилсан мэдээллээр хангах боломжтой гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Комиссын олон улсын, бүсийн болон үндэсний хэмжээний хүний эрхийн байгууллагуудтай хамтран ажиллах асуудлын хүрээнд ХЭҮКтХ-ийн 13.2.2 дахь заалтыг сонгон судалж дараах дүгнэлтэд хүрлээ.

ХЭҮК олон улсын, бүсийн, хүний эрхийн бусад үндэсний байгууллагатай хамтран ажиллах тухай зохицуулалт нь хүний эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулах, хөхүүлэн дэмжих зорилгод нийцсэн байна. ХЭҮК-ын хэрэгжүүлж буй үйл ажиллагаа энэ заалтын зорилгод нийцсэн байх бөгөөд практикт нийцэх байдал нь мөн адил хангалттай сайн гэж дүгнэсэн байна.

Комиссын олон улсын болон бүсийн хүний эрхийн байгууллагуудтай үргэлжлүүлж буй хамтын ажиллагаа идэвхитэй байхад гадаадын хүний эрхийн байгууллагуудын идэвхи санаачлага, манай байгууллагыг дэмжих хүсэл их байдагтай шууд холбоотой байна. Тухайлбал, Комисс нь одоогоор зөвхөн олон

[39] “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь: Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн 2008 оноос хойших хэрэгжилт. Хавсралт тайлан ”. ХЗҮХ. 2016 он. Уб хот. 205 дахь тал.

улсын байгууллагуудад зөвхөн гишүүнчлэлийн төлбөрөө төлдөг бөгөөд бусад зардал гадаадад Монгол Улсыг төлөөлөн оролцоход хүрэлцдэггүй байна.

Комиссоос Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар илтгэл бэлтгэж жил бүрийн эхний улиралд багтаан Улсын Их Хуралд илтгэх асуудлын хүрээнд ХЭҮКтХ-ийн 13.2.3., 20.1 дэх заалтыг сонгон судалж дараах дүгнэлтэд хүрлээ.

ХЭҮК Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл бэлтгэж, УИХ-д илтгэх зорилгоо хангалттай хэрэгжүүлж байгаа боловч түүний практик ач холбогдол нь хангалттай биш байна.

Хуулийн 20.1 дэх хэсэгт Комисс хүний эрх, эрх чөлөөний талаарх илтгэлээ УИХ-д “илтгэнэ” гэж зохицуулсан нь энэхүү илтгэх процессыг хэрхэн хэрэгжүүлэх тухайд ойлгомжгүй байдал үүсгэдэг тул үүнийг хуулийн тайлбар хийх, нарийвчлан зохицуулах шаардлагатай гэж үзэж байна. Тухайлбал, илтгэнэ гэдэгт УИХ-ын даргад илтгэлийг өргөн барих, эсхүл УИХ-ын чуулганаар илтгэлээ хэлэлцүүлэх үйл явцын алиныг ойлгохыг тайлбарлах асуудал тулгамдаж байна. Учир нь практикт улс төрийн амьдралд гарч буй өөрчлөлтийн, тухайлбал сонгуулийн дараа шинээр бүрдэж буй бүтэц бүр дээрх зохицуулалтыг өөр өөрөөр тайлбарлах явдал байнга гардаг, хамгийн сүүлд 2016 оны илтгэлийг цахим хэлбэрээр авах нь “илтгэх” гэсэн ойлголтод багтана гэж үзэж байна.

Мөн Комиссын илтгэлийг хэлэлцэх асуудлыг тодорхой болгох, тухайлбал УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг гаргадаг байх, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаар Комисст мэдэгддэг байх асуудлыг хуульчлах, заалтын хэрэгжилтийг сайжруулах үүднээс хуулийн нэр томъёо, илтгэх процессыг нэг мөр болгох шаардлагатай байна.

Комиссын хүний эрхийн талаарх хууль тогтоомж, олон улсын гэрээг олон нийтэд сурталчлах, эрх зүйн боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих асуудлын хүрээнд ХЭҮКтХ-ийн 13.2.4., 13.2.5 дахь заалтыг сонгон судалж дараах дүгнэлтэд хүрсэн байна.

ХЭҮК хүний эрхийн талаарх хууль тогтоомж, олон улсын гэрээг олон нийтэд сурталчлах зорилгод хүрч ажиллаж байгаа боловч эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэх төсөв бага, хууль тогтоомж сурталчлах үйл ажиллагаа явуулах үүрэг бүхий бусад байгууллагын үйл ажиллагаатай харилцан уялдаагүй зэрэг асуудал тулгамддаг байна.

Хууль тогтоомж, олон улсын гэрээг олон нийтэд сурталчлах ажлын үр дүнг дээшлүүлэхэд юуны өмнө адил чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах шаардлага байна. Тухайлбал, холбогдох хууль тогтоомжоор тухайн асуудлыг хариуцсан яаманд олон улсын гэрээг орчуулах, сурталчлах ажлыг зохион байгуулах үүрэг хүлээлгэсэн байдаг. Үүний зэрэгцээ Комисс болон бусад хууль сурталчлах чиг үүрэг бүхий байгууллагуудад мөн адил энэ үүргийг хүлээлгэсэн байдаг. Гэтэл эдгээр байгууллагуудын хоорондын уялдаа холбоог сайжруулах арга хэмжээ дутагдаж байна. Ялангуяа олон улсын гэрээ, конвенцийн орчуулгын асуудал, тэдгээрийг хууль, хяналтын байгууллагууд хэрэглэх асуудлыг нэн даруй шийдвэрлэх асуудалд бодлогын түвшинд онцгой анхаарах шаардлага байна.

Комиссоос иргэд, олон нийтэд хүний эрхийн боловсрол олгох чиглэлээр цөөнгүй арга хэмжээ авч, тодорхой үр дүнд хүрч байна. Гэхдээ хүний эрхийн боловсролыг дэмжих үйл ажиллагааны хүрээнд хийж гүйцэтгэсэн ажилдаа хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг тогтмол гүйцэтгэдэг байх асуудал орхигдсон байна. Энэ нь сургалт, сурталчилгааны ажлууд хүссэн үр дүндээ хүрэхэд хангалттай агуулга, арга, хэрэгслээр хийгдэж байгааг тогтооход чухал үүрэгтэй. Манай улсын хувьд хүний эрхийн боловсролыг дэмжих ажиллагаанд хэвлэл мэдээллийг татан оруулах, ялангуяа сургуулийн өмнөх боловсролын төв, сургуулиуд дахь хүний эрхийн боловсролын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд илүүтэй анхаарах шаардлагатай байгаа нь ажиглагдаж байна.

Иргэдээс Комисст хандаж гомдол гаргах эрх, гомдлыг хянах ажиллагаатай холбогдох асуудлын хүрээнд ХЭҮКтХ-ийн 9.1., 9.2., 9.3., 9.4 дэх заалтыг сонгон судалж дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

Комисст гомдол гаргах хэлбэрийн тухайд иргэд гомдлоо зөвхөн өөрийн биеэр болон төлөөлөгчөөрөө дамжуулан гаргаж байгаа ба утсаар болон цахим хэлбэрээр гомдол гаргах боломжгүй, энэ боломжийг олгосон эрх зүйн орчин бүрдээгүй байна. Практикт хэрэгжиж буй байдлыг судлахад Комисс иргэдээс дээр дурдсан бүх хэлбэрээр гомдлыг хүлээн авдаг тул нэгэнт практикт хэрэгжиж буй утсаар болон цахим хэлбэрээр гомдол гаргах, түүнийг нотлох баримтын түвшинд хүлээж авах процессыг хуульчлах шаардлагатай юм.

Мөн Комиссын тухай хуулийн 9 дүгээр зүйлд Комисст гомдол гаргах эрх бүхий субъектүүдийг өргөн хүрээнд тодорхойлж өгсөн боловч үүнд хүүхэд өөрөө шууд ХЭҮК-т хандаж гомдол гаргах эрх зүйн орчин бүрдээгүй байна. Сүүлийн жилүүдэд нийгэмд ядуурал, гэр бүлийн хүчирхийлэл, согтууруулах ундаа, мансуурах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хэрэглээ газар авч байгаа зэрэг нь хүүхдийн эрхийг зөрчих орчин нөхцөлийг бий болгосоор байна. Иймд дээр дурдсан орчин, гэр бүлд өсөж буй хүүхэд эрхээ хамгаалуулахдаа заавал асран хамгаалагч, төлөөлөгчөөр дамжуулан ХЭҮК-т хандах нь зохистой эсэхийг судлах хэрэгтэй юм. Практикт Комисс үйл ажиллагааны явцад хүүхдээс гаргасан өргөдлийг хүлээн авч холбогдох арга хэмжээг авч ажилладаг. Иймд энэ асуудлыг мөн адил хуульчлах шаардлагатай байна.

Үүнээс гадна гомдол гаргах хэлбэрийн шаардлагын хувьд гомдлыг зөвхөн монгол хэлээр, бичгээр эсхүл амаар биечлэн гаргана. Монгол хэл мэдэхгүй хүн эх хэлээрээ гомдол гаргаж болох бөгөөд гомдлоо монгол хэлнээ орчуулж, зохих журмаар баталгаажуулсан байхаар зохицуулсан нь гомдол гаргагч хэрэв бичиг үсэг мэддэггүй, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй байх, гадаадын иргэн, үндэсний цөөнх байх зэрэг тохиолдолд иргэн гомдол гаргах эрхээ бүрэн эдэлж чадахгүй байх, монгол хэлнээс бусад хэлээр гомдол гаргаж буй иргэнд орчуулгын, хэлмэрчийн хөлс зэрэг нэмэлт зардал шаардах байдлаар гомдол гаргах процесс өөрөө хүндрэл, чирэгдэл үүсгэх магадлалтай байгаатай холбогдуулан тус ажиллагааг хялбаршуулах боломжийг судлах шаардлага байна.

Гомдол шалгах ажиллагааны явцад мэдээлэл цуглуулах Комиссын үйл ажиллагааны хүрээнд ХЭҮКтХ-ийн 16.1.2-4., 16.1.8., 18.3., 23.4 дэх заалтын хэрэгжилтийг судалж дараах дүгнэлтэд хүрсэн болно. Үүнд:

Иргэдээс ирсэн гомдлыг хууль тогтоомжид заасан шаардлага хангасан гэж үзсэн тохиолдолд Комисс хүлээн авч холбогдох арга хэмжээ авч ажиллаж байна. Эдгээр ажиллагаанаас Комисс иргэдээс хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн байдалтай холбоотой гаргасан гомдлыг шалгах ажиллагааны явцад шаардлагатай мэдээлэл гаргуулж авах, газар дээр нь танилцах болон холбогдох этгээдүүдтэй биечлэн уулзах тухай хуулийн зохицуулалтын хэрэгжилт хүндрэлтэй байна. Үүнийг нэгдүгээрт, холбогдох байгууллага, этгээдүүд мэдээ, баримт сэлтийг гаргаж өгөхдөө хойрго, ямар нэгэн шалтгаанаар удаашруулах, саатуулах оролдлого гаргах нь түгээмэл байдаг бол иргэдийн зүгээс өөртэй нь болон шалгагдаж буй гомдолтой холбогдох мэдээллийг нуух, мэдээлэл өгснөөр өөрт нь ямар нэг сөрөг үр дагавар учрахаас эмээх байдал их тохиолддог байна. Эдгээр шалтгааны улмаас хуулийн энэ заалтын хэрэгжилт практикт хэрэгжих байдал нь хүнд, мөн хүний эрхийн зөрчлийг илрүүлэх ажиллагааг удаашруулах нэг хүчин зүйл болж байна.

Комиссын зүгээс хэрэгжүүлж буй гомдол хянан шийдвэрлэх ажиллагаанд хуулийн 16.1.4 дэх заалтыг голлон ашиглаж шаардлагатай баримт мэдээллийг албан тушаалтан, байгууллагаас шаардаж авдаг. Гэвч энэ эрх нь зөвхөн гишүүний бүрэн эрхийн хүрээнд авч болох арга хэмжээ байхаар зохицуулагдсан бөгөөд ажлын албаны албан хаагчдад хамаарахгүй байгаа нь хүндрэл учруулдаг байна. Тухайлбал комиссын гишүүн зөвхөн өөрийн биеэр ирсэн тохиолдолд мэдээлэл өгөх асуудал тогтмол хөндөгддөг бөгөөд үйл ажиллагаагаа хэвийн явуулах үүднээс

хууль хяналтын байгууллагууд хувьд удирдлагын түвшинд харилцан тохиролцсоны үндсэн дээр тухайн хэргийг хариуцсан Комиссын мэргэжилтэнд гишүүний зүгээс итгэмжлэл олгох байдлаар дээрх хуулийн заалтын хэрэгжилтийг хангаж байгаа бол хувийн хэвшлийн байгууллагуудыг шалгах, тэдгээрээс баримт, мэдээ авах нөхцөлд энэ заалтыг хэрэгжүүлэхэд ихээхэн хүндрэл учирдаг байна. Иймд тухайн хэргийг хариуцсан Комиссын мэргэжилтэнд орон байранд нэвтрэх, мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн эрх зүйн зохицуулалттай болох шаардлага бий.

Шаардлага хангаагүй, эсхүл үндэслэлгүй гэх үндэслэлээр гомдол буцаах зохицуулалтын хүрээнд 12.2., 15.1.2., 17.1.5 дахь заалтын хүрээнд асуудлыг судалж дараах дүгнэлтэд хүрсэн байна.

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан гомдолд тавьсан шаардлагыг хангаагүй гэж үзэн иргэний зүгээс гаргасан гомдлыг буцаасан тохиолдлын тоо нийт гомдлын 3 гаруй хувийг, харин үндэслэлгүй гомдол гаргасан үндэслэлээр буцаасан гомдол 4,42 хувийг эзэлж байгаа нь хуулийн эдгээр заалтын зорилгод хүрэх байдалд нөлөөлөх хэмжээнд хүрэхгүй байна. Иймд тус хуулийн заалт хэрэгжих боломжтой гэж үзлээ.

Гомдлыг харьяаллын дагуу шилжүүлэх асуудлын хүрээнд ХЭҮКтХ-ийн 15.1.3., 15.1.4., 16.1.6 дахь заалтын хэрэгжилтийг судалж дараах дүгнэлтэд хүрлээ.

ХЭҮК нь төрийн эрх мэдлийн хуваарилалтын дагуу шүүх эрх мэдлийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлдэггүй. Иймд эрүүгийн болон иргэний эрх зүйн шинжтэй маргааныг харьяаллын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх тухай хуулийн энэ зохицуулалт зорилгодоо нийцсэн, практикт хэрэгжих боломжтой гэж үзэж байна. Харин энэ заалтын хүрээнд гомдлыг захиргааны хэргийн шүүхэд харьяаллын дагуу шилжүүлэх асуудлыг нэмж тусгах шаардлагатай байна.

Комиссын гишүүн өөрийн санаачлагаар, эсхүл аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүсэлтээр шалгалт хийх асуудлын хүрээнд ХЭҮКтХ-ийн 18.2. 16.1.7 дахь заалтын хэрэгжилтийг судлан дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

Хуулийн 18.2 дахь заалтын хүрээнд Комисс дангаар, эсхүл бусад байгууллагатай буюу мэргэжлийн хяналт, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, үйлдвэрчний эвлэл, төрийн бус байгууллага зэрэг байгууллагатай хамтран шалгалт хийж буй шалгалтын хувьд ямар нэг асуудал гардаггүй хэрэгжих боломжтой байна.

Харин хуулийн 16.1.7 дахь хэсэгт үндэслэн байгууллагын хүсэлт, захиалгаар шалгалт хийсэн тохиолдол одоогоор байхгүй байна. Өнөөгийн практикаас харахад аль нэг байгууллага өөр нэг байгууллагын үйл ажиллагаа хүний эрх зөрчиж байгааг шалгуулах тухай хүсэлтээ шууд гаргаагүй боловч байгууллага, иргэдийн зүгээс хүний эрхийн зөрчлийн талаар мэдээлэл өгөх тохиолдол гардаг. Эдгээр мэдээллийн мөрөөр Комиссоос тухайн байгууллагын үйлл ажиллагаанд шалгалт хийдэг байна.

Комиссоос шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргах асуудлын хүрээнд ХЭҮКтХ-ийн 17.1.1 дэх заалтын хэрэгжилтийг судлан дараах дүгнэлтэд хүрсэн байна. Үүнд:

ХЭҮК-оос гаргаж буй төлөөлөн нэхэмжлэлийг шүүхээр шийдвэрлэж хохирогчдын эрх ашгийг хамгаалах, хохирлыг тодорхой хэмжээнд барагдуулах талаар хэрэгжүүлсэн ажиллагаа өнгөрсөн хугацаанд амжилттай хэрэгжиж, шүүхийн практикт анх удаа шийдэгдсэн тохиолдол цөөнгүй байна. Энэ нь хүний эрхийг хангахад чухал үр дүнтэй ажил болж байна. Харин шүүхээс нэхэмжлэлийн үнийн дүнгийн маш бага хэсгийг хүлээн зөвшөөрдөг нь хохирогчийн зүгээс гарсан бодит зардлыг нөхөж чадахгүй байна. Энэ нь хохирлын хэмжээг тооцох аргачлал байхгүй, ялангуяа эрүүл мэнд, сэтгэл санаа, нэр хүнд, олох байсан орлоготой холбоотой хохирлын хэмжээг тооцохтой холбоотой хүндрэлээс үүдэлтэй гэж үзэж болох байна.

Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд 17.1.2., 17.1.3., 18.4., 19.1-19.6 дахь заалтын хэрэгжилтийг тус тус судалсны үндсэн дээр дараах дүгнэлтэд хүрсэн байна. Үүнд:

Манай улсын хувьд Комиссын гишүүний гаргасан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагын хэмжээг

нэмэгдүүлэх ажил хийгдэхгүй байна. Энэ нь шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байх гол хүчин зүйлийн нэг юм. Дэлхийн бусад орны хүний эрхийн үндэсний байгууллага, омбудсмены чиг үүрэг нь гомдол гаргагчийн эрхийг хамгаалахын тулд ялангуяа түүнд тохиолдсон бэрхшээлийн шалтгаан болж буй хууль тогтоомж, нийгмийн хэв журам, захиргааны практикийг өөрчлөх, засч залруулах шаардлага, зөвлөмжийг эрх бүхий байгууллагуудад хүргүүлэх, тухайн шаардлага, зөвлөмжийг хүлээж авсан этгээд биелүүлэх талаар арга хэмжээ авах үүрэг хүлээх явдал байдаг.

Гэтэл практикт Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн хариу хуулиар тогтоосон хугацаанд ирдэггүй. Комиссын ажилтан өөрөө шаардлага, зөвлөмж хүлээн авсан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтантай утсаар холбогдон, албан бичгээр хариу ирүүлэхийг шаардан ажилладаг. Шаардлага, зөвлөмжийн хариу ирүүлэх хуулиар тогтоосон хугацааг нарийвчлан тооцож үзэх асуудал тодорхой бус байгаа нь хүндрэл учруулдаг. Тухайлбал, аймаг, сумдад явуулсан шаардлага, зөвлөмжийг тухайн байгууллага, албан тушаалтан хүлээн авсан өдрөөс нь хугацааг тооцож эхлэх үү, эсвэл Комиссоос явуулсан шаардлага, зөвлөмж дээрх сар, өдрөөр хугацааг тооцох уу гэдэг асуудал тодорхойгүй байна.

ХЭҮК 2001- 2016 оны хооронд хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн гэж үзсэн албан тушаалтанд хариуцлага ногдуулах тухай нийт 229 хүсэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьсан бөгөөд эдгээр шаардлагын дагуу хэрэгжүүлж буй арга хэмжээний хэрэгжилт удаан, зарим тохиолдолд зөрчлийн хэмжээтэй харьцуулахад харьцангүй бага хариуцлага ногдуулдаг болон зөрчил шалгах ажиллагаа шударга явагдаж байгаа зэрэгт иргэд, олон нийт зүгээс өгөх үнэлгээ, итгэл зэргээс хамааран зохицуулалтын хэрэгжилт зохистой түвшинд хүрэхгүй, үр дүн сул байна. Энэ нь ялангуяа хууль сахиулах байгууллагын ажилтан, албан хаагчдын гаргасан зөрчлийг тухайн байгууллага өөрөө шалгаж байгаатай холбоотой үүсэж байна.

Комиссоос хүргүүлсэн шаардлагыг хүлээж авахгүй байх, шаардлагын хариуг ирүүлэхгүй байх, эсхүл үндэслэлгүй гэх шалтгаанаар буцаах асуудалд хариуцлага тооцох тогтолцоо, шийдвэрлэх арга, зохицуулалт байхгүй байна.

Комиссоос хүргүүлсэн шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх асуудал хүндрэлтэй байдаг. Тухайлбал, шаардлага хүргүүлсэн байгууллагуудаас ирүүлж буй мэдээлэлд хүний эрхийг зөрчсөн тодорхой үйлдлийг таслан зогсоосон гэхээс илүүтэй таслан зогсоохын тулд ямар нэг үйл ажиллагаа хийх, арга хэмжээ авах тухай төлөвлөж, хичээж байгаа тухай эсхүл тухайн зөрчил дотоод хяналт, шалгалтын хүрээнд тогтоогдоогүй тул арга хэмжээ авах боломжгүй тухай ирүүлсэн мэдээллийг хэрхэн үнэлэх нь үзэмжээр шийдэж болох нөхцөлийг үүсгэж, хүний эрхийн зөрчлийг даамжруулах боломжийг бүрдүүлж байна.

Комиссын эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хүрээнд ХЭҮКтХ-ийн 17.1.4 дэх заалтын хэрэгжилтийг судлан дараах дүгнэлтэд хүрсэн байна. Үүнд:

Комиссын тухай хуулийн 17.1.4 дэх хэсэгт талуудыг эвлэрүүлэх замаар гомдол шийдвэрлэх асуудлыг тусгасан. Гэвч энэ үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэх процессын талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй тул Комисс хүний эрхийн ямар зөрчлийг эвлэрүүлэх замаар шийдвэрлэх, эвлэрлийн үйл ажиллагаанд комиссын ажилтнууд ямар статустай оролцох (эвлэрүүлэн зуучлагч), ямар бүрэн эрх, чиг үүрэгтэй байх, уг ажиллагааг ямар арга хэлбэрээр явуулах нь тодорхойгүй байна. Үүнээс үзэхэд ХЭҮК-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх хэсэгт заасан эвлэрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрэн бүрэлдээгүй, эвлэрүүлэх үйл ажиллагааны үр дүн болох эвлэрлийн гэрээг хэрхэн үнэлэх, гэрээг зөрчсөн эсхүл гэрээнээс татгалзсан тохиолдолд ямар эрх зүйн үр дагавар үүсэх нь тодорхойгүй, 2012 онд батлагдсан Эвлэрүүлэн зуучлалын тухай хуультай хэрхэн уялдуулах талаар тодорхой арга хэмжээг аваагүй зэрэг асуудлууд өнөөг хүртэл байсаар байна. Иймд хуулийн энэ зохицуулалтын зорилгод хүрэх төвшин хангалтгүй, практикт хэрэгжих боломж бүрдээгүй байна.

САНАЛ

Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийг боловсронгуй болгох, хуулийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүднээс дараах арга хэмжээ авах боломжтой гэж үзэж байна. Үүнд:

- Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийг Парисын зарчимд нийцүүлэн шинэчлэн боловсруулах;
- ХЭҮК-ын гишүүнд нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах ажиллагааг Парисын зарчимд нийцүүлэн олон нийтийн оролцоотойгоор ил тод, нээлттэй зохион байгуулах;
- Гишүүнд нэр дэвшиж буй этгээдийн хүний эрхийн талаарх мэдлэг, туршлагын талаар бусад эрх бүхий байгууллагаас авч буй саналд тусгуулдаг байх;
- Жендэрийн тэгш байдлыг хангах тухай зохицуулалтыг хуульд нэмж тусгах;
- Комиссоос Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл бэлтгэх, олон улсын хүний эрхийн гэрээний биелэлт, энэ тухай Засгийн газрын илтгэлийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, бодит нөхцөл байдалд нийцсэн санал боловсруулахад шаардлагатай судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд хүрэлцэхүйц мэргэшсэн боловсон хүчин, төсөв санхүүгийн баталгаат байдлыг хангах талаар анхаарах;
- Комиссын илтгэлийг хэлэлцэх асуудлыг тодорхой болгох, тухайлбал УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг гаргадаг байх, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаар Комисст мэдэгддэг байх асуудлыг хуульчлах;
- Хүний эрхийн талаарх хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенцийг сурталчлах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах;
- Комиссын төсвийг УИХ-аас баталдаг байх;
- Комисст гаргасан гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гишүүнийг төлөөлөн ажиллаж буй тухайн чиг үүргийг хэрэгжүүлж буй Комиссын ажлын албаны мэргэжилтний мэдээлэл цуглуулах ажиллагааны явцад эдлэх эрхийг хууль тогтоомжоор баталгаажуулах, эрх зүйн хамгаалалтад авах асуудлыг шийдвэрлэх;
- Комиссоос хүргүүлж буй шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах үүднээс шаардлага, зөвлөмж хүлээж авсан байгууллагын хэрэгжүүлсэн арга хэмжээг үнэлэх аргачлал боловсруулах, мөн шаардлага, зөвлөмжийг биелүүлэхгүй удаашруулах, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох талаар шуурхай, тодорхой арга хэмжээ авахгүй байгаа нь илэрхий байгаа тохиолдолд хүлээлгэх хариуцлагын шатлал, төрлийг нэг мөр тодорхой болгох;
- Комисст ирүүлсэн иргэний болон эрүүгийн хэрэг маргаантай холбоотой гомдлыг харьяаллын дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлж буй зохицуулалтад захиргааны хэрэг маргааныг нэмж тусгах;

Комиссын эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааны эрх зүйн орчныг тодорхой болгох, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуультай уялдуулах зэрэг санал багтаж байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Хүний эрхийг хамгаалах тогтолцоо. ХЭҮК, UNDP Mongolia, Уб хот. 2002 он.

2. Хүний эрхийн конвенцуудын хорооноос батлан гаргасан ерөнхий санал, зөвлөмжүүдийн эмхэтгэл. Монгол Улсад хүний эрхийг хангах төсөл. Уб хот. 2004 он.

3. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл 2002 он. ХЭҮК. Уб хот.

4. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл 2003 он. ХЭҮК. Уб хот.

5. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл 2004 он. ХЭҮК. Уб хот.

6. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл 2005 он. ХЭҮК. Уб хот.

7. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл 2006 он. ХЭҮК. Уб хот.

8. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл 2007 он. ХЭҮК. Уб хот.

9. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл 2009 он. ХЭҮК. Уб хот.

10. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 11 дэх илтгэл. ХЭҮК. Уб хот. 2012 он.

11. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэл. ХЭҮК. Уб хот. 2014 он.

12. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэл. ХЭҮК. Уб хот. 2015 он.

13. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэл. ХЭҮК. Уб хот. 2016 он.

14. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл. ХЭҮК. Уб хот. 2017 он.

15. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын тайланд өгсөн зөвлөмжийн /UPR/ хэрэгжилтийн тайлан, ХЗҮХ, 2014 он.

16. Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь судалгааны тайлан. ХЗҮХ.Уб хот. 2016 он.

17. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт, хэлэлцүүлэг /UPR/-т Монгол Улсын төрийн бус байгууллагуудын Форумын үйл ажиллагааны хүрээнд бэлтгэсэн тайлан. Хүйсийн тэгш эрх төв, Хүний эрх хөгжил төв, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Үндсэн уртраг ТББ, 2014 он.

18. Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит илтгэлүүд, НҮБ-ын холбогдох хороодын хуралдааны тэмдэглэл, зөвлөмжүүдийн эмхэтгэл. ХЭҮК, UNDP Mongolia, Уб хот. 2004 он.

19. Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит илтгэлүүд, НҮБ-ын холбогдох хороодоос Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжийн эмхэтгэл /1977-2014/. ХЭҮК, UNDP Mongolia, Уб хот. 2014 он.

20. Хүний эрхийн үндэсний комисс Гурван жилд 2001-2003. Уб хот. 2004 он.

21. Хүний эрхийн үндэсний комисс Арван жилд 2001-2011. Уб хот. 2011 он.

22. Хүний эрхийн үндэсний бага хурал /эмхэтгэл/ 200 оны 12 сарын 9-10. Уб хот. 2000 он.

23. Хүний эрхийг хамгаалах тогтолцоо. ХЭҮК, UNDP Mongolia, Уб хот. 2002 он.

24. Эрүү шүүлтийн эсрэг олон улсын эрх зүйн эх сурвалж ба үндэсний илтгэлүүд, Нэгдсэн үндэстний байгууллагаас өгсөн зөвлөмжүүд. ХЭҮК, Asia Pacific forum /APF/,

Хүний эрхийн ндэсний хороо www.nhrc.gov.mn

Addociation for the prevention of torture /APT/. Уб хот. 2015 он.

25. Хүний эрхийн боловсрол. Хүний эрхийн үндэсний байгууллагуудын гарын авлага. Asia Pacific forum /APF/ 2013 он.

26. Эмэгтэйчүүдийн эрх ба жендэрийн тэгш байдал. Хүний эрхийн үндэсний байгууллагуудад зориулсан гарын авлага. ЕАБХАБ-ын Ардчилсан институт, ХЭҮК. Уб хот. 2013 он.

27. Хүний эрх. Улирал тутмын сэтгүүл 2005/01. ХЭҮК. Уб хот. 2005 он.

28. Хүний эрх. Улирал тутмын сэтгүүл 2005/2. ХЭҮК. Уб хот. 2005 он.

29. Хүний эрх. Улирал тутмын сэтгүүл 2005/3. ХЭҮК. Уб хот. 2005 он.

30. Хүний эрх. Улирал тутмын сэтгүүл 2005/4. ХЭҮК. Уб хот. 2005 он

31. Хүний эрх. Улирал тутмын сэтгүүл 2006/2. ХЭҮК. Уб хот. 2006 он.

32. Хүний эрх. Улирал тутмын сэтгүүл 2006/3. ХЭҮК. Уб хот. 2006 он.

33. Хүний эрх. Улирал тутмын сэтгүүл 2011/02. ХЭҮК. Уб хот. 2011 он

34. Хүний эрх. Улирал тутмын сэтгүүл 2012/02. ХЭҮК. Уб хот. 2012 он

35. Хүний эрх. Улирал тутмын сэтгүүл 2013/01. ХЭҮК. Уб хот. 2013 он

36. Хүний эрх. Улирал тутмын сэтгүүл 2013/2. ХЭҮК. Уб хот. 2013 он

37. Хүний эрх. Улирал тутмын сэтгүүл 2014/01. ХЭҮК. Уб хот. 2014 он

38. Хүний эрх. Улирал тутмын сэтгүүл 2016/01. ХЭҮК. Уб хот. 2016 он

39. Хүний эрх. Улирал тутмын сэтгүүл. 2006/4. ХЭҮК. Уб хот. 2006 он

---o0o---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ҮЙЛЧЛЭЛ
www.nli.gov.mn

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН /шинэчилсэн найруулга/ ЗАРИМ ЗААЛТАД ХИЙХ ЭДИЙН ЗАСГИЙН ҮР НӨЛӨӨНИЙ СУДАЛГАА[1]

УДИРТГАЛ

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулсан 2002 оны Эрүүгийн хуулийг дагаж мөрдсөнөөс хойш цаг үеийн нөхцөл байдал, нийгмийн харилцааны өөрчлөлтийг харгалзан уг хуульд 10 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд нь гэмт хэргийн хохирлын хэмжээг тогтоох болон гэмт хэрэгт тооцох нөхцөлийг тодорхой болгох, шинэ гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хуульчлах, Монгол Улс нэгдэн орсон, соёрхон баталсан олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх, түүнчлэн бусад хууль шинээр батлагдаж, бусад хуульд өөрчлөлт орсонтой холбоотойгоор хийгдэж иржээ.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аас 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр батлан 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн нийтээр дагаж мөрдөхөөр тогтсон билээ.

Гэвч Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд тус хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил бүрэн хангагдаагүй буюу гол нөхцөл болох дагалдах хуулиуд[2] ёсчлогдоогүй, холбогдох дүрэм, журам батлагдаагүй, хуулийн хэрэгжилтийг хангах алба хаагчид сургалтад бүрэн хамрагдаагүй, иргэд, олон нийтэд шинэ хуулийн үзэл баримтлал, агуулгыг сурталчлах, таниулах ажил хангалттай хийгдээгүй, тус хуульд заасан зарим ялын төрлийг хэрэгжүүлэх орчин, эдийн засаг, техникийн нөхцөл байдал шийдэгдээгүй зэрэг шалтгааны улмаас УИХ-аас 2016 оны 8 дугаар сарын 30-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай[3] хуулиар хэрэгжиж эхлэх хугацааг 2017 оны 7 дугаар сарын 1-нийг хүртэл хойшлуулаад байна.

Иймд ХЗҮХ-ээс “Хууль тогтоомжийн үр нөлөөний судалгаа” гүйцэтгэх ажлын хүрээнд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад тусгасан ялын зарим төрлийг хэрэгжүүлэхэд гарах зардлыг тоймлон тооцох буюу “хорих” болон “зорчих эрхийг хязгаарлах” ялын эдийн засгийн үр нөлөөг тооцох, түүн дотроо “хорих ял” болон “зорчих эрхийг хязгаарлах ял”-ын эдийн засгийн үр нөлөө, зардлыг урьдчилан тооцоолох шаардлага бий гэж үзсэний үндсэн дээр энэхүү судалгааг гүйцэтгэв.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилттэй холбоотой маргаан дагуулж буй асуудал бол “хорих” болон шинээр бий болсон “зорчих эрхийг хязгаарлах” ялыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нийгэм, эдийн засгийн нөхцөл бүрдсэн эсэхийг тодруулах явдал юм. Тухайлбал хорих ялын хугацааг тогтоохдоо “гэмт хэрэг үйлдсэн хүний эрх чөлөөг тодорхой хугацаагаар /7 хоногоос 20 жил хүртэл/,[4] эсхүл 7 хоногоос бүх насаар нь хязгаарлах тухай заажээ.[5] Мөн тус хуулийн 5.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хорих байгууллагыг нээлттэй, эсхүл хаалттай нөхцөлд, харуул хамгаалалтын 5 зэрэглэлтэй байхаар зохицуулсан байна.

Тус судалгааны зорилго нь дээр дурдсан 2 төрлийн ялыг хэрэгжүүлэхэд улсын хэмжээнд гарах зардлыг тоймлон тооцох, улмаар эдийн засгийн хувьд төр, төрийн байгууллага хэр ачаалал хүлээх, нийгэмд үзүүлэх үр нөлөө ямар байх талаар

[1] Энэхүү судалгааг Хууль зүйн судалгааны төвийн бодлогын судлаач Ж.Бариаширсүрэн, Б.Ундрах, Ж.Алтансүх нар хамтран гүйцэтгэв.

[2] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны хуулийн шинэчилсэн найруулга, Прокурорын байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулга.

[3] “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2016.09.06. №33/942/.

[4] Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 5.6 дугаар зүйл. 3 дахь хэсэг.

[5] Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 5.6 дугаар зүйл. 1 дэх хэсэг.

судлах явдал бөгөөд эдгээрийн эдийн засагт үзүүлэх үр нөлөөг тойм байдлаар тооцож гаргах давхар зорилготой.

“Эрүүгийн хуулийн /шинэчилсэн найруулга/ зарим зүйл заалтад хийх эдийн засгийн үр нөлөөний судалгаа”-г урьдчилан баталсан судалгааны ажлын удирдамжид тусгасан асуудлын хүрээнд баримт бичгийн судалгааны арга; задлан шинжлэх ба нэгтгэн дүгнэх арга; харьцуулалтын арга; хууль зүйн техник, хууль тайлбарлах аргуудыг тус тус хэрэглэн хараат бус бие даасан, шинжлэх ухааны арга зүйд тулгуурласан судалгааны дүгнэлтэд хүрсэн бөгөөд энэ дүгнэлт нь зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон үр дүнд үндэслэсэн болно.

Судалгааны багийн зөвлөхөөр Хууль зүйн судалгааны төвийн ЭНБД др.Х.Эрдэм-Ундрах ажиллаж судалгааны ажлын удирдамж, нарийвчилсан төлөвлөгөөг баталж, багийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, бодлогын судлаач Ж.Бариаширсүрэн ахалж, бодлогын судлаач Ж.Алтансүх, Б.Ундрах нар хамтран гүйцэтгэв.

Энэхүү судалгааг Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомж хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу гүйцэтгэв.

Судалгааны ажлын үр дүнд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 5.5 дахь зүйл “Зорчих эрхийг хязгаарлах ял” болон 5.6 дахь зүйл “Хорих ял”-ыг хэрэгжүүлэхэд шаардагдах барилга байгууламж, хүний нөөц, тоног төхөөрөмж болон бусад холбогдох зардлын тооцоог ерөнхий байдлаар тооцож, холбогдох дүгнэлт гарсан болно.

Судалгааны ажлын хэрэгцээнд зориулан холбогдох тоо баримт, мэдээ, мэдээллээр судалгааны багийг дэмжиж ажилласан ШШГЕГ-ын Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газар болон Тогтоол гүйцэтгэх газарт талархал илэрхийлье.

НЭГ. ХОРИХ АНГИ ШИНЭЭР БАРИХ ЗАРДЛЫН ТООЦОО

2002 оны Эрүүгийн хууль мөрдөгдөж эхэлснээс хойш жилд дунджаар 7000-8000 хүн хорих ялыг биечлэн эдэлж, цаашид хорих ангид ял эдэлж байгаа хүний тоо буурах шинжгүй байгаа талаар судалгаануудад дурдах болсон. Улсын Их Хурлаас 2000, 2006, 2009 онуудад Өршөөл үзүүлэх тухай хуулийг тус тус батлан гаргаж, нэг удаа дунджаар 2500 орчим хүн суллагдаж, хорих ангид ял эдлэгсдийн тоо 4000 орчим болж буурдаг ч жилийн дотор эргээд хорих ангийн дүүргэлт нэмэгддэг нь судалгаагаар тогтоогдсон. Хорих ял биечлэн эдлэгсдийн тоо өндөр байгаа нь хорих ангийн ачааллыг ихэсгэж, ялтанд зарцуулах зардлын хэмжээ жил бүр нэмэгдэж, улсын төсөвт ачаалал үүсгэж байна.[6]

Судалгаанаас үзэхэд 2012 оны байдлаар Монгол Улсад төвлөрсөн 25 хорих анги, баривчлах, цагдан хорих байр 26, баривчлах ял эдлүүлэх байр 13 байна.[7] Эдгээр төвлөрсөн хорих ангид жилд нийтдээ 6911 ялтан ял эдэлж байгаа ба эдгээр ялтнуудад төрөөс нэг хүнд 10650 төгрөгийн урсгал зардал /хоол, хувцас, байрлаж буй байрны гэрэл, цахилгаан гэх мэт../ буюу нийт 6911 ялтанд нэг өдөрт 73 602 150 төгрөг, жилд 26 864 784 750 төгрөг зарцуулдаг байсан талаар судалгаа гарч байжээ.[8] Энэ нь эдийн засгийн хувьд их хэмжээний зардал гарч байгаа буюу улсын

[6] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал.

[7] Б.Нямгомбо, Хорих болон хорихоос өөр төрлийн ялын үр нөлөө, чиг хандлага, http://criminology.mn/print.php?id=160&lang=1#_ftn5.

[8] Б.Нямгомбо, Хорих болон хорихоос өөр төрлийн ялын үр нөлөө, чиг хандлага, http://criminology.mn/print.php?id=160&lang=1#_ftn5.

төсөвт ихээхэн дарамт болж байгаа талаар судлаачид тэмдэглэжээ. Иймд дээр дурдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийг баталсан.

Уг хуулийн төслийн үзэл баримтлалын дагуу Эрүүгийн ял, албадлагын арга хэмжээг үр нөлөөтэй эдлүүлэх нөхцөл бололцоог хангах, хорих ялыг хувь хүний онцлогт тохируулан ялгамжтай эдлүүлэх, мөн хорих ял эдлэгсдийн тоог бууруулах, мөн хорих ял эдлүүлэх үйл ажиллагааны зардлыг бууруулахын тулд зорчих эрхийг хязгаарлах гэх шинэ төрлийн ялыг нэвтрүүлсэн. Мөн тус батлагдсан хуулийн дагуу хорих ялыг 7 хоногоос 20 жилийн хугацаагаар нээлттэй, эсхүл хаалттай хорих ангид эдлүүлэхээр тусгасан. Ийнхүү ялын интервал уртассантай холбогдуулан хорих ангийн ачааллыг нэмэгдүүлж болзошгүй байдал үүсгэж байна. Жишээ болгон шинэчлэн батлагдсан Эрүүгийн хуулийн ялын доод хэмжээг түүвэрлэж үзэхэд долоо хоногоос 5 жил хүртэлх хугацаагаар ял оногдуулахаар төлөвлөсөн 11 заалт байна.[9]

Энэ нь хорих ангийн ачааллыг нэмэгдүүлэх магадлалтай бөгөөд ШШГЕГ-ын тайланд дурдсанаар шинэчлэн батлагдсан Эрүүгийн хуулийг хэрэгжүүлэх буюу хорих ялыг нээлттэй, хаалттай хорих ангид эдлүүлэх, мөн нээлттэй, хаалттай хорих анги нь харуул хамгаалалтын “А”, “Б”, “В”, “Г”, “Д” зэрэглэлтэй байх шаардлагыг үндэслэн аймаг бүрт нээлттэй хорих анги байгуулах, хаалттай хорих ангийг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулах шаардлагатай гэсэн эдийн засгийн тооцоолол гаргажээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мэдээгээр 2016 оны 9 дүгээр сарын байдлаар улсын хэмжээнд сэжигтэн, яллагдагчаар цагдан хоригдож буй болон хорих ял эдлэж буй ялтаны тоо 5496 байгаа бөгөөд үүнээс баривчлах ял эдэлж буй 119, цагдан хорих байранд 1000 сэжигтэн, яллагдагч байна.[10]

Шинэчлэн батлагдсан Эрүүгийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.5, 5.6-д заасан ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэхдээ нээлттэй болон хаалттай хорих ангид ял эдлүүлэх талаар журамласан. ШШГЕГ-ын тайланд дурдсанаар “Улсын Их Хурлаас шинэчлэн баталсан Эрүүгийн хуулийн хэрэгжилтийг хангахын тулд аймаг бүрт нээлттэй хорих анги байгуулах шаардлагатай. Мөн хорих ангиудыг нээлттэй, хаалттай төгтолцоонд шилжүүлэхдээ шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаа, хэлтэсийг бүсчлэн, бүсийн дунд 1-2 хаалттай хорих анги байгуулах шаардлагатай”[11] гэсэн эдийн засгийн тооцоолол хийгдсэн байна. Энэхүү тайланд дурдсанаар нэг хорих ангид дунджаар **1 856 062 720** /нэг тэрбум найман зуун тавин зургаан сая жаран хоёр мянга долоон зуун хорин/ төгрөг шаардлагатай[12] гэжээ.

Түүнчлэн уг тайланд дурдсанаар Хэнтий аймгийн Бор-Өндөр сум, Өмнөговь аймгийн Ханбогд сум, Ховд аймгийн Булган суманд Шийдвэр гүйцэтгэх хэлтэс байгуулах шаардлагатай гэсэн ба дээрх аймгуудад Шийдвэр гүйцэтгэх хэлтэс байгуулахад дараах хөрөнгийн эх үүсвэр шаардлагатай гэж үзжээ.

- Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд шийдвэр гүйцэтгэх хэлтэс байгуулахад нийт 16 орон тоо, цалин, даатгалын зардалд 176,3 сая төгрөг;
- Өмнөговь аймгийн Ханбогд суманд шийдвэр гүйцэтгэх хэлтэс байгуулахад нийт 21 орон тоо, цалин, даатгалын зардалд 231,3 сая төгрөг;

[9] Шинэчлэн батлагдсан Эрүүгийн хуулийн 11.6, 11.7, 13.5, 16.7, 17.1, 17.5, 17.11, 20.15, 21.8, 24.6, 28.13 тус тус заалтуудад хорих ялыг 7 хоногоос 5 хүртэл жилийн хугацаагаар тогтоожээ.

[10] Тогтоол гүйцэтгэх газраас авсан статистик мэдээ. 2016.09.07

[11] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2017 оны урсгал төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний талаарх танилцуулга, 8.

[12] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны нэг хэв маягийн “Нэг цэгийн үйлчилгээ бүхий контор, нээлттэй хорих байрны барилга угсралтын ажлын төсөв”.

- Ховд аймгийн Булган суманд шийдвэр гүйцэтгэх хэлтэс байгуулахад нийт 21 орон тоо, цалин, даатгалын зардалд 231,3 сая төгрөг тус тус шаардлагатай талаар эдийн засгийн тооцоолол хийгджээ.

Мөн шинэчлэн батлагдсан Эрүүгийн хуулийн хэрэгжилтийг хангахын тулд Шийдвэр гүйцэтгэлийн тойргийн тоог шинээр тогтоох шаардлагын улмаас Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь ШШГА-д шийдвэр гүйцэтгэлийн 1 тойрог шинээр нэмж тогтоох; Налайх дүүрэг дэх Шийдвэр гүйцэтгэх хэсэгт 2 тойрог шинээр тогтоох; Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд 6 тойрог, 1 ахлах гүйцэтгэгчийн орон тоо шинээр тогтоох шаардлага, хэрэгцээ бий болж байна. Үүнд нийтдээ Шийдвэр гүйцэтгэлийн 10 орон тоо, цалингийн зардалд 110,2 сая төгрөг шаардлагатай гэж тооцоолжээ. Түүнчлэн Эрүүгийн хуульд заасан ял, албадлагын арга хэмжээний төрөл болох торгох ял, нийтэд тустай ажил хийлгэх ял, зорчих эрхийг хязгаарлах ял, эрх хасах ял, татан буулгах ял нэмэгдэж тусгагдсантай холбогдуулан уг ялын бодлогыг хэрэгжүүлэхэд тойргийн системээр явуулах бөгөөд нэмж нийт 173 орон тоо бий болгох, түүний цалин, даатгалын зардалд 1905,8 сая төгрөг шаардлагатай гэсэн.

Ингээд шинэчлэн батлагдсан Эрүүгийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.5, 5.6-д заасан ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэхдээ нээлттэй болон хаалттай хорих ангид ял эдлүүлнэ гэсний дагуу нийт 74796,7 сая төгрөгийн өртөг бүхий шинээр баригдах хорих ангиудын зардлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тайланд үндэслэн хүснэгтээр дор үзүүлье.

Хорих анги шинээр байгуулахдаа нэг жилд хорих ангид ял эдэлж буй хоригдлын дундаж тоог 7500-гаар төсөөлөн, хорих ангийн өрөө тасалгаа, орчин нөхцөлд тавигдах олон улсын жишиг, дотоодын хууль тогтоомжид заасан стандартад нийцүүлэн боловруулсан байна.

Хүснэгт №1. Нийт шинээр барих хорих ангийн төсвийн тооцоолол[13]

д	Аймаг, нийслэл	Сум, дүүрэг	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил /Шинэ хорих анги барих зардал/	Хүчин чадал	Хэм-жих нэгж	Обьек-тийн төрөл	Обьек-тийн ангилал	Хугацаа		Төсөвт өртөг /сая төгрөг/
								Эх-лэх он	Дуу-сах он	
1	**Баян-Өлгий**	**Өлгий**	Нэг цонхны үйлчилгээтэй нэгдсэн контор, нээлттэй хорих байр барих /Баян-Өлгий, Өлгий/	260	хүн	контор, хорих байр	шинэ	2017	2017	1,856.1
2	**Өвөрхангай**	**Арвайхээр**	Нэг цонхны үйлчилгээ бүхий контор, цагдан хорих байр барих /Өвөрхангай, Арвайхээр/	120	хүн	контор, цагдан хорих байр	шинэ	2017	2017	1,856.1
3	**Нийслэл**	**ШШГЕГ**	Цахим хяналтын төвийн барилга барих /УБ хот ШШГЕГ/	150	хүн	контор	шинэ	2017	2017	1,841.7

[13] Энэхүү зардалд хорих ангиудын тог, дулаан, цахилгаан гэх мэт урсгал зардлуудыг хамруулаагүй болно.

4	**Ховд**	**Ховд**	Дэлхийн жишигт нийцүүлсэн нэгдсэн хорих ангийн байр барих /Ховд/	670	хүн	хорих анги	шинэ	2017	2018	4,475.4
5	**Нийслэл**	**Сонгино-хайрхан**	Тусгай эмнэлэг / УБ, СХД, хорих 429-р анги/	25	хүн	Эмнэлэгийн байр	шинэ	2017	2017	425.0
6	**Хөвсгөл**	**Мөрөн**	Албан контор, нээлттэй хорих байр барих / Хөвсгөл, Мөрөн/	210	хүн	контор, цагдан хорих байр	шинэ	2017	2017	1,611.6
7	**Өмнөговь**	**Ханбогд**	Нэг цонхны үйлчилгээ бүхий албан контор, цагдан хорих байр барих / Өмнөговь, Ханбогд/	60-80	хүн	контор, цагдан хорих байр	шинэ	2017	2017	859.9
8	**Завхан**	**Тосонцэнгэл**	Нэг цонхны үйлчилгээ бүхий албан контор, цагдан хорих байр барих /Завхан, Тосонцэнгэл/	60-80	хүн	контор, цагдан хорих байр	шинэ	2017	2017	859.9
9	**Хэнтий**	**Бор-Өндөр**	Нэг цонхны үйлчилгээ бүхий албан контор, цагдан хорих байр барих /Хэнтий, Бор-Өндөр/	60-80	хүн	контор, цагдан хорих байр	шинэ	2017	2017	859.9
10	**Төв**	**Зуунмод**	Нэг цонхны үйлчилгээ бүхий албан контор, цагдан хорих байр барих /Төв, Зуунмод/	60-80	хүн	контор, цагдан хорих байр	шинэ	2017	2017	859.9
11	**Өвөрхангай**	**Хархорин**	Албан контор, хаалттай хорих байр, бүс тусгаалах хашаа барих / Өвөрхангай, Хар хорин/	660	хүн	контор, цагдан хорих байр	шинэ	2017	2018	4,421.5
13	**Нийслэл**	**Нийслэл**	Насанд хүрээгүй-чүүдийн хорих байр /Албан контор, ялтны байр, сургууль, спорт заал, соёлын төв/ / УБ хот Хорих 411 анги /	160	хүн	контор, хорих байр, сургууль	шинэ	2018	2019	2,676.9
14	**Нийслэл**	**Сонгино-хайрхан**	Сүрьеэгийн эмнэлэг /УБ, СХД, хорих 429-р анги/	150	хүн	Эмнэлэгийн байр	шинэ	2018	2018	1,183.3
15	**Төв**	**Лүн**	Албан контор, нээлттэй ялтны байр, тусгаарлах хашаа /Төв, Лүн-Авдрант/	260	хүн	контор, цагдан хорих байр	шинэ	2018	2018	1,886.1

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nii.gov.mn

16	**Өмнөговь**	**Даланзадгад**	Нэг цонхны үйлчилгээ бүхий албан контор, цагдан хорих байр	60-80	хүн	контор, цагдан хорих байр	шинэ	2018	2018	1,611.6
17	**Нийслэл**	**Баянгол**	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв/Албан контор, сургалтын төв, үйлдвэрлэл, дадлагын байр / УБ, БЗД/	80	хүн	контор, цагдан хорих байр	шинэ	2018	2019	1,844.7
18	**Сэлэнгэ**	**Мандал**	Нэг цэгийн үйлчилгээ бүхий албан контор, хаалттай хорих байр барих / Сэлэнгэ/	70	хүн	контор, цагдан хорих байр	шинэ	2018	2019	1,430.1
19	**Нийслэл**	**Баянзүрх**	Албан контор, хаалттай хорих байр, тусгаарлах хашаа барих /УБ хот, Баянзүрх дүүрэг Хорих 407 анги/	150	хүн	контор, цагдан хорих байр	шинэ	2019	2019	1,712.7
20	**Сүхбаатар**	**Баруун-Урт**	Ялтны нээлттэй хорих байр барих / Сүхбаатар, Баруун-Урт/	45	хүн	нээлттэй хорих байр	шинэ	2019	2019	975.1
21	**Хэнтий**	**Чингис хаан**	Дэлхийн жишигт нийцүүлсэн нэгдсэн хорих ангийн байр барих /Хэнтий, Чингис хаан хот/	450	хүн	хорих анги	шинэ	2018	2019	4,475.4
1	**Нийслэл**	**Баянзүрх**	Дэлхийн жишигт нийцүүлсэн нэгдсэн хорих анги байгуулах - 1500 хүний багтаамжтай / УБ, БЗД 11-р хороо/	1500	хүн	хорих анги	шинэ	2013	2019	37,074.1
Нийт шаардлагатай хөрөнгө оруулалт								**74,796.7**		

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ ХҮРЭЭЛЭН www.mn.gov.mn

ХОЁР. ХҮНИЙ НӨӨЦИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгад “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны алба хаагчид үндсэн цалингаас гадна, яллагдагч, шүүгдэгч, хоригдолтой ажилласны, төрийн алба хаасан хугацааны, онцгой нөхцөлийн болон **тусгай албаны**, цолны, **мэргэшлийн зэргийн нэмэгдэл** олгох ба нэмэгдлийн хэмжээг Засгийн газар тогтооно” гэж заасан. Мөн хуулийн 111.5 дахь хэсэгт “Хорих байгууллагын алба хаагч харуул хамгаалалт, жижүүрийн үүргийг 18, 6 цагаар дөрвөн ээлжээр гүйцэтгэнэ” зэрэг хүний нөөцтэй холбоотой гарах зардалд шууд нөлөөлөх зохицуулалтууд байна. Үүнээс гадна алба хаагчдад үзүүлэх нэг удаагийн буцалтгүй тусламж, дүрэмт хувцас, хоол, унааны зардал, тусгай хэрэгсэл зэрэг бусад нийгэм, эдийн засгийн болон аюулгүй байдлын баталгааг хангахад чиглэсэн дүрэм, журам цөөнгүй байна.

Хүний нөөцийн зардлыг тооцохдоо нэг аймагт байрлах ШГА-нд хоригдож буй сэжигтэн, яллагдагч, ялтны дундаж тоог 30-50 байгааг харгалзан шинээр бий болгох хорих ангийг 100-аас доош хүний багтаамжтай хорих анги гэж үзэн тэнд ажиллах алба хаагчдын орон тоо болон бусад хүний нөөцтэй холбоотой гарах зардлыг төсөөлөл хэлбэрээр боловсруулав.

ШШГЕГ-аас гаргасан судалгаагаар Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжсэнээр улсын хэмжээнд нийт 1443 орон тоо шинээр бий болгох хэрэгцээтэйг тогтоожээ.

Хүснэгт №2 Нэмэх шаардлагатай орон тоо

№	Үйл ажиллагаа явуулах чиглэл	Шинээр бий болох орон тоо
	Тогтоол гүйцэтгэх чиглэлээр	612
	Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ хэрэгжүүлэх чирлэлээр	173
	Аюулгүй байдал тусгай ажиллагааны чиглэлээр	401
	Шийдвэр гүйцэтгэх чиглэлээр	78
	Санхүүгийн чиглэлээр	158
	Нийт	**1443**

Дээрхээс харахад ШШГЕГ-ын бүтэц, зохион байгуулалт, санхүүжилтэд үлэмж хэмжээний өөрчлөлт орохоор харагдаж байна. ШШГЕГ-т шинээр нэмж авах 1443 алба хаагч нь “Төрийн тусгай албан тушаалын цалингийн сүлжээ”-нд тусгасан албан тушаалын ТТ7-ТТ18 зэрэглэлээр цалинжиж, дүрэм журамд заасан нэмэгдэл, урамшуулал авах, нийгмийн баталгаагаа хангуулах эрх үүсэх юм.

Өнөөгийн байдлаар ШШГЕГ-ын харьяа хорих анги байгууллагуудад хоригдож буй сэжигтэн, яллагдагч, ялтны дундаж тоо жилд 7500 орчим ба үүнийг нийт хүн өдрөөр нь авч үзвэл 2 675 450 өдөр байдаг.

Хүснэгт №3 Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хорих газар

№	Хорих анги	Сэжигтэн, ялтны тоо	№	Хорих анги	Сэжигтэн, ялтны тоо
	хорих 401 анги	170		Дорнод	40
	хорих 403 анги	150		Дундговь	35
	хорих 405 анги	104		Завхан	30
	хорих 407 анги	280		Зүүнхараа	300

Үүнь зөвхөн дээрх хэрэглэгчийн хэрэглэх зориулалттай www.nii.gov.mn

	хорих 409 анги	350		Хархорин	432
	хорих 411 анги	34		Ховд	200
	хорих 415 анги	450		Хэнтий	392
	хорих 417 анги	173		Хөвсгөл	121
	хорих 421 анги	250		Өвөрхангай	30
	хорих 427 анги	400		Өмнөговь	30
	хорих 429 анги	134		Орхон	150
	баривчлах 431 анги	94		Сүхбаатар	35
	хорих 433 анги	400		Сэлэнгэ	30
	хорих 435 анги	300		Төв	43
	хорих 439 анги	300		Увс	39
	хорих 441 анги	11		Тосонцэнгэл	10
	ЦХ 461 анги	800		Налайх	10
	Архангай	50		Хөтөл	10
	Баян-Өлгий	35		Багануур	20
	Баянхонгор	39		баривчлах	100
	Булган	35		ДӨ анги	71
	Говь-Алтай	17		МСҮТ	60
	Говьсүмбэр	250		СМДӨАЭАХХГ	98
	Дархан-Уул	250		Хэрэмт цамхаг УТҮГ	44
	Дорноговь	35		ОСБХ	56
				ТГГ	5
				НИЙТ	**7500**

Дээрх хүснэгтээс харахад хөдөө орон нутагт байрлах хорих ангийн ачаалал бага, дунджаар 30-50 сэжигтэн, яллагдагч, ялтантай байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Гэсэн хэдий ч шинэ хуулиудын хэрэгжилтийг хангахын тулд аймаг тус бүрд нэг бие даасан хорих анги байгуулах зайлшгүй шаардлагатай байгаа тухай ШШГЕГ-аас гаргасан судалгаанд дурдсан бөгөөд үүнийг богино хугацаатай ялын төрөл, тоо хэмжээ өссөн, нээлттэй, хаалттай системд шилжих болон бусад хүчин зүйлтэй холбон тайлбарлаж болох юм. Тухайлбал хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 117 дугаар зүйлийн 117.1 дэх хэсэгт “Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 10 хоногийн дотор аймаг, нийслэл дэх жирийн дэглэмтэй хорих ангид ял эдлэх ялтныг шууд, ... хүргэнэ.” гэж заасан бөгөөд энэ нь 7 хоногийн хорих ялаар шийтгэгдсэн этгээдийн хувьд хүндрэлтэй, хүний эрх зөрчигдөх магадлалтай асуудал болж байна.

Өргөн уудам нутагт хүн ам нь сийрэг суурьшдаг онцлогтой манай орны хувьд хүн амын нягтаршил, хамрах тойргийн хэмжээнээс хамааран харилцан адилгүй бүтэцтэй хорих ангиудыг аймаг бүрт байгуулах хэрэгцээ байх боломжтой юм. Иймд ШШГЕГ-аас дараах байршилд хорих анги байгуулах хэрэгцээ байгааг тодорхойлжээ. Үүнд:

хуулийн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn



Иймд жишээ болгон Говь-Алтай аймаг дахь ШГА-д буюу харуул хамгаалалтын “А”, “Б” зэрэглэлийн нээлттэй хорих ангид ажиллах хүний нөөцийг авч үзье.

Хүснэгт №4 Нэг хорих ангийн хүний нөөц

№	Албан тушаал	Орон тоо
1	Дотоод ажлын хэлтсийн дарга	1
2	Цагдан хорих байрны дарга	1
3	Төлөөлөгч	2
4	Нийгмийн ажилтан	1
5	Сэтгэлзүйч	1
6	Ерөнхий жижүүр	4
7	Ээлжийн дарга	4
8	Хянагч	20
9	Их эмч	1
10	Холбоочин	4
11	Телекамерийн операторчин	4
12	Сувилагч	4
13	Хүний тоо бүртгэлийн байцаагч	1
14	Тоо бүртгэлийн туслах	1
	Нийт	**49**

Дээрх хүснэгтээс харахад энэ хорих ангид зөвхөн хорих ял эдлүүлэхэд шаардлагатай харуул хамгаалалт, үйлчилгээтэй холбоотой 49 алба хаагчийн хэрэгцээ байгааг харуулж байна. Тус хүний нөөцийн тооцоонд үйлчилгээний алба хаагчдыг оруулаагүй болно.

www.nlrc.gov.mn

Үүнээс гадна тус аймагт байрлах ШГА нь хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ хэрэгжүүлэх, аюулгүй байдал тусгай ажиллагааны, шийдвэр гүйцэтгэх чиглэлээр тус тус үйл ажиллагаа явуулах ба эдгээр үйл ажиллагаанд дараах хүний нөөцийн хэрэгцээ байна. Үүнд:

Хүснэгт №5 Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ хэрэгжүүлэх, аюулгүй байдал тусгай ажиллагааны, шийдвэр гүйцэтгэх чиглэлээр тус тус үйл ажиллагаа явуулахад шаардагдах хүний нөөц

№	Албан тушаал	Орон тоо
Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ хэрэгжүүлэх чиглэлээр		
2	Тасгийн дарга бөгөөд ахлах тогтоол гүйцэтгэгч	1
3	Тогтоол гүйцэтгэгч	2
4	Инженер, техникийн ажилтан	1
Аюулгүй байдал тусгай ажиллагааны чиглэлээр		
7	Аюулгүй байдлын ахлах мэргэжилтэн	1
8	Аюулгүй байдлын ажилтан	1
9	Шуурхай бүлгийн офицер	2
10	Шуурхай бүлгийн ажлтан	3
Шийдвэр гүйцэтгэх чиглэлээр		
13	Бүртгэл, хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн	1
14	Жолооч	1
Санхүүгийн чиглэлээр		
	Тооцооны нягтлан бодогч	1
	Нийт	**14**

Өмнөх мэдээллээс харахад аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дундаж хүний нөөцийн хэрэгцээ 63 байх төлөвтэй байна.

Алба хаагчид төрөөс олгох цалин ба түүнтэй төсөөтэй зардал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллаж буй алба хаагчдын 2015 оны цалингийн дундаж хэмжээнд түшиглэн төрийн зүгээс нэг алба хаагчид зориулан гаргах зардлын хэмжээг дараах байдлаар тоймлон гаргав.

Цалингийн дундаж хэмжээг тогтоохдоо цалин урамшуулал, нэмэгдэл зэргийг хувь хэмжээг дундажлан гаргасан тул доорх хүснэгтэд тусгасан сарын дундаж цалингийн хэмжээнээс албан тушаалын зэрэглэл, цол, ажилласан жил зэргээс хамааран өөр өөр дүн гарах нь дамжиггүй юм.

Энэ тооцоололд тоо хэмжээг нь тодорхойлох боломжгүй нэг удаагийн тусламж, нэмэлт, дүрэмт хувцасны хангамж, тэтгэмж болон алба хаагчийн хоол, унааны зардал, томилолтын зардал зэрэг бусад зардлыг оруулаагүй тул эдгээр зардлыг нэг алба хаагчийн дундаж цалин болох **1 750 628** /нэг сая долоон зуун тавин мянга зургаан зуун хорин найм/ төгрөг дээр нэмж бодох шаардлагатай.

хүний нөөцийн хүрээлэл www.khr.gov.mn

Хүснэгт №6. алба хаагчийн цалингийн дундаж

№	Зардлын төрөл /дунджаар/	Хэмжээ /Дундаж/	Давтамж /сараар/	Нийт	Тохиолд-лын тоо /хүн/	Нийт
	Үндсэн цалин[15]	917800	12	11013600	49	539666400
	НДШ 20%	183560	12	2202720	49	107933280
	ЭМДШ 2%	18356	12	220272	49	10793328
	Алба хаасан хуга-цааны нэмэгдэл	133081	12	1596972	49	78251628
	Хоригдолтой ажил-ласны нэмэгдэл	71588	12	859056	49	42093744
	Гүйцэтгэх ажилтанд гүйцэтгэх ажил эрхэлсэн хугацаанд олгох тусгай албаны нэмэгдэл	100958	12	1211496	49	59363304
	Албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл	137670	12	1652040	49	80949960
	Цолны нэмэгдэл	160615	12	1927380	49	94441620
	Гэнэтийн ослын даатгал	27000	1	27000	49	1323000
	Нийт	**1750628**		**20710536**		**1014816264**

Хорих ангид сэжигтэн, яллагдагч, ялтныг байрлуулахад зайлшгүй шаардлагатай харуул хамгаалалт, үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагаанд 49 алба хаагчийн хэрэгцээ байгааг дээр дурдсан бөгөөд эдгээр алба хаагчдын нэг жилийн цалин хөлсөнд **1 014 816 264** /нэг тэрбум арван дөрвөн сая найман зуун арван зургаан мянга хоёр зуун жаран дөрвөн/ төгрөг зарцуулах тооцоо гарч байна.

Ийнхүү төрийн зүгээс шүүхийн тогтоол биелүүлэх чиглэлээр хорих ангид ажиллах хүний нөөцийн зардлын нэг алба хаагчид оногдох хувь хэмжээг тогтоосноор Эрүүгийн хуулийн холбогдох заалтууд хэрэгжиж эхлэхтэй зэрэгцэн улсын хэмжээнд шийдвэр гүйцэтгэх байгууллагад шаардлагатай байгаа 1443 алба хаагчийн цалингийн зардлыг ойролцоогоор тооцож болох юм.

Алба хаагчдын ажлын цаг

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2013 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн А/84 тушаалын хавсралтаар батлсан “Хөдөлмөрийн дотоод журам”-д албан хаагчдын ажлын цагийн тухай тусгасан байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуульд[14] заасан ажлын цагтай адил буюу 7 хоногийн 40 цаг, 1 өдрийн 8 цаг байх ба ажлын дараалсан 2 өдрийн хоорондох тасралтгүй амралтын хугацаа 12 цаг байхаар зохицуулжээ. Энэ заалт нь хүчлэн хамгаалах болон өндөржүүлсэн бэлэн байдлын үед хамаардаггүй. Амралтын өдрүүд /бямба, ням гараг/ болон бүх нийтээр амрахаар заасан амралтын өдрүүдэд ажиллахгүй.

ХЗДХ-ийн сайд, НХХ-ийн сайдын 2008 оны 205/94 дүгээр хамтарсан тушаалаар батлсан “ШШГЕГ-ын алба хаагчдын ажлын ачааллын жишиг норматив” –ын хүрээнд нэг алба хаагчид ногдох сэжигтэн, яллагдагч, ялтны тоо, зайлшгүй

[14] Хөдөлмөрийн хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.2 дах заалт. Эх сурвалж: http://www.legalinfo.mn/law/details/565?lawid=565

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.legal.gov.mn

байх шаардлагатай албан тушаалыг заасан байх боловч бодит нөхцөлд хүний нөөцийн хомсдол үүсч алба хаагчдын ажлын ачаалал хэт өндөр, зарим орон тоонд хүн ажиллахгүй байх зэрэг олон шалтгааны улмаас илүү цагаар ажиллах, норм хэтрүүлэх нь энгийн үзэгдэл болсон байна.

Иймд энэ судалгааны хүрээнд хуулийн төслийн эдийн засгийн үр нөлөөг тооцох аргачлалын дагуу “хүн/цаг” хэмжигдэхүүнээр хүний нөөцийн хэрэгцээ шаардлагыг тогтоохоос зайлсхийлээ.

Төрийн зүгээс нэг хоригдолд гаргах зардал

Шүүхээс хорих ялаар шийтгүүлж хүчин төгөлдөр тогтоолын дагуу хорих ангид ял эдэлж буй нэг хоригдолд гарах зардал нь шууд болон шууд бус гэсэн хоёр хэлбэрээр илэрдэг.

Шууд зардал /хүснэгтийн 14,15,16 дахь мөр/ нь хорих ангид ял эдэлж буй хоригдлын тооны өсөлт, бууралттай шууд хамааралтайгаар өсч, буурч байдаг бол шууд бус зардал нь үүнээс хамааралгүй тогтмол шинжтэй байдаг.

Хүснэгт №7. Нэг хоригдолд гаргах зардал

№	Зардлын зүйл	Хэрэгцээ		Улсын төсвөөс олгож буй санхүүжилт
		Нэг хоригдолд ногдох /төгрөгөөр/		Нэг хоригдолд ногдох /төгрөгөөр/
		Хоногт	Жилд	Жилд
	Цалин, хөлс, нэмэгдэл	11517	4203797	3311452
	ЭМД, НДШ	108	39422	21575,3
	Бичиг хэрэг	25	9067	6045
	Гэрэл цахилгаан	501	183034	152528,1
	Түлш халаалт	500	182417	165833,8
	Тээвэр, шатахуун	411	149853	115271,9
	Шуудан холбоо	49	18040	11275,1
	Цэвэр, бохир ус	80	29366	22588,9
	Дотоод албан томилолт	44	15964	12279,8
	Гадаад томилолт	11	4083	2551,6
	Ном, хэвлэл авах	8	2816	1564,4
	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага	100	36645	15932,6
	Тавилга, БҮТЭЗ	92	33682	28068
	Нормын хувцас, зөөлөн эдлэл	970	353983	141593,1
	Хоол	3749	1368437	977454,7
	Эм	380	138791	92527,3
	Урсгал засвар	414	150932	100621,2
	Нэг удаагийн тэтгэмж	74	27003	19287,7
	Газрын төлбөр	34	12371	8247,3
	Бараа үйлчилгээний бусад зардал	347	126785	84523,1
	Харуул хамгаалалтын зардал	78	28478	18985,4
	Дүн	**19 493**	**7 114 964**	**5 310 206**

Хүснэгт дэх мэдээллээс харахад нэг хоригдолд гаргах зардал өдөрт **19 493** /арван есөн мянга дөрвөн зуун ерэн гурван/ төгрөг, жилд **7 114 964** /долоон сая нэг зуун арван дөрвөн мянга есөн зуун жаран дөрвөн/ төгрөг байна**.**

Хорих ял эдлүүлэх зардал нь улсын төсвөөс санхүүждэг бөгөөд нэг хоригдолд оногдох зардлын 70 гаруй хувийг улсын төсвөөс санхүүжүүлж үлдсэн хэсгийг хорих ангийн үйл ажиллагаанаас буюу хорих ял эдэлж буй ялтнуудаар гүйцэтгүүлсэн ажлын орлогоос нөхөн санхүүлжүүлдэг.

Хүний эрхийн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

Улсын хэмжээнд жилд дунджаар 7500 ялтан хорих ял эдэлдэг гэж үзвэл нэг жилд **53 362 230 000** /тавин гурван тэрбум гурван зуун жаран хоёр сая хоёр зуун гучин мянган/ төгрөгийг хорих ялыг хэрэгжүүлэхэд зарцуулдаг бөгөөд үүнээс **39 826 545 000** /гучин есөн тэрбум найман зуун хорин зургаан сая таван зуун дөчин таван мянган/ төгрөг буюу 40 орчим тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлдэг байна.

ГУРАВ. ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад заасан ял, албадлагын арга хэмжээний төрөлд торгох ял, нийтэд тустай ажил хийлгэх ял, **зорчих эрхийг хязгаарлах ял**, эрх хасах ял, татан буулгах ял нэмэгдэж тусгагдсан.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын **тусгай ангийн 21 бүлгийн 437 заалтаас 170 заалтад** зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулах боломжтой байхаар тусгасан байна.[15] ШШГЕГ-аас гүйцэтгэсэн судалгаанд зорчих эрхийг хязгаарлах заалтыг одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн тусгай ангитай харьцуулж үзжээ. Ингэхэд нийт 170 заалтад заасан 60 баривчлах, 48 хорих болон 62 баривчлах, хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах буюу хорих ялыг сонгож хэрэглэхээр өөрчлөн тусгасан байна.[16]

Улсын Дээд шүүхээс гаргасан статистик мэдээнд улсын хэмжээнд анх удаа хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдэж баривчлах ялаар 499, 1-5 жилийн хугацаатай хорих ялаар 970 этгээд ял шийтгүүлсэн байна.[17] Үүнд үндэслэн нэг жилд дунджаар **1500** орчим этгээдэд “Зорчих эрхийг хязгаарлах ял”-ыг оногдуулах боломжтой гэж ШШГЕГ-аас тооцоолсон байна.[18]

Тус байгууллагаас боловсруулсан “Цахим хяналт, удирдлагын төв систем байгуулах” төсөлд тусгасан тоо баримт, мэдээллийг зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нэг удаагийн хөрөнгө оруулалтын зардал, урсгал зардал, хүний нөөцийн тооцоо зэрэг зардлыг тооцоход ашигласан болно.

Хүний нөөцийн зардал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бүтцэд Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх газар байгуулахаар заасан. ШШГЕГ нь ялын бодлогыг тойргийн системээр хэрэгжүүлдэг учраас зорчих эрхийг хязгаарлах ял болон албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх хүний нөөцийг нэгдсэн байдлаар тооцдог байна. Иймд тус байгууллагаас хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд нэмэх шаардлагатай нэгдсэн байдлаар тооцоолсон орон тоог дор авч үзлээ.

[15] Электрон гав бүхий цахим хяналтын систем байгуулах ажлын танилцуулга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, 2016.

[16] Мөн тэнд.

[17] Мөн тэнд.

[18] Мөн тэнд.

Хүснэгт №8. Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ хэрэгжүүлэх чиглэлээр шинээр нэмэгдэх орон тоо

Одоо ажиллаж байгаа	Нэмэх шаардлагатай	Нийт
Улсын хэмжээнд хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх чиглэлээр **34** хүн ажиллаж байна.	Зорчих эрхийг хязгаарлах ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийт **173** хүн нэмэх шаардлагатай. Үүнд: - Цахим хяналтын төв – 14 - Ахлах тогтоол гүйцэтгэгч – 32 - Тогтоол гүйцэтгэгч – 80 - Инженер, техникийн ажилтан – 38 - Харуул хамгаалалтын ажилтан - 7	207 алба хаагч

Зорчих эрхийг хязгаарлах ялыг тойргийн системээр хэрэгжүүлэх бөгөөд нийт 173 орон тооны цалин, даатгалын зардалд 1905,8 сая төгрөг орчим шаардлагатай.[19] Энэхүү тооцоог гаргахдаа шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэх алба хаагчийн нэг сарын цалингийн дундаж хэмжээг 918 000 төгрөгөөр тооцоолж, шинээр бий болох 173 орон тоогоор үржүүлсэн бөгөөд үүнийг улсын төсвөөс жилийн түвшинд гарах зардлаар тооцоолсон болно.

Шинэ төрлийн ялыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын буюу материаллаг зардал

Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор дараах 3 үе шат бүхий үйл ажиллагааг гүйцэтгэхээр байна.[20] Үүнд:

1. Цахим хяналт, удирдлагын төв, салбар төвийн барилга барих, дэд бүтцийг сайжруулах;

2. Програм хангамж, шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах, суурилуулах, мэдээллийн технологийг боловсронгуй болгох;

3. ШШГЕГ-ын ажилтнуудыг програм хангамж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг ажиллуулах, засвар үйлчилгээ хийхэд суралцах, дадлагажуулах сургалтад хамруулах хамаарна.

Цахим хяналт тавих үндсэн хяналтын төвийг Улаанбаатар хотод, дэд төвийг НШГА, Дархан, Эрдэнэт хотод барихаар тооцоолсон.



Зураг 1. Технологийн схем[21]

19 Мөн тэнд.

20 Мөн тэнд.

21 Электрон гав бүхий цахим хяналтын систем байгуулах ажлын танилцуулга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, 2016.

Удирдлагын төв, дэд төв: Цахим хяналт, удирдлагын төвийн барилгыг "...4-5 давхар /400 мкв-аас багагүй/ нөөц цахилгаан тэжээлийн найдвартай эх үүсвэртэй, галын болон агааржуулалт, хяналтын системтэй, 30-50 ажилтан ажиллах орчин нөхцөл бүрдсэн, олон улсын шаардлага хангасан техникийн өрөөтэй, төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон..." байхаар "Цахим хяналт, удирдлагын төв систем байгуулах" төсөлд тооцоолсон байна.[22] Дэд төвийн барилгыг "...2 давхар /100 мкв-аас багагүй/ нөөц цахилгаан тэжээлийн найдвартай эх үүсвэртэй, галын болон агааржуулалт, хяналтын системтэй 10-20 ажилтан ажиллах орчин нөхцөл бүрдсэн, олон улсын шаардлага хангасан техникийн өрөөтэй, төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон..." байхаар тооцоог гаргасан.[23]

Шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслүүд[24]

- Шилэн кабелиар холбох
- Сервер
- Нөөц хадгалах систем
- Компьютер
- Програм хангамж /албан ёсны эрхтэй/
- Сүлжээний хамгаалалтын төхөөрөмж
- Сүлжээний төхөөрөмж
- Тог тогтворжуулагч, баригч
- Бусад шаардлагатай тоног төхөөрөмж

Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх үндсэн хэрэгсэл болох электрон гавын үнийг хэд хэдэн боломжит хувилбараар судалсан бөгөөд ШШГЕГ-аас хийсэн судалгааны хүрээнд дараах харьцуулалтыг гаргасан байна.

Хүснэгт №9. Электрон гавны харьцуулсан үнэ[25]

Д/д	Судалсан улс орон	Хэрэгжүүлэх боломжтой эсэх	Нэг ширхэг электрон гавны үнэ /ам.доллар/	Тайлбар
1	АНУ, Израйль, Франц	Боломжгүй	2500-6000	Програм хангамж болон серверийг тухайн орон худалдахгүй бөгөөд хяналт, засвар үйлчилгээг тус улс хэрэгжүүлнэ. Үнэ өндөр
2	БНХАУ	Боломжгүй	300-500	Үнэ хямд боловч техникийн шаардлага хангахгүй.
3	ОХУ	Боломжтой	1800	Програм хангамжийг серверийн хамт худалдаалдаг. Шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг нийлүүлэх боломжтой.
4	БНСУ	Боломжтой	1800	

Мөн электрон гавыг хянах, түүний ашиглалтад шаардлагатай систем, техник хэрэгслийн судалгааг гүйцэтгэж дараах үнийн саналыг гаргасан байна. Үүнд:

[22] "Цахим хяналт, удирдлагын төв систем байгуулах" төсөл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, 2016.

[23] "Цахим хяналт, удирдлагын төв систем байгуулах" төсөл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, 2016.

[24] Мөн тэнд.

[25] Мөн тэнд.

ХУУЛЬ ЗҮЙН ИНДЭКСНИЙ ХҮРЭЭЛЭН www.legalinfo.mn

№	Тоног төхөөрөмж	НИЙТ /ам.доллар/
1	Электрон гав, сервер, сүлжээний тоног төхөөрөмж, техник хэрэгсэл	3,637,151
2	Цахим хяналтын програм хангамжийн систем	3,869,519
3	“Хяналтын төв”-ийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл	449,250
4	“Нэгдсэн хяналтын төв”-ийн барилга	438,180
5	Төслийн менежмент, Сургалт	995,700
6	Магадлашгүй ажил	110,200
	НИЙТ	9,500,000

Урьдчилсан зардлын тооцоо /1500 ширхэг электрон гав/

Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэхэд нэн түрүүнд шаардлагатай хөрөнгө оруулалтын зардал **23,4 тэрбум төгрөг** болох төлөвтэй байгаа бөгөөд үүнд тус ялыг хэрэгжүүлэх тогтолцоог бий болгоход шаардлагатай барилга байгууламж, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтад 21,2 тэрбум төгрөг орчим, бусад урьдчилан тооцоолох боломжгүй нэмэгдэл зардалд 2.2 тэрбум төгрөгийн зардал гаргахаар тооцоолсон.

Нэг удаагийн хөрөнгө оруулалтын зардал болох 9.5 сая ам.доллар буюу 21.2 тэрбум төгрөг орчмыг БНСУ-ын EDCF-ийн зээлээр бүрдүүлэхээр төлөвлөсөн байна. Үндсэндээ материаллаг зардлыг тооцоход томоохон хэмжээний зардал бүхий барилга, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн тооцоог багцаалан оруулсан болно. Иймд бага хэмжээний хөрөнгө оруулалт шаардах материаллаг зардлыг оруулаагүй.

Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх тогтолцооны **урсгал зардал нэг жилд 277,5 сая төгрөг орчим** байх магадлалтай. Энэ зардалд урьдчилан тооцоолох боломжгүй цахилгаан, цэвэр бохир ус, халаалт зэрэг бусад зардал ороогүй болно. Эдгээр зардлыг тооцох нь цаг хугацаа, хүний нөөц шаардсан ажил юм. Түүнчлэн цахим гавны ашиглалтын буюу элэгдэл хорогдлын хугацаа нь 3 жил орчим учраас 3 жил тутам 5.4 тэрбум төгрөг орчим буюу жилд 1.8 тэрбум төгрөг орчим хөрөнгө оруулах шаардлагатай байна.

Гурван жил тутам электрон гавыг шинэчлэхэд шаардлагатай зардал	Нэг жилд ногдох электрон гавыг шинэчлэхэд шаардлагатай зардал
1500 /ялтны тоо/ * 3.6 сая орчим /нэг ширхэг гавны өртөг/= 5.4 тэрбум төгрөг орчим	5.4 тэрбум : 3 жил = 1.8 тэрбум орчим төгрөг

Зорчих эрхээ хязгаарлуулсан ялтанд үүсэх зардлыг дараах байдлаар тооцох боломжтой. Үүнд

№	Төрөл	Төлбөр /хоногоор/
1	Үүрэн холбооны гар утасны сүлжээний урсгал зардал	1900 төгрөг
2	Сансрын холбооны сүлжээний урсгал зардал	4500 төгрөг

Хууль санаачлагчдын зүгээс зорчих эрхээ хязгаарлуулсан ялтнаас сүлжээний зардлыг нь гаргуулахаар тооцож байгаа боловч төлбөрийн чадваргүй ялтны тухайд эдгээр зардлыг төр хариуцах юм.

Үүнээс харахад нэг ялтны **электрон гавны сүлжээ ашигласны жилийн урсгал зардал болох 684,000 төгрөг** улсын төсөвт нэмэгдэх магадлалтай. Харин төлбөрийн чадвартай, хөдөлмөр эрхэлдэг этгээдээс сүлжээний урсгал зардлаас гадна хяналтын зардлыг гаргуулан төсвийн зардлыг хэмнэх боломжтой хэдий ч энэ нь ялтны эдийн засгийн байдлаас хамааран адил тэгш байх зарчмыг алдагдуулах эрсдэлтэй юм.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад нэмж тусгагдсан ялын төрөл болох зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэхэд зөвхөн эхний жилд 23.4 тэрбум орчим төгрөг шаардлагатай байгаа боловч, анхны хөрөнгө оруулалт хийгдсэний дараа зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн нэг ялтанд ногдох зардал нь огцом буурах төлөвтэй байна.

Хүснэгт 11 Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн нэг ялтанд гаргах зардал

№	Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн нэг ялтанд гаргах зардал	
1	Хүний нөөцийн зардал	1.9 тэрбум
2	Сүлжээний зардал	277.5 сая
3	Нэг жилд ногдох электрон гавыг шинэчлэхэд шаардлагатай зардал	1.8 тэрбум
	Нийт 1500 ялтанд ногдох зардал	**3 977 500 000**
	Нэг ялтанд ногдох зардал	**2 651 666 төгрөг**

Дээрх нийлбэр дүнгээс харахад нэг жилд нэг ялтанд **2 651 666 /хоёр сая зургаан зуун тавин нэгэн мянга зургаан зуун жаран зургаа/** орчим төгрөгийн зардал гарахаар төсөөлж болохоор байна. Гэвч судалгааны багын зүгээс урьдчилан тооцох боломжгүй байсан урсгал зардал буюу цахилгаан, дулаан, ус, бусад засвар үйлчилгээний зэрэг зардлын тооцоог дээрх зардал дээр нэмж тооцох шаардлагатай.

Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх зардлыг бууруулах үүднээс электрон гавыг /гавны үнэ 3.6 сая төгрөг орчим/ аливаа байдлаар гэмтээсэн этгээдээр нөхөн төлүүлэх, ажилтай, орлоготой этгээдээс хяналт тогтоосны болон техник хэрэгсэл ашигласны зардлын тодорхой хувийг гаргуулан авах зэрэг асуудлыг нарийвчлан судлах шаардлагатай .

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаанд зөвхөн хорих ял эдлүүлэхтэй холбогдож төрд үүсэх материаллаг зардлыг авч үзсэн бөгөөд хорихоос суллагдсаны дараа тухайн хүнийг нийгэмшүүлэхэд гарах өртөг зардал, хувь хүнд өөрт нь үүсэх хүндрэл бэрхшээл, түүнийг даван туулахтай холбогдон гарах зардлыг оруулаагүй.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын ялын төрлүүдээс шинэ төрлийн ял болох “Зорчих эрхийг хязгаарлах ял”, ял эдлүүлэх хугацааны хувьд багагүй өөрчлөлт орсон “Хорих ял”-ыг сонгон авч, эдгээр ялыг хэрэгжүүлэхэд төрд үүсэх эдийн засгийн ачааллыг тооцох зорилго бүхий судалгааны ажлын үр дүнд судалгааны баг дараах дүгнэлтэд хүрсэн. Үүнд:

Хорих анги байгуулах зардлын тухайд

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад ялын төрөл, хэмжээнд орсон өөрчлөлтийн үр дүнд өмнө нь хорих ялгүй байсан зарим гэмт үйлдэлд хорих ял оноодог болох, мөн ялтай байдал, давтан үйлдсэн зэрэг ял хүндрүүлэх байдлыг халснаар зарим гэмт үйлдэлд оноох хорих ялын хэмжээ буурах зэрэг өөрчлөлт орсноор хорих ял биечлэн эдлэх ялтны тоонд өөрчлөлт орох магадлал өндөр байна.

Үүнээс гадна хорих ангийг нээлттэй, хаалттай гэсэн 2 төрөлтэй, харуул хамгаалалтын 5 зэрэглэлтэй байхаар хуульчилсан нь хорих ял эдлүүлэх чиг үүрэг бүхий шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа хорих ангиудын байршил, багтаамж, харуул хамгаалалтын систем, үйл ажиллагааны хэлбэр, бүтэц, орон тоонд өөрчлөлт оруулах хэрэгцээг шууд тодорхойлж байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

2016 оны байдлаар Монгол Улсад нийт 51 байршилд[26] сэжигтэн, яллагдагч, ялтныг хорьж байгаа бөгөөд эдгээр нь Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын "хорих" ялыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээлтэй байна. Тухайлбал эдгээр хорих байрыг нээлттэй, хаалттай хэлбэрт шилжүүлэх, харуул хамгаалалтын зэрэглэлд өөрчлөлт оруулах ажлыг нөхцөл бололцоондоо нийцүүлэн өөрчлөх боломжтой хэдий ч зарим алслагдсан бүс нутагт шинэ хорих байр барихгүйгээр богино хугацаатай ялыг хэрэгжүүлэх боломжгүй болох нь тодорхой байна.

Хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан ШШГЕГ-аас аймаг тус бүрт шинээр хорих анги/байр барих хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон байдаг. Судалгааны үр дүнгээс харахад хорих анги байгуулах зардалд улсын төсвөөс **74,796.700,000 /далан дөрвөн тэрбум долоон зуун ерэн зургаан сая долоон зуун мянган/** төгрөг зарцуулах шаардлага үүсэж байна.

Улсын хэмжээнд одоо ашиглагдаж буй хорих ангиудын барилга байгууламжийн нөхцөл байдлыг сайжруулах, хоригдлуудын амьдарч буй орчныг стандартад нийцүүлэх талаар олон улсын болон дотоодын хүний эрхийн байгууллагуудаас болон прокурор, мэргэжлийн хяналтын газраас гаргаж буй шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах үүднээс ч энэ төрлийн хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар хийх хэрэгцээ бий.

Хорих ангиудын барилга байгууламж, үйлдвэрийн газруудыг шинэчлэх бодит шаардлага өнөө хир тулгамдсан асуудлын нэг тул энэхүү хэрэгцээ, шаардлагатай уялдуулан хорих анги байгуулах, шинэчлэх ажлыг хэрэгжүүлэх шаардлага байна гэж үзлээ.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга дахь "хорих" ялыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд шинээр барих болон шинэчлэх шаардлагатай хорих ангиудад зориулан төрөөс гаргах зардал нь зөвхөн энэ хуулийн хэрэгжилтийг хангахаас гадна ерөнхийдөө улсын хэмжээнд хорих ангиудыг олон улсын жишигт нийцсэн, дотоодын хууль тогтоомжид заасан стандартын шаардлага хангасан эрүүл, аюулгүй орчинг бий болгох давхар үр нөлөөтэй.

Хүний нөөцийн зардлын тухайд

Хорих болон хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх чиглэлээр Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад орсон өөрчлөлтийн хүрээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллаж буй алба хаагчдын орон тоог нэмэх хэрэгцээ үүсэж байна. Энэ нь нэгдүгээрт шинэ хорих анги байгуулахтай, хоёрдугаарт шинэ төрлийн ял бий болсонтой холбоотой.

ШШГЕГ-аас гаргасан тооцоо судалгаагаар шинээр нэмж 1443 орон тоо бий болгох хэрэгцээ байгааг тогтоосон байна. Судалгааны ажлын хүрээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллаж буй алба хаагчдын үндсэн цалингийн дундаж хэмжээг 917 800 төгрөг байхаар авч үзсэн.

Төрийн тусгай алба хашиж буй алба хаагчид нь үндсэн цалингийн тодорхой хувьтай тэнцэх хэмжээний алба хаасан хугацааны, цолны, онцгой нөхцөлийн, хоригдолтой ажилласны, хоол, унааны гэх зэрэг нэмэгдэл, нэг удаагийн тусламж, урамшуулал, дүрэмт хувцас болон бусад хангамж авахаас гадна ажлын онцлогоос хамааран зарим төрлийн даатгалд хамрагддаг.

Шүүхий шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид зориулан төрийн зүгээс гаргах зардлыг дээр дурдсан цалин, урамшуулал, нэмэгдлийн дундаж хэмжээг чиглэл болгон тооцсон бөгөөд нэг алба хаагчид ногдох цалингийн хэмжээ

[26] Үүнд хорих анги, баривчлах, цагдан хорих байр баривчлах ял эдлүүлэх байр орно.

нэг сард **1 750 628 /нэг сая долоон зуун тавин мянга зургаан зуун хорин найм**/ төгрөг байхаар тооцов. Энэ цалинд судалгааны ажлын явцад нарийвчлан тогтоох боломжгүй байсан хоол, унааны зардал, нэг удаагийн тусламж зэрэг зарим зардлыг тооцож оруулаагүй тул нарийвчилсан судалгаа хийж ТТ1-ТТ18 зэрэглэл тус бүрээр нь тооцож гаргах, мөн тус байгууллагад ажиллаж буй төрийн үйлчилгээний ангилалд багтах ажилтны цалинг тусад нь нэмж гаргаснаар төсөвт үүсэх ачааллыг улам тодорхой болгоход дөхөм болохоор байна.

2015 онд баталсан Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/ хэрэгжиж эхэлснээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шинээр нэмэх шаардлагатай 1443 орон тоо нь улсын төсөвт нэг сард дунджаар **2 526 156 204 /хоёр тэрбум таван зуун хорин зургаан сая нэг зуун тавин зургаан мянга хоёр зуун дөрвөн**/ төгрөгийн ачаалал үүсгэх магадлалтай байна.

Зорчих эрх хязгаарлах ялын тухайд

Эрүүгийн хуулийн /шинэчилсэн найруулга/ **тусгай ангийн 170** зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулах боломжтой байхаар тусгасан ба Монгол Улсын хэмжээнд нэг жилд дунджаар 1500 хүнд энэ төрлийн ял оногдуулах магадлалтай гэсэн тооцоо судалгааг ШШГЕГ-аас гаргаад байна.

Зорчих эрхийг хязгаарлах ял нь эрүүгийн хууль болон ялын бодлогын шинэчлэлийн хүрээнд манай улсад анх удаа хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ялын шинэ төрөл юм. Тус ялыг хэрэгжүүлэх гол хэрэгсэл болох электрон гав болон түүнийг хянах тогтолцоог шинээр бий болгохын тулд эхний ээлжинд төрийн зүгээс их хэмжээний хөрөнгө оруулалт хийх шаардлагатай.

ШШГЕГ-аас зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх арга зам, нийгэм, эдийн засгийн хувьд манай улсад хэрэгжүүлж болох хэд хэдэн хувилбарыг “Цахим хяналт, удирдлагын төв систем байгуулах” төслийн хүрээнд судалж үзсэн байна.

Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал нь 1/ Цахим хяналт, удирдлагын төв, салбар төвийн барилга барих, дэд бүтцийг сайжруулах; 2/ Програм хангамж, шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах, суурилуулах, мэдээллийн технологийг боловсронгуй болгох; 3/ ШШГЕГ-ын ажилтнуудыг програм хангамж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг ажиллуулах, засвар үйлчилгээ хийхэд суралцах, дадлагажуулах сургалтад хамруулах зардлаас бүрдэнэ. Эдгээр хөрөнгө оруулалтад эхний ээлжинд **9,500,000 ам.доллар** буюу **21,2 тэрбум төгрөг** шаардагдахаар байна.

Дээрх зардалд 1800 ам.доллар буюу 3,6 сая төгрөгийн өртөг бүхий 1500 ширхэг электрон гавны зардал болох 5,4 тэрбум төгрөг багтсан байна. Гэвч тус гавны ашиглалтын хугацаа дунджаар 3 жил байх ба ашиглалтын хугацаанаас хамааран жилд 1,8 тэрбум төгрөг орчим зардлыг гав шинэчлэх, засварлах зэрэгт зарцуулах хэрэгцээ үүсэх магадлалтай байна.

Зорчих эрх хязгаарлах ял шийтгүүлсэн ялтан аль төрлийн сүлжээ ашиглаж байгаагаас хамааран өдөр тутам 1900 – 4500 төгрөгийн сүлжээ ашигласны төлбөрийг барагдуулах шаардлагатай. Үүнээс харахад нэг сард /30 хоног/ 57 000- 135 000 төгрөгийн төлбөр төлөх санхүүгийн чадвартай хүнд энэ төрлийн ял оногдуулах нь төрд ашигтай байна. Гэтэл энэ ялаар шийтгүүлэх магадлалтай сэжигтний 40 гаруй хувь нь төлбөрийн чадваргүй, үлдсэн 50 гаруй хувь нь төлбөрийн чадвартай гэсэн судалгаа байна[27].

[27] ШШГЕГ-аас 2015-2016 онд хийсэн судалгаанаас ишлэв.

Энэ судалгааны ажлын хүрээнд зөвхөн эхний ээлжинд нэн даруй хөрөнгө оруулах шаардлагатай зардлыг тооцох оролдлого хийсэн бөгөөд сүүлд гарах барилга байгууламж, тоног төхөөрөмжтэй холбоотой урсгал зардал болон бусад зардлыг тооцох боломжгүй байлаа.

Эцэст нь нэгтгэн дүгнэхэд Эрүүгийн хуулийн /шинэчилсэн найруулга/ Тавдугаар бүлгийн 5.5 дугаар зүйл “Зорчих эрхийг хязгаарлах ял” болон 5.6 дугаар зүйл “Хорих ял”-ыг хэрэгжүүлэхэд төрийн зүгээс юуны түрүүнд 126 тэрбум төгрөгийн зардал гарах төлөвтэй байна[28].

№	Зардлын нэр	Зардлын хэмжээ /төгрөг/
1	Хорих анги байгуулах нэг удаагийн зардал	**74,8 тэрбум**
2	Нэмэх шаардлагатай хүний нөөцийн нэг жилийн зардал	**30 тэрбум**
3	Цахим гав болон түүний хяналтын тоглолцоог бий болгох зардал	**21,2 тэрбум**
	Нийт	**126 тэрбум**

Эрүүгийн эрх зүй, ялын бодлогын шинэчлэл нь удаан хугацаанд үргэлжилдэг, төрийн зүгээс их хэмжээний хөрөнгө оруулалт, санхүүжилт шаарддаг асуудал юм. Иймд ялын бодлого, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хэлбэр, орчин нөхцөлийг олон улсын жишигт нийцүүлэх, хүний эрхийг хангах, ялтнуудын эрүүл аюулгүй орчныг бий болгох, хорихоос өөр төрлийн ял хэрэглэх замаар анх удаа гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр, давтан гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх зэрэг урт хугацааны зорилготой уялдуулан шийдвэрлэх шаардлагатай юм.

Өнөөдөр улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хорих ангиудад ашиглагдаж буй барилга байгууламжийн ашиглалтын хугацаа хэтэрсэн, стандартын шаардлага хангахгүй байгаа нөхцөл байдал ялангуяа орон нутагт түгээмэл байна.

Иймд хорих ангиудын барилга байгууламжийн нөхцөл байдлыг сайжруулах, хоригдлуудын амьдарч буй орчныг стандартад нийцүүлэх нь нэг талаас хуулийн хэрэгжилтийг хангах, нөгөө талаас олон улсын болон дотоодын хүний эрхийн байгууллагуудаас хорих ангийн нөхцөл байдалтай холбогдуулан гаргаж буй шүүмжлэл, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах үүднээс ч мөн адил энэ төрлийн хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар хийх шаардлагатай юм.

Харин Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхлэхээс өмнө зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх техник, програм хангамж, мэдээлэл, хяналтын сүлжээ, бүтэц, орон тоог шинээр бий болгох хэрэгцээтэй. Судалгааны дүнгээс харахад уг ялын төрлийг хэрэгжүүлэх бэлтгэл ажилд нэн түрүүнд урьдчилсан байдлаар 23,4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг төрөөс гаргах шаардлагатай бөгөөд үүнээс зөвхөн цахим гав худалдан авах болон түүнтэй холбоотой мэдээлэл, хяналтын тоглолцоотой холбоотой зардал 21,2 тэрбум төгрөг юм.

Улс орны нийгэм, эдийн засгийн байдал хүнд байгаа энэ үед энэхүү шинэ төрлийн ялыг хэрэгжүүлж эхлэхэд шаардагдах техник, тоног төхөөрөмж, програм хангамж, барилга, байгууламж болон боловсон хүчнийг бэлтгэх санхүүжилтыг гаргах нь улсын төсөвт хүндрэл учруулах магадлалтайн зэрэгцээ 3,6 сая орчим төгрөгийн нэгж үнэ бүхий цахим гавны хэрэглээний хугацаа 3 жил байгаа нь төрөөс гарах зардлын хэмжээг улам нэмэгдүүлэх төлөвтэй байна.

[28] Дээрх зардалд хорих анги болон алба хаагчдыг ажил, үйлчилгээнд шаардлагатай машин, техник тоног төхөөрөмж, тусгай хэрэгсэл болон харуул хамгаалалт, аюулгүй байдлыг хангах зорилго бүхий хэрэгслийг оруулаагүй болно.

Иймд энэ төрлийн ялыг хэрэгжүүлэх ажлыг хууль хэрэгжиж эхлэх хугацаанд баригдаж яаравчлалгүй, харин тодорхой үе шаттай зохион байгуулах, үүнд дотоодын нөөц бололцоогоо ашиглах боломжтой эсэхийг судлах нь зүйтэй юм. Тухайлбал бүх техник хэрэгслийг гадаадаас импортлох шаардлагатай эсэх, эсхүл зарим зүйлийг дотооддоо үйлдвэрлэх, програм хангамжийг хөгжүүлэх боломжтой эсэхийг судлах шаардлага байна. Хэдийгээр дотоодын зах зээлээс бараа бүтээгдэхүүн нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх нь цаг хугацаа шаардсан ажил боловч энэ хожим төрөөс гарах зардлыг хэмнэх боломж гэж үзэж байна.

Хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллаж буй хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэх нь тухайн хуулийн хэрэгжилт болон ялын бодлогын үр дүн ямар байхыг илэрхийлдэг. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжсэнээр улсын хэмжээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын орон тоог 1443-аар нэмэгдүүлэх хэрэгцээтэйг ШШГЕГ-аас гаргасан судалгаагаар тогтоожээ.

Үүнээс харахад ШШГЕГ-ын бүтэц, зохион байгуулалт, санхүүжилтэд үлэмж хэмжээний өөрчлөлт орохоор харагдаж байна. ШШГЕГ-т шинээр нэмж авах 1443 алба хаагч нь “Төрийн тусгай албан тушаалын цалингийн сүлжээ”-нд тусгасан албан тушаалын ТТ1-ТТ18 зэрэглэлээр цалинжиж, дүрэм журамд заасан нэмэгдэл, урамшуулал авах, нийгмийн баталгаагаа хангуулах эрх үүсэх юм.

Судалгааны ажлын хүрээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллаж буй алба хаагчдын цалингийн дундаж хэмжээг 917800 төгрөгөөр тооцсон бөгөөд нэг алба хаагчийн нэг сарын цалин 1750628 /нэг сая долоон зуун тавин мянга зургаан зуун хорин найм/ төгрөг, нэг жилд 20710536 /хорин сая далан нэгэн мянга таван зуун гучин зургаан/ төгрөгийг төрийн зүгээс гаргах дундаж зардлын хэмжээ байх урьдчилсан тооцоололд хүрсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллаж буй алба хаагчдын ажиллах орчин нөхцөл хүнд, ажлын ачаалал их байдаг зэргээс шалтгаалан тус салбарт ажиллах сонирхолтой иргэдийн тоо бага байдаг.

Иймд одоо ажиллаж буй алба хаагчдын ажлын ачааллыг бууруулах, жишиг стандартад нийцүүлэх асуудал өнөө хир тулгамдсан асуудлын нэг бөгөөд энэ асуудлыг яаралтай шийдвэрлэх, хуулийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэх нь зохистой гэж үзлээ

Хавсралт №1

ЦАЛИНГИЙН ДУНДАЖ ХЭМЖЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ

Хүний нөөцийн зардал буюу цалингийн дундаж хэмжээг гаргахад дараах эрх зүйн актуудад тусгасан хувь хэмжээг чиглэл болгон ашигласан болно.

Үндсэн цалин: Шүүхийн тогтоол гүйцэтгэх чиглэлээр хорих анги болон түүний салбар нэгжид ажиллаж буй алба хаагчид нь Засгийн газрын 2014 оны 332 дугаар тогтоолоор баталсан “Төрийн тусгай албан тушаалын цалингийн сүлжээ”-нд тусгасан албан тушаалын ТТ-1-ээс ТТ-18 хүртэл зэрэглэлээр үндсэн цалингийн хэмжээг тогтоодог. УИХ-ын Судалгаа шинжилгээний хэлтсээс 2014 онд хийсэн “Төрийн албан хаагчийн баталгааг хангах чиглэлд үйлчилж буй хууль эрхзүйн зохицуулалт, тэдгээрийн хэрэгжилтийн зарим байдал” лавлагаанаас харахад 2013 оны байдлаар төрийн албаны нийт бие бүрэлдэхүүний 17,68% буюу 28773 алба хаагч төрийн тусгай албан тушаал хашиж байсан ба тэдний дундаж цалингийн хэмжээ 605800 төгрөг байсан байна.

Нэмэгдэл хөлс: Төрийн албаны тухай хуульд зааснаар тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цол зэрэг дэвийн, докторын, мэргэшлийн зэргийн нэмэгдлээс бүрддэг.

Төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдлийн хэмжээг ЗГ-ын 1999 оны 211 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан бөгөөд шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын алба хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож олгодог байна. Үүнд:

Төрийн алба хаасан хугацаа /жилээр/	Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн хэмжээ /хувиар/
5-7	5
8-10	8
11-14	12
15-19	15
20-24	20
24 ба түүнээс дээш	27
Дундаж хэмжээ	**14,5**

Хорих байгууллагын алба хаагчид хоригдолтой ажилласны нэмэгдэл олгох журмыг ЗГ-ын 2002 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар баталсан ба 2003 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөж байна. Үүнд:

Хорих ангийн дэглэмийн төрөл	Хоригдолтой ажилласны нэмэгдлийн хэмжээ / хувиар/
Жирийн дэглэмтэй хорих ангид	6
Чанга дэглэмтэй хорих ангид	7
Онцгой дэглэмтэй хорих ангид	8
Нэгдсэн эмнэлэг болон сүрьеэгийн хорих ангид	8
Гянданд	9
Мөрдөн хөөх, эрэн сурвалжлах	9
Дундаж хэмжээ	**7,8**

Хорих байгууллагын гүйцэтгэх ажилтанд гүйцэтгэх ажил эрхэлсэн хугацаанд тусгай албаны нэмэгдэлийг олгох тухай журмыг ЗГ-ын 2002 оны 215 дугаар тогтоолын хавсралтаар баталж 2003 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөж байна. Үүнд:

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Ажилласан жил	Нэмэгдлийн хэмжээ
0-5	8
6-10	10
11-ээс дээш жил	15
Дундаж хэмжээ	**11**

Хорих байгууллагын алба хаагчдад албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох[29] журмыг ЗГ-ын 2011 оны 6 дугаар сарын 22-ны өдөр баталж 2012 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөж байна. Үүнд:

Албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох алба	Нэмэгдлийн хэмжээ /үндсэн цалингийн хувиар/
Гяндан, чанга, онцгой дэглэмтэй хорих анги, цагдан хорих 461-р анги, эмэгтэйчүүдийн хорих 407-р анги	20
Баривчлах байр, жирийн дэглэмтэй хорих анги, согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар, насанд хүрээгүйчүүдийн хорих 411-р анги, аймгууд дахь цагдан хорих байр	15
Бусад алба	10
Дундаж хэмжээ	**15**

Засгийн газрын 2014 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн “Цагдаагийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай” 99 дүгээр тогтоолоор цагдаагийн албан тушаалын цолны нэмэгдлийн хувь хэмжээг тогтоосон.[30]

Цагдаагийн албан тушаалын цолны ангилал	Цагдаагийн цол	Сар бүр олгох нэмэгдлийн хувь хэмжээ (үндсэн цалингийн хувиар)
Бага цол	Цагдаагийн дэд ахлагч	25
	Цагдаагийн ахлагч	
	Цагдаагийн ахлах ахлагч	
Дунд цол	Цагдаагийн дэслэгч	30
	Цагдаагийн ахлах дэслэгч	
	Цагдаагийн ахмад	
Ахлах цол	Цагдаагийн хошууч	
	Цагдаагийн дэд хурандаа	
	Цагдаагийн хурандаа	
Дээд цол	Туслах комиссар	
	Дэд комиссар	
	Тэргүүн дэд комиссар	
	Тэргүүн комиссар	
Дундаж хэмжээ		**17,5**

Төрийн албаны тухай хууль тогтоомжид тусгаснаар төрийн албан хаагч дараах баталгаагаар хангагдах эрхтэй. Үүнд:

- төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал, урамшил, тэтгэвэр, тэтгэмж авах;
- гүйцэтгэж байгаа албан үүргийнх нь шинж байдлыг харгалзан зохих журмын дагуу албаны унаа хэрэглэх, ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардлын зохих хэсгийг нөхөн авах;
- төрөөс орон байраар хангагдах;
- хөдөлмөрийн тухай хуулиар тогтоосон ээлжийн амралт эдлэх;

[29] Энэ төрлийн нэмэгдлийг өвчтэй, чөлөөтэй, ээлжийн амралттай, жирэмсний болон амаржсаны амралттай байх хугацаанд олгохгүй.

[30] Эх сурвалж: http://www.tuv.police.gov.mn/media/hunii_nuuts/zg_togtool.pdf

хууль зүйн үндэсний хүрээлэн www.legal.gov.mn

- төрийн алба хаах хугацаанд болон тэтгэвэрт гарсан үедээ хууль тогтоомжоор тогтоосон нөхцөл, журмын дагуу эмнэлгийн үйлчилгээнд хамрагдах;
- Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг болон магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр гадаад оронд эмчлүүлэх зайлшгүй шаардлагатай болсон тохиолдолд зардлынх нь 60% -с доошгүй хувийг төр хариуцах;
- төрийн хөрөнгөөр давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэх, энэ хугацаанд эрхэлж байгаа албан тушаалынхаа цалин хөлсийг авах;
- хууль тогтоомжоор тогтоосон бусад баталгаа; Тухайлбал тусгай журмын дагуу алба хаагчийг тэтгэвэрт гарахад ажилласан жилийг нь харгалзан 36 хүртэл сарын цалинтай нь тэнцэх хэмжээний 1 удаагийн буцалтгүй тусламж олгох зэргийг дурдаж болох юм.

Төрийн тусгай үйлчилгээний байгууллагад ажиллаж буй алба хаагчдын нийгмийн баталгааг хангах тухайд төрөөс ихээхэн анхаардаг болох нь үүнтэй холбогдуулж гаргасан ЗГ-ын тогтоол, сайдын тушаал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын даргын тушаалаас харагдаж байна.

Тухайлбал ШШГ байгууллагын офицер, ахлагч нарт нэг удаагийн тэтгэмж олгох журмыг ХЗДХ-ийн сайдын 2003 оны 54 дүгээр тушаалын хавсралтаар баталсан ба 2003 оны 4 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөж байна. Үүнд: Цэргийн алба хаагч эрэгтэй 25-аас доошгүй, эмэгтэй 20-иос доошгүй жил алба хаагаад цэргийн алба хаасны тэтгэвэрт гарах, орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэндээр, эсхүл цэргийн алба хаах насны хязгаарт хүрч халагдахад болон албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдолгүй осол, тарилгын дараах хүндрэл, ердийн өвчний улмаас нас барсан албан хаагчийн ар гэрт тэдний ажиллаж байсан нөхцөл, ажлын үр дүн, амьдралын нөхцөл байдлыг харгалзан нэг удаагийн тэтгэмж олгох асуудлыг зохицуулсан байна.

Тэтгэмжийн хэмжээг тооцох суурь үзүүлэлт нь цэргийн алба хаасны тэтгэвэрт гарах үед 18-36 сарын цалинтай тэнцэх, бусад тохиолдолд алба хаасан 2 жил тутамд 2 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж байх ба тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэхэд тухайн албан хаагчийн гаргасан амжилт, хүрсэн үр дүн зэргийг харгалздаг байна. Үүнээс үзвэл тэтгэвэрт гарах үед дунджаар 27 сарын тэтгэмж авдаг гэж үзэж болох юм.

Мөн ХЗДХ-ийн сайдын 2007 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн А/95 тушаалаар ШШГЕГ-т ажиллаж байсан, цэргийн жинхэнэ алба хаасны тэтгэвэр тогтоолгосон бэлтгэл болон чөлөөнд байгаа генералуудад сар бүр тэтгэмж олгож байхаар тогтоосон.

ШШГЕГ-ын даргын 2013 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн А/35 тушаалаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын орон сууцны асуудлыг шийдвэрлэхэд баримтлах журам”-ыг баталсан ба тус байгууллагын харьяа төв суурин газраас алслагдсан хорих ангид 5 жил, бусад газар тогтвор суурьшил, үр бүтээлтэй 8 жил ажилласан, хувийн орон сууцгүй, өмнө нь орон сууц авч байгаагүй алба хаагчид орон сууцны дэмжлэг үзүүлэх асуудлыг, 3 жил ажилласан алба хаагчид хүсэлтийн дагуу монгол гэр олгох асуудлыг хамт олны хурлын дэмжсэн шийдвэрийг үндэслэн шийдвэрлэдэг байна. Мөн албан үүргээ гүйцэтгэх явцдаа онцгүй гавьяа байгуулсан алба хаагч, албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан алба хаагчийн ар гэрт болон байгалийн гамшиг, давтагдашгүй хүчин зүйлийн улмаас орон гэрээ алдсан зэрэг хүндэтгэн үзэх шалтгаантай алба хаагчдад ажилласан жил харгалзахгүйгээр орон сууцны дэмжлэг үзүүлэх боломжтой.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2013 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн А/84 тушаалын хавсралтаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 9.3 – 9.8 дугаар заалтад тус байгууллагын албa хаагчдад олгох нэг удаагийн тусламжийн талаар тусгасан байна. Тухайлбал байгалийн гамшигт орон гэр нь өртсөн бол 1 сая хүртэл төгрөгийн тусламж, ахмад ажилтан нас барвал ар гэрт нь 250,000 төгрөгийн тусламж үзүүлэх зэрэг заалт багтсан байна.

***Нөхөх олговор*:** Төрийн албан хаагчид дараах нөхөх төлбөр олгохоор хуульчилсан. Үүнд:

Албан томилолтын зардалд замын зардал, байр, зам хоногийн зардал багтана.

ШШГЕГ-ын албa хаагчдын дотоод дахь томилолтын зардлыг тооцохдоо Сангийн сайдын 2011 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 132 дугаар тушаалд үндэслэн тооцдог бол гадаад томилолтын зардлыг Сангийн сайдын 2011 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн “Гадаад томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай”. 188 дугаар тушаалаар баталсан нормативын дагуу тооцдог.

Харин хөдөө орон нутагт зорчих зардлын хэмжээг Автотээврийн үндэсний төвөөс гаргасан “Хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээний үнэ тариф”[31] –ийг жишиг болгон тогтоосон тарифын дагуу тооцдог байна. Тухайлбал 2 талдаа зорчих зардал Архангай – 37250, Завхан – 53420, Багануур – 19900 төгрөг байдаг байна.

Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам (хэмжээг) төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтоодог.

Дээрхээс харахад Монгол Улсад төрийн албан хаагчийн цалингаас гадуурхи хангамж нь төрийн албаны нийт цалин, урамшууллын үлэмж хэсгийг бүрдүүлж байна. Төрийн албан хаагчийн цалингаас гадуурх хангамжид орон сууц олгох .. зэрэг өөр олон асуудал ордог.Түүнээс гадна Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хуульд зааснаар цалингийн тодорхой хувьтай тэнцэх гүйцэтгэлийн бонус болон ажлын үр дүнтэй холбосон бусад төрлийн шан урамшуулал олгохыг зөвшөөрдөг. Төрийн албаны тухай хуулийн дагуу олгох нэмэгдэл болон цалингаас гадуурх бусад хангамжийн нийт хэмжээ нь тухайн төрийн албан хаагчийн албан тушаалын цалинтай жишигдэх хэмжээнд очих тохиолдол элбэг байна.[32].

ХУУЛЬ ЗҮЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН
www.legal.gov.mn

[31] Хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээний үнэ тариф. Эх сурвалж: http://transdep.mn/search.php?subm/51.html

[32] Төрийн албан хаагчийн баталгааг хангах чиглэлд үйлчилж буй хууль эрхзүйн зохицуулалт, тэдгээрийн хэрэгжилтийн зарим байдал” лавлагаанаас. 2014 он. УИХ-ын Судалгаа, шинжилгээний хэлтэс.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Электрон гав бүхий цахим хяналтын систем байгуулах ажлын танилцуулга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, 2016.

2. “Цахим хяналт, удирдлагын төв систем байгуулах” төсөл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, 2016.

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал.

4. Б.Нямгомбо, Хорих болон хорихоос өөр төрлийн ялын үр нөлөө, чиг хандлага, Цахим хуудас: http://criminology.mn/print.php?id=160&lang=1#_ftn5.

5. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: http://legalinfo.mn/

6. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2016.09.06. №33/942/.

7. Эрүүгийн хуулийн /шинэчилсэн найруулга/ танилцуулга.

8. Эрүүгийн хуулийн /шинэчилсэн найруулга/ үзэл баримтлал.

9. ШШГЕГ-аас гаргасан судалгаа, тоо баримт болон бусад эх сурвалж.

---o0o---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ САНГИЙН ЭЛЭГ
www.nli.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ХОЁР. ЗАСГИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ 249 ДҮГЭЭР ТОГТООЛД ЗААСАН АРГАЧЛАЛЫН ДАГУУ ГҮЙЦЭТГЭСЭН СУДЛАГАА

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

БҮХ НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР[1]

Нөлөөллийн урьдчилсан үнэлгээ

УДИРТГАЛ

Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны статистикийн нэгдсэн санд мэдээлснээр 2017 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн байдлаар нийт хүн амын тоо 3.119.935 байгаагаас эрэгтэй 1.533.983, эмэгтэй 1.585.952 байна.



Эдгээр иргэдийнхээ эрх зүйн ухамсар, боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх үүднээс төрөөс энэхүү “Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөр” хэмээх бодлогын баримт бичгийг батлан хэрэгжүүлэхээр зорьж байна.

Хөтөлбөрийн төслийг Монгол Улсын Засгийн газрын 2016 онд баталсан 249 дүгээр тогтоол “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-д нийцүүлэн боловсруулсан байна. Иймээс “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-д зааснаар түүний 4 дүгээр хавсралтын дагуу баримт бичигт нөлөөллийн урьдчилсан үнэлгээг хийж байна.

Нөлөөллийн урьдчилсан үнэлгээг бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчин, аливаа байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, эрх зүйн орчинд үзүүлэх нөлөөллийн талаарх судалгааг өмнө хийсэн судалгаа, үнэлгээ, албан ёсны тоон болон чанарын мэдээлэлд үндэслэн хийдэг учраас бид 2017 онд ХЗҮХ-ээс хийсэн “Эрх зүйн боловсрол олгох, мэдээлэл түгээх үр нөлөөтэй арга хэлбэр” сэдэвт судалгааны ажлыг үндэслэн хийлээ.

Уг судалгааны ажилд тусгасан гол анхаарах хэсгүүдийг товчлон авч үзье.[2]

Монгол Улс улс төр, нийгэм, эдийн засгийн шилжилтийн үедээ байгаа орны нэг юм. Энэ нь иргэдийн эрх зүйн ухамсар, соёл төдийлөн төлөвшөөгүй, хууль тогтоомжийн талаарх мэдлэг, ойлголт муу байгаад шууд нөлөөлдөг. Иймээс төрөөс иргэдийн эрх зүйн ерөнхий мэдлэг, ухамсрыг нэмэгдүүлэх үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь нийгэмд шударга ёсыг тогтооход төдийгүй хууль тогтоомжийн хэрэгжилтийг үр дүнтэй хангахад чухал нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

[1] Тус судалгааг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Х.Эрдэм-Ундрах удирдаж, эрдэм шинжилгээний ажилтан Б.Гончигсумлаа, Г.Халиунаа нар хамтран гүйцэтгэв.

[2] “Эрх зүйн боловсрол олгох, мэдээлэл түгээх үр нөлөөтэй арга хэлбэр” сэдэвт судалгааны тайлангаас дэлгэрүүлэн үзнэ үү.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.legal.gov.mn

Монгол Улсын тухайд эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлыг ХЗДХЯ, түүний харьяа Хууль зүйн үндэсний хүрээлэн зохион байгуулж байна. Тус хүрээлэн нь өөрийн чиг үүргийн хүрээнд эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлыг өрнүүлдэг боловч өнөөгийн байдлаар эрх зүйн мэдээлэл сурталчилгаа болон сургалт хариуцсан тус бүр нэг мэргэжилтэнтэй. Иймд тус хүрээлэнгээс улсын хэмжээнд иргэдийн эрх зүйн мэдлэг, ухамсрыг дээшлүүлэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх боломжгүй байдалд хүргэж байна. Мөн 2015 онд батлагдсан, 2017 оноос хэрэгжиж эхэлсэн “Хууль тогтоомжийн тухай” хуулийн дагуу хууль тогтоомжийг олон нийтэд таниулах ажлыг нийт төрийн байгууллагууд, засаг дарга нар өөрийн бүрэн эрх, чиг үүргийн дагуу харьяалах салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулахаар зохицуулжээ. Иймхүү хууль тогтоомжийг сурталчлах ажлыг төвлөрсөн бус байдлаар бүхий л төрийн байгууллагуудад даалгасан нь сайшаалтай юм. Гэсэн хэдий ч иргэдийн эрх зүйн мэдлэг, ухамсрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулахыг бүх шатны төрийн байгууллагуудад хариуцуулаагүй нь учир дутагдалтай байна.

Түүнчлэн төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх Хууль зүйн туслалцааны төв нь өнөөгийн байдлаар зөвхөн эрүүгийн хэрэгт холбогдсон төлбөрийн чадваргүй иргэдэд туслалцаа үзүүлж байгаа учраас төрөөс хүний эрхийг хангах үүргээ зүй ёсоор биелүүлэхийн тулд бусад салбар эрх зүйн асуудлаар төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөлөл, зөвлөгөө авах боломжоор хангах асуудал шийдвэрлэгдээгүй хэвээр байна.

Хөгжилтэй улс оронд иргэдийн эрх зүйн ухамсар, мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг ерөнхийд нь:

- иргэдийн эрх зүйн боловсрол (public legal education)-ыг дээшлүүлэх
- иргэдэд эрх зүйн мэдээлэл түгээх (public legal information) хэмээн ангилдаг байна.

Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтыг түгээгч байгууллагын хувьд олон төрлийн төрийн болон төрийн бус байгууллага эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлыг явуулдаг. Үүнд голлох үүрэг хүлээдэг Хууль зүйн яам, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн мэдээллийн төв, төрийн бүх шатны байгууллага, хууль хяналтын байгууллагууд, Хуульчдын холбоо, эрх зүйн боловсролын чиглэлээр ажилладаг ТББ-ууд, Олон улсын байгууллагууд, боловсролын бүх шатны сургууль, байгууллагууд, их дээд сургуулийн клиник сургалтын төвүүд болон хэвлэл мэдээллийн байгууллагуудыг дурдаж болох юм

Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтыг түгээх зорилтот бүлгийн хувьд зорилтот бүлгийг дараах байдлаар ангилж болно. Үүнд:

- Нас, Хүйс /хүүхэд, өндөр настан зэрэг/;
- Сургагч багш, бизнес эрхлэгчид, хууль сахиулах байгууллагын ажилтан зэрэг;
- Газар зүйн хүрээгээр /жишээ нь: алслагдмал газар амьдардаг иргэд/;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд;
- Хүчирхийлэлд өртсөн хохирогч;
- Гэмт хэрэгтэн;
- Бусад.

Үүний зэрэгцээ тодорхой бүлгийн эрэлт хэрэгцээнээс хамааран тодорхой сэдвийн дагуу жишээ нь татвар, зээл, хөдөлмөр эрхлэлт, тэтгэвэр, гэрлэлт зэрэг асуудлын хүрээгээр зорилтот бүлгийг тодорхойлдог.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.jli.gov.mn

Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтыг түгээх арга хэрэгслийн хувьд зорилтот бүлгийн харилцан адилгүй хэрэгцээ шаардлага, онцлогийг харгалзан эрх зүйн мэдээлэл, сурталчилгааг түгээх арга хэрэгсэл нь олон янз байдаг. Үүнд:

- Цахим хэлбэрээр үнэ төлбөргүй хууль эрх зүйн баримт бичиг, ном, сэтгүүл, сонин авах боломжоор олон нийтийг хангах;
- Нийгмийн сүлжээ;
- Ухаалаг утас;
- Ярилцлага, асуулт хариулт;
- Сэдэвчилсэн уралдаан, тэмцээн;
- Өдөрлөг, уулзалт;
- Тоглолт, хошин үзүүлбэр;
- Кино, радио телевизийн нэвтрүүлэг;
- Ном, сонин, сэтгүүл, хэвлэмэл хуудас, мэдээллийн хуудас, товхимол;
- Явуулын видео, аудио, кино;
- Лекц семинар;
- Сэдэвчилсэн түр сургалтууд;
- Олон нийт цугладаг газар эсхүл төрийн байгууллагын өмнө дэлгэцээр шторк, сурталчилгаа, танилцуулга явуулах;
- Бусад арга хэлбэрүүд хамаарна.

Эрх зүйн мэдээлэл зүй (legal informatics)-н хувьд мэдээллийн технологи ашиглан дэвшилттэй байдлаар эрх зүйн мэдээллийг түгээх арга замыг эрх зүйн мэдээлэл зүй хэмээн нэрийддэг. Эрх зүйн мэдээллийг хурдан, үнэ төлбөргүй, үр дүнтэй иргэдэд төдийгүй мэргэжлийн хүмүүст түгээх энэхүү арга нь өнөө үед улам боловсронгуй болон хөгжиж буй мэдээллийн салбар юм. Сүүлийн үед мэдээллийн технологийн хөгжилтэй холбоотойгоор эрх зүйн мэдээлэл түгээх төдийгүй хууль зүйн зөвлөгөө өгөх програм, эдийн засгийн хууль тогтоомжийн талаарх мэдээлэл агуулсан хуулийн этгээдэд зориулагдсан програм зэрэг олон шинэлэг эрх зүйн мэдлэг, мэдээлэл түгээх арга зам бий болсоор байна.

Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтыг зохион байгуулахад анхаарах асуудлын хувьд дараах зүйлийг анхаарах шаардлагатай байдаг. Үүнд:

- Зорилтот бүлгийн онцлогт тохирсон, тэдний эрэлт хэрэгцээнд нийцүүлэн тохиромжтой хэлбэрээр, нээлттэй, хүртээмжтэй, тасралтгүй түгээх;
- Ойлгомжтой энгийнээр бичих буюу иргэдэд ойлгомжтой, энгийн үг хэллэг ашиглах;
- Мэдээллийн дизайн /текст, зураг, график зэргийн балансыг хангах/;
- Хууль тоочих бус хуулийг тайлбарлах, мөн чанарыг нь ойлгуулах;
- Олон төрлийн арга, хэрэгсэл ашиглан харилцан адилгүй зорилтот бүлэгт мэдээлэл сурталчилгааг түгээх, сургалтыг зохион байгуулах;
- Бусад.

Дээрх хүрээнд судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөрийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээг Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 4 дүгээр хавсралтын дагуу дараах аргачлалаар хийлээ.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.legal.gov.mn

НЭГ. ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ, ЗАХИРГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Хүснэгт 1

А. “Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөр”ийг хэрэгжүүлснээр эдийн засгийн хөгжил, захиргааны үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөлөл	
1.Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэг-жүүлснээр нөлөө үзүүлэх зорилтот бүлэг болон бусад бүлэг	Эрх зүйн боловсрол олгохоор зорьж буй зорилтот бүлэг нь нийт ***иргэд*** байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Иргэний хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг зааснаар “Иргэн гэж иргэний эрх зүйн харилцаанд оролцогч- Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг ойлгоно”. Мөн эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтыг түгээх зорилтот бүлгийг дараах байдлаар ангилж болно. Үүнд:[3] 1. Нас, хүйс /хүүхэд, өндөр настан зэрэг/; 2. Сургагч багш, бизнес эрхлэгчид, хууль сахиулах байгууллагын ажилтан зэрэг; 3. Газар зүйн хүрээгээр /жишээ нь, алслагдмал газар амьдардаг иргэд/; 4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд; 5. Хүчирхийлэлд өртсөн хохирогч; 6. Гэмт хэрэгтэн; 7. Бусад. Үүний зэрэгцээ тодорхой бүлгийн эрэлт хэрэгцээнээс хамааран тодорхой сэдвийн дагуу жишээ нь , татвар, зээл, хөдөлмөр эрхлэлт, тэтгэвэр, гэрлэлт зэрэг асуудлын хүрээгээр зорилтот бүлгийг тодорхойлдог.
2. Эдийн засгийн хөгжил болон захиргааны үйл ажил-лагаанд үзүүлэх нөлөө	*1. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилт олон улсын болон үндэсний хэмжээний бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан байна. Үүнд:* 1.1. Олон улсын бодлогын баримт бичгүүд: - НҮБ-ийн гишүүн 193 орны хамтын шийдвэрээр 2015 онд батлагдсан “Тогтвортой хөгжил-2030” хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн зорилтын 16-д “Тогтвортой хөгжлийн төлөөх тайван, бүгдийг хамарсан нийгмийг дэмжих, шударга ёсыг бүгдэд хүртээмжтэй болгох, бүх түвшинд үр дүнтэй, хариуцлагатай, бүгдийг хамарсан тогтолцоог бий болгох” зорилт дэвшүүлсэн байна. Энэ нь эрх зүй, шударга ёсны хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэгдсэн юм. 1.2. Үндэсний хэмжээний бодлогын баримт бичгүүд: - “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”[4]-д “ядуурлын бүх төрлийг эцэс болгоно, хүний хөгжлийн өндөр үзүүлэлт бүхий 70 орны нэг болно, хөгжлийн бодлогоо бүх түвшинд хэрэгжүүлэх чадвартай, авилгаас ангид, иргэдийн оролцоог хангасан, мэргэшсэн тогтвортой засаглал төлөвшсөн байна” гэсэн зорилтуудыг тодорхойлсон байдаг. Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд иргэдийн эрх зүйн мэдлэг, чадавхийг дээшлүүлэх замаар шударга ёс, хууль ёсыг тэгш хүргэх явдал юм. - Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Засаглалын бодлого” зорилтын Шүүх эрх мэдлийн байгууллагын тогтолцоог боловсронгуй болгож, хүний эрх чөлөөний баталгааг хангах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд “5.3.7. Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлнэ”[5] гэж заасны дагуу энэхүү хөтөлбөр батлагдсанаар Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд тусгасан томоохон зорилтын нэг хэрэгжинэ. Монгол Улсын Засгийн газраас эрх зүйн шинэтгэл хийх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, мэдээлэх, сурталчлах талаар олон арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн байна. Эдгээрээс дурдвал, - “Эрх зүйн сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлыг сайжруулах тухай” Засгийн газрын 1993 оны 57 дугаар тогтоол; - “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахтай холбогдсон зарим арга хэмжээний тухай” 1996 онд батлагдсан Засгийн газрын 66 дугаар тогтоол; - “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр” Улсын Их Хурлын 1998 оны 18 дугаар тогтоол; - “Эрх зүйн сурталчилгааны дунд хугацааны хөтөлбөр” Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 67 дугаар тушаал; - “Эрх зүйн сурталчилгааг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө” Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 67 дугаар тушаал; - “Сум, дүүрэгт эрх зүйн хөтөч /ухуулагч/-ийн ажиллах журам” Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2011 оны 124 дүгээр тушаал; - “Хууль зүйн салбарын үйл ажиллагаанд холбогдох мэдээ, мэдээлэл бэлтгэж, олон нийтэд хүргэх журам” Хууль зүйн сайдын 2016 оны А/50 дугаар тушаал; - “Эрх зүйн мэдээлэл бэлтгэх, түгээх аргачлал” 2016 онд Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга баталсан зэрэг эрх зүйн баримт бичгийг тус тус батлан хэрэгжүүлж иржээ. *2. Захиргааны үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг урьдчилан тооцоолох:* 2.1. захиргааны үйл ажиллагааны нөлөө хэвээр үлдэхгүй, нэмэгдэж байгаа тул энэ хэсэгт хамаарахгүй. (-) 2.2. захиргааны үйл ажиллагааны нөлөө буураагүй нэмэгдэж байгаа тул энэ хэсэгт хамаарахгүй. (-)

[3] “Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалт: үр нөлөөтэй арга зам” сэдэвт судалгааны тайлан, /УБ: ХЗҮХ, 2017/.

[4] Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан

[5] Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан

2.3. Захиргааны үйл ажиллагааны нөлөө дараах байдлаар нэмэгдэж байна.

2.3.1. Энэхүү хөтөлбөр хэрэгжсэнээр төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд бүх нийтэд чиглэсэн эрх зүйн чиглэлийн мэдлэг, мэдээлэл түгээх, зөвлөх гэсэн томоохон үүрэг бий болж байна. Тиймээс төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааны нөлөө нэмэгдэхээр байна. Тухайлбал, хөтөлбөрт тусгаснаар төрийн болон төрийн бус байгууллагад үүсэх дараах үүргүүд байна. Үүнд:

1. Хууль зүй дотоод хэргийн яам:
   - Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах.
2. Хууль зүйн үндэсний хүрээлэн:
   - эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан / legalinfo.mn /, эрх зүйн цахим хөтөч /e-hutuch.mn/ -г эрхлэн хөтлөх;
   - эрх зүйн сургалт, сурталчилгааны агуулга /материал/ бэлтгэх /түгээх/ арга зүйг боловсруулж, батлуулах;
   - эрх зүйн хөтөч бэлтгэх;
   - иргэдэд зориулсан эрх зүйн анхан шатны сургалтын хөтөлбөр боловсруулж, батлуулах /хэрэгжүүлэх/;
   - бүх шатны боловсролын байгууллагаар дамжуулан хүүхэд, залуучуудад эрх зүйн боловсрол олгох, эрх зүйн ухамсрыг төлөвшүүлэхэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;
   - бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд шаардлагатай судалгаа хийх.
3. Төрийн бусад байгууллага:
   - хариуцсан салбарын хүрээнд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах;
   - хариуцсан салбарын хууль, эрх зүйн актуудыг олон нийтэд таниулахад чиглэгдсэн сургалт, сурталчилгааны материалыг нэгдсэн /батлагдсан арга зүйн дагуу бэлтгэж, хүргэх арга хэмжээ авах;
   - хэрэгжилтийн явцын мэдээллийг хагас жил, жилээр гарган Үндэсний зөвлөлд хүргүүлэх;
   - өөрсдийн мэргэшсэн чиглэлээр эрх зүйн сургалт, сурталчилгаа хийх, судалгаанд оролцох, өөрийн байгууллагын ажилтан, албан хаагчдын эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.
3. Бүх шатны Засаг дарга:
   - Бүх шатны засаг дарга, төрийн байгууллага жил бүр хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллах ба хөтөлбөрт тодорхой хугацаанд, тогтмол зохион байгуулагдахаар тусгагдсан арга хэмжээг оролцогч талуудын үйл ажиллагаатай уялдуулах замаар хамтран төлөвлөнө;
   - Бүх шатны засаг дарга, төрийн байгууллагууд эрхэлсэн асуудлын хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн мэдээлэл бэлтгэх, эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд оруулах, эрх зүйн хөтчийн үүрэг гүйцэтгэх ажилтантай болж, тогтвор суурьшилтай ажиллуулна.
4. Төрийн бус байгууллага:
   - төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагууд өөрсдийн мэргэшсэн чиглэлээр эрх зүйн сургалт, сурталчилгаа хийх, судалгаанд оролцох, өөрийн байгууллагын ажилтан, албан хаагчдын эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.

Эдгээр үүргүүдийг нэгтгэн үзвэл, ХЗДХЯ нэгдсэн удирдлагаар хангаж, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр, ХЗҮХ-нд хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажил үндсэндээ төвлөрч зохион байгуулагдахаар, төрийн болон төрийн бус байгууллагын хувьд мөн хөтөлбөрийг дэмжин ажиллах, өөрөөр хэлбэл байгууллага бүр өөрийн салбарын хүрээнд эрх зүйн хөтчийг бэлтгэн ажиллуулахаар заасан байгаа нь захиргааны хувьд үүсэх үүрэг нэлээд нэмэгдэхээр байгааг харуулж байна.

2.3.2. Хөтөлбөр хэрэгжсэнээр зорилтот бүлэг буюу иргэдэд дараах эерэг үр нөлөө үзүүлэхээр тусгагдсан байна. Үүнд:

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.legal.gov.mn

	1. Хөтөлбөрийн нийгэмд үзүүлэх үр нөлөө: - иргэд хаана, ямар нөхцөлд амьдарч байгаагаас үл хамааран хууль зүйн үйлчилгээ, мэдээллийг авах нөхцөл бүрдэнэ; - иргэд өөрийн хууль ёсны ашиг сонирхлоо хуулийн хүрээнд хамгаалах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх чадвар, боломж нэмэгдэнэ; - төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоо нэмэгдэж, иргэний ашиг сонирхол зөрчигдөж байгаа болон төрийн байгууллагаас гарах аливаа шийдвэр нь хууль ёсны эрх, ашиг сонирхолтой зөрчилдөнө гэж үзсэн тохиолдолд үзэл бодол байр сууриа илэрхийлэх чадвар нэмэгдэнэ; - бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, хамт олон, иргэний оролцоо, дэмжлэг сайжирна; - хууль дээдлэх зарчмыг төрийн үйл ажиллагаанд хэвшүүлэх, хуулийг хүндэтгэн сахин биелүүлэх талаар нийгмийн ухамсрыг дээшлүүлнэ. 2. Хөтөлбөрийн эдийн засгийн үр нөлөө: - иргэд өөрийн эрхийг баталгаажуулах, амьжиргаагаа дээшлүүлэх чадвар, боломж бололцоо нэмэгдэнэ; - иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хамгаалах, зөрчигдсөн эрхээ сэргээх иргэдийн чадвар нэмэгдсэнээр бусдын буруутай үйл ажиллагаанаас учрах эдийн засгийн хохирол буурна; - иргэдийн эрх зүйн боловсрол сайжирснаар хууль зүйн мэдээлэл, туслалцаа авахад хялбар болж, үр ашиггүй илүү зардал гаргахгүй болно; - эрх зүйн мэдээлэл, хууль зүйн туслалцаа үзүүлэх цахим сүлжээг нэвтрүүлснээр хууль зүйн мэдээлэл, туслалцааны бодит зардал буурна; - хуулийг хүндэтгэн сахин биелүүлэх иргэдийн ухамсар дээшилснээр гэмт хэрэг, зөрчил буурна. Дээрхээс дүгнэж үзвэл иргэд хууль зүйн анхан шатны зөвлөгөө үйлчилгээг өөрийн байгаа газраасаа зардал, чирэгдэл багатайгаар авах, цаг хугацааны хувьд хэдийд ч өөрт шаардлагатай хууль зүйн мэдээллийг түргэн шуурхай авч байх, иргэдийн хууль зүйн мэдлэг тодорхой түвшнээр нэмэгдэх, төрийн болон төрийн бус байгууллагуудын үүрэг хариуцлага нэмэгдэх нөхцөл бүрдэхээр байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.mlt.gov.mn

3. Бусад мэдээлэл	Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр зорилтот бүлгийн хувьд эдийн засгийн зардлын хэмжээ буурахаар байгаа бол хөтөлбөрийг хэрэгжүүлэх төрийн болон төрийн бус байгууллагын эдийн засгийн хувьд гарах зардлын хэмжээ нэмэгдэхээр байна. Энэ хэсэгт байгууллагуудад үүсэх эдийн засаг, хүний нөөцийн талаар авч үзлээ. Тухайлбал, Үндэсний зөвлөлийн ажлын алба нь ХЗҮХ байхаар хөтөлбөрт тусгасан. Одоогийн бүтэц бүрэлдэхүүнтэйгээр улсын хэмжээний энэхүү томоохон бодлогыг хэрэгжүүлэх хүндрэлтэй байхаар байгаа тул ХЗҮХ-ийн бүтэц бүрэлдэхүүнд тодорхой хэмжээгээр өөрчлөлт орохоор байна. /урьдчилсан төсөөлөл/ - ХЗҮХ-ийн сургалт, мэдээлэл, сурталчилгааны төв нь 13 ажилтны орон тоотой ажиллаж байгаа бол хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр ажлын ачаалал нэмэгдэх тул 7 ажилтны орон тоог нэмж ажиллуулахаар төсөл бэлтгэж хавсаргав. /ХАВСРАЛТ I/ - Цахим эрх зүйн хөтөч буюу e-khutuch.mn цахим санг цаашид хүрээлэнгийн бүтцийн нэгжид ажиллуулахаар төсөл боловсруулсан. Уг төслөөр 7 ажилтны орон тоотой байхаар төлөвлөж уг төслийг хавсаргав. /ХАВСРАЛТ II/ - Хууль зүйн судалгааны төв нь өнөөдрийн байдлаар 13 хүний бүрэлдэхүүнтэй, үүнээс 8 үндсэн ажилтан, 5 нь гэрээт ажилтан байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 2018-2022 он хүртэл “Иргэдэд тулгамдаж буй хууль зүйн үр дагавар бүхий асуудлыг тодорхойлох, эрх зүйн хэрэгцээ шаардлагын судалгаа”-г жил бүр, 2020, 2022 онуудад тус тус “Иргэдэд тулгамдаж буй асуудлыг хууль зүйн хувьд шийдвэрлэх бодлогын хувилбарыг тодорхойлох судалгаа”-г 2 жил тутамд, 2019-2022 онд “Цахим хэлбэрээр тодорхой сэдвээр судалгаа” хийх, хэлэлцүүлэг өрнүүлэх, 2020-2022 онд судалгаанд суурилсан хэлэлцүүлгийг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, олон нийтийн санал шүүмжийг авах, 2020 онд “Эрх зүйн хөтчийн үйл ажиллагаа, түүний үр дүнд мониторинг хийх” зэрэг судалгааны ажлыг гүйцэтгэхээр байна. эдгээрийг нэгтгэж үзвэл ойролцоогоор 12 судалгааны ажил хийж гүйцэтгэхээр байна. Хэрэв эдгээр судалгааг ХЗҮХ-ээр хийлгэхээр бол тус хүрээлэнгийн судалгааны төвийн бүтэц, бүрэлдэхүүний асуудлыг мөн анхаарч үзэх нь зүйтэй. Энэхүү судалгаа нь бүх нийтийг, өөрөөр хэлбэл, нийслэл, орон нутгийн бүхий л иргэдийг хамран хийгдэх тул цаг хугацаа, орон зайн хувьд нэлээд бэрхшээл тулгарч болзошгүй. Тиймээс ХЗСТ-ийн бүтцэд өөрчлөлт оруулах төслийг мөн хавсаргав. /ХАВСРАЛТ III/ - Засаг захиргааны нэгж бүрд эрх зүйн хөтөч ажиллуулах үйл ажиллагааны хүрээнд засаг захиргааны нэгж бүрд 1-ээс доошгүй эрх зүйн хөтөчтэй болсон байна гэж үзвэл, аймаг - 21 дүүрэг - 9 сум - 330 хороо - 152 баг - 1613 байна. Эдгээр нэгжид доод тал нь нэг эрх зүйн хөтөч байхаар тооцвол ***2125*** эрх зүйн хөтөч бэлтгэж, албан ёсоор ажлын байрны тодорхойлолтод нь нэмэлт, өөрчлөлт оруулах замаар энэхүү ажил үүргийг хариуцуулж өгөх шаардлагатай. - Төрийн байгууллагуудад мэргэшсэн эрх зүйн хөтөч бэлтгэх үйл ажиллагааны хүрээнд төрийн байгууллагууд өөрийн үйл ажиллагааны чиглэлээр мэргэшсэн эрх зүйн хөтөчтэй болсон байна гэж үзвэл 2016 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд төсөвт байгууллага 4278 байна.[6] Байгууллага бүр өөрийн одоогийн нөөц боломждоо нийцүүлэн хуулийн хэлтсийн ажилтан, мэргэжилтэн гэх мэт аж илтныхаа ажлын байрны тодорхойлолтод нь нэмэлт, өөрчлөлт оруулах замаар энэхүү ажил үүргийг нэмж хариуцуулж өгөх шаардлагатай.

[6] Монгол Улсын хэмжээнд төсөвт байгууллага 4278 байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ АЛБА
www.legal.gov.mn

ХОЁР. ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН НИЙГМИЙН ХӨГЖИЛД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Хүснэгт 2

Б. Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөрийн нийгмийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл

1. Хөтөлбөрийн нөлөө үзүүлэх нийгмийн бүлэг

Гадаадын зарим оронд иргэдийн эрх зүйн ухамсар, мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг ерөнхийд нь иргэдийн эрх зүйн боловсрол (public legal education)-ыг дээшлүүлэх болон иргэдэд эрх зүйн мэдээлэл түгээх (public legal information) хэмээн ангилдаг байна.[7] Эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг үр дүнтэй явуулахад дараах хүчин зүйлс нөлөөлөх нь зайлшгүй юм. Тухайлбал, нийгмийн болоод эдийн засгийн байдал, ядуурал, эрх зүйн соёл, ухамсар, газар зүйн байршил, хүн амын нягтаршил, хүн амын боловсролын түвшин, эрх зүйн боловсрол олгох чанар, эрх зүйн боловсрол олгох мэргэжлийн боловсон хүчний чадвар, тоо гэх мэт байж болох юм. Эрх зүйн боловсролыг түгээхдээ зорилтот бүлгийн хэрэгцээ, онцлогт нийцүүлэн харилцан адилгүй арга замаар мэдээлэл түгээх нь үр дүнтэй болох юм. Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөр нь бүх нийт буюу иргэдийг аливаа шалгууруар ангилахгүйгээр тэдэнд бүгдэд нь чиглэгдэж байгаа учраас нийтийг хамрах зорилготой. Харин үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ иргэдийнхээ хэрэгцээ шаардлагыг дараах байдлаар ангилан тэдэнд түгээх мэдлэг мэдээллийн хэлбэр төрлөө өөр өөр байхаар зохицуулж болох юм. Тухайлбал,

- нас, хүйс /хүүхэд, залуучууд, өндөр настан гэх мэт/;
- газар зүйн хүрээгээр /алслагдмал газар амьдардаг иргэд эсхүл орон нутагт амьдардаг иргэд, нийслэлийн иргэд/;
- эрхэлж буй ажил мэргэжлээр нь /төрийн албанд ажиллагсад, хувийн хэвшлийн ажиллагсад, малчид гэх мэт/
- хөгжлийн бэрхшээлтэй иргэд;
- хүчирхийлэлд өртсөн хохирогч;
- ажилгүйчүүд;
- гэмт хэрэгтэн гэх мэт.

Хөтөлбөрийг 2018-2023 онд 5 жилийн хугацаанд 2 үе шаттай хэрэгжүүлнэ.

- 1 дүгээр үе шат /2018-2020 он/-нд бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

Энэхүү үе шатанд хөтөлбөрийг хэрэгжүүлэх бүхий л бэлтгэл ажил хангагдан хэрэгжиж эхэлнэ /эрх зүйн хөтчөө бэлтгэх, сургах, e-hutuch цахим сайтыг бэлэн болгох, хууль зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгааны агуулгыг боловсруулах өөрөөр хэлбэл, хүний нөөц, техник тоног төхөөрөмжийн нөөц гэх мэт ажлыг хийж гүйцэтгэсэн байна/.

- 2 дугаар үе шат /2021-2023 он/-нд эхний шатны үйл ажиллагаанд үнэлгээ хийж, бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2018-2020 онд хийгдсэн ажилдаа үнэлгээ өгч цаашид анхаарах асуудлыг тодорхойлж тэдгээрийг хэрхэн зохицуулж боловсронгуй болгох талаар арга хэмжээ авна.

2. Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр нийгэмд ямар нөлөө үзүүлэхийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

2.1. Хүмүүсийн амьдралын хэв маягт дараах байдлаар нөлөөлөхөөр байна.

- хүн бүр өөрийн гэсэн цахим хуулийн зөвлөхтэй болно гэж үзэж болохоор байна.
- эдийн засгийн хувьд иргэдийн ачааллыг багасгана. Жишээлбэл, зайнаас хууль зүйн анхан шатны мэдлэг, мэдээлэл, зөвлөгөөг авч болохоор e-hutuch цахим сайт ажиллана.
- цахим орчноос энэхүү үйлчилгээг авах бололцоогүй иргэдэд зориулан эрх зүйн хөтөч нар аймаг, нийслэл, сум, дүүрэг, төрийн болон төрийн бус байгууллагуудад заавал ажиллахаар зохицуулалт орсон.
- иргэдийн хандалтад дүн шинжилгээ хийж тэдний хэрэгцээ, шаардлагыг цаг алдалгүй богино хугацаанд тодорхойлж, хаана ямар асуудлыг зохицуулах шаардлага, хэрэгцээ байна вэ гэдгийг олж харж тэр чиглэлд нь тухайн асуудлыг шийдвэрлэх арга замыг түлхүү оруулж өгөх, сургалт, сурталчилгааг явуулна.
- энэ мэтчилэн өөрийн хэрэгцээт мэдээ, мэдээллийг авснаар иргэдийн хууль зүйн мэдлэг чадвар дээшилнэ.
- хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслалцаа үзүүлэх эрх зүйн хөтчийг тусгайлан бэлтгэнэ. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй иргэд хууль зүйн мэдлэг, мэдээллийг өөрт төв багтайгаар авах боломж нээгдэнэ.
- зайнаас сургалт зохион байгуулах ажлыг түлхүү ашиглана. Ингэснээр аль аль талдаа эдийн засаг хийгээд бусад зардал, чирэгдэл багасна.
- Иргэд хууль зүйн зөвлөгөөг үнэ төлбөргүйгээр авна.

1.2. Хүмүүсийн соёлд дараах байдлаар нөлөөлнө. Үүнд:

- хууль дээдлэх зарчмыг төрийн үйл ажиллагаанд хэвшүүлэх, хуулийг хүндэтгэн сахин биелүүлэх талаар нийгмийн ухамсар дээшлэнэ.
- хуулийг хүндэтгэн сахин биелүүлэх иргэдийн ухамсар дээшилснээр гэмт хэрэг, зөрчлийн гаралт буурах магадлал өндөрсөнө.

1.3. Хүмүүсийн амьдардаг суурин болон нийгмийн бүлэгт ямар нөлөө үзүүлэх (уялдаа, тогтвортой байдал, шинж чанар, үйлчилгээ, байгууламж);

- орон нутаг бүрд эрх зүйн хөтөч ажиллах учраас тухайн орон нутгийн иргэдийг хамарсан сургалт, сурталчилгаа, зөвлөгөө тасралтгүй үргэлжлэн тогтмол зохион байгуулагдаж байна.

1.4. Хүрээлэн буй орчинд ямар нөлөө үзүүлэх

[7] "Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалт: үр нөлөөтэй арга зам" сэдэвт судалгааны тайлан, /УБ: ХЗҮХ, 2017/.

3. Бусад мэдээлэл	e-hutuch цахим сайт ажиллаж эхэлснээр: - иргэд хууль зүйн холбогдолтой мэдээллийг нэг дороос авах боломж бүрдэнэ; - иргэд хэрэгцээтэй, шаардлагатай байгаа хууль зүйн мэдээллээ цахимаар хэдийд ч авах боломж нээгдэнэ; - хүн бүр өөрийн гэсэн хуулийн зөвлөхтэй болж байна гэж үзэж болохоор байна; - ухаалаг төхөөрөмжөөр дамжуулан мэдээлэл авах боломжтой болно; - анхан шатны зөвлөгөөг заавал хуульчаас авах шаардлагагүй болно; - зардал багасна; - хууль зүйн мэдээлэл иргэдэд илүү хүртээмжтэй болно; - энэхүү цахим программ нь анализ, дүн шинжилгээг өөрөө хийнэ. Иргэдийн хэрэгцээ шаардлагын судалгааг үүгээр дамжуулан хийж болно; - сайтын мэдээллүүд маш нарийвчлалтай гарна; - сайтын мэдээлэл нь баталгаатай эх сурвалж байна гэх мэт давуу талыг нийгэмд, иргэдэд үзүүлэхээр байна; - төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, чиг үүрэг иргэдэд илүү нээлттэй, хүртээмжтэй болно.

ГУРАВ. ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ДАГАЖ МӨРДӨЖ БАЙГАА ХУУЛЬ ТОГТООМЖ БОЛОН ЭХ ЗҮЙН ТОГТОЛЦООНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Хүснэгт 3

В. Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж болон эрх зүйн тогтолцоонд үзүүлэх нөлөө	
1. Бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль, эрх зүйн акт	**Хууль зүйн тусламжийн тухай хууль** Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 132 дугаар зүйлд “Хууль зүйн тусламжийн тухай хууль”-ийг боловсруулан батлахаар заасан байна. 2013 онд батлагдан хүчин төгөлдөр мөрдөж буй “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн тусламжийн тухай хуулийг шинэчлэн найруулж “Хууль зүйн тусламжийн тухай хууль”-ийг батлах бөгөөд хуульд бүх нийтэд эрх зүйн боловсрол олгох тогтолцоог бий болгох, иргэдэд хууль зүйн үйлчилгээ үзүүлэх хэлбэрийг хуульчлан тогтоохоор заасан байна. Уг хуульд тусгавал зохих зохицуулалтыг ерөнхийд нь авч үзвэл: - бүх нийтийн эрх зүйн боловсрол олгох үндсэн тогтолцоо, суурь бүтцийг тодорхойлох; - иргэдэд хууль зүйн үйлчилгээ үзүүлэх хэлбэрийг тогтоох; - бүх улсын өмгөөлөгчдийг сургалтад үе шаттай хамруулж, эдгээр сургалтыг хуульчийн үргэлжилсэн сургалтын кредит цагт тооцдог болох. **Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль** Түс хуулийн 24 дүгээр зүйлд Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны төрлийг заасан байна. Хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д “Хуульч нь дараах мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэн явуулна: 24.1.1.хууль зүйн асуудлаар амаар болон бичгээр лавлагаа, зөвлөгөө өгөх” хэмээн тусгажээ. Түс зохицуулалтаар хууль зүйн асуудлаар зөвлөгөө өгөх нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд хамаарах бөгөөд бусад этгээд эрхлэх боломжгүй мэт харагдаж байна. Иймд Хөтөлбөрийн 4.1.7-д заасан хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд хууль зүйн зөвлөгөөг зөвхөн хуульч төдийгүй бусад эрх зүйн сургалтад хамрагдсан этгээд үзүүлэх боломжтой байхаар тус зохицуулалтыг өөрчлөн найруулах нь зүйтэй байна. **Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хууль** Бүх нийтийн эрх зүйн боловсрол олгох хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг дэмжих зорилгоор аж ахуйн нэгж, иргэнээс хандивласан зохих хэмжээний төгрөгийг тухайн татварын жилд уг аж ахуйн нэгжийн албан татвар ногдох орлогоос хасаж тооцох гэх мэт татварын хөнгөлөлт үзүүлэх зохицуулалтыг судлах нь зүйтэй. Энэ нь иргэн, аж ахуйн нэгжээс хөрөнгө төвлөрүүлэх, идэвх санаачлагыг дэмжих эерэг талтай байна. **Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай**

	Тус хуулийн 15 дугаар зүйлд өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хариу өгөх зохицуулалтыг хуульчилсан. Ингэхдээ өргөдөл гомдлын хариуг өгөх хэлбэр болон хугацааг дурджээ. Дээрх агуулгад нэмж шаардлагатай тохиолдолд “өргөдөл гомдлын үндэслэлийг дэлгэрэнгүй тайлбарлах, өргөдөл, гомдлын хариуг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд үргэлжлүүлэн хэнд хандах, энэ талаар мэдээлэл, зөвлөгөө авах бол хэрхэн авах арга зам бүхий мэдээллийг нэмж тусгуулах” нь ач холбогдолтой байж болохоор байна. **Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай** Хөтөлбөрийн 4.1.2-т “Нийт иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангасан, зорилтот бүлэгт тухайлбал, харааны болон сонсголын бэрхшээлтэй иргэн, өндөр настанд эзлэтэй, хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон эрх зүйн боловсролын агуулгыг бий болгох”-д чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэхийг тусгасан байна. Энэ хүрээнд зорилтод бүлгийн иргэдэд чиглэсэн эрх зүйн боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих зорилгоор дараах хууль тогтоомжид нэмэлт зохицуулалт оруулах боломжтой. Үүнд: - Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль; - Жендерийн тухай хууль; - Хүүхдийн эрхийн тухай хууль гэх мэт. **Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль** Нийгмийн сүлжээ болон бусад хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гэмт хэргийг сурталчилсан, өдөөсөн, уриалан дуудсан, иргэдэд эрх зүйн худал мэдлэг олгосон, хууль зөрчсөн мэдээллийг ялгаж таних, холбогдох байгууллагад хандах чадварыг олгоход чиглэсэн зохицуулалтыг тус хуульд нэмж оруулах боломжтой байна. **Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль** Олон нийтэд болон гэр бүлийн гишүүдэд гэр бүлийн хүчирхийллийн талаарх ойлголтыг түгээх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцох бололцоог дэмжсэн зохицуулалтыг тусгах нь ач холбогдолтой. Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд мөрдөгдөх дараах журмыг боловсруулах шаардлагатай. Үүнд: - Үндэсний зөвлөлийн дүрэм, болон Үндэсний зөвлөлийн ажиллах журам */Тус байгууллагын бүтэц, зохион байгуулалт, орон тоо, үйл ажиллагааны журмыг зохицуулна/;* - Эрх зүйн хөтчийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх журам; - Эрх зүйн мэдээлэл, сургалт сурталчилгаа, судалгаанд мэдээллийн технологийг ашиглах журам болон аргачлал; Мэдээллийн нэгдсэн сан legalinfo.mn-ийн хүртээмжийг нэмэгдүүлэн хөгжүүлэлт зорилгоор журамд нэмэлт, өөрчлөлт оруулах.
2. Хариуцах байгууллага	**Хууль зүйн туслалцааны төв** Хөтөлбөрийн 4.3-д заасан “Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд бүх талын идэвхтэй оролцоог хангаж, тэдний үйл ажиллагааг уялдуулна” гэсэн зорилтын хүрээнд нийслэл болон хөдөө орон нутагт эрх зүйн сургалт, сурталчилгаа явуулах этгээдэд дараах субъектүүд хамаарна. Үүнд: - Орон нутгийн засаг захиргааны байгууллагууд; - Хууль зүйн туслалцааны төвийн орон нутаг дахь салбар. **Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль** - Хууль зүй, дотоод хэргийн яам; - Монголын хуульчдын холбоо; - Хуулийн сургуулиуд болон төрийн бус байгууллагуудын дэргэдэх хуулийн клиник төв; - Өмгөөлөгчид. **Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль** Тус хуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг дараах байгууллага гүйцэтгэнэ. - Хууль зүй, дотоод хэргийн яам, Үндэсний зөвлөл. **Боловсролын тухай, Бага дунд боловсролын тухай, Дээд боловсролын тухай тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай** Холбогдох зохицуулалтыг дараах байгууллага хариуцан гүйцэтгэнэ. Үүнд: - Хууль зүй, дотоод хэргийн яам; - Боловсролын яам; - Үндэсний зөвлөл.

Хууль зүйн яамны хүрээлэн www.legalinfo.mn

	Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хууль Холбогдох зохицуулалтыг дараах байгууллага хариуцан гүйцэтгэнэ. Үүнд: - Сангийн яам; - Татварын ерөнхий газар. **Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай** Холбогдох зохицуулалтыг дараах байгууллага хариуцан гүйцэтгэнэ. Үүнд: - Хууль зүй, дотоод хэргийн яам. **Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Жендерийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль** Холбогдох зохицуулалтыг дараах байгууллага хариуцан гүйцэтгэнэ. Үүнд: - Хөдөлмөр, нийгмийн хамгаалллын яам; - Хууль зүй, дотоод хэргийн яам; - Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар; - Үндэсний зөвлөл. **Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль** Холбогдох зохицуулалтыг дараах байгууллага хариуцан гүйцэтгэнэ. Үүнд: - Хууль зүй, дотоод хэргийн яам; - Цагдаагийн ерөнхий газар. **Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль** Холбогдох зохицуулалтыг дараах байгууллага хариуцан гүйцэтгэнэ. Үүнд: - Хууль зүй, дотоод хэргийн яам; - Үндэсний зөвлөл. **Боловсролын тухай, Бага дунд боловсролын тухай, Дээд боловсролын тухай тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль** Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дэмжих зорилгоор холбогдох зохицуулалтыг оруулах эсэхийг анхаарч судлах. **Үндэсний зөвлөлийн дүрэм болон Үндэсний зөвлөлийн ажиллах журам** Холбогдох зохицуулалтыг дараах байгууллага хариуцан гүйцэтгэнэ. - Хууль зүй, дотоод хэргийн яам.

ДӨРӨВ. ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ОДООГИЙН БАЙДЛААР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА БАЙГУУЛЛАГЫН (ИНСТИТУЦИЙН) ТОГТОЛЦООНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Хүснэгт 4

Г. Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр одоогийн байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын (институцийн) тогтолцоонд үзүүлэх нөлөө	
1. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд оролцох байгууллагууд	Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцож болох субъектүүд: - Хууль зүй, дотоод хэргийн яам; - Үндэсний зөвлөл; - Хууль зүйн үндэсний хүрээлэн; - Төрийн бусад яам, агентлагууд; - Төрийн бус байгууллагууд

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.mojha.gov.mn

2. Төрийн удирдлагын үйл ажиллагаа, бүтцэд үзүүлэх нөлөө (шинээр бүтэц бий болох, өнөөгийн институцийг татан буулгах, эсхүл бүтцийг өөрчлөн байгуулах)	Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангана. Хөтөлбөр нь үндэсний хэмжээнд өргөн хүрээнд хэрэгжих тул дагнасан чиг үүрэг бүхий байгууллага хяналт тавих нь тохиромжтой. Өөрөөр хэлбэл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд эрх зүйн боловсролын агуулгын нэгдсэн байдал, салбар дундын уялдаа холбоог хангах, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавих чиг үүрэг бүхий бүх нийтийн эрх зүйн боловсролын орон тооны бус Үндэсний зөвлөл ажиллах нь тохиромжтой байна. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд хууль зүй, боловсрол, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн салбар, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөл оролцсон байна. Хөтөлбөрийн 7.3-т Үндэсний зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа байгууллага Хууль зүйн үндэсний хүрээлэн гүйцэтгэхээр заасан байна. Тус байгууллага нь хууль тогтоомжийн төлөв байдал, хандлага, хэрэгцээ, үр нөлөөг судалж, эрдэм шинжилгээний зөвлөмж, аргачлал боловсруулах, хууль тогтоомжийн төсөлд шинжлэх ухааны санал, дүгнэлт өгөх, хууль эрх зүйн сургалт, сурталчилгаа, мэдээллээр үйлчлэх, хууль тогтоомжийн бүртгэл, системчлэл, мэдээлэл, сурталчилгааг зохион байгуулах, эрдэм шинжилгээ, сургалт судалгааны чиг үүрэг бүхий байгууллага юм. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/67 дугаар тушаалаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлийг баталсан. Тушаалд захиргааны хэлтсийн 5 ажилтан, Хууль зүйн сургалт, мэдээлэл, сурталчилгаа болон хэвлэх үйлдвэрийн 13 ажилтан, хууль зүйн судалгааны төвийн 14 ажилтантай байхаар тусгажээ. Тус байгууллагын гүйцэтгэж буй ажлын ачаалал өндөр байдгийг Үйл ажиллагааны жилийн тайлангаас харж болно. Хөтөлбөрийн ажлын албаны чиг үүргийг гүйцэтгэх нь өргөн хүрээний ажил тул тус хүрээлэн одоогийн бүтцээр дээрх чиг үүргийг нэмж гүйцэтгэх боломжгүй байна. Иймд бүтэц орон тоог нэмэх шаардлагатай болно.
3. Хүний нөөцөд үзүүлэх нөлөө	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн бүтэц, орон тоог нэмэгдүүлэхгүйгээр Хөтөлбөрийн ажлын албаны чиг үүргийг гүйцэтгэх нь боломжгүй болно.

ТАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Бүх нийтийн эрх зүйн боловсролын асуудлыг боловсронгуй болгох, нэгдсэн нэг системд оруулах зорилтын хүрээнд үе шаттай, дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага өнөөгийн нийгэмд зайлшгүй тулгарч байна. Хөтөлбөрийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд үндэслэн дараах дүгнэлтэд хүрч байна. Дүгнэлт болон дэвшүүлэх саналаа 4 бүлгээр тус тусд нь гаргав.

Нэг. Эдийн засгийн хөгжил, захиргааны үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөлөл

Иргэд хаанаас, хэзээ ч өөрт шаардлагатай хууль зүйн мэдээллийг цаг алдалгүй, бага зардлаар олж авах орчин бүрдэж байна. Өөрөөр хэлбэл, цахим орчноор дамжуулан ухаалаг төхөөрөмж ашиглан хэрэгцээт мэдээллээ олж авах төдийгүй өөрийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох судалгаанд цахимаар хамрагдах бүрэн боломж нээгдэхээр байна. Нөгөө талаас төрийн байгууллага цаг хугацаа, зардлаа хэмнэж иргэдийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох судалгааг цахим хэлбэрээр зохион байгуулж үйл ажиллагааны цаашдын чиглэлийг урьдчилан тандан судлах боломж бүрдэж байна.

Энэхүү хөтөлбөр хэрэгжүүлэхээр чиглэж буй зорилтот бүлгийн хувьд гарах зардал буурах, тэдэнд үүсэх ачаалал багасахаар харагдаж байгаа ч төрийн болон төрийн бус байгууллагын хувьд тэнд үүсэх ачаалал, зардал нэмэгдэхээр харагдаж байна. Тухайлбал, ХЗҮХ дээр энэхүү хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа төвлөрч, бусад байгууллагуудын хувьд дотооддоо заавал эрх зүйн

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.jli.gov.mn

хөтөч бэлтгэн ажиллуулах үүрэгтэй болж байна. Мөн e-khutuch цахим сайтын үйл ажиллагааг ХЗҮХ-ийн нэгжид хариуцуулан ажиллуулахаар төсөөлж байгаа нь тус хүрээлэнгийн бүтэц, бүрэлдэхүүнд зайлшгүй өөрчлөлт оруулах шаардлагыг үүсгэж байна.

Дээрх дүгнэлтэд үндэслэн ХЗҮХ-ийн бүтцэд өөрчлөлт оруулах саналыг урьдчилан төсөөлж энэхүү тайланд хавсралтаар оруулсан. Урьдчилсан төслийг товч авч үзвэл, ХЗҮХ-ийн Сургалт, мэдээлэл, сурталчилгааны төвийн одоогийн орон тоо 13 байгааг 6-аар нэмж 19 болгох, мөн энэхүү төвд e-hutuch.mn цахим сангийн үйл ажиллагааг хариуцсан 7 орон тоо бүхий нэгж бий болгох, Хууль зүйн судалгааны төвийн одоогийн орон тоо 14 байгааг 13-аар нэмж 27 болгох гэсэн байдлаар бэлтгэсэн.

Бүх шатны төрийн байгууллагуудад өөрийн эрх зүйн хөтчийг бэлтгэн ажиллуулах гэж заасан учраас тухайн байгууллагууд холбогдох албан тушаалтныхаа ажлын байрны тодорхойлолтод нэмэлт, өөрчлөлт оруулах замаар эрх зүйн хөтчийн ажлыг хариуцуулж өгөх шаардлагатай.

Хоёр. Нийгмийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл

Хөтөлбөрийг хэрэжүүлэхэд бүх шатны төрийн байгууллага болон төрийн бус байгууллага дэмжин оролцохоор заасан /эрх зүйн хөтөчтэй болох/ нь хууль зүйн мэдлэг, мэдээлэл, зөвлөгөө хүргэх асуудал иргэдэд ойр байж, тэгш, хүртээмжтэй байх нэг боломжийг бүрдүүлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн хөтчийг тусгайлан бэлтгэж ажиллуулахаар заасан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд төвөг багатайгаар мэдээлэл, зөвлөгөө олж авах орчин бүрдэж байгаа юм.

Зайнаас хууль зүйн мэдээ, мэдээлэл олж авах, зөвлөгөө, сургалтад хамрагдах боломж бүрдэнэ. Ингэснээрээ иргэд өөрсдийн хэрэгцээ шаардлагын талаарх мэдээллийг цахим хэлбэрээр судалгаанд хамрагдан өгөх боломж нээгдэх юм.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд хууль зүйн нэгдсэн цахим сан болох “e-hutuch”-ийн үйл ажиллагааг тогтмолжуулах, хариуцаж буй мэргэжилтэнг мэргэшүүлэх, программын шинэчлэлийг байнга хийж байх шаардлагатай.

Иргэдэд зориулан бэлтгэж байгаа гарын авлага, тараах материал, сурталчилгаа болон сургалтын хөтөлбөрийг зорилтод бүлгийнхээ хэрэгцээ шаардлагаар ангилан тодорхой хэсэг бүлэг болгон тус бүрд тохирсон байдлаар боловсруулж байх, тэдэнд ойлгоход хялбар, энгийн, хууль зүйн хэллэгээс аль болох татгалзсан байвал илүү үр дүнтэй.

Гурав. Хууль тогтоомж болон эрх зүйн тогтолцоонд үзүүлэх нөлөөлөл

Энэхүү хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр зарим хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах нөхцөл байдал үүсч байгаа тул тэдгээр хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах шаардлагатай. Тухайлбал, Хууль зүйн туслалцааны тухай хууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Аж ахуй нэгжийн албан татварын тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Жендерийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Сургуулийн

өмнөх боловсролын тухай хуулиуд тодорхой хэмжээгээр нэмэлт, өөрчлөлт оруулахаар байна.

Дөрөв. Одоо үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын тогтолцоонд үзүүлэх нөлөөлөл

Хөтөлбөрийн төсөл боловсруулагчдын төсөөллөөр байгууллагуудад дарамт учруулахгүйгээр одоогийн нөөц бололцоогоор үйл ажиллагаа явагдана гэсэн төсөөлөлтэй байна. Өөрөөр хэлбэл, бүх шатны төрийн байгууллагууд одоогийн байгаа нэг албан тушаалтны ажил үүрэгт эрх зүйн хөтчийн үйл ажиллагааг давхар хариуцуулан өгч ажиллуулахаар тусгасан байна.

Хөтөлбөр аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо гэсэн засаг захиргааны бүхий л нэгжийг хамран өргөн хүрээнд хэрэгжихээр төлөвлөсөн бөгөөд хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын албаны болох ХЗҮХ одоогийн бүтцээр ажлын албаны чиг үүргийг гүйцэтгэхэд хүндрэл учирч болзошгүй байна. Тиймээс ХЗҮХ-ийн бүтэц, орон тоог нэмэгдүүлэх тал дээр анхаарах шаардлагатай.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ЭХ СУРВАЛЖ

Нэг. Хууль тогтоомж

1. Монгол Улсын Иргэний хууль
2. Хууль зүйн туслалцааны тухай хууль
3. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль
4. Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хууль
5. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай
6. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай
7. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль
8. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
9. Боловсролын тухай хууль Бага дунд боловсролын тухай хууль
10. Дээд боловсролын тухай тухай хууль
11. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль
12. Сургуулийн өмнөх боловсролын тухай
13. Жендерийн тухай хууль
14. Хүүхдийн эрхийн тухай хууль
15. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
16. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр
17. Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам

Хоёр. Бусад

1. “Эрх зүйн боловсрол олгох, мэдээлэл түгээх үр нөлөөтэй арга хэлбэр” сэдэвт судалгаа/УБ: ХЗҮХ, 2017/.
2. Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөрийн танилцуулга /танилцуулах илтгэл, асуулт хариулт/

Гурав. Цахим хуудас

1. https://www.nso.mn/
2. http://www.1212.mn

---o0o---

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ[1]

НЭГ. МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТИЙН ТАЛААР БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

2001 онд Монгол Улсын нэгдэн орсон “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг” Нэгдсэн Үндэстний байгууллагын конвенцийн 1 дүгээр зүйлийн “m” хэсэгт, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын **хууль бус эргэлт** гэж энэхүү конвенцийн 3 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг ойлгохоор заасан ба эдгээр гэмт хэрэгт дараах зүйлүүдийг хамруулахаар тусгасан байна. Үүнд:

-мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх, гаргаж авах, бэлдэх, санал болгох, худалдахаар санал болгох, түгээх, худалдах, ямар ч нөхцлөөр хамаагүй хүргэх, зуучлах, илгээх, дамжуулан өнгөрүүлэх, тээвэрлэх, экспортлох, импортлох;

-мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг үйлдвэрлэх зорилгоор опиумын намуу, кока бут, каннабис ургамлыг тариалжуулах, үйлдвэрлэх мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг бэлтгэхэд зориулагдсан тоног төхөөрөмж эд зүйлсийг бэлтгэх, тээвэрлэх, түгээх;

-дээр дурдсан гэмт хэргийг удирдах, санхүүжүүлэх, зохион байгуулах, хууль

бус эх үүсвэрийг халхавчлах, нуун дарагдуулах, хувиргах, шилжүүлэх, олж авах;

-мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар хэрэглэхэд олон

нийтийг өдөөн хатгах, уриалах.

Дээрх конвенцид нэгдэн орсон улс орны тухайд уг асуудлуудыг эрүүгийн хуульдаа тусгах үүрэг хүлээдэг ба манай улсын хувьд эрүүгийн хуулийн тусгай ангийн 188, 192-196 дугаар зүйлд эдгээр асуудал тусгагдсан байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн байдалд нөхцөл байдлын дүн шинжилгээ хийхийн тулд юуны өмнө ЗГ-ын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан журмын Дөрөв дэх хэсэгт заасныг үндэслэн 1994 оноос хойш УИХ, ЗГ-аас батлагдсан нийт 265 бодлогын баримт бичиг[2]-ийг судалж үзэв.

Судалгаанаас харахад уг асуудлаар үндэсний хэмжээний бие даасан хөтөлбөр батлагдаагүй байна. Харин бусад чиглэлээр УИХ, ЗГ-ын батлагдсан 10 орчим бодлогын баримт бичигт энэхүү асуудалтай холбоотой цөөн тооны арга хэмжээ тусгагдсан байна. Хүснэгтээр тодруулбал:

[1] Тус судалгааг эрдэм шинжилгээний ахлах ажилтан М.Төрбаяр ахлан, эрдэм шинжилгээний ажилтан М.Цэдэвсүрэн, Б.Алтангэрэл, У.Буянтогтох нар хамтран гүйцэтгэв.

[2] http://legalinfo.mn/advenced-search. 1994 оноос хойш батлагдсан 265 үндэсний хөтөлбөрийн хүрээнд судалсан болно.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн талаар бодлогын баримт бичигт тусгагдсан асуудлууд

д/д	Тогтоолын нэр	Огноо, дугаар	Бодлогын баримт бичгийн нэр	Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ	Хэрэгжүүлэх байгууллага
Улсын Их Хурлын тогтоол					
1	Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай	2010 оны 48 дугаар тогтоол	Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал	3.1.3.4. Цус ойртолтыг багасгах, архидан согтууралт, мансууралтай тэмцэх ажлыг эрчимжүүлж, **хүн амын удмын санд учрах сөрөг нөлөөллийг бууруулах**аар; 3.4.4.3. Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих, **хууль бус хэрэглээтэй тэмцэх үндэсний чадавхийг бэхжүүлнэ**.	Цагдаагийн байгууллага
2	Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого батлах тухай	2015 оны 12 дугаар тогтоол	Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого /2014-2024 он/	2.1.10. ...мансууруулах бодис, хүн болон байгаль орчинд ноцтой сөрөг нөлөө үзүүлэхүйц **үйлдвэрлэл, ажил, үйлчилгээг зохион байгуулахыг хориглох**.	Уг бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны Байнгын хорооны даргад үүрэг болгосон.
Засгийн газрын тогтоол					
1	“Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр” батлах тухай	2006.11.21, №282	Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр	3.15.5. архи, тамхи, мансууруулах бодист донтсон залуучуудыг эмчлэх, нөхөн сэргээх, хор нөлөөг бууруулах үйлчилгээг **хувийн хэвшил, төрийн бус байгууллагын оролцоотойгоор хөгжүүлэх.**	НХХЯам хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг ЗГ-т танилцуулах, НХХЯаманд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан ирүүлэх байгууллага: -Засгийн газрын холбогдох гишүүн, -Аймаг, Нийслэлийн засаг дарга,

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nji.gov.mn

2	Журам батлах тухай	2010 оны 277 дугаар тогтоол	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн эргэлтэд хяналт тавих зорилгоор мэдээлэл солилцон хамтран ажиллах журам	2.1.1. хөрш зэргэлдээ улс болон олон улсын хэмжээнд үйлдэгдэж байгаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын **хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн нөхцөл байдлын талаархи мэдээ, мэдээллээр** цагдаа, тагнуулын байгууллагыг тухай бүрт хангаж ажиллахаар; 2.5.2. хөрш зэргэлдээ болон бүс нутаг, олон улсын хэмжээнд үйлдэгдэж байгаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой **гэмт хэргийн нөхцөл байдлын тухай мэдээ, мэдээллээр** холбогдох бусад байгууллагыг хангахаар; 2.8.2. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд болон мансууруулах бодисын үйлдвэрлэлд ашиглагддаг бодисыг **улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлж, гааль, мэргэжлийн хяналтын** байгууллагатай мэдээлэл солилцон хамтран ажиллах.	Гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага Тагнуулын байгууллага Хил хамгаалах байгууллага
3	Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр батлах тухай	2010 оны 289 дугаар тогтоол	Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр	1.3.9. “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хяналт” гэж хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг **агаарын хөлгөөр хууль бусаар тээвэрлэхэд тавих хяналт,** шалгалтын арга хэмжээг; 4.6.6, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын тээвэрлэлт, хууль бус цагаачлал, хуурамч бичиг баримтаар зорчих зөрөг зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх.	Зөвлөлийн нарийн бичгийн даргын ажлын алба
4	Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай	2012.10.20, №98	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн эргэлтэд хяналт тавих үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн эргэлтэд хяналт тавих үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталсан	Дарга-хууль зүйн сайд, орлогч дарга-эрүүл мэндийн дэд сайд, нарийн бичгийн дарга-ажлын албаны дарга нараас гадна 14 албан тушаалтан Үндэсний зөвлөлийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд багтдаг.

ХОЁР. СТАТИСТИК СУДАЛГАА

Эрүүгийн хуулийн тусгай ангид Хар тамхи, мансууруулах бодисыг **хууль бусаар Монгол улсын хил нэвтрүүлэх** /188-р зүйл/, Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг **хууль бусаар бэлтгэх**, **олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах** /192-р зүйл/, Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг **үйлдвэрлэх, бэлтгэх журам зөрчих** /193-р зүйл/, Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг **хууль бусаар авах** /194-р зүйл/, Мансууруулах бодис агуулсан **ургамлыг тарих, ургуулах, хурааж авах** /195-р зүйл/, Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодисыг **хэрэглэх газар зохион байгуулах** /196-р зүйл/ зэрэг үйлдлүүдийг гэмт хэрэг гэж заасан. Холбогдох байгууллагуудаас авсан судалгаанаас харахад энэ төрлийн гэмт хэрэг болон эдгээрт холбогдогчын тоо нэмэгдэх хандлага харагдаж байна. Тодруулбал:

1) Эрүүгийн цагдаагийн газрын "Хар тамхитай тэмцэх хэлтэс"[3] -ээс авсан судалгаанаас харахад 2012-2016 оны хооронд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 188, 192-196-р зүйлд заасан гэмт хэрэг 323 бүртгэгдэж, түүнд 839 хүн холбогдон шалгагдсан байна. Бүртгэгдсэн гэмт хэрэг болон түүнд холбогдогчын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр үзүүлбэл:

Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг, түүнд холбогдогч /188-р зүйл/

д/д	Гэмт хэрэг, холбогдогч	Огноо				
		2012	2013	2014	2015	2016
1	Бүртгэгдсэн гэмт хэрэг	7	3	5	8	15
2	Гэмт хэрэгт холбогдогч	19	5	15	15	36

2013 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, түүнд холбогдогчын үзүүлэлтийг 2012 онтой харьцуулахад гэмт хэрэг 2.3 дахин, холбогдогч 3.8 дахин буурсан боловч 2014-2016 онд эдгээр үзүүлэлт өссөн байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 192-196-р зүйлээр бүртгэгдсэн гэмт хэрэг, түүнд холбогдогч

д/д	Гэмт хэрэг, холбогдогч	Огноо				
		2012	2013	2014	2015	2016
1	Бүртгэгдсэн гэмт хэрэг	29	37	57	71	94
2	Гэмт хэрэгт холбогдогч	175	103	129	154	188

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 188, 192-196 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт холбогдогчдийн насны байдал

д/д	Гэмт хэрэг, холбогдогчдын нас	Огноо				
		2012	2013	2014	2015	2016
1	00-18	24	2	3	10	6
2	19-25	44	74	82	87	113
3	26-35	86	24	50	58	72
4	36-аас дээш	40	8	9	14	33

[3] Эрүүгийн цагдаагийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 13е/386 тоот албан бичиг

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Гэмт хэрэгт холбогдогчдийн хүйсийн байдал

д/д	Гэмт хэрэгт холбогдогчдын хүйсийн байдал	Огноо				
		2012	2013	2014	2015	2016
1	Эрэгтэй	155	92	126	143	177
2	Эмэгтэй	39	16	18	26	47

Гэмт хэрэгт холбогдогчдийн боловсролын байдал

д/д	Гэмт хэрэгт холбогдогчдын боловсролын байдал	Огноо				
		2012	2013	2014	2015	2016
1	Боловсролгүй	5	2	2	0	0
2	Бага	12	1	4	4	5
3	Бүрэн бус дунд	26	13	29	48	74
4	Бүрэн дунд	87	59	52	74	85
5	Дээд	64	33	57	43	60

Гэмт хэрэгт холбогдогчдийн нийгмийн байдал

д/д	Гэмт хэрэгт холбогдогчдын нийгмийн байдал	Огноо				
		2012	2013	2014	2015	2016
1	Ажилгүй	69	45	55	74	92
2	Төрийн албан хаагч	0	1	1	2	2
3	Хувийн хэвшил болон хувиараа хөдөлмөр эрхлэгч	84	40	70	47	82
4	Оюутан	21	22	16	39	42
5	Сурагч	20	0	2	7	6

2) Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс авсан мэдээлэл[4]-ийг хүснэгтээр үзүүлбэл:

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 192 дугаар зүйлээр шийдвэрлэсэн бүгд хэрэг, ял шийтгэсэн бүгд хүний тоо /2012-2016 он/

д/д	Үзүүлэлт	он					нийт[5]
		2012	2013	2014	2015	2016	
1	Шийдвэрлэсэн бүгд хэрэг	12	20	33	42	72	194
2	Ял шийтгэсэн бүгд хүн	18	35	54	76	130	343

2013 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 192 дугаар зүйлээр шийдвэрлэсэн хэрэг 1.6 дахин, ял шийтгэсэн хүн 1.9 дахин, 2014 онд шийдвэрлэсэн хэрэг 1.6 дахин, ял шийтгэсэн хүн 1.5 дахин, 2015 онд шийдвэрлэсэн хэрэг 1.2 дахин өссөн, ял шийтгэсэн хүн 1.4 дахин, 2016 онд шийдвэрлэсэн хэрэг, ял шийтгэсэн хүн тус тус 1.7 дахин өссөн байгаа нь 2016 онд энэ төрлийн гэмт хэрэг өмнөх жилүүдээс ихээхэн өссөн нь харагдаж байна.

[4] Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн статистик мэдээлэлд үндэслэв.

[5] 2012-2016 онд Эрүүгийн хуулийн тусгай ангиийн 192-р зүйлээр 194 хэрэг шийдвэрлэгдэж, түүнд 343 хүн ял шийтгэгдсэн статистик мэдээ гарсан байна. Энэхүү гэмт хэрэг нь хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой үйлдэгдсэн нийт гэмт хэрэгт хамгийн өндөр хувийг эзэлсээр байна.

хуульчийн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

3) Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Химийн лабораториас авсан мэдээгээр[6] мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой шинжилгээг 2015 онд 200, 2016 онд 250 удаа хийсэн мэдээлэл байгаа ба энэ чиглэлээр хийж буй шинжилгээний тоо жилээс жилд нэмэгдэх хандлагатай байна.

ГУРАВ. ОЛОН НИЙТИЙН САНАЛ

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой олон нийтийн саналыг судлахдаа уг асуудлаар судалгаа хийсэн эрдэмтдийн бүтээл, мөн судлаачид болон олон нийтийн зүгээс нийтлүүлсэн өгүүлэл, илтгэл, судалгааны тайланг эх сурвалж[7] болгов. /хавсралт 1-ээс харна уу/

Эдгээр эх сурвалжаас харахад хэд хэдэн нийтлэг санал, асуудал хөндөгдсөн байна. Тодруулбал:

-Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлт, хууль бус эргэлтийг зохицуулсан хуулиудыг уялдуулах, боловсронгуй болгох;

- Захиргааны шийтгэлийн хэмжээг нэмэгдүүлэх;

- Энэ төрлийн зөрчил, гэмт хэргийн талаарх мэдээллийг түгээх, урьдчилан сэргийлэх, нийгэмд учруулах хор уршиг болон оногдуулах шийтгэлийг сурталчилан таниулах асуудлаар нийтийг хамарсан ажлыг тодорхой үе шаттайгаар зохион байгуулах;

- Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Химийн лабораторийг шаардлагатай тоног төхөөрөмж, бодисоор хангах, хил гаалийн хяналтын бүсийн тоног төхөөрөмжийг сайжруулах[8];

- Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх тусгай чиг үүрэг бүхий алба хаагчдыг чадавхжуулах, мэргэшүүлэх;

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлт бодисын хууль бус эргэлтийг хянах төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдааг сайжруулах, чадавхижуулах зэрэг.

Иймд эдгээр асуудлыг бодлогын баримт бичиг боловсруулах шатанд анхаарах нь зүйтэй гэж үзэж байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой бодлогын баримт бичгийг судалж үзэхэд хэд хэдэн баримт бичиг /3-5 хуудас/-т уг асуудлаар цөөн тооны зорилт, арга хэмжээ тусгагдсан боловч нэгдсэн зорилт, арга хэмжээ бүхий томоохон баримт бичиг байхгүй байна.

Харин Эрүүгийн хуульд энэ төрлийн гэмт хэргийн талаар нилээд тодорхой тусгагдсан боловч уг асуудалтай холбоотой тоон судалгаанаас харахад энэ төрлийн гэмт хэрэг болон түүнд холбогдогчын тоо сүүлийн жилүүдэд өссөн байна.

Уг асуудлын талаар олон нийтийн санаа бодлыг тусгасан материалаас / хавсралт 1/ харахад манай улсын тухайд мансуурах болон сэтгэцэд нөлөөт үйлчилгээтэй ургамлууд түгээмэл байдаг ба хүн амын ихэнхи нь эдгээр ургамлын хор уршгийн талаар эрх зүйн болон эмнэлзүйн мэдээлэлгүйгээс тэдгээрийг хэрэглэх,

[6] Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс авсан мэдээлэлд үндэслэв.

[7] Б.Батбаяр, А.Түвшинтулга. Хууль зүйн шинжлэх ухааны ном зүйн бүртгэл (1911-2012 он). УБ., 2014.

[8] Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс авсан мэдээлэлд үндэслэв.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

цаашлаад энэ нь эдгээр гэмт хэрэгт холбогдох нөхцөл шалтгаан болж байгаа тухай санал, дүгнэлт цөөнгүй гарсан байна.

Иймд энэ төрлийн гэмт хэрэгтэй хийх тэмцлийг эрчимжүүлэх, гэмт хэргийн шалтгаан нөхцлийг нарийвчлан судлах, илрүүлэх арга ажиллагаанд технологийн дэвшлийг ашиглах, мэргэшсэн ажилтнуудыг бэлтгэх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бэлдмэл, бодисын хууль бус эргэлттэй тэмцэх эрх зүйн орчныг илүү боловсронгуй болгох, ялангуяа хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага, албан тушаалтнуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, энэ чиглэлийн үйл ажиллагаанд хамтарсан байдлаар томоохон хэмжээний хяналт шинжилгээ үнэлгээ хийх, дорвитой зорилт, арга хэмжээ бүхий тусгай хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх замаар энэхүү асуудалд анхаарал хандуулах нь зүйтэй байна.

ТАВ. ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Мансууруулах эмийн тухай конвенц 1961 он
2. Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц 1971 он
3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх хууль бус эргэлтийн эсрэг Нэгдсэн үндэсний байгууллагын конвенц 1988 он
4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль 2002 он
5. Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль 2013 он
6. Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хууль 2000 он
7. Мансууруулах эмийн ба сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэх талаар олон улсын стандарт 2015 он
8. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем http://www.legalinfo.mn
9. Эрүүгийн цагдаагийн газрын Хар тамхитай тэмцэх хэлтэс 2017 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 13е/386 тоот албан бичиг
10. Монгол Улсын шүүн таслах ажиллагааны тайлан
11. Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухааны ном зүйн бүртгэл. Гарын авлага. УБ., 2014 он
12. Олон Улсын гэрээ хэлэлцээрийн эмхтгэл. Эрүүгийн эрх зүй, Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. Д.Баярсайхан, Т.Золбоо. УБ., 2012 он
13. Монгол улсын засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө. Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолын хавсралт
14. Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл технологийн төв. Монгол Улсад 2015 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал. Албан хэрэгцээнд зориулав. УБ., 2005

---o0o---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ГУРАВ. ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ХЗҮХ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД МӨРДӨГДӨЖ БУЙ ХУУЛЬ ТОГТООМЖУУДЫН ДАВХАРДАЛ, ХИЙДЭЛ, ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ НИЙЦЛИЙН МОНИТОРИНГ[1]

ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМААРАЛТАЙ ЭРХ ЗҮЙН АКТАД ХИЙСЭН МОНИТОРИНГ- ШИНЖИЛГЭЭ

Тус хүрээлэнгийн Хууль зүйн мэдээлэл сургалт, сурталчилгааны төв нь хууль тогтоомжийг сурталчилах, тайлбарлан таниулах, хэрэглээнд хялбар дөхөм болгон хэвлэх, хууль тогтоомж, эрх зүйн бусад актын нэгдсэн бүртгэл, эрх зүйн мэдээллийн нэгдсэн сүлжээ, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг нэгж юм.

Хууль зүйн сайдын 2015 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар тус байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж Сургалтын төвийг татан буулгаж нэг ажилтны орон тоотойгоор Хууль зүйн мэдээлэл, сурталчилгааны чиг үүргийг хэрэгжүүлэгч нэгжтэй нэгтгэсэн. Мөн Хууль зүйн сайдын 2016 оны А/64 дүгээр тушаалаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дүрэмд дахин өөрчлөлт орсноор эрх зүйч, хуульч, хуулийн байгууллагын ажилтны мэдлэг, ёс зүй, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх албан бус сургалт, хуульчийн мэргэжлийн шалгалтанд бэлтгэгчдэд зориулсан сургалтыг зохион байгуулах чиг үүрэгтэй болсон.

Эрх зүйн актад хийсэн шинжилгээ

Хууль зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгааны төвийн үйл ажиллагаанд шууд бус байдлаар тухайлбал, эрх зүйн холбогдолтой мэдээлэл түгээх, хууль тогтоомжийг сурталчлах, иргэдэд хүргэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэхэд хамааралтай байж болох Зар сурталчилгааны тухай хуульд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 84 дүгээр тушаалаар батлсан аргачлалын дагуу мониторинг судалгааг хийв.

Бусад эрх зүйн актын хувьд Засгийн газрын тогтоол 3, Хууль зүйн сайдын тушаалаар батлсан журам 4, хамтарсан тушаал, захирамж 1, Байгууллагын өөрийн үйл ажиллагаатай холбоотойгоор захирлын батлсан 32 журам үйлчилж байна.

Засгийн газрын тогтоол

Засгийн газрын тогтоолын хувьд Засгийн газрын “Эрх зүйн сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлыг сайжруулах тухай” 1993 оны 57 дугаар тогтоол, Засгийн газрын “Журам батлах тухай” “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам” 2011 оны 119 дүгээр тогтоол, 2009 оны “Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл, сурталчилгааны үндэсний төвийг өөрчлөн зохион байгуулах тухай” 18 дугаар тогтоол байна. Энэхүү Засгийн газрын 3 тогтоолын хувьд 2009 оны 18 дугаар тогтоол нь хэм хэмжээ агуулсан буюу тодорхой харилцааг журамлан зохицуулсан агуулгагүй өөрөөр хэлбэл нэг удаагийн шинжтэй, байгууллагыг өөрчлөн байгуулсан тогтоол байна.

[1] Энэхүү мониторингийг Хууль зүйн судалгааны төвийн эрдэм шинжилгээний ажилтан Ж.Бариаширсүрэн, Хууль зүйн сургалт, мэдээлэл, сурталчилгааны төвийн эрхлэгч А.Түвшинтулга, тус төвийн эрх зүйн мэдээлэл хариуцсан мэргэжилтэн Д.Мөнхжаргал нар хамтран гүйцэтгэв.

Харин Засгийн газрын 1993 оны 57 дугаар тогтоол, 2011 оны 119 дүгээр тогтоолын хувьд:

1. Засгийн газрын "Эрх зүйн сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлыг сайжруулах тухай" 1993 оны 57 дугаар тогтоол:

Энэхүү тогтоолоор нийтийг хамарсан эрх зүйн сургалтыг зохион байгуулах, эрх зүйн акт, тогтоол шийдвэрийн лавлагаа олгох, хуулийн сурталчилгааг гүйцэтгэх харилцаа үүргийг ХЗЯ-нд хариуцуулсан байдаг. Тус тогтоолын 3-ын В-д заасан үүргийг тус хүрээлэнгийн Хууль зүйн, мэдээлэл, сургалт, сурталчилгааны төв Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийн ажлын хүрээнд гүйцэтгэж байна.

Засгийн газрын 1993 оны 57 дугаар тогтоолын агуулга, ач холбогдол алдагдаагүй ч гэсэн цаг үеийн шаардлагаар улам бүр сайжруулах, боловсронгуй болгох зорилгоор хүчингүй болгон Захиргааны ерөнхий хуультай уялдуулан шинээр батлах шаардлагатай.

2. Засгийн газрын "Журам батлах тухай" 2011 оны 119 дүгээр тогтоол:

"Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам"-аар захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн тухай ойлголт, тавигдах шаардлага, шийдвэрийг хэрхэн боловсруулах, батлах, хянан бүртгэх, олон нийтэд мэдээлэх, хүчин төгөлдөр болох зэрэг асуудлыг нарийвчлан зохицуулсан. Үүнд:

- Нийтээр дагаж мөрдүүлэх хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах болсон үндэслэл, шаардлага, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээг судлан төслийг бэлтгэн, батлах;
- Дүрэм журам буюу шийдвэрийг батлан гаргасан байгууллага нь уг шийдвэрээ Хууль зүйн яаманд хянуулж, бүртгүүлэхээр хүргүүлснээр тухайн шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн эсэх, журамд тавигдах шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянаад улсын нэгдсэн санд бүртгэж бүртгэлийн дугаар олгон бүртгэсэн тухайгаа тухайн этгээдэд мэдэгдэнэ;
- Хууль зүйн яам улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн шийдвэрийг бүртгэсэн өдрөөс хойш ажлын 1 хоногийн дотор www.legalinfo.mn цахим хуудсанд байршуулж, бүртгэсэн өдрөөс хойш 10 хоногийн дотор "Хууль зүйн мэдээлэл" эмхэтгэлд бүрэн эхээр нь нийтлүүлнэ. Мөн 2.5.2-д шийдвэрийг зөвхөн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Хууль зүйн мэдээлэл" эмхэтгэлд нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлнэ гэж заасан.

Энэхүү журмын 2.5.1, 2.5.4, 4.3, 6.5-г баримтлан өдөр тутамдаа мөрдлөгө болгон ажиллаж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн эрх зүйн актыг "Хууль зүйн мэдээлэл" эмхэтгэлд бүрэн эхээр нь нийтлэж, мөн ЭЗМНС /www.legalinf.mn/-д байршуулах ажлыг гүйцэтгэж байна. Захиргааны ерөнхий хууль батлагдсантай холбоотойгоор Засгийн газрын 2011 оны 119 дүгээр тогтоолыг хүчингүй болгох эсвэл журмыг шинэчлэн боловсруулах шаардлагатай.

Хамтарсан шийдвэр

1. Үндсэн хуулийн цэц, Улсын Их Хурлын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Хууль зүйн яам, Шүүхийн ерөнхий зөвлөл байгууллагын хамтарсан Журам батлах тухай 2007 оны 22,40, 3г-3/06, 234, 50, 341 дүгээр захирамж, тушаал:

Эрх зүйн мэдээллийг олон нийтэд нээлттэй, түргэн шуурхай хүргэх, эрх зүйн хэм хэмжээний уялдаа холбоог сайжруулах зорилгоор "Эрх зүйн мэдээллийн

нэгдсэн системийг ажиллуулах журам”-ыг гаргасан. Уг журам нь Монгол Улсын хууль тогтоомж, эрх зүйн акт, хууль зүйн нэр томъёо, статистик мэдээг компьютерийн сүлжээгээр дамжуулан хүлээн авах, ангилан боловсруулах, хадгалж түгээх програм хангамж мэдээллийн нэгдсэн систем түүний аюулгүй байдлыг хянах харилцааг зохицуулна.

Энэхүү журмаар ЭЗМНС /www.legalinfo.mn/-н өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулан, эрх зүйн актуудыг оруулах, ангилах, системийн өдөр тутмын үйл ажиллагааг хангах үүргийг хүлээн ажиллаж байна.

Захиргааны ерөнхий хуультай уялдуулан 2007 оны 22,40, 3г-3/06, 234, 50, 341 дүгээр захирамж, тушаалаар батлагдсан журмыг өөрчлөн шинэчлэн батлах шаардлагатай юм. Одоогоор Хууль зүйн яамнаас энэ журмыг хүчингүй болгон шинэчилсэн журмыг батлахаар төслийг боловсруулсан байгаа бөгөөд тус хүрээлэнгийн зүгээс төсөлд саналаа өгч, холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт хийсэн байгаа болно.

Хууль тогтоомжийн шинэчлэлттэй нийцүүлэх шаардлагын үүднээс энэхүү журмыг шинэчлэн боловсруулж буй тул мониторинг үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзлээ.

Эдгээр дүрэм, журмаас Улсын Их Хурлаас шинээр баталсан хууль тухайлбал, Захиргааны ерөнхий хууль, Хууль тогтоомжийн тухай хууль зэрэгтэй нийцүүлэх үүднээс зарим журмыг шинэчлэх, өөрчлөх шаардлага үүсч байна.

Байгууллагын өөрийн үйл ажиллагаатай холбоотойгоор захирлын баталсан 31 журам үйлчилж байгаас бүтэц зохион байгуулалт, эрх зүйн актын өөрчлөлт, шинэчлэлтэй холбоотойгоор тухайлан 3 журмыг өөрчлөхөөр төслийг боловсруулж байгаа. Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй бусад журмын хувьд одоогоор өөрчлөх шаардлагагүй байна.

Хууль зүйн сайдын тушаалаар баталсан журам

Тус нэгжийн үндсэн чиг үүрэгтэй холбоотой хоёр журмыг тухайлан авч үзлээ.

1. Эрх зүйн актыг бүртгэх, эрх зүйн актын ангилагчийг ашиглаж системчилсэн картын сан, хяналтын хувийн хөтлөх аргачилсан зөвлөмж (2009-03-11)

Аргачилсан зөвлөмжийн зорилго нь:

- хэрэглэгчдийг үнэн зөв, бодит эрх зүйн мэдээллээр шуурхай хангах
- эрх зүйн актын системчлэлийг боловсронгуй болгох
- эрх зүйн актын картын болон цахим санг боловсронгуй болгох явдал.

Актын бүртгэл

Төрийн холбогдох байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагын хууль зүйн хэлтэс (газар, алба, мэргэжилтэн) эрх зүйн актыг хүлээн авч бүртгэнэ. Бүртгэлийг актын төрөл тус бүрт хөтлөнө. Бүртгэлд:

- Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, захирамж, Улсын Их Хурлын даргын захирамж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Улсын Их Хурлаас томилогддог байгууллагын шийдвэр, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбар, яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагаас баталж гаргасан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон акт, аймаг, нийслэл, дүүрэг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас баталж гаргасан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон акт.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

- “Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем ажиллуулах журам”-ын 3.5-д заасан байгууллага тогтоосон хугацаанд эрх зүйн мэдээллийн цахим санд ангилагдсан эрх зүйн актаа оруулна.
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2003 оны 147 дугаар тушаалаар “Эрх зүйн актын ангилагч”-ийг баталсан. Ангилагч нь 9 оронтой /дугаар буюу индекс/, 21 ерөнхий ангилал, 197 дэд ангилал бүхий 1138 нэгжтэй.
- Байгууллага зөвхөн өөрийн эрх хэмжээний хүрээнд баталж гаргасан эрх зүйн актаа бүртгэж, ангилж, системчилсэн мэдээллийн сан бүрдүүлнэ.

Энэхүү зөвлөмжийг Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн актуудыг ангилах, хяналтын хувийг хөтлөхөд удирдлага болгон ажиллаж байна.

Захиргааны ерөнхий хуультай уялдуулан энэхүү Аргачилсан зөвлөмжийг шинэчлэх шаардлагатай.

2. Хууль зүй, дотоод хэргийн сайдын Журам батлах тухай 2010 оны 220 дугаар тушаал:

Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг бүртгэх, хэвлэх, нийтэд түгээхэд “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын нэгдсэн санг эрхлэн хөтлөх журам”-ыг баримталдаг. Хуул зүйн яам захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг бүртгэн, ЭЗМНС-д оруулах ажлыг гүйцэтгэж байна. Манайд хяналтын хувь ирдэг ба уг хяналтын хувийг файлтай нь тулган “Хууль зүйн мэдээлэл” эмхэтгэлд нийтлэх үүрэг хүлээдэг. Энэхүү журмын 5.1, 5.2, 5.3, 5.4, 7.5-г баримтлан ажиллаж байна.

Захиргааны ерөнхий хуультай уялдуулан 2010 оны 220 дугаар тушаалаар батлагдсан журмыг шинэчлэн батлах шаардлагатай.

Хууль зүйн судалгааны төвийн үйл ажиллагаанд хамааралтай эрх зүйн актад хийсэн мониторинг – шинжилгээ

Хууль зүйн судалгааны төв /цаашид Судалгааны төв гэх/ нь хууль зүйн бодлогын болон хавсарга судалгаа хийх, хууль тогтоомжийн төсөл боловруулахад хамтран ажиллах, судалгаа, мэдээлэл, онол-арга зүйн туслалцаа үзүүлэх чиг үүрэгтэй.

Судалгааны төвд тус хүрээлэнгийн номын сан харьяалагдана. Тус номын сангийн фонд нь зөвхөн хууль, эрх зүйн чиглэлийн монгол, гадаад ном, сэтгүүл, бусад бүтээлээс бүрддэг бөгөөд улсын хэмжээнд хууль зүйн чиглэлээр дагнан төрөлжсөн номын сан юм.

Судалгааны төв үйл ажиллагаандаа Шинжлэх ухаан, технологийн тухай хууль /2006 он/, Номын сангийн тухай хууль /2014 он/ болон бусад хууль тогтоомж, эрх зүйн актыг мөрддөг.

Мониторингийн хүрээнд цуглуулсан эрх зүйн актууд[2]

Судалгаа, шинжилгээний үйл ажиллагаатай уялдуулан Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн хийдэл, давхардал, зөрчлийг арилгах, бусад хуулиудыг уялдуулах ажлын хүрээнд холбогдох хууль тогтоомж, уг хуулийг хэрэгжүүлэхээр Улсын Их Хурал, Засгийн газраас баталж гаргасан холбогдох нийт 27 эрх зүйн актад мониторинг хийсэн. Үүнд:

[2] Хавсралт 2-оор дэлгэрэнгүй жагсаалтыг хавсаргав.

Эрх зүйн актын төрөл	**Тоо**
- 1/ Хууль;	10
- 2/ ОУ-ын гэрээ;	0
- 3/ УИХ-ын тогтоол;	1
- 4/Ерөнхийлөгчийн зарлиг;	0
- 5/Үндсэн хуулийн Цэцийн шийдвэр;	0
-	
- 6/Улсын Дээд шүүхийн тогтоол;	0
- 7/Засгийн газрын тогтоол;	7
- 8/ Сайдын тушаал;	8
- 9/ Засгийн газрын агентлагийн даргын тушаал;	1
- 10/УИХ-аас томилогддог байгууллагын дарга түүнтэй адилтгах албан тушаалтны шийдвэр	0

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ТУХАЙ ХУУЛЬ[3]
2002 он

ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ДАВХАРДАЛ, ЗӨРЧИЛ, ХИЙДЛИЙГ ТОГТООХ АЖЛЫН ТАЙЛАН[4]

I ХЭСЭГ. ТАНИЛЦУУЛГА

2016 оны 2 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн 2016 оны 3 дугаар сарын 09-ний өдрийг дуустал, УИХ-аас 2002 оны 5 дугаар сарын 30-ны өдөр батлсан Зар сурталчилгааны тухай хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг тогтоох ажлыг хийж гүйцэтгэлээ.

Ажлыг дараах үндсэн үе шатаар хийж гүйцэтгэсэн болно:

1. Зар сурталчилгааны тухай хуультай шууд холбоотой хууль, эрх зүйн бусад актыг нэгтгэн цуглуулах, түүнд ангилал хийх;

2. Зар сурталчилгааны тухай хуулийг цуглуулан нэгтгэсэн хууль эрх зүйн акттай харьцуулж уг хуульд давхардал, хийдэл, зөрчил байгаа эсэхийг тогтоох;

3. Илэрсэн зөрчил, давхардал, хийдлийг хуулийн зүйл заалт тус бүрээр гарган санал боловсруулах.

Зар сурталчилгааны тухай хуультай шууд холбоотой хууль, эрх зүйн бусад актыг нэгтгэн цуглуулах үе шат:

Энэ шатанд эрх зүйн актыг дараах дараалаар цуглуулсан:

- Зар сурталчилгааны харилцаатай холбоотойгоор МУ-ын олон улсын гэрээ конвенц: -0
- Зар сурталчилгааны тухай хуультай холбогдох хууль: 61
- УИХ-ын тогтоол 1
- Зар сурталчилгааны тухай хуультай холбоотой УДШ-ээс гаргасан тогтоол: 5
- Үндсэн хуулийн цэцийн шийдвэр: 0
- -Засгийн газрын тогтоол: 1
- -Төрийн захиргааны төв байгууллага, сайдын тушаал: 0
- -Засгийн газрын агентлагаас гаргасан эрх зүйн акт: 1
- -Аймаг, нийслэлийн ИТХ-ын шийдвэр: 2

Судалгааны арга:

- Баримт бичиг судлах;
- Задлан шинжлэх ба нэгтгэн дүгнэх;
- Харьцуулалт хийх;
- Бичвэр харьцуулах арга;
- Ярилцлагын арга.

[3] ХЗДХС-ын Аргачлал батлах тухай 2010 оны 84 дүгээр тушаалаар батлагдсан “Хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах аргачлал”-ын дагуу хийв.

[4] Иргэн, эдийн засгийн хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах төслийн хүрээнд 2010 онд Зар сурталчилгааны тухай хуулийн давхардал, зөрчил хийдэлд хийсэн тайланд үндэслэн шинэчлэн боловсруулж хийв.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

Зар сурталчилгааны тухай хууль батлагдсан нөхцөл байдал, түүний хэрэгжилт

Зар сурталчилгааны тухай хууль нь 2002 оны 5 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан бөгөөд 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр өөрчлөлт, 2009 оны 6 дугаар сарын 25-ны өдөр нэмэлт, 2010 оны 6 дугаар сарын 10-ны өдөр өөрчлөлт 2 удаа, 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр нэмэлт, 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдөр нэмэлт, өөрчлөлт, 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдөр өөрчлөлт тус тус орсон.

Эрх зүйн шаардлага

Монгол Улсад зар сурталчилгаа, түүнтэй холбоотой харилцааг зохицуулдаг тусгайлан гаргасан хууль эрхийн акт байхгүй харин “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” /2003/, “Архидан согтуурахтай тэмцэх тухай” /2000/, ”Тамхины хяналтын тухай” /2005/, “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” /1996/, “Садар самуун явдалтай тэмцэх тухай” /1998/ хуулиудад зар сурталчилгаанд хамаарч болох зарим зүйл заалтууд тусгагдсан байсан. Гэвч эдгээр хуулиудын зохицуулалт нь ерөнхий шинжтэй бөгөөд зар сурталчилгаатай холбогдож хориглосон заалтуудыг зөрчсөн тохиолдолд эрх зүйн ямар механизм хэрэглэх нь тодорхой бус, шаардлага хангахгүй байсан. Эдгээр нөхцөл байдлаас шалтгаалан хуулийг хариуцан хэрэгжүүлэх, хяналт тавих этгээд тодорхой бус, хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог бүрдүүлээгүй зэрэг олон хүчин зүйл байгаагаас хууль хэрэгжих боломжгүй байсан. Дээрх байдлаас үүдэн өрсөлдөөний тухай болон бусад зар сурталчилгаатай холбогдон гарсан хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэх механизмыг сайжруулах эрх зүйн шаардлага бий болсон.

Практик шаардлага

Өнөөдөр зар сурталчилгааны үйл ажиллагаа маш эрчимтэй хөгжиж байгаа ба үүнийг дагаад зарим нэг сөрөг үзэгдэл гарах болсон. Тухайлбал: архи, тамхийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, гадна зар сурталчилгаагаар сурталчлах, сурталчилгааны нэвтрүүлгийг нэвтрүүлэх явдал маш их байсан. Мөн хэрэглэгчдийн эрх ашгийг хөндөж байгаа асуудлын нэг нь телевизийн дундуур болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр эерэг болон сөрөг нөлөөтэй зар сурталчилгаа хэт их явуулах байдал ихсэж байна. Зар сурталчилгаа гэдэгт юуг хамааруулж ойлгох талаар тодорхой хууль тогтоомж байхгүй нь хуулийн хийдэл үүсгэж, дээрх бараа бүтээгдэхүүнийг нийтэд сурталчлах боломжийг бүрдүүлсээр байсан.

Хуулийн бүтэц, зохицуулах харилцаа

Зар сурталчилгааны тухай хууль нь 6 бүлэг, 29 зүйлтэй. Хуулийн зорилт нь зар сурталчилгааг бүтээх, байрлуулах, түгээх, түүнд хяналт тавих болон шударга өрсөлдөөнд харшлах, хэрэглэгчийг төөрөгдөлд оруулах, хуурч мэхлэх, тэдний ашиг сонирхолд хохирол учруулахуйц зар сурталчилгааг хориглохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Нэгдүгээр бүлэг: Ерөнхий зүйл

Энэ бүлэгт зар сурталчилгааны харилцаанд хамаарах хууль тогтоомж, хуульд хэрэглэсэн нэр томьёоны тайлбар, зар сурталчилгаанд оюуны үнэт зүйлийг ашиглах, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон зар сурталчилгаанаас хамгаалах зэргийг тусгасан.

Хоёрдугаар бүлэг: Зар сурталчилгаа, түүнд тавих ерөнхий шаардлага, хориглох зүйл

Энэ бүлэгт зар сурталчилгаа бүтээх, түгээхэд тавих ерөнхий шаардлага, хууль бус зар сурталчилгаанд юуг хамааруулах талаар тусгасан.

Гуравдугаар бүлэг: Зар сурталчилгаанд тавих тусгай шаардлага

Энэ бүлэгт, тээврийн хэрэгслээр түгээх зар сурталчилгаа, гадна зар сурталчилгаа, харилцуур утасны болон бусад лавлахаар түгээх зар сурталчилгаа, радио, телевизээр түгээх зар сурталчилгаа, интернэтээр түгээх зар сурталчилгаа, эрүүл мэндийн салбар дахь зар сурталчилгаа, байгаль орчны салбар дахь зар сурталчилгаа, хатуулаг багатай дарс, пиво, шимийн архины зар сурталчилгаа, нийгмийн зар сурталчилгаа, зар сурталчилгаа бүтээх, байрлуулах, түгээхэд хүүхдийн эрхийг хамгаалах, банк, санхүү, хөрөнгө оруулалтын сан, даатгалын үйл ажиллагаа, үнэт цаасны зар сурталчилгаа зэрэг асуудлыг тусгаж өгсөн.

Дөрөвдүгээр бүлэг: Зар сурталчилгаа захиалагч, бүтээгч, түгээгчийн эрх, үүрэг

Энэ бүлэгт зар сурталчилгааны төлбөр, ивээн тэтгэгчийн зар сурталчилгаа, зар сурталчилгаатай холбоотой баримтыг хадгалах, зар сурталчилгаанд хамаарах мэдээллийг шаардах, зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийг зөрчсөн талаар урьдчилан мэдэгдэх, зар сурталчилгаа бүтээх, түгээхэд хувь хүн, хуулийн этгээдийн оролцоог тодорхойлсон.

Тавдугаар бүлэг: Зар сурталчилгааг хянах, зохицуулах

Энэ бүлэгт төрөөс зар сурталчилгаанд тавих хяналт, зар сурталчилгаанд тавих олон нийтийн хяналт, зар сурталчилгаанд тавих хамтын хяналт, зар сурталчилгааны хяналтын байцаагчийн шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргах, зар сурталчилгааны хяналтын албаны шийдвэр, үйл ажиллагаанд гомдол, нэхэмжлэл гаргах зэргийг заасан.

Зургадугаар бүлэг: Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

Энэ бүлэгт хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх захиргааны хариуцлагыг зааж өгсөн.

II ХЭСЭГ. ДҮГНЭЛТ

Шалгуур	Тоо
7.1. Давхардал	**13**
7.1.1.тухайн хуульд байгаа зохицуулалтын бичвэрийг бусад хуульд давтан хуулбарлан хуульчилсан эсэх	4
7.1.2.тухайн хуульд байгаа зохицуулалтыг уг хуульд болон бусад хуульд бичвэрийн эсхүл агуулгын хувьд хуулбарлан хуульчилсан эсэх	9
7.1.3.төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг хуульд давхардуулан хуульчилсан эсэх	-
7.1.4.тухайн хуулийн тодорхой зохицуулалтыг Улсын дээд шүүхээс тайлбарлаж байсан эсэх, энэхүү тайлбар нь түүний давхардлыг арилгахад чиглэгдсэн эсэх	-
7.2. Зөрчил	**14**
7.2.1.тухайн зохицуулалт нь хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	-
7.2.2.хууль тогтоомжийн хэсэгт заасан хуулийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	
7.2.3.хуулийн зүйлийн нэр тухайн зүйлд байгаа хэсэг, заалтын агуулгын нийлбэртэй нийцэж байгаа эсэх	-
7.2.4.хуулийн зүйл, заалт, зохицуулалт нь хэл зүйн найруулгын хувьд салаа утгатай эсэх	-

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

7.2.5.хуульд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн болон бусад хуулийн нэр томъёотой зөрчилдөж байгаа эсэх	4
7.2.6.тодорхой асуудлыг гагцхүү хуулиар зохицуулахаар заасан боловч уг асуудлаар өөр журмыг өөр хуульд заасан эсэх	-
7.2.7.хуульд заасан ишлэл алдаатай эсэх	1
7.2.8.тухайн хуульд бусад хуулиас авсан Ишлэлийн дугаар нь нөгөө хуульд байгаа зохицуулалттай нийцэж байгаа эсэх	2
7.2.9.татварынхаас бусад хуульд тогтоомжид албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	-
7.2.10.тухайн хуульд тусгай зөвшөөрөл олгохоор заасан нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд туссан эсэх	-
7.2.11.өмчлөх эрхийг хязгаарласан буюу хязгаарлахад чиглэгдсэн эрх зүйн акт гаргах эрхийг бусад этгээдэд хуулиар олгосон эсэх	-
7.2.12.тухайн хуулийн тодорхой зохицуулалтыг Улсын дээд шүүхээс тайлбарлаж байсан эсэх, энэхүү тайлбар нь түүний зөрчлийг арилгахад чиглэгдсэн эсэх	-
7.2.13.тухайн хуулийн зүйл, заалт өөр хуулийн заалттай зөрчилдөж буй эсэх	7
7.3. Хийдэл	**4**
7.3.1.тухайн хуульд тодорхой харилцааг нарийвчлан хуулиар зохицуулахаар заасан бол уг нарийвчилсан зохицуулалт бүхий хууль батлагдсан эсэх	-
7.3.2.тухайн хуульд тодорхой харилцааны нарийвчилсан зохицуулалтыг батлах эрхийг төрийн бусад байгууллагад шилжүүлсэн бол уг нарийвчилсан зохицуулалт батлагдсан эсэх	-
7.3.3.тухайн хуульд заасан процедурын шинжтэй зохицуулалт нь ойлгомжтой, тасралтгүй үргэлжлэх боломжтой байдлаар томъёолсон эсэхийг тодорхойлох	-
7.3.4.тодорхой эрх, үүргийг хэрэгжүүлэх субьект нь тодорхой эсэх	1
7.3.5.төрийн байгууллага, албан тушаалтнаас тодорхой асуудал шийдвэрлэхээр хуульд заасан бол уг асуудлыг шийдвэрлэх хугацааг тодорхой заасан эсэх	-
7.3.6.хуульд заасан хориглосон зохицуулалт нь түүнийг зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх;	1
7.3.7.тухайн хуулийн тодорхой зохицуулалтыг Улсын дээд шүүхээс тайлбарлаж байсан эсэх, энэхүү тайлбар нь түүний хийдлийг арилгахад чиглэгдсэн эсэх	-
7.3.8.хуульд байх шаардлагатай зохицуулалт тусгагдсан эсэх	-
7.3.9.хуулийн зүйл, заалт, зохицуулалт нь ойлгомжтой байгаа эсэх	2
Нийт	**31**

Зар сурталчилгааны тухай хуулийн зохицуулалтын давхардлыг ХЗДХС-ын Аргачлал батлах тухай 2010 оны 84 дүгээр тушаалаар баталсан “Хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах аргачлал”-д заасан шалгуурын дагуу тогтоолоо.

I. ДАВХАРДАЛ

Зар сурталчилгааны тухай хуулийн холбогдох бусад хуультай давхардсан зохицуулалтыг дараах байдлаар тогтоолоо:

7.1.1. Тухайн хуульд байгаа зохицуулалтын бичвэрийг бусад хуульд давтан хуулбарлан хуульчилсан эсэх

Д/д	Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/	Олон нийтийн радио, телевизийн тухай хууль /2005.01.27/
1	11.2.Хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн дундуур зөвхөн хүүхдэд зориулсан зар сурталчилгаа нэвтрүүлж болно.	13.2.1.хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн дундуур зөвхөн хүүхдэд зориулсан зар сурталчилгаа нэвтрүүлэх; 13.4.Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгаатай холбогдсон бусад харилцааг Зар сурталчилгааны тухай хуулиар зохицуулна

Дүгнэлт: Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1 дэх хэсэг нь Зар сурталчилгааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгтэй бичвэрийн хувьд давхардаж байна.
Санал: Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгаатай холбогдсон бусад харилцааг Зар сурталчилгааны тухай хуулиар зохицуулна гэсэн заалт байна. Иймд Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1 дэх хэсгийг хүчингүй болгох.

Д/д	Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/	Олон нийтийн радио, телевизийн тухай хууль /2005.01.27/
2	11.3.Улс орны болон дэлхий дахины амьдралын цаг үеийн шинжтэй үйл явдлын талаархи тогтмол мэдээллийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно.	13.2.2.**улс орны болон дэлхий дахины амьдралын цаг үеийн шинжтэй үйл явдлын талаархи тогтмол мэдээллийн хөтөлбөрийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхгүй байх**, мөн ийм мэдээллийн нэвтрүүлэгч зар сурталчилгаа бэлтгэх, бүтээх, дамжуулахад оролцохгүй байх; 13.4.Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгаатай холбогдсон бусад харилцааг Зар сурталчилгааны тухай хуулиар зохицуулна
Дүгнэлт: Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.2 дахь хэсэг нь Зар сурталчилгааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэгтэй бичвэр болоод агуулгын хувьд давхардаж байна. ***Санал:*** Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгаатай холбогдсон бусад харилцааг Зар сурталчилгааны тухай хуулиар зохицуулна гэсэн заалт байна. Иймд Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.2 дахь хэсгийг хүчингүй болгох.		

Д/д	Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/	Олон нийтийн радио, телевизийн тухай хууль /2005.01.27/
3	11.5.Үргэлжлэх хугацаа нь 20 минутаас дээшгүй нэвтрүүлгийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно.	13.2.5. 20 минутаас дээшгүй үргэлжлэх нэвтрүүлгийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхгүй байх. 13.4.Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгаатай холбогдсон бусад харилцааг Зар сурталчилгааны тухай хуулиар зохицуулна.
Дүгнэлт: Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.5 дахь хэсэг нь Зар сурталчилгааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсэгтэй бичвэр болоод агуулгын хувьд давхардаж байна. ***Санал:*** Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгаатай холбогдсон бусад харилцааг Зар сурталчилгааны тухай хуулиар зохицуулна гэсэн заалт байна. Иймд Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.5 дахь хэсгийг хүчингүй болгох.		

Хууль зүйн үндэсний төв www.nli.gov.mn

7.1.2. Тухайн хуульд байгаа зохицуулалтыг уг хуульд болон бусад хуульд бичвэрийн эсхүл агуулгын хувьд хуулбарлан хуульчилсан эсэх

Д/д	Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/	Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/
1	5.1.Зар сурталчилгаа нь **хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон**, энэ хуулийн 21.1, 21.2-т заасан журмыг зөрчсөн, бусдын бүтээгдэхүүнийг муутган өөрийн бүтээгдэхүүнийг давуутай гэж харьцуулан сурталчилсан, түүнчлэн энэ хуулийн 7.2.1, 7.2.3-т заасан үйлдэл хийсэн бол иргэн, хуулийн этгээд хуульд заасан үндэслэл, журмын дагуу няцаалт хийлгэх, учирсан гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй.	**7 дугаар зүйл. Хууль бус зар сурталчилгаа** 7.2.Дараах зар сурталчилгааг зүй бус зар сурталчилгаанд тооцно: 7.2.2.бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд харш сурталчилгаа;
Дүгнэлт: Зар сурталчилгааны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "...хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон..." гэсэн хэсэг нь 7 дугаар зүйлийн 7.2.2-той бичвэрийн хувьд давхардаж байна. ***Санал:*** Иймд 5 дугаар зүйлийн 5.1-дэх "...хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон..." гэсэн хэсгийг хасаж, 7 дугаар зүйлийн 7.2.2-ыг ишлэл хэлбэрээр оруулах. Ишлэл хэлбэрээр оруулахдаа "... энэ хуулийн 7.2.1, 7.2.3-т заасан үйлдэл хийсэн бол..." гэсэн хэсэгт оруулах.		

Д/д	Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/	Банкны тухай хууль /2010.01.28/
2	**17 дугаар зүйл. Банк, санхүү, хөрөнгө оруулалтын сан, даатгалын үйл ажиллагаа, үнэт цаасны зар сурталчилгаа** 17.1.**Банкны үйл ажиллагааны зар сурталчилгаа нь тухайн банкны төлбөрийн чадварын болон банкны хуулиар заагдсан бусад үзүүлэлтүүдэд үндэслэсэн, үнэн зөв байна.** Банкны үйл ажиллагааны зар сурталчилгаанд мөнгөн хадгаламжийн гэрээний гол нөхцлүүдийн талаар заавал мэдээлнэ.	**8 дугаар зүйл. Банкны зар сурталчилгаа** 8.1.Банкнаас хийх зар сурталчилгаа нь түүний тухайн үеийн үйл ажиллагааг үнэн зөв тусгасан, хууль тогтоомжид нийцсэн байна.
Дүгнэлт: Банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг нь агуулгын хувьд Зар сурталчилгааны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дүгээр зүйлтэй давхардаж байна. ***Санал:*** Банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийг хүчингүй болгох.		

Д/д	Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/	Банкны тухай хууль /2010.01.28/	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль /2002.12.12/
3	**17 дугаар зүйл. Банк, санхүү, хөрөнгө оруулалтын сан, даатгалын үйл ажиллагаа, үнэт цаасны зар сурталчилгаа** 17.1.Банкны үйл ажиллагааны зар сурталчилгаа нь тухайн банкны төлбөрийн чадварын болон банкны хуулиар заагдсан бусад үзүүлэлтүүдэд үндэслэсэн, <u>үнэн зөв байна.</u> Банкны үйл ажиллагааны зар сурталчилгаанд мөнгөн хадгаламжийн гэрээний гол нөхцлүүдийн талаар заавал мэдээлнэ.		

	17.2.Хөрөнгө оруулалтын сан, үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд болон үнэт цаас гаргагч, банк, санхүү, даатгалын болон бусдын мөнгөн хөрөнгийг ашиглах, захиран зарцуулахтай холбоотой бусад үйлчилгээ, үйл ажиллагаа, түүнчлэн үнэт цаасны зар сурталчилгааг бүтээх, тоон мэдээ, үзүүлэлтийг ашиглах, түгээхэд дараах зүйлийг хориглоно: 17.2.1.сурталчилж буй бүтээгдэхүүнд шууд хамаарахгүй тоон мэдээ, үзүүлэлтийг ашиглах;	7 дугаар зүйл. Банк, түүний хараат болон охин компанид хориглох үйл ажиллагаа 7.4.8.өөрийн үйл ажиллагааны талаар буруу ташаа зар сурталчилгаа хийх, мэдээлэл өгөх;	**12 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хориглох зүйл** 12.1.2. Өөрийн үйл ажиллагааны талаар буруу ташаа зар сурталчилгаа хийх, мэдээлэл өгөх;
Дүгнэлт: Зар сурталчилгааны тухай хуулийн 17 дугаар зүйлтэй 1.Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.8 дахь хэсэг, 2.ББСҮА-ны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь хэсэг агуулгын хувьд тус тус давхардаж байна. **Санал:** 1.Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.8-г хүчингүй болгох. 2.ББСҮА тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2-г хүчингүй болгох. 3.Зар сурталчилгааны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “*банкны үйл ажиллагааны зар сурталчилгаа” гэдгийг “банк, санхүүгийн үйл ажиллагааны*” гэж нэмэх.			

Д/д	Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль /2010.05.27/
4	13.4.Эм, эмийн зүйлс (цаашид “эм” гэх)-ийн зар сурталчилгаанд дараах зүйлийг хориглоно: 13.2.Жороор олгох, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, эмчилгээний зориулалт бүхий мансууруулах бодис, ургамал, түүнчлэн тусгай мэдлэг, мэргэжил шаардагдах эмнэлгийн хэрэгслийг зөвхөн эрүүл мэндийн салбарын ажилтнуудад зориулсан мэдээлэх хэрэгслээр сурталчилна.	27.4.Эмийн зар сурталчилгаанд Зар сурталчилгааны тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаас гадна дараах зүйлийг хориглоно: 27.4.3. жороор олгох эмийг сурталчлах;
Дүгнэлт: Зар сурталчилгааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2, 13.4 дэх хэсгүүд Эм, эмнэлгийн хэрэгсэлийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4, 27.4.3 дахь хэсгүүдтэй агуулгын болоод бичвэрийн хувьд давхардаж байна. ***Санал:*** Эм эмнэлгийн хэрэгсэлийн тухай хуулийн дээрх заалтыг хүчингүй болгож, Зар сурталчилгааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д заасны дагуу зохицуулна гэж ишлэл хэлбэрээр заалт оруулж өөрчлөх.		

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Д/д	Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/	Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль /2004.04.30/	Даатгалын тухай хууль /2004.04.30/
5 6	6.1.**Зар сурталчилгаа нь үнэн,** хэрэглэгчдэд хүртээмжтэй байж, агуулга, хэлбэр, түүнийг түгээж байгаа арга хэрэгслээс үл хамааран зар сурталчилгаа гэж ойлгогдохоор байна. 7.5.Энэ хуулийн 6.1-д заасныг зөрчсөн, хэрэглэгчийн ухамсарт шууд бусаар нөлөөлөх зар сурталчилгааг далд зар сурталчилгаа гэж тооцно.	**28 дугаар зүйл. Төөрөгдүүлсэн зар сурталчилгаа** 28.1.Даатгалын мэргэжлийн оролцогч нь төөрөгдүүлсэн, эсхүл **худал мэдээлэл агуулсан зар сурталчилгаа,** мэдээлэл, товхимол болон түүнтэй адилтгах бусад бичиг баримт гаргах, тараах, тараахыг зөвшөөрөхийг хориглоно.	**58 дугаар зүйл. Төөрөгдүүлсэн зар сурталчилгаа** 58.1.Даатгагч нь төөрөгдүүлсэн, эсхүл **худал мэдээлэл агуулсан зар сурталчилгаа,** мэдээлэл, товхимол болон түүнтэй адилтгах бусад баримт бичиг гаргах, тараах, тараахыг зөвшөөрөхийг хориглоно.
Дүгнэлт: 1.Зар сурталчилгааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалт, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, Даатгалын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1 дэх хэсэгтэй агуулгын хувьд тус тус давхардаж байна. ***Санал:*** Иймд Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, Даатгалын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1 дэх хэсгийг хүчингүй болгох.			

7.1.4. Тухайн хуулийн тодорхой зохицуулалтыг Улсын дээд шүүхээс тайлбарлаж байсан эсэх, энэхүү тайлбар нь түүний давхардлыг арилгахад чиглэгдсэн эсэх

Зар сурталчилгааны тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг тайлбарласан тогтоол Улсын дээд шүүхээс гараагүй боловч дараах хуулиудын зүйл заалтыг тайлбарласан УДШ-ийн тогтоол байгаа нь Зар сурталчилгааны тухай хуулийн зарим зохицуулалтад хамаарч байна.

1. 2006 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн “Банкны болон банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн зарим зүйл, заалт, хэсгийг тайлбарлах тухай” 52 дугаар тогтоолд:

a. 2.4.Хуулийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 3-т заасан “өөрийн үйл ажиллагааны талаар буруу ташаа зар сурталчилгаа хийх, мэдээлэл өгөх” гэдэгт хууль тогтоомж, Монголбанкнаас тогтоосон журмын дагуу гаргавал зохих тайлан, тэнцэл болон бусад мэдээ, түүнчлэн мөн хуулийн 6 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа, түүний дотор хадгаламж, зээлийн хүү, зээлийн чанар зэрэг асуудлаар бодит байдалд нийцэхгүй сурталчилгаа, мэдээллийг холбогдох байгууллагад өгөх, олон нийтэд тараахыг хамруулан ойлгоно.

b. 3.3.Мөн зүйлийн 12.1.2-т заасан “өөрийн үйл ажиллагааны талаар буруу ташаа зар сурталчилгаа хийх, мэдээлэл өгөх” гэдэг нь хууль тогтоомжийн дагуу гаргавал зохих тайлан, тэнцэл болон бусад мэдээ, түүнчлэн мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.-д заасан үйл ажиллагааны талаар буюу байгууллагынхаа орлого, санхүүгийн байдал, зээлийн хүү, зээлийн чанар зэрэг асуудлаар бодит байдалд нийцэхгүй сурталчилгаа, мэдээллийг холбогдох байгууллагад өгөх, олон нийтэд тараахыг ойлгоно.

2. 1997 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн “Төв банк /Монгол банкны/-ны тухай хууль, Банкны тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай” 379 дүгээр тогтоолд:

a. 2.2.Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 3 дахь заалтын “өөрийн үйл ажиллагааны талаар буруу ташаа зар сурталчилгаа хийх, мэдээлэл

өгөх” гэдгийг хууль тогтоомж, Монголбанкнаас тогтоосон журмын дагуу гаргавал зохих тайлан, тэнцэл болон бусад мэдээ, түүнчлэн мөн хуулийн 6 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа, түүний дотор хадгаламж, зээлийн хүү, зээлийн чанартай холбогдсон асуудлаар буруу ташаа сурталчилгаа, мэдээллийг холбогдох байгууллагад өгөх, олон нийтэд тараахыг хамааруулан ойлгоно гэсэн тайлбарууд нь Зар сурталчилгааны тухай хуулийн 7.2.3 дахь хэсэгтэй нийцэж байна.

3. 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн “Эрүүгийн хуулийн 110, 111 дүгээр зүйлүүдийн зарим заалтыг тайлбарлах тухай” 40 дүгээр тогтоолд:

а. 1.5.Мөн зүйл, хэсэгт заасан “…хэвлэл мэдээллийн хэрэгсэл…” гэдгийг Зар сурталчилгааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д зааснаар ойлгоно.

4. 2007 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн “Эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйлийг тайлбарлах тухай” 51 дүгээр тогтоолд:

а. 1.4.Мөн зүйл, хэсэгт заасан “…нийтэд тараах…” гэж Зар сурталчилгааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасан хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээллийг олон нийтэд түгээхийг хэлнэ гэж тус тус Зар сурталчилгааны тухай хуулиас иш татаж тайлбарласан байна.

II. ЗӨРЧИЛ

Зар сурталчилгааны тухай хуулийн зөрчлийг дараах шалгууруар авч үзлээ.

7.2.1. Тухайн зохицуулалт нь хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх

Д/д	Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/	Зорилтод тодорхойлоогүй харилцааг зохицуулсан эсэх
1.	*1 дүгээр зүйл. Хуулийн зорилт* 1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт зар сурталчилгааг бүтээх, байрлуулах, түгээх, түүнд хяналт тавих болон шударга өрсөлдөөнд харшлах, хэрэглэгчийг төөрөгдөлд оруулах, хуурч мэхлэх, тэдний ашиг сонирхолд хохирол учруулахуйц зар сурталчилгааг хориглохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.	Ийм зохицуулалт байхгүй байна.
Дүгнэлт: Зар сурталчилгааны тухай хуулийн зорилт нь хуулийн агуулгаа бүрэн илэрхийлсэн гэж үзэж байна.		

7.2.2. Хууль тогтоомжийн хэсэгт заасан хуулийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх

Зар сурталчилгааны тухай хуульд хууль тогтоомж гэсэн хэсэг байхгүй бөгөөд хуулийн хэсэгт заасан хуулийн нэр нь тухайн харилцаанд дараах байдлаар хамаарч байна.

Хуулийн үнэсний мэдээлэл www.mn.gov.mn

Д/д	Зар сурталчилгааны тухай хуулийн хэсэгт заасан хуулийн нэр	Тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх
1	27.3.Гомдол гаргах, хүлээн авах, хянах, шийдвэрлэхэд **Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай** хуульд заасан журмыг баримтална.	*Хамаарна* Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль /1995.04.17/ **11 дүгээр зүйл. Өргөдөл, гомдол гаргах** **12 дугаар зүйл. Өргөдөл, гомдлыг хүлээн авах, бүртгэх** **13 дугаар зүйл. Өргөдөл, гомдлыг хянан үзэх** **15 дугаар зүйл. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хариу өгөх**
2	29.3.Оюуны өмчийн улсын хяналтын албаны шийдвэр, үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг Иргэний хуульд заасан журмын дагуу арилгана.	*Хамаарна* Иргэний хууль /2002.01.10. **498 дугаар зүйл. Байгууллага, албан тушаалтан бусдад гэм хор учруулсны хариуцлага**
Дүгнэлт: Зар сурталчилгааны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь заалтад Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 11, 12, 13, 15 дугаар зүйлүүд, 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалтад Иргэний хуулийн 498 дахь заалт тус тус хамаарч байна.		

7.2.5. Хуульд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн болон бусад хуулийн нэр томъёотой зөрчилдөж байгаа эсэх

Зар сурталчилгааны талаарх эрх зүйн зохицуулалт нь нэр томьёоны хувьд нэг мөр жигдрээгүй, хэл зүйн хувьд салаа утга илэрхийлсэн дутагдалтай тал байна. Тухайн харилцааны зохицуулалтын үндсэн зүйл “зар сурталчилгаа”-ны хувьд “зар”, “зар мэдээ”, “зарлал”, “зар сурталчилгаа”, “сурталчилгаа”, “реклам” гэх мэт олон нэр томьёо байгаа бөгөөд эдгээрийг хууль бүрт өөр өөрөөр хэрэглэсэн байна. Үүнд “сурталчилгаа” гэсэн нэр томьёо орсон 41 хууль, “зар” гэсэн нэр томьёо орсон 4 хууль[5], “зар мэдээ” гэсэн нэр томьёо орсон 1 хууль[6], “зарлал” гэсэн нэр томьёо орсон 6 хууль[7], “реклам” гэсэн нэр томьёо орсон 1 хууль[8] “зар сурталчилгаа” гэсэн нэр томьёо хэрэглэсэн 14 хууль байна. Зарим нэр томьёог үг зүйн талаас нь авч үзвэл:

- “Зар”-алив нэг зүйлийн тухай олон нийтэд зарлан мэдэгдэх, тунхаглан нийтлэх ам мэдээ, бичиг;
- “зарлал”-аливаа үйлийг олонд сонордуулах, мэдээлэх мэдээ, мэдээлэл,
- “мэдээ”-сонсгон мэдэгдэх үг сураг;
- “мэдээлэл”-ямар нэгэн үйл хэргийн тухай ам болон бичгээр дэлгэрэнгүй мэдээлэх явц;
- “сурталчилгаа”-сурталчлах үйл ажиллагаа;

[5] Иргэний бүртгэлийн тухай /1999.10.14/ - 32.2.1 зүйл Иргэний хууль /2002.01.10/ - 197.13, 197.14, 197.17,197.23 зүйл
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /2005-12-01/ - 52.1.12 зүйл
Компанийн тухай /2011.10.06/ - 50.1, 54.1, 57.3, 65.3 зүйл

[6] Төрийн болон орон нутгийн өмчийн тухай /1996-05-27/ - 36.2, 38.5, 39.1, 39.2, 40.2.1, 47.1, 47.2, 48.3, 49.1, 52.1, 52.5 зүйл

[7] Банкны тухай /2010.01.28/ - 61.1 зүйл
Иргэний хууль /2002.01.10/ - 420.2 зүйл
Сонгуулийн тухай /2015.12.25/ - 77.7.1 зүйл
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай /1996-05-27/ - 42.7 зүйл
Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай /1995-10-24/ - 4.3.5 зүйл
Монгол Улсын Шүүхийн тухай /2012.03.07/ - 13.1.2, 25.3 зүйл

[8] Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай /1995-10-24/ - 4.3.5 зүйл

Хуулийн зүйлийн шинжлэх ухааны төв www.lri.edu.mn

- “зар сурталчилгаа”-аливаа нэг бараа бүтээгдэхүүн, үйл ажиллагааны сайн талыг олонд танилцуулан мэдээлэх, сурталчлах, хамтран ажиллах[9] гэсэн утгыг илэрхийлнэ.

Зар сурталчилгааны тухай хуульд “зар сурталчилгаа” гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас бараа, ажил, үйлчилгээ, төсөл, үйл ажиллагаа /цаашид “бүтээгдэхүүн” гэх/-ны зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх, боломжит хэрэглэгчийн анхаарлыг татах зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр түгээсэн мэдээллийг томьёолсон. Зарим хуулиудад хэрэглэгдэх нэр томьёо нь тухайн заалтынхаа агуулгад бүрэн нийцээгүй гэж үзээд дараах байдлаар өөрчлөх санал гаргалаа.

Д/д	Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/	Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль /2010.06.10/
1	3.1.1.”зар сурталчилгаа” гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас бараа, ажил, үйлчилгээ, төсөл, үйл ажиллагаа /цаашид “бүтээгдэхүүн” гэх/-ны зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх, боломжит хэрэглэгчийн анхаарлыг татах зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр түгээсэн мэдээллийг;	**13 дугаар зүйл. Барааны тэмдгийг ашиглах** 13.1.4.барааны тэмдгийг албан бичиг, танилцуулга, бусад баримт, интернэт, сурталчилгаанд ашигласан бол.
2		27.1.4.газар зүйн заалтыг албан бичиг, танилцуулга, бусад баримт, интернэт, сурталчилгаанд ашигласан бол.
Дүгнэлт: “сурталчилгаа”-сурталчлах үйл ажиллагаа, ”зар сурталчилгаа” гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас бараа, ажил, үйлчилгээ, төсөл, үйл ажиллагаа /цаашид “бүтээгдэхүүн” гэх/-ны зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх, боломжит хэрэглэгчийн анхаарлыг татах зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр түгээсэн мэдээллэл гэсэн утгатай. Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4, 27 дугаар зүйлийн 27.1.4 дэх хэсгүүдэд “сурталчилгаа”-г “зар сурталчилгаа” гэж өөрчлөх нь зүйтэй юм. ***Санал:*** Иймд “сурталчилгаа” гэдэг үгийн урьд нь “зар” гэж нэмэх.		

Д/д	Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/	Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль /1995.10.24/
4.	3.1.1.”зар сурталчилгаа” гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас бараа, ажил, үйлчилгээ, төсөл, үйл ажиллагаа /цаашид “бүтээгдэхүүн” гэх/-ны зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх, боломжит хэрэглэгчийн анхаарлыг татах зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр түгээсэн мэдээллийг;	4.3.Танхим нь бүрэн эрхийнхээ хүрээнд дараах үйл ажиллагаа явуулна. 5/реклам, сурталчилгааны үйлчилгээ үзүүлэх, уран сайхны зарлал, чимэглэлийн эхийг бэлтгэх, хийлгэх;
Дүгнэлт: Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3.5 дахь хэсэгт реклам гэсэн үг оруулсан байна. ***Санал:*** Иймд “сурталчилгаа” гэдэг үгийн урьд нь “зар” гэж нэмж, “реклам” гэдэг үгийг хасах.		

7.2.7. Хуульд заасан ишлэл алдаатай эсэх

Зар сурталчилгааны тухай хуульд тухайн хуулийн зүйл заалтыг дараах байдлаар ишлэсэн байх бөгөөд алдаатай ишлэсэн 1 заалт байна.

9 Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. 2008 он. Л.Болд, Т.Пүрэвсүрэн. МУ-ын Шинжлэх ухааны академи.

Д/д	Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/	Ишлэсэн зүйлийн агуулга
1	5.1.Зар сурталчилгаа нь хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон, энэ хуулийн 21.1, 21.2-т заасан журмыг зөрчсөн, бусдын бүтээгдэхүүнийг муутган өөрийн бүтээгдэхүүнийг давуутай гэж харьцуулан сурталчилсан, түүнчлэн энэ хуулийн 7.2.1, 7.2.3-т заасан үйлдэл хийсэн бол иргэн, хуулийн этгээд хуульд заасан үндэслэл, журмын дагуу няцаалт хийлгэх, учирсан гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй.	21.1.Зар сурталчилгаа бүтээгч, түгээгч тухайн зар сурталчилгаа үнэн зөв болохыг нотлох баримтыг зар сурталчилгаа захиалагчаас шаардах эрхтэй. 21.2.Тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагааны хувьд зар сурталчилгаа захиалагч нь өөрийгөө, эсхүл бүтээгдэхүүнээ сурталчлуулахдаа тусгай зөвшөөрлийн гэрчилгээ буюу түүний зохих ёсоор баталгаажсан хуулбарыг үзүүлэх үүрэгтэй. 7.2.1.өөрийн бараг бусдынхтай ижилсгэн сурталчилсан; 7.2.3.хангалттай тодорхой мэдээллийг орхигдуулан, эсхүл мэдлэг, туршлага дутмаг буюу итгэмтгий байдлыг нь ашиглан хэрэглэгчийг төөрөгдөлд оруулсан.
2	7.5.Энэ хуулийн 6.1-д заасныг зөрчсөн, хэрэглэгчийн ухамсарт шууд бусаар нөлөөлөх зар сурталчилгааг далд зар сурталчилгаа гэж тооцно.	6.1.Зар сурталчилгаа нь үнэн, хэрэглэгчдэд хүртээмжтэй байж, агуулга, хэлбэр, түүнийг түгээж байгаа арга хэрэгслээс үл хамааран зар сурталчилгаа гэж ойлгогдохоор байна.
3	7.6.Шүүх энэ хуулийн агуулга, зарчимд нийцүүлэн энэ хуулийн 7 дугаар зүйлд зааснаас бусад үндэслэлээр зар сурталчилгааг хууль бус гэж тооцож болно.	**7 дугаар зүйл. Хууль бус зар сурталчилгаа**
4	14^1.1.2.энэ хуулийн 14.1.1-д зааснаас бусад сонин нэг удаагийн дугаарын хэвлэлийн нэг нүүрний 50 хувиас хэтрэхгүй хэмжээгээр сард 1 удаа;	14.1.1 гэсэн заалт байхгүй бөгөөд 14^1.1.1-ийн “ ^{1} ” тэмдэглэгээг орхиж бичсэн байна. “14^1.1.1.өдөр тутмын сонин нэг нүүрний 50 хувиас хэтрэхгүй хэмжээгээр долоо хоногт 1 удаа”.
5	14^1.2. 18 хувь хүртэл этилийн спирт агуулсан дарс, пиво, шимийн архины зар сурталчилгааг энэ хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу интернэтээр түгээж болно.	**12 дугаар зүйл. Интернэтээр түгээх зар сурталчилгаа**
6	19.2. Энэ хуулийн 19.1-д заасны дагуу өргөсөн хандив нь зар сурталчилгааны төлбөрт тооцогдоно.	19.1.Ивээн тэтгэгч нь гэрээний үндсэн дээр зар сурталчилгаа түгээгчид эд хөрөнгө шилжүүлэх, оюуны үнэт зүйл ашиглуулах, ажил гүйцэтгэх зэргээр үйл ажиллагаанд нь хандив өргөн (ивээн тэтгэж) өөрийгөө, эсхүл бүтээгдэхүүнээ сурталчлуулж болно.
7	21.3.Зар сурталчилгаа бүтээгч, түгээгч нь энэ хуулийн 21.2-т заасан тусгай зөвшөөрлийн гэрчилгээ буюу зохих ёсоор баталгаажсан баримт үзүүлэхийг шаардах эрхтэй.	21.2.Тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагааны хувьд зар сурталчилгаа захиалагч нь өөрийгөө, эсхүл бүтээгдэхүүнээ сурталчлуулахдаа тусгай зөвшөөрлийн гэрчилгээ буюу түүний зохих ёсоор баталгаажсан хуулбарыг үзүүлэх үүрэгтэй.
8	21.4.Зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах нотлох баримт, тайлбар, видео болон аудио бичлэг, бусад мэдээллийг зар сурталчилгаа захиалагч, бүтээгч, түгээгчээс шаардан авах эрхтэй.	**24 дүгээр зүйл. Төрөөс зар сурталчилгаанд тавих хяналт**
9	21.6.Энэ хуулийн 21.1-д заасны дагуу шаардсан нотлох баримтыг гаргаж өгөөгүй бол зар сурталчилгаа бүтээгч, түгээгч холбогдох гэрээг цуцалж, өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэхийг захиалагчаас шаардах эрхтэй.	21.1.Зар сурталчилгаа бүтээгч, түгээгч тухайн зар сурталчилгаа үнэн зөв болохыг нотлох баримтыг зар сурталчилгаа захиалагчаас шаардах эрхтэй.
10	22.2.Энэ хуулийн 22.1-д заасны дагуу урьдчилан мэдээлсэн боловч зар сурталчилгаа захиалагч өөрийн захиалга, даалгаврыг өөрчлөөгүй тохиолдолд зар сурталчилгаа бүтээгч зар сурталчилгаа бэлтгэхээс татгалзах үүрэгтэй.	22.1.Зар сурталчилгаа бүтээгч нь зар сурталчилгаа захиалагчаас өгсөн захиалга, даалгавар нь зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийг зөрчиж байгааг түүнд урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nilo.gov.mn

11	23.2.Нийтэд танил, нэр хүнд бүхий хуулийн этгээдийн нэр, бэлгэдэл, бүтээгдэхүүн, барааны тэмдэг, нэрийн товчлолыг зар сурталчилгаанд ашиглахад энэ хуулийн 23.1-дэх хэсгийн заалт нэгэн адил хамаарна.	23.1.Зар сурталчилгаанд хувь хүн, түүний нэр, алдар нэр, амьдрал ахуй, эд хөрөнгө, уран бүтээлийг үзүүлэх, дүрслэх, хэлсэн үгнээс нь ишлэл татах болон бусад хэлбэрээр ашиглахдаа тухайн хүн, эсхүл өв залгамжлагч, эрх залгамжлагчийн зөвшөөрлийг урьдчилан авна.
12	24.5.Тухайн орон нутгийн хэмжээнд мэдээлэл тараадаг мэдээлэх хэрэгслээр түгээсэн зар сурталчилгаанд аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний томилсон байцаагч хяналт тавих бөгөөд энэ хуулийн 24.4-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.	24.4.Оюуны өмчийн улсын хяналтын албаны байцаагч, Өрсөлдөөний тухай хуульд заасан асуудлаар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9-д зааснаас гадна дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:
13	24.6.Зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийн биелэлтэд эм, био бэлдмэл, эрүүл ахуй, байгаль орчин, чанар, стандартчилал, барилга, тээвэр, гааль, татвар, худалдаа, үйлчилгээ зэрэг мэргэжлийн хяналтын алба, нутгийн захиргааны байгууллага, түүнчлэн энэ хуулийн 6.2-т заасан тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага тус тусын чиг үүргийн дагуу хяналт тавих, бүрэн эрхийнхээ хүрээнд арга хэмжээ авах үүрэгтэй.	6.2.Тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагаатай холбоотой бичмэл зар сурталчилгаанд тусгай зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагын нэр, зөвшөөрлийн дугаарыг тусгасан байна.
14	24.7.Энэ хуулийн 24.6-д заасан хяналтын алба, байгууллага нь зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийг зөрчсөн тухай мэдээллийг тодорхой үндэслэл, саналын хамт зар сурталчилгаанд хяналт тавих эрх бүхий байгууллагад шуурхай ирүүлэх үүрэгтэй.	24.6.Зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийн биелэлтэд эм, био бэлдмэл, эрүүл ахуй, байгаль орчин, чанар, стандартчилал, барилга, тээвэр, гааль, татвар, худалдаа, үйлчилгээ зэрэг мэргэжлийн хяналтын алба, нутгийн захиргааны байгууллага, түүнчлэн энэ хуулийн 6.2-т заасан тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага тус тусын чиг үүргийн дагуу хяналт тавих, бүрэн эрхийнхээ хүрээнд арга хэмжээ авах үүрэгтэй.
15	26.1.Оюуны өмчийн улсын хяналтын алба энэ хуулийн 24.6, 25 дугаар зүйлд заасан этгээдтэй харилцан мэдээлэл солилцох, шаардлагатай хяналт, шалгалт, судалгаа хамтран явуулах зэргээр ажиллаж болно.	**25 дугаар зүйл. Зар сурталчилгаанд тавих олон нийтийн хяналт** 24.6.Зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийн биелэлтэд эм, био бэлдмэл, эрүүл ахуй, байгаль орчин, чанар, стандартчилал, барилга, тээвэр, гааль, татвар, худалдаа, үйлчилгээ зэрэг мэргэжлийн хяналтын алба, нутгийн захиргааны байгууллага, түүнчлэн энэ хуулийн 6.2-т заасан тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага тус тусын чиг үүргийн дагуу хяналт тавих, бүрэн эрхийнхээ хүрээнд арга хэмжээ авах үүрэгтэй.
16	28.1.Энэ хуулийн 25.1, 27.1-д заасан этгээд Оюуны өмчийн улсын хяналтын албаны шийдвэр, үйл ажиллагааны талаар шүүхэд нэхэмжлэл, гомдол гаргаж болно.	25.1.Аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийг зөрчсөн болон түүнтэй холбоотой мэдээллийг тодорхой үндэслэл, саналын хамт эрх бүхий байгууллагад тавих, шаардлагатай бол мэдээлэх хэрэгслээр нийтийг сэрэмжлүүлж болно. 27.1.Оюуны өмчийн улсын хяналтын албаны байцаагчийн шийдвэр, үйл ажиллагааг зөвшөөрөөгүй этгээд зар сурталчилгаанд хяналт тавих эрх бүхий байгууллагын даргад гомдол гаргана.
17	28.2.Энэ хуулийн 27.1, 28.1-д заасны дагуу нэхэмжлэл, гомдол гаргасан нь хариуцлага хүлээлгэх болон захиргааны шийтгэл биелүүлэхийг хойшлуулах үндэслэл болохгүй.	27.1.Оюуны өмчийн улсын хяналтын албаны байцаагчийн шийдвэр, үйл ажиллагааг зөвшөөрөөгүй этгээд зар сурталчилгаанд хяналт тавих эрх бүхий байгууллагын даргад гомдол гаргана. 28.1.Энэ хуулийн 25.1, 27.1-д заасан этгээд Оюуны өмчийн улсын хяналтын албаны шийдвэр, үйл ажиллагааны талаар шүүхэд нэхэмжлэл, гомдол гаргаж болно.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГ
www.legal.mn

18	29.1.2.хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 6.1, 6.3, 6.4 дэх хэсэгт, 6.5.1-6.5.8 дахь заалт, 7 дугаар зүйл, 9.3 дахь хэсэг, 10-14, 14[1], 16, 17 дугаар зүйл, 19.3, 22.1 дэх хэсэг, 23 дугаар зүйлд заасан шаардлагыг зөрчсөн бол гэм буруутай иргэнийг 10000-50000 хүртэл төгрөгөөр, албан тушаалтныг 25000-60000 хүртэл төгрөгөөр, байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-250000 хүртэл төгрөгөөр торгох.	6.1.Зар сурталчилгаа нь үнэн, хэрэглэгчдэд хүртээмжтэй байж, агуулга, хэлбэр, түүнийг түгээж байгаа арга хэрэгслээс үл хамааран зар сурталчилгаа гэж ойлгогдохоор байна. 6.3.Зар сурталчилгаанд статистик мэдээ, судалгааны дүн, баримтыг ашиглахдаа тухайн эх сурвалжийг нь заавал тусгасан байна. 6.4.Хортой, галын аюултай барааны зар сурталчилгаанд тухайн барааны эдгээр шинж чанарын талаар заасан байна. 6.5.1.тусгай зөвшөөрөл аваагүй тохиолдолд тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагааны талаар аливаа зар сурталчилгаа явуулах; 6.5.2.Монгол Улсын хууль тогтоомжоор үйлдвэрлэх, худалдах, улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон бүтээгдэхүүнийг сурталчлах; 6.5.3.тарифын бус хязгаарлалт тогтоосон барааг сурталчлах; 6.5.4.хуульд заасны дагуу чанар, стандарт, эрүүл ахуйн баталгаажуулалтад заавал хамруулах бүтээгдэхүүнийг ийнхүү баталгаажуулаагүй бол сурталчлах; 6.5.5.Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчих үйлдэл, үйл ажиллагаанд хүргэж болох зар сурталчилгааг; 6.5.6.хуульд заасны дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх төслийг үнэлгээ хийлгэхээс өмнө, эсхүл үнэлгээ хийгдсэн боловч төслийг хэрэгжүүлэх боломжгүй гэсэн дүгнэлт гарсан бол уг төслийг сурталчлах; 6.5.7.айдас төрүүлэх, хүчирхийлэл, садар самуунд уруу татах, түүнчлэн хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд гэм хор учруулах үйлдэл, үйл ажиллагаанд хүргэж болох зар сурталчилгааг; 6.5.8.хуулиар сурталчлахыг хориглосон бараа, ажил, үйлчилгээг сурталчилах. **7 дугаар зүйл. Хууль бус зар сурталчилгаа** 9.3.Гадна зар сурталчилгаа нь замын хөдөлгөөн зохицуулах дохио, тэмдэг, тэмдэглэлтэй төстэй байх, тэдгээрийг халхлах, далдлах болон бусад хэлбэрээр замын хөдөлгөөнд саад учруулахыг хориглоно. **10 дугаар зүйл. Харилцуур утасны болон бусад лавлахаар түгээх зар сурталчилгаа** **11 дүгээр зүйл. Радио, телевизээр түгээх зар сурталчилгаа** **12 дугаар зүйл. Интернэтээр түгээх зар сурталчилгаа** **13 дугаар зүйл. Эрүүл мэндийн салбар дахь зар сурталчилгаа** **14 дүгээр зүйл. Байгаль орчны салбар дахь зар сурталчилгаа** **14[1] дүгээр зүйл. Хатуулаг багатай дарс, пиво, шимийн архины зар сурталчилгаа** **16 дугаар зүйл. Зар сурталчилгаа бүтээх, байрлуулах, түгээхэд хүүхдийгн эрхийг хамгаалах** **17 дугаар зүйл. Банк, санхүү, хөрөнгө оруулалтын сан, даатгалын үйл ажиллагаа, үнэт цаасны зар сурталчилгаа** 19.3.Ивээн тэтгэгч зар сурталчилгаа түгээгчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно. 22.1.Зар сурталчилгаа бүтээгч нь зар сурталчилгаа захиалагчаас өгсөн захиалга, даалгавар нь зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийг зөрчиж байгааг түүнд урьдчилан мэдэгдэх үүрэгтэй. **23 дугаар зүйл. Зар сурталчилгаа бүтээх, түгээхэд хувь хүн, хуулийн этгээдийн оролцоо**

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ САН
www.nli.mn

19	29.2.Энэ хуулийн 29.1-д заасан захиргааны хариуцлага нь хууль тогтоомжийн бусад актад заасан хариуцлага, зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэл, үйл ажиллагааг таслан зогсоох шаардлагыг биелүүлэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.	29.1.2.хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 6.1, 6.3, 6.4 дэх хэсэгт, 6.5.1-6.5.8 дахь заалт, 7 дугаар зүйл, 9.3 дахь хэсэг, 10-14, 14[1], 16, 17 дугаар зүйл, 19.3, 22.1 дэх хэсэг, 23 дугаар зүйлд заасан шаардлагыг зөрчсөн бол гэм буруутай иргэнийг 10000-50000 хүртэл төгрөгөөр, албан тушаалтныг 25000-60000 хүртэл төгрөгөөр, байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-250000 хүртэл төгрөгөөр торгох.
Дүгнэлт: Зар сурталчилгааны тухай хуульд тухайн хуулиас нийт 19 ишлэл авсан бөгөөд 18 ишлэлүүд алдаагүй байна. 1 ишлэл алдаатай байна. **1/** 14[1].1.2.энэ хуулийн 14.1.1-д зааснаас бусад сонин нэг удаагийн дугаарын хэвлэлийн нэг нүүрний 50 хувиас хэтрэхгүй хэмжээгээр сард 1 удаа; 14.1.1 гэсэн заалт байхгүй бөгөөд 14[1].1.1-ийн “[1]” тэмдэглэгээг орхиж бичсэн байна. Энэ ишлэлийн алдаа нь ХЗДХЯ-ны архивын хяналтын хувьд алдаагүй бичигдсэн бөгөөд бусад эх сурвалж болох Улсын Их хурлын Тамгын газрын архив, Legalinfo.mn сайтад байгаа Зар сурталчилгааны хуульд алдаатай бичигдсэн байна. ***Санал:*** Тэмдэглэгээг засаж бичих.		

7.2.8. Тухайн хуульд бусад хуулиас авсан ишлэлийн дугаар нь нөгөө хуульд байгаа зохицуулалттай нийцэж байгаа эсэх

Д/д	Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/	Ишлэсэн зүйлийн агуулга
1	24.3.Оюуны өмчийн улсын хяналтын алба, Өрсөлдөөний тухай хуульд заасан асуудлаар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар нь **Төрийн хяналт шалгалтын тухай** хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:	Төрийн хяналт шалгалтын тухай хууль /2003.01.03/ нь 4 бүлэг 16 зүйлтэй. Ишлэл нь алдаатай байна.
Дүгнэлт: Төрийн хяналт шалгалтын тухай хууль нь анх 1995 оны 3 дугаар сарын 27-нд 7 бүлэг, 27 зүйлтэй батлагдаж байсан ба 2003 оны 1 дүгээр сарын 03-ны өдөр 4 бүлэг 16 зүйлтэй шинэ хууль батлагдсанаар хуучин хууль нь хүчингүй болсон. Зар сурталчилгааны тухай хуульд хүчингүй болсон хуулийн ишлэлийг өөрчлөөгүй байна. ***Санал:*** Төрийн хяналт шалгалтын тухай хуулиас холбогдох зүйл заалтыг олж ишлэлийг өөрчлөх.		

7.2.12. Тухайн хуулийн тодорхой зохицуулалтыг Улсын дээд шүүхээс тайлбарлаж байсан эсэх, энэхүү тайлбар нь түүний зөрчлийг арилгахад чиглэгдсэн эсэх

Зар сурталчилгааны тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг тайлбарласан тогтоол Улсын дээд шүүхээс гараагүй боловч дараах хуулийн зүйл заалтыг тайлбарласан УДШ-ийн тогтоол байгаа нь Зар сурталчилгааны тухай хуулийн зарим заалтад хамаарч байна.

2000 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн “Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай” 151 дүгээр тогтоолд:

“4.Энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт заасан “Согтууруулах ундаа худалдах, борлуулах, хэрэглэх талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа хийхийг хориглоно” гэснийг бүх төрлийн сонин, сэтгүүл, радио, телевизээр болон зурагт ухуулах хуудсаар энэ хуулинд нэр заагдсан согтууруулах ундааг худалдан авах, хэрэглэхийг уриалсан, ухуулсан зар сурталчилгаа, рекламыг хамааруулан ойлгоно.” гэж заасан нь Зар сурталчилгааны тухай хуулийн зарим зүйл заалттай нийцэж байна. Гэвч “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль”-ийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт 2003 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр өөрчлөн найруулалт хийгдсэн байна. Харин УДШ-ийн 151 дүгээр тогтоол хүчингүй болоогүй байгаа нь зөрчилдөж байна. Иймд уг тогтоолыг хүчингүй болгох саналтай байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

7.2.13. Тухайн хуулийн зүйл, заалт уг хуулийн болон өөр хуулийн заалттай зөрчилдөж буй эсэх

Зар сурталчилгааны хуулиар нийгмийн зарим онцлог салбарт явуулах зар сурталчилгааг хэрхэн түгээх, тэдгээрт тавих шаардлагыг дараах байдлаар зохицуулсан:

- Эрүүл мэндийн салбар дахь зар сурталчилгааны талаар хуулийн 13 дугаар зүйлд;

- Банк, санхүү, хөрөнгө оруулалтын сан, даатгалын үйл ажиллагаа, үнэт цаасны зар сурталчилгаанд тавигдах шаардлага, тэдгээрийг түгээх онцлогийн талаар хуулийн 17 дугаар зүйлд;

- Хууль бус зар сурталчилгааны талаар 7 дугаар зүйлд тус тус зааж өгсөн.

Зар сурталчилгааны тухай хуулийн 29 дүгээр зүйлд уг хууль зөрчигсдөд хүлээлгэх захиргааны хариуцлагыг тусгасан бөгөөд 29.1.2 дахь хэсэгт дээрх харилцаатай холбоотойгоор захиргааны зөрчил гаргасан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг заасан.

Гэтэл Зар сурталчилгааны тухай хуулийн 7, 13, 17 дугаар зүйлийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг Зар сурталчилгааны тухай хуулиар тогтоож өгсөн байхад Эм эмнэлгийн хэрэгсэлийн тухай хууль, Банкны тухай хууль, Банк бус санхүүгийн тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулиудад дээрх зүйл, заалтыг зөрчсөн нөхцөлд давхар хариуцлага ногдуулахаар заасан нь захиргааны нэг зөрчилд нэг хариуцлага ногдуулах буюу өөрөөр хэлбэл, эрх зүйн онолын нэг зөрчилд хариуцлагыг давхардуулж ногдуулж үл болно гэсэн зарчмыг алдагдуулж байна.

Үүнийг тодорхой болгох үүднээс Зар сурталчилгааны тухай хуулийн 7, 13, 17 дугаар зүйлийн зохицуулалт бусад хуулийн зарим зүйл заалттай хэрхэн давхардаж байгаа болон нэг зөрчилд хүлээлгэх хариуцлага хууль тус бүрт харилцан адилгүй байгааг доорх хүснэгтээр харуулав. Мөн зар сурталчилгаатай холбоотой аливаа харилцааг Зар сурталчилгааны тухай хуулиар зохицуулахаар бусад хуулийн зүйл заалтыг хүчингүй болгох санал оруулаа.

Д/д	Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль /2010.05.27/
1	13.4.Эм, эмийн зүйлс (цаашид “эм” гэх)-ийн зар сурталчилгаанд дараах зүйлийг хориглоно:	27.4.Эмийн зар сурталчилгаанд Зар сурталчилгааны тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаас гадна дараах зүйлийг хориглоно:
2	29.1.Энэ хуулийг зөрчсөн гэм буруутай этгээдэд Оюуны өмчийн улсын хяналтын албаны байцаагч дараах захиргааны шийтгэл ногдуулна: 29.1.2.хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 6.1, 6.3, 6.4 дэх хэсэгт, 6.5.1-6.5.8 дахь заалт, 7 дугаар зүйл, 9.3 дахь хэсэг, **10-14**, 14[1], 16, 17 дугаар зүйл, 19.3, 22.1 дэх хэсэг, 23 дугаар зүйлд заасан шаардлагыг зөрчсөн бол гэм буруутай иргэнийг 10000-50000 хүртэл төгрөгөөр, албан тушаалтныг 25000-60000 хүртэл төгрөгөөр, байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-250000 хүртэл төгрөгөөр торгох.	29.2.Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх болон хуурамч эм үйлдвэрлэх, импортлох, экспортлох, түгээх, худалдахтай холбоотойгоос бусад байдлаар эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дор дурдсан захиргааны шийтгэлийг шүүгч, эсхүл улсын байцаагч ногдуулна: 29.2.11.энэ хуулийн 26, 27 дугаар зүйлийг зөрчсөн иргэнийг 200000-300000 төгрөгөөр, албан тушаалтныг 300000-500000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 1000000-1500000 төгрөгөөр торгох.

Дүгнэлт:
1.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.4, 27.4.3 дахь заалтууд нь Зар сурталчилгааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2, 13.4 дэх заалтуудтай агуулгын болон бичвэрийн хувьд давхардаж байгааг аргачлалын 7.1.2-д заасан.
2.Дээрх давхардаж байгаа заалтуудад ногдуулах хариуцлагын хэмжээ нь харилцан адилгүй байгаа бөгөөд мөн хоёр байгууллага давхардуулж хариуцлага ногдуулж байгаа нь зөрчилдөж байна.
Санал:
1.Эм, эмнэлгийн хэрэгсэлийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.11 дэх хэсгийг хүчингүй болгох.
2.Зар сурталчилгааны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн торгуулийн хэмжээг хууль батлагдах үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцон тогтоосон. Өнөөдөр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ тэр үеэс бараг 5 дахин өссөн. Иймд Зар сурталчилгааны тухай хуулийн хариуцлагын хэмжээг өөрчлөх.

Д/д	Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/	Банкны тухай хууль /2010.01.28/
3	17 дугаар зүйл. Банк, санхүү, хөрөнгө оруулалтын сан, даатгалын үйл ажиллагаа, үнэт цаасны зар сурталчилгаа 17.1.**Банкны үйл ажиллагааны зар сурталчилгаа нь тухайн банкны төлбөрийн чадварын болон банкны хуулиар заагдсан бусад үзүүлэлтүүдэд үндэслэсэн, үнэн зөв байна.** Банкны үйл ажиллагааны зар сурталчилгаанд мөнгөн хадгаламжийн гэрээний гол нөхцлүүдийн талаар заавал мэдээлнэ. 29.1.2.хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 6.1, 6.3, 6.4 дэх хэсэгт, 6.5.1-6.5.8 дахь заалт, 7 дугаар зүйл, 9.3 дахь хэсэг, 10-14, 14[1],16, **17** дугаар зүйл, 19.3, 22.1 дэх хэсэг, 23 дугаар зүйлд заасан шаардлагыг зөрчсөн бол гэм буруутай иргэнийг 10000-50000 хүртэл төгрөгөөр, албан тушаалтныг 25000-60000 хүртэл төгрөгөөр, байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-250000 хүртэл төгрөгөөр торгох.	**8 дугаар зүйл. Банкны зар сурталчилгаа** **8.1.Банкнаас хийх зар сурталчилгаа нь түүний тухайн үеийн үйл ажиллагааг үнэн зөв тусгасан, хууль тогтоомжид нийцсэн байна.** 68.1.Банкны тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд Монголбанкны хянан шалгагч дараах хариуцлага ногдуулна: 68.1.11.энэ хуулийн **8 дугаар** зүйлд заасныг зөрчин хуурамч, худал ташаа мэдээлэл бүхий зар сурталчилгааг тараасан бол тухайн банк, түүний хараат болон охин компанийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 200-250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, уг зар сурталчилгааг тараах үед ажиллаж байсан гүйцэтгэх удирдлагыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-25 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох;

Дүгнэлт:
1.Зар сурталчилгааны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17. 1, Банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг агуулгын хувьд давхардаж байгааг аргачлалын 7.1.2-д заасан.
2.Дээрх давхардаж байгаа заалтуудад ногдуулах хариуцлагын хэмжээ нь харилцан адилгүй байгаа бөгөөд мөн хоёр байгууллага давхардуулж хариуцлага ногдуулж байгаа нь зөрчилдөж байна.
Санал:
1.Зар сурталчилгааны тухай хуулийн банкинд ногдуулах торгуулийн хэмжээг Банкны тухай хуулийн хариуцлага ногдуулах торгуулийн хэмжээтэй ойролцоо болгох.
2.Банкны тухай хуулийн 68.1.11 дэх заалтыг хүчингүй болгох.

Д/д	Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/	Банкны тухай хууль /2010.01.28/	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль /2002.12.12/
4

Д/д	Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/	Өрсөлдөөний тухай хууль /2010.06.10/
6	7.1.Хууль бус зар сурталчилгаанд зүй бус, бодит байдалд үл нийцсэн, ёс суртахуунд үл нийцсэн, далд зар сурталчилгаа хамаарна. 7.2.Дараах зар сурталчилгааг зүй бус зар сурталчилгаанд тооцно: 7.2.2.бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд харш сурталчилгаа; 7.4.Дараах зар сурталчилгааг ёс суртахуунд үл нийцсэнд тооцно: 7.4.1.бусдын бүтээгдэхүүнийг гутаан доромжилсон; 29.1.2.хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 6.1, 6.3, 6.4 дэх хэсэгт, 6.5.1-6.5.8 дахь заалт, **7 дугаар зүйл,** 9.3 дахь хэсэг, 10-14, 14[1], 16, 17 дугаар зүйл, 19.3, 22.1 дэх хэсэг, 23 дугаар зүйлд заасан шаардлагыг зөрчсөн бол гэм буруутай иргэнийг 10000-50000 хүртэл төгрөгөөр, албан тушаалтныг 25000-60000 хүртэл төгрөгөөр, байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-250000 хүртэл төгрөгөөр торгох.	12.1.Аж ахуй эрхлэгч өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 12.1.1.өрсөлдөгчийн болон түүний бараа бүтээгдэхүүний нэр хүндийг гутаах, эсхүл өрсөлдөгчөө алдагдалд оруулж болохуйц худал, зөрүүтэй буюу гуйвуулсан мэдээ тараах; 12.1.3.өрсөлдөөнд харш үр дагавар үзүүлэх зар сурталчилгаа явуулах; 27.1.Өрсөлдөөний тухай хууль тогтоомж зөрчигчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол улсын байцаагч хохирлын хэмжээг харгалзан дараах захиргааны шийтгэл ногдуулна: 27.1.3.энэ хуулийн 12.1-д заасныг зөрчсөн аж ахуй эрхлэгчийг 10 000 000 хүртэл төгрөгөөр торгох, хууль бусаар олсон орлого, эд зүйлийг хураах;
Дүгнэлт: Зар сурталчилгааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2, 7.4.1, Өрсөлдөөний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3 дах хэсэг ижил зохицуулалтад хоёр өөр байгууллага давхардуулан хариуцлага тооцож байна. ***Санал****:* Иймд Өрсөлдөөний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3 дахь хэсгийг хүчингүй болгох.		

Д/д	Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/	Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль /2004.04.30/	Даатгалын тухай хууль /2004.04.30/
7 8	6.1.**Зар сурталчилгаа нь үнэн,** хэрэглэгчдэд хүртээмжтэй байж, агуулга, хэлбэр, түүнийг түгээж байгаа арга хэрэгслээс үл хамааран зар сурталчилгаа гэж ойлгогдохоор байна. 7.5.Энэ хуулийн 6.1-д заасныг зөрчсөн, хэрэглэгчийн ухамсарт шууд бусаар нөлөөлөх зар сурталчилгааг далд зар сурталчилгаа гэж тооцно. 29.1.2.хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 6.1, 6.3, 6.4 дэх хэсэгт, 6.5.1-6.5.8 дахь заалт, **7 дугаар зүйл,** 9.3 дахь хэсэг, 10-14, 14[1],16, 17 дугаар зүйл, 19.3, 22.1 дэх хэсэг, 23 дугаар зүйлд заасан шаардлагыг зөрчсөн бол гэм буруутай иргэнийг 10000-50000 хүртэл төгрөгөөр, албан тушаалтныг 25000-60000 хүртэл төгрөгөөр, байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-250000 хүртэл төгрөгөөр торгох.	**28 дугаар зүйл. Төөрөгдүүлсэн зар сурталчилгаа** 28.1.Даатгалын мэргэжлийн оролцогч нь төөрөгдүүлсэн, эсхүл **худал мэдээлэл агуулсан зар сурталчилгаа,** мэдээлэл, товхимол болон түүнтэй адилтгах бусад бичиг баримт гаргах, тараах, тараахыг зөвшөөрөхийг хориглоно. 28.2.Даатгалын мэргэжлийн оролцогч болон түүний нэрийн өмнөөс гаргасан мэдээлэл, товхимол болон түүнтэй адилтгах бусад баримт бичиг нь төөрөгдүүлсэн буюу худал мэдээлэл агуулсан, эсхүл нийтийн ашиг сонирхолд харшилсан гэж үзвэл Зохицуулах хороо тухайн баримт бичгийг гаргахыг хориглох, няцаахыг даалгах, эсхүл шаардлагатай гэж үзсэн өөрчлөлт, залруулга хийж гаргахыг бичгээр даалгана.	**58 дугаар зүйл. Төөрөгдүүлсэн зар сурталчилгаа** 58.1.Даатгагч нь төөрөгдүүлсэн, эсхүл **худал мэдээлэл агуулсан зар сурталчилгаа,** мэдээлэл, товхимол болон түүнтэй адилтгах бусад баримт бичиг гаргах, тараах, тараахыг зөвшөөрөхийг хориглоно. 58.2.Даатгагчийн болон түүний нэрийн өмнөөс гаргасан мэдээлэл, товхимол болон түүнтэй адилтгах бусад баримт бичиг нь төөрөгдүүлсэн буюу худал мэдээлэл агуулсан, эсхүл нийтийн ашиг сонирхолд харшилсан гэж үзвэл Зохицуулах хороо тухайн баримт бичгийг гаргахыг хориглох, няцаахыг даалгах, эсхүл шаардлагатай гэж үзсэн өөрчлөлт, залруулга хийж гаргахыг бичгээр даалгана.

ХУУЛЬ ЗҮЙН УНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГ www.mn

Дүгнэлт:
1.Зар сурталчилгааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалт, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, Даатгалын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1 дэх хэсэгтэй агуулгын хувьд тус тус давхардаж байгаа.
2.Мөн ижил зохицуулалтад хоёр өөр байгууллага давхардуулан хариуцлага тооцож байгаа нь зөрчилдөж байна.
Санал: Иймд Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2, Даатгалын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2 дэх хэсгийг хүчингүй болгох.

Д/д	Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль /2000.01.28/
9	**14[1] дүгээр зүйл. Хатуулаг багатай дарс, пиво, шимийн архины зар сурталчилгаа** 29.1.2.хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 6.1, 6.3, 6.4 дэх хэсэгт, 6.5.1-6.5.8 дахь заалт, 7 дугаар зүйл, 9.3 дахь хэсэг, 10-14, **14[1],** 16, 17 дугаар зүйл, 19.3, 22.1 дэх хэсэг, 23 дугаар зүйлд заасан шаардлагыг зөрчсөн бол гэм буруутай иргэнийг 10000-50000 хүртэл төгрөгөөр, албан тушаалтныг 25000-60000 хүртэл төгрөгөөр, байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-250000 хүртэл төгрөгөөр торгох.	9.2. Дараах хэлбэрээр согтууруулах ундаа сурталчлахыг хориглоно: 9.2.7.Зар сурталчилгааны тухай хуулийн 14[1] дүгээр зүйлд зааснаас бусад тохиолдолд 18 хувь хүртэл этилийн спирт агуулсан дарс, пиво, шимийн архины зар сурталчилгааг явуулах. 16.1. Энэ хуулийг зөрчсөн этгээдэд дараах захиргааны шийтгэл ногдуулна: 16.1.12. энэ хуулийн **9.2,** 9.3-т заасныг зөрчсөн бол албан тушаалтныг 35000-60000, аж ахуйн нэгж, байгууллагыг 200000-250000 төгрөгөөр торгож, согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох;

Дүгнэлт: Зар сурталчилгааны тухай хуулийн 14[1] дүгээр зүйл, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.7 дахь заалтууд зөрчигдсөн тохиолдолд хоёр өөр байгууллага давхардуулан хариуцлага тооцохоор тус тусын хуульд заасан нь зөрчилдөж байна.
Санал*:* Иймд Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийг хүчингүй болгож, Зар сурталчилгааны тухай хуульд оруулах.

Д/д	Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/	Олон нийтийн радио, телевизийн тухай хууль /2005.01.27/
10	7.1.Хууль бус зар сурталчилгаанд зүй бус, бодит байдалд үл нийцсэн, ёс суртахуунд үл нийцсэн, далд зар сурталчилгаа хамаарна.	13.1. Олон нийтийн радио, телевизээр арилжааны болон далд зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно.

Дүгнэлт: Зар сурталчилгааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт *хууль бус* зар сурталчилгаа гэдэгт *зүй бус, бодит байдалд үл нийцсэн, ёс суртахуунд үл нийцсэн, далд зар сурталчилгаа* хамаарахаар заасан. Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт арилжааны болон *далд* зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно гэж заасан. Энэ нь *далд* зар сурталчилгааг хориглоод *зүй бус, бодит байдалд үл нийцсэн, ёс суртахуунд үл нийцсэн* зар сурталчилгааг хориглоогүй нэвтрүүлж болохоор мэт байна.
Санал*:* Иймд Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “далд” гэдгийг “хууль бус“ гэж өөрчлөх.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

III. ХИЙДЭЛ

Зар сурталчилгааны тухай хуульд хийдэл байгаа эсэхийг дараах аргачлалаар тогтоолоо:

7.3.1. Тухайн хуульд тодорхой харилцааг нарийвчлан хуулиар зохицуулахаар заасан бол уг нарийвчилсан зохицуулалт бүхий хууль батлагдсан эсэх

Д/д	Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/	Нарийвчилсан зохицуулалт бүхий хууль батлагдсан эсэх
1	4.2.Зар сурталчилгаа нь Монгол Улсын хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тохиолдолд бүхэлдээ, эсхүл хэсэгчлэн **оюуны өмчийн эрхийн тухай** хууль тогтоомжоор хамгаалагдана.	**Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай** /2006.01.19/ **7 дугаар зүйл. Зохиогчийн эрхээр хамгаалах бүтээл** 7.1.9.дуу авиа бүхий дүрст бүтээл; 3.1.13.“дуу авиа бүхий дүрст бүтээл” гэж ямар материаллаг хэлбэрт оруулснаас үл шалтгаалан, техник хэрэгсэл ашиглан бүтээсэн дүрсийг дуу авианы хамт үзүүлэх боломжтой бүтээлийг;
2	21.5.Энэ зүйлд заасны дагуу зар сурталчилгаа бүтээгч, түгээгчийн талаар мэдээлэлтэй болсон этгээд тэдгээрийн **нууцыг хууль** тогтоомжид заасны дагуу хадгалах үүргэтэй бөгөөд энэхүү үүргээ биелүүлээгүй бол холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.	**Хувь хүний нууцын тухай** /1995.04.21/ 5.4.Хувь хүний нууцыг хуулийн дагуу болон итгэмжлэлээр олж мэдсэн этгээд бусдад задруулахыг хориглоно. 8.Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалтыг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч 20000-50000 төгрөгөөр торгох захиргааны шийтгэл ногдуулна. **Байгууллагын нууцын тухай** /1995.05.16/ 5.2.Байгууллагын нууцыг хариуцаж байгаа, эсхүл түүнтэй албан үүрэг, мэргэжлийн үйл ажиллагааны дагуу танилцсан, олж мэдсэн этгээд уул нууцыг чанд хадгалах үүрэгтэй. 9.Байгууллагын нууцыг хариуцдаг, эсхүл түүнтэй танилцсан этгээд уул нууцыг задруулсан бол хөдөлмөрийн гэрээ, тухайн байгууллагын дотоод журамд заасны дагуу хариуцлага хүлээх бөгөөд хуулиар тогтоосон байгууллагын нууцыг задруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч 20000-50000 төгрөгөөр торгох захиргааны шийтгэл ногдуулна.
Дүгнэлт: Зар сурталчилгааны тухай хуульд заасан нарийвчилсан зохицуулалт бүхий хуулиуд батлагдсан байна.		

7.3.2. Тухайн хуульд тодорхой харилцааны нарийвчилсан зохицуулалтыг батлах эрхийг төрийн бусад байгууллагад шилжүүлсэн бол уг нарийвчилсан зохицуулалт батлагдсан эсэх

Д/д	Тодорхой харилцааны нарийвчилсан зохицуулалтыг батлах эрх бүхий төрийн байгууллага	Батлагдсан эсэх
1	9.4.Нийтийн эзэмшлийн газар, барилга, байгууламж дээр зар сурталчилгаа байрлуулах зөвшөөрөл олгох нийтлэг журмыг тухайн орон нутгийн өөрөө удирдах байгууллага тогтооно.	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Журам шинэчлэн батлах тухай” 2006 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 145 дугаар тогтоол
		Дархан-Уул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн “Журам батлах” тухай 2004 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 31 дүгээр тогтоол
2	24.3.Оюуны өмчийн улсын хяналтын алба, Өрсөлдөөний тухай хуульд заасан асуудлаар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 24.3.3.зар сурталчилгаа бүтээх, байрлуулах, түгээхэд баримтлах зөвлөмж, гэрээний үлгэрчилсэн загварыг батлах;	Хууль зүйн үндэсний хүрээлэн, Нийслэлийн Цагдаагийн газар, Оюуны өмчийн газрын хамтарсан журам 2009 он

Дүгнэлт: Зар сурталчилгааны тухай хуульд Орон нутгийн өөрөө удирдах байгууллага, Оюуны өмчийн улсын хяналтын албанаас журам гаргахаар заасан бөгөөд эдгээр журмыг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргаж хэрэгжүүлж байна.

7.3.4. Тодорхой эрх, үүргийг хэрэгжүүлэх субъект нь тодорхой эсэх

Д/д	Эрх , үүрэг хэрэгжүүлэх субъект	Хамаарах зүйл
1	Зар сурталчилгаа захиалагч	19, 20, 21, 22
2	Зар сурталчилгаа бүтээгч	19, 20, 21, 22
3	Зар сурталчилгаа түгээгч	19, 20, 21, 22
4	Оюуны өмчийн улсын хяналтын алба	24
5	Оюуны өмчийн улсын хяналтын албаны байцаагч	24, 29
6	Эм, био бэлдмэл, эрүүл ахуй, байгаль орчин, чанар, стандартчилал, барилга, тээвэр, гааль, татвар, худалдаа, үйлчилгээ зэрэг мэргэжлийн хяналтын алба, нутгийн захиргааны байгууллага, тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага	24
7	Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллага	25
8	Аймаг, нийслэлийн Засаг дарга, томилсон байцаагч	24

Дүгнэлт: Зар сурталчилгааны тухай хуульд эрх, үүрэг хэрэгжүүлэх субъектыг зааж тэдгээрийн эрх, үүргийг тодорхой зааж өгсөн байна.

Харин Зар сурталчилгааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Мэдээлэх хэрэгсэл ашиглан сурвалжлага, мэдээ, тоймчийн нийтлэл болон зар сурталчилгааны бус хэлбэрээр зар сурталчилгаа байрлуулсан, түгээсний төлөө төлбөр авахыг хориглоно.” гэсэн заалт нь аль субьектэд хамаарагдах эрх, үүрэг болох нь тодорхойгүй байна.

Санал: Аль субьектэд хамаарагдахыг тодорхой болгох.

7.3.6. Хуульд заасан хориглосон зохицуулалт нь түүнийг зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх

Д/д	Хуульд заасан хориглосон зохицуулалт	Хариуцлагыг заасан зүйл заалт
1	6.5.Зар сурталчилгаа бүтээх, түгээхэд дараах зүйлийг хориглоно: 6.5.1.тусгай зөвшөөрөл аваагүй тохиолдолд тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагааны талаар аливаа зар сурталчилгаа явуулах; 6.5.2.Монгол Улсын хууль тогтоомжоор үйлдвэрлэх, худалдах, улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон бүтээгдэхүүнийг сурталчлах; 6.5.3.тарифын бус хязгаарлалт тогтоосон барааг сурталчлах; 6.5.4.хуульд заасны дагуу чанар, стандарт, эрүүл ахуйн баталгаажуулалтад заавал хамруулах бүтээгдэхүүнийг ийнхүү баталгаажуулаагүй бол сурталчлах; 6.5.5.Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчих үйлдэл, үйл ажиллагаанд хүргэж болох зар сурталчилгааг; 6.5.6.хуульд заасны дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх төслийг үнэлгээ хийлгэхээс өмнө, эсхүл үнэлгээ хийгдсэн боловч төслийг хэрэгжүүлэх боломжгүй гэсэн дүгнэлт гарсан бол уг төслийг сурталчлах; 6.5.7.айдас төрүүлэх, хүчирхийлэл, садар самуунд уруу татах, түүнчлэн хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд гэм хор учруулах үйлдэл, үйл ажиллагаанд хүргэж болох зар сурталчилгааг; 6.5.8.хуулиар сурталчлахыг хориглосон бараа, ажил, үйлчилгээг сурталчилах.	29.1.2
2	7.7.Хууль бус зар сурталчилгаа захиалах, бүтээх, түгээхийг хориглоно.	29.1.2
3	9.3.Гадна зар сурталчилгаа нь замын хөдөлгөөн зохицуулах дохио, тэмдэг, тэмдэглэлтэй төстэй байх, тэдгээрийг халхлах, далдлах болон бусад хэлбэрээр замын хөдөлгөөнд саад учруулахыг хориглоно.	29.1.2
4	11.3.Улс орны болон дэлхий дахины амьдралын цаг үеийн шинжтэй үйл явдлын талаархи тогтмол мэдээллийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно.	29.1.2
5	11.5.Үргэлжлэх хугацаа нь 20 минутаас дээшгүй нэвтрүүлгийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно.	29.1.2
6	12.1.Зар сурталчилгаа түгээгч нь бусдын эзэмшилд байгаа интернэтийн хуудсанд өөрийн зар сурталчилгаагаа зөвшөөрөлгүй байрлуулахыг хориглоно.	29.1.2

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.pli.gov.mn

7	13.4.Эм, эмийн зүйлс (цаашид “эм” гэх)-ийн зар сурталчилгаанд дараах зүйлийг хориглоно:	29.1.2
8	13.5.Аймаг, нийслэлийн хүн, мал эмнэлгийн удирдах болон мэргэжлийн байгууллагаас тусгай зөвшөөрөл аваагүй эм хангамжийн байгууллага (эмийн үйлдвэр, эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сан)-ыг сурталчлахыг хориглоно.	29.1.2
9	13.6.Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлгүй эрүүл мэндийн байгууллага, эмчлэх эрхгүй мэргэжилтэн, эрх, зөвшөөрөл аваагүй буюу баталгаажаагүй эмчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээг сурталчлахыг хориглоно.	29.1.2
10	13.8.Эмнэлгийн үйлчилгээний талаар магтсан, үйлчлүүлэхийг уриалсан сурталчилгаа явуулахыг хориглоно.	29.1.2
11	14.1.Нэн ховор, ховор ургамал, амьтны жагсаалтад орсон болон тэдгээрийн үндэс, иш, мөчир, навч, бугын цусан эвэр, чив, засаа, согооны сүүл, сав, хүдрийн заар, баавгайн доньд зэрэг эрхтэнийг бэлтгэх, худалдах, худалдан авах тухай зар сурталчилгааг хориглоно.	29.1.2
12	14.2.Хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд Засгийн газраас гаргасан шийдвэрийн дагуу тодорхой хугацаанд агнах, бэлтгэхийг хориглосон амьтан, ургамлын эд эрхтэн, түүхий эдийг худалдах, худалдан авах тухай зар сурталчилгаа явуулахыг хориглоно.	29.1.2
13	16.1.Зар сурталчилгаа бүтээх, байрлуулах, түгээхэд дараах зүйлийг хориглоно:	29.1.2
14	17.2.Хөрөнгө оруулалтын сан, үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд болон үнэт цаас гаргагч, банк, санхүү, даатгалын болон бусдын мөнгөн хөрөнгийг ашиглах, захиран зарцуулахтай холбоотой бусад үйлчилгээ, үйл ажиллагаа, түүнчлэн үнэт цаасны зар сурталчилгааг бүтээх, тоон мэдээ, үзүүлэлтийг ашиглах, түгээхэд дараах зүйлийг хориглоно:	29.1.2
15	18.1.Мэдээлэх хэрэгсэл ашиглан сурвалжлага, мэдээ, тоймчийн нийтлэл болон зар сурталчилгааны бус хэлбэрээр зар сурталчилгаа байрлуулсан, түгээсний төлөө төлбөр авахыг хориглоно.	Тодорхой заагаагүй
16	19.3.Ивээн тэтгэгч зар сурталчилгаа түгээгчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно.	29.1.2
	Эрүүгийн хуулийн зохицуулалт	
1	169.1.Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны байгууллагын ажилтан буруу жинлэх буюу хэмжих, үнэ, тарифыг өсгөх, баталгаагүй буюу баталгааны хугацаа дууссан жин, хэмжүүр ашиглах, хэмжих хэрэгслийн заалтыг санаатай өөрчлөх, бараа бүтээгдэхүүний чанар, нэр төрөл, хэмжээ, хэрэглээний шинж байдлын талаар зориуд худал мэдээлэл өгөх, хуурамч зар сурталчилгаа явуулах зэргээр хэрэглэгчдийг хуурч мэхэлсэн, төөрөгдүүлсний улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. 169.2.Энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавиас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	**169 дүгээр зүйл. Хэрэглэгчийг хуурч мэхлэх, төөрөгдүүлэх**
Дүгнэлт: Хуульд заасан хориглосон зохицуулалтад хүлээлгэх хариуцлагыг 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заагаагүй байна. ***Санал:*** 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт хүлээлгэх хариуцлагыг тодорхой зааж өгөх.		

Д/д	Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/
1	21.2.Тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагааны хувьд зар сурталчилгаа захиалагч нь өөрийгөө, эсхүл бүтээгдэхүүнээ сурталчлуулахдаа тусгай зөвшөөрлийн гэрчилгээ буюу түүний **зохих ёсоор баталгаажсан** хуулбарыг үзүүлэх үүрэгтэй. 21.3.Зар сурталчилгаа бүтээгч, түгээгч нь энэ хуулийн 21.2-т заасан тусгай зөвшөөрлийн гэрчилгээ буюу **зохих ёсоор баталгаажсан** баримт үзүүлэхийг шаардах эрхтэй.
Дүгнэлт: Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар зохих ёсоор баталгаажсан байх гэдэг нь ойлгомжгүй байна. Нотариатаар баталгаажуулах уу, эсвэл зохих ёсоор баталгаажуулахад ямар журмаар зохицуулагдах нь тодорхойгүй байна. ***Санал:*** Иймд нотариатаар баталгаажуулсныг зохих ёсоор баталгаажсан гэж үзэх бол нотариатаар баталгаажуулах гэж өөрчлөх.	

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.mlt.gov.mn

7.3.9. Хуулийн зүйл, заалт, зохицуулалт нь ойлгомжтой байгаа эсэх

III ХЭСЭГ. САНАЛ

Зар сурталчилгааны тухай хуулийг бусад хуультай харьцуулан давхардал, хийдэл, зөрчлийг арилгах ажлын хүрээнд хамааралтай 61 хуулийг харьцуулсан бөгөөд дараах саналыг гаргаж байна. Үүнд:

- Зар сурталчилгааны тухай хууль сонгосон хуулиудтай давхардсаныг тогтооход давхардал-13
- Зар сурталчилгааны тухай хууль сонгосон хуулиудтай зөрчилдсөн зөрчил-14
- Зар сурталчилгааны тухай хуулийн хүрээнд хийдэл-4 тогтоосон болно.

Зар сурталчилгааны тухай хуулийн зарим зүйл заалт бусад хуулийн зүйл заалттай бичвэрийн болоод агуулгын хувьд давхардсан байдалд дараах саналыг өгч байна.

- Зар сурталчилгааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 11.3, 11.5 дахь хэсгүүд Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дах хэсгийн 13.2.1, 13.2.2, 13.2.5 дах заалтуудтай давхардсан. Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн дээрх заалтуудыг хүчингүй болгох. Учир нь Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт “Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгаатай холбогдсон бусад харилцааг Зар сурталчилгааны тухай хуулиар зохицуулна.” гэсэн заалт байна.
- Зар сурталчилгааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2, 7.4.1 дэх хэсэг нь Өрсөлдөөний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3 дахь хэсэгтэй агуулгын хувьд давхардаж байгаа тул Өрсөлдөөний тухай хуулийн дээрх заалтыг хүчингүй болгох.
- Зар сурталчилгааны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг нь Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.8 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь хэсэгтэй тус тус давхардаж байна. Банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийг Зар сурталчилгааны тухай хуулиас ишлэх, 7 дугаар зүйлийн 7.4.8, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь хэсгүүдийг хүчингүй болгох. Учир нь дээрх заалтууд Зар сурталчилгааны тухай хуулиар зохицуулагдах харилцаа юм.
- Зар сурталчилгааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2, 13.4 дэх хэсгүүд Эм, эмнэлгийн хэрэгсэлийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4, 27.4.3 дахь хэсгүүдтэй агуулгын болоод бичвэрийн хувьд давхардаж байна. Эм эмнэлгийн хэрэгсэлийн тухай хуулийн дээрх заалтуудыг хүчингүй болгож, Зар сурталчилгааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д заасны дагуу зохицуулна гэж ишлэл хэлбэрээр заалт оруулж өөрчлөх.
- Зар сурталчилгааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэгтэй Даатгалын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1 дэх хэсэг, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг тус тус давхардаж байна. Иймд дээрх хоёр хуулийн заалтыг хүчингүй болгох.

Зар сурталчилгааны тухай хуулийг аргачлалын дагуу судалж үзээд илэрсэн зөрчилд дараах санал өглөө.

Зар сурталчилгааны тухай хуулийн “зар сурталчилгаа” нэр томьёог бусад хуульд хэрхэн хэрэглэснийг судлан үзээд дараах хэд хэдэн саналыг гаргалаа.

ХУУЛЬ ЗҮЙН УНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.legal.gov.mn

- Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх хэсэгт “сурталчилгаа”, 27 дугаар зүйлийн 27.1.4 дэх хэсэгт “сурталчилгаа”, Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3.5 дахь хэсэгт “реклам” гэж орсныг “зар сурталчилгаа” гэж өөрчлөх. Учир нь зүйлүүдэд сурталчилгаа гэдэг үгийг урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх бус олон нийтэд таниулах түгээн дэлгэрүүлэх утга санаагаар оруулсан байгаа тул зар сурталчилгаа нь илүү тохиромжтой гэж үзлээ. Мөн Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуульд хэрэглэсэн реклам гэдгийг зар сурталчилгаа гэж солих нь илүү тохиромжтой юм.

- Зар сурталчилгааны тухай “14^1.1.2. энэ хуулийн 14.1.1-д зааснаас бусад сонин нэг удаагийн дугаарын хэвлэлийн нэг нүүрний 50 хувиас хэтрэхгүй хэмжээгээр сард 1 удаа” гэсэн ишлэсэн заалт байгаа бөгөөд 14.1.1 гэсэн заалт байхгүй бөгөөд 14^1.1.1-ийн “1” тэмдэглэгээг орхиж бичсэн байна. Энэхүү тэмдэглэгээг засаж бичих.

- Зар сурталчилгааны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дах хэсэгт “Оюуны өмчийн улсын хяналтын алба, Өрсөлдөөний тухай хуульд заасан асуудлаар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж ишлэсэн байна. Төрийн хяналт шалгалтын тухай хууль нь анх 1995 оны 3 дугаар сарын 27-нд 7 бүлэг, 27 зүйлтэй батлагдаж байсан ба 2003 оны 1 дүгээр сарын 03-ны өдөр 4 бүлэг 16 зүйлтэй шинэ хууль батлагдсанаар хуучин хууль нь хүчингүй болсон. Зар сурталчилгааны тухай хуульд хүчингүй болсон хуулиас ишлэсэн заалтаа өөрчлөөгүй байгааг өөрчлөх.

- Зар сурталчилгааны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалт нь Эм эмнэлгийн хэрэгсэлийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.11 дэх хэсэгтэй мөн Банкны тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1.11 дэх хэсэгтэй, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9 дэх хэсэгтэй нэг зөрчилд хоёр байгууллага давхардуулан хариуцлага тооцож байгаа нь зөрчилдөж байна. Иймд дээрх зүйл заалтыг хүчингүй болгох. Учир нь энэхүү харилцаа нь Зар сурталчилгааны тухай хуулиар зохицуулагдах харилцаа юм.

- Зар сурталчилгааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгтэй, Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг зөрчилдөж байгааг нийцүүлэн Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн агуулгыг өөрчлөн найруулах.

Зар сурталчилгааны тухай хуулийг аргачлалын дагуу судалж үзээд илэрсэн хийдэлд дараах санал өглөө.

- Зар сурталчилгааны тухай хуулийн 21.2, 21.3 дахь зүйлүүдэд заасан “Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар зохих ёсоор баталгаажсан байх” гэдэг нь ойлгомжгүй байна. Нотариатаар баталгаажуулах уу, эсвэл зохих ёсоор баталгаажуулахад ямар журмаар зохицуулагдах нь тодорхойгүй байгааг ойлгомжтой тодорхой болгох.

- Зар сурталчилгааны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтад “Энэ хуулийн 29.1-д заасан захиргааны хариуцлага нь хууль тогтоомжийн бусад актад заасан хариуцлага, зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэл, үйл ажиллагааг таслан зогсоох шаардлагыг биелүүлэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй” гэж заасан нь захиргааны нэг зөрчилд нэг хариуцлага ногдуулах буюу өөрөөр хэлбэл, эрх зүйн онолын нэг зөрчилд хариуцлагыг давхардуулж ногдуулж үл болно гэсэн зарчмыг алдагдуулж байна. Иймд дээрх заалтыг хүчингүй болгох.

- Зар сурталчилгааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Мэдээлэх хэрэгсэл ашиглан сурвалжлага, мэдээ, тоймчийн нийтлэл болон зар сурталчилгааны бус хэлбэрээр зар сурталчилгаа байрлуулсан, түгээсний төлөө төлбөр авахыг хориглоно” гэсэн хориглосон зохицуулалтанд хүлээлгэх хариуцлагыг хуульд тусгаагүй байна. Хариуцлагыг заасан зүйл заалт оруулах гэсэн санал тус тус дэвшүүлж байна.

Зар сурталчилгааны тухай хууль зөрчигдөж байгаа нийтлэг заалт

Зар сурталчилгааны тухай хуулийн заалт	Тайлбар
6.5.1.тусгай зөвшөөрөл аваагүй тохиолдолд тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагааны талаар аливаа зар сурталчилгаа явуулах;	Гадаадад ажиллах хүч зуучлах зард тусгай зөвшөөрөлийн дугаарыг тавьж нийтэлдэггүй.
6.5.2.Монгол Улсын хууль тогтоомжоор үйлдвэрлэх, худалдах, улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон бүтээгдэхүүнийг сурталчлах;	Олон нийтийн зах дээр бууны сум зарна гэсэн зар радиогоор байнга зарлагдаж байдаг.
6.5.4.хуульд заасны дагуу чанар, стандарт, эрүүл ахуйн баталгаажуулалтад заавал хамруулах бүтээгдэхүүнийг ийнхүү баталгаажуулаагүй бол сурталчлах;	Үр зулбуулах, тураах эмийг эрүүл ахуйн баталгаажилтанд хамруулахгүйгээр сонин, радио, телевизээр худалдаалахаар нэвтрүүлдэг.
6.5.7.айдас төрүүлэх, хүчирхийлэл, садар самуунд уруу татах, түүнчлэн хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд гэм хор учруулах үйлдэл, үйл ажиллагаанд хүргэж болох зар сурталчилгааг;	Богино долгионы радио, тв чатаар 18-22 нсаны охидтой танилцана гэх мэт зарууд байнга явдаг.
9.3.Гадна зар сурталчилгаа нь замын хөдөлгөөн зохицуулах дохио, тэмдэг, тэмдэглэлтэй төстэй байх, тэдгээрийг халхлах, далдлах болон бусад хэлбэрээр замын хөдөлгөөнд саад учруулахыг хориглоно.	Уран сайхны кино, урлагийн арга хэмжээний зар сурталчилгааны самбарт замын хөдөлгөөний тэмдэг ашигласан зөрчил байдаг.
11.3.Улс орны болон дэлхий дахины амьдралын цаг үеийн шинжтэй үйл явдлын талаархи тогтмол мэдээллийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно.	Телевизийн 19, 21 цагт гардаг тогтмол мэдээллийн дундуур зар сурталчилгаа болон “Бизнес зар” гаргадаг.
11.5.Үргэлжлэх хугацаа нь 20 минутаас дээшгүй нэвтрүүлгийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно.	Олон ангит киноны үргэлжлэх хугацаа 30 минут байхад кино 15 минут, зар сурталчилгаа нь 15 минут гардаг.
13.3.Эмийг сурталчлахдаа тэдгээрийг хэрэглэх заавартай танилцахыг заавал сануулна.	Эмийн сайн талыг сурталчилж байхдаа эмийн сөрөг нөлөөг дурьдах, хэрэглэх заавартай танилцахыг сануулсан зар сурталчилгаа сонин, зурагтаар цөөн байдаг.
13.7.Эмнэлгийн байгууллагын талаархи зар сурталчилгаа нь зөвхөн байршил, үйлчилгээний чиглэл, эмчийн нэр хаягаар хязгаарлагдана.	Хувийн эмнэлэг, сувиллын газрууд эмчилгээний үр дүнгээр баталгаа өгөх, заавал ирээрэй гэж ятгах хэлбэрээр телевиз радиогоор зар сурталчилгаа ихээр явуулдаг болсон.
13.8.Эмнэлгийн үйлчилгээний талаар магтсан, үйлчлүүлэхийг уриалсан сурталчилгаа явуулахыг хориглоно.	
13.4.4.тухайн эмийн үйлчлэлийн талаар урьдчилсан баталгаа гаргах;	Зар сурталчилгаагаар эмийг уугаад л эрч хүчтэй, эрүүл саруул болж байгаагаар үзүүлж байгаа нь урьдчилсан баталгаа гаргаж байгаа хэлбэр юм.
14.1.Нэн ховор, ховор ургамал, амьтны жагсаалтад орсон болон тэдгээрийн үндэс, иш, мөчир, навч, бугын цусан эвэр, чив, засаа, согооны сүүл, сав, хүдрийн заар, баавгайн доньд зэрэг эрхтэнийг бэлтгэх, худалдах, худалдан авах тухай зар сурталчилгааг хориглоно.	Шуурхай зар, Зар мэдээ сонингуудад олон төрлийн зэрлэг ховор амьтны бүтээгдэхүүнийг зарах зар маш их байдаг.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ ХУУЛЬ[10] /2006 ОН/

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ДАВХАРДАЛ, ХИЙДЭЛ, ЗӨРЧЛИЙГ ТАЙЛАГНАХ АЖЛЫН ТАЙЛАН

I ХЭСЭГ. ТАНИЛЦУУЛГА

2016 оны 1 дүгээр сарын 18-ны өдрөөс 2016 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн хооронд УИХ-аас 2006 оны 12 дугаар сарын 28-ны өдөр баталсан Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг тогтоох ажлыг хийж гүйцэтгэв.

Хуулийн хийдэл, зөрчил, давхардлыг илрүүлэх зорилгоор эрх зүйн актыг шалгах дараалал:

- Тухайн хуулийн дотоод давхардал, зөрчил, хийдлийг илрүүлэх,
- Тухайн хуулийг бусад хуультай харьцуулж давхардал, зөрчил, хийдлийг илрүүлэх,
- Тухайн хуулийг Улсын Их Хурлын тогтоолтой харьцуулж давхардал, зөрчил, хийдлийг илрүүлэх,
- Тухайн хуулийг Засгийн Газрын тогтоолтой харьцуулж давхардал, зөрчил, хийдлийг илрүүлэх,
- Тухайн хуулийг сайдын тушаалтай харьцуулж давхардал, зөрчил, хийдлийг илрүүлэх.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуультай холбоотой нэгтгэн цуглуулсан эрх зүйн актууд:

Судалгаа, шинжилгээний үйл ажиллагаатай уялдуулан Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн хийдэл, давхардал, зөрчлийг арилгах, бусад хуулиудыг уялдуулах ажлын хүрээнд холбогдох хууль тогтоомж, уг хуулийг хэрэгжүүлэхээр Улсын Их Хурал, Засгийн газраас баталж гаргасан холбогдох нийт 27 эрх зүйн актад мониторинг хийсэн. Үүнд:

Эрх зүйн актын төрөл	Тоо
- 1/ Хууль;	10
- 2/ ОУ-ын гэрээ;	0
- 3/ УИХ-ын тогтоол;	1
- 4/Ерөнхийлөгчийн зарлиг;	0
- 5/Үндсэн хуулийн Цэцийн шийдвэр;	0
- 6/Улсын Дээд шүүхийн тогтоол;	0

[10] ХЗДХС-ын Аргачлал батлах тухай 2010 оны 84 дүгээр тушаалаар батлагдсан “Хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах аргачлал”-ын дагуу хийв.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ АКТ РЭЭЛЭН www.mn.gov.mn

- 7/Засгийн газрын тогтоол; 7
- 8/ Сайдын тушаал; 8
- 9/ Засгийн газрын агентлагийн даргын тушаал; 1
- 10/УИХ-аас томилогддог байгууллагын дарга, түүнтэй адилтгах албан тушаалтны шийдвэр 0

Судалгааны арга:

- Задлан шинжлэх ба нэгтгэн дүгнэх;
- Харьцуулалтын арга:
  - Бичвэрийн харьцуулалтын арга
  - Агуулгын харьцуулалтын арга
- Ярилцлагын арга.

Шинжлэх ухаан технологийн тухай хууль батлах хэрэгцээ шаардлага.

Шинжлэх ухаан,технологийн бүтээлч, цогц үйл ажиллагааг хангах, дэмжих, түүний эрх зүйн орчинг бүрдүүлэх нь Монгол Улсын хөгжлийн нэг үндэс бөгөөд энэ нь манай улсын эдийн засгийг дээшлүүлэх хүчин зүйлийн нэг юм.

Иймд хууль санаачлагчийн зүгээс шинжлэх ухаан, технологийн салбарыг төрөөс онцгойлон анхаарч түүний тогтвортой хөгжлийг хангах, төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоо, эрх үүргийг тодорхойлох, мөн эрдэмтэн судлаачдын ур чадварыг нэмэгдүүлэх, үүрэг хариуцлага, ёс зүйд анхаарал хандуулснаар тухайн салбарын чадамж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх үндсэн хүчин зүйлд нөлөөлнө гэж үзсэн нь энэхүү хуулийг боловсруулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон.

Хуулийн бүтэц, зохицуулах харилцаа

Шинжлэх ухаан, технологийн тухай хууль нь 6 бүлэг, 25 зүйлтэй. Хуулийн зорилт нь шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, уг үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, санхүүжилтийн эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Нэгдүгээр бүлэг: Нийтлэг үндэслэл

Энэ бүлэгт хуулийн зорилт, хуульд хэрэглэсэн нэр томъёоны тайлбар, шинжлэх ухаан, технологийн үйл ажиллгааанд баримтлах үндсэн зарчим зэргийг тусгасан байна.

Хоёрдугаар бүлэг: Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны удирдлага

Энэ бүлэгт шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны удирдлагын тогтолцоог тодорхойлсон байх бөгөөд шинжлэх ухаан, технологийн асуудлаар бодлого боловсруулах, санал зөвлөмж гаргах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих эрх үүрэг бүхий дараах байгууллагуудтай холбоотой зохицуулалт агуулсан байна. Үүнд Засгийн газар, Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөл, төрийн захиргааны төв байгууллага, яамны шинжлэх ухаан, технологийн зөвлөл, Шинжлэх ухааны академи багтаж байна.

Гуравдугаар бүлэг: Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд оролцогч

Энэ бүлэгт эрдэм шинжилгээний ажилд оролцогч талуудыг, тэдгээрийн нийтлэг эрх, үүргийг тодорхойлсон байна. Энэ хуулийн дагуу эрдэм шинжилгээний байгууллага болон эрдэм шинжилгээний ажилтан оролцогч талууд байхаар заажээ.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХЭРЭЭЛЭН www.nli.gov.mn

Мөн эрдэм шинжилгээний байгууллагын хэлбэр, эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлохын зэрэгцээ эдгээр байгууллагыг үүсгэн байгуулах, татан буулгахтай холбоотой зохицуулалт орсон.

Дөрөвдүгээр бүлэг: Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны санхүүжилт

Энэ бүлэгт шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг санхүүжүүлэх эх үүсвэрийг тогтоож өгсөн байх ба санхүүжүүлэх болон санхүүжилт олгох журмыг мөн адил оруулж өгсөн. Мөн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын санхүүжүүлэгч болох захиалагчийн болон гүйцэтгэгчийн эрх, үүрэг, хариуцлагыг тогтоосон байна.

Тавдугаар бүлэг: Эрдэм шинжилгээний ажилтан, түүний нийгмийн баталгаа

Энэ бүлэгт эрдэм шинжилгээний ажилтанд олгох зэрэг дэвийн ангилал, нийгмийн баталгаа болно тэдгээрийн ёс зүйн асуудлыг тусгасан байна.

Зургадугаар бүлэг: Бусад зүйл

Энэ хэсэгт шинжлэх ухаан, технологийн салбарын шагнал, хамтын ажиллагаа, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, маргааныг хянан шийдвэрлэх, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг зааж өгсөн байна.

II. ХЭСЭГ. ДҮГНЭЛТ

ХЗҮХ-ийн Судалгааны төв хууль зүйн бодлогын болон хавсарга судалгаа хийх, хууль тогтоомжийн төсөл боловруулахад хамтран ажиллах, судалгаа, мэдээлэл, онол-арга зүйн туслалцаа үзүүлэх чиг үүргийн хүрээнд гүйцэтгэж буй үндсэн үйл ажиллагаандаа мөрдөж буй хууль, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, дүрэм, журам, тушаал шийдвэрүүд болох нийт 27 эрх зүйн актын холбогдох хэсэгт хуулийн хийдэл, давхардал, зөрчлийн мониторинг хийсэн.

Дээрхи хуулийн хийдэл, давхардал, зөрчлийн мониторингийн үр дүнд хуулийн давхардал 1, зөрчил 2 байгааг олж тогтоов.

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 84 дүгээр тушаалаар баталсан “Хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах аргачлал”-ын дагуу дараах байдлаар танилцуулж байна. Үүнд:

Шалгуур үзүүлэлт	Тоо
7.1. Давхардал	**1**
7.1.1.тухайн хуульд байгаа зохицуулалтын бичвэрийг бусад хуульд давтан хуулбарлан хуульчилсан эсэх;	
7.1.2.тухайн хуульд байгаа зохицуулалтыг уг хуульд болон бусад хуульд бичвэрийн эсхүл агуулгын хувьд хуулбарлан хуульчилсан эсэх;	1
7.1.3.төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг хуульд давхардуулан хуульчилсан эсэх;	
7.1.4.тухайн хуулийн тодорхой зохицуулалтыг Улсын дээд шүүхээс тайлбарлаж байсан эсэх, энэхүү тайлбар нь түүний давхардлыг арилгахад чиглэгдсэн эсэх;	
7.2. Зөрчил	**2**
7.2.1.тухайн зохицуулалт нь хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	
7.2.2.хууль тогтоомжийн хэсэгт заасан хуулийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	
7.2.3.хуулийн зүйлийн нэр тухайн зүйлд байгаа хэсэг, заалтын агуулгын нийлбэртэй нийцэж байгаа эсэх;	
7.2.4.хуулийн зүйл, заалт, зохицуулалт нь хэл зүйн найруулгын хувьд салаа утгатай эсэх;	

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nlt.gov.mn

7.2.5.хуульд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн болон бусад хуулийн нэр томъёотой зөрчилдөж байгаа эсэх;	1
7.2.6. тодорхой асуудлыг гагцхүү хуулиар зохицуулахаар заасан боловч уг асуудлаар өөр журмыг өөр хуульд заасан эсэх;	
7.2.7.хуульд заасан ишлэл алдаатай эсэх;	1
7.2.8.тухайн хуульд бусад хуулиас авсан Ишлэлийн дугаар нь нөгөө хуульд байгаа зохицуулалттай нийцэж байгаа эсэх;	
7.2.9.татварынхаас бусад хуульд тогтоомжид албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	
7.2.10.тухайн хуульд тусгай зөвшөөрөл олгохоор заасан нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд туссан эсэх;	
7.2.11. өмчлөх эрхийг хязгаарласан буюу хязгаарлахад чиглэгдсэн эрх зүйн акт гаргах эрхийг бусад этгээдэд хуулиар олгосон эсэх;	
7.2.12.тухайн хуулийн тодорхой зохицуулалтыг Улсын дээд шүүхээс тайлбарлаж байсан эсэх, энэхүү тайлбар нь түүний зөрчлийг арилгахад чиглэгдсэн эсэх;	
7.2.13. тухайн хуулийн зүйл, заалт өөр хуулийн заалттай зөрчилдөж буй эсэх;	
7.3. Хийдэл	**0**
7.3.1.тухайн хуульд тодорхой харилцааг нарийвчлан хуулиар зохицуулахаар заасан бол уг нарийвчилсан зохицуулалт бүхий хууль батлагдсан эсэх;	
7.3.2.тухайн хуульд тодорхой харилцааны нарийвчилсан зохицуулалтыг батлах эрхийг төрийн бусад байгууллагад шилжүүлсэн бол уг нарийвчилсан зохицуулалт батлагдсан эсэх;	
7.3.3.тухайн хуульд заасан процедурын шинжтэй зохицуулалт нь ойлгомжтой, тасралтгүй үргэлжлэх боломжтой байдлаар томъёолсон эсэхийг тодорхойлох;	
7.3.4.тодорхой эрх, үүргийг хэрэгжүүлэх субьект нь тодорхой эсэх;	
7.3.5.төрийн байгууллага, албан тушаалтнаас тодорхой асуудал шийдвэрлэхээр хуульд заасан бол уг асуудлыг шийдвэрлэх хугацааг тодорхой заасан эсэх;	
7.3.6.хуульд заасан хориглосон зохицуулалт нь түүнийг зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх;	
7.3.7.тухайн хуулийн тодорхой зохицуулалтыг Улсын дээд шүүхээс тайлбарлаж байсан эсэх, энэхүү тайлбар нь түүний хийдлийг арилгахад чиглэгдсэн эсэх;	
7.3.8. хуульд байх шаардлагатай зохицуулалт тусгагдсан эсэх;	
7.3.9. хуулийн зүйл, заалт, зохицуулалт нь ойлгомжтой байгаа эсэх;	
Нийт	**4**

I. ДАВХАРДАЛ

7.1.1. Тухайн хуульд байгаа зохицуулалтын бичвэрийг бусад хуульд давтан хуулбарлан хуульчилсан эсэх

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн зохицуулалтын бичвэрийг бусад хуульд хуулбарласан тохиолдол байхгүй байна. Харин хуульд нийцүүлэн гаргасан журам, дүрэмд хуулбарлан оруулсан тохиолдол байна.

7.1.2. Тухайн хуульд байгаа зохицуулалтыг уг хуульд болон бусад хуульд бичвэрийн эсхүл агуулгын хувьд хуулбарлан хуульчилсан эсэх

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн зохицуулалтыг уг хуульд болон бусад хуульд бичвэрийн эсхүл агуулгын хувьд хуулбарласан тохиолдолд байхгүй байна. Харин хуульд нийцүүлэн гаргасан журам, дүрэмд хуулбарлан оруулсан тохиолдол байна. Тухайлбал:

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

	Шинжлэх ухаан, технологийн тухай хууль	**Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн ерөнхий дүрэм** *БСШУ-ны сайдын 2007 оны 454 дүгээр тушаалын хавсралт*
1.	*4 дүгээр зүйл. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны зарчим* 4.1.1.үндэсний аюулгүй байдал, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил явуулахгүй байх;	*Гурав. Эрдэм шинжилгээний ажилтны үйл ажиллагааны ёс зүйн зарчим* 3.1.3. Үндэсний аюулгүй байдал, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрдэм шинжилгээ, туршилт зохион бүтээх ажил явуулахгүй байх

7.1.3.Төрийн байгууллагын чиг үүргийг давхардуулан хуульчилсан эсэх

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд төрийн байгууллагуудын чиг үүргийг давхардуулсан зохицуулалт байхгүй.

7.1.4. Тухайн хуулийн тодорхой зохицуулалтыг Улсын дээд шүүхээс тайлбарлаж байсан эсэх, энэхүү тайлбар нь түүний давхардлыг арилгахад чиглэгдсэн эсэх

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн тодорхой зохицуулалтыг тайлбарласан УДШ-ийн тогтоол байхгүй.

II. ЗӨРЧИЛ

7.2.1.Тухайн зохицуулалт нь хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх

	Шинжлэх ухаан, технологийн тухай хууль
1.	**Хуулийн зорилт**: Энэ хуулийн зорилт нь шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, уг үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, санхүүжилтийн эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
Дүгнэлт: Шинжлэх ухаан, технологийн тухай хууль нь ерөнхийдөө хуулийн үндсэн зорилтод нийцсэн зохицуулалтыг агуулж байна. Гэвч сүүлийн жилүүдэд эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудаас гаргаж буй бүтээгдэхүүний нэр төрлийг бүрэн тодорхойлоход хуулийн 3 дугаар зүйл дэх “Хуулийн нэр томъёо” хангалтгүй байна. Мөн энэ хууль болон үүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн актууд нь ихэвчлэн байгалийн шинжлэх ухаан болон технологийн дэвшил гаргасан буюу гаргахад чиглэсэн үйл ажиллагааг гол төлөв зохицуулж байна. Иймээс нийгмийн шинжлэх ухаан, түүн дотроо хууль, эрх зүйн чиглэлээр судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг хөгжүүлэх, хөхиүлэн дэмжих, нийтийн хүртээл болгох тал дээр зохицуулалт тусгахад анхаарах шаардлагатай байна.	

7.2.2. Хуулийн “хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн “Хууль тогтоомж” хэсэгт Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ гэж заасан байдаг. Иймд энэ харилцаанд хамаарахгүй хууль тогтоомжийн актыг дурдаагүй болно.

7.2.3. Хуулийн зүйлийн нэр тухайн зүйлд байгаа хэсэг, заалтын агуулгын нийлбэртэй нийцэж байгаа эсэх

Шинжлэх ухаан, технологийн тухай хууль нь 6 бүлэг, 25 зүйлтэй. Уг хуулийн зүйлийн нэртэй зөрчилдөж буй хэсэг, заалт байхгүй байна.

7.2.4. Хуулийн зүйл, заалт, зохицуулалт нь хэл зүйн найруулгын хувьд салаа утгатай эсэх

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд хэл зүйн найруулгын хувьд салаа утгатай үр, хэллэг хэрэглээгүй.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.legal.gov.mn

7.2.5. Хуульд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн болон бусад хуулийн нэр томъёотой зөрчилдөж байгаа эсэх

1.	Шинжлэх ухаан, технологийн тухай хууль	Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн дүрэм
	7.1.Засгийн газар нь шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогын талаар санал боловсруулах, бодлогын хэрэгжилтэд үнэлэлт өгөх, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах талаар зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны бус Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөл /цаашид **“Зөвлөл**” гэх/-тэй байна.	1.1. Энэ дүрмээр Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөл (цаашид **“Үндэсний зөвлөл”** гэнэ)-ийн үйл ажиллагааг зохицуулна.
Дүгнэлт: ШУТҮЗөвлөлийн дүрэм дэх товчлол нь ШУТТХуулийн 7.1 заалтаас зөрүүтэй байна. ***Санал:*** ШУТҮЗөвлөлийн дүрэм дэх товчлолын ШУТТХуулийн 7.1 заалттай адил болгох		

7.2.6. Тодорхой асуудлыг гагцхүү тухайн хуулиар зохицуулахаар заасан боловч уг асуудлаар өөр журмыг өөр хуульд заасан эсэх

Шинжлэх ухаан, технологийн тухай хуультай холбоотой ийм төрлийн зөрчил байхгүй.

7.2.8. Тухайн хуульд бусад хуулиас авсан Ишлэлийн дугаар нь нөгөө хуульд байгаа зохицуулалттай нийцэж байгаа эсэх

1.	Шинжлэх ухаан, технологийн тухай хууль	Шинжлэх ухаан, технологийн тухай хууль
	17.4. */Энэ хэсгийг 2012 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*	25.1.4.энэ хуулийн **17.4,** 17.5-д заасан үүргээ биелүүлээгүй захиалагч байгууллага, хуулийн этгээдийг 150000-200000 төгрөгөөр, албан тушаалтныг 30000-50000 төгрөгөөр торгох;
Дүгнэлт: Хуулийн хүчингүй болсон хэсгийг Шинжлэх ухаан, технологийн тухай хууль тогтоомж зөрчигдөд хүлээлгэх хариуцлага хэсэгт ишилсэн хэвээр байна. ***Санал:*** Хуулийн 25.1.4. дэх хэсгээс “**17.4,”** хэсгийг хасах.		

III. ХИЙДЭЛ

7.3.1.Тухайн хуульд тодорхой харилцааг нарийвчлан хуулиар зохицуулахаар заасан бол уг нарийвчилсан зохицуулалт бүхий хууль батлагдсан эсэх

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд ямар нэг тодорхой харилцааг өөр хуулиар нарийвчлан зохицуулах тухай заалт байхгүй.

7.3.2. Тухайн хуульд тодорхой харилцааны нарийвчилсан зохицуулалтыг батлах эрхийг төрийн бусад байгууллагад шилжүүлсэн бол уг нарийвчилсан зохицуулалт батлагдсан эсэх

Д/д	Тодорхой харилцааны нарийвчилсан зохицуулалтыг батлах эрх бүхий төрийн байгууллага	Батлагдсан эсэх
1.	7.3.Зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Засгийн газар батална.	**Дүрэм батлагдсан.** ЗГ-ын 2007 оны 146 дугаар тогтоол
2.	11.6.Дээд боловсролын байгууллагыг энэ хуулийн 11.2.2-т заасан эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамааруулах үнэлгээний үзүүлэлтийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.	**Үнэлгээний үзүүлэлт батлагдсан.** Үнэлгээний үзүүлэлт батлах тухай /Дээд боловсролын байгууллага, үндэсний хэмжээний музей, номын санг эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамааруулах үнэлгээний үзүүлэлт/ БСШУ-ны сайдын 2007 оны 463 дугаар тушаал

www.nlt.gov.mn

3.	11.11.Энэ хуулийн 11.2.3-т заасан байгууллагын үлгэрчилсэн дүрмийг Засгийн газар батлах бөгөөд удирдлагыг нь Удирдах зөвлөл хэрэгжүүлнэ.	**Дүрэм батлагдсан** Дүрэм шинэчлэн батлах тухай /Шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдлийн үлгэрчилсэн дүрэм/ ЗГ-ын 2006 оны 142 дугаар тогтоол
4.	11.12.Энэ хуулийн 11.2.4-т заасан байгууллага нь өөрийн үйл ажиллагааны чиглэлд хамаарах судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг дангаараа буюу эрдэм шинжилгээний бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх эрхтэй бөгөөд тэдгээрийг эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамааруулах үнэлгээний үзүүлэлтийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.	**Үнэлгээний үзүүлэлт батлагдсан.** Үнэлгээний үзүүүлэлт батлах тухай /Дээд боловсролын байгууллага, үндэсний хэмжээний музей, номын санг эрдэм шинжилгээний байгууллагаын зэрэглэлд хамааруулах үнэлгээний үзүүлэлт/ БСШУ-ны сайдын 2007 оны 463 дугаар тушаал
5.	19.3.Эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэвийн тодорхойлолт, нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	**Журам батлагдсан** БШУ-ны сайдын 2012 оны №А/88 тушаал
6.	19.4.Судалгааны ажлын арга барил эзэмшсэн байдал, ур чадварынх нь түвшин, ажлын үр дүнг үнэлэх, зэрэг дэвийг ахиулах зорилгоор эрдэм шинжилгээний ажилтныг 4 жил тутамд аттестатчилалд хамруулах бөгөөд журмыг нь шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	**Журам батлагдсан** Журам батлах тухай / эрдэм шинжилгээний ажилтныг аттестатчилах журам/ БШУ-ны сайдын 2007 оны №211 тушаал
7.	20.2.Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн дүрмийг эрдэм шинжилгээний байгууллагуудын саналыг харгалзан шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	**Журам батлагдсан** Дүрэм батлах тухай /Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн дүрэм/ БСШУ-ны сайдын 2007 оны №454 тушаал
8.	21.2.Улсын төсвөөс санхүүждэг эрдэм шинжилгээний байгууллагын ажилтны цалингийн сүлжээ, тэдгээрт нэмэгдэл, нэмэгдэл хөлс олгох журмыг Засгийн газар батална.	**Журам батлагдсан** Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийн шинэчлэн батлах тухай ЗГ-ын 2014 оны 75 дугаар тогтоол
9.	22.2. Шинжлэх ухаан, технологийн салбарын шагнал олгох журам, шагналын хэмжээг Монгол Улсын Засгийн газар батална.	**Журам батлагдсан** Журам батлах, шагналын хэмжээ тогтоох тухай / Шинжлэх ухаан, технологийн салбарын шагнал олгох журам/ ЗГ-ын 2007 оны 147 дугаар тогтоол

7.3.3. Тухайн хуульд заасан процедурын шинжтэй зохицуулалт нь ойлгомжтой, тасралтгүй үргэлжлэх боломжтой байдлаар томъёолсон эсэхийг тодорхойлох

Шинжлэх ухаан, технологийн тухай хууль дахь процедурын шинжтэй зохицуулалт нь ойлгомжтой, тодорхой байна.

7.3.4. Тодорхой эрх, үүргийг хэрэгжүүлэх субъект нь тодорхой эсэх

Д/д	Эрх , үүрэг хэрэгжүүлэх субъект	Хамаарах зүйл
1.	Засгийн газрын бүрэн эрх	6 дугаар зүйл, 12 дугаар зүйлийн 12.1.1 хэсэг
2.	Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх	8 дугаар зүйл
	Төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх	12 дугаар зүйлийн 12.2. хэсэг
3.	Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөл	7 дугаар зүйл
4.	Яамны шинжлэх ухаан, технологийн зөвлөл	9 дүгээр зүйл
5.	Монгол Улсын Шинжлэх ухааны академи	10 дугаар зүйл
6.	Үүсгэн байгуулагч	12 дугаар зүйлийн 12.2., 12.3., хэсэг
Дүгнэлт: Эрх, үүрэг хэрэгжүүлэх субъект тодорхой, ойлгомжтой.		

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

7.3.5. Төрийн байгууллага, албан тушаалтнаас тодорхой асуудал шийдвэрлэхээр хуульд заасан бол уг асуудлыг шийдвэрлэх хугацааг тодорхой заасан эсэх

Д/д	Тодорхой асуудал шийдвэрлэх төрийн байгууллага, албан тушаалтан	Шийдвэрлэх хугацаа заасан эсэх
1.	6.1.1. шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг нь зохион байгуулах;	Тодорхой заагаагүй
2.	6.1.2. шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг тодорхойлон батлах;	Тодорхой заагаагүй
3.	6.1.3. шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх мастер төлөвлөгөө, үндэсний хөтөлбөрийг батлах;	Тодорхой заагаагүй
4.	6.1.5. үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх;	Тодорхой заагаагүй
5.	6.1.5.шинжлэх ухаан, технологийн салбарт мөрдөх нийтлэг дүрэм, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн батлах;	Тодорхой заагаагүй
6.	6.1.6.Засгийн газрын захиалгаар улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх шинжлэх ухаан, технологийн хөтөлбөр, төсөл, судалгааны ажлын хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэмжээг тооцож, улсын төсөвт тусгуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;	Тодорхой заагаагүй
7.	6.1.7.төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах;	Тодорхой заагаагүй
8.	7.2.Зөвлөл нь дор дурдсан асуудлыг хэлэлцэж зөвлөмж гаргана:	Тодорхой заагаагүй
9.	8.1.1.шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;	Тодорхой заагаагүй
10.	8.1.2.шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх үзэл баримтлал, үндсэн чиглэл, хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх;	Тодорхой заагаагүй
11.	8.1.3.Засгийн газрын захиалгаар улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн төслийг сонгон шалгаруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, суурь, хавсарга судалгааны чиглэл, санхүүжилтийг батлах;	Тодорхой заагаагүй
12.	8.1.4.төрийн захиргааны бусад төв болон орон нутгийн байгууллагаас шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;	Тодорхой заагаагүй
13.	8.1.5.шинжлэх ухаан, технологийн мэдээллийн нэгдсэн сан, сүлжээг бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;	Тодорхой заагаагүй
14.	8.1.6.улсын захиалгатай эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын хөрөнгийн ашиглалт, зарцуулалтын байдалтай танилцах, үр дүнд нь хянан магадлагаа хийлгэх, үнэлгээ, дүгнэлт гаргуулах, шаардлагатай тохиолдолд санхүүжилтийг зогсоох, хохирлыг барагдуулах асуудлыг шийдвэрлэх;	Тодорхой заагаагүй
15.	8.1.7.эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, семинар зохион байгуулах, мэргэжилтэн бэлтгэх арга хэмжээг санхүүжүүлэх;	Тодорхой заагаагүй
16.	8.1.8.эрдэм шинжилгээний байгууллагад эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил гүйцэтгэх, түүний үр дүнг ашиглахад зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр санхүүжилт хийх, олгосон хөрөнгийг эргэж төлүүлэх арга хэмжээ авах;	Тодорхой заагаагүй
17.	8.1.9.шинжлэх ухаан, технологийн салбарын боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх;	Тодорхой заагаагүй
18.	8.1.13.төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын эрдэм шинжилгээний ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх;	Тодорхой заагаагүй
19.	8.1.14.эрдэм шинжилгээний шилдэг бүтээл шалгаруулж урамшуулах;	Тодорхой заагаагүй
20.	8.1.15.шинжлэх ухаан, технологийн салбарт гадаад улс, олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төслийн нэгдсэн бүртгэл хөтлөх, зохицуулах;	Тодорхой заагаагүй
21.	9.1.1.эрхэлсэн салбарын шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх;	Тодорхой заагаагүй
22.	9.1.2.салбарын шинжлэх ухаан, технологи, инновацийн чадавхийг хөгжүүлэх;	Тодорхой заагаагүй

хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

23.	9.1.3.салбарын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох;	Тодорхой заагаагүй
24.	9.1.4.салбарын хэмжээнд хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн хөтөлбөр, төсөл боловсруулах, захиалах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	Тодорхой заагаагүй
25.	9.1.5.хэрэгжүүлсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын тайланг хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт өгөх;	Тодорхой заагаагүй
26.	9.1.6.эрхэлсэн салбарын хэмжээнд шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэх арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлэх;	Тодорхой заагаагүй
27.	9.1.7.эрдэм шинжилгээ, туршилт зохион бүтээх ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;	Тодорхой заагаагүй
28.	9.1.8.салбарын эрдэм шинжилгээний байгууллагын удирдлага, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулах;	Тодорхой заагаагүй
29.	13.2.4.эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын тайланг уг ажлыг дуусснаас хойш 60 хоногт багтаан шинжлэх ухаан, технологийн мэдээллийн санд хүргүүлж хадгалуулах;	60 хоног
30.	13.2.5.эрдэм шинжилгээний ажлын явц, гүйцэтгэл, түүнчлэн санхүүжилтийн зориулалтаар олгосон хөрөнгийн зарцуулалтын мэдээ, тайланг захиалагч, санхүүжүүлэгч байгууллагын шаардсанаар тухай бүр үнэн зөв гаргаж өгөх;	Тухай бүр
31.	13.2.6.эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын явц буюу үр дүнд байгаль орчин, хүн, мал, амьтны эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлэхээр байдал илэрвэл мэргэжлийн байгууллагад мэдэгдэж дүгнэлт гаргуулах, уг байдал тогтоогдвол ажлаа зогсоох, учирч болох сөрөг нөлөөлөл, хохирлын талаар захиалагч, санхүүжүүлэгч, холбогдох бусад байгууллагад мэдэгдэх;	Тухай бүр
32.	13.2.7.шинжлэх ухаан, технологийн салбарт гадаад улс, олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төслийн тухай мэдээллийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэх;	Тухай бүр
33.	13.2.8.эрдэм шинжилгээнийх нь ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, ашиглахад хамтран ажиллаж дэмжлэг үзүүлэх.	Тодорхой заагаагүй
34.	16.3.Энэ хуулийн 16.1-д заасан ажлын захиалагч нь төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага байх бөгөөд тэдгээр нь Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлд заасны дагуу гүйцэтгэгчтэй төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээ байгуулна.	Тодорхой заагаагүй
35.	16.6.Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын барилга байгууламж, сорилт, туршилтын зориулалттай тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангахтай холбогдсон зардлыг улсын төсөвт тусгах, санхүүжүүлэх асуудлыг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.	Тодорхой заагаагүй
36.	17.2.1.захиалсан эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын санхүүжүүлэгчтэй гэрээ байгуулах;	Тодорхой заагаагүй
37.	17.2.2.санхүүжүүлэгчээс олгосон хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах;	Тодорхой заагаагүй
38.	17.2.3.гүйцэтгэсэн ажлын үр дүнг хүлээн авч хянан, баталгаажуулах арга хэмжээг уг ажлын үр дүнг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэх;	30 хоног
39.	17.2.4.захиалсан ажлынхаа санхүүжилтийн сар, улирлын хуваарийг санхүүжүүлэгчтэй хамтран тодорхойлох;	Тодорхой заагаагүй
40.	17.5.Шинжлэх ухаан, технологийн сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрхэн нэвтрүүлж ашигласан талаар Зөвлөлд хоёр жил тутамд тайлагнана.	2 жил тутамд
41.	18.1.5.гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлэх, хөрөнгө зардлыг оновчтой хуваарилж, үр ашигтай зарцуулах, үр дүнг тоо, чанарын хувьд захиалсан түвшингээс нь бууруулахгүйгээр боловсруулж захиалагчид хүлээлгэн өгөх;	Хугацаанд нь
42.	18.1.6.эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын явцад гэрээнд заасан үр дүнд хүрэх бололцоогүй нь нотлогдсон, эсхүл давагдашгүй хүчин зүйл, хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас уг ажлыг цаашид хэрэгжүүлэх бололцоогүй болсон бол энэ тухайгаа захиалагчид даруй мэдэгдэх;	Даруй

43.	18.1.8.гадаад, дотоодын байгууллага, хуулийн этгээд, иргэний хөрөнгөөр гүйцэтгэж буй эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын гүйцэтгэгч нь уг ажлын сэдвийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэх.	Тодорхой заагаагүй
44.	19.4.Судалгааны ажлын арга барил эзэмшсэн байдал, ур чадварынх нь түвшин, ажлын үр дүнг үнэлэх, зэрэг дэвийг ахиулах зорилгоор эрдэм шинжилгээний ажилтныг 4 жил тутамд аттестатчилалд хамруулах бөгөөд журмыг нь шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	4 жил тутамд
45.	21.1.3.энэ хуулийн 11.2-т заасан байгууллагад тасралтгүй 25 ба түүнээс дээш жил эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил эрхэлсэн эрдэм шинжилгээний болон инженер-техникийн ажилтан, лаборант өндөр насны тэтгэвэр тогтоолгох бол ажиллаж байгаа байгууллагаас нь 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох;	Тухай бүр

7.3.6. Хуульд заасан хориглосон зохицуулалт нь түүнийг зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх

Дд	Хуульд заасан хориглосон зохицуулалт	Хариуцлагыг заасан зүйл заалт
1.	13.2.4.эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын тайланг уг ажлыг дуусснаас хойш 60 хоногт багтаан шинжлэх ухаан, технологийн мэдээллийн санд хүргүүлж хадгалуулах;	25.1.1.
2.	13.2.5.эрдэм шинжилгээний ажлын явц, гүйцэтгэл, түүнчлэн санхүүжилтийн зориулалтаар олгосон хөрөнгийн зарцуулалтын мэдээ, тайланг захиалагч, санхүүжүүлэгч байгууллагын шаардсанаар тухай бүр үнэн зөв гаргаж өгөх;	25.1.1.
3.	13.2.6.эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын явц буюу үр дүнд байгаль орчин, хүн, мал, амьтны эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлэхээр байдал илэрвэл мэргэжлийн байгууллагад мэдэгдэж дүгнэлт гаргуулах, уг байдал тогтоогдвол ажлаа зогсоох, үүнээс болох сөрөг нөлөөлөл, хохирлын талаар захиалагч, санхүүжүүлэгч, холбогдох бусад байгууллагад мэдэгдэх;	25.1.2.
4.	17.2.3.гүйцэтгэсэн ажлын үр дүнг хүлээн авч хянан, баталгаажуулах арга хэмжээг уг ажлын үр дүнг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэх;	25.1.3.
5.	17.5.Шинжлэх ухаан, технологийн сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрхэн нэвтрүүлж ашигласан талаар Зөвлөлд хоёр жил тутамд тайлагнана.	25.1.4.
6.	17.2. Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын захиалагч дор дурдсан үүрэгтэй:	25.1.5.
7.	18.1.8.гадаад, дотоодын байгууллага, хуулийн этгээд, иргэний хөрөнгөөр гүйцэтгэж буй эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын гүйцэтгэгч нь уг ажлын сэдвийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэх.	25.1.6.

III ХЭСЭГ. САНАЛ

Шинжлэх ухаан, технологийн тухай Монгол Улсын хуулийн бусад хуультай харьцуулан давхардал, хийдэл, зөрчлийг арилгах ажлын хүрээнд нийт шууд хамааралтай 10 хуулийг харьцуулсан бөгөөд Улсын Их Хурал, Засгийн газар, холбогдох яам, агентлагаас гаргасан 17 тогтоол, шийдвэр зэргийг харьцуулсны үндсэн дээр дараах саналыг гаргаж байна.

Уг хууль нь шинжлэх ухаан, технологийн салбарын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын үйл ажиллагаанд хэрэглэгдэх нэр томъёо, үндсэн зарчим, үйл ажиллагааны удирдлага, түүний эрх, үүрэг, эрдэм шинжилгээний байгууллагыг үүсгэн байгуулах, татан буулгах, санхүүжүүлэх болон эрдэм шинжилгээний ажилтны эрх, үүрэг, нийгмийн баталгаа, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын асуудлыг зохицуулсан байна. Хуулийн хэрэгжилттэй холбогдуулан ЗГ, УИХ, сайдын зүгээс гаргасан тогтоол, дүрэм, журам цөөнгүй байна.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.legal.mn

Сүүлийн жилүүдэд улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүйн чиглэлээр судалгаа, шинжилгээ хийдэг төрийн болон төрийн бус судалгааны байгууллагуудын тоо эрс нэмэгдэж байна. Үүнтэй холбогдуулан судалгаа, шинжилгээний байгууллагуудаас гаргаж буй бүтээгдэхүүний нэр төрөл, тоо мөн адил өсөж байна.

Иймд шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн " Хуулийн нэр томъёо" хэсэгт суурь болон хавсарга судалгааны төрлөөс гадна бусад судалгааны төрлүүдийг нэмж оруулах хэрэгцээ шаардлага байна.

Мөн Судалгааны төвийн дэргэдэх номын сан нь зөвхөн хууль, эрх зүйн чиглэлийн монгол, гадаад ном, сэтгүүл, бусад бүтээлээс бүрдсэн номын фондтой бөгөөд улсын хэмжээнд хууль зүйн чиглэлээр дагнан төрөлжсөн номын сан юм.

Тус номын сангийн үйл ажиллагааг дэмжих, номын фондыг баяжуулах зорилгоор хууль эрх зүйн чиглэлээр гаргасан бүтээл, эрдэм шинжилгээний ажлын тайлан, эрдмийн зэрэг хамгаалсан бүтээл зэргийн тодорхой тооны хувийг тус номын санд шилжүүлж байх нь ном эрх зүйн чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх, лавлагааг нэг дороос авах нөхцөлийг бүрдүүлэх юм.

Үүний тулд Номын сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлд "Төрөлжсөн номын санд заавал авах хувьтай байх", 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт "Төрөлжсөн номын санд эрдмийн зэрэг хамгаалсан бүтээлээс 2 хүртэл ширхэгийг авах" болон Журам батлах тухай БСШУ-ны сайдын 2007 оны 187 дугаар тушаалаар баталсан "Магистр, докторын сургалт эрхлэхэд баримтлах нийтлэг журам"-ын 19.1 дэх хэсэгт "Төрөлжсөн номын санд докторын диссертацийн ажил өгдөг байх" зэрэг заалтыг нэмж оруулах шаардлага байна.

IV ХЭСЭГ. ТУХАЙН ХУУЛИЙН БИЧВЭРИЙН ХАРЬЦУУЛАЛТ

"Шинжлэх ухаан, технологийн тухай" хууль болон бусад хууль тогтоомжийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем /www.legalinfo.mn/-д байгаа хувийг бусад хуулийн хувьтай тулгасан нь:

№	www.legalinfo.mn	"Төрийн мэдээлэл" сэтгүүл
	Шинжлэх ухаан технологийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2007 оны №4/481/ дугаарт нийтлэгдсэн	
1.	7.3.15.эрдэм шинжилгээний байгууллагын бүтэц, зохион байгуулалт;	7.3.15.эрдэм шинжилгээний байгууллагын бүтэц, зохион байгуулалт;
2.	7.3.16.хуульд заасан бусад чиг үүрэг.	7.3.16.хуульд заасан бусад чиг үүрэг.
	***Санал**: Хууль, улсын их хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 17.2.1 дэх заалтын дагуу дэс дараалалд оруулах*	

№	www.legalinfo.mn	"Төрийн мэдээлэл" эмхэтгэл 2006 оны №7 /436/ дугаар
	Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль	
	2.1.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.	2.1.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль', Иргэний хууль[2], энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. *1. Монгол Улсын Үндсэн хууль – "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.* *2. Иргэний хууль - "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.*
	***Санал**: Ишлэл хэсгийг "Төрийн мэдээлэл" эмхэтгэлд нийтлэгдсэн эх хувьтай нийцүүлэх.*	

хууль зүйн үндэсний төв www.mn.gov.mn

№	www.legalinfo.mn	"Төрийн мэдээлэл" эмхэтгэл 2006 оны №7 /436/ дугаар
	Патентийн тухай хууль	
1.	2.1.Патентийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.	2.1. 2.1.Патентийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль', Иргэний хууль², энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. *1. Монгол Улсын Үндсэн хууль – "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.* *2. Иргэний хууль - "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.*
	Санал: *Ишлэл хэсгийг "Төрийн мэдээлэл" эмхэтгэлд нийтлэгдсэн эх хувьтай нийцүүлэх.*	

---o0o---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ДӨРӨВ. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

АЖ АХУЙН НЭГЖИЙН ДАМПУУРАЛ БА ДАХИН ХӨРӨНГӨЖҮҮЛЭХ АЖИЛЛАГАА[1]

/Харьцуулсан судалгаа/

ХУРААНГУЙ

Сүүлийн жилүүдэд олон улсын төдийгүй бүс нутгийн шинжтэй эдийн засгийн хямрал гарах болсонтой холбогдуулан улс орнууд өөрийн эдийн засгийн хууль тогтоомжийг шинэчлэх ажил өрнүүлж байна. Үүний нэг тод илрэл бол Дампуурлын эрх зүй, түүний нэгэн институт болох дахин хөрөнгөжүүлэх талаар хууль тогтоомждоо тусгах, боловсронгуй болгох асуудал юм. Тухайлбал, БНСУ нь эдийн засгийн хямралтай холбогдуулан 2005 онд хуулиа шинэчлэн батлсан бол 2008 оны дэлхийн эдийн засгийн хямралтай холбогдуулан ХБНГУ хууль тогтоомжоо шинэчлэх ажил өрнүүлсэн байдаг.

Монгол Улсын хувьд анх 1991 онд “БНМАУ-ын Аж ахуйн нэгжийн дампуурлын тухай” хуулийг батлан, 1997 онд шинэчилсэн боловч үүнээс хойш энэ хууль нь дорвитой шинэчлэгдээгүй байдаг. Энэхүү хууль нь 1990-ээд оны шилжилтийн үеийг даван туулах, тухай үеийн аж ахуйн нэгж, байгууллагуудын дампууралтай холбогдон үүссэн харилцааг зохицуулахад зохих үүргээ гүйцэтгэсэн гэж дүгнэж болно.

2005 оноос хойш шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг маргааны статистик мэдээллээс үзэхэд Дампуурлын тухай хуулийн хүрээнд нийтдээ 132 хэрэг шийдвэрлэгдсэнээс 5 хэргийг шүүхээс дахин хөрөнгөжүүлэхээр шийдвэрлэсэн байна. Энэ нь Дампуурлын тухай хуулиар хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэхээр гаргасан шийдвэр болон аж ахуйн нэгж /цаашид “ААН” гэх/-ийг татан буулгахаар шийдвэрлэсэн хэргийн тоотой харьцуулахад хангалтгүй байгааг харуулж байна. Үүнээс үүдэн дахин хөрөнгөжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх, энэ талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь өнөөгийн эдийн засаг, санхүүгийн хүндрэлийг хохирол багатайгаар даван туулахад чухал ач холбогдолтой юм.

Иймд энэхүү судалгааны хүрээнд Дампуурлын тухай хууль, нэн ялангуяа аж ахуйн нэгжийн дахин хөрөнгөжүүлэх асуудлыг судлан, практикт тулгамдаж буй асуудлыг тодорхойлохын зэрэгцээ БНСУ, болон ХБНГУ-ын дахин хөрөнгөжүүлэх бодлого, хууль эрх зүйн орчинг харьцуулан судлах замаар Монгол Улсын дахин хөрөнгөжүүлэх ажиллагаатай холбоотой эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар санал, зөвлөмжийг боловсруулсан. Тодруулбал дахин хөрөнгөжүүлэх бодлого, зорилго, зарчим, зохицуулалтын хүрээ, үр дүнтэй тогтолцооны хувилбарыг тодорхойлсон болно.

Үүний зэрэгцээ ААН-ийг дахин хөрөнгөжүүлэхтэй холбоотой хялбарчилсан шуурхай, зардал багатайгаар хэргийг хянан шийдвэрлэхэд чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг судалж санал болгосон. Түүнчлэн шүүхийн бус журмаар аж ахуйн нэгжийг дахин хөрөнгөжүүлэх зохицуулалтыг хэрэгжүүлэх механизм, түүний давуу болон сул тал, хэрэгжүүлэхэд шаардлагатай урьдчилсан нөхцөл зэргийг судлах замаар Монгол Улсад нэвтрүүлэх боломж бололцоонд урьдчилсан дүн шинжилгээ хийж, тодорхой санал зөвлөмжийг тусгасан болно.

[1] Тус судалгааг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Зүмбэрэллхам удирдан, эрдэм шинжилгээний ажилтан Ж.Алтансүх, Б.Ундрах МУИС-ийн ХЗС-ийн Хувийн эрх зүйн тэнхмийн багш Л.Банзрагч нар хамтран гүйцэтгэв.

УДИРТГАЛ 1. Судалгааны асуудал

Манай улсад шүүхэд хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэхээр шийдвэрлэгдсэн хэрэг ердөө 5 байгаа[2] нь дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа үр дүнгүй хэрэгжиж байгааг илтгэж байна. Дэлхийн өндөр хөгжилтэй улс орнууд эдийн засгийн хямрал бусад нөхцөл байдалтай уялдуулан ААН-ийг дахин хөрөнгөжүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг хууль тогтоомждоо тусгаж ирсэн байдаг. Тухайлбал, БНСУ нь эдийн засгийн хямралтай холбогдуулан 2005 онд хуулиа шинэчлэн баталсан бол 2008 оны дэлхийн эдийн засгийн хямралтай холбогдуулан ХБНГУ хууль тогтоомжоо шинэчлэх ажил өрнүүлсэн байдаг. Харин манай улсын хувьд Дампуурлын тухай хуулийг 1997 онд баталснаас хойш дорвитой шинэчлэл хийгээгүй, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлага тулгарч байна.

Иймээс өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан төлбөрийн чадваргүй болсон ААН-ийн үйл ажиллагааг дэмжих, дампуурахаас урьдчилан сэргийлэх зохицуулалтыг судлах, хууль тогтоомжийг шинэчлэх шаардлагатай.

2. Судалгааны зорилго

Энэхүү судалгааны зорилго нь Хууль зүй, дотоод хэргийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу Дампуурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд холбогдох судалгаа хийх, дампуурлын эрх зүйн орчныг сайжруулах боломжийг тодорхойлох, хуулийг боловсруулахад хууль санаачлагчид дэмжлэг үзүүлэх, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөхийг зорилоо.

Түүнчлэн энэхүү судалгаагаар гадаадын зарим орны туршлагыг судлах, өөрийн улсад тулгарч буй асуудлыг нээн илрүүлэх замаар түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилго агуулсан. Ялангуяа дампуурлын эрх зүйн нэгэн салбар судлагдахуун болох дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа түүний зорилго, зарчим, зохицуулалтын хүрээ, үр дүнтэй механизмыг бүрдүүлэхэд судалгааны зорилго оршино.

3. Судалгааны хамрах хүрээ

Энэхүү судалгаа нь өөрийн улсын ААН-ийг дахин хөрөнгөжүүлэхтэй холбоотой зохицуулалтын онцлог, холбогдох хууль тогтоомж, шүүхийн практик болон энэ хүрээн дэх гадаад улсын туршлагыг судална. Мөн манай улсын аж ахуйн нэгжийн дахин хөрөнгөжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгох тодорхой санал, зөвлөмж боловсруулах хүрээнд хийгдэнэ. Судалгааны үр дүнг бодитой болгох үүднээс Азийн өндөр хөгжилтэй орнуудаас Өмнөд Солонгос, Европын холбооны улсуудаас Герман улсын зохицуулалтыг өнөөгийн Монгол Улсын зохицуулалттай харьцуулан судлав.

Дахин хөрөнгөжүүлэхтэй холбоотой, тэр дундаа шүүхийн бус арга хэрэгслээр дахин хөрөнгөжүүлэх асуудлаар судалгаа хийгдээгүй зэргийг харгалзан энэхүү судалгаанд шүүхийн бус арга хэрэгслээр дахин хөрөнгөжүүлэх асуудлыг судаллаа. Уг судалгаа нь ААН-ийг дахин хөрөнгөжүүлэх асуудлын хүрээнд хийгдсэн учраас судалгаанд хувь хүнийг дахин хөрөнгөжүүлэх зохицуулалтыг авч үзээгүй болно.

Нэр томьёо

Монгол Улсын Дампуурлын тухай хуульд дахин хөрөнгөжүүлэх гэсэн нэр томъёог нарийвчлан тодорхойлоогүй боловч судлагдсан орнуудад “дахин хөрөнгөжүүлэх” гэсэн ойлголтыг нийтлэг агуулгаар компанийн үйл ажиллагааг сэргээн босгох буюу “restructuring”, “rescue”, “rehabilitation” гэсэн нэр томьёогоор

[2] ШЕЗ-ийн ШСМСХ-ийн 2015 оны статистикийн тайлан.

илэрхийлдэг. Иймд энэхүү судалгааны хүрээнд манай улсын хуульд заасан дахин хөрөнгөжүүлэх гэсэн нэр томьёог хуулийн этгээдийг татан буулгахгүйгээр түүний үйл ажиллагааг сэргээх, дахин хөрөнгөжүүлэх гэсэн ойлголтын хүрээнд судалгаандаа ашиглана.

4. Судалгааны арга зүй

Судалгаанд холбогдох хууль тогтоомжид дүн шинжилгээ хийх, гадаад улсын туршлагыг судалж харьцуулах, мөн түүнчлэн түүхчлэх, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх гэсэн судалгааны нийтлэг аргуудыг ашигласан болно.

5. Судалгааны бүтэц

Судалгааны нэгдүгээр бүлэгт дахин хөрөнгөжүүлэх ажиллагааны хүрээн дэх ерөнхий ойлголт; Хоёрдугаар бүлэгт Монгол Улсын эрх зүйн зохицуулалт, харьцуулсан дүн шинжилгээ; Гуравдугаар бүлэгт холбогдох дүгнэлт, саналыг дэвшүүлсэн ба Хавсралт хэсэгт Бүгд Найрамдах Солонгос Улс болон Холбооны Бүгд Найрамдах Герман улсын дахин хөрөнгөжүүлэх талаарх туршлагыг судалсан.

НЭГ. ДАХИН ХӨРӨНГӨЖҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭН ДЭХ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

1. Дахин хөрөнгөжүүлэх бодлогын зорилго, чиг хандлага, арга хэмжээ

Манай улсад нэвтрүүлэхэд урьдчилсан дүн шинжилгээ хийх нь

Өнөөгийн эдийн засгийн хөгжил, өрийн зах зээл дээрх бүтээгдэхүүний хөгжил нь шүүхийн бус арга хэрэгслээр дахин зохион байгуулах ажиллагааг хэрэгжүүлэх таатай эрэлтийг бий болгосон. Шүүхийн бус арга хэрэгслээр дахин зохион байгуулах тогтолцоо нь үүрэг гүйцэтгүүлэгчид давуу нөхцөлийг олж авах /хувьцаа олж авах зэрэг/ боломжийг олгодог төдийгүй ААН-д бизнесийн нэр хүндээ унагаахгүйгээр, шуурхай, зардал багатай санхүүгийн асуудлаа шийдвэрлэх боломжийг олгодог.

Гэсэн хэдий ч өрийн зах зээл дээрх Хедж сан (Hedge Fund) болон бусад хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа нь тодорхой биш, эрсдэлтэй, богино хугацаанд үйлчилдэг учраас санхүүгийн зах зээл дээр тогтолцооны хямрал дагуулах эрсдэл бий болгох боломжтой гэж шүүмжлэгддэг. Түүнчлэн гадаад улс оронд энэхүү тогтолцоог хэрэгжүүлэхэд шаардлагатай дахин хөрөнгөжүүлэх чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүд бий болсон ба энэ хүрээнд дийлэнх банк, санхүүгийн байгууллагууд нь дахин хөрөнгөжүүлэх мэргэжилтнүүдийн багтай байдаг. Иймд энэхүү тогтолцоог нэвтрүүлэхэд төрөөс санхүүгийн зах зээл дээр үүсэж болох эрсдэлийг арилгах, шаардлагатай хүний нөөцийг төрөөс дэмжин бэлтгэх зэрэг урьдчилсан нөхцөлүүдийг бүрдүүлэн, бэлтгэл ажлыгхангах шаардлагатай байна.

Түүнчлэн Герман, Солонгос Улсын жишгийг харахад энэхүү бодлогыг эдийн засаг, санхүү, хууль зүй зэрэг салбар дундын бодлогын хүрээнд тодорхойлон хэрэгжүүлдэг жишиг байгааг харгалзан шүүхийн бус арга хэрэгслээр ААН-ийг дахин зохион байгуулах тогтолцоог салбар дундын хамтарсан бодлогоор үр дүнтэй тодорхойлох нь зүйтэй болов уу.

Үндсэндээ шаардлагатай бэлтгэл ажлыг хангаснаар Герман, Солонгос Улсын жишгийг харгалзан шүүхийн бус арга хэрэгслээр ААН-ийг дахин зохион байгуулах тогтолцоог манай улсад нэвтрүүлэх бололцоотой төдийгүй нийгэм, эдийн засгийн өндөр ач холбогдолтой гэж үзэж байна.

Эдийн засгийн хямралаас үүдэх сөрөг нөлөө, эрсдэлийг багасгах зорилгоор дийлэнх улс орнууд ААН-ийг дахин хөрөнгөжүүлэх талаар хууль тогтоомждоо

тусгах болсон.[3] Энэхүү бодлогоор төлбөрийн чадваргүйд тооцогдсон ч цаашид үр бүтээлтэй ажиллах боломжтой ААН-ийг дэмжих, үйл ажиллагааг нь сэргээх замаар үүрэг гүйцэтгүүлэгчийн ашгийг хангах төдийгүй тухайн улс орны эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилготой. Тийм ч учраас дахин хөрөнгөжүүлэх бодлогыг эдийн засгийн бодлого гэж үзэхээс илүүтэй нийгмийн сайн сайханд чиглэсэн бодлого гэдэгтэй судлаачид санал нэгддэг байна.[4]

1990-ээд оноос эхлэн дахин хөрөнгөжүүлэх бодлогын үндсэн зорилго, зарчим нь дампуурлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тооцох, үйл ажиллагаагаа дахин идэвхжүүлэх сэдлийг ААН-д төрүүлэхэд чиглэгдсэн. Энэ хүрээнд үүрэг гүйцэтгэгчид тодорхой цаг хугацаа, зээлийн хэмжээгээр хязгаарлалт тогтоон дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагааг эхлүүлэх үүрэг бий болгосон. Үүний зэрэгцээ дахин хөрөнгөжүүлснээр нийт үүрэг гүйцэтгүүлэгчдийн ашиг сонирхлыг дампуурснаас илүү хангах бололцоог бий болгосон нь талуудад дахин хөрөнгөжүүлэх аргыг сонгоход түлхэц болсон.[5]

Зарим улс оронд дахин хөрөнгөжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд зөвхөн шүүхэд нэхэмжлэл гаргах замаар төдийгүй банк, санхүүгийн байгууллагын оролцоотой шүүхийн бус арга хэрэгслээр дахин хөрөнгөжүүлэх тогтолцоо бий болсон.[6]

Шүүхийн бус арга хэрэгслээр дахин хөрөнгөжүүлэх бодлогын хүрээнд үүрэг гүйцэтгүүлэгч болох санхүүгийн байгууллагуудыг дахин хөрөнгөжүүлэх ажиллагаанд татан оролцуулах замаар дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг үр дүнтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлдэг.[7]

Үндсэндээ өнөө үед төрөөс төлбөрийн чадваргүй байдлыг зохицуулахдаа ААН-ийг аль болох татан буулгахгүйгээр, цаашид үр ашигтай ажиллах боломжтой ААН-ийн үйл ажиллагааг сэргээх, ингэхдээ үүрэг гүйцэтгэгч, үүрэг гүйцэтгүүлэгчдийн эрх ашгийг тэнцвэртэй байдлаар хангах чиг хандлагыг баримталж байна.[8]

Дахин хөрөнгөжүүлэх арга хэмжээ

Дахин хөрөнгөжүүлэх ажиллагааны хамгийн чухал асуудал нь санхүүгийн хүндрэлд орсон ААН-ийн “үйл ажиллагааг сэргээх, хүндрэлээс гаргах арга хэмжээ авах” болно.[9] Энэ талаар олон төрлийн арга хэмжээг дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлдэг. Тухайлбал: удирдлагын болон үйл ажиллагааны өөрчлөлт (managerial and organizational reforms), үр ашиггүй зардлыг /салбар, хэлтэс мөн хамаарна/ танах (asset reductions), зардлыг бууруулах /энэ хүрээнд хэмнэж болох түүхий эд, тоног төхөөрөмжөөс гадна хүний нөөцийн зардлыг мөн ойлгодог/ (cost reductions), зээлийн нөхцөлийг ашигтай болгох /хугацааг сунгах, бусад бага зардалтай газраас авах зэрэг/ (debt restructuring), зээлийг хувьцаагаар солих (debt/equity conversions), нэмэлт хөрөнгө оруулалт татах зэрэг хамаарна.

---

[3] Edited by Michael Pomerleano and William Shaw, Corporate Restructuring: Lessons from Experience, the World Bank, 2005.

[4] Vanessa Finch, Corporate Insolvency Law: Perspectives and Principles, Second Edition, Cambridge University Press, 2009.

[5] Мөн тэнд

[6] Мөн тэнд, хуудас 277

[7] Мөн тэнд, хуудас 269

[8] Мөн тэнд.

[9] Vanessa Finch, Corporate Insolvency Law: Perspectives and Principles, Second Edition, Cambridge University Press, 2009.

2. Хэрэгжүүлэх хэлбэрүүд

Шүүхэд нэхэмжлэл гаргах замаар дахин хөрөнгөжүүлэх

Дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагаа нь шүүхэд нэхэмжлэл гаргах замаар (formal, incourt) болон шүүхийн бус арга хэрэгслээр (informal, out-of-court) хэрэгждэг.

Шүүхэд нэхэмжлэл гаргах замаар дахин хөрөнгөжүүлэх тохиолдолд ААН-ийн төлбөрийн чадваргүй болсон тухай нийтэд мэдээлдэг нь ААН-ийн нэр хүнд унахад хүргэх, мөн удирдлагын буруутай үйл ажиллагаанаас болж төлбөрийн чадваргүй болсон тохиолдлоос бусад тохиолдолд ААН-ийн удирдах эрхийг хэрэг гүйцэтгэгчид шилжүүлдэг. Тийм учраас ААН-ийн үйл ажиллагааг удирдах хүний нөөцийн нэмэлт зардал болон цаг хугацаа алдахад хүргэдэг төдийгүй хэрэг гүйцэтгэгч нь түргэн хугацаанд бизнесийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх нэмэлт санхүүжилтийг олох хүндрэлтэй тулгардаг зэрэг сул талтай байдаг.[10] Иймд шүүхэд нэхэмжлэл гаргах замаар дахин хөрөнгөжүүлэхэд үүрэг гүйцэтгэгч бизнесийн удирдлагаа алдах, харин зарим үүрэг гүйцэтгүүлэгч хөрөнгө оруулалтаа бүрэн буцааж авах боломжгүй байх явдал гардаг. Мөн шүүхийн шийдвэр зарим үүрэг гүйцэтгүүлэгчийн хүсэл зоригийн эсрэг гарах магадлалтай байдаг. Дээрх хүндрэл, бэрхшээлтэй холбоотойгоор талуудыг шүүхэд нэхэмжлэл гаргах замаар дахин хөрөнгөжүүлэх аргыг сонгодог.[11]

Харин өрийн зах зээлийн (debt market)[12] бүтэц хөгжин төрөл бүрийн эх үүсвэрээс (fragmented) зээл авах боломжтой болсон (тухайлбал хөрөнгийн зах зээлээс санхүүжилт босгох бололцоо) мөн олон янзын ашиг сонирхол бүхий олон төрлийн үүрэг гүйцэтгүүлэгч сайн дурын үндсэн дээр нэгдсэн байдлаар шүүхийн бус арга хэрэгслээр тохиролцоонд хүрэх төвөгтэй байдаг. Тийм учраас шүүхийн бус арга хэрэгслээр дахин хөрөнгөжүүлэх асуудлыг шийдвэрлэх нь тийм ч хялбар зүйл биш байдаг.[13] Улмаар олон улсад дээр дурдсан бизнесийн нэр хүнд унах, удирдлагыг солих, үүрэг гүйцэтгүүлэгчдийн ашиг сонирхлыг хангах асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн 'pre-packaged administration' 'self-administration' буюу өмнө нь тохиролцсоноор дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг өөрөө хянан шийдвэрлэх арга хэлбэр хэрэгжих болсон.[14] Энэхүү хэрэг хянан шийдвэрлэх журмыг ХБНГУ-ын туршлагыг судлахад дэлгэрэнгүй авч үзнэ.

Шүүхийн бус арга хэрэгслээр дахин хөрөнгөжүүлэх

Шүүхийн бус арга хэрэгслээр дахин хөрөнгөжүүлэх механизм нь санхүүгийн хямралын үед Английн Төв банкны оролцоотой хэрэгжиж байсан 'London approach' буюу дахин хөрөнгөжүүлэх Лондон арга барилд үндэслэсэн байдаг. Энэ талаар товчхон авч үзье.[15]

Шүүхийн бус арга хэрэгслээр үүрэг гүйцэтгүүлэгчдийн олон янзын ашиг сонирхлыг нэгтгэх асуудлыг шийдвэрлэх арга зам 1970-90-ээд оны үед Лондонд үүсэж хөгжсөн ба түүнийг хожим нь "Лондон арга" хэмээн нэрлэсэн байдаг.[16] Энэхүү

[10] John Armour, The Rise of the 'PRE-PACK': Corporate Restructuring in the UK *and* Proposals for Reform, Restructuring Companies in Troubled Times: Director and Creditor Perspectives, Sydney: Ross Parsons Centre, 2012.

[11] Мөн тэнд.

[12] http://www.investopedia.eom/terms/c/credit_market.asp

[13] Мөн тэнд, хуудас 15-16

[14] Мөн тэнд.

[15] Edited by Michael Pomerleano and William Shaw, Corporate Restructuring: Lessons from Experience, the

[16] World Bank, page 14, 2005.
Vanessa Finch, Corporate Insolvency Law: Perspectives and Principles, Second Edition, Cambridge University Press, page 307, 2009.

аргын гол ажиллах зарчим нь үүрэг гүйцэтгүүлэгч банк, санхүүгийн байгууллага болон нийт хамаарал бүхий этгээдэд шаардлагатай мэдээллийг ил тод болгодог ба тэд үүрэг гүйцэтгэгчийг дахин хөрөнгөжүүлэх талаар авч хэлэлцэн дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг боловсруулдаг. Улмаар үүрэг гүйцэтгүүлэгчид нь үүрэг гүйцэтгэгчийн эсрэг өр төлбөр барагдуулах аливаа нэхэмжлэл шүүхэд гаргахгүй ба нийт үүрэг гүйцэтгүүлэгчид дахин хөрөнгөжүүлэхтэй холбоотой гарах зардал, үр ашгийг адил тэгш хэмжээтэй байхаар хуваарилдаг. Тухайн талуудын ашиг сонирхлыг тэнцвэржүүлэн зуучлан, чиглүүлэгч нь Английн Төв Банк байв.[17] Английн Төв Банк нь санхүүгийн байгууллагуудыг зохицуулах, хяналт тавих, хариуцлага тооцох эрх үүрэг бүхий байгууллага байсан учраас шүүхийн бус арга хэрэгслээр талуудыг дахин хөрөнгөжүүлэх тохиролцоонд хүрэхэд тодорхой хэмжээнд албан бус байдлаар нөлөө үзүүлж байсан.'[18]

Ингээд энэхүү шүүхийн бус арга хэрэгслээр дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх ерөнхий механизм, давуу болон сул тал, үе шат, хэрэгжүүлэхэд анхаарах асуудлыг товчхон авч үзье.[19] Шүүхийн бус арга хэрэгслээр дахин хөрөнгөжүүлэх гэдэгт талууд сайн дурын, гэрээний үндсэн дээр тохиролцон, мэргэжлийн хүмүүс, байгууллагын зөвлөгөөг авч үр дүнтэй боломжит арга замаар дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг хэрэгжүүлэхийг ойлгодог. Шүүхийн бус арга хэрэгслээр болон шүүхэд нэхэмжлэл гаргах замаар дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг хэрэгжүүлэхэд адил арга хэмжээ /жишээлбэл менежментийн, үйл ажиллагааны өөрчлөлт, дахин санхүүжилт хийх зэрэг/ авч хэрэгжүүлэх боломжтой.

Зарим улс орон шүүхийн бус арга хэрэгслээр дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг банк санхүүгийн байгууллагын оролцоон дээр түшиглэн хэрэгжүүлдэг. Улмаар ААН-ийг санхүүгийн асуудалтай тулгарахад банк санхүүгийн байгууллага нь илүү идэвхтэй үүрэг гүйцэтгэж тухайн компанийн удирдлагатай хамтарч ажиллах, удирдлагын үйл ажиллагаанд үнэлгээ хийх, хянах байдлаар ААН-ийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож эхэлдэг (hands-on approach). Дийлэнх банк санхүүгийн байгууллагууд нь дахин хөрөнгөжүүлэх мэргэжилтнүүдийн багтай болсон ба улс оронд өрийн зах зээл (debt market) дээр шинэ төрлөгчид болох компанийг дахин хөрөнгөжүүлэх мэргэжилтнүүд (turnover specialists) бий болсон.[20]

Шүүхийн бус арга хэрэгслээр дахин хөрөнгөжүүлэх асуудлын хүрээнд өрийн зах зээлтэй холбоотой 3 өөрчлөлт, шинэчлэлтийг дурдах нь зүйтэй.[21] Нэгдүгээрт зөвхөн банк гэлтгүй олон төрлийн санхүүгийн байгууллага болох хөрөнгө оруулалтын Хедж сан (Hedge Fund), хувийн хөрөнгө оруулалтын сан (Private Equity Fund), өр, зээлийн хүндрэлд орсон үүрэг гүйцэтгэгчдэд хөрөнгө оруулагчид (distressed debt investors) зэрэг төрлөөр хөгжсөн. Энэ нь санхүүгийн хүндрэлд орсон ААН нь банкнаас илүүтэй шинэ төрлийн хедж сан, хувийн хөрөнгө оруулалтын сан зэргээс хамааралтай болох нөхцөлийг бүрдүүлсэн. Хоёрдугаарт санхүүгийн хүндрэлд орсон ААН-ийг санхүүгийн хүндрэлээс гаргах олон төрлийн зээлийн бүтээгдэхүүн бий болсон. Тухайлбал хөдлөх, үл хөдлөх хөрөнгөнд түшиглэсэн зээл (asset-backed lending), зах зээлийн бүтээгдэхүүнүүд (debt capital market products) хөгжсөн. Гуравдугаарт төлбөрийн чадваргүй ААН-д хөрөнгө оруулалт хийх асуудлыг 'найдлагагүй, ашиггүй' хөрөнгө оруулалт гэж үзэх хандлага өөрчлөгдсөн. Харин ч төлбөрийн чадваргүй

[17] *Vanessa* Finch, Corporate Insolvency Law: Perspectives and Principles, Second Edition, Cambridge University Press, page 307, 2009.

[18] Мөн тэнд, хуудас 309

[19] Мөн тэнд, хуудас 295

[20] Мөн тэнд, хуудас 295

[21] Мөн тэнд, хуудас 295

ААН-д хөрөнгө оруулах нь ашигтай хөрөнгө оруулалт байх нөхцөл бүрдсэн. Эдгээр өөрчлөлт нь шүүхийн бус арга хэрэгслээр ААН-ийг дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг хэрэгжүүлэх таатай нөхцөл, эрэлтийг бий болгосон.

Иймд шүүхийн бус арга хэрэгслээр дахин хөрөнгөжүүлэх ажиллагааны гол давуу тал нь зах зээлийн нөхцөл байдлыг харгалзан алдагдлыг багасгах, орлого, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор илүү хурдан хариу арга хэмжээг бүтээлчээр авч хэрэгжүүлэх боломжийг талуудад олгосонд оршино.[22] Мөн шүүхэд нэхэмжлэл гаргах замаар дахин хөрөнгөжих нь ААН-ийг ''амжилтгүй, бүтэлгүй'' байгууллага гэдэг ойлголтыг нийгэмд төрүүлдэг учраас шүүхийн бус арга хэрэгслээр дахин хөрөнгөжих нь ААН-д бизнесийн нэр хүнд, үнэ цэнээ алдахгүй байх боломжийг олгодог. Түүнчлэн энэ арга нь бага зардлаар хэрэгждэг төдийгүй тухайн нөхцөл байдлаас шалтгаалан дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, дахин зөвшилцөх, сайжруулах, уян хатан нөхцөлийн дагуу хэрэгждэг.[23] Удирдлагын тухайд компанийн удирдлага шүүхээс томилсон хөндлөнгийн этгээд буюу хэрэг гүйцэтгэгчийн хяналт шалгалт, зааврааас гадна үйл ажиллагаагаа явуулах, шийдвэр гаргах боломжтой байдаг учраас компанийн удирдлагад давуу тал болж өгдөг.[24] Үүрэг гүйцэтгүүлэгч, банк санхүүгийн байгууллагын тухайд ч зээлдүүлсэн мөнгөө бүрэн хэмжээнд буцааж авах боломжийг олгодог төдийгүй шинэ хувьцаа, шинэ хөрөнгө оруулалт оруулах замаар ашигтай хувьцаа, *хөрөнгө* олж авах, удирдах албан тушаалд томилогдох зэрэг давуу боломжийг олгодог.[25]

Харин өрийг худалдаж буй болон худалдан авч буй байгууллага, дахин хөрөнгөжүүлэх мэргэжилтэн, зөвлөгөөний байгууллага, төлбөрийн чадваргүй болсон ААН зэрэг олон төрлийн ашиг сонирхол бүхий этгээдүүдийн хамтын ажиллагааг хангах нь нэлээд бэрхшээлтэй асуудал байдаг. Ялангуяа энэ нь өрийн үүсмэл зах зээл (credit derivative market) дээрх тоглогчдын алсын зорилго, ашиг сонирхлын зөрөө, тэдгээрийн сонирхлын ил тод биш байдал зэрэг асуудлыг улам хүндрэлтэй болдог. Улмаар саналын зөрөөтэй үүрэг гүйцэтгүүлэгчид нь шүүхэд нэхэмжлэл гаргах, ААН-ийг татан буулгах нэхэмжлэлийг шүүхэд гаргах боломжтой байдаг.[26] Түүнчлэн Хедж болон бусад хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа нь тодорхой биш, эрсдэлтэй, богино хугацаанд үйлчилдэг учраас санхүүгийн зах зээл дээр тогтолцооны хямрал (system risk) дагуулах эрсдэлтэй гэж шүүмжлэгддэг.[27] БНСУ нь шүүхийн бус арга хэрэгслээр дахин хөрөнгөжүүлэх бодлогыг амжилттай хэрэгжүүлдэг. Тус улсын туршлагыг судлах хэсэгт шүүхийн бус арга хэрэгслээр дахин хөрөнгөжүүлэх бодлого, хэрэгжүүлэх тогтолцоог дэлгэрэнгүй авч үзнэ.[28]

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХАРЬЦУУЛСАН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсад анх 1991 оны 06 дугаар сарын 03-ны өдөр “БНМАУ-ын Аж ахуйн нэгжийн дампуурлын тухай” хууль батлагдсан. Энэхүү хуулиар аж ахуйн нэгжийн дампуурал, түүнтэй холбогдох харилцааг хуульчилсан боловч энэ нь тухайн үеийн төлбөрийн чадваргүй аж ахуйн нэгжийг санхүүгийн хүндрэлээс гаргах, дахин хөрөнгөжүүлэх боломж олгохыг зориогүй, харин төлбөрийн чадваргүй болсон аж

[22] Мөн тэнд, хуудас 296

[23] Мөн тэнд

[24] Мөн тэнд

[25] Мөн тэнд

[26] Мөн тэнд

[27] Мөн тэнд, хуудас 297

[28] ICLG to: Corporate Recovery and Insolvency 2016 /Japan/

ахуйн нэгжийг зах зээлээс шахан гаргах бодлогыг барьж байсан[29] хэмээн зарим судлаачид шүүмжлэлтэй хандсан байдаг. Дээр дурдсан болон бусад шалтгаанаар[30] 1997 онд Дампуурлын тухай хуулийг шинэчлэн баталсан.

Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын /International Development Law Organization/ Монгол Улс дахь "Худалдааны эрх зүйн чиглэлээр шүүгчдийг сургах төсөл"-өөс эрхлэн гаргасан судалгаанд Дампуурлын тухай хуулийн /1997 он/ талаар "1997 онд батлагдсан Дампуурлын тухай хуулиар дампуурлын хэрэг үүсгэх, түүнийг хянан шийдвэрлэх, төлбөрийн чадваргүй аж ахуйн нэгжийг дахин хөрөнгөжүүлэх, татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгыг тодорхойлсноороо өмнөх хуулиас зарчмын ялгаатайг харж болно."[31] гэж дүгнэжээ.

Үүнээс үзэхэд 1997 онд батлагдсан Дампуурлын тухай хууль нь өмнө хэрэгжиж байсан "БНМАУ-ын Аж ахуйн нэгжийн дампуурлын тухай" хуультай харьцуулахад ААН-ийг дахин хөрөнгөжүүлэх асуудлыг уг хуулийн зорилт болгож тусгасан нь өмнөх хуультай харьцуулахад эрх зүйн зохицуулалтын хувьд зарим талаар шинэлэг болсон байна. Ингээд 1997 оноос хойш дампуурлын хэргийг шүүхээс хэрхэн шийдвэрлэж байсан талаар шүүхийн статистикийн мэдээллийг дор авч үзье.

Хүснэгт 1. Дампуурлын хэргийн талаарх статистик, тоон мэдээлэл[32]

Он	Дампуурлын тухай хууль		
	23-32 дугаар зүйл Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх	33-38 дугаар зүйл Хариуцагчийг татан буулгах	Бусад
2005	-	4	2
2006	-	51	1
2007	-	3	3
2008	-	17	-
2009	-	1	-
2010	-	-	1
2011	1	2	4
2012	-	2	-
2013	-	7	4
2014	1	8	4
2015	3	7	6
Нийт	5	102	25

[29] А.Мөнхзуя, Л.Энхбилэг, У.Мөнхбат нар, Дампуурлын эрх зүй гарын авлага, Худалдааны эрх зүйн чиглэлээр шүүгчдийг сургах төсөл, УБ, 2014, 22.

[30] 1996 оноос манай улсад төрийн өмчит томоохон аж ахуйн нэгжийн хувьчлал, зарим банкны дампуурал, эдийн засгийн хямрал, тэдгээрийн нийгэмд үзүүлэх сөрөг хүчин зүйлүүдээс үүдэн төлбөрийн чадваргүй аж ахуйн нэгжийг дахин хөрөнгөжүүлэх /reorganization/, арга замыг хуульчлах, мөн нийгэм эдийн засгийн бусад шаардлагаар дампуурлын харилцааг орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн УИХ-аас одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Дампуурлын тухай хуулийг 1997 онд шинэчлэн боловсруулж баталсан. А.Мөнхзул, Л.Энхбилэг, У.Мөнхбат нар, Дампуурлын эрх зүй гарын авлага, Худалдааны эрх зүйн чиглэлээр шүүгчдийг сургах төсөл, УБ, 2014, 22.

[31] Мөн тэнд.

[32] ШЕЗ-ийн ШСМСХ-ийн статистикийн 2015 оны тайлан.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХЭЛТЭС www.nli.gov.mn

Дээрхээс үзэхэд 2005-2015 оны хооронд Дампуурлын тухай хуулиар 132 хэрэг шүүхээр хянан шийдвэрлэгдсэн байна. Үүнээс хариуцагчийг татан буулгахаар шийдвэрлэсэн 102, хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэхээр шийдвэрлэсэн хэрэг ердөө 5 хэрэг байгаа нь хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэхээр шийдвэрлэсэн хэргийн тоо бага байгаа болохыг харуулж байна. Үүнээс үүдэн одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Дампуурлын тухай хуульд хариуцагчийг дахин херөнгөжүүлэх талаарх эрх зүйн зохицуулалтыг судалж, тулгамдаж байгаа асуудлыг илрүүлэхийн зэрэгцээ судлагдсан орнуудын туршлагыг дор авч үзье.

Монгол Улс дахь аж ахуйн нэгжийг дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг дараах асуудлын хүрээнд судалж харьцуулалт хийлээ.[33] Үүнд: 1/ Хууль тогтоомжийн зохицуулалтын хүрээ, зорилго зарчим; 2/ Хэрэг хянан шийдвэрлэх ерөнхий тогтолцоо; 3/ Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа; 4/ Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа; 5/ Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага; 6/ Шүүхийн бус арга хэрэгслээр дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа.

1. Хууль тогтоомжийн нэр томьёо, зорилго, зарчим

Солонгос Улсад төлбөрийн чадваргүй байдал түүнтэй холбогдох эрх зүйн харилцааг “Сэргээн босгох болон дампуурлын тухай хууль”-иар зохицуулдаг. Энэ хуулийн зорилтын дагуу ААН-ийг сэргээн босгох ажиллагаа нь шударга ёсны зарчмыг хөндөхөөс бусад тохиолдолд ААН-ийг татан буулгахгүйгээр түүний үйл ажиллагааг сэргээх чиглэлийг тэргүүлэх чиглэл болгон тууштай хэрэгжүүлж байна. Энэ үүднээс Солонгос Улсын төлбөрийн чадваргүй байдлыг зохицуулах зорилгоор батлагдсан хуулийг “Сэргээн босгох болон дампуурлын тухай хууль” хэмээн нэрлэдэг. Солонгос Улсын ААН-ийг дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагааг ‘debtor rehabilitation’ буюу ‘ААН-ийн үйл ажиллагааг сэргээн босгох’ хэмээн томьёолсон ба энэхүү утга нь санхүүгийн хүндрэлд орсон ААН-ийн үйл ажиллагааг татан буулгахгүйгээр сэргээн босгох, үйл ажиллагаа нь жигдэртэл дэмжлэг үзүүлэх байдлаар хэвийн үйл ажиллагаатай болгох гэсэн утга санааг илэрхийлдэг.

Энэ хуульд ‘сэргээн босгох’ буюу ‘rehabilitation’—ын хууль зүйн тодорхой тайлбарыг тусгаагүй байна. Харин энэ хуулийн сэргээн босгох төлөвлөгөө гэсэн 6-р бүлгийн 193 дугаар зүйлд “сэргээн босгох төлөвлөгөөнд бизнесийн тодорхой хэсэг, хөрөнгө зэргийг шилжүүлэх, үүсгэн байгуулах гэрээнд өөрчлөлт оруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, удирдлагыг солих, хөрөнгийг (capital) багасгах, шинэ хувьцаа, бонд гаргах, нэгдэх, хуваагдах” зэрэг асуудлыг зохицуулдаг. Мөн бусад арга хэмжээ буюу сэргээн босгох арга хэмжээг ямар ч төрлийн шинэлэг арга хэмжээгээр хийж болохоор тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл эдийн засаг, санхүү, өрийн зах зээлийн хөгжилтэй холбоотойгоор өргөн хэрэглэгддэг сэргээн босгох арга хэмжээнээс гадна шинэ төрлийн нэмэлт арга хэмжээг ч талууд харилцан тохиролцож, хэрэгжүүлэх боломж бүрдүүлсэн.

Солонгосын Сэргээн босгох болон дампуурлын тухай хуулийн 1-р бүлгийн 1-р зүйлд “Энэ хууль нь санхүүгийн хүндрэлийн улмаас татан буугдах магадлалтай үүрэг гүйцэтгэгчийг сэргээн босгох, түүний бизнесийн үйл ажиллагааг тухайн хэрэгт хамааралтай этгээдүүд болох үүрэг гүйцэтгүүлэгч, хувьцаа эзэмшигч зэрэг этгээдүүдийн хоорондын харилцааг зохицуулан холбож, үр дүнтэйгээр сэргээн босгох; үйл ажиллагаа нь сэргээн босгоход маш төвөгтэй эсхүл тэгш, шударгаар асуудлыг шийдвэрлэх боломжгүй тохиолдолд ААН-ийг татан буулгах зорилготой”

[33] 32 Хавсралт 1, 2-оос ХБНГУ болон БНСУ-ын дампуурал түүнтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг дэлгэрүүлэн үзнэ үү.

гэж хуулийн зорилгыг тодорхойлсон байна. Иймдээ ч /250 орчим хуудастай/ тус хуулийн дийлэнх хэсэг нь үүрэг гүйцэтгэгчийг сэргээн босгоход чиглэсэн харилцааг зохицуулсан. Түүнчлэн уг хуулийн 32-р зүйлд ялгаварлан гадуурхахыг хориглох зарчмыг хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах талаар тусгасан.

Сэргээн босгох ажиллагааны явцад хэнийг ч, ялангуяа үүрэг гүйцэтгүүлэгчийг зохих үндэслэлгүйгээр хохироох ёсгүй байна. Тиймээс тэднийг мэдээллээр хангах, бүхий л асуудалд санал бодлоо илэрхийлэх, эрхээ хамгаалах боломжийг олгох, тэдэнд ил тод, хариуцлагатай байдал бий болгох, тэдний эрх ашгийг хөндсөн этгээдийг хатуу шийтгэх зэрэг үүрэг гүйцэтгүүлэгчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг аливаа байдлаар хохироохоос урьдчилан сэргийлсэн, хамгаалсан зохицуулалтыг хуулийг хэрэгжүүлэх бүхий л үе шатанд тусгасан.

Герман улсын хувьд төлбөрийн чадваргүй байдал, түүнтэй холбогдох харилцааг “Төлбөрийн чадваргүй байдлыг зохицуулах тухай” /Insolvenzordnung/ хуулиар зохицуулдаг. Энэхүү хуулийн зохицуулах үндсэн асуудал бол аж ахуйн нэгж болон хувь этгээдийн төлбөрийн чадваргүй байдал түүнтэй холбогдох харилцааг зохицуулах бөгөөд энэхүү ойлголт нь хоёр үндсэн агуулгыг илэрхийлдэг байна. Нэг талаас аж ахуйн нэгжийг дахин хөрөнгөжүүлж, сэргээн босгох нөгөө талаас аж ахуйн нэгжийг татан буулгах юм. Энэ хуульд дахин хөрөнгөжүүлэх гэсэн нэр томьёог нарийвчлан тусгаагүй боловч хуулийн 1 дүгээр хэсэгт томъёолсон зорилгын хүрээнд хариуцагч буюу компани дампуурахаас сэргийлэх нөгөө талаар нэхэмжлэгч буюу үүрэг гүйцэтгүүлэгчийн авах ёстой мөнгөн төлбөрийн ногдол хувийг нэмэгдүүлэх гэсэн агуулгаар ойлгодог байна.

Монгол Улсын хувьд дампуурлын эрх зүйн нэгэн институт болох дахин хөрөнгөжүүлэх асуудлыг нарийвчлан тодорхойлоогүй. Өөрөөр хэлбэл Дампуурлын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтад “Энэ хуулийн зорилт нь дампуурлын хэрэг үүсгэх, хянан шийдвэрлэх, төлбөрийн чадваргүй аж ахуйн нэгжийг дахин хөрөнгөжүүлэх, татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэсэн боловч дахин хөрөнгөжүүлэх гэдэгт ямар үйл ажиллагаа хамаарахыг нарийвчлан тодорхойлоогүй. Хуулийн заалтаас харахад дараах харилцааг зохицуулахаар тусгасан болох нь харагдаж байна. Үүнд:

А/ Дампуурлын хэрэг үүсгэх, хянан шийдвэрлэх;

Б/ Төлбөрийн чадваргүй аж ахуйн нэгжийг дахин хөрөнгөжүүлэх;

В/ Төлбөрийн чадваргүй аж ахуйн нэгжийг татан буулгах.

1997 онд батлагдсан Дампуурлын тухай хуулиар дахин хөрөнгөжүүлэх асуудлыг уг хуулийн нэг зорилт болгон тусгасан боловч энэ хуульд хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх төрөл, хэлбэрийг нарийвчлан тусгаагүй. Үүнээс үүдэн дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа хийгдэх боломж аж ахуйн нэгжид хязгаарлагдмал байдаг нь шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийх явцад харагдсан. Дэлхийн улс орнуудын сүүлийн үеийн эрх зүйн чиг хандлагаас үзэхэд дахин хөрөнгөжүүлэх гэсэн ойлголт эдийн засаг, санхүү, өрийн зах зээлийн хөгжилтэй холбоотойгоор өөрчлөгдөж байна. Тухайлбал, санхүүгийн хүндрэлд орсон ААН-ийг татан буулгахгүйгээр үйл ажиллагааг нь сэргээх зорилгоор ААН-ийн өрийг бусдад худалдаалах, өөр аж ахуйн нэгжтэй нийлэх нэгдэх, зарим үр ашиггүй хэсгийг зарах зэрэг төрөл бүрийн аргаар хэрэгжих боломжтой болсон. Цаашлаад дахин хөрөнгөжүүлэхэд чиглэсэн арга хэлбэрүүд эдийн засаг, санхүү, өрийн зах зээлийн хөгжилтэй холбоотойгоор шинэ арга хэлбэр бий болох боломжтой юм. Иймд дэлхийн улс орнуудын туршлагыг судлах, дахин хөрөнгөжүүлэх арга хэлбэрүүдийг нарийвчлан тодорхойлж, талууд өөрсдийн үйл ажиллагаанд тохирсон арга хэрэгслээр дахин хөрөнгөжих боломжийг хууль тогтоомждоо тусгах шаардлагатай.

Судлагдсан гадаад орнуудад дахин хөрөнгөжүүлэх асуудлыг хууль тогтоомжийн нэг үндсэн зорилт болгон авч үздэг учраас энэ төрлийн харилцааг зохицуулах хуулийг “Дампуурлын тухай хууль” гэж нэрлэхээс илүүтэйгээр Төлбөрийн чадваргүй байдлыг зохицуулах тухай хууль эсхүл Сэргээн босгох болон дампуурлын тухай хууль гэх зэргээр нэрлэсэн байдаг. Монгол Улсын хувьд 1997 онд батлагдсан “Дампуурлын тухай хууль”-иар энэ төрлийн харилцааг зохицуулж байгаа бөгөөд цаашид энэ хуулийг өөрчлөх төслийг боловсруулахдаа энэ хуулийн нэршилд анхаарах шаардлагатай гэж үзэж байна. Иймд Герман, Солонгос Улсуудын төдийгүй олон улсын жишгийг харгалзан хуулийн нэршлийг шинэчлэх нь зүйтэй.

Дэд хэсгийн дүгнэлт, санал

Герман, Солонгос улсуудад санхүүгийн хүндрэлд орсон ААН-ийн үйл ажиллагааг сэргээн, хэвийн болгох бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засгийн хөгжлийг дэмжих төдийгүй нийтийн эрх ашгийг хамгаалах, хангахыг зорьсон. Иймд дахин хөрөнгөжүүлэх бодлогыг манай улсын Дампуурлын тухай хуульд тэргүүн зорилгоо болгон тусгах нь ААН-ийг аль болох татан буулгахгүйгээр дахин хөрөнгөжүүлэхэд нэхэмжлэгч, хариуцагч, шүүгч, хэрэг гүйцэтгэгч зэрэг нийт оролцогчдын ухамсар хандлагыг нэмэгдүүлэх төдийгүй эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байна. Ялангуяа энэхүү бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлснээр өнөөгийн эдийн засгийн хямралыг хохирол багатайгаар даван туулахад өндөр ач холбогдолтой юм.

Герман, Солонгос улсуудын холбогдох хуулиудад дахин хөрөнгөжүүлэх ажиллагааны хүрээнд үүрэг гүйцэтгүүлэгчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг аливаа байдлаар хохироохгүй байх гэсэн гол зарчмыг баримталдаг. Хуулийн энэхүү зарчимтай холбоотойгоор хуулийг хэрэгжүүлэх бүхий л үе шатанд үүрэг гүйцэтгүүлэгчийн эрх ашгийг хангах зохицуулалтыг хуульд тусгасан. Энэ механизм нь үүрэг гүйцэтгүүлэгч сэргээн босгох ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийг дэмжих, үүрэг гүйцэтгүүлэгчид бизнесээ хэвийн явуулах итгэл, эрмэлзэл бий болгодог учраас дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх гол нөхцөл болдог. Иймд манай улсын хуульд дахин хөрөнгөжүүлэх бодлогыг тэргүүлэх чиглэл болгохын зэрэгцээ үүрэг гүйцэтгүүлэгчдийн эрх ашгийг хангах зарчмыг хуулийг хэрэгжүүлэх бүхий л үе шатанд тусгах нь хуулийн үр дүнтэй хэрэгжилтийг хангахад чухал гэж үзэж байна. Үүнтэй уялдуулан дараах саналыг гаргаж байна. Үүнд:

2. Дампуурлын тухай хуулийн төслийг боловсруулахдаа энэ хуулийн нэршлийг анхаарч “Дампуурал ба дахин хөрөнгөжүүлэх тухай” гэсэн агуулгаар уг хуулийн нэрийг нэрлэх;

3. Дампуурлын тухай хуулийн төслийн зорилго, зарчим агуулгад анхаарч аж ахуйн нэгжийг дахин хөрөнгөжүүлэх боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үзэл баримтлалыг батлах;

4. Дампуурлын тухай хуулийн төсөлд дахин хөрөнгөжүүлэх арга, хэлбэрийг тусгах;

2. Хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо

Солонгос Улс нь сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэх хороог Дээд шүүхийн баталсан журмын дагуу дүүргийн шүүхийн дэргэд байгуулсан. Энэхүү хорооны гишүүд нь эдийн засагч, хуульч, санхүүгийн өндөр туршлагатай мэргэжилтэн байхаар заасан. Хороо болон нэхэмжлэгчдийн зөвлөлийн саналыг авснаар хэрэг гүйцэтгэгчийг шүүх томилдог ба хэрэг гүйцэтгэгч нь шүүх, хорооны хяналт, удирдлага дор сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлдэг мөн нэхэмжлэгчдийн зөвлөл хяналт тавьж ажилладаг. Үүнээс гадна нэхэмжлэгчдийн зөвлөл, хорооны санал шийдвэрээр сэргээн босгох ажиллагааг зохих ёсны дагуу хэрэгжүүлж

байгаа эсэхэд хяналт шалгалт хийх байцаагчийг мөн томилж болдог. Мэдээллээр хангах асуудлын тухайд зөвхөн нэхэмжлэгчдийн зөвлөлөөс гадна бүхий л үүрэг гүйцэтгүүлэгч нь хэрэгтэй холбоотой мэдээлэлтэй танилцах, тодорхой асуудалд гомдол, шүүмж гаргах эрхээр хангагдсан байдаг. Түүнчлэн тус улсын сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэх тогтолцоо нь мэдээллийн ил тод байдлыг бий болгох, нээлттэй үйл ажиллагааг хангах, талуудад харилцан хяналт тавих нөхцөлийг бүрдүүлж өгөх замаар талуудад төдийгүй олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, ил тод, шударга тогтолцоог бүрдүүлэхийг зорьсон байна.

Тогтолцооны хүрээнд баримтлах бодлогын талаар тус улсын судлаач, шүүгч Жаеван Парк "...дахин хөрөнгөжүүлэх институцийг хагас зуун жилийн турш хөгжүүлсэн, туршлагатай, мэргэжлийн чадвар, ёс зүйн соёл төлөвшсөн хөгжилтэй АНУ-тай харьцуулахад дахин хөрөнгөжүүлэх бодлогыг 1990-ээд оноос хойш хэрэгжүүлж буй улс учраас манай улсын бодлого нь нийгэм, эдийн засгийн онцлогт илүүтэй тохирсон байх магадлалтай" гэж дүгнэсэн байдаг. Улмаар АНУ-ын бие даасан тогтолцоогоор дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг хэрэгжүүлдэг тогтолцоотой харьцуулахад Солонгос Улсад илүү төрийн оролцоо, хяналттайгаар шүүхийн дэргэд хуулийг хэрэгжүүлэх хороог байгуулан сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлдгээрээ онцлог юм.

Өөрөөр хэлбэл төрийн оролцоо бүхий шүүхийн хяналттай дахин хөрөнгөжүүлэх бодлогыг хэрэгжүүлснээр ил тод, хариуцлагатай, шударга байдлыг бий болгохыг зорьсон. Тийм ч учраас шүүхийн чиг үүрэг нь талуудын саналыг харгалзан хэрэг гүйцэтгэгчийг томилох, төлөвлөгөөг батлах, үйл ажиллагаанд хяналт тавих, санал гомдлыг шийдвэрлэх, мэдээллээр хангах зэрэг аливаа үйл ажиллагааг болон асуудлыг ил тод, хариуцлагатай, тэгш явуулах, шийдвэрлэхэд чиглэгджээ. Нөгөө талаас Солонгос Улс нь дахин хөрөнгөжүүлэх институцийг 1990-ээд оноос хөгжүүлж буй улс учраас тус улсын шүүгчид нь эдийн засаг, санхүүгийн өндөр мэргэшил, туршлага шаардах дахин хөрөнгөжүүлэх тогтолцоог хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг туслалцаа авах шаардлагатай. Иймд шүүхийн дэргэд хуулийг хэрэгжүүлэх санхүү, эдийн засаг, мэргэшсэн хуульчдын бүрэлдэхүүнтэй хороог байгуулж нэг талаас шүүгчдийг мэргэжил арга зүйгээр хангах, нөгөө талаас дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

Герман улсын хувьд төлбөрийн чадваргүй байдал түүнтэй холбогдох харилцааг Дүүргийн анхан шатны шүүх / англиар "The lower court of the district", германаар "Amtsgerichts'/ хянан шийдвэрлэдэг. Хэрэв хариуцагчийн үйл ажиллагаа явуулж буй газар нь өөр дүүрэгт үйл ажиллагаа явуулж байвал тухайн газрын шүүх хэргийг хянан шийдвэрлэдэг. Хэрвээ хариуцагчийн хэрэг хянан шийдвэрлэх шүүх хоёр ба түүнээс дээш байвал анх хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэсэн шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлдэг.[34] Өнөөгийн байдлаар Герман улсад нийтдээ 191 шүүх төлбөрийн чадваргүй байдал түүнээс үүссэн маргааныг хянан шийдвэрлэж байна.[35] Эдгээр шүүхүүд нь түр хэрэг гүйцэтгэгч болон нэхэмжлэгчдийн түр хороог томилохоос эхлүүлээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд голлох үүрэгтэй оролцдог. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь үе шатын хувьд үндсэндээ шүүхийн хяналтан дор хэрэг гүйцэтгэгчийг томилох, төлбөрийн чадваргүй байдлыг тогтоох, улмаар ААН-ийн дампуурлыг зарлах эсхүл дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг батлах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгах зэрэг үе шатаар хийгддэг.

[34] Franz Aleth and Nils Derksen, Restructuring and Insolvency, 2015, p.170. http://www.freshfields.com/uploadedFiles/SiteWide/Campaigns/R_and_I/Content/Germany%202014.pdf

[35] Weil, Comparative guide to Restructuring Procedures 2012, p.72.

Хэрэг гүйцэтгэгчийн хувьд шүүхээс томилох бөгөөд Төлбөрийн чадваргүй байдлыг зохицуулах тухай хуульд зааснаар дампуурлын хэрэг эрхлэх ажилд бэлтгэгдсэн мэргэжилтнүүдээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тохирох, бизнесийн туршлагатай, хариуцагч болон нэхэмжлэгчээс хараат бус бие даасан хувь хүнийг шүүх дампуурлын хэрэг гүйцэтгэгчээр сонгож томилно. Эдгээр хэрэг гүйцэтгэгч нь хариуцагч эд хөрөнгийг захиран зарцуулахаас урьдчилан сэргийлэх, өмчийг хамгаалах мөн хариуцагчийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх, дампуурлын болон дахин херенгежүүлэх ажиллагааг удирдах зэрэг чиг үүргийг гүйцэтгэдэг.

Монгол Улсад дампуурлын харилцаа, түүнтэй холбогдох ажиллагааг үндсэндээ шүүхийн хяналт дор хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл Дампуурлын тухай хуулиар зохицуулагдсан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх, хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх, хариуцагчийг татан буулгах ажиллагаанууд шүүхийн хяналтан дор хэрэгждэг. Нөгөө талаар Дампуурлын тухай хуульд заасанчлан дампуурал ба дахин хөрөнгежүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахдаа шүүхийн дэргэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий тогтвортой бие даасан бүтэц ажилладаггүй.

Өөрөөр хэлбэл хуульд заасан түр хэрэг гүйцэтгэгч, хэрэг гүйцэтгэгчийн эрх зүйн орчин тодорхой бус байдалтай байна. Энэ талаар зарим ажлууд хийгдэж байсан боловч одоогоор зогсонги байдалтай байна. Тухайлбал, 1998 оны 9 дүгээр сард Дэлхийн банкны санхүүжилтээр Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамнаас “BELTAC” хөтөлбөрийн хүрээнд Олон улсын хуулийн институтээс Дампуурлын хуулийн талаар сургалт явуулсан. Энэхүү сургалтад шүүгч, өмгөөлөгч, банкны ажилтнууд, эдийн засагчид, хуулийн сургуулийн оюутнууд, төрийн холбогдох байгууллагын ажилтнуудаас бүрдсэн 50 гаруй хүмүүс хамрагдсан. Түүнчлэн Дэлхийн банкнаас “World bank IDF Grant No:027281” ба “Монгол Улсын дампуурлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах төсөл”-ийн дагуу Хэрэг гүйцэтгэгчдийн сургалт 1999 оны 10 дугаар сарын 25-наас 11 дүгээр сарын 08-ныг дуустал 3 долоо хоног үргэлжилсэн ба үүний дараа Хууль зүйн сайдын 2000 оны 5 дугаар сарын 16-ны 185 тоот тушаалаар дампуурлын хэрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг шалгалтад тэнцсэн 9 хүнд олгосон байдаг. Үүнээс улбаалан Монголын Дампуурлын хэрэг гүйцэтгэгчдийн үндэсний холбоог 1999 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр байгуулсан бөгөөд энэ үед 26 гишүүн нэгдэж байсан боловч одоогоор тус холбооны үйл ажиллагаа идэвхгүй байдалд байна. Мөн Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2002 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 74 тоот тушаалаар Дампуурлын тухай хуульд заасан шалгууруар хэрэг гүйцэтгэгчээр оролцох сонирхолтой, зохих шаардлагыг хангасан этгээд томилогдон ажиллаж байгаа боловч энэ төрлийн харилцааны зохицуулалт хангалтгүй байна.

Дэд хэсгийн дүгнэлт , санал

Герман улсын тухайд төлбөрийн чадваргүй байдлыг хянан шийдвэрлэх олон жилийн туршлагатай улс учраас тус улсын шүүгчид нь төлбөрийн чадваргүй байдлыг зохицуулах асуудлаар мэргэшсэн. Харин Солонгос Улсын тухайд дахин хөрөнгөжүүлэх асуудлаар мэргэшсэн хороог шүүхийн дэргэд байгуулах замаар дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг мэргэшсэн хороогоор хянуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангуулах асуудлыг шийдвэрлэсэн байна. Иймд манай улсын тухайд дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэхдээ энэ чиглэлийн хороог байгуулах талаар судалж үзэх шаардлагатай.

Мөн бидний судалсан Герман, Солонгос улсуудад манай улсад хэлж заншсанаар хэрэг гүйцэтгэгч болох ААН-ийг дахин хөрөнгөжүүлэх мэргэжилтэн нь

зах зээлийн эрэлт хэрэгцээгээ дагаад өндөр түвшинд мэргэшсэн байдаг. Үүнтэй холбоотойгоор хэрэг гүйцэтгэгчийг албан журмаар бүртгэх, сонгох зохицуулалт байдаггүй ба харин түүнд холбогдох хуулиудаар өндөр шалгуурыг тогтоон, цалин урамшууллыг шийдвэрлэсэн байдгийн зэрэгцээ өндөр хариуцлагыг ч оноодог байна. Иймд манай улс мөн адил дахин хөрөнгөжүүлэх бодлогыг тэргүүлэх чиглэл болгосноор хэрэг гүйцэтгэгчийн эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэн, өрсөлдөөнт орчинг бий болгох боломжтой. Үүний зэрэгцээ тэдний санхүүгийн баталгаа, болон тэдэнд тавигдах шаардлага, хариуцлагын тогтолцоог бодлогын түвшинд зохицуулах шаардлагатай гэж үзэж байна.

3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

Солонгос Улсын тухайд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дараах үе шатаар явагддаг. Тус хуулийн 1-р бүлэгт Сэргээн босгох ажиллагааг үүсгэх нэхэмжлэл гаргахдаа сайн дурын үндсэн дээр гаргах болон заавал биелүүлэх үүрэг байхаар хуульд тусгасан.

Сайн дурын үндсэн дээр сэргээн босгох нэхэмжлэл гаргах

Энэ хуулийн 34-р зүйлд үүрэг гүйцэтгэгч бизнесийн үйл ажиллагаандаа ямар нэгэн саад учруулахгүйгээр үүргийн гүйцэтгэлээ заасан хугацаанд нь төлж чадахгүй тохиолдолд, мөн төлбөрийн чадваргүй болно гэж үзэж байгаа бол сэргээн босгох ажиллагааг үүсгэх нэхэмжлэл гаргаж болдог. Хувьцаат компани, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн оруулсан хувьцааны хувиас нь хамааран шалгуур босго тогтоон нэхэмжлэл гаргах нээлттэй боломжийг үүрэг гүйцэтгэгч, үүрэг гүйцэтгүүлэгчид олгосон.[36] Мөн хувьцаа эзэмшигч болон үүрэг гүйцэтгүүлэгч нэхэмжлэл гаргаж байгаа тохиолдолд шүүх үүрэг гүйцэтгэгчийг шаардлагатай мэдээллээр хангах талаар захирамж гаргадаг.[37] Мөн заавал хуульд хатуу босго заан тогтоохгүйгээр сэргээн босгох үйл ажиллагааг талуудын ашиг сонирхлыг харгалзан үүсгэх боломжтой байна.

Дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг үүсгэх нэхэмжлэл гаргах үүрэг

Сэргээн босгох ажиллагааг үүсгэх нэхэмжлэл гаргах үүргийг 35-р зүйлд үүрэг гүйцэтгэгч, үүрэг гүйцэтгүүлэгч, татан буулгагч гаргахаар зохицуулсан.[38] Сэргээн босгох үйл ажиллагааг үүсгэх нэхэмжпэл гаргасан этгээд нь нэхэмжлэл гаргасан үндэслэлээ тайлбарлан, нотлох үүрэгтэй төдийгүй сэргээн босгохтой холбоотой гарах зардлыг хариуцах үүрэгтэй байна.[39] Гэсэн хэдий ч нэхэмжлэл гаргасан үүрэг гүйцэтгүүлэгч нь нийтийн ашиг сонирхлын нэхэмжлэл нэртэйгээр хариуцагчаас зардлыг гаргуулан авах боломжтой байдаг. Улмаар үүрэг гүйцэтгүүлэгчид сэргээн босгох нэхэмжлэл гаргахтай холбоотой аливаа хохирол учрахгүй байхаар зохицуулжээ.[40]

Өргөдлийг хүлээн аваад шүүх хариуцагчтай холбоотой мэдээллийг захиргааны байгууллага, татвар, санхүүгийн байгууллага зэрэг холбоо бүхий төрийн байгууллагуудад явуулан хариуцагчийн үйл ажиллагаа, түүнийг сэргээн босгохтой холбоотой саналыг авдаг.[41] Эдгээр байгууллагын хамтын ажиллагааны механизмыг хуулиар тодорхойлсон.[42]

[36] Мөн тэнд, зүйл 34

[37] Мөн тэнд

[38] Мөн тэнд, зүйл 34, 35

[39] Мөн тэнд, зүйл 38, 39

[40] Мөн тэнд, зүйл 39

[41] Мөн тэнд, зүйл 41

[42] Мөн тэнд, зүйл 41

Түүнчлэн хуулийн 6-р бүлэг нь сэргээн босгох төлөвлөгөө, 7-р бүлэг нь төлөвлөгөөг баталсны дараах зохион байгуулалт, 8-р бүлэг нь сэргээн босгох ажиллагааг зогсоохтой холбоотой асуудлыг тус тус зохицуулсан. Төлөвлөгөөний тухайд 4 хэсэг бүхий 63 зүйл заалттай материаллаг болон процессын зохицуулалттай. Бүлгийн 1-р хэсэг нь сэргээн босгох төлөвлөгөөний агуулга, 2-р хэсэг нь сэргээн босгох төлөвлөгөөний төслийг мэдүүлэх, 3-р хэсэг нь төлөвлөгөөг хэрэгжүүлэхийг шийдвэрлэх, 4-р хэсэг нь төлөвлөгөөг батлах гэсэн хэсгээс бүрддэг.

Төлөвлөгөөний агуулга

Төлөвлөгөөний агуулгыг 193-р зүйлд тусгасан. Үүнд: нэхэмжлэгчдийн эдлэх эрх, нийтийн ашиг сонирхлын нэхэмжлэлийг төлөх асуудал, нэхэмжлэлийг хангахад чиглэсэн хариуцагчийн хөрөнгө, мөнгө босгох арга хэлбэр зэргийг тодорхойлох юм. Мөн удирдлагыг солих, удирдлагыг сонгох болон томилох асуудалтай холбоотой журамд өөрчлөлт оруулах, ХК болон ХХК хөрөнгийг багасгах, шинээр хувьцаа гаргах, хувьцааг солилцох, бонд гаргах, нийлэх нэгдэх, хувьцаат компанийг салгах зэрэг сэргээн босгох арга хэмжээнүүдийг тодорхойлсон.[43] Дээрх сэргээн босгох арга хэмжээнүүд нь тус тусдаа тавигдах шаардлага, агуулга болон процессын нарийн зохицуулалттай.[44] Тухайлбал: хариуцагчийн удирдлагад өөрчлөлт оруулахад түүнийг сонгосон шалгуур, арга, сонгогдон ажиллах хугацаа; төдийгүй хууран мэхлэлт, компанийн удирдлагын буруутай үйл ажиллагааны улмаас ААН-д хүндрэл бий болсон бол тэрхүү удирдлагыг хэвээр үлдээж болдоггүй зэрэг нарийн шалгууруудыг тусгасан. Нэхэмжлэгчдийн зөвлөлийн саналыг сонссоны дараагаар шүүх аудитыг сонгон, удирдлагын ажиллах хугацааг тодорхойлдог зэрэг арга хэмжээ тус бүрийн тухайд нарийвчилсан шалгуур, агуулга болон процессын зохицуулалт оруулсан.[45]

Төлөвлөгөөг хэрэгжүүлэн нэхэмжлэгчдийн шаардлагыг хангах хугацааны тухайд барьцаат нэхэмжлэгчдийн шаардлагыг барьцааны хөрөнгийн хугацаагаар харин бусад нэхэмжлэлийн тухайд 10 жилээс ихгүй байхаар харьцангуй уян хатан байдлаар хуульд заасан.[46] Нөгөө талаас нэхэмжлэгчдийн эдлэх эрхтэй холбоотой бүхий л өөрчлөлтийг төлөвлөгөөнд нарийвчлан тусгах ёстой ба энэ нь тэдний эрх ашиг хөндөгдөх нөхцөлийг ойлгомжтой ил тод байдлаар мэдэгдсэнээр тэдэнд санал бодлоо илэрхийлэх, давж заалдах боломжийг олгосон.[47]

Төлөвлөгөөнд тусгагдсан зарчим, шалгуур нь тухайн сэргээн босгох төлөвлөгөө тэгш, шударга, хэрэгжихүйц байх шаардлагатай.[48] Нэхэмжлэгчдийн шаардлагыг хангах дарааллыг хуульд заасан ба төлөвлөгөө нь шаардлагыг хангах эрэмбэ, дарааллын дагуу бүхий л нэхэмжпэлийг тэгш, шударгаар хангахаар боловсруулагдсан байх ёстой байдаг.[49]

- Төлөвлөгөөг боловсруулах, мэдүүлэх

Шүүх тухайн ААН-ийн үйл ажиллагааг сэргээн босгосон нь татан буулгаснаас илүү үр ашигтай (value) гэж үзвэл хэрэг гүйцэтгэгчид сэргээн босгох төлөвлөгөөний

[43] Мөн тэнд, зүйл 193
[44] Мөн тэнд, зүйл 202-216
[45] Мөн тэнд, зүйл 203
[46] Мөн тэнд, зүйл 195
[47] Мөн тэнд, зүйл 194
[48] Мөн тэнд, зүйл 217, 218
[49] Мөн тэнд, зүйл 217

төслийг нэн даруй боловсруулан танилцуулах талаар захирамж гаргадаг.[50] Хугацааны тухайд төлөвлөгөөг ААН- ийн хувьд хамгийн ихдээ 4 сарын дотор үүнийг 2 сар хүртэл хугацаагаар сунгах боломжтойгоор, хувь хүн, ЖДҮ-ийн хувьд хамгийн ихдээ 2 сар, үүнийг 1 сар хүртэл хугацаагаар сунгах боломжтойгоор мэдүүлэх ёстой байдаг.[51]

Төлөвлөгөөг дэмжих, батлах

Төлөвлөгөөг батлахад хэрэгт хамаарал бүхий этгээд болох байцаагч, хэрэг гүйцэтгэгч, нэхэмжлэгчид, хариуцагч болон бусад төрийн байгууллага саналын эрхтэй байдаг.[61] Түүнчлэн саналын зөрүүтэй төлөвлөгөөг хэрхэн батлах, баталсантай холбоотой шийдвэрийг давж заалдах, төлөвлөгөөг баталсантай холбоотой нэхэмжлэгчдийн шаардлагаас хариуцагчийг чөлөөлөх, нэхэмжлэгчдийн эрх нь өөрчлөгдсөн бол төлөвлөгөөнд түүнийг тусгах, хариуцагчийн эсрэг нэхэмжлэгдсэн аливаа шаардлагын биелэлт, эд хөрөнгө хурааж авах шийдвэр гүйцэтгэл зэрэг түр хойшлуулсан шаардлагуудыг хүчингүй болгох зэрэг олон асуудлыг төлөвлөгөөг батлах хүрээнд тусгадаг.[52] Ингэхдээ эрх ашиг нь бүрэн хангагдаагүй гэж үзсэн төлөвлөгөөг дэмжихээс татгалзсан үүрэг гүйцэтгүүлэгчдийн эрхийг хангах талаар нэмэлт зохицуулалтыг шүүх төлөвлөгөөнд тусган батлах эрхтэй байдаг.[53] Өөрөөр хэлбэл төлөвлөгөөг батлахтай холбоотой үүсэж болох бүхий л асуудлыг зохицуулснаар төлөвлөгөөний цаашдын хэрэгжилтийг ойлгомжтой, үр дүнтэй болгохыг зорьжээ.

Төлөвлөгөөг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлэхдээ шаардлагыг хангах эрэмбэ дарааллын дагуу шүүхээс нэхэмжлэгчдийг бүлэг болгон /баталгаат нэхэмжлэгчид, ерөнхий давуу эрх бүхий нэхэмжлэгчид зэргээр/ хуваадаг ба ингэхдээ хэрэг гүйцэтгэгч, хариуцагч, үүрэг гүйцэтгүүлэгчдийн саналыг сонсдог.[54] Төлөвлөгөөг батлах эрх бүхий бүлгийн санал өгөх эрхийг (voting rights) нарийвчлан тодорхойлох замаар санал хураан төлөвлөгөөг дэмждэг.[55] Тодруулбал ААН-ийн баталгаат бус зээлийн 2/3 -ыг эзлэх нэхэмжлэгчид, баталгаат зээлийн %-ийг олгосон нэхэмжлэгчид /тухайн ААН-ийн зээл нь нийт хөрөнгөөс давсан тохиолдолд дийлэнх хувьцаа эзэмшигчид/ төлөвлөгөөг дэмжих ёстой байдаг ба үүний дараагаар дэмжигдсэн төлөвлөгөөг шүүх баталдаг.[56]

Үүгээр шүүх өргөдөл гаргасан нийт үүрэг гүйцэтгүүлэгчид, нэхэмжлэгч, хэрэг гүйцэтгэгч, хэрэгт хамаарал бүхий төрийн байгууллагуудад урьдчилан мэдэгдэж, саналыг сонсож, шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөний төсөлд засвар, нэмэлт өөрчлөлт оруулахыг даалгах мөн төлөвлөгөөг хянахтай холбогдуулан нэхэмжлэгчдийн хурлыг зарлан хуралдуулж баталдаг.[57] Үндсэндээ хамаарал бүхий олон талыг тэгш оролцуулах, тэдний саналыг тэнцвэртэйгээр тусгах уян хатан процессыг бий болгосон байна.[58]

Хугацааны тухайд хамаарал бүхий этгээдүүдийн анхны хуралдаанаас хойш 2 сарын дотор төлөвлөгөөг батлах ёстой байдаг ба харин сэргээн босгох ажиллагааг эхлүүлснээс хойш 1 жилийн дотор, үүнийг шүүхээс 6 хүртэл сараар сунгах

[50] Мөн гэнд, зүйл 220, Jaewan Park, Global Insolvency Law database, World Bank, 2003.

[51] Мөн тэнд, зүйл 220

[52] Мөн тэнд, зүйл 242-256

[53] Insolvency and Corporate Reorganization Report: South Korea, IFLR, 2016.

[54] Мөн тэнд, зүйл 236

[55] Мөн тэнд, зүйл 237

[56] Insolvency and Corporate Reorganization Report: South Korea, IFLR, 2016.

[57] Мөн тэнд, зүйл 237

[58] Мөн тэнд, зүйл 224-234

боломжтой ба энэ хугацаанд төлөвлөгөөг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлэж дуусгах ёстой байна.[59]

Төлөвлөгөөг Хэрэгжүүлэх

Төлөвлөгөөг шүүхээс баталснаар хэрэг гүйцэтгэгч нь шүүхийн хяналт, удирдлага дор төлөвлөгөөг тэр даруй хэрэгжүүлж эхэлдэг.[60]

Хороо нь хэрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагааг хянах үүднээс жил бүр төлөвлөгөөний биелэлтийг үнэлэн, тайланг харьяалах шүүхэд мэдүүлдэг.[61] Түүнчлэн хороо нь төлөвлөгөөг биелүүлснээр төлөвлөгөөг дуусгавар болгохтой холбоотой саналаа шүүхэд мэдүүлж болдог.[62] Тухайлбал төлөвлөгөөг зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд саналын зөрүүтэй нэхэмжлэгчийн шаардлагыг хангах, төлөвлөгөөг хэрэгжүүлэхийг зогсоох, төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах, нэхэмжлэгчдийн зөвлөлийн гаргасан хүсэлтийн дагуу хяналт шалгалт явуулах зэрэг бусад шийдвэрийг шүүх гаргах эрхтэй байдаг.[63]

Төлөвлөгөөг дуусгавар болгох

Хуулийн 8-р дэд бүлэг нь ямар нөхцөлд, ямар процессын дагуу төлөвлөгөөг хэрэгжүүлэхийг дуусгавар болгох асуудлыг зохицуулснаар талуудад ил тод ойлгомжтой байдлыг бий болгосон төдийгүй тэдний эрх ашгийг хангаж хамгаалсан.

Герман улсын тухайд төлбөрийн чадваргүй байдлын хэрэг үүсгэх үндэслэлийг тус хуулийн 13 дугаар зүйлд тусгасан байдаг. Тухайлбал энэ хуулийн 13.1-д зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхийн тулд хариуцагч өөрөө болон нэхэмжлэгч шүүхэд бичгээр хүсэлт гаргана. Хариуцагч нэхэмжлэлдээ нэхэмжлэгчид болон тэдний нэхэмжлэлүүдийн жагсаалтыг хавсаргана. Хэрэв хариуцагчийн үйл ажиллагаа зогсоогүй байгаа бол жагсаалтад их үнийн дүн бүхий нэхэмжлэл, их үнийн дүн бүхий барьцаат нэхэмжпэл, болон төсвийн захиргааны нэхэмжлэл, нийгмийн даатгалын газрын нэхэмжлэл, ажилчдын тэтгэмжийг нийлүүлсэн нэхэмжлэлүүдийг дурдана.[64] Үүнээс гадна Холбооны Хууль зүйн яам хууль тогтоомжийн хүрээнд Бундестагийн зөвшөөрснөөр хариуцагчаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэх хүсэлт гаргах хэлбэрүүдийг батлах эрхтэй бөгөөд хариуцагч заавал уг хэлбэрийг ашиглахаар заажээ. Мөн тус хуулийн 14 дүгээр зүйлийн дагуу нэхэмжлэгчээс гаргах хүсэлт нь төлбөрийн чадваргүй байдлын талаар хэргийг шүүхээс үүсгэх үндэслэл, нэхэмжлэлээ нотлох, төлбөрийн чадваргүй байдлын талаар хэрэг үүсгэх хууль ёсны эрх бүхий этгээдээс гарна.[65]

Тус хуульд тусгаснаар шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэх 3 үндсэн урьдчилсан нөхцөлийг тусгасан. Энэ нь а/ Төлбөрийн чадваргүй байдал; б/ Төлбөрийн чадваргүй байдал үүсэх нь гарцаагүй байх; в/ Их хэмжээний өртэй байх гэсэн шалгуур үзүүлэлтүүд хамаарна.[66]

Төлбөрийн чадваргүй байдлыг зохицуулах тухай хуульд заасанчлан хариуцагчийн болон нэхэмжлэгчдийн эрх ашгийг 1/ хариуцагчийн хөрөнгийг

[59] Мөн тэнд, зүйл 239

[60] Мөн тэнд, зүйл 257

[61] Мөн тэнд, зүйл 257

[62] Мөн тэнд, зүйл 257

[63] Мөн тэнд, зүйл 258, 259

[64] Insolvency statute, section 13, http://www.gesetze-im-internet.cle/englischJnso/englischJnso.pdf.

[65] Мөн тэнд, 14 дүгээр зүйл.

[66] Мөн тэнд, 17, 18, 19 дүгээр зүйл.

худалдан борлуулах, олсон орлогоос нэхэмжлэгчийн хохирлыг барагдуулах; *2/* хариуцагч бизнесийн үйл ажиллагаагаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд үргэлжлүүлэх; 3/ хариуцагч өөрөө дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удирдан зохион байгуулж, дампуурлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зэрэг арга замаар хангадаг.[67]

Төлбөрийн чадваргүй байдал, түүнтэй холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь үндсэн 2 үе шатаар хэрэгждэг. Үүнд:

Урьдчилсан ажиллагаа;

Нээлттэй ажиллагаа.

Эдгээр үе шатууд нь шүүхийн хяналт дор хийгдэх бөгөөд тухайн ААН санхүүгийн хүндрэлд орсон эсхүл төлбөрийн чадваргүй байдалд орж болзошгүй шинж илэрсэн тохиолдолд компанийн удирдлагууд /зарим тохиолдолд хувьцаа эзэмшигчид байж болно/ эрүүгийн хариуцлагад татагдахаас сэргийлж шүүхэд мэдэгдсэнээр эхэлдэг. Түүнчлэн компанийн төлбөрийн чадваргүй байдлыг компанийн удирдлагуудаас гадна нэхэмжлэгч буюу үүрэг гүйцэтгүүлэгч бас шүүхэд мэдэгдэж болдог. Үүний дараа шүүхээс нэхэмжлэгчдийн түр хороо болон дампуурлын түр хэрэг гүйцэтгэгчийг томилж хариуцагчийн хөрөнгийг хамгаалалтад авах, шүүхийн дараа дараачийн ажиллагаанд бэлтгэх болон шүүхийн нээлттэй ажиллагааг эхлүүлэхэд бэлтгэх үүргийг хүлээдэг.[68]

Урьдчилсан ажиллагаа

Урьдчилсан ажиллагаа гэдэгт шүүхээс 2 үндсэн асуудлыг хамааруулан авч үздэг байна. Энэ нь 1/ төлбөрийн чадваргүйд тооцох нөхцөл хангагдсан эсэх; *2/* хариуцагчийн эд хөрөнгө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэхэд хүрэлцэхүйц байж чадах эсэхийг хянаж үздэг. Хэрэв хариуцагчийн эд хөрөнгө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэхэд хүрэлцэхгүй /шүүхийн зардал, хэрэг гүйцэтгэгч болон нэхэмжлэгчдийн хурлын гишүүд зэрэг/ байдал тогтоогдвол шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэдэггүй байна. Энэ үе шатанд шүүхээс түр хэрэг гүйцэтгэгчийг томилох замаар хариуцагчийн эд хөрөнгийг хамгаалалтад авч нэхэмжлэгч болон хариуцагчийн эд хөрөнгийг захиран зарцуулах эрх хэмжээг хязгаарладаг байна.[69]

Нээлттэй ажиллагаа

Нээлттэй ажиллагаа явуулахын тулд Төлбөрийн чадваргүй байдлыг зохицуулах тухай хуулийн 17, 18, 19 дүгээр зүйлд заасны дагуу дараах шалгууруудын аль нэг нь хангагдсан бол нэхэмжлэл, хүсэлт гаргана. Тухайлбал, 1/ төлбөрийн чадваргүй байдал *2/* төлбөрийн чадваргүй болох нь зайлшгүй 3/ их хэмжээний өр зээлтэй байх зэрэг болно. Эдгээр тохиолдолд шүүх хариуцагчийн эд хөрөнгийг битүүмжлэх, хамгаалах арга хэмжээг заавал авах шаардлагатай.

Түр хэрэг гүйцэтгэгч болон нэхэмжлэгчдийн түр хороог байгуулах Төлбөрийн чадваргүй байдлыг зохицуулах тухай хуулийн 21 дугаар зүйлийн 2-т зааснаар шүүх талуудын гаргасан хүсэлтэд үндэслэн түр хэрэг гүйцэтгэгчийг томилох болон нэхэмжлэгчдийн түр хороог байгуулах шийдвэрийг гаргадаг. Түр хэрэг гүйцэтгэгч гэдэгт хариуцагчийн эд хөрөнгийг захиран зарцуулахаас урьдчилан сэргийлэх,

---

[67] Stephen Halladay, Peter Jark, Summary of German Insolvency law, 2012, p.8. https://www.dlapiper.eom/~/media/Files/Insights/Publications/2012/05/Summary%20of%20the%20German%20Insolvency%20Law%20Booklet/Files/2_Edition_German_Insolvency__Booklet_May%202012/FileAttachme nt/2_Edition_GermanJnsolvency_Booklet_May%202012.PDF.

[68] Mayor Brown, Germany Insolvency Law-overview, 2016, p.2.

[69] Weil, Comparative guide to Restructuring Procedures 2012, p.76.

хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа явуулсан бол томоохон аж ахуйн нэгжийн хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгчдийн түр хороог томилдог.

Төлбөрийн чадваргүй байдлыг зохицуулах тухай хуулийн 22 дугаар зүйлд зааснаар түр хэрэг гүйцэтгэгч дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

Хариуцагчийн өмчийг хамгаалах болон битүүмжлэхэд анхаарах;

Шүүх хариуцагчийн өмчид их хэмжээний хохирол бий болохоос сэргийлэхийн тулд тухайн ААН-ийн үйл ажиллагааг зогсоогоогүй, шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэх шийдвэр гаргах хүртэл хариуцагчаас удирдаж байгаа аж ахуйн үйл ажиллагааг үргэлжлүүлэх;

Хариуцагчийн өмч хөрөнгө дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг бүрэн төлөх чадвартай эсэхийг шалгах, үүнээс гадна шүүхээс дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх үндэслэлийг нотлох эсэх судалгаа явуулахыг шаардах мөн хариуцагч үйл ажиллагаагаа үргэлжлүүлбэл ямар байдал бий болохыг судлах.

Шүүх дампуурлын түр хэрэг гүйцэтгэгчийг хариуцагчийн гаргаж байгаа шийдвэрүүдэд ерөнхий хязгаарлалт хийх эрхгүйгээр томилж болно. Түр хэрэг гүйцэтгэгч хариуцагчийн бизнесийн үйл ажиллагаанд оролцох, түүнд хяналт, шалгалт явуулах эрхтэй. Хариуцагч дампуурлын түр хэрэг гүйцэтгэгчийг өөрийн нягтлан бодох бүртгэлийн данс болон бизнесийн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийх боломжоор хангана. Мөн хариуцагч хэрэг гүйцэтгэгчийн үүргээ биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх болон шаардлагатай аливаа мэдээллээр хангана. Түр хэрэг гүйцэтгэгчийн цалин хөлсийг хуулийн 26 а дугаар заалтад тусгаснаар дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үүсээгүй үед, дампуурлын шүүх төлөгдөх цалин хөлсийг тогтоосон шийдвэр гаргах бөгөөд зардлыг хариуцагч нөхөн төлнө. Шийдвэр нь түр хэрэг гүйцэтгэгч болон хариуцагч нарт тус бүрчлэн үйлчилнэ.

Түүнчлэн хэрэг гүйцэтгэгч эсхүл нэхэмжлэгчдийн түр хороо аль нь ч хариуцагч бизнесийн үйл ажиллагаагаа цаашид үргэлжлүүлэхэд хяналт тавин, хариуцагчийн санхүүгийн байдал, төлбөрийн чадваргүй байдлын шалгууруудын аль нэг нь бүрдэж буй эсэхийг баталгаажуулан, хариуцагчийн эд хөрөнгө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх зардлыг хангаж чадах эсэх талаар мэдээллийг шүүхэд гарган өгч байдаг. Шүүх эдгээр тайлан мэдээллийг шалган үзэж, нээлттэй ажиллагаа явуулах эсэх талаар шийдвэр гаргана. “Эд хөрөнгийн дутагдлаас нээлттэй ажиллагаа явуулахгүй байх” тохиолдолд дампуурч буй компанийг татан буулгана.[70]

Жинхэнэ хэрэг гүйцэтгэгчийг томилох /fully fledget/

Төлбөрийн чадваргүй байдлыг зохицуулах тухай хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу дампуурлын хэрэг эрхлэх ажилд бэлтгэгдсэн этгээдүүдийн дундаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тохирох, бизнесийн ажил хэргийн туршлагатай, хариуцагч болон нэхэмжлэгчээс хараат бус бие даасан хувь хүнийг дампуурлын хэрэг гүйцэтгэгчээр шүүх сонгож томилно.[71] Жинхэнэ хэрэг гүйцэтгэгчийн чиг үүрэг нь өмч хөрөнгийг захиран зарцуулж, нэхэмжлэгчдийн төлбөрийг төлөх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Түүнчлэн шүүхээс нэхэмжлэгчдийн анхны хурлын товыг зарлана. Ийнхүү нээлттэй ажиллагаа эхэлмэгц хэрэг гүйцэтгэгч нэхэмжлэгчдийн өргөдөл гомдлыг хэргийн хуваарьт бүртгэн авна. Тайлангийн буюу анхны хурлын

[70] Stephen Halladay, Peter Jark, Summary of German Insolvency law, 2012, p.8. https://www.dlapiper.eom/~/media/Files/Insights/Publications/2012/05/Summary%20of%20the%20German%20Insolvency%20Law%20Booklet/Files/2_Edition_German_Insolvency_Booklet_May%202012/FileAttachme nt/2_Edition_German_Insolvency_Booklet_May%202012.PDF.

[71] http://www.gesetze-im-intemet.de/englischJnso/englisch_inso.pdf

дараа баталгаажуулах хурлыг зохион байгуулж, энэ хурлаар нэхэмжлэгчдээс гаргасан нэхэмжлэлийг үнийн дүнгийн дагуу гаргасан жагсаалтыг баталгаажуулна. Нэхэмжлэгчдийн гаргасан нэхэмжлэлд хэрэг гүйцэтгэгч болон нэхэмжлэгчдийн аль аль нь маргаан үүсгэж болно.[72]

Хэрэг гүйцэтгэгч өөрийн томилгооны баримт бичгийг томилогдсоноор хүлээн авах бөгөөд түүний албан тушаал дуусгавар болоход уг баримт бичгийг дампуурлын шүүхэд буцаан өгөхөөр тусгасан.[73] Хэрэг гүйцэтгэгч нь Төлбөрийн чадваргүй байдлыг зохицуулах тухай хуулийн 262 дугаар зүйлд зааснаар нэхэмжлэлийг шалгах явцдаа хангагдахгүй эсвэл хангагдах боломжгүй гэдгийг тогтоовол энэ талаар нэхэмжлэгчдийн хороо болон шүүхэд даруй мэдэгдэнэ. Хэрэв нэхэмжлэгчдийн хороо томилогдоогүй бол хариуцагч эсвэл дампуурлын төлөвлөгөөний хэрэгжилтийн хэсгийн дагуу нэгтгэн нийлүүлсэн компанийн эсрэг нэхэмжлэл гаргасан бүх нэхэмжлэгчид мэдэгдэх үүргийг хүлээдэг.[74]

Хэрэв нэхэмжлэлд маргаан үүссэн тохиолдолд тухайн нэхэмжлэлийг гаргасан нэхэмжлэгч нэхэмжлэлээ батлах шаардлагатай. Баталгаажуулах хурал зохион байгуулагдах хүртэл барьцаагүй нэхэмжлэгчид ямар нэгэн төлбөр төлөгдөхгүй. Барьцаат зээл зэрэг урьдчилсан өр төлбөрийг төлж дууссаны дараа “доогуур” жагсаасан төлбөр буюу жишээлбэл, хувьцаа эзэмшигчдийн зээл гэх мэт төлбөрийг төлж барагдуулах ба эцсийн төлбөрийг хариуцагчийн бүх хөрөнгийг худалдаж олсон орлогоос төлдөг. Эцсийн төлбөрийг төлөхдөө хэрэг гүйцэтгэгч заавал шүүхээс зөвшөөрөл авна. Хариуцагчийн бүх хөрөнгийг барагдуулж дууссанаар шүүх тухайн дампуурлын ажиллагааг дууссаныг зарлана.[75] Хэрэв хэрэг гүйцэтгэгч болон хариуцагч этгээд ААН-ийг дампууруулах шаардлагагүй гэж үзэн дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө санал болговол нэхэмжлэгчдийн олонхын хурлаар хэлэлцүүлж, санал нэгдвэл шүүхээр дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг баталдаг.[76]

Үүнээс үзэхэд судлагдсан орнуудад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа өөр өөрийн орны онцлогт тохирсон байдлаар хэрэгждэг болох нь харагдаж байна. Тухайлбал, Солонгос Улсын тухайд үр дүнтэй сэргээн босгох ажиллагааг хангах зорилгын хүрээнд төрөөс сэргээн босгох талаар хүсэлт, нэхэмжлэлийг шийдвэрлэх үед болон нэхэмжлэлийг шийдвэрлэсний дараа ААН-ийн эсрэг гаргасан олон төрлийн нэхэмжлэлийг түр зогсоох, гүйцэтгэлийг хойшлуулах захирамжийг шүүхээс гаргаж болдог. Энэ хүрээнд төрөөс татварын нэхэмжлэлийг хойшлуулахад чиглэсэн ээлтэй бодлого хэрэгжүүлдэг байна. Улмаар ААН-д сэргээн босгох ажиллагаанд анхаарлаа хандуулах бололцоог олгодог. Түүнчлэн сэргээн босгох ажиллагааг хариуцаж байгаа шүүх ААН-ийн эсрэг гаргасан олон төрлийн нэхэмжлэлүүдийг нэгдсэн байдлаар шийдвэрлэдэг. Мөн сэргээн босгох ажиллагааг шийдвэрлэж буй шүүх нь ААН-ийг сэргээн босгохтой холбоотой хамаарал бүхий төрийн байгууллагуудын санал, шүүмжийг нэгдсэн байдлаар авч сэргээн босгох ажиллагааг үүсгэх эсэхийг шийдвэрлэдэг.

---

[72] Мөн тэнд.

[73] Мөн тэнд, 56 дугаар зүйл.

[74] Мөн тэнд, 262 дугаар зүйл

[75] Мөн тэнд, 9.

[76] https://www.dlapiper.com/~/media/Files/Insights/Publications/2012/05/Summary%20of%20the%20German %20Insolvency%20Law%20Booklet/Files/2_Edition_German_Insolvency_Booklet_May%202012/FileAttachm ent/2_Edition_German_Insolvency_Booklet_May%202012.PDF p. 19.

Ингэснээр ААН-д аливаа хүндрэл учруулахгүйгээр сэргээн босгох ажиллагааг шийдвэрлэж буй шүүх нь ААН-ийн асуудлыг нэгдсэн байдлаар шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн. Солонгос Улсын холбогдох хуулийн сэргээн босгох ажиллагааны хүрээнд баримталдаг давж заалдах бодлого нь зөвхөн тодорхой тохиолдолд тодорхой эрх ашиг нь хөндөгдөж буй этгээдэд давж заалдах эрхийг олгосноор сэргээн босгох ажиллагааг саадгүй, тууштай гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлсэн байдгийг онцлон дурдах нь зүйтэй юм.

Герман улсын тухайд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэхдээ 3 үндсэн арга хэрэгслээр зохицуулдаг. Үүнд: Төлбөрийн чадваргүй байдлыг зохицуулах тухай хуульд заасанчлан хариуцагчийн болон нэхэмжлэгчдийн эрх ашгийг 1/ хариуцагчийн хөрөнгийг худалдан борлуулах, олсон орлогоос нэхэмжлэгчийн хохирлыг барагдуулах; 2/ хариуцагчийн бизнесийн үйл ажиллагааг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд үргэлжлүүлэх; 3/ хариуцагч өөрөө дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удирдан зохион байгуулж, дампуурлын телөвлөгөөг хэрэгжүүлэх зэрэг арга замаар хангадаг. Эдгээр арга хэрэгслийг хэрэгжүүлэхдээ шүүхээс төлбөрийн чадваргүй болсон хариуцагчийг аль болох дахин хөрөнгөжүүлэхэд анхаарсан байна.

Түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хэрэгжих үе шатын хувьд урьдчилсан ба нээлттэй ажиллагаа гэсэн үе шатын хүрээнд хийгддэг. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны урьдчилсан үе шат гэдэгт шүүхээс 2 үндсэн асуудлыг хамааруулан авч үздэг байна. Энэ нь 1/ төлбөрийн чадваргүйд тооцох нөхцөл хангагдсан эсэх; 2/ хариуцагчийн эд хөрөнгө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэхэд хүрэлцэхүйц байж чадах эсэхийг хянаж үздэг. Хэрэв хариуцагчийн эд хөрөнгө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэхэд хүрэлцэхгүй /шүүхийн зардал, хэрэг гүйцэтгэгч болон нэхэмжлэгчдийн хурлын гишүүд зэрэг/ байдал тогтоогдвол шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэдэггүй байна. Энэ үе шатанд шүүхээс түр хэрэг гүйцэтгэгчийг томилох замаар хариуцагчийн эд хөрөнгийг хамгаалалтад авч нэхэмжлэгч болон хариуцагчийн эд хөрөнгийг захиран зарцуулах эрх хэмжээг хязгаарладаг байна.

Харин нээлттэй ажиллагаа гэдэгт Төлбөрийн чадваргүй байдлыг зохицуулах тухай хуулийн 17, 18, 19 дүгээр зүйлд заасны дагуу дараах шалгууруудын аль нэг нь хангагдсаны үндсэн дээр нэхэмжлэл, хүсэлт гаргана. Тухайлбал, 1/ төлбөрийн чадваргүй байдал 2/ төлбөрийн чадваргүй болох нь зайлшгүй 3/ их хэмжээний өр зээлтэй байх зэрэг болно. Эдгээр нөхцөл хангагдсаны дараа шүүхээс жинхэнэ хэрэг гүйцэтгэгчийг томилсноор хариуцагчийн эрх зүйн байдалд дүн шинжилгээ хийж хариуцагчийн дампуурлыг зарлах эсхүл дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг шүүхийн хяналт дор хийдэг.

Монгол Улсын хувьд Дампуурлын тухай хуулийн 23-32 дугаар зүйлүүдэд тусгаснаар дахин хөрөнгөжүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг дараах үе шатаар хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд:

Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргах

Дампуурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар:

Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлж, үйл ажиллагааг нь цаашид үргэлжлүүлэх нь татан буулгаснаас нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн шаардлагыг илүү хэмжээгээр хангах боломжтой гэж үзвэл холбогдох этгээд хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх тухай хүсэлтийг түүнийг төлбөрийн чадваргүйд тооцсон өдрөөс хойш 60 хоногийн дотор шүүхэд гаргаж болно. Дахин хөрөнгөжүүлэх хүсэлтийг дараах этгээдүүдийн аль нэг нь гаргана. Үүнд:

хариуцагч өөрөө;

хариуцагчаас нэхэмжилсэн нийт төлбөрийн гуравны нэг буюу түүнээс дээш хувийг нэхэмжилж байгаа нэхэмжлэгчид;

Хэрэг гүйцэтгэгч.

Дээрх хуулийн заалтаас харвал дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргах гол үндэслэл нь нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн шаардлагыг илүү хэмжээгээр хангах явдал байна. Өөрөөр хэлбэл нэхэмжлэгчдийг аль болох бага хэмжээний хохирол амсуулах, тэдний хохирол, нэхэмжлэлийг барагдуулах боломжийг бүрдүүлэх нөхцөлийг бий болгох нь дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө гаргах гол үндэслэл болж байна.

Дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө

Дампуурлын тухай хуульд зааснаар нэхэмжлэгчийн нэхэмжпэлийг барагдуулахын тулд дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг гаргадаг. Төлөвлөгөөг хариуцагч, нэхэмжлэгч, хэрэг гүйцэтгэгч нар хэрэг гүйцэтгэгчийн дүгнэлттэй танилцсан өдрөөс хойш 30 хоногийн дотор шүүхэд гаргаж өгнө. /Дампуурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалт/

Дахин хөрөнгөжүүлэх шийдвэр гаргахдаа дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг нэхэмжлэгчдийн хурлаар хэлэлцүүлж, санал хураана. Төлөвлөгөөг батлах санал хураалтад зөвхөн нэхэмжлэлийг нь шүүх хүлээн авсан нэхэмжлэгчид оролцох эрхтэй бөгөөд санал хураалтыг дараах хэсэг тус бүрээр явуулна.[77] Үүнд:

1. нэхэмжилсэн үнийн дүнгийн 10 буюу түүнээс дээш хувийг эзлэх барьцаат нэхэмжлэгчид;

2. бусад барьцаат нэхэмжлэгчид;

3. хариуцагчтай хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчид;

4. Бусад.

Төлөвлөгөөнд дараах үйл ажиллагааг тодорхой тусгана:

Хариуцагчийг үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт оруулах эсэх, хэрэв оруулбал түүнд оруулах өөрчлөлт;

Хариуцагчийн удирдлагад өөрчлөлт оруулах эсэх, түүнд ажиллах хүмүүсийн нэр, хаяг;

Нэхэмжлэлийн шаардлагын оронд үнэт цаас гаргах эсэх;

Хариуцагчийн гаргасан үнэт цаасны төлбөрийн хугацааг сунгах, түүний хүүгийн хувь хэмжээнд өөрчлөлт оруулах эсэх, оруулбал ямар хэмжээнд;

Шинээр хийх гэрээ, хэлцлийн тухай;

Хариуцагчийн эд хөрөнгөөс худалдах бол түүний хэмжээ;

Хариуцагчаас бусдад шилжүүлэх эд хөрөнгө;

Хариуцагчид үлдэх эд хөрөнгө;

Хуулийн 35.4-т заасан нэхэмжлэгчдийн хэсэг;

Хуулийн 35.4-т заасан дараалал тус бүрээр нэхэмжлэлийн шаардлагыг хангах арга, хэлбэр, хэмжээ, хугацаа;

Хариуцагчийг дампуурсанд тооцож татан буулгах, эсхүл дахин хөрөнгөжүүлснээр нэхэмжлэгчдэд хуваарилагдах төлбөрийн хэмжээний зөрүүг харьцуулсан тооцоо;

77 27.3 дахь хэсэг, Монгол Улсын Дампуурлын тухай хууль, 1997.

Хуулийн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

Ажилчидтай байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцлах буюу түүнд өөрчлөлт оруулах бол тэдгээрт хууль тогтоомжийн зохих актын дагуу тэтгэмж олгох, шинээр мэргэжил эзэмшүүлэх, мэргэшүүлэх арга хэмжээ;

Төлөвлөгөөг биелүүлж дүгнэх хугацаа;

Хэрэг гүйцэтгэгч болон холбогдох бусад этгээдэд олгох урамшуулал, ажлын хөлсний хэмжээ, түүнийг олгох журам;

Хариуцагчийг төлбөрийн чадвартай болгох талаар энэ хуулийн дагуу явуулах бусад үйл ажиллагаа зэргийг тусгах шаардлагатай.

Шүүхээс дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг батлахдаа 1/ төлөвлөгөөг нэхэмжлэгчдийн хоёроос доошгүй хэсэг дэмжсэн; 2/ төлөвлөгөөг хэрэгжүүлснээр нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч татан буугдсанаас илүү хангаж чадах гэсэн үндэслэлийг харгалзаж төлөвлөгөөг батална. Дампуурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 3 болон 4 дэх хэсэгт нэхэмжлэгчдээс хэд хэдэн дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг дэмжиж, хэрэгжүүлэх зохицуулалтыг тусгасан. Тухайлбал, нэхэмжлэгчдийн хурлаар хэд хэдэн төлөвлөгөөг зөвшөөрч дэмжсэн бол шүүх хариуцагчийн санал болгосон төлөвлөгөөг батална. Хэрвээ хариуцагчийн санал болгосон төлөвлөгөө нь нэхэмжлэгчдийн 2-оос доошгүй хэсгээр дэмжигдээгүй эсхүл, хариуцагчийн боловсруулсан төлөвлөгөөг хэрэгжүүлсний үр дүнд түүнийг татан буулгаж, эд хөрөнгөөр нь нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийг барагдуулахаас илүү хэмжээгээр хангаж чадахааргүй байна гэж шүүх үзвэл эрх зүйн байдлын хувьд хамгийн тааруу нөхцөлд байгаа нэхэмжлэгчдийн хэсгийн зөвшөөрсөн төлөвлөгөөг батална. Тохиромжгүй нөхцөлд гэдэгт тухайн нэхэмжлэгчид түүний нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангахааргүй хэмжээний хөрөнгө хуваарилагдахыг ойлгоно.[78]

Хэрвээ шүүх хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг батлаагүй бол хариуцагчийг дампуурсанд тооцож, татан буулгах тухай шийдвэр гаргана. Харин шүүхээс төлөвлөгөөг баталж, шийдвэрлэсэн тохиолдолд дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг нэг бол хэрэг гүйцэтгэгч эсхүл хэрэг гүйцэтгэгчийн хяналтын дор хариуцагч өөрөө хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. Хариуцагч өөрөө дампуурлын хэрэг үүсгэх хүсэлтийг шүүхэд гаргасан, мөн шүүхээс хариуцагчийн боловсруулсан төлөвлөгөөг баталсан бол тухайн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, биелүүлэх үүргийг хариуцагчид даалгаж болно. Ийнхүү хариуцагч өөрөө дахин хөрөнгөжүүлэх ажлыг зохион байгуулж биелүүлэх тохиолдолд хариуцагч хэрэг гүйцэтгэгчийн тогтоосон нөхцөл, хязгаарлалтын хүрээнд эд хөрөнгийг захиран зарцуулах эрхтэй болно.

Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг биелүүлэх хугацаа 2 жил байх бөгөөд шаардлагатай бол хэрэг гүйцэтгэгч болон нэхэмжлэгчдийн хурлаас төлөвлөгөөг биелүүлэх хугацааг сунгуулах хүсэлтээ шүүхэд тавьж болно. Шүүхээс төлөвлөгөөний биелэлтийн явцад нэхэмжлэгчдийн нэхэмжлэл, шаардлагыг хангах боломжтой гэж үзвэл төлөвлөгөөгөө биелүүлэх хугацааг 6 сар хүртэл хугацаагаар сунгаж болно. Хэрэгжиж буй дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг сар бүр хариуцагч, хэрэг гүйцэтгэгч болон нэхэмжлэгчдийн хуралд тайлагнах үүрэгтэй.

Дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг шүүхээс дараах 3 үндэслэлээр дуусгавар болгоно.

Үүнд:

1. Төлөвлөгөөг биелүүлэх боломжгүй болсон;

2. Төлөвлөгөөг бүрэн биелүүлж дууссан;

[78] А.Мөнхзул, Л.Энхбилэг, У.Мөнхбат нар, Дампуурлын эрх зүй гарын авлага, Худалдааны эрх зүйн чиглэлээр шүүгчдийг сургах төсөл, УБ, 2014, 60.

3. Төлөвлөгөөг биелүүлж дуусаагүй боловч нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн шаардлагыг төлөвлөгөөний дагуу бүрэн хангасан.

Төлөвлөгөөг биелүүлэх боломжгүй болсон бол шүүх хариуцагчийг дампуурсанд тооцож, татан буулгах тухай шийдвэр гаргана. Харин бусад хоёр тохиолдолд нь буюу төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлж дууссан эсхүл нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийг бүрэн хангасан бол шүүх дампуурлын хэргийг хэрэгсэхгүй болгож, хариуцагч үйл ажиллагаагаа сэргээж хэвийн ажиллах нөхцөл бүрдэнэ.

Дэд хэсгийн дүгнэлт , санал

Солонгос Улсын сэргээн босгох төлөвлөгөөг боловсруулах, дэмжих, батлах, хэрэгжүүлэх, хэрэгжүүлэхийг зогсоох материаллаг болон процессын нарийн зохицуулалт нь сэргээн босгох тогтолцооны онцлогийг тодорхой илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл төлөвлөгөөг боловсруулахаас эхлээд хэрэгжүүлэхийг зогсоох хүртэлх хуулийн зохицуулалтууд нь бүхий л үе шатанд мэдээллийн ил тод байдал болон талуудын оролцоог нээлттэй тэгш хангах, талуудын ашиг сонирхол, байр суурийг сонсох, харилцан ойлголцох, асуудлыг хамтран шийдвэрлэх боломжийг бий болгоход чиглэсэн.

Герман улсын тухайд төлбөрийн чадваргүй байдлын талаар хэрэг үүсгэх, төлбөрийн чадваргүй байдлыг хэрхэн тогтоох, хариуцагч шүүхэд хэдий хугацааны дотор төлбөрийн чадваргүй байдалд орсон талаар мэдэгдэх, хэрэв мэдэгдэхгүй бол ямар хариуцлага оногдуулах талаар хуульдаа тусгажээ. Түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат урьдчилсан ба нээлттэй ажиллагаа гэсэн байдлаар хэрэгждэг.

Монгол Улсын хувьд дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг Дампуурлын тухай хуульд нарийвчлан тусгаагүй, дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг үүсгэх, хэрэгжүүлэх, дуусгавар болгох ажиллагааг нарийвчлан зохицуулаагүйгээс хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэхэд зарим бэрхшээл үүсч байна. Өөрөөр хэлбэл хариуцагч хэдий хугацааны дараа дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргах, шүүхэд төлбөрийн чадваргүй болсон талаараа хэдий хугацааны дотор мэдэгдэх ёстой зэрэг үүргийг нарийвчлан зохицуулаагүйгээс хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа цаг хугацаа алдаж зарим талаар дахин хөрөнгөжүүлэх боломжийг хязгаарладаг байна.

Нөгөө талаар шүүхээс түр болон жинхэнэ хэрэг гүйцэтгэгчийг ямар шалгууруар томилох, хэрэг гүйцэтгэгч өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад мэргэжлийн алдаа гаргавал хэрхэн шийдвэрлэх, мөн хариуцлагын тогтолцоо сул байгаа байдал нь дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа хэрэгжихэд хүндрэл учруулдаг байж болзошгүй.

Түүнчлэн манай улс хариуцагчийн эсрэг гаргасан олон төрлийн нэхэмжлэлийг нэгдсэн байдлаар шийдвэрлэх, төрийн байгууллагуудын харилцан уялдаатай ажиллах ажиллагааг хангах, дахин хөрөнгөжүүлэх бодлогын хүрээнд татварын эрх зүйн орчныг сайжруулах болон дахин хөрөнгөжүүлэх бодлогын хүрээнд давж заалдах бодлогыг үр дүнтэй тодорхойлох нь зүйтэй. Эдгээр арга хэмжээ нь дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шууд нөлөөлдөг.

1. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

Солонгос Улсын Сэргээн босгох болон дампуурлын тухай хуульд зах зээлийн эдийн засгийн нөхцөлд нийцсэн нэмэлт өөрчлөлтийг 2016 онд оруулсан. Энэхүү зохицуулалт нь хариуцагч, нэхэмжлэгч талууд урьдчилан тохиролцсоноор сэргээн босгох төлөвлөгөөг шүүхээр батлуулан хэрэгжүүлэх боломжийг олгосноор хуулийн тодорхой үе шатыг алгасах улмаар цаг хугацаа, зардал хэмнэн асуудлаа шийдвэрлэх

боломжийг тэдэнд олгожээ. Тус нэмэлт өөрчлөлтөөр шинээр хөрөнгө оруулж байгаа үүрэг гүйцэтгүүлэгчид өргөн хүрээний давуу эрхийг хангаж өгсөн. Тухайлбал: шинээр зээл олгосон үүрэг гүйцэтгүүлэгч сэргээн босгох ажиллагаатай холбоотой санал гаргах, мэдээлэл гаргуулан авах эрхтэй. Ийнхүү ил тод, хариуцлагатай сэргэн босгох ажиллагааг бүрдүүлснээр шинээр зээл олгох үүрэг гүйцэтгүүлэгчид шинээр хөрөнгө оруулах итгэл, сэдлийг бий болгожээ.

Германы Төлбөрийн чадваргүй байдлыг зохицуулах тухай хуульд Pre-packed administration буюу хэргийг өөрөө удирдах зохицуулалтыг тус хуулийн 270 дугаар зүйлд тусгасан. Энэ зохицуулалтын дагуу хариуцагч буюу төлбөрийн чадваргүй болсон этгээд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өөрөө удирдах хүсэлт бүхий төлөвлөгөөг шүүхэд гаргадаг.[79] Энэ хүсэлтийг шүүх хэрэв хүлээж авбал хариуцагч 3 сарын хугацаанд төлбөрийн чадваргүй байдлаас үүсэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өөрөө удирдах бөгөөд энэ хугацаанд хариуцагч компаниа хөл дээр нь босгох зорилгоор дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө гаргах, өөрсдийн хөрөнгө оруулагчдаас нэмэлт зээл олох зэрэг ажиллагааг хийх ач холбогдолтой.[80] Энэхүү зохицуулалт нь хэдийгээр шинэчлэн батлагдсан Төлбөрийн чадваргүй байдлыг зохицуулах тухай хуулийн нэгэн шинэлэг зохицуулалт болсон боловч практикт одоогоор хэрэгжсэн тохиолдол ховор байна.[81]

Тус хуулийн 270 дугаар зүйлд заасны дагуу хариуцагч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өөрөө удирдах талаар дараах урьдчилсан нөхцлүүд хангасан байх шаардлагатай.

Хариуцагчаас дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өөрөө явуулах хүсэлт гаргасан байх;

Хүсэлтийг шийдвэрлэснээр нэхэмжлэгч нарт хохирол учрах ямар нэгэн нөхцөл бүрдээгүй байх;

Хүсэлтийг шийдвэрлэхээс өмнө нэхэмжлэгчдийн түр хорооноос хариуцагчийн санхүүгийн байдалд хохирол учруулахуйц байдал илрээгүй тохиолдолд энэ боломжийг олгоно. 270 а дугаар зүйлд зааснаар өөрөө удирдан явуулах хариуцагчийн хүсэлт нь ирээдүйд шийдвэр гаргах ерөнхий хязгаарлалтыг тогтоож, хариуцагчийн бүх шийдвэрүүд нь түр хэрэг гүйцэтгэгчийн зөвшөөрөлтэйгөөр үр дагавар үүсгэдэг байхаар шийдвэртээ тусгах ба хариуцагч өөрөө удирдах ажиллагааг үүсгэнэ.

Нэхэмжлэгчдийн хүрлаас хариуцагчийн төлбөрийн чадваргүй байдал, түүнтэй холбогдох хэргийг өөрөө удирдах хүсэлтийг зөвшөөрсөн тохиолдолд хариуцагчийн хүсэлтийг хангаж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удирдах эрхийг олгодог. Хариуцагч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өөрөө удирдан зохион байгуулахын давуу тал нь хариуцагч компанийн одоогийн удирдлагууд хэвээр үлдэх боломжтой, мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг багасгах боломжтой зэрэг юм.

Төлбөрийн чадваргүй байдлыг зохицуулах тухай хуульд хариуцагч өөрөө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удирдан явуулах үед дахин хөрөнгөжүүлэх бэлтгэл ажиллагааны талаар 270 б заалтад тусгаснаар хариуцагч гарцаагүй төлбөрийн чадваргүй байдалд орсон эсвэл их хэмжээний өртэй болсны улмаас төлөгдөөгүй үүргийн шаардлагын тухай дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх хүсэлт гаргасан мөн ирээдүйд хохирол учруулахгүйгээр дахин хөрөнгөжүүлэх зорилгоор хүсэлт гаргасан бол шүүхээс дампуурлын төлөвлөгөө гаргах эцсийн

[79] https://www.iiiglobal.org/sites/default/files/annerosetashiro.pdf.

[80] https://www.lw.com/thoughtLeadership/pre-packaged-insolvencies-on-the-rise-in-germany-evaluating-the-german-esug

[81] https://www.iiiglobal.org/sites/default/files/annerosetashiro.pdf

хугацааг тогтооно. Тогтоосон хугацаа 3 сараас хэтрэхгүй. Хариуцагчийн хүсэлтэд их хэмжээний өртэй эсвэл гарцаагүй төлбөрийн чадваргүй байдлыг нотлох эрх бүхий бүхий гэрчилгээтэй этгээд эсвэл энэ талаарх туршлага бүхий хуульч эсвэл нягтлан бодогч, татварын зөвлөхөөс гаргасан үндэслэлээ хавсаргах эсвэл дампуурлын түр зөвлөх нь хариуцагч төлбөрийн чадваргүй болсон даруй шүүхэд мэдэгдэх үүрэгтэй. Хариуцагч өөрөө удирдах шийдвэрийг хүчингүй болгосон эсвэл шүүхийн эцсийн хугацааг хэтрүүлсэн бол дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэх шийдвэр гаргах талаар заасан байдаг.

Монгол Улсын Дампуурлын тухай хуулиар төлбөрийн чадваргүй байдал, түүнтэй холбогдох маргааныг хялбаршуулсан журмаар хэрхэн шийдвэрлэх талаар нарийвчлан тусгаагүй. Харин 2012 онд батлагдсан Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулиар талуудын хооронд үүссэн маргааныг шүүхийн бус аргаар эвлэрүүлэн зуучлагчийн тусламжтайгаар хянан шийдвэрлэх боломж байхыг үгүйсгэхгүй болно.

Дэд хэсгийн дүгнэлт , санал

Дээрхээс үзэхэд судлагдсан орнуудад дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг хялбаршуулсан журмаар хэрхэн хянан шийдвэрлэж болох талаар зохицуулалт тусгагджээ. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Дампуурлын тухай хуулиар дампуурал, тэр дундаа дахин хөрөнгөжүүлэх асуудлыг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг тусгах шаардлагатай.

2. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

Солонгос Улсын тухайд төрөөс үүрэг гүйцэтгэгчид сэргээн босгох ээлтэй бодлогыг хэрэгжүүлдэг боловч хууль зөрчсөн этгээдийг хатуу шийтгэдэг. Хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий хорооны гишүүд, хэрэг гүйцэтгэгч, түр хэрэг гүйцэтгэгч, байцаагч нарт ч мэргэжил туршлагын төдийгүй ёс зүйн өндөр шаардлага тавихын зэрэгцээ тэдэнд олгох төлбөрийн асуудлыг давуу байдлаар зохицуулсан. Хууль зөрчигчид өндөр хариуцлага ногдуулдаг. Тухайлбал хорооны гишүүн нь Эрүүгийн болон бусад хуулийн хүрээнд хариуцлага хүлээхэд төрийн албан тушаалтны адил хариуцлага хүлээдэг. Ийнхүү нэг талаас ээлтэй байдлыг нөгөө талаас тэгш шударга байхыг нийт оролцогчдод үүрэг болгосон.

Германы Төлбөрийн чадваргүй байдлыг зохицуулах тухай хуульд зааснаар хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой зарим хариуцлагыг хуульчилсан. Тухайлбал, тус хуулийн 15 а зүйлд зааснаар хэрэв хариуцагч буюу компанийн удирдлага компанид их хэмжээний өртэй болсон ба өрийг төлөх боломжгүй байдал илэрсэн тохиолдолд шүүхэд нэн даруй 3 долоо хоногийн дотор мэдэгдэх үүрэгтэй. Хэрэв хариуцагч шүүхэд 3 долоо хоногийн дотор хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр мэдэгдээгүй бол 3 жил хүртэлх хугацаагаар эрүүгийн хариуцлага хүлээхийн зэрэгцээ нийгмийн даатгал, татварын хөнгөлөлт эдлэх боломжоо алдах эрсдэлийг үүсгэдэг.[82] Түүнчлэн тус хуулийн 58 дугаар зүйлд хэрэг гүйцэтгэгч хуульд заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол захиргааны торгууль оногдуулдаг. Торгуулийн хэмжээ нь 25 мянган еврогоос хэтрэхээргүй байна гэжээ.

Монгол Улсын хувьд Дампуурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлд энэ хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгасан. Үүнд:

хэрэг гүйцэтгэгчийн тавьсан шаардлагыг биелүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзсан бол хариуцагч, нэхэмжлэгч, холбогдох бусад этгээдийг 20000-50000 төгрөгөөр торгох;

[82] Schultze and Braun,Germany Insolvency Law, p.3.

шүүх дампуурлын хэрэг үүсгэсэн, эсхүл үүсгэх гэж байгааг мэдсээр байж тухайн аж ахуйн нэгжийн эд хөрөнгө, баримт бичгийг нуусан, эсхүл нуухад тусалсан бол уг этгээдийг 30000-50000 төгрөгөөр торгох;

олгогдсон бүрэн эрхээ хэтрүүлсэн, хувийн зорилгод ашигласан, холбогдох хууль тогтоомж зөрчиж бусдын нууцыг задруулсан бол хэрэг гүйцэтгэгчийг 40000-60000 төгрөгөөр торгох;

энэ хуулийн 34.5-д заасан баталгааг хуурамчаар гаргасан хариуцагчийг 30000-50000 төгрөгөөр торгох.

Түүнчлэн хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж тусгажээ. Үүнээс үзэхэд энэхүү хуулиар ногдуулсан шаардлагыг зөрчсөн этгээдийг дунджаар 20000-50000 төгрөгөөр торгохоор заасан нь ААН-ийн хувьд хэтэрхий сул болсон нь харагдаж байна. Энэ талаар судлагдсан орнуудад дараах байдлаар зохицуулжээ. Тухайлбал, Солонгос Улсын тухайд төрөөс үүрэг гүйцэтгэгчид сэргээн босгох ээлтэй бодлогыг хэрэгжүүлдэг учраас хууль зөрчсөн үүрэг гүйцэтгэгчийг хатуу шийтгэдэг. Түүнчлэн хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий хорооны гишүүд, хэрэг гүйцэтгэгч, түр хэрэг гүйцэтгэгч, байцаагч нарт ч мэргэжил туршлагын төдийгүй ёс зүйн өндөр шаардлага тавихын зэрэгцээ тэдэнд олгох төлбөрийн асуудлыг давуу байдлаар зохицуулсан ба хууль зөрчсөн тохиолдолд тэдэнд мөн өндөр хариуцлага ногдуулдаг. Тухайлбал хорооны гишүүн нь Эрүүгийн болон бусад хуулийн хүрээнд хариуцлага хүлээхэд төрийн албан тушаалтны адил хариуцлага хүлээдэг. Ийнхүү нэг талаас эзэлтэй байдлыг нөгөө талаас тэгш шударга байхыг нийт оролцогчдод үүрэг болгосон.

Дэд хэсгийн дүгнэлт , санал

Монгол Улсад төлбөрийн чадваргүй байдал түүнтэй холбогдох эрх зүйн зөрчил гаргасан холбогдох этгээдэд оногдуулах хариуцлагын хэмжээ судлагдсан орнуудтай харьцуулахад сул байна. Түүнчлэн хариуцагч буюу компанийн удирдлага компанид их хэмжээний өртэй болсон буюу дампуурах эрсдэлтэй болсон үед шүүхэд даруй мэдэгдэх эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Үүний улмаас аж ахуйн нэгжийн дампуурлын ажиллагаа хугацаа алдах, тухайн аж ахуйн нэгжийг дампуурахаас сэргийлэх, дахин хөрөнгөжүүлэхэд хүндрэл гарч байна. Иймд хууль зөрчигчид оногдуулах хариуцлагыг чангаруулах, торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх мөн дампуурах эрсдэл үүссэн тохиололд хэдий хугацааны дотор шүүхэд мэдэгдэх талаар нарийвчилсан зохицуулалт тусгах талаар хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлагатай.

3. Шүүхийн бус арга хэрэгслээр дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа

Солонгос Улсын шүүхийн бус арга хэрэгслээр дахин зохион байгуулах ажиллагаа нь ААН-ийг дахин зохион байгуулахыг дэмжих тухай хуулийн дагуу хэрэгждэг. Тус улс нь 1990- ээд оны эдийн засгийн хямралтай холбогдуулан шүүхийн бус арга хэрэгслээр дахин зохион байгуулах үр дүнтэй тогтолцоог бүрдүүлсэн байдаг. Үүний үр дүнд тус улсын эдийн засгийн хөгжлийг хангахад чухал оролцоотой олон томоохон корпорацыг дампууруулахгүйгээр амжилттай дахин зохион байгуулсан байдаг.

Тус хуулийн зорилгыг зах зээлийн механизмд суурилсан хялбар, шуурхай ААН-ийг дахин зохион байгуулах ажиллагааг дэмжих гэж хуульд тодорхойлсон. Гэсэн хэдий ч ААН-ийн өрийг төрөөс худалдан авах, Санхүүгийн удирдан зохицуулах байгууллага нь саналын зөрөөтэй үүрэг гүйцэтгүүлэгчдийг үүрэг гүйцэтгэгчийн эсрэг шүүхэд нэхэмжлэл гаргахыг нь хориглох /шүүхийн бус арга хэрэгслээр дахин зохион байгуулах ажиллагааг хангахын тулд/ зэрэг төрийн оролцоотой хэрэгждэг.

Хуулийн үндсэн зарчмыг дор авч үзье. Үүнд:

Банк, санхүүгийн байгууллагууд дахин зохион байгуулах ажиллагааг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах гэрээ байгуулсан тохиолдолд дийлэнх үүрэг гүйцэтгүүлэгчид шүүхийн бус арга хэрэгслээр дахин зохион байгуулах ажиллагааг гүйцэтгэхээр шийдвэрлэсэн тохиолдолд бусад үүрэг гүйцэтгүүлэгч нь шүүхэд нэхэмжлэл гаргах эрхгүй болдог;

Шүүхийн бус арга хэрэгслээр дахин зохион байгуулах ажиллагааг шуурхай хэрэгжүүлэх арбитрын оролцоог хангасан;

Хуулийн үр дүнтэй хэрэгжилтийг хангахын тулд хууль зөрчсөн үүрэг гүйцэтгэгч, үүрэг гүйцэтгүүлэгчид оногдуулах хариуцлагыг тодорхой болгосон зэрэг хамаарна.

Талуудын оролцоог тэгш хангах, мэдээллийн ил тод байдлыг бий болгох, нээлттэй процессын дагуу дахин зохион байгуулах ажиллагааг явуулах, хариуцлага тооцох зэрэг үндсэн механизм, зарчмын тухайд шүүхэд нэхэмжлэл гаргах замаар сэргээн босгох ажиллагаатай адил төстэй. Гэсэн хэдий ч шүүхийн бус арга хэрэгслээр дахин зохион байгуулах ажиллагаа нь шүүхийн оролцоогүй шуурхай хэрэгждэг төдийгүй дахин зохион байгуулах ажиллагааг хэрэгжүүлэхэд төрөөс дэмжлэг авах боломжтой байдгаараа онцлог байна.

Солонгос Улсын шүүхийн бус арга хэрэгслээр дахин зохион байгуулах тогтолцоо нь үр дүнтэй хэрэгжиж байсан учраас гадаадын болон санхүүгийн бус байгууллагыг банк, санхүүгийн байгууллагад хамруулан ойлгохоор хуулийн үйлчлэх хүрээг өргөтгөсөн. Үүнтэй холбоотойгоор шүүхийн бус арга хэрэгслээр дахин зохион байгуулах ажиллагаа нь өргөнөөр ашиглагдах байх гэсэн хүлээлтийг салбарын мэргэжилтнүүдийн хүрээнд бий болгосон байна. Энэхүү тогтолцооны хүрээнд өрийг хувьцаа болгох, шинээр зээл олгогчид давуу боломж олгох зэрэг үүрэг гүйцэтгүүлэгч төдийгүй үүрэг гүйцэтгэгчид ашигтай нөхцөлийг бүрдүүлж чадсан.

Үндсэндээ тус улсын эдийн засаг, санхүү, хууль зүйн хамтарсан бодлогын үр дүнд салбар дундын ил тод, шударга, үр дүнтэй шүүхийн бус арга хэрэгслээр дахин зохион байгуулах механизмыг бүрдүүлсэн байна.

Герман улсын “Төлбөрийн чадваргүй байдлыг зохицуулах тухай” хуульд шүүхийн бус арга хэрэгслээр дахин хөрөнгөжүүлэх эрх зүйн зохицуулалтыг тусгаагүй боловч энэ асуудлыг Германы Өрийн бичгийн тухай хуульд /German bond Act/ зарим зохицуулалтыг тусгасан. Энэ хуульд тусгаснаар хэрэв үүрэг гүйцэтгүүлэгчдийн 5 хувийн саналаар дахин хөрөнгөжүүлэх талаар үүрэг гүйцэтгүүлэгчдийн хурлыг хуралдуулах шаардлагатай гэж үзвэл үүрэг гүйцэтгүүлэгчдийн хурлыг хуралдуулдаг. Энэхүү хурлаар төлбөрийн чадваргүйд тооцогдож байгаа этгээдийг дахин хөрөнгөжүүлэх асуудлыг хэлэлцэж, хуралд оролцсон саналын эрхтэй гишүүдийн 75 хувийн саналаар үүрэг гүйцэтгэгчийг дахин хөрөнгөжүүлэх асуудлыг шийдвэрлэдэг.[83]

Энэхүү ажиллагаа нь шүүхийн бус арга хэрэгслээр хийгддэг буюу олон нийтэд зарлагдахгүй зэрэг онцлогтой учраас төлбөрийн чадваргүй этгээдийн ажил хэргийн нэр хүнд унахаас сэргийлэх, хэрэглэгч, үйлчлүүлэгчидтэй харилцах, гэрээ хэлэлцээр хийхэд хялбар, мөн хөрөнгө оруулагчаас нэмэлт зээл олоход хялбар болгодог зэргээрээ онцлогтой. Түүнчлэн төлбөрийн чадваргүй этгээдийн хувьд шүүхийн бус арга хэрэгслээр дахин хөрөнгөжүүлэх үйл явц нь ердийн журмаар дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас илүү хурдан, зардал багатай

[83] https://www.noerr.com/en/newsroom/News/new-german-bonds-act-options-for-bondholders-in-case-of-issuer%E2%80%99s-crisis.aspx

байдгаараа ашигтай. Тухайлбал, шүүхийн болон төлбөрийн чадваргүй байдлын талаар хэрэг гүйцэтгэгчийн зардлаас чөлөөлөгдөх, мөн нэхэмжлэгчид нь хуулийн этгээдийн одоогийн удирдлагыг үлдээх эсхүл өөрчлөх зэрэг чухал шийдвэр гаргах процесст оролцох боломжтой.[84]

Гэхдээ энэхүү ажиллагааг хэрэгжүүлэхдээ дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг хожимдож эхлүүлсэн эсхүл дахин хөрөнгөжүүлэх үйл явц амжилтгүй хэрэгжсэн бол төлбөрийн чадваргүй этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өөрөө удирдах ажиллагаа цаашид хэрэгжих боломжгүй болж, улмаар хариуцагч талын удирдлагууд, хувьцаа эзэмшигчид нь эрүүгийн хариуцлагад татагдах үндэслэл бий болж болно. Герман улсын “Төлбөрийн чадваргүй байдлыг зохицуулах тухай” хуулийн 15а заалтад зааснаар хэрэв хариуцагч буюу компанийн удирдлага компани их хэмжээний өртэй болсон ба өрийг төлөх боломжгүй байдал илэрсэн тохиолдолд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх шүүхэд 3 долоо хоногийн дотор мэдэгдэх үүрэгтэй. Хэрэв хариуцагч шүүхэд 3 долоо хоногийн дотор хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр нэн даруй мэдэгдээгүй бол 3 жил хүртэлх хугацаагаар эрүүгийн хариуцлага хүлээхийн зэрэгцээ нийгмийн даатгал, татварын хөнгөлөлт эдлэх боломжоо алдах эрсдэлийг үүсгэдэг.[85]

Дэд хэсгийн дүгнэлт , санал

Шүүхийн бус арга хэрэгслээр дахин зохион байгуулах ажиллагаа нь шүүхийн оролцоогүй шуурхай хэрэгждэг төдийгүй дахин зохион байгуулах ажиллагааг хэрэгжүүлэхэд төрөөс дэмжлэг авах боломжтой байдгаараа онцлог байна. Энэхүү ажиллагаа нь шүүхийн бус арга хэрэгслээр хийгддэг буюу олон нийтэд зарлагдахгүй зэрэг онцлогтой учраас төлбөрийн чадваргүй этгээдийн ажил хэргийн нэр хүнд унахаас сэргийлэх, хэрэглэгч, үйлчлүүлэгчидтэй харилцах, гэрээ хэлэлцээр хийхэд хялбар, мөн хөрөнгө оруулагчаас нэмэлт зээл олоход хялбар болгодог зэргээрээ онцлогтой. Түүнчлэн төлбөрийн чадваргүй этгээдийн хувьд шүүхийн бус арга хэрэгслээр дахин хөрөнгөжүүлэх үйл явц нь ердийн журмаар дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас илүү хурдан, зардал багатай байдгаараа ашигтай. Иймд Монгол Улсад судлагдсан орнуудын туршлагыг харгалзан шүүхийн бус арга хэрэгслээр дахин хөрөнгөжүүлэх асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлагатай.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ, САНАЛ

1.Хууль тогтоомжийн нэр томьёо, зорилго зарчим

Монгол Улсын Дампуурлын тухай хуулийг шинэ нэршил, шинэ үзэл баримтлал, зарчмыг тусган дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг нээлттэй, шударга, үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэн шинэчлэн найруулах нь цаг үеийн тулгамдсан асуудал болсон байна.

Судлагдсан орнуудад санхүүгийн хүндрэлд орсон ААН-ийн үйл ажиллагааг сэргээн хэвийн болгох бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засгийн хөгжлийг дэмжих төдийгүй нийтийн эрх ашгийг хамгаалах, хангахыг зорьсон. Иймд дахин хөрөнгөжүүлэх бодлогыг манай улсын Дампуурлын тухай хуульд тэргүүлэх чиглэл болгон тусгах нь ААН-ийг аль болох татан буулгахгүйгээр дахин хөрөнгөжүүлэхэд нэхэмжлэгч, хариуцагч, шүүгч, хэрэг гүйцэтгэгч зэрэг нийт оролцогчдын ухамсар хандлагыг нэмэгдүүлэх төдийгүй эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

[84] Weil, Comparative guide to Restructuring Procedures 2012, p.68

[85] Schultze and Braun, Germany Insolvency Law, p.3. https://www.schubra.de/downloads/broschueren/0027_en.pdf

Ялангуяа энэхүү бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлснээр өнөөгийн эдийн засгийн хямралыг нийгэм, эдийн засагт сөрөг нөлөө багатай даван туулахад өндөр ач холбогдолтой юм.

Герман, Солонгос улсуудын холбогдох хуулиудад дахин хөрөнгөжүүлэх ажиллагааны хүрээнд үүрэг гүйцэтгүүлэгчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг аливаа байдлаар хохироохгүй байх гэсэн гол зарчмыг баримталдаг. Энэхүү зарчимтай холбоотойгоор хуулийг хэрэгжүүлэх бүхий л үе шатанд үүрэг гүйцэтгүүлэгчийн эрх ашгийг хангах зохицуулалтад тусгасан байна. Энэ механизм нь үүрэг гүйцэтгүүлэгч сэргээн босгох ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийг дэмжих, үүрэг гүйцэтгүүлэгчид бизнесээ хэвийн явуулах итгэл, эрмэлзэл бий болгодог учраас дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх гол нөхцөл болдог. Иймд манай улсын хуульд дахин хөрөнгөжүүлэх бодлогыг тэргүүлэх чиглэл болгохын зэрэгцээ үүрэг гүйцэтгүүлэгчдийн эрх ашгийг хангах зарчмыг хуулийг хэрэгжүүлэх бүхий л үе шатанд тусгах нь хуулийн үр дүнтэй хэрэгжилтийг хангахад чухал гэж үзэж байна. Үүнтэй уялдуулан дараах саналыг гаргаж байна. Үүнд:

Дампуурлын тухай хуулийн төслийг боловсруулахдаа энэ хуулийн нэршлийг анхаарч “Дампуурал ба дахин хөрөнгөжүүлэх тухай” гэсэн агуулгаар уг хуулийн нэрийг нэрлэх; Дампуурлын тухай хуулийн төслийн зорилго, зарчим агуулгад анхаарч ААН-ийг дахин хөрөнгөжүүлэх боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үзэл баримтлалыг батлах; Дампуурлын тухай хуулийн төсөлд дахин херөнгөжүүлэх арга, хэлбэрийг дэлхийн улс орнуудын хууль тогтоомжийг судлах замаар тусгах.

2. Хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо

Судлагдсан орнуудын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дараах онцлогтой байна. Тухайлбал, Герман улс төлбөрийн чадваргүй байдлыг хянан шийдвэрлэх олон жилийн туршлагатай улс учраас тус улсын шүүгчид нь төлбөрийн чадваргүй байдлыг зохицуулах асуудлаар мэргэшсэн байдаг. Харин Солонгос Улсын тухайд дахин хөрөнгөжүүлэх асуудлаар мэргэшсэн хороог шүүхийн дэргэд байгуулах замаар дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг мэргэшсэн хороогоор хянуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангуулах асуудлыг шийдвэрлэсэн байна. Мэргэжлийн хорооны оролцоотой, шүүхийн хяналттай дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд анхаарч ажилладаг. Иймд манай улсын тухайд дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэхдээ энэ чиг үүргийг хэрэгжүүлэх хороог байгуулах талаар судалж үзэх шаардлагатай.

Мөн судлагдсан орнуудад манай улсад хэлж заншсанаар хэрэг гүйцэтгэгч болох ААН- ийг дахин хөрөнгөжүүлэх мэргэжилтэн нь зах зээлийн эрэлт хэрэгцээгээ дагаад өндөр мэргэшсэн, өрсөлдөхүйц чадвартай байдаг. Үүнтэй холбоотойгоор хэрэг гүйцэтгэгчийг албан журмаар бүртгэх, сонгох зохицуулалт байдаггүй ба харин түүнд холбогдох хуулиудаар өндер шалгуурыг тогтоон, цалин урамшууллыг шийдвэрлэсэн байдгийн зэрэгцээ өндөр хариуцлагыг ч оноодог байна. Иймд манай улс мөн адил дахин хөрөнгөжүүлэх бодлогын хүрээнд хэрэг гүйцэтгэгчийн эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэн, өрсөлдөөнт орчинг бий болгох, тэдний санхүүгийн баталгаа, болон тэдэнд тавигдах шаардлага, оногдуулах хариуцлагыг хуульд тусгах шаардлагатай гэж үзэж байна.

3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

Судлагдсан орнуудын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь Монгол Улстай харьцуулахад зарим дэвшилтэд арга замаар хэрэгждэг байна. Тухайлбал, Солонгос Улсын сэргээн босгох төлөвлөгөөг боловсруулах, дэмжих, батлах, хэрэгжүүлэх, хэрэгжүүлэхийг зогсоох материаллаг болон процессын нарийн зохицуулалт нь сэргээн босгох тогтолцооны онцлогийг тодорхой илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл төлөвлөгөөг боловсруулахаас эхлээд хэрэгжүүлэхийг дуусгавар болох бүхий л үе шатанд мэдээллийн ил тод байдлыг болон талуудын оролцоог нээлттэй тэгш хангах, талуудын ашиг сонирхол, байр суурийг сонсох, харилцан ойлголцох, асуудлыг хамтран шийдвэрлэх боломжийг бий болгоход чиглэсэн.

Герман улсын тухайд төлбөрийн чадваргүй байдлын талаар хэрэг үүсгэх нөхцөл, төлбөрийн чадваргүй байдлыг хэрхэн тогтоох, хариуцагч шүүхэд хэдий хугацааны дотор төлбөрийн чадваргүй байдалд орсон талаараа мэдэгдэх, хэрэв мэдэгдэхгүй бол хэрхэн хариуцлага оногдуулах талаар хуульдаа тусгажээ. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь урьдчилсан ба нээлттэй ажиллагаа гэсэн үе шатуудаар хэрэгжүүлдэг.

Монгол Улсын хувьд дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг Дампуурлын тухай хуульд нарийвчлан тусгагдаагүй, дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг үүсгэх, хэрэгжүүлэх, дуусгавар болгох ажиллагаа нарийвчлан зохицуулагдаагүйгээс хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэхэд зарим бэрхшээл үүсч байна. Өөрөөр хэлбэл хариуцагч хэдий хугацааны дараа дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргах, хэрэв шүүхэд төлбөрийн чадваргүй болсон талаараа хэдий хугацааны дотор мэдэгдэх ёстой зэрэг үүргийг нарийвчлан зохицуулаагүйгээс хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа цаг хугацаа алдаж зарим талаар дахин хөрөнгөжүүлэх боломжийг хязгаарладаг байна.

Нөгөө талаар шүүхээс түр болон жинхэнэ хэрэг гүйцэтгэгчийг ямар шалгууруур томилох, хэрэг гүйцэтгэгч өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад гаргасан мэргэжлийн алдааг хэрхэн шийдвэрлэх, мөн хариуцлагын тогтолцоо сул байгаа байдал нь дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа хэрэгжихэд хүндрэл учруулдаг байж болзошгүй.

Манай улс хариуцагчийн эсрэг гаргасан нэхэмжпэлийг нэгдсэн байдлаар шийдвэрлэх, төрийн байгууллагуудын харилцан уялдааг хангах, дахин хөрөнгөжүүлэх бодлогын хүрээнд татварын эрх зүйн орчныг сайжруулах болон дахин хөрөнгөжүүлэх бодлогын хүрээнд давж заалдах бодлогыг үр дүнтэй тодорхойлох нь зүйтэй. Эдгээр арга хэмжээ нь дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шууд хамааралтай юм.

4. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

Судлагдсан орнуудад дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг хялбаршуулсан журмаар хэрхэн хянан шийдвэрлэж болох талаар зохицуулсан байна. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Дампуурлын тухай хуулиар дампуурал, тэр дундаа дахин хөрөнгөжүүлэх асуудлыг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг тусгах шаардлагатай.

5. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

Монгол Улсад төлбөрийн чадваргүй байдал түүнтэй холбогдох эрх зүйн зөрчил гаргасан холбогдох этгээдэд оногдуулах хариуцлагын хэмжээ судлагдсан орнуудтай харьцуулахад сул байна. Түүнчлэн хариуцагч буюу компанийн удирдлага компанид их хэмжээний өртэй болсон буюу дампуурах эрсдэлтэй болсон үед шүүхэд даруй мэдэгдэх эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Үүний улмаас аж

ахуйн нэгжийн дампуурлын ажиллагаа хугацаа алдах, тухайн аж ахуйн нэгжийг дампуурахаас сэргийлэх, дахин хөрөнгөжүүлэхэд хүндрэл гарч байна. Иймд хууль зөрчигчид оногдуулах хариуцлагыг чангаруулах, торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх мөн дампуурах эрсдэл үүссэн тохиололд хэдий хугацааны дотор шүүхэд мэдэгдэх талаар нарийвчилсан зохицуулалт тусгах талаар хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлагатай.

6. Шүүхийн бус арга хэрэгслээр дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа

Шүүхийн бус арга хэрэгслээр дахин зохион байгуулах ажиллагаа нь шүүхийн оролцоогүйгээр шуурхай хэрэгждэг төдийгүй дахин зохион байгуулах ажиллагааг хэрэгжүүлэхэд төрөөс дэмжлэг авах боломжтой байдгаараа онцлог байна. Энэхүү ажиллагаа нь шүүхийн бус арга хэрэгслээр хийгддэг буюу олон нийтэд зарлагдагүй зэрэг онцлогтой учраас төлбөрийн чадваргүй этгээдийн ажил хэргийн нэр хүнд унахаас сэргийлэх, хэрэглэгч, үйлчлүүлэгчидтэй харилцах, гэрээ хэлэлцээр хийхэд хялбар, мөн хөрөнгө оруулагчаас нэмэлт зээл олоход хялбар болгодог зэргээрээ онцлогтой. Түүнчлэн төлбөрийн чадваргүй этгээдийн хувьд шүүхийн бус арга хэрэгслээр дахин хөрөнгөжүүлэх үйл явц нь ердийн журмаар дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас илүү хурдан, зардал багатай байдгаараа ашигтай. Иймд Монгол Улсад судлагдсан орнуудын туршлагыг харгалзан шүүхийн бус арга хэрэгслээр дахин хөрөнгөжүүлэх талаар судалж, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлагатай гэж үзлээ.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ САН-ЗЭЭН
www.nli.gov.mn

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын Дампуурлын тухай хууль, 1997.ШЕЗ-ийн ШСМСХ-ийн 2015 оны статистикийн тайлан.

2. А.Мөнхзул, Л.Энхбилэг, У.Мөнхбат нар, Дампуурлын эрх зүй гарын авлага, Худалдааны эрх зүйн чиглэлээр шүүгчдийг сургах төсөл, УБ, 2014.

3. Д.Энхзул, Дампуурлын эрх зүйн зарим асуудалд, Эрх зүй сэтгүүл, дугаар 1/2011(20), 2011 он.

4. Edited by Michael Pomerleano and William Shaw, Corporate Restructuring: Lessons from Experience, the World Bank, 2005.

5. Insolvency and Corporate Reorganization Report: South Korea, IFLR, 2016.

6. Jaewan Park, Global Insolvency Law database, World Bank, 2003.

7. John Armour, The Rise of the 'PRE-PACK': Corporate Restructuring in the UK and Proposals for Reform, Restructuring Companies in Troubled Times: Director and Creditor Perspectives, Sydney: Ross Parsons Centre, 2012.

8. Vanessa Finch, Corporate Insolvency Law: Perspectives and Principles, Second Edition, Cambridge University Press, 2009.

9. Yulchon LLC, National Assembly Passes Bill to Amend the Debtor Rehabilitation and Bankruptcy Act, May 19 2016.

10. Corporate Restructuring Promotion Act, 2007.

11. Debtor Rehabilitation and Bankruptcy Act, 2005.

12. Globe Business Media Group, http://www.lexology.com

13. Oxford Dictionaries, https://en.oxforddictionaries.com

http://www.investopedia.com/

14. Franz Aleth and Nils Derksen, Restructuring and Insolvency, 2015, p.170. http://www.freshfields.com/uploadedFiles/SiteWide/Campaigns/R_and_I/Content/Germany%202014.pdf

15. Weil, Comparative guide to Restructuring Procedures 2012, p.72.

16. Stephen Halladay, Peter Jark, Summary of German Insolvency law, 2012, p.8. https://www.dlapiper.eom/~/media/Files/Insights/Publications/2012/05/Summary%20of%20t he%20German%20Insolvency%20Law%20Booklet/Files/2_Edition_German_Insolvency_Booklet_ May%202012/FileAttachment/2_Edition_German_Insolvency_Booklet_May%202012.PDF.

17. Mayor Brown, Germany Insolvency Law-overview, 2016.

18. http://www.gesetze-im-internet.de/englischJnso/englischJnso.pdf

19. https://www.dlapiper.eom/~/media/Files/Insights/Publications/2012/05/Summary%20of%20the%20 German%20Insolvency%20Law%20Booklet/Files/2_Edition_German_Insolvency_Booklet_May%2 02012/FileAttachment/2_Edition_German_Insolvency_Booklet_May%202012.PDF p. 19.

20. https://www.iiiglobal.org/sites/default/files/annerosetashiro.pdf

21. https://www.lw.com/thoughtLeadership/pre-packaged-insolvencies-on-the~rise-in- germany-evaluating-the-german-esug

22. Schultze and Braun, Germany Insolvency Law. https://www.schubra.de/downloads/broschueren/0027_en.pdf

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН www.nli.gov.mn

23. https://www.noerr.com/en/newsroom/News/new-german-bonds-act-options-for- bondholders-in-case-of-issuer%E2%80%99s-crisis.aspx

24. Franz Aleth and Nils Derksen, Restructuring and Insolvency, 2015. http://www.freshfields.com/uploadedFiles/SiteWide/Campaigns/R_and_I/Content/Germany %20 2014.pdf

25. Insolvency statute, section 13, http://www.gesetze-im- internet.de/englisch_inso/englisch_inso.pdf

26. https://www.lw.com/thoughtLeadership/pre-packaged-insolvencies-on-the-rise-in- germany-evaluating-the-german-esug

---o0o---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ГААЛИЙН БАЙГУУЛЛАГА, ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ЗАРИМ АСУУДАЛ[1]

УДИРТГАЛ

Аливаа улсын гаалийн байгууллага нь тухайн улсын хилээр нэвтэрч буй бараа, бүтээгдэхүүн, тээврийн хэрэгсэл, зорчигчид хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу татвар тогтоох, хураах, гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил илрүүлэх, улсын төсвийн тодорхой хувийг бүрдүүлэхээс гадна улс орны үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдал, нийгмийн эрүүл мэндийг сахин хамгаалахад онцгой үүрэг гүйцэтгэдэг бөгөөд энэхүү үүргээ хэрэгжүүлэхэд мэргэжил туршлагатай, чадварлаг боловсон хүчинтэй байх шаардлага зайлшгүй тавигддаг учир тэдгээрийг бэлтгэх, мэргэшүүлэх асуудлыг хариуцдаг.

Даяарчлалын орчин үед улс орнуудын дундах хил хязгаар бүдгэрч, дэлхийн орнуудын эдийн засаг, нийгэм, соёлын хамтын ажиллагаа, харилцан хамаарал өмнөх үетэй харьцуулахад шинэ шатанд гарч, XXI зууны гаалийн байгууллагын үүрэг, хариуцлага, сэтгэлгээг үндсээр нь өөрчлөх хэрэгцээг үүсгэж байна. Улс орнуудын хооронд гадаад худалдаа, аялал жуулчлал хөгжихийн хэрээр гаалийн байгууллагын үүрэг, оролцоо улам нэмэгдэж байна. Иймд өргөжин тэлж буй гадаад худалдааны орчинд нийцүүлэн худалдааг хөнгөвчлөх, түргэн шуурхай, ил тод, хүнд сурталгүй үйлчилгээг нэвтрүүлэх, улмаар гаалийн байгууллагыг авилга, албан тушаалын дарамтгүй болгох шаардлага улам бүр нэмэгдэж байгаатай холбогдуулан дэлхийн улс орнууд энэ чиглэлээр хамтран ажиллах, олон улсын төвшинд нэгдмэл байдлаар хэрэгжүүлэх боломжтой хэм хэмжээ боловсруулан батлах, түүнд нэгдэн орох нь түгээмэл болсон. Тухайлбал, Дэлхийн гаалийн байгууллагын Зөвлөлөөс гаргасан „21 дүгээр зуунд гаалийн баримтлах бодлого", "Гаалийн бүрдүүлэлтийн горимыг хялбарчлах уялдуулах тухай" Киотогийн конвенц, "Гаалийн хамтын ажиллагааны зөвлөл байгуулах тухай конвенц" зэргийг энд дурдаж болох юм.

Өргөн уудам нутаг дэвсгэртэй, гадны импортоос ихээхэн хараат, тэр дундаа стратегийн гол нэрийн бүтээгдэхүүн, хүнсний барааны хувьд нэг орноос давамгай хамааралтай манай улсын хувьд улсын хил, хилийн боомтуудаар гадаад, дотоод руу нэвтрэх ачаа бараа, бүтээгдэхүүн, түүхий эд, тээврийн хэрэгсэл, зорчигчид хяналт тавих, гаалийн татвар тогтоох, хураах болон гаалийн холбогдолтой бусад үйл ажиллагааг улсын хэмжээнд 1200 орчим албан хаагчтай Гаалийн байгууллага гүйцэтгэж байна. Тус байгууллагын үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх, нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай хүчин зүйлийн нэг бол эрх зүйн орчныг боловсронгуй болгох явдал юм.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд 2008 онд шинэчлэгдэн баталсан Гаалийн тухай хууль хэрэгжээд 10 жил болж байна. Энэ хугацаанд эдийн засаг, нийгэм, техник, технологийн төвшинд ихээхэн дэвшил, өөрчлөлт гарсныг харгалзан 2017 онд Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулж байна. Энэхүү ажлын хэрэгцээнд зориулан Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс Гаалийн ерөнхий газрын захиалгаар "Гаалийн байгууллага, гаалийн улсын байцаагчийн эрх зүйн байдлын зарим асуудал" сэдэвт харьцуулсан судалгааг гүйцэтгэв.

[1] Энэхүү судалгааг ГЕГ-ын захиалгаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ж.Бариаширсүрэн, Б.Сүнжидмаа нар хамтран гүйцэтгэв. Судалгааны ажлын зөвлөхөөр ХЗҮХ-ийн захирал С.Энхцэцэг, Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор, профессор Д.Зүмбэрэллхам нар ажиллав.

Судалгааны ажлын зорилго

“Гаалийн байгууллага, гаалийн улсын байцаагчийн эрх зүйн байдлын зарим асуудал**”** харьцуулсан судалгааны ажлын зорилго нь Гаалийн ерөнхий газраас ирүүлсэн захиалгын дагуу Монгол Улсын гаалийн байгууллагын үйл ажиллагааг олон улсын стандарт, чиг хандлагад нийцүүлэх, гаалийн харилцаатай холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажилд зориулан гадаад орнуудын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийж тодорхой дүгнэлт, санал боловсруулж хүргүүлэхэд оршино.

Судалгааны ажлаар эрх зүйн тогтолцоо, эдийн засаг, нийгмийн хөгжлийн төвшинг харгалзан үзсэний үндсэн дээр Азийн орнуудаас Шинэ Зеланд, Бүгд найрамдах Солонгос Улс, Зүүн европын орнуудаас Унгар улсыг тус тус сонгон авч эдгээр орнуудын хууль тогтоомжид гаалийн байгууллагатай холбоотой дараахь асуудлуудыг хэрхэн зохицуулсныг харьцуулан судлав. Үүнд:

1. Гаалийн байгууллагын статус:
- чиг үүрэг;
- бүтэц;
- зохион байгуулалт.
2. Гаалийн улсын байцаагчийн эрх зүйн байдал:
- цолны схем;
- эрх, үүрэг;
- ёс зүйн хэм хэмжээ;
- сахилгын шийтгэл;
- гаалийн албанд томилох, чөлөөлөх, халах үндэслэл;
- албан тушаалын ангилал;
- зэрэг, дэв;
- эрхийн болон эдийн засгийн баталгаа.

Судалгааны арга зүй

Судалгааг судлаачид хараат бус, бие даасан байдлаар шинжлэх ухааны арга зүйг баримтлан, баримт бичгийн судалгааны арга, харьцуулалтын арга, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргыг ашиглан явуулсан бөгөөд судалгааны дүгнэлт, саналыг зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон үр дүнд үндэслэн боловсруулж гаргалаа.

Судалгааны хүрээ

“Гаалийн байгууллага, гаалийн улсын байцаагчийн эрх зүйн байдлын зарим асуудал” харьцуулсан судалгааны ажлын хүрээнд сонгон авсан гадаад орнуудын гаалийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг өөрийн орны эрх зүйн зохицуулалттай харьцуулан судалж, гаалийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг болон гаалийн улсын байцаагчийн эрх зүйн байдлын зарим онцлог зохицуулалтыг түүвэрлэн судаллаа.

ҮНДСЭН СУДАЛГАА

НЭГ. ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ

Судалгааны ажлын хүрээнд сонгон судалсан гадаад орнуудын эрх зүйн баримт бичигт хийсэн судалгаанаас харахад гаалийн байгууллагын хариуцах салбар, чиглэлийг дараахь үндсэн гурван хувилбарт ангилж болохоор байна. Гаалийн байгууллага

1. зөвхөн гаалийн үйл ажиллагаатай холбоотой чиг үүрэг гүйцэтгэдэг /Монгол, Солонгос/;

2. татварын болон гаалийн үйл ажиллагаатай холбоотой чиг үүрэг гүйцэтгэдэг /Унгар/;

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭЛ www.ulj.gov.mn

3. гаалийн болон хилийн хяналтын үйл ажиллагаатай холбоотой чиг үүрэг хэрэгжүүлдэг /Шинэ Зеланд/ байна.

Судалгаанд дээрх чиглэлээс зөвхөн гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хамаарах үндсэн чиг үүргүүдийг сонгон судаллаа.

Гадаад орнуудын туршлагаас харахад гаалийн байгууллага нь улсын хилээр нэвтрэх зорчигч болон импорт, экспортын бараанд хяналт тавих, гаалийн татвар хураах замаар төсвийн орлого бүрдүүлэх, нийгэм, эдийн засаг, эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргээс гадна гаалийн үйл ажиллагаатай холбоотой бүртгэл, мэдээлэл хөтлөх, боловсруулах, мэдээллээр хангах, мэдээллийн технологи, програм хангамжийг хөгжүүлэх, хянах, хууль сахиулах, соён гэгээрүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулдаг байна.

Гадаад орнуудын гаалийн байгууллагаас хэрэгжүүлж буй хамгийн чухалд тооцогдох чиг үүргийн нийтлэгийг авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Хууль бус импортын бараатай тэмцэх замаар дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах;
- Нийгэм, эдийн засаг, эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах зорилгоор нэвтрүүлэх ажиллагаанд хяналт тавих,
- Экологийн тэнцвэрт байдал болон байгаль орчныг хамгаалах зорилгоор хилээр химийн хорт бодис болон ховор ургамал/амьтныг хилээр нэвтрүүлэх асуудлыг хянах;
- Шударга өрсөлдөөнийг хамгаалах үүднээс оюуны өмчийн эрх болон бараа, бүтээгдэхүүний гарал үүслийн байдалд хяналт тавих;
- Хууль бус мөнгөний урсгал гүйлгээ болон гадаад валютын гүйлгээний эргэлтэд хяналт тавих;
- Улсын төсөв бүрдүүлэгч байгууллагын хувьд төсвийн орлого бүрдүүлэхтэй холбоотой үүргийн хүрээнд татвар, гааль, мөнгөний гүйлгээний мэдээ, мэдээллийг нэгтгэх, боловсруулах;
- Гаалийн холбогдолтой гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, тэдгээрийг мөрдөн шалгах, хариуцлага хүлээлгэх, урьдчилан сэргийлэх;
- Төсвийн болон улсын орлогод гэмт хэргийн улмаас үүссэн хохирлыг барагдуулахад чиглэсэн нэхэмжлэлийг төрийн нэрийн өмнөөс гаргах;
- Байнгын албан хаагчдад зориулсан сургалт, давтан сургалт зохион байгуулах, сургалтын сэдвийг тогтоох;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, мөн эдгээрээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах.

Үүнээс харахад гаалийн байгууллага нь улсын хилээр нэвтэрч буй ачаа бараа, зорчигчид хяналт тавих, татвар тогтоох, хураах замаар төсвийн орлого бүрдүүлдэг бол гаалийн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, гаалийн байгууллага, үйл ажиллагаатай холбоотой бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, олон улсын хэмжээнд хил дамнасан байдлаар үйлдэгддэг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, хил дамнасан худалдааны залилан/луйвартай тэмцэх, мөнгөний эргэлтэд хяналт тавих, оюуны өмчийг хамгаалах, хонжворт тоглоомын төрөлд хамаарах үйл ажиллагааг хянах, боловсон хүчний хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, тэднийг бэлтгэх зэрэг чиг үүргийг давхар хэрэгжүүлж байна. Эдгээр чиг үүргийг гаалийн байгууллагад хариуцуулах нь нэгдүгээрт энэ төрлийн мэдээллийн сан бүрдүүлэх бүрэн боломжтой байгууллага болохын хувьд, хоёрдугаарт гаалийн байгууллага энэ төрлийн мэдээллээр цаг тутам хангагдаж байх нь тэдний зүгээс хэрэгжүүлж буй хяналт, шалгалтыг үр нөлөөтэй болгохын сацуу ялангуяа гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй ачаа бараа, мөнгө, зорчигчийг улсын хилээр нэвтрүүлэхгүй

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.ulii.gov.mn

байх арга хэмжээ авах боломжтой болох ба үүгээрээ улс орны нийгэм, эдийн засаг, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх ажил болдог байна.

ХОЁР. ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Гаалийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтын талаар гадаадын зарим орны туршлагаас судлахад судлагдсан орнуудын гаалийн байгууллага Санхүү, эдийн засгийн яам буюу улсын төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд үйл ажиллагаа явуулж байна.

Гаалийн байгууллагыг дийлэнх тохиолдолд дарга/ерөнхий захирал, түүний орлогч/дэд дарга мэргэжлийн шууд удирдлагаар хангаж ажилладаг байна. Харин Шинэ Зеландын гаалийн байгууллагыг Гүйцэтгэх зөвлөл удирддаг бөгөөд зөвлөлийг Гаалийн ерөнхий дарга удирддаг[2]. Энэ нь хамтын удирдлага гэдгээрээ онцлог байна.

Гаалийн байгууллагын хариуцаж буй салбар, чиглэл, үйл ажиллагааны үндсэн чиглэлээс хамааран бүтцийн хувьд харилцан адилгүй хэмжээтэй байна. Тухайлбал, Монгол Улс[3], БНСУ[4] зөвхөн гаалийн асуудал хариуцсан бие даасан байгууллагатай байх ба эдгээрийн бүтцэд хамаарах газар нэгжийн тоо цөөн, харин татвар, хилийн хяналтыг давхар хариуцдаг Унгар улс[5] болон Шинэ Зеландын гаалийн байгууллага том бүтэцтэй, олон газар, хэлтэстэй байна.

Судалгааны дүнгээс харахад гаалийн байгууллага нь удирдлагын босоо тогтолцоотой, анхан, дунд, дээд шатны байгууллагатай, ихэнх тохиолдолд гаалийн хяналт тавих, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, хууль сахиулах чиглэлээр ажилладаг байна. Гаалийн хяналтыг хэрэгжүүлэх явцдаа хууль сахиулах, гаалийн хэрэг, зөрчлийг шалгах, түүнийг мөрдөх, илрүүлэх ажиллагаа явуулах эрхтэй, энэ чиглэлийн үйл ажиллагааг илүү түлхүү хөгжүүлсэн хандлага ажиглагдаж байна. Үүний зэрэгцээ гаалийн байгууллага, үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, дүрэм журмыг сурталчлах, үйлчлүүлэгчдийн мэдлэгийг дээшлүүлэх, хууль тогтоомж зөрчихөөс урьдчилан сэргийлэх ажиллагаа явуулахад илүү анхаарч ажилладаг. Мөрдөн шалгах ажиллагаа хариуцсан газар ихэнхдээ гаалийн байгууллагын дарга эсхүл ерөнхий газрын шууд удирдлага, хяналтад үйл ажиллагаа явуулдаг бөгөөд мөнгө угаах, хил дамнасан залилан/луйврын гэмт хэрэгтэй тэмцэх зэрэг олон улсын хэмжээний асуудлыг хариуцдаг байна.

Гаалийн байгууллагын дарга эсхүл удирдах газрын шууд удирдлага дор гаалийн зөрчилтэй тэмцэх чиг үүрэг бүхий нэгжээс гадна албан хаагчдын сургалт, эрүүл мэнд, нийгмийн асуудлыг болон мэдээллийн технологи, програм хангамжийг хөгжүүлэх асуудал хариуцсан хүрээлэнгүүд харьяалагддаг байна.

Судлагдсан гадаад орнуудын гаалийн байгууллагын бүтцийг ерөнхийд нь харахад гаалийн байгууллагуудад дараахь бүтцийн нэгжүүд нийтлэг гэж үзэхээр байна. Үүнд:

- Гаалийн хяналт, шалгалт, бүрдүүлэлт хариуцсан;
- Гаалийн хэрэг, зөрчлийг шалгах, мөрдөх, шийдвэр гүйцэтгэх, өр барагдуулах; хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх асуудал хариуцсан;
- Гаалийн мэдүүлэг, татвар, харилцах данс, санхүү, татварын чиглэлийн асуудал хариуцсан;
- Эрх зүй, координаци, давхар шалгалт, давж заалдах, стратеги төлөвлөлт, гадаад харилцаа зэрэг бодлогын асуудал хариуцсан;

[2] Шинэ Зеландын гаалийн байгууллагын талаарх судалгааг Хавсралт №4-өөс үзнэ үү.

[3] Монгол Улсын гаалийн байгууллагын талаарх судалгааг Хавсралт №1-ээс үзнэ үү.

[4] Солонгос улсын гаалийн байгууллагын талаарх судалгааг Хавсралт №3-аас үзнэ үү.

[5] Унгар улсын гаалийн байгууллагын талаарх судалгааг Хавсралт №2-оос үзнэ үү.

- Мэдээллийн технологи, системийн хяналт, програм хангамж зэрэг асуудал хариуцсан;
- Хүний нөөц, сургалт, судалгаа, албан хаагчдын эрүүл мэнд, нийгмийн асуудал хариуцсан;
- Аж ахуй, хангамж үйлчилгээ, эд мөрийн баримт болон гаалийн бараа бүтээгдэхүүний агуулах байр, хадгалалт зэрэг асуудал хариуцсан;
- Төсөл, хөтөлбөр хариуцсан;
- Эрсдлийн удирдлага, мөнгөний урсгал, гадаад валютын хөдөлгөөн зэрэг асуудал хариуцсан.

Судлагдсан орнуудын гаалийн байгууллагууд хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх ажиллагаанд илүү төвлөрсөн бүтэц, зохион байгуулалттай байгаа бол манай улсад төсвийн орлого бүрдүүлэх буюу санхүү, татварын асуудалд илүү төвлөрсөн бүтэцтэй байна.

Гадаад орнуудын гаалийн байгууллагын бүтцийн зарим нэгжийн үйл ажиллагааны онцлогыг ач холбогдлыг нь харгалзан тусгайлан авч үзлээ.

1. Мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгжүүд нь програм хангамжийн тасралтгүй, баталгаатай, аюулгүй байдлыг хангаж ажиллахаас гадна энэ чиглэлийн програм хангамжийг хөгжүүлэх, мэдээлэл боловсруулах арга хэлбэрийг хөнгөвчлөх, бусад санхүү, гаалийн системийг боловсронгуй болгох, сургалт зохион байгуулах ажлыг хариуцдаг.

2. Гаалийн байгууллагын харьяанд ажиллаж буй хүрээлэнгүүд нь програм хангамж, мэргэжлийн шинжилгээ, албан хаагчдын эрүүл мэнд, нийгмийн асуудал, гаалийн үнэлгээ, ангилал тогтоох чиглэлээр үйл ажиллагаа явуулах бөгөөд хэд хэдэн хүрээлэнтэй байдаг байна. Эдгээр хүрээлэнгүүд нь тухайн байгууллагын үйл ажиллагааг хэвийн, баталгаатай явуулах үүднээс шаардлагатай шинжилгээ, судалгаа хийх, байгууллагын үйл ажиллагааг хөгжүүлэх, ашиглагдаж буй програм хангамж, мэдээллийн сан зэргийг боловсронгуй болгох, албан хаагчдын эрүүл мэнд, нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиг үүрэгтэй ажилладаг байна. Тухайлбал, Унгар улсын Сургалт, эрүүл мэнд, соёлын хүрээлэн нь Унгарын Үндэсний татвар, гаалийн албаны сургалт, хүний нөөцийн ур чадварыг хөгжүүлэх асуудлыг бүхэлд нь хариуцах үүргийг хуулиар хүлээсэн. Хүрээлэн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт, үргэлжилсэн сургалт зохион байгуулах, албан хаагчдад эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн болон бие бялдрын, сэтгэцийн байдлыг шалгах болон тэдний соёл, амралттай холбоотой арга хэмжээг хариуцдаг байна. Сургалт зохион байгуулах ажлын хүрээнд мэргэжлийн албан хаагчдыг бэлтгэх сургалт, мөн суурь болон мэргэшүүлэх сургалт, дунд шатны сургалтыг танхимын болон алсын зайны сургалтын хэлбэрээр зохион байгуулж шалгалт авдаг байна. Сургалтыг хяналт шалгалт, шийдвэр гүйцэтгэл, харилцагчтай харилцах, хүний нөөцийн бодлого зэрэг ерөнхий салбар чиглэлээр зохион байгуулдаг бөгөөд эдгээр нь нарийвчлагдсан сэдвүүдэд задардаг байна.

3. Төсөл хөтөлбөр хариуцсан нэгж нь гаалийн байгууллагын үйл ажиллагааны хэтийн, дунд хугацааны, ойрын төлөвлөгөөнд нийцсэн олон улсын болон гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрийг судлах, төслийн материал бэлтгэж өгөх, хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг зохион байгуулах, хяналт тавих, төслийн хэрэгжилтийн үр дүнг тайлагнах зэрэг ажиллагааг хариуцдаг. Зарим улсад энэ нэгж хэрэгжүүлж буй төслийг заавал амжилттай дуусгах, төлөвлөсөн ажлыг бүрэн хэрэгжүүлэх хариуцлага хүлээдэг байна.

4. Эрсдлийн удирдлага, мөнгөний урсгалын асуудал хариуцсан нэгж нь улсын хэмжээнд мөнгөний урсгалын бүртгэл хөтлөх, мөнгөний урсгалыг хөгжүүлэх үйл

ажиллагааг дэмжих, мэдээллийн сангийн аюулгүй байдал, Эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх, мэдээллээр хангах, гадаад цахим орчин дахь сүлжээг хөгжүүлэх асуудлыг хариуцдаг.

5. Хэрэг бүртгэх, мөрдөн шалгах чиг үүрэг бүхий нэгж нь гаалийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, мөрдөн шалгах эрхтэй. Тухайлбал, Унгарт Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд заасан гаалийн байгууллагын мөрдөн шалгах албанд харьяалах хэргийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг, хэрэг зөрчил илрүүлсэн тохиолдолд анхан шатны шийдвэр гаргах, шаардлагатай тохиолдолд галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх эрхтэй байдаг байна. Энэ нэгжид ажиллаж буй албан хаагчид хууль сахиулах чиг үүрэг гүйцэтгэдэг, төрийн тусгай албан хаагчид байдаг.

ГУРАВ. ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

Гаалийн байгууллагын албан хаагчийн эрх зүйн байдал, ёс зүйн дүрэм, албан тушаалын ангилал, зэрэг дэв, цол, сахилгын шийтгэл зэрэг асуудлыг Унгар, Солонгос, Шинэ Зеланд орны эрх зүйн баримт бичгүүдээс судлах явцад зарим зохицуулалт, ялангуяа цол, зэрэг дэвийн тухай, гаалийн албанд томилох, чөлөөлөх тухай зохицуулалт олдоц муутай, судалгаанд ашигласан хэл дээр олдохгүй байсан зэрэг хүндрэл гарч байлаа.

Баримт бичгийн судалгааны аргаар хийгдэж буй энэхүү харьцуулсан судалгааны хүрээнд энэ асуудалтай холбоотой олдсон мэдээлэлд дүн шинжилгээ хийснээр дараахь нийтлэг байдлыг тогтоолоо.

Албан хаагчийн эрх, үүрэг

Монгол Улсын гаалийн улсын байцаагч Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн нийтлэг эрхээс гадна Гаалийн тухай хуульд заасан бусад эрх эдэлнэ. Үүнд: гаалийн хяналт тавьж, бүрдүүлэлт хийх, гаалийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор иргэн, албан тушаалтанд хууль ёсны шаардлага тавьж биелэлтийг хангуулах, гаалийн бүрдүүлэлттэй холбоотойгоор байр, агуулахад нэвтрэн орж үзлэг тооллого хийх, тэдгээрийн данс, бүртгэлийг шалгах, шаардлагатай мэдээлэл, тайлбар, лавлагааг холбогдох этгээдээс гаргуулах, гаалийн зөрчилтэй холбоотой баримт, материалыг түр хугацаагаар хураах, эсхүл хуулбарлуулан авах, албан үүргээ гүйцэтгэх үед улсын хилийн хориотой зурваст нэвтрэх, гаалийн хууль тогтоомж зөрчсөн захиргааны зөрчилд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх эрхтэй байна. Харин төрийн албан хаагчийн нийтлэг үүргээс гадна өргөсөн тангарагтаа үнэнч байх, гаалийн хяналт, шалгалтыг хийхдээ сонор сэрэмжтэй байж, төр, байгууллага болон хувь хүний нууцыг чанд хадгалж, хувь хүний нэр хүндийг гутаахгүй байх; гаалийн хяналт, бүрдүүлэлтийг хийхдээ төр, байгууллага, хувь хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироохгүй, албан тушаалаа урвуулан ашиглахгүй, хэтрүүлэхгүй байх; гаалийн хууль тогтоомжийг зөрчсөн хууль бус үйлдэл /эс үйлдэхүй/-ийн талаар зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлэх; мэргэшүүлэх сургалтад хамрагдах; гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрмийг чанд сахиж ажиллах гэсэн үүрэг хүлээдэг.

Солонгосын гаалийн байгууллагын албан хаагчдыг хууль тогтоомжид заасны дагуу гүйцэтгэж буй ажил үүргийн онцлог шинжээс хамааран хууль сахиулагчаар эсхүл төрийн захиргааны албан хаагчаар томилох бөгөөд албан тушаалын ангилалдаа нийцсэн эрх эдэлж, үүрэг хүлээдэг. Солонгосын гаалийн байгууллагын Аудитын бодлого зохицуулах товчоо, Мөрдөн шалгах, хяналт шалгалтын товчоо

Хэвлэсүүний хяналтын албаны www.ikh.gov.mn

болон Мэдээллийн менежмент болон гадаад харилцааны товчоонд ажиллаж буй албан хаагчид нь хууль сахиулах чиг үүрэг хэрэгжүүлдэг тул энд алба хааж буй албан хаагч хууль сахиулагчийн нийтлэг эрх, үүргийг хэрэгжүүлдэг.

Унгар улсын ҮТГА-ны албан хаагчид гүйцэтгэж буй ажил ангилалд нийцүүлэн Нийтийн үйлчилгээний төрийн албан хаагчийн тухай хууль[6], Хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын байнгын албан хаагчдын үйл ажиллагааны эрх зүйн харилцааны тухай хууль[7] болон Хөдөлмөрийн тухай хууль[8]-д заасан эрх, үүргийг эдэлж, хариуцлага хүлээдэг байна[9].

Үүнээс гадна Солонгосын жишээнээс харахад албан хаагчдад хариуцаж буй ажлыг чиг үүргээс хамааран 1-9 хүртэлх зэрэг олгодог бөгөөд энэ нь албан хаагчдын ур чадвар, ажлын туршлага, ажилласан жилийг харгалзан зэрэг олгох замаар албан хаагчдыг эрх зүйн болон эдийн засаг, нийгмийн баталгааг хангаж, улмаар гаалийн байгууллага тогтвортой боловсон хүчинтэй байх боломжийг бүрдүүлдэг гэж үзэж болох байна.

Дээрхээс харахад гаалийн байгууллагын албан хаагчдын албан тушаалын ангилал нь хариуцаж буй ажил үүргээс хамааран харилцан адилгүй байна. Иймд гаалийн байгууллагын албан хаагчдыг гүйцэтгэж байгаа ажил үүргээс нь хамаарч төрийн захиргааны, төрийн үйлчилгээний албан тушаалд томилж тус бүрт нь зохих эрх үүргийг хүлээлгэдэг нийтлэг хандлага байна.

Иймд гаалийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, чадварлаг боловсон хүчнээр хангах, нэгэнт бэлтгэгдэж, дадлагажсан албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах үүднээс гадаад орнуудын сайн туршлагаас судлан албан хаагчдын зэрэг дэвийн тогтолцоонд зарим өөрчлөлт оруулах, мөн хариуцах ажлын чиг үүргээс хамааран төрийн тусгай, төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалд томилж ажлуулах нь байгууллагын үйл ажиллагаа, залгамж чанарт эерэг үр нөлөө үзүүлэх боломжтой юм.

Албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ

Гаалийн байгууллагын албан хаагчийн ёс зүйтэй холбоотой зохицуулалтаас харахад судлагдсан орнуудад нийтлэг байдлаар тавигддаг хэд хэдэн шаардлага, зарчим байна. Үүнд: ажил үүрэгтээ үнэнч байх, үндэсний эрх ашгийг эхэнд тавих, шударга байх, намын харьяалалгүй байх, хариуцлагатай байх, мэргэшсэн байх, төвийг сахих, тэгш хандах зэргийг дурдаж болох юм. Ерөнхийдөө гаалийн албан хаагч шударга, мэргэжлийн ур чадвартай, хувийн ашиг сонирхлыг илүүд үзэхгүй, хөндлөнгийн нөлөөлөлд автахгүйгээр хүн бүртэй адил тэгш хандаж, ажил үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх, үйл ажиллагааны явцад бусдын нэр хүндэд хор учруулахгүй байхыг шаарддаг байна.

Албан хаагчийн сахилгын шийтгэл

Монгол Улсад гаалийн улсын байцаагч албан үүрэгтээ хайнга хандсан, эсхүл Гаалийн тухай хуулийн хууль тогтоомжид тусгаснаас өөр бичиг баримт мэдүүлэгчээс шаардах болон бусад хэлбэрээр бүрэн эрхээ хэтрүүлсэн, түүнчлэн гаалийн хууль тогтоомж, өргөсөн тангаргаа зөрчсөн тохиолдолд сануулах, зэрэг дэвийг 1 жил хүртэл хугацаагаар бууруулах, албан тушаалыг 3 сар хүртэл хугацаагаар бууруулах,

[6] A közszolgálati tisztviselőkről szóló 2011. évi CXCIX. törvény

[7] a rendvédelmi feladatokat ellátó szervek hivatásos állományának szolgálati jogviszonyáról szóló 2015. évi XLII. törvény

[8] a munka törvénykönyvéről szóló 2012. évi I. törvény

[9] Үндэсний татвар, гаалийн албаны Бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны дүрмийн 79. §

гаалийн албанаас халах хүртэл сахилгын шийтгэлийг[10] ногдуулна. Гаалийн улсын байцаагчийн сахилгын дүрмийг Засгийн газар батлахаар[11] зохицуулсан байна.

Гадаад орнуудын туршлагаас харахад ерөнхийдөө гаалийн байгууллагын албан хаагчийн албан тушаалын ангилалд хамаарах хууль тогтоомжид заасан сахилгын шийтгэл ногдуулах бөгөөд үүнээс гадна гаалийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжид тусгайлсан зохицуулалтыг нэмж тусгаж өгсөн байна.

Тухайлбал, Унгар улсад сахилгын зөрчил гаргасан гаалийн албан хаагчид сануулах, цалингийн шатлал ахиулах хугацааг 6 сараас 2 жил хүртэлх хугацаагаар хойшлуулах, цалингийн шатлалыг 1-ээс 2 жил хүртэлх хугацаагаар бууруулах, цалингийн нэмэгдлийг хасах, албан тушаалын зэрэглэлийг 6 сараас 2 жил хүртэлх хугацаагаар нэг шатлал бууруулах /зөвхөн гаалийн улсын байцаагчийн хувьд/, цол хураах, удирдах албан тушаалтныг огцруулан энгийн ажилд томилох, төрийн албан хаагчийн ангилалд багтах албан хаагчийг ажлаас халах, гаалийн улсын байцаагчийг гаалийн албанаас чөлөөлөх хүртэл сахилгын арга хэмжээ авдаг. Гэхдээ сахилгын зөрчлийг сэтгэцийн өөрчлөлтөд орсон үедээ, хүчирхийлэл, заналхийллийн нөлөөгөөр, аргагүй хамгаалалт хийхээр, зайлшгүй шаардлагаар, андуурсан тохиолдолд гаргасан бол сахилгын шийтгэл хүлээлгэхгүй байхаар хуульчилжээ.

Сахилгын шийтгэлийг ажил олгогчийн эрх эдэлж буй, эсхүл энэ эрхийг шилжүүлэн авсан удирдах албан тушаалтан ногдуулна. Энэ эрхийг шилжүүлж авсан удирдах албан тушаалтан өөр удирдах албан тушаалтанд дамжуулан шилжүүлэх эрхгүй байдаг. Сахилгын шийтгэл хүлээлгэх тухай шийдвэрийг ихэнх тохиолдолд сахилгын хороо гаргах ба үндэслэл бүхий шийдвэрээ бичгээр үйлдэнэ. Сахилгын шийтгэл хүлээлгэх хэрэг, зөрчил гаргасныг илрүүлснээс хойш 3 сар, зөрчил гарснаас хойш 3 жил өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулахгүй.

Гадаад орнуудын туршлагаас харахад ажил үүргээ гүйцэтгэх хугацаандаа зөрчил гаргасан албан хаагчид оногдуулах сахилгын шийтгэлийн төрөл манай улсынхаас харьцангуй олон төрөлтэй байна. Энэ нь санаатай болон санаандгүй үйлдлийн улмаас гаргасан зөрчилд ногдуулж буй шийтгэл нь дийлэнхдээ цалин, урамшууллын хэмжээ, зэрэг дэв, цол бууруулах шинжтэй байгаа нь удаан хугацаанд бэлтгэж мэргэшүүлсэн мэргэжлийн албан хаагчийг алдахгүй байх, тэдний хариуцлагыг чангатгах, анхаарал сэрэмжийг нэмэгдүүлэх зорилготой байна. Сахилгын шийтгэлийн хугацаа харьцангуй уян хатан байгаа нь онцлог байлаа.

Дээрхээс харахад гаалийн улсын байцаагчийн эдийн засаг, нийгмийн баталгааг тодорхой болгох, сайжруулах нь гаалийн байгууллагын нэр хүндийг дээшлүүлэх, үйл ажиллагааны чанар, төвшинг нэмэгдүүлэхийн зэрэгцээ тус байгууллагын авилгын эрсдлийг бууруулах үр нөлөөтэй юм. Мэдээж эдийн засаг, нийгмийн баталгааг сайжруулахын хэрээр гаалийн байгууллагын албан хаагчаас хүлээх мэдлэг, ур чадвар, ёс зүй, хариуцлагын хэмжээ, шалгуур үзүүлэлт өндөр байдаг туршлага ажиглагдаж байна.

Албан хаагчийг гаалийн албанд томилох, чөлөөлөх, халах үндэслэл

Шинэ Зеландын гаалийн байгууллагад ажиллах хүсэлтэй этгээд ажилд орох хүсэлтээ илэрхийлсэн өргөдөл гаргана. Өргөдлийг шалгаж, ажилд ороход тавигдах шаардлага хангасан этгээдийг 9 долоон хоногийн сургалтад хамруулах бөгөөд энэ хугацаанд дадлагажигчаар ажиллана. Хэрэв сургалтын хөтөлбөрийг амжилттай дүүргэвэл тухайн этгээдийг гаалийн байгууллагын албан хаагчаар томилж, тангараг

[10] Хуулийн 284 дүгээр зүйл

[11] Хуулийн 284.3 дугаар зүйл

өргөснөөр ажиллаж эхэлдэг байна.

Унгар улс Үндэсний татвар, гаалийн албаны тухай хууль тогтоомждоо уг албанд томилох, чөлөөлөх, сэлгэн ажиллуулах асуудлыг зохицуулсан байна. ҮТГА-нд албан хаагчаар зөвхөн тус байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд хариуцсан асуудлын аль нэг чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн этгээдийг авах тухай зохицуулсан байна[12]. Харин түүнийг мэргэжүүлэх асуудлыг хуулиар ҮТГА-нд даалгасан. Удирдах албан тушаалд томилоход тавигдах шаардлагыг албан тушаалын шатлал тус бүрээр боловсролын байдал, мэргэшсэн байдал, ажлын туршлага зэргийг нарийвчлан зохицуулжээ.

Тус албанд томилох, чөлөөлөх, зэрэг дэв, цол нэмэх/хасах зэрэг асуудал болон ажил олгогчийн эрхийг тухайн албан хаагчийн хариуцан ажиллаж буй удирдах албан тушаалтан ҮТГА-ны даргаас шилжүүлэн өгсөн эрхийн хүрээнд шийдвэрлэнэ[13]. Хэрэв нэг албан хаагчтай холбоотой хэд хэдэн удирдах албан тушаалтны шийдвэр гарсан бол хамгийн өндөр албан тушаалтны гаргасан шийдвэрийг хэрэгжүүлдэг байна[14]. Сахилгын хорооноос ажлаас халах тухай шийдвэр гаргана. Энэ шийдвэрийн эсрэг гомдол гаргаагүй, давж заалдах өргөдөл гаргаагүй тохиолдолд уг шийдвэрийг 15 хоногийн дотор биелүүлэх үүрэгтэй байна.

Судалгаанаас харахад гаалийн албанд томилох, чөлөөлөх, халах асуудлыг тухайн албан хаагчийн ажил олгогч удирдах албан тушаалтан шийдвэрлэнэ. Аливаа этгээдийг гаалийн албанд томилохоос өмнөх шалгуур харьцангуй өндөр байна. Тухайлбал, зарим улсад тодорхой хугацаагаар сургалтад хамруулж, дадлагажигчаар ажиллуулах замаар ажил үүргээ гүйцэтгэх чадварыг ажиглаж байгаа бол зарим улсад зөвхөн тодорхой мэргэжлийн дагуу дээд боловсрол эзэмшсэн этгээдийг сонгон шалгаруулах замаар томилдог бөгөөд гаалийн байгууллагад түүнийг мэргэшүүлэх үүргийг хүлээлгэдэг. Гаалийн албанаас чөлөөлөх, халах асуудлыг тухайн албан хаагчийн албан тушаалын ангилалд хамаарах хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэдэг бол хууль сахиулах чиг үүрэг хэрэгжүүлдэг албан хаагчдын хувьд сахилгын хороо зөрчлийг шалган сахилгын арга хэмжээний хамгийн хүнд хэлбэр болох ажлаас халах шийтгэл ногдуулдаг.

Үүнээс харахад гаалийн байгууллагын албан хаагчийг сонгон шалгаруулах, томилох, зэрэг дэв нэмэх, хасах, албанаас чөлөөлөх, халах зэрэг асуудлыг нарийвчлан зохицуулсан байх бөгөөд энэ нь гаалийн байгууллага, албан хаагчийн тогтвортой, мэргэшсэн байдлыг хангах, хамгаалахад чухал нөлөө үзүүлдэг байна.

Албан хаагчийн албан тушаалын ангилал

Унгар улсын ҮТГА-ны харьяа байгууллагуудад хөдөлмөр эрхэлж буй албан хаагчдыг төрийн захиргааны албан хаагч, Засгийн газрын хэрэг эрхлэгч, хөдөлмөр эрхлэгч, байнгын үйлчилгээний гэрээт ажилтан, албан хаагч гэж ангилдаг. Албан тушаалын хувьд удирдах албан тушаалтан, 1 дүгээр зэрэглэлд хамаарах ажил үүргийн албан тушаалтан, 2 дугаар зэрэглэлд хамаарах ажил үүргийн албан тушаалтан гэж ангилна. 1 дүгээр зэрэглэлд хамаарах ажил үүргийн албан тушаалыг дотор нь „A", „B", „C", „D" „E" гэсэн 5 төрөлд, 2 дугаар зэрэглэлд хамаарах ажил үүргийн албан тушаалыг дотор нь A", „B", „C", „D" гэсэн 4 төрөлд хуваадаг. Зарим ажил үүргийг ямар албан тушаалтан хаших талаар ҮТГА-ны дарга журмаар зохицуулах эрхтэй. Харин Шинэ Зеландад гаалийн байгууллагын албан хаагчдийг

[12] Үндэсний татвар, гаалийн албаны тухай хуулийн 18/E§

[13] Үндэсний татвар, гаалийн албаны Бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны дүрмийн 68. §

[14] Үндэсний татвар, гаалийн албаны Бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны дүрмийн 69. §

гаалийн байгууллагын албан хаагч болон гаалийн байгууллагын туслах албан хаагч 2 гэж ангилдаг.

Солонгосын гаалийн байгууллагын албан хаагчдыг хууль тогтоомжид заасны дагуу тухайн ажил үүргийн онцлог шинжээс хамааран хууль сахиулагч эсхүл төрийн нийтийн албан хаагч гэж ангилдаг бөгөөд албан тушаалын ангилалдаа нийцсэн эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Солонгосын гаалийн байгууллагын Аудитын бодлого зохицуулах товчоо, Мөрдөн шалгах, хяналт шалгалтын товчоо, Мэдээллийн менежмент, гадаад харилцааны товчоо нь хууль сахиулах чиг үүрэг хэрэгжүүлэгчид тооцогддог байна.

Албан тушаалын цол, зэрэг дэв

Унгар улсад хууль сахиулах байгууллагад алба хааж буй албан хаагчдын цол үндсэн 5 ангилалд хуваагддаг бөгөөд эдгээр цол нь тус бүрдээ 3-4 төрлийн зэрэг дэв агуулсан байдаг байна. Нийт хууль сахиулах байгууллагын албан хаагчдын цолны төрөл, түүнд тавигдах шаардлага нэгэн адил байх боловч алба хашиж буй байгууллагын таних тэмдэг, тамга, тэмдгийг хэрэглэснээр өөр хоорондоо ялгагдана[15]. Хууль сахиулах байгууллагад анх ажилд орж буй этгээд цолны хамгийн эхний шатлалаас эхлэх тухай хууль тогтоомжид тусгасан байна. Цол ахиулах гол үндэслэл нь ажилласан жил бөгөөд энэ нь цалингийн шатлалтай уялдсан байдаг. Албан тушаалын цолноос гадна мэргэжлийн ур чадварт суурилсан “мэргэжлийн зөвлөх”, “мэргэжлийн ерөнхий зөвлөх” цол бас олгодог. Энэ төрлийн цол бүхий албан хаагчдын тоонд хязгаарлалт тогтоодог бөгөөд нэг байгууллагын нийт албан хаагчийн 10%-иас хэтрэхгүй байхаар тогтоосон байна.

Монгол Улсын хувьд гаалийн улсын байцаагчийн албан тушаал нь тэргүүн түшмэл, эрхэлсэн түшмэл, ахлах түшмэл, дэс түшмэл, туслах түшмэл гэсэн 5 ангилалтай байна. Үндсэн 5 ангилал тус бүртээ тэргүүн, дэд, гутгаар, дөтгөөр гэсэн зэрэг дэвтэй байна[16]. Зэрэг дэв олгохдоо төрийн албанд нийт ажилласан болон тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, мэргэшлийн төвшин, ёс зүйн хэм хэмжээг сахиж буй байдлыг харгалзана[17]. Мөн гаалийн улсын байцаагчид гаалийн жинхэнэ зөвлөх, гаалийн итгэмжит зөвлөх, гаалийн зөвлөх цол олгож болно[18] гэж заасан байна.

Судалгаанаас харахад албан тушаалын цолны ангилал, зэрэг дэвтэй холбоотой зохицуулалт харьцангуй ижил төстэй байна. Харин гаалийн байгууллагын албан хаагчид хууль сахиулах үйл ажиллагаа эсхүл төрийн захиргааны үйл ажиллагаа эрхэлж байгаагаасаа хамааран цол олгох явдал ялгаатай зохицуулалттай байна. Гаалийн байгууллагын хууль сахиулах үйл ажиллагаа явуулж буй албан хаагчдад тусгай албаны цол, захиргааны үйл ажиллагаа эрхэлж буй албан хаагчдад мэргэжлийн ур чадварыг нь үнэлсэн цол олгодог байх магадлалтай байна.

Дээрхээс харахад гаалийн байгууллагын албан хаагчдад зэрэг дэв, цол олгох асуудал нь харилан адилгүй зохицуулагдсан байна. Ерөнхийд нь дүгнэхэд гаалийн байгууллагад хууль сахиулах буюу төрийн тусгай чиг үүрэг бүхий үйл ажиллагаа эрхэлж буй албан хаагчдад цэргийн цол олгож байгаа бол төрийн захиргааны, төрийн үйлчилгээний чиг үүрэг бүхий үйл ажиллагаа эрхэлж буй албан хаагч тодорхой шаардлага хангасан тохиолдолд мэргэжлийн зэрэг дэв олгох, албан тушаалын ангилалд хамааруулах, мэргэжлийн цол олгох зэргээг ур чадвар,

[15] Мөн тэнд 15-16 §.§.

[16] **Мөн тэнд** 280.1. **дүгээр зүйл.**

[17] **Хуулийн** 280.3. **дугаар зүйл.**

[18] Хуулийн **281 дүгээр зүйл**

мэргэшсэн байдлыг нь үнэлдэг, үүний дагуу нийгэм, эдийн засгийн баталгаа нь бэхжиж байдаг сайн туршлага байна.

Албан хаагчийн эрхийн болон эдийн засгийн баталгаа

Монгол Улсын гаалийн улсын байцаагчийн цалин хөлс нь албан тушаалын үндсэн цалин, албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, эрдмийн зэргийн нэмэгдлээс тус тус бүрддэг[19].

Унгар улсад мөн адил албан тушаалын үндсэн цалин, ажилласан хугацааны нэмэгдэл, нийтийн албаны нөхөн төлбөр, зэрэг дэв, цолны нэмэгдлээс бүрддэг байна. Үүнээс гадна гадаад хэлний мэдлэг, илүү цагаар ажилласны, жижүүрийн хөлс олгодог. Нийтийн албаны нөхөн төлбөрийн хэмжээ ажлын байрны онцлог, онцгой ажиллагаанд оролцох, галт зэвсэг хэрэглэх Эрсдлийн давтамжаас хамааран үндсэн цалингийн 0-650%-тай тэнцэх хэмжээгээр тогтоох боломжтой. Ажилласан жилийн нөхөн олговрын хэмжээ 3-30 жил ажилласан хугацаанд 1-10 сарын үндсэн цалинтай дүйцэхүйц хэмжээний байдаг байна. Гаалийн байгууллагын албан хаагчийн ээлжийн амралтын үндсэн хугацаа нь нэг жилд 25 ажлын өдөр байх ба энэ нь ажилласан жилээс хамааран 3-13 ажлын өдрөөр нэмэгддэг байна. Унгарын ҮТГА-ны албан хаагчид дүрэмт хувцас эсхүл энгийн хувцастай албан үүргээ гүйцэтгэж болно. Дүрэмт хувцсыг байнгын алба хашиж буй албан хаагч, хууль тогтоомжид заасан тохиолдолд өндөр насны тэтгэвэрт гарсан хууль сахиулах байгууллагын өндөр настан өмсөх эрхтэй байна[20].

Судалгааны явцад цуглуулсан мэдээллээс харахад гаалийн байгууллагын албан хаагчдын эрхийг гаалийн тухай хууль тогтоомж болон бусад хууль тогтоомжоор баталгаажуулж өгдөг, цалин хөлс, нэмэгдэл бусад хоол, унаа, байр зэрэг асуудлын хүрээний хангамж олгох хэмжээ, нөхцөл бусад албан хаагчдаас арай илүү өндөр төвшинд тогтоогддог байдал ажиглагдаж байна. Энэ нь гаалийн байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны явцад гарах эрсдлийн байдал, албан хаагчдын үүрэг, хариуцлага, ажлын байрны нөхцөл байдалтай шууд холбоотой юм.

ДҮГНЭЛТ

Гаалийн байгууллага нь олон улсын жишгээр тухайн улсын хилээр нэвтэрч буй бараа, бүтээгдэхүүн, тээврийн хэрэгсэл, зорчигчид хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу татвар тогтоох, хураах, гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил илрүүлэх, мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулдаг. Улмаар улсын төсвийн тодорхой хувийг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдал, нийгэм, эдийн засаг, нийгмийн эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангах, сахин хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг төрийн байгууллага юм.

Дэлхийн улс орнуудын хооронд гадаад худалдаа, аялал жуулчлал гээд эдийн засаг, нийгэм, соёлын хамтын ажиллагаа даяарших, хөгжихийн хэрээр гаалийн байгууллагын ажлын ачаалал нэмэгдэж байна. Дээрх хүчин зүйлс нь гаалийн байгууллагын үйл ажиллагааг шуурхай, баталгаатай, ил тод, хүнд сурталгүй болгох хэрэгцээг улам илүү бий болгодог.

Гаалийн байгууллагын тогтолцоог үндсэн 3 төрөлд хувааж болох дүгнэлтэд хүрсэн бөгөөд үүнд:

1. Иргэдийн гаалийн байгууллага, үйл ажиллагааны талаарх мэдлэгийг дээшлүүлэх замаар гаалийн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулах;

---

[19] Хуулийн 283.1. дүгээр зүйл

[20] Мөн тэнд 17. §

2. Гаалийн хяналт шалгалтыг боловсронгуй болгох. Тухайлбал, гадаад худалдааг хөнгөвчлөх үүднээс үйлчлүүлэгчид дарамт болж буй шат дамжлагыг цөөлөх, цахим бүртгэл, мэдээлэл, төлбөр тооцооны тогтолцоонд шилжих, байгууллагын үйл ажиллагааг ил тод, ойлгомжтой, хүртээмжтэй болгоход мэдээллийн технологийн боломжуудыг бүрэн ашиглах зэрэг арга хэмжээ авах;

3. Гаалийн хилээр аюултай, хориотой бараа бүтээгдэхүүнийг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, хууль сахиулах үйл ажиллагаа явуулах гэсэн үндсэн 3 чиглэл багтаж байна.

Сонгон судалсан орнуудын жишээнээс харахад гаалийн байгууллага нь Санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн яамны харьяа, хууль сахиулах чиг үүрэг хэрэгжүүлэгч, удирдлагын босоо тогтолцоотой, төсвийн орлого бүрдүүлэгч байгууллага байна.

Гаалийн байгууллага бүтцийн хувьд 1/ гаалийн асуудал дагнан хариуцсан 2/ татвар, гаалийн асуудал хариуцсан, 3/ хилийн хяналт, гаалийн асуудал хариуцсан хэлбэртэй байна.

Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд уламжлалт гаалийн хяналт шалгалтын төрлөөс гадна хууль бус импортын бараатай тэмцэх замаар дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, байгаль орчин, экологийн тэнцвэрт байдалд сөрөг нөлөө үзүүлэх хортой, аюултай бодис, нийгмийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх мансууруулах бодис, галт зэвсэг, аюултай хоол, хүнсийг хилээр нэвтрүүлэхгүй байх зэрэг шинэ үүрэг, хариуцлага нэмэгдсэн байна.

Гаалийн байгууллага хяналт шалгалт хийх үйл ажиллагааныхаа явцад улсын хилээр орж гарч буй мөнгөний урсгалыг тогтоох, хянах мэдээллээр хангагддаг тул гадаад орнуудад мөнгөний урсгал, гадаад валютын урсгалын удирдлагын асуудлыг тус байгууллагад хариуцуулах болжээ. Ингэснээр мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, хил дамнасан худалдааны залилан/луйврын хэрэгтэй тэмцэх, эдгээрээс урьдчилан сэргийлэх ажиллагаа үр дүнтэй болно гэж үздэг байна. Мөн оюуны өмчийг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлж байна.

Манай улсын Гаалийн ерөнхий газрын бүтцийг харахад тус байгууллага төсвийн орлого бүрдүүлэх буюу татвар, хураамж хураах буюу орлогын эх үүсвэр олох үйл ажиллагаандаа илүү төвлөрсөн бүтэцтэй байна. Харин хууль сахиулах буюу гаалийн зөрчилтэй тэмцэх, иргэдийн гаалийн үйл ажиллагааны талаарх мэдлэг, ухамсрыг дээшлүүлэх болон боловсон хүчин бэлтгэх, сургалт, судалгааны чиглэлийн ажиллагаанд сул хандсан, зөнд нь орхисон байдал ажиглагдаж байна.

Гаалийн байгууллагын албан хаагчийг томилох, чөлөөлөх, ажлаас халах, зэрэг дэв, цол олгох, нийгмийн баталгааг хангах асуудлыг улс бүр өөр өөрийн онцлогтоо нийцүүлэн зохицуулдаг. Тус байгууллагын албан хаагчид албан тушаалын өөр өөр ангилалд хамаарах нь түгээмэл байна. Тухайлбал, хууль сахиулагч буюу төрийн тусгай албаны албан хаагч, төрийн захиргааны албан хаагч, үйлчилгээний албан хаагч, гэрээт ажилтан зэрэг ажилладаг тул эдгээрийн эрх, үүрэг, хариуцлагын тогтолцоог төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, хөдөлмөрийн харилцаа, хууль сахиулах ажиллагааг зохицуулдаг хэд хэдэн хууль тогтоомж үйлчилдэг байна.

Гадаад орнуудын туршлагаас харахад гаалийн байгууллагын албан хаагчдад зэрэг дэв, цол олгох асуудал нь харилцан адилгүй зохицуулагдсан байна. Ерөнхийд нь дүгнэхэд гаалийн байгууллагад хууль сахиулах буюу төрийн тусгай чиг үүрэг бүхий үйл ажиллагаа эрхэлж буй албан хаагчдад цэргийн цол олгож байгаа бол төрийн захиргааны, төрийн үйлчилгээний чиг үүрэг бүхий үйл ажиллагаа эрхэлж буй албан хаагч тодорхой шаардлага хангасан тохиолдолд мэргэжлийн зэрэг дэв

олгох, албан тушаалын ангилалд хамааруулах, мэргэжлийн цол олгох зэргээг ур чадвар, мэргэшсэн байдлыг нь үнэлдэг, үүний дагуу нийгэм, эдийн засгийн баталгаа нь бэхжиж байдаг сайн туршлага байна.

Зарим орны жишээнээс харахад албан хаагчдад хариуцаж буй ажлыг чиг үүргээс хамааран 1-9 хүртэлх зэрэг олгодог бөгөөд энэ нь албан хаагчдын ур чадвар, ажлын туршлага, ажилласан жилийг харгалзан зэрэг олгох замаар албан хаагчдыг эрх зүйн болон эдийн засаг, нийгмийн баталгааг хангаж, улмаар гаалийн байгууллага тогтвортой боловсон хүчинтэй байх боломжийг бүрдүүлдэг. Мөн албан хаагчдын албан тушаалын ангилал нь хариуцаж буй ажил үүргээс хамааран харилцан адилгүй байна. Иймд гаалийн байгууллагын албан хаагчдыг гүйцэтгэж байгаа ажил үүргээс нь хамаарч төрийн захиргааны, төрийн үйлчилгээний албан тушаалд томилж тус бүрт нь зохих эрх, үүргийг хүлээлгэдэг нийтлэг хандлага тогтжээ гэж үзэж болохоор байна. Иймд гаалийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, чадварлаг боловсон хүчээр хангах, нэгэнт бэлтгэгдэж, дадлагажсан албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах үүднээс гадаад орнуудын сайн туршлагаас судлан албан хаагчдын зэрэг дэвийн тогтолцоонд зарим өөрчлөлт оруулах, мөн хариуцах ажлын чиг үүргээс хамааран төрийн тусгай, төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалд томилж ажлуулах нь байгууллагын үйл ажиллагаа, залгамж чанарт эерэг үр нөлөө үзүүлэх боломжтой юм.

Гаалийн улсын байцаагчийн эдийн засаг, нийгмийн баталгааг тодорхой болгох, сайжруулах нь гаалийн байгууллагын нэр хүндийг дээшлүүлэх, үйл ажиллагааны чанар, төвшинг нэмэгдүүлэхийн зэрэгцээ тус байгууллагын авилгын эрсдлийг бууруулах үр нөлөөтэй юм. Мэдээж эдийн засаг, нийгмийн баталгааг сайжруулахын хэрээр гаалийн байгууллагын албан хаагчаас хүлээх мэдлэг, ур чадвар, ёс зүй, хариуцлагын хэмжээ, шалгуур үзүүлэлт өндөр байдаг туршлага ажиглагдаж байна.

Гаалийн байгууллагын үндсэн зорилго нь гаалийн үйлчилгээ зөрчилгүй, хурдан шуурхай байхад оршдог. Гэтэл өнөөгийн байдлаар гаалийн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн орчин бүрэн хангагдаагүй учир хууль сахиулах ажиллагаа төгс хэрэгжих боломжгүй, гаалийн албан хаагчдыг бэлтгэх, мэргэшүүлэх сургалтын тогтолцоогүй, гаалийн бүртгэл, мэдээллийн сангийн ашиглалт хариуцсан, санд байршуулсан мэдээллийг боловсруулах програм хангамжийг хөгжүүлэх чиглэлийн ажил дорвитой хийгдэхгүй байгаа зэрэг нь Монгол Улсын улс төр, эдийн засгийн нөхцөл байдлаас хамааралтай байж болох юм.

Манай улс Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааг дэлхийн жишигт нийцүүлэх үүднээс сүүлийн жилүүдэд Дэлхийн худалдааны байгууллага, Дэлхийн гаалийн байгууллагаас гаргасан олон улсын гэрээнд нэгдэн орсон бөгөөд үүгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомжийг шинэчлэх асуудал тулгамдаж байна.

Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй оны Гаалийн тухай хууль нь эрх зүйн шинэтгэлийн хүрээнд 2008 онд шинэчлэгдсэн хэдий ч эрчимтэй хөгжиж буй эдийн засаг, гадаад худалдаа, технологийн хөгжлийн үр дүнд бий болж буй шинэ харилцааг зохицуулахад зарим талаар дутмаг харагдаж байна.

Иймээс Гаалийн тухай хуулийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг 2017 онд байгуулагдан ажиллаж байна. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахдаа Гаалийн ерөнхий газрын чиг үүрэг, үйл ажиллагааг Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль зэрэг эрх зүйн бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго, зорилтод нийцүүлэх, уялдуулах тал дээр анхаарч ажиллаж байна.

Хуулийн төсөлд тусгагдаж буй нэмэлт, өөрчлөлтүүд нь хуулийн нэр томъёо, ойлголтыг олон улсын гэрээ, конвенц, шинээр батлагдсан дотоодын хууль тогтоомжтой уялдуулах, гаалийн байгууллагын үйл ажиллагааг ил тод, ойлгомжтой болгох, хуулийн зохицуулалтын цар хүрээг өргөжүүлэх, зарим шинэ төрлийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг нэмж оруулах замаар Дэлхийн гаалийн байгууллага, Дэлхийн худалдааны байгууллагаас хэрэгжүүлж буй бодлогод өөрийн эрх зүйн орчноо нийцүүлэхэд чиглэсэн алхам болж байна. Тухайлбал, "Оюуны өмчийн эрхийг хамгаалах" дэд бүлгийг шинээр оруулж, хуулийн төсөлд "Гаалийн байгууллага оюуны өмчийн эрхийн илэрхий зөрчилтэй барааг саатуулна."[21] гэсэн эрх зүйн зохицуулалт оруулсан нь "Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай" -TRIPS-ийн хэлэлцээрийн заалттай уялдсан бол "Худалдааг хөнгөвчлөх тухай" ДХБ-ын хэлэлцээрт заасан "Эрсдэлийн удирдлага" хэсгийг хэрэгжүүлэхийн тулд хуулийн төсөлд дэд бүлэг болгон "Эрсдэлийн удирдлага"-ыг, Итгэмжлэгдсэн эдийн засгийн оператор"-ын ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг тус тус шинээр нэмж оруулсан нь гадаад худалдаа эрхлэгчдэд худалдааны таатай орчин бүрдүүлэх, бараа, тээврийн хэрэгслийг шуурхай хүлээн авах, экспортлох, гадаад худалдаа эрхлэгчдийн хууль сахин биелүүлэх сахилгын түвшинг дээшлүүлэх ач холбогдолтой юм. Мөн "Мэдээллийн технологи гаалийн үйл ажиллагаанд ашиглах" бүлэг нэмж оруулан бичиг баримтыг цаасаар бүрдүүлэхэд цахим гарын үсэг, тоон гарын үсэг зэрэг нь баталгаа болж болох зохицуулалтыг тусгажээ. Энэ нь баталгаажуулалтыг цахим аргаар болон цаасаар хийх эрх зүйн зохицуулалтыг конвенцод заасан стандартад нийцүүлэх хуульд тусгасан нь гаалийн байгууллагын үйл ажиллагааг шинэчлэх ач холбогдолтой гэж үзэхээр байна.

САНАЛ

1. Гаалийн байгууллагын хууль сахиулах, мөрдөн шалгах, хариуцлага хүлээлгэх, албадлагын арга хэмжээ авахтай холбоотой үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар гаалийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах;

2. Гаалийн зөрчилтэй тэмцэх нэгжийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг баталгаажуулах;

3. Гаалийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг сурталчлах чиг үүргийг хуульчилснаар иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх боломжийг нэмэгдүүлэх, гаалийн зөрчлийн хэмжээг бууруулах;

4. Гаалийн байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд мөнгөний урсгалын удирдлага, бүртгэл хөтлөх, мэдээлэл боловсруулах үйл ажиллагааг нэмж оруулах, мөн санхүүгийн буюу мөнгөний урсгалыг хянахад цахим төлбөр хийх хэлбэр, арилжааны банктай харилцах, гаалийн байгууллагын эрх хэмжээг тодорхойлох, эрхээ хэрэгжүүлэхэд тусдаа нэгжтэй байх эрх зүйн зохицуулалтыг бий болгох хэрэгцээ шаардлагыг судлах;

5. Нэгэнт хэрэгжиж буй нэг цонхны цахим үйл ажиллагааг хуульчилж, эрх зүйн орчныг бүрдүүлэх;

6. Гаалийн байгууллагын мэргэшсэн албан хаагч бэлтгэх, давтан болон үргэлжилсэн сургалтын тогтолцоог бий болгох;

7. Гаалийн албан хаагчдын эрх зүй, нийгэм, эдийн засгийн баталгааг шинэ төвшинд гаргах, мөн хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох замаар боловсон хүчний тогтвортой, мэргэшсэн байдлыг хангах зэрэг саналтай байна.

[21] Гаалийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн төслийн 165.2 дахь хэсэг.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Монгол Улс

Хууль тогтоомж

1. Гаалийн тухай хууль /2008/
2. Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /2017/
3. Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай марракешийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколд нэгдэн орох тухай хууль /2016/
4. Гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын конвенц /2006/
5. Бусад хууль тогтоомж, дүрэм журам
6. Гаалийн ерөнхий газраас авсан мэдээ, мэдээлэл

Цахим хуудас

7. Гаалийн ерөнхий газрын албан ёсны цахим хуудас: http://www.customs.gov.mn
8. Эрх зүйн нэгдсэн мэдээллийн систем: http://legalinfo.mn

Унгар улс

Хууль тогтоомж

1. Үндэсний татвар гаалийн албаны тухай 2010 оны 122 дугаар хууль /2010. ïvi CXXII. Tqrvйny a Nemzeti Ady- йs Vбmhivatalryl/
2. Үндэсний татвар, гаалийн албаны Бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны дүрэм
3. “Үндэсний татвар, гаалийн албаны түүх, чиг үүрэг, бүтэц зохион байгуулалтын хөгжил” судалгаа. 2016 он.
4. “Төрийн захиргааны албан хаагчийн хариуцлагын тогтолцоо” PhD зэрэг горилсон эрдэм шинжилгээний судалгааны ажил. 2010 он.
5. 2011 оны Нийтийн үйлчилгээний төрийн албан хаагчийн тухай 199 дүгээр хууль
6. 2015 оны Хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын байнгын албан хаагчдын үйл ажиллагааны эрх зүйн харилцааны тухай 42 дугаар хууль
7. 2012 оны Хөдөлмөрийн тухай 1 дүгээр хууль

Цахим хуудас

1. Үндэсний татвар, гаалийн албаны цахим хуудас: https://www.nav.gov.hu/
2. Хууль тогтоомжийн цахим сан: http://net.jogtar.hu/

Бүгд найрамдах Солонгос Улс

Хууль тогтоомж

1. Солонгосын гаалийн тухай хууль. Customs Act.1949.
2. Засгийн газрын байгууллагын тухай хууль. Government Organization Act. 1948
3. Development History of the Korea Customs Service and its Automation. Korea Customs Service 2012.
4. Төрийн нийтийн албан хаагчийн тухай хууль. State Public Officials Act. 1949.
5. Хууль сахиулахын албан хаагчийн тухай. Enforcement Officers Act. 1995

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nlc.gov.mn

Цахим хуудас

6. Татвар болон Гаалийн байгууллагын цахим хуудас: https://english.mosf.go.kr/co/selectAboutMosf.do?boardCd=C0006#link

7. Солонгосын Гаалийн байгууллагын цахим хуудас: http://www.customs.go.kr/kcshome/site/index.do?layoutSiteId=english

Шинэ Зеланд

Хууль тогтоомж

1. Гааль болон Хэрэглээний татварын тухай хууль 1996. /Customs and Excise Act 1996./

2. Шинэ Зеландын гаалийн тухай хууль. Ёс зүйн дүрэм. /New Zealand Customs Service. Code of Conduct/

3. Шинэ Зеландын Гаалийн байгууллагын 2016 оны жилийн тайлан. /Annual Report 2016. New Zealand Customs Service/

Цахим хуудас

4. Шинэ Зеландын гаалийн байгууллагын албан ёсны цахим хуудас. http://www.customs.govt.nz/Pages/default.aspx

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

Хавсралт №1

МОНГОЛ УЛСЫН ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Монгол Улсын гаалийн байгууллага нь Монгол Улсын Гаалийн хууль тогтоомжийн биелэлтийг хангах төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх төрийн байгууллага[22] бөгөөд ёс зүйг эрхэмлэх, үйлчлүүлэгчээ дээдлэх, мэргэшсэн, өндөр чадвартай байх, шинийг эрэлхийлэх, багаар ажиллах гэсэн үнэт зүйлсэд суурилсан үйл ажиллаагаагаар үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, Гадаад худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх зорилго тавьж ажилладаг.

Стратегийн зорилтдоо гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны шат дамжлагыг багасгах, бичиг баримтыг сүлжээгээр мэдүүлэх аргаар экспорт, импортын зардлыг бууруулах, мэдээллийн технологи ашиглах ажиллагааг нэвтрүүлэх замаар гадаад худалдааг хөнгөвчлөх, гаалийн бүрдүүлэлтийг хялбарчлах, эрх зүйн орчныг шинэчлэх, эрсдэлийн менежментийг нэвтэртрүүлэх, зорчигч, бараа, тээврийн хэрэгслийг хилээр орж ирэхээс өмнө сүлжээгээр мэдүүлэх, хянах боломж бий болгох замаар Гаалийн хяналтыг боловсронгуй болгож, үр нөлөөг дээшлүүлэх, гаалийн байгууллагыг шаардлагатай нарийн мэргэшсэн боловсон хүчнээр хангах, ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, гадаад орны болон олон улсын гаалийн харилцааг хөгжүүлэх, сайн туршлагыг нэвтрүүлэх замаар хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, гаалийн байгууллагын үйл ажиллагааг тодорхой, ил тод, нээлттэй байлгах гэсэн зорилгуудыг дэвшүүлэн ажилладаг.

Гаалийн байгууллага өнөөгийн байдлаар 23 хууль, 12 сайдын тушаал, ГЕГ-аас баталсан 96 журам болон Засгийн газрын тогтоол, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам зэрэг гаалийн байгууллага түүний үйл ажиллагааг зохицуулсан 150 гаруй хууль эрхийн акт мөрдөгдөж байна[23].

Түүнчлэн гаалийн байгууллага гаалийн холбогдолтой “Барааг тодорхойлох, кодлох уялдсан системийн тухай олон улсын конвенц”, “Гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын конвенц”, “Барааг түр хугацаагаар оруулах тухай Конвенц”, “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц”, “ТИР карней ашиглан олон улсын хэмжээнд бараа тээвэрлэх тухай конвенц”, “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенц”, “Дипломат харилцааны тухай Венийн Конвенц”, “Олон улсын хэмжээнд бараа худалдах, худалдан авах гэрээний тухай НҮБ-ийн конвенц” зэрэг олон конвенцийг хэрэгжүүлдэг.

Гаалийн эрх зүйн шинэчлэлтийн хүрээнд 1996 онд батлагдсан “Гаалийн тухай” болон “Гаалийн тариф, гаалийн татварын тухай” хуулиудыг шинэчлэн найруулж, УИХ-аар батлуулан, 2008 оны 7 дугаар сарын 1-нээс хэрэгжүүлж байгаа бөгөөд 2017 онд дээрх хуулийн шинэчилсэн найруулгын төслийг шинэчлэн боловсруулах гаалийн хуулиудыг хэрэгжүүлэх журмуудыг цөөрүүлж, шинэчлэн боловсруулах, батлуулах, мөрдөх ажил хийгдэж эхлээд байна.

Олон улсын хэмжээнд гадаад худалдааны эргэлт нэмэгдэж буйтай холбогдуулан гаалийн үйлчилгээг улам бүр хурдан шуурхай, ил тод, хүндрэлгүй, олон улсын жишигт нийцүүлэн хийх хэрэгцээ шаардлага тулгамдсан асуудлын нэг болж байна. Үүнээс гадна хил дамнасан худалдаа арилжааны хэлбэр нь уламжлалт хэлбэрээс гадна цахим хэлбэрээр хурдтай хөгжиж байгаа, хил дамнасан худалдаа, мөнгөний урсгалын цөөнгүй хувь нь мөнгө угаах, залилах, терроризмыг санхүүжүүлэх зэрэг хууль бус зохион байгуулалттай үйл ажиллагаатай хамааралтай болж байна. Иймд манай улсын гаалийн байгууллагын үйл ажиллагааг нэгдүгээрт худалдааг

[22] Гаалийн тухай хуулийн 265.1. дүгээр зүйл

[23] http://www.customs.gov.mn/2012-03-14-03-12-51/2014-08-18-04-33-55

хөнгөвчлөх, хоёрдугаарт хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, зохих арга хэмжээ авах чиглэлээр бэхжүүлэх, эдгээрийг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчинг цаг үеийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох хэрэгтэй.

Монгол Улс 2016 онд Дэлхийн худалдааны байгууллагын "Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протокол"-д нэгдэн орсон[24] нь энэ чиглэлд хэрэгжүүлж буй нэг томоохон алхам гэж үзэж болно.

ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО

- Гаалийн тухай хуулийн 267 дугаар зүйлд гаалийн байгууллагын тогтолцооны талаар зохицуулалт орсон байдаг. Үүнд зааснаар Гаалийн байгууллагын тогтолцоо нь гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний харьяа гаалийн газар, хорооноос бүрдэх бөгөөд гаалийн газар нь алба, салбартай байх[25] ба гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гаалийн хууль тогтоомжийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага[26] байна. Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дарга, дэд даргатай байна[27]. Гаалийн ерөнхий газрын даргыг Монгол Улсын Засгийн газар томилохоор, байгууллагын дүрмийг Засгийн газар батлахаар[28] тусгасан байна.

Гаалийн ерөнхий газар нь эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх, гаалийн ажилтан бэлтгэх, давтан сургах чиг үүрэг бүхий эрдэм шинжилгээний байгууллага, гаалийн лаборатори, хэвлэх үйлдвэр, мэдээлэл-тооцооллын төв, хөрөнгө оруулалт, хангамж үйлчилгээний газар, эрэлч нохойн албыг байгуулан ажиллуулах боломжтой[29]

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ[30]

Гаалийн ерөнхий газар үндсэн чиг үүргийн хүрээнд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- гаалийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, биелэлтийг хангуулах;
- гаалийн асуудлаар санал боловсруулж хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх;
- эрсдэл тооцох системд үндэслэсэн гаалийн хяналтын стратегийг тодорхойлох;
- гаалийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх;
- гаалийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, мэргэжлийн удирдлагаар хангах, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх;
- бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэхтэй холбогдсон энэ хуульд заасан дүрэм, журам, зааврыг боловсруулах;
- гадаад худалдааны гаалийн статистикийн мэдээлэл гаргах, дүн шинжилгээ хийх;
- барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн үндэсний код боловсруулах;

[24] 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр баталсан Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколд нэгдэн орох тухай Монгол Улсын хууль. Эх сурвалж: http://legalinfo.mn/uploads/akts/16-g-13-h1%20TFA%20mon.pdf

[25] 267[1] дүгээр зүйл. Гаалийн байгууллагын тогтолцоо

[26] Мөн тэнд 267[1].2. дугаар зүйл.

[27] Мөн тэнд 267[1].3. дугаар зүйл.

[28] Мөн тэнд 267[1].6. дугаар зүйл.

[29] Мөн тэнд 267[1].5. дугаар зүйл.

[30] Мөн тэнд 268[1] дугаар зүйл. Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

- бараа мэдүүлэх, гаалийн бүрдүүлэлт хийх гаалийн байгууллагыг тогтоох;
- гаалийн байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг төлөвлөх, хангалтыг зохион байгуулах;
- гаалийн асуудлаар мэдээлэл, зөвлөгөө өгөх, гаалийн харилцаанд оролцогчийн мэргэжилтэнг бэлтгэх, сургах, давтан сургахад дэмжлэг үзүүлэх;
- гаалийн байгууллагын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх;
- гаалийн асуудлаарх өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх;
- хуульд заасан бусад бүрэн эрх.

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Гаалийн ерөнхий газрыг дарга буюу Улсын гаалийн ерөнхий байцаагч[31] удирдах бөгөөд 2 орлогч даргатай, эдгээр нь мэргэжлийн удирдлагаар хангаж ажилладаг. Даргын шууд удирдлага доор Төрийн захиргааны удирдлагын газар байна. Тус газарт Хүний нөөцийн хэлтэс, Хуулийн хэлтэс, Гадаад хамтын ажиллагааны хэлтэс, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс, Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, Гаалийн зөрчилтэй тэмцэх газар харьяална. Орлогч дарга нар мэргэжлийн чиглэлийн дагуу асуудлыг хариуцах бөгөөд нэг нь гаалийн хяналт, шалгалтын газар, Гаалийн бүрдүүлэлтийн газар, Гаалийн эрсдэлийн удирдлагын хэлтэс, Гаалийн төв лаборатори, Эрэлч нохойн сургалтын төвийг буюу гаалийн хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх асуудлыг хариуцан ажилладаг бол нөгөөх нь Татварын орлогын газар, Статистикийн хэлтэс, Боомтын хөгжлийн хэлтэс гэх татвар, мэдээллийн асуудал хариуцан ажилладаг байна.

Гаалийн ерөнхий газрын даргын дэргэд Үйлчилгээ аж, ахуйн алба, Хэвлэл, мэдээлэл, сургалт, судалгааны төв, Бүрдүүлэлтийн дараахь шалгалтын газар, Мэдээллийн технологийн төв ажилладаг. /Зураг №1/

Зураг №1 ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



[31] Мөн тэнд 267[1].5. дугаар зүйл.



ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

Гаалийн байгууллагын алба хаагчийг томилох, чөлөөлөх, түдгэлзүүлэх, өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, шагнаж урамшуулах, төр засгийн шагналд тодорхойлох[32], мөн гаалийн улсын байцаагчийн эрх олгох, эрхийг нь түдгэлзүүлэх, сахилгын шийтгэл ногдуулах[33] асуудлыг ГЕГ-ын дарга шийдвэрлэнэ.

Гаалийн улсын байцаагч нь гаалийн хууль тогтоомжийн дагуу хяналт, шалгалт хийх эрх эдэлж, үүрэг хүлээх[34] ба тангараг өргөсөн[35] төрийн тусгай албан тушаалын ангилалд хамаарна[36].

Гаалийн улсын байцаагч нь гадаад хэлний зохих мэдлэгтэй, дээд боловсролтой Монгол Улсын иргэн байх бөгөөд гаалийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр мэргэжлийн тусгай сургалтад хамрагдсан[37], гаалийн байгууллагаас зохион байгуулсан мэргэшлийн шалгалтад[38] тэнцсэн байх шаардлагатай байдаг.

Гаалийн улсын байцаагч дүрэмт хувцас, ялгах тэмдэг хэрэглэх, эсхүл хувцасны хангамж эдлэх[39] бөгөөд албан үүргээ гүйцэтгэж байх явцад тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх эрхтэй[40]..

Гаалийн улсын байцаагчийн эрх, үүрэг[41]

Гаалийн улсын байцаагч нь Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн нийтлэг эрхээс гадна дараахь эрх эдэлнэ:

- хууль тогтоомжид заасны дагуу гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавьж, бүрдүүлэлт хийх;
- гаалийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор иргэн, албан тушаалтанд хууль ёсны шаардлага тавьж биелэлтийг хангуулах;
- гаалийн бүрдүүлэлттэй холбоотойгоор аж ахуйн нэгж, байгууллагын байр, агуулахад нэвтрэн орж үзлэг тооллого хийх, тэдгээрийн данс, бүртгэлийг шалгах;
- гаалийн хяналт, шалгалтад ач холбогдол бүхий бичиг баримт, тайлбар, лавлагааг холбогдох этгээдээс гаргуулан авах
- гаалийн болон бусад татвар ногдох барааг нуусныг гэрчлэх баримт, материалыг татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс түр хугацаагаар хураах, эсхүл хуулбарлуулан авах;

---

[32] Хуулийн 271[1].1.10. дугаар зүйл

[33] Хуулийн 271[1].1.11. дүгээр зүйл.

[34] Хуулийн 273.1. дүгээр зүйл.

[35] Хуулийн 273.4. дүгээр зүйл.

[36] Хуулийн 273.2. дугаар зүйл

[37] Хуулийн 273.5. дугаар зүйл

[38] Хуулийн 273.6. дугаар зүйл

[39] Хуулийн 276.1. дүгээр зүйл.

[40] Хуулийн 277 дугаар зүйл

[41] Хуулийн 274 дүгээр зүйл.

- албан үүргээ гүйцэтгэх үед улсын хилийн хориотой зурваст нэвтрэх;
- гаалийн хууль тогтоомж зөрчсөн захиргааны зөрчилд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх эрхтэй бол,

Гаалийн улсын байцаагч нь Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн нийтлэг үүргээс гадна дараахь үүрэг хүлээнэ:

- өргөсөн тангарагтаа үнэнч, гаалийн хяналт, шалгалтыг хийхдээ сонор сэрэмжтэй байж, төр, байгууллага болон хувь хүний нууцыг чанд хадгалж, хувь хүний нэр хүндийг гутаахгүй байх;
- гаалийн хяналт, бүрдүүлэлтийг хийхдээ төр, байгууллага, хувь хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироохгүй, албан тушаалаа урвуулан ашиглахгүй, хэтрүүлэхгүй байх;
- гаалийн хууль тогтоомжийг зөрчсөн хууль бус үйлдэл /эс үйлдэхүй/-ийн талаар зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлэх;
- мэргэшлийн сургалтад хамрагдах;
- гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрмийг чанд сахиж ажиллах.

Гаалийн улсын байцаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл[42]

Гаалийн улсын байцаагч Төрийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлд зааснаас гадна дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

- улс төрийн намын гишүүн байх;
- өөрийн нь гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүмүүсийн гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт, бүрдүүлэлт хийх, эсхүл уг үйл ажиллагаанд оролцох, нөлөөлөх;
- энэ хуульд зааснаас бусад мэдээлэл шаардах, иргэдэд чирэгдэл учруулах, бусдад давуу байдал олгох зэргээр ялгаварлах;
- албан үүрэгтэйгээ холбоогүйгээр гаалийн хяналт тавих, шалгалт хийх.

Гаалийн улсын байцаагчийн албан тушаалын ангилал[43]

Гаалийн улсын байцаагчийн албан тушаал нь тэргүүн түшмэл, эрхэлсэн түшмэл, ахлах түшмэл, дэс түшмэл, туслах түшмэл гэсэн 5 ангилалтай байна[44]. Үндсэн 5 ангилал тус бүртээ тэргүүн, дэд, гутгаар, дөтгөөр гэсэн зэрэг дэвтэй байна[45]. Зэрэг дэв олгохдоо төрийн албанд нийт ажилласан болон тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, мэргэшлийн төвшин, ёс зүйн хэм хэмжээг сахиж буй байдлыг харгалзана[46].

Гаалийн улсын байцаагчид гаалийн жинхэнэ зөвлөх, гаалийн итгэмжит зөвлөх, гаалийн зөвлөх цол олгож болно[47].

Гаалийн улсын байцаагчийн цалин хөлс нь албан тушаалын үндсэн цалин, албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, эрдмийн зэргийн нэмэгдлээс тус тус бүрдэнэ[48].

Гаалийн улсын байцаагч албан үүрэгтээ хайнга хандсан, эсхүл энэ хуулийн хууль тогтоомжид тусгаснаас өөр бичиг баримт мэдүүлэгчээс шаардах болон бусад хэлбэрээр бүрэн эрхээ хэтрүүлсэн, түүнчлэн гаалийн хууль тогтоомж, өргөсөн тангаргаа зөрчсөн тохиолдолд сануулах, зэрэг дэвийг 1 жил хүртэл хугацаагаар бууруулах, албан тушаалыг 3 сар хүртэл хугацаагаар бууруулах, албан тушаалыг 3 сар хүртэл хугацаагаар бууруулах, гаалийн албанаас халах хүртэл сахилгын

[42] Хуулийн 275 дугаар зүйл.
[43] Хуулийн 279 дүгээр зүйл.
[44] Хуулийн 279.1 дүгээр зүйл.
[45] Хуулийн 280.1. дүгээр зүйл.
[46] Хуулийн 280.3. дугаар зүйл.
[47] Хуулийн 281 дүгээр зүйл
[48] Хуулийн 283.1. дүгээр зүйл

шийтгэлийг[49] ногдуулна. Гаалийн улсын байцаагчийн сахилгын дүрмийг Засгийн газар батална[50].

ДҮГНЭЛТ

Монгол Улсын Гаалийн ерөнхий газар нь үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, гадаад худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх зорилгоор гаалийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэгч төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллага. Удирдлагын босоо тогтолцоотой, Сангийн яамны харьяа, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг юм.

Гаалийн үйлчилгээг олон улсын стандарт, жишиг болон эдийн засгийн хөгжил, худалдааны эргэлтийн өсөлт зэрэгт нийцүүлэхэд зорилгоор дотоодын хууль тогтоомж, журам дүрмийн шинэчлэхийн зэрэгцээ олон улсын болон гэрээ, конвенцид, ялангуяа Дэлхийн худалдааны байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичигт нэгдэн орж байна. Тухайлбал, хамгийн сүүлд 2016 онд ДХБ-ын “Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протокол”-д нэгдэн орсон байна.

Үүнээс гадна манай улсын шүүхүүд болон хууль сахиулах байгууллагууд үйл ажиллагаандаа олон улсын гэрээг бүрэн ашигладаггүй гэх шүүмжлэлийг олон нийтийн зүгээс байнга гаргадаг болох нь судалгааны ажлуудад удаа дараа дурдагддаг. Олон улсын гэрээг хамгийн түгээмэл ашигладаг, ашиглах шаардлагатай гаалийн байгууллагын хувьд “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2017 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн №12 дугаарт МУ-ын нэгдэн орсон 7 олон улсын гэрээний албан ёсны орчуулгыг нийтлүүлж үндэсний хүчин төгөлдөр хууль тогтоомжийн нэгэн адил хэрэглэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Гаалийн тухай хуулийг олон улсын гэрээтэй уялдуулах баталгааг хангасан байна.

Гаалийн байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулах, боловсронгуй болгох ажлын хүрээнд 2008 оны Гаалийн тухай хуулийг шинэчлэн найруулах ажлын хэсэг байгуулагдан хуулийн төслийн шинэчилсэн найруулгыг боловсруулж байна. Хуулийн төсөл боловсруулахдаа Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль зэрэг төрийн бодлогын баримт бичиг болон эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр, МУ-ын нэгдэн орсон ОУ-ын гэрээ, хэлэлцээрт тусгагдсан зарчмын болон үйл ажиллагааны шинэ зохицуулалтыг тусгаснаараа гаалийн байгууллагын үйл ажиллагааг үйлчлүүлэгчид ид тод, ойлгомжтой, хүндрэлгүй болгох алхам хийгдэж байна. Тухайлбал, гаалийн бүрдүүлэлтийн горимыг хялбарчлах, оюуны өмчийг хамгаалах асуудлаар гаалийн байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, “Эрсдэлийн удирдлага”-ыг гаалийн байгууллагын үйл ажиллагааг шинэ шатанд гаргах, Итгэмжлэгдсэн эдийн засгийн оператор”-ын ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг шинээр оруулсан, түүнчлэн гаалийн байгууллагын үйл ажиллагааны чанарын баталгаа болсон албан хаагчдын эрх зүйн байдлыг дээшлүүлэх, мэргэшсэн, тогтвортой байдлыг хангах, хариуцлагын тогтолцоог сайжруулах зэрэгт илүү анхаарснаас харж болох байна.

Монгол Улсын гаалийн байгууллага нь гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний харьяа гаалийн газар, хорооноос бүрдэх бөгөөд гаалийн газар нь алба, салбартай байх боломжтой босоо удирдлагын тогтолцоотой байна. Бүтцийн хувьд дарга, 2 орлогч дарга, 4 газар, 9 хэлтэстэй бөгөөд Гаалийн төв лаборатори, Эрэлч нохойн сургалтын төв, Эрэлч нохойн сургалтын төв, Мэдээллийн технологийн төв, Үйлчилгээ аж, ахуйн алба, Бүрдүүлэлтийн дараахь

[49] Хуулийн 284 дүгээр зүйл.

[50] Хуулийн 284.3. дугаар зүйл

шалгалтын газар гэсэн 6 дэргэдэх байгууллагатайгаар үйл ажиллагаа явуулдаг.

Үндсэн чиг үүргийн хувьд гаалийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, биелэлтийг хангуулах, гаалийн хяналтын стратегийг тодорхойлох, гаалийн статистикийн мэдээлэл гаргах, дүн шинжилгээ хийх, гаалийн байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг төлөвлөх, хангалтыг зохион байгуулах, мэргэжилтэнг бэлтгэх, сургах, давтан сургахад дэмжлэг үзүүлэх, гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, холбогдох дүрэм, журам боловсруулах зэрэг чиг үүрэг хэрэгжүүлж байна.

Гаалийн байгууллагад ажиллах хүсэлтэй этгээд тодорхой шалгалт, шалгуур үзүүлэлтэд тэнцсэн тохиолдолд байгууллагын даргын тушаалаар тус байгууллагад томилогдон ажиллах бөгөөд гаалийн албан хаагчийн тангараг өргөснөөр албан хаагч төрийн тусгай албан хаагч болдог. Гаалийн улсын байцаагч хууль тогтоомжид заасны дагуу хяналт, шалгалт хийх эрх эдэлж, үүрэг хүлээх бөгөөд албан үүргээ гүйцэтгэхдээ дүрэмт хувцас, тусгай хэрэгсэл хэрэглэх эрхтэй байна. Гаалийн улсын байцаагчийн албан тушаал нь тэргүүн түшмэл, эрхэлсэн түшмэл, ахлах түшмэл, дэс түшмэл, туслах түшмэл гэсэн 5 ангилалтай, ангилал тус бүр тэргүүн, дэд, гутгаар, дөтгөөр гэсэн зэрэг дэвтэй байна[51]. Мөн гаалийн албан хаагчид гаалийн жинхэнэ зөвлөх, гаалийн итгэмжит зөвлөх, гаалийн зөвлөх цол олгодог байна.

Гаалийн улсын байцаагч ажил үүргээ гүйцэтгэх явцдаа хууль тогтоомж зөрчсөн, ёс зүйгүй байсан, эрх мэдлээ хэтрүүлэн ашигласан зэрэг буруутай үйл ажиллагаа явуулсан бол сануулах, зэрэг дэвийг 1 жил хүртэл хугацаагаар бууруулах, албан тушаалыг 3 сар хүртэл хугацаагаар бууруулах, албан тушаалыг 3 сар хүртэл хугацаагаар бууруулах, гаалийн албанаас халах хүртэл сахилгын шийтгэлийг ногдуулах боломжтой байдаг.

Монгол Улсын гаалийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны үндсэн чиглэлээс харахад улсын хэмжээн дэх мөнгөний урсгалыг хянах эрх олгогдоогүй, санхүүгийн буюу мөнгөний урсгалыг хянахад цахим төлбөр хийх хэлбэр, арилжааны банктай харилцах, гаалийн байгууллагын эрх хэмжээг тодорхойлоогүй, хил дамнасан гэмт хэргийн нэг төрөл болох залилан/луйврын гэмт хэрэгтэй тэмцэх хамтын ажиллагааг хууль тусгаагүйн улмаас энэ эрхээ хэрэгжүүлэхэд тусдаа нэгжтэй байх эрх зүйн зохицуулалт огт байхгүй, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хууль сахиулах чиг үүрэг бүхий тус байгууллагын тухайд иргэд, үйлчлүүлэгчдийн дунд хууль сахих идэвхи санаачлага, мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг үндсэн чиг үүрэг болгож тодорхойлоогүй, хууль сахиулах ажиллагааг хэрэгжүүлж буй Гаалийн зөрчилтэй тэмцэх газрын эрх хэмжээ, оролцоог зөрчлийн болон эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаанд тодорхой тусгаагүй, зарим зариргааны болон мөрдөн шалгах эрх нь хязгаарлагдмал байгаа, одоо хэрэгжиж буй нэг цонхны үйлчилгээг хуульчлаагүй зэрэг нь тус байгууллага хууль сахиулах ажиллагааг бүрэн төгс хэрэгжүүлэхэд хүндрэл учруулдаг байх магадлалтай байна.

Түүнчлэн гаалийн байгууллага түүний үйл ажиллагааг зохицуулсан 150 гаруй эрх зүйн акт үйлчилж байгаагийн талаас илүү хувь нь журам байгаа нь хуулийн хийдэл, давхардал, зөрчил үүсгэх, гаалийн байгууллагаар үйлчлүүлэгч төдийгүй албан хаагчид хүртэл тухайн харилцааг хэрхэн зохицуулсан талаар нарийн, тодорхой мэдээлэл авахад хүндрэл, үл ойлголцох байдал үүсгэх, мөн гаалийн албан хаагчид эрх мэдлээ урвуулан ашиглах, өөртөө давуу байдал үүсгэх, авилга, хээл хахуулийг хөхиүлэх нөхцөл байдлыг бий болгох магадлалтай юм. Иймд журам, дүрмийг цөөлөх, зарим асуудлыг, ялангуяа албан хаагчдын эрх зүйн байдалтай холбоотой асуудлуудыг гаалийн тухай хууль тогтоомжид нэмж оруулах байдлаар шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх шаардлага тулгамдаж байна гэж үзлээ.

[51] Хуулийн 280.1. дүгээр зүйл.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль тогтоомж

9. Гаалийн тухай хууль /2008/
10. Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /2017/
11. Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай марракешийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколд нэгдэн орох тухай хууль /2016/
12. Гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын конвенц /2006/
13. Бусад хууль тогтоомж, дүрэм журам
14. Гаалийн ерөнхий газраас авсан мэдээ, мэдээлэл

Цахим хуудас

15. Гаалийн ерөнхий газрын албан ёсны цахим хуудас: http://www.customs.gov.mn
16. Эрх зүйн нэгдсэн мэдээллийн систем: http://legalinfo.mn

---o0o---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

Хавсралт №2

УНГАР УЛСЫН ҮНДЭСНИЙ ТАТВАР, ГААЛИЙН АЛБА

Унгар улсад анх 1867 онд татвар, гаалийн байгууллага үүссэн бөгөөд хэд хэдэн удаа бүтцийн томоохон өөрчлөлт орж байжээ. Хамгийн сүүлд 2011 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн Татвар, Санхүүгийн хяналтын алба /Pőnzьgyi Ellenőrzősi Hivatal/ Гааль, санхүүгийн байгууллага /Vбm йs Pőnzьgyőrsőg/-тай нэгдэж 23,000 гаруй албан хаагчтай Үндэсний татвар, гаалийн алба /Nemzeti Ady- йs Vбmhivatal/ болсон. Тус албаны үйл ажиллагааг Үндэсний татвар, гаалийн албаны тухай 2010 оны 122 дугаар хууль[52], Үндэсний эдийн засгийн сайдын 26/2015.(XII.30)тоот тушаалаар батлсан "Үндэсний татвар, гаалийн албаны бүтэц, үйл ажиллагааны дүрэм"[53]-ээр зохицуулдаг байна.

Үндэсний татвар, гаалийн алба /цаашид ҮТГА гэх/ Үндэсний эдийн засгийн сайдын удирдлага доор үйл ажиллагаа явуулдаг төрийн захиргааны болон галт зэвсэг хэрэглэх эрх бүхий хууль сахиулах чиг үүрэг бүхий хуулийн этгээдийн эрхтэй төсвийн төв байгууллага бөгөөд улсын төсөвт бие даасан бүлэг үүсгэдэг байгууллага юм[54].

Үндэсний татвар, гаалийн алба нь үнэт зүйлсэд суурилсан үйл ажиллагаа, үйлчилгээний чанарыг сайжруулах, мэргэжлийн үйл ажиллагааны тэгш байдлыг хангах гэсэн үндсэн зарчмыг хэрэгжүүлэх стратегийн зорилго тавьж ажилладаг. Эдгээр зарчмууд нь харилцагчдад татвар төлөх ухамсар, мэдлэг, мэдээллийг олгох, шаардлагатай тохиолдолд албадлагын арга хэрэглэх бол ямар үр дагавар дагуулах боломжтой тухай, мөн татвар, гаалийн албаны алба хаагч ажил үүргээ хурдан шуурхай, баталгаатай, хүндрэл чирэгдэлгүй, хэмнэлттэй, харилцагчид ээлтэй байдлаар явуулах замаар иргэдийн хуулиар тогтоосон энэхүү үүргээ сайн дураараа биелүүлэх ухамсрыг нэмэгдүүлэх зэрэг агуулгад задардаг байна.

ҮНДЭСНИЙ ТАТВАР, ГААЛИЙН АЛБАНЫ ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ

Улсын Үндэсний татвар, гаалийн албаны үндсэн чиг үүрэг нь "улсын төсөв, нийгмийн даатгалын сан, эрүүл мэндийн даатгалын сан, эсхүл улсын тусгай сан, зайлшгүй төлөх төлбөр, эдгээрээс төлөгддөг тусламж, татварын бүцаан олголт, Холбооны гаалийн тухай хуулийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулийн үйлчлэлд хамаарах төлбөр тогтоох, түүнийг хураах, бүртгэх, шийдвэр гүйцэтгэх, буцаан олгох, шилжүүлэг хийх, хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм.

ҮНДЭСНИЙ ТАТВАР, ГААЛИЙН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Тус байгууллага нь дараахь үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулна:

- Төсвийн тухай хуульд заасан төсвийн орлого бүрдүүлэхтэй холбоотой үүргийн хүрээнд татвар, гааль, мөнгөний эргэлтийн мэдээ, мэдээллийг нэгтгэх, боловсруулах;
- Улсын санхүүгийн үйл ажиллагаанд шаардлагатай мэдээ мэдээллийг боловсруулж татварын бодлого хариуцсан сайдад хүргүүлэх;

---

[52] 2010. évi CXXII. Törvény a Nemzeti Adó- és Vámhivatalról

[53] 2017.02.22-től hatályos NAV SZMSZ Эх сурвалж: https://www.nav.gov.hu/nav/kozerdeku_adatok/altalanos_kozzeteteli_lista/nav_feladat_es_hataskore_ 1366633265651/szmsz/nav_szmsz

[54] Үндэсний татвар, гаалийн албаны Бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны дүрмийн 1-3.§ §

- Удирдах газар болон бусад мэдээллийн технологийн үүрэг хариуцсан хэлтсүүд чиг үүргийн хүрээнд хариуцсан, ялангуяа Хонжворт тоглоомын тухай хуулийн хүрээнд тавих төрийн хяналттай холбоотой үүссэн мэдээллийг мэдээлэл боловсруулах эрх бүхий байгууллагад хүргүүлэх;
- Төрийн нэрийн өмнөөс төсвийн болон улсын орлогод гэмт хэргийн улмаас үүссэн хохирлыг барагдуулахад чиглэсэн нэхэмжлэл гаргах;
- Байнгын албан хаагчдад зориулсан сургалт, давтан сургалт зохион байгуулах, эдгээрийг зохион байгуулах, сургалтын сэдвийг тогтоох;
- Хонжворт тоглоом зохион байгуулах, сугалаа, автомат тоглоомын машины бүртгэл, зөвшөөрөлтэй холбогдох асуудлыг хариуцах ба эдгээр үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдүүлэх, хууль тогтоомж зөрчсөн үйлдэлд хяналт тавих;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, мөн эдгээрээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах;
- Холбооны болон тусгай хууль тогтоомжийн дагуу хариуцсан үйл ажиллагаа болон эдгээрийн цахим санг ажиллуулахтай холбоотой үүсэх бусад үүргийг хүлээх,
- Ерөнхий асуудлаас гадна татвар, гааль, нэмэгдсэн өртгийн татвартай холбоотой мэргэшсэн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах;
- Хууль тогтоомжид заасан бусад үйл ажиллагаа явуулдаг байна.

ҮНДЭСНИЙ ТАТВАР, ГААЛИЙН АЛБАНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ҮТГА-ны бүтэц дотоод ажил үүргийн хуваарьт үндэслэн мэргэжлийн болон үйл ажиллагааны чиглэлээр гүйцэтгэх ажлыг хариуцсан хэсгүүдэд хуваагддаг. Нэгжийн зохион байгуулалтыг авч үзвэл ерөнхий газар/алба, газар/хэлтэс, салбар/төлөөлөгчийн газраас бүрдэнэ.[55] Үйл ажиллагааны хувьд татварын захиргааны, гааль – нэмэгдсэн өртгийн татварын захиргааны, гэмт хэрэгтэй тэмцэх, хэв журам сахиулах гэсэн үндсэн 4 чиглэлд хуваагддаг байна.

Үндэсний татвар, гаалийн алба бүтцийн хувьд дээд, дунд болон анхан шатны төвшинд үйл ажиллагаа явуулдаг газруудаас бүрддэг.

Дээд шатны байгууллага буюу төв газарт ҮТГА Ерөнхий удирдлага, Гэмт хэргийн /хэрэг бүртгэлийн/ ерөнхий газар ордог бол, дунд шатны байгууллагад Онцгой хэрэг ба Татвар төлөгчийн татварын ерөнхий газар[56], Бүс нутгийн гааль, санхүүгийн ерөнхий газрууд[57], Нисэх буудлын ерөнхий газар[58], Бэлэн байдлын ерөнхий газар[59], Давж заалдах газар[60], Мэргэжлийн шинжээчийн хүрээлэн[61], Бүс нутгийн гэмт хэргийн/хэрэг бүртгэлийн газар[62], Мэдээллийн технологийн хүрээлэн[63], Сургалт, эрүүл мэнд, Соёлын хүрээлэн[64], Эдийн засгийн хангамжийн газар[65] ордог байна. /зураг №1/

[55] Үндэсний татвар, гаалийн албаны Бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны дүрмийн 8. §

[56] Kiemelt Ügyek és Adózók Adó Főigazgatósága

[57] Regionális Vám- és Pénzügyőri Főigazgatóságok

[58] Repülőtéri Főigazgatóság

[59] Bevetési Főigazgatóság

[60] Fellebbviteli Igazgatóság,

[61] Szakértői Intézet

[62] Regionális Bűnügyi igazgatóságok

[63] Informatikai Intézet

[64] Képzési, Egészségügyi és Kulturális Intézet

[65] Gazdasági Ellátó Igazgatóság

Зураг №1 ҮТГА-ны бүтэц, зохион байгуулалт



ҮТГА-ны дарга байгууллагын үйл ажиллагааг 5 орлогч даргаар дамжуулан удирдах бөгөөд эдгээр орлогч дарга нар нь мэргэжлийн чиглэлийн дагуу асуудлыг хариуцаж ажиллана. /Зураг №2/

ҮТГА -ны бүтэц дэх газар, хэлтсээс үйл ажиллагааны чиглэлийн хувьд анхаарал татаж буй зарим нэгжийг онцлон авч бүтэц зохион байгуулалтыг нь дэлгэрэнгүй авч үзье.

Хэрэг бүртгэлийн газар нь Хэрэг бүртгэлийн координацийн газар, Төв мөрдөн байцаах газар, Хэрэг бүртгэлийн хангамжийн газар, Аудитын газар, Эрх зүй, захиргааны газар, Мэдээллийн технологийн газар, Хүний нөөцийн газар, Бараа, гэмт хэргийн эд мөрийн баримт хариуцсан газраас бүрддэг.

Нисэх буудлын удирдах газрын харьяанд Гаалийн процессын газар, Хожуу гаалийн процессын газар, Зөвшөөрөл, эрсдэлийн удирдлагын газар, Хилийн шалган нэвтрүүлэх газар, Дэг журмын, жижүүрийн газар, Захиргаа, эрх зүйн газар багтдаг.

Тус байгууллагын харьяанд Мэргэжлийн шинжээчийн хүрээлэн /Зураг №3/, Мэдээллийн технологийн хүрээлэн /Зураг №4/, Сургалт, эрүүл мэнд, соёлын хүрээлэн /Зураг №5/ гэсэн 3 хүрээлэн үйл ажиллагаа явуулдаг. Эдгээр хүрээлэнгүүд нь шаардлагатай шинжилгээ, судалгаа хийх, тухайн байгууллагын үйл ажиллагааг хөгжүүлэх, байгууллагын үйл ажиллагаа, ашиглагдаж буй програм хангамж, мэдээллийн сан зэргийг боловсронгуй болгох, албан хаагчдын эрүүл мэнд, нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиг үүрэгтэй ажилладаг байна. Хүрээлэнгүүдийн бүтцийн зураглалаас тэдгээрийн үйл ажиллагаа, хариуцаж буй чиг үүргийг харах боломжтой юм. Тухайлбал, Сургалт, эрүүл мэнд, соёлын хүрээлэн нь ҮТГА-ны сургалт, хүний нөөцийн ур чадварыг хөгжүүлэх асуудлыг бүхэлд нь хариуцдаг. Хүрээлэн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт, үргэлжилсэн сургалт зохион байгуулах, албан хаагчдад эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн болон бие бялдрын, сэтгэцийн байдлыг шалгах болон тэдний соёл, амралттай холбоотой арга хэмжээ, хооллох асуудлыг хариуцан зохион байгуулдаг байна. Сургалт зохион байгуулах ажлын хүрээнд мэргэжлийн албан хаагчдыг бэлтгэх сургалт, мөн суурь, мэргэшүүлэх сургалт, дунд шатны сургалтыг танхимын

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

болон алсын зайны сургалтын хэлбэрээр зохион байгуулж шалгалт авдаг байна. Сургалтыг хяналт шалгалт, шийдвэр гүйцэтгэл, харилцагчтай харилцах, хүний нөөцийн бодлого зэрэг ерөнхий салбар чиглэлээр зохион байгуулдаг бөгөөд эдгээр нь нарийвчлагдсан сэдвүүдэд задардаг байна. Эдгээр сургалтад тус албаны албан хаагч сайн дурааараа бүртгүүлэх боломжтой боловч сургалтад хамрагдах нь түүнийг ажил үүргээ гүйцэтгэхэд саад болохгүй, давхцахгүй байх шаардлага тавигддаг байна.

Зураг №2 Удирдлагын зохион байгуулалт



Хууль зүйн үндэсний хүрээлэн
www.nils.mn

Зураг №3 Мэргэжлийн шинжээчийн хүрээлэн



Зураг №4 Мэдээллийн технологийн хүрээлэн



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.ilt.gov.mn



Харин анхан шатны байгууллагад Аймаг, нийслэлийн татварын газар, Онцгой хэргийн татварын газар, Аймаг, нийслэлийн гааль, санхүүгийн газар, Нисэх буудлын газрууд, Харуул хамгаалалт, дэмжлэгийн газар[66], Бараа, гэмт хэргийн эд мөрийн баримт хариуцсан алба[67] зэрэг газар багтана.

Зохион байгуулалтын хувьд удирдлагын босоо тогтолцоотой буюу албан хаагч бүр өөрийн дээд шатны удирдлагын дор үйл ажиллагаа явуулна.

Дунд төвшний байгууллагын бүтэц зохион байгуулалтыг харуулахын тулд тус улсын хэлтэсийн зохион байгуулалттай Татвар, гаалийн албыг жишээ болгон үзье.

Мужийн ҮТГА-ны харьяа газрын дарга удирдах ба 4 орлогчтой байдаг. Эдгээр нь

- Гааль, санхүүгийн хяналтын асуудал эрхэлсэн орлогч[68];
- Хяналт шалгалтын асуудал эрхэлсэн орлогч[69];
- Татварын асуудал эрхэлсэн орлогч[70];
- Харилцах данс, шийдвэр гүйцэтгэлийн асуудал эрхэлсэн орлогч[71] дарга байна.

Үүнээс гадна Ерөнхий газрын даргын шууд урирдлага доор дараахь хэлтсүүд үйл ажиллагаа явуулна:

- Мэдээллийн хэлтэс[72];
- Захиргаа удирдлагын хэлтэс[73] ;
- Хууль, координаци, хууль ёсны хяналтын хэлтэс[74];
- Хүний нөөцийн бодлогын хэлтэс[75];
- Төлөвлөлт, хяналт шинжилгээний хэлтэс[76].

66 Őrzésvédelem- és Támogató Igazgatóság
67 Áru- és Bűnjelkezelő Hivatal
68 Vám és Pénzügyőri igazgatóhelyettes
69 Ellenőrzési igazgatóhelyettes
70 Adóügyi igazgatóhelyettes
71 Folyószámla-kezelési és Végrehajtási igazgatóhelyettes
72 Tájékoztatási osztály
73 Igazgatási osztályok
74 Jogi-koordinációs és Törvényességi osztály
75 Humánpolitikai osztály
76 Tervezési és elemzési osztály

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Татварын асуудал эрхэлсэн орлогч даргын удирдлага доор дараахь хэлтсүүд үйл ажиллагаа явуулна:

- Татвар төлөгчийн бүртгэлийн хэлтэс[77];
- Татварын орлогын мэдүүлгийн хэлтэс[78];
- Процесс ажиллагааны хэлтэс[79];
- Тэмдэгтийн хураамжийн хэлтэс[80];
- Олон нийттэй харилцах хэлтэс[81].

Хяналт шалгалтын асуудал эрхэлсэн орлогч даргын удирдлага доор дараахь хэлтсүүд үйл ажиллагаа явуулна:

- Ерөнхий гүйлгээний татварын хяналтын хэлтэс[82];
- Хувь хүн, хувираа хөдөлмөр эрхлэгчийн хяналтын хэлтэс[83];
- Онцгой татвар төлөгч, хамтарсан хуулийн этгээдийн хяналтын хэлтэс[84];
- Мэдээллийн технологийн хэлтэс;
- Эрсдэлийн удирдлага, сонгон шалгаруулах хэлтэс.

Гааль, санхүүгийн хяналтын асуудал эрхэлсэн орлогч даргын удирдлага доор дараахь хэлтсүүд үйл ажиллагаа явуулна:

- Гаалийн дараахь болон татварын хяналтын хэлтэс;
- Нэмэгдсэн өртгийн татварын бүртгэлийн хэлтэс;
- Нэмэгдсэн өртгийн татварын хяналтын хэлтэс;
- Оператив хяналтын хэлтэс;
- Дэг журмын, жижүүрийн хэлтэс.

Харилцах данс, шийдвэр гүйцэтгэлийн асуудал эрхэлсэн орлогч даргын удирдлага доор дараахь хэлтсүүд үйл ажиллагаа явуулна:

- Төлбөрийн хөнгөлөлтийн хэлтэс[85];
- Харилцах данс хариуцсан хэлтэс[86];
- Шийдвэр гүйцэтгэлийн хэлтэс[87];
- Хугацаа хэтэрсэн үлдэгдэл хариуцсан хэлтэс[88];
- Татан буулгах, төгсгөлийн тооцооны хэлтэс[89].

ҮНДЭСНИЙ ТАТВАР, ГААЛИЙН АЛБАНЫ АЛБАН ХААГЧИД

ҮТГА-ны харьяа байгууллагуудад хөдөлмөр эрхэлж буй албан хаагчид дараахь ангилалд хуваагдана. Үүнд: Төрийн захиргааны албан хаагч[90], Засгийн газрын хэрэг эрхлэгч[91], хөдөлмөр эрхлэгч[92], байнгын үйлчилгээний гэрээт ажилтан[93], албан

[77] Adóalany nyilvántartási osztály
[78] Bevallási osztály
[79] Eljárási osztály
[80] Illeték osztály
[81] Ügyfélkapcsolati osztály
[82] Általános Forgalmi Adó ellenőrzése főosztály
[83] Magánszemélyes és Egyéni Vállalkozások és Társas Vállalkozások ellenőrzése osztály
[84] Kiemelt Adóalanyok ellenőrzése osztály
[85] Fizetési Kedvezmények Osztály
[86] Folyószámla-kezelési Osztály
[87] Végrehajtási Osztály
[88] Hátralékkezelési Osztály
[89] Felszámolási és Végelszámolási Osztály
[90] Kormánytisztviselő
[91] Kormányzati Ügykezelő
[92] Munkavállaló
[93] Hivatásos szolgálati jogviszonyban álló tag

Хүний эрхийн үндэсний хороо
www.nhrc.gov.mn

хаагч[94] багтана.

ҮТГА-ны албан хаагчид дээрх ангиллын аль төрөлд хамаарч буйгаас шалтгаалан 2011 оны Нийтийн үйлчилгээний төрийн албан хаагчийн тухай 199 дүгээр хууль[95], 2015 оны Хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын байнгын албан хаагчдын үйл ажиллагааны эрх зүйн харилцааны тухай 42 дугаар хууль[96] болон 2012 оны Хөдөлмөрийн тухай 1 дүгээр хууль[97]-д заасан эрх, үүргийг эдэлж хариуцлага хүлээдэг байна[98].

Тус албанд томилох, буцааж авах, чөлөөлөх, зэрэг дэв, цол нэмэх/хасах зэрэг асуудал болон ажил олгогчийн эрхийг тухайн албан хаагчийн хариуцан ажиллаж буй удирдах албан тушаалтан ҮТГА-ны даргаас шилжүүлэн өгсөн эрхийн хүрээнд шийдвэрлэнэ[99]. Хэрэв нэг албан хаагчтай холбоотой хэд хэдэн шийдвэр гарсан бол хамгийн өндөр албан тушаалтны гаргасан шийдвэрийг хэрэгжүүлдэг байна[100].

2015 оны Хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын байнгын албан хаагчдын үйл ажиллагааны эрх зүйн харилцааны тухай 42 дугаар хуулийн 1 дүгээр зүйлд хуулийн үйлчлэх хүрээг тодорхойлсон байх ба h/ хэсэг болон 3 дугаар заалтад ҮТГА-ны байнгын албан хаагчид болон тэдгээрийн ойрын хамаатан садан ҮТГА-ны тухай хуульд заасан өөрчлөлтийн хамт энэ хуульд харьяалагдах тухай заажээ[101].

Хууль сахиулах албаны ёс зүйн үндсэн зарчим нь үнэнч байх, үндэсний эрх ашгийг эхэнд тавих, шударга байх, намын харьяалалгүй байх, хариуцлагатай байх, мэргэшсэн байх, багаар ажиллах чадвартай байх, ялгаварлан гадуурхахгүй байх, тэгш байдлыг эрхэмлэх, үлгэр жишээ байх зэрэг байна[102].

Албан хаагчдын цолны тухайд үндсэн 5 ангилалд хуваагддаг бөгөөд эдгээр цол нь тус бүрдээ 3-4 төрлийн цол агуулсан байдаг байна. Нийт хууль сахиулах байгууллагын албан хаагчдын цолны төрөл, түүнд тавигдах шаардлага нэгэн адил байх боловч алба хашиж буй байгууллагын таних тэмдэг, тамга, тэмдгийг хэрэглэснээр өөр хоорондоо ялгагдана[103].

Албан хаагчид дүрэмт хувцас эсхүл энгийн хувцастай албан үүргээ гүйцэтгэж болно. Дүрэмт хувцасыг байнгын алба хашиж буй албан хаагч, хууль тогтоомжид заасан тохиолдолд өндөр насны тэтгэвэрт гарсан хууль сахиулах байгууллагын өндөр настан өмсөх эрхтэй байна[104].

ҮТГА-ны албан хаагчийн эрх, үүрэг ба эрх, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхдээ авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч дурдъя.

Хилийн боомт, дамжин өнгөрөх газарт гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мөрдөн шалгах, захиргааны арга хэмжээ авах, гаалийн болон нэмэгдсэн өртгийн татварт хяналт тавих, гүний шалгалт хийх, харуул хамгаалалт хийх, захиргааны болон шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой даалгавар гүйцэтгэх, мөн эдгээрт хяналт тавих, шалгалт хийх эрх “санхүүгийн хянагч” буюу манайхаар татварын/гаалийн улсын байцаагчид олгогдсон байна. Иймд

94 Hivatásos állományú tagok

95 A közszolgálati tisztviselőkről szóló 2011. évi CXCIX. törvény

96 a rendvédelmi feladatokat ellátó szervek hivatásos állományának szolgálati jogviszonyáról szóló 2015. évi XLII. törvény

97 a munka törvénykönyvéről szóló 2012. évi I. törvény

98 Үндэсний татвар, гаалийн албаны Бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны дүрмийн 79. §

99 Үндэсний татвар, гаалийн албаны Бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны дүрмийн 68. §

100 Үндэсний татвар, гаалийн албаны Бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны дүрмийн 69. §

101 a rendvédelmi feladatokat ellátó szervek hivatásos állományának szolgálati jogviszonyáról szóló 2015. évi XLII. Törvény 1.§

102 Мөн тэнд 11.§

103 Мөн тэнд 15-16 §.§.

104 Мөн тэнд 17. §

санхүүгийн хянагчид хууль сахиулах үйл ажиллагаа хэрэгжүүлэх бөгөөд дүрэмт хувцас, албаны галт зэвсэг ашиглах эрхтэй, мөн холбогдох хууль тогтоомжид заасны дагуу албадлагын арга хэмжээ авах, хүч хэрэглэх хэрэгсэл ашиглах, ажил үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан тухайн хэрэгт холбогдох, шаардлагатай мэдээллээр хангах магадлалтай аливаа этгээдэд асуулт тавих, мэдээлэл авах эрхтэй байна. Мөн мэдээлэл авах хугацаанд тухайн этгээдийг түр саатуулах эрхтэй бөгөөд холбогдсон этгээд өөрийн мэдэж буй нөхцөл, мэдээллийн талаар санхүүгийн хянагчид хариулт өгөхөөс татгалзах эрхгүй. Хүч хэрэглэх хэрэгсэл ашиглахыг зөвхөн хууль ёсны үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн нөхцөлд хэрэглэх боломжтой.

ДҮГНЭЛТ

Унгар улсын Үндэсний татвар, гаалийн алба нь Үндэсний эдийн засгийн сайдын удирдлага доор үйл ажиллагаа явуулдаг төрийн захиргааны байгууллага бөгөөд галт зэвсэг хэрэглэх эрх бүхий хууль сахиулах буюу улсын төсөв, нийгмийн даатгалын сан, эрүүл мэндийн даатгалын сан, эсхүл улсын тусгай сан, зайлшгүй төлөх төлбөр, эдгээрээс төлөгддөг тусламж, татварын буцаан олголт, Холбооны гаалийн тухай хуулийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулийн үйлчлэлд хамаарах төлбөр тогтоох, түүнийг хураах, бүртгэх, шийдвэр гүйцэтгэх, буцаан олгох, шилжүүлэг хийх, хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хяналт тавих чиг үүрэгтэй хуулийн этгээдийн эрхтэй төсвийн төв байгууллага бөгөөд улсын төсөвт бие даасан бүлэг үүсгэдэг байгууллага байна.

Дээр дурдсан чиг үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь улсын хэмжээнд татвар, гааль, мөнгөний эргэлтийн мэдээ, мэдээллийг нэгтгэх, боловсруулах, Төрийн нэрийн өмнөөс төсвийн болон улсын орлогод гэмт хэргийн улмаас үүссэн хохирлыг барагдуулахад чиглэсэн нэхэмжлэл гаргах, хонжворт тоглоом зохион байгуулах, сугалаа, автомат тоглоомын машины бүртгэл, зөвшөөрөлтэй холбогдох асуудлыг хариуцах ба эдгээр үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдүүлэх, хууль тогтоомж зөрчсөн үйлдэлд хяналт тавих, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, мөн эдгээрээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, тус албаны үйл ажиллагаанд ашиглагдаж буй мэдээллийн технологи, програм хангамжийг хөгжүүлэх, гаалийн албаны албан хаагчдыг бэлтгэх, сургах, амралт, эрүүл мэнд, соёлын үйлчилгээ үзүүлэх зэрэг өргөн цар хүрээг хамардаг байна.

Унгар улсын Үндэсний татвар, гаалийн алба нь олон шатлал бүхий бүтэцтэй, удирдлагын босоо тогтолцоотой байна.

ҮТГА-ны бүтэц дотоод ажил үүргийн хуваарьт үндэслэн мэргэжлийн болон үйл ажиллагааны чиглэлийн дагуу 1/ татварын захиргааны, 2/ гааль – нэмэгдсэн өртгийн татварын захиргааны, 3/ гэмт хэрэгтэй тэмцэх, 4/ хэв журам сахиулах гэсэн үндсэн 4 чиглэлд хуваагддаг байна. Нэгжийн зохион байгуулалтыг авч үзвэл ерөнхий газар/алба, газар/хэлтэс, салбар/төлөөлөгчийн газраас бүрдэнэ.

Тус албаны харьяанд ажиллаж буй албан хаагчдыг төрийн захиргааны албан хаагч, Засгийн газрын хэрэг эрхлэгч, хөдөлмөр эрхлэгч, байнгын үйлчилгээний гэрээт ажилтан, байнгын албан хаагч гэж ангилдаг бөгөөд ангиллын дагуу эдлэх эрх, хүлээх хариуцлагын хэм хэмжээ нь тодорхойлогдож байдаг.

Ялангуяа хилийн боомт, дамжин өнгөрөх газарт ажиллаж буй “санхүүгийн хянагч” буюу манайхаар татварын/гаалийн улсын байцаагчид гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мөрдөн шалгах, захиргааны арга хэмжээ авах, гаалийн болон нэмэгдсэн өртгийн татварт хяналт тавих, гүний шалгалт хийх, харуул хамгаалалт хийх, захиргааны болон шийдвэр гүйцэтгэх

ажиллагаатай холбоотой даалгавар гүйцэтгэх, мөн эдгээрт хяналт тавих, шалгалт хийх эрх олгосон байна.

Мөн санхүүгийн хянагчид хууль сахиулах үйл ажиллагаа хэрэгжүүлэх бөгөөд дүрэмт хувцас, албаны галт зэвсэг ашиглах эрхтэй, мөн холбогдох хууль тогтоомжид заасны дагуу адбадлагын арга хэмжээ авах, хүч хэрэглэх хэрэгсэл ашиглах, ажил үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан тухайн хэрэгт холбогдох, шаардлагатай мэдээллээр хангах магадлалтай аливаа этгээдэд асуулт тавих, мэдээлэл авах эрхтэй байна. Мөн мэдээлэл авах хугацаанд тухайн этгээдийг түр саатуулах эрхтэй бөгөөд холбогдсон этгээд өөрийн мэдэж буй нөхцөл, мэдээллийн талаар санхүүгийн хянагчид хариулт өгөхөөс татгалзах эрхгүй байх зэрэг зохицуулалттай байдаг байна. Гэхдээ хүч хэрэглэх хэрэгсэл ашиглахыг зөвхөн хууль ёсны үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн нөхцөлд хэрэглэх боломжтой бөгөөд үүнийг нотлох шаардлага тавьдаг байна.

Унгар улсын туршлагаас харахад татвар, гаалийн байгууллагын үйл ажиллагаа нь хууль сахиулах, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, бүртгэл хөтлөх чиглэлүүг илүү нарийвчлан хөгжсөн харагдаж байна. Тухайлбал, ҮТГА-ны даргын шууд удирдлага доор ажилладаг Хэрэг бүртгэлийн газар нь гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдлийг мөрдөн шалгах, таслан зогсоох, эд мөрийн баримт хураах болон бусад арга хэмжээг авах эрхтэй, харин ҮТГА-ны харьяа хүрээлэнгүүд нь мэргэшсэн албан хаагчдыг бэлтгэх тогтолцоог болон албан хаагчдын эрүүл мэнд, амралт, соёлын арга хэмжээг хариуцдаг, татвар, гаалийн албаны үйл ажиллагаанд ашиглагдаж буй програм хангамжийг хөгжүүлэх, мэдээлэл боловсруулах үйл ажиллагааг сайжруулах, байгууллагын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэхэд шаардлагатай хяналт, шалгалтын арга зүй, технологийг шинэчлэх ажлыг хариуцан ажилладаг байна.

Үндэсний татвар, гаалийн алба улсын төсөв санхүүгийн нөхцөл байдлыг үнэлж болохуйц, бодит мэдээ, мэдээллээр хангагдаж байдаг онцлогтой байгууллагын хувьд улсын хэмжээний мөнгөний хөдөлгөөний бүртгэл, мэдээлэл, мөнгө угаахтай тэмцэх, залиланчийн үйлдлийн эсрэг болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг үйл ажиллагааг хариуцан, хяналт тавьж ажилладаг байна.

ЭХ СУРВАЛЖ

1. Үндэсний татвар гаалийн албаны тухай 2010 оны 122 дугаар хууль /2010. йvi CXXII. Tцrvйny a Nemzeti Ady- йs Vбmhivatalryl/

2. Үндэсний татвар, гаалийн албаны Бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны дүрэм

3. “Үндэсний татвар, гаалийн албаны түүх, чиг үүрэг, бүтэц зохион байгуулалтын хөгжил” судалгаа. 2016 он.

4. “Төрийн захиргааны албан хаагчийн хариуцлагын тогтолцоо” PhD зэрэг горилсон эрдэм шинжилгээний судалгааны ажил. 2010 он.

5. 2011 оны Нийтийн үйлчилгээний төрийн албан хаагчийн тухай 199 дүгээр хууль

6. 2015 оны Хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын байнгын албан хаагчдын үйл ажиллагааны эрх зүйн харилцааны тухай 42 дугаар хууль

7. 2012 оны Хөдөлмөрийн тухай 1 дүгээр хууль

Хавсралт №3

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ГААЛИЙН БАЙГУУЛЛАГА

Солонгос улсад анх 1878 онд Думожин нэртэй тэнгисийн гаалийн байгууллага байгуулагдсан бөгөөд худалдааны эрэлт хэрэгцээ, зорчигчдын өсөн нэмэгдэлтээс үүдэн 1970 онд Солонгосын гаалийн байгууллага нэрээр (Korea Customs Service) бие даасан байгууллага болсон. Тус байгууллага нь Засгийн газрын байгууллагын тухай (Government Organization Act) хуульд зааснаар Стратеги, санхүүгийн яамны (Ministry of Strategy and Finance) харьяанд үйл ажиллагаагаа явуулдаг.

Засгийн газрын байгууллагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 6-д зааснаар Солонгосын гаалийн байгууллага(цаашид СГБ гэх) нь Комиссар болон Дэд комиссартай байна. Дэд комиссарыгулс төрийн албанд (political service) нийтийн албан хаагчдын дундаас, Комиссарыг Ахлах иргэний байгууллагын албанд (Senior Civil Service) харьяалагдах төв байгууллагын (gen eral service) төрийн нийтийн албан хаагчдын дундаас (State public officials) томилогддог.

СГБ нь 1970 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш гаалийн байгууллагын системд хийсэн томоохон өөрчлөлтүүдийн нэг нь Санхүүгийн яам ба СГБ хоорондын эрх мэдлийг тусгаарласан явдал юм. Бие даасан үйл ажиллагаатай СГБ-г үүсгэн байгуулагдсанаас хойш Санхүүгийн яам зөвхөн гаалийн тарифын бодлогыг боловсруулах чиг үүрэгтэй буюу бодлогод чиглэсэн үйл ажиллагааг хариуцсан байгууллага болсон бол СГБ нь гаалийн байгууллага, түүний үйл ажиллагаатай холбоотой бусад бүх асуудлуудыг буюу гаалийн байгууллагуудын удирдлага, хяналт шалгалтыг хариуцах болсон. Ингэснээр гаалийн бодлого зохицуулах болон гаалийн байгууллагын үйл ажиллагаа бэхэжсэн гэж үздэг байна.

ТАТВАР, ГААЛИЙН ГАЗАР (Tax and Customs office)

Солонгосын Стратеги, санхүүгийн яамны Гаалийн бодлого зохицуулах чиг үүрэг бүхий Татвар ба гаалийн газарнь хувь хүний татвар, аж ахуй нэгжтэй холбогдох татвар, өмчтэй холбоотой татвар, импортын гаалийн татвар зэрэг 14 ангилалд багтах үндэсний татварын эх үүсвэрийн бодлогыг боловсруулан гаргадаг. Тус байгууллага нь төсвийн орлого бүрдүүлэх асуудлыг хариуцдаг бөгөөд татварын орлогыг хураах, татварын хэмжээг тодорхойлох асуудлыг хариуцдаг байна. Татвар, гаалийн газрын үндсэн чиг үүрэгт дараахь асуудлууд багтдаг. Үүнд:

- Татварын бодлого болон татварын системийг боловсруулах;
- Татварын орлогын зарцуулалтыг хянах, татварын урамшууллын системийг бий болгох, хөгжүүлэх;
- Татварын орлогын хэмжээг нэмэгдүүлэх ба татварын орлогын хэтийн төлвийг гаргах;
- Гаалийн татварын хэмжээг Олон талт тарифын хамтын ажиллагаа болон Чөлөөт худалдааны хэлэлцээртэй уялдуулах зохицуулах.

Татвар, гаалийн газрын бүтэц, зохион байгуулалтын талаар товч авч үзье.

Татвар, гаалийн байгууллагыг Ерөнхий захирал удирдах бөгөөд 4 дэд захиралтай байна. Дэд захирлууд нь мэргэжлийн чиглэлийн дагуух асуудлыг хариуцан, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажилладаг байна. Дэд захирлуудын нь дараахь асуудлуудыг хариуцан ажилладаг. Үүнд:

- Татварын бодлого зохицуулалтын асуудал хариуцсан дэд захирал дараахь асуудлыг хариуцна:
  - Татварын бодлогын зохицуулалтын хэлтэс;
  - Татварын шилжилгээний хэлтэс;
  - Татварын хөнгөлөлтийн хэлтэс;

- Татварын хууль тогтоомжийг боловсруулах хэлтэс.
- Хувь хүн ба аж ахуй нэгжийн орлогын албан татварын асуудал хариуцсан дэд захирал дараахь асуудлыг хариуцна:Орлогын албан татварын хэлтэс;
- Аж ахуй нэгжийн татварын хэлтэс;
- Санхүүгийн татварын хэлтэс.
- Үл хөдлөх хөрөнгийн ба хэрэглээний татварын асуудал хариуцсан дэд захирал дараахь асуудлыг хариуцна:
- Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хэлтэс;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын хэлтэс;
- Хувь хүний орлогын албан татварын хэлтэс.
- Олон улсын татвар ба гаалийн харилцааны асуудал эрхэлсэн дэд захирал дараахь асуудлыг хариуцна:
- Гаалийн бодлогын зохицуулалтын хэлтэс;
- Олон улсын татварын хэлтэс;
- Үйлдвэрлэлийн тарифын хэлтэс;
- Татварын гэрээний хэлтэс;
- Гаалийн хамтын ажиллагааны хэлтэс;
- Чөлөөт худалдааны хэлэлцээрийн хэрэгжилтийн хэлтэс

СОЛОНГОСЫН ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

СГБ нь үндсэн чиг үүргийн хүрээнд гаалийн бүрдүүлэлт, гаалийн татвар ногдуулах ба хураах, хууль бусаар хил давуулах асуудлыг хянах зэрэг ажиллагааг хариуцан ажилладаг. Хэрэгжүүлж буй үйл ажиллагаануудын гол зорилго нь төсвийн орлогыг баталгаажуулах, дотоодын үйлдвэрлэлийг хамгаалахад оршино.СГБ-н үндсэн чиг үүрэг нь дараахь долоон төрөлтэй байна:

1. Зорчигч болон импорт, экспортын барааг хянах;
2. Дотоодын татвар болон гаалийн татварыг хураах замаар төсвийн орлогыг бүрдүүлэх;
3. Хууль бус импортын бараатай тэмцэх замаар дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах;
4. Нийгмийн аюулгүй аюулгүй байдал, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор мансууруулах бодис, галт зэвсэг, аюултай хоол, хүнсийг хилээр нэвтрүүлэх асуудлыг хянах;
5. Экологийн тэнцвэрт байдал болон байгаль орчныг хамгаалах зорилгоор хилээр химийн хорт бодис болон ховор ургамал/амьтныг нэвтрүүлэх асуудлыг хянах;
6. Шударга өрсөлдөөнийг хамгаалах үүднээс оюуны өмчийн эрхийг болон бараа, бүтээгдэхүүний гарал үүслийг нотлох баримтыг хянах;
7. Хууль бус мөнгөний гүйлгээ болон гадаад валютын гүйлгээний эргэлтэд хяналт тавих.

СГБ нь хүчирхэг эдийн засаг болон аюулгүй нийгмийг бүрдүүлэхийн тулд гаалийн хил хязгаарыг хянах эрхэм зорилгын хүрээнд хөгжингүй худалдааны улс болгохын тулд дэлхийн хамгийн сайн гаалийн байгууллага болох зорилт тавьж ажилладаг.

СГБ-ЫН АЛБАН ХААГЧДЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

Гаалийн байгууллагын албан хаагчийн ёс зүйн дүрмийн гол зарчим нь бүтээлчээр сэтгэх, хэрэглэгчийн дуу хоолойг сонсох, идэвхтэй ажиллах, газар дээр нь шийдвэрлэх, соёлтой харилцах гэсэн үндсэн 5 зүйл байдаг.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Гаалийн байгууллагын албан хаагчын эрх, үүрэг

Солонгосын гаалийн байгууллагын албан хаагчдыг хууль тогтоомжид заасны дагуу тухайн ажил үүргийн онцлог шинжээс хамааран хууль сахиулагчаар эсхүл төрийн нийтийн албан хаагчаар томилох бөгөөд албан тушаалын ангилалдаа нийцсэн эрх эдэлж, үүрэг хэрэгжүүлнэ.

Солонгосын гаалийн байгууллагын Аудитын бодлого зохицуулах товчоо, Мөрдөн шалгах хяналт шалгалтын товчоо болон Мэдээллийн менежмент, гадаад харилцааны товчоо нь хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагад тооцогддог байна.

Гаалийн байгууллагын албан хаагч шударга бусаар ажиллах, мөрдөн шалгах эрхээ урвуулан ашиглах, байцаасан хүнээ дахин байцаах зэрэг хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Гаалийн байгууллагын албан хаагч дүрэмт хувцастай байх ба шаардлагатай тохиолдолд галт зэвсэг биедээ авч явах болон хэрэглэхийг зөвшөөрдөг байна. Харин ажил үүргээ гүйцэтгэх явцад дүрэмт хувцасгүй, бусад баримт бичгээр албан тушаалаа нотлож чадахгүй бол түүний өгсөн үүрэг даалгаварыг биелүүлэх, асуултад хариулахаас татгалзах эрх тухайн хүнд олгогдсон байна..

Төрийн нийтийн албан хаагчийн цолны төрөл, албан тушаалын зэрэг дэв

Гаалийн төв байгууллагын төрийн албан хаагчдийн ажлын чиг үүрэг болон төрлөөс хамаарч I-IX гэсэн зэрэг олгодог.

Төрийн нийтийн албан хаагчийн тухай хуулийн 28-р зүйлийн 1-т олон нийтийн албан тушаалтныг нээлттэй өрсөлдөөнт шалгалтаар сонгон шалгаруулж авна гэж заасан байдаг хэдий ч зарим тохиолдолд нээлттэй сонгон шалгаруулалт шаардлагагүй. Тухайлбал, үйлчилгээний тусгай салбар, арал, алс газарт томилогдож байгаа хүнийг нээлттэй өрсөлдөөнт ажил шалгаруулалтаар шалгаруулах боломжгүй байдаг байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХИЧЭЭЛИЙН www.nli.gov.mn

Зураг №1 Солонгосын гаалийн байгууллагын бүтэц



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.mli.gov.mn

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ:

1. Солонгосын гаалийн тухай хууль. Customs Act.1949.
2. Засгийн газрын байгууллагын тухай хууль. Government Organization Act. 1948
3. Development History of the Korea Customs Service and its Automation. Korea Customs Service 2012.
4. Төрийн нийтийн албан хаагчийн тухай хууль. State Public Officials Act. 1949.
5. Хууль сахиулахын албан хаагчийн тухай. Enforcement Officers Act. 1995
6. Татвар болон Гаалийн байгууллагав Tax & Customs Office. https://english.mosf.go.kr/co/selectAboutMosf.do?boardCd=C0006#link
7. Солонгосын Гаалийн байгууллага. Korean Customs Service. http://www.customs.go.kr/kcshome/site/index.do?layoutSiteId=english

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭЛ
www.nli.gov.mn

ШИНЭ ЗЕЛАНДЫН ГААЛИЙН АЛБА

Шинэ Зеланд Улсад анх 1840 онд[105] гаалийн байгууллага байгуулагдсан. Тус улсын гаалийн байгууллагын чиг үүрэг 175 жилийн өмнө[106] үүсэн байгууллагдснаас цагаас хойш томоохон өөрчлөлтөд ороогүй улсын нэг юм.

Гаалийн байгууллага нь хилийн албa, түүний дэд бүтцийг хангадаг бөгөөд энэ нь Шинэ Зеландыг нутаг дэвсгэр, аюулгүй байдлыг хамгаалах, эдийн засгийг хөгжүүлэхэд нөлөөлдөг гэж үздэг байна.

Шинэ Зеландын гаалийн байгууллага нь хил хамгаалах, аюулгүй, ашигтай худалдаа, аялалыг дэмжиж туслаж өгөх, Титэм орлогыг (Crown revenue) бүрдүүлэх гэсэн гурван үндсэн үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Гаалийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаар “Гаалийн байгууллагын акциз[107]1996” хууль болон бусад үйл ажиллагаанд нь хамааралтай журмаар зохицуулагддаг. Үүнээс гадна 70 гаруй хууль тогтоомжид тус байгууллагын үйл ажиллаагааны үндсэн чиг үүрэгт хамаарах асуудлыг зохицуулдаг.

ШИНЭ ЗЕЛАНДЫН ГААЛИЙН БАЙГУУЛЛАГА

Шинэ Зеландын гаалийн байгууллага нь Санхүү, эдийн засгийн яамны харьяанд үйл ажиллагаа явуулдаг. Үйл ажиллагааны үндсэн зорилго нь үүсэж болзошгүй аюул заналхийлэл, эрсдлийг Шинэ Зеландын хилээр нэвтрэхээс хамгаалах явдал юм. Тухайлбал, хууль бус зэвсэг, зохимжгүй материал, мансууруулах бодис, аюултай бодис болон бусад хүнд аюул, заналхийлэл учруулж болзошгүй бараа, бүтээгдэхүүн зэргийг хилээр нэвтрүүлэхгүй байх асуудлыг хариуцдаг байна.

ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Шинэ Зеландын гаалийн байгууллага нь тус улсын хамгийн анхны Засгийн газрын байгууллагуудын нэг юм.

Гаалийн байгууллагыг Удирдах зөвлөл удирдана. Удирдах зөвлөлийн дарга нь Гаалийн албаны Ерөнхий дарга байна.

Гаалийн байгууллага гаалийн хилээр нэвтрэх биологийн аюулгүй байдалтай холбогдох зүйлс болох хүнс болон бусад хөдөө аж ахуйн зүйлсийн хяналтыг хариуцдаггүй харин Аж үйлдвэрийн яам хариуцдаг байна.

Гаалийн албыг Ерөнхий дарга удирдах ба түүний удирдлага доор дараахь асуудал, хөтөлбөрийг хариуцан ажилладаг үндсэн нэгжүүд үйл ажиллагаа явуулдаг байна.

- Гааль 2020 (Customs 2020);
- Санхүү,Стратеги болон Гүйцэтгэл (Finance, Strategy and Performance);
- Мэдээллийн алба (Information Services);
- Үйл ажиллагаа(Operations);
- Хүмүүс болон Чадвар (People and Capability);
- Бодлого, Хууль зүй болон Засаг(Policy, Legal and Governance).

[105] http://www.customs.govt.nz/about/profile/Pages/our-history.aspx

[106] http://www.customs.govt.nz/about/profile/Pages/our-history.aspx

[107] Customs and Excise Act 1996.

ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧДЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

Гаалийн байгууллага нь улс орон даяар тархсан 1200 гаруй[108] албан хаагчтай үйл ажиллагаа явуулдаг. Гаалийн албан хаагчид гаалийн нисэх онгоцны албан хаагч, далайн гаалийн албан хаагч, нохой сургагч мэргэжилтэн, мөрдөн шалгах ажиллагааны аналист, хуульч, менежер, зөрчил хянан шалгагч, хүний нөөцийн мэргэжилтэн, бичиг хэргийн ажилтан, техникийн мэргэжилтэн зэрэг ордог.

Гаалийн байгууллагын албан хаагчдийг гаалийн байгууллагын албан хаагч болон гаалийн байгууллагын туслах албан хаагч[109] гэж хоёр ангилдаг. Гаалийн албан хаагч болох хүсэлтэй этгээд тус албанд ажиллах хүсэлт илэрхийлсэн өргөдөл гаргах бөгөөд тухайн этгээд анхан шатны шаардлага хангасан тохиолдолд гаалийн албан хаагчийг бэлтгэх есөн 7 хоногийн сургалтад хамрагдана. Энэ хугацаанд дадлагажигчаар ажиллаж эхлэдэг бөгөөд сургалтын хөтөлбөрийг амжилттай дуусгаснаар Гаалийн албан хаагчаар томилогдож тангараг өргөнө.

Шинэ Зеландын Гаалийн байгууллага нь хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагын нэг бөгөөд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг юм.

Гаалийн байгууллагын албан хаагчийн албан тушаалын цол нэмэх, зэрэг дэв дэвших асуудлыг ихэвчлэн гурван жил[110]тутамд авч хэлэлцдэг байна. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл, тавигдах шаардлагыг албан хаагчтай байгуулсан хөдөлмөрийн гэрээнд тусгаж болдог.

Гаалийн байгууллагын тухай хуульд зааснаар гаалийн албан хаагч дараах эрх үүрэгтэй. Үүнд: мөрдөн байцаах ажиллагаа явуулах, шаардлагатай гэж үзвэл аль нисэх онгоцны зогсох зурвасаас эхлээд бүх барилга, байгууламж дээр хянан шалгалт явуулах[111], нэгжлэх хийх зэргийн эрх дурдаж болох юм. Гаалийн албан хаагч Гаалийн байгууллагын тухай хуульд заасан тусгай эрхээ[112] зөвхөн гаалийн зөрчил гаргасан байх магадлалтай тохиолдолд ашиглаж болно. Үүнээс гадна хуулийн 209 зүйлд заасны дагуу сэжигтэй этгээдийг гэмт хэрэг үйлдэх, үйлдэхийг завдсан, үйлдсэн тохиолдолд сэжиглэсэн өдрөөс эхлэн 7 хоног хүртэл хугацаагаар түр баривчлах эрхтэй[113].

Гаалийн байгууллагын тухай хуулийн 176-д зааснаар[114] гаалийн байгууллагын албан хаагчийг албан үүргээ гүйцэтгэж байх үед ямар нэгэн байдлаар айлгаж сүрдүүлэх, дарамтлах, санаатайгаар саад болох, эсэргүүцэл үзүүлсэн үйлдэл гэм буруу нь тогтоосон бол 12 сар хүртэл хугацаагаар хорих эсхүл 15,000 доллараар торгох арга хэмжээ авдаг байна.

Гааль, Хэрэглээний татварын тухай 1996 хуулийн 249-д зааснаар[115] мэргэшсэн, бэлтгэгдсэн хүнийг Гүйцэтгэх албан хаагчийг (хуулийн 248-д Гаалийн Ерөнхий дарга гэж нэрийднэ[116]) гаалийн алба хаагчаар томилж болох бөгөөд эдгээр нь гаалийн байгууллагын гүйцэтгэх үйл ажиллагаанд шаардлагатай ур чадвартай, мэргэшсэн, тусгайлан бэлтгэгдсэн этгээдэд гаалийн албан хаагчийн үйл ажиллагааг гүйцэтгүүлэхийг эрх олгож[117] болдог бөгөөд эдгээр нь ихэнхдээ цагдаагийн болон

[108] http://www.customs.govt.nz/about/profile/whoweare/Pages/default.aspx

[109] http://www.customs.govt.nz/about/careers/acustomscareer/Pages/default.aspx

[110] Position Description. Customs Officer. New Zealand Customs Office. 2016. p.4.

[111] Customs and Excise Act 1996. 137-b

[112] Customs and Excise Act 1996.140-2.

[113] Customs and Excise Act 1996.174-1.

[114] Customs and Excise Act 1996. 176.

[115] Customs and Excise Act.1996. 249

[116] Customs and Excise Act. 1996.248.

[117] Customs and Excise Act. 1996.250.

зэвсэгт хүчний байгууллагын гишүүн[118] байдаг байна. Тэдний гэрээг 3 жил хүртэлх хугацаагаар шинэчилнэ.

Зураг №1 Шинэ Зеландын гаалийн байгууллагын Удирдах зөвлөлийн бүтэц[119]

Удирдах Зөвлөл



Зураг №2 Шинэ Зеландын гаалийн байгууллагын дунд шатны байгууллагын бүтэц[120]

Ахлах удирдлагын бүтэц



Шинэ Зеландын гаалийн байгууллагын албан хаагчдын ёс зүйн дүрэмд[121]. 1/Шударга, 2/Голч, 3/Хариуцлагатай, 4/Итгэл даасан байх гэсэн үндсэн 4 стандартын хүрээнд албан хаагчдаас шаардах зан байдлыг тодорхойлсон байна. Гаалийн байгууллагын бүх албан хаагч нэхүү ёс зүйн дүрэмтэй нийцсэн байдлаар авирлах, бусдыг энэхүү ёс зүйн дүрэмтэй нийцсэн байдлаар авирлахыг дэмжих, ёс зүйн дүрэмд нийцээгүй зан байдал гаргасан тохиолдолд үүнийг мэдэгдэх үүрэгтэй байдаг байна. Ялангуяа гаалийн менежерүүдийн тухайд нэмэлт шаардлага тавигдах бөгөөд үүнд сайн ажилчин байж, ажилчидтай соёлтой боловсон хандах,

118 Customs and Excise Act. 1996.252-b.

119 Annual Report 2016. P.30. http://www.customs.govt.nz/news/resources/corporate/Documents/AR20152016.pdf

120 Annual Report 2014/2015. p.28

121 New Zealand Customs Service. Code of Conduct http://www.customs.govt.nz/news/resources/corporate/Documents/Code%20of%20conduct.pdf

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.mli.gov.mn

ёс зүйн дүрэмд заасан зан байдлын стандартыг үлгэр дурайлал болгож харуулах, ёс зүйн дүрмийг бодитойгоор хэрэгжүүлэх үүрэгтэй байна.

Ёс зүйн дүрэмд нийцээгүй зан байдлыг хүлээн зөвшөөрөхгүй. Ийм зан байдал гаргасан албан хаагчид гаалийн байгууллагын сахилгын бодлого, журмын дагуу сахилгын арга хэмжээ авна.

Гаалийн албан хаагчид тавигдах ерөнхий шаардлага бол шударга, мэргэжлийн, хувийн ашиг сонирхолд автахгүй, нэг талыг баримтлахгүй, хүн бүрт хүндэтгэлтэйгээр хандах, бүх ард түмний сайн сайхны төлөө, улс төрийн төвийг сахисан, бусдын нэр хүндэд хор учруулахгүй байх явдал юм.

Зураг №3. Гаалийн байгууллагын бүтэц[122]



АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. Гааль болон Хэрэглээний татварын тухай хууль 1996. Customs and Excise Act 1996.

2. Шинэ Зеландын гаалийн тухай хууль. Ёс зүйн дүрэм. New Zealand Customs Service. Code of Conduct. Сүүлд нэвтэрсэн. 2017

3. Шинэ Зеландын Гаалийн байгууллагын 2016 оны жилийн тайлан. Annual Report 2016. New Zealand Customs Service. Сүүлд нэвтэрсэн. 2017

4. Шинэ Зеландын гаалийн байгууллагын албан ёсны вэб хуудас. New Zealand Customs Service official website. Сүүлд нэвтэрсэн. 2017
http://www.customs.govt.nz/Pages/default.aspx

---o0o---

[122] http://www.customs.govt.nz/about/profile/organisationalstructure/Pages/default.aspx

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.edu.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.legal.mn

ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ /2008 ОН/, ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХАРЬЦУУЛАЛТ[1]

Гаалийн тухай хууль/2008 он/ ба Гаалийн тухай хууль/шинэчилсэн найруулга/-ийн төслийн өөрчлөлтийг харуулсан харьцуулсан хүснэгтийг хавсаргав.

Хавсралт

№	ХҮЧИН ТӨГӨЛДӨР ДАГАЖ МӨРДӨЖ БАЙГАА ХУУЛЬ	ХУУЛИЙН ТӨСӨЛ	КИОТО КОНВЕНЦИ ХАВСРАЛТ	ТАЙЛБАР
1.	**ГААЛИЙН ТУХАЙ** /шинэчилсэн найруулга/	**ГААЛИЙН ТУХАЙ**		*Хуулийн нэрээс "/шинэчилсэн найруулга/" гэснийг хассан*
2.	**I ХЭСЭГ** **Ерөнхий зүйл**	**I ХЭСЭГ** **ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**		-
3.	**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ** **Нийтлэг үндэслэл**	**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ** **НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**		-
4.	**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**	**1 дүгээр зүйл.Хуулийн зорилго**		*1 дүгээр зүйлийн гарчгийн "зорилт" гэснийг "зорилго" гэж өөрчилсөн*
5.	1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлт хийх, гаалийн хяналт хэрэгжүүлэх журам, гаалийн бүрдүүлэлтийн горим, нөхцөл, шаардлагыг тогтоох, гаалийн байгууллагын тогтолцоо, гаалийн байгууллага, албан тушаалтны эрх, үүргийг тодорхойлох, тэдгээрийн шийдвэрт иргэнээс гомдол гаргах, түүнийг гаалийн байгууллага, албан тушаалтнаас шийдвэрлэх, гаалийн хууль тогтоомжийг зөрчигчид хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	1.1.Энэ хуулийн зорилт нь бараа, тээврийн хэрэгсэлд үндэсний аюулгүй байдлын тусгайлсан чиг үүргийн зорилгоор гаалийн хяналт, бүрдүүлэлтийг хэрэгжүүлж, гаалийн бүрдүүлэлтийн горимын үндсэнд Монгол Улсын гаалийн хилээр нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэн хууль ёсны гадаад худалдааг хөнгөвчилж хялбарчлах үйл ажиллагаа болон гаалийн албаны зохион байгуулалт, бүрэн эрх, эрх хэмжээ, гүйцэтгэх үүрэг, гаалийн албан тушаалтан, тэдгээрийн эрх зүйн байдлыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.		*Хуулийн 1 дүгээр зүйлийг бүхэлд нь өөрчлөн найруулсан*
6.	**2 дугаар зүйл.Хууль тогтоомж**	**2 дугаар зүйл.Хууль тогтоомж**		-
7.	2.1.Монгол Улсын гаалийн хууль тогтоомж нь Үндсэн хууль, Татварын ерөнхий хууль, энэ хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай, Хилийн боомтын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.	2.1.Монгол Улсын гаалийн хууль тогтоомж нь Үндсэн хууль, Захиргааны ерөнхий хууль, энэ хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.		*Хуулийн 2.1 дэх заалтын "Хилийн боомтын тухай хууль болон" гэснийг тус хассан*

[1] Тус харьцуулалтыг ГЕГ-ын захиалгаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ж.Бариаширсүрэн, Б.Сүнжидмаа нар хамтран гүйцэтгэж, зөвлөхөөр ХЗҮХ-ийн захирал С.Энхцэцэг, Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор, профессор Д.Зүмбэрэллхам нар ажиллав.

8.	2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг дагаж мөрдөнө.	2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг дагаж мөрдөнө.		-
9.	2.3.Монгол Улсын чөлөөт бүсэд энэ хуульд зааснаас өөрөөр тогтоож болно.	-		*Хуулийн 2.3 дахь хэсгийг бүхэлд нь хассан*
10.	**3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**	**3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**		-
11.	3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:	3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:		-
12.		3.1.4."гаалийн шалгалт" гэж гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилт, гаалийн хилээр нэвтрүүлэх барааны нэр төрөл, тоо хэмжээ, үнэ болон бусад үзүүлэлт нь гаалийн мэдүүлэгтэй тохирч байгаа эсэхийг шалгах үйл ажиллагааг;		
13.				
14.	3.1.1.**"бараа"** гэж гаалийн хилээр нэвтрүүлэх ачаа, тээш, эд юмс, валют, валютын үнэт зүйл, улс хоорондын шуудангийн илгээмж, бүх төрлийн эрчим хүч, мал, амьтан, ургамал зэрэг хөдлөх эд хөрөнгө болон энэ хуулийн 3.1.5-д зааснаас бусад тээврийн хэрэгслийг;	3.1.5."бараа" гэж гаалийн хилээр нэвтрүүлэх эд юмс, валют, валютын үнэт зүйл, улс хоорондын шуудангийн илгээмж, мал, амьтан, ургамал, зэрэг бүх төрлийн хөдлөх хөрөнгө, зураг төсөл, эрчим хүч, цахим мэдээлэл тээгч хэрэгсэлд хадгалсан, эсхүл цахим сүлжээгээр дамжуулсан мэдээллийн технологийн програм хангамж, дүрс, дуу бичлэг болон тэдгээртэй адилтгах бусад бичгэн болон тоон мэдээлэл, бүтээгдэхүүн зэрэг биет болон биет бус хөрөнгө болон энэ хуулийн 3.1.9-д зааснаас бусад тээврийн хэрэгслийг;		*Хуулийн 3.1.1 дэх заалт буюу "бараа"-ны тодорхойлолтыг бүхэлд нь өөрчлөн найруулсан*
15.	3.1.2.**"монголын бараа"** гэж энэ хуулийн 99.1-д заасан горимын дагуу боловсруулалт хийснээс бусад Монгол Улсад үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, эсхүл Монгол Улсын нутаг дэвсгэр дээр чөлөөт эргэлтэд байгаа гадаадын барааг;	3.1.6."монголын бараа" гэж энэ хуулийн 209.1-д заасан гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу боловсруулалт хийснээс бусад Монгол Улсад тарьж ургуулсан, өсгөж бойжуулсан болон үйлдвэрлэсэн бараа, эсхүл Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аливаа хязгаарлалтгүй, чөлөөт эргэлтэд байгаа барааг;		*Хуулийн 3.1.1 дэх заалтаас "бүтээгдэхүүн" гэснийг хассан*
16.	3.1.3.**"гадаадын бараа"** гэж энэ хуулийн 3.1.2-т зааснаас бусад барааг;	3.1.7."гадаадын бараа" гэж энэ хуулийн 3.1.6-д зааснаас бусад барааг;		*Хуулийн 3.1.3 дахь заалтын "3.1.2" гэснийг "3.1.7" гэж өөрчилсөн*
17.	3.1.4.**"чөлөөт эргэлтэд байгаа бараа"** гэж гаалийн хууль тогтоомжоор тогтоосон хязгаарлалтгүйгээр Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрт захиран зарцуулах барааг;	3.1.8."чөлөөт эргэлтэд байгаа бараа" гэж гаалийн хууль тогтоомжоор тогтоосон хязгаарлалтгүйгээр Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрт захиран зарцуулах барааг;		-

ХУУЛЬ ЗҮЙН ХУДАЛДАН АВАЛЦАХ ХУРЭЭЛЭН www.ulsg.gov.mn

18.	3.1.5.**“тээврийн хэрэгсэл”** гэж бараа болон зорчигчийг улс хооронд тээвэрлэж гаалийн хилээр 6 сараас дээшгүй хугацаагаар нэвтрэх бүх төрлийн тээврийн хэрэгсэл, түүний дотор чингэлэг, ердийн хөсөг, тухайн аяллын хугацаанд тээврийн хэрэгсэлд шаардагдах шатахуун, тосолгооны материал, сэлбэгийг;	3.1.9.“тээврийн хэрэгсэл” гэж бараа болон зорчигчийг улс хооронд тээвэрлэж гаалийн хилээр зургаан сараас дээшгүй хугацаагаар нэвтрэх бүх төрлийн тээврийн хэрэгсэл, түүний дотор бүх төрлийн чингэлэг, тээврийн хэрэгслийн шатахууны саванд байгаа шатахуун, тос, тослох материал, аялал болон маршрутын хугацаанд шаардагдах сэлбэгийг;		*Хуулийн 3.1.5 дахь заалтын “ердийн хөсөг, тухайн аяллын хугацаанд тээврийн хэрэгсэлд шаардагдах шатахуун, тосолгооны материал,” гэснийг “тээврийн хэрэгслийн шатахууны бак-д буй шатахуун, аяллын хугацаанд шаардагдах” гэж өөрчилсөн*
19.	3.1.6.**“тээвэрлэгч”** гэж гаалийн хилээр бараа, зорчигч нэвтрүүлэх, эсхүл гаалийн нутаг дэвсгэрт гаалийн хяналт дор тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээдийг;	3.1.10.“тээвэрлэгч” гэж гаалийн хилээр бараа, зорчигч нэвтрүүлж байгаа, эсхүл гаалийн нутаг дэвсгэрт гаалийн хяналтдоор тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж байгаа субъект болон тээврийн хэрэгслийг жолоодож байгаа этгээдийг;		*Хуулийн 3.1.5 дахь заалтын “нэвтрүүлэх” гэснийг “нэвтрүүлж буй” гэж өөрчилсөн, мөн заалтын “эрхэлж” гэсний дараа “байгаа болон тээврийн хэрэгслийг жолоодож” гэж нэмсэн*
20.	3.1.7.**“гаалийн мэдүүлэг”** гэж мэдүүлэгчийн сонгосон гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу шаардагдах мэдээлэл агуулсан бичиг баримтыг;	3.1.18.“гаалийн мэдүүлэг” гэж мэдүүлэгчийн сонгосон гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу шаардагдах мэдээлэл агуулсан цахим болон бичгээр гаргасан бичиг баримтыг, зорчигчийн хувьд биедээ болон биеэс тусдаа авч яваа ачаа тээшээ мэдүүлсэн зорчигчийн хуудсыг;		-
21.	3.1.8.**“мэдүүлэгч”** гэж гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллагад мэдүүлж байгаа аливаа этгээдийг;	3.1.19.“мэдүүлэгч” гэж гаалийн хилээр нэвтрүүлж байгаа бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллагад мэдүүлж байгаа болон мэдүүлэх үүрэгтэй аливаа этгээдийг;		*Хуулийн 3.1.8 дахь заалтын “нэвтрүүлэх бараа” гэснийг “нэвтрүүлж буй бараа” гэж өөрчилсөн*
22.	3.1.9.**“гаалийн хилээр нэвтрүүлэх”** гэж бараа, тээврийн хэрэгслийг гаалийн нутаг дэвсгэрт оруулах, дамжуулан өнгөрүүлэх, гаргахыг;	3.1.11.“гаалийн хилээр нэвтрүүлэх” гэж бараа, тээврийн хэрэгслийг гаалийн нутаг дэвсгэрт оруулах, гаалийн нутаг дэвсгэрээс гаргах болон гаалийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэх үйл ажиллагааг;		*Хуулийн 3.1.8 дахь заалтын “дамжуулан өнгөрүүлэх, гаргахыг” гэснийг “гаалийн нутаг дэвсгэрээс гаргах үйл ажиллагаа” гэж өөрчилсөн*

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.legal.gov.mn

23.	3.1.10.**“гаалийн зам”** гэж гаалийн хяналтад байгаа бараа, тээврийн хэрэгслийг Монгол Улсын хил, хилийн гаалийн байгууллагын, эсхүл гаалийн нэг байгууллагаас гаалийн нөгөө байгууллагын хооронд тээвэрлэхээр гаалийн удирдах төв байгууллагаас тусгайлан тогтоосон замыг;	3.1.12.“гаалийн зам” гэж гаалийн хяналтад байгаа барааг Монгол Улсын хил, хилийн гаалийн байгууллагын хооронд, эсхүл гаалийн нэг байгууллагаас гаалийн нөгөө байгууллагын хооронд тээвэрлэхээр гаалийн удирдах төв байгууллагаас тусгайлан тогтоосон замыг;		*Хуулийн 3.1.10 дахь заалтын “тээврийн хэрэгслийг” гэснийг хассан, мөн “байгууллагын” гэсний дараа “хооронд” гэж нэмсэн*
24.	3.1.11.**“гаалийн хяналт”** гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт гаалийн хууль тогтоомжийг мөрдүүлж, биелэлтийг нь хангуулах зорилгоор гаалийн байгууллагаас хэрэгжүүлэх цогц арга хэмжээг;	3.1.3.“гаалийн хяналт” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт гаалийн хууль тогтоомжийг мөрдүүлж, биелэлтийг нь хангуулах зорилгоор гаалийн байгууллагаас хэрэгжүүлэх цогц арга хэмжээг;		-
25.	3.1.12.**“гаалийн бүрдүүлэлт”** гэж гаалийн хилээр нэвтрүүлэх барааг гаалийн байгууллагад мэдүүлсэн үеэс гаалийн бичиг баримтыг, шаардлагатай тохиолдолд барааг шалгах, ногдуулсан татварыг төлсний дараа барааг олгох, эсхүл гаалийн хилээр гаргахыг зөвшөөрөх хүртэлх цогц үйл ажиллагаа;	3.1.13.“гаалийн бүрдүүлэлт” гэж гаалийн хилээр нэвтрүүлэх барааг гаалийн байгууллагад мэдүүлсэн үеэс гаалийн бичиг баримтыг, шаардлагатай тохиолдолд барааг шалгах, ногдуулсан татварыг төлсний дараа барааг олгох, эсхүл гаалийн хилээр гаргахыг, болон оруулахыг зөвшөөрөх хүртэлх цогц үйл ажиллагааг;		-
26.	3.1.13.**“гаалийн бүрдүүлэлтийн горим”** гэж гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийн талаар тогтоосон хэм хэмжээ, нөхцөл, шаардлагыг;	3.1.14.“гаалийн бүрдүүлэлтийн горим” гэж бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэх, мөн гаалийн нутаг дэвсгэрт болон нутаг дэвсгэрийн гадна ашиглах, захиран зарцуулах нөхцөл шаардлагыг тодорхойлсон гаалийн зохицуулалт, хэм хэмжээний цогцыг;		*Хуулийн 3.1.13 дахь заалтыг бүхэлд нь өөрчлөн найруулсан*
27.	3.1.14.**“тарифын бус хязгаарлалт”** гэж Монгол Улсын хилээр бараа нэвтрүүлэхийг хориглох, эсхүл эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, тоон хязгаарлалт тогтоох болон бусад арга хэмжээг;	3.1.15.“тарифын бус хязгаарлалт” гэж Монгол Улсын хилээр бараа нэвтрүүлэхийг хориглох, эсхүл эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр Монгол Улсын хилээр нэвтрүүлэх тоон хязгаарлалт тогтоох болон бусад хязгаарлалтын арга хэмжээг;		-
28.	3.1.15.**“хилийн гаалийн байгууллага”** гэж хилийн боомт болон олон улсын нисэх онгоцны буудалд ажилладаг гаалийн байгууллагыг;	3.1.1.“хилийн гаалийн байгууллага” гэж хилийн боомт болон олон улсын нисэх онгоцны буудалд ажилладаг гаалийн байгууллагыг;		-
29.	3.1.16.**“гүний гаалийн байгууллага”** гэж энэ хуулийн 3.1.15-д зааснаас бусад гаалийн байгууллагыг;	3.1.2.“гүний гаалийн байгууллага” гэж энэ хуулийн 3.1.1-д зааснаас бусад гаалийн байгууллагыг;		*Хуулийн 3.1.16 дахь заалтын “3.1.15” гэснийг “3.1.1” гэж өөрчилсөн*
30.	3.1.17.**“гаалийн баталгаат бүс”** гэж гаалийн баталгаат агуулах, үйлдвэрийн болон үзэсгэлэнгийн газар, барилгын талбай, гаалийн тусгай бүс, татваргүй барааны дэлгүүрийг;	3.1.21.“гаалийн баталгаат бүс” гэж чөлөөт бүс, гаалийн баталгаат агуулах, татваргүй барааны дэлгүүрийг;		*Хуулийн 3.1.17 дахь заалтын”гэж” гэсний дараа “чөлөөт бүс” гэж нэмсэн*
31.	3.1.18.**“гаалийн хяналтын бүс”** гэж бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналт дор ачих, буулгах, шилжүүлэн ачих, хадгалах, тээвэрлэх, гаалийн хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор тусгайлан тогтоосон байр, агуулах, талбайг;	3.1.22.“гаалийн хяналтын бүс” гэж бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналт доор ачих, буулгах, шилжүүлэн ачих, хадгалах, тээвэрлэх болон гаалийн хяналт, бүрдүүлэлтийг хэрэгжүүлэх зорилгоор тогтоосон байр, агуулах, талбайг;		-

32.	3.1.19.**“гаалийн харилцаанд оролцогч”** гэж гаалийн байгууллага болон мэдүүлэгч, гаалийн зуучлагч, тээвэрлэгч, гаалийн түр агуулахын болон баталгаат бүсийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч, банк, даатгалын байгууллагыг.	3.1.20.“гаалийн харилцаанд оролцогч” гэж гаалийн байгууллага болон мэдүүлэгч, гадаад худалдаа эрхлэгч, гаалийн зуучлагч, тээвэрлэгч, тээвэр зуучлагч, хяналтын бүс, гаалийн түр агуулахын болон баталгаат бүсийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч, чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч, гадаад худалдааны төлбөр тооцоо эрхэлсэн банк, даатгалын байгууллагыг;		*Хуулийн 3.1.9 дэх заалтын “мэдүүлэгч” гэсний дараа “гадаад худалдаа эрхлэгч” гэж, “тээвэрлэгч” гэсний дараа “тээвэр зуучлагч, хяналтын бүс” гэж, “эзэмшигч,” гэсний дараа “чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч,” гэж тус тус нэмсэн*
33.		3.1.4.”гаалийн шалгалт” гэж гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилт, гаалийн хилээр нэвтрүүлэх барааны нэр төрөл, тоо хэмжээ, үнэ болон бусад үзүүлэлт нь гаалийн мэдүүлэгтэй тохирч байгаа эсэхийг шалгах үйл ажиллагааг;		*Хуулийн төслөөр нэр томьёоны тодорхойлолтод “гаалийн шалгалт” гэсэн нэр томьёо нэмэгдсэн*
34.		3.1.16.“бараа нэвтрүүлэхийг хориглох” гэж барааг гаалийн хилээр оруулах, гаргах, дамжуулан өнгөрүүлэхийг хориглосон тарифын бус хязгаарлалтын төрлийг;		
35.		3.1.17.“бараа нэвтрүүлэхийг хязгаарлах” гэж барааг эрх бүхий байгууллагын тогтоосон тоон хязгаартайгаар, эсхүл зөвшөөрөл лицензийн үндсэнд гаалийн хилээр нэвтрүүлэх тарифын бус хязгаарлалтын төрлийг;		
36.		3.1.23.“чөлөөт бүс” гэж Чөлөөт бүсийн тухай хуулийн 3.1.1-д заасныг;		*Хуулийн төслөөр нэр томьёоны тодорхойлолтод “чөлөөт бүс” гэсэн нэр томьёо нэмэгдсэн*
37.		3.1.24.“гаалийн цахим мэдээллийн сан” гэж харилцан уялдаатай, тодорхой бүтэц, дүрмээр бүрдүүлсэн гаалийн байгуулагын өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэгдэх цахим мэдээллийн нэгдэл;		
38.		.1.25.“статистикийн мэдээллийн цахим сан“ гэж гаалийн мэдээллийн цахим сангаас статистикийн зорилгоор үүсгэсэн санг		
39.		3.1.26.“цахим бичиг баримт” гэж Цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.4-т заасныг;		
40.		3.1.27.“тоон гарын үсэг” гэж Цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.2-т заасныг.		

ХУУЛЬ ЗҮЙН ХҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.pil.gov.mn

41.	**4 дүгээр зүйл. Гаалийн нутаг дэвсгэр, гаалийн хил**	**4 дүгээр зүйл.Гаалийн нутаг дэвсгэр, гаалийн хил**		-
42.	4.1.Монгол Улсын нутаг дэвсгэрийг гаалийн нутаг дэвсгэр гэж үзнэ.	4.1.Монгол Улсын нутаг дэвсгэрийг гаалийн нутаг дэвсгэр гэж үзнэ.		-
43.	4.2.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгуулсан гаалийн баталгаат бүсийн **болон чөлөөт бүсийн** нутаг дэвсгэр нь тарифын болон тарифын бус хязгаарлалтын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна байгаад тооцогдоно.	4.2.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгуулсан гаалийн баталгаат бүсийн нутаг дэвсгэр нь тарифын болон тарифын бус хязгаарлалтын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна байгаад, гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилт, гаалийн хяналт шалгалт, бүрдүүлэлтийн хувьд гаалийн нутаг дэвсгэрт тооцогдоно.		*Хуулийн 4.2 дахь хэсгийн “болон чөлөөт бүсийн” гэснийг хассан*
44.		4.3.Гаалийн хяналтын бүс, түр агуулах, гаалийн хяналтын зорилгоор тогтоосон байр, агуулах, талбай нь тухайн хэсэгтээ гаалийн нутаг дэвсгэрт хамаарна.		
45.	4.3.Монгол Улсын хилийг гаалийн хил гэж үзнэ.	4.4.Монгол Улсын хилийг гаалийн хил гэж үзнэ.		-
46.	4.4.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгуулсан гаалийн баталгаат бүсийг гаалийн нутаг дэвсгэрээс тусгаарласан шугам болон гаалийн хяналтын бүсийн хилийг гаалийн хилд тооцно.	4.5.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгуулсан гаалийн баталгаат бүс, гаалийн хяналтын бүс, гаалийн хяналтын зорилгоор тогтоосон байр, агуулах, талбайг гаалийн нутаг дэвсгэрээс болон нийтийн эзэмшлийн нутаг дэвсгэрээс зааглаж тусгаарласан зурвасыг гаалийн хилд тооцно.		*Хуулийн 4.4-ийн “бүсийг гаалийн нутаг дэвсгэрээс тусгаарласан шугам болон” гэснийг хассан, “болон” гэсний дараа “хяналтын бүсийг” гэж нэмсэн*
47.	**5 дугаар зүйл.Гаалийн хяналтыг хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээлэл, бичиг баримтыг ашиглах**			*Хасагдсан*
48.	5.1.Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэхэд шаардлагатай мэдээлэл, бичиг баримтыг холбогдох этгээд гаалийн хууль тогтоомжид заасны дагуу гаалийн байгууллагад гаргаж өгнө.			*Хасагдсан*
49.	5.2.Гаалийн байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 5.1-д заасан мэдээлэл, бичиг баримтыг хүлээн авч түүнийг гагцхүү гаалийн зорилгоор ашиглах бөгөөд хуульд зааснаас бусад тохиолдолд задруулах, эсхүл гуравдагч этгээдэд дамжуулахыг хориглоно.			*Хасагдсан*
50.	5.3.Гаалийн байгууллага, албан тушаалтнаас гаалийн хууль тогтоомжийн дагуу авсан төр, хувь хүний, байгууллагын нууцад хамаарах мэдээллийг ашиглах, хадгалахтай холбогдсон харилцааг нууцын хууль тогтоомжоор зохицуулна.			*Хасагдсан*

Хуулийн хүчинтэй эсэхийг хүрээлэн www.mli.gov.mn

51.	**ХОЁРДУГААР БҮЛЭГ Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэхэд баримтлах зарчим**	**ХОЁРДУГААР ДЭД БҮЛЭГ БАРАА, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ГААЛИЙН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ**		*Хуулийн 2 дугаар бүлгийн гарчгийн "нэвтрүүлэхэд баримтлах зарчим" гэснийг нэвтрүүлэх" гэж өөрчилсөн*
52.	**6 дугаар зүйл.Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэх зарчим**	**40 дүгээр зүйл.Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэх**		*Хасагдсан*
53.	6.1.Аливаа этгээд энэ хууль болон Монгол Улсын олон улсын гэрээ /цаашид "олон улсын гэрээ" гэх/-нд заасан нөхцөл, журмын дагуу бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр чөлөөтэй нэвтрүүлэх эрхтэй.	40.1.Аливаа этгээд энэ хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан нөхцөл, журмын дагуу бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр чөлөөтэй нэвтрүүлэх эрхтэй.		*Хасагдсан*
54.	6.2.Хуульд зааснаас бусад тохиолдолд бараа, тээврийн хэрэгслийг улсын хилээр орсон үеэс мэдүүлэгчид олгох хүртэл, эсхүл бараа, тээврийн хэрэгслийг мэдүүлсэн үеэс улсын хилээр гарах хүртэлх хугацаанд тэдгээрийг ашиглах, эзэмших, захиран зарцуулахыг хориглоно.			*Хасагдсан*
55.	**7 дугаар зүйл.Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэх**			-
56.	7.1.Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллага бүхий хилийн боомтоор нэвтрүүлнэ.	40.2.Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллага бүхий хилийн боомтоор нэвтрүүлнэ		-
57.	7.2.Энэ хуулийн 7.1-д зааснаас бусад хилийн боомтоор бараа, тээврийн хэрэгслийг гаалийн удирдах төв байгууллагын зөвшөөрөлтэйгээр нэвтрүүлж болно.	40.3.Энэ хуулийн 40.1-д зааснаас бусад хилийн боомтоор бараа, тээврийн хэрэгслийг гаалийн удирдах төв байгууллагын зөвшөөрөлтэйгээр нэвтрүүлж болно.		-
58.	7.3.Энэ хуулийн 7.2-т заасан зөвшөөрлийг гаалийн удирдах төв байгууллага дор дурдсан тохиолдолд олгоно:	40.4.Энэ хуулийн 40.3-т заасан зөвшөөрлийг гаалийн удирдах төв байгууллага доор дурдсан тохиолдолд олгоно:		-
59.	.3.1.гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын үед;	40.3.1.гамшгийн шинжтэй онцгой нөхцөл байдлын үед;		*Өөрчлөн найруулсан*
60.	77.3.2.олон улсын гэрээнд заасан;	40.3.2.олон улсын гэрээнд заасан;		
61.	7.3.3.улсыг батлан хамгаалах зорилгоор гадаад улсаас тусламж авах;	40.3.3.улсыг батлан хамгаалах зорилгоор гадаад улсаас тусламж авах;		
62.	7.3.4.хуульд заасан бусад.	40.3.4.хуульд заасан бусад.		
63.	7.4.Энэ хуулийн 7.3-т заасны дагуу бараа, тээврийн хэрэгслийг хилээр нэвтрүүлэхэд гаалийн удирдах төв байгууллага гаалийн албан тушаалтныг томилон ажиллуулна.	40.5.Энэ хуулийн 40.3-т заасны дагуу бараа, тээврийн хэрэгслийг хилээр нэвтрүүлэхэд гаалийн удирдах төв байгууллага гаалийн албан тушаалтныг томилон ажиллуулна.		-
64.	7.5.Бараа, тээврийн хэрэгслийг энэ хуулийн 7.2-т заасны дагуу хилээр нэвтрүүлэх тохиолдолд мэдүүлэгч нь гаалийн удирдах төв байгууллагад хүсэлтээ гаргах бөгөөд түүнд холбогдох байгууллагын зөвшөөрөл, бараа, тээврийн хэрэгслийн жагсаалтыг хавсаргана.	40.6.Бараа, тээврийн хэрэгслийг энэ хуулийн 40.3-т заасны дагуу хилээр нэвтрүүлэх тохиолдолд мэдүүлэгч нь гаалийн удирдах төв байгууллагад хүсэлтээ урьдчилан гаргах бөгөөд түүнд холбогдох байгууллагын зөвшөөрөл, бараа, тээврийн хэрэгслийн жагсаалтыг хавсаргана.		-

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН www.legal.mn

65.	**8 дугаар зүйл. Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэхийг хориглох, хязгаарлах**	**41 дүгээр зүйл.Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон, хязгаарласан бараа**		-
66.	8.1.Хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурал улсын хилээр оруулах, гаргахыг хориглох барааны, Засгийн газар тарифын бус хязгаарлалттай нэвтрүүлэх барааны жагсаалтыг тухайн барааны ангиллын кодыг Бараг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн дагуу зааж тус тус батална.	41.1.Хууль тогтоомжоор улсын хилээр оруулах, гаргах, дамжуулан өнгөрүүлэхийг хориглосон, тарифын бус бусад хязгаарлалт тогтоосон барааны жагсаалт, ангиллын кодыг Засгийн газар бараг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн дагуу зааж батална.		*Хуулийн 8.1 дэх хэсгийн “барааны” гэсний дараа”жагсаалтыг” гэж нэмсэн*
67.	8.2.Улсын хилээр оруулахыг хориглосон бараг гаалийн нутаг дэвсгэрт оруулахгүй.	41.2.Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалттай бараг хууль тогтоомж, олон улсын гэрээнд заасан нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд гаалийн хилээр нэвтрүүлнэ.		*Хууль 8.2 дахь хэсгийг бүхэлд нь өөрчлөн найруулсан*
68.	8.3.Энэ хуулийн 8.2-т заасан бараг Монгол Улсын нутаг дэвсгэрт оруулсан бол нэн даруй буцаан гаргах ба ийнхүү гаргах боломжгүй бол гаалийн хяналтын бүс, эсхүл түр агуулахад 3 хүртэл хоног хадгалах бөгөөд энэ хугацаанд иргэн, хуулийн этгээд бараагаа буцаан гаргаагүй бол гаалийн байгууллага бараа устгах горимын дагуу арга хэмжээг авна.			*Хасагдсан*
69.	8.4.Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалттай бараг хууль тогтоомж, олон улсын гэрээнд заасан нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд гаалийн хилээр нэвтрүүлнэ.			*Хасагдсан*
70.	8.5.Улсын хилээр гаргахыг хориглосон бараг гаалийн нутаг дэвсгэрээс гаргахгүй.			*Хасагдсан*
71.	8.6.Олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон бараг гаалийн нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэхгүй.	41.3.Олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэхийг хориглосон бараг гаалийн нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэхгүй.		*“улсын хилээр нэвтрүүлэхийг” гэснийг “Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэхийг” гэж өөрчилсөн*
72.	8.7.Гаалийн удирдах төв байгууллага бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх хилийн боомт, гаалийн байгууллагын байршил, тэдгээрийн ажиллах цагийн хуваарийг болон гаалийн хилээр нэвтрүүлэхийг хориглосон, хязгаарласан барааны тухай нийтэд мэдээлнэ.			-
73.	8.8.Энэ хуулийн 8.3-т заасан үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг тухайн иргэн, хуулийн этгээд хариуцна.			-
74.	8.9.Гаалийн хилээр нэвтрүүлэхийг хориглосон бараг хууль бусаар нэвтрүүлсэн, эсхүл нэвтрүүлэхийг завдсан үйлдэл нь энэ хуулийн 8.3-т хамаарахгүй.			-

Хүний эрхийн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

75.	**9 дүгээр зүйл. Гаалийн бүрдүүлэлт, гаалийн хяналт**			-
76.	9.1.Гаалийн байгууллага, албан тушаалтан нь улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавьж, гаалийн бүрдүүлэлт хийх бөгөөд уг үүргээ хэрэгжүүлэхдээ хууль тогтоомжид зааснаас бусад шаардлага тавихыг хориглоно.			-
77.		**II ХЭСЭГ МЭДЭЭЛЭЛ, ЗӨВЛӨГӨӨ, ЛАВЛАГАА, ГОМДОЛ**	**9 ДҮГЭЭР БҮЛЭГ ГААЛИЙН БАЙГУУЛЛАГААС ГАРГАЖ ӨГСӨН МЭДЭЭЛЭЛ, ШИЙДВЭР БОЛОН УРЬДЧИЛСАН ШИЙДВЭР**	-
78.	**ГУРАВДУГААР БҮЛЭГ Гаалийн хууль тогтоомжийн талаархи мэдээлэл, зөвлөгөө**	**ХОЁРДУГААР БҮЛЭГ ГААЛИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ, ЗӨВЛӨГӨӨ**	**А. НИЙТЛЭГ ХЭРЭГЛЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ**	-
79.	**10 дугаар зүйл.Гаалийн байгууллага, албан тушаалтны амаар болон бичгээр гаргасан шийдвэрийн талаар мэдээлэл авах**	**37 дугаар зүйл.Гаалийн байгууллага, албан тушаалтны амаар болон бичгээр гаргасан шийдвэрийн талаар**		-
80.	10.1.Иргэн, хуулийн этгээд нь түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гаалийн байгууллага, албан тушаалтны амаар болон бичгээр гаргасан шийдвэр, эс үйлдэхүй /цаашид “шийдвэр” гэх/-н шалтгаан, үндэслэлийн талаар мэдээлэл авах эрхтэй.	37.1.Иргэн, хуулийн этгээд нь түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гаалийн байгууллага, албан тушаалтны амаар болон бичгээр гаргасан шийдвэр, эс үйлдэхүй /цаашид “шийдвэр” гэх/-н шалтгаан, үндэслэлийн талаар мэдээлэл авах эрхтэй мэдээлэл авах эрхтэй.		-
81.	10.2.Энэ хуулийн 10.1-д заасан гаалийн байгууллага, албан тушаалтан хүссэн мэдээллийг нь нэн даруй хэрэв ийнхүү өгөх боломжгүй бол ажлын 3 өдөрт багтаан иргэн, хуулийн этгээдэд бичгээр өгөх үүрэгтэй.	37.2.Энэ хуулийн 37.1-д заасан мэдээллийг гаалийн байгууллага, албан тушаалтан нэн даруй өгөх боломжгүй бол ажлын 3 өдөрт багтаан бичгээр өгөх үүрэгтэй.		*“хүссэн мэдээллийг нь нэн даруй хэрэв ийнхүү өгөх боломжгүй бол ажлын 3 өдөрт багтаан иргэн, хуулийн этгээдэд бичгээр өгөх үүрэгтэй.” гэснийг “нэн даруй өгөх боломжгүй бол ажлын 3 өдөрт багтаан бичгээр өгөх үүрэгтэй.” гэж өөрчилсөн*
82.	**11 дүгээр зүйл.Гаалийн хууль тогтоомжийг нийтэд мэдээлэх**	**5 дугаар зүйл.Гаалийн хууль тогтоомжийг нийтэд мэдээлэх**	**9.1 Стандарт**	-
83.	11.1.Гаалийн удирдах төв байгууллага гаалийн хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэх зорилгоор гаргасан бусад шийдвэрийг гаалийн харилцаанд оролцогчид болон нийтэд чөлөөтэй, үнэ төлбөргүй мэдээлэх үүрэгтэй.	5.1.Гаалийн удирдах төв байгууллага гаалийн хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэх зорилгоор гаргасан бусад шийдвэр, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийг гаалийн харилцаанд оролцогчид болон нийтэд чөлөөтэй, үнэ төлбөргүй мэдээллэх үүрэгтэй.	Гаалийн байгууллага гаалийн хууль тогтоомжид хамаарах нийтлэг хэрэглээний холбогдох бүх мэдээллийг сонирхогч этгээд олж авах боломжтой байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.	

хууль зүйн үндэсний хүрээлэн www.legal.gov.mn

84.		5.2.Гаалийн хууль тогтоомжийг гаалийн харилцаанд оролцогчид болон нийтэд дараах хэлбэрээр мэдээлнэ:	**9.2 Стандарт** Гаалийн хууль тогтоомж, захиргааны арга хэмжээ буюу шаардлагад нэмэлт, өөрчлөлт орсоны улмаас нийтэд ил тод болгосон мэдээлэлд өөрчлөлт оруулах шаардлагатай бол гаалийн байгууллага тэдгээр шинэчилсэн мэдээллийг урьдчилан мэдэгдэхийг хориглосноос бусад тохиолдолд сонирхогч этгээдэд анхаарч үзэх боломж олгох зорилгоор хүчин төгөлдөр болохоос хангалттай хугацааны өмнө нийтийн хүртээл болгоно **9.3 Шилжилтийн стандарт** Гаалийн байгууллага мэдээллээр хангах явдлыг сайжруулах зорилгоор мэдээллийн технологи ашиглана	
85.		5.2.1.Гаалийн хууль тогтоомж, үйл ажиллагаа, барааны ангилал, гаалийн үнэ, үнэлгээний аргууд, гаалийн тариф, бусад татварын хувь хэмжээ, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, хориглосон, хязгаарласан бараа зэрэг нийтлэг хэрэглээний мэдээллүүдийг гаалийн харилцаанд оролцогчид болон нийтэд гаалийн байгууллагын албан ёсны цахим хуудсаар;		
86.		5.2.2.энэ хуулийн 5.2.1-д заасан мэдээллийг гаалийн байгууллагын лавлах утсаар;		
87.		5.2.3.харьяа гаалийн байгууллага гаалийн хууль тогтоомжтой холбоотой асуудлаар гаалийн харилцаанд оролцогчид болон нийтэд мэдээлэл, зөвлөгөө, лавлагаа өгөх нэгжээр;		
88.		5.2.4.гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлс, хориглосон, хязгаарласан бараа, гаалийн зөрчил үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлага болон гаалийн хууль тогтоомж, холбогдох захиргааны хэм хэмжээний акт болон лавлах утасны дугаар зэргийг хэвлэмэл хуудас, танилцуулга хэлбэрээр, түүнчлэн гадаад хэлээр;		
89.		5.3.Гаалийн байгууллага энэ хуулийн 5.2.1-д заасан албан мэдээллийг гаалийн харилцаанд оролцогчид олж авах боломжтой байх бусад нөхцөлийг бүрдүүлсэн байна.		
90.	11.2.Гаалийн хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн албан ёсны эхийг “Төрийн мэдээлэл”, бусад тушаал, шийдвэрийг Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 14.1-д заасан эмхтгэлд тус тус нийтэлнэ.			*Хасагдсан*
91.	11.3.Гаалийн хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэх зорилгоор гаргасан бусад шийдвэрт оруулсан нэмэлт, өөрчлөлтөд энэ хуулийн 11.1 дэх заалт нэгэн адил хамаарна.			*Хасагдсан*
92.		5.4.Иргэн, хуулийн этгээд хууль тогтоомж, холбогдох захиргааны хэм хэмжээний акт, түүнд орсон нэмэлт, өөрчлөлтийг мэдээгүйн улмаас, эсхүл албан бус хэвлэл болон хэвлэлийн алдаанаас учирсан хохирлыг гаалийн байгууллага хариуцахгүй.		*Шинээр нэмэгдсэн*

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХҮРЭЭЛЭН www.legalinfo.gov.mn

93.	**12 дугаар зүйл.Зөвлөгөө өгөх**	**6 дугаар зүйл. Зөвлөгөө өгөх**		
94.	12.1.Гаалийн байгууллага нь гаалийн хууль тогтоомжтой холбогдсон асуудлаар иргэн, хуулийн этгээдэд зөвлөгөө өгч болох бөгөөд ийнхүү зөвлөгөө өгөх журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална._	6.1.Гаалийн байгууллага нь гаалийн хууль тогтоомжтой холбогдсон асуудлаар иргэн, хуулийн этгээдэд зөвлөгөө өгч болно.		"болох бөгөөд ийнхүү зөвлөгөө өгөх журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална." гэснийг "болно." гэж өөрчилсөн.
95.		6.2.Гаалийн байгууллагын чиглэл хариуцсан албан тушаалтан гаалийн хууль тогтоомжийг сурталчлах, мэдээлэх, таниулах зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гаалийн хууль тогтоомжийн хүрээнд мэдээлэл, ярилцлага өгөх, гаалийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар зохион байгуулсан уулзалт, зөвлөгөөнд оролцож, сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллана.		
96.	12.2.Энэ хуулийн 12.1-д заасан журмаас гадуур өгсөн зөвлөгөө, хууль тогтоомж болон холбогдох бусад шийдвэрт орсон нэмэлт, өөрчлөлтийг мэдээгүйн улмаас, эсхүл хэвлэлийн алдаанаас учирсан хохирлыг гаалийн байгууллага хариуцахгүй.			*Хасагдсан*
97.		**7дугаар зүйл.Дэмжлэг үзүүлэх**		
98.		7.1.Гаалийн харилцаанд оролцогчид хууль ёсны худалдаа эрхлэх, тэдний хууль сахилтын түвшинг дээшлүүлэх, гадаад худалдааг хөнгөвчлөх, хялбарчлах чиглэлээр гаалийн байгууллага хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд зөвлөн туслах дэмжлэг үзүүлж болно.		
99.		**8 дугаар зүйл.Гаалийн байгууллага, албан тушаалтны шийдвэрийн талаар мэдээлэл авах**	**С. ШИЙДВЭР БОЛОН УРЬДЧИЛСАН ШИЙДВЭР**	
100.		8.1.Иргэн, хуулийн этгээд нь түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гаалийн байгууллага, албан тушаалтны амаар болон бичгээр гаргасан шийдвэр, эс үйлдэхүй /цаашид "шийдвэр" гэх/-н шалтгаан, үндэслэлийн талаар мэдээлэл авах эрхтэй.	**9.8 Стандарт** Гаалийн байгууллага нь холбогдох этгээдийн бичгээр гаргасан хүсэлтийн хариу шийдвэрийг үндэсний хууль тогтоомжид заасан хугацаанд багтаан бичгээр мэдэгдэнэ. Хэрэв уг шийдвэр нь холбогдох этгээдийн хүссэнээр гараагүй бол тийм шийдвэр гаргах болсон шалтгааныг зааж, мөн давж заалдах эрхийг нь сануулна.	

Хуулъ зүйл үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

101.		8.2.Энэ хуулийн 8.1-д заасан мэдээллийг гаалийн байгууллага, албан тушаалтан нэн даруй өгөх боломжгүй бол ажлын гурван өдөрт багтаан бичгээр өгөх үүрэгтэй.	**9.9 Стандарт** Гаалийн байгууллагад шаардлагатай гэж үзсэн бүх мэдээлэл байгаа бол сонирхогч этгээдийн хүсэлтээр гаалийн байгууллага заавал дагаж мөрдөх урьдчилсан шийдвэр гаргана.	
102.		**9 дүгээр зүйл.Мэдээллийн нууц**	**9.6 Стандарт**	
103.		9.1.Гаалийн байгууллага гадаад худалдаанд оролцогч иргэн, хуулийн этгээдийн талаархи мэдээллийн нууцлалыг хамгаална.	Гаалийн байгууллага нь мэдээллээр хангахдаа үндэсний хууль тогтоомжоор ил тод болгохыг зөвшөөрснөөс бусад тохиолдолд гаалийн байгууллага болон гуравдагч талтай холбоотой хувийн чанартай, эсхүл нууцлалын зэрэглэлтэй мэдээллийг задлахгүй байх нөхцөлийг хангана	
104.		9.2.Гаалийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэх явцдаа төр, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг задруулахгүй байх, хувийн болон бусдын ашиг сонирхлын төлөө ашиглахгүй байх, баталгаажсан албан ёсны шийдвэр гараагүй аливаа асуудлаар байр суурь илэрхийлэхгүй байх, зөвшөөрөгдөөгүй мэдээ, мэдээлэл тараахгүй байх үүрэгтэй.		
105.		**ГУРАВДУГААР БҮЛЭГ ЛАВЛАГАА**	**В.ТУСГАЙ МЭДЭЭЛЭЛ**	
106.		**10дугаар зүйл.Лавлагаа өгөх**	**9.4 Стандарт**	
107.		10.1.Иргэн, хуулийн этгээд гаалийн харилцаанд орсон өөрийн үйл ажиллагаатай холбоотой лавлагаа мэдээллийг гаалийн байгууллагаас гаргуулан авч болно.	Гаалийн байгууллага, сонирхогч этгээдийн хүсэлтээр, уг сонирхогч этгээдээс тавьсан тодорхой асуудалтай холбоотой, мөн гаалийн хууль тогтоомжийн холбогдолтой мэдээллийг аль болох хурдан хугацаанд, үнэн зөв гаргаж өгнө.	
108.		10.2.Гаалийн байгууллага иргэн, хуулийн этгээдийн гадаад худалдааны үйл ажиллагааны болон татварын өр авлагатай холбоотой лавлагааг бичгээр гаргасан хүсэлтэд үндэслэн хүсэлт гаргагчид төлбөртэй олгож болно. Төлбөрийн хэмжээг гаалийн удирдах төв байгууллагын дарга тогтооно.	**9.5 Стандарт** Гаалийн байгууллага нь зөвхөн тусгайлан тавьсан хүсэлтэд заасан мэдээллийг бүс бас сонирхогч этгээд мэдэж байх нь зүйтэй гэж үзсэн хамаарал бүхий бусад мэдээллийг гаргаж өгнө	
109.		10.3.Хууль хяналтын байгууллагад төдний албан хүсэлтийг үндэслэн иргэн, хуулийн этгээдийн талаархи лавлагаа мэдээллийг үнэ төлбөргүй олгоно.	**9.7 Стандарт** Хэрэв гаалийн байгууллага мэдээллийг үнэ төлбөргүй гаргаж өгөх боломжгүй бол аливаа төлбөр нь түүний үзүүлсэн үйлчилгээний өртөгтэй ойролцоо хэмжээгээр хязгаарлагдсан байна.	
110.	**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ Гаалийн статистик**	**ТАВДУГААР БҮЛЭГ ГААЛИЙН СТАТИСТИК**		-
111.	**13 дугаар зүйл. Гаалийн статистикийн мэдээлэл**	**19 дүгээр зүйл.Гаалийн статистикийн мэдээлэл**		-
112.	13.1.Монгол Улсын гадаад худалдааны үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, төсвийн орлогын бүрдүүлэлт болон гаалийн хилээр нэвтрүүлэх барааны хөдөлгөөнд хяналт тавих зорилгоор гаалийн байгууллага статистикийн мэдээлэл гаргана.	19.1.Гаалийн байгууллага статистикийн мэдээллийг гаргах зорилгоор гаалийн хилээр нэвтрүүлсэн барааны мэдээллийг бүртгэх, цуглуулах, дамжуулах, мэдээллийн үнэн зөвийг хангах, нэгтгэн боловсруулах үйл ажиллагаа явуулна.		*13-ын 1, 2-ыг нэгтгэсэн*

113.	13.2 Энэ хуулийн 13.1-д заасан мэдээллийн бараа тодорхойлох, кодлох уялдуулсан системийн ангиллын код, нэр төрлөөр гаргана.			
114.	13.3.Гаалийн удирдах төв байгууллага нь энэ хуулийн 13.1-д заасан мэдээллийг гаргах зорилгоор гаалийн мэдүүлэгт үндэслэсэн гаалийн мэдээллийн санг бүрдүүлж, хөтөлнө.	19.2.Гаалийн байгууллага гаалийн хилээр нэвтрүүлсэн барааны бүртгэлийн мэдээллийг үндэслэн статистикийн цахим мэдээллийн сан бүрдүүлж түүний бүрэн бүтэн байдал, нууцлалыг хамгаална.		
115.	**14 дүгээр зүйл.Гаалийн статистикийн мэдээллийн төрөл, мэдээллийг гаргах аргачлал**			-
116.	14.1.Гаалийн байгууллага дараахь төрлийн статистикийн мэдээллийг эрхлэн гаргана:	19.3.Гаалийн удирдах төв байгууллага дараах төрлийн статистикийн мэдээллийг эрхлэн гаргана:		“байгууллага” гэсний дараа “Монгол Улсын гадаад худалдааны үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, олон нийтийг мэдээллээр хангах үүднээс” гэж нэмсэн
117.	14.1.1. гадаад худалдааны барааны;	19.3.1.гадаад худалдааны барааны		-
118.	14.1.2. захиргааны.	19.3.2.гаалийн захиргааны;		*“захиргааны” гэсний өмнө “гаалийн” гэж нэмсэн*
119.		19.3.3.улсын төсвийн гаалийн орлогын.		
120.		**20 дугаар зүйл.Гадаад худалдааны гаалийн статистикийн мэдээлэл**		
121.		20.1.Гаалийн удирдах төв байгууллага нь Монгол Улсын гадаад худалдааны байдалд дүн шинжилгээ хийх, макро эдийн засгийн чиг хандлагыг тодорхойлох, худалдаа эдийн засгийн гэрээ хэлэлцээр байгуулах, тарифын болон тарифын бус зохицуулалтын, худалдааны, төлбөрийн тэнцлийн тооцоо судалгаа хийх төрийн болон төрийн бус байгууллага, бусад хэрэглэгчийг гадаад худалдааны барааны статистикийн мэдээллээр хангана.		
122.		20.2.Гадаад худалдааны барааны статистикийн мэдээллийн үндсэн эх сурвалж нь гаалийн мэдүүлэг бөгөөд мэдээллийн бодит байдлыг сайжруулах зорилгоор гаалийн бусад бүртгэлийн мэдээллийг ашиглаж болно.		
123.		20.3.Гадаад худалдааны барааны статистикийн мэдээллийг олон улсын статистикийн болон бусад байгууллагаас гаргасан зөвлөмжид тулгуурлан боловсруулсан үндэсний аргачлалын дагуу гаргана. Үндэсний аргачлалыг гаалийн удирдах төв байгууллага, статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга хамтран батална.		

ХУУЛЬ ЗҮЙН УЛСЫН ТӨВ САНГИЙН ХУРЭЭЛЭН www.legalinfo.mn

124.	20.4.Гаалийн удирдах төв байгууллага нь гадаад худалдааны барааны статистикийн мэдээллийг эмхэтгэн боловсруулж, төрийн байгууллага, бусад хэрэглэгчийг хангахаас гадна хэрэглэгчийн хүсэлтээр шаардлагатай мэдээллийг зөвшөөрөгдсөн үзүүлэлтээр гаргаж болно.			
125.	20.5.Гаалийн байгууллага гадаад худалдаанд оролцогчийн гадаад худалдааны мэдээллийн нууцыг хадгална.			
126.	20.6.Гаалийн удирдах төв байгууллага гадаад худалдаанд оролцогч иргэн, хуулийн этгээдийн бараны дэлгэрэнгүй үзүүлэлтийг агуулсан нэгтгэн боловсруулаагүй мэдээллийг зөвхөн татварын болон статистикийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хамтран ажиллах, мэдээлэл солилцох гэрээнд тусгасан үзүүлэлтүүдийн дагуу өгч болно.			
127.	20.7.Гаалийн удирдах төв байгууллага статистикийн мэдээллийг төрийн байгууллагад үнэ төлбөргүй, бусад хэрэглэгчдэд төлбөртэй олгож болно. Төлбөрийн хэмжээг гаалийн удирдах төв байгууллагын дарга тогтооно.			
128.	**21 дүгээр зүйл. Гаалийн захиргааны статистикийн мэдээлэл**			
129.	21.1.Гаалийн байгууллагын дотоод үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, цаашдын зориттыг тодорхойлох зорилгоор гаалийн удирдах төв байгууллага захиргааны статистикийн мэдээллийг эрхэлэн гаргана.			
130.	21.2.Захиргааны статистикийн мэдээллийн хамрах хүрээ, үзүүлэлт, давтамж, мэдээллийг цуглуулах, дамжуулах, нэгтгэн боловсруулах журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батлана.			
131.	21.3.Захиргааны статистикийн мэдээлэлд гаалийн мэдээллийн сангаас гарах мэдээлэл болон гаалийн газар хороод, дэргэдэх байгууллага, зохион байгуулалтын нэгжүүдийн үйл ажиллагааны талаарх статистикийн мэдээлэл багтана.			
132.	21.4.Захиргааны статистикийн мэдээллийг эмхэтгэн гаргаж зөвхөн гаалийн албаны дотоод хэрэгцээнд ашиглана.			
133.	**22 дугаар зүйл.Улсын төсвийн гаалийн орлогын статистикийн мэдээлэл**			
134.	22.1.Гаалийн байгууллагын төсвийн өмнө хүлээсэн үүргийг биелүүлэхэд хэналт тавих, орлогын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх зорилгоор улсын төсвийн гаалийн орлогын статистикийн мэдээллийг /цаашид төсвийн орлогын статистикийн мэдээлэл гэх/ эрхлэн гаргана.			

ХУРЭЭЛЭН

135.		22.3.Төсвийн орлогын статистикийн мэдээллийн үндсэн эх сурвалж нь гаалийн мэдүүлэг бөгөөд мэдээллийн бодит байдлыг сайжруулах зорилгоор гаалийн бусад бүртгэлийн мэдээллийг ашиглаж болно.		
136.		22.4.Гаалийн удирдах төв байгууллага нь гаалийн орлогын статистикийн мэдээллийг аргачлалд заасан үзүүлэлтүүдээр эмхэтгэн гаргаж, тогтоосон хугацаанд санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон хууль тогтоох дээд байгууллагад хүргүүлнэ.		
137.		22.5.Гаалийн удирдах төв байгууллага төсвийн орлогын статистикийн мэдээллийг гадаад худалдаанд оролцогч иргэн, хуулийн этгээдийн нэрээр зөвхөн төрийн байгууллагад олгоно.		
138.	14.2.Энэ хуулийн 14.1.1-д заасан мэдээллийг олон улсын статистикийн болон бусад байгууллагаас гаргасан аргачлалд тулгуурлан боловсруулсан үндэсний аргачлалын дагуу гаргана.	20.3.Гадаад худалдааны барааны статистикийн мэдээллийг олон улсын статистикийн болон бусад байгууллагаас гаргасан зөвлөмжид тулгуурлан боловсруулсан үндэсний аргачлалын дагуу		*Бүхэлд нь өөрчлөн найруулсан*
139.	14.3.Энэ хуулийн 14.2-т заасан үндэсний аргачлалыг гаалийн удирдах төв байгууллагын болон Үндэсний статистикийн хорооны дарга хамтран батална.	гаргана. Үндэсний аргачлалыг гаалийн удирдах төв байгууллага, статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга хамтран батална.		*Бүхэлд нь өөрчлөн найруулсан*
140.	14.4.Энэ хуулийн 14.1.2-т заасан статистикийн мэдээллийн аргачлал, үзүүлэлтийг Статистикийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.	22.2.Төсвийн орлогын статистикийн мэдээллийг эрхлэн гаргах аргачлал, давтамжийг гаалийн удирдах төв байгууллагын дарга батлана.		-
141.		22.3.Төсвийн орлогын статистикийн мэдээллийн үндсэн эх сурвалж нь гаалийн мэдүүлэг бөгөөд мэдээллийн бодит байдлыг сайжруулах зорилгоор гаалийн бусад бүртгэлийн мэдээллийг ашиглаж болно.		
142.		22.4.Гаалийн удирдах төв байгууллага нь гаалийн орлогын статистикийн мэдээллийг аргачлалд заасан үзүүлэлтүүдээр эмхэтгэн гаргаж, тогтоосон хугацаанд санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон хууль тогтоох дээд байгууллагад хүргүүлнэ.		
143.		22.5.Гаалийн удирдах төв байгууллага төсвийн орлогын статистикийн мэдээллийг гадаад худалдаанд оролцогч иргэн, хуулийн этгээдийн нэрээр зөвхөн төрийн байгууллагад олгоно.		
144.	**15 дугаар зүйл.Гаалийн статистикийн мэдээллийг ашиглах**	**50 дугаар зүйл.Гаалийн статистикийн мэдээллээр хангах**		*“мэдээллийг ашиглах” гэснийг “мэдээллээр хангах” гэж өөрчилсөн*
145.	15.1.Гадаад худалдааны барааны статистик мэдээллийг төрийн байгууллагад үнэ төлбөргүй ашиглуулна.	50.1.Гадаад худалдааны барааны статистикийн мэдээллийг төрийн байгууллагад үнэ төлбөргүй ашиглуулна.		-

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.legalinfo.mn

146.	15.2.Гаалийн байгууллага нь иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр гадаад худалдааны барааны статистик мэдээллийг төлбөртэй ашиглуулж болно.	50.2.Гаалийн байгууллага нь иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр гадаад худалдааны барааны статистикийн мэдээллийг төлбөртэй ашиглуулж болно.		-
147.	15.3.Энэ хуулийн 15.2-т заасан төлбөрийн хэмжээг тухайн мэдээллийг гаргаж өгөхөд шаардагдах зардлаас хэтрүүлэлгүйгээр гаалийн удирдах төв байгууллагын дарга тогтооно.	50.3.Энэ хуулийн 50.2-т заасан төлбөрийн хэмжээг тухайн мэдээллийг гаргаж өгөхөд шаардагдах зардлаас хэтрүүлэлгүйгээр гаалийн удирдах төв байгууллагын дарга тогтооно.		-
148.	**ТАВДУГААР БҮЛЭГ Гаалийн байгууллага, албан тушаалтны шийдвэрийн талаар гомдол гаргах**	**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ГААЛИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ ШИЙДВЭРТ ГОМДОЛ ГАРГАХ**	**10 ДУГААР БҮЛЭГ ГААЛИЙН АСУУДЛААР ДАВЖ ЗААЛДАХ А. ДАВЖ ЗААЛДАХ ЭРХ**	-
149.	**16 дугаар зүйл.Гомдол гаргах эрх**	**11 дүгээр зүйл.Гомдол гаргах эрх**	**10.1 Стандарт**	
150.	16.1.Мэдүүлэгч нь өөрийнхөө эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчигдсөн гэж үзвэл гаалийн байгууллага, албан тушаалтны шийдвэрт гомдол гаргах эрхтэй.	11.1.Иргэн, хуулийн этгээд нь өөрийнхөө эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчигдсөн гэж үзвэл гаалийн байгууллага, албан тушаалтны шийдвэрийг хууль нийцэж байгаа эсэхийг хянуулахаар гомдол гаргах эрхтэй.	Үндэсний хууль тогтоомжид гаалийн байгууллагын шийдвэрийг давж заалдах эрхийг заасан байна.	*“шийдвэрт” гэснийг “шийдвэрийг хууль нийцэж буй эсэхийг хянуулахаар” гэж өөрчилсөн*
151.	**17 дугаар зүйл. Гомдол гаргах журам, хугацаа**	**12 дугаар зүйл.Гомдол гаргах журам, хугацаа**	**10.3 Стандарт**	-
152.	17.1.Мэдүүлэгч гомдлоо дараахь журмаар гаргана:	12.1.Иргэн, хуулийн этгээд гомдлоо дараах журмаар гаргана:	Холбогдох этгээд хүсэлт гаргасны дагуу гаалийн байгууллага өөрийн гаргасан шийдвэр, эсхүл эс үйлдлийн шалтгааныг үндэсний хууль тогтоомжид заасан хугацаанд гаргаж өгнө. Энэ нь давж заалдахаар шийдэхэд нөлөөлөхөөр, эсхүл нөлөөлөхөөргүй ч байж болно.	-
153.	17.1.1.гаалийн улсын байцаагчийн шийдвэрт гаргах гомдлыг тухайн гаалийн байгууллагын дарга, эрхлэгчид;	12.1.1.гаалийн улсын байцаагчийн шийдвэрт гаргах гомдлыг тухайн гаалийн байгууллагын салбар, нэгжийн удирдах албан тушаалтанд;		*“дарга, эрхлэгчид;” гэснийг “удирдлагад;” гэж өөрчилсөн*
154.		12.1.2.гаалийн байгууллагын салбар, нэгжийн удирдах албан тушаалтны шийдвэрт гаргах гомдлыг тухайн гаалийн байгууллагын даргад;	**10.4 Стандарт** Үндэсний хууль тогтоомжид эхний зэлжинд гаалийн байгууллагад давж заалдах эрхтэй байх талаар заасан байна.	
155.	17.1.2.гаалийн байгууллагын дарга, эрхлэгчийн шийдвэрт гаргах гомдлыг холбогдох дээд шатны байгууллага, албан тушаалтанд;	12.1.3.харъяа гаалийн байгууллагын удирдлагын шийдвэрт гаргах гомдлыг гаалийн удирдах төв байгууллагын даргад	**10.5 Стандарт** Хэрэв гаалийн байгууллага давж заалдсан хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд давж заалдагч этгээд дараагийн шатанд гаалийн байгууллагаас өөр бие даасан эрх бүхий байгууллагад давж заалдах эрхтэй байна.	*“холбогдох дээд шатны байгууллага, албан тушаалтанд;” гэснийг “гаалийн улсын ерөнхий байцаагчид;” гэж өөрчилсөн*

156.	17.1.3.гомдлыг хянан шийдвэрлэсэн дээд шатны байгууллага, албан тушаалтны шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд.	12.1.4.гаалийн удирдах төв байгууллагын даргын шийдвэрт гаргах гомдлыг харъяалах шатны шүүхэд	**10.6 Стандарт** Давж заалдагч этгээд нь сүүлийн шатанд шүүхэд давж заалдах эрхтэй байна.	*“дээд шатны байгууллага, албан тушаалтны” гэснийг “гаалийн улсын ерөнхий байцаагчийн” гэж өөрчилсөн*
157.	17.2.Гаалийн байгууллага, албан тушаалтны шийдвэрт холбогдох гомдлыг мэдүүлэгч тухайн шийдвэрийг хүлээн авснаас, эсхүл мэдсэнээс хойш 30 хоногийн дотор гаргаж болно.	12.2.Гаалийн байгууллага, албан тушаалтны шийдвэрт гаргах гомдлыг иргэн, хуулийн этгээд тухайн шийдвэрийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор гаргаж болно.		*“мэдүүлэгч” гэснийг “иргэн, хуулийн этгээд” гэж өөрчилсөн, мөн “эсхүл мэдсэнээс” гэснийг хассан*
158.	17.3.Энэ хуулийн 17.2-т заасан хугацаа хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хэтэрсэн нь тогтоогдвол гомдол гаргагчийн хүсэлтээр уг хугацааг Захиргааны ерөнхий хуулийн 94.2-т заасны дагуу гаалийн байгууллага, албан тушаалтан нөхөн сэргээж болно.	12.3.Энэ хуулийн 12.2-т заасан хугацаа хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хэтэрсэн нь тогтоогдвол гомдол гаргагчийн хүсэлтээр уг хугацааг гаалийн байгууллага, албан тушаалтан нэг сарын дотор нөхөн сэргээж болно.		*Захиргааны ерөнхий хуулийн 94.2-т заасны дагуу” гэснийг хассан, мөн “тушаалтан” гэсний дараа “3 сарын дотор” гэж нэмсэн*
159.	**18 дугаар зүйл.Гомдол гаргах хэлбэр**	**13 дугаар зүйл.Гомдол гаргах хэлбэр**	**В. ДАВЖ ЗААЛДАХ ХЭЛБЭР БОЛОН ҮНДЭСЛЭЛ**	-
160.	18.1.Гаалийн байгууллага, албан тушаалтны шийдвэрийн талаарх гомдлыг бичгээр гаргана.	13.1.Гаалийн байгууллага, албан тушаалтны шийдвэрийн талаарх гомдлыг бичгээр гаргана.	**10.7 Стандарт** Давж заалдах гомдлыг бичгээр гаргах бөгөөд түүнд давж заалдах үндэслэлийг заасан байна.	-
161.	18.2.Энэ хуулийн 18.1-д заасан гомдол нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.	13.2.Энэ хуулийн 13.1-д заасан гомдол нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.	**10.8 Стандарт** Гаалийн байгууллагын шийдвэрийг давж заалдах гомдол гаргах хугацааг тогтоосон байх бөгөөд энэ нь давж заалдагч эдгээд давж заалдах асуудлаа судлах, давж заалдахад бэлтгэх хангалттай хугацааг олгосон байна.	-
162.	18.3.Энэ хуулийн 17.1.1,17.1.2-т заасны дагуу гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх үүрэг хүлээсэн гаалийн байгууллага, албан тушаалтан шаардлагатай бичиг баримтыг гомдол гаргагчаас гаргуулан авч болно.	13.3.Энэ хуулийн 12.1.1, 12.1.2-т заасны дагуу гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх үүрэг хүлээсэн гаалийн байгууллага, албан тушаалтан шаардлагатай бичиг баримтыг гомдол гаргагчаас гаргуулан авч болно.	**1.9 Стандарт** Гаалийн байгууллагад давж заалдах гомдол гаргасан үед зарчмын хувьд давж заалдах өргөдлийн хамт аливаа нотлох баримт гаргаж өгөхийг шаардахгүй боловч зарим тохиолдолд тийм нотлох баримт гаргаж өгөх боломжтой хугацааг олгоно.	-

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮЛЭЭЛЭН
www.pii.gov.mn

163.	**19 дүгээр зүйл.Гомдол гаргаснаас үүсэх үр дагавар**	**14 дүгээр зүйл.Гомдол гаргаснаас үүсэх үр дагавар**	**С. ДАВЖ ЗААЛДСАН АСУУДЛЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ**	-
164.	19.1.Гаалийн байгууллага, албан тушаалтны шийдвэрийн талаар гомдол гаргасан нь гомдол гаргагчаас тэрхүү шийдвэрийг биелүүлэхээс татгалзах үндэслэл болохгүй.	14.1.Гаалийн байгууллага, албан тушаалтны шийдвэрийн талаар гомдол гаргасан нь гомдол гаргагчаас тэрхүү шийдвэрийг биелүүлэхээс татгалзах үндэслэл болохгүй.	**1.9 Стандарт** Гаалийн байгууллага нь давж заалдсан хэргийн талаар зохих шийдвэр гаргах бөгөөд энэ талаар давж заалдагч этгээдэд нэн даруй бичгээр мэдэгдэнэ. **1.10 Стандарт** Гаалийн байгууллагад давж заалдсан хэргийг хэрэгсэхгүй болгосон бол гаалийн байгууллага үндэслэлийг бичгээр үйлдэж, тухайн шийдвэрийн талаар дараагийн шатанд захиргааны буюу бие даасан байгууллагад давж заалдах гомдол гаргах эрх болон давж заалдах гомдол гаргах хугацааны талаар давж заалдагч этгээдэд сануулна.	-
165.	19.2.Гомдолд дурдсан шийдвэр нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцэхгүй байх хангалттай үндэслэл байгаа, эсхүл тухайн шийдвэрийг биелүүлснээр үлэмж хэмжээний хохирол учрахаар бол гомдлыг хүлээн авсан гаалийн байгууллага, албан тушаалтан уг шийдвэрийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түдгэлзүүлж болно.	14.2.Гомдолд дурдсан эрх бүхий албан тушаалтны шийдвэр нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцэхгүй байх хангалттай үндэслэл байгаа, эсхүл тухайн шийдвэрийг биелүүлснээр гомдол гаргагчид үлэмж хэмжээний хохирол учрахаар бол гомдлыг хүлээн авсан гаалийн байгууллага, албан тушаалтан уг шийдвэрийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түдгэлзүүлж энэ тухай бичгээр мэдэгдэнэ.	**1.11 Стандарт** Давж заалдсан гомдлыг хангасан тохиолдолд, гаалийн байгууллага өөрийн шийдвэрийг, эсхүл бие даасан эрх бүхий байгуулагын буюу шүүх байгууллагын тогтоол шийдвэрийг давж заалдахаас бусад тохиолдолд тэдний тогтоол шийдвэрийг нэн даруй хэрэгжүүлнэ.	-
166.	**20 дугаар зүйл. Гомдлыг хүлээн авахаас татгалзах үндэслэл**	**15 дугаар зүйл.Гомдлыг хянан үзэхгүй байх**		*“хүлээн авахаас татгалзах үндэслэл” гэснийг “хянан үзэхгүй байх” гэж өөрчилсөн*
167.	20.1.Энэ хуулийн 17.1.1, 17.1.2-т заасан гаалийн байгууллага, албан тушаалтан дараахь тохиолдолд гомдлыг хүлээн авахаас татгалзана:	15.1.Энэ хуулийн 12.1.1-12.1.3-т заасан гаалийн байгууллага, албан тушаалтан дараах тохиолдолд гомдлыг хянан үзэхгүй:		*“хүлээн авахаас татгалзана” гэснийг “хянан үзэхгүй” гэж өөрчилсөн*
168.	20.1.1.гомдол гаргах хугацаа хэтэрсэн бөгөөд гомдол гаргагч тухайн хугацааг нөхөн сэргээлгэх тухай хүсэлт гаргаагүй;	15.1.1.гомдол гаргах хугацаа хэтэрсэн бөгөөд гомдол гаргагч тухайн хугацааг сэргээлгэх тухай хүсэлт гаргаагүй;		
169.	20.1.2.энэ хуулийн 18.1, 18.2-т заасан шаардлагыг хангаагүй;			*Хасагдсан*
170.	20.1.3.гомдолд дурдсан асуудлаар шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр байгаа;	15.1.2.өргөдөл, гомдолд дурдсан асуудлаар шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарсан;		-
171.	20.1.4.гомдолд дурдсан асуудал гаалийн байгууллагын эрх хэмжээнд хамааралгүй.	15.1.3.гомдолд дурдсан асуудал гаалийн байгууллагын эрх хэмжээнд хамааралгүй.		

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.legal.mn

172.	20.2.Гомдлыг хүлээн авахаас энэ хуулийн 20.1-д заасан үндэслэлээр татгалзах бол гаалийн байгууллага, албан тушаалтан гомдол хүлээн авсан өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор энэ тухай гомдол гаргагчид бичгээр мэдэгдэнэ.	15.2.Энэ хуулийн 13.1, 13.2-т заасан шаардлагыг хангаагүй бол шаардлага хангахыг мэдэгдэж, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор гомдол гаргагчид буцаана.		*Өөрчлөн найруулсан*
173.	20.3.Энэ хуулийн 20.2-т заасан шийдвэрийг гомдол гаргагч эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.			*Хасагдсан*
174.	**21 дүгээр зүйл. Гомдол гаргагч гомдлоосоо татгалзах, түүнээс үүсэх үр дагавар**	**16 дугаар зүйл.Гомдол гаргагч гомдлоосоо татгалзах, түүнээс үүсэх үр дагавар**		-
175.	21.1.Гомдол гаргагч гомдлоосоо татгалзан хэдийд ч буцаан авч болно.	16.1.Гомдол гаргагч гомдлоосоо татгалзан хэдийд ч буцаан авч болно.		-
176.	21.2.Энэ хуулийн 21.1-д заасны дагуу гомдлоо буцаан авсан нь тухайн гомдлыг хянан үзэхгүй байх, гэм буруутай албан тушаалтанд хариуцлага хүлээлгэхгүй байх үндэслэл болохгүй.	16.2.Энэ хуулийн 16.1-д заасны дагуу гомдлоо буцаан авсан нь тухайн гомдлыг хянан үзэхгүй байх, хэрэв гаргасан гомдолтой холбоотой гаалийн албан тушаалтан буруутай нь тогтоогдвол түүнд хариуцлага хүлээлгэхгүй байх үндэслэл болохгүй.		-
177.	**22 дугаар зүйл. Гомдлыг хянан шийдвэрлэх хугацаа**	**17дугаар зүйл. Гомдлыг хянан шийдвэрлэх хугацаа**		-
178.	22.1.Гаалийн байгууллага нь энэ хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу гаргасан гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлэнэ.	17.1.Гаалийн байгууллага нь энэ хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу гаргасан гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлэнэ.	**1.12 Стандарт** Давж заалдсан гомдлыг хангасан тохиолдолд, гаалийн байгууллага өөрийн шийдвэрийг, эсхүл бие даасан эрх бүхий байгуулагын буюу шүүх байгууллагын тогтоол шийдвэрийг давж заалдахаас бусад тохиолдолд тэдний тогтоол шийдвэрийг нэн даруй хэрэгжүүлнэ.	-
179.	**23 дугаар зүйл. Гомдлыг хянан шийдвэрлэх**	**18дугаар зүйл.Гомдлыг хянан шийдвэрлэх**		-
180.	23.1.Гаалийн байгууллага, албан тушаалтан нь энэ хуулийн 17.1-д заасан гомдлыг хянаж гаргасан шийдвэрээ гаалийн удирдах төв байгууллагын даргаас баталсан загварын дагуу бичгээр үйлдэнэ.	18.1.Гаалийн байгууллага, албан тушаалтан нь гомдлыг хянаж, гаргасан шийдвэрээ албан бичгээр үйлдэн баталгаажуулна.		-
181.	23.2.Энэ хуулийн 23.1-д заасан шийдвэр дараахь бүрдүүлбэртэй байна: 23.2.1.гомдлыг хянан шийдвэрлэсэн гаалийн байгууллагын нэр; 23.2.2.гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн гаалийн байгууллагын албан тушаалтны овог, нэр, албан тушаал; 23.2.3.гомдол гаргагчийн овог, нэр, эсхүл хуулийн этгээдийн нэр; 23.2.4.гомдлын товч агуулга; 23.2.5.гомдлыг шийдвэрлэсэн байдал; 23.2.6.шийдвэрийн үндэслэл; 23.2.7.шийдвэрт гомдол гаргах журмын тухай мэдээлэл.	18.2.Энэ хуулийн 18.1-д заасан шийдвэр дараах бүрдүүлбэртэй байна: 18.2.1.гомдлыг хянан шийдвэрлэсэн гаалийн байгууллагын нэр; 8.2.2.гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн гаалийн байгууллагын албан тушаалтны овог, нэр, албан тушаал; 18.2.3.гомдол гаргагчийн овог, нэр, эсхүл хуулийн этгээдийн нэр; 18.2.4.гомдлын товч агуулга; 18.2.5.гомдлыг шийдвэрлэсэн байдал; 18.2.6.шийдвэрийн үндэслэл; 18.2.7.шийдвэрт гомдол гаргах журмын тухай мэдээлэл.		-

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.legal.gov.mn

182.	23.3.Гомдлыг хянан үзсэн гаалийн байгууллага, албан тушаалтан дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:	18.3.Гомдлыг хянан үзсэн гаалийн байгууллага, албан тушаалтан дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:		-
183.	23.3.1.гаалийн байгууллага, албан тушаалтны шийдвэрийг хэвээр үлдээж, гомдлыг хангахаас татгалзах;	18.3.1.гаалийн байгууллага, албан тушаалтны шийдвэрийг хэвээр үлдээж, гомдлыг хангахаас татгалзах;		
184.	23.3.2.гаалийн байгууллага, албан тушаалтны шийдвэрийг бүхэлд нь, эсхүл холбогдох хэсгийг өөрчлөх буюу хүчингүй болгох;	18.3.2.гаалийн байгууллага, албан тушаалтны шийдвэрийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг өөрчлөх буюу хүчингүй болгох;		
185.	23.3.3.гаалийн байгууллага, албан тушаалтны амаар гаргасан шийдвэр, эс үйлдэхүй нь хууль бус болох нь тогтоогдвол зохих шийдвэр гаргахыг түүнд даалгах.	18.3.3.гаалийн байгууллага, албан тушаалтны амаар гаргасан шийдвэр нь хууль бус болох нь тогтоогдвол зөвтгөх шийдвэр гаргахыг даалгах.		*“, эс үйлдэхүй” гэснийг хассан*
186.	23.4.Энэ хуулийн 23.3.2, 23.3.3-т заасны дагуу гаргах шийдвэрт биелүүлэх хугацааг нь заах бөгөөд түүнийг холбогдох гаалийн байгууллага, албан тушаалтан заавал биелүүлнэ.	18.4.Энэ хуулийн 18.3.2, 18.3.3-т заасны дагуу гаргах шийдвэрт биелүүлэх хугацааг нь заах бөгөөд түүнийг холбогдох гаалийн байгууллага, албан тушаалтан заавал биелүүлнэ.		-
187.		18.5.Энэ хуулийн 18.3.2, 18.3.3-т заасны дагуу гомдлыг хянан шийдвэрлэсэн эрх бүхий албан тушаалтны шийдвэр гарч, гомдлын шаардлагыг хангасан тохиолдолд буруу шийдвэр гаргасан гаалийн албан тушаалтанд сахилга, ёс зүйн хариуцлага хүлээлгэнэ.		
188.	**II ХЭСЭГ ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТ**			
189.	**ЗУРГАДУГААР БҮЛЭГ Гаалийн бүрдүүлэлт хийх**	**ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТ**		*“хийх” гэснийг хассан*
190.	**Нэгдүгээр дэд бүлэг Нийтлэг үндэслэл**			
191.	**24 дүгээр зүйл. Гаалийн бүрдүүлэлт хийх**	**83 дугаар зүйл.Гаалийн бүрдүүлэлт хийх**		-
192.	24.1.Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд энэ хуульд заасан журмын дагуу гаалийн бүрдүүлэлт хийнэ.	83.1.Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд энэ хуульд заасан журмын дагуу гаалийн байгууллага гаалийн бүрдүүлэлт хийнэ		-
193.		83.3.Гаалийн бүрдүүлэлтийг зөвхөн ажил үүргийн хуваарийн хүрээнд эрх олгогдсон албан тушаалтан гаалийн байгууллагын нэрийн өмнөөс хийнэ.		
194.	24.2.Бараа илгээх, хүлээн авах болон барааны гарал үүслийн улсаас үл хамааран гаалийн хилээр нэвтрүүлэх бараанд гаалийн бүрдүүлэлт хийнэ.	83.4.Гаалийн бүрдүүлэлтийг илгээгч, хүлээн авагч, гарал үүслийн улсаас үл хамааран гаалийн хилээр нэвтэрч буй бүх бараанд хийнэ		
195.		83.5.Гаалийн бүрдүүлэлт нь барааг гаальд мэдүүлсэн үеэс эхэлж, мэдүүлэгчийн сонгосон горимд байршуулснаар дуусна		*хасагдсан*

ХУУЛЬ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН

196.	24.3.Гаалийн хилээр нэвтрүүлэх зарим бараа, тээврийн хэрэгслийн төрөл, онцлогийг харгалзан гаалийн бүрдүүлэлтийн журмыг энэ хуульд нийцүүлэн гаалийн удирдах төв байгууллагын дарга тусгайлан баталж болно.	83.2.Гаалийн хилээр нэвтрүүлж байгаа барааны нэр төрөл, тээврийн хэрэгслийн төрөл, нэвтрүүлж байгаа этгээдээс хамааран гаалийн бүрдүүлэлтийн технологи ажиллагааны зааврыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална. Энэ технологи ажиллагааны зааварт татвар, хураамж, тарифын бус хязгаарлалтын арга хэмжээнээс хэсэгчилэн болон бүрэн чөлөөлөх агуулга бүхий заалт оруулахгүй.		*хасагдсан*
197.	**25 дугаар зүйл. Гаалийн бүрдүүлэлт хийх газар, цаг**	**84 дүгээр зүйл.Гаалийн бүрдүүлэлт хийх газар, цаг**		-
198.	25.1.Гаалийн бүрдүүлэлтийг гаалийн байгууллага бүхий газарт, гаалийн удирдах төв байгууллагын даргаас тогтоосон цагт хийнэ.	84.1.Гаалийн бүрдүүлэлтийг гаалийн байгууллага бүхий газарт, гаалийн удирдах төв байгууллагаас тогтоосон ажлын цагт хийнэ.		-
199.		84.2.Мэдүүлэгчийн бичгээр гаргасан хүсэлтийг зайлшгүй гэж үзвэл энэ хуулийн 84.1-т зааснаас өөр газарт, ажлын бус цагаар гаалийн байгууллага гаалийн бүрдүүлэлтийг хийж болно.		
200.		**85 дугаар зүйл. Гаалийн бүрдүүлэлтийн дэс дараалал**		
201.		85.1.Гаалийн бүрдүүлэлтийг дараах дарааллын дагуу хийнэ: 85.1.1.гаалийн мэдүүлгийг хүлээн авах; 85.1.2.гаалийн мэдүүлэг, бичиг баримт шалгах; 85.1.3.бараа, тээврийн хэрэгслийг шалгах; 85.1.4.зөрчил илэрсэн тохиолдолд хянан шийдвэрлэх; 85.1.5.бараа, тээврийн хэрэгслийг гаалийн бүрдүүлэлтийн горимд байршуулах.		
202.				
203.	**26 дугаар зүйл. Гаалийн бүрдүүлэлтийн хураамж**	**86 дугаар зүйл. Гаалийн бүрдүүлэлтийн хураамж**		-
204.	26.1.Мэдүүлэгч гаалийн бүрдүүлэлтийн үйлчилгээний хураамж төлнө.	86.1.Мэдүүлэгч гаалийн бүрдүүлэлтийн үйлчилгээний хураамж төлнө		-
205.	26.2.Энэ хуулийн 26.1-д заасан хураамжийн хэмжээг үйлчилгээний зардлыг харгалзан гаалийн удирдах төв байгууллагын дарга тогтооно.	86.2.Энэ хуулийн 86.1-д заасан хураамжийг улсын төсөвт төвлөрүүлэх бөгөөд хураамжийн хэмжээг гаалийн удирдах төв байгууллагын дарга тогтооно		*Хуулийн 26.2, 26.3-ийг нэгтгэсэн*
	26.3.Энэ хуулийн 26.1-д заасан хураамжийг улсын төсөвт төвлөрүүлнэ.			
206.	**27 дугаар зүйл.Гаалийн бүрдүүлэлт хийхэд шаардагдах мэдээлэл, бичиг баримт**	**87 дугаар зүйл.Гаалийн бүрдүүлэлт хийхэд шаардагдах мэдээлэл, бичиг баримт**		-
207.	27.1.Гаалийн байгууллага гаалийн бүрдүүлэлт хийхэд шаардагдах мэдээлэл, бичиг баримтыг мэдүүлэгчээс гаргуулан авна.	87.1.Гаалийн бүрдүүлэлтэд шаардагдах мэдээлэл, бичиг баримтыг мэдүүлэгч гаргаж өгнө.		-
208.	27.2.Энэ хуулийн 27.1-д заасан мэдээлэл, бичиг баримт гаргаж өгөх хугацааг гаалийн удирдах төв байгууллагын дарга тогтооно.			*“Энэ хуулийн 27.1-д заасан” гэснийг “Гаалийн бүрдүүлэлтэд шаардагдах” гэж өөрчилсөн*

Хууль зүйн үндэсний хүрээлэн

209.	27.3.Гаалийн удирдах төв байгууллага гаалийн бүрдүүлэлтийг хялбарчлах, түргэвчлэх зорилгоор гадаад улсын гаалийн байгууллагатай мэдээлэл, бичиг баримтыг харилцан хүлээн зөвшөөрөх тухай гэрээ байгуулж болно.	87.2.Гаалийн удирдах төв байгууллага гаалийн бүрдүүлэлтийг хялбарчлах, түргэвчлэх зорилгоор гадаад улсын гаалийн байгууллагатай мэдээлэл, бичиг баримтыг харилцан хүлээн зөвшөөрөх тухай гэрээ байгуулж болно.		-
210.	27.4.Энэ хуулийн 27.1-д заасан мэдээлэл, бичиг баримтыг гадаад хэл дээр үйлдэж болох боловч шаардлагатай гэж үзвэл гаалийн байгууллага тэдгээрийг төрийн албан ёсны хэлээр үйлдүүлэн мэдүүлэгчээс гаргуулан авна.	87.3.Энэ хуулийн 87.1-д заасан мэдээлэл, бичиг баримт гадаад хэл дээр үйлдэгдсэн бол шаардлагатай тохиолдолд гаалийн байгууллага тэдгээрийг төрийн албан ёсны хэлээр үйлдүүлэн мэдүүлэгчээс гаргуулан авна.		-
211.		87.4.Гаалийн байгууллага бүрдүүлэлтэд нөлөөлөхөөргүй техникийн, дүрмийн, хэвлэлийн алдаанаас шалтгаалан бичиг баримтыг хүлээн авахаас татгалзаж болохгүй.		
212.	27.5.Гаалийн байгууллага энэ хуулийн 27.1-д заасан мэдээлэл, бичиг баримтын эх хувийг, эсхүл түүний хуулбарыг гаргуулан авах бөгөөд шаардлагатай бол бичиг баримтын хуулбарыг эх хувьтай нь тулган шалгана.			*Хасагдсан*
213.	27.6.Энэ хуулийн 27.1-д заасан мэдээлэл, бичиг баримтыг факс, нийтийн электрон шуудан, гаалийн байгууллагатай холбогдсон бусад байгууллагын мэдээллийн сүлжээ /цаашид “мэдээллийн сүлжээ” гэх/-гээр ирүүлж болно.	87.5.Энэ хуулийн 87.1-д заасан мэдээлэл, бичиг баримтыг цахим хэлбэрээр ирүүлж болно.		-
214.	27.7.Мэдээллийн сүлжээгээр ирүүлсэн мэдээлэл, бичиг баримтыг хэвлэж эрх бүхий этгээдийн гарын үсгээр баталгаажуулна.			-
215.	27.8.Мэдээллийн сүлжээгээр ирүүлсэн бичиг баримтыг эх хувьд тооцож болно.	87.6.Мэдээллийн сүлжээгээр ирүүлсэн бичиг баримтыг эх хувьд тооцож болно.		-
216.				*нэмэгдсэн*
217.	**28 дугаар зүйл.Гаалийн бүрдүүлэлт хийхэд мэдүүлэгч, эсхүл түүний төлөөлөгчийг оролцуулах**	**88 дугаар зүйл.Гаалийн бүрдүүлэлт хийхэд мэдүүлэгч, эсхүл түүний төлөөлөгчийг оролцуулах**		-
218.	28.1.Гаалийн бүрдүүлэлт хийхэд мэдүүлэгч, эсхүл түүний төлөөлөгчийг оролцуулна.	88.1.Гаалийн бүрдүүлэлт хийхэд мэдүүлэгч, эсхүл түүний төлөөлөгчийг оролцуулна		-
219.	28.2.Гаалийн байгууллага, албан тушаалтан гаалийн бүрдүүлэлт хийх үйл ажилллагааг хялбарчлах зорилгоор мэдүүлэгч, эсхүл түүний төлөөлөгчийн туслалцаа авч болно.	88.2.Гаалийн байгууллага, албан тушаалтан гаалийн бүрдүүлэлт хийх үйл ажиллагааг хялбарчлах зорилгоор мэдүүлэгч, эсхүл түүний төлөөлөгчийн туслалцаа авч болно.		-
220.	**29 дүгээр зүйл. Гаалийн түргэвчилсэн бүрдүүлэлт**	**89 дүгээр зүйл.Гаалийн түргэвчилсэн бүрдүүлэлт**		-
221.	29.1.Гаалийн хилээр нэвтрүүлэх дор дурдсан барааnd гаалийн түргэвчилсэн бүрдүүлэлтийг хийж болно:	89.1.Гаалийн хилээр нэвтрүүлэх дараах барааnd гаалийн түргэвчилсэн бүрдүүлэлтийг хийж болно:		-

Хяналт шалгалтын үндэсний хүрээлэн www.nii.gov.mn

222.	29.1.1.гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас бий болсон хохирлыг арилгах зориулалтын бараа;	89.1.1.гамшгийн хохирлыг арилгах зориулалтын бараа		*“гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас бий болсон” гэснийг “Гамшгийн” гэж өөрчилсөн*
223.	29.1.2.цацраг идэвхт бодис, химийн хорт болон аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис;	89.1.2.цацраг идэвхт бодис, химийн хорт болон аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис;		-
224.	29.1.3.мал, амьтан;	89.1.3.мал, амьтан;		-
225.	29.1.4.улс хоорондын шуудангийн илгээмж;	89.1.9.олон улсын шуудан, илгээмж;		*Хасагдсан*
226.	29.1.5.сонин, тогтмол хэвлэл, мэдээллийн болон эрдэм шинжилгээ, судалгааны материал;			*Хасагдсан*
227.	29.1.6.амархан муудах, гэмтэх магадлал бүхий хадгалалтын онцгой нөхцөл шаардсан бараа;	89.1.4.амархан муудах, гэмтэх зэрэг хадгалалтын онцгой нөхцөл шаардсан бараа;		-
228.	29.1.7.донорын эд эрхтэн, цус, цусан бүтээгдэхүүн;	89.1.5.донорын эд эрхтэн, цус, цусан бүтээгдэхүүн;		
229.	29.1.8.хуульд заасан бусад бараа.	89.1.6.хүмүүнлэгийн болон техникийн туслалцааны бараа;		
230.		89.1.7.энхийг сахиулах ажиллагаа болон цэргийн сургуулилттай холбоотой цэргийн техник хэрэгсэл, зэвсэг, хэрэгсэл;		
231.		89.1.8.улс хоорондын үйлчилгээний тээврийн хэрэгслийг засварлах сэлбэг, тос, тосолгооны материал;		
232.		89.1.10.хуульд заасан бусад бараа.		
233.	29.2.Энэ хуулийн 29.1-д заасан барааnд гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтыг гаалийн байгууллагаас тогтоосон хугацаанд бүрдүүлж өгөх болзолтойгоор дараалал харгалзахгүй гаалийн бүрдүүлэлт хийнэ.	89.2.Энэ хуулийн 89.1-д заасан барааnд гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтыг ажлын гурван хоногийн дотор бүрдүүлж өгөх болзолтойгоор дараалал харгалзахгүй гаалийн бүрдүүлэлт хийнэ.		*“гаалийн байгууллагаас тогтоосон хугацаанд” гэснийг “ажлын 3 хоногийн дотор” гэж өөрчилсөн*
234.	29.3.Энэ хуулийн 29.1-д заасан барааг мэдүүлэгч нь гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтыг гаалийн байгууллагаас тогтоосон хугацаанд гаргаж өгөх баталгааг бичгээр гаргана.	89.3.Энэ хуулийн 89.1-д заасан барааг мэдүүлэгч нь гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтыг гаалийн байгууллагад тогтоосон хугацаанд гаргаж өгөх баталгааг бичгээр гаргана.		-
235.	29.4.Гаалийн түргэвчилсэн бүрдүүлэлтийг дараахь тохиолдолд хийхийг хориглоно:	89.4.Гаалийн түргэвчилсэн бүрдүүлэлтийг дараах тохиолдолд хийхийг хориглоно:		
236.	29.4.1.гаалийн бичиг баримт зөрчилтэй;	89.4.1.гаалийн бичиг баримт зөрчилтэй;		
237.	29.4.2.мэдүүлсэн барааны тоо, хэмжээ зөрүүтэй, эсхүл үнийн дүн нь зөрчилтэй;	89.4.2.мэдүүлсэн барааны тоо, хэмжээ зөрүүтэй, эсхүл үнийн дүн зөрчилтэй;		
238.	29.4.3.мэдүүлэгч нь гаалийн хууль тогтоомжийн зөрчил удаа дараа /2 буюу түүнээс дээш/ гаргаж байсан;			*удаа дараа /2 буюу түүнээс дээш/ гэснийг хоёр буюу түүнээс дээш удаа гэж өөрчилсөн*

ХУУЛЬ ЗҮЙН ЯНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

239.	29.4.4.энэ хуулийн 29.3-т заасан баталгааг гаргаж өгөөгүй;	89.4.3.энэ хуулийн 89.3-т заасан баталгааг гаргаж өгөөгүй;		
240.	29.4.5.гаалийн болон бусад татвар, хураамж төлөөгүй, эсхүл төлөх баталгааг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн дагуу гаргаагүй.	89.4.4.гаалийн болон бусад татвар, хураамж төлөөгүй, эсхүл төлөх баталгааг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн дагуу гаргаагүй.		-
241.	**30 дугаар зүйл.Гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт**	**90 дүгээр зүйл.Гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт**		-
242.	30.1.Энэ хуульд заасан бичиг баримтыг шаардахгүйгээр гаалийн мэдүүлгийн зарим хэсгийг нөхөн бичүүлэх замаар гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт хийж, барааг гаалийн хилээр нэвтрүүлж болно.	90.1.Энэ хуульд заасан бичиг баримтыг шаардахгүйгээр гаалийн мэдүүлгийн зарим хэсгийг, эсхүл товч мэдүүлэг нөхөн бичүүлэх замаар гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт хийж, барааг гаалийн хилээр нэвтрүүлж болно.		-
243.	30.2.Гаалийн хялбарчилсан бүрдүүлэлтийг дараахь тохиолдолд хийж болно:	90.2.Гаалийн хялбарчилсан бүрдүүлэлтийг дараах тохиолдолд хийж болно:		-
244.	30.2.1.барааг гаалийн нутаг дэвсгэрээр дамжуулахгүйгээр хилийн чанадаас шууд гаалийн баталгаат бүсэд оруулах;	90.2.1.барааг хилийн чанадаас гаалийн баталгаат бүсэд оруулах;		*“гаалийн нутаг дэвсгэрээр дамжуулахгүйгээр хилийн чанадаас шууд” гэснийг “хилийн чанадаас” гэж өөрчилсөн*
245.	30.2.2.барааг гаалийн баталгаат бүсээс гаалийн нутаг дэвсгэрээр дамжуулахгүйгээр хилийн чанадад гаргах.	90.2.2.барааг гаалийн баталгаат бүсээс хилийн чанадад гаргах.		*“гаалийн баталгаат бүсээс гаалийн нутаг дэвсгэрээр дамжуулахгүйгээр” гэснийг “гаалийн баталгаат бүсээс” гэж өөрчилсөн*
246.	**Хоёрдугаар дэд бүлэг Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн нутаг дэвсгэрт оруулах**			
247.	**31 дүгээр зүйл. Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн нутаг дэвсгэрт оруулах**	**36 дугаар зүйл.Гаалийн хяналтын бүсэд бараа хадгалах хугацаа**		
248.		36.1.Барааг гаалийн хяналтын бүсэд оруулснаас хойш гурав хүртэл хоног хадгалах бөгөөд энэ хугацаанд гаалийн бүрдүүлэлт хийгдээгүй бол барааг гаалийн түр агуулахад шилжүүлнэ.		
249.		36.2.Энэ хуулийн 36.1-д заасны дагуу барааг шилжүүлэх боломжгүй бол барааг гаалийн нээлттэй түр агуулахад шилжсэнд тооцох бөгөөд энэ тохиолдолд хяналтын бүс нь түр агуулахын үүрэг гүйцэтгэнэ.		
250.		36.3.Гаалийн шалгалтыг гаалийн хяналтын бүсэд хийх боломжгүй бол өөр газарт мэдүүлэгчийн зардлаар хийж болно.		
251.	31.1.Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн нутаг дэвсгэрт Монгол Улсын хоёр талын олон улсын гэрээний дагуу тогтоосон хилийн боомтоор оруулна.			

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

252.	31.2.Гаалийн нутаг дэвсгэрт зарим нэр төрлийн бараа оруулах хилийн боомтыг энэ хууль, холбогдох бусад хуульд заасны дагуу, эсхүл Засгийн газрын шийдвэрээр тогтоож болно.			*Өөрчлөн найруулсан*
253.	**32 дугаар зүйл. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын үед авах арга хэмжээ**	**62 дугаар зүйл.Гашгийн үед авах арга хэмжээ**		*Өөрчилсөн*
254.	32.1.Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрт оруулах бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллага бүхий газарт тээвэрлэн хүргэх боломжгүй болсон тохиолдолд хамгийн ойр байрлах гаалийн байгууллагад мэдэгдэх, түүнд хүргэх арга хэмжээ авна.	62.1.Гамшгийн улмаас Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрт оруулах бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллага бүхий газарт тээвэрлэн хүргэх боломжгүй болсон тохиолдолд тээвэрлэгчхамгийн ойр байрлах гаалийн байгууллагад мэдэгдэх, түүнд хүргэх арга хэмжээ авна.		*“Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын” гэснийг “Гамшгийн” гэж өөрчилсөн*
255.	32.2.Энэ хуулийн 32.1-д заасан тохиолдолд тухайн бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр ашиглах, эсхүл бусдад шилжүүлэхийг хориглоно.	62.2.Энэ хуулийн 62.1-д заасан тохиолдолд тухайн бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр ашиглах, эсхүл бусдад шилжүүлэхийг хориглоно.		-
256.	32.3.Энэ хуулийн 32.1-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд гарах зардлыг мэдүүлэгч өөрөө хариуцна.	62.3.Энэ хуулийн 62.1-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд гарах зардлыг мэдүүлэгч өөрөө хариуцна.		-
257.	**33 дугаар зүйл. Бараа, тээврийн хэрэгслийн талаар гаалийн байгууллагад урьдчилан мэдэгдэх**	**42 дугаар зүйл.Бараа, тээврийн хэрэгслийн талаар гаалийн байгууллагад урьдчилан мэдэгдэх**		
258.	33.1.Гаалийн хилээр бараа, тээврийн хэрэгсэл оруулах хилийн боомт, хүрэх газрыг тээвэрлэгч нь гаалийн байгууллагад урьдчилан мэдэгдэнэ.	42.1.Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн нутаг дэвсгэрт оруулах хилийн боомт, хүрэх газар, тухайн бараа, тээврийн хэрэгслийн талаарх мэдээллийг тээвэрлэгч, тээвэр зуучлагчийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд гаалийн байгууллагад урьдчилан мэдэгдэх үүрэгтэй. Шуудангийн байгууллага нь мөн дээрх мэдээллийг тээвэрлэгчид хүлээлгэн өгсөн үеэс гаалийн байгууллагад урьдчилан мэдэгдэнэ.		*“гаазрыг тээвэрлэгч нь гаалийн байгууллагад урьдчилан мэдэгдэнэ.” гэснийг “газар, тухайн бараа, тээврийн хэрэгслийн талаарх мэдээллийг тээвэр зуучлагчийн үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд тэдгээрийг хилээр нэвтрүүлэхээс 3-аас доошгүй хоногийн өмнө гаалийн байгууллагад урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.” гэж өөрчилсөн*
259.		42.2.Тээвэрлэгч, тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэгч нь ачаа тээврийн гэрээ, гадаад худалдааны бичиг баримт, тээврийн зардал, хүрэх боомтын нэр зэрэг мэдээллийг гаалийн байгууллагад гаргаж өгнө.		

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

260.		42.3.Олон улсын тээвэр зуучийн үйл ажиллагаа эрхлэгч этгээд дараах мэдээллийг гаргаж өгнө: 42.3.1.илгээгч, хүлээн авагчийн мэдээлэл; 42.3.2.тээврийн хэрэгслийн талаарх мэдээлэл; 42.3.3.барааны талаарх мэдээлэл /үнэ, тоо хэмжээ жин зэрэг/; 42.3.4.тээврийн зардал; 42.3.5.чингэлэг эзэмшигчийн талаарх мэдээлэл; 42.3.6.сав баглаа боодлын талаарх мэдээлэл.		
261.		42.4.Шуудангийн байгууллага нь дараах мэдээллийг гаргаж өгнө: 42.4.1.илгээгч, хүлээн авагчийн мэдээлэл; 42.4.2.барааны талаарх мэдээлэл /үнэ, тоо хэмжээ жин зэрэг/; 42.4.3.тээврийн зардал; 42.4.4.дамжин өнгөрсөн улс, шуудангийн байгууллагын мэдээлэл.		
262.	33.2.Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хил дээр ирсэн даруйд нь тээвэрлэгч энэ тухай гаалийн байгууллагад мэдэгдэнэ.	42.5.Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хил дээр ирсэн даруйд тээвэрлэгч энэ тухай гаалийн байгууллагад мэдэгдэнэ.		-
263.		42.6.Төмөр замын дагуу байрлах гаалийн хяналтын бүсэд улиралд ачиж, буулгах бараа, тээврийн хэрэгслийн тоог улирал бүрийн эхний сарын 10-ны өдрийн дотор харьяалах гаалийн байгууллагад өгч, сар бүр тодотгол хийж байх.		
264.	33.3.Тогтоосон цагийн хуваарьтай зорчигч үйлчилгээний тээврийн хэрэгсэл гаалийн хилээр нэвтрэхээс нэг цагийн өмнө гаалийн байгууллагад мэдэгдэнэ.	42.7.Тогтоосон цагийн хуваарьтай зорчигч үйлчилгээний тээврийн хэрэгсэл гаалийн хилээр нэвтрэхээс нэг цагийн өмнө гаалийн байгууллагад мэдэгдэнэ.		-
265.		42.8.Энэ хуулийн 42.5-т заасны дагуу мэдэгдэхдээ зорчигчийн тоо, нэрс, ачааны мэдээллийг гаргаж өгнө.		
266.	**34 дүгээр зүйл.Мэдээлэл, бичиг баримт гаргаж өгөх**	**43 дугаар зүйл.Тээвэрлэгч мэдээлэл, бичиг баримт гаргаж өгөх**		*“Мэдээлэл” гэсний өмнө “Тээвэрлэгч” гэж нэмсэн*
267.	34.1.Бараа, тээврийн хэрэгсэл гаалийн хил дээр ирмэгц тээвэрлэгч нь тээврийн хэрэгслийн төрлөөр, энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан мэдээлэл, бичиг баримтыг гаалийн байгууллагад гаргаж өгнө.	43.1.Бараа, тээврийн хэрэгсэл гаалийн хил дээр ирмэгц тээвэрлэгч нь тээврийн хэрэгслийн төрлөөр, энэ хуулийн 44 дүгээр зүйлд заасан мэдээлэл, бичиг баримтыг гаалийн байгууллагад гаргаж өгнө.		-
268.	34.2.Энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан мэдээлэл, бичиг баримт нь шаардлага хангаагүй тохиолдолд тээвэрлэгч болон мэдүүлэгч нь нэмэлт мэдээлэл гаргаж өгнө.	43.2.Энэ хуулийн 44 дүгээр зүйлд заасан мэдээлэл, бичиг баримт нь шаардлага хангаагүй тохиолдолд тээвэрлэгч болон мэдүүлэгч нь нэмэлт мэдээлэл гаргаж өгнө.		
269.	34.3.Тээвэрлэгч нь энэ хуулийн 34.1, 34.2-т заасан мэдээлэл, бичиг баримтыг мэдээллийн сүлжээгээр гаалийн байгууллагад ирүүлж болно.	43.3.Тээвэрлэгч нь энэ хуулийн 44 дүгээр зүйлд заасан мэдээлэл, бичиг баримтыг мэдээллийн сүлжээгээр гаалийн байгууллагад ирүүлж болно.		

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.legalinfo.mn

270.	**35 дугаар зүйл. Гаалийн бүрдүүлэлт хийхэд шаардагдах мэдээлэл, бичиг баримт**	**44 дүгээр зүйл.Тээвэрлэгчээс гаргаж өгөх мэдээлэл, бичиг баримт**		*Гаалийн бүрдүүлэлт хийхэд шаардагдах” гэснийг “Тээвэрлэгчээс гаргаж өгөх” гэж өөрчилсөн*
271.	35.1.Улс хооронд авто тээврийн хэрэгслээр бараа тээвэрлэсэн тээвэрлэгч нь дараахь бичиг баримтыг гаалийн байгууллагад гаргаж өгнө: 35.1.1.авто тээврийн хэрэгслийн гэрчилгээ; 35.1.2.ачаа тээвэрлэлтийн бичиг баримт; 35.1.3.худалдааны бичиг баримт.	44.1.Улс хооронд авто тээврийн хэрэгслээр зорчигч, бараа тээвэрлэсэн тээвэрлэгч нь дараах бичиг баримтыг гаалийн байгууллагад гаргаж өгнө: 44.1.1.тээврийн хэрэгслийн гэрчилгээ; 44.1.2.ачаа тээвэрлэлтийн бичиг баримт; 44.1.3.худалдааны бичиг баримт.		-
272.	35.2.Энэ хуулийн 35.1-д заасан бичиг баримтад дараахь мэдээллийг оруулна: 35.2.1.тээвэрлэгчийн нэр, хаяг; 35.2.2.тээврийн хэрэгслийн харьяалал; 35.2.3.бараа илгээх, хүлээн авах улсын нэр; 35.2.4.бараа илгээгч, хүлээн авагчийн нэр, хаяг; 35.2.5.худалдагч, худалдан авагчийн нэр, хаяг; 35.2.6.барааны нэр төрөл, тоо, хэмжээ, баглаа боодлын төрөл, тэмдэг 35.2.7.тухайн бараа тарифын бус хязгаарлалтад хамаарах эсэх	44.2.Энэ хуулийн 44.1-д заасан бичиг баримтад дараах мэдээллийг оруулна: 44.2.1.зорчигчийн мэдээлэл; 44.2.2.тээвэрлэгчийн нэр, хаяг; 44.2.3.тээврийн хэрэгслийн харьяалал; 44.2.4.бараа илгээх, хүлээн авах улсын нэр; 44.2.5.бараа илгээгч, хүлээн авагчийн нэр, хаяг; 44.2.6.барааны нэр төрөл, тоо, хэмжээ, баглаа боодлын төрөл, тэмдэг.		*Хасагдсан*
273.	35.3.Улс хооронд агаарын тээврийн хэрэгслээр тээвэрлэсэн тээвэрлэгч нь дараахь бичиг баримтыг гаалийн байгууллагад гаргаж өгнө:	44.3.Улс хооронд агаарын тээврийн хэрэгслээр зорчигч, бараа тээвэрлэсэн тээвэрлэгч нь дараах бичиг баримтыг гаалийн байгууллагад гаргаж өгнө:		*“бараа” гэсний дараа “зорчигч, бараа тээвэрлэсэн” гэж нэмсэн*
274.		44.3.1. зорчигчийн мэдээлэл		*Шинээр нэмэгдсэн*
275.	35.3.1.тээврийн хэрэгслийн гэрчилгээ;			*Хасагдсан*
276.	35.3.2.ерөнхий мэдүүлэг;			*Хасагдсан*
277.	35.3.3.зорчигчийн нэрсийн жагсаалт;			*Хасагдсан*
278.	35.3.4.ачааны жагсаалт /карго манифест/;	44.3.2. ачааны жагсаалт /карго манифест, шуудангийн манифест/;		*“/карго манифест/” гэснийг “/cargo manifest, mail manifest/” гэж өөрчилсөн*
279.	35.3.5.ачаа тээвэрлэлтийн бичиг баримт;			-
280.		44.3.3. агаарын тээврийн дагалдах бичиг баримт;		
281.	35.3.6.аяллын хугацаанд хэрэглэх зорчигчийн хүнс, хэрэгслийн жагсаалт;	44.3.4. аяллын хугацаанд хэрэглэх зорчигчийн хүнс, хэрэгслийн жагсаалт;		-
282.	35.3.7.худалдааны бичиг баримт.	44.3.5. худалдааны бичиг баримт.		-
283.	35.4.Энэ хуулийн 35.3-т заасан бичиг баримтад дараахь мэдээллийг оруулна:	44.4.Энэ хуулийн 44.3-т заасан бичиг баримтад дараах мэдээллийг оруулна:		-
284.		44.4.1. тээврийн хэрэгслийн харьяалал, эзэмшигч;		
285.	35.4.1.тээврийн хэрэгслийн харьяалал,эзэмшигч;	44.4.2. нислэгийн дугаар, маршрут;		
286.	35.4.2.нислэгийн дугаар, маршрут;			

хуулийн мэдээллийн хүрээлэн www.legal.mn

287.	35.4.3.агаарын хөлгийн багтай холбогдсон мэдээлэл;			*Хасагдсан*
288.		44.4.3.зорчигчийн нэр		*Нэмэгдсэн*
289.	35.4.4.барааны нэр төрөл, тоо, хэмжээ, баглаа боодлын төрөл, тэмдгийн талаар;	44.4.4.барааны нэр төрөл, тоо, хэмжээ, үнийн дүн, баглаа боодлын төрөл, тэмдэг		*"тэмдгийн талаар" гэснийг "тэмдэг" гэж өөрчилсөн*
290.	35.4.5.бараа тарифын бус хязгаарлалтад хамаарах эсэх.			*Хасагдсан*
291.\	35.5.Улс хооронд төмөр замаар бараа тээвэрлэхэд тээвэрлэгч нь дараахь бичиг баримтыг гаалийн байгууллагад гаргаж өгнө:	44.5.Улс хооронд төмөр замаар зорчигч, бараа тээвэрлэхэд тээвэрлэгч нь дараах бичиг баримтыг гаалийн байгууллагад гаргаж өгнө:		-
292.	35.5.1.дамжуулах хуудас;	44.5.1.дамжуулах хуудас;		
293.	35.5.2.вагон хуудас;	44.5.2.вагон хуудас;		
294.	35.5.3.тээврийн бичиг баримт;	44.5.3.тээврийн бичиг баримт;		
295.	35.5.4.худалдааны бичиг баримт.	44.5.4.худалдааны бичиг баримт;		
296.		44.5.5.зорчигчийн мэдээлэл;		
297.		44.5.6.тээшний вагоны ачаа дагалдах хуудас.		
298.	35.6.Энэ хуулийн 35.5-д заасан бичиг баримтад дараахь мэдээллийг оруулна:	44.6.Энэ хуулийн 44.5-д заасан бичиг баримтад дараах мэдээллийг оруулна:		
299.	35.6.1.бараа илгээгч, хүлээн авагчийн нэр, хаяг;	44.6.1. бараа илгээгч, хүлээн авагчийн нэр, хаяг;		*Нэмэгдсэн*
300.	35.6.2.бараа илгээх, дамжин өнгөрөх, хүлээн авах өртөө;	44.6.2. бараа илгээх, дамжин өнгөрөх, хүлээн авах өртөө;		
301.	35.6.3.ачааны нэр төрөл, тоо, хэмжээ, баглаа боодлын төрөл, тэмдэг;	44.6.3. ачааны нэр төрөл, тоо, хэмжээ, баглаа боодлын төрөл, тэмдэг;		
302.	35.6.4.чингэлэгийн дугаар.	44.6.4. чингэлэгийн дугаар.		
303.	**36 дугаар зүйл.Ачааны манифест**	**45 дугаар зүйл.Ачааны манифест, тээврийн мэдүүлэг**		*"манифест" гэсний дараа ", тээврийн мэдүүлэг" гэж нэмсэн*
304.		45.1.Манифест нь хилээр нэвтрүүлж байгаа бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналтад авах бичиг баримт болно.		
305.	36.1.Энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан бичиг баримтыг үндэслэн ачааны манифест үйлдэнэ.	45.2 Энэ хуулийн 44 дүгээр зүйлд заасан бичиг баримтыг үндэслэн тээвэрлэгч ачааны манифест үйлдэнэ.		*"үндэслэн" гэсний дараа "тээвээрлэгч" гэж нэмсэн*
306.		45.3.Ачааны манифесттай барааг гаалийн байгууллага хооронд бүрэн болон хэсэгчлэн шилжүүлэх тохиолдолд тээврийн хэрэгслийн төрөл солигдох эсэхээс үл хамааран манифестыг үндэслэн тээврийн мэдүүлгийг бичнэ.		*Нэмэгдсэн*
307.	36.2.Ачааны манифест нөхөн бичих, хянах, бүртгэх журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.	45.4.Ачааны манифест болон тээврийн мэдүүлгийг бөглөж бичих, хянах, бүртгэх журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.		*"нөхөн бичих," гэснийг "болон тээврийн мэдүүлгийг бөглөж бичих," гэж өөрчилсөн*

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.uli.gov.mn

308.		**46 дугаар зүйл.Барааг тээвэрлэх**		
309.		46.1.Тээвэрлэгч гаалийн хяналтад тээвэрлэгдэх барааг гаалийн байгууллагаас тогтоосон хугацаанд гаалийн замаар дараах гаалийн байгууллага хооронд тээвэрлэнэ:		
310.		46.1.1.хилийн гаалийн байгууллагаас гүний гаалийн байгууллага хооронд;		
311.		46.1.2.гүний гаалийн нэг байгууллагаас гүний гаалийн нөгөө байгууллага хооронд;		
312.		46.1.3.хилийн гаалийн нэг байгууллагаас хилийн гаалийн нөгөө байгууллага хооронд.		
313.		46.2.Гаалийн байгууллага хооронд барааг гаалийн удирдах төв байгууллагаас хүлээн зөвшөөрсөн гаалийн тээвэрлэгч тээвэрлэнэ.		
314.		46.3.Барааг гаалийн байгууллага хооронд тээвэрлэхэд дараах шаардлагыг хангасан байна:		
315.		46.3.1.гаалийн байгууллага тухайн бараанд хяналт тавих боломжтой;		
316.		46.3.2.гаалийн байгууллага гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийх боломжтой;		
317.		46.3.3.барааг дотоодод дамжуулан өнгөрүүлэхэд ашиглах тээврийн хэрэгсэлд гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийх боломжтой байх.		
318.		46.4.Гаалийн байгууллага хооронд барааг тээвэрлэхэд ачааны манифест, эсхүл тээврийн мэдүүлгийг үндэслэнэ.		
319.		46.5.Тээвэрлэгч барааг хүрэх өртөө, буулгах газарт хүргээд гаалийн байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.		
320.	**37 дугаар зүйл.Бараа буулгах, шилжүүлэн ачих**	**47 дугаар зүйл.Бараа буулгах, шилжүүлэн ачих**		
321.	37.1.Тээвэрлэгчээс бараатай холбогдсон мэдээлэл, бичиг баримтыг хүлээн авмагц гаалийн байгууллага барааг нь гаалийн хяналтын бүсэд буулгах, эсхүл шилжүүлэн ачих шийдвэр гаргана.	47.1.Тээвэрлэгчээс бараатай холбогдсон мэдээлэл, бичиг баримтыг хүлээн авмагц гаалийн байгууллага барааг нь гаалийн хяналтын бүсэд ачих, буулгах, шилжүүлэн ачих шийдвэр гаргана.		-
322.	37.2.Гаалийн нутаг дэвсгэрт барааг тээврийн хэрэгслээс буулгах, шилжүүлэн ачих ажиллагааг энэ хуулийн 25.1-д заасан цагт хийнэ.	47.2.Гаалийн нутаг дэвсгэрт барааг тээврийн хэрэгслээс ачих, буулгах, шилжүүлэн ачих ажиллагааг энэ хуулийн 84.1-д заасан цагт хийнэ.		
323.	37.3.Энэ хуулийн 37.1, 37.2-т зааснаас өөр газар, цагт барааг тээврийн хэрэгслээс буулгах, шилжүүлэн ачих бол зөвшөөрлийг гаалийн байгууллагаас авна.	47.3.Энэ хуулийн 47.1, 47.2-т зааснаас өөр газар, цагт барааг тээврийн хэрэгслээс ачих, буулгах, шилжүүлэн ачих зайлшгүй шаардлага гарсан бол тээвэрлэгч хүсэлтээ гаалийн байгууллагын удирдлагад бичгээр гаргаж, шийдвэрлүүлнэ.		*“ачих” гэсний дараа “зайлшгүй шаардлага гарсан” гэж нэмсэн*
324.	**Гуравдугаар дэд бүлэг Тээвэрлэгч**	**ГУРАВДУГААР ДЭД БҮЛЭГ ТЭЭВЭРЛЭГЧ**		-
325.	**38 дугаар зүйл.Тээвэрлэгч, түүний үүрэг**	**48 дугаар зүйл.Тээвэрлэгч, түүний үүрэг**		-
326.	38.1.Тээвэрлэгч энэ хуульд заасны дагуу барааг гаалийн хяналт дор тээвэрлэнэ.	48.1.Тээвэрлэгч энэ хуульд заасны дагуу барааг гаалийн хяналт доор тээвэрлэнэ.		-
327.	38.2.Тээвэрлэгч дараахь үүрэг хүлээнэ:	48.2.Тээвэрлэгч дараах үүрэг хүлээнэ:		-
328.	38.2.1.гаалийн хяналтад байгаа барааг тээвэрлэхэд энэ хуулиар тогтоосон шаардлагыг дагаж мөрдөх;	48.2.1.гаалийн хяналтад байгаа барааг тээвэрлэхэд энэ хуулиар тогтоосон шаардлагыг дагаж мөрдөх;		

Хүлээн хүндэсний хүрээлэн www.pdf.gov.mn

329.		48.2.2.гаалийн тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасан бичиг баримтын бүрэн бүтэн байдлыг хариуцах;		
330.	38.2.2.барааг гаалийн байгууллагын зөвшөөрөлтэйгээр ачих, буулгах, шилжүүлэн ачих, бусдад шилжүүлэх;	48.2.3.барааг гаалийн байгууллагын зөвшөөрөлтэйгээр ачих, буулгах, шилжүүлэн ачих, бусдад шилжүүлэх;		
331.	38.2.3.тээврийн нэг бичиг баримттай, эсхүл ачилтын нэг мэдүүлэгтэй барааг гаалийн хяналтад байх хугацаанд салгаж тээвэрлэхгүй байх;	48.2.4.тээврийн нэг бичиг баримттай, эсхүл ачилтын нэг мэдүүлэгтэй барааг гаалийн хяналтад байх хугацаанд салгаж тээвэрлэхгүй байх		
332.		48.2.5.барааг хүрэх өртөө, буулгах газарт гаалийн байгууллагын ажлын бус цагаар ирсэн бол барааг гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр олгогдох, алдагдахаас сэргийлэх арга хэмжээ авах;		
333.	38.2.4.барааг гаалийн хилээр хууль бусаар нэвтрүүлэх зорилгоор тээврийн хэрэгслийг нуувч болгон ашиглахгүй, эсхүл ийм боломж олгохгүй байх;	48.2.6.барааг гаалийн хилээр хууль бусаар нэвтрүүлэх зорилгоор тээврийн хэрэгслийг нуувч болгон ашиглахгүй, эсхүл ийм боломж олгохгүй байх;		
334.	38.2.5.тээврийн хэрэгсэлтэй холбогдол бүхий мэдээллийг гаалийн байгууллагад өгөх, гаалийн албан тушаалтанд мэргэжлийн туслалцаа үзүүлэх;	48.2.7.гаалийн байгууллагын албан тушаалтан тээврийн хэрэгслийг нарийвчлан шалгах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд мэргэжлийн туслалцаа үзүүлэх;		*Өөрчлөн найруулсан*
335.	38.2.6.бараанд аливаа өөрчлөлт орохгүй байх нөхцөлийг хангах, гаалийн зорилгоор хийсэн тэмдэглэгээг өөрчлөх, гэмтээх, устгахаас сэргийлэх;	48.2.8.бараанд аливаа өөрчлөлт орохгүй байх нөхцөлийг хангах, гаалийн зорилгоор хийсэн тэмдэглэгээг өөрчлөх, гэмтээх, устгахаас сэргийлэх;		-
336.	38.2.7.улсын хилээр нэвтрүүлэх барааны талаархи шаардлагатай мэдээллийг урьдчилан гаалийн байгууллагад гаргаж өгөх;			*Хассан*
337.	38.2.8.гаалийн хяналт, шалгалтыг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний явцад хийх тохиолдолд гаалийн албан тушаалтныг ажиллах нөхцөлөөр хангаж, тухайн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчуулах;	48.2.9.гаалийн хяналт, шалгалтыг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний явцад хийх тохиолдолд гаалийн албан тушаалтныг ажиллах нөхцөлөөр хангаж, тухайн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчуулах;		-
338.	38.2.9.тээврийн хэрэгслийг тогтоосон хугацаанд гаалийн хилээр буцаан нэвтрүүлэх;	48.2.10.тээврийн хэрэгслийг тогтоосон хугацаанд гаалийн хилээр буцаан нэвтрүүлэх;		
339.		48.2.11. Олон улсын гэрээнд заасан тээвэрлэхийг хориглосон барааг улсын хилээр нэвтрүүлэхгүй байх.		
340.	38.2.10.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.	48.2.12.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.		
341.	38.3.Барааг энэ хуулийн 35.3, 35.5-д заасан тээврийн хэрэгслээр тээвэрлэгч нь гаалийн мэдээллийн сүлжээнд холбогдсон байна.	48.3.Барааг энэ хуулийн 44.3, 44.5-д заасан тээврийн хэрэгслээр тээвэрлэгч гаалийн мэдээллийн цахим сүлжээнд холбогдсон байна.		
342.		**49 дүгээр зүйл.Гаалийн тээвэрлэгч**		
343.		49.1.Гаалийн хяналтад байгаа барааг гаалийн тээвэрлэгч тээвэрлэнэ.		
344.		49.2.Хуульд заасан шаардлагыг хангасан тээврийн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдийг гаалийн удирдах төв байгууллага гаалийн тээвэрлэгчээр хүлээн зөвшөөрч, бүртгэлд авна.		

345.		49.3.Гаалийн тээвэрлэгчийн талаарх мэдээллийг мэдээллийн технологийг ашиглан олон нийтэд нээлттэй зарлана.		
346.		**50 дугаар зүйл. Гаалийн тээвэрлэгчид тавигдах шаардлага**		
347.		50.1.Дараах шаардлагыг хангасан хуулийн этгээд гаалийн тээвэрлэгчээр хүлээн зөвшөөрүүлэх тухай хүсэлтийг гаалийн удирдах төв байгууллагад гаргана:		
348.		50.1.1.тээвэрлэлтийн үйл ажиллагааг хоёроос доошгүй жил эрхэлсэн туршлагатай байх;		
349.		50.1.2.гаалийн татвар, хураамжийг төлөх баталгааг бичгээр гаргах;		
350.		50.1.3.хууль тогтоомжийн дагуу улс хооронд ачаа тээвэрлэх зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас авсан байх;		
351.		50.1.4.тээвэрлэгч нь өөрийн өмчлөлийн тээврийн хэрэгсэлтэй байх;		
352.		50.1.5.гаалийн татвар, хураамжийн өргүй байх;		
353.		50.1.6.сүүлийн нэг жилийн дотор гаалийн хууль тогтоомжийн зөрчил гаргаагүй байх;		
354.		50.1.7.хууль тогтоомжид заасан бусад шаардлага.		
355.		50.2.Дараах тохиолдолд гаалийн тээвэрлэгчийн бүртгэлээс хасна:		
356.		50.2.1.энэ хуулийн 50.1.2-50.1.4,50.1.7-д заасан шаардлагыг хангахгүй болсон;		
357.		50.2.2.энэ хуулийн 51 дүгээр заасан үүргийг биелүүлээгүй;		
358.		50.2.3.хуулийн этгээд өөрөө хүсэлт гаргасан;		
359.		50.2.4.тээвэрлэгч байгууллага татан буугдсан, өөр байгууллагатай нэгдсэн, албан ёсны нэрээ сольсон.		
360.		**51 дүгээр зүйл.Гаалийн тээвэрлэгчийн үүрэг**		
361.		51.1.Гаалийн тээвэрлэгч нь энэ хуулийн 48.2-т зааснаас гадна дараах үүргийг хүлээнэ:		
362.		51.1.1.дотоодод болон улс хооронд дамжуулан өнгөрүүлэх барааг тээвэрлэхдээ энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг дагаж мөрдөх;		
363.		51.1.2.гаалийн тээвэрлэгчийн хувьд тээвэрлэсэн ачааны тооцоог хөтлөж, гаалийн байгууллагад тайлагнах;		
364.		51.1.3.гаалийн хяналтад байгаа барааг алдсан тохиолдолд гаалийн болон бусад татвар, хураамжийг төлөх;		
365.		51.1.4.ажил үүргийнхээ хүрээнд олж авсан харилцагчдын худалдааны, банкны, мөн хуулиар нууцад тооцох бусад мэдээллүүдийг бусдад тараахгүй, хувийн зорилгоор ашиглахгүй байх;		

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.legal.mn

366.		51.1.5.гаалийн тээвэрлэгчээр бүртгүүлэхдээ гаргаж өгсөн мэдээлэлд өөрчлөлт орсон бол тухай бүр гаалийн удирдах төв байгууллагад мэдэгдэх.		
367.		51.2.Гаалийн хяналтад байгаа барааг тээвэрлэхдээ энэ хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.		
368.	**Дөрөвдүгээр дэд бүлэг Барааг түр хадгалах**	**ДӨРӨВДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ БАРААГ ТҮР АГУУЛАХАД ХАДГАЛАХ**		
369.	**39 дүгээр зүйл. Барааг түр хадгалах**	**52 дугаар зүйл.Барааг түр агуулахад хадгалах**		
370.		52.1.Гаалийн хяналтын бүсэд оруулсан барааг гаалийн бүрдүүлэлтийн горим сонгоогүй бол гурав хоногийн дараа түр агуулахад шилжүүлнэ.		
371.	39.1.Барааг гаалийн хяналтад авсан үеэс гаалийн бүрдүүлэлтийн горимд байршуулах хүртэлх хугацаанд гаалийн тарифын болон тарифын бус хязгаарлалтгүйгээр түр агуулахад хадгална.	52.2.Барааг гаалийн байгууллагын шийдвэрээр гаалийн тарифын болон тарифын бус хязгаарлалтгүйгээр түр агуулахад хадгална.		*“хугацаанд” гэсний дараа “гаалийн байгууллагын шийдвэрээр” гэж нэмсэн*
372.	39.2.Мэдүүлэгч энэ хуулийн 44.1, 44.2-т заасан хугацаанд бараатай холбогдсон мэдээллийг гаалийн байгууллагаас авч болно.			*Хасагдсан*
373.		52.5.Гаалийн түр агуулахад бараа, тээврийн хэрэгсэл хадгалсан хадгалалтын хөлсний хэмжээг түр агуулах эзэмшигч тогтооно.		
374.	**40 дүгээр зүйл.Түр агуулах**	**53 дугаар зүйл.Түр агуулах**		
375.	40.1.Түр агуулах нь битүү агуулах байр, эсхүл задгай талбай байж болно.	53.1.Түр агуулах нь битүү агуулах байр, эсхүл задгай талбай байж болно.		-
376.	40.2.Түр агуулахыг гаалийн хяналтын бүсэд тооцно.	53.2.Түр агуулахыг гаалийн хяналтын бүсэд тооцно.		
377.	**41 дүгээр зүйл.Түр агуулахын төрөл**	**54 дүгээр зүйл.Түр агуулахын төрөл**		
378.	41.1.Түр агуулах дараахь төрөлтэй байна:	54.1.Түр агуулах дараах төрөлтэй байна:		-
379.	41.1.1.нийтэд зориулалттай буюу нээлттэй;	54.1.1. нийтэд зориулсан буюу нээлттэй;		
380.	41.1.2.нэг болон хэд хэдэн аж ахуйн нэгж, байгууллагын зориулалттай буюу хаалттай.	54.1.2. нэг болон хэд хэдэн хуулийн этгээдэд зориулсан буюу хаалттай.		*“аж ахуйн нэгж, байгууллагын зориулалттай” гэснийг “хуулийн этгээдэд зориулсан” гэж өөрчилсөн*
381.	41.2.Хадгалалтын тусгай нөхцөл шаардах барааг зориулалтын тоног төхөөрөмжөөр тоноглогдсон түр агуулахад хадгална.	52.3.Хадгалалтын тусгай нөхцөл шаардах барааг зориулалтын тоног төхөөрөмжөөр тоноглогдсон түр агуулахад хадгална		*Хасагдсан*
382.	**42 дугаар зүйл. Барааг түр агуулахад хадгалах**	**74 дүгээр зүйл.Барааг түр агуулахад хадгалах**		-
383.	42.1.Гаалийн хилээр нэвтрүүлэх барааг гаалийн байгууллагын шийдвэрээр түр агуулахад хадгална.	74.1.Гаалийн хяналтын бүсэд оруулсан барааг гаалийн бүрдүүлэлтийн горим сонгоогүй бол 3 хоногийн дараа түр агуулахад шилжүүлнэ.		*Өөрчлөн найруулсан*
384.	42.2.Гаалийн хяналтын бүсэд оруулсан барааг гаалийн бүрдүүлэлтийн горим сонгоогүй бол 3 хоногийн дараа түр агуулахад шилжүүлнэ.	74.2.Хадгалалтын тусгай нөхцөл шаардах барааг зориулалтын тоног төхөөрөмжөөр тоноглогдсон түр агуулахад хадгална.		*Өөрчлөн найруулсан*

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.legal.mn

385.	42.3.Холбогдох хууль тогтоомжийн дагуу хураагдсан, саатуулагдсан барааг түр агуулахад хадгалж болно.	52.4.Гаалийн болон бусад хууль тогтоомжийн дагуу хураагдсан, саатуулагдсан барааг түр агуулахад хадгалж болно.		*Өөрчлөн найруулсан*
386.	**43 дугаар зүйл. Барааг түр агуулахад оруулах үед шаардагдах бичиг баримт**	**55 дугаар зүйл. Барааг түр агуулахад оруулах үед шаардагдах бичиг баримт**		
387.	43.1.Барааг ачааны манифест болон түүнийг дагалдах бичиг баримтыг үндэслэн түр агуулахад оруулна.	55.1.Барааг ачааны манифест, эсхүл тээврийн мэдүүлэг, түүнийг дагалдах бичиг баримтыг үндэслэн түр агуулахад оруулна		
388.	43.2.Энэ хуулийн 43.1-д заасан бичиг баримтыг мэдээллийн сүлжээгээр ирүүлж болно.	55.2.Энэ хуулийн 55.1-д заасан бичиг баримтыг мэдээллийн сүлжээгээр ирүүлж болно		*“болон” гэснийг “, эсхүл тээврийн мэдүүлэг,” гэж өөрчилсөн*
389.	**44 дүгээр зүйл. Хадгалалтын хугацаа**	**56 дугаар зүйл.Барааг түр агуулахад хадгалах хугацаа**		
390.	44.1.Барааг түр агуулахад 2 сар хүртэл хугацаанд хадгалах ба гаалийн байгууллага энэ хугацааг 1 сар хүртэл хугацаагаар нэг удаа сунгаж болно.	56.1.Барааг түр агуулахад хоёр сар хүртэл хугацаанд хадгалах ба гаалийн байгууллага энэ хугацааг нэг сар хүртэл хугацаагаар нэг удаа сунгаж болно.		
391.	44.2.Түргэн гэмтэх, эсхүл аюултай барааг 7 хоног хүртэл хугацаагаар хадгалах ба гаалийн байгууллага энэ хугацааг 7 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.	56.2.Түргэн гэмтэх, эсхүл аюултай барааг долоо хоног хүртэл хугацаагаар хадгалах ба гаалийн байгууллага энэ хугацааг долоо хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.		
392.	44.3.Барааг түр агуулахад оруулсан, эсхүл шилжүүлсэн гэж тооцсон өдрөөс эхлэн түр хадгалах хугацааг тоолно.	56.3.Барааг түр агуулахад оруулсан, эсхүл шилжүүлсэн гэж тооцсон өдрөөс эхлэн түр хадгалах хугацааг тоолно.		
393.	44.4.Энэ хуулийн 42.3-т заасан бараанд мөн хуулийн 44.1, 44.2-т заасан хугацаа хамаарахгүй.	56.4.Энэ хуулийн 52.4-т заасан бараанд мөн хуулийн 56.1, 56.2-т заасан хугацаа хамаарахгүй.		-
394.	**45 дугаар зүйл.Түр агуулахад хадгалах бараанд хийгдэх ажиллагаа**	**57 дугаар зүйл.Түр агуулахад хадгалах бараанд хийгдэх ажиллагаа**		
395.	45.1.Түр агуулахад хадгалагдаж байгаа бараанд болон түүний сав, баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүйгээр гаалийн байгууллагын зөвшөөрлөөр арчилгаа, үйлчилгээ хийж болно.	57.1.Түр агуулахад хадгалагдаж байгаа бараанд болон түүний сав, баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүйгээр гаалийн байгууллагын зөвшөөрлөөр арчилгаа, үйлчилгээ хийж болно.		-
396.	45.2.Мэдүүлэгч нь гаалийн байгууллагын зөвшөөрлөөр гаалийн бүрдүүлэлт хийхээс өмнө барааг үзэж сорьц, дээж, загвар авч болно.			*Хасагдсан*
397.		57.2.Мэдүүлэгч энэ хуулийн 56.1, 56.2-т заасан хугацаанд түр агуулахад хадгалсан бараатай холбогдох мэдээллийг гаалийн байгууллагаас авч болно.		*Шинээр нэмсэн*
398.	**46 дугаар зүйл.Чанараа алдсан, эвдэрсэн, гэмтсэн бараа**	**58 дугаар зүйл.Чанараа алдсан, эвдэрсэн, гэмтсэн бараа**		

Хэвлэлийн хүрээлэн www.parliament.mn

399.	46.1.Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас түр агуулахад хадгалагдаж байгаа бараа чанараа алдсан, эсхүл эвдэрсэн, гэмтсэн нь эрх бүхий байгууллагын холбогдох баримтаар нотлогдсон бол чанараа алдсан, эвдэрсэн, гэмтсэн байдлаар гаалийн бүрдүүлэлтийг хийнэ.	58.1.Гамшгийн улмаас түр агуулахад хадгалагдаж байгаа бараа чанараа алдсан, эсхүл эвдэрсэн, гэмтсэн нь эрх бүхий байгууллагын холбогдох баримтаар нотлогдсон бол чанараа алдсан, эвдэрсэн, гэмтсэн байдлаар гаалийн бүрдүүлэлтийг хийнэ.		-
400.	**47 дугаар зүйл. Барааг түр агуулахад хадгалж байгаад тооцох**	**59 дүгээр зүйл.Барааг түр агуулахад хадгалж байгаад тооцох**		
401.	47.1.Гаалийн хяналтад байгаа хадгалалтын тусгай нөхцөл шаардах барааг гаалийн байгууллагын зөвшөөрснөөр мэдүүлэгчид хадгалуулж болох бөгөөд энэ тохиолдолд уг бараа түр агуулахад байгаад тооцогдоно.	59.1.Гаалийн хяналтад байгаа хадгалалтын тусгай нөхцөл шаардах барааг гаалийн байгууллагын зөвшөөрснөөр мэдүүлэгчид хадгалуулж болох бөгөөд энэ тохиолдолд уг бараа түр агуулахад байгаад тооцогдоно		
402.	47.2.Энэ хуулийн 47.1-д заасан барааг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.	59.2.Энэ хуулийн 59.1-д заасан барааг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.		
403.	47.3.Барааг энэ хуулийн 47.1-д заасны дагуу хадгалуулах зөвшөөрөл олгохдоо гаалийн байгууллага нь Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн дагуу гаалийн болон бусад татвар төлөх баталгаа гаргуулна.	59.3.Барааг энэ хуулийн 59.1-д заасны дагуу хадгалуулах зөвшөөрөл олгохдоо гаалийн байгууллага нь Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн дагуу гаалийн болон бусад татвар төлөх баталгаа гаргуулна.		-
404.	**48 дугаар зүйл.Түр агуулахад тавигдах шаардлага**	**60 дугаар зүйл.Түр агуулахад тавигдах шаардлага**		
405.	48.1.Түр агуулах нь бараа хадгалах дараахь нөхцөл, шаардлагыг хангасан байна:	60.1.Түр агуулах нь дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:		*“бараа хадгалах” гэснийг хассан*
406.	48.1.1.гаалийн хяналт хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;	60.1.1.бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт, шалгалт явуулах нөхцөл хангасан байх;		*Өөрчлөн найруулсан*
407.	48.1.2.бараа ачих, буулгах, шилжүүлэн ачих тоног төхөөрөмж, гаалийн хяналтын техник хэрэгсэл, тавцан, зам, талбай, цахилгаан, ус суваг, холбооны шугам сүлжээтэй байх;	60.1.2.бараа ачих, буулгах, шилжүүлэн ачих тоног төхөөрөмж, гаалийн хяналтын техник хэрэгсэл, тавцан, зам, талбай, цахилгаан, ус суваг, холбооны шугам сүлжээтэй байх;		
408.	48.1.3.гаалийн албан тушаалтны ажиллах нөхцөлийг хангах	60.1.3.гаалийн албан тушаалтны ажиллах нөхцөлийг хангах;		
409.	48.1.4.хамгаалалт, дохиоллын системтэй байх	60.1.4.хамгаалалт, дохиоллын системтэй байх;		
410.	48.1.5.гадны хүн агуулахад нэвтрүүлэхгүй байх.	60.1.5.гадны хүн агуулахад нэвтрүүлэхгүй байх		-
411.		60.1.6.гаалийн түр агуулах нь задгай талбай байх тохиолдолд орох, гарах хаалганаас бусад газраар бараа, тээврийн хэрэгсэл, хүн нэвтрэх боломжийг хаасан хашаа татсан байх;		
412.		60.1.7.олон нийтэд мэдэгдэхүйц таних тэмдэгтэй байх бөгөөд таних тэмдэг нь тэгш өнцөгт хэлбэртэй цагаан дэвсгэртэй самбар дээр хар хөх өнгөөр “Гаалийн түр агуулах” гэсэн бичээстэй, зүүн дээд өнцөгт Монгол Улсын гаалийн байгууллагын бэлгэ тэмдэг байх;		*Шинээр нэмсэн*
413.		60.1.8.гаалийн цахим сүлжээнд холбогдсон, цахим бүртгэлийн системийг нэвтрүүлсэн байх.		

414.	**49 дүгээр зүйл. Түр агуулах ажиллуулах зөвшөөрөл**	**61 дүгээр зүйл.Түр агуулах ажиллуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг**		
415.	49.1.Түр агуулах ажиллуулах зөвшөөрлийг гаалийн удирдах төв байгууллага Монгол Улсын хуулийн этгээдэд 1 жилийн хугацаагаар олгож, нийтэд мэдээлнэ.	61.1.Түр агуулах ажиллуулах зөвшөөрлийг гаалийн удирдах төв байгууллага Монгол Улсын хуулийн этгээдэд гурав хүртэл жилийн хугацаагаар олгож, нийтэд мэдээлнэ.		
416.	49.2.Энэ хуулийн 49.1-д заасан хугацааг 1 жилийн хугацаагаар хэдэн ч удаа сунгаж болно.	61.2.Энэ хуулийн 61.1-д заасан хугацааг сунгаж болно.		
417.	49.3.Түр агуулах ажиллуулах зөвшөөрөл эзэмшигч дараахь үүрэг хүлээнэ:	61.3.Түр агуулах ажиллуулах зөвшөөрөл эзэмшигч дараах үүрэг хүлээнэ:		
418.	49.3.1.түр агуулах нь энэ хуулийн 48.1-д заасан нөхцөл, шаардлагыг хангасан байх;	61.3.1.түр агуулахад энэ хуулийн 60 дугаар зүйлд заасан нөхцөл, шаардлагыг хангах;		
419.	49.3.2.хадгалж байгаа барааны бүртгэл хөтөлж, барааны хөдөлгөөний тухай мэдээ, тайланг гаалийн байгууллагад гаргаж өгөх;	61.3.2.хадгалж байгаа барааны бүртгэл хөтөлж, барааны хөдөлгөөний тухай мэдээ, тайланг гаалийн байгууллагад гаргаж өгөх;		
420.	49.3.3.гаалийн байгууллагын зөвшөөрлөөр барааг агуулахад оруулах, агуулахаас гаргах;	61.3.3.гаалийн байгууллагын зөвшөөрлөөр барааг агуулахад оруулах, агуулахаас гаргах;		
421.	49.3.4.хадгалж байгаа бараа, түүний сав, баглаа боодол, битүүмжлэлд гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр өөрчлөлт оруулахгүй байх;	61.3.4.хадгалж байгаа бараа, түүний сав, баглаа боодол, тэмдэглэгээнд гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр өөрчлөлт оруулахгүй байх;		
422.	49.3.5.хадгалж байгаа бараг ачих, буулгах, шилжүүлэн ачих, мэдүүлэгчид нь олгох ажиллагааг гаалийн байгууллагын зөвшөөрлөөр гүйцэтгэх;	61.3.5.хадгалж байгаа бараг ачих, буулгах, шилжүүлэн ачих, мэдүүлэгчид нь олгох ажиллагааг гаалийн байгууллагын зөвшөөрлөөр гүйцэтгэх		
423.	49.3.6.бараг төрөлжүүлэн хадгалах;	61.3.6.бараг төрөлжүүлэн хадгалах;		
424.	49.3.7.бараа хадгалах хугацаа дуусахаас ажлын 5 хоногийн өмнө энэ талаар мэдүүлэгчид мэдэгдэх.	61.3.7. дуусахаас ажлын таван өдрийн өмнө энэ талаар мэдүүлэгчид мэдэгдэх;		
425.	49.3.8.өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас бусдад учруулсан гэм хорыг нөхөн төлөх, арилгах.	61.3.8.өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас бусдад учруулсан гэм хорыг нөхөн төлөх, арилгах		-
426.	**50 дугаар зүйл.Түр агуулах ажиллуулах зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох**	**62 дугаар зүйл.Түр агуулах ажиллуулах зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох**		
427.	50.1.Түр агуулах энэ хуулийн 48.1-д заасан нөхцөл, шаардлагыг хангахгүй болсон, эсхүл зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 49.3-т заасан үүргээ биелүүлээгүй бол зөрчлийг арилгуулах зорилгоор гаалийн удирдах төв байгууллага түр агуулах ажиллуулах зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно.	62.1.Түр агуулах энэ хуулийн 60.1-д заасан нөхцөл, шаардлагыг хангахгүй болсон, эсхүл зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 61.3-т заасан үүргээ биелүүлээгүй бол зөрчлийг арилгуулах зорилгоор гаалийн удирдах төв байгууллага түр агуулах ажиллуулах зөвшөөрлийг гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно.		
428.	50.2.Түр агуулах ажиллуулах зөвшөөрлийг дараахь үндэслэлээр хүчингүй болгоно:	62.2.Түр агуулах ажиллуулах зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгоно:		
429.	50.2.1.зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;	62.2.1.зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;		
430.	50.2.2.энэ хуулийн 50.1-д заасан хугацаанд зөрчлийг арилгаагүй;	62.2.2.энэ хуулийн 62.1-д заасан хугацаанд зөрчлийг арилгаагүй;		
431.	50.2.3.энэ хуулийн 48.1-д заасан нөхцөл, шаардлага, 49.3-т заасан үүргээ удаа дараа биелүүлээгүй;	62.2.3.энэ хуулийн 60.1-д заасан нөхцөл, шаардлага, 61.3-т заасан үүргээ хоёр буюу түүнээс дээш удаа биелүүлээгүй;		
432.	50.2.4.зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд татан буугдсан, эсхүл түр агуулахаа бусдад шилжүүлсэн;	62.2.4.зөвшөөрлийг эзэмшигч байгууллага татан буугдсан, өөр байгууллагатай нэгдсэн, албан ёсны нэрээ сольсон;		

ХЭВЛЭЛИЙН ХУРЭЭЛЭН

433.	50.2.5.зөвшөөрөл олгосноос хойш 6 сарын хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй;	62.2.5.зөвшөөрөл олгосноос хойш зургаан сарын хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй;		
434.	50.2.6.зөвшөөрлийн хугацаа дууссан боловч сунгуулах хүсэлт гаргаагүй.	62.2.6.зөвшөөрлийн хугацаа дууссан боловч сунгуулах хүсэлт гаргаагүй.		
435.	50.3.Зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш ажлын 3 хоногийн дотор агуулахад хадгалж байгаа барааг өөр түр агуулахад гаалийн байгууллагын хяналт дор шилжүүлнэ.	62.3.Зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш ажлын гурав хоногийн дотор агуулахад хадгалж байгаа барааг өөр түр агуулахад гаалийн байгууллагын хяналтын доор шилжүүлнэ.		
436.	50.4.Түр агуулах ажиллуулах зөвшөөрлийг хүчингүй болгосон шийдвэрийг гаалийн удирдах төв байгууллагын дарга гаргаж нийтэд мэдээлнэ.	62.4.Түр агуулах ажиллуулах зөвшөөрлийг хүчингүй болгосон шийдвэрийг гаалийн удирдах төв байгууллагын дарга гаргаж, нийтэд мэдээлнэ.		-
437.	**Тавдугаар дэд бүлэг Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн нутаг дэвсгэрээс гаргах**	**ЗУРГАДУГААР ДЭД БҮЛЭГ БАРАА, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ГААЛИЙН НУТАГ ДЭВСГЭРЭЭС ГАРГАХ**		-
438.	**51 дүгээр зүйл. Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн нутаг дэвсгэрээс гаргах**	**157 дугаар зүйл.Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн нутаг дэвсгэрээс гаргах**		-
439.	51.1.Тээврийн хэрэгслийн төрлийг харгалзаж, энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан мэдээлэл, бичиг баримтыг үндэслэн барааг гаалийн нутаг дэвсгэрээс олон улсын гэрээний дагуу тогтоосон хилийн боомтоор гаргана.	157.1.Барааг гаалийн мэдүүлэг болон тээврийн хэрэгслийн төрлийг харгалзаж, энэ хуулийн 38, 44 дүгээр зүйлд заасан мэдээлэл, баримт бичгийг үндэслэн гаалийн нутаг дэвсгэрээс олон улсын гэрээний дагуу тогтоосон хилийн боомтоор гаалийн байгууллагын ажлын цагаар гаргана.		*Өөрчлөн найруулсан*
440.	51.2.Зарим нэр төрлийн барааг гаалийн нутаг дэвсгэрээс гаргах хилийн боомтыг энэ хууль, холбогдох бусад хуульд заасны дагуу, эсхүл Засгийн газрын шийдвэрээр тогтоож болно.	157.2.Зарим нэр төрлийн барааг гаалийн нутаг дэвсгэрээс гаргах хилийн боомтыг энэ хууль, холбогдох бусад хуульд заасны дагуу, эсхүл Засгийн газрын шийдвэрээр тогтоож болно.		-
441.	**52 дугаар зүйл. Мэдээлэл, бичиг баримт гаргаж өгөх** 52.1.Барааг гаалийн нутаг дэвсгэрээс гаргахад тээвэрлэгч энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан мэдээлэл, бичиг баримтыг гаалийн байгууллагад гаргаж өгнө.			*Хасагдсан*
442.\	52.2.Энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан мэдээлэл, бичиг баримт шаардлага хангаагүй тохиолдолд тээвэрлэгч нэмэлт мэдээлэл гаргаж өгнө.			*Хасагдсан*
443.	**53 дугаар зүйл.Тээврийн хэрэгсэлд бараа ачих**	**158 дугаар зүйл.Тээврийн хэрэгсэлд бараа ачих**		
444.	53.1.Гаалийн мэдүүлэг, гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтыг үндэслэн гаалийн нутаг дэвсгэрээс гаргах барааnd гаалийн хяналт, шалгалт хийсний дараа гаалийн хяналт дор ачина.	158.1.Гаалийн мэдүүлэг, гаалийн бүрдүүлэлтийн баримт бичгийг үндэслэн гаалийн нутаг дэвсгэрээс гаргах барааnd хяналт, шалгалт хийсний дараа гаалийн хяналт дор ачна.		
445.	53.2.Гаалийн нутаг дэвсгэрээс гаргах барааг гаалийн байгууллагын ажлын цагаар, гаалийн хяналтын бүсэд тээврийн хэрэгсэлд ачина.	158.2.Гаалийн нутаг дэвсгэрээс гаргах барааг хилийн боомтын ажиллах цагийн хуваарьт нийцүүлэн, гаалийн хяналтын бүсэд тээврийн хэрэгсэлд ачна.		
446.	53.3.Барааг энэ хуулийн 53.2-т зааснаас өөр газар, цагт ачих тохиолдолд зөвшөөрлийг гаалийн байгууллагаас авна.	158.3.Барааг энэ хуулийн 158.2-т зааснаас өөр газар, цагт ачих тохиолдолд гаалийн байгууллагаас зөвшөөрөл авна.		

447.	**54 дүгээр зүйл. Барааг улсын хилээр гаргах**	**159 дүгээр зүйл.Барааг улсын хилээр гаргах**		-
448.	54.1.Тээвэрлэгч нь улсын хилээр гаргах барааг гаалийн зорилгоор хийсэн тэмдэглэгээнд өөрчлөлт оруулалгүй гаалийн хяналт дор тээвэрлэлэнэ.	159.1.Тээвэрлэгч нь улсын хилээр гаргах бараанд гаалийн зорилгоор хийсэн тэмдэглэгээг өөрчлөхгүй, өөрчлөлт оруулалгүй гаалийн хяналт доор тээвэрлэн улсын хилээр гаргана.		*“тээвэрлэлэнэ” гэснийг “тээвэрлэн улсын хилээр гаргана” гэж өөрчилсөн*
449.	54.2.Энэ хуулийн 54.1-д заасан бараанд тээвэрлэлтийн ердийн нөхцөлд гарах элэгдэл, хорогдлоос бусад өөрчлөлт ороогүй байна.	159.2.Энэ хуулийн 159.1-д заасан бараанд тээвэрлэлтийн ердийн нөхцөлд гарах элэгдэл, хорогдлоос бусад өөрчлөлт ороогүй байна.		-
450.	54.3.Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гаалийн нутагт дэвсгэрээс гаргах бараа, тээврийн хэрэгслийг улсын хилээр гаргах боломжгүй болсон тохиолдолд хамгийн ойр байрлах гаалийн байгууллагад хүргэх арга хэмжээ авах бөгөөд энэ тохиолдолд барааг гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлэхийг хориглоно.	159.3.Гамшиг болон бусад нөхцөл байдлын улмаас гаалийн нутагт дэвсгэрээс гаргах бараа, тээврийн хэрэгслийг улсын хилээр гаргах боломжгүй болсон тохиолдолд хамгийн ойр байрлах гаалийн байгууллагад хүргэх арга хэмжээ авах бөгөөд энэ тохиолдолд барааг гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлэхийг хориглоно.		*“Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын” гэснийг “Гамшгийн” гэж өөрчилсөн*
451.		**НАЙМДУГААР БҮЛЭГ БАРААГ МЭДҮҮЛЭХ**	**3 ДУГААР БҮЛЭГ ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТ БОЛОН ГААЛИЙН ЁС ЖУРМЫН БУСАД АЖИЛЛАГАА**	
452.	**Зургадугаар дэд бүлэг Бараа мэдүүлэх**	**НЭГДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ БАРААГ МЭДҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**		“**Бараа мэдүүлэх**” гэснийг **“БАРААГ МЭДҮҮЛЭХ АЖИЛЛАГАА”** гэж өөрчилсөн
453.	**55 дугаар зүйл. Барааг гаалийн байгууллагад мэдүүлэх**	**63 дугаар зүйл.Барааг гаалийн байгууллагад мэдүүлэх**	**МЭДҮҮЛЭГЧ**	
454.	55.1.Мэдүүлэгч гаалийн хилээр нэвтрүүлэх барааг энэ хуульд заасны дагуу гаалийн байгууллагад мэдүүлнэ.	63.1.Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллагад дараах этгээд мэдүүлнэ:	**3.6 Стандарт** Үндэсний хууль тогтоомжид аливаа нэг этгээд мэдүүлэгчээр ажиллах эрх эдлэх болзол нөхцөлийг заасан байна.	

Хуульчдаар ундэсний хүрээлэн www.mi.gov.mn

455.		63.1.1.бараа илгээх, эсхүл хүлээн авах Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага өөрөө, эсхүл холбогдох хууль тогтоомжийн дагуу түүний итгэмжлэгдсэн этгээд;	**3.7 Стандарт** Холбогдох барааг захиран зарцуулах эрх бүхий аливаа этгээд мэдүүлэгчээр ажиллах эрхтэй байна. **1.8 Стандарт** Мэдүүлэгч нь холбогдох Барааны мэдүүлэгт дурдсан мэдээллийн үнэн зөвийг, мөн гаалийн болон бусад татвар төлөх асуудлыг гаалийн байгууллагын өмнө хариуцах үүрэг хүлээнэ.	
456.		63.1.2.гаалийн хилээр нэвтрэх зорчигч, бараа хүлээн авах, илгээх хүн;		
457.		63.1.3.энэ хуулийн 63.1.1, 63.1.2-т заасан этгээдтэй байгуулсан гаалийн зуучлалын үйлчилгээ үзүүлэх гэрээний үндсэн дээр гаалийн зуучлагч		
458.		63.1.4.шаардлагатай тохиолдолд тээвэрлэгч, гаалийн түр агуулахын болон баталгаат бүсийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч этгээд.		
459.	55.2.Гаалийн хилээр нэвтрүүлэх барааг дараахь хэлбэрээр мэдүүлж болно:	63.2.Гаалийн хилээр нэвтрүүлэх барааг дараах хэлбэрээр мэдүүлж болно:		
460.	55.2.1.бичгээр	63.2.1.бичгээр;		
461.	55.2.2.мэдээллийн сүлжээгээр	63.2.2.цахим хэлбэрээр;		
462.	55.2.3.зорчигч хувийн хэрэглээний эд зүйлийнхээ, мэдүүлэгч улс хоорондын шуудан илгээлтийн тухай түс түс амаар;	63.2.3.зорчигч хувийн хэрэглээний эд зүйлийн тухай, мэдүүлэгч улс хоорондын шуудан илгээлтийн тухай түс түс амаар;		
463.	55.2.4.зорчигч улаан, ногоон гарцыг сонгох буюу үйл хөдлөлөөр.	63.2.4.зорчигч улаан, ногоон гарцыг сонгох буюу үйл хөдлөлөөр		
464.		**64 дүгээр зүйл.Гаалийн мэдүүлэг**	**Барааны мэдүүлэг**	
465.	55.3.Мэдүүлэгч энэ хуулийн 55.1-д заасан бараг гаалийн мэдүүлгийн маягтын дагуу мэдүүлнэ.	64.1.Бараг гаалийн байгууллагад мэдүүлэхдээ гаалийн бүрдүүлэлтийн горим, нэвтрүүлж байгаа этгээд, барааны онцлогоос хамаарч гаалийн мэдүүлгийн дараах төрлөөс сонгоно: 64.1.1.гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг; 64.1.2.дамжуулан өнгөрүүлэх мэдүүлэг; 64.1.3.зорчигчийн гаалийн мэдүүлэг; 64.1.4.тээврийн хэрэгслийн мэдүүлэг.	**3.11 Стандарт** Барааны мэдүүлгийн агуулгыг гаалийн байгууллага батална. Барааны мэдүүлгийн цаасан маягт нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын үлгэрчилсэн загвартай тохирч байна. Гаалийн автоматжуулсан бүрдүүлэлтийн хувьд цахим сүлжээгээр дамжуулах Барааны мэдүүлгийн маягт нь Гаалийн хамтын ажиллагааны зөвлөлийн Мэдээллийн технологийн тухай зөвлөмжид заасан цахим мэдээ дамжуулах олон улсын стандартад нийцсэн байна.	-
466.	55.4.Гаалийн мэдүүлгийг мэдээллийн сүлжээгээр нөхөн бичиж хүргүүлж болно.			Хасагдсан

467.	55.5.Гаалийн мэдүүлгийн маягтын загвар, түүнийг нөхөн бичих, шалгах зааврыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.	64.2.Энэ хуулийн 64.1.1-д заасан үндсэн мэдүүлэг нь нэмэлт мэдүүлэгтэй байж болно. Гаалийн мэдүүлгийн маягтын загвар, түүнийг нөхөн бичих, шалгах зааврыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.	**3.12 Стандарт** Гаалийн байгууллага нь Барааны мэдүүлэгт байвал зохих мэдээллийг гаалийн болон бусад татвар тооцох, хураан авах, статистик мэдээ гаргах болон гаалийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзсэн мэдээллээр хязгаарлана. **3.18 Шилжилтийн стандарт** Гаалийн байгууллага нь хавсралт бичиг баримтыг цахим сүлжээгээр илгээхийг зөвшөөрнө.	
468.		64.3.Гаалийн мэдүүлгийн цахим хувилбарын бүтэц, хэлбэр, түүнийг ашиглах, дамжуулах журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.		
469.	55.6.Гаалийн мэдүүлгийн маягт олон улсын стандарт бүхий загварт нийцсэн байна.	64.4.Гаалийн мэдүүлгийн маягт олон улсын стандарт бүхий загварт нийцсэн байна.		
470.	55.7.Гаалийн мэдүүлэгт бичигдэх мэдээлэл нь гаалийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, статистикийн мэдээлэл гаргах, гаалийн болон бусад татвар ногдуулахад шаардлагатай мэдээллээр хязгаарлагдана.	64.5.Гаалийн мэдүүлэгт бичигдэх мэдээлэл нь гаалийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, статистикийн мэдээлэл гаргах, гаалийн болон бусад татвар ногдуулахад шаардлагатай мэдээллээр хязгаарлагдана.		
471.		64.6.Гаалийн мэдүүлэгт байгаа мэдээллүүдийг гаалийн бүрдүүлэлтийн горим, барааны нэр төрөл, хилээр нэвтрүүлж байгаа этгээд, тээврийн хэрэгсэлийн төрлөөс хамааран товчилж болно.		
472.		64.7.Тээврийн, худалдааны бусад бичиг баримтуудад тухайн барааг олгоход хангалттай мэдээлэл агуулагдаж байвал гаалийн мэдүүлэгт тооцож болно.		
473.	55.8.Гаалийн мэдүүлгийг монгол хэлээр үйлдэнэ.	64.8.Гаалийн мэдүүлгийг монгол хэлээр үйлдэнэ.		
474.		64.9.Дараах тохиолдолд гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг бичигдэхгүй: 64.9.1.дипломат төлөөлөгчийн газар болон түүнтэй адилтгах бусад байгууллагын гаалийн хилээр нэвтрүүлэх бараа; 64.9.2.дамжуулан өнгөрүүлэх бараа; 64.9.3.холбогдох хууль тогтоомжид маягтаар гаалийн бүрдүүлэлт хийхээр заасан бараа.		
475.\	55.9.Улсын хилээр нэвтрэх зорчигч болон тээврийн хэрэгслийн багийн гишүүний хувийн хэрэглээний эд зүйл болон бусад барааг зорчигчийн гаалийн мэдүүлгээр мэдүүлнэ.			-
476.		**65 дугаар зүйл.Дамжуулан өнгөрүүлэх мэдүүлэг**		
477.		65.1.Барааг дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулахад дамжуулан өнгөрүүлэх мэдүүлгийг гаалийн байгууллагад гаргаж өгнө.		
478.		65.2.Тээврийн, худалдааны болон бусад бичиг баримтыг дамжуулан өнгөрүүлэх мэдүүлэгт тооцож болно.		
479.		65.3.Дамжуулан өнгөрүүлэх мэдүүлгийг гаалийн байгууллага цахим хэлбэрээр авна.		

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
mn.gov.mn

480.	**56 дугаар зүйл.Нэг ачилтын барааг мэдүүлэх**	**66 дугаар зүйл.Нэг ачилтын барааг мэдүүлэх**		-
481.	56.1.Нэг илгээгчээс нэг хүлээн авагчид илгээх, тус тусдаа тээврийн бичиг баримт бүхий, барааны оноосон нэр, ангиллын код, гарал үүслийн улс нь ижил бөгөөд барааг нэг өдөр илгэжж байгаа, эсхүл нэг өдөр хүлээн авч байгаа тохиолдолд нэг ачилт гэж үзэж, барааны гаалийн нэг мэдүүлгээр бүрдүүлэлт хийж болно.	66.1.Хилийн чанад дахь нэг илгээгчээс илгээсэн, эсхүл нэг илгээгчээс хилийн чанад дахь нэг хүлээн авагчид илгээх тус тусдаа тээврийн бичиг баримт бүхий, барааны оноосон нэр, ангиллын код, гарал үүслийн улс нь ижил бөгөөд барааг нэг өдөр, нэг мэдүүлэгч хүлээн авч, илгээж байгаа тохиолдолд нэг ачилт гэж үзэж, барааны гаалийн нэг мэдүүлгээр бүрдүүлэлт хийж болно.		*Өөрчлөн найруулсан*
482.	56.2.Иж бүрдэл бүхий тоног төхөөрөмж, машин, техникийг тээвэрлэлтийн боломжоос шалтгаалан эд анги, бүрдэл хэсгээр нь салгаж тээвэрлэсэн тохиолдолд нэг ачилтад хамааруулж болно.	66.2.Иж бүрдэл бүхий тоног төхөөрөмж, машин, техникийг тээвэрлэлтийн боломжоос шалтгаалан эд анги, бүрдэл хэсгээр нь салгаж тээвэрлэсэн тохиолдолд нэг ачилтад хамааруулж болно.		
483.	56.3.Нэг тээврийн хэрэгсэлд ачигдсан олон нэр төрлийн бараа нь Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн нэг зүйлд хамрагдах бол мэдүүлэгчийн хүсэлтээр хамгийн өндөр тарифтай нэг бараагаар төлөөлүүлэн мэдүүлж болох бөгөөд энэ тохиолдолд бусад барааны нэр, тоо, хэмжээ, үнийг тусгасан баримтыг гаалийн мэдүүлэгт хавсаргана.	66.3.Нэг тээврийн хэрэгсэлд ачигдсан олон нэр төрлийн бараа нь Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн нэг зүйлд хамрагдах бол мэдүүлэгчийн хүсэлтээр хамгийн өндөр тарифтай нэг бараагаар төлөөлүүлэн мэдүүлж болох бөгөөд энэ тохиолдолд бусад барааны нэр, тоо, хэмжээ, үнийг тусгасан баримтыг гаалийн мэдүүлэгт хавсаргана.		-
484.		66.4.Гаалийн бүрдүүлэлтийн нэг горимтой, барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн нэг кодтой барааг хоёр буюу түүнээс дээш тээврийн хэрэгсэлээр тээвэрлэхээр бол нэг гаалийн мэдүүлгээр багцалж мэдүүлж болно.		
485.		66.5.Гаалийн нэг мэдүүлгээр багцалж бүрдүүлэлт хийсэн экспортын барааг ачсан тээврийн хэрэгслийг цуваанаас салгаж тээвэрлэхгүй. Хэрэв техникийн шалтгаанаар цуваанаас салгах тохиолдолд гаалийн байгууллагад мэдэгдэн хасалт хийлгэж, шинээр гаалийн мэдүүлэг бичүүлэн гаалийн бүрдүүлэлт хийнэ.		
486.	**57 дугаар зүйл.Мэдүүлэгчийн эрх, үүрэг**	**67 дугаар зүйл. Мэдүүлэгчийн эрх, үүрэг**	**3.9 Стандарт** Мэдүүлэгч холбогдох Барааны мэдүүлгийг гаргаж өгөхөөс өмнө, гаалийн байгууллагаас тогтоож болох нөхцөлийн дагуу дараах боломжийг эдэлнэ:	
487.	57.1.Мэдүүлэгч дараахь эрх эдэлнэ:	67.1.Мэдүүлэгч дараах эрх эдэлнэ:		
488.	57.1.1.гаалийн бүрдүүлэлтийн горим сонгох, өөрчлөх;	67.1.1.гаалийн бүрдүүлэлтийн горим сонгох, өөрчлөх;		
489.		67.1.2.импортын барааны гаалийн тарифын төрөл сонгох;		
490.	57.1.2.барааг бодитой мэдүүлэх зорилгоор бараагаа мэдүүлэхээс өмнө үзэх, хэмжих;	67.1.3.барааг бодитой мэдүүлэх зорилгоор бараагаа мэдүүлэхээс өмнө үзэх, хэмжих;	(a) барааг шалгах; мөн	
491.	57.1.3.гаалийн байгууллагын зөвшөөрлөөр гаалийн хяналтад байгаа бараанаас дээж, сорьц, загвар авах;	67.1.4.гаалийн байгууллагын зөвшөөрлөөр гаалийн хяналтад байгаа бараанаас дээж, сорьц, загвар авах;	(b) дээж загвар авах	-

492.	57.1.4.гаалийн байгууллага, албан тушаалтан бараанд шалгалт хийх, дээж, сорьц, загвар авахад байлцах;			-
493.	57.1.5.гаалийн байгууллагаас бараанд хийсэн магадлан шинжилгээ, болон бусад шинжилгээний дүнтэй танилцах;	67.1.5.гаалийн байгууллагаас бараанд хийсэн шинжилгээний дүнтэй танилцах		
494.	57.1.6.бараанд холбогдох мэдээлэл, бичиг баримтыг мэдээллийн сүлжээгээр ирүүлэх;	67.1.6.бараанд холбогдох мэдээлэл, бичиг баримтыг мэдээллийн сүлжээгээр ирүүлэх;		
495.		67.1.7.гаалийн байгууллагын албан тушаалтны гаргасан шийдвэр, үйлдэл, эс үйлдэлд гомдол гаргах;		
496.		67.1.8.мэдүүлсэн барааны тухай мэдээллийг тодруулахын тулд эксперт оролцуулах;		
497.	57.1.7.энэ хуульд заасан бусад эрх.	67.1.9.энэ хуульд заасан бусад эрх.		
498.	57.2.Мэдүүлэгч дараахь үүрэг хүлээнэ:	67.2.Мэдүүлэгч дараах үүрэг хүлээнэ:	**3.8 Стандарт** Мэдүүлэгч нь холбогдох Барааны мэдүүлэгт дурдсан мэдээллийн үнэн зөвийг, мөн гаалийн болон бусад татвар төлөх асуудлыг гаалийн байгууллагын өмнө хариуцах үүрэг хүлээнэ.	
499.		67.2.1. бараа, тээврийн хэрэгслийн талаар үнэн, зөв мэдүүлэх;		
500.	57.2.1.гаалийн мэдүүлгийн дагуу өгсөн мэдээллийн үнэн зөвийг хариуцаж, гаалийн болон бусад татвар, хураамжийг төлөх, эсхүл төлөх баталгаа гаргах;	67.2.3.гаалийн мэдүүлгийн дагуу өгсөн мэдээллийн үнэн зөвийг хариуцаж, гаалийн болон бусад татвар, хураамжийг төлөх, эсхүл төлөх баталгаа гаргах;		
501.	57.2.2.гаалийн мэдүүлгийн маягтыг нөхөн бичиж, шаардагдах мэдээлэл, бичиг баримтыг гаалийн байгууллагад гаргаж өгөх;	67.2.2.гаалийн мэдүүлгийн маягтыг нөхөн бичиж, шаардагдах мэдээлэл, бичиг баримтыг гаалийн байгууллагад гаргаж өгөх;		
502.	57.2.3.гаалийн мэдүүлэг, барааны дагалдах бичиг баримтыг хуульд заасан хэлбэрээр бүрдүүлж гаалийн байгууллагад хүргүүлэх;	67.2.4.гаалийн мэдүүлэг, барааны дагалдах бичиг баримтыг хуульд заасан хэлбэрээр бүрдүүлж гаалийн байгууллагад хүргүүлэх;		-
503.	57.2.4.мэдүүлсэн барааг гаалийн байгууллагад шалгуулах;	67.2.5.гаалийн байгууллага, албан тушаалтан бараанд шалгалт хийх, дээж, сорьц, загвар авах нөхцлийг бүрдүүлэх, байлцах;		*Хасагдсан*
504.	57.2.5.гаалийн хяналтын бүсэд барааг ачих, буулгах, задлах, гаалийн байгууллагын зөвшөөрлөөр тээврийн хэрэгслийг хөдөлгөх;	67.2.6.гаалийн хяналтын бүсэд барааг ачих, буулгах, задлах, гаалийн байгууллагын зөвшөөрлөөр тээврийн хэрэгслийг хөдөлгөх;		
505.	57.2.6.гаалийн хууль тогтоомжийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх;	67.2.7.гаалийн хууль тогтоомж зөрчихөөс урьдчилан сэргийлэх;		
506.		67.2.8.сонгосон гаалийн бүрдүүлэлтийн горимын нөхцөл шаардлагыг биелүүлэх;		
507.		67.2.9 олон улсын гэрээ хэлэлцээр болон үндэсний хууль тогтоомжоор улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааг гаалийн хилээр нэвтрүүлэхгүй байх, гаалийн хилээр нэвтрүүлэх хязгаарласан барааны талаарх мэдээ, мэдээллийг гаалийн байгууллагад цаг алдалгүй өгөх;		

www.nlp.gov.mn
ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

508.	57.2.7.түр хугацаагаар нэвтрүүлсэн бараа, тээврийн хэрэгслийг энэ хуульд заасан хугацаанд буцаан нэвтрүүлэх, ийнхүү нэвтрүүлэх боломжгүй бол гаалийн бүрдүүлэлтийн өөр горимд байршуулах;			
509.	57.2.8.хуульд заасан бусад үүрэг.	67.2.10.хуульд заасан бусад үүрэг.		-
510.		67.3.Мэдүүлэгч энэ хуульд заасан үүргээ биелүүлээгүй, бүрэн бус мэдээлэлд үндэслэн гаальд мэдүүлсэн, энэ нь гаалийн байгууллагын эрсдэлийн удирдлагын системээс гаргах шийдвэрт нөлөөлсөн бол хууль тогтоомжоор тогтоосон хариуцлага хүлээнэ.		
511.		**68 дугаар зүйл.Гаалийн мэдүүлэг өгөх**		
512.		68.1.Мэдүүлэгч тухайн гаалийн мэдүүлгийг хүлээн авч бүртгэх эрх бүхий гаалийн байгууллагад гаргана.		
513.		68.2.Гаалийн мэдүүлэг өгсөн огноо, цаг нь гаалийн цахим мэдээллийн системд бүртгэгдэнэ		
514.		68.3.Гаалийн мэдүүлэг гаалийн цахим мэдээллийн системд бүртгэгдсэнээс ажлын хоёроос доошгүй цагийн дотор гаалийн байгууллага түүнийг бүртгэх эсхүл бүртгэхээс татгалзах шийдвэр гаргана.		
515.		68.4.Дараах тохиолдолд гаалийн байгууллага гаалийн мэдүүлгийг бүртгэхээс татгалзана: 68.4.1.мэдүүлэгч гаалийн мэдүүлгийг хүлээн авч бүртгэх эрхгүй гаалийн байгууллагад гаргасан; 68.4.2.гаалийн мэдүүлэг гаргах эрхгүй этгээд гаргасан; 68.4.3.гаалийн мэдүүлэгт зайлшгүй тусгагдах заалтууд бүрэн тусгагдаагүй; 68.4.4.гаалийн мэдүүлгийг тогтоосон маягтаар үйлдээгүй, эсхүл хуульд заасан хэлбэрээр баталгаажуулаагүй; 68.4.5.гаалийн мэдүүлэг гаргахаас өмнө буюу гаргах үед мэдүүлэгчийн зүгээс зайлшгүй хийж гүйцэтгэхээр хууль тогтоомжоор тогтоосон үйлдлийг хийгээгүй.		
516.		68.5.Гаалийн байгууллага гаалийн мэдүүлгийг бүртгэхээс татгалзах үндэслэлийг бичнэ. Энэ тохиолдолд мэдүүлэг, дагалдах бичиг баримтыг мэдүүлэгчид буцаана.		
517.		68.6.Гаалийн мэдүүлгийг бүртгээгүй нь гаальд мэдүүлээгүйд тооцогдоно.		
518.		68.7.Гаалийн байгууллага, албан тушаалтан гаалийн мэдүүлэг, барааны дагалдах бичиг баримтыг хүлээн авч бүртгэснээр барааг гаалийн байгууллагад мэдүүлсэнд тооцно.		

Хууль зүйн сайдын хүрээлэн www.legalinstitute.mn

519.	**58 дугаар зүйл. Гаалийн мэдүүлэг өгөх хугацаа**	**69 дүгээр зүйл.Гаалийн мэдүүлэг өгөх хугацаа**		-
520.	58.1.Мэдүүлэгч гаалийн мэдүүлгийг энэ хуулийн 25.1-д заасан цагт гаалийн байгууллагад хүргүүлэх, бөгөөд мэдээллийн сүлжээгээр ирүүлсэн гаалийн мэдүүлэг, мэдээлэл, баримт бичигт энэ хугацаа мөн адил хамаарна.	86.1.Мэдүүлэгч гаалийн мэдүүлгийг энэ хуулийн 100.1-д заасан цагт гаалийн байгууллагад хүргүүлэх бөгөөд мэдээллийн сүлжээгээр ирүүлсэн гаалийн мэдүүлэг, мэдээлэл, бичиг баримтад энэ хугацаа мөн адил хамаарна.		-
521.	58.2.Мэдүүлэгч барааг гаалийн хяналтын бүс, эсхүл гаалийн түр агуулахад байх хугацаанд гаалийн байгууллагад мэдүүлнэ.	69.1.Мэдүүлэгч гаалийн нутаг дэвсгэрт оруулах барааг гаалийн хяналтын бүс, түр агуулахад байх хугацаанд гаалийн байгууллагад мэдүүлнэ.	**3.22 Стандарт** Барааны мэдүүлгийг гаалийн байгууллагаас тогтоосон цагт багтаан гаргаж өгнө.	*“бүс,” гэсний “баталгаат болон чөлөөт бүс” гэж нэмсэн*
522.		69.2.Гаалийн хилээр гаргах барааг гаалийн хяналтын бүсэд оруулахаас өмнө гаалийн байгууллагад мэдүүлнэ.	**3.24 Стандарт** Мэдүүлэгчийн хүсэлтээр, мөн гаалийн байгууллагаас зөвшөөрсөн хүндэтгэн үзэх шалгаанаар гаалийн байгууллага Барааны мэдүүлэг гаргаж өгөх хугацааг сунгана.	
523.	58.3.Гаалийн мэдүүлэг өгөх хугацааг сунгах үндэслэлтэй гэж үзвэл гаалийн байгууллага мэдүүлэгчийн хүсэлтээр уг хугацааг энэ хуулийн 44.1, 44.2-т зааснаар дахин нэг удаа сунгана.	69.3.Гаалийн мэдүүлэг өгөх хугацааг сунгах үндэслэлтэй гэж үзвэл гаалийн байгууллага мэдүүлэгчийн хүсэлтээр уг хугацааг энэ хуулийн 56.1, 56.2-т заасан хугацаанд багтаан нэг удаа сунгана.	**3.25 Стандарт** Үндэсний хууль тогтоомжид барааг ирэхээс өмнө Барааны мэдүүлэг болон хавсралт бичиг баримт гаргаж өгөх, бүртгэх, эсхүл шалгах тухай заалт оруулсан байна.	-
524.		69.4.Гаалийн зөрчил болон эрүүгийн хэрэгт холбоотойгоор саатуулагдсан барааг буцаан олгох тухай шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш 10 хоногийн дотор гаалийн мэдүүлгийг шинээр гаргана.		
525.		69.5.Энэ зүйлийн 69.4-т заасан хугацаанд мэдүүлээгүй бол гаалийн байгууллага барааг гаалийн түр агуулахад шилжүүлнэ.		
526.	**59 дүгээр зүйл. Барааг урьдчилан мэдүүлэх**	**72 дугаар зүйл.Барааг урьдчилан мэдүүлэх**		
527.	59.1.Илгээгч улсын нутаг дэвсгэрээс ачигдсан гадаадын барааг Монгол Улсын хилээр оруулахаас өмнө, эсхүл хилийн гаалийн байгууллагын хяналтаас гүний гаалийн байгууллагын хяналтад орохоос өмнө тус тус урьдчилан мэдүүлж болно.	72.1.Илгээгч улсын нутаг дэвсгэрээс ачигдсан гадаадын барааг Монгол Улсын хилээр оруулахаас өмнө, эсхүл хилийн гаалийн байгууллагын хяналтаас гүний гаалийн байгууллагын хяналтад орохоос өмнө тус тус урьдчилан мэдүүлж болно.		
528.	59.2.Энэ хуулийн 59.1-д заасан барааны дагалдах бичиг баримтын хуулбарыг гаалийн байгууллага гаргуулан авах бөгөөд бараа ирсний дараа бичиг баримтын эх хувийг хуулбартай тулгаж шалгана.	72.2.Энэ хуулийн 72.1-д зааснаар урьдчилан мэдүүлэх барааны дагалдах бичиг баримтын хуулбарыг гаалийн байгууллага гаргуулан авах бөгөөд бараа ирсний дараа бичиг баримтын эх хувийг хуулбартай тулгаж шалгана.		-
529.		72.3.Мэдүүлэгч өөрийн урьдчилан мэдэх боломжгүй мэдээллийг гаалийн мэдүүлэгт бичихгүй байж болно. Барааг хилээр орж ирсний дараа гаалийн бүрдүүлэлт хийхээс өмнө дээрх мэдээллийг нөхөж бичсэн байна.		
530.		72.4.Урьдчилан мэдүүлэх үед гаргаж өгсөн бичиг баримт дээрх үнэ, тоо хэмжээ, жин бодит байдал дээр зөрсөн тохиолдолд энэ өөрчлөлтийг тайлбарласан нотлох баримтыг мэдүүлэгч гаргаж өгнө.		

531.		72.5.Бараа гаалийн хилээр орж ирсний дараа мэдүүлэгч өөрөө үнэ, тоо хэмжээ, жинд өөрчлөлт орж байгааг мэдсэн тохиолдолд урьдчилан мэдүүлсэн гаалийн мэдүүлгийг буцаан авч болно.		
532.		72.6.Бараа нь урьдчилсан мэдүүлэг гаргасан гаалийн байгууллагаас өөр гаалийн байгууллагын хамрах нутаг дэвсгэрт орсон, үүнийг тухайн гаалийн байгууллагад мэдэгдсэн эсхүл бараатай холбоотойгоор хориглосон, хязгаарласан шийдвэр гарсан бол гаалийн байгууллага барааг олгохоос татгалзана.		
533.		72.7.Барааг урьдчилан мэдүүлэх журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.		*Шинээр нэмэгдсэн*
534.	**60 дугаар зүйл.Бараа мэдүүлэхэд шаардагдах бусад бичиг баримт**	**70 дугаар зүйл.Барааг мэдүүлэхэд шаардагдах бичиг баримт**		
535.	60.1.Мэдүүлэгч гаалийн мэдүүлэгтээ барааны дагалдах бичиг баримтыг хавсаргаж гаалийн байгууллагад өгнө.			
536.	60.2.Гаалийн байгууллага бүрэн эрхээ хэрэгжүүлэх болон гаалийн хууль тогтоомжид заасан шаардлагыг хангах хүрээнд барааны дагалдах бичиг баримтыг гаргуулан авна.			
537.	60.3.Мэдүүлэгч гаалийн мэдүүлэгт өгсөн мэдээллийнхээ үнэн зөвийг нотлох зорилгоор дараах бичиг баримтыг гаалийн байгууллагад өгнө:	70.1.Мэдүүлэгч гаалийн мэдүүлэгт өгсөн мэдээллийнхээ үнэн зөвийг нотлох зорилгоор дараах бичиг баримтыг гаалийн байгууллагад өгнө:		
538.	60.3.1.гадаад худалдааны гэрээ, эсхүл үнийн нэхэмжлэх;	70.1.1.гадаад худалдааны бичиг баримт		
539.	60.3.2.тээврийн бичиг баримт;	70.1.2.тээврийн бичиг баримт		
540.	60.3.3.тарифын бус хязгаарлалтад хамаарах барааны шаардагдах зөвшөөрөл, лиценз;	70.1.4.тарифын бус хязгаарлалтад хамаарах барааны шаардагдах зөвшөөрөл, лиценз;		
541.	60.3.4.хууль тогтоомжид тусгайлан заасан барааны мэргэжлийн хяналтын байгууллагаас олгосон дүгнэлт	70.1.5.хууль тогтоомжид тусгайлан заасан барааны холбогдох байгууллагаас олгосон дүгнэлт;		
542.		70.1.6.шаардлагатай тохиолдолд магадлан шинжилгээний дүгнэлт.		
543.	60.3.5.Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу эрх бүхий этгээд шаардсан тохиолдолд гарал үүслийг нотлох баримт бичиг.	70.1.3.гарал үүслийг нотлох бичиг баримт;		*Шинэчлэн найруулсан*
544.		70.2.Энэ хуулийн 70.1-д заасан бичиг баримт нь цахилгаан шуудан, цахим худалдан авалтын гэрээ зэрэг хэлбэрээр хийгдсэн байж болно.		
545.	**61 дүгээр зүйл. Барааг гаалийн байгууллагад мэдүүлсэнд тооцох** 61.1.Гаалийн байгууллага, албан тушаалтан гаалийн мэдүүлэг, барааны дагалдах бичиг баримтыг хүлээн авч бүртгэснээр барааг гаалийн байгууллагад мэдүүлсэнд тооцно.	**89 дүгээр зүйл.Барааг гаалийн байгууллагад мэдүүлсэнд тооцох** 89.1.Гаалийн байгууллага, албан тушаалтан гаалийн мэдүүлэг, барааны дагалдах бичиг баримтыг хүлээн авч бүртгэснээр барааг гаалийн байгууллагад мэдүүлсэнд тооцно.		-

546.	**62 дугаар зүйл. Гаалийн мэдүүлэгт нэмэлт, өөрчлөлт оруулах**	**71 дүгээр зүйл.Гаалийн мэдүүлэгт нэмэлт, өөрчлөлт оруулах**	**3.27 Стандарт**	
547.	62.1.Мэдүүлэгч гаалийн байгууллагын хүлээн авсан гаалийн мэдүүлэгт нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтээ бичгээр гаргана.	71.1.Мэдүүлэгч гаалийн байгууллагын бүртгэн авсан гаалийн мэдүүлэгт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл хүсэлтээ бичгээр гаргана.	Гаалийн байгууллага хэрэв холбогдох Барааны мэдүүлгийг, эсхүл холбогдох барааг шалгаж эхлээгүй бол мэдүүлэгч аль хэдийнэ гаргаж өгсөн Барааны мэдүүлэгт өөрчлөлт оруулахыг зөвшөөрнө. **3.28 Шилжилтийн стандарт** Хэрэв Барааны мэдүүлэгт өөрчлөлт оруулах хүсэлтийг гаалийн байгууллага холбогдох Барааны мэдүүлгийг шалгаж эхэлсний дараа хүлээн авсан бөгөөд мэдүүлэгчийн шалтгааныг үндэслэлтэй гэж үзсэн бол мэдүүлэгч уг Барааны мэдүүлэгт өөрчлөлт оруулахыг гаалийн байгууллага зөвшөөрнө.	*“оруулах” гэсний дараа “шаардлагатай гэж үзвэл” гэж нэмсэн*
548.	62.2.Гаалийн байгууллага дараахь тохиолдолд гаалийн мэдүүлэгт нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвшөөрнө:	71.2.Гаалийн байгууллага дараах тохиолдолд гаалийн мэдүүлэгт нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвшөөрнө:		
549.	62.2.1.гаалийн мэдүүлгээр өгсөн мэдээлэл бүрэн бус бол;	71.2.5.гаалийн байгууллагын бүртгэн авсан гаалийн мэдүүлэгт мэдүүлээгүй барааг нэмэхгүй бол.		
550.	62.2.2.гаалийн мэдүүлэгт нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтээ мэдүүлэгчээс гаргах үед гаалийн байгууллага барааг шалгаж эхлээгүй бол;			
551.	62.2.3.гаалийн мэдүүлэгт оруулах нэмэлт, өөрчлөлт нь ногдуулсан гаалийн болон бусад татварын дүн, тарифын бус хязгаарлалтын арга хэмжээнд нөлөөлөхөөргүй бол.	71.2.1.барааг олгох тухай гаалийн байгууллагын шийдвэрт нөлөөлөхөөргүй;		-
552.		71.2.2.барааны гаалийн үнийг өөрчлөхөөс бусад тохиолдлоор татварын үнийн дүнд өөрчлөлт орох бол;		
553.		71.2.3.тарифын бус хязгаарлалтын арга хэмжээтэй хамааралгүй бол;		
554.		71.2.4.гаалийн мэдүүлэгт нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтээ мэдүүлэгч гаргах үед гаалийн байгууллага барааг шалгах газар, хугацааг мэдэгдээгүй бол;		
555.		71.2.5.гаалийн байгууллагын бүртгэн авсан гаалийн мэдүүлэгт мэдүүлээгүй барааг нэмэхгүй бол.		
556.		71.3.Хүчин төгөлдөр болсон гаалийн мэдүүлэгт гаалийн байгууллага дараах тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулж болно:		
557.		71.3.1.гаалийн байгууллагын дотоод хяналтын үр дүнд алдаа, зөрчил илрэх тохиолдолд;		
558.		71.3.2.гарал үүслийг нотлох баримтаа Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд заасан хугацаанд гаргаж өгсөнөөр хөнгөлөлттэй тарифт шилжсэн;		
559.		71.3.3.гаалийн үнэ, барааны ангилал, гарал үүсэл, татварын болон тарифын хувь хэмжээнд өөрчлөлт оруулахаар хуульд заасан журмын дагуу эрх бүхий албан тушаалтан, байгууллагаас шийдвэр гаргасан бол.		
560.	62.3.Гаалийн байгууллага, албан тушаалтан өөрийн санаачилгаар, эсхүл бусад этгээдийн хүсэлт, даалгавраар гаалийн мэдүүлэг бичих буюу түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.	71.4.Гаалийн байгууллага, түүний албан тушаалтан өөрийн санаачилгаар, эсхүл бусад этгээдийн хүсэлт, даалгавраар гаалийн мэдүүлэг бичих, энэ хуулийн 71.3-т зааснаас бусад тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.		*“буюу түүнд” гэснийг “, энэ хуулийн 90.3-д зааснаас бусад тохиолдолд” гэж өөрчилсөн*

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМАНДАЛЫН ХҮРЭЭЛЭН
www.zalgov.gov.mn

561.	**63 дугаар зүйл. Гаалийн мэдүүлгийг шалгах** 63.1.Гаалийн байгууллага, албан тушаалтан гаалийн мэдүүлгийг хүлээн авсан даруйд дараахь байдлаар шалгана: 63.1.1.гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу шаардагдах бичиг баримт нь бүрэн, хүчин төгөлдөр эсэх; 63.1.2.гаалийн мэдүүлэг, барааны дагалдах бичиг баримтад дурдсан мэдээлэл үнэн зөв, бодитой, хоорондоо тохирч байгаа эсэх; 63.1.3.гаалийн болон бусад татварын ногдуулалт зөв эсэх.	**109 дүгээр зүйл.Гаалийн мэдүүлгийг шалгах** 109.1.Гаалийн байгууллага, албан тушаалтан гаалийн мэдүүлгийг хүлээн авсан даруйд дараах байдлаар шалгана: 109.1.1.гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу шаардагдах бичиг баримт нь бүрэн, хүчин төгөлдөр эсэх; 109.1.2.гаалийн мэдүүлэг, барааны дагалдах бичиг баримтад дурдсан мэдээлэл үнэн зөв, бодитой, хоорондоо тохирч байгаа эсэх; 109.1.3.гаалийн болон бусад татварын ногдуулалт зөв эсэх.		-
562.		109.2.Гаалийн байгууллага бүрэн эрхээ хэрэгжүүлэх болон гаалийн хууль тогтоомжид заасан шаардлагыг хангах хүрээнд барааны дагалдах бичиг баримтыг гаргуулан авна.		*Шинээр нэмэгдсэн*
563.	**64 дүгээр зүйл. Гаалийн мэдүүлгийг буцаан авах**	**73 дугаар зүйл.Гаалийн мэдүүлгийг буцаан авах**	**3.29 Шилжилтийн стандарт**	
564.	64.1.Гаалийн бүрдүүлэлтийн горимыг өөрчлөх зорилгоор мэдүүлэгч нь барааг гаалийн бүрдүүлэлтийн горимд байршуулахаас өмнө гаалийн мэдүүлгээ буцаан авч болох бөгөөд энэ тухай хүсэлтээ бичгээр гаргана.	73.1.Мэдүүлэгч барааг гаалийн бүрдүүлэлтийн горимд байршуулахаас өмнө гаалийн мэдүүлгээ буцаан авч болох бөгөөд энэ тухай хүсэлтээ бичгээр гаргана.	Мэдүүлэгч барааг олгохоос өмнө гаалийн байгууллагад хүсэлтээ гаргасан, мөн шалтгааныг нь гаалийн байгууллага үндэслэлтэй гэж үзсэн бол мэдүүлэгчид Барааны мэдүүлгээ буцаан авч гаалийн өөр горим сонгохыг зөвшөөрнө.	
565.	64.2.Гаалийн байгууллага энэ хуулийн 64.1-д заасан хүсэлтийг ажлын 3 хоногийн дотор нягтлан шалгаж, хүсэлтийг хүлээн авах эсэх талаар бичгээр хариу өгөх бөгөөд хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан бол үндэслэлийг дурдана.	73.2.Гаалийн байгууллага энэ хуулийн 73.1-д заасан хүсэлтийг ажлын гурав хоногийн дотор нягтлан шалгаж, хүсэлтийг хүлээн авах эсэх талаар бичгээр хариу өгөх бөгөөд хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан бол үндэслэлийг дурьдана.		
566.		73.3.Дараах тохиолдолд гаалийн мэдүүлгийг буцаан авах хүсэлтийг хүлээн авахгүй: 73.3.1.гаалийн мэдүүлэгт нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтээ мэдүүлэгчээс гаргах үед гаалийн байгууллага барааг шалгах газар, цагийг мэдэгдсэн бол; 73.3.2.зөрчил илэрсэн бол.		
567.	64.3.Гаалийн байгууллага энэ хуулийн 64.1-д заасан хүсэлтийг хүлээн авсан бол мэдүүлэгч нь ажлын 3 хоногийн дотор өөрчлөн сонгосон горимын дагуу барааг дахин мэдүүлнэ.	73.4.Гаалийн байгууллага энэ хуулийн 73.1-д заасан хүсэлтийг хүлээн авсан бол мэдүүлэгч ажлын гурав хоногийн дотор өөрчлөн сонгосон горимын дагуу барааг дахин мэдүүлнэ		-
568.		73.5.Гаалийн шалгалтаар ямар нэг зөрчил илрээгүй бол өмнө гаргасан мэдүүлэг буцаан авах хүсэлтийг гаалийн байгууллага хүлээн авч болно.		

ХУУЛЬЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.uli.gov.mn

569.		**74 дүгээр зүйл. Гаальд мэдүүлэх онцлог тохиолдол**		
570.		74.1.Дараах тохиолдолд барааны нэр төрөл, тэдгээрийг нэвтрүүлж байгаа этгээдээс шалтгаалан хууль, тогтоомжийн хүрээнд гаалийн байгууллагад мэдүүлэх ажиллагааг өөрөөр тогтоож болно:		
571.		74.1.1.цахилгаан дулааны эрчим хүч, хий, уур, ус зэрэг тусгай хоолой, шугамаар тээвэрлэгдэх барааны тоо хэмжээг нь нарийвчлан хянах баталгаат тоолуурын үндсэн дээр холбогдох бичиг баримтыг үндэслэн;		
572.		74.1.2.угсраагүй задалсан байдалтайгаар эд анги, бүрдэл хэсгээр нь салган тээвэрлэх бөгөөд тодорхой хугацааны турш орж ирэх барааны холбогдох бичиг баримтыг үндэслэн;		
573.		74.1.3.нэг этгээд нэг төрлийн барааг тодорхой хугацаанд гаалийн хилээр тогтмол нэвтрүүлдэг бол.		
574.	**65 дугаар зүйл. Гаалийн мэдүүлгийг хүчингүй болгох**	**75 дугаар зүйл.Барааны гаалийн мэдүүлгийг хүчингүй болгох**		
575.	65.1.Гаалийн байгууллага дараахь тохиолдолд гаалийн мэдүүлгийг хүчингүй болгоно	75.1.Гаалийн байгууллага барааны гаалийн мэдүүлгийг дараах тохиолдолд хүчингүй болгоно:		
576.	65.1.1.урьдчилан мэдүүлсэн бараа мэдүүлэгчээс үл хамаарах нөхцөл байдлын улмаас Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирээгүй, эсхүл Монгол Улсын нутаг дэвсгэрээс гараагүй;	75.1.1.урьдчилан мэдүүлсэн бараа мэдүүлэгчээс үл хамаарах нөхцөл байдлын улмаас Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирээгүй, эсхүл мэдүүлсэн бараа Монгол Улсын нутаг дэвсгэрээс гараагүй;		*“мэдүүлгийг” гэсний дараа “дараах” гэж нэмсэн*
577.		75.1.2.тодорхой шалтгааны улмаас тухайн барааг мэдүүлэгчийн сонгосон горимд байршуулахыг гаалийн байгууллага зөвшөөрөөгүй;		
578.	65.1.2.гаалийн бүрдүүлэлтийн горим өөрчлөхөөр гаргасан мэдүүлэгчийн хүсэлтийг гаалийн байгууллага хүлээн авсан.	75.1.3.гаалийн бүрдүүлэлтийн горим өөрчлөхөөр мэдүүлэгчийн бичгээр гаргасан хүсэлтийг гаалийн байгууллага зөвшөөрсөн.		
579.		75.1.4.хилээр гаргасан барааг хүлээн авагч улсын гаалийн байгууллага буцаасан.		*“хүсэлтийг гаалийн байгууллага хүлээн авсан” гэснийг “бичгээр гаргасан хүсэлтийг гаалийн байгууллага зөвшөөрсөн” гэж өөрчилсөн*

ХУУЛЬ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН

580.	**Долдугаар дэд бүлэг Гаалийн зуучлагч**	**ХОЁРДУГААР ДЭД БҮЛЭГ ГААЛИЙН ЗУУЧЛАЛ**		-
581.	**66 дугаар зүйл. Гаалийн зуучлаг**	**76 дугаар зүйл.Гаалийн зуучлал**		
582.	66.1.Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийн гаалийн бүрдүүлэлтийг гэрээний үндсэн дээр гаалийн зуучлагчаар гүйцэтгүүлж болно.	76.1.Гадаад худалдаа эрхлэгч этгээд гаалийн хилээр нэвтрүүлэх барааны гаалийн бүрдүүлэлт хийлгэх ажиллагааг гэрээний үндсэн дээр гаалийн зуучлагчаар гүйцэтгүүлж болно		*“Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийн гаалийн бүрдүүлэлтийг” гэснийг “Гадаад худалдаа эрхлэгч этгээд гаалийн хилээр нэвтрүүлэх барааг гаалийн байгууллагад мэдүүлэх ажиллагаа” гэж өөрчилсөн*
583.		76.2.Гаалийн зуучлалын үйл ажиллагаанд хяналт тавих журмыг гаалийн удирдах төв байгууллага батална.		*Шинээр нэмсэн*
584.	66.2.Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх Монгол Улсын хуулийн этгээд нь тусгай зөвшөөрөлтэй байх бөгөөд уг зөвшөөрлийг гаалийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно. 66.3.Энэ хуулийн 66.2-т заасан хуулийн этгээд гаалийн зуучлагчийн үйл ажиллагааг тодорхой нутаг дэвсгэрт, эсхүл тодорхой барааны нэр төрлөөр дагнан эрхэлж болно. 66.4.Энэ хуулийн 66.2-т заасан тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхийг хориглоно.			*Хасагдсан*
585.		**77 дугаар зүйл.Гаалийн зуучлалд хамаарах үйлчилгээ**		
586.		77.1.Гаалийн зуучлалд дараах үйлчилгээ хамаарна: 77.1.1.гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллагад мэдүүлэх; 77.1.2.бараа, тээврийн хэрэгслийн гаалийн бүрдүүлэлтэд шаардлагатай мэдээлэл, бичиг баримтыг гаалийн байгууллагад гаргаж өгөх; 77.1.3.барааны гаалийн үнийг хуулийн дагуу тодорхойлох; 77.1.4.барааны гаалийн тарифын төрлийг хуулийн дагуу тодорхойлох; 77.1.5.бараа, тээврийн хэрэгслийн гаалийн болон бусад татвар, хураамжийг төлөх; 77.1.6.бараа, тээврийн хэрэгсэлд биет шалгалт хийх үед төлөөлөгч байлцуулах.		*Шинээр нэмсэн*

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.mli.gov.mn

587.	**67 дугаар зүйл.Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхэхэд тавих шаардлага** 67.1.Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд нь дараахь шаардлага хангана: 67.1.1.татварын өргүй байх, 67.1.2.зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх санхүүгийн чадавхтай байх; 67.1.3.хоёроос доошгүй гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэнтэй байх; 67.1.4.мэдүүлэгчийн өмнөөс гаалийн болон холбогдох бусад татварыг төлөх, эсхүл төлөхөөр гаргасан батлагаат хангахад учирч болзошгүй алдагдлаас хамгаалах зорилгоор эрсдлийн сан байгуулсан байх. 67.2.Энэ хуулийн 67.1.4-т заасан сан байршуулах хөрөнгийн хэмжээг зуучлалын үйлчилгээнд хамаарах барааны хэмжээнээс хамаарулан гаалийн удирдах төв байгууллагын дарга тогтооно. 67.3.Гаалийн зуучлагч болон бүртгэгдсэн мэргэжилтний үйл ажиллагаанд гаалийн байгууллага хяналт тавих бөгөөд гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.				*Хасагдсан*
588.	**68 дугаар зүйл. Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн** 68.1.Гаалийн удирдах төв байгууллагаас тогтоосон шалгуурыг хангасан иргэнд гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний гэрчилгээ олгоно. 68.2.Гаалийн удирдах төв байгууллага нь гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх зорилгоор 2 жил тутам шалгалт авна. 68.3.Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний гэрчилгээг дараахь үндэслэлээр хүчингүй болсонд тооцно: 68.3.1.гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон; 68.3.2.гаалийн хууль тогтоомжийг удаа дараа зөрчсөн; 68.3.3.хуурамч бичиг баримт бүрдүүлэн гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний гэрчилгээг авсан нь тогтоогдсон; 68.3.4.энэ хуулийн 68.2-т заасан шалгалтад хангалттүй дүн үзүүлсэн.				

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

589.		**98 дугаар зүйл.Гаалийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох** 98.1.Гаалийн удирдах төв байгууллага энэ хуулийн 97 дугаар зүйлд заасан үүргээ удаа дараа биелүүлээгүй гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ. 98.2.Гаалийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг гаалийн удирдах төв байгууллагын дарга тушаалаар түдгэлзүүлнэ. Тушаалд гаалийн зуучлалын үйл ажиллагааг түдгэлзүүлсэн үндэслэлийг заасан байна. 98.3.Гаалийн удирдах төв байгууллагын даргын тушаалаар гаалийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг дараах тохиолдолд хүчингүй болгоно: 98.3.1.гаалийн зуучлагч гаалийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд уг зөвшөөрлийг түдгэлзүүлэх үндэслэл болсон шалтгааныг арилгаагүй; 98.3.2.гаалийн зуучлагч, түүний ажилтан гаалийн хууль тогтоомжийг хоёр болон түүнээс дээш удаа зөрчсөн нь тогтоогдсон, 98.3.3.гаалийн зуучлагч байгууллага татан буугдсан, өөр байгууллагатай нэгдсэн, албан ёсны нэрээ сольсон; 98.3.4.гаалийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгосноос, эсхүл сунгаснаас хойш гаалийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэхгүйгээр 3 сар болсон; 98.3.5.хуурамч бичиг баримт бүрдүүлэн гаалийн зуучлагчийн эрх авсан нь тогтоогдсон.		*Шинээр нэмсэн*
590.		**80 дугаар зүйл.Гаалийн зуучлалын гэрээ байгуулах**		
591.		80.1.Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийн гаалийн бүрдүүлэлтийг гаалийн зуучлагчаар төлөөлүүлэн хийлгэх гадаад худалдаа эрхлэгч, гаалийн зуучлагчтай гаалийн зуучлалын гэрээ бичгээр байгуулна.		
592.		80.2.Гаалийн хилээр бараа, тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх гадаад худалдаа эрхлэгч гаалийн зуучлалын гэрээг нэг буюу хэд хэдэн гаалийн зуучлагчтай байгуулж болно.		

Хуулийн өмнөх хүрээлэн www.mlsi.gov.mn

593.	**69 дүгээр зүйл.Гаалийн зуучлагчийн эрх, үүрэг**	**81 дүгээр зүйл.Гаалийн зуучлагчийн эрх, үүрэг**		
594.	69.1.Гаалийн зуучлагч энэ хуулийн 57.1-д зааснаас гадна гаалийн хууль тогтоомжид орсон өөрчлөлтийн талаар гаалийн байгууллагаас тухай бүр мэдээлэл авах эрх эдэлнэ.	81.1.1.гаалийн байгууллагаас зөвлөгөө авах; 81.1.2.гэрээгээр төлөөлж байгаа этгээдээс гаалийн бүрдүүлэлтэд ашиглах бичиг баримт, мэдээлэл, түүний дотор байгууллагын нууцад хамаарах худалдааны болон банкны мэдээллийг гаргуулан авах; 81.1.3.барааг цахим хэлбэрээр гаальд мэдүүлэх, мэдүүлгийг илгээх хэмжээнд гаалийн цахим мэдээллийн системд орох, ажиллах эрх авах; 81.1.4.үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосон, шийтгэл ногдуулсан үндэслэлийн талаар бичгээр тайлбар авах.		*Өөрчлөн найруулсан*
595.	69.2.Гаалийн зуучлагч энэ хуулийн 57.2-т зааснаас гадна дараахь үүрэг хүлээнэ: 69.2.1.мэдүүлэгчийг төлөөлөн гаалийн бүрдүүлэлт хийх тухай гэрээ байгуулах; 69.2.2.гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнээрээ дамжуулан гаалийн үйл ажиллагаанд оролцох; 69.2.3.гаалийн зуучлагчийн үйл ажиллагаатай холбоотой бүртгэл хөтлөх, мэдээ, тайлан гаргаж гаалийн байгууллагад өгөх; 69.2.4.энэ хуулийн 66.2-т заасан тусгай зөвшөөрөл авах үед гаалийн байгууллагад гаргаж өгсөн мэдээлэлд орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэх; 69.2.5.мэдүүлэгчийн нууцыг задруулахгүй, хууль бусаар ашиглахгүй байх; 69.2.6.улсын хилээр нэвтрүүлэх барааны талаархи мэдээллийг 10 хоногийн өмнө гаалийн байгууллагад өгөх.	81.2.Гаалийн зуучлагч энэ хуульд заасан мэдүүлэгчийн үүргээс гадна дараах үүрэг хүлээнэ: 81.2.1.энэ хуулийн 80 дугаар зүйлийн дагуу гаалийн зуучлалын гэрээ байгуулах; 81.2.2.гаалийн байгууллагын тогтоосон цагаар ажиллах; 81.2.3.ажлын ачааллыг хангахуйц тооны ажилтантай байх; 81.2.4.санхүүгийн чадавхитай байх; 81.2.5.үйлчлүүлэгчээс авсан нууцад хамаарах болон бусад мэдээллийг бусдад задруулахгүй, шилжүүлэхгүй, хувийн зорилгоор ашиглахгүй байх; 81.2.6.зөвхөн өөрийн хариуцсан нутаг дэвсгэрт орох, эсхүл түүнээс гарах, гаалийн хилээр нэвтрэх бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллагад мэдүүлэх; 81.2.7.хуулиар гаалийн байгууллагад өгөхөөр заасан тайлан мэдээллийг тогтоосон хугацаанд гаргаж өгөх; 81.2.8.зөвшөөрөл авах үед гаалийн байгууллагад гаргаж өгсөн мэдээлэлд орсон өөрчлөлтийг тухай бүр гаалийн байгууллагад мэдээлэх; 81.2.9.гаалийн хууль тогтоомжид заасан нөхцөл шаардлагыг зөрчсөн, хүлээсэн үүргээ биелүүлээгүй, мөн гаалийн зуучлагч байгууллагаа төлөөлөн харилцаанд оролцсон ажилтны гаргасан алдаа, зөрчилд хариуцлага хүлээх.		*Өөрчлөн найруулсан*
596.		81.3. Гаалийн байгуулагын өмнө хүлээх гаалийн зуучлагчийн үүрэг нь түүний гэрээгээр төлөөлж байгаа этгээдийн гэрээгээр хязгаарлагдахгүй.		
597.		**78 дугаар зүйл.Гаалийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэх**		
598.		78.1.Гаалийн зуучлалын зөвшөөрөл хүссэн хуулийн этгээд дараах материалыг бүрдүүлэн гаалийн удирдах төв байгууллагад гаргаж өгнө:		
599.		78.1.1.гаалийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн хүсэлт;		
600.		78.1.2.улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаат хуулбар;		

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН

601.		78.1.3.татварын өргүй болохыг нотлох татварын болон гаалийн байгууллагын тодорхойлолт;		
602.		78.1.4.сүүлийн хоёр жилийн санхүүгийн тайлан баланс;		
603.		78.1.5.гаалийн зуучлал эрхлэн явуулах нутаг дэвсгэр, салбар нэгжийн зохион байгуулалтын бүдүүвч;		
604.		78.1.6.гэмт хэрэг, зөрчилд холбогдолгүй болохыг нотлох цагдаагийн байгууллагын тодорхойлолт.		
605.		78.2.Энэ зүйлийн 78.1-д заасан хүсэлт, бусад материалыг цахим хэлбэрээр гаргаж өгч болно.		
606.		81.3.Гаалийн байгууллагын өмнө хүлээх гаалийн зуучлагчийн үүрэг нь түүний гэрээгээр төлөөлж байгаа этгээдийн гэрээгээр хязгаарлагдахгүй.		
607.	**70 дугаар зүйл. Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох**	**79 дүгээр зүйл.Гаалийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах**		
608.	70.1.Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилээс доошгүй хугацаагаар олгоно.	79.2.Гаалийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг гаалийн удирдах төв байгууллагын дарга гурван жилээс доошгүй хугацаагаар олгоно.		
609.	70.2.Тусгай зөвшөөрөл хүсэгч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1.1-11.1.4-т зааснаас гадна дараахь бичиг баримт бүрдүүлж гаалийн удирдах төв байгууллагад ирүүлнэ:	79.1.Дараах нөхцөл шаардлагыг хангасан тохиолдолд гаалийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг гаалийн удирдах төв байгууллага олгоно:		
610.		79.1.1.зохих сургалтад хамрагдсан, гаалийн хууль тогтоомжийн хангалттай хэмжээний мэдлэгтэй хоёроос доошгүй ажилтантай байх;		
611.		79.1.2.үйлчлүүлэгчийнх нь бараанд учрах хохирол болон гэрээг зөрчснөөс үүсэх харицлагыг хүлээх хэмжээний эрсдлийн даатгалыг хийлгэсэн байх;		
612.		79.1.3.гаалийн татвар хураамжийг төлөх баталгаат эх үүсвэртэй байх;		
613.		79.1.4.хууль тогтоомжид заасан бусад нөхцөл, шаардлагыг хангасан байх.		
614.	70.2.1.энэ хуулийн 67.1-д заасан шаардлагыг хангасан талаархи холбогдох байгууллагын тодорхойлолт, эсхүл гэрчилгээ			
615.	70.2.2.гаалийн хууль тогтоомжийн зөрчил гаргаж байгаагүйг нотолсон гаалийн болон цагдаагийн байгууллагын тодорхойлолт			
616.	70.2.3.гаалийн зуучлагчийн үйл ажиллагааг тодорхой төрөл, чиглэл, нутаг дэвсгэрээр дагнан эрхлэх тухай санал			
617.	70.3.Энэ хуулийн 70.2.3-т заасан санал ирүүлсэн тохиолдолд тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд үйл ажиллагааны төрлийг заана			

618.	70.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 67.1-д заасан шаардлагыг хангахгүй болсон, эсхүл энэ хуулийн 69.2-т заасан үүргээ биелүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг нь 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх, шийдвэрийг гаалийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаалийн удирдах төв байгууллагын саналыг үндэслэн гаргана.			
619.	70.5.Энэ хуулийн 70.4-т заасан хугацаанд зөрчлийг арилгаагүй, эсхүл гаалийн хууль тогтоомжийг 2 буюу түүнээс дээш удаа зөрчсөн бол гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг гаалийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаалийн удирдах төв байгууллагын саналыг үндэслэн хүчингүй болгоно.			
620.	70.6.Тусгай зөвшөөрлийг олгох, хүчингүй болгох, зөвшөөрлийн хугацааг нь сунгах, түдгэлзүүлэх, зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавихтай холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай[1] хуулиар зохицуулна.			*Өөрчлөн найруулсан*
621.		79.2.Гаалийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг гаалийн удирдах төв байгууллагын дарга гурван жилээс доошгүй хугацаагаар олгоно.		
622.		79.3.Гаалийн удирдах төв байгууллагын дарга гаалийн зуучлалын эрхийг нутаг дэвсгэр, барааны нэр төрөл, тээврийн хэрэгслийн төрлөөр хязгаарлаж болно. Энэ тохиолдолд гаалийн зуучлалын эрх олгох тухай шийдвэрт заана.		
623.		79.4.Гаалийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг гаалийн удирдах төв байгууллагын даргын шийдвэрээр анх зөвшөөрөл олгосон хугацаагаар сунгана		
624.		79.5.Энэ хуулийн 82.3-т заасан үндэслэлээр гаалийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд гурван жилийн хугацаанд дахин зөвшөөрөл олгохгүй.		
625.		79.6.Гаалийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг бусдад шилжүүлэхийг хориглоно.		
626.		**82 дугаар зүйл.Гаалийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох**		
627.		82.1.Гаалийн удирдах төв байгууллага энэ хуулийн 81 дүгээр зүйлд заасан үүргээ хоёр буюу түүнээс дээш удаа биелүүлээгүй гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ.		

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.legal.mn

628.		82.2.Гаалийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг гаалийн удирдах төв байгууллагын даргын тушаалаар түдгэлзүүлнэ. Тушаалд гаалийн зуучлалын үйл ажиллагааг түдгэлзүүлсэн үндэслэлийг заасан байна.		
629.		82.3.Гаалийн удирдах төв байгууллагын даргын шийдвэрээр гаалийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг дараах тохиолдолд хүчингүй болгоно:		
630.		82.3.1.гаалийн зуучлагч гаалийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд уг зөвшөөрлийг түдгэлзүүлэх үндэслэл болсон шалтгааныг арилгаагүй;		
631.		82.3.2.гаалийн зуучлагч, түүний ажилтан гаалийн хууль тогтоомжийг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчсөн нь тогтоогдсон;		
632.		82.3.3.гаалийн зуучлагч байгууллага татан буугдсан, өөр байгууллагатай нэгдсэн, албан ёсны нэрээ сольсон;		
633.		82.3.4.гаалийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгосноос, эсхүл сунгаснаас хойш гаалийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэхгүйгээр гурван сар болсон;		
634.		82.3.5.хуурамч бичиг баримт бүрдүүлэн гаалийн зуучлагчийн эрх авсан нь тогтоогдсон		
635.		82.3.6.энэ хуулийн 79 дүгээр зүйлд заасан нөхцөл шаардлагуудыг хангахгүй болсон;		
636.		82.3.7.зөвшөөрлийг хүчингүй болгуулахаар өөрөө хүсэлт гаргасан.		
637.	**Наймдугаар дэд бүлэг Гаалийн байгууллагад мэдүүлсэн барааг олгох**	**ТАВДУГААР ДЭД БҮЛЭГ БАРААГ ОЛГОХ**		*“Гаалийн байгууллагад мэдүүлсэн” гэснийг хассан*
638.	**71 дүгээр зүйл. Барааг олгох үндэслэл**			
639.	71.1.Гаалийн байгууллагад мэдүүлсэн барааг дараахь тохиолдолд мэдүүлэгчид нь олгоно:	152.1.Гаалийн байгууллагад мэдүүлсэн барааг дараах нөхцөл бүрдсэн тохиолдолд мэдүүлэгчид олгоно:		
640.	71.1.1.гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу шаардагдах бичиг баримт бүрдсэн;	152.1.1.гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу шаардагдах, мөн импорт, экспортын лицензболон бусад шаардлагатай зөвшөөрөл, бичиг баримт бүрдсэн;		
641.	71.1.2.гаалийн бүрдүүлэлтийн сонгосон горимын нөхцөл, шаардлага хангагдсан;	152.1.2.гаалийн бүрдүүлэлтийн сонгосон горимын нөхцөл, шаардлага хангагдсан;		
642.	71.1.3.гаалийн болон бусад татварыг төлсөн, эсхүл төлөх баталгааг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд зааснаар гаргасан;	152.1.3.гаалийн болон бусад татварыг төлсөн, эсхүл төлөх баталгааг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд зааснаар гаргасан;		
643.	71.1.4.гаалийн мэдүүлгийн дагуу барааг гаалийн хяналт, шалгалт хийгдсэн;	152.1.4.гаалийн мэдүүлгийн дагуу барааг гаалийн хяналт, шалгалт хийгдсэн;		-
644.	71.1.5.энэ хуулийн 71.1.4-т заасны дагуу хийсэн хяналт, шалгалтаар зөрчил илрээгүй бол.	152.1.5.энэ хуулийн 152.1.4-т заасны дагуу хийсэн хяналт, шалгалтаар зөрчил илрээгүй.		*“илрээгүй гэсний дараах “бол” гэснийг хассан*

645.		152.2.Зөрчил, гэмт хэрэг илэрсэн боловч хуулийн дагуу тухайн зөрчил, гэмт хэрэгт барааг хураах заалт байхгүй, бараа нь эд мөрийн баримт болохгүй бөгөөд түүнд ногдох гаалийн болон бусад татвар төлөгдсөн, эсхүл нэмж төлөх,торгууль төлөх баталгааг хуульд тогтоосон журмаар гаргасан бол гаалийн байгууллага мэдүүлэгчид барааг олгож болно.		
646.	**72 дугаар зүйл. Гаалийн хяналтад байх нөхцөлөөр бараа олгох**	**153 дугаар зүйл.Гаалийн хяналтад байх нөхцөлөөр барааг олгох**		
647.	72.1.Гаалийн хяналтад байх нөхцөлтэйгээр дараахь барааг мэдүүлэгчид нь олгоно:	153.1.Гаалийн хяналтад байх нөхцөлтэйгээр дараах барааг мэдүүлэгчид нь олгоно:		
648.	72.1.1.түр хугацаагаар оруулах, гаргах;	153.1.1.түр хугацаагаар оруулах, гаргах;		-
649.		153.1.2.гаалийн нутаг дэвсгэрт, эсхүл хилийн чанадад боловсруулах;		
650.	72.1.2.гаалийн баталгаат бүсэд оруулах;	153.1.3.гаалийн баталгаат бүсэд оруулах;		-
651.	72.1.3.гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлөгдөж чөлөөт эргэлтэд орсон.	153.1.4.гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлөгдсөн;		*“орсон” гэснийг “ороогүй” гэж өөрчилсөн*
652.		153.1.5.энэ хуулийн 152.1.1-д заасан зөвшөөрөл, лицензийг хууль, тогтоомжид заасан тохиолдолд дараа гаргаж өгөхөөр баталгаа гаргасан;		
653.		153.1.6.хууль, тогтоомжид заасны дагуу ашиглалт, захиран зарцуулалтыг нь хязгаарласан бараа.		
654.	72.2.Энэ хуулийн 72.1.1, 72.1.3-т заасан барааг гаалийн нутаг дэвсгэрт зориулалтын дагуу ашиглана.	153.2.Энэ хуулийн 153.1.1, 153.1.2, 153.1.4-т заасан барааг гаалийн нутаг дэвсгэрт зориулалтын дагуу ашиглана.		-
655.		153.3.Энэ хуулийн 153.1-д заагдсан бараа гадаадын бараанд тооцогдоно.		
656.		153.4. Энэ хуулийн 153.1.4-т заасан бараа дараах тохиолдолд монголын бараа болно: 153.4.1.тооцогдсон татварыг төлөх үүрэг хуульд заасан журмаар дуусгавар болсон; 153.4.2.энэ хуулийн 153.1.5-д заасан барааны хувьд 152.1.1-д заасан бичиг баримтыг гаргаж өгсөн.		
657.		153.5.Энэ хуулийн 153.4-т зааснаар барааг монголын бараа гэж тооцоход бүрдүүлэлтийг дахин хийхгүй.		
658.		153.6.Энэ хуулийн 153.1-д заагдсан барааг өөр этгээдэд шилжүүлэх, худалдахыг хориглоно.		

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.legalinfo.mn

659.		**154 дүгээр зүйл.Барааг олгохгүй байх** 154.1.Гаалийн байгууллага дараах тохиолдолд барааг олгохоос татгалзана: 154.1.1.энэ хуулийн 152.1-д заасан нөхцөл хангагдаагүй; 154.1.2.энэ хуулийн 72.6-д заасан нөхцөлд; 154.1.3.зөрчил илэрснээр энэ хуулийн 154.2-т заасан тохиолдолд. 154.2.Гаалийн хяналт, шалгалтаар зөрчил илэрвэл доор дурьдснаас бусад тохиолдолд барааг олгохоос татгалзана: 154.2.1.илэрсэн зөрчилд зөрчлийн болон гэмт хэрэг үүсгэхээргүй бол; 154.2.2.илэрсэн зөрчлийг арилгасан, эсхүл энэ хуулийн 152.2-т заасан нөхцөл бүрдсэн. 154.3.Барааг олгохоос татгалзсан үндэслэлээ гаалийн байгууллага мэдүүлэгчид бичгээр мэдэгдэнэ.		
660.		**155 дугаар зүйл.Гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийх**		
661.		155.1.Гаалийн хяналтад байгаа бараа, тээврийн хэрэгсэл, тэдгээрийг хадгалж байгаа байр, сав, агуулах зэрэгт гаалийн байгууллага тэмдэглэгээ хийнэ. 155.2.Гаалийн тэмдэглэгээг дараах аргаар хийнэ: 155.2.1.лац, ломбо тавих; 155.2.2.тоон болон үсгэн тэмдэглэгээ тавих; 155.2.3.тамга дарах; 155.2.4.сав, баглаа, боодол болгон боож, түүнд хийсэн тэмдэглэгээ; 155.2.5. дээж, сорьц, загвар авах 155.2.6.гадаад, дотоод шинжийг тодорхойлон бичих; 155.2.7.схем дүрс зургаар илэрхийлэх; 155.2.8.ерөнхий болон дүрслэн зураглал гаргах 155.2.9.дүрс бичлэг хийх, фото зураг авах; 155.2.10.олон улсын худалдааны тэмдэглэгээний Жи Эс систем хэрэглэх; 155.2.11.бичиг баримтын хуудсыг дэс дарааллуулан тоогоор дугаарлан баталгаажуулах; 155.2.12.тэмдэглэгээ бүхий наалт; 155.2.13.хуулбарлаж авах; 155.2.14.үсэг дугаар бүхий код ашиглах; 155.2.15.бичиг баримтыг уут, сав, дугтуйнд хийж түүнд хийх тэмдэглэгээ жин овор хэмжээ, тоо ширхэгийг тодорхойлж тэмдэглэх; 155.2.16.холбогдох тайлбар, тодруулга, лавлагааг гаргуулан авч баримтжуулах; 155.2.17.бусад. 155.3.Гаалийн хяналтад байгаа бараа, тээврийн хэрэгсэл, түүнийг хадгалж байгаа агуулах, байр, талбай болон гаалийн хяналтад байгаа бараанаас дээж, сорьц, загвар зэрэгт тэмдэглэгээ хийхэд энэ хуулийн 155.2-т заасан хэлбэрээс аль тохирохыг сонгож хэрэглэнэ.		*Шинээр нэмсэн*

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН

	155.4.Хилийн чанадад тур хугацаагаар гаргах болон гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимд байршуулах бараа, тээврийн хэрэгслийн техник хэрэгслийн үзүүлэлт, марк, артикул, зориулалт, жин, тоо, овор хэмжээ, шинж байдлыг тодорхойлон бичих, фото зурвас авч тусгайлан тэмдэглэгээний цахим сан үүсгэж, хадгалах үүргийг Гаалийн байгууллага хэрэгжүүлнэ. 155.5.Бараа хилийн чанадад түр хугацаагаар гаргах, бараа гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимд байршсан бараа, тээврийн хэрэгслийг буцааж нэвтрүүлэхдээ тэмдэглэгээний цахим сан авагдсан тодорхойлолттой нэг бүрчлэн тулгаж нягталсаны дараа гаалийн бүрдүүлэлт хийнэ. 155.6.Гаалийн байгууллагын тэмдэглэгээний бүрэн бүтэн байдлыг гаалийн харилцаанд оролцогч тал хариуцна. 155.7.Гаалийн зорилгоор гадаад орны гаалийн байгууллагын болон илгээгч, тээвэрлэгчийн тавьсан тэмдэглэгээг хүлээн зөвшөөрч болно.			
662.		**156 дугаар зүйл.Гаалийн тэмдэглэгээг өөрчлөх**		
663.		156.1.Гаалийн тэмдэглэгээг гамшгийн нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд зөвхөн гаалийн байгууллага авч, өөрчилж болно. 156.2.Гамшгийн улмаас бараа, тээврийн хэрэгсэл устах, урэгдэх, гэмтэж муудах нөхцөл байдал үүссэн үед гаалийн харилцаанд оролцогч этгээд тухайн нөхцөл байдлыг хамгийн ойр орших гаалийн байгууллагад нэн даруй мэдээлж, гаалийн байгууллагын зөвшөөрснөөр тэмдэглэгээг авч, өөрчилж болно. 156.3.Бараа дамжуулан өнгөрүүлэх болон шилжүүлэн ачих горимд байршуулах бараа, тээврийн хэрэгсэлд гадаадын болон үндэсний гаалийн байгууллагын тавьсан тэмдэглэгээг өөрчлөх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд тэмдэглэгээг шинээр тавьсан гаалийн байгууллага тэмдэглэгээ өөрчилсөн тухай тэмдэглэл үйлдэнэ. 156.4.Гаалийн байгууллагын зөвшөөрсний дагуу тэмдэглэгээг авсан, өөрчилсөн этгээд энэ тухайгаа гаалийн байгууллагад бичгээр мэдэгдэж, энэ хуулийн 156.1-д заасан нөхцөл байдал үүссэн болохыг нотолсон гамшгаас хамгаалах байгууллагын тодорхойлолтыг холбогдох албан тушаалтнаас гаргуулан авч хавсаргасан байна. 156.5.Энэ хуулийн 156.3-т заасан тэмдэглэлд бараа, тээврийн хэрэгслийн зэмшигчийн тухай мэдээлэл, тэмдэглэгээний арга, лац, ломбоны дугаар, огноо, тэмдэглэгээнд өөрчлөлт орох болсон шалтгаан, тэмдэглэгээг өөрчлөх шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтны тапаарх мэдээлэл, тэмдэглэгээ үйлдсэн албан тушаалтны мэдээллийг агуулна.		

ХУУЛЬ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН
www.legal.mn

664.	**III ХЭСЭГ ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТИЙН ГОРИМ**	**V ХЭСЭГ ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТИЙН ГОРИМ**		-
665.	**ДОЛДУГААР БҮЛЭГ Гаалийн бүрдүүлэлтийн горим**	**АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТИЙН ГОРИМЫН НИЙТЛЭГ ЗАРЧИМ**		-
666.	**Нэгдүгээр дэд бүлэг Нийтлэг үндэслэл**			
667.	**73 дугаар зүйл.Гаалийн бүрдүүлэлтийн горим сонгох** 73.1.Гаалийн бүрдүүлэлтийн горимыг мэдүүлэгч сонгоно.	**152 дугаар зүйл.Гаалийн бүрдүүлэлтийн горим сонгох** 152.1.Гаалийн бүрдүүлэлтийн горимыг мэдүүлэгч сонгоно.		-
668.		152.2.Гаалийн бүрдүүлэлтийн горимыг хэрэгжүүлэх журам, горимын код, тухайн горимын дагуу шаардах мэдээлэл, бичиг баримтын жагсаалтыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.		*Шинээр нэмсэн*
669.	**74 дүгээр зүйл. Бараг гаалийн бүрдүүлэлтийн горимд байршуулах** 74.1.Мэдүүлэгч нь гаалийн бүрдүүлэлтийн тухайн горимын нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд гаалийн байгууллагын зөвшөөрлөөр бараг түүний сонгосон горимд байршуулна. 74.2.Гаалийн бүрдүүлэлтийн горимд бараа байршуулсан өдрийг гаалийн байгууллага бараг олгосон, эсхүл гаалийн хилээр гаргасан өдрөөр тооцно. 74.3.Дараахь бичиг баримтыг үндэслэн гаалийн бүрдүүлэлтийн горимд бараг байршуулна: 74.3.1.энэ хуулийн 79.4.1, 79.4.2-т заасан төрлийн горимд ачааны манифестыг; 74.3.2.энэ хуулийн 79.4.1, 79.4.2-т зааснаас бусад төрлийн горимд гаалийн мэдүүлгийг.	**153 дугаар зүйл.Бараг гаалийн бүрдүүлэлтийн горимд байршуулах** 153.1.Мэдүүлэгч нь гаалийн бүрдүүлэлтийн тухайн горимын нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд гаалийн байгууллагын зөвшөөрлөөр бараг түүний сонгосон горимд байршуулна. 153.2.Гаалийн бүрдүүлэлтийн горимд бараа байршуулсан өдрийг гаалийн байгууллага бараг олгосон, эсхүл гаалийн хилээр гаргасан өдрөөр тооцно. 153.3.Дараах бичиг баримтыг үндэслэн бараг гаалийн бүрдүүлэлтийн горимд байршуулна: 153.4.1.энэ хуулийн 243, 250 дугаар зүйлд заасан горимд ачааны манифестыг; 153.4.2.энэ хуулийн 243, 250 дугаар зүйлд зааснаас бусад төрлийн горимд гаалийн мэдүүлгийг.		-
670.	**75 дугаар зүйл. Гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу шаардах мэдээлэл, бичиг баримт**	**154 дүгээр зүйл.Гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу шаардагдах мэдээлэл, бичиг баримт**		*“шаардах” гэснийг “шаардагдах” гэж өөрчилсөн*
671.	75.1.Гаалийн байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 60.3-т заасан бичиг баримтаас гадна гаалийн бүрдүүлэлтийн тухайн горимд шаардагдах мэдээлэл, бичиг баримтыг мэдүүлэгчээс шаардаж авна.	154.1.Гаалийн байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 88.1-д заасан бичиг баримтаас гадна гаалийн бүрдүүлэлтийн тухайн горимд шаардагдах мэдээлэл, бичиг баримтыг мэдүүлэгчээс шаардаж авна.		
672.	75.2.Энэ хуулийн 75.1-д заасны дагуу авсан мэдээлэл, баримт бичиг нь шаардлага хангахгүй бол нэмэлт мэдээлэл шаардаж болно.	154.2.Энэ хуулийн 154.1-д заасны дагуу авсан мэдээлэл, бичиг баримт нь шаардлага хангахгүй бол нэмэлт мэдээлэл шаардаж болно.		*“баримт бичиг“ гэснийг “бичиг баримт” гэж өөрчилсөн*

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН

673.	75.3.Тухайн горимын бараа нь Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалтад хамаарах, эсхүл гаалийн болон бусад татвараас бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөгдөхөөр бол мэдүүлэгч нь холбогдох бичиг баримтыг бүрдүүлнэ.	154.3.Тухайн горимд байршуулах бараа нь тарифын бус хязгаарлалтад хамаарах, эсхүл гаалийн болон бусад татвараас бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөгдөхөөр бол мэдүүлэгч нь холбогдох бичиг баримтыг бүрдүүлнэ.		*"Тухайн горимын бараа нь Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад" гэснийг "Тухайн горимд байршуулах бараа нь" гэж өөрчилсөн*
674.	**76 дугаар зүйл. Гаалийн бүрдүүлэлтийн горимд мөрдөх баталгаа** 76.1.Мэдүүлэгч нь гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу гаалийн хилээр нэвтрүүлэх бараанд ногдох гаалийн болон бусад татварыг төлөх, эсхүл Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд заасны дагуу холбогдох татвар төлөх баталгаа гаргаж болно. 76.2.Энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан барааг буцаан гаргах, эсхүл гаалийн нутаг дэвсгэрээс түр хугацаагаар гаргасан барааг буцаан оруулна. 76.3.Барааг энэ хуулийн 76.2-т заасны дагуу гаргасан, эсхүл оруулсан тохиолдолд төлсөн гаалийн болон бусад татварыг буцаан олгоно.	**155 дугаар зүйл.Гаалийн бүрдүүлэлтийн горимд мөрдөх баталгаа** 155.1.Мэдүүлэгч нь гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу гаалийн хилээр нэвтрүүлэх бараанд ногдох гаалийн болон бусад татварыг төлөх, эсхүл Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд заасны дагуу холбогдох татвар төлөх баталгаа гаргаж болно. 155.2.Энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан барааг буцаан гаргах, эсхүл гаалийн нутаг дэвсгэрээс түр хугацаагаар гаргасан барааг буцаан оруулна. 155.3.Барааг энэ хуулийн 155.2-т заасны дагуу гаргасан, эсхүл оруулсан тохиолдолд төлсөн гаалийн болон бусад татварыг буцаан олгоно.		-
675.	**77 дугаар зүйл.Гаалийн зөрчлийн улмаас горимын үйлчлэл дуусгавар болох** 77.1.Гаалийн бүрдүүлэлтийн горимд байршуулсан бараа нь гаалийн зөрчлийн улмаас саатуулагдсан, хураагдсан бол гаалийн горимын үйлчлэл дуусгавар болсонд тооцогдоно.	**156 дугаар зүйл.Гаалийн зөрчлийн улмаас горимын үйлчлэл дуусгавар болох** 156.1.Гаалийн бүрдүүлэлтийн горимд байршуулсан бараа нь гаалийн зөрчлийн улмаас саатуулагдсан, хураагдсан бол горимын үйлчлэл дуусгавар болсонд тооцогдоно.		-
676.	**78 дугаар зүйл.Гаалийн бүрдүүлэлтийн горимын ангилал** 78.1.Гаалийн бүрдүүлэлтийн горимыг дор дурдсанаар ангилна: 78.1.1.барааг гаалийн нутаг дэвсгэрт оруулах; 78.1.2.барааг хилийн чанадад гаргах; 78.1.3.гаалийн баталгаат бүс; 78.1.4.барааг дамжуулан өнгөрүүлэх, шилжүүлэн ачих; 78.1.5.барааг хүлээн авахаас татгалзах, устгах; 78.1.6.тусгай горим.	**157 дугаар зүйл.Гаалийн бүрдүүлэлтийн горимын ангилал** 157.1.Гаалийн бүрдүүлэлтийн горимыг дор дурдсанаар ангилна: 157.1.1.барааг гаалийн нутаг дэвсгэрт оруулах; 157.1.2.барааг хилийн чанадад гаргах; 157.1.3.гаалийн баталгаат бүс; 157.1.4.барааг дамжуулан өнгөрүүлэх, шилжүүлэн ачих; 157.1.5.барааг хүлээн авахаас татгалзах, устгах; 157.1.6.тусгай горим.		-

ХУУЛЬ ЗҮЙЛ ҮЙЛЧЛЭНИЙ ХҮРЭЭЛЭН
www.zalan.gov.mn

677.	**79 дүгээр зүйл. Гаалийн бүрдүүлэлтийн горимын төрөл** 79.1.Бараг гаалийн нутаг дэвсгэрт оруулах горим дараахь төрөлтэй байна: 79.1.1.бараг дотоодын хэрэглээнд зориулан оруулах; 79.1.2.бараг дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах; 79.1.3.бараг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах; 79.1.4.бараг гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах; 79.1.5.бараг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах. 79.2.Бараг хилийн чанадад гаргах горим дараахь төрөлтэй байна: 79.2.1.бараг хилийн чанадад бүрмөсөн гаргах; 79.2.2.бараг хилийн чанадад түр хугацаагаар гаргах; 79.2.3.бараг хилийн чанадад боловсруулах; 79.2.4.бараг хилийн чанадад буцаан гаргах. 79.3. Гаалийн баталгаат бүсийн горим дараахь төрөлтэй байна: 79.3.1.гаалийн баталгаат агуулах; 79.3.2.гаалийн баталгаат үйлдвэрийн газар; 79.3.3.гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газар; 79.3.4.гаалийн баталгаат барилгын талбай; 79.3.5.татваргүй барааны дэлгүүр; 79.3.6.гаалийн тусгай бүс. 79.4.Бараг дамжуулан өнгөрүүлэх, шилжүүлэн ачих горим дараахь төрөлтэй байна: 79.4.1.бараг улс хооронд дамжуулан өнгөрүүлэх; 79.4.2.бараг дотоодод дамжуулан өнгөрүүлэх; 79.4.3.бараг шилжүүлэн ачих. 79.5.Бараг хүлээн авахаас татгалзах, устгах горим дараахь төрөлтэй байна: 79.5.1.бараа хүлээн авахаас татгалзах; 79.5.2.бараа устгах. 79.6.Тусгай горим дараахь төрөлтэй байна: 79.6.1.улс хоорондын тээврийн үйлчилгээний бараг гаалийн хилээр нэвтрүүлэх; 79.6.2.дипломат төлөөлөгчийн газар болон түүнтэй адилтгах бусад байгууллагын бараг гаалийн хилээр нэвтрүүлэх; 79.6.3.улс хоорондын шуудангийн илгээмжийг гаалийн хилээр нэвтрүүлэх; 79.6.4.зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх; 79.6.5.чөлөөт бүсийн горим.	**158 дугаар зүйл.Гаалийн бүрдүүлэлтийн горимын төрөл** 158.1.Бараг гаалийн нутаг дэвсгэрт оруулах горим дараахь төрөлтэй байна: 158.1.1.бараг дотоодын хэрэглээнд зориулан оруулах; 158.1.2.бараг дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах; 158.1.3.бараг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах; 158.1.4.бараг гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах; 158.1.5.бараг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах. 158.2.Бараг хилийн чанадад гаргах горим дараахь төрөлтэй байна: 158.2.1.бараг хилийн чанадад бүрмөсөн гаргах; 158.2.2.бараг хилийн чанадад түр хугацаагаар гаргах; 158.2.3.бараг хилийн чанадад боловсруулах; 158.2.4.бараг хилийн чанадад буцаан гаргах. 158.3.Гаалийн баталгаат бүсийн горим дараахь төрөлтэй байна: 158.3.1.гаалийн баталгаат агуулах; 158.3.2.гаалийн баталгаат үйлдвэрийн газар; 158.3.3.гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газар; 158.3.4.гаалийн баталгаат барилгын талбай; 158.3.5.татваргүй барааны дэлгүүр; 158.3.6.гаалийн тусгай бүс. 158.4.Бараг дамжуулан өнгөрүүлэх, шилжүүлэн ачих горим дараахь төрөлтэй байна: 158.4.1.бараг улс хооронд дамжуулан өнгөрүүлэх; 158.4.2.бараг дотоодод дамжуулан өнгөрүүлэх; 158.4.3.бараг шилжүүлэн ачих. 158.5.Бараг хүлээн авахаас татгалзах, устгах горим дараахь төрөлтэй байна: 158.5.1.бараа хүлээн авахаас татгалзах; 158.5.2.бараа устгах. 158.6.Тусгай горим дараахь төрөлтэй байна: 158.6.1.улс хоорондын тээврийн үйлчилгээний бараг гаалийн хилээр нэвтрүүлэх; 158.6.2.дипломат төлөөлөгчийн газар болон түүнтэй адилтгах бусад байгууллагын бараг гаалийн хилээр нэвтрүүлэх; 158.6.3.улс хоорондын шуудангийн илгээмжийг гаалийн хилээр нэвтрүүлэх; 158.6.4.зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх; 158.6.5.чөлөөт бүсийн горим.		-

ХУУЛЬ ЗҮЙН ДЭЭДИЙН ХУРЭЭЛЭН

678.	79.7.Гаалийн бүрдүүлэлтийн горимыг хэрэгжүүлэх журам, горимын код, тухайн горимын дагуу шаардах мэдээлэл, бичиг баримтын жагсаалтыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.			*Хасагдсан*
679.	**НАЙМДУГААР БҮЛЭГ Барааг гаалийн нутаг дэвсгэрт оруулах горим**	**АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ БАРААГ ГААЛИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ОРУУЛАХ ГОРИМ**		-
680.	**Нэгдүгээр дэд бүлэг Нийтлэг үндэслэл**	**НЭГДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**		-
681.	**80 дугаар зүйл. Барааг гаалийн нутаг дэвсгэрт оруулах горимын дагуу гаалийн болон бусад татвар төлөх, баталгаа гаргуулах** 80.1.Энэ хуулийн 78.1.1-д заасан горимд байршуулах барааг гаалийн байгууллага импортын гаалийн болон бусад татвар ногдуулж, хураан авч, улсын төсөвт төвлөрүүлнэ.	**159 дүгээр зүйл.Барааг гаалийн нутаг дэвсгэрт оруулах горимын дагуу гаалийн болон бусад татвар төлөх, баталгаа гаргуулах** 159.1.Энэ хуулийн 157.1.1-д заасан горимд байршуулах барааг гаалийн байгууллага импортын гаалийн болон бусад татвар ногдуулж, хураан авч, улсын төсөвт төвлөрүүлнэ.		-
682.		159.2.Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулахад гаалийн болон бусад татварыг ногдуулж, энэ хуулийн 172, 176 дугаар зүйлд заасан горимоор бүрдүүлэлт хийлгэхдээ гаалийн болон бусад татвар төлсөн мэдүүлгийг үндэслэн татварыг төлүүлэхгүйгээр төрийн сангийн тусгай дансанд байршуулсан мөнгийг улсын төсөвт төвлөрүүлнэ.		*Шинээр нэмсэн*
683.	80.2.Барааг гаалийн нутаг дэвсгэрт оруулах горимд байршуулахад гаалийн байгууллага импортын гаалийн болон бусад татвар төлөх баталгааг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд заасны дагуу гаргуулан авч болно.	159.3.Барааг гаалийн нутаг дэвсгэрт оруулах горимд байршуулахад гаалийн байгууллага импортын гаалийн болон бусад татвар төлөх баталгааг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд заасны дагуу гаргуулан авч болно.		-
684.	**81 дүгээр зүйл. Гаалийн нутаг дэвсгэрт оруулах горимын бараа тарифын бус хязгаарлалтад хамаарах** 81.1.Гаалийн нутаг дэвсгэрт оруулах горимын бараа Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалтад хамаарна.	**160 дугаар зүйл.Гаалийн нутаг дэвсгэрт оруулах горимын бараа тарифын бус хязгаарлалтад хамаарах** 160.1.Гаалийн нутаг дэвсгэрт оруулах горимын бараа тарифын бус хязгаарлалтад хамаарна.		*“Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад” гэснийг хассан*
685.	**Хоёрдугаар дэд бүлэг Барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах горим**	**ХОЁРДУГААР ДЭД БҮЛЭГ БАРААГ ДОТООДЫН ХЭРЭГЛЭЭНД ЗОРИУЛАН ОРУУЛАХ ГОРИМ**		-
686.	**82 дугаар зүйл.Барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах горимын агуулга**	**162 дугаар зүйл.Барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах горимын агуулга**		-

ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН
www.legalinfo.mn

687.	82.1.Энэ хуулийн 79.1.1-д заасан горимын дагуу шаардах бичиг баримтыг үндэслэн ногдуулсан импортын гаалийн болон бусад татварыг бүрэн төлсөн тохиолдолд гадаадын барааг гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд оруулна. 82.2.Импортын гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлөгдсөн барааг гаалийн хууль тогтоомжид заасан зориулалтын дагуу захиран зарцуулна.	162.1.Шаардагдах бичиг баримтыг үндэслэн ногдуулсан импортын гаалийн болон бусад татварыг бүрэн төлсөн тохиолдолд гадаадын барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах горимд байршуулна. 162.2.Дотоодын хэрэглээнд зориулан оруулах горимд байршуулсан барааг чөлөөт эргэлтэд байгаад тооцно. 162.3.Импортын гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлөгдсөн барааг гаалийн хууль тогтоомжид заасан зориулалтын дагуу захиран зарцуулах бөгөөд чөлөөт эргэлтэд байгаа гэж тооцогдохгүй. 162.4.Энэ хуулийн 134.1.4-д заасан барааг зориулалтын дагуу захиран зарцуулаагүй, эсхүл бусдад шилжүүлсэн тохиолдолд гаалийн байгууллагад мэдэгдэж, гаалийн болон бусад татварыг төлнө.		*Өөрчлөн найруулсан*
688.	**83дугаар зүйл.Дотоодын хэрэглээнд зориулан оруулах горимд байршуулах барааны** 83.1.Дотоодын хэрэглээнд зориулан оруулах горимд дараахь барааг байршуулна: 83.1.1.хилийн чанадаас ирсэн гадаадын бараа; 83.1.2.бусад горимоос дотоодын хэрэглээнд зориулан оруулах гадаадын бараа.	**163 дугаар зүйл.Дотоодын хэрэглээнд зориулан оруулах горимд байршуулах барааны** 163.1.Дотоодын хэрэглээнд зориулан оруулах горимд дараах барааг байршуулна: 163.1.1.хилийн чанадаас ирсэн гадаадын бараа; 163.1.2.бусад горимоос дотоодын хэрэглээнд зориулан оруулах гадаадын бараа.		-
689.	**84 дүгээр зүйл.Барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах горим дуусгавар болох** 84.1.Барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах горим нь барааг мэдүүлэгчид олгосноор, эсхүл өөр горимд байршуулснаар дуусгавар болсонд тооцно.	**164 дүгээр зүйл.Барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах горим дуусгавар болох** 164.1.Барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах горим нь барааг мэдүүлэгчид олгосноор, эсхүл өөр горимд байршуулснаар дуусгавар болсонд тооцно.		-
690.	**Гуравдугаар дэд бүлэг Барааг дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горим**	**ГУРАВДУГААР ДЭД БҮЛЭГ БАРААГ ДОТООДЫН ХЭРЭГЛЭЭНД ЗОРИУЛАН БОЛОВСРУУЛАХ ГОРИМ**		-
691.	**85 дугаар зүйл.Барааг дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горимын агуулга** 85.1.Барааг дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горимын дагуу энэ хуулийн 82.1-д заасан горимд байршуулах зорилгоор шаардагдах бичиг баримтыг үндэслэн гадаадын барааг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулна.	**165 дугаар зүйл.Барааг дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горимын агуулга** 165.1.Барааг дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горимын дагуу энэ хуулийн 162.1-д заасан горимд байршуулах зорилгоор шаардагдах бичиг баримтыг үндэслэн гадаадын барааг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулна.		-
692.	85.2.Энэ хуулийн 85.1-д заасан боловсруулах үйл ажиллагаанд дараахь үйл ажиллагаа хамаарна: 85.2.1.тухайн барааг боловсруулах, эсхүл баяжуулах; 85.2.2.тухайн бараагаар шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх.	165.3.Дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горимд байршуулах бараа тарифын бус хязгаарлалтад хамаарна.		-
693.		165.2.Энэ горимд байршуулах барааны жагсаалт, боловсруулалтын түвшинг Засгийн газраас батална		*Шинээр нэмэгдсэн*

694.	**86 дугаар зүйл.Дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горимд байршуулах барааны тавих шаардлага** 86.1.Дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горимд байршуулах бараа дараахь шаардлагыг хангасан байна: 86.1.1.тухайн барааны импортын гаалийн болон бусад татвар нь боловсруулсан бүтээгдэхүүнд ногдуулах гаалийн болон бусад татвараас өндөр байх; 86.1.2.тухайн барааны боловсруулалтад гаалийн байгууллага хяналт тавих боломжтой байх; 86.1.3.гаалийн байгууллага тухайн бараг боловсруулсан бүтээгдэхүүнээс ялгах боломжтой байх; 86.1.4.тухайн бараг боловсруулсны дараа анхны байдалд нь оруулах боломжгүй байх.	**166 дугаар зүйл.Дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горимд байршуулах барааны тавих шаардлага** 166.1.Дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горимд байршуулах бараа дараах шаардлагыг хангасан байна: 166.1.1.тухайн барааны импортын гаалийн болон бусад татвар нь боловсруулсан бүтээгдэхүүнд ногдуулах гаалийн болон бусад татвараас өндөр байх; 166.1.2.тухайн барааны боловсруулалтад гаалийн байгууллага хяналт тавих боломжтой байх; 166.1.3.гаалийн байгууллага тухайн бараг боловсруулсан бүтээгдэхүүнээс ялгах боломжтой байх; 166.1.4.тухайн бараг боловсруулсны дараа анхны байдалд нь оруулах боломжгүй байх.		-
695.	**87 дугаар зүйл.Дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горимд байршуулах бараа** 87.1.Дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горимд дараахь бараг байршуулна: 87.1.1.хилийн чанадаас ирсэн гадаадын бараа; 87.1.2.гаалийн баталгаат бүсээс оруулах гадаадын бараа.	**167 дугаар зүйл.Дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горимд байршуулах бараа** 167.1.Дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горимд дараах бараг байршуулна: 167.1.1.хилийн чанадаас ирсэн гадаадын бараа; 167.2.галийн баталгаат бүсээс оруулах гадаадын бараа		-
696.	**88 дугаар зүйл.Дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горимын бараанд гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийх** 88.1.Бараг дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горимд байршуулахад гаалийн байгууллага тухайн бараанд гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийнэ. 88.2.Энэ хуулийн 88.1-д заасан тэмдэглэгээ хийхдээ мөн хуулийн 261.1.-д заасан тэмдэглэгээнээс аль тохирохыг нь сонгон хэрэглэнэ.	**161 дүгээр зүйл.Барааnd гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийх** 161.1.Энэ хуулийн 165, 172, 176 дугаар зүйлд заасан горимд байршуулах барааnd гаалийн байгууллага гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийнэ. 161.2.Энэ хуулийн 161.1-д заасан тэмдэглэгээ хийхдээ мөн хуулийн мөн хуулийн 135.1-д заасан т.эмдэглэгээнээс аль тохирохыг нь сонгон хэрэглэнэ.		-
697.	**89 дүгээр зүйл.Бараг дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горимд байлгах хугацаа** 89.1.Дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горимд байршуулах хугацаа нь бараг тухайн горимд байршуулсан өдрөөс хойш 1 жилээс дээшгүй байна.	**168 дугаар зүйл.Бараг дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горимд байршуулах хугацаа** 168.1.Дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горимд байршуулах хугацаа нь бараг тухайн горимд байршуулсан өдрөөс хойш 1 жилээс дээшгүй байна.		-
698.	89.2.Гаалийн удирдах төв байгууллага нь энэ хуулийн 89.1-д заасан хугацааг 6 сар хүртэл хугацаагаар нэг удаа сунгаж болно.	168.2.Гаалийн удирдах төв байгууллага нь энэ хуулийн 168.1-д заасан хугацааг 1 жил хүртэл хугацаагаар нэг удаа сунгаж болно.		*“6 сар” гэснийг “1 жил” гэж өөрчилсөн*
699.		168.3.Горимд байршуулах хугацаа дууссан барааnd гаалийн байгууллага дотоодын хэрэглээнд зориулан оруулах горимоор гаалийн бүрдүүлэлт хийж, импортын гаалийн болон бусад татварыг ногдуулж, хураан авч, улсын төсөвт төвлөрүүлнэ.		*Шинээр нэмэгдсэн*

УЛСЫН ТЕСНИЙ ХУРЭЭЛЭН

700.	**90 дүгээр зүйл.Барааг дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд** 90.1.Барааг дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах үйл ажиллагаа эрхлэхийг хүсэгч хуулийн этгээд нь барааг гаалийн хилээр нэвтрүүлэхээс өмнө гаалийн удирдах төв байгууллагад хүсэлт гаргана. 90.2.Энэ хуулийн 90.1-д заасан хуулийн этгээд хүсэлтээ бичгээр гаргаж дараахь мэдээлэл, бичиг баримтыг ирүүлнэ: 90.2.1.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, хаяг; 90.2.2.горимд байршуулах бараа, түүгээр боловсруулах бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллын код, орцын норм, хаягдал, үлдэгдлийн хэмжээ; 90.2.3.барааг боловсруулах үйлдвэрийн газрын нэр, хаяг, байршил; 90.2.4.барааг боловсруулах арга, үе шат, хугацаа; 90.2.5.барааг боловсруулахтай холбогдсон бусад мэдээлэл. 90.3.Гаалийн удирдах төв байгууллага нь энэ хуулийн 90.1-д заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 21 хоногийн дотор багтаан шийдвэрлэж, хариуг бичгээр мэдэгдэнэ. 90.4.Дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горимд байгаа барааг бусдад шилжүүлэх тохиолдолд гаалийн удирдах төв байгууллагад мэдэгдэнэ.	**169 дүгээр зүйл.Барааг дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд** 169.1.Барааг дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах үйл ажиллагаа эрхлэхийг хүсэгч хуулийн этгээд нь барааг гаалийн хилээр нэвтрүүлэхээс өмнө гаалийн удирдах төв байгууллагад хүсэлт гаргана. 169.2.Энэ хуулийн 169.1-д заасан хуулийн этгээд хүсэлтээ бичгээр гаргаж дараах мэдээлэл, бичиг баримтыг ирүүлнэ: 169.2.1.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, хаяг; 169.2.2.горимд байршуулах бараа, түүгээр боловсруулах бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллын код, орцын норм, хаягдал, үлдэгдлийн хэмжээ; 169.2.3.барааг боловсруулах үйлдвэрийн газрын нэр, хаяг, байршил; 169.2.4.барааг боловсруулах арга, үе шат, хугацаа; 169.2.5.барааг боловсруулахтай холбогдсон бусад мэдээлэл. 169.3.Гаалийн удирдах төв байгууллага нь энэ хуулийн 169.1-д заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 21 хоногийн дотор багтаан шийдвэрлэж, хариуг бичгээр мэдэгдэнэ. 169.4.Дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горимд байгаа барааг бусдад шилжүүлэх тохиолдолд гаалийн удирдах төв байгууллагад мэдэгдэнэ.		-
701.	**91 дүгээр зүйл. Дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах барааны хаягдал, үлдэгдэл** 91.1.Дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах барааны боловсруулалтын явцад гарсан хаягдал, үлдэгдэлд мэдүүлэгчийн сонгосон гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийнэ.	**170 дугаар зүйл.Дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах барааны хаягдал, үлдэгдэл** 170.1.Дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах барааны боловсруулалтын явцад гарсан хаягдал, үлдэгдэлд мэдүүлэгчийн сонгосон гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийнэ.		-
702.	**92 дугаар зүйл.Дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горим дуусгавар болох** 92.1.Барааг дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горим холбогдох бараа, эсхүл түүгээр боловсруулсан бүтээгдэхүүнийг дотоодын хэрэглээнд зориулан оруулах горимд, эсхүл өөр горимд байршуулснаар дуусгавар болно.	**171 дүгээр зүйл.Дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горим дуусгавар болох** 171.1.Бараг дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горим холбогдох бараа, эсхүл түүгээр боловсруулсан бүтээгдэхүүнийг дотоодын хэрэглээнд зориулан оруулах горимд байршуулснаар дуусгавар болно.		-

НЭЛЭЭНИЙ ХУРЭЭЛЭН www.bij.gov.mn

703.	**Дөрөвдүгээр дэд бүлэг Барааг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горим**	**ДӨРӨВДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ БАРААГ ГААЛИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ТҮР ХУГАЦААГААР ОРУУЛАХ ГОРИМ**		-
704.	**93 дугаар зүйл.Барааг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимын агуулга** 93.1.Барааг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимын дагуу шаардагдах бичиг баримтыг үндэслэн гадаадын бараанд өөрчлөлт оруулахгүйгээр хугацаанд нь буцаан гаргах нөхцөлөөр гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулна. 93.2.Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан барааг зориулалтаар нь ашиглана. 93.3.Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан бараанд хадгалалт, тээвэрлэлт, ашиглалтын ердийн нөхцөлд гарах элэгдэл, хорогдлоос бусад өөрчлөлт оруулахыг хориглоно. 93.4.Хэрэглээнийх нь чанарыг хадгалах зорилгоор гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан бараанд үйлчилгээ хийж болно.	**172 дугаар зүйл. Барааг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимын агуулга** 172.1.Барааг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимын дагуу шаардагдах бичиг баримтыг үндэслэн гадаадын бараанд өөрчлөлт оруулахгүйгээр хугацаанд нь буцаан гаргах нөхцөлөөр гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулна. 172.2.Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан барааг зориулалтаар нь ашиглана. 172.3.Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан бараанд хадгалалт, тээвэрлэлт, ашиглалтын ердийн нөхцөлд гарах элэгдэл, хорогдлоос бусад өөрчлөлт оруулахыг хориглоно. 172.4.Хэрэглээнийх нь чанарыг хадгалах зорилгоор гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан бараанд үйлчилгээ хийж болно.		-
705.	**94 дүгээр зүйл. Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимд байршуулах бараа** 94.1.Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимд дараахь барааг байршуулна: 94.1.1.хилийн чанадаас ирсэн гадаадын бараа; 94.1.2.гаалийн баталгаат бүсээс оруулах гадаадын бараа.	**173 дугаар зүйл.Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимд байршуулах бараа** 173.1.Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимд дараах барааг байршуулна: 173.1.1.хилийн чанадаас ирсэн гадаадын бараа; 173.1.2.гаалийн баталгаат бүсээс оруулах гадаадын бараа.		-
706.		173.2.Барааг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимд дараах барааг байршуулж болохгүй: 173.2.1.арилжааны шинжтэй хүнсний бүтээгдэхүүн, согтууруулах ундаа, тамхи, түүхий эд, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, ашиглалтын явцад үрэгдэж үгүй болох бараа; 173.2.2.үйлдвэрийн болон бусад хаягдал; 173.2.3.Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон болон Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэхийн хориглосон бараа; 173.2.4.гаалийн тэмдэглэгээ хийх боломжгүй, мөн гаалийн хяналт тавих боломжгүй бараа; 173.2.5.гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар ашиглах зорилго нь тодорхой бус бараа.		*Шинээр нэмсэн*

ХУУЛЬ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН

707.	**95 дугаар зүйл. Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах барааnd гаалийн болон бусад татвар төлөх, баталгаа гаргах** 95.1.Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимд байршуулах барааnd гаалийн байгууллага импортын гаалийн болон бусад татвар ногдуулж, хураан авч, төрийн сангийн тусгай дансанд байршуулна. 95.2.Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимд бараг байршуулахад гаалийн байгууллага импортын гаалийн болон бусад татвар төлөх баталгааг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд заасны дагуу гаргуулан авч болно.			*Хасагдсан*
708.	**96 дугаар зүйл.Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах барааnd гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийх** 96.1.Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимд бараг байршуулахад гаалийн байгууллага тухайн барааnd гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийнэ. 96.2.Энэ хуулийн 96.1-д заасан тэмдэглэгээг хийхдээ мөн хуулийн 261.1-д заасан тэмдэглэгээнээс аль тохирохыг нь сонгон хэрэглэнэ.			*Хасагдсан*
709.	**97 дугаар зүйл. Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах барааг буцаан гаргах хугацаа**	**174 дүгээр зүйл.Горимд байршуулах хугацаа**		*Өөрчлөгдсөн*
710.	97.1.Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимд байршуулсан барааг гаалийн нутаг дэвсгэрээс буцаан гаргах хугацаа нь барааг тухайн горимд байршуулсан өдрөөс хойш газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах талаар Засгийн газартай байгуулсан гэрээний дагуу газрын тос хайх, олборлох, ашиглахад зориулагдсан бараа болон иргэний агаарын зорчигч тээврийн хөлөг онгоцны хувьд 3 жил 6 сар хүртэл, бусад барааны хувьд 1 жилээс дээшгүй байна. /Энэ хэсэгт 2010 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/	174.1.Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимд байршуулах хугацаа нь барааг тухайн горимд байршуулсан өдрөөс хойш 1 жилээс дээшгүй байна.		*Өөрчлөгдсөн*

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nlib.gov.mn

711.		174.2.Гаалийн удирдах төв байгууллага нь энэ хуулийн 171.3-т зааснаас бусад барааны энэ хуулийн 174.1-д заасан хугацааг 1 жил хүртэл хугацаагаар нэг удаа сунгаж болно. 174.3.Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах талаар Засгийн газартай байгуулсан гэрээний дагуу газрын тос хайх, олборлох, ашиглахад зориулагдсан бараа болон иргэний агаарын зорчигч тээврийн хөлөг онгоцны хувьд 3 жил 6 сараас хэтрэхгүй байна. 174.4.Барааны түр хугацаагаар оруулсан горимын хугацаа дууссан бол дотоодын хэрэглээнд зориулан оруулах горимоор гаалийн бүрдүүлэлт хийж, төрийн сангийн тусгай данснад байршуулсан гаалийн болон бусад татварыг улсын төсөвт төвлөрүүлнэ. 174.5.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасан баталгааг гаргаж түр хугацаагаар оруулсан барааг гаргаагүй тохиолдолд гаалийн болон бусад татварыг нөхөн төлүүлнэ.		*Шинээр нэмсэн*
712.	**98 дугаар зүйл.Барааг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горим дуусгавар болох** 98.1.Барааг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горим уг барааг хилийн чанадад буцаан гаргаснаар, эсхүл өөр горимд шилжүүлснээр дуусгавар болно.	**175 дугаар зүйл.Барааг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горим дуусгавар болох** 175.1.Барааг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горим уг барааг хилийн чанадад буцаан гаргаснаар, эсхүл өөр горимд шилжүүлснээр дуусгавар болно.		-
713.	**Тавдугаар дэд бүлэг Барааг гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах горим**	**ТАВДУГААР ДЭД БҮЛЭГ БАРААГ ГААЛИЙН НУТАГ ДЭВСГЭРТ БОЛОВСРУУЛАХ ГОРИМ**		-
714.	**99 дүгээр зүйл.Барааг гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах горимын агуулга** 99.1.Барааг гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах горимын дагуу шаардагдах бичиг баримтыг үндэслэн гадаадын барааг боловсруулж хугацаанд нь буцаан гаргах нөхцөлөөр гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулна. 99.2.Энэ хуулийн 99.1-д заасан боловсруулах үйл ажиллагаанд дараахь үйл ажиллагаа хамаарна:	**176 дугаар зүйл.Барааг гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах горимын агуулга** 176.1.Барааг гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах горимын дагуу шаардагдах бичиг баримтыг үндэслэн гадаадын барааг боловсруулж хугацаанд нь буцаан гаргах нөхцөлөөр гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулна. 176.2.Энэ хуулийн 176.1-д заасан боловсруулах үйл ажиллагаанд дараах үйл ажиллагаа хамаарна:		-
715.	99.2.1.тухайн барааг боловсруулах, эсхүл баяжуулах; 99.2.2.тухайн бараагаар шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх; 99.2.3.тухайн бараанд засвар хийх; 99.2.4.тухайн барааг өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглах.	176.2.1.тухайн барааг боловсруулах, эсхүл баяжуулах буюу түүхий эд, материалыг цэвэршүүлэх, анхан шатны боловсруулалт хийх зэргээр үйлдвэрлэлд ашиглахад бэлэн болгох; 176.2.2.тухайн аж ахуйн нэгж өөрийн хийсэн гэрээ, хэлцлийн дагуу гаалийн хилээр нэвтрүүлсэн үндсэн түүхий эд материалаар эцсийн, эсхүл хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх; 176.2.3.тухайн барааны эвдэрч гэмтсэн хэсгийг засах, солих, шинэчлэх, дутуу хэсгийг нөхөн гүйцээх; 176.2.4.тухайн барааг өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглах.		*Өөрчлөн найруулсан*

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.legal.mn

716.	99.3.Энэ хуулийн 99.2.4-т зааснаар тухайн барааг ашиглах явцад бараа уусах, шингэх зэрэг байдлаар үгүй болж болно.	176.3.Энэ хуулийн 176.2.4-т зааснаар тухайн барааг ашиглах явцад бараа уусах, шингэх зэрэг байдлаар үгүй болж болно.		-
717.	**100 дугаар зүйл.Гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах горимд байршуулах бараанд тавих шаардлага** 100.1.Гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах горимд байршуулах бараа дараахь шаардлагыг хангасан байна: 100.1.1.тухайн барааны боловсруулалтад гаалийн байгууллага хяналт тавих боломжтой байх; 100.1.2.гаалийн байгууллага тухайн барааг боловсруулсан бүтээгдэхүүнээс ялгах боломжтой байх.	**177 дугаар зүйл.Гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах горимд байршуулах бараанд тавих шаардлага** 177.1.Гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах горимд байршуулах бараа дараах шаардлагыг хангасан байна: 177.1.1.тухайн барааны боловсруулалтад гаалийн байгууллага хяналт тавих боломжтой байх; 177.1.2.гаалийн байгууллага тухайн барааг боловсруулсан бүтээгдэхүүнээс ялгах боломжтой байх.		-
718.	**101 дүгээр зүйл.Гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах горимд байршуулах бараа** 101.1.Гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах горимд дараахь барааг байршуулна: 101.1.1.хилийн чанадаас ирсэн гадаадын бараа; 101.1.2.гаалийн баталгаат бүсээс оруулах гадаадын бараа.	**178 дугаар зүйл.Гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах горимд байршуулах бараа** 178.1.Гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах горимд дараах барааг байршуулна: 178.1.1.хилийн чанадаас ирсэн гадаадын бараа; 178.1.2.гаалийн баталгаат бүсээс оруулах гадаадын бараа.		-
719.		178.1.3.гаалийн байгууллагын зөвшөөрлийг үндэслэн чанар, техникийн болон бусад шинж байдлаар адил үзүүлэлт бүхий энэ хуулийн 178.1, 178.2-т заасан барааг орлох дотоодын, эсхүл гадаадын өөр бараа.		*Шинээр нэмсэн*
720.	**102 дугаар зүйл.Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах бараанд гаалийн болон бусад татвар төлөх, баталгаа гаргах** 102.1.Гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах горимд байршуулах бараанд гаалийн байгууллага импортын гаалийн болон бусад татвар ногдуулж, хураан авч төрийн сангийн тусгай дансанд төвлөрүүлнэ.			*Хасагдсан*
721.	**103 дугаар зүйл. Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах бараанд гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийх** 103.1.Гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах горимд байршуулах бараанд гаалийн байгууллага гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийнэ. 103.2.Энэ хуулийн 103.1-д заасан тэмдэглэгээг хийхдээ мөн хуулийн 261.1-д заасан тэмдэглэгээнээс аль тохирохыг нь сонгон хэрэглэнэ.			*Хасагдсан*

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛИЙ ХҮРЭЭЛЭН
www.mn.gov.mn

722.	**104 дүгээр зүйл.Барааг буцаан гаргах хугацаа**	**179 дүгээр зүйл.Горимд байршуулах хугацаа**		*Өөрчлөгдсөн*
723.	104.1.Гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах горимд байршуулсан барааг гаалийн нутаг дэвсгэрээс буцаан гаргах хугацаа нь уг барааг тухайн горимд байршуулсан өдрөөс хойш 1 жилээс дээшгүй байна.	179.1.Гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах горимд байршуулсан хугацаа нь уг барааг тухайн горимд байршуулсан өдрөөс хойш 1 жилээс дээшгүй байна.		*“барааг гаалийн нутаг дэвсгэрээс буцаан гаргах” гэснийг хассан*
724.	104.2.Гаалийн удирдах төв байгууллага нь энэ хуулийн 104.1-д заасан хугацааг 6 сар хүртэл хугацаагаар нэг удаа сунгаж болно.	179.2.Гаалийн удирдах төв байгууллага нь энэ хуулийн 179.1-д заасан хугацааг 1 жил хүртэл хугацаагаар нэг удаа сунгаж болно.		*“6 сар “ гэснийг “1 жил” гэж өөрчилсөн*
725.		179.3.Горимд байршуулсан хугацаанд буцаан гаргаагүй бараанд гаалийн байгууллага зохих горимоор гаалийн бүрдүүлэлт хийж, тусгай дансанд байршуулсан гаалийн болон бусад татварыг улсын төсөвт төвлөрүүлнэ.		*Шинээр нэмсэн*
726.	**105 дугаар зүйл.Гаалийн нутаг дэвсгэрт бараа боловсруулах үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд** 105.1.Гаалийн нутаг дэвсгэрт бараа боловсруулах хуулийн этгээд нь гаалийн удирдах төв байгууллагад урьдчилан хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.	**180 дугаар зүйл.Гаалийн нутаг дэвсгэрт бараа боловсруулах үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд** 180.1.Гаалийн нутаг дэвсгэрт бараа боловсруулах хуулийн этгээд нь гаалийн удирдах төв байгууллагад урьдчилан мэдэгдэнэ.		-
727.	105.2.Энэ хуулийн 105.1-д заасан хүсэлтийг шийдвэрлэхэд гаалийн удирдах төв байгууллага энэ хуулийн 90.2, 90.3-т заасныг баримтална.			*Хассан*
728.	**106 дугаар зүйл.Гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах барааны хаягдал, үлдэгдэл** 106.1.Барааг гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах явцад гарсан үйлдвэрийн хаягдал, үлдэгдэлд мэдүүлэгчийн сонгосон горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийнэ.	**181 дүгээр зүйл.Гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах барааны хаягдал, үлдэгдэл** 181.1.Барааг гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах явцад гарсан үйлдвэрийн хаягдал, үлдэгдэлд мэдүүлэгчийн сонгосон горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийнэ.		-
729.	**107 дугаар зүйл.Барааг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горим дуусгавар болох** 107.1.Барааг гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах горим нь барааг гаалийн нутаг дэвсгэрээс буцаан гаргаснаар, эсхүл өөр горимд байршуулснаар дуусгавар болно.	**182 дугаар зүйл.Барааг гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах горим дуусгавар болох** 182.1.Барааг гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах горим нь барааг гаалийн нутаг дэвсгэрээс буцаан гаргаснаар, эсхүл өөр горимд байршуулснаар дуусгавар болно.		-
730.	**Зургадугаар дэд бүлэг Барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах горим**	**ЗУРГААДУГААР ДЭД БҮЛЭГ БАРААГ ГААЛИЙН НУТАГ ДЭВСГЭРТ БУЦААН ОРУУЛАХ ГОРИМ**		-
731.	**108 дугаар зүйл.Барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах горимын агуулга** 108.1.Барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах горимын дагуу шаардагдах бичиг баримтыг үндэслэн энэ хуулийн 79.2.1-д заасан горимын дагуу хилийн чанадад гаргасан монголын барааг Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулна.	**183 дугаар зүйл.Барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах горимын агуулга** 183.1.Барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах горимын дагуу шаардагдах бичиг баримтыг үндэслэн энэ хуулийн 191, 195, 200 дүгээр зүйлд заасан горимын дагуу хилийн чанадад гаргасан монголын барааг Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулна.		-

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.legal.mn

732.	**109 дүгээр зүйл.Гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах горимд байршуулах бараа** 109.1.Гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах горимд дараахь барааг байршуулна: 109.1.1.хилийн чанадаас оруулах монголын бараа; 109.1.2.гаалийн баталгаат бүсийн горимд байршуулсан монголын бараа. 109.2.Хилийн чанадад бүрмөсөн гаргасан монголын барааг өөрчлөлт орсон бол гадаадын бараа гэж үзэж гаалийн бүрдүүлэлтийн өөр горимд байршуулна.	**184 дүгээр зүйл.Гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах горимд байршуулах бараа** 184.1.Гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах горимд дараах барааг байршуулна: 184.1.1.хилийн чанадаас оруулах монголын бараа; 184.1.2.гаалийн баталгаат бүсийн горимд байршуулсан монголын бараа. 184.2.Хилийн чанадад бүрмөсөн гаргасан монголын барааг өөрчлөлт орсон бол гадаадын бараа гэж үзэж гаалийн бүрдүүлэлтийн өөр горимд байршуулна.		-
733.		184.3.Гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах горимд байршуулах бараа тарифын бус хязгаарлалтад хамаарна.		*Шинээр нэмсэн*
734.	**110 дугаар зүйл. Гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах барааг гаалийн болон бусад татвар төлөх** 110.1.Гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах бараа монголын бараа болох нь нотлогдсон тохиолдолд тухайн барааг гаалийн байгууллага импортын гаалийн болон бусад татвар ногдуулахгүй. 110.2.Хилийн чанадад бүрмөсөн гаргасан монголын барааг буцаан оруулахад экспортын гаалийн болон бусад татварыг буцаан олгохгүй	**185 дугаар зүйл.Гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах барааг гаалийн болон бусад татвар төлөх** 185.1.Гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах бараа монголын бараа болох нь нотлогдсон тохиолдолд гаалийн байгууллага импортын гаалийн болон бусад татвар ногдуулахгүй. 185.2.Хилийн чанадад бүрмөсөн гаргасан монголын барааг буцаан оруулахад экспортын гаалийн болон бусад татварыг буцаан олгохгүй.		-
735.	.	185.3.Хилийн чанадад бүрмөсөн гаргасан барааг хадгалалт тээвэрлэлт, ашиглалтын ердийн нөхцөлд гарах элэгдэл хорогдлоос өөр өөрчлөлт орсон бол гадаадын бараа гэж үзэж гаалийн бүрдүүлэлтийн өөр горимд байршуулан гаалийн болон бусад татварыг ногдуулж, хураан авч, улсын төсөвт төвлөрүүлнэ. 185.4.Хилийн чанадад боловсруулсан барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах горимд байршуулах барааг гаалийн үнээс экспортлосон үеийн барааны үнийг хасч гаалийн болон бусад татвар ногдуулж, хураан авч, улсын төсөвт төвлөрүүлнэ. 185.5.Хилийн чанадад түр хугацаагаар гаргасан болон хилийн чанадад боловсруулахаар гаргасан барааг тухайн горимд байршуулах хугацаанд нь буцаан оруулсан тохиолдолд хилээр гарахад төлж, тусгай дансанд байршуулсан экспортын татварыг буцаан олгоно.		*Шинээр нэмсэн*
736.	**111 дүгээр зүйл.Барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулахад бүрдүүлэх бичиг баримт** 111.1.Барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах горимд байршуулахад түүнийг урьд нь гаалийн хилээр гаргахад бүрдүүлсэн гаалийн мэдүүлгийг гаалийн байгууллагад гаргаж өгнө.	**186 дугаар зүйл.Барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулахад бүрдүүлэх бичиг баримт** 186.1.Барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах горимд байршуулахадурьд нь гаалийн хилээр гаргахад бүрдүүлсэн гаалийн мэдүүлгийг гаалийн байгууллагад гаргаж өгнө.		-

737.	**112 дугаар зүйл. Гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах горим дуусгавар болох** 112.1.Барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах горим нь түүнийг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулснаар, эсхүл өөр горимд шилжүүлснээр дуусгавар болно.	**187 дугаар зүйл зүйл.Гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах горим дуусгавар болох** 187.1.Барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах горим нь түүнийг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулснаар, эсхүл өөр горимд шилжүүлснээр дуусгавар болно.		-
738.	**ЕСДҮГЭЭР БҮЛЭГ** **Барааг хилийн чанадад гаргах горим**	**АРВАНГУРАВДУГААР БҮЛЭГ** **БАРААГ ХИЛИЙН ЧАНАДАД ГАРГАХ ГОРИМ**		-
739.	**Нэгдүгээр дэд бүлэг** **Барааг хилийн чанадад гаргах горимын нийтлэг үндэслэл**	**НЭГДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ** **БАРААГ ХИЛИЙН ЧАНАДАД ГАРГАХ ГОРИМЫН НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**		-
740.	**113 дугаар зүйл.Барааг хилийн чанадад гаргахад гаалийн болон бусад татвар төлөх, баталгаа гаргуулах** 113.1.Хилийн чанадад гаргах горимд байршуулсан барааанд гаалийн байгууллага экспортын гаалийн болон бусад татвар ногдуулж, хураан авч, улсын төсөвт төвлөрүүлнэ.	**188 дугаар зүйл.Барааг хилийн чанадад гаргах горимын дагуу гаалийн болон бусад татвар төлөх, баталгаа гаргуулах** 188.1.Хилийн чанадад гаргах горимд байршуулах барааанд гаалийн байгууллага экспортын гаалийн болон бусад татвар ногдуулж, хураан авч, улсын төсөвт төвлөрүүлнэ.		-
741.	113.2.Хилийн чанадад гаргах горимд байршуулсан барааанд гаалийн байгууллага экспортын гаалийн болон бусад татвар төлөх баталгааг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд заасны дагуу гаргуулан авч болно.	188.3.Барааг гаалийн нутаг дэвсгэрт оруулах горимд байршуулахад гаалийн байгууллага экспортын гаалийн болон бусад татвар төлөх баталгааг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд заасны дагуу гаргуулан авч болно.		*“Хилийн чанадад гаргах горимд байршуулсан барааанд” гэснийг “Барааг гаалийн нутаг дэвсгэрт оруулах горимд байршуулахад” гэж өөрчилсөн*
742.		188.2.Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар гаргасан барааг хилийн чанадад бүрмөсөн гаргахад гаалийн болон бусад татварыг ногдуулж, энэ хуулийн 195, 200 дугаар зүйлд заасан горимоор бүрдүүлэлт хийлгэхдээ гаалийн болон бусад татвар төлсөн мэдүүлгийг үндэслэн татварыг төлүүлэхгүйгээр төрийн сангийн тусгай дансанд байршуулсан мөнгийг улсын төсөвт төвлөрүүлнэ.		*Шинээр нэмсэн*
743.		188.4.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасан баталгааг гаргаж, түр хугацаагаар хилийн чанадад гаргасан барааг буцаан оруулаагүй тохиолдолд гаалийн болон бусад татварыг нөхөн төлүүлнэ.		*Шинээр нэмсэн*

Хууль зүйн үндэсний хүрээлэн

744.	**114 дүгээр зүйл.Хилийн чанадад гаргах горимд байршуулсан барааны тарифын бус хязгаарлалт** 114.1.Хилийн чанадад гаргах горимд байршуулсан бараанд Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалтад хамаарна.	**189 дүгээр зүйл.Гаалийн нутаг дэвсгэрээс гаргах горимын бараа тарифын бус хязгаарлалтад хамаарах** 189.1.Гаалийн нутаг дэвсгэрээс гаргах горимын бараа тарифын бус хязгаарлалтад хамаарна.		*"Хилийн чанадад гаргах горимд байршуулсан бараанд Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад" гэснийг "Гаалийн нутаг дэвсгэрээс гаргах горимын бараа" гэж өөрчилсөн*
745.	**Хоёрдугаар дэд бүлэг** **Барааг хилийн чанадад бүрмөсөн гаргах горим**	**ХОЁРДУГААР ДЭД БҮЛЭГ** **БАРААГ ХИЛИЙН ЧАНАДАД БҮРМӨСӨН ГАРГАХ ГОРИМ**		-
746.	**115 дугаар зүйл.Барааг хилийн чанадад бүрмөсөн гаргах горимын агуулга** 115.1.Барааг хилийн чанадад бүрмөсөн гаргах горимын дагуу шаардагдах бичиг баримтыг үндэслэн монголын барааг түүний экспортын гаалийн болон бусад татварыг төлүүлсний үндсэн дээр гаалийн нутаг дэвсгэрээс гаргана.	**191 дүгээр зүйл.Барааг хилийн чанадад бүрмөсөн гаргах горимын агуулга** 191.1.Барааг хилийн чанадад бүрмөсөн гаргах горимын дагуу шаардагдах бичиг баримтыг үндэслэн монголын барааг экспортын гаалийн болон бусад татварыг төлүүлж гаалийн нутаг дэвсгэрээс гаргана.		*"төлүүлсний үндсэн дээр" гэснийг "төлүүлж" гэж өөрчилсөн*
747.	**116 дугаар зүйл.Хилийн чанадад бүрмөсөн гаргах горимд байршуулах бараа** 116.1.Хилийн чанадад бүрмөсөн гаргах горимд дараахь барааг байршуулна: 116.1.1.гаалийн нутаг дэвсгэрт байгаа монголын бараа; 116.1.2.гаалийн бусад горимд байгаа монголын бараа.	**192 дугаар зүйл.Хилийн чанадад бүрмөсөн гаргах горимд байршуулах бараа** 192.1.Хилийн чанадад бүрмөсөн гаргах горимд дараах барааг байршуулна: 192.1.1.гаалийн нутаг дэвсгэрт байгаа монголын бараа; 192.1.2.гаалийн бусад горимд байгаа монголын бараа.		-
748.	**117 дугаар зүйл.Чөлөөт эргэлтэд орсон гадаадын барааг хилийн чанадад бүрмөсөн гаргах** 117.1.Чөлөөт эргэлтэд орсон гадаадын барааг хилийн чанадад бүрмөсөн гаргахад урьд нь төлсөн импортын гаалийн болон бусад татварыг буцаан олгохгүй.	**193 дугаар зүйл.Чөлөөт эргэлтэд орсон гадаадын барааг хилийн чанадад бүрмөсөн гаргах** 193.1.Чөлөөт эргэлтэд орсон гадаадын барааг хилийн чанадад бүрмөсөн гаргахад урьд нь төлсөн импортын гаалийн болон бусад татварыг буцаан олгохгүй.		-
749.	**118 дугаар зүйл.Барааг хилийн чанадад бүрмөсөн гаргах горим дуусгавар болох** 118.1.Барааг улсын хилээр гаргаснаар, эсхүл өөр горимд шилжүүлснээр хилийн чанадад бүрмөсөн гаргах горим дуусгавар болно.	**194 дүгээр зүйл.Барааг хилийн чанадад бүрмөсөн гаргах горим** **дуусгавар болох** 194.1.Барааг улсын хилээр гаргаснаар, эсхүл өөр горимд шилжүүлснээр хилийн чанадад бүрмөсөн гаргах горим дуусгавар болно.		-

ХУДАЛЬ ЗҮЙЛ ҮЙЛДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.mn.gov.mn

750.	**Гуравдугаар дэд бүлэг Барааг хилийн чанадад түр хугацаагаар гаргах горим**	**ГУРАВДУГААР ДЭД БҮЛЭГ БАРААГ ХИЛИЙН ЧАНАДАД ТҮР ХУГАЦААГААР ГАРГАХ ГОРИМ**		-
751.	**119 дүгээр зүйл.Барааг хилийн чанадад түр хугацаагаар гаргах горимын агуулга** 119.1.Барааг хилийн чанадад түр хугацаагаар гаргах горимын дагуу монголын барааnd өөрчлөлт оруулахгүйгээр хугацаанд нь буцаан оруулах нөхцөлөөр, гаалийн бичиг баримтыг үндэслэн гаалийн нутаг дэвсгэрээс түр хугацаагаар гаргана. 119.2.Хилийн чанадад түр хугацаагаар гаргах барааnd хадгалалт, тээвэрлэлт, ашиглалтын ердийн нөхцөлд гарах элэгдэл, хорогдлоос бусад өөрчлөлт оруулахыг хориглоно.	**195 дугаар зүйл.Барааг хилийн чанадад түр хугацаагаар гаргах горимын агуулга** 195.1.Барааг хилийн чанадад түр хугацаагаар гаргах горимын дагуу монголын барааnd өөрчлөлт оруулахгүйгээр хугацаанд нь буцаан оруулах нөхцөлөөр, гаалийн бичиг баримтыг үндэслэн гаалийн нутаг дэвсгэрээс түр хугацаагаар гаргана. 195.2.Хилийн чанадад түр хугацаагаар гаргах барааnd хадгалалт, тээвэрлэлт, ашиглалтын ердийн нөхцөлд гарах элэгдэл, хорогдлоос бусад өөрчлөлт оруулахыг хориглоно.		-
752.	119.3.Барааны хэрэглээний чанарыг хадгалах зорилгоор гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан барааnd үйлчилгээ хийж болно.	195.3.Хилийн чанадад түр хугацаагаар гаргасан барааны хэрэглээний чанарыг хадгалах зорилгоор үйлчилгээ хийж болно.		*Өөрчлөн найруулсан*
753.	**120 дугаар зүйл.Хилийн чанадад түр хугацаагаар гаргах горимд байршуулах бараа** 120.1.Хилийн чанадад түр хугацаагаар гаргах горимд дараахь барааг байршуулна: 120.1.1.гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд байгаа монголын бараа; 120.1.2.бусад горимоос оруулах бараа.	**196 дугаар зүйл.Хилийн чанадад түр хугацаагаар гаргах горимд байршуулах бараа** 196.1.Хилийн чанадад түр хугацаагаар гаргах горимд дараах барааг байршуулна: 196.1.1.гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд байгаа монголын бараа; 196.1.2.бусад горимоос оруулах бараа.		-
754.	**121 дүгээр зүйл.Чөлөөт эргэлтэд оруулсан гадаадын барааг хилийн чанадад түр хугацаагаар гаргах** 121.1.Чөлөөт эргэлтэд оруулсан гадаадын барааг хилийн чанадад түр хугацаагаар гаргахад урьд нь төлсөн импортын гаалийн болон бусад татварыг буцаан олгохгүй.	**197 дугаар зүйл.Чөлөөт эргэлтэд оруулсан гадаадын барааг хилийн чанадад түр хугацаагаар гаргах** 197.1.Чөлөөт эргэлтэд оруулсан гадаадын барааг хилийн чанадад түр хугацаагаар гаргахад урьд нь төлсөн импортын гаалийн болон бусад татварыг буцаан олгохгүй.		-
755.	**122 дугаар зүйл.Хилийн чанадад түр хугацаагаар гаргах горимд байршуулах барааnd гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийх**	**190 дугаар зүйл.Барааnd гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийх**		*“Хилийн чанадад түр хугацаагаар гаргах горимд байршуулах” гэснийг хассан*
756.	122.1.Гаалийн нутаг дэвсгэрээс түр хугацаагаар гаргах горимд байршуулах барааnd гаалийн байгууллага гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийнэ.	190.1.Энэ хуулийн 191, 195, 200, 206 дугаар зүйлд заасан горимд байршуулах барааnd гаалийн байгууллага гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийнэ.		*“Гаалийн нутаг дэвсгэрээс түр хугацаагаар гаргах” гэснийг “Энэ хуулийн 191, 195, 200, 206 дугаар зүйлд заасан” гэж өөрчилсөн*
757.	122.2.Энэ хуулийн 122.1-д заасан тэмдэглэгээ хийхдээ мөн хуулийн 261.1-д заасан тэмдэглэгээнээс аль тохирохыг нь сонгон хэрэглэнэ.	190.2..Энэ хуулийн 190.1-д заасан тэмдэглэгээ хийхдээ мөн хуулийн мөн хуулийн 135.1-д заасан т.эмдэглэгээнээс аль тохирохыг нь сонгон хэрэглэнэ.		-

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.legal.mn

758.	**123 дугаар зүйл.Барааг буцаан оруулах хугацаа** 123.1.Хилийн чанадад түр хугацаагаар гаргах горимд байршуулсан барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах хугацаа нь барааг уг горимд байршуулсан өдрөөс хойш 1 жилээс дээшгүй байна.	**198 дугаар зүйл.Барааг горимд байршуулах хугацаа** 198.1.Хилийн чанадад түр хугацаагаар гаргах горимд байршуулах хугацаа нь барааг уг горимд байршуулсан өдрөөс хойш 1 жилээс дээшгүй байна.		*“байршуулсан” гэснийг “байршуулах хугацаа нь” гэж өөрчилсөн*
759.	123.2.Гаалийн удирдах төв байгууллага нь энэ хуулийн 123.1-д заасан хугацааг 6 сар хүртэл хугацаагаар нэг удаа сунгаж болно	198.2.Гаалийн удирдах төв байгууллага нь энэ хуулийн 198.1-д заасан хугацааг 1 жил хүртэл хугацаагаар нэг удаа сунгаж болно.		*“6 сар” гэснийг “1 жил” гэж өөрчилсөн*
760.	**124 дүгээр зүйл.Барааг хилийн чанадад түр хугацаагаар гаргах горим дуусгавар болох** 124.1.Барааг хилийн чанадад түр хугацаагаар гаргах горим нь уг барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулснаар, эсхүл өөр горимд байршуулснаар дуусгавар болно.	**199 дугаар зүйл.Барааг хилийн чанадад түр хугацаагаар гаргах горим дуусгавар болох** 199.1.Барааг хилийн чанадад түр хугацаагаар гаргах горим нь уг барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулснаар, эсхүл өөр горимд байршуулснаар дуусгавар болно.		-
761.	**Дөрөвдүгээр дэд бүлэг Барааг хилийн чанадад боловсруулах горим**	**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БАРААГ ХИЛИЙН ЧАНАДАД БОЛОВСРУУЛАХ ГОРИМ**		-
762.	**125 дугаар зүйл.Барааг хилийн чанадад боловсруулах горимын агуулга** 125.1.Барааг хилийн чанадад боловсруулах горимын дагуу шаардагдах бичиг баримтыг үндэслэн монголын барааг хилийн чанадад боловсруулж хугацаанд нь буцаан оруулах нөхцөлөөр түр хугацаагаар хилийн чанадад гаргана. 125.2.Энэ хуулийн 125.1-д заасан “боловсруулах” гэдгийг мөн хуулийн 99.2-т заасан утгаар ойлгоно.	**200 дугаар зүйл.Барааг хилийн чанадад боловсруулах горимын агуулга** 200.1.Барааг хилийн чанадад боловсруулах горимын дагуу шаардагдах бичиг баримтыг үндэслэн барааг хилийн чанадад боловсруулж хугацаанд нь буцаан оруулах нөхцөлөөр түр хугацаагаар хилийн чанадад гаргана. 200.2.Энэ хуулийн 200.1-д заасан “боловсруулах” гэдгийг мөн хуулийн 176.2-т заасан утгаар ойлгоно.		-
763.		200.3.Чөлөөт эргэлтэд орсон гадаадын барааг хилийн чанадад боловсруулалт хийхэд урьд нь төлсөн импортын гаалийн болон бусад татварыг буцаан олгохгүй. 200.4.Хилийн чанадад боловсруулах горимд байршуулсан бараанд тарифын бус хязгаарлалт хамаарна.		*Шинээр нэмсэн*
764.	**126 дугаар зүйл.Хилийн чанадад боловсруулах горимд байршуулах бараанд тавих шаардлага** 126.1.Хилийн чанадад боловсруулах горимд байршуулах бараа дараахь шаардлагыг хангасан байна: 126.1.1.тухайн барааны боловсруулалтад гаалийн байгууллага хяналт тавих боломжтой; 126.1.2.гаалийн байгууллага тухайн барааг оролцуулан боловсруулсан бүтээгдэхүүнд гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийх боломжтой.	**201 дүгээр зүйл.Хилийн чанадад боловсруулах горимд байршуулах бараанд тавих шаардлага** 201.1..Хилийн чанадад боловсруулах горимд байршуулах бараа дараах шаардлагыг хангасан байна: 201.1.1.тухайн барааны боловсруулалтад гаалийн байгууллага хяналт тавих боломжтой; 201.1.2.гаалийн байгууллага тухайн барааг оролцуулан боловсруулсан бүтээгдэхүүнд гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийх боломжтой.		-

ХЭВЛЭЛИЙН ЭРХИЙН ХУРЭЭЛЭН
www.legalinfo.mn

765.		201.1.3.гэмтэл, согогтой барааг өөр бараагаар солих тохиолдолд солигдох барааны чанар, техникийн үзүүлэлт, ангиллын код Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн 8 оронгийн түвшинд адилхан байх; 201.1.4.гэмтэл, согогтой барааг хилээр гаргахаас өмнө гаалийн байгууллагаас тавьсан нөхцөл шаардлагын дагуу солих барааг оруулж болно. 201.1.5.Гэмтэл, согогтой барааг хилээр гаргаагүй тохиолдолд түүнийг солихоор оруулах бараанд гаалийн болон бусад татварыг ногдуулан хураан авна.		*Шинээр нэмсэн*
766.	**127 дугаар зүйл.Хилийн чанадад боловсруулах горимд байршуулах бараа** 127.1.Хилийн чанадад боловсруулах горимд дараахь барааг байршуулна: 127.1.1.гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд байгаа монголын бараа; 127.1.2.бусад горимоос оруулах бараа.	**202 дугаар зүйл.Хилийн чанадад боловсруулах горимд байршуулах бараа** 202.1.Хилийн чанадад боловсруулах горимд дараах барааг байршуулна: 202.1.1.гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд байгаа монголын бараа; 202.1.2.бусад горимоос байршуулах бараа.		-
767.	**128 дугаар зүйл.Чөлөөт эргэлтэд оруулсан гадаадын барааг хилийн чанадад боловсруулах горимд байршуулах** 128.1.Чөлөөт эргэлтэд оруулсан гадаадын барааг хилийн чанадад боловсруулах горимд байршуулахад урьд нь төлсөн импортын гаалийн болон бусад татварыг буцаан олгохгүй.	**203 дугаар зүйл.Чөлөөт эргэлтэд оруулсан гадаадын барааг хилийн чанадад боловсруулах горимд байршуулах** 203.1.Чөлөөт эргэлтэд оруулсан гадаадын барааг хилийн чанадад боловсруулах горимд байршуулахад урьд нь төлсөн импортын гаалийн болон бусад татварыг буцаан олгохгүй.		-
768.	**129 дүгээр зүйл.Хилийн чанадад боловсруулах горимын бараанд гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийх**	**190 дугаар зүйл.Бараанд гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийх**		*“Хилийн чанадад боловсруулах горимын” гэснийг хассан*
769.	129.1.Барааг хилийн чанадад боловсруулах горимд байршуулахад гаалийн байгууллага тухайн бараанд гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийнэ.	190.1.Энэ хуулийн 191, 195, 200, 206 дугаар зүйлд заасан горимд байршуулах бараанд гаалийн байгууллага гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийнэ.		*“Барааг хилийн чанадад боловсруулах горимд байршуулахад гаалийн байгууллага тухайн” гэснийг “Энэ хуулийн 191, 195, 200, 206 дугаар зүйлд заасан горимд байршуулах” гэж өөрчилсөн*
770.	129.2.Энэ хуулийн 129.1-д заасан тэмдэглэгээ хийхдээ мөн хуулийн 261.1-д заасан тэмдэглэгээнээс аль тохирохыг нь сонгон хэрэглэнэ.	190.2..Энэ хуулийн 190.1-д заасан тэмдэглэгээ хийхдээ мөн хуулийн мөн хуулийн 135.1-д заасан т.эмдэглэгээнээс аль тохирохыг нь сонгон хэрэглэнэ.		*“Барааг хилийн чанадад боловсруулах” гэснийг “Энэ хуулийн 191, 195, 200, 206 дугаар зүйлд заасан” гэж өөрчилсөн*
771.	**130 дугаар зүйл.Барааг буцаан оруулах хугацаа** 130.1.Хилийн чанадад боловсруулах горимд байршуулсан барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах хугацаа нь тухайн барааг уг горимд байршуулсан өдрөөс хойш 1 жилээс дээшгүй байна.	**204 дүгээр зүйл.Горимд байршуулах хугацаа** 204.1.Хуульд өөрөөр заагаагүй бол хилийн чанадад боловсруулах горимд байршуулах хугацаа нь тухайн барааг уг горимд байршуулсан өдрөөс хойш 1 жилээс дээшгүй байна.		

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.legal.mn

772.	130.2.Гаалийн удирдах төв байгууллага нь энэ хуулийн 130.1-д заасан хугацааг 6 сар хүртэл хугацаагаар нэг удаа сунгаж болно.	204.2.Гаалийн удирдах төв байгууллага нь энэ хуулийн 204.1-д заасан хугацааг 1 жил хүртэл хугацаагаар нэг удаа сунгаж болно.		*“6 сар” гэснийг “1 жил” гэж өөрчилсөн*
773.		204.3.Горимд байршуулсан хугацаанд буцаан оруулаагүй бараанд гаалийн байгууллага зохих горимоор гаалийн бүрдүүлэлт хийж, тусгай дансанд байршуулсан гаалийн болон бусад татварыг улсын төсөвт төвлөрүүлнэ. 204.4.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасан баталгааг гаргаж боловсруулалт хийхээр хилийн чанадад гаргасан барааг буцаан оруулаагүй тохиолдолд гаалийн болон бусад татварыг нөхөн төлүүлнэ.		*Шинээр нэмсэн*
774.	**131 дүгээр зүйл. Барааг хилийн чанадад боловсруулах горим дуусгавар болох** 131.1.Барааг хилийн чанадад боловсруулах горим нь уг барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулснаар, эсхүл өөр горимд байршуулснаар дуусгавар болно.	**205 дугаар зүйл.Барааг хилийн чанадад боловсруулах горим дуусгавар болох** 205.1.Барааг хилийн чанадад боловсруулах горим нь уг барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулснаар, эсхүл өөр горимд байршуулснаар дуусгавар болно.		-
775.	**Тавдугаар дэд бүлэг Барааг хилийн чанадад буцаан гаргах горим**	**ТАВДУГААР ДЭД БҮЛЭГ БАРААГ ХИЛИЙН ЧАНАДАД БУЦААН ГАРГАХ ГОРИМ**		-
776.	**132 дугаар зүйл.Барааг хилийн чанадад буцаан гаргах горимын агуулга** 132.1.Барааг хилийн чанадад буцаан гаргах горимын дагуу шаардагдах бичиг баримтыг үндэслэн гадаадынх болох нь нотлогдсон барааг гаалийн болон бусад татвар ногдуулахгүйгээр гаалийн нутаг дэвсгэрээс хилийн чанадад буцаан гаргана.	**206 дугаар зүйл.Барааг хилийн чанадад буцаан гаргах горимын агуулга** 206.1.Хилийн чанадад буцаан гаргах горимын дагуу шаардагдах бичиг баримтыг үндэслэн гадаадынх болох нь нотлогдсон барааг гаалийн болон бусад татвар ногдуулахгүйгээр гаалийн нутаг дэвсгэрээс хилийн чанадад буцаан гаргана.		-
777.		206.2.Хилийн чанадад буцаан гаргах горимд байршуулах бараанд тарифын бус хязгаарлалт хамаарна. 206.3.Хилийн чанадад буцаан гаргах горимд байршуулах барааг анх оруулсан боомтоос өөр боомтоор буцаан гаргаж болно. 206.4.Хилийн чанадад буцаан гаргах горимд байршуулах барааг анх оруулсан улсаас өөр улс руу гаргаж болно.		*Шинээр нэмсэн*
778.	**133 дугаар зүйл.Хилийн чанадад буцаан гаргах горимд байршуулах бараа** 133.1.Хилийн чанадад буцаан гаргах горимд дараахь барааг байршуулна: 133.1.1.гаалийн нутаг дэвсгэрт байгаа бөгөөд чөлөөт эргэлтэд орсноос бусад гадаадын бараа; 133.1.2.гаалийн баталгаат бүсийн горимд байршуулсан гадаадын бараа.	**207 дугаар дугаар зүйл.Хилийн чанадад буцаан гаргах горимд байршуулах бараа** 207.1.Хилийн чанадад буцаан гаргах горимд дараах барааг байршуулна: 207.1.1.гаалийн нутаг дэвсгэрт байгаа бөгөөд чөлөөт эргэлтэд орсноос бусад гадаадын бараа; 207.1.2.гаалийн баталгаат бүсийн горимд байршуулсан гадаадын бараа.		-

www.legalinfo.mn Хууль зүйн мэдээллийн хүрээлэн

779.	**134 дүгээр зүйл.Хилийн чанадад буцаан гаргах горимын бараанд гаалийн болон бусад татвар төлөх, баталгаа гаргах**	**208 дугаар зүйл.Хилийн чанадад буцаан гаргах горимд байршуулах бараанд гаалийн болон бусад татвар төлөх, баталгаа гаргах**		*"горимын" гэснийг "горимд байршуулах" гэж өөрчилсөн*
780.	134.1.Хилийн чанадад буцаан гаргах бараа гадаадынх болох нь нотлогдвол тухайн бараанд гаалийн байгууллага экспортын гаалийн татвар ногдуулахгүй.	208.1.Хилийн чанадад буцаан гаргах бараа гадаадынх болох нь нотлогдвол тухайн бараанд гаалийн байгууллага экспортын гаалийн татвар ногдуулахгүй.		-
781.	34.2.Дотоодын хэрэглээнд зориулан оруулах горимд байршуулсан гадаадын барааг хилийн чанадад буцаан гаргахад урьд нь төлсөн импортын гаалийн болон бусад татварыг буцаан олгохгүй.			*Хасагдсан*
782.	134.3.Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан барааг хилийн чанадад буцаан гаргахад хадгалалт, тээвэрлэлтийн ердийн нөхцөлд гарах элэгдэл, хорогдлоос өөр өөрчлөлт орсон бол урьд нь төлсөн импортын гаалийн болон бусад татварыг буцаан олгохгүй.	208.2.Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан барааг хилийн чанадад буцаан гаргахад хадгалалт, тээвэрлэлтийн ердийн нөхцөлд гарах элэгдэл, хорогдлоос өөр өөрчлөлт орсон бол урьд нь төлсөн импортын гаалийн болон бусад татварыг буцаан олгохгүй.		-
783.	134.4.Гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах горимд байршуулсан гадаадын барааг хилийн чанадад буцаан гаргахдаа боловсруулалт хийсэн бол гарсан зардалд нь экспортын гаалийн болон бусад татвар ногдуулж, төлүүлнэ.	208.3.Гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах горимд байршуулсан барааг буцаан гаргахад боловсруулалт хийхэд гарсан зардалд нь экспортын гаалийн болон бусад татвар ногдуулж, төлүүлнэ.		*Өөрчилсөн*
784.	**135 дугаар зүйл.Гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу шаардагдах бичиг баримт** 135.1.Барааг хилийн чанадад буцаан гаргах горимд байршуулахад түүнийг урьд нь гаалийн хилээр оруулахад бүрдүүлсэн гаалийн мэдүүлгийг гаалийн байгууллагад гаргаж өгнө.	**209 дүгээр зүйл.Гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу шаардагдах бичиг баримт** 209.1.Барааг хилийн чанадад буцаан гаргах горимд байршуулахад урьд нь гаалийн хилээр оруулахад бүрдүүлсэн гаалийн мэдүүлгийг гаалийн байгууллагад гаргаж өгнө.		-
785.	**136 дугаар зүйл.Хилийн чанадад буцаан гаргах горим дуусгавар болох** 136.1.Барааг хилийн чанадад буцаан гаргах горим нь уг барааг гаалийн хилээр гаргаснаар, эсхүл өөр горимд байршуулснаар дуусгавар болно.	**210 дугаар зүйл.Хилийн чанадад буцаан гаргах горим дуусгавар болох** 210.1.Хилийн чанадад буцаан гаргах горим нь уг барааг гаалийн хилээр гаргаснаар, эсхүл өөр горимд байршуулснаар дуусгавар болно.		-
786.	**АРАВДУГААР БҮЛЭГ Гаалийн баталгаат бүсийн горим**	**АРВАНДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ГААЛИЙН БАТАЛГААТ БҮСИЙН ГОРИМ**		-
787.	**Нэгдүгээр дэд бүлэг Гаалийн баталгаат бүсийн горимын нийтлэг үндэслэл**	**НЭГДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**		*"Гаалийн баталгаат бүсийн горимын" гэснийг хассан*
788.	**137 дугаар зүйл.Гаалийн баталгаат бүсийн горимын зарчим** 137.1.Гаалийн баталгаат бүсийн горимд байршуулах бараанд уг горимын дагуу шаардагдах бичиг баримтыг үндэслэн гаалийн бүрдүүлэлт хийнэ.	**211 дүгээр зүйл.Гаалийн баталгаат бүсийн горимын зарчим** 211.1.Гаалийн баталгаат бүсийн горимд байршуулах бараанд уг горимындагуу шаардагдах бичиг баримтыг үндэслэн гаалийн бүрдүүлэлт хийнэ.		
789.	137.2.Барааг гаалийн нутаг дэвсгэрээр дамжуулахгүйгээр хилийн чанадаас шууд гаалийн баталгаат бүсийн горимд байршуулах, тэндээс мөн гаалийн нутаг дэвсгэрээр дамжуулахгүйгээр шууд хилийн чанадад гаргах тохиолдолд гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт хийх бөгөөд гаалийн болон бусад татвар төлөх баталгаа шаардахгүй.	211.2.Барааг гаалийн нутаг дэвсгэрээр дамжуулахгүйгээр хилийн чанадаас шууд гаалийн баталгаат бүсийн горимд байршуулах бараа, тэндээс мөн гаалийн нутаг дэвсгэрээр дамжуулахгүйгээр шууд хилийн чанадад гаргах тохиолдолд гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт хийх бөгөөд гаалийн болон бусад татвар төлөх баталгаа шаардахгүй.		*"байршуулах" гэсний дараа "бараа" гэж нэмсэн*

ХАРЬЦЫ ЗУЙЛ ХУДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.tuli.gov.mn

790.	137.3.Гаалийн баталгаат бүсэд оруулах, тэндээс гаргах бараанд гаалийн бүрдүүлэлт хийхдээ ийнхүү оруулах, эсхүл гаргах өдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа гаалийн хууль тогтоомж, валютын ханш, гаалийн тарифыг баримтална.	211.3.Гаалийн баталгаат бүсэд оруулах, тэндээс гаргах бараанд гаалийн бүрдүүлэлт хийхдээ ийнхүү оруулах, эсхүл гаргах өдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа гаалийн хууль тогтоомж, валютын ханш, гаалийн тарифыг баримтална.		-
791.	137.4.Гаалийн баталгаат бүсийн горимд байршуулахаар хилийн чанадаас оруулах гадаадын бараанд гаалийн болон бусад татвар ногдуулахгүй бөгөөд харин гаалийн нутаг дэвсгэрээс гаалийн баталгаат бүсийн горимд оруулах монголын бараанд экспортын барааны болон бусад татвар ногдуулан хураан авч, улсын төсөвт төвлөрүүлнэ.	211.5.Гаалийн нутаг дэвсгэрээс гаалийн баталгаат бүсийн горимд байршуулах монголын бараанд экспортын барааны гаалийн татвар ногдуулан хураан авч, улсын төсөвт төвлөрүүлнэ.		*“Гаалийн баталгаат бүсийн горимд байршуулахаар хилийн чанадаас оруулах гадаадын бараанд гаалийн болон бусад татвар ногдуулахгүй бөгөөд харин” гэснийг хассан*
792.	137.5.Чөлөөт эргэлтэд байгаа гадаадын барааг гаалийн баталгаат бүсийн горимд байршуулахад урьд нь төлсөн импортын гаалийн татварыг буцаан олгохгүй.	211.6.Чөлөөт эргэлтэд байгаа гадаадын барааг гаалийн баталгаат бүсийн горимд байршуулахад урьд нь төлсөн импортын гаалийн болон бусад татварыг буцаан олгохгүй.		-
793.	137.6.Гаалийн баталгаат бүсэд байршуулах бараа Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалтад хамаарахгүй.	211.7.Гаалийн баталгаат бүсэд байршуулах гадаадын бараанд Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалт хамаарахгүй.		*“бараа” гэснийг “гадаадын бараанд” гэж өөрчилсөн*
794.		211.4.Хилийн чанадаас гаалийн баталгаат бүсийн горимд байршуулах гадаадын бараанд импортын барааны гаалийн болон бусад татвар ногдуулахгүй.		*Шинээр нэмсэн*
795.		211.8.Гаалийн баталгаат бүсэд байршуулах монголын бараа тарифын бус хязгаарлалтад хамаарна.		*Шинээр нэмсэн*
796.	137.7.Барааг хилийн чанадаас гаалийн баталгаат бүсэд оруулах, тэндээс хилийн чанадад буцаан гаргахад нийгмийн аюулгүй байдал, ёс суртахуун, эрүүл ахуй, эрүүл мэнд, хорио цээр, худалдааны тэмдэгт, оюуны өмчийн эрхтэй холбогдуулснаас бусад үндэслэлээр хязгаарлал тогтоохыг хориглоно.	211.9.Барааг хилийн чанадаас гаалийн баталгаат бүсэд оруулах, тэндээс хилийн чанадад буцаан гаргахад нийгмийн аюулгүй байдал, ёс суртахуун, эрүүл ахуй, эрүүл мэнд, хорио цээр, худалдааны тэмдэгт, барааны тэмдэг, зохиогчийн эрхтэй холбогдуулснаас бусад үндэслэлээр хязгаарлалт тогтоохыг хориглоно.		-
797.	**138 дугаар зүйл. Гаалийн баталгаат бүсэд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох**	**213 дугаар зүйл.Гаалийн баталгаат бүсийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох**		-
798.	138.1.Гаалийн баталгаат бүсэд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь дор дурдсан төрөлтэй байна: 138.1.1.гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх; 138.1.2.гаалийн баталгаат үйлдвэрийн газар ажиллуулах; 138.1.3.гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газар ажиллуулах; 138.1.4.гаалийн баталгаат барилгын талбай ажиллуулах;	**212 дугаар зүйл.Гаалийн баталгаат бүсийн төрөл** 212.1.Гаалийн баталгаат бүс нь дор дурдсан төрөлтэй байна: 212.1.1.гаалийн баталгаат агуулах; 212.1.2.гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газар; 212.1.3.гаалийн баталгаат барилгын талбай;		-
799.	138.1.5.гаалийн тусгай бүс байгуулах;			*Хассан*
800.	138.1.6.татваргүй барааны дэлгүүр ажиллуулах.	212.1.4.татваргүй барааны дэлгүүр.		-

ХЭЛЭЛЦЭЭНИЙ ХУРЭЭЛЭН ЦЫНЭЛ ЗҮЙН ЧИГЛЭЛИЙН ХУРЭЭЛЭН

801.		213.1.Энэ хуулийн 212.1-д заасан үйл ажиллагааг зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ.		-
802.	138.2.Энэ хуулийн 138.1-д заасан зөвшөөрлийг тухайн үйл ажиллагааны онцлогийг харгалзан 3 жил хүртэл хугацаагаар гаалийн удирдах төв байгууллага олгох бөгөөд уг хугацааг анх олгосноос доошгүй хугацаагаар сунгаж болно.	213.2.Зөвшөөрлийг тухайн үйл ажиллагааны онцлогийг харгалзан гаалийн удирдах төв байгууллага 3 жил хүртэл хугацаагаар олгох бөгөөд уг хугацааг анх олгосноос доошгүй хугацаагаар сунгаж болно.		*“Энэ хуулийн 138.1-д заасан” гэснийг хассан*
803.	138.3.Энэ хуулийн 138.1.6-д заасан зөвшөөрлийг гаалийн удирдах төв байгууллагаас баталсан журмын дагуу сонгон шалгаруулалтын үндсэн дээр олгоно.	213.3.Энэ хуулийн 212.1.4-д заасан зөвшөөрлийг зорчигчийн урсгал ихтэй, олон улсын шинжтэй, байнгын ажиллагаатай хилийн боомтод гаалийн удирдах төв байгууллагаас баталсан журмын дагуу сонгон шалгаруулалтын үндсэн дээр олгоно.		*“зөвшөөрлийг” гэсний дараа “зорчигчийн урсгал ихтэй, олон улсын шинжтэй, байнгын ажиллагаатай хилийн боомтод” гэж нэмсэн*
804.		213.3.1Олон улсын нислэгийн үед татваргүй барааны агаарын худалдаа эрхлэх зөвшөөрлийг гаалийн удирдах төв байгууллагаас баталсан журмын дагуу олгоно.		*Шинээр нэмэгдсэн*
805.	138.4.Энэ хуулийн 138.1-д заасан зөвшөөрлийг олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, зөвшөөрлийн хугацааг нь сунгах, зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавихтай холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.	213.4.Энэ хуулийн 212.1-д заасан зөвшөөрлийг олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, зөвшөөрлийн хугацааг нь сунгах, зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавихтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.		*“энэ хуулиар зохицуулаагүй бусад” гэснийг хассан, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” гэснийг “энэ” гэж өөрчилсөн*
806.	**139 дүгээр зүйл.Зөвшөөрөл эзэмших хүсэлт гаргах** 139.1.Энэ хуулийн 138.1-д заасан үйл ажиллагааг эрхлэх хүсэлтэд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1.1-11.1.4-т зааснаас гадна дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ:	**214 дүгээр зүйл.Үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргах** 214.1.Энэ хуулийн 212.1-д заасан үйл ажиллагааг эрхлэх хүсэлтэд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1.1-11.1.4-т зааснаас гадна дараах бичиг баримтыг бүрдүүлнэ:		-
807.		214.1.1.зөвшөөрөл хүссэн хүсэлт; 214.1.2.хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээ; 214.1.3.тэмдэгтийн хураамж төлсөн баримт;		*Шинээр нэмэгдсэн*
808.	139.1.1.тухайн үйл ажиллагаанаас үүсэх эрсдлийг хангах санхүүгийн чадавхтай болохыг нотолсон бичиг баримт; 139.1.2.үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтын тухай мэдээлэл ; 139.1.3.барилга, байгууламж, талбайн бүдүүвч зураг; 139.1.4.холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлт; 139.1.5.ажлын байрны дүгнэлт; 139.1.6.гаалийн хяналт тавих нөхцөлийг хангасан тухай мэдээлэл.	214.1.4.тухайн үйл ажиллагаанаас үүсэх эрсдлийг хангах санхүүгийн чадавхтай болохыг нотолсон бичиг баримт; 214.1.5.үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтын тухай мэдээлэл; 214.1.6.барилга, байгууламж, талбайн бүдүүвч зураг; 214.1.7.холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлт; 214.1.8.ажлын байрны дүгнэлт; 214.1.9.гаалийн хяналт тавих нөхцөлийг хангасан тухай мэдээлэл.		-

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.mn.gov.mn

809.	139.2.Гаалийн удирдах төв байгууллага нь энэ хуулийн 139.1-д заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 21 хоногийн дотор шийдвэрлэх бөгөөд хүсэлтийг хүлээн авах боломжгүй гэж үзсэн бол татгалзах үндэслэлийг тусган бичгээр хариу өгөх, харин хүсэлтийг хүлээн авсан бол зөвшөөрөл олгосон тухай шийдвэр гаргаж, гэрчилгээ олгоно.	214.2.Гаалийн удирдах төв байгууллага нь энэ хуулийн 214.1-д заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 21 хоногийн дотор шийдвэрлэх бөгөөд хүсэлтийг хүлээн авах боломжгүй гэж үзсэн бол татгалзах үндэслэлийг тусган бичгээр хариу өгөх, харин хүсэлтийг хүлээн авсан бол зөвшөөрөл олгосон тухай шийдвэр гаргаж, гэрчилгээ олгоно.		-
810.	**140 дүгээр зүйл. Зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох** 140.1.Энэ хуулийн 139.1-д заасан зөвшөөрөл эзэмшигч нь тухайн бүсэд тавигдах нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд үйл ажиллагааг нь 3 сар хүртэл хугацаагаар гаалийн удирдах төв байгууллага түдгэлзүүлнэ. 140.2.Энэ хуулийн 139.1-д заасан зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 140.1-д заасан хугацаанд зөрчлийг засаагүй, эсхүл гаалийн хууль тогтоомжийг 2 буюу түүнээс дээш удаа зөрчсөн бол зөвшөөрлийг хүчингүй болгоно.	**215 дугаар зүйл.Зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох** 215.1.Энэ хуулийн 212.1-д заасан зөвшөөрөл эзэмшигч нь тухайн бүсэд тавигдах нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд үйл ажиллагааг нь 3 сар хүртэл хугацаагаар гаалийн удирдах төв байгууллага түдгэлзүүлнэ. 215.2.Энэ хуулийн 212.1-д заасан зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 215.1-д заасан хугацаанд зөрчлийг засаагүй, эсхүл гаалийн хууль тогтоомжийг 2 буюу түүнээс дээш удаа зөрчсөн бол зөвшөөрлийг хүчингүй болгоно.		-
811.	140.3.Энэ хуулийн 140.2-т заасны дагуу зөвшөөрлийг хүчингүй болгосон бол тухайн баталгаат бүсэд байршиж буй бараа өөр горимд шилжүүлэх хугацаанд гаалийн удирдах төв байгууллагын дарга тогтоож хяналт тавина.	215.3.Зөвшөөрлийг хүчингүй болгосон өдрөөс 3 хоногийн дотор тухайн баталгаат бүсэд байршиж буй бараа өөр горимд шилжүүлээгүй бол гаалийн түр агуулахад хадгалж байгаад тооцож энэ хуулийн 76, 293 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.		*Өөрчлөн найруулсан*
812.	**Хоёрдугаар дэд бүлэг** **Гаалийн баталгаат агуулахын горим**	**ХОЁРДУГААР ДЭД БҮЛЭГ** **ГААЛИЙН БАТАЛГААТ АГУУЛАХЫН ГОРИМ**		
813.	**141 дүгээр зүйл.Гаалийн баталгаат агуулахын горимын агуулга** 141.1.Зах зээл хайх боломжийг бүрдүүлэх, гаалийн болон бусад татвар төлөх хугацаа олгох зорилгоор шаардагдах мэдээлэл, бичиг баримтыг үндэслэн бараа гаалийн баталгаат агуулахын горимд байршуулна.	**216 дугаар зүйл.Гаалийн баталгаат агуулахын горимын агуулга** 216.1.Зах зээл хайх боломжийг бүрдүүлэх, гаалийн болон бусад татвар төлөх хугацаа олгох зорилгоор шаардагдах мэдээлэл, бичиг баримтыг үндэслэн бараа гаалийн баталгаат агуулахын горимд байршуулна.		-
814.	**142 дугаар зүйл. Гаалийн баталгаат агуулахын горимд байршуулах бараа** 142.1.Гаалийн баталгаат агуулахын горимд дараахь бараа байршуулна: 142.1.1.монголын бараа; 142.1.2.хилийн чанадаас ирсэн гадаадын бараа; 142.1.3.бусад горимын бараа.	**217 дугаар зүйл. Гаалийн баталгаат агуулахын горимд байршуулах бараа** 217.1.Гаалийн баталгаат агуулахын горимд дараах бараа байршуулна: 217.1.1.монголын бараа; 217.1.2.хилийн чанадаас ирсэн гадаадын бараа; 217.1.3.бусад горимоос байршуулах бараа.		-

хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

815.	**143 дугаар зүйл. Гаалийн баталгаат агуулахын бараа тарифын бус хязгаарлалтад хамаарах** 143.1.Гаалийн баталгаат агуулахын горимд байршуулах гадаадын бараа Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалтад хамаарахгүй. 143.2.Гаалийн баталгаат агуулахын горимд байршуулах монголын бараа Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалтад хамаарна.			*Хасагдсан*
816.	**144 дүгээр зүйл.Гаалийн баталгаат агуулахын төрөл** 144.1.Гаалийн баталгаат агуулах нь нийтэд зориулагдсан нээлттэй, нэг буюу хэд хэдэн аж ахуйн нэгж, байгууллага ашиглахад зориулагдсан хаалттай байж болно.	**218 дугаар зүйл.Гаалийн баталгаат агуулахын төрөл** 218.1.Гаалийн баталгаат агуулах нь нийтэд зориулагдсан нээлттэй, нэг буюу хэд хэдэн хуулийн этгээд ашиглахад зориулагдсан хаалттай байж болно.		-
817.	144.2.Гаалийн нээлттэй баталгаат агуулахад аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүний Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад бүх төрлийн барааг байршуулж болно.			*Хассагдсан*
818.	144.3.Гаалийн хаалттай баталгаат агуулахад хадгалалтын онцгой нөхцөл, техник, тоног төхөөрөмж тусгайлан шаардах, эсхүл бусад бараанд нөлөөлж болох тодорхой нэр төрлийн барааг байршуулна.			*Хассагдсан*
819.		218.2.Хадгалалтын тусгай нөхцөл шаардах барааг зориулалтын тоног төхөөрөмжөөр тоноглогдсон гаалийн баталгаат агуулахад байршуулна.		*Шинээр нэмэгдсэн*
820.	**145 дугаар зүйл.Гаалийн баталгаат агуулахад тавигдах шаардлага** 145.1.Гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч нь дараахь нөхцөл, шаардлагыг хангаж ажиллана: 145.1.1.агуулахын үйл ажиллагааны болон агуулахад нэвтрэх журмыг тогтоон мөрдөх; 145.1.2.агуулахын үйл ажиллагаанд хяналт тавих гаалийн албан тушаалтны ажиллах нөхцөлөөр хангасан байх;	**219 дүгээр зүйл.Гаалийн баталгаат агуулахад тавигдах шаардлага** 219.1.Гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч нь дараах нөхцөл, шаардлагыг хангаж ажиллана: 219.1.1.агуулахын үйл ажиллагааны болон агуулахад нэвтрэх дэглэм тогтоон мөрдөх; 219.1.2.агуулахын үйл ажиллагаанд хяналт тавих гаалийн албан тушаалтны ажиллах нөхцөлөөр хангасан байх;		-
821.	145.1.3.агуулахад барааг оруулах, гаргахдаа гаалийн байгууллагын хяналт дор гүйцэтгэх;	219.1.4.агуулахад бараа оруулах, гаргахдаа гаалийн байгууллагын хяналт дор гүйцэтгэх;		-
822.	145.1.4.агуулах эзэмшигч өөрийн гэм буруутай үйл ажиллагааны улмаас барааг дутаасан, гэмтээсэн, чанар байдлыг нь алдагдуулсан тохиолдолд бусдад учруулсан хохирлыг хуулийн дагуу барагдуулах;	219.1.6.агуулах эзэмшигч өөрийн гэм буруутай үйл ажиллагааны улмаас барааг дутаасан, гэмтээсэн, чанар байдлыг нь алдагдуулсан тохиолдолд учруулсан хохирлыг хуулийн дагуу барагдуулах;		-
823.	145.1.5.агуулах нь гаалийн мэдээллийн сүлжээнд холбогдсон байх;	219.1.7.агуулах нь гаалийн мэдээллийн сүлжээнд холбогдсон байх;		-

824.	145.1.6.агуулахын барааны хөдөлгөөний бүртгэлийг хөтлөх, мэдээг тогтоосон хугацаанд гаалийн байгууллагад гаргаж өгөх;	219.1.8.агуулахын барааны хөдөлгөөний бүртгэлийг хөтлөх, мэдээг тогтоосон хугацаанд гаалийн байгууллагад гаргаж өгөх;		-
825.	145.1.7.зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд хадгалагдаж буй барааны чанар, бүрэн бүтэн байдлыг хангах;	219.1.9.зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд хадгалагдаж буй барааны чанар, бүрэн бүтэн байдлыг хангах;		-
826.	145.1.8.агуулахад барааг төрөлжүүлэн хадгалж, нэр, төрөл, тоо хэмжээ, үлдэгдлийг заасан шошго тавьсан байх;	219.1.10.агуулахад барааг төрөлжүүлэн хадгалж, нэр, төрөл, тоо хэмжээ, үлдэгдлийг заасан шошго тавьсан байх;		-
827.	145.1.9.агуулах эзэмшигч нь барааг хадгалах хугацаа дуусахаас 14 хоногийн өмнө мэдүүлэгч, эсхүл холбогдох этгээдэд бичгээр мэдэгдэж байх;	219.1.11.агуулах эзэмшигч нь барааг хадгалах хугацаа дуусахаас 14 хоногийн өмнө мэдүүлэгч, эсхүл холбогдох этгээдэд бичгээр мэдэгдэж байх;		-
828.	145.1.10.агуулахыг бусад барилга байгууламжаас тусгаарлах, холбогдох стандарт техникийн нөхцөл, шаардлагын дагуу барааны чанарыг алдагдуулахгүйгээр хадгалах зориулалтын тоног төхөөрөмжөөр тоноглох, эрүүл ахуйн шаардлага хангасан байх.	219.1.12.агуулахыг бусад барилга байгууламжаас тусгаарлах, холбогдох стандарт техникийн нөхцөл, шаардлагын дагуу барааны чанарыг алдагдуулахгүйгээр хадгалах зориулалтын тоног төхөөрөмжөөр тоноглох, эрүүл ахуйн шаардлага хангасан байх.		-
829.		219.1.3.гаалийн нэгдсэн онлайн сүлжээнд холбогдсон, зураасан код ашиглан электрон бүртгэлийн системыг нэвтрүүлсэн байх;		*Шинээр нэмэгдсэн*
830.		219.1.5.агуулахад жижиглэнгийн худалдаа хийхгүй байх;		*Шинээр нэмэгдсэн*
831.		219.1.13.гаалийн нэгдсэн онлайн сүлжээнд холбогдсон, зураасан код ашиглан электрон бүртгэлийн системыг нэвтрүүлсэн байх;		*Шинээр нэмэгдсэн*
832.	**146 дугаар зүйл.Гаалийн баталгаат агуулахад зөвшөөрөгдөх үйл ажиллагаа** 146.1.Гаалийн баталгаат агуулахад гаалийн байгууллагын зөвшөөрлөөр дараахь үйл ажиллагаа явуулж болно: 146.1.1.барааны бүрэн бүтэн байдлыг хангах; 146.1.2.барааны баглаа, боодлыг задлах, төрөлжүүлэх, савлах, дахин савлах, тусгай зориулалтын тэмдэг тавих ; 146.1.3.барааг ачилтад бэлтгэх; 146.1.4.барааны сорьц, дээж, загвар авах; 146.1.5.гаалийн байгууллагаас зөвшөөрсөн бусад үйл ажиллагаа.	**220 дугаар зүйл.Гаалийн баталгаат агуулахад зөвшөөрөгдөх үйл ажиллагаа** 220.1.Гаалийн баталгаат агуулахад гаалийн байгууллагын зөвшөөрлөөр дараах үл ажиллагаа явуулж болно: 220.1.1.барааны бүрэн бүтэн байдлыг хангах; 220.1.2.барааны баглаа, боодлыг задлах, төрөлжүүлэх, савлах, дахин савлах, тусгай зориулалтын тэмдэг тавих; 220.1.3.барааг ачилтад бэлтгэх; 220.1.4.барааны сорьц, дээж, загвар авах; 220.1.5.гаалийн байгууллагаас зөвшөөрсөн бусад үйл ажиллагаа.		-
833.	**147 дугаар зүйл.Гаалийн баталгаат агуулахад барааг байршуулах хугацаа** 147.1.Барааг гаалийн баталгаат агуулахад 2 жил хүртэл хугацаагаар байршуулахыг зөвшөөрөх бөгөөд гаалийн удирдах төв байгууллага уг хугацааг 1 жил хүртэл хугацаагаар нэг удаа сунгаж болно.	**221 дүгээр зүйл.Гаалийн баталгаат агуулахад барааг байршуулах хугацаа** 221.1.Барааг гаалийн баталгаат агуулахад 2 жил хүртэл хугацаагаар байршуулахыг зөвшөөрөх бөгөөд гаалийн удирдах төв байгууллага уг хугацааг 1 жил хүртэл хугацаагаар нэг удаа сунгаж болно.		-

834.	**148 дугаар зүйл.Гаалийн баталгаат агуулахын горим дуусгавар болох**	**222 дугаар зүйл.Гаалийн баталгаат агуулахын горим дуусгавар болох**		
835.	148.1.Барааг өөр горимд байршуулснаар, эсхүл агуулах татан буугдсанаар гаалийн баталгаат агуулахын горим дуусгавар болно.	222.1.Гаалийн баталгаат агуулахын горим барааг өөр горимд байршуулснаар дуусгавар болно.		*Өөрчлөн найруулсан*
836.	**Гуравдугаар дэд бүлэг Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын горим**			*Хасагдсан*
837.	**149 дүгээр зүйл.Гаалийн баталгаат үйлдвэрийн газар** 149.1.Улсын эдийн засагт тэргүүлэх ач холбогдол бүхий тодорхой салбар, тэргүүлэх чиглэлийн үйлдвэрлэлийг хөхиүлэн дэмжих, тодорхой нэрийн барааны дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор гаалийн нутаг дэвсгэр дээр гаалийн баталгаат үйлдвэрийн газар ажиллуулна.			*Хасагдсан*
838.	**150 дугаар зүйл.Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын горимд байршуулах бараа** 150.1.Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын горимд дараахь барааг байршуулна: 150.1.1.монголын бараа; 150.1.2.хилийн чанадаас ирсэн гадаадын бараа; 150.1.3.бусад горимын бараа. 150.2.Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйлдвэрлэл явуулахад шаардагдах техник, тоног төхөөрөмжийг энэ хуулийн 150.1-д заасан горимд байршуулахыг хориглоно.			*Хасагдсан*
839.	**151 дүгээр зүйл.Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын бараа тарифын бус хязгаарлалтад хамаарах** 151.1.Гаалийн нутаг дэвсгэрээс гаалийн баталгаат үйлдвэрийн газрын горимд байршуулах монголын бараа тарифын бус хязгаарлалтад хамаарна. 151.2.Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын горимд байршуулах гадаадын бараа Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалтад хамаарахгүй.			*Хасагдсан*

Хуульд зүйн үндэсний хүрээлэн
www.nli.gov.mn

840.	**152 дугаар зүйл.Гаалийн баталгаат үйлдвэрийн газарт тавигдах шаардлага** 152.1.Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл зээмшигч нь дараахь нөхцөл, шаардлагыг хангаж ажиллана: 152.1.1.тэргүүний дэвшилтэт техник технологийн дагуу оруулж суурилуулах техник, тоног төхөөрөмж болон үйлдвэрлэх бүтээгдэхүүн нь зах зээлд өрсөлдөх чадвартай болохыг нотолсон тодорхойлолттыг холбогдох байгууллагаас авсан байх; 152.1.2.гаалийн хяналт, шалгалтыг хэвийн явуулах техник хэрэгсэл болон гаалийн албан тушаалтныг ажиллах нөхцөлөөр хангасан байх; 152.1.3.харуул хамгаалалт, хяналтын камер, дохиоллын найдвартай систем болон гэрэлтүүлэгтэй, галын аюулгүй байдлыг хангасан байх; 152.1.4.үйлдвэрийн барилгыг бусад барилга байгууламжаас тусгаарласан хашаатай, таних тэмдэг, анхааруулга тавьсан байх; 152.1.5.үйлдвэрт бараа оруулах, гаргахдаа гаалийн байгууллагын хяналт дор гүйцэтгэж байх; 152.1.6.гаалийн баталгаат үйлдвэрийн газар зээмшигч нь өөрийн гэм буруутай үйл ажиллагааны улмаас бараа дутаасан, гэмтээсэн, чанар байдлыг нь алдагдуулсан тохиолдолд бусдад учруулсан хохирлыг хуулийн дагуу барагдуулах.				*Хасагдсан*
841.	**153 дугаар зүйл.Гаалийн баталгаат үйлдвэрийн газарт явуулах үйл ажиллагаа** 153.1.Гаалийн баталгаат үйлдвэрийн газарт дараахь үйл ажиллагаа явуулна: 153.1.1.бүтээгдэхүүн үйлдвэрлэх; 153.1.2.материал, түүхий эдийг боловсруулах; 153.1.3.засвар, үйлчилгээ хийх; 153.1.4.барааны дээж, сорьц, загвар авах; 153.1.5.гаалийн байгууллагаас зөвшөөрсөн бусад үйл ажиллагаа.				*Хасагдсан*
842.	**154 дүгээр зүйл.Гаалийн баталгаат үйлдвэрийн газарт бараа байршуулах хугацаа** 154.1.Гаалийн баталгаат үйлдвэрийн газарт бараг 2 жил хүртэл хугацаагаар байршуулахыг зөвшөөрөх бөгөөд гаалийн удирдах төв байгууллага уг хугацаг 1 жил хүртэл хугацаагаар нэг удаа сунгаж болно.				*Хасагдсан*
843.	**155 дугаар зүйл.Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын горим дуусгавар болох** 155.1.Барааг өөр горимд байршуулснаар, эсхүл гаалийн баталгаат үйлдвэрийн газар татан буугдсанаар гаалийн баталгаат үйлдвэрийн газрын горим дуусгавар болно.				*Хасагдсан*

УУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

844.	**Дөрөвдүгээр дэд бүлэг Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын горим**	**ГУРАВДУГААР ДЭД БҮЛЭГ ГААЛИЙН БАТАЛГААТ ҮЗЭСГЭЛЭНГИЙН ГАЗРЫН ГОРИМ**		-
845.	**156 дугаар зүйл.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газар** 156.1.Тэргүүний техник технологи судлах, захиалах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор гаалийн нутаг дэвсгэр дээр гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газар байгуулна.	**223 дугаар зүйл.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газар** 223.1.Тэргүүний техник технологи судлах, захиалах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор гаалийн нутаг дэвсгэр дээр гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газар байгуулна.		-
846.	**157 дугаар зүйл.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын горимд байршуулах бараа** 157.1.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын горимд дараахь барааг байршуулна: 157.1.1.чөлөөт эргэлтэд байгаа монголын бараа; 157.1.2.хилийн чанадаас ирсэн гадаадын бараа;	**224 дүгээр зүйл.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын горимд байршуулах бараа** 224.1.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын горимд дараах барааг байршуулна: 224.1.1.чөлөөт эргэлтэд байгаа монголын бараа; 224.1.2.хилийн чанадаас ирсэн гадаадын бараа;		-
847.	157.1.3.бусад горимын бараа.	224.1.3.бусад горимоос байршуулах бараа.		*“горимын” гэснийг “горимоос байршуулах” гэж өөрчилсөн*
848.	**158 дугаар зүйл.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын бараа тарифын бус хязгаарлалтад хамаарах** 158.1.Гаалийн нутаг дэвсгэрээс гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт байршуулах монголын бараа тарифын бус хязгаарлалтад хамаарна. 158.2.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын горимд байршуулах гадаадын бараа Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалтад хамаарахгүй.			*Хасагдсан*
849.	**159 дүгээр зүйл. Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт тавигдах шаардлага** 159.1.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт дараахь нөхцөл, шаардлагыг хангаж ажиллана: 159.1.1.зөвхөн үзэсгэлэнгийн зориулалтын бараа оруулах; 159.1.2. харуул хамгаалалт, хяналтын камер, дохиоллын найдвартай систем болон гэрэлтүүлэгтэй, галын аюулгүй байдлыг хангасан байх;	**225 дугаар зүйл.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт тавигдах шаардлага** 225.1.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт дараах нөхцөл, шаардлагыг хангаж ажиллана: 225.1.1.зөвхөн үзэсгэлэнгийн зориулалтын бараа оруулах; 225.1.2.харуул хамгаалалт, хяналтын камер, дохиоллын найдвартай систем болон гэрэлтүүлэгтэй, галын аюулгүй байдлыг хангасан байх;		-
850.		225.1.3.гаалийн нэгдсэн онлайн сүлжээнд холбогдсон, зураасан код ашиглан электрон бүртгэлийн системыг нэвтрүүлсэн байх;		*Нэмэгдсэн*
851.	159.1.3.үзэсгэлэнгийн талбай бусад барилга байгууламжаас тусгаарласан хашаатай, таних тэмдэг, анхааруулга тавьсан байх;	225.1.4.үзэсгэлэнгийн талбай бусад барилга байгууламжаас тусгаарласан хашаатай, таних тэмдэг, анхааруулга тавьсан байх;		-
852.	159.1.4.гаалийн хяналт, шалгалтыг хэвийн явуулах техник хэрэгсэл болон гаалийн албан тушаалтныг ажиллах нөхцөлөөр хангасан байх.	225.1.5.гаалийн хяналт, шалгалтыг хэвийн явуулах техник хэрэгсэл болон гаалийн албан тушаалтныг ажиллах нөхцөлөөр хангасан байх.		-

ХҮҮЛЬ ЗҮЙЛ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

853.	**160 дугаар зүйл.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт явуулах үйл ажиллагаа** 160.1.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт дараахь үйл ажиллагаа явуулна: 160.1.1.үзэсгэлэн гаргах; 160.1.2.туршилт хийх; 160.1.3.үйлчилгээ үзүүлэх; 160.1.4.барааны дээж, сорьц, загвар авах.	**226 дугаар зүйл.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт явуулах үйл ажиллагаа** 226.1.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт дараах үйл ажиллагаа явуулна: 226.1.1.үзэсгэлэн гаргах; 226.1.2.туршилт хийх; 226.1.3.үйлчилгээ үзүүлэх; 226.1.4.барааны дээж, сорьц, загвар авах.		-
854.	**161 дүгээр зүйл. Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газар бараа байршуулах хугацаа** 161.1.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт барааг 2 жил хүртэл хугацаагаар байршуулахыг зөвшөөрөх бөгөөд гаалийн удирдах төв байгууллага энэ хугацааг 1 жил хүртэл хугацаагаар нэг удаа сунгаж болно.	**227 дугаар зүйл.Горимд бараа байршуулах хугацаа** 227.1.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт барааг 1 жил хүртэл хугацаагаар байршуулахыг зөвшөөрөх бөгөөд гаалийн удирдах төв байгууллага энэ хугацааг 1 жил хүртэл хугацаагаар нэг удаа сунгаж болно.		*“Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газар” гэснийг “Горимд” гэж өөрчлөх*
855.	**162 дугаар зүйл.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын горим дуусгавар болох** 162.1.Барааг өөр горимд байршуулснаар, эсхүл гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газар татан буугдсанаар гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын горим дуусгавар болно.	**228 дугаар зүйл.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын горим дуусгавар болох** 228.1.Барааг өөр горимд байршуулснаар гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын горим дуусгавар болно.		*“эсхүл гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газар татан буугдсанаар” гэснийг хасах*
856.	**Тавдугаар дэд бүлэг Гаалийн баталгаат барилгын талбайн горим**	**ДӨРӨВДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ ГААЛИЙН БАТАЛГААТ БАРИЛГЫН ТАЛБАЙН ГОРИМ**		-
857.	**163 дугаар зүйл.Гаалийн баталгаат барилгын талбай** 163.1.Монгол Улсын эдийн засагт стратегийн чухал ач холбогдол бүхий барилга байгууламжийг гадаадын барилгын материалыг ашиглан барих ажлыг хөхиүлэн дэмжих зорилгоор гаалийн нутаг дэвсгэр дээр гаалийн баталгаат барилгын талбай байгуулна.	**229 дүгээр зүйл.Гаалийн баталгаат барилгын талбай** 229.1.Монгол Улсын эдийн засагт стратегийн чухал ач холбогдол бүхий барилга байгууламжийг гадаадын барилгын материалыг ашиглан барих ажлыг дэмжих зорилгоор гаалийн нутаг дэвсгэр дээр гаалийн баталгаат барилгын талбай байгуулна.		-
858.	**164 дүгээр зүйл.Гаалийн баталгаат барилгын талбайд байршуулах бараа** 164.1.Гаалийн баталгаат барилгын талбайн горимд дараахь барааг байршуулна: 164.1.1.хилийн чанадаас ирсэн гадаадын барилгын материал;	**230 дугаар зүйл.Гаалийн баталгаат барилгын талбайд байршуулах бараа** 230.1.Гаалийн баталгаат барилгын талбайн горимд дараах барааг байршуулна: 230.1.1.хилийн чанадаас ирсэн гадаадын барилгын материал;		-
859.	164.1.2.бусад горимд байгаа гадаадын барилгын материал.	230.1.4.бусад горимд байгаа гадаадын барилгын материал.		-
860.		230.1.2.хилийн чанадаас ирсэн барилга барихад ашиглагдах тоног төхөөрөмж, машин механизм		*Шинээр нэмэгдсэн*
861.		230.1.3.хилийн чанадаас ирсэнбарилгад суурилагдах техник хэрэгсэл, тоног төхөөрөмж		*Шинээр нэмэгдсэн*
862.	164.2.Тухайн барилгыг барихад ашиглагдах техник, тоног төхөөрөмж, машин механизм, багаж хэрэгслийг энэ хуулийн 163.1-д заасан горимд байршуулахыг хориглоно.	230.2.Тухайн барилгыг барихад ашиглагдах техник, тоног төхөөрөмж, машин механизм, багаж хэрэгслийг энэ хуулийн 230.1-д заасан горимд байршуулахыг хориглоно.		-
863.		230.3.Гаалийн баталгаат барилгын талбайн горимд байршуулах бараа Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалтад хамаарахгүй.		*Шинээр нэмэгдсэн*

ХУДАЛДАН АВАЛТЫН ТУХАЙ ХУРЭЭЛЭН
www.mn.gov.mn

864.	**165 дугаар зүйл. Гаалийн баталгаат барилгын талбайн бараа тарифын бус хязгаарлалтад хамаарах** 165.1.Гаалийн баталгаат барилгын талбайн горимд байршуулах гадаадын барилгын материал Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалтад хамаарахгүй. 165.2.Гаалийн баталгаат барилгын талбайн горимд байршуулах монголын бараа Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалтад хамаарна.				*Хасагдсан*
865.	**166 дугаар зүйл.Гаалийн баталгаат барилгын талбайд тавигдах шаардлага** 166.1.Гаалийн баталгаат барилгын талбайд дараахь нөхцөл, шаардлагыг хангаж ажиллана: 166.1.1.харуул хамгаалалт, дохиоллын найдвартай систем болон гэрэлтүүлэгтэй, галын аюулгүй байдлыг хангасан байх; 166.1.2.барилгын талбайг бусад барилга байгууламжаас тусгаарласан хашаатай, таних тэмдэг, анхааруулга тавьсан байх; 166.1.3.гаалийн хяналт, шалгаптыг хэвийн явуулах техник хэрэгсэл болон гаалийн албан тушаалтныг ажиллах нөхцөлөөр хангасан байх; 166.1.4.барилга угсралтын ажлын явц дунд, уе шатанд гаалийн хяналт тавих болзлоогоор хангасан байх; 166.1.5.барилга байгууламжийг байгуулах түүнчлэн газар олгосон тухай холбогдох байгууллагын шийдвэр, татварын өргүй болохыг тодорхойлсон татварын байгууллагын тодорхойлолт зэргийг гаргуулсан байх; 166.1.6.барилгын талбайд оруулсан бараа, барилгын ажлын гүйцэтгэл, орсон барааны орц, нормын мэдээг тогтоосон хугацаанд тартаж гаалийн байгууллагад өгөх.	**231 дүгээр зүйл.Гаалийн баталгаат барилгын талбайд тавигдах шаардлага** 231.1.Гаалийн баталгаат барилгын талбайд дараах нөхцөл, шаардлагыг хангаж ажиллана: 231.1.1.харуул хамгаалалт, дохиоллын найдвартай систем болон гэрэлтүүлэгтэй, галын аюулгүй байдлыг хангасан байх; 231.1.2.барилгын талбайг бусад барилга байгууламжаас тусгаарласан хашаатай, таних тэмдэг, анхааруулга тавьсан байх; 231.1.3.гаалийн хяналт, шалгаптыг хэвийн явуулах техник хэрэгсэл болон гаалийн албан тушаалтныг ажиллах нөхцөлөөр хангасан байх; 230.1.4.барилга угсралтын ажлын явц дунд, уе шатанд гаалийн хяналт тавих болзлоогоор хангасан байх; 231.1.5.барилга байгууламжийг байгуулах түүнчлэн газар олгосон тухай холбогдох байгууллагын шийдвэр, татварын өргүй болохыг тодорхойлсон татварын байгууллагын тодорхойлолт зэргийг гаргуулсан байх; 231.1.6.барилгын талбайд оруулсан бараа, барилгын ажлын гүйцэтгэл, орсон барааны орц, нормын мэдээг тогтоосон хугацаанд гаалийн байгууллагад гаргаж өгөх; 231.1.7.гаалийн нэгдсэн онлайн сүлжээнд холбогдсон, зураасан код ашиглан электрон бүртгэлийн системыг нэвтрүүлсэн байх.	-	
866.					*Шинээр нэмэгдсэн*

УЛСЫН ИХ ХУРЭЭЛЭН

867.	**167 дугаар зүйл.Гаалийн баталгаат барилгын талбайд явуулах үйл ажиллагаа** 167.1.Гаалийн баталгаат барилгын талбайд дараахь үйл ажиллагаа явуулна: 167.1.1.барилгын материалын бүрэн бүтэн байдлыг шалгах; 167.1.2.барилгын материал боловсруулах; 167.1.3.барилга угсралтын үйл ажиллагаа явуулах; 167.1.4.гаалийн байгууллагаас зөвшөөрсөн бусад үйл ажиллагаа. 167.2.Гаалийн баталгаат барилгын талбайд барааг тухайн барилга бүрэн ашиглалтад оруулах хүртэлх хугацаанд байршуулна. 167.3.Тухайн барилга угсралтын ажил дууссаны дараа ашиглагдаагүй үлдсэн барааг гаалийн бусад горимд байршуулна.	**232 дугаар зүйл.Гаалийн баталгаат барилгын талбайд явуулах үйл ажиллагаа** 232.1.Гаалийн баталгаат барилгын талбайд дараах үйл ажиллагаа явуулна: 232.1.1.барилгын материалын бүрэн бүтэн байдлыг шалгах; 232.1.2.барилгын материал боловсруулах; 232.1.3.барилга угсралтын үйл ажиллагаа явуулах; 232.1.4.гаалийн байгууллагаас зөвшөөрсөн бусад үйл ажиллагаа. 232.2.Гаалийн баталгаат барилгын талбайд барааг тухайн барилга бүрэн ашиглалтад оруулах хүртэлх хугацаанд байршуулна. 232.3.Тухайн барилга угсралтын ажил дууссаны дараа ашиглагдаагүй үлдсэн барааг гаалийн бусад горимд байршуулна.		-
868.		232.4.Барилга угсралтын ажилд ашиглагдсан, энэ хуулийн 230.1-д заасан бараанд дотоодын хэрэглээнд зориулан оруулах горимоор гаалийн бүрдүүлэлт хийж, импортын гаалийн болон бусад татварыг ногдуулан хураан авч, улсын төсөвт төвлөрүүлнэ.		*Шинээр нэмэгдсэн*
869.	**168 дугаар зүйл.Гаалийн баталгаат барилгын талбайн горим дуусгавар болох** 168.1.Барааг өөр горимд байршуулснаар, эсхүл тухайн барилгыг ашиглалтад оруулснаар гаалийн баталгаат барилгын талбайн горим дуусгавар болно.	**233 дугаар зүйл.Гаалийн баталгаат барилгын талбайн горим дуусгавар болох** 233.1.Барааг өөр горимд байршуулснаар гаалийн баталгаат барилгын талбайн горим дуусгавар болно.		*“, эсхүл тухайн барилгыг ашиглалтад оруулснаар” гэснийг хассан*
870.	**Зургадугаар дэд бүлэг Татваргүй барааны дэлгүүрийн горим**	**ТАВДУГААР ДЭД БҮЛЭГ ТАТВАРГҮЙ БАРААНЫ ДЭЛГҮҮРИЙН ГОРИМ**		-
871.	**169 дүгээр зүйл.Татваргүй барааны дэлгүүрийн горимын агуулга** 169.1.Гаалийн нутаг дэвсгэрт хэрэглэх зориулалтгүй гадаадын барааг гаалийн болон бусад татваргүйгээр оруулж, гаалийн хяналт дор борлуулах татваргүй барааны дэлгүүрийг гаалийн нутаг дэвсгэр дээр байгуулж болно. 169.2.Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрын болон олон улсын байгууллагын дипломат эрх ямба, дархан эрх эдлэх албан тушаалтан, түүнчлэн Монгол Улсын гаалийн хилээр нэвтрэх зорчигчид үйлчлэх зориулалт бүхий татваргүй барааны дэлгүүрийг улсын хилийн боомт болон олон улсын нисэх буудал, гаалийн нутаг дэвсгэрийн гүнд байгуулж болно.	**234 дүгээр зүйл.Татваргүй барааны дэлгүүрийн горимын агуулга** 234.1.Гаалийн нутаг дэвсгэрт хэрэглэх зориулалтгүй гадаадын барааг гаалийн болон бусад татваргүйгээр оруулж, гаалийн хяналт дор борлуулах татваргүй барааны дэлгүүрийг гаалийн нутаг дэвсгэрт байгуулж болно. 234.2.Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрын болон олон улсын байгууллагын дипломат эрх ямба, дархан эрх эдлэх албан тушаалтанд үйлчлэх зориулалт бүхий татваргүй барааны дэлгүүрийг гаалийн нутаг дэвсгэрийн гүнд, зорчигчид үйлчлэх зориулалт бүхий татваргүй барааны дэлгүүрийг улсын хилийн боомт болон олон улсын нисэх буудал байгуулж болно.		-

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

872.	**170 дугаар зүйл.Татваргүй барааны дэлгүүрийн горимд байршуулах бараа** 170.1.Татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа аж ахуйн нэгж дор дурдсанаас бусад бараг татваргүй барааны дэлгүүрийн горимд байршуулна: 170.1.1.Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон бараа; 170.1.2.хувийн хэрэглээний бус үйлдвэрлэл, техникийн зориулалттай бараа, барилгын материал; 170.1.3.хүндийн жин нь 20 кг-аас дээш, эсхүл урт, өндөр, өргөний нийлбэр хэмжээ 200 см-ээс их; 170.1.4.зорчигчийн хувийн хэрэглээнд зориулан татваргүй нэвтрүүлэх хэмжээнээс илүү хэмжээгээр, эсхүл жижиглэн худалдаалахаас бусад зориулалтаар савлагдсан согтууруулах ундаа, тамхи сигар; 170.1.5.эм, эмийн бүтээгдэхүүн; 170.1.6.бусад аж ахуйн нэгж, байгууллага импортоор оруулсан, эсхүл гадаадад захиалгаар хийлгэсэн бараа.	**235 дугаар зүйл.Татваргүй барааны дэлгүүрийн горимд байршуулах бараа** 235.1.Татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа аж ахуйн нэгж дор дурдсанаас бусад бараг татваргүй барааны дэлгүүрийн горимд байршуулна: 235.1.1.Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон бараа; 235.1.2.хувийн хэрэглээний бус үйлдвэрлэл, техникийн зориулалттай бараа, барилгын материал; 235.1.3.хүндийн жин нь 20 кг-аас дээш, эсхүл урт, өндөр, өргөний нийлбэр хэмжээ 200 см-ээс их; 235.1.4.зорчигчийн хувийн хэрэглээнд зориулан татваргүй нэвтрүүлэх хэмжээнээс илүү хэмжээгээр, эсхүл жижиглэн худалдаалахаас бусад зориулалтаар савлагдсан согтууруулах ундаа, тамхи,сигар; 235.1.5.эм, эмийн бүтээгдэхүүн; 235.1.6.бусад хуулийн этгээд импортоор оруулсан, эсхүл гадаадад захиалгаар хийлгэсэн бараа.		-
873.	170.2.Монгол Улсад үйлдвэрлэсэн бараг татваргүй барааны дэлгүүрийн горимд байршуулж болно.	235.2.Монгол Улсад үйлдвэрлэсэн, олон улсын стандартад нийцсэн бараг татваргүй барааны дэлгүүрийн горимд байршуулж болно.		*“, олон улсын стандартад нийцсэн” гэж нэмсэн*
874.	**171 дүгээр зүйл.Татваргүй барааны дэлгүүрт тавигдах шаардлага** 171.1.Татваргүй барааны дэлгүүр дараахь нөхцөл, шаардлагыг хангаж ажиллана: 171.1.1.олон улсын жишигт нийцсэн худалдааны танхим, агуулах, туслах байгууламжтай байх; 171.1.2.тоног төхөөрөмж, тавилга, гэрэлтүүлэг, дохиолол, камерийн хяналтын систем нь бусад орнуудын татваргүй барааны дэлгүүрийн түвшинд хийгдсэн байх; 171.1.3.хилийн боомтод байгуулагдсан татваргүй барааны дэлгүүрийн худалдааны танхим нь дэлгүүрээс худалдаж авсан бараг гаалийн нутаг дэвсгэрт нэвтрүүлэх, бусдад дамжуулах боломжийг хаасан байдлаар зохион байгуулагдсан байх; 171.1.4.татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хилийн чанад дахь бараа нийлүүлэгчтэй гэрээ байгуулсан байх; 171.1.5.бараг гаалийн болон бусад татвар үл шингэсэн, олон улсын жишигт нийцсэн үнээр борлуулах; 171.1.6.хилийн боомтод ажиллаж байгаа татваргүй барааны дэлгүүр нь зорчигчийн гадаадад зорчих тийз, гадаад паспорт, зорчигчийн гаалийн мэдүүлгийг үндэслэн үйлчлэх;	**236 дугаар зүйл.Татваргүй барааны дэлгүүрт тавигдах шаардлага** 236.1.Татваргүй барааны дэлгүүр дараах нөхцөл, шаардлагыг хангаж ажиллана: 236.1.1.олон улсын жишигт нийцсэн худалдааны танхим, агуулах, туслах байгууламжтай байх; 236.1.2.тоног төхөөрөмж, тавилга, гэрэлтүүлэг, дохиолол, камерийн хяналтын систем нь бусад орнуудын татваргүй барааны дэлгүүрийн түвшинд хийгдсэн байх; 236.1.3.хилийн боомтод байгуулагдсан татваргүй барааны дэлгүүрийн худалдааны танхим нь дэлгүүрээс худалдаж авсан бараг гаалийн нутаг дэвсгэрт нэвтрүүлэх, бусдад дамжуулах боломжийг хаасан байдлаар зохион байгуулагдсан байх; 236.1.4.татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч хилийн чанад дахь бараа нийлүүлэгчтэй гэрээ байгуулсан байх; 236.1.5.бараг гаалийн болон бусад татвар үл шингэсэн, олон улсын жишигт нийцсэн үнээр борлуулах; 236.1.6.хилийн боомтод ажиллаж байгаа татваргүй барааны дэлгүүр нь зорчигчийн гадаад паспорт, гадаадад зорчих тийз, эсхүл суух тасалбарыг үндэслэн үйлчлэх;		-

Хуулийн этгээдийн хүрээлэн

875.	171.1.7.татваргүй барааны дэлгүүр ажиллуулах зөвшөөрөл олгосноос хойш 3 сарын дотор үйл ажиллагаагаа эхлүүлэх;	236.1.8.татваргүй барааны дэлгүүр ажиллуулах зөвшөөрөл олгосноос хойш 3 сарын дотор үйл ажиллагаагаа эхлүүлэх;		-
876.	171.1.8.худалдааны тавигдах нөхцөл, шаардлага, стандартыг хангасан байх.	236.1.9.худалдааны тавигдах нөхцөл, шаардлага, стандартыг хангасан байх;		-
877.		236.1.7.нутаг дэвсгэрийн гүнд байрших дэлгүүр нь Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газар болон олон улсын байгууллагын дипломат эрх ямба, дархан эрх эдлэх албан тушаалтнуудад паспорт, эсхүл дипломат үнэмлэхийг үндэслэн үйлчилнэ.		*Шинээр нэмэгдсэн*
878.		236.1.10.гаалийн нэгдсэн онлайн сүлжээнд холбогдож, зураасан код ашиглан электрон бүртгэлийн системыг нэвтрүүлсэн байх.		*Шинээр нэмэгдсэн*
879.	**172 дугаар зүйл.Татваргүй барааны дэлгүүрийн бараа тарифын бус хязгаарлалтад хамаарах** 172.1.Татваргүй барааны дэлгүүрийн горимд байршуулах бараа Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалтад хамаарахгүй. 172.2.Татваргүй барааны дэлгүүрийн горимд байршуулах монголын бараа Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалтад хамаарна.			*Хасагдсан*
880.	**173 дугаар зүйл.Татваргүй барааны дэлгүүрийн горим дуусгавар болох** 173.1.Барааг борлуулснаар, эсхүл өөр горимд байршуулснаар, түүнчлэн татваргүй барааны дэлгүүр татан буугдсанаар татваргүй барааны дэлгүүрийн горим дуусгавар болно.	**237 дугаар зүйл.Татваргүй барааны дэлгүүрийн горим дуусгавар болох** 237.1.Барааг борлуулснаар, эсхүл өөр горимд байршуулснаар татваргүй барааны дэлгүүрийн горим дуусгавар болно.		*“түүнчлэн татваргүй барааны дэлгүүр татан буугдсанаар” гэснийг хассан*
881.	**Долдугаар дэд бүлэг Гаалийн тусгай бүсийн горим**			*Хасагдсан*
882.	**174 дүгээр зүйл.Гаалийн тусгай бүс** 174.1.Тодорхой нэг салбарын хөгжлийг дэмжих, дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх, хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх зорилгоор гаалийн нутаг дэвсгэр дээр гаалийн тусгай бүс байгуулж болно.			*Хасагдсан*
883.	**175 дугаар зүйл.Гаалийн тусгай бүсийн горимд байршуулах бараа** 175.1. Гаалийн тусгай бүсийн горимд дараахь барааг байршуулна: 175.1.1.монголын бараа; 175.1.2.хилийн чанадаас ирсэн гадаадын бараа; 175.1.3.бусад горимд байгаа бараа			*Хасагдсан*

ХЯНАЛТЫН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН www.nlis.gov.mn

884.	**176 дугаар зүйл.Гаалийн тусгай бусийн горимд байршуулах бараа тарифын бус хязгаарлалтад хамаарах** 176.1.Гаалийн тусгай бусийн горимд байршуулах гадаадын бараа Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоносоос бусад тарифын бус хязгаарлалтад хамаарахгүй. 176.2.Гаалийн нутаг дэвсгэрээс гаалийн тусгай бусийн горимд байршуулах монголын бараа Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоносоос бусад тарифын бус хязгаарлалтад хамаарна.			*Хасагдсан*
885.	**177 дугаар зүйл. Гаалийн тусгай бусэд тавигдах шаардлага** 177.1.Гаалийн тусгай бус дарааҳь нөхцөл, шаардлага хангасан байна: 177.1.1.тодорхой нэг салбарын хөгжлийг дэмжих, дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх, хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх зорилгоор энэ хуулийн 178.1-д заасан үйл ажиллагаа явуулахыг нотолсон бичиг баримт, холбогдох материал бүрдүүлсэн, шаардлагатай бол эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байх; 177.1.2.гаалийн тусгай бусийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл зэрмшигч нь гаалийн байгууллагын мэдээллийн сүлжээнд холбогдсон байх; 177.1.3.үйл ажиллагаатай нь холбоотой асуудлаар хяналт тавих талаар гаалийн байгууллагатай гэрээ байгуулах, шаардагдах мэдээ, тайланг тухай бүр гаргаж өгөх; 177.1.4.гаалийн тусгай бусэд оруулж байгаа бараа, тээврийн хэрэгслийг хянан бүртгэж, бараат боловсруулах, үйлдвэрлэх, үзэсгэлэнд тавих үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих, гаалийн хяналт, шалгалт явуулах, гаалийн улсын байцаагчийг ажиллах нөхцөлөөр хангасан байх; 177.1.5.гаалийн тусгай бусийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл зэрмшигч нь уг бусэд байгаа эд хөрөнгийн тоо ширхэг тооцоо, бүрэн бүтэн байдлыг хариуцах бөгөөд бусэд оруулсан барааны бүртгэлийг зохих маягтын дагуу хөтлөх, барааны хөдөлгөөний мэдээг харьяалагдах гаалийн байгууллагад сар тутам гаргаж өгөх; 177.1.6.гаалийн тусгай бусийг бусад барилга байгууламжаас тусгаарласан хашаатай, таних тэмдэг, анхааруулга тавьсан байх; 177.1.7.харуул хамгаалалт, дохиоллын найдвартай систем болон гэрэлтүүлэгтэй, галын аюулгүй байдлыг хангасан байх. 177.2.Гаалийн тусгай бусэд оруулсан барааны хадгалах хугацааг онцгой тохиолдоос бусад үед хязгаарлахгүй.			*Хасагдсан*

УЛСЫН ЗҮЙН ЯНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nli.gov.mn

886.	**178 дугаар зүйл.Гаалийн тусгай бүсэд явуулах үйл ажиллагаа** 178.1.Гаалийн тусгай бүсэд дараахь үйл ажиллагаа явуулна: 178.1.1.үйлдвэрлэл явуулах; 178.1.2.боловсруулалт хийх; 178.1.3.үйлчилгээ үзүүлэх.				*Хасагдсан*
887.	**179 дүгээр зүйл.Гаалийн тусгай бүсийн горим дуусгавар болох** 179.1.Бараат өөр горимд байршуулснаар, эсхүл гаалийн тусгай бүс татан буугдсанаар гаалийн тусгай бүсийн горим дуусгавар болно.				*Хасагдсан*
888.		**ЗУРГАДУГААР ДЭД БҮЛЭГ** **ЧӨЛӨӨТ БҮСИЙН ГОРИМ**			*Шинээр нэмэгдсэн*
889.		**238 дугаар зүйл.Чөлөөт бүсийн горимд байршуулах** 238.1.Чөлөөт бүсийн горимд дараах бараанг байршуулна: 238.1.1.хилийн чанадаас чөлөөт бүсэд оруулах гадаадын бараа; 238.1.2.гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд байгаа монголын бараа; 238.1.3.бусад горимд байгаа бараа. 238.2.Чөлөөт бүсийн төрөл, татварын асуудлыг Чөлөөт бүсийн тухай хуулиар зохицуулна.			

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.legal.gov.mn

890.		**239 дүгээр зүйл.Чөлөөт бүсийн горимын шаардлага** 239.1.Чөлөөт бүсэд оруулах, гаргах бараа, ажил үйлчилгээ нь гаалийн хяналтад байна. 239.2.Чөлөөт бүсийн орох, гарах хаалга, бүсийн доторхи барилга байгууламж, объектыг дохиоллын найдвартай систем, байнгын гэрэлтүүлгээр тоноглож, теле-хяналтын систем бүхий харуул хамгаалалттай байна. 239.3.Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд нь гаалийн нэгдсэн онлайн сүлжээнд холбогдсон, зураасан код ашиглан электрон бүртгэлийн системыг нэвтрүүлсэн байна. 239.4.Чөлөөт бүсийн горимд байршуулах бараанд Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалт хамаарахгүй. 239.5.Чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба нь гаалийн байгууллагыг үйл ажиллагаа явуулах хэвийн нөхцөлөөр хангана. 239.6.Мэдүүлэгч нь барааг чөлөөт бүсэд боловсруулахтай холбогдсон бүхий л мэдээллээр гаалийн байгууллагыг хангана. 239.7.Гадаадын барааг монголын бараатай нийлүүлж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, монголын барааг өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглах бол материалын орцын норм хэмжээг тогтоосон байна. 239.8.Барааг хилийн чанадаас чөлөөт бүсэд оруулах, чөлөөт бүсээс хилийн чанадад гаргахад гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт хийж болно.		*Шинээр нэмэгдсэн*
891.		**240 дүгээр зүйл.Чөлөөт бүсийн горим дуусгавар болох** 240.1.Барааг өөр горимд байршуулснаар чөлөөт бүсийн горим дуусгавар болно.		
892.	**АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ** **Барааг дамжуулан өнгөрүүлэх, шилжүүлэн ачих, хүлээн авахаас татгалзах, устгах горим**	**АРВАНТАВДУГААР БҮЛЭГ** **БАРААГ ДАМЖУУЛАН ӨНГӨРҮҮЛЭХ, ШИЛЖҮҮЛЭН АЧИХ ГОРИМ**		*“, хүлээн авахаас татгалзах, устгах” гэснийг хассан*
893.	**Нэгдүгээр дэд бүлэг** **Барааг улс хооронд дамжуулан өнгөрүүлэх горим**	**НЭГДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ** **БАРААГ УЛС ХООРОНД ДАМЖУУЛАН ӨНГӨРҮҮЛЭХ ГОРИМ**		-
894.	**180 дугаар зүйл.Барааг улс хооронд дамжуулан өнгөрүүлэх горимын агуулга** 180.1.Барааг улс хооронд дамжуулан өнгөрүүлэх горимын дагуу гадаадын бараанд өөрчлөлт оруулахгүйгээр тогтоосон хугацаанд, гаалийн замаар хилийн гаалийн нэг байгууллагаас хилийн гаалийн нөгөө байгууллагад шилжүүлнэ. 180.2.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх барааны хүлээн авагч болон илгээгч нь хилийн чанадад оршин суух буюу байрлана.	**241 дүгээр зүйл.Барааг улс хооронд дамжуулан өнгөрүүлэх горимын агуулга** 241.1.Барааг улс хооронд дамжуулан өнгөрүүлэх горимын дагуу гадаадын бараанд өөрчлөлт оруулахгүйгээр тогтоосон хугацаанд, гаалийн замаар хилийн гаалийн нэг байгууллагаас хилийн гаалийн нөгөө байгууллагад шилжүүлнэ. 241.2.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх барааны хүлээн авагч болон илгээгч нь хилийн чанадад оршин суух буюу байрлана.		-

ХУДАЛДАА ЭДИЙН ХУРЭЭЛЭН
www.tuzgov.mn

895.	180.3.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх барааг хадгалалт, тээвэрлэлтийн ердийн нөхцөлд гарах элэгдэл, хорогдлоос бусад өөрчлөлт оруулж болохгүй.			*Хасагдсан*
896.	**181 дүгээр зүйл.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах барааг тавигдах шаардлага** 181.1.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах бараа нь хилийн чанадаас Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрээр дамжин хилийн чанадад гарах бараа байна. 181.2.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах бараа дараахь шаардлагыг хангасан байна: 181.2.1.гаалийн байгууллага тухайн барааг хяналт тавих боломжтой;	**242 дугаар зүйл.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах барааг тавигдах шаардлага** 242.1.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах бараа нь хилийн чанадаас Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрээр дамжин хилийн чанадад гарах бараа байна. 242.2.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах бараа дараах шаардлагыг хангасан байна: 242.2.1.гаалийн байгууллага тухайн барааг хяналт тавих боломжтой;		-
897.	181.2.2.гаалийн байгууллага гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийх боломжтой;	242.2.3.гаалийн байгууллага гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийх боломжтой;		-
898.	181.2.3.барааг улс хооронд дамжуулан өнгөрүүлэхэд ашиглах тээврийн хэрэгсэл гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийх боломжтой байх.	242.3.Барааг улс хооронд дамжуулан өнгөрүүлэхэд ашиглах тээврийн хэрэгсэлд гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийх боломжтой байна.		*Заалтаар байсан зохицуулалт хэсэг болсон “байх.” гэснийг “байна” гэж өөрчилсөн*
899.		242.2.2.хадгалалт, тээвэрлэлтийн ердийн нөхцөлд гарах элэгдэл, хорогдлоос бусад өөрчлөлт орохгүй.		*Шинээр нэмэгдсэн*
900.		242.4.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх барааны тээврийн хэрэгслийг гаалийн байгууллагын зөвшөөрлөөр, гаалийн хяналт дор сольж болно.		*Шинээр нэмэгдсэн*
901.	**182 дугаар зүйл.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх горимын барааг гаалийн болон бусад татвар төлөх, баталгаа гаргах**	**243 дугаар зүйл.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах барааг гаалийн болон бусад татвар төлөх, баталгаа гаргах**		*“горимын” гэснийг “горимд байршуулах” гэж өөрчилсөн*
902.	182.1.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах барааг гаалийн байгууллага гаалийн болон бусад татвар ногдуулахгүй.	243.1.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах барааг гаалийн байгууллага гаалийн болон бусад татвар ногдуулахгүй.		-
903.	182.2.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх бараа энэ хуулийн 181.2-т заасан шаардлагыг хангаагүй бол гаалийн байгууллага Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд зааснаар баталгаа гаргуулж болно.	243.2.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх бараа энэ хуулийн 242.2-т заасан шаардлагыг хангаагүй бол гаалийн байгууллага Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд зааснаар баталгаа гаргуулж болно.		-
904.	**183 дугаар зүйл.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх горимын бараа тарифын бус хязгаарлалтад хамаарах** 183.1.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах барааг тарифын бус хязгаарлалт хамаарахгүй.	**244 дүгээр зүйл.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх горимын барааг тарифын бус хязгаарлалт хамаарах** 244.1.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах барааг дамжуулан өнгөрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалт хамаарахгүй.		*“барааг” гэсний дараа “дамжуулан өнгөрүүлэхийг хориглосноос бусад” гэж нэмсэн*

905.	**184 дүгээр зүйл.Барааанд гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийх** 184.1.Барааг улс хооронд дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулахад гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийнэ. 184.2.Энэ хуулийн 184.1-д заасан тэмдэглэгээ хийхдээ мөн хуулийн 261.1-д заасан тэмдэглэгээнээс аль тохирохыг нь сонгон хэрэглэнэ.			*Хасагдсан*
906.	**185 дугаар зүйл.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх барааг гаалийн замаар тээвэрлэх** 185.1.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх барааг олон улсын тээврийн маршрутаар, холбогдох байгууллагаас тогтоосон замаар тээвэрлэнэ. 185.2.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх барааг гаалийн удирдах төв байгууллагаас итгэмжлэл авсан тээвэрлэгч тээвэрлэнэ.	**245 дугаар зүйл.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх барааг гаалийн замаар тээвэрлэх** 245.1.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх барааг олон улсын тээврийн маршрутаар, холбогдох байгууллагаас тогтоосон замаар тээвэрлэнэ. 245.2.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх барааг гаалийн удирдах төв байгууллагаас итгэмжлэл авсан тээвэрлэгч тээвэрлэнэ.		-
907.	**186 дугаар зүйл.Бараа, тээврийн хэрэгслийг бүртгэх** 186.1.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулсан бараа, тээврийн хэрэгслийг хилийн гаалийн байгууллага бүртгэнэ.	**246 дугаар зүйл.Бараа, тээврийн хэрэгслийг бүртгэх** 246.1.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулсан бараа, тээврийн хэрэгслийг хилийн гаалийн байгууллага бүртгэнэ.		-
908.	**187 дугаар зүйл.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх горим дуусгавар болох** 187.1.Барааг улсын хилээр гаргаснаар, эсхүл өөр горимд байршуулснаар улс хооронд дамжуулан өнгөрүүлэх горим дуусгавар болно.	**247 дугаар зүйл.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх горим дуусгавар болох** 247.1.Барааг улсын хилээр гаргаснаар, эсхүл өөр горимд байршуулснаар улс хооронд дамжуулан өнгөрүүлэх горим дуусгавар болно.		-
909.	**Хоёрдугаар дэд бүлэг Барааг дотоодод дамжуулан өнгөрүүлэх**	**ХОЁРДУГААР ДЭД БҮЛЭГ БАРААГ ДОТООДОД ДАМЖУУЛАН ӨНГӨРҮҮЛЭХ ГОРИМЫН**		-
910.	**188 дугаар зүйл.Барааг дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимын агуулга** 188.1.Дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимын дагуу барааг өөрчлөлт оруулахгүйгээр, тогтоосон хугацаанд Монгол Улсын нутаг дэвсгэрт гаалийн хяналт дор дараахь гаалийн байгууллагын хооронд тээвэрлэнэ: 188.1.1.хилийн гаалийн байгууллагаас гүний гаалийн байгууллага хооронд; 188.1.2.гүний гаалийн байгууллагаас хилийн гаалийн байгууллага хооронд; 188.1.3.гүний гаалийн нэг байгууллагаас гүний гаалийн нөгөө байгууллага хооронд; 188.1.4.хилийн гаалийн нэг байгууллагаас хилийн гаалийн нөгөө байгууллага хооронд. 188.2.Монгол Улсын хилээс хилийн гаалийн байгууллага хооронд, эсхүл хилийн гаалийн байгууллагаас Монгол Улсын хил хүртэл барааг дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимын дагуу тээвэрлэнэ.	**248 дугаар зүйл.Барааг дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимын агуулга** 248.1.Дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимын дагуу барааг өөрчлөлт оруулахгүйгээр, тогтоосон хугацаанд Монгол Улсын нутаг дэвсгэрт гаалийн хяналт дор дараах гаалийн байгууллагын хооронд тээвэрлэнэ: 248.1.1.хилийн гаалийн байгууллагаас гүний гаалийн байгууллага хооронд; 248.1.2.гүний гаалийн байгууллагаас хилийн гаалийн байгууллага хооронд; 248.1.3.гүний гаалийн нэг байгууллагаас гүний гаалийн нөгөө байгууллага хооронд; 248.1.4.хилийн гаалийн нэг байгууллагаас хилийн гаалийн нөгөө байгууллага хооронд. 248.2.Монгол Улсын хилээс хилийн гаалийн байгууллага хооронд, эсхүл хилийн гаалийн байгууллагаас Монгол Улсын хил хүртэл барааг дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимын дагуу тээвэрлэнэ.		-

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
ИНН ... ПРОЕКТ

911.	**189 дүгээр зүйл.Дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах бараанд тавигдах шаардлага** 189.1.Дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах бараа дараахь шаардлагыг хангасан байна: 189.1.1.гаалийн байгууллага тухайн бараанд хяналт тавих боломжтой; 189.1.2.гаалийн байгууллага гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийх боломжтой; 189.1.3.барааг дотоодод дамжуулан өнгөрүүлэхэд ашиглах тээврийн хэрэгсэлд гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийх боломжтой байх.	**249 дүгээр зүйл.Дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах бараанд тавигдах шаардлага** 249.1.Дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах бараа дараах шаардлагыг хангасан байна: 249.1.1.гаалийн байгууллага тухайн бараанд хяналт тавих боломжтой; 249.1.2.гаалийн байгууллага гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийх боломжтой; 249.1.3.барааг дотоодод дамжуулан өнгөрүүлэхэд ашиглах тээврийн хэрэгсэлд гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийх боломжтой байх.		-
912.	**190 дүгээр зүйл.Дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах барааны гаалийн болон бусад татвар төлөх, баталгаа гаргах** 190.1.Дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах бараанд гаалийн байгууллага гаалийн болон бусад татвар ногдуулж, хураан авч улсын төсөвт төвлөрүүлнэ. 190.2.Дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах бараанд гаалийн болон бусад татвар төлөх баталгааг Гаалийн тариф, гаалийн татварын хуульд заасны дагуу гаргуулж болно.	**250 дугаар зүйл.Дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах барааны гаалийн болон бусад татвар төлөх, баталгаа гаргах** 250.1.Энэ хуулийн 248.1.2-д заасан дотоодод дамжуулан өнгөрүүлэх бараанд гаалийн байгууллага гаалийн болон бусад татвар ногдуулж, хураан авч улсын төсөвт төвлөрүүлнэ. 250.2.Дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах бараанд гаалийн болон бусад татвар төлөх баталгааг Гаалийн тариф, гаалийн татварын хуульд заасны дагуу гаргуулж болно.		-
913.	**191 дүгээр зүйл.Дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах бараа тарифын бусхязгаарлалтад хамаарах** 191.1.Дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах бараа Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалтад хамаарахгүй.			*Хасагдсан*
914.	**192 дугаар зүйл.Гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу шаардагдах бичиг баримт** 192.1.Хилийн гаалийн байгууллагаас гүний гаалийн байгууллагад хүргэх барааг дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулахад ачааны манифестыг үндэслэнэ. 192.2.Гүний гаалийн байгууллагаас хилийн гаалийн байгууллагад хүргэх барааг дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулахад гаалийн мэдүүлгийг үндэслэнэ.	**251 дүгээр зүйл.Гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу шаардагдах бичиг баримт** 251.1.Гаалийн байгууллага хооронд барааг тээвэрлэхэд ачааны манифест, эсхүл тээврийн мэдүүлгийг үндэслэнэ.		*192.1, 192.2 дахь хэсгүүдийг нэгтгэж 251.1 дэх хэсэг болгосон*
915.	**193 дугаар зүйл. Дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах бараанд гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийх** 193.1.Барааг дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулахад гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийнэ. 193.2.Энэ хуулийн 193.1-д заасан тэмдэглэгээ хийхдээ мөн хуулийн 261.1-д заасан тэмдэглэгээнээс аль тохирохыг нь сонгон хэрэглэнэ.	**252 дугаар зүйл.Дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах бараанд гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийх** 252.1.Барааг дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах бараанд гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийнэ. 252.2.Энэ хуулийн 252.1-д заасан тэмдэглэгээ хийхдээ мөн хуулийн 135.1-д заасан тэмдэглэгээнээс аль тохирохыг нь сонгон хэрэглэнэ.		-

ХУУЛЬ ЗҮЙ ХЭЛЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.mn.gov.mn

916.	**194 дүгээр зүйл.Гаалийн замаар дотоодод дамжуулан өнгөрүүлэх барааг тээвэрлэх** 194.1.Дотоодод дамжуулан өнгөрүүлэх барааг гаалийн байгууллагаас тогтоосон замаар тээвэрлэнэ. 194.2.Дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах барааг гаалийн удирдах төв байгууллагаас итгэмжлэл авсан тээвэрлэгч тээвэрлэнэ.	**253 дугаар зүйл.Гаалийн замаар дотоодод дамжуулан өнгөрүүлэх барааг тээвэрлэх** 253.1.Дотоодод дамжуулан өнгөрүүлэх барааг гаалийн байгууллагаас тогтоосон замаар тээвэрлэнэ. 253.2.Дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах барааг гаалийн удирдах төв байгууллагаас итгэмжлэл авсан тээвэрлэгч тээвэрлэнэ.		-
917.	**195 дугаар зүйл.Бараа, тээврийн хэрэгслийг бүртгэх** 195.1.Дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулсан бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллага бүртгэнэ.	**254 дүгээр зүйл.Бараа, тээврийн хэрэгслийг бүртгэх** 254.1.Дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулсан бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллага бүртгэнэ.		-
918.	**196 дугаар зүйл.Барааг дотоодод дамжуулан өнгөрүүлэх горим дуусгавар болох** 196.1.Барааг Монгол Улсын хилээр гаргаснаар, эсхүл өөр горимд байршуулснаар дотоодод дамжуулан өнгөрүүлэх горим дуусгавар болно.	**255 дугаар зүйл.Барааг дотоодод дамжуулан өнгөрүүлэх горим дуусгавар болох** 255.1.Барааг Монгол Улсын хилээр гаргаснаар, эсхүл өөр горимд байршуулснаар дотоодод дамжуулан өнгөрүүлэх горим дуусгавар болно.		-
919.	**Гуравдугаар дэд бүлэг Бараа шилжүүлэн ачих горим**	**ГУРАВДУГААР ДЭД БҮЛЭГ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ ГОРИМ**		-
920.	**197 дугаар зүйл.Шилжүүлэн ачих горимын агуулга** 197.1.Шилжүүлэн ачих горимын дагуу холбогдох бичиг баримтыг үндэслэн барааанд өөрчлөлт оруулахгүйгээр хилийн гаалийн нэг байгууллагын хяналтын бүсэд улсын хилээр орсон тээврийн хэрэгслээс гарах тээврийн хэрэгсэлд уг барааг шилжүүлэн байршуулна.	**256 дугаар зүйл.Шилжүүлэн ачих горимын агуулга** 256.1.Шилжүүлэн ачих горимын дагуу холбогдох бичиг баримтыг үндэслэн барааанд өөрчлөлт оруулахгүйгээр хилийн гаалийн нэг байгууллагын хяналтын бүсэд улсын хилээр орсон тээврийн хэрэгслээс гарах тээврийн хэрэгсэлд уг барааг шилжүүлэн байршуулна.		-
921.	**198 дугаар зүйл.Шилжүүлэн ачих горимд байршуулах бараа** 198.1.Шилжүүлэн ачих горимд байршуулах бараа нь хилийн чанадаас ирсэн гаалийн нутаг дэвсгэрээр дамжуулалгүйгээр хилийн чанадад гарах гадаадын бараа байна.	**257 дугаар зүйл.Шилжүүлэн ачих горимд байршуулах бараа** 257.1.Шилжүүлэн ачих горимд хилийн чанадаас ирсэн,гаалийн нутаг дэвсгэрээр дамжихгүйгээр хилийн чанадад гарах гадаадын барааг байршуулна.		*“бараа байна” гэснийг “барааг байршуулна” гэж өөрчилсөн*
922.	**199 дүгээр зүйл.Шилжүүлэн ачих барааны татвар** 199.1.Шилжүүлэн ачих горимд байршуулах барааанд гаалийн байгууллага гаалийн болон бусад татвар ногдуулахгүй.	**258 дугаар зүйл.Шилжүүлэн ачих барааны татвар** 258.1.Шилжүүлэн ачих горимд байршуулах барааанд гаалийн байгууллага гаалийн болон бусад татвар ногдуулахгүй.		-
923.	**200 дугаар зүйл.Шилжүүлэн ачих горимын бараа тарифын бус хязгаарлалтад хамаарах** 200.1.Шилжүүлэн ачих горимд байршуулах бараа тарифын бус хязгаарлалтад хамаарахгүй.	**259 дүгээр зүйл.Шилжүүлэн ачих горимд байршуулах бараа тарифын бус хязгаарлалтад хамаарах** 259.1.Шилжүүлэн ачих горимд байршуулах бараа тарифын бус хязгаарлалтад хамаарахгүй.		*“горимын” гэснийг “горимд байршуулах” гэж өөрчилсөн*
924.	**201 дүгээр зүйл.Шилжүүлэн ачих горим дуусгавар болох** 201.1.Барааг улсын хилээр гаргаснаар, эсхүл өөр горимд байршуулснаар шилжүүлэн ачих горим дуусгавар болно.	**260 дугаар зүйл.Шилжүүлэн ачих горим дуусгавар болох** 260.1.Барааг улсын хилээр гаргаснаар, эсхүл өөр горимд байршуулснаар шилжүүлэн ачих горим дуусгавар болно.		-

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМАНЫ ХУРЭЭЛЭН
www.zhi.gov.mn

925.		**АРВАНЗУРГАДУГААР БҮЛЭГ БАРААГ ХҮЛЭЭН АВАХААС ТАТГАЛЗАХ, УСТГАХ ГОРИМ**		*Шинээр нэмэгдсэн*
926.	**Дөрөвдүгээр дэд бүлэг Бараг хүлээн авахаас татгалзах горим**	**НЭГДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ БАРААГ ХҮЛЭЭН АВАХААС ТАТГАЛЗАХ ГОРИМ**		-
927.	**202 дугаар зүйл.Бараг хүлээн авахаас татгалзах горимын агуулга** 202.1.Хүлээн авагч нь гаалийн хяналтад байгаа бараг хүлээн авахаас татгалзвал уг бараг хүлээн авахаас татгалзах горимд байршуулна.	**261 дүгээр зүйл.Бараг хүлээн авахаас татгалзах горимын агуулга** 261.1.Хүлээн авагч нь гаалийн хяналтад байгаа бараг хүлээн авахаас татгалзсан тухай гаалийн байгууллагад бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн бараг хүлээн авахаас татгалзах горимд байршуулна.		*“татгалзвал” гэснийг “татгалзсан тухай гаалийн байгууллагад бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн” гэж өөрчилсөн*
928.	202.2.Бараг энэ хуулийн 202.1-д заасан горимд байршуулсан тохиолдолд түүний тээвэрлэлт, зуучлал, хадгалалттай холбогдон гарах зардлыг мэдүүлэгч хариуцна.	261.2.Бараг энэ хуулийн 261.1-д заасан горимд байршуулсан тохиолдолд түүний тээвэрлэлт, зуучлал, хадгалалттай холбогдон гарах зардлыг мэдүүлэгч хариуцна.		-
929.	**203 дугаар зүйл.Хүлээн авахаас татгалзах горимд байршуулах бараа** 203.1.Хүлээн авахаас татгалзах горимд байршуулах бараа нь түүнийг борлуулсны дараа зардлаа нөхөх боломжтой байна. 203.2.Энэ хуулийн 203.1-д заасан нөхцөл хангаагүй бараг бараа устгах горимд байршуулна.	**262 дугаар зүйл.Хүлээн авахаас татгалзах горимд байршуулах бараа** 262.1.Хүлээн авахаас татгалзах горимд байршуулах бараа нь түүнийг борлуулсны дараа зардлаа нөхөх боломжтой байна. 262.2.Энэ хуулийн 262.1-д заасан нөхцөл хангаагүй бараг бараа устгах горимд байршуулна.		-
930.	**204 дүгээр зүйл.Бараг хүлээн авахаас татгалзах горимын барааны татвар**	**263 дугаар зүйл.Бараг хүлээн авахаас татгалзах горимд байршуулах барааны татвар**		*“горимын” гэснийг “горимд байршуулах” гэж өөрчилсөн*
931.	204.1.Хүлээн авахаас татгалзах горимд байршуулах бараанд гаалийн байгууллага гаалийн болон бусад татвар ногдуулахгүй.	263.1.Хүлээн авахаас татгалзах горимд байршуулах бараанд гаалийн байгууллага гаалийн болон бусад татвар ногдуулахгүй.		-
932.	**205 дугаар зүйл.Бараг хүлээн авахаас татгалзах горимын бараа тарифын бус хязгаарлалтад хамаарах** 205.1.Хүлээн авахаас татгалзах горимд байршуулах бараа Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалтад хамаарахгүй.	**264 дүгээр зүйл.Бараг хүлээн авахаас татгалзах горимд байршуулах бараа тарифын бус хязгаарлалтад хамаарах** 264.1.Хүлээн авахаас татгалзах горимд байршуулах бараа Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалтад хамаарахгүй.		-
933.	**206 дугаар зүйл.Гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу шаардагдах бичиг баримт** 206.1.Хүлээн авахаас татгалзах горимд бараг байршуулахад холбогдох байгууллагын дүгнэлт гаргуулсан байна.	**265 дугаар зүйл.Гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу шаардагдах бичиг баримт** 265.1.Хүлээн авахаас татгалзах горимд бараг байршуулахад холбогдох байгууллагын дүгнэлт гаргуулсан байна.		-
934.	**207 дугаар зүйл.Бараг хүлээн авахаас татгалзах горим дуусгавар болох** 207.1.Холбогдох бараг төрийн өмчлөлд шилжүүлснээр бараг хүлээн авахаас татгалзах горим дуусгавар болно.	**266 дугаар зүйл.Бараг хүлээн авахаас татгалзах горим дуусгавар болох** 266.1.Холбогдох бараг төрийн өмчлөлд шилжүүлснээр бараг хүлээн авахаас татгалзах горим дуусгавар болно.		-

935.	**Тавдугаар дэд бүлэг Бараа устгах горим**	**ХОЁРДУГААР ДЭД БҮЛЭГ БАРАА УСТГАХ ГОРИМ**		
936.	**208 дугаар зүйл.Бараа устгах горимын агуулга** 208.1.Бараа гаалийн хяналтад байх хугацаанд гэмтэж муудсан, чанарын шаардлага хангахгүй болсон, мэргэжлийн холбогдох байгууллагын дүгнэлтээр эрүүл ахуй, эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөлтэй болох нь тогтоогдсон бол түүнийг байгаль орчинд хор хөнөөлгүй аргаар гаалийн байгууллагын хяналтын дор устгана.	**267 дугаар зүйл.Бараа устгах горимын агуулга** 267.1.Бараа гаалийн хяналтад байх хугацаанд гэмтэж муудсан, чанарын шаардлага хангахгүй болсон, мэргэжлийн холбогдох байгууллагын дүгнэлтээр эрүүл ахуй, эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөлтэй болох нь тогтоогдсон бол түүнийг байгаль орчинд хор хөнөөлгүй аргаар гаалийн байгууллагын хяналтын дор устгана.		-
937.	208.2.Энэ хуулийн 8.3-т заасан барааг устгах горимд байршуулна.			*Хасагдсан*
938.	208.3.Энэ хуулийн 208.1, 208.2-т заасан барааг эдийн засгийн анхны байдалдаа орохооргүйгээр устгана.	267.3.Энэ хуулийн 267.1-дзаасан барааг эдийн засгийн анхны байдалдаа орохооргүйгээр устгана.		-
939.		267.2.Мэдүүлэгч нь барааг устгах горимд байршуулах хүсэлт, мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг гаалийн байгууллагад бичгээр гарган өгсөн байх бөгөөд горимын нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд барааг уг горимд байршуулахыг гаалийн байгууллага зөвшөөрнө. 267.3.Барааг устгах арга хэлбэр, ажиллагааг мэдүүлэгч мэргэжлийн хяналтын байгууллагатай зөвшилцөж, хариуцан гүйцэтгэнэ.		*Шинээр нэмэгдсэн*
940.	**209 дүгээр зүйл.Устгах горимд үл байршуулах бараа**	**268 дугаар зүйл.Устгах горимд үл байршуулах бараа**		
941.	209.1.Дор дурдсанаас бусад барааг устгах горимд байршуулж болно:	268.1.Дор дурдсан барааг устгах горимд байршуулахгүй:		*“дурдсанаас бусад” гэснийг “дурдсан” гэж өөрчилсөн*
942.	209.1.1.түүх, соёлын дурсгалт зүйл; 209.1.2.амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйл, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн /хүн, малын гоц халдварт өвчин гарснаас бусад тохиолдолд/; 209.1.3.гаалийн болон бусад татварын барьцаанд байгаа бараа; 209.1.4.холбогдох хуулийн дагуу саатуулагдсан, битүүмжлэгдсэн эд хөрөнгө; 209.1.5.гаалийн хууль тогтоомжоор устгахыг хориглосон бусад бараа.	268.1.1.түүх, соёлын дурсгалт зүйл; 268.1.2.амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйл, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн /хүн, малын гоц халдварт өвчин гарснаас бусад тохиолдолд/; 268.1.3.гаалийн болон бусад татварын барьцаанд байгаа бараа; 268.1.4.холбогдох хуулийн дагуу саатуулагдсан, битүүмжлэгдсэн эд хөрөнгө; 268.1.5.гаалийн хууль тогтоомжоор устгахыг хориглосон бусад бараа.		-
943.	**210 дугаар зүйл.Устгах горимын барааны татвар** 210.1.Устгах горимд байршуулах барааанд гаалийн байгууллага гаалийн болон бусад татвар үл ногдуулна.	**269 дүгээр зүйл.Устгах горимд байршуулах барааны татвар** 269.1.Устгах горимд байршуулах барааанд гаалийн байгууллага гаалийн болон бусад татвар үл ногдуулна.		-
944.	**211 дүгээр зүйл.Устгах горимын барааанд тарифын бус хязгаарлалт хамаарах** 211.1.Устгах горимд байршуулах бараа тарифын бус хязгаарлалтад хамаарахгүй.	**270 дугаар зүйл.Устгах горимд байршуулах барааанд тарифын бус хязгаарлалт хамаарах** 270.1.Устгах горимд байршуулах бараа тарифын бус хязгаарлалтад хамаарахгүй.		*“горимын” гэснийг “горимд байршуулах” гэж өөрчлсөн*

ХУУЛЬ ЗҮЙЛ ХЭРЭГЛЭНИЙ ХҮРЭЭЛЭН www.pfu.gov.mn

945.	**212 дугаар зүйл.Барааг устгаж үл болох тохиолдол** 212.1.Дараахь нөхцөл байдал үүсэхээр байвал бараа устгахыг хориглоно: 212.1.1.тухайн барааг устгах нь байгаль орчинд илэрхий хор хөнөөл учруулахаар бол; 212.1.2.тухайн барааг устгах нь хүний амь нас, эрүүл мэндэд шууд, эсхүл болзошгүй аюул учруулахаар бол.	**271 дүгээр зүйл.Барааг устгаж үл болох тохиолдол** 271.1.Дараах нөхцөл байдал үүсэхээр байвал бараа устгахыг хориглоно: 271.1.1.тухайн барааг устгах нь байгаль орчинд илэрхий хор хөнөөл учруулахаар бол; 271.1.2.тухайн барааг устгах нь хүний амь нас, эрүүл мэндэд шууд, эсхүл болзошгүй аюул учруулахаар бол;		-
946.		271.1.3.барааг устгахад гаалийн байгууллага хяналт тавих боломжгүй бол.		*Шинээр нэмэгдсэн*
947.	212.2.Барааг зориулалтаар нь хэрэглэх замаар устгахыг хориглоно.	271.2.Барааг зориулалтаар нь хэрэглэх замаар устгахыг хориглоно.		-
948.		271.3.Барааг устгах явцад бий болсон цаашид өөр зориулалтаар ашиглах боломжтой хаягдал хэсэг, үлдэгдлийг импорт, экспортын барааны нэгэн адилаар гаалийн хяналтан дор хадгалж, гаалийн удирдах төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн дараагийн хэрэглэгчдэд шилжүүлэх бөгөөд түүнийг гаалийн бүрдүүлэлтийн өөр горимд шилжүүлнэ.		*Шинээр нэмэгдсэн*
949.	**213 дугаар зүйл.Гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу шаардагдах бичиг баримт** 213.1.Барааг устгах горимд байршуулахад гаалийн байгууллага шаардлагатай бол мэргэжлийн холбогдох байгууллагын дүгнэлт, барааг устгахыг зөвшөөрсөн эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөс өөр бичиг баримт шаардахгүй.	**272 дугаар зүйл.Гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу шаардагдах бичиг баримт** 272.1.Барааг устгах горимд байршуулах барааnd гаалийн байгууллага шаардлагатай бол мэргэжлийн холбогдох байгууллагын дүгнэлт, барааг устгахыг зөвшөөрсөн эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөс өөр бичиг баримт шаардахгүй.		*“байршуулах” гэсний дараа “барааnd” гэж нэмсэн*
950.	**214 дүгээр зүйл.Бараа устгах горим дуусгавар болох** 214.1.Холбогдох барааг устгаснаар бараа устгах горим дуусгавар болно.	**273 дугаар зүйл.Бараа устгах горим дуусгавар болох** 273.1.Холбогдох барааг устгаснаар, эсхүл устгах ажиллагаанаас үлдсэн хаягдал, үлдэгдлийг өөр горимд байршуулснаар бараа устгах горим дуусгавар болно.		*Өөрчлөн найруулсан*
951.	**АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ Түсгай горим**	**АРВАНДОЛООДУГААР БҮЛЭГ ТУСГАЙ ГОРИМ**		-
952.	**Нэгдүгээр дэд бүлэг Улс хоорондын тээврийн үйлчилгээний барааг нэвтрүүлэх горим**	**НЭГДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ УЛС ХООРОНДЫН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАРААГ НЭВТРҮҮЛЭХ ГОРИМ**		-
953.	**215 дугаар зүйл.Улс хоорондын тээврийн үйлчилгээний барааг нэвтрүүлэх горимын агуулга** 215.1.Улс хоорондын тээврийн үйлчилгээний барааг нэвтрүүлэх горимын дагуу шаардагдах бичиг баримтыг үндэслэн тухайн аяллын үед зорчигч болон багийн гишүүдийн хэрэгцээнд, түүнчлэн тээврийн хэрэгслийн хэвийн ажиллагааг хангахад зориулагдсан барааг гаалийн хилээр нэвтрүүлнэ.	**274 дүгээр зүйл.Улс хоорондын тээврийн үйлчилгээний барааг нэвтрүүлэх горимын агуулга** 274.1.Горимын дагуу шаардагдах бичиг баримтыг үндэслэн тухайн аяллын үед шаардлагатай барааг гаалийн хилээр нэвтрүүлэнэ.		*Өөрчлөн найруулсан*

954.	**216 дугаар зүйл.Улс хоорондын тээврийн үйлчилгээний горимд байршуулах бараа** 216.1.Улс хоорондын тээврийн үйлчилгээний горимд дараахь барааг байршуулна: 216.1.1.улс хооронд аяллын хугацаанд тээврийн хэрэгслийн хэвийн ажиллагаа, техник үйлчилгээг хангах бараа; 216.1.2.зорчигч, багийн гишүүдийн аяллын хугацаанд хэрэглэх бараа; 216.1.3.зорчигчид зориулан борлуулах татваргүй барааны дэлгүүрийн горимд байгаа бараа. 216.2.Улс хоорондын тээврийн үйлчилгээ эрхэлж буй дотоодын тээврийн хэрэгсэлд нийлүүлэх шатах, тослох материалыг энэ хуулийн 215.1-д заасан горимд байршуулахыг хориглоно.	**275 дугаар зүйл.Улс хоорондын тээврийн үйлчилгээний горимд байршуулах бараа** 275.1.Улс хоорондын тээврийн үйлчилгээний горимд дараах барааг байршуулна: 275.1.1.улс хооронд аяллын хугацаанд тээврийн хэрэгслийн хэвийн ажиллагаа, техник үйлчилгээг хангах бараа; 275.1.2.зорчигч, багийн гишүүдийн аяллын хугацаанд хэрэглэх бараа; 275.1.3.зорчигчид зориулан борлуулах татваргүй барааны дэлгүүрийн горимд байгаа бараа. 275.2.Улс хоорондын тээврийн үйлчилгээ эрхэлж буй дотоодын тээврийн хэрэгсэлд нийлүүлэх шатах, тослох материалыг энэ хуулийн 274.1-д заасан горимд байршуулахыг хориглоно.		-
955.	**217 дугаар зүйл.Улс хоорондын тээврийн үйлчилгээний барааны татвар** 217.1.Улс хоорондын тээврийн үйлчилгээний барааг гаалийн хилээр нэвтрүүлэхэд гаалийн байгууллага гаалийн болон бусад татвар үл ногдуулна. 217.2.Дотоодын хэрэглээнд зориулан оруулсан горимын барааг энэ хуулийн 215.1-д заасан горимд байршуулахад урьд нь төлсөн импортын гаалийн татварыг буцаан олгохгүй.	**276 дугаар зүйл.Улс хоорондын тээврийн үйлчилгээний барааны татвар** 276.1.Улс хоорондын тээврийн үйлчилгээний барааг гаалийн хилээр нэвтрүүлэхэд гаалийн байгууллага гаалийн болон бусад татвар үл ногдуулна. 276.2.Дотоодын хэрэглээнд зориулан оруулах горимд байршуулсан барааг энэ хуулийн 274.1-д заасан горимд байршуулахад урьд нь төлсөн импортын гаалийн татварыг буцаан олгохгүй.		-
956.	**218 дугаар зүйл.Улс хоорондын тээврийн үйлчилгээний бараа тарифын бус хязгаарлалтад хамаарах** 218.1.Улс хоорондын тээврийн үйлчилгээний горимын бараа Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалтад үл хамаарна.	**277 дугаар зүйл.Улс хоорондын тээврийн үйлчилгээний бараа тарифын бус хязгаарлалтад хамаарах** 277.1.Улс хоорондын тээврийн үйлчилгээний горимд байршуулах барааанд Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалт үл хамаарна.		-
957.	**219 дүгээр зүйл.Улс хоорондын тээврийн үйлчилгээний барааг нэвтрүүлэх горим дуусгавар болох** 219.1.Барааг зориулалтаар нь зарцуулснаар энэ хуулийн 215.1-д заасан горим дуусгавар болно.	**278 дугаар зүйл.Улс хоорондын тээврийн үйлчилгээний барааг нэвтрүүлэх горим дуусгавар болох** 278.1.Барааг зориулалтаар нь зарцуулснаар энэ хуулийн 274.1-д заасан горим дуусгавар болно.		-
958.	**Хоёрдугаар дэд бүлэг Дипломат төлөөлөгчийн газар болон түүнтэй адилтгах бусад байгууллагын барааг гаалийн хилээр нэвтрүүлэх**	**ХОЁРДУГААР ДЭД БҮЛЭГ ДИПЛОМАТ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ БУСАД БАЙГУУЛЛАГЫН БАРААГ ГААЛИЙН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ**		
959.	**220 дугаар зүйл.Дипломат төлөөлөгчийн газар болон түүнтэй адилтгах бусад байгууллагын барааг гаалийн хилээр нэвтрүүлэх**	**96 дугаар зүйл.Дипломат төлөөлөгчийн газар болон түүнтэй адилтгах бусад байгууллагын бараа**		
960.	220.1.Дипломат төлөөлөгчийн газар болон түүнтэй адилтгах бусад байгууллагын гаалийн хилээр нэвтрүүлэх бараанд дараахь бараа хамаарна:	96.1.Дипломат төлөөлөгчийн газар болон түүнтэй адилтгах бусад байгууллагын гаалийн хилээр нэвтрүүлэх бараанд дараах бараа хамаарна:		
961.	220.1.1.гадаадын дипломат төлөөлөгчийн газар болон түүнтэй адилтгах бусад байгууллагын албан хэрэгцээний бараа;	96.1.1.гадаадын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, түүнтэй адилтгах бусад байгууллагын албан хэрэгцээний бараа;		

Хуулийн Хүрээлэн ULU.MN.MN.gov.mn

962.	220.1.2.гадаадын дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, дипломат ажилтан, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн суух улсдаа шилжин суурьшихад шаардагдах хувийн хэрэглээний эд зүйл;	96.1.2.гадаадын дипломат төлөөлөгчийн болон консулын газрын тэргүүн, дипломат ажилтан, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн суух улсдаа шилжин суурьшихад шаардагдах хувийн хэрэглээний эд зүйл;		
963.	220.1.3.гадаадын дипломат төлөөлөгчийн газрын үйлчилгээ, техникийн ажилтан, тэдгээрийн гэр бүлийн гишүүд Монгол Улсын иргэн биш, Монгол Улсад байнга оршин суугч биш бол суух улсдаа шилжин суурьшихад шаардагдах хувийн хэрэглээний эд зүйл;	96.1.3.гадаадын дипломат төлөөлөгчийн болон консулын газрын үйлчилгээ, техникийн ажилтан, тэдгээрийн гэр бүлийн гишүүд Монгол Улсын иргэн биш, Монгол Улсад байнга оршин суугч биш бол суух улсдаа шилжин суурьшихад шаардагдах хувийн хэрэглээний эд зүйл;		
964.	220.1.4.дипломат шуудан.	96.1.4.дипломат шуудан.		
965.		**97 дугаар зүйл.Дипломат төлөөлөгчийн газар болон түүнтэй адилтгах бусад байгууллагын барааг гаалийн хилээр нэвтрүүлэх нөхцөл, шаардлага**		
966.		97.1.Энэ хуулийн 96.1-д заасан бараа нь хориглосноос бусад тарифын бус хязгаарлалтад үл хамаарна.		
967.		97.2.Энэ хуулийн 96.1.1-д заасан бараа зөвхөн тухайн байгууллагын хэрэгцээнд зориулагдсан байх бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулахад шаардагдах хэмжээгээр хязгаарлагдана.		
968.		97.3.Энэ хуулийн 96.1.1-д дурьдсан барааг гадаадын дипломат төлөөлөгчийн газар болон түүнтэй адилтгах бусад байгууллагын албан бичиг, барааны жагсаалтыг үндэслэн гаалийн бүрдүүлэлт хийж, улсын хилээр нэвтрүүлнэ. Албан бичиг, барааны жагсаалтыг гаалийн мэдүүлэгт тооцно. Барааны жагсаалтад барааны нэр, тоо хэмжээ, хэмжих нэгж, нийт үнэ, улсын хилээр нэвтрүүлсэн он, сар, өдөр зэргийг тусгасан байна.		
969.		**98 дугаар зүйл.Дипломат төлөөлөгчийн газар болон түүнтэй адилтгах бусад байгууллагын барааг гаалийн хилээр нэвтрүүлэх нөхцөл, шаардлага**		
970.	220.2.Энэ хуулийн 220.1-д заасан бараанд гаалийн болон бусад татвар ногдуулахгүй бөгөөд Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалтад үл хамаарна.	98.1.Энэ хуулийн 96.1-д заасан бараанд гаалийн агуулахад хадгалах, захиалга дуудлагаар гаалийн бүрдүүлэлт хийхэд авах хураамжаас бусад хураамж, татвар ногдуулахгүй.		
971.	220.3.Хүн, малын гоц халдварт өвчин гарсан, эсхүл Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон бараа байгаа гэх хангалттай үндэслэл байхгүй бол энэ хуулийн 220.1-д заасан бараанд гаалийн шалгалт хийхийг хориглоно.	98.2.Хүн, малын гоц халдварт өвчин гарсан, эсхүл Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон бараа байгаа гэх хангалттай үндэслэл байхгүй бол энэ хуулийн 96.1-д заасан бараанд гаалийн шалгалт хийхгүй.		
972.	220.4.Энэ хуулийн 220.3-т заасан үндэслэл байна гэж үзвэл гаалийн байгууллага гадаадын дипломат төлөөлөгчийн газрын бие төлөөлөгчийг байлцуулан шалгалт хийнэ.	98.3.Энэ хуулийн 98.2-т заасан үндэслэл байна гэж үзвэл гаалийн байгууллага гадаадын дипломат төлөөлөгчийн газрын бие төлөөлөгчийг байлцуулан барааанд шалгалт хийнэ.		

973.	220.5.Энэ хуулийн 220.1-д заасан барааг гаалийн хилээр нэвтрүүлэх журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.	98.4.Энэ хуулийн 96.1-д заасан барааг гаалийн хилээр нэвтрүүлэх журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.		
974.		**99 дүгээр зүйл.Гадаадын дипломат төлөөлөгчийн болон консулын газрын тэргүүн, дипломат ажилтан, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн суух улсдаа шилжин суурьшихад шаардагдах хувийн хэрэглээний эд зүйл**		
975.		99.1.Энэ хуулийн 96.1.2-т заасан албан тушаалтан, түүний гэр бүлийн хүмүүс шилжин суурьших, тохинох болон хувийн хэрэгцээнд зориулсан бараанд гаалийн болон бусад тавар ногдуулахгүй.		-
976.		99.2.Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон болон арилжааны шинж чанартай бараа байгаа гэх хангалттай үндэслэлгүй бол гаалийн шалгалт хийхгүй. Шалгалт хийх тохиолдолд албан тушаалтан, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийг байлцуулна.		
977.		**100 дугаар зүйл.Гадаадын дипломат төлөөлөгчийн болон консулын газрын үйлчилгээ, техникийн ажилтан, тэдгээрийн гэр бүлийн гишүүд Монгол Улсын иргэн биш, Монгол Улсад байнга оршин суугч биш бол суух улсдаа шилжин суурьшихад шаардагдах хувийн хэрэглээний эд зүйл**		
978.		100.1.Гадаадын дипломат төлөөлөгчийн болон консулын газрын үйлчилгээ, техникийн ажилтан, тэдгээрийн гэр бүлийн гишүүд Монгол Улсын иргэн биш, Монгол Улсад байнга оршин суугч биш бол суух улсдаа шилжин суурьшихад шаардагдах хувийн хэрэглээний эд зүйлийг хилээр нэвтрүүлэхэд энэ хуулийн 99 дүгээр зүйлд заасныг мөрдөнө.		
979.	**221 дүгээр зүйл. Дипломат шууданг гаалийн хилээр нэвтрүүлэх**	**101 дүгээр зүйл.Диломат шуудан**		
980.	221.1.Дипломат шууданг гаалийн хилээр саадгүй нэвтрүүлнэ.	101.1.Дипломат шууданг гаалийн хилээр саадгүй нэвтрүүлнэ.		
981.	221.2.Дипломат албаны бус бичиг баримт, эд зүйл байгаа гэх хангалттай сэжиг байгаа тохиолдолд гаалийн байгууллага гадаадын дипломат төлөөлөгчийн газар болон түүнтэй адилтгах бусад байгууллагын төлөөлөгчийг байлцуулан дипломат шууданг нээж болно.	101.4.Энэ хуулийн 101.3-т зааснаас бусад эд зүйл байгаа гэх хангалттай үндэслэл бүхий сэжиг байгаа тохиолдолд гаалийн байгууллага гадаадын дипломат төлөөлөгчийн газар болон түүнтэй адилтгах бусад байгууллагын төлөөлөгчийг байлцуулан дипломат шууданг нээж шалгаж болно.		
982.	221.3.Энэ хуулийн 221.1-д заасан шуудан гаднаа дипломат шуудангийн шинжийг тодорхойлсон таних тэмдэгтэй байна.	101.2.Дипломат шуудангийн бүх сав баглаа нь гадна талдаа шинж байдлыг тодорхойлсон таних тэмдэгтэй байна.		*“Дипломат албаны бус бичиг баримт,” гэснийг “Энэ хуулийн 279.1-д зааснаас бусад” гэж өөрчилсөн*
983.		101.3.Дипломат шуудан дотор зөвхөн дипломат бичиг баримт ба албан хэрэгт зориулагдсан зүйлс агуулагдсан байна.		

ХУУЛЬ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН

984.		**АРАВДУГААР БҮЛЭГ ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БАРААГ ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ, ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТ ХИЙХ ОНЦЛОГ**	**Тусгай хавсралт J 2 дугаар бүлэг ШУУДАН ТЭЭВЭР**	
985.	**Гуравдугаар дэд бүлэг Улс хоорондын шуудангийн илгээмжийг гаалийн хилээр нэвтрүүлэх**	**НЭГДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ УЛС ХООРОНДЫН ШУУДАН ИЛГЭЭМЖИД ХИЙХ ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТ**		-
986.	**222 дугаар зүйл.Улс хоорондын шуудангийн илгээмжийг гаалийн хилээр нэвтрүүлэх**	**91 дүгээр зүйл. Улс хоорондын шуудан илгээмж**	**Тодорхойлолт**	
987.	222.1.“Улс хоорондын шуудангийн илгээмж” гэдэгт Шуудангийн тухай хуульд тодорхойлсон захидал, боодол, илгээлтийн хэлбэртэй биет зүйлийг ойлгоно.	91.1.Шуудан илгээмжид Дэлхийн шуудангийн холбооны одоо мөрдөгдөж байгаа актуудад заасан, шуудангийн байгууллагын сүлжээг ашиглан илгээгдэж байгаа улс хоорондын илгээмж, захидлыг ойлгоно.	“шуудан илгээмж” гэж Дэлхийн шуудангийн холбооны одоо мөрдөж буй актуудад заасан, шуудангийн байгууллагын шугамаар, эсхүл түүний төлөө тээвэрлэж буй захидал болон илгээлтийг;	*“Шуудангийн тухай хуульд тодорхойлсон захидал, боодол, илгээлтийн хэлбэртэй” гэснийг “үйлчлүүлэгчээс шуудангийн сүлжээ ашиглан, хаягласан ээнд нь хүргүүлэхээр захидал, боодол, илгээлтийн хэлбэрээр хүлээлгэн өгсөн, гаалийн хилээр нэвтрүүлэх” гэж өөрчилсөн*
988.		91.2.Шуудан илгээмжийг Дэлхийн шуудангийн холбооноос баталсан бичиг баримтууд дагалдана.		
989.	222.2.Улс хоорондын шуудангийн илгээмжийг гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр хүлээн авагчид олгох, эсхүл гадаад улсад илгээхийг хориглоно.	91.3.Улс хоорондын шуудан илгээмжийг гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр хүлээн авагчид олгох, эсхүл гадаад улсад илгээхийг хориглоно.		-
990.	222.3.Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон бараа байгаа гэх сэжиг бүхий тохиолдолд, эсхүл гадаад орны гаалийн байгууллагын хүсэлтээр гаалийн нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэх улс хоорондын шуудангийн илгээмжийг гаалийн байгууллага саатуулан шалгаж болно.			-

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

991.	222.4.Улс хоорондын шуудангийн илгээмжийг гаалийн хилээр нэвтрүүлэх журмыг гаалийн болон шуудангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.			*“журмыг гаалийн болон шуудангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран” гэснийг “журам, улс хоорондын шуудангийн илгээмжээр татваргүй нэвтрүүлэх барааны тоо, хэмжээг гаалийн удирдах төв байгууллагын дарга” гэж өөрчилсөн*
992.	**223 дугаар зүйл.Улс хоорондын шуудангийн илгээмжээр илгээхийг хориглох эд зүйл, тэдгээрт тарифын бус хязгаарлалт тогтоох**	**92 дугаар зүйл.Улс хоорондын шуудан илгээмжээр барааг илгээх**		
993.	223.1.Дараахь бараа, эд зүйлийг улс хоорондын шуудангийн илгээмжээр илгээхийг хориглоно: 223.1.1.Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон бараа; 223.1.2.үндэсний болон гадаад валют, үнэт цаас; 223.1.3.ариутгал хийгдээгүй хуучин гутал, хувцас, цагаан хэрэглэл; 223.1.4.цацраг идэвхт бодис, химийн хорт болон аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис зэрэг аюултай бараа; 223.1.5.амархан муудах, гэмтэх хадгалалтын онцгой нөхцөл шаардсан бараа; 223.1.6.хуулиар хориглосон бусад бараа. 223.2.Энэ хуулийн 223.1-д зааснаас бусад тарифын бус хязгаарлалттай барааг гаалийн хилээр нэвтрүүлэх тохиолдолд илгээгч, хүлээн авагч болон тэдгээрийн төлөөлөгч нь холбогдох зөвшөөрөл, лицензийг гаалийн байгууллагад гаргаж өгөх үүрэг хүлээнэ.	92.1.Дараах барааг улс хоорондын шуудан илгээмжээр илгээхийг хориглоно: 92.1.1.Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон бараа; 92.1.2.үндэсний болон гадаад валют, үнэт цаас; 92.1.3.ариутгал хийгдээгүй хуучин гутал, хувцас, цагаан хэрэглэл; 92.1.4.амархан муудах, гэмтэх хадгалалтын онцгой нөхцөл шаардсан бараа; 92.1.5.цацраг идэвхит бодис, химийн хорт болон аюултай бодис, тэсэрч, дэлбэрэх бодис зэрэг аюултай бараа; 92.1.6.шуудангийн болон гаалийн ажилтанг аюул заналд оруулах, эсхүл шуудан илгээмжийг бохирдуулах, устгах эрсдэлтэй эд зүйлс; 92.1.7.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис; 92.1.8.хүлээн авагч улсад хүлээн авахыг болон эргэлтэд оруулахыг хориглосон эд зүйлс; 92.1.9.садар самууныг сурталчилсан эд зүйл; 92.1.10.зэгий, хануур хорхой, торгоны хүр хорхой, хортон амьтныг устгах шимэгчдээс бусад амьд амьтан; 92.1.11.хуульд заасан бусад бараа.		-
994.		**93 дугаар зүйл.Хувийн хэрэгцээний барааг мэдүүлэх**		
995.		93.1.Хувь хүний нэр дээр хувийн хэрэгцээнд зориулан илгээсэн, улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалтад хамаарах барааг гаалийн байгууллага шаардлагатай гэж үзвэл, хүлээн авагч нотлох баримтыг гаргаж өгөх үүрэгтэй.	**2. Стандарт** Үндэсний хууль тогтоомжид шуудан илгээмжийн гаалийн бүрдүүлэлттэй холбогдуулан гаалийн байгууллагын болон шуудангийн байгууллагын тус тусын хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон байна.	

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.legal.gov.mn

996.	**224 дүгээр зүйл.Улс хоорондын шуудангийн илгээмжийн гаалийн бүрдүүлэлт**	**94 дүгээр зүйл.Улс хоорондын шуудан илгээмж дэх гаалийн бүрдүүлэлт**		
997.	224.1.Улс хоорондын шуудангийн илгээмжид гаалийн байгууллага гаалийн тургэвчилсан бүрдүүлэлт хийнэ.			
998.	224.2.Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх шуудангийн илгээмжид гаалийн байгууллага хяналт тавих бөгөөд гаалийн бүрдүүлэлт хийхгүй.			
999.		94.1.Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн бүрдүүлэлтийг шуудангийн гаалийн байгууллага дээр, эсхүл гаалийн байгууллагаас тогтоосон өөр газарт хийнэ.		
1000.		94.2.Дэлхийн шуудангийн холбооноос гаргасан бичиг баримтуудыг гаалийн мэдүүлэгт тооцож болно.		
1001.		94.3.Улс хоорондын шуудан илгээмжээр илгээсэн хувийн хэрэглээнийхээс бусад дараах барааг гаалийн мэдүүлгээр мэдүүлнэ: 94.3.1.гаалийн татвар хураамж төлөгдөх бараа; 94.3.2.тарифын бус хязгаарлалт тогтоосон бараа; 94.3.3.дотоодын хэрэглээнд зориулан оруулах болон гадаадад бүр мөсөн гаргахаас бусад горимд байрших бараа; 94.3.4.аж ахуйн нэгж, байгууллагын илгээх, хүлээн авах бараа; 94.3.5.шинжлэх ухаан, техникийн ололт, газар нутгийн загвар дүрс, зураг зүйн болон бусад материал, судалгаа, шинжилгээ, геологи, байгаль, амьтан судлал, биологи, палентологийн олдвор болон бусад бүх төрлийн дээж, сорьц.	**6. Стандарт** Гаалийн байгууллага гаалийн хяналтын зорилгоор түүнд ямар шуудан илгээмж үзүүлэх болон тэдгээрийг хэрхэн үзүүлэхийг шуудангийн холбогдох байгууллагад тогтоож өгнө **7. Стандарт** Гаалийн байгууллага, хэрэв шуудан илгээмж дотор дор дурдсан бараа байхгүй бол уг шуудан илгээмжийг экспортоор гаргах үед гаалийн хяналт тавих зорилгоор гаалийн байгууллагад үзүүлэхийг шаардахгүй: • экспортоор гарсныг нь гэрчлэх ёстой бараа; • экспортын хориг, хязгаарлалт тогтоосон, эсхүл экспортын гаалийн болон бусад татвартай бараа; • үндэсний хууль тогтоомжид заасан хэмжээнээс дээш үнэ бүхий бараа; эсхүл • түүвэр сонголтын, эсхүл санамсаргүй сонголтын үндсэн дээр гаалийн хяналт тавихаар сонгосон бараа.	
1002.		94.4.Хувь хүний нэр дээр ирсэн, хууль тогтоомжоор татвараас чөлөөлөхөөр заасан тоо хэмжээ, үнийн дүнгээс илүү гарсан барааг гаалийн удирдах төв байгууллагаас баталсан мэдүүлгийн загварын дагуу мэдүүлж, гаалийн бүрдүүлэлт хийнэ.		

1003.		94.5.Улс хоорондын шуудан илгээмжээр илгээх барааг шуудангийн байгууллагад өгөхөөс өмнө гаалийн байгууллагад мэдүүлнэ.		
1004.		94.6.Дэлхийн шуудангийн холбооноос тогтоосон журмаар илгээгчид буцаах илгээмжийг шуудангийн байгууллага гаальд мэдүүлнэ.		-
1005.		94.7.Энэ хуулийн 94.6-д заасан барааг Дэлхийн шуудангийн холбооноос баталсан дагалдах баримт, мэдээллийн хамт гаалийн байгууллага хүлээн авснаар гаальд мэдүүлсэнд тооцно.		
1006.		94.8.Шуудангийн байгууллага энэ хуульд заасан гаалийн зуучлагчаар ажиллаж болно.		
1007.		**95 дугаар зүйл.Шуудан илгээмжид хийх гаалийн шалгалт**		
1008.		95.1.Шуудан илгээмжийг шуудангийн байгууллага хариуцаж гаалийн байгууллагад шалгуулна.		
1009.		95.2.Гаалийн байгууллага хилээр нэвтрүүлэх дараах төрлийн шуудан илгээмжийг шалгуулахыг шаардахгүй байж болно: 95.2.1.зөвхөн хувийн чанартай мэдээлэл агуулсан ил захидал болон захидал; 95.2.2.харааны бэрхшээлтэй хүнд зориулсан ном зохиол.	**8. Практик зөвлөмж** Гаалийн байгууллага зарчмын хувьд импортоор оруулах дараах төрлийн шуудан илгээмжийг гаалийн байгууллагад үзүүлэхийг шаардахгүй: (a) зөвхөн хувийн чанартай мэдээлэл агуулсан ил захидал болон захидал; (b) хараагүй хүмүүст зориулсан ном зохиол; (c) импортын гаалийн болон бусад татваргүй хэвлэмэл материал.	
1010.		95.3.Дээрх илгээмжид хориглосон, хязгаарласан бараа байгаа гэх үндэслэлтэй, мөн гаднах байдлын болон түүвэр эсхүл санамсаргүй сонголтын шалгалтын үндсэн дээр илгээмжийг шалгана.		
1011.		95.4.Баглаа боодлын бүрэн бүтэн байдалнь алдагдсан, жин зөрсөн, дагалдах бичиг баримтгүй илгээмж ирсэн тохиолдолд хариуцсан шуудангийн байгууллага акт үйлдэж гаалийн байгууллагад гаргаж өгнө.		
1012.		95.5.Гаалийн шалгалтаар барааны нэр төрөл, жин, тоо хэмжээ зөрсөн тохиолдолд шуудангийн ажилтан, гаалийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан үзлэг хийсэн тухай тэмдэглэл үйлдэж, гарын үсэг зурж баталгаажуулна.		
1013.				

ХУУЛЬ ЗҮЙН ТӨВИЙН ХУРЭЭЛЭН
www.legal.gov.mn

1014.	**Дөрөвдүгээр дэд бүлэг Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх**	**ГУРАВДУГААР ДЭД БҮЛЭГ ЗОРЧИГЧ**	**Тусгай хавсралт J ТУСГАЙ ГОРИМУУД**	
1015.	**225 дугаар зүйл.Зорчигч**	**102 дугаар зүйл.Зорчигч**	**1 дүгээр бүлэг ЗОРЧИГЧ**	
1016.	225.1.“Зорчигч” гэдэгт дараахь этгээдийг ойлгоно:	102.1.“Зорчигч” гэдэгт дараах этгээдийг ойлгоно:	**Тодорхойлолт**	
1017.	225.1.1.Монгол Улсад байнга оршин суудаггүй, улсын хилээр түр орж, эсхүл түүнээс буцаж гарч байгаа хувь хүн;	102.1.1.Монгол Улсад байнга оршин суудаггүй, улсын хилээр түр орж, эсхүл түүнээс буцаж гарч байгаа хувь хүн;	“Зорчигч” гэж дараах этгээдийг хэлнэ: (1) ерөнхийдөө байнга оршин суудаггүй аль нэг улсын нутаг дэвсгэрт түр хугацаагаар орж байгаа (“байнгын бус оршин суугч”), эсхүл тийм нутаг дэвсгэрээс гарч байгаа аливаа этгээд; мөн (2) ерөнхийдөө байнга оршин суудаг аль нэг улсын нутаг дэвсгэрээс гарч байгаа (“явж буй байнгын оршин суугч”), эсхүл тийм нутаг дэвсгэрт эргэн ирж байгаа (буцаж ирж байгаа оршин суугч) аливаа этгээд.	-
1018.	225.1.2.Монгол Улсад байнга оршин суудаг, улсын хилээр түр гарч, эсхүл буцаж орж байгаа хувь хүн.	102.1.2.Монгол Улсад байнга оршин суудаг, улсын хилээр түр гарч, эсхүл буцаж орж байгаа хувь хүн		-
1019.	**226 дугаар зүйл.Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйл, тээврийн хэрэгсэл**	**103 дугаар зүйл.Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйл**		*“, тээврийн хэрэгсэл” гэснийг хассан*
1020.	226.1.“Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйл” гэдэгт дараахь зүйлийг ойлгоно:	226.1.“Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйл” гэдэгт дараахь зүйлийг ойлгоно:		
1021.	226.1.1.аяллын хугацаанд зорчигчийн хувийн хэрэглээнд шаардагдах эд зүйл	103.1.1.аяллын хугацаанд зорчигчийн хувийн хэрэглээнд шаардагдах эд зүйл		
1022.	226.1.2.зорчигчийн хувийн хэрэглээний эм;	103.1.2.зорчигчийн хувийн хэрэглээний эм;		-
1023.	226.1.3.хууль тогтоомжид заасан тоо хэмжээ, үнийн дүнд багтаж буй гаалийн болон бусад татваргүйгээр гаалийн хилээр нэвтрүүлэх эд зүйл.	103.1.3.хууль тогтоомжид заасан тоо хэмжээ, үнийн дүнд багтаж байгаа гаалийн болон бусад татваргүйгээр гаалийн хилээр нэвтрүүлэх бараа.	“Хувийн хэрэглээний эд зүйлс” гэж зорчигчийн аяллын хугацаанд түүний хувийн хэрэглээнд шаардагдах (шинэ, эсхүл хуучин) бүх эд зүйлсийг хэлнэ. Үүнд тухайн аяллын нөхцөл байдлыг харгалзан үзэх бөгөөд арилжааны зорилгоор оруулж, гаргасан аливаа бараа хамаарахгүй; “Түр хугацаагаар оруулах” гэж тодорхой барааг импортын гаалийн болон бусад татвараас болзолтойгоор чөлөөлж гаалийн нутаг дэвсгэрт оруулах гаалийн горимыг хэлнэ. Ийм барааг тусгай зорилгоор, мөн тогтоосон хугацааны дараа буцаан гаргах болзолтойгоор оруулах буюу чингэхдээ ашиглалтаас үүдэлтэй хэвийн элэгдэл хорогдлоос өөр ямар нэгэн өөрчлөлт ороогүй байвал зохино.	-
1024.		103.2.Боловсруулаагүй, эсхүл дахин боловсруулалт хийгдэх бараа, мал, амьтан, ургамлын гаралтай түүхий эд, үйлдвэрлэл, худалдааны зориулалттай түүхий эд, бараа, химийн болон цацраг идэвхит бодис, шилжмэл генитэй хүнсний бүтээгдэхүүн зэргийг зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлд хамааруулахгүй.		*Шинээр нэмэгдсэн*
1025.		103.3.Гаалийн болон бусад татваргүйгээр гаалийн хилээр нэвтрүүлэх зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийн жагсаалт, тоо хэмжээг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.		*Шинээр нэмэгдсэн*

1026.		103.4.Олон улсын чанартай хурал, зөвлөлгөөн, соёл, боловсрол, шинжлэх ухааны сургалт, төрийн айлчлал, судалгаа, шинжилгээ, спортын уралдаан, тэмцээн, урлагийн арга хэмжээнд оролцох зорчигч шаардагдах барааг гаалийн хилээр нэвтрүүлж байгаа тохиолдолд зорчигчийн гаалийн мэдүүлэг, холбогдох бичиг баримтыг үндэслэн хилээр түр хугацаагаар нэвтрүүлж, бүртгэлээр хяналт тавина.	**6. Практик зөвлөмж** Хос гарцын системийг зорчигчдод гаалийн хяналт тавих, мөн тэдний авч яваа барааnd болон, шаардлагатай бол, тэдний хувийн хэрэглээний тээврийн хэрэгсэлд бүрдүүлэлт хийхэд ашиглавал зохино. **9. Практик зөвлөмж** Зорчигч өөрийн авч яваа барааны хувьд амаар мэдүүлэг өгөхийг зөвшөөрнө. Гэхдээ зорчигчдын авч яваа арилжааны шинжтэй импорт, экспортын барааг, эсхүл үнэ, тоо хэмжээний хувьд үндэсний хууль тогтоомжид заасан хэмжээнээс хэтэрсэн барааг гаалийн байгууллага бичгээр, эсхүл цахим сүлжээгээр мэдүүлэхийг шаардаж болно. **11. Стандарт** Зорчигчийн авч яваа барааг гаалийн холбогдох горимоор бүрдүүлэлт хийх, буцаан гаргах, эсхүл үндэсний хууль тогтоомжийн дагуу өөр журмаар захиран зарцуулах хүртэл гаалийн байгууллагаас тогтоосон нөхцөлийн дагуу дараах тохиолдолд агуулахад, эсхүл өөр ямар нэгэн байдлаар хадгална : • тухайн зорчигчийн хүсэлтээр; • тухайн барааnd шууд бүрдүүлэлт хийх боломжгүй; эсхүл • уг барааnd энэ бүлгийн бусад заалт хамаарахгүй бол. **12.Стандарт** Биеэс тусдаа яваа (өөрөөр хэлбэл, зорчигчоос өмнө, эсхүл хойно ирж байгаа, эсхүл явж байгаа) ачаа тээшинд биедээ авч яваа ачаа тээшинд хамаарах горимын дагуу, эсхүл гаалийн бусад хялбарчилсан горимын дагуу бүрдүүлэлт хийнэ. **18. Стандарт** Буцаж ирж байгаа оршин суугчид нь тухайн улсаас гарах үедээ биедээ авч явсан бөгөөд тухайн улсад чөлөөт эргэлтэд байсан хувийн эд зүйлс болон хувийн хэрэглээний тээврийн хэрэгслийг импортын гаалийн болон бусад татваргүйгээр буцаан оруулахыг зөвшөөрнө.	*Шинээр нэмэгдсэн*
1027.	**227 дугаар зүйл.Зорчигчийн хувийн хэрэглээний эмийг гаалийн хилээр нэвтрүүлэх**	**106 дугаар зүйл.Зорчигчийн хувийн хэрэглээний эмийг гаалийн хилээр нэвтрүүлэх**		-
1028.	227.1.Улс хоорондын үйлчилгээний төмөр зам, автобус, хөлөг онгоц, нисэх онгоц болон хувийн тээврийн хэрэгслээр зорчигч нь өөрийн хэрэгцээнд зориулан авч яваа эмийг зорчигчийн хувийн хэрэглээний эм гэнэ.	106.1.Улс хоорондын үйлчилгээний төмөр зам, автобус, хөлөг онгоц, нисэх онгоц болон хувийн тээврийн хэрэгслээр зорчигч нь өөрийн хэрэгцээнд зориулан авч яваа эмийг зорчигчийн хувийн хэрэглээний эм гэнэ.		
1029.	227.2.Энэ хуулийн 227.1-д заасан эмийг импортын бараа гэж үзэхгүй ба импортын зөвшөөрөл шаардахгүй.	106.2.Энэ хуулийн 106.1-д заасан эмийг импортын бараа гэж үзэхгүй ба импортын зөвшөөрөл шаардахгүй.		

хууль зүйн үндэсний мэдээлэл www.nli.gov.mn

1030.	227.3.Зорчигчийн хувийн хэрэглээний эмэнд яаралтай тусламж /7 хүртэл хоног/-ийн эм болон удаан хугацаанд нөхөх эмчилгээ шаардах /чихрийн шижин, хорт хавдар, сэтгэцийн эмгэг, дархлалын олдмол хомсдол зэрэг/ өвчтэй хүмүүсийн хэрэглэдэг эм багтана.	106.3.Зорчигчийн хувийн хэрэглээний эмэнд яаралтай тусламж /долоо хүртэл хоног/-ийн эм болон удаан хугацаанд нөхөх эмчилгээ шаардах /чихрийн шижин, хорт хавдар, сэтгэцийн эмгэг, дархлалын олдмол хомсдол зэрэг/ өвчтэй хүмүүсийн хэрэглэдэг эм багтана.		
1031.	227.4.Дараахь төрлийн эмийг хувийн хэрэглээний зориулалтаар улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоно:	106.4.Дараах төрлийн эмийг хувийн хэрэглээний зориулалтаар улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоно:		
1032.	227.4.1.судсаар сэлбэх шингэн;	106.4.1.судсаар сэлбэх шингэн;		
1033.	227.4.2.антибиотик тариа;	106.4.2.антибиотик тариа;		
1034.	227.4.3.мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм;	106.4.3.мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм;		
1035.	227.4.4.цусны бэлдмэл сийвэн орлох эм;	106.4.4.цусны бэлдмэл сийвэн орлох эм;		
1036.	227.4.5.нийтлэг дархлаажуулалтад хэрэглэх эм, бэлдмэл.	106.4.5.нийтлэг дархлаажуулалтад хэрэглэх эм, бэлдмэл.		-
1037.	**228 дугаар зүйл.Зорчигчийг гаалийн хилээр нэвтрүүлэх тусгай журам**	**105 дугаар зүйл.Зорчигчийг гаалийн хилээр нэвтрүүлэх**		*“тусгай журам” гэснийг хассан*
1038.	228.1.Гаалийн байгууллага нь зорчигчийг гаалийн хилээр нэвтрүүлэхдээ гаалийн хяналтын улаан, ногоон гарцыг хэрэглэж болно.	105.1.Гаалийн байгууллага зорчигчийг гаалийн хилээр нэвтрүүлэхдээ гаалийн хяналтын улаан, ногоон гарцыг хэрэглэж болно.		-
1039.	228.2.Зорчигч гаалийн хилээр нэвтрэх гарцаа өөрөө сонгоно.	105.3.Зорчигч гаалийн хилээр нэвтрэх гарцыг өөрөө сонгох бөгөөд үүнийг гаальд мэдүүлж байгаад тооцно.		
1040.	228.3.Энэ хуулийн 8.1-д заасан бараа байхгүй тохиолдолд зорчигч гаалийн хилийн ногоон гарцаар нэвтэрч болно.	105.4.Зорчигчийн бие, ачаа тээш, биеэс тусдаа ачаанд энэ хуулийн 41.1-д заасан бараа байхгүй тохиолдолд, зорчигч гаалийн хилийн ногоон гарцаар нэвтэрч болно.		
1041.	228.4.Гадаад улс, олон улсын байгууллагын дипломат эрх ямба бүхий ажилтан гаалийн хилээр нэвтрэх асуудлыг олон улсын конвенцээр зохицуулна.	105.8.Гадаад улс, олон улсын байгууллагын дипломат эрх ямба бүхий ажилтан гаалийн хилээр нэвтрэх асуудлыг олон улсын конвенцээр зохицуулна.		
1042.	228.5.Зорчигч гаалийн хилийн ногоон гарцаар нэвтэрч байгаа тохиолдолд зорчигчийн гаалийн мэдүүлэг бичихгүй байж болно.	105.5.Зорчигч гаалийн хилийн ногоон гарцаар нэвтэрч байгаа тохиолдолд зорчигчийн гаалийн мэдүүлэг бичихгүй байж болно.		
1043.	228.6.Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйл, эмэнд гаалийн бүрдүүлэлт хийх танхимд улаан, ногоон гарцын таних тэмдэг, тайлбар, танилцуулгыг зорчигчид харагдахаар газар байрлуулсан байна.	105.2.Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлд гаалийн бүрдүүлэлт хийх танхимд улаан, ногоон гарцын таних тэмдэг, тайлбар, танилцуулгыг зорчигчид харагдахаар газар байрлуулсан байна.		“зүйл, эмэнд” гэснийг “зүйлд” гэж өөрчилсөн
1044.	228.7.Ногоон гарцаар нэвтэрч буй зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйл, эмэнд гаалийн хяналт тавьж гаалийн хилээр нэвтрүүлнэ.	105.6.Ногоон гарцаар нэвтэрч буй зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйл, эмэнд гаалийн хяналт тавьж гаалийн хилээр нэвтрүүлнэ.		-
1045.		105.7.Гаалийн байгууллага зорчигчийг амаар мэдүүлэхийг зөвшөөрнө. Шаардлагатай тохиолдолд бичгээр мэдүүлэг гаргуулан авна.	**9. Практик зөвлөмж** Зорчигч өөрийн авч яваа барааны хувьд амаар мэдүүлэг өгөхийг зөвшөөрнө. Гэхдээ зорчигчдын авч яваа арилжааны шинжтэй импорт, экспортын барааг, эсхүл үнэ, тоо хэмжээний хувьд үндэсний хууль тогтоомжид заасан хэмжээнээс хэтэрсэн барааг гаалийн байгууллага бичгээр, эсхүл цахим сүлжээгээр мэдүүлэхийг шаардаж болно.	*Шинээр нэмэгдсэн*
1046.				*Шинээр нэмэгдсэн*

1047.	**229 дүгээр зүйл.Зорчигчийн хувийн тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэх**	**107 дугаар зүйл.Зорчигчийн хувийн тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэх**		-
1048.	229.1.“Зорчигчийн хувийн тээврийн хэрэгсэл” гэдэгт зорчигчийн байнга оршин суугаа газарт улсын бүртгэлтэй хувийн тээврийн хэрэгслийг ойлгоно.	107.1.“Зорчигчийн хувийн тээврийн хэрэгсэл” гэдэгт зорчигчийн байнга оршин суугаа газарт улсын бүртгэлтэй хувийн тээврийн хэрэгслийг ойлгоно.		-
1049.	229.2.Зорчигчийн хувийн тээврийн хэрэгслийг гаалийн хилээр гаалийн болон бусад татваргүйгээр түр хугацаагаар нэвтрүүлнэ.	107.2.Зорчигчийн хувийн тээврийн хэрэгслийг гаалийн хилээр гаалийн болон бусад татваргүйгээр түр хугацаагаар нэвтрүүлнэ.		-
1050.	229.3.Зорчигчийн хувийн тээврийн хэрэгсэлд байгаа засвар, үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай сэлбэг, хэрэгсэл болон шатахууныг гаалийн болон бусад татваргүйгээр гаалийн хилээр нэвтрүүлнэ.	107.3.Зорчигчийн хувийн тээврийн хэрэгсэлд байгаа засвар, үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай сэлбэг, хэрэгсэлийг гаалийн болон бусад татваргүйгээр гаалийн хилээр нэвтрүүлнэ.		*“хэрэгсэл болон шатахууныг” гэснийг “хэрэгсэлийг” гэж өөрчилсөн*
1051.		107.4.Зорчигчийн хувийн тээврийн хэрэгслийн зориулалтын шатахуун цэнэглэхээр хийгдсэн үндсэн саванд байгаа шатахууныг гаалийн болон бусад татваргүйгээр гаалийн хилээр нэвтрүүлнэ.		
1052.		**ДӨРӨВДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ УЛС ХООРОНД ТЭЭВЭРЛЭЛТ ГҮЙЦЭТГЭЖ БАЙГАА ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД ХИЙХ ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТ**		

ХУУЛЬ ЗҮЙН ИНЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.mli.gov.mn

1053.		**108 дугаар зүйл. Улс хооронд тээвэрлэлт гүйцэтгэж байгаа тээврийн хэрэгсэл**	**Тодорхойлолт** “Худалдааны үйл ажиллагаанд ашиглах зориулалттай тээврийн хэрэгсэл” гэж хүмүүсийг төлбөртэй тээвэрлэх, эсхүл үйлдвэрлэлийн буюу худалдааны зориулалттай барааг төлбөртэй, эсхүл төлбөргүй тээвэрлэх зориулалтаар олон улсын тээвэрт ашиглаж буй аливаа хөлөг онгоц (үүнд өөрөө явдаг, эсхүл чирэгдэж явдаг лихтёр болон ачааны чиргүүл онгоц, түүнчлэн нисдэг завь хамаарна), хийлсэн агаар дээр хөвөгч онгоц, агаарын хөлөг, автомашин (үүнд чиргүүл, хагас чиргүүл, мөн автомашины хослол хамаарна), эсхүл төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, тэдгээрийн ердийн сэлбэг, туслах, дагалдах хэрэгсэл болон тоног хэрэгсэл, мөн худалдааны үйл ажиллагаанд ашиглах зориулалттай тээврийн хэрэгсэлтэй хамт тээвэрлэж байгаа тосолгооны материал болон түлшний хэвийн саванд байгаа шатахууныг тус тус хэлнэ. **3. Практик зөвлөмж** Худалдааны үйл ажиллагаанд ашиглах зориулалтай тээврийн хэрэгслийг түр хугацаагаар оруулсан улсын гаалийн нутаг дэвсгэрт дотоодын тээвэрт ашиглахгүй байх тохиолдолд түүнийг ачаатай, ачаагүйг нь үл харгалзан гаалийн нутаг дэвсгэрт импортын гаалийн болон бусад татвараас болзолтойгоор чөлөөлөн оруулахыг зөвшөөрнө. Түүнийг түүний ашиглалтаас үүдэлтэй хэвийн элэгдэл хорогдол, тосолгооны материал, шатахууны хэвийн хэрэглээ болон шаардлагатай засвараас өөр ямар нэгэн өөрчлөлт оруулахгүйгээр буцаан гаргах зорилготой байна. **4. Стандарт** Хилийн чанадад зохих ёсоор бүртгэгдсэн худалдааны үйл ажиллагаанд ашиглах зориулалттай тээврийн хэрэгслийн хувьд гаалийн байгууллага зөвхөн гаалийн хяналтын зорилгоор шаардлагатай гэж үзсэн бол баталгаа, эсхүл түр хугацаагаар оруулах бичиг баримт шаардана. **5. Стандарт** Гаалийн байгууллага худалдааны үйл ажиллагаанд ашиглах зориулалттай тээврийн хэрэгслийг буцаан гаргах хугацааг тогтоох бол төлөвлөгдсөн тээврийн үйл ажиллагааны бүх нөхцөл байдлыг анхаарч үзнэ. **6. Практик зөвлөмж** Холбогдох этгээдийн хүсэлтээр, мөн гаалийн байгууллага үндэслэлтэй гэж үзсэн бол тэр нь анх тогтоосон хугацаагаа сунгана.	
1054.		108.1.Улс хооронд тээвэрлэлт гүйцэтгэж байгаа тээврийн хэрэгсэлд гадаад улсад бүртгэлтэй бөгөөд бараа, зорчигч тээвэрлэн хилээр түр хугацаагаар оруулаад буцаж гарах, эсхүл монгол улсад бүртгэлтэй бөгөөд бараа, зорчигч тээвэрлэн хилээр түр хугацаагаар гаргаад буцаж орох бүх төрлийн тээврийн хэрэгсэл хамаарна		
1055.		**109 дүгээр зүйл. Улс хооронд тээвэрлэлт гүйцэтгэж байгаа тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх**		
1056.		109.1.Улс хооронд тээвэрлэлт гүйцэтгэж байгаа тээврийн хэрэгслийг гаалийн байгууллагад тээврийн хэрэгслийн гаалийн мэдүүлгээр мэдүүлнэ.		
1057.		109.2.Улс хооронд тээвэрлэлт гүйцэтгэж байгаа тээврийн хэрэгслийн төрөл, түүний маршрут, ачаа, зорчигч, аяллын баг, аяллын зорилгыг тусгасан олон улсын гэрээгээр батлагдсан стандарт бичиг баримтыг тээврийн хэрэгслийн гаалийн мэдүүлэгт тооцно.		
1058.		**110 дугаар зүйл. Улс хооронд тээвэрлэлт гүйцэтгэж байгаа тээврийн хэрэгслийг түр хугацаагаар нэвтрүүлэх**		
1059.		110.1.Улс хооронд тээвэрлэлт гүйцэтгэж, хилээр түр хугацаагаар нэвтрүүлж байгаа гадаад улсад бүртгэлтэй тээврийн хэрэгсэлд гаалийн болон бусад татвар ногдуулахгүй.		
1060.		110.2.Улс хооронд тээвэрлэлт гүйцэтгэж байгаа тээврийн хэрэгслийг түр хугацаагаар нэвтрүүлэх хугацаа нь тээврийн хэрэгсэл хилээр нэвтэрсэн үеэс 6 сараас дээшгүй байна.		
1061.		110.3.Энэ хуулийн 110.2-т заасан хугацаанд буцаан нэвтрүүлэх боломжгүй бол тээвэрлэгчийн хүсэлтээр энэ хугацааг гаалийн байгууллага гурван сараас дээшгүй хугацаагаар нэг удаа сунгаж болно.		
1062.		**111 дүгээр зүйл.Улс хооронд тээвэрлэлт гүйцэтгэж түр хугацаагаар нэвтрүүлсэн тээврийн хэрэгсэлд тавих шаардлага**		
1063.		111.1.Улс хооронд тээвэрлэлт гүйцэтгэж түр хугацаагаар нэвтрүүлсэн тээврийн хэрэгсэлд шаардлагатай засвар, техникийн үйлчилгээ хийж болно.		

1064.		111.2.Улс хооронд тээвэрлэлт гүйцэтгэж түр хугацаагаар нэвтрүүлсэн тээврийн хэрэгсэлд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 111.2.1.улс хооронд тээвэрлэлт гүйцэтгэж түр хугацаагаар нэвтрүүлсэн тээврийн хэрэгслээр аль нэг улсын дотоодод тээвэр хийх; 111.2.2.түрээсийн гэрээгээр бусдад шилжүүлэх; 111.2.3.худалдах, бусдын өмчлөлд шилжүүлэх.		
1065.		111.3.Энэ хуулийн 111.2-т заасан шаардлагыг зөрчсөн тохиолдолд тээврийн хэрэгслийг дотоодын хэрэглээнд зориулан оруулах горимд байршуулан, гаалийн болон бусад татварыг төлүүлнэ.		
1066.		**ТАВДУГААР ДЭД БҮЛЭГ ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ШУГАМ, ХООЛОЙГООР ДАМЖУУЛАХ БАРААНД ХИЙХ ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТ**		
1067.		**112 дугаар зүйл.Цахилгаан эрчим хүчний шугам, хоолойгоор дамжуулах барааг гаалийн байгууллагад мэдүүлэх**		
1068.		112.1.Мэдүүлэгч цахилгаан эрчим хүчний шугам, хоолойгоор дамжуулах барааг улсын хилээр нэвтрүүлсэн тоо хэмжээгээр сард нэг удаа мэдүүлнэ.		
1069.		112.2.Хилээр нэвтрүүлсэн барааны тоо хэмжээг тоолуурын заалтыг үндэслэн тогтооно		
1070.		**113 дугаар зүйл.Гаалийн бүрдүүлэлтэд шаардагдах бичиг баримт**		
1071.		113.1.Цахилгаан эрчим хүчний шугам, хоолойгоор дамжуулах барааг гаалийн байгууллагад мэдүүлэхэд энэ хуулийн 112-д зааснаас гадна дараах бичиг баримтыг гаалийн байгууллагад гаргаж өгнө: 113.1.1.тоолуурын заалтыг баталгаажуулсан баримт 113.1.2.цахилгаан болон бусад барааг хүлээлцсэн тухай акт, 113.1.3.тоолуур гадаад улсын гаалийн нутаг дэвсгэрт байгаа тохиолдолд гадаад улсын гаалийн байгууллагатай харилцан тохиролцсон, тухайн гаалийн байгууллагын баталгаажуулсан бичиг баримт.		
1072.		**114 дүгээр зүйл.Цахилгаан эрчим хүчний шугам, хоолойгоор дамжуулах барааны хяналт тавих**		
1073.		114.1.Хилээр нэвтрүүлсэн цахилгаан эрчим хүчний шугам, хоолойгоор дамжуулах барааг тоолуурын заалтаар хянана.		
1074.		114.2.Энэ хуулийн 114.1-д заасан тоолуур, түүнд хийсэн тэмдэглэгээ гаалийн хяналтад байх бөгөөд тоолуурыг байрлуулсан байгууламж, танхим гаалийн хяналтын бүсэд тооцогдоно.		
1075.		114.3.Энэ хуулийн 114.1-д заасан тоолуур нь гадаад улсын гаалийн нутаг дэвсгэрт байрлаж болно.		

ХУУЛЬ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН

1076.	**230 дугаар зүйл.Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийн тоо хэмжээ**	**104 дүгээр зүйл.Зорчигчийн хувийн хэрэглээний барааг мэдүүлэх**		
1077.	30.1.Гаалийн болон бусад татваргүйгээр гаалийн хилээр нэвтрүүлэх зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийн жагсаалт, тоо хэмжээг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.	104.2.Зорчигчийн гаалийн мэдүүлгийн хэлбэр, түүнийг бөглөх журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.		*Хасагдсан*
1078.		104.1.Зорчигч улсын хилээр нэвтрэх үедээ дараах барааг гаалийн байгууллагад бичгээр зорчигчийн гаалийн мэдүүлгээр мэдүүлнэ: 104.1.1.биеэс тусдаа яваа бараа; 104.1.2.тарифын бус хязгаарлалтад хамаарах хувийн хэрэглээний бараа; 104.1.3.зорчигчийн хувийн хэрэглээний татваргүй нэвтрүүлэх үнэ, тоо хэмжээнээс хэтэрсэн бараа; 104.1.4.түр хугацаагаар нэвтрүүлсэн зорчигчийн хувийн тээврийн хэрэгсэл; 104.1.5.хуулиар гаальд мэдүүлэхгүйгээр тогтоосон тоо хэмжээнээс илүү гарсан валют, валютын үнэт зүйлс, үнэт цаас; 104.1.6.хувийн эзэмшлийн соёлын үнэт зүйлс; 104.1.7.зорчигч бусдын дайвар ачааг авч яваа.		
1079.		104.3.Зорчигч өөрийн хүсэлтээр хувийн хэрэглээ, хэрэгцээний барааг зорчигчийн гаалийн мэдүүлгээр мэдүүлж болно.		
1080.		104.4.6 насанд хүрээгүй зорчигчийн барааг эцэг, эхийн эсхүл асран хамгаалагчийн гаалийн мэдүүлэгт бичнэ.		
1081.		104.5.Нас барсан хүний шарилтай авс болон чандартай савыг бичгийн хэлбэрээр /зорчигчийн гаалийн мэдүүлгээс бусад/ гаальд мэдүүлж, дараах баримт бичгийг хавсаргана: 104.5.1.нас барсныг тодорхойлсон эрх бүхий байгууллагын бичиг баримт; 104.5.2.шарил шилжүүлэн зөөж байгаа бол тухайн шарилыг шилжүүлэхээр хуульд заасан хэлбэрээр гаргасан эрх бүхий байгууллагын шийдвэр; 104.5.3.авсанд шарилтай хамт байгаа эд зүйлийн талаар холбогдох зан үйл, үйл ажиллагааг эрхлэн явуулсан байгууллагын шарил бүхий авсыг битүүмжлэх үед үйлдэгдсэн тэмдэглэл, тодорхойлолт.		
1082.				
1083.	**Тавдугаар дэд бүлэг Чөлөөт бүсийн горим**			*Хуулийн төслийн 6 дугаар дэд бүлэгт өөрчлөн найруулсан*

ХУУЛЬ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН

1084.	**231 дүгээр зүйл.Чөлөөт бүсийн горим** 231.1.Чөлөөт бүсийн горимд дараахь бараа байршуулна: 231.1.1.хилийн чанадаас чөлөөт бүсэд оруулах гадаадын бараа; 231.1.2.гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд байгаа монголын бараа; 231.1.3.бусад горимд байгаа бараа. 231.2.Чөлөөт бүсийн төрөл, тавигдах шаардлага, татварын асуудлыг Чөлөөт бүсийн тухай хуулиар зохицуулна.				*Хуулийн төслийн 6 дугаар дэд бүлэгт өөрчлөн найруулсан*
1085.		**ДӨРӨВДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ** **ИТГЭМЖЛЭГДСЭН ЭДИЙН ЗАСГИЙН ОПЕРАТОР**			*Шинээр нэмэгдсэн*
1086.		**145 дугаар зүйл.Итгэмжлэгдсэн эдийн засгийн оператор** 145.1.Итгэмжлэгдсэн эдийн засгийн оператор гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт үүсгэн байгуулагдсан, гаалийн хууль тогтоомжид заасан шалгуурыг хангасан, энэ хуулийн 147.1-д заасан хөнгөлөлт эдлэх эрх бүхий хуулийн этгээдийг ойлгоно. 145.2.Гаалийн удирдах төв байгууллага итгэмжлэгдсэн эдийн засгийн оператор тодгийг хүлээн зөвшөөрсөн тухай гэрчилгээ олгож статусыг нь тодорхойлно. Энэ статус нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хүлээн зөвшөөрөгдөнө.			*Шинээр нэмэгдсэн*
1087.		**146 дугаар зүйл.Итгэмжлэгдсэн эдийн засгийн операторт тавигдах шалгуур** 146.1.Итгэмжлэл авахыг хүссэн хуулийн этгээд дараах үндсэн шалгуурыг хангасан байна: 146.1.1.энэ хуулийн 145.2-т заасан статусын чиглэлээр суулийн таван жил тасралтгүй үйл ажиллагаа явуулсан; 146.1.2.гаалийн хууль тогтоомж, хууль сахиптын тувшин сайн гэж тодорхойлогдсон байх; 146.1.3.санхүүгийн бүрэн чадавхитай байх, татварын өргүй байх; 146.1.4.дотоод хяналтын систем, түүний дотор санхүүгийн болон татварын бүртгэл тооцоог олон улсын стандартад нийцүүлэн хөтөлдөг байх; 146.1.5.аюулгүй байдал хангагдсан байх;			*Шинээр нэмэгдсэн*

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН

1088.	**147дугаар зүйл.Итгэмжлэгдсэн эдийн засгийн оператортүүлэх хөнгөлөлт** 147.1.Итгэмжлэгдсэн эдийн засгийн операторын эрх авсан хуулийн этгээдэд гаалийн байгууллага дараах хөнгөлөлт эдлүүлнэ: 147.1.1.гаалийн байгууллагад мэдүүлэхээс өмнө бараагаа эзэнд нь олгох; 147.1.2.мэдүүлсэн бараагаа эзэмшигчийн өөрийн байр, ачуулах, талбайд тур хугацаагаар хадгалах; 147.1.3.гаалийн шалгалтыг итгэмжлэгдсэн этгээдийн өөрийн байр, ачуулах, талбайд хийх; 147.1.4.тодорхой төхөөлөлд бичиг баримтын болон бараа, түүврийн хэрэгсэлд хийх шалгалтаас чөлөөлөх; 147.1.5.гаалийн болон бусад татвар төлөх хугацааг сунгах; 147.1.6.тодорхой хугацаанд зөвхөн нэг гаалийн мэдүүлгээр гаалийн бүрдүүлэлт хийх; 147.1.7.гаалийн байгууллагаас хөлбөгдох хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, олон улсын шилдэг туршлагын талаарх мэдээллийг хүргүүлэх, хүлээн авах; 147.1.8.итгэмжлэгдсэн хуулийн этгээдийн талаар олон нийтэд найдвартай, ашиглуй хүдалдааны түншээр сурталчлах; 147.1.9.харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр байгуулсан оронд хөнгөлөлт эдлэх; 147.1.10.зарим төрлийн бараа гаалийн байгууллагад мэдүүлэхэд энэ хуулийн 68.1-д заасан заалтыг дагаж мөрдөх шаардлага тавихгүй; 147.1.11.өөрийн талбайд зарим барааны лац, ломбыг авах, тэмдэглэгээ хийх ажиллагаа гаалийн байгууллагын хяналтгүй гүйцэтгэж болно. Үүнд хамаарахгүй барааны жагсаалтыг гаалийн удирдах тев байгууллага батлана. 147.2.Энэ хуулийн 147.1-д заасан хөнгөлөлтийг бүгдийг эсхүл хэсэгчлэн эдлүүлж болно.			*Шинээр нэмэгдсэн*

1089.	**148 дугаар зүйл.Итгэмжлэл авах тухай хүсэлт гаргах** 148.1.Гаалийн итгэмжлэлийн эрх авахыг хүссэн хуулийн этгээд хүсэлт гаргахдаа гаалийн удирдах төв байгууллагаас гаргасан ергөдлийн маягтын дагуу бөглөх хүргүүлнэ. 148.2.Энэ хуулийн 146 дугаар зүйлд заасан шалгуурыг хангасан тухай нотлох баримтыг дараах бичиг баримтын хамт хавсаргана: 148.2.1.улсын бүртгэлийн болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар; 148.2.2.татварын байгууллагын тодорхойлолт; 148.2.3.хуулийн этгээдийн өөрийн үнэлгээний худалс; 148.2.4.аудитын байгууллагаар баталгаажуулсан сүүлийн таван жилийн санхүүлийн тайлан; 148.2.5.бай. агуулахын үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар; 148.2.6.өөрийн талбайн эзэмшлийн гэрчилгээ; 148.2.7.хэрэв түрээсийн байр. агуулах, талбай ашигладаг бол түрээсийн гэрээ. 148.3.Хуулийн этгээд өргөдөлд шаардлагатай гэж үзсэн бусад бичиг баримтыг өөрийн хүсэлтээр нэмж гаргаж өгч болно. 148.4.Гаалийн байгууллага энэ хуулийн 148.2-т заасан хүсэлт, холбогдох бичиг баримтыг хянаж шаардлага хангасан болон хангаагүй эсэх талаар ажлын таван хоногийн дотор хариу мэдэгдэнэ. 148.5.Шаардлага хангасан гэж үзсэн хуулийн этгээдэд энэ хуулийн 148.4-т заасан мэдэгдлийг хүргүүлснээс хойш хуанлийн 90 хоногийн дотор бичиг баримтын болон ажлын байрны шалгалтыг хийж шийдвэр гаргана. Шаардлагатай тохиолдолд шалгалтын хугацааг нэг сараар сунгаж болно. 148.6.Хүсэлт гаргагч этгээдийн өгсөн мэдээлийн үнэн зөвийг шалгах зорилгоор төрийн байгууллагаас лавлагаа гаргуулж болно. 148.7.Хүсэлт гаргагч этгээд энэ хуулийн 148.2-т заасан баримт бичгийн мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдол бүрт ажлын тав хоног багтаан гаалийн байгууллагад мэдэгдэнэ.		*Шинээр нэмэгдсэн*

ХУУЛЬ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН

1090.		**149 дүгээр зүйл.Итгэмжлэлийн гэрчилгээ олгох** 149.1.Итгэмжлэлийн гэрчилгээ энэ хуулийн 146.1-д заасан шалгуур хангасан, мөн энэ хуулийн 148.5-д заасан шалгалтад тэнцсэн хуулийн этгээдэд гаалийн байгууллага итгэмжлэгдсэн эдийн засгийн операторын гэрчилгээ олгоно. 149.2.Итгэмжлэлийн гэрчилгээнд дараах мэдээлэл агуулагдана: 149.2.1.хуулийн этгээдийн нэр; 149.2.2.олгосон статус /үйл ажиллагааны чиглэл/ 149.2.3.хуулийн этгээдийн хаяг, байршил; 149.2.4.эдлэх хөнгөлөлт; 149.2.4.итгэмжлэгдсэн хугацаа. 149.3.Итгэмжлэлийг гаалийн удирдах төв байгууллагын даргын тушаалаар гурван жилээс доошгүй хугацаагаар олгоно. 149.4.Итгэмжлэгдсэн хуулийн этгээд итгэмжлэлийн хугацаа дуусгавар болохоос зургаан сарын өмнө гаалийн байгууллагад итгэмжлэлийн хугацааг сунгуулах талаар албан хүсэлт гаргана. 149.5.Хуульд өөрөөр заагаагүй бол хугацаа дуусгавар болсон өдрөөс эхлэн анх олгосон хугацаанаас доошгүй хугацаагаар сунгаж болно. 149.6.Гаалийн байгууллага итгэмжлэгдсэн хуулийн этгээдэд итгэмжлэгдсэн эдийн засгийн операторын ялгах тэмдэг ашиглах эрх өгч, хамтран ажиллах тухай гэрээ байгуулна. 149.7.Гаалийн байгууллага итгэмжлэл олгосон хуулийн этгээдийг ажлын гурав хоногт багтаан өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.		*Шинээр нэмэгдсэн*

ХУУЛЬ ЗҮЙЛ ХЭРЭГЛЭЛ ХУРЭЭЛЭН
www.mgov.mn

1091.	**150 дугаар зүйл.Иттэмжлэлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох** 150.1.Гаалийн байгууллагаас гаалийн итгэмжлэгдсэн хүүлийн этгэдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. 150.2.Гаалийн байгууллагаас энэ хуулийн 148.5-д заасан шалгалтыг давтан хийнэ. 150.3.Иттэмжлэгдсэн хуулийн этгэдийн гэрчилгээний үйлчлэлийг дараах тохиолдолд түдгэлзүүлнэ: 150.3.1.иттэмжлэгдсэн хуулийн этгэд өөрөө хүсэлт гаргасан; 150.3.2.гаалийн байгууллагаас тогтоосон шалгуураас нэг болон түүнээс дээш шалгууры хангахгүй болсон; 150.3.3.тогтоосон хугацаанд тайлангаа гаалийн байгууллагад гаргаж өгөөгүй; 150.3.4.гаалийн байгууллагаас хийсэн шалгалтаар гаалийн болон бусад хууль тогтоомжийг нэг удаа зөрчсөн; 150.3.5.хуулийн этгэдийг үүсгэн байгуулагч, давуу эрхийн хувьцаа эзэмшигч, хараат болон охин компаний удирдлага гэмт хэрэг зөрчилд шалгагдаж байгаа. 150.4.Иттэмжлэгдсэн хуулийн этгэдийн эрхийг дараах үндэслэлээр хүчингүй болгоно: 150.4.1.иттэмжлэгдсэн хуулийн этгэд өөрөө хүсэлт гаргасан; 150.4.2.зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгэд тухайн бүтдсэн, өөр хуулийн этгэдтэй нэгдсэн, албан ёсны нэрээ сольсон; 150.4.3.гаалийн байгууллагатай байгуулсан гэрээ цуцлагдсан; 150.4.4.гаалийн болон бусад хууль, тогтоомжийг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчсөн; 150.4.5.хуулийн этгэдийг үүсгэн байгуулагч, давуу эрхийн хувьцаа эзэмшигч, хараат болон охин компанийн удирдлагад хамаарах эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай шийдвэр хүчин төгөлдөр болсон; 150.5.Түдгэлзүүлэх, хүчингүй болгох шийдвэр нь гарсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. 150.6.Гэрчилгээ нь хүчингүй болсон хуулийн этгэд энэ хуульд заасан шаардлагыг хангаж байгаа гэж үзвэл гурван жилийн дараа дахин хүсэлт гаргаж болно. 150.7.Иттэмжлэл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох болон бусад харилцааг зохицуулах журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.			

ХУУЛЬ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН www.legal.mn

1092.		**151 дүгээр зүйл.Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр** 151.1.Гаалийн байгууллага бусад орны гаалийн байгууллагатай итгэмжлэгдсэн эдийн засгийн операторын итгэмжлэлийг харилцан хүлээн зөвшөөрөх гэрээ, хэлэлцээр байгуулж хамтран ажиллана.		
1093.	**IV ХЭСЭГ ГААЛИЙН ХЯНАЛТ**	**III ХЭСЭГ ГААЛИЙН ХЯНАЛТ, БҮРДҮҮЛЭЛТ**	**6 ДУГААР БҮЛЭГ ГААЛИЙН ХЯНАЛТ**	*“хяналт” гэсний дараа “, бүрдүүлэлт” гэж нэмсэн*
1094.	**АРВАНГУРАВДУГААР БҮЛЭГ Гаалийн хяналт**	**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ГААЛИЙН ХЯНАЛТ**		-
1095.		**НЭГДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**		
1096.	**232 дугаар зүйл.Гаалийн хяналтын нийтлэг үндэслэл**	**29 дүгээр зүйл.Гаалийн хяналтын нийтлэг үндэслэл**		-
1097.	232.1.Гаалийн байгууллага нь гаалийн хяналтыг гаалийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлнэ.	29.1.Гаалийн байгууллага нь гаалийн хяналтыг гаалийн нутаг дэвсгэрт гаалийн хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлнэ.	**6.1 Стандарт** Гаалийн нутаг дэвсгэрт орж байгаа, эсхүл гаалийн нутаг дэвсгэрээс гарч байгаа бүх бараа, тээврийн хэрэгслийг гаалийн болон бусад татварт хамаарах эсэхийг харгалзахгүйгээр гаалийн хяналтанд хамруулна.	
1098.		29.2.Эрх бүхий албан тушаалтан ажил үүргийн хуваарийн дагуу гаалийн хяналтыг гаалийн байгууллагын нэрийн өмнөөс хэрэгжүүлнэ.		
1099.	232.2.Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батлах бөгөөд зарим бараа, тээврийн хэрэгслийн төрөл, онцлогийг харгалзан тусгай журам тогтоож болно.	29.3.Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батлах бөгөөд зарим бараа, тээврийн хэрэгслийн төрөл, онцлогийг харгалзан тусгай журам тогтоож болно.		
1100.	232.3.Гаалийн хяналтад байгаа барааг ачих, буулгах, задлах, сав, баглаа боодлыг өөрчлөх, тээврийн хэрэгслийг хөдөлгөхийг гагцхүү гаалийн байгууллагын зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.	29.4.Гаалийн хяналтад байгаа барааг ачих, буулгах, задлах, сав, баглаа боодлыг өөрчлөх, тээврийн хэрэгслийг хөдөлгөхийг гагцхүү гаалийн байгууллагын зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.		
1101.		29.7.Гаалийн байгууллагын шаардлагаар мэдүүлэгч, түр агуулах эзэмшигч, гаалийн зуучлагч болон бусад гаалийн харилцаанд оролцогч этгээдүүд нь гаалийн шалгалтад хамрагдаж байгаа барааг зөөх, жигнэх, тоо хэмжээг тодорхойлох бусад ажиллагаа хийх, ачих, буулгах, шилжүүлэн ачих, баглаа боодлыг нээх, түүнчилэн байр, агуулах, савыг онгойлгох ажиллагааг хийх үүрэг хүлээнэ.		

Хүчинь зүйл үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

1102.				
1103.	232.4.Гаалийн хяналтад байгаа барааг ачих, буулгах, хадгалах, шилжүүлэн ачих, түүнчлэн тээврийн хэрэгслийг саатуулсантай холбогдон гарах зардал, хохирлыг мэдүүлэгч өөрөө хариуцна.	29.8.Гаалийн хяналтад байгаа барааг ачих, буулгах, хадгалах, шилжүүлэн ачих, түүнчлэн тээврийн хэрэгслийг саатуулсантай холбогдон гарах зардал, хохирлыг холбогдох этгээд хариуцна.		*“мэдүүлэгч өөрөө хариуцна” гэснийг “гаалийн байгууллага хариуцахгүй” гэж өөрчилсөн*
1104.	232.5.Гаалийн хяналтыг тээврийн хэрэгслийн хөдөлгөөн дунд хэрэгжүүлж болно.	29.5.Гаалийн хяналтад байгаа барааг тээвэрлэх, ачих, буулгах, шилжүүлэн ачих ажиллагаа болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд гаалийн байгууллага, албан тушаалтан ажиглалт хийх бөгөөд ингэхдээ техник хэрэгсэл ашиглаж болно.		*232.5, 232.6-г нэгтгэж өөрчлөн найруулсан*
1105.	232.6.Гаалийн хяналтыг хэрэгжүүлэхдээ техник, багаж хэрэгсэл, эрэлч нохой зэргийг ашиглаж болно.			
1106.	232.7.Гаалийн байгууллага нь гаалийн хяналтыг хэрэгжүүлэхдээ мэдээллийн технологийг ашиглаж болно. 232.8.Гаалийн байгууллага нь гаалийн харилцаанд оролцогчдын мэдээллийн сүлжээг гаалийн зорилгоор хууль тогтоомжийн хүрээнд ашиглаж болно.			
1107.	232.9.Гаалийн хууль тогтоомж зөрчсөн болон зөрчихийг завдсан үйлдлийн талаархи мэдээллийг гаалийн байгууллага төлбөртэй, эсхүл төлбөргүйгээр хүлээн авч нууцлалыг хадгалах бөгөөд энэхүү мэдээллийг хүлээн авах журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.	29.6.Гаалийн байгууллага, албан тушаалтан нь гаалийн харилцаанд оролцогч болон бусад этгээдээс гаалийн хяналтад ач холбогдол бүхий мэдээлэл, тайлбарыг бичгээр гаргуулан авч болно.		*Өөрчлөн найруулсан*
1108.		**30 дугаар зүйл.Гаалийн хяналтын объект**		
1109.		30.1.Гаалийн хяналтад дараах объект хамрагдана:		*Шинээр нэмэгдсэн*
1110.		30.1.1.гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл;		
1111.		30.1.2.барааны гаалийн мэдүүлэг, холбогдох бусад бичиг баримт гаалийн хууль тогтоомжийн дагуу ирүүлсэн барааны талаарх мэдээлэл;		
1112.		30.1.3.гаалийн харилцаанд оролцогчийн гаалийн хяналт, бүрдүүлэлттэй холбоотой үйл ажиллагаа;		
1113.		30.1.4.гаалийн хилээр нэвтрэх зорчигч.		
1114.	**233 дугаар зүйл.Гаалийн хяналтын зарчим**	**31 дүгээр зүйл.Гаалийн хяналтын зарчим**		-
1115.	233.1.Гаалийн хяналтыг гацхүү хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэгжүүлнэ.	31.1.Гаалийн хяналтыг гацхүү хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэгжүүлнэ.	**6.1 Стандарт** Гаалийн нутаг дэвсгэрт орж байгаа, эсхүл гаалийн нутаг дэвсгэрээс гарч байгаа бүх бараа, тээврийн хэрэгслийг гаалийн болон бусад татварт хамаарах эсэхийг харгалзахгүйгээр гаалийн хяналтанд хамруулна.	

ХУУЛЬ ЗҮЙН УНИВЕРСИТЕТИЙН ХУРЭЭЛЭН www.lri.edu.mn

1116.		31.2.Хууль ёсны худалдааг хөнгөвчилж, үйлчилгээний шуурхай байдлыг хангана.	**6.2 Стандарт** Гаалийн хяналтыг гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хэмжээнд хязгаарлана.	
1117.		31.3.Хууль бус худалдааны уршиг нь хууль ёсны худалдаанд сөргөөр нөлөөлөхгүй байна.		
1118.		31.4.Гаалийн хяналт нь гаалийн хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах хэмжээнд хязгаарлагдана.	**6.3 Стандарт** Гаалийн байгууллага нь гаалийн хяналтыг	
1119.	233.2.Гаалийн удирдах төв байгууллага эрсдэл тооцох системд үндэслэн гаалийн хяналтын стратегийг тодорхойлно.	31.5.Гаалийн шалгалтын объект, хэлбэрийг сонгохдоо эрсдэлийн удирдлагын системийг ашиглан сонгон шалгах зарчимд үндэслэнэ.	явуулахдаа эрсдлийг тооцох аргыг хэрэглэнэ. **6.7 Стандарт**	*Хасагдсан*
1120.	233.3.Гаалийн хяналтын талаар гадаад орны гаалийн байгууллагатай хамтран ажиллаж, гаалийн хяналт, шалгалтыг аль нэг орны гаалийн нутаг дэвсгэр дээр хийхээр харилцан тохиролцож болно.	31.6.Гаалийн хяналтыг боловсронгуй болгох зорилгоор олон улсын гэрээний үндсэн дээр гадаад орны гаалийн байгууллагатай хамтран ажиллаж болно.	Гаалийн байгууллага нь бусад гаалийн байгууллагатай хамтран ажиллахыг, мөн гаалийн хяналтыг сайжруулах зорилгоор	-
1121.		31.7.Хөрш орны гаалийн байгууллагатай гаалийн хамтарсан шалгалтыг хэрэгжүүлнэ. Гаалийн хяналт шалгалтыг аль нэг орны гаалийн нутаг дэвсгэр дээр хийхээр харилцан тохиролцож болно.	байгууллагын хүрээнд харилцан туслалцаа үзүүлэх тухай хэлэлцээр байгуулахыг эрмэлзэнэ. **6.8 Стандарт**	
1122.	233.4.Гаалийн хяналтын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор гаалийн харилцаанд оролцогч талуудтай хамтран ажиллана.	31.8.Гаалийн хяналтын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор төрийн бусад хяналтын байгууллага, төрийн бус байгууллага, гаалийн харилцаанд оролцогч болон бусад этгээдүүдтэй хамтран ажиллана.	Гаалийн байгууллага нь худалдаанд оролцогч худалдаа эрхлэгч нартай хамтран ажиллахыг, мөн гаалийн хяналтыг сайжруулах зорилгоор харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулахыг эрмэлзэнэ.	*Хасагдсан*
1123.		31.9.Гаалийн байгууллага нь хууль тогтоомжид нийцүүлэн өөрийн эрх хэмжээний хүрээнд бусад хяналтыг хэрэгжүүлнэ.		*Шинээр нэмэгдсэн*
1124.		31.10.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол гаалийн хяналт, шалгалт хийхэд ямар нэгэн зөвшөөрөл, тогтоол, мэдэгдэл шаардагдахгүй.		*Шинээр нэмэгдсэн*
1125.	**234 дүгээр зүйл.Бараа, тээврийн хэрэгслийн гаалийн хяналтад байх хугацаа**	**32 дугаар зүйл.Бараа, тээврийн хэрэгслийн гаалийн хяналтад байх хугацаа**		*Шинээр нэмэгдсэн*
1126.	234.1.Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл нь дор дурдсан хугацаанд гаалийн хяналтад байна:	32.1.Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл доор дурдсан хугацаанд гаалийн хяналтад байна:		-
1127.	234.1.1.дотоодын хэрэглээнд зориулан хилийн чанадаас оруулах бараа,тээврийн хэрэслийн хувьд улсын хилээр орсон үеэс чөлөөт эргэлтэд оруулахыг гаалийн байгууллага зөвшөөрөх хүртэл;	32.1.1.дотоодын хэрэглээнд зориулан хилийн чанадаас оруулах бараа, тээврийн хэрэгсэл улсын хилээр орсон үеэс чөлөөт эргэлтэд оруулахыг гаалийн байгууллага зөвшөөрөх хүртэл, тодорхой болзолтойгоор чөлөөт эргэлтэд оруулсан бол тухайн болзолд заасан хязгаарлалтын хүрээнд хугацаагүйгээр;		
1128.	234.1.2.гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах бараа, тээврийн хэрэгслийн хувьд улсын хилээр орсон үеэс гаалийн нутаг дэвсгэрээс буцаан гаргах , эсхүл гаалийн бүрдүүлэлтийн өөр горимд байршуулах хүртэл;	32.1.2.гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах бараа, тээврийн хэрэгсэл нь улсын хилээр оруулсан үеэс гаалийн нутаг дэвсгэрээс буцаан гаргах, эсхүл гаалийн бүрдүүлэлтийн өөр горимд байршуулах хүртэл;		

1129.	234.1.3.улс хооронд дамжуулан өнгөрүүлэх бараа, тээврийн хэрэгслийн хувьд улсын хилээр орсон үеэс улсын хилээр гаргахыг хилийн гаалийн байгууллага зөвшөөрөх хүртэл; хилийн гаалийн байгууллагаас гүний гаалийн байгууллагад шилжүүлэх бол улсын хилээр орсон үеэс гүний гаалийн байгууллагад хүргэх хүртэл; гүний гаалийн байгууллагаас хилийн гаалийн байгууллагад шилжүүлэх бол гүний гаалийн байгууллагад мэдүүлсэн үеэс улсын хилээр гаргахыг хилийн гаалийн байгууллага зөвшөөрөх хүртэл; гүний гаалийн нэг байгууллагаас гүний гаалийн нөгөө байгууллагад шилжүүлэх бол гүний гаалийн нэг байгууллагаас гүний гаалийн нөгөө байгууллагад хүргэх хүртэл;	32.1.3.улс хооронд дамжуулан өнгөрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл улсын хилээр орсон үеэс улсын хилээр гаргахыг хилийн гаалийн байгууллага зөвшөөрөх хүртэл; хилийн гаалийн байгууллагаас гүний гаалийн байгууллагад шилжүүлэх бол улсын хилээр орсон үеэс гүний гаалийн байгууллагад хүргэх хүртэл; гүний гаалийн байгууллагаас хилийн гаалийн байгууллагад шилжүүлэх бол гүний гаалийн байгууллагад мэдүүлсэн үеэс улсын хилээр гаргахыг хилийн гаалийн байгууллага зөвшөөрөх хүртэл; гүний гаалийн нэг байгууллагаас гүний гаалийн нөгөө байгууллагад шилжүүлэх бол гүний гаалийн нэг байгууллагаас гүний гаалийн нөгөө байгууллагад хүргэх хүртэл;		*“хэрэгслийн хувьд” гэснийг “хэрэгсэл” гэж өөрчилсөн*
1130.	234.1.4.шилжүүлэн ачих барааны хувьд улсын хилээр орсон үеэс улсын хилээр гаргах хүртэл;	32.1.4.шилжүүлэн ачих бараа улсын хилээр орсон үеэс улсын хилээр гарах хүртэл;		
1131.	234.1.5.гаалийн нутаг дэвсгэрээс бүрмөсөн гаргах барааны хувьд гаалийн байгууллагад мэдүүлсэн үеэс улсын хилээр гаргахыг хилийн гаалийн байгууллага зөвшөөрөх хүртэл;	32.1.5.гаалийн нутаг дэвсгэрээс бүрмөсөн гаргах бараа гаалийн байгууллагад мэдүүлсэн үеэс улсын хилээр гаргахыг хилийн гаалийн байгууллага зөвшөөрөх хүртэл;		
1132.	234.1.6.гаалийн нутаг дэвсгэрээс түр хугацаагаар гаргах бараа, тээврийн хэрэгслийн хувьд гаалийн байгууллагад мэдүүлсэн үеэс гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах хүртэл, эсхүл гаалийн бүрдүүлэлтийн өөр горимд байршуулах хүртэл.	32.1.6.гаалийн нутаг дэвсгэрээс түр хугацаагаар гаргах бараа, тээврийн хэрэгсэл гаалийн байгууллагад мэдүүлсэн үеэс гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах хүртэл, эсхүл гаалийн бүрдүүлэлтийн өөр горимд байршуулах хүртэл.		
1133.	234.2.Бараа, тээврийн хэрэгсэл гаалийн баталгаат бүсэд байх хугацаанд гаалийн хяналтад байна.	32.2.Бараа, тээврийн хэрэгсэл гаалийн баталгаат бүсэд байх хугацаанд гаалийн хяналтад байна.		
1134.	**235 дугаар зүйл.Чөлөөт эргэлтэд байгаа барааны мэдээллийн үнэн зөвийг шалгах**			-
1135.	235.1.Гаалийн байгууллага гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор чөлөөт эргэлтэд байгаа барааны мэдээллийн үнэн зөвийг шалгах эрхтэй. 235.2.Чөлөөт эргэлтэд оруулсан барааны мэдээллийн үнэн зөвийг дараахь үндэслэлээр шалгана: 235.2.1.эрсдэл тооцох системд үндэслэн гаалийн хяналтын стратегийг тодорхойлох зорилгоор мэдээлэл цуглуулах; 235.2.2.гаалийн бүрдүүлэлтийн дараахь шалгалт хийх, зөрчлийг арилгуулах; 235.2.3.хууль тогтоомж зөрчсөн, эсхүл зөрчихийг завдаж байгаа тухай мэдээллийг шалгах; 235.3.Гаалийн удирдах төв байгууллагын даргын томилсон гаалийн албан тушаалтан мэдээллийн үнэн зөвийг шалгана. 235.4.Чөлөөт эргэлтэд орсон барааг гаалийн хилээр нэвтрүүлснээс хойш 5 жил хүртэл хугацаанд шалгаж болно.			*Хасагдсан*

ХУУЛЬ ЗҮЙН ИНДЭКСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.pmg.gov.mn

1136.	**236 дугаар зүйл.Гаалийн хяналтын бүс**	**33 дугаар зүйл.Гаалийн хяналтын бүс**		
1137.		33.1.Гаалийн удирдах төв байгууллагаас гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлийг хяналтад авах, бүрдүүлэлт хийхээр тогтоосон байр, талбай, гаалийн түр агуулах нь гаалийн хяналтын бүс байна.		
1138.		33.2.Гаалийн хяналтын бүсийг нутгийн гүнд болон хилийн боомтод байгуулж болно.		
1139.	236.1.Гаалийн байгууллага нь гаалийн хяналтын бүсийг тогтооно.	33.6.Гаалийн удирдах төв байгууллагын даргын тушаалаар гаалийн хяналтын бүсийг гурав хүртэл жилийн хугацаатайгаар тогтоох ба энэ хугацааг сунгаж болно.		*Өөрчлөн найруулсан*
1140.	236.2.Гаалийн хяналтын бүс байнгын болон түр байж болно.	33.3.Гаалийн хяналтын бүс нь байнгын болон түр байж болно.		
1141.		33.4.Гаалийн байгууллагын зөвшөөрлөөр тээвэрлэгч барааг гаалийн хяналтын бүсэд оруулна.		
1142.		33.5.Гаалийн хяналтын бүс байгуулах төслийг гаалийн байгууллага хянан үзэж, нөхцөл шаардлагыг хангасан тохиолдолд гаалийн хяналтын бүсийн зориулалтаар хөрөнгө оруулалт хийх болон үйл ажиллагааны зөвшөөрлийг гаалийн удирдах төв байгууллага бичгээр өгнө.		
1143.	236.3.Барааг гаалийн хяналтын бүсэд оруулснаас хойш 3 хүртэл хоног хадгалах бөгөөд энэ хугацаанд гаалийн бүрдүүлэлт хийгдээгүй бол барааг гаалийн түр агуулахад шилжүүлнэ. э			
1144.	236.4.Энэ хуулийн 236.3-т заасны дагуу барааг шилжүүлэх боломжгүй бол барааг гаалийн нээлттэй түр агуулахад шилжсэнд тооцох бөгөөд энэ тохиолдолд хяналтын бүс нь түр агуулахын үүрэг гүйцэтгэнэ.			
1145.	236.5.Гаалийн шалгалтыг гаалийн хяналтын бүсэд хийх боломжгүй бол өөр газарт мэдүүлэгчийн зардлаар хийж болно.			
1146.	236.6.Гаалийн хяналтын бүсийн журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.	33.7.Гаалийн хяналтын бүсийн журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.		-
1147.		33.8.Хилийн боомт, шалган нэвтрүүлэх цогцолбор дахь гаалийн хяналтын бүс нь энэ хуулийн 33.5-д хамаарахгүй.		
1148.		**34 дүгээр зүйл.Гаалийн хяналтын бүсэд тавигдах шаардлага**		*Шинээр нэмэгдсэн*
1149.		34.1.Гаалийн хяналтын бүс дараах шаардлагыг хангасан байна:		*Шинээр нэмэгдсэн*

ХУУЛЬ ЗҮЙН ТЕХНИКИЙН ХУРЭЭЛЭН www.pli.gov.mn

1150.		34.1.1.гаалийн хяналтын бүсэд орох, гарах хаалганаас бусад газраар бараа, тээврийн хэрэгсэл, бие хүн нэвтрэх боломжийг хаасан байх;		*Шинээр нэмэгдсэн*
1151.		34.1.2.гаалийн хяналтын бүс нь Монгол Улсын стандартад нийцсэн байх;		*Шинээр нэмэгдсэн*
1152.		34.1.3.гаалийн хяналтын бүс нь гаалийн хяналт, шалгалт хийх шаардлага хангасан байх;		*Шинээр нэмэгдсэн*
1153.		34.1.4.гаалийн байгууллагатай гаалийн цахим сүлжээнд холбогдон гаалийн хяналтын бүсэд гаалийн хяналт тавихад шаардагдах техник, тоног төхөөрөмж суурилуулсан байх;		*Шинээр нэмэгдсэн*
1154.		34.1.5.гаалийн хяналтын бүс нь олон нийтэд мэдэгдэхүйц, гаалийн удирдах төв байгууллагаас тогтоосон таних тэмдэг, хаягтай байх;		*Шинээр нэмэгдсэн*
1155.		34.1.6.гаалийн хяналтын бүсэд болон гадна талд нь тарифын бус хязгаарлалттай бараатай холбогдол бүхий хууль тогтоомж, бүсийн дэглэмийг олон нийтэд анхааруулсан самбар, дэлгэц байрлуулсан байх;		*Шинээр нэмэгдсэн*
1156.		34.1.7.гаалийн байгууллагын албан хаагч хэвийн, аюулгүй байдалд ажиллах нөхцөл хангасан ажлын байр, шаардлагатай тохиолдолд амьдрах байрны нөхцөл шаардлага хангасан байх;		*Шинээр нэмэгдсэн*
1157.		34.2.Гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаа эрхлэгч гаалийн хяналтын бүсэд оруулсан, гаргасан бараа, тээврийн хэрэгслийн мэдээг сар бүр гаргаж, дараа сарын 05-ны өдрийн дотор хяналт тавьж байгаа гаалийн байгууллагад гаргаж өгнө.		
1158.		**35 дугаар зүйл.Гаалийн хяналтын бүсийн дэглэм**		
1159.		35.1.Гаалийн хяналтын бүсэд нэвтрэхэд гаалийн байгууллагын зөвшөөрлийг үндэслэнэ. Уг зөвшөөрөл нь байнгын болон түр хугацаатай байна.		
1160.		35.2.Байнгын зөвшөөрөл нь тухайн хяналтын бүсэд тогтмол ажил үүрэг гүйцэтгэдэг ажилтанд олгогдоно. Тухайн гаалийн байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр дээрх зөвшөөрлийг эрх бүхий байгууллагын үнэмлэх орлож болно.		
1161.		35.3.Шаардлагатай бол түр хугацааны зөвшөөрлийг дараахь ажилтан, албан тушаалтанд олгоно:		
1162.		35.3.1.мэргэжлийн хяналтын ажилтан;		
1163.		35.3.2.засвар үйлчилгээ-техникийн ажилтан;		
1164.		35.3.3.нийгмийн дэг журам сахиулах ажилтан;		
1165.		35.3.4.хүн эмнэлгийн ажилтан;		
1166.		35.3.5.онцгой байдлын албаны ажилтан;		
1167.		35.3.6.эрх бүхий бусад ажилтан.		
1168.		35.4.Зорчигч, бараа, тээврийн хэрэгслийн эзэмшигчийг гаалийн бүрдүүлэлт хийлгэх зорилгоор хяналтын бүсэд нэвтрүүлэхэд биеийн байцаалтын баримт бичиг /үнэмлэх, гадаад паспорт/, зорчигчийн тийз, холбогдох барааны баримтыг үндэслэн нэвтрүүлнэ.		

ХУУЛЬ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН

1169.		35.5.Бараа эзэмшигч, тээвэрлэгч гаалийн хяналтын бүсэд бараа, тээврийн хэрэгслийг оруулснаас хойш 30 минутын дотор гаалийн байгууллагад бүртгүүлнэ.		
1170.		35.6.Барааг гаалийн хяналтын бүсэд оруулснаас хойш гурав хүртэл хоног хадгалах бөгөөд энэ хугацаанд гаалийн бүрдүүлэлт хийлгээгүй бол гаалийн хяналтын бүсийн эзэмшигч барааг гаалийн хяналт доор гаалийн түр агуулахад оруулна.		
1171.		35.7.Хяналтын бүсэд хадгалах хугацаа хэтэрсэн барааг шилжүүлэх түр агуулах байхгүй тохиолдолд гаалийн нээлттэй түр агуулахад шилжсэнээр тооцож гаалийн хяналтын бүсэд хадгална. Хадгалалтын хураамжийг эзэмшигч байгууллагын тогтоосны дагуу тооцно.		
1172.		35.8.Гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаа эрхлэгч гаалийн хяналтын бүсэд байршиж байгаа бараа, тээврийн хэрэгсэлд өөрчлөлт орсон тохиолдолд энэ тухай гаалийн байгууллагад мэдэгдэнэ.		
1173.		35.9.Гаалийн хяналтын бүсэд аж ахуйн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг гаалийн байгууллагын дарга олгоно. Хяналтын бүсэд явуулж байгаа үйл ажиллагаа нь гаалийн хяналтын үйл ажиллагаанд саад учруулахааргүй байна.		
1174.		35.10.Гаалийн хяналтын бүсэд дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:		
1175.		35.10.1.гаалийн хяналтын бүсэд зөвшөөрөгдсөнөөс бусад газраар бараа, тээврийн хэрэгсэл, хүн нэвтрүүлэх;		
1176.		35.10.2.гаалийн хяналтын бүсэд гаалийн байгууллагын зөвшөөрөлгүй бараа, тээврийн хэрэгсэл, хүн нэвтрүүлэх;		
1177.		35.10.3.гаалийн байгууллага зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулах;		
1178.		35.10.4.гаалийн хяналтын бүс, гаалийн хилийг тодорхойлсон анхааруулга, тэмдгийг эвдэх, гэмтээх, өөрчлөх, хяналтын бүсэд нийгмийн хэв журам алдагдуулах;		
1179.		35.10.5.гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр аж ахуйн зориулалтаар байр талбай түрээслүүлэх, аж ахуйн үйл ажиллагаа явуулах.		
1180.		**37 дугаар зүйл.Гаалийн хяналтын бүсийг татан буулгах**		
1181.		37.1.Гаалийн хяналтын бүсийг дараахь тохиолдолд татан буулгана:		
1182.		37.1.1.гаалийн байгууллагын байршил өөрчлөгдсөн;		
1183.		37.1.2.хилийн боомт хаагдсан;		
1184.		37.1.3.гаалийн хяналтад байгаа барааг хадгалах газар өөрчлөгдсөн;		

1185.		37.1.4.барааг ачих, буулгах, шилжүүлэн ачих газар өөрчлөгдсөн;		
1186.		37.1.5.гаалийн хяналтад байгаа барааг тээвэрлэж байгаа тээврийн хэрэгслийн зогсоол өөрчлөгдсөн;		
1187.		37.1.6.гаалийн хяналтын бүсийн эзэмшигч хүсэлт гаргасан.		
1188.		37.2.Гаалийн хяналтын бүсийг татан буулгах асуудлыг гаалийн удирдах төв байгууллага шийдвэрлэнэ.		
1189.	**237 дугаар зүйл.Гаалийн хяналтад шаардлагатай мэдээлэл, бичиг баримт гаргаж өгөх**	**38 дугаар зүйл.Гаалийн хяналтад шаардлагатай мэдээлэл, бичиг баримт гаргаж өгөх**		
1190.	237.1.Гаалийн харилцаанд оролцогч нь гаалийн хяналтад шаардлагатай мэдээлэл, бичиг баримтыг гаалийн байгууллагад гаргаж өгөх үүрэг хүлээнэ.	38.1.Гаалийн харилцаанд оролцогч нь гаалийн хяналтад шаардлагатай мэдээлэл, бичиг баримтыг гаалийн байгууллагад гаргаж өгөх үүрэг хүлээнэ.		
1191.	237.2.Гаалийн байгууллага нь гаалийн хяналтад шаардлагатай мэдээлэл, бичиг баримтыг тогтоосон хугацаанд гаргуулан авна.	38.2.Гаалийн байгууллага нь гаалийн хяналтад шаардлагатай мэдээлэл, бичиг баримтыг тогтоосон хугацаанд гаргуулан авна.		
1192.	237.3.Гаалийн байгууллага нь гаалийн хяналтад шаардагдах мэдээлэл, бичиг баримтыг энэ хуулийн 237.1-д зааснаас бусад этгээдээс гаргуулан авч болно.	38.3.Гаалийн байгууллага нь гаалийн хяналтад шаардагдах мэдээлэл, бичиг баримтыг энэ хуулийн 38.1-д зааснаас бусад холбогдох этгээдээс гаргуулан авч болно.		-
1193.	237.4.Мэдүүлэгч, тээвэрлэгч, түүнчлэн түр агуулах, гаалийн баталгаат бүсийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч нь гаалийн үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтыг 5 жил хадгална.			*Хасагдсан*
1194.		**39 дүгээрзүйл.Гамшгийн үед авах арга хэмжээ**		
1195.		39.1.Гаалийн хяналтад байгаа бараа, тээврийн хэрэгслийг гамшгийн улмаас гаалийн байгууллага бүхий газарт тээвэрлэн хүргэх боломжгүй болсон тохиолдолд тээвэрлэгч хамгийн ойр байрлах гаалийн байгууллагад мэдэгдэх, түүнд хүргэх арга хэмжээ авна.		
1196.		39.2.Энэ хуулийн 39.1-д заасан тохиолдолд тухайн бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр ашиглах, эсхүл бусдад шилжүүлэхийг хориглоно.		
1197.		39.3.Энэ хуулийн 39.1-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд гарах зардлыг гаалийн байгууллага хариуцахгүй.		
1198.	**238 дугаар зүйл.Гаалийн хяналтад шаардагдах тайлан** 238.1.Зуучлагч, тээвэрлэгч, түүнчлэн түр агуулах, гаалийн баталгаат бүсийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч нь гаалийн байгууллагаас баталсан загварын дагуу тайлан гаргана.			*Хасагдсан*
1199.	**239 дүгээр зүйл. Хохирол учрахаас сэргийлэх**			*Хасагдсан*
1200.	239.1.Гаалийн байгууллага, албан тушаалтан нь хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэхдээ бараа, тээврийн хэрэгсэлд хохирол учруулах аливаа үйлдэл, эс үйлдэхүй гаргаж үл болно.			*Хасагдсан*

Хүчин зүйл ундэсний хүрээлэн www.nli.gov.mn

1201.	239.2.Гаалийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас бусдад учруулсан хохирлыг гаалийн байгууллага барагдуулна.			*Хасагдсан*
1202.	239.3.Бусдад хохирол учруулсан гаалийн албан тушаалтанд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.			*Хасагдсан*
1203.	239.4.Гаалийн байгууллага энэ хуулийн 239.2-т зааснаар барагдуулсан хохирлыг буруутай гаалийн албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргана.			*Хасагдсан*
1204.	**240 дүгээр зүйл.Гаалийн хяналтын хэлбэр** 240.1.Гаалийн хяналт нь дараахь хэлбэртэй байна: 240.1.1.мэдээлэл, бичиг баримтыг шалгах; 240.1.2.амаар мэдүүлэх; 240.1.3.тайлбар гаргуулах; 240.1.4.гаалийн зорилгоор ажиглалт хийх; 240.1.5.бараа, тээврийн хэрэгслийн гаднах байдлыг шалгах; 240.1.6.бараа, тээврийн хэрэгслийг шалгах; 240.1.7.хүний биед үзлэг хийх; 240.1.8.байр, агуулах, талбайг шалгах; 240.1.9.гаалийн бүрдүүлэлтийн дараахь шалгалт; 240.1.10.бусад. 240.2.Гаалийн байгууллага нь гаалийн хяналтыг хэрэгжүүлэхдээ эрсдэл тооцох аргыг хэрэглэнэ.			*Хасагдсан*
1205.		**АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ ГААЛИЙН ШАЛГАЛТ**		*Шинээр нэмэгдсэн*
1206.		**НЭГДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**		*Шинээр нэмэгдсэн*
1207.		**115 дугаар зүйл.Гаалийн шалгалт** 115.1.Гаалийн байгууллагын албан тушаалтан дараах объектод гаалийн шалгалт хийнэ: 115.1.1.гаалийн байгууллагад мэдүүлсэн бараа, тээврийн хэрэгсэл; 115.1.2.гаалийн мэдүүлэг, бичиг баримт; 115.1.3.гаалийн хилээр нэвтэрч байгаа зорчигч, түүний бараа, эд зүйл. 115.2.Гаалийн шалгалтыг гаалийн хяналтын бүсэд хийнэ. 115.3.Бараа, тээврийн хэрэгсэл, бичиг баримт хадгалагдаж байгаа байр, агуулах, талбайд гаалийн шалгалтыг хийж болно. 115.4.Гаалийн шалгалтыг тээврийн хэрэгслийн хөдөлгөөн дунд хэрэгжүүлж болно. 115.5.Гаалийн шалгалтад зарцуулах цаг хугацааг багасгах, шалгалтын үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор техник, багаж хэрэгсэл, эрэлч нохой зэргийг ашиглаж болно.		*Шинээр нэмэгдсэн*

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

1208.	**116 дугаар зүйл.Гаалийн шалгалтын хэлбэр** 116.1.Гаалийн шалгалт дараах хэлбэртэй байна: 116.1.1.гаалийн мэдүүлэг, бичиг баримт шалгах; 116.1.2.тайлбар гаргуулах; 116.1.3.бараа, тээврийн хэрэгслийн гаднах байдлыг шалгах; 116.1.4.бараа, тээврийн хэрэгслийг шалгах; 116.1.5.хүний биед үзлэг хийх; 116.1.6.байр, агуулах, талбайг шалгах; 116.1.7.гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалт.			*Шинээр нэмэгдсэн*
1209.	**117 дугаар зүйл.Гаалийн шалгалтын түвшин** 117.1.Гаалийн шалгалтыг эрсдэлийн удирдлагын системээс сонгогдсон дараах түвшинд хийнэ: 117.1.1.бичиг баримт, бараа тээврийн хэрэгсэлд шалгалт хийхгүй; 117.1.2.зөвхөн бичиг баримтын шалгалт хийх; 117.1.3.бичиг баримт, бараа тээврийн хэрэгсэлд шалгалт хийх.			*Шинээр нэмэгдсэн*
1210.	**118 дугаар зүйл.Гаалийн мэдүүлгийг шалгах** 118.1.Гаалийн байгууллага, албан тушаалтан гаалийн мэдүүлгийг хүлээн авч дараах байдлаар шалгана: 118.1.1.гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу шаардагдах бичиг баримт бүрэн, хүчин төгөлдөр эсэх; 118.1.2.гаалийн мэдүүлэгт өгөгдсөн мэдээллийг баталгаажуулах бичиг баримт гаалийн бүрдүүлэлтийн горимын агуулгад нийцэж байгаа эсэх; 118.1.3.гаалийн мэдүүлгийн маягтын хүснэгт түс бүрийн мэдээллийг холбогдох бичиг баримтын мэдээлэлтэй тулгах; 118.1.4.гаалийн мэдүүлэг, барааны дагалдах бичиг баримтад дүрсэн мэдээлэл үнэн зөв, бодитой, хоорондоо тохирч байгаа эсэх; 118.1.5.барааны нэр төрөл, марк, зориулалт, хүчин чадал, ангиллын код, хэмжих нэгжийг уялдуулан шалгах; 118.1.6.мэдүүлэгч гаалийн үнийг үнэн зөв, бодитой тодорхойлсон эсэхийг шалгах; 118.1.7.барааны гарал үүслийн улс, тарифын төрлийг үнэн зөв мэдүүлсэн эсэхийг нягтлан шалгах; 118.1.8.гаалийн болон бусад татварын ногдуулалт зөв эсэхийг шалгах; 118.1.9.тухайн өдөр хүчин төгөлдөр мөрдөж байгаа татварын хувь хэмжээ, валютын ханшийг шалгах; 118.1.10.гаалийн болон бусад татвараас чөлөөлөгдсөн үндэслэл, бичиг баримт, чөлөөлөлтийн кодыг шалгах; 118.1.11.татвар төлөлт, төлөлтийн кодыг шалгах. 118.2.Гаалийн мэдүүлгийн хүснэгтүүдийн харилцан хамаарал, уялдаа холбоог дараах байдлаар нягтлан шалгана:			

ХУУЛЬ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН
www.legal.mn

	118.2.1.сонгосон гаалийн бүрдүүлэгтийн горимын код хэлцлийн төрлийн кодтой тохирч байгаа эсэх; 118.2.2.барааны нэр төрөл шаардлагын дагуу бүрэн, зөв бичигдсэн эсэх тэврийн хэрэгслийн арал, хөдөлгүүрийн дугаар, үйлдвэрлэсэн он бүрэн зөв бичигдсэн эсэх; 118.2.3.гарал үүслийн улсыг тухайн илгээч улстай нь харьцуулан нягтлах; 118.2.4.хэлцлийн тоо хэмжээг ангилын тоо хэмжээнд зөв шилжүүлсэн эсэхийг шалгах; 118.2.5.ангилын хэмжих нэгжээр илэрхийлэгдэх ангиллын тоо хэмжээ зөв тооцоологдсон эсэх; 118.2.6.ангиллын хэмжих нэгж килограмм байхад ангиллын тоо хэмжээ цөөр жингийн тоон үзүүлэлт тэнцүү байхыг нягтлах; 118.2.7.гаалийн бүрдүүлэгтийн хураамжийн дүнг зөв тооцоолсон эсэхийг нягтлах; 118.2.8.тодотгох тоо хэмжээ бичигдсэн тохиолдолд тодотгох тоонд хамаарах бусад хүснэгтүүдийн тооцоолол зөв хийгдсэн эсэх; 118.3.Гаалийн байгууллага бүрэн эрхээ хэрэгжүүлэх болон гаалийн хууль тогтоомжид заасан шаардлагыг хангах хүрээнд барааны дагалдах бичиг баримтыг гаргуулан авна.			
1211.	**241 дүгээр зүйл.Мэдээлэл, бичиг баримтыг шалгах**	**119 дүгээр зүйл.Мэдээлэл, бичиг баримтыг шалгах**			
1212.	241.1.Гаалийн байгууллага нь мэдүүлэгчээс ирүүлсэн мэдээлэл, бичиг баримт хүчинтэй, зөв бүрдүүлсэн эсэхийг шалгана.	119.1.Гаалийн байгууллага нь мэдүүлэгчээс ирүүлсэн мэдээлэл, бичиг баримт хүчинтэй, үндэслэлтэй, зөв бүрдүүлсэн эсэхийг дараах аргаар шалгана: 119.1.1.бичиг баримтуудын мэдээлэл хоорондоо тохирч байгаа эсэх; 119.1.2.мэдээлэл агуулсан бичиг баримтуудыг бусад эх сурвалжийн мэдээлэлтэй харьцуулах; 119.1.3.гаалийн мэдээллийн сангийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх; 119.1.4.мэдээллийн технологийг ашигласан мэдээллийг боловсруулах;			
1213.		119.2.Гаалийн байгууллага мэдээлэл, бичиг баримтын эх хувийг, эсхүл түүний хуулбарыг гаргуулан авах бөгөөд шаардлагатай бол бичиг баримтын хуулбарыг эх хувьтай нь тулган шалгана.			
1214.	241.2.Гаалийн байгууллага нь энэ хуулийн 241.1-д заасан бичиг баримт, мэдээллийг шалгахдаа үндэслэлэх амаар болон бичгээр танилцуулж, нэмэлт бичиг баримт, мэдээлэл шаардаж болно.	119.3.Гаалийн байгууллага энэ хуулийн 119.1-д заасан бичиг баримт, мэдээллийг шалгахдаа үндэслэлэх амаар болон бичгээр танилцуулж, нэмэлт бичиг баримт, мэдээлэл шаардаж болно.			
1215.		119.4.Гаалийн шалгалтад ашиглах зорилгоор гаалийн байгууллага хууль тогтоомжийн хүрээнд банк, санхүүгийн үйл ажиллагаа явуулдаг бусад байгууллагаас гадаад худалдааны хэлцлийн дагуу хийгдсэн гүйлгээний баримт, мөнгөн гүйлгээний мэдээллийг гаргуулж авах эрхтэй.			

ХУУЛЬ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН
www.legal.mn

1216.		119.5.Барааг гаалийн байгууллага мэдүүлэгчийн сонгосон горимд байршуулсны дараа мэдүүлэгчээс худалдааны, санхүүгийн болон бусад мэдээлэл, түүний дотор барааг хилээр нэвтрүүлэх, барааг хүлээн авах, мөн барааг гаалийн нутаг дэвсгэр дээр ашиглаж байгаа талаарх мэдээллийг бичгээр болон цахимаар авч болно.		
1217.		119.6.Гаалийн бүрдүүлэлт, хяналт, шалгалтад шаардлагатай баримт, мэдээлэл, гаалийн мэдүүлгийг гаалийн харилцаанд оролцогчид болон гаалийн байгууллага архивын хууль тогтоомжид заагдсан нөхцөлийн хүрээнд архивын нэгж үүсгэн, хуульд өөрөөр заагаагүй бол таван жилийн хугацаагаар хадгална.		
1218.	**242 дугаар зүйл.Амаар мэдүүлэх** 242.1.Гаалийн албан тушаалтан гаалийн хяналтыг хэрэгжүүлэхдээ гаалийн харилцаанд оролцогчоос амаар мэдүүлэг авч болно.			*Хасагдсан*
1219.	**243 дугаар зүйл.Тайлбар гаргуулах**	**120 дугаар зүйл.Тайлбар гаргуулах**		
1220.	243.1.Гаалийн байгууллага, албан тушаалтан нь гаалийн харилцаанд оролцогч болон бусад этгээдээс гаалийн хяналтад ач холбогдол бүхий тайлбарыг бичгээр гаргуулан авч болно.	120.1.Гаалийн байгууллага, албан тушаалтан гаалийн харилцаанд оролцогч болон бусад этгээдээс гаалийн хяналт, шалгалтад ач холбогдол бүхий тайлбарыг бичгээр гаргуулан авч болно.		*Хасагдсан*
1221.	**244 дүгээр зүйл.Ажиглалт хийх**			
1222.	244.1.Гаалийн хяналтад байгаа барааг тээвэрлэх, ачих, буулгах, шилжүүлэн ачих ажиллагаа болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд гаалийн байгууллага, албан тушаалтан ажиглалт хийх бөгөөд ингэхдээ техник хэрэгсэл ашиглаж болно.			*Хасагдсан*
1223.	**245 дугаар зүйл.Бараа, тээврийн хэрэгслийн гаднах байдлыг шалгах**	**121 дүгээр зүйл.Бараа, тээврийн хэрэгслийн гадна байдлыг шалгах**		
1224.	245.1.Гаалийн байгууллага нь гаалийн хилээр нэвтрүүлж буй бараа, тээврийн хэрэгслийн гаднах байдал, битүүмжлэл, тодорхой нэрийн барааны тусгай тэмдгийг шалгана.	121.1.Гаалийн байгууллага гаалийн хилээр нэвтрүүлж байгаа бараа, тээврийн хэрэгслийн гаднах байдал, тэмдэглэгээ, тодорхой нэрийн барааны тусгай тэмдгийн бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүйгээр шалгана.		бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүйгээр
1225.	245.2.Энэ хуулийн 245.1-д заасан шалгалтыг мэдүүлэгчийг байлцуулахгүйгээр хийж болно.	121.3.Энэ хуулийн 121.1-д заасан шалгалтыг мэдүүлэгчийг байлцуулахгүйгээр хийж болно.		-
1226.		121.2.Бараа, тээврийн хэрэгслийн гадна байдлыг шалгахдаа хяналтын техник хэрэгслийг ашиглан дотоод бүтэц, байдлыг тодорхойлно		
1227.	**246 дугаар зүйл.Бараа, тээврийн хэрэгслийг шалгах**	**112 дугаар зүйл.Бараа, тээврийн хэрэгслийг шалгах**		
1228.	246.1.Гаалийн байгууллага, албан тушаалтан нь барааны гаалийн мэдүүлгийг хүлээн авсны дараа түүний үнэн зөвийг тогтоох зорилгоор бараа, тээврийн хэрэгсэлд шалгалт хийнэ.	122.1.Гаалийн байгууллага, албан тушаалтан нь барааны гаалийн мэдүүлгийг хүлээн авсаны дараа түүний үнэн зөвийг тогтоох зорилгоор бараа, тээврийн хэрэгсэлд шалгалт хийж болно.		*“хийнэ” гэснийг “хийж болно” гэж өөрчилсөн*

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.legalinfo.mn

1229.		122.2.Гаалийн байгууллагын албан тушаалтан нь бараа, тээврийн хэрэгсэлд шалгалт хийх газар, цагийг мэдүүлэгч болон бусад холбогдох этгээдэд мэдэгдэнэ		
1230.	246.2.Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны шинж байдлыг тогтоох, эсхүл гаалийн хууль тогтоомж зөрчсөн тухай мэдээллийг нягтлан шалгах зорилгоор гаалийн байгууллага, албан тушаалтан нь гаалийн мэдүүлгийг хүлээн авахаас өмнө энэ хуулийн 246.1-д заасан шалгалт хийж болно	122.3.Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны шинж байдлыг тогтоох, эсхүл гаалийн хууль тогтоомж зөрчсөн тухай мэдээллийг нягтлан шалгах зорилгоор гаалийн байгууллага, албан тушаалтан нь гаалийн мэдүүлгийг хүлээн авахаас өмнө энэ хуулийн 122.1-д заасан шалгалт хийж болно.		
1231.	246.3.Гаалийн хяналтад байгаа бараа, тээврийн хэрэгслийн битүүмжлэлийг авах, онгойлгох, баглаа боодлыг задлах, барааг таних, тоолох зэрэг аль тохиромжтой аргаар шалгана.	122.4.Гаалийн хяналтад байгаа бараа, тээврийн хэрэгслийн тэмдэглэгээг авах, онгойлгох, баглаа боодлыг задлах, барааг таних, тоолох зэрэг аль тохиромжтой аргаар шалгана.		
1232.	246.4.Бараа, тээврийн хэрэгслийг шалгахад мэдүүлэгчийг байлцуулах бөгөөд мэдүүлэгч нь шалгалтад биечлэн байлцах боломжгүй тохиолдолд тээвэрлэгчийг оролцуулж болно.	122.5.Бараа, тээврийн хэрэгслийг шалгахад мэдүүлэгчийг байлцуулах бөгөөд мэдүүлэгч нь шалгалтад биечлэн байлцах боломжгүй тохиолдолд тээвэрлэгчийг байлцуулна.		тээвэрлэгчийг байлцуулна.
1233.	246.5.Гаалийн байгууллага, албан тушаалтан нь дараахь барааг мэдүүлэгчийг байлцуулахгүйгээр шалгаж болно:	122.6.Гаалийн байгууллага, албан тушаалтан дараах барааг мэдүүлэгчийг байлцуулахгүйгээр шалгаж болно:		
1234.	246.5.1.нийтийн аюулгүй байдал, хүн ам, ургамал, амьтан, хүрээлэн буй орчинд аюул учруулж болохуйц тэсэрч дэлбэрэх, түргэн шатах бараа, цацраг идэвхт бодис, химийн хорт болон аюултай бодис, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, түүх, соёлын үнэт зүйлс;	122.6.1.нийтийн аюулгүй байдал, хүн ам, ургамал, амьтан, хүрээлэн байгаа орчинд аюул учруулж болохуйц тэсэрч дэлбэрэх, түргэн шатах бараа, цацраг идэвхт бодис, химийн хорт болон аюултай бодис, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, түүх, соёлын үнэт зүйлс		
1235.	246.5.2.улс хоорондын шуудангийн илгээмж	122.6.2.улс хоорондын шуудангийн илгээмж;		
1236.	246.5.3.гаалийн хууль тогтоомж зөрчсөн тухай мэдээллийн дагуу нягтлан шалгах бараа	122.6.3.гаалийн хууль тогтоомж зөрчсөн тухай мэдээллийн дагуу нягтлан шалгах бараа;		
1237.		122.6.4.гаалийн байгууллагын гаалийн шалгалт хийхээр тогтоосон газар, цагт мэдүүлэгч ирээгүй бол;		
1238.		122.6.5.гаалийн хяналтаас гадуур эзэнгүй орхигдсон бараа.		
1239.	246.6.Гаалийн байгууллага нь энэ хуулийн 246.5-д заасны дагуу барааг шалгалт хийсэн тохиолдолд хөндлөнгийн гэрчийг байлцуулж шалгасан тухай акт үйлдэнэ.	122.7.Гаалийн байгууллага энэ хуулийн 122.6-д заасны дагуу барааг шалгалт хийсэн тохиолдолд хөндлөнгийн гэрчийг байлцуулж, бараа шалгасан тухай акт үйлдэнэ.		
1240.	246.7.Гаалийн шалгалтыг дахин хийж болно.	122.8.Гаалийн шалгалт дууссаны дараа шаардлагатай тохиолдолд бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналтын бүсээс гарахаас өмнө дахин шалгаж болно.		*“шалгалтыг” гэснийг “шалгалт дууссаны дараа шаардлагатай тохиолдолд бараа тээврийн хэрэгслийг” гэж өөрчилсөн*

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН

1241.	246.8.Гаалийн шалгалтыг гаалийн хяналтын бүсэд хийх боломжгүй бол гаалийн байгууллагын зөвшөөрлөөр шалгалт хийх нөхцөлөөр хангагдсан албаны болон ахуйн байранд мэдүүлэгчийн зардлаар хийж болох бөгөөд энэ тохиолдолд тухайн албаны болон ахуйн байр нь гаалийн хяналтын бүсийн үүргийг түр гүйцэтгэнэ.	122.9.Гаалийн шалгалтыг гаалийн хяналтын бүсэд хийх боломжгүй бол гаалийн байгууллагын зөвшөөрлөөр шалгалт хийх нөхцөлөөр хангагдсан албаны болон ахуйн байранд мэдүүлэгчийн зардлаар хийж болох бөгөөд энэ тохиолдолд тухайн албаны болон ахуйн байр нь гаалийн хяналтын бүсийн үүргийг түр гүйцэтгэнэ.		
1242.	246.9.Гаалийн байгууллага нь тогтоосон цагийн хуваарьтай улс хоорондын зорчигч болон бараа тээврийн хэрэгсэлд хийх шалгалтыг хуваарьт цагт нь багтаан дуусгах бөгөөд зайлшгүй гэж үзвэл гаалийн байгууллагын даргын шийдвэрээр уг хугацааг сунгаж болно.	122.10.Гаалийн байгууллага тогтоосон цагийн хуваарьтай улс хоорондын зорчигч болон бараа тээврийн хэрэгсэлд хийх шалгалтыг хуваарьт цагт нь багтаан дуусгах бөгөөд шаардлагатай гэж үзвэл гаалийн байгууллагын даргын шийдвэрээр уг хугацааг сунгаж болно		-
1243.	**247 дугаар зүйл.Хүний биед үзлэг хийх**	**123 дугаар зүйл.Хүний биед үзлэг хийх**		
1244.	247.1.Гаалийн зөрчил илэрсэн, эсхүл барааг биедээ нуусан гэх хангалттай үндэслэл, сэжиг байгаа бол гаалийн албан тушаалтан дор дурдсан журмыг баримтлан хүний биед үзлэг хийнэ:	123.1.Гаалийн зөрчил илэрсэн, эсхүл барааг биедээ нуусан гэх хангалттай үндэслэл, сэжиг байгаа бол гаалийн албан тушаалтан доор дурдсан журмыг баримтлан хүний биед үзлэг хийнэ:		
1245.	247.1.1.үзлэг хийх тухай гаалийн байгууллагын удирдах албан тушаалтанд мэдэгдэх;	123.1.1.үзлэг хийх тухай гаалийн байгууллагын удирдах албан тушаалтанд мэдэгдэх;		
1246.	247.1.2.үзлэг хийхийн өмнө энэ тухайгаа уг этгээдэд мэдэгдэж, эрх, үүргийг нь тайлбарлах, биедээ нуусан барааг сайн дураар гаргаж өгөхийг сануулах;	123.1.2.үзлэг хийхийн өмнө энэ тухайгаа уг этгээдэд мэдэгдэж, үүргийг тайлбарлах, биедээ нуусан бараа байгаа бол сайн дураар гаргаж өгөхийг сануулах;		
1247.	247.1.3.эрүүл ахуйн шаардлага хангасан, гадны хүн орох болон үзлэгийн явцыг гаднаас харах боломжгүй өрөөнд үзлэг хийх;	123.1.3.эрүүл ахуйн шаардлага хангасан, гадны хүн орох болон үзлэгийн явцыг гаднаас харах боломжгүй өрөөнд үзлэг хийх;		
1248.	247.1.4.үзлэг хийх гаалийн албан тушаалтан нь шалгуулж байгаа хүнтэй ижил хүйсийнх байх, ийм хүйсийн хүн байхгүй бол хүний эмч урьж үзлэгт оролцуулах;	123.1.4.үзлэг хийх гаалийн албан тушаалтан шалгуулж байгаа хүнтэй ижил хүйсийнх байх, тийм хүн байхгүй бол хүний эмчээр үзлэг хийлгэх;		байх, тийм хүн байхгүй бол хүний эмчээр үзлэг хийлгэх
1249.	247.1.5.үзлэг хийх үед шалгуулж байгаа хүнтэй ижил хүйсийн хөндлөнгийн гэрчийг байлцуулах;	123.1.5.үзлэг хийх үед шалгуулж байгаа хүнтэй ижил хүйсийн хөндлөнгийн гэрчийг байлцуулах;		
1250.	247.1.6.насанд хүрээгүй, эсхүл эрх зүйн чадамжгүй хүний биед үзлэг хийх бол тэдний хууль ёсны төлөөлөгч, эсхүл дагалдан яваа хүнийг нь байлцуулах.	123.1.6.насанд хүрээгүй, эсхүл эрх зүйн чадамжгүй хүний биед үзлэг хийх бол тэдний хууль ёсны төлөөлөгч, эсхүл дагалдан яваа хүнийг нь байлцуулах.		
1251.	247.2.Энэ хуулийн 247.1-д заасны дагуу шалгуулж байгаа хүн нь дор дурдсан эрх эдэлнэ:	123.2.Энэ хуулийн 123.1-д заасны дагуу шалгуулж байгаа хүн доор дурдсан эрх эдэлнэ:		
1252.	247.2.1.өөрийн эрх, үүрэгтэй танилцах;	123.2.1.өөрийн эрх, үүрэгтэй танилцах;		
1253.	247.2.2.тайлбар өгөх, хүсэлт гаргах;	123.2.2.тайлбар өгөх, хүсэлт гаргах;		
1254.	247.2.3.биед үзлэг хийсэн тухай тэмдэглэлтэй танилцах;	123.2.3.биед үзлэг хийсэн тухай тэмдэглэлтэй танилцах;		
1255.	247.2.4.өөрийн төрөлх хэлээр ярих, шаардлагатай тохиолдолд орчуулагч байлцуулах;	123.2.4.өөрийн төрөлх хэлээр ярих, монгол хэл мэддэггүй, эсхүл хэл ярианы бэрхшээлтэй бол орчуулагч, эсхүл хэлмэрч байлцуулах;		
1256.	247.2.5.биед нь үзлэг хийх явцад өөрийнх нь хууль ёсны эрхийг зөрчсөн гэж үзвэл энэ хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу гомдол гаргах.	123.2.5.биед нь үзлэг хийх явцад өөрийнх нь хууль ёсны эрхийг зөрчсөн гэж үзвэл энэ хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу гомдол гаргах.		

ЦАГДАН ХУРЭЭЛЭН НЭЛЭЭРХИЙ ХУРЭЭЛЭН

1257.	247.3.Үзлэг хийлгэж байгаа хүн гаалийн албан тушаалтны хууль ёсны шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.	123.3.Үзлэг хийлгэж байгаа хүн гаалийн албан тушаалтны хууль ёсны шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.		
1258.	247.4.Гаалийн албан тушаалтан нь хүний биед үзлэг хийхдээ тухайн этгээдийн нэр төр, алдар хүндийг гутаах, хүний эрүүл мэндэд аюултай арга хэрэглэхийг хориглоно.	123.4.Гаалийн албан тушаалтан хүний биед үзлэг хийхдээ тухайн этгээдийн нэр төр, алдар хүндийг гутаах, хүний эрүүл мэндэд аюултай арга, хэрэгсэл ашиглахыг хориглоно.		
1259.	247.5.Гаалийн албан тушаалтан хүний биед үзлэг хийсэн тухай тэмдэглэл хөтөлж, түүнд үзлэг хийлгэсэн этгээд болон оролцсон албан тушаалтан, хөндлөнгийн гэрч, бусад этгээдээр гарын үсэг зуруулна.	123.5.Гаалийн албан тушаалтан хүний биед үзлэг хийсэн тухай тэмдэглэл хөтөлж, түүнд үзлэг хийлгэсэн этгээд болон оролцсон албан тушаалтан, хөндлөнгийн гэрч, бусад этгээдээр гарын үсэг зуруулна.		-
1260.		123.6.Биедээ нуусан барааг сайн дураар гаргаж өгсөн нь үзлэг хийхгүй байх үндэслэл болохгүй.		
1261.	**248 дугаар зүйл.Байр, агуулах, талбайг шалгах**	**124 дүгээр зүйл.Байр, агуулах, талбайг шалгах**		*Шинээр нэмэгдсэн*
1262.	248.1.Гаалийн байгууллага, албан тушаалтан нь дараахь бараа байрших байр, агуулах, талбайд шалгалт хийнэ:	124.1.Гаалийн байгууллага, албан тушаалтан дараах бараа байрших байр, агуулах, талбайд шалгалт хийнэ:		
1263.	248.1.1.гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан бараа;	124.1.1.гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан бараа;		
1264.	248.1.2.гаалийн байгууллагын зөвшөөрлөөр мэдүүлэгчид хадгалуулсан бараа;	124.1.2.гаалийн байгууллагын зөвшөөрлөөр мэдүүлэгчид хадгалуулсан бараа;		
1265.	248.1.3.түр агуулах, гаалийн баталгаат бүсэд байгаа бараа.	124.1.3.түр агуулах, гаалийн баталгаат бүсэд байгаа бараа;		
1266.		124.1.4.тодорхой нөхцөл болзолтойгоор олгосон бараа.		*ШИНЭ*
1267.	248.2.Гаалийн хяналтад байгаа бараа, тээврийн хэрэгсэл алдагдсан,эсхүл гаалийн хууль тогтоомж зөрчсөн тухай мэдээлэл байгаа бол байр, агуулах, талбайд гаалийн байгууллага, албан тушаалтан шалгалт хийнэ.	124.2.Гаалийн баталгаат бүсийн байр, агуулах, талбай хууль тогтоомжоор тогтоосон нөхцөл шаардлагыг хангаж байгаа эсэхэд шалгалт хийнэ. Уг шалгалтыг батлагдсан удирдамжийн дагуу гаалийн албаны үнэмлэх үзүүлэн хийж, тэмдэглэл үйлдэнэ.		*өөрчилсөн-*
1268.	248.3.Энэ хуулийн 248.1-д зааснаас бусад газар гаалийн хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бараа байгаа гэх хангалттай үндэслэл, сэжиг байгаа бол гаалийн байгууллага уг бараа хадгалагдаж буй байр, агуулах, талбайд шалгалт хийж болох бөгөөд энэ нөхцөлд барааны тусгай тэмдгийг шалгана.	124.3.Энэ хуулийн 124.1-д зааснаас бусад газарт гаалийн хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бараа байгаа гэх мэдээлэл, хангалттай үндэслэл, сэжиг байгаа бол гаалийн байгууллага уг бараа хадгалагдаж байгаа байр, агуулах, талбайд шалгалт хийнэ.		*“болох бөгөөд энэ нөхцөлд барааны тусгай тэмдгийг шалгана.” гэснийг “хийж болно.” гэж өөрчилсөн*
1269.	248.4.Гаалийн хяналтад байгаа бараа, тээврийн хэрэгслийг хадгалж байгаа байр, агуулах, талбайн эзэмшигч нь шалгалт хийлгэхээс татгалзсан тохиолдолд гаалийн байгууллага хөндлөнгийн гэрчийг байлцуулан тэдгээрт нэвтрэн орж шалгалт хийх бөгөөд энэ тухай прокурорын байгууллагад холбогдох хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ.	124.4.Гаалийн хяналтад байгаа бараа, тээврийн хэрэгслийг хадгалж байгаа байр, агуулах, талбайн эзэмшигч гаалийн шалгалт хийх албан тушаалтныг байр, агуулахад шалгалт хийлгэх үүрэгтэй бөгөөд татгалзсан тохиолдолд гаалийн байгууллага хөндлөнгийн гэрчийг байлцуулан тэдгээрт нэвтрэн орж шалгалт хийх бөгөөд энэ тухай прокурорын байгууллагад холбогдох хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ.		-

1270.	**125 дугаар зүйл.Тээврийн хэрэгслийг шалгах**			
1271.	125.1.Гаалийн байгууллага тээврийн хэрэгслийг зогсоох, гаалийн нутаг дэвсгэрээс хууль бусаар гарсан тээврийн хэрэгслийг албадан бүцаах эрхтэй. 125.2.Тээврийн хэрэгсэл өөр улсын нутаг дэвсгэрт орсон байвал хоёр улсын гаалийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд болон олон улсын гэрээгээр шийдвэрлэнэ. 125.3.Бараа, бичиг баримтыг шалгах зорилгоор тээврийн хэрэгслийг гаалийн хяналтын бус байхгүй газарт зогсоосон бол шалгалтыг аль болох богино хугацаанд хийж, шалгалт хийсэн тухай тэмдэглэл үйлдэнэ.			
1272.	**126 дугаар зүйл.Бараг гаалийн хяналтын доор хүргэх** 126.1.Гаалийн байгууллагаас олон улсын гэрээний, эсхүл бусад улсын гаалийн болон эрх бүхий байгууллагатай харилцан тохиролцсоны үндсэн дээр Монгол Улсын гаалийн хилээр нэвтрүүлэхэд тарифын бус хязгаарлалт тогтоосон барааны хууль бус эргэлтийг таслан зогсоох, оролцогч этгээдийг илрүүлэх зорилгоор уг бараг гаалийн хяналтын доор хүргэх арга хэрэглэж болно. 126.2.Бараг гаалийн хяналтын доор хүргэх арга хэрэглэх журмыг Засгийн газар тогтооно.			

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.legal.gov.mn

1273.	**127 дугаар зүйл.Бараа, тээврийн хэрэгслийг саатуулах** 127.1.Дараах тохиолдолд бараа, тээврийн хэрэгслийг хууль тогтоомжоор эрх олгогдсон гаалийн албан тушаалтан саатуулна: 127.1.1.гаалийн түр агуулахад хадгалах хугацаа дууссан; 127.1.2.гаалийн баталгаат агуулахад хадгалах хугацаа дууссан; 127.1.3.гаальд мэдүүлэх тогтоосон хугацаа хэтэрсэн; 127.1.4.гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслэд мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулах, шинжилгээ хийлгэх; 127.1.5.мэргэжлийн байгууллагаас мэдээлэл, лавлагаа авах, холбогдох байгууллага, албан тушаалтныг гаалийн шалгалтад оролцуулах; 127.1.6.зөрчлийг хянан шийдвэрлэх. 127.2.Бараа, тээврийн хэрэгслийг саатуулахдаа бараа, тээврийн хэрэгслийг саатуулах хуудсыг хоёр хувь бичиж, нэгдүгээр хувийг гаалийн байгууллагад, хоёрдугаар хувийг мэдүүлэгчид өгнө. 127.3.Энэ хуулийн 127.2-т заасан хуудсанд бараа, тээврийн хэрэгслийг саатуулах үндэслэл, саатуулах шийдвэр гаргасан албан тушаалтны овог, нэр зэрэг мэдээллийг тусгасан байна. 127.4.Саатуулсан бараа, тээврийн хэрэгслийг гаалийн түр агуулахад оруулах бөгөөд бараа, тээврийн хэрэгслийг гаалийн түр агуулахад хадгалах хугацаа нь саатуулсан бараанд хамаарахгүй. 127.5.Зарим нэрийн онцлог /хадгалалтын тусгай нөхцөл шаардах, амархан муудаж гэмтэх, аюултай бараа зэрэг/ бараа, тээврийн хэрэгслийг эриулалтын тоног төхөөрөмжөөр тоноглогдсон түр агуулахад хадгалах бөгөөд боломжгүй бол зэмшигчийн агуулах, байр, саванд хадгалуулж болно. Гаалийн байгууллага энэ тохиолдолд тухайн агуулах, байр, сав, бараа, тээврийн хэрэгслийг битүүмжилнэ.		

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.legal.mn

1274.	**128 дугаар зүйл.Саатуулсан барааг шийдвэрлэх** 128.1.Бараа, тээврийн хэрэгслийг саатуулсан гаалийн албан тушаалтан мэргэжлийн байгууллагын дүгнэлт, мэдээлэл, лавлагаа гаргуулах, холбогдох байгууллага, албан тушаалтныг гаалийн шалгалтад оролцуулах зэрэг ажиллагаа нэн даруй эхлүүлнэ. 128.2.Бараа, тээврийн хэрэгслийг саатуулсан гаалийн албан тушаалтан саатуулсан үндэслэл, шийдвэрээ гаалийн байгууллагын удирдах албан тушаалтанд ажлын өдөрт багтаан мэдэгдэнэ. 128.3.Гаалийн албан тушаалтан саатуулсан бараа, тээврийн хэрэгслийн талаар мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, мэдээллийн талаар удирдах албан тушаалтан болон мэдүүлэгчид танилцуулна. Гаалийн удирдах албан тушаалтан нь шалгалтын материалтай танилцаж, хэрэн шийдвэрлэх талаар чиглэл өгнө. 128.4.Гаалийн албан тушаалтан бараа, тээврийн хэрэгсэл саатуулан шалгах явцад захиргааны эрчил илэрвэл холбогдох хуулийн дагуу шийдвэрлэж, харин гэмт хэргийн шинжтэй зөрчил илэрсэн тохиолдолд гэмдэлтэй үйлдэж эрх бүхий байгууллагад шилжүүлнэ. 128.5.Саатуулсан бараа, тээврийн хэрэгслийн талаар дүгнэлт, лавлагаа гаргуулах ажиллагааг 30 хоногоос дөшгүй хугацаанд багтаан гүйцэтгэж, холбогдох шийдвэр гаргуулах ба энэ хугацаанд гаалийн байгууллагын дараа шаардлагатай гэж үзвэл 60 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно. 128.6.Энэ хуулийн 127.1.1-127.1.3-т заасан барааг саатуулах хугацаа 10 хүртэл хоног байна. 128.7.Барааг гаалийн түр агуулах, гаалийн баталгаат агуулахад хадгалах хугацаа дууссан, гаальд мэдүүлэх тогтоосон хугацаа хэтэрсэн барааг саатуулах шийдвэр гаргасан тухай бараа зээмшигчид мэдэгдэнэ. Мэдэгдэлд барааг саатуулсны улмаас энэ хуулийн 128.8, 129.1, 129.2-т заасан үр дагавар үүсэхийг дурьдана. 128.8.Гаалийн түр агуулах, гаалийн баталгаат агуулахад хадгалах хугацаа дууссан барааг саатуулахад энэ хуулийн 128.6-д заасан хугацаа 10 хоногоос хэтрэхгүйгээр тогтоох бөгөөд уг хугацааг сунгахгүй. 128.9.Барааг гаалийн түр агуулах, гаалийн баталгаат агуулахад хадгалах хугацаа дууссан барааг саатуулах шийдвэр гаргасан тухай бараа зээмшигчид мэдэгдэнэ. 128.10.Бараа, тээврийн хэрэгслийг саатуулснаас хойш энэ хуулийн 128.6, 128.8-д заасан хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажиллагаа явуулаагүй, хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэхдээ бараа, тээврийн хэрэгслээд хохирол учруулах аливаа үйлдэл, эс үйлдэхүй гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. 128.11.Бараа, тээврийн хэрэгслийг саатуулсантай холбогдон гарах зардал, хохирлыг мэдүүлэгч хариуцна.			

ХУУЛЬ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН
www.legalinfo.mn

1275.		**129 дүгээр зүйл.Саатуулах хугацаа дууссан барааг шийдвэрлэх** 129.1.Энэ хуулийн 128.5, 128.8-д заасан хугацаа дуусахад мэдүүлэгч барааны гаалийн бүрдүүлэлт хий лгээгүй бол гаалийн байгууллага уг барааг борлуулна. 129.2.Барааг хадгалах, тээвэрлэх, борлуулахтай холбоотой ажиллагаанд гарах зардал нь тухайн барааны өртгөөс илүү гарч байвал барааг саатуулсан гаалийн байгууллага түүнийг устгах, эсхүл хууль тогтоомжийн хүрээнд ашиглах шийдвэр гаргана. 129.3.Устгахад гарах зардлыг мэдүүлэгч хариуцна. Хэрэв мэдүүлэгч байхгүй бол тус зардлыг улсын төсвөөс гаргана.		
1276.		**130 дугаар зүйл.Борлуулсан барааны орлогыг зарцуулах** 130.1.Энэ хуулийн 129.1-д зааснаар борлуулж орсон орлогоос эхний ээлжинд саатуулсан барааны ногдох гаалийн болон бусад татвар хураамжийг, дараа нь тээвэрлэх, хадгалах, борлуулахад гарсан зардлыг тус тус суутгана. 130.2.Барааг борлуулснаас хойш гурван сарын дотор эзэмшигч нь хүсэлт гаргасан тохиолдолд, энэ хуулийн 130.1-д заасан зарлуудыг суутгаж, зөрүүг эргүүлэн олгож болно.		
1277.		**ГУРАВДУГААР ДЭД БҮЛЭГ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА**		*Шинээр нэмэгдсэн*
1278.		140.1.Энэ бүлэгт хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:		*Шинээр нэмэгдсэн*
1279.		140.1.1.“эрсдэл” гэж гаалийн хууль тогтоомж зөрчих магадлал, гаалийн хяналтын объектын хувьд үүссэн эргэлзээний үр дүн; 140.1.2.“эрсдэлийн удирдлага” гэж гаалийн байгууллагаас эрсдэлийг удирдах ба хянахад чиглэсэн үйл ажиллагааг; 140.1.3.“эрсдэлийн удирдлагын систем” гэж гаалийн байгууллагаас гаалийн хяналтын объект, түүнд хийх гаалийн шалгалтын хэлбэр, түвшинг тодорхойлох зорилгоор хэрэгжүүлж байгаа цахим болон бусад үйл ажиллагааг; 140.1.4.“эрсдэлийн үнэлгээ”гэж эрсдэлийг илрүүлэх, дүн шинжилгээ хийх, үнэлэх болон эрэмбэлэх үйл ажиллагааг; 140.1.5.“эрсдэлт бүлэг” гэж гаалийн шалгалтын хэлбэрийг сонгоход чиглэгдсэн эрсдэлийн тусгайлан бүлэглэсэн объект, субъектыг.		*Шинээр нэмэгдсэн*

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.legalinfo.mn

1280.		**141дүгээр зүйл.Эрсдэлийн удирдлагын зорилго** 141.1.Эрсдэлийн удирдлагыг дараах зорилгоор хэрэгжүүлнэ: 141.1.1.хууль ёсны гадаад худалдааг хөнгөвчлөх, гаалийн хяналт, бүрдүүлэлтэд зарцуулах цаг хугацаа багасгах, өртөг зардлыг бууруулах; 141.1.2.хууль сахилтын түвшин өндөр гаалийн харилцаанд оролцогчийн бараа, тээврийн хэрэгслийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд таатай нөхцөл бүрдүүлэх; 141.1.3.өндөр эрсдэлт бүлэгт хязгаарлагдмал нөөцийг үр дүнтэй хуваарилах; 141.1.4.гаалийн хууль тогтоомж зөрчих магадлалыг урьдчилан тооцоолох, илрүүлэх, таслан зогсоох.		
1281.		**142 дугаар зүйл.Эрсдэлийн дүн шинжилгээний объект** 142.1.Эрсдэлийн дүн шинжилгээг дараах объектод хийнэ: 142.1.1.гаалийн хяналтад байгаа бараа, дотоодын хэрэглээнд зориулан оруулах горимд байршуулсан бараа; 142.1.2.улс хооронд тээвэрлэлт хийж байгаа тээврийн хэрэгсэл; 142.1.3.худалдааны, тээврийн, гаалийн болон бусад бичиг баримт, түүнд агуулагдаж байгаа мэдээлэл; 142.1.4.гаалийн харилцаанд оролцогч, түүний үйл ажиллагаа; 142.1.5.гаалийн шалгалтын хэлбэрийг хэрэгжүүлсний үр дүн.		*Шинээр нэмэгдсэн*

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.ulig.gov.mn

1282.		**143 дугаар зүйл.Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх** 143.1.Эрсдэлийг удирдах чиглэлээр гаалийн байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ: 143.1.1.эрсдэлийн удирдлагын системийн мэдээллийн санг бүрдүүлэх; 143.1.2.энэ хуулийн 142.1.3-т заасан мэдээлэл, хууль хяналтын байгууллагад шалгагдаж байгаа болон шийдвэрлэгдсэн зөрчлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх; 143.1.3.эрсдэлт бүлгийг тодорхойлж, эрсдэлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулах; 143.1.4.эрсдэлийн дүн шинжилгээ, эрх бүхий байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн шалгуур үзүүлэлтийг өөрчлөх, баталгаажуулах; 143.1.5.гаалийн харилцаанд оролцогчдыг хууль сахилтын түвшингээр ангилах, ангилал тус бүрт зохих арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах; 143.1.6.гаалийн шалгалтын түвшинг тодорхойлох. 143.2.Энэ хуулийн 143.1.3-т заасан шалгуур үзүүлэлтийг бусад байгууллага, албан тушаалтан, нийтэд мэдээлэхийг хориглоно. 143.3.Мэдээлэл цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, эрсдэлийг үнэлэх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон журам, зааврыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.		*Шинээр нэмэгдсэн*
1283.		**НАЙМДУГААР ДЭД БҮЛЭГ** **ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТИЙН ДАРААХ ШАЛГАЛТ**		*Шинээр нэмэгдсэн*
1284.		**НАЙМДУГААР ДЭД БҮЛЭГ** **ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТИЙН ДАРААХ ШАЛГАЛТ**		
1285.	**249 дүгээр зүйл.Гаалийн бүрдүүлэлтийн дараахь шалгалт**	**167 дугаар зүйл.Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалт**		
1286.	249.1.Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлт хийж, гаалийн хяналтаас гаргах зөвшөөрөл олгосны дараа гаалийн мэдүүлэг болон гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтад өгөгдсөн мэдээллийн үнэн зөвийг нягтлан шалгах, мэдүүлэгчийн экспорт, импортын үйл ажиллагаанд гаалийн зорилгоор гаалийн байгууллага бүрдүүлэлтийн дараахь шалгалтыг явуулна.	167.1.Бүрдүүлэлтийн дараах шалгалтын зорилго нь гадаад худалдааг хөнгөвчлөх, хууль ёсны худалдааг дэмжих, бизнесийн цаг хугацааг хэмнэх, эрсдэлийн үнэлгээг үндэслэн иргэн, хуулийн этгээдийн хууль сахилтын түвшинд дүгнэлт өгөхөд чиглэнэ.		

1287.	**142 дугаар зүйл.Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх** 142.1.Гадаад худалдаа эрхлэгчийн гаалийн хилээр нэвтрүүлсэн барааны гаалийн мэдүүлгийн үнэн зөвийг нягтлах зорилгоор бүрдүүлэлтийн дараах шалгалтыг хийж болно. 142.2.Бүрдүүлэлтийн дараах шалгалт нь аудит, бүрдүүлэлтийн дараах шуурхай шалгалт гэсэн хэлбэртэй байна.			*Өөрчлөн найруулсан*
1288.	**143 дугаар зүйл.Аудит** 143.3.Аудит нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус гэсэн төрөлтэй, иж бүрэн, хэсэгчилсэн гэсэн хэлбэртэй байна. 143.4.Иж бүрэн аудит гэж тодорхой нэг хуулийн этгээдийн гадаад худалдааны бүхийл үйл ажиллагааг хамруулахыг ойлгоно. 143.5.Хэсэгчилсэн аудит гэж хуулийн этгээдийн гадаад худалдааны тодорхой нэг хэсгийг, эсхүл тодорхой хугацаанд барааны нэр төрлөөр хэсэгчлэн хамруулахыг ойлгоно. 143.4.Аудитыг гаалийн удирдах төв байгуулагын дэргэдэх аудитын асуудал хариуцсан нэгжийн гаалийн улсын байцаагч гаалийн удирдах төв байгуулагын даргын батлсан удирдамжийн дагуу хийнэ. 143.5.Аудит хийх журам, зааврыг гаалийн удирдах төв байгуулагын дарга батална.			*Шинээр нэмэгдсэн*

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.legalinfo.gov.mn

1289.	249.2.Гаалийн байгууллага, албан тушаалтан бүрдүүлэлтийн дараахь шалгалтыг хийхдээ дор дурдсан эрх эдэлнэ: 249.2.1.мэдүүлэгчээс гааль, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн болон бусад шаардлагатай бичиг баримтыг гаргуулан авах, мэдээллийн санд нь нэвтрэх; 249.2.2.шалгалттай холбоотой бичиг баримтыг нягтлан шалгах, хуулбарлан авах, баталгаажуулах, холбогдох тайлбар, тодруулга, лавлагаа гаргуулан авах; 249.2.3.бараа хүлээн авагч, зээмшигч, өмчлөгч, тэдгээрээс хариуцан хамааралтай этгээдийн бүрдүүлэлтийн дүнд хяналт тавих, шалгалт хийх, шаардлагатай гэж үзвэл битүүмжлэх; 249.2.4.бараа, тээврийн хэрэгслийг мэдүүлэгч, хүлээн авагч, зээмшигч, өмчлөгч, тэдгээртэй хариуцан хамаарал бүхий этгээд нь байр, агуулах, талбайдаа орууллахгүй байх, бусад хэлбэрээр шалгалт хийлгэхээс татгалзах тохиолдолд хөндлөнгийн 2-оос доошгүй гэрч байцаулан тэдгээрт нэвтрэн орж шалгалт хийх; 249.2.5.хуульд заасан бусад эрх. 249.3.Бүрдүүлэлтийн дараахь шалгалт хийсэн гаалийн албан тушаалтан нь бариматаар нотлогдсон зөрчилд дүнэлт гаргаж төлбөрийн акт тогтоох бөгөөд энэ тохиолдолд гаалийн мэдүүлийг нөхөн бичүүлж, гаалийн бүрдүүлэлт хийлгэж болно. 249.4.Гаалийн бүрдүүлэлтийн дараахь шалгалт хийх журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.	**144 дүгээр зүйл.Аудит хийх гаалийн улсын байцаагчийн эрх** 144.1.Гаалийн улсын байцаагч аудитыг хийхдээ энэ хуулийн 19.1-д зааснаас гадна дор дурьдсан эрхийг эдэлнэ: 144.1.1.аудитад хамрагдах болон тэдгээртэй хамаарал бүхий этгээдийн /цаашид “шалгуулагч” гэх/ зээмшлийн агуулах, байр, талбай, болон бусад объектод нэвтрэх, битүүмжлэх, тэдгээрт хадгалагдаж байгаа бараа төлөөлөгчийг байццулан бүрэн буюу хэсэгчилсэн байдлаар шалгах тоолох, бүртгэл, тэмдэглэл үйлдэж баталгаажуулах; 144.1.2.аудитад шаардагдах гааль, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн болон бусад бичиг баримтыг гаргуулан авах, хуулбарлан авах, баталгаажуулах, тэдгээртэй холбоотой тайлбар, тодруулга гаргуулан авах; 144.1.3.шалгуулагчийн мэдэллийн санд нэвтрэх, барааны зэрэг, дээжид шинжилгээ хийлгэх, холбогдох байгууллагаар дүнэлт гаргуулах; 144.1.4.аудитад шаардагдах бичиг баримтын хуулбар, банкны гүйлгээний хуулга, гадаад төлбөрийн тапаарх мэдээллийг шалгуулагчтай харилцаач хуулийн этгээд, хувь хүн, санхүүгийн байгууллагаас үнэ төлбөргүй гаргуулан авах; 144.1.5.шалгуулагч ажуулах, байр, талбай, болон бусад объектод оруулахгүй байх, бусад хэлбэрээр шалгалт хийхэд саад учруулах тохиолдолд хөндлөнгийн 2-оос доошгүй гэрч байцуулан тэдгээрт нэвтрэн орж шалгалт, тооллого хийх, битүүмжлэх; 144.1.6.аудит хийсэн гаалийн улсын байцаагч нь баримтаар нотлогдсон зөрчилд дүнэлт гаргаж, төлбөрийн акт тогтоох.		*Өөрчлөн найруулсан*

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨСӨЛ

1290.	**145 дугаар зүйл.Шалгуулагчийн эрх, үүрэг** 145.1.Шалгуулагч этгэд нь дараах эрх эдэлнэ: 145.1.1.аудиттай холбоотой үйлдэгдсэн акт, дүнэлттэй танилцах, тайлбар авах буюу өгөх; 145.1.2.хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд аудит хойшлуулах тухай хүсэлтийг гаалийн удирдах төв байгууллагын ерөнхий байцаагчид бичгээр гаргаж, шийдвэрлүүлэх; 145.2.аудитад хамрагдах болон тэдгээртэй хамаарал бүхий этгэд нь Гаалийн тухай хуулийн 85.2-т зааснаас гадна дараах үүрэг хүлээнэ: 145.2.1.аудит хийх гаалийн улсыг байцаагчаас шаардсан бичиг баримт, мэдээ, тайланг тогтоосон хугацаанд бэлэн болгох, шаардлагатай тохиолдолд шалгалт хийдэг газарт хүргэх, шалгуулах; 145.2.2.аудитын бүрэлдэхүүнээс тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;		*Шинээр нэмэгдсэн*
1291.	**146 дугаар зүйл.Төлбөрийн акт тогтоох** 146.1.Гаалийн улсын байцаагчийн акт нь аудит хийсэн гаалийн улсын байцаагч гарын үсэг зурж, хувийн дугаар бүхий тэмдэг дараад шалгуулагчид танилцуулан гарын үсэг зурулж, тамга даруулсанаар хүчин төгөлдөр болно. 146.2.Шалгуулагч актыг үл зөвшөөрөх, гарын үсэг зурах, тамга тэмдэг дарахаас татгалзсан нь актыг биелүүлэхээс татгалзах үндэслэл болохгүй.		*Шинээр нэмэгдсэн*
1292.	**147 дугаар зүйл.Хөөн хэлэлцэх хугацаа** 147.1.Аудитаар илэрсэн зөрчилд татвар нөхөн ногдуулах, алданги, торгууль ногдуулах хөөн хэлэлцэх хугацаа Татварын ерөнхий хуульд зааснаар зохицуулна. 147.2.Энэ хуулийн 147.1-д заасан хөөн хэлэлцэх хугацаа барааг улсын хилээр нэвтрүүлсэн өдрийн дараагийн жилын өдрөөс тус эхлэн тоолно. 147.3.Татвар, алданги, торгуулийн ерийг төлөхөд хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй.		*Шинээр нэмэгдсэн*
1293.	**148 дугаар зүйл.Төлбөр төлөх хугацаа** 148.1.Актаар тогтоосон төлбөрийг акт хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш хуанлийн 15 хоногт багтаан төлнө. 148.2.Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас төлбөрийг хугацаанд нь төлөх боломжгүй бол шалгуулагчийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн гаалийн улсын ерөнхий байцаагчийн шийдвэрээр 60 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.		*Шинээр нэмэгдсэн*

ХУУЛЬ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН

1294.\		**149 дүгээр зүйл.Гаалийн бүрдүүлэлтийг нөхөн хийх** 149.1.Гаалийн мэдүүлгийг дараах тохиолдолд нөхөн бичиж болно: 149.1.1.Гадаад худалдаанд оролцогч этгээд гаалийн бүрдүүлэлт хийлгэх тухай хүсэлтийг гаалийн байгууллагад аудит хийхээс өмнө сайн дураар гаргасан; 149.1.2.Гаалийн бүрдүүлэлтийн горимын шаардлага хангуулах зорилгоор гаалийн байгууллагаас шаардсан		*Шинээр нэмэгдсэн*
1295.		**150 дугаар зүйл.Бүрдүүлэлтийн дараах шуурхай шалгалт** 150.1.Гаалийн бүрдүүлэлт дуусч гаалийн хяналтаас гарсан бараа тээврийн хэрэгслийг гаалийн мэдүүлэгтэй тохирч байгаа эсэхийг бүрдүүлэлтийн дараах шуурхай шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагч нягтлан шалгаж болно. 150.2.Шалгалт нь гаалийн хяналтын бүсийн гадна МУ-ын нутаг дэвсгэрт хийгдэнэ. 150.3.Шалгалт нь дараах эх сурвалжтай байна: 150.3.1.иргэд, хуулийн этгээдийн хууль бус үйлдлийн талаарх мэдээлэл; 150.3.2хамтын ажиллагааны хүрээнд гаалийн холбооны гишүүн орны хүсэлтийн дагуу 150.3.3.хууль, хяналтын байгууллагын мэдээллийн эх сурвалж/ цагдаа, татнуул, банк, татвар/ 150.3.4.мэдээллийн хэрэгсэл болон бусад найдвартай эх сурвалжийн мэдээлэл 150.3.5гаалийн бүрдүүлэлт хийгдсэн мэдүүлгийн санд боловсруулалт хийж онилсон, 150.3.6.гаалийн мэдүүлэгт заагдсан бараа, тээврийн хэрэгсэл гадна байдлаасаа зөрчилтэй байх тохиолдолд. 150.4.Шалгалт хийсэн гаалийн улсын байцаагч нь баримтаар нотлогдсон зөрчилд дүгнэлт гаргаж, хойшлуулшгүй ажиллагаа явуулах ба гэмт хэргийн шинжтэй бол хууль хяналтын байгууллагад зохих журмын дагуу шилжүүлнэ.		*Шинээр нэмэгдсэн*

ХУДАЛДААНЫ ЯАМНЫ ЦАХИМ ХУУДАСНЫ ХУРЭЭЛЭН
www.mof.gov.mn

1296.	**151 дүгээр зүйл.Бүрдүүлэлтийн дараах шүүрхай шалгалт хийх гаалийн улсын байцаагчийн эрх, үүрэг** 151.1.Гаалийн бүрдүүлэлтийн дараах шүүрхай шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагч нь энэ хуулийн 19.1-д заасан эрхээс гадна дор дурдсан эрх эдэлнэ: 151.1.1.гаалийн бүрдүүлэлт хийгдсэн бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлтийн дараах шүүрхай шалгалт хийх 151.1.2.шалгалтаар эрчил илэрсэн тохиолдолд Гэмт хэргийн тухай болон Эрчлийн тухай хуулийн дагуу хойшлуулшгүй ажиллагаа явуулах: 151.1.3.-Эрчилд хамаарал бүхий этгээдээс мэдээлэл авах, холбогдох бичиг баримтыг гаргуулж шалгах, тайлбар авах, лавлагаа гаргуулах, 151.1.4.Эрчил холбогдох нотлох баримтыг бэхжүүлэх, -эрчилд холбогдогчийн байр, агуулах, бусад хамаарал бүхий объектод нэвтрэх, битүүмжлэх; 151.1.5.эрчилд холбогдох бараа, тээврийн хэрэгслийг саатуулах, бичиг баримтыг түр хураан авах, 151.1.6.гаалийн үзлэг хийх 151.1.7.эрчлийн шалтгаан нөхцлийг тогтоох; 151.1.8.шаардлагатай тохиолдолд эрчилд холбогдох барааны дээж, загвар авч холбогдох байгууллагаар дүгнэлт гаргуулах; 151.1.9хуульд заасан бусад эрх. 151.2.Гаалийн бүрдүүлэлтийн дараах шүүрхай шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагч нь энэ хуулийн 18.1-д заасан үүргээс гадна дор дурдсан үүрэг хүлээнэ: 151.2.1.шалгаптын ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулах 151.2.2.нотлох баримтыг фото болон видео халбэрээр бэхжүүлэх, 151.2.3.шалгаптын талаар тэмдэглэл үйлдэж, үр дүнг бичгээр удирдлагадаа танилцуулах 151.2.4.шалгапттай холбоотой мэдээллийг нууцлах, бусдад задлахгүй байх; 151.2.5.эрчлийн мэдээллийг мэдээллийн санд оруулах;			*Шинээр нэмэгдсэн*

ХУУЛЬ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН
www.legal.mn

1297.\	**250 дугаар зүйл.Барааг гаалийн хяналтын дор хүргэх** 250.1.Гаалийн байгууллагаас олон улсын гэрээний, эсхүл бусад улсын гаалийн болон эрх бүхий байгууллагатай харилцан тохиролцсоны үндсэн дээр Монгол Улсын гаалийн хилээр нэвтрүүлэхэд тарифын бус хязгаарлалт тогтоосон барааны хууль бус эргэлтийг таслан зогсоох, оролцогч этгээдийг илрүүлэх зорилгоор уг барааг гаалийн хяналтын дор хүргэх аргыг хэрэглэж болно. 250.2.Барааг гаалийн хяналтын дор хүргэх арга хэрэглэх журмыг Засгийн газар тогтооно.	**115 дугаар зүйл.Барааг гаалийн хяналтын дор хүргэх** 115.1.Гаалийн байгууллагаас олон улсын гэрээний, эсхүл бусад улсын гаалийн болон эрх бүхий байгууллагатай харилцан тохиролцсоны үндсэн дээр Монгол Улсын гаалийн хилээр нэвтрүүлэхэд тарифын бус хязгаарлалт тогтоосон барааны хууль бус эргэлтийг таслан зогсоох, оролцогч этгээдийг илрүүлэх зорилгоор уг барааг гаалийн хяналтын дор хүргэх аргыг хэрэглэж болно. 115.2.Барааг гаалийн хяналтын дор хүргэх арга хэрэглэх журмыг Засгийн газар тогтооно.		-
1298.	**251 дүгээр зүйл.Бараа, тээврийн хэрэгслийг саатуулах** 251.1.Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулах, шинжилгээ хийлгэх, мэргэжлийн байгууллагаас мэдээлэл, лавлагаа авах, холбогдох байгууллага, албан тушаалтныг гаалийн шалгалтад оролцуулах зорилгоор бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллага, албан тушаалтны шийдвэрээр саатуулж болно. 251.2.Энэ хуулийн 251.1-д заасан шийдвэрт бараа, тээврийн хэрэгслийг саатуулах үндэслэл, хугацаа, саатуулах шийдвэр гаргасан албан тушаалтны овог, нэр зэрэг мэдээллийг тусгасан байх бөгөөд шийдвэрийн хувийг мэдүүлэгчид гардуулна. 251.3.Бараа, тээврийн хэрэгслийг саатуулах журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.	**116 дугаар зүйл.Бараа, тээврийн хэрэгслийг саатуулах** 116.1.Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулах, шинжилгээ хийлгэх, мэргэжлийн байгууллагаас мэдээлэл, лавлагаа авах, холбогдох байгууллага, албан тушаалтныг гаалийн шалгалтад оролцуулах, нягтлан шалгах зорилгоор бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллага, албан тушаалтны шийдвэрээр саатуулж болно. 116.2.Энэ хуулийн 116.1-д заасан шийдвэрт бараа, тээврийн хэрэгслийг саатуулах үндэслэл, хугацаа, саатуулах шийдвэр гаргасан албан тушаалтны овог, нэр зэрэг мэдээллийг тусгасан байх бөгөөд шийдвэрийн хувийг мэдүүлэгчид гардуулна. 116.3.Бараа, тээврийн хэрэгслийг саатуулах журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.		-
1299.	**Нэгдүгээр дэд бүлэг** **Гаалийн хяналтыг хэрэгжүүлэх үед хийх магадлан шинжилгээ, шинжилгээ**	**ХОЁРДУГААР ДЭД БҮЛЭГ** **ГААЛИЙН ШАЛГАЛТЫН ҮЕД ХИЙХ МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭ**		*“хяналтыг хэрэгжүүлэх” гэснийг “ШАЛГАЛТЫН” гэж өөрчилсөн “магадлан шинжилгээ,” гэснийг хассан*
1300.		**131 дүгээр зүйл.Энэ бүлэгт хэрэглэсэн нэр томьёоны тайлбар** 131.1.Энэ бүлэгт хэрэглэсэн нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно: 131.1.1.“шинжээчийн дүгнэлт” гэж магадлан шинжилгээний үндсэн дээр нарийн мэргэжлийн үнэлэлт, дүгнэлтийг хууль зүйн хүрээнд гаргасан баримтыг; 131.1.2.”магадлан шинжилгээ” гэж бараа судлал, барааны ангиллын код тодорхойлох, материал судлал, хөдөлмөр аюулгүй байдал, мэдээллийн болон бусад технологийн, криминалистикийн ба бусад шинжилгээг.		

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

1301.	**132 дугаар зүйл.Шинжээч томилох** 132.1.Гаалийн бүрдүүлэгчийн явцад тусгай мэдлэг, нарийн мэргэшил шаардагдах тохиолдолд магадлан шинжилгээ хийнэ. 132.2.Гаалийн байгууллага магадлан шинжилгээнд шинжээчийг томилох бөгөөд гаалийн шинжээч хийх боломжгүй тохиолдолд хууль тогтоомжийн дагуу бусад эрх бүхий байгууллагын шинжээчийг томилно. 132.3.Магадлан шинжилгээ хийлгэх тухай шийдвэрт магадлан шинжилгээ хийх үндэслэл, зорилго, хугацаа болон шинжээчийн овог, нэр, эсхүл байгууллагын нэр, шинжээчийн өмнө тавигдах асуулт, шинжээчид шилжүүлсэн материал, бичиг баримтын жагсаалт, дүгнэлт буруу дүгнэлт гаргасан тохиолдолд шинжээчид хүлээлгэх хариуцлагын талаарх анхааруулга зэргийг тусгана. 132.4.Дараах тохиолдолд шинжилгээ хийхээс татгалзаж болно: 132.4.1.магадлан шинжилгээ хийх мэдэлгэл нь шаардлага хангахгүй; 132.4.2.магадлан шинжилгээ хийлгэх тухай шийдвэрийг хуульд заасан журмаар гаргаагүй; 132.4.3.сорьц, дээж, загварын баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдсан; 132.4.4.магадлан шинжилгээг хийх тусгай нөхцөл, шаардлагатай урвалж бодис, тоног төхөөрөмж, бүгаж хэрэгсэл байхгүй; 132.4.5.хуульд заасан бусад тохиолдол. 132.5.Магадлан шинжилгээ хийхээс татгалзсан тухай бичгээр мэдэгдэж, шинжилгээ хийлгэх материал, бичиг баримт, сорьц, дээж, загварыг гаалийн байгууллагад буцаана. 132.6.Гаалийн лабораторид хийгдэх шинжилгээний төлбөр, хураамжийг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална. 132.7.Магадлан шинжилгээ хийх, сорьц, дээж, загвар авах, шинжээч томилох, дүгнэлт гаргах журам, шинжээчид тавигдах ажлын байрны шаардлагыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална. 132.8.Магадлан шинжилгээ хийлгэх, шинжээч томилох тухай гаалийн байгууллагын шийдвэрийг өмчийн аль ч хэлбэрийн байгууллага хүлээн авч хэрэгжүүлнэ. 132.9.Магадлан шинжилгээг мэргэжлийн, төрийн, хувийн өмчийн болон төрийн бус байгууллага, эсхүл бие даасан шинжээчээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болох бөгөөд энэ тохиолдолд магадлан шинжилгээний төлбөрийг мэдүүлэгч хариуцна.			

ХУУЛЬ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН
www.legal.mn

1302.	**132 дугаар зүйл.Шинжээч томилох** 132.1.Гаалийн бүрдүүлэлтийн явцад тусгай мэдлэг, нарийн мэргэшил шаардагдах тохиолдолд магадлан шинжилгээ хийнэ. 132.2.Гаалийн байгууллага магадлан шинжилгээнд шинжээчийг томилох бөгөөд гаалийн шинжээч хийх боломжгүй тохиолдолд хуульт тоттоомжийн дагуу бусад эрх бүхий байгууллагын шинжээчийг томилно. 132.3.Магадлан шинжилгээ хийлгэх тухай шийдвэрт магадлан шинжилгээ хийх үндэслэл, зорилго, хугацаа болон шинжээчийн овог, нэр, эсхүл байгууллагын нэр, шинжээчийн өмнө тавигдах асуулт, шинжээчид шилжүүлсэн материал, бичиг баримтын жагсаалт, дүгнэлт буруу дүгнэлт гаргасан тохиолдолд шинжээчид хүлээлгэх хариуцлагын талаарх анхааруулга зэргийг тусгана. 132.4.Дараах тохиолдолд шинжилгээ хийхээс татгалзаж болно: 132.4.1.магадлан шинжилгээ хийх мэдээлэл нь шаардлага хангахгүй; 132.4.2.магадлан шинжилгээ хийлгэх тухай шийдвэрийг хуульд заасан журмаар гаргаагүй; 132.4.3.сорьц, дээж, загварын багтаа бодлын бүрэн бүтэн байдал алдагдсан; 132.4.4.магадлан шинжилгээг хийх түгээмэл, шаардлагатай урвалж бодис, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл байхгүй; 132.4.5.хуульд заасан бусад тохиолдол. 132.5.Магадлан шинжилгээ хийхээс татгалзсан тухай бичгээр мэдэгдэж, шинжилгээ хийлгэх материал, бичиг баримт, сорьц, дээж, загварыг гаалийн байгууллагад буцаана. 132.6.Гаалийн лабораторид хийдэх шинжилгээний төлбөр, хураамжийг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална. 132.7.Магадлан шинжилгээ хийх, сорьц, дээж, загвар авах, шинжээч томилох, дүгнэлт гаргах журам, шинжээчид тавигдах ажлын байрны шаардлагыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална. 132.8.Магадлан шинжилгээ хийлгэх, шинжээч томилох тухай гаалийн байгууллагын шийдвэрийг өмчийн аль ч хэлбэрийн байгууллага хүлээн авч хэрэгжүүлнэ. 132.9.Магадлан шинжилгээг мэргэжлийн, төрийн, хувийн өмчийн болон төрийн бус байгууллага, эсхүл бие даасан шинжээчээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болох бөгөөд энэ тохиолдолд магадлан шинжилгээний төлбөрийг мэдүүлэгч хариуцна			

ХУУЛЬ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН www.legal.mn

1303.		**133 дугаар зүйл.Шинжилгээ хийх хугацаа.** 133.1.Шинжилгээг дараах хугацаанд хийнэ: 133.1.1.барааг мэдүүлэгчийн сонгосон горимд байршуулах хугацаанд; 133.1.2.тээврийн хэрэгсэлд шинжилгээ хийх тохиолдолд нэг сар хүртэлх хугацаанд; 133.1.3.энэ хуулийн 128.5-д заасан журамд заасан хугацаанд; 133.1.4.бусад тохиолдолд гурван сар хүртэлх хугацаанд. 133.2 Дараах тохиолдолд шинжилгээ хийх хугацааг түр зогсооно: 133.2.1 Шинжээч нь нэмэлт материал, сорьц, дээж, загварыг гаргаж өгөх тухай гаалийн байгууллагад хүсэлт гаргасан бол, 133.2.2.хуульд заасан бусад тохиолдолд		
1304.	**252 дугаар зүйл.Гаалийн хяналт хийхэд шинжээч томилох** 252.1.Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл болон тэдгээртэй холбоотой бичиг баримтад гаалийн хяналт хийх явцад мэргэжлийн тусгай мэдлэг зайлшгүй шаардагдах, гаалийн зорилгоор барааны ангиллын кодыг тодорхойлох тохиолдолд магадлан шинжилгээ хийнэ.	**117 дугаар зүйл.Шинжилгээ хийх тохиолдол** 117.1.Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл болон тэдгээртэй холбоотой бичиг баримтад гаалийн шалгалт хийх явцад мэргэжлийн тусгай мэдлэг зайлшгүй шаардагдах, гаалийн зорилгоор барааны ангиллын кодыг тодорхойлох тохиолдолд шинжилгээ хийнэ.		*“хяналт” гэснийг “шалгалт” гэж өөрчилсөн*
1305.				
1306.	252.2.Магадлан шинжилгээг гаалийн лаборатори, гаалийн байгууллагаас томилсон байгууллага, эсхүл шинжээч хийнэ.	117.2.Шинжилгээг гаалийн лаборатори, гаалийн байгууллагаас сонгосон нарийн мэргэжлийн шинжилгээний байгууллага, эсхүл шинжээч хийнэ.		*“Магадлан шинжилгээг” гэснийг “Шинжилгээг” гэж, “томилсон” гэснийг “сонгосон нарийн мэргэжлийн шинжилгээний” гэж тус тус өөрчилсөн*
1307.	252.3.Магадлан шинжилгээ хийх, шинжээч томилох тухай гаалийн байгууллагын шийдвэрийг өмчийн аль ч хэлбэрийн байгууллага хүлээн авч хэрэгжүүлнэ.	117.3.Шинжилгээ хийх тухай гаалийн байгууллагын шийдвэрийг өмчийн аль ч хэлбэрийн байгууллага хэрэгжүүлнэ.		*“Магадлан шинжилгээ хийх, шинжээч томилох” гэснийг “Шинжилгээ хийх” гэж өөрчилсөн*
1308.	252.4.Магадлан шинжилгээг мэргэжлийн хувийн өмчийн болон төрийн бус байгууллага, эсхүл бие даасан шинжээчээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болох бөгөөд энэ тохиолдолд магадлан шинжилгээний төлбөрийг мэдүүлэгч хариуцна.	117.4.Шинжилгээг мэргэжлийн хувийн өмчийн болон төрийн бус байгууллага, эсхүл бие даасан шинжээчээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болох бөгөөд энэ тохиолдолд шинжилгээний төлбөрийг мэдүүлэгч хариуцна.		*“Магадлан” гэснийг хассан*

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.mn.gov.mn

1309.	252.5.Магадлан шинжилгээ хийлгэх тухай гаалийн байгууллагын даргын тогтоолд магадлан шинжилгээ хийх үндэслэл, зорилго, хугацаа болон шинжээчийн овог, нэр, эсхүл байгууллагын нэр, шинжээчийн өмнө тавигдах асуулт, шинжээчид шилжүүлсэн материал, бичиг баримтын жагсаалт, дүгнэлт, буруу дүгнэлт гаргасан тохиолдолд шинжээчид хүлээлгэх хариуцлагын талаарх анхааруулга зэргийг тусгана.	117.5.Шинжилгээ хийлгэх тухай гаалийн байгууллагын удирдах албан тушаалтны шийдвэрт шинжилгээ хийх үндэслэл, зорилго, хугацаа болон шинжээчийн овог, нэр, эсхүл байгууллагын нэр, шинжээчийн өмнө тавигдах асуулт, шинжээчид шилжүүлсэн материал, бичиг баримтын жагсаалт, дүгнэлт, буруу дүгнэлт гаргасан тохиолдолд шинжээчид хүлээлгэх хариуцлагын талаарх анхааруулга зэргийг тусгана.		*“Магадлан” гэснийг хассан*
1310.	252.6.Магадлан шинжилгээг дараахь хугацаанд хийнэ: 252.6.1.барааг магадлан шинжилгээний дүгнэлтийн дараа мэдүүлэгчийн сонгосон горимд байршуулах тохиолдолд түр агуулахад байх хугацаанд; 252.6.2.тээврийн хэрэгсэлд магадлан шинжилгээ хийх тохиолдолд 1 сар хүртэлх хугацаанд; 252.6.3.бусад тохиолдолд 3 сар хүртэлх хугацаанд. 252.7.Гаалийн байгууллагын удирдах албан тушаалтан бараа, тээврийн хэрэгсэл болон тэдгээртэй холбоотой бичиг баримтад магадлан шинжилгээ хийх болсон тухай шийдвэр гаргаж, түүнийг мэдүүлэгчид танилцуулна. 252.8.Магадлан шинжилгээ хийх, шинжээч томилох, дүгнэлт гаргах журам, шинжээчид тавигдах шаардлагыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална			*Хасагдсан*
1311.		117.6.Гаалийн байгууллагын удирдах албан тушаалтан бараа, тээврийн хэрэгсэл болон тэдгээртэй холбоотой бичиг баримтад шинжилгээ хийх болсон тухай шийдвэр гаргаж, түүнийг мэдүүлэгчид танилцуулна.		*Шинээр нэмэгдсэн*
1312.		**119 дүгээр зүйл.Шинжээч томилох** 119.1.Шинжилгээ хийлгэх тухай шийдвэр, Дээж, сорьц авсан тухай баримт, эсхүл шинжилгээ хийлгүүлэхээр хүсэлт гаргасан мэдүүлэгч болон төрийн байгууллагаас ирүүлсэн албан бичиг, сорьц, дээж, загварын битүүмжлэлийн бүрэн бүтэн байдал, дагалдах бичиг баримтыг дээж хүлээн авах лабораторийн ажилтан шалган авч, лабораторийн удирдлага нь шинжилгээ хийх, дүгнэлт гаргах шинжээчийг томилно. Нэг шинжилгээнд хоёр буюу түүнээс дээш шинжээч томилж болно.		*Шинээр нэмэгдсэн*

ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nli.mn

1313.		**121 дүгээр зүйл.Шинжээчийн үйл ажиллагаанд хориглох зүйл** 121.1.Шинжээчийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно: 121.1.1.Шинжилгээний ажлыг лабораторийн удирдлагын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр хийж гүйцэтгэх; 121.1.2.Шинжилгээ хийлгэх тухай шийдвэр, тогтоол, албан бичигт зааснаас бусад барааны сорьц, дээж, загварт шинжилгээ хийх; 121.1.3.Өөрт даалгасан нууцлалын зэрэгтэй шинжилгээний ажилд бусад шинжээчдийг татан оролцуулах; 121.1.4.Өөрийн эрх хэмжээнээс хэтэрсэн асуудлыг шийдвэрлэх; 121.1.5.Шинжилгээний холбогдолтой бичиг, баримт, дээж, сорьцыг албаны бус байранд хадгалах; 121.1.6.Хуульд тогтоомжоор хориглосон бусад үйл ажиллагаа.		*Шинээр нэмэгдсэн*
1314.	**253 дугаар зүйл.Шинжээчийн дүгнэлт**	**137 дугаар зүйл.Шинжээчийн дүгнэлт**		
1315.	253.1.Шинжээч шинжилгээний үндсэн дээр дүгнэлтийг бичгээр гаргана.			*Өөрчлөн найруулсан*
1316.		137.1.Шинжээчийн дүгнэлтэд дараах зүйлийг тусгасан байна.		
1317.		137.1.1.газар, огноо, магадлан шинжилгээ эхэлсэн, дууссан газар, огноо, цаг,		
1318.	253.2.Шинжээчийн дүгнэлтэд магадлан шинжилгээ хийсэн үндэслэл, газар, хугацаа болон шинжээчийн овог, нэр, эсхүл байгууллагын нэр, шинжээчийн өмнө тавигдсан асуулт, түүний хариулт, шинжилгээний объект, материал, бичиг баримт, шинжилгээ хийсэн арга, үр дүн зэргийг бичнэ.	137.1.2.магадлан шинжилгээ хийсэн үндэслэл		
1319.		137.1.3.гаалийн шинжилгээ хийсэн шинжээчийн овог, нэр, мэргэшлийн чиглэл		
1320.		137.1.4.шинжээч худал дүгнэлт гаргавал хүлээх хариуцлагатай танилцсан тухай тэмдэглэл,		
1321.		137.1.5.шинжээчид тавигдсан асуулт		
1322.		137.1.6.магадлан шинжилгээ хийлгэхээр шинжээчийн хүлээн авсан бичиг баримт, материал, сорьц, дээж, загварын жагсаалт		
1323.		137.1.7.магадлан шинжилгээ хийхэд ашигласан арга, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, шинжилгээний дүн, тавигдсан асуултуудын дагуу гаргасан дүгнэлт, үндэслэл,		
1324.		137.1.7.магадлан шинжилгээ хийхэд ашигласан арга, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, шинжилгээний дүн, тавигдсан асуултуудын дагуу гаргасан дүгнэлт, үндэслэл,		

Хуулийн цахим сан www.legalinfo.mn

1325.	253.3.Энэ хуулийн 253.2-т заасан дүгнэлтэд шинжээч томилсон тогтоолын асуултад тусгагдаагүй боловч тухайн шинжилгээнд ач холбогдолтой байж болох бусад дүгнэлтийг бичиж болно.			
1326.	253.4.Шинжээч дүгнэлтдээ нотлох баримт болон холбогдох бусад материал, бичиг баримтыг хавсаргах бөгөөд энэ нь шинжээчийн дүгнэлтийн салшгүй хэсэгт тооцогдоно.	137.2.Шинжээчийн дүгнэлтэд холбогдох материал, бичиг баримт, шинжилгээг хэд хэдэн шинжээч хийсэн бол шинжээч тус бүрийн дүгнэлтийг хавсаргана.		
1327.		137.3.Шинжилгээнд хэд хэдэн шинжээч оролцсон бол оролцсон бүх шинжээч тус бүр гарын үсэг зурж, байгууллагын тамга тэмдгээр баталгаажуулна.		
1328.	253.5.Магадлан шинжилгээ хийсэн болон түүнд оролцсон шинжээч нар дүгнэлтэд гарын үсэг зурах бөгөөд санал зөрсөн тохиолдолд шинжээч бүр өөрийн дүгнэлтийг гаргана.			
1329.	253.6.Гаалийн байгууллага шинжээчийн дүгнэлтийн хуулбарыг мэдүүлэгчид өгнө.	137.4.Шинжээчийн дүгнэлтийг хоёр хувь үйлдэх бөгөөд нэг хувийг гаалийн байгууллагад, үлдэх хувийг магдлан шинжилгээ хийлгэсэн этгээдэд өгнө.		
1330.	253.7.Гаалийн байгууллага, албан тушаалтан нь шийдвэр гаргахдаа шинжээчийн дүгнэлтийг харгалзан үзнэ.			-
1331.		137.5.Магадлан шинжилгээний үр дүнг шинжээч хариуцна.		*Шинээр нэмэгдсэн*
1332.	**254 дүгээр зүйл.Нэмэлт болон давтан магадлан шинжилгээ хийх**	**138 дугаар зүйл.Нэмэлт болон давтан шинжилгээ хийх**		*“магадлан” гэснийг хассан*
1333.		138.1.Шинэ нөхцөл байдал илэрсэн тохиолдолд нэмэлт шинжилгээ хийнэ. Нэмэлт шинжилгээг эхний шинжилгээ хийсэн шинжээч болон өөр шинжээчийн аль алинаар хийлгэж болно.		
1334.		138.2.Дараах тохиолдолд гаалийн байгууллага давтан шинжилгээ хийлгэнэ: 138.2.1.Мэдүүлэгч болон гаалийн байгууллага тухайн дээжтэй холбогдох дүгнэлт, шинжилгээний үр дүнг хүлээн зөвшөөрөөгүй; 138.2.2.Мэдүүлэгч болон гаалийн байгууллага нь эхний болон нэмэлт шинжилгээний дүнг хүлээн зөвшөөрөөгүй.		
1335.	254.1.Шинжээчийн дүгнэлт тодорхой бус, бүрэн гүйцэд гараагүй тохиолдолд дүгнэлт гаргасан шинжээч, эсхүл өөр шинжээч, байгууллагаар нэмэлт магадлан шинжилгээг хийлгэнэ.	138.3.Давтан шинжилгээг эхний болон нэмэлт шинжилгээнд оролцоогүй хоёр буюу түүнээс дээш бүрэлдэхүүнтэй шинжээч хийнэ.		

Хууль зүйн яаманд хэвлэлийн хүрээлэн www.nlo.mn

1336.	254.2.Шинжээчийн дүгнэлт үндэслэлгүй, эргэлзээтэй байгаа бол гаалийн байгууллага өөр шинжээч томилж, давтан магадлан шинжилгээ хийлгэнэ.			*Өөрчлөн найруулсан*
1337.	254.3.Нэмэлт болон давтан магадлан шинжилгээг хийлгэхэд энэ хуулийн 252, 253 дугаар зүйлийн холбогдох заалтыг баримтална.			-
1338.		138.4.Давтан шинжилгээнд эхний болон нэмэлт шинжилгээ хийсэн шинжээч нар байлцаж, тайлбар хийж болох боловч шинжилгээний дүгнэлт гаргах ажиллагаанд оролцохыг хориглоно.		
1339.		138.5.Нэмэлт болон давтан шинжилгээг хийхээс өмнө эхний магадлан шинжилгээний дүгнэлтийг хүргүүлсэн байна.		
1340.				
1341.	**255 дугаар зүйл.Шинжээчийн эрх, үүрэг**	**134 дүгээр зүйл.Шинжээчийн эрх, үүрэг**		
1342.	255.1.Шинжээч дараахь эрх эдэлнэ:	134.1.Шинжээч дараах эрх эдэлнэ:		*“шинжээч” гэсний өмнө “Гаалийн улсын байцаагч” гэж нэмсэн*
1343.	255.1.1.магадлан шинжилгээ хийх бичиг баримт, бараа, тээврийн хэрэгсэлтэй танилцах;	134.1.1.магадлан шинжилгээ хийх бараа, тээврийн хэрэгсэл, бичиг баримттай танилцах;		
1344.	255.1.2.магадлан шинжилгээнд гаалийн байгууллагын зөвшөөрлөөр бусад шинжээчийг оролцуулах;	134.1.2.магадлан шинжилгээнд гаалийн байгууллагын зөвшөөрлөөр бусад нарийн мэргэжлийн шинжээчийг оролцуулах;		
1345.	255.1.3.магадлан шинжилгээ хийхэд зайлшгүй шаардлагатай материал, нэмэлт мэдээлэл, бичиг баримт гаргуулан авах;	134.1.4.магадлан шинжилгээ хийхэд зайлшгүй шаардлагдах материал, нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг мэдүүлэгчээс гаргуулан авах;		
1346.	255.1.4.магадлан шинжилгээ хийхээс татгалзах;	134.1.3.итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтод заагдаагүй шинжилгээ хийлгэхээр сорьц, дээж, загвар ирсэн тохиолдолд татгалзах,		
1347.		134.1.5.магадлан шинжилгээнд дээж, сорьц хүрэлцээгүй тохиолдолд дахин сорьц, дээж, загвар авчруулах;		
1348.		134.1.6.шинжээч томилох шийдвэрт байгаа асуудлын талаар тодруулга авах;		
1349.		134.1.7.шинжлэх ухаан, техникийн мэдээллийг нийтэлсэн цахим болон бусад эх сурвалж ашиглах;		
1350.		134.1.8.өөрийн хийсэн шинжилгээний дүн болон бусад судалгаа, шинжилгээний байгууллагуудад хийгдсэн судалгааны дүнг ашиглах,		
1351.	255.1.5.гаалийн байгууллагын зөвшөөрлөөр гаалийн хяналтыг хэрэгжүүлэх тодорхой ажиллагаанд оролцох.	134.1.9.гаалийн байгууллагын зөвшөөрлөөр гаалийн хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох.		*“магадлан” гэснийг тохиолдол бүрт хассан*

Хууль тогтоомжийн хүрээлэн www.legalinfo.mn

1352.	255.2.Шинжээч энэ хуулийн 255.1.4-т зааснаар магадлан шинжилгээ хийхээс татгалзсан бол энэ тухай гаалийн байгууллагад бичгээр гаргана. 255.3.Шинжээч магадлан шинжилгээ хийх болон шинжээчийн дүгнэлттэй холбоотой мэдээллийн нууцыг хадгалах, оролцож буй тухайн гаалийн үйл ажиллагаа өөрийн нь гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн, эсхүл өөрийн нь өмчтэй холбоотой бол уг үйл ажиллагаанаас татгалзан гарах үүрэгтэй.			*Хасагдсан*
1353.		134.2.Шинжээч дараах үүрэг хүлээнэ: 134.2.1.Шинжилгээ хийлгэх асуултад ороогүй боловч гаалийн хяналтад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар дүгнэлтэд тусгах; 134.2.2.аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүний бараанд хийгдсэн шинжилгээний арга, аргачлал, үр дүнд холбогдох мэдээллийн нууцлалыг хадгалах; 134.2.3.хуульд заасан магадлан шинжилгээ хийх хугацааг мөрдөх; 134.2.4.Холбогдох баримтыг дутуу бүрдүүлснээс шалтгаалж шинжилгээ хийх боломжгүй тохиолдолд энэ тухай удирдах албан тушаалтан болон мэдүүлэгчид мэдэгдэх; 134.2.5.Магадлан шинжилгээнд хамруулах барааны битүүмжлэл алдагдсан, эсхүл зөрчил илэрсэн тохиолдолд удирдлагад мэдэгдэх; 134.2.6.Шинжилгээнд ирүүлсэн дээж, сорьц, загвар, бичиг баримтын бүрэн бүтэн байдал, хадгалалтыг хариуцах; 134.2.7.харилцан хамааралтай болон нэгдмэл сонирхолтой этгээдийн бараа бүтээгдэхүүнд шинжилгээ хийхээс татгалзах 134.2.8.Энэ хуулийн 134.2.7-д зааснаар шинжилгээ хийхээс татгалзсан бол энэ тухай гаалийн байгууллагад бичгээр мэдэгдэнэ.		*Шинээр нэмэгдсэн*

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.lri.gov.mn

1354.	134.2.Шинжээч дараах үүрэг хүлээнэ: 134.2.1.Шинжилгээ хийлгэх асуултад ороогүй болон гаалийн хяналтад ач холбогдол бухий нөхцөл байдлын талаар дүгнэлтэд тусгах; 134.2.2.аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүний бараанд хийдсэн шинжилгээний арга, аргачлал, үр дүнд холбогдох мэдээллийн нууцлалыг хадгалах; 134.2.3.хуульд заасан магадлан шинжилгээ хийх хугацаг мөрдөх; 134.2.4.Холбогдох баримтыг дутуу бүрдүүлснээс шалтгаалж шинжилгээ хийх боломжгүй тохиолдолд энэ тухай удирдах албан тушаалтан болон мэдүүлэгчид мэдэгдэх; 134.2.5.Магадлан шинжилгээнд хамруулах барааны бүтүүмжлэл алдагдсан, эсхүл зөрчил илэрсэн тохиолдолд удирдлагад мэдэгдэх; 134.2.6.Шинжилгээнд ирүүлсэн дээж, сорьц, загвар, бичиг баримтын бүрэн бүтэн байдал, хадгалалтыг хариуцах; 134.2.7.харилцан хамааралтай болон нэгдмэл сонирхолтой этгээдийн бараа бүтээгдэхүүнд шинжилгээ хийхээс татгалзах 134.2.8.Энэ хуулийн 134.2.7-д зааснаар шинжилгээ хийхээс татгалзсан бол энэ тухай гаалийн байгууллагад бичгээр мэдэгдэнэ.			
1355.	**135дугаар зүйл.Мэдүүлэгчийн эрх, үүрэг** 135.1. Магадлан шинжилгээ хийх үед мэдүүлэгч дараах эрх эдэлнэ: 135.1.1.шинжээчид нэмэлт асуулт тавих; 135.1.2.шинжээчийн дүгнэлттэй танилцах, хуулбарыг авах; 135.1.3.гаалийн байгууллага сорьц, дээж, загвар авахад байлцах; 135.1.4.нэмэлт болон давтан шинжилгээ хийлгэх хүсэлт гаргах. 135.2.Энэ хуулийн 135.1.1, 135.1.4-т заасан мэдүүлэгчийн хүсэлтийг гаалийн байгууллага хүлээж авах тохиолдолд энэ тухай шийдвэрийг гаргана. Харин хүсэлтийг хүлээн авахаас татгалзах тохиолдолд энэ тухай мэдүүлэгчид бичгээр мэдэгдэнэ.			

ХУУЛЬ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН
www.legalinfo.mn

1356.		**136 дугаар зүйл.Шинжээчийн үйл ажиллагаанд хориглох зүйл** 136.1.Шинжээчийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно: 136.1.1.шинжилгээний ажлыг удирдлагын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр хийж гүйцэтгэх; 136.1.2.шинжилгээнд хамруулах тухай шийдвэр, тогтоол, албан бичигт дурдагдаагүй барааны сорьц, дээж, загварт шинжилгээ хийх 136.1.3.өөрт даалгасан нууцлалын зэрэгтэй шинжилгээний ажилд бусад шинжээчдийг татан оролцуулах; 136.1.4.хууль тогтоомжоор тогтоосон эрхийг хэтрүүлэх; 136.1.5.шинжилгээнд холбогдолтой бичиг, баримтыг хувилах, бусдад дамжуулах, мэдээлэл өгөх; 136.1.6.Хууль тогтоомжоор хориглосон бусад үйл ажиллагаа.		
1357.	**256 дугаар зүйл.Сорьц, дээж, загвар авах**	**139 дүгээр зүйл.Сорьц, дээж, загвар авах**		
1358.	256.1.Гаалийн байгууллага, албан тушаалтан нь гаалийн хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор барааны сорьц, дээж, загварыг авч болно.	139.1.Гаалийн байгууллага, албан тушаалтан нь гаалийн хяналтыг хэрэгжүүлэх, магадлан шинжилгээнд хамруулах зорилгоор бараа, бүтээгдэхүүнээс холбогдох стандартын дагуу сорьц, дээж, загвар авна.		
1359.	256.2.Мэдүүлэгч гаалийн байгууллагын зөвшөөрснөөр сорьц, дээж, загвар авч болно	139.2.Шаардлагатай тохиолдолд тусгай мэдлэгтэй мэргэжилтэн, зориулалтын техник хэрэгсэл ашиглан сорьц, дээж, загварыг авч болно.		-
1360.	256.3.Төрийн эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтан холбогдох хууль тогтоомжийн дагуу сорьц, дээж, загвар авахад гаалийн байгууллагын албан тушаалтан болон мэдүүлэгч байлцана.	139.6.Хуульд заасны дагуу мэдүүлэгчийг байлцуулахгүйгээр бараа, тээврийн хэрэгслийг шалгахдаа сорьц, дээж, загвар авч болно. Энэ үед хөндлөнгийн хоёроос доошгүй гэрчийг байлцуулна.		
1361.	256.4.Мэдүүлэгч нь сорьц, дээж, загвар авахад туслалцаа үзүүлж, үүнтэй холбогдон гарах зардлыг хариуцна.	139.5.Мэдүүлэгч нь сорьц, дээж, загвар авахад мэргэжлийн туслалцаа үзүүлж, үүнтэй холбогдон гарах зардлыг хариуцна.		
1362.	256.5.Сорьц, дээж, загварын тоо хэмжээ нь шинжилгээ, дүгнэлтэд хүрэлцэхүйц хамгийн бага хэмжээтэй байна.	139.3.Сорьц, дээж, загварын тоо хэмжээ нь шинжилгээ, дүгнэлтэд хүрэлцэхүйц, холбогдох стандартад заасан хамгийн бага хэмжээтэй байна		
1363.	256.6.Энэ хуулийн 256.1-256.3-т заасны дагуу барааны сорьц, дээж, загварыг авсан тухай тэмдэглэл хөтлөх бөгөөд уг ажиллагаанд шинжээч, мэргэжилтнийг оролцуулж болно.	139.4.Энэ хуулийн 139.3-т заасны дагуу сорьц, дээж, загварыг авсан тухай тэмдэглэл хөтлөх бөгөөд уг ажиллагаанд шинжээч, мэргэжилтнийг оролцуулж болно.		-
1364.	256.7.Сорьц, дээж, загвар авах, шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.			*Хасагдсан*
1365.		139.7.Магадлан шинжилгээ дууссаны дараа маргаан гараагүй, сорьц, дээж, загварыг устгахаас бусад тохиолдолд түүнийг мэдүүлэгч эсхүл гаалийн байгууллагад буцаан өгнө.		
1366.		139.8.Дээж, сорьц, загвар авсан албан тушаалтан нь түүнээс үүсэн гарах хариуцлагыг хүлээнэ.		

1367.	**257 дугаар зүйл.Гаалийн хяналтад мэргэжилтнийг оролцуулах** 257.1.Гаалийн хяналтыг хэрэгжүүлэхэд техник хэрэгсэл, мэргэжлийн мэдлэг, ур чадвар ашиглах шаардлага гарвал гаалийн байгууллага холбогдох мэргэжилтэнг гэрээний үндсэн дээр гаалийн үйл ажиллагаанд оролцуулж болно. 257.2.Энэ хуулийн 257.1-д заасан мэргэжилтэн дараахь эрх эдэлнэ: 257.2.1.өөрийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд холбогдох материалтай танилцах; 257.2.2.гаалийн байгууллагын албан тушаалтны зөвшөөрлөөр тухайн үйл ажиллагаанд хамаарах асуулт тавих; 257.2.3.өөрийн оролцсон үйл ажиллагааны үр дүн, холбогдох бичиг баримттай танилцах, тайлбар хийх. 257.3.Энэ хуулийн 257.1-д заасан мэргэжилтэн дараахь үүрэг хүлээнэ: 257.3.1.гэрээнд заасан үүргээ биелүүлэх; 257.3.2.гаалийн хяналтын тодорхой үйл ажиллагаанд оролцсон болохыг гарын үсгээр баталгаажуулах, уг ажиллагааны явцад олж мэдсэн мэдээллийн нууцыг задруулахгүй байх; 257.3.3.оролцож буй тухайн гаалийн үйл ажиллагаа нь өөрийн нь гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн, эсхүл өөрийн нь өмчтэй холбоотой бол уг үйл ажиллагаанаас татгалзан гарах үүрэгтэй. 257.4.Гаалийн байгууллагын саналчилгаар гаалийн хяналтад оролцсон мэргэжилтний зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.				*Хасагдсан*
1368.	**258 дугаар зүйл.Гаалийн хяналт хийхэд төрийн эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны оролцоо** 258.1.Гаалийн хяналт хийх үед мэргэжлийн хяналт, цагдаагийн зэрэг төрийн эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтан холбогдох хууль тогтоомжийн дагуу оролцож болно. 258.2.Энэ хуулийн 258.1-д заасан байгууллага, албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хийх хяналт, шалгалтыг гаалийн шалгалтай зэрэг хийж болно.				*Хасагдсан*

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

1369.	**Хоёрдугаар дэд бүлэг** **Гаалийн хяналтын нэмэлт нөхцөл**			
1370.	**259 дүгээр зүйл.Гаалийн харилцаанд оролцож буй этгээдийн талаархи мэдээлэл** 259.1.Гаалийн байгууллага нь гаалийн хилээр бараа, тээврийн хэрэгсэл нэвтрүүлж байгаа болон гадаад худалдааны үйл ажиллагаа эрхэлж буй этгээдийн талаарх мэдээллийг энэхүү хуульд заасны дагуу авна. 259.2.Гаалийн байгууллага нь гаалийн хяналт хэрэгжүүлэх, гаалийн татвар, хураамжийг ногдуулах, хураан авах зорилгоор гаалийн харилцаанд оролцогчийн үйл ажиллагаа, хөрөнгө, санхүү, байршил зэрэгтэй холбоотой мэдээллийг авна.			*Хасагдсан*
1371.	**260 дугаар зүйл.Гаалийн хяналтад шаардлагатай бусад үйл ажиллагаа** 260.1.Тус агуулах болон гаалийн баталгаат бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл зэрэмшигч, мэдүүлэгч, тээвэрлэгч нь гаалийн байгууллагын шаардлагаар гаалийн хяналтад байгаа барааг тээвэрлэх, ачих, буулгах, шилжүүлэн ачих, баглаа боодлыг задлах, боох, жигнэх, тоо хэмжээ тогтоох, баглаа боодлын гэмтлийг арилгах, дахин савлах болон байр, агуулахыг онгойлгох, хаах үүрэг хүлээнэ.			*Хасагдсан*

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

1372.	**261 дүгээр зүйл.Бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийх** 261.1.Гаалийн хяналтад байгаа бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн зорилгоор тэмдэглэгээ \цаашид "гаалийн тэмдэглэгээ" гэх\ хийхдээ лац, ломбо, үсгэн болон бусад тэмдэглэгээ тавих, марклах, тээврийн болон худалдааны бичиг баримтад хяналтын тэмдэг дарах, сорыц, дээж, загвар авах, бараа, тээврийн хэрэгслийн шинж байдлыг дэлгэрэнгүй тодорхойлон бичих, фото зураг авах, бичлэг хийх, зураг, будуувч зураг гаргах зэрэг боломжтой бухий л артыг хэрэглэнэ. 261.2.Энэ хуулийн 261.1-д заасан тэмдэглэгээг гаалийн байгууллага, албан тушаалтан хийнэ. 261.3.Бараа, тээврийн хэрэгсэл устах, үрэгдэх, гэмтэж муудах бодит аюул тулгарсан, эсхүл гаалийн байгууллага гаалийн тэмдэглэгээ хийх боломжгүй бол энэ тухай гаалийн байгууллагад шуурхай мэдэлгэх түүний зөвшөөрөлтэйгээр гаалийн тэмдэглэгээ бусад этгээд авах, өөрчлөх, сольж болно. 261.4.Энэ хуулийн 261.3-т заасан нөхцөл байдлыг гаалийн байгууллагад мэдэлгэх боломжгүй бол тэрийн холбогдох эрх бухий албан тушаалтны оролцоотойгоор гаалийн тэмдэглэгээг бусад этгээд авах, өөрчлөх, сольж болно. 261.5.Энэ хуулийн 261.3, 261.4-т заасан тохиолдолд гаалийн удирдах төв байгууллагын даргын баталсан маягтын дагуу акт үйлдэх ба бодит аюул учирсныг холбогдох байгууллагын бичиг баримтаар нотолно. 261.6.Энэ хуулийн 261.1-д заасан тэмдэглэгээ нь гадаад улсын гаалийн байгууллагаас тавьсан лац, ломбо, хяналтын тэмдэг зэрэгт нэгэн адил хамаарах бөгөөд түүнийг гаалийн зорилгоор ашиглана. 261.7.Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд тэмдэглэгээ хэрэглэх журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.				*Хасагдсан*

УЛСЫН ЗҮЙН ЧАНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nli.gov.mn

	Гуравдугаар дэд бүлэг Оюуны өмчийн эрхэд хамаарах бараат гаалийн хилээр нэвтрүүлэх	ДОЛООДУГААР ДЭД БҮЛЭГ ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ		
1373.		**160 дугаар зүйл.Оюуны өмчийн эрхийг хамгаалах** 160.1.Гаалийн байгууллага нь өөрийн чиг үүргийн хүрээнд оюуны өмчийн эрхийг хамгаалах чиглэлээр энэ бүлэгт заасан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. 160.2.Доор дурьдснаас бусад тохиолдолд гаалийн хилээр нэвтрүүлж байгаа оюуны өмчийн эрхэд хамаарах бараат хамгаална: 160.2.1.хувийн хэрэглээндээ зориулан нэвтрүүлж байгаа, түүний дотор шуудан илгээмжээр хүвь хүний нэр дээр илгээсэн бараа; 160.2.2.улс хооронд дамжуулан өнгөрүүлэх бараа; 160.2.3.дипломат эрх ямба эдлэх олон улсын байгууллага, тэдгээрийн ажилтнуудыг албан болон хувийн хэрэглээндээ зориулан нэвтрүүлж байгаа бараа. 160.3.Оюуны өмчийн эрхийг хамгаалах чиглэлээр гаалийн байгууллагаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь оюуны өмчийн эрх эзэмшигчийн хууль, тогтоомжийн дагуу эрхээ хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд саад болохоргүй байна. 160.4.Гаалийн байгууллага нь өөрт бүртгэгдсэн хүсэлтэд хамаарах бараанд оюуны өмчийн эрхийг хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	
1374.				
1375.		**161 дүгээр зүйл.Оюуны өмчийн эрхийг гаалийн байгууллага хамгаалах хугацаа** 161.1.Оюуны өмчийн эрх эзэмшигчийн гаргасан хүсэлтийн дагуу гаалийн байгууллага бүртгэж авсан өдрөөс хойш жилээс илүүгүй хугацаанд тухайн эрхийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ. 161.2.Оюуны өмчийн эрх эзэмшигчийн хүсэлтээр 161.1-д заасан хугацааг мөн хойш жил жил хүртэл хугацаагаар хэдэн ч удаа сунгаж болно. 161.3.Энэ хуулийн 161.1, 161.2-т заасан хугацаа нь оюуны өмчийн эрхийн хүчин төгөлдөр хугацаанаас илүү гарч болохгүй.	*Шинээр нэмэгдсэн*

ХУУЛЬ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН
www.legal.mn

1376.	**162дугаар зүйл.Оюуны өмчийн эрхийн гаалийн бүртгэл** 162.1.Гаалийн удирдах төв байгууллага оюуны өмчийн эрх зөрчсөн бичгээр гаргасан өргөдлийг үндэслэн, зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх, барааны тэмдэг, газар зүйн заалтад хамаарах барааг буртгэж, гаалийн бүртгэл хөтөлнө. 162.2.Оюуны өмчийн гаалийн бүртгэлд дараах мэдээллийг оруулсан байна: 162.2.1.эрх эзэмшигч нь хуулийн этгээд бол түүний оносон нэр, хаяг, зохион байгуулалтын хэлбэр, хүн бол овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, хаяг, харъяалал, байнга оршин суудаг буюу үйл ажиллагаа явуулдаг улсын нэр; 162.2.2.оюуны өмчийн эрх эзэмшигч итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулж бүртгүүлэх бол түүний овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, хаяг; 162.2.3.зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх, барааны тэмдэг, газар зүйн заалтад хамаарах барааны нэр, тайлбар, дүрс; 162.2.4.бүртгэлд оруулж, хамгаалалтад авах барааны жагсаалт /барааны нэр, бараа, үйлчилгээний олон улсын ангиллын, зохиол барааны ангиллын код/. 162.2.5.эрх эзэмшигчийн эрх хэрхэн эрчигдсэн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл; 162.2.6.гаалийн байгууллагаас авч хэрэгжүүлэхийг хүссэн арга хэмжээ, хугацаа.		*Шинээр нэмэгдсэн*
1377.	**163 дугаар зүйл. Оюуны өмчийн эрхийн гаалийн бүртгэлд өөрчлөлт оруулах** 163.1.Дараахь тохиолдолд гаалийн бүртгэлд өөрчлөлт оруулж болно: 163.1.1.өргөдөл болон түүнд хавсаргасан бичиг баримтад заасан мэдээлэл өөрчлөгдсөн талаар оюуны өмчийн эрх эзэмшигч өргөдөл гаргагч өөрөө хандсан; 163.1.2.оюуны өмчийн эрхийн хамгаалалтын хугацаа дуусгавар болсон, оюуны өмчийн эрх хүчингүй болсон, эрх эзэмшигчийн нэр өөрчлөгдсөн тухай хууль хэлтэн болон төрийн бусад байгууллагаас гаалийн байгууллагад бичгээр мэдэгдсэн. 163.2.Гаалийн бүртгэлд өөрчлөлт оруулахдаа холбогдох мэдээллийг нягталж, алхлын гурван өдөрт багтаан хийж гүйцэтгэнэ. 163.3.Оюуны өмчийн эрхийн гаалийн бүртгэлд бүртгэдсэн мэдээллийг алхлын нэг өдөрт багтаан холбогдох гаалийн байгууллагад мэдэгдэнэ.		

ХУУЛЬ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН

1378.		**164 дүгээр зүйл.Оюуны өмчийн эрх эзэмшигч өргөдөл гаргах, түүнийг шийдвэрлэх** 164.1.Барааны тэмдэг, газар зүйн заалт, зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зөрчилтэй барааг гаалийн хилээр нэвтрүүлж байгаа болон гаалийн хяналтад байна гэх хангалттай үндэслэл байгаа талаар гаалийн байгууллагад өргөдөл гаргаж болно. 164.2.Энэ хуулийн 164.1-д заасан өргөдөлд дараах мэдээллийг агуулсан байна: 164.2.1.оюуны өмчийн эрх эзэмшигчийн тухай, хэрэв итгэмжлэгдсэн төлөөлөгч өргөдөл гаргаж байгаа бол түүний тухай; 164.2.2.оюуны өмчийн обьектын тухай; 164.2.3.улсын хилээр нэвтэрч байгаа болон гаалийн хяналтад байгаа бараа нь оюуны өмчийн эрх зөрчсөн гэж үзсэн барааны ялгах шинж, тодорхой мэдээлэл зэргийг; 164.2.4.гаалийн байгууллагаас барааг саатуулан, оюуны өмчийн эрхийг хамгаалах чиглэлээр шалгах ажиллагааг явуулах хугацааг зааж өгөх. 164.3.Оюуны өмчийн эрх эзэмшигч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч дараах баримтыг бүрдүүлсэн байна: 164.3.1.оюуны өмчийн эрх эзэмших эрхийн гэрчилгээний эх хувь эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хувь; 164.3.2.оюуны өмчийн эрх эзэмшигч эрхээ бусдад шилжүүлсэн бол эрх шилжүүлсэн тухай гэрээ; 164.3.3.итгэмжлэгдсэн төлөөлөгч өргөдөл гаргаж байгаа тохиолдолд эрх эзэмшигчээс олгосон итгэмжлэлийн эх хувь; 164.3.4.гаалийн байгууллага оюуны өмчийн эрхийг зөрчсөн барааг ялган танихад зориулан оюуны өмчийн барааны дээж, сорьц, загварын дээж; 164.4.Барааг саатуулж шалгаснаас мэдүүлэгчид учрах хохирлыг хариуцах тухай баталгааг бичгээр гаргаж өргөдөлд хавсаргана.		

ХУДАЛДАН АВАЛТЫН ХУРЭЭЛЭН www.nii.gov.mn

1379.		**165 дугаар зүйл.Оюуны өмчийн эрхийн зөрчилтэй барааг саатуулах** 165.1.Саатуулагдсан барааны оюуны өмчийн эрхийн зөрчлийн талаар дүгнэлт гаргуулахаар хууль ёсны эрх эзэмшигч нь оюуны өмчийн эрхийн асуудал хариуцсан байгууллагад хандаж, шийдвэр гаргуулна. 165.2.Шүүхийн шийдвэр болон эрх бүхий байгууллагаас ирүүлсэн албан бичгийн дагуу оюуны өмчийн эрхийн зөрчилтэй барааг саатуулна. 165.3.Гаалийн байгууллага олон улсын болон, бусад орны гаалийн байгууллагаас ирүүлсэн албан хүсэлтийн дагуу оюуны өмчийн эрхийн зөрчилтэй барааг саатуулж болно. 165.4.Гаалийн байгууллага оюуны өмчийн эрхийн илэрхий зөрчилтэй барааг саатуулна. 165.5.Оюуны өмчийн эрхийн зөрчилтэй болох нь илэрхий их хэмжээний барааг саатуулах ажиллагааг холбогдох эрх бүхий хууль хяналтын байгууллагатай хамтран гүйцэтгэж болно. 165.6.Гаалийн байгууллага энэ арга хэмжээг авч хэрэгжүүлсэнтэй холбогдуулан хуулийн өмнө аливаа хариуцлага хүлээхгүй.		
1380.		**166 дугаар зүйл.Бусад байгууллагатай хамтран ажиллах** 166.1.Гаалийн болон оюуны өмчийн байгууллага нь оюуны өмчийн эрхээр хамгаалагдсан, өөрийн мэдээллийн санд бүртгэлтэй барааны талаарх мэдээллийг шаардлагатай үед харилцан солилцоно. 166.2.Оюуны өмчийн бүртгэлийн байгууллагын мэдээллийн санг ашиглаж байгаа гаалийн албан тушаалтан мэдээллийн сангийн нууцлалыг хадгалах үүрэгтэй. 166.3.Оюуны өмчийн эрхийн зөрчилтэй барааг гаалийн байгууллага ялган таних, шалгах, саатуулах, хадгалах зэрэг үйл ажиллагаатай холбогдуулан оюуны өмчийн байгууллагаас мэргэжлийн зөвлөгөө туслалцааг үнэ төлбөргүй авч, оюуны өмчийн эрхийн талаарх сургалтыг тогтмол хамтран явуулна. 166.4.Гаалийн байгууллага нь барааг хуурамчаар үйлдэх, оюуны өмчийн эрх зөрчих үйлдэлтэй тэмцэх үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн бусад байгууллагатай хамтран ажиллана.		
1381.	**262 дугаар зүйл.Оюуны өмчийн эрхэд хамаарах барааг гаалийн хилээр нэвтрүүлэх** 262.1.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай , Патентийн тухай хуульд заасны дагуу зохиогчийн эрхийн гэрчилгээ эзэмшигчийн өмчлөлд байгаа бүтээл, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар буюу оюуны өмчид хамаарах барааг бусад хуульд өөрөөр заагаагүй, эсхүл энэ хуулийн 264 дүгээр зүйлд заасны дагуу өргөдөл ирүүлснээс бусад тохиолдолд гаалийн хилээр нэвтрүүлнэ.			*Хасагдсан*

ХУУЛЬ ЗҮЙН ИНДЭКСИЙ ХҮРЭЭЛЭН
www.mnlaw.edu.mn

1382.	262.2.Оюуны өмчийн эрхэд хамаарах барааг гаалийн хилээр нэвтрүүлэх журмыг гаалийн удирдах төв байгууллагын болон Оюуны өмчийн газрын дарга нар хамтран батална.			*Хасагдсан*
1383.	**263 дугаар зүйл.Оюуны өмчийн эрхэд хамаарах барааг гаалийн хилээр нэвтрүүлэхгүй байх үндэслэл** 263.1.Гаалийн байгууллага нь оюуны өмчийн эрхэд хамаарах бөгөөд гаалийн хяналтад байгаа барааг оюуны өмчийн эрх эзэмшигчийн өргөдлийг үндэслэн гаалийн хилээр нэвтрүүлэхгүй байх арга хэмжээ авна. 263.2.Гаалийн байгууллагаас хэрэгжүүлэх арга хэмжээ нь оюуны өмчийн эрх эзэмшигчийг Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу эрхээ хамгаалахад саад болохгүй.			*Хасагдсан*
1384.	**264 дүгээр зүйл.Оюуны өмчийн эрх эзэмшигч өргөдөл гаргах, түүнийг хянан шийдвэрлэх** 264.1.Оюуны өмчийн эрх эзэмшигч нь түүний эрхийг зөрчин барааг гаалийн хилээр хууль бусаар нэвтрүүлсэн, эсхүл тухайн бараа гаалийн хяналтад байгааг нотлох хангалттай үндэслэл байгаа тохиодолд гаалийн байгууллагад барааг гаалийн хилээр нэвтрүүлэхгүй байх арга хэмжээг авах тухай өргөдлийг дараахь бүрдүүлбэртэйгээр гаргана: 264.1.1.эрх эзэмшигчийн талаархи мэдээлэл; 264.1.2.оюуны өмчийн объектын талаархи мэдээлэл; 264.1.3.өргөдөл гаргагчийн тодорхойлсноор хууль бусаар нэвтрүүлсэн байж болох барааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл; 264.1.4.гаалийн байгууллагаас авах арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа тогтоох. 264.2.Өргөдөлд оюуны өмчийн болон барааны загварын гэрчилгээг хавсаргана. 264.3.Гаалийн байгууллага өргөдлийг хүлээн авч, холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэнэ.			*Өөрчлөн найруулсан*
1385.	**Ү ХЭСЭГ** **ГААЛИЙН БАЙГУУЛЛАГА**	**II ХЭСЭГ** **ГААЛИЙН АЛБА**		
1386.		**НЭГДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ** **ГААЛИЙН БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ҮҮРЭГ, ЭРХ**		
1387.	**АРВАНДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ** **Гаалийн байгууллага**	**ХОЁРДУГААР БҮЛЭГ** **ГААЛИЙН АЛБА**		
1388.	**265 дугаар зүйл.Гаалийн байгууллага** 265.1.Гаалийн байгууллага нь Монгол Улсын гаалийн хууль тогтоомжийн биелэлтийг хангах төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх төрийн байгууллага мөн.	**5 дугаар зүйл.Гаалийн алба, түүний үйл ажиллагааны зарчим** 5.1.Гаалийн алба нь Монгол Улсын гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, эдийн засгийн болон хүн амын аюулгүй байдлыг хангах төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн.		*Өөрчлөн найруулсан*

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

1389.		5.2.Гаалийн алба, алба хаагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хуульд зааснаас гадна ил тод, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх зарчмыг баримтлан ажиллана		*Шинээр нэмэгдсэн*
1390.		**7 дугаар зүйл.Гаалийн албаны туг, бэлгэ тэмдэг**		
1391.	265.2.Гаалийн байгууллага бэлгэ тэмдэгтэй байх бөгөөд түүний загвар, хэрэглэх зааврыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.	7.1.Гаалийн алба нь тусгайлсан туг, бэлгэ тэмдэгтэй байх бөгөөд түүний загвар, хэрэглэх журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.		*“байгууллага бэлгэ тэмдэгтэй байх бөгөөд түүний загвар, хэрэглэх зааврыг” гэснийг “алба нь тусгайлсан туг, бэлгэ тэмдэгтэй байх бөгөөд түүний загвар, хэрэглэх журмыг” гэж өөрчилсөн*
1392.		7.2.Гаалийн албаны туг, бэлгэ тэмдэгтэй ижил загварын туг, бэлгэ тэмдэг хэрэглэхийг бусад байгууллагад хориглоно.		*Шинээр нэмэгдсэн*
1393.	265.3.Гаалийн байгууллагыг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана,	**8 дугаар зүйл.Гаалийн албаны санхүүжилт**1 8.1.Гаалийн албыг улсын төсвөөс санхүүжүүлэх бөгөөд энэхүү төсөв нь уг албанаас үйл ажиллагаагаа шуурхай, үр дүнтэй явуулах шаардлагыг бүрэн хангасан байна. 8.2.Энэ хуулийн 8.1-д заасан шаардлагын хүрээнд гаалийн алба хаагчийн нийгмийн баталгаа хөдөлмөрийн аюулгүй байдал, дүрэмт хувцас, техник хэрэгслийн зэрэг зардлыг улсын төсөвт тусгаж санхүүжүүлнэ.5.		*Өөрчлөн найруулсан*
1394.	**2671 дүгээр зүйл.Гаалийн байгууллагын тогтолцоо**	**6 дугаар зүйл.Гаалийн албаны тогтолцоо**		*“байгууллагын” гэснийг “албаны” гэж өөрчилсөн*
1395.	2671.1.Гаалийн байгууллагын тогтолцоо нь гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний харьяа гаалийн газар, хорооноос бүрдэх бөгөөд гаалийн газар нь алба, салбартай байж болно.	6.1.Гаалийн албаны тогтолцоо нь гаалийн удирдах төв байгууллага, гаалийн байгууллагаас, гаалийн байгууллага нь гаалийн газар, хорооноос бүрдэнэ. Гаалийн газар нь алба, хэлтэс, салбартай байж болно.		*Өөрчлөн найруулсан*
1396.	2671.2.Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гаалийн хууль тогтоомжийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн.	**10 дугаар зүйл.Гаалийн удирдах төв байгууллага** 10.1.Гаалийн удирдах төв байгууллага нь гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэгдмэл төвлөрсөн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн.		
1397.	2671.3.Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дарга, дэд даргатай байна.	10.2.Гаалийн удирдах төв байгууллага нь дарга, гаалийн хяналт,бүрдүүлэлтийн асуудал хариуцсан тэргүүн дэд дарга, гаалийн үнэ, тариф, татварын орлого хариуцсан дэд даргатай байна.		

ХУУЛЬ ЗҮЙН УЛСЫН ТӨВИЙН ХҮРЭЭЛЭН
www.legal.mn

1398.	2671.4.Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргыг гаалийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг, дэд даргыг гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын саналыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газар томилно.	10.3.Гаалийн удирдах төв байгууллагын даргыг гаалийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар, тэргүүн дэд, дэд даргыг гаалийн удирдах төв байгууллагын даргын саналыг үндэслэн гаалийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус томилно.		*Өөрчлөн найруулсан*
1399.	2671.5.Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дэргэдээ эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх, гаалийн ажилтан бэлтгэх, давтан сургах чиг үүрэг бүхий эрдэм шинжилгээний байгууллага, гаалийн лаборатори, хэвлэх үйлдвэр, мэдээлэл-тооцооллын төв, хөрөнгө оруулалт, хангамж үйлчилгээний газар, эрэлч нохойн албыг байгуулан ажиллуулж болно.	6.2.Гаалийн удирдах төв байгууллагын дэргэд энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслах зорилго бүхий сургалт судалгаа, бүрдүүлэлтийн дараах шалгалт, лаборатори, мэдээллийн технологи, хангамж үйлчилгээ, эрэлч нохой, хэвлэлийн зэрэг /***асуудал хариуцсан?***/ нэгж байгуулан ажиллуулж болно.		*Өөрчлөн найруулсан*
1400.	2671.6.Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүрмийг Засгийн газар батална.	6.3.Гаалийн удирдах төв байгууллагын дүрмийг Засгийн газар батална.		*“асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэснийг “удирдах төв байгууллагын” гэж өөрчилсөн*
1401.	2671.7.Гаалийн газар, хороо болон энэ зүйлийн 2671.5-д заасан байгууллагын дүрмийг гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална. 2671.8.Энэ зүйлийн 2671.5-д заасан эрдэм шинжилгээний байгууллагын эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагааг Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Дээд боловсролын тухай хуулиар зохицуулна. 2671.9.Гаалийн байгууллага нь хилийн боомтын хяналтын болон аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааг уялдуулах, ерөнхий зохицуулалтаар хангах тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд холбогдох харилцааг *Хилийн боомтын тухай хуулиар нарийвчлан зохицуулна.*			*Хасагдсан*
1402.	**2681 дүгээр зүйл.Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх**			
1403.	2681.1.Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:	**11 дүгээр зүйл.Гаалийн удирдах төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:**		
1404.	2681.1.1.гаалийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, биелэлтийг хангуулах; 2681.1.2.гаалийн асуудлаар санал боловсруулж хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх;	11.1.гаалийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, биелэлтийг хангуулах; 11.2.гаалийн асуудлаар санал боловсруулж хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх;		
1405.	2681.1.3.эрсдэл тооцох системд үндэслэсэн гаалийн хяналтын стратегийг тодорхойлох;	11.3.эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын стратегийг тодорхойлох;		*“эрсдэл тооцох системд үндэслэсэн” гэснийг “эрсдэлийн удирдлагад суурилсан” гэж өөрчилсөн*

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

1406.	2681.1.4.гаалийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх; 2681.1.5.гаалийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, мэргэжлийн удирдлагаар хангах, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх; 2681.1.6.бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэхтэй холбогдсон энэ хуульд заасан дүрэм, журам, зааврыг боловсруулах; 2681.1.7.гадаад худалдааны гаалийн статистикийн мэдээлэл гаргах, дүн шинжилгээ хийх; 2681.1.8.барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн үндэсний код боловсруулах; 2681.1.9.бараа мэдүүлэх, гаалийн бүрдүүлэлт хийх гаалийн байгууллагыг тогтоох; 2681.1.10.гаалийн байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг төлөвлөх, хангалтыг зохион байгуулах; 2681.1.11.гаалийн асуудлаар мэдээлэл, зөвлөгөө өгөх, гаалийн харилцаанд оролцогчийн мэргэжилтэнг бэлтгэх, сургах, давтан сургахад дэмжлэг үзүүлэх; 2681.1.12.гаалийн байгууллагын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх; 2681.1.13.гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх; 2681.1.14.гаалийн асуудлаарх өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх; 2681.1.15.хуульд заасан бусад бүрэн эрх.	11.4.гаалийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх; 11.5.гаалийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, мэргэжлийн удирдлагаар хангах, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх; 11.6.бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэхтэй холбогдсон энэ хуульд заасан дүрэм, журам, зааврыг боловсруулах; 11.7.гадаад худалдааны гаалийн статистикийн мэдээлэл гаргах, дүн шинжилгээ хийх; 11.8.барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн үндэсний код боловсруулах; 11.9.бараа мэдүүлэх, гаалийн бүрдүүлэлт хийх гаалийн байгууллагыг тогтоох; 11.10.гаалийн байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг төлөвлөх, хангалтыг зохион байгуулах; 11.11.гаалийн асуудлаар мэдээлэл, зөвлөгөө өгөх, гаалийн харилцаанд оролцогчийн мэргэжилтэнг бэлтгэх, сургах, давтан сургахад дэмжлэг үзүүлэх; 11.12.гаалийн байгууллагын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх; 11.13.гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх; 11.14.гаалийн асуудлаарх өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх; 11.15.хуульд заасан бусад бүрэн эрх.		-
1407.	**269[1] дүгээр зүйл.Гаалийн байгууллагын гүйцэтгэх үндсэн үүрэг** 269[1].1.Гаалийн байгууллага дараахь үндсэн үүргийг гүйцэтгэнэ: 269[1].1.1.гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих; 269[1].1.2.гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөнд хяналт тавих; 269[1].1.3.гаалийн бүрдүүлэлт хийж, гаалийн болон бусад татвар, хураамжийг ногдуулах, хураах, албадан хураах, тэдгээрт хяналт тавих; 269[1].1.4.гаалийн мэдээллийн системийг боловсронгуй болгох, мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, хамгаалах; 269[1].1.5.гадаад худалдааны гаалийн статистикийн мэдээлэл гаргах; 269[1].1.6.гаалийн хууль тогтоомжийг олон нийтэд таниулах, мэдээллээр хангах; 269[1].1.7.гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хуульд заасан хариуцлага хүлээлгэх; 269[1].1.8.гаалийн байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлэх; 269[1].1.9.энэ хуульд заасны дагуу оюуны өмчийн эрхийг хамгаалах. /Энэ зүйлийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/			*Хасагдсан*

Хуулийн этгээдийн хүрээлэн www.mnl.gov.mn

1408.	**270[1] дүгээр зүйл.Гаалийн байгууллагын эрх**	**13 дугаар зүйл.Гаалийн байгууллагын эрх, үүрэг**		*“эрх” гэсний дараа “, үүрэг” гэж нэмсэн*
1409.		13.1.Гаалийн байгууллага нь дараах үүргийг гүйцэтгэнэ: 13.1.1.гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг өөрийн хариуцах нутаг дэвсгэрт зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих; 13.1.2.гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөнд хяналт тавих; 13.1.3.гаалийн бүрдүүлэлт хийж, гаалийн болон бусад татвар, хураамжийг ногдуулах, хураах, албадан хураах, тэдгээрт хяналт тавих; 13.1.4.гаалийн мэдээллийн системийг боловсронгуй болгох, мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, хамгаалах; 13.1.5.гадаад худалдааны гаалийн статистикийн мэдээлэл гаргах; 13.1.6.гаалийн хууль тогтоомжийг олон нийтэд таниулах, мэдээллээр хангах; 13.1.7.гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хуульд заасан хариуцлага хүлээлгэх; 13.1.8.гаалийн байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлэх; 13.1.9.энэ хуульд заасны дагуу оюуны өмчийн эрхийг хамгаалах. /санхүүгийн урсгалыг хянах/		*Шинээр нэмэгдсэн*
1410.	270[1].1.Гаалийн байгууллага дараахь эрх эдэлнэ: 270[1].1.1. энэ хуульд заасны дагуу гаалийн зорилгоор мэдээлэл, бичиг баримт шаардах, шалгах; 270[1].1.2.өөрийн тээврийн болон холбооны хэрэгслийг ашиглах боломжгүй нөхцөл байдлын үед бусдын тээврийн болон холбооны хэрэгсэл ашиглах; 270[1].1.3.гаалийн асуудлаар шүүхэд нэхэмжлэл, гомдол гаргах; 270[1].1.4.хуульд заасан бусад эрх.	13.2.Гаалийн байгууллага дараах эрх эдэлнэ: 13.2.1.энэ хуульд заасны дагуу гаалийн зорилгоор мэдээлэл, бичиг баримт шаардах, шалгах; 13.2.2.өөрийн тээврийн болон холбооны хэрэгслийг ашиглах боломжгүй нөхцөл, байдлын үед бусдын тээврийн болон холбооны хэрэгсэл ашиглах; 13.2.3.гаалийн асуудлаар шүүхэд нэхэмжлэл, гомдол гаргах; 13.2.4.хуульд заасан бусад эрх.		

ХУУЛЬ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН www.legal.mn

1411.	**271[1] дүгээр зүйл.Гаалийн байгууллагын удирдлагын бүрэн эрх**	**12 дугаар зүйл.Гаалийн удирдах төв байгууллагын даргын бүрэн эрх**		*байгууллагын удирдлагын удирдах төв байгууллагын даргын гэж өөрчилсөн*
1412.	271[1].1.Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 271[1].1.1.гаалийн үйл ажиллагааг өдөр тутмын зохион байгуулалтын удирдлагаар хангах; 271[1].1.2.гаалийн хууль тогтоомжоор эрх олгосон бол нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон дүрэм, журам, заавар батлах; 271[1].1.3.гаалийн бодлого боловсруулахад оролцох, тарифын болон тарифын бус хязгаарлалтын арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	12.1.Гаалийн удирдах төв байгууллагын дарга Агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай хуульд заасан бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхтэй: 12.1.1.гаалийн албаны чиг үүрэг, эрхэм зорилго, стратегийн зорилтоо хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг батлах; 12.1.2.гаалийн асуудлаарх төрийн бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах;		
1413.	271[1].1.4.гаалийн асуудлаар байгуулах Монгол Улсын олон улсын гэрээний төслийг боловсруулах, Монгол Улсын Засгийн газраас эрх олгосон тохиолдолд олон улсын гэрээнд гарын үсэг зурах, гэрээгээр Монгол Улсын хүлээсэн үүргийн биелэлтийг хангуулах;	12.1.3.гаалийн асуудлаар байгуулах Монгол Улсын олон улсын гэрээний төслийг боловсруулах ажлыг зохион байгуулах, Монгол Улсын Засгийн газраас эрх олгосон тохиолдолд олон улсын гэрээнд гарын үсэг зурах, гэрээгээр Монгол Улсын хүлээсэн үүргийн биелэлтийг хангуулах;		-

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.mn.gov.mn

1414.	271[1].1.5.гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх ажлыг гаалийн хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулах; 271[1].1.6.гаалийн хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор гаалийн харилцаанд оролцогчидтой хамтран ажиллах; 271[1].1.7.гаалийн асуудлаарх өргөдөл, гомдлыг хүлээн авч, хянан үзэж, бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэр гаргах; 271[1].1.8.гаалийн удирдах төв байгууллагын харьяа болон дэргэдэх байгууллагыг байгуулах, өөрчлөх, татан буулгах; 271[1].1.9.харьяа гаалийн байгууллагын хариуцах хяналтын нутаг дэвсгэрийг тогтоох, тэдгээрийн эрх хэмжээг тодорхой бараа, тээврийн хэрэгсэл болон гаалийн бүрдүүлэлтийн горимоор хязгаарлах; 271[1].1.10.гаалийн алба хаагчийг томилох, чөлөөлөх, түдгэлзүүлэх, өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, шагнаж урамшуулах, төр засгийн шагналд тодорхойлох; 271[1].1.11.гаалийн улсын байцаагчийн эрх олгох, эрхийг нь түдгэлзүүлэх, сахилгын шийтгэл ногдуулах; 271[1].1.12.хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд гаалийн байгууллагын төсөв, хөрөнгийг захиран зарцуулах; 271[1].1.13.гаалийн байгууллагыг гадаад, дотоодод болон шүүх, арбитрт төлөөлөх; 271[1].1.14.гаалийн болон бусад татвар, хураамжийн ногдуулалт, төлөлт, хураалтад хяналт тавих; 271[1].1.15.гадаад худалдааны төлбөр тооцоонд гаалийн зорилгоор хяналт тавих; 271[1].1.16.улс хоорондын худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлыг хангах, олон улсын стандартын дагуу гаалийн удирдах төв байгууллагаас тогтоосон шалгуурыг хангасан тохиолдолд гаалийн харилцаанд оролцогчид гаалийн итгэмжлэл олгох;	12.1.4.тарифын болон тарифын бус хязгаарлалтын арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; 12.1.5.гаалийн удирдах төв байгууллагын харьяа болон дэргэдэх байгууллагыг байгуулах, өөрчлөх, татан буулгах; 12.1.6.харьяа гаалийн байгууллагын хариуцах хяналтын нутаг дэвсгэрийг тогтоох, тэдгээрийн эрх хэмжээг тодорхой бараа, тээврийн хэрэгсэл болон гаалийн бүрдүүлэлтийн горимоор хязгаарлах; 12.1.7.гаалийн байгууллагыг шүүх, арбитрт төлөөлөх; 12.1.8.гаалийн болон бусад татвар, хураамжийн ногдуулалт, төлөлт, хураалтад хяналт тавих; 12.1.9.гаалийн газар, хороо болон энэ хуулийн 6.2-т заасан байгууллагын дүрмийг батлах; 12.1.10.гаалийн улсын байцаагчийн эрх олгох, эрхийг нь түдгэлзүүлэх, сахилгын хариуцлага ногдуулах;		
1415.	271[1].1.17.хуульд заасан бусад бүрэн эрх.	12.1.11.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.		*“хуульд” гэснийг “хууль тогтоомжид” гэж өөрчилсөн*
1416.	271[1].2.Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын эзгүйд түүнийг дэд дарга орлоно.	12.2.Гаалийн удирдах төв байгууллагын даргын эзгүйд түүнийг тэргүүн дэд дарга орлоно.		*“асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэснийг “удирдах төв” байгууллага гэж өөрчилсөн*

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

1417.	**272[1] дүгээр зүйл.Төрийн бусад байгууллагатай хамтран ажиллах** 272[1].1.Гаалийн байгууллага энэ хуулийн 288, 289 дүгээр зүйлд заасан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор төрийн бусад байгууллагатай хамтран ажиллаж болно.	**9 дүгээр зүйл.Төрийн болон бусад байгууллагатай хамтран ажиллах** 9.1.Гаалийн алба нь хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор төрийн бусад байгууллагатай хамтран ажиллаж болно.		*"байгууллага энэ хуулийн 288, 289 дүгээр зүйлд заасан үйл ажиллагааны зорилтыг" гэснийг "алба нь хуулиар хүлээсэн чиг үүргээ" гэж өөрчилсөн*
1418.	272[1].2.Гаалийн байгууллага нь гаалийн хяналт хийхээс бусад үүргийг холбогдох хуулийн дагуу төрийн бусад байгууллагаар гүйцэтгүүлж болно.			*Хасагдсан*
1419.		**ХОЁРДУГААР ДЭД БҮЛЭГ ГААЛИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ**		-
1420.	**273 дугаар зүйл. Гаалийн улсын байцаагч** 273.1.Гаалийн хууль тогтоомжийн дагуу хяналт, шалгалт хийх эрх эдэлж, үүрэг хүлээх гаалийн албан тушаалтныг гаалийн улсын байцаагч гэнэ.	**16 дугаар зүйл.Гаалийн улсын байцаагч** 16.1.Гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах эрх эдэлж, үүрэг хүлээх төрийн тусгай албан тушаалтныг гаалийн улсын байцаагч гэнэ.		-
1421.	273.2.Гаалийн улсын байцаагч нь төрийн тусгай албан тушаалд хамаарна.			*Хуулийн төслийн 16.1-д орсон*
1422.	273.3.Гаалийн удирдах төв байгууллагын дарга Монгол Улсын гаалийн ерөнхий байцаагч байна.	16.2.Гаалийн удирдах төв байгууллагын дарга Гаалийн улсын ерөнхий байцаагч байна.		*"Монгол Улсын гаалийн" гэснийг "Гаалийн улсын ерөнхий" гэж өөрчилсөн*
1423.	273.4.Гаалийн улсын байцаагч нь "Гаалийн улсын байцаагч би, Монгол Улсын тусгаар тогтнол, эдийн засгийн аюулгүй байдлыг хангахын төлөө үнэнчээр зүтгэж, гаалийн хяналт, бүрдүүлэлт хийхдээ хууль, шударга ёсыг дээдлэн, гаалийн улсын байцаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, хэний ч нөлөөнд үл автахаа батлан тангараглая. Өргөсөн тангарагаас няцвал төрийн хуулийн хариуцлага хүлээнэ" гэсэн тангаргийг гаалийн улсын байцаагчийн эрх авахад өргөнө.	16.4.Гаалийн улсын байцаагч "Гаалийн улсын байцаагч би хуулийг даган мөрдөж, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхдээ гаалийн улсын байцаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, хэний ч нөлөөнд үл автахаа батлан тангараглая. Өргөсөн тангарагаасаа няцвал төрийн хуулийн хариуцлага хүлээнэ" гэсэн тангараг өргөнө.		*Өөрчлөн найруулсан*
1424.	273.5. Гаалийн улсын байцаагч нь гадаад хэлний зохих мэдлэгтэй, дээд боловсролтой Монгол Улсын иргэн байх бөгөөд гаалийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр мэргэжлийн тусгай сургалтад хамрагдсан байвал зохино.	16.5.Гаалийн улсын байцаагч нь гадаад хэлний зохих мэдлэгтэй, дээд боловсролтой, урьд нь ял шийтгүүлж байгаагүй Монгол Улсын иргэн байх бөгөөд гаалийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр мэргэшлийн чиглүүлэх сургалтад хамрагдсан байвал зохино.		*"боловсролтой" гэсний дараа ", урьд нь ял шийтгүүлж байгаагүй" гэж нэмсэн* "тусгай" гэснийг "чиглүүлэх" гэж өөрчилсөн
1425.	273.6.Гаалийн улсын байцагчийн албан тушаалд орох хүсэлтэй иргэдээс мэргэшлийн шалгалт авах болзол журмыг Төрийн албаны төв байгууллага батална.	**21 дүгээр зүйл.Гаалийн улсын байцаагчийг томилох** 21.1.Гаалийн албанд ажиллахыг хүсч буй тодорхой шаардлага хангасан иргэдээс Төрийн албаны төв байгууллагын баталсан журмын дагуу сонгон шалгаруулах замаар гаалийн албаны боловсон хүчний нөөцийг бүрдүүлнэ.		

Хууль зүйн ундэсний хүрээлэн www.nlrc.gov.mn

1426.		16.3.Гаалийн удирдах төв байгууллагын дэд дарга, нэгжийн болон дэргэдэх байгууллагын дарга, орлогч дарга, гаалийн байгууллагын дарга, орлогч дарга гаалийн улсын ахлах байцаагч байна.		
1427.		**22 дугаар зүйл.Гаалийн шалгагч** 22.1.Энэ хуулийн 21.1-д заасан нөөцөд байгаа иргэнийг гаалийн албаны хүний нөөцийн хэрэгцээ, мэргэжлийн бэлтгэлийн түвшин, томилогдох албан тушаалын онцлог зэргээс нь хамааран нэг жил хүртэлх туршилтын хугацаагаар гаалийн шалгагчаар томилж, гэрээ байгуулан ажиллуулна. 22.2.Гаалийн шалгагчийг төрийн үйлчилгээний албан тушаалд хамааруулан, тухайн албан тушаалын цалин олгоно. 22.3.Гаалийн шалгагч бие дааж гаалийн хяналт, бүрдүүлэлт хийх эрх эдлэхгүй. 22.4.Гаалийн шалгагч өвчтэй, сургалт, бусад шалтгаанаар чөлөөтэй байсан хугацааг туршилтын хугацаанд оруулан тооцохгүй. 22.5.Туршилтын хугацааг гаалийн албанд ажилласан хугацаанд оруулан тооцно. 22.6.Дор дурдсан үндэслэлээр туршилтын хугацааг дуусахаас өмнө гэрээг цуцална: 22.6.1.гэмт хэрэг, зөрчилд холбогдсон; 22.6.2.үүрэг гүйцэтгэх чадвар хангалтгүй гэж дүгнэгдсэн; 22.6.3.хоёр буюу түүнээс дээш удаа үүрэг, даалгавар биелүүлээгүй; 22.6.4.чөлөөлөгдөх хүсэлт гаргасан. 22.7.Гаалийн шалгагчийг ажиллаж байгаа гаалийн байгууллагын саналыг үндэслэн гаалийн мэргэшлийн чиглүүлэх сургалтад хамруулсаны дараа гаалийн улсын байцаагчаар томилж болно. 1. 2. 22.8.Гаалийн шалгагчийг удирдах албан тушаалд томилохыг хориглоно.		*Шинээр нэмэгдсэн*
1428.	**274 дүгээр зүйл.Гаалийн улсын байцаагчийн эрх, үүрэг**	**17 дугаар зүйл.Гаалийн улсын байцаагчийн үүрэг** **18 дугаар зүйл.Гаалийн улсын байцаагчийн эрх**		*“эрх”, “үүрэг”-ийн салгасан*
1429.	274.1.Гаалийн улсын байцаагч нь Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн нийтлэг эрхээс гадна дараахь эрх эдэлнэ: 274.1.1.энэ хуульд заасны дагуу гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавьж, бүрдүүлэлт хийх; 274.1.2.гаалийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор иргэн, албан тушаалтанд хууль ёсны шаардлага тавьж биелэлтийг хангуулах;	18.1.Гаалийн улсын байцаагч нь Төрийн албаны тухай болон бусад хуульд зааснаас гадна дараах эрх эдэлнэ: 18.1.1.гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих, бүрдүүлэлт хийх;/шалгалт оруулах/ 18.1.2.гаалийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор иргэн, албан тушаалтанд хууль ёсны шаардлага тавьж биелэлтийг хангуулах;		-
1430.		18.1.3.удирдлагаас өгсөн хууль бус үүрэг даалгаврыг биелүүлэхээс татгалзах;		*Шинээр нэмэгдсэн*

1431.	274.1.3.гаалийн бүрдүүлэлттэй холбоотойгоор аж ахуйн нэгж, байгууллагын байр, агуулахад нэвтрэн орж үзлэг тооллого хийх, тэдгээрийн данс, бүртгэлийг шалгах;			*Хасагдсан*
1432.	274.1.4.гаалийн хяналт, шалгалтад ач холбогдол бүхий бичиг баримт, тайлбар, лавлагааг холбогдох этгээдээс гаргуулан авах;	18.1.4.гаалийн хяналт, бүрдүүлэлтэд ач холбогдол бүхий бичиг баримт, тайлбар, лавлагааг холбогдох этгээдээс гаргуулан авах;		*“, шалгалтад” гэснийг “бүрдүүлэлтэд” гэж өөрчилсөн*
1433.	274.1.5.гаалийн болон бусад татвар ногдох барааг нуусныг гэрчлэх баримт, материалыг татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс түр хугацаагаар хураах, эсхүл хуулбарлуулан авах;	18.1.6.гаалийн болон бусад татвар төлөхөөс зайлсхийснийг гэрчлэх бичиг баримтыг түр хугацаагаар хураах, эсхүл хуулбарлуулан авах;		*“гаалийн болон бусад татвар ногдох барааг нуусныг гэрчлэх баримт, материалыг татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс түр” гэснийг “гаалийн болон бусад татвар төлөхөөс зайлсхийснийг гэрчлэх бичиг баримтыг түр” гэж өөрчилсөн*
1434.	274.1.6.албан үүргээ гүйцэтгэх үед улсын хилийн хориотой зүрваст нэвтрэх;	18.1.7.албан үүргээ гүйцэтгэх үед улсын хилийн хориотой зүрваст нэвтрэх;		-
1435.	274.1.7.гаалийн хууль тогтоомж зөрчсөн захиргааны зөрчилд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх.	18.1.8.гаалийн хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх;		-
1436.		18.1.5.гаалийн зорилгоор хүний бие, хувцас, хувийн эд зүйлсэд үзлэг хийх; 18.1.9.амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлаа аливаа халдлагаас хамгаалах, хамгаалуулах; 18.1.10.албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай удирдлага, зохион байгуулалт, техник хэрэгсэл, ажиллах нөхцөлөөр хангагдсан байх; 18.1.11.өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалуулах, зөрчигдсөн тохиолдолд гомдол гаргаж шийдвэрлүүлэх; 18.1.12.хууль тогтоомжид заасан бусад эрх.		*Шинээр нэмэгдсэн*

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nlic.mn

1437.	274.2.Гаалийн улсын байцаагч нь Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн нийтлэг үүргээс гадна дараахь үүрэг хүлээнэ: 274.2.1.өргөсөн тангарагтаа үнэнч, гаалийн хяналт, шалгалтыг хийхдээ сонор сэрэмжтэй байж, төр, байгууллага болон хувь хүний нууцыг чанд хадгалж, хувь хүний нэр хүндийг гутаахгүй байх; 274.2.2. гаалийн хяналт, бүрдүүлэлтийг хийхдээ төр, байгууллага, хувь хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироохгүй, албан тушаалаа урвуулан ашиглахгүй, хэтрүүлэхгүй байх; 274.2.3. гаалийн хууль тогтоомжийг зөрчсөн хууль бус үйлдэл /эс үйлдэхүй/-ийн талаар зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлэх;	17.1.Гаалийн улсын байцаагч нь бусад хуульд зааснаас гадна дараах үүргийг хүлээнэ: 17.1.1.удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврыг хуульд заасны дагуу биелүүлж, гаалийн зөрчилтэй тэмцэх; 17.1.2.ажил үүргээ биелүүлэх явцдаа хууль тогтоомжийг чанд сахиж, хүний эрх, эрх чөлөө, нэр төрийг хүндэтгэн, хүнлэг харьцах; хамгийн эхэнд байх; 17.1.3.бие даан гаргасан шийдвэрийнхээ дагуу хийсэн үйлдэл, эс үйлдэхүйн төлөө хариуцлага хүлээх; 17.1.4.үйлчлүүлэгчийн зүй ёсны шаардлага, санал, хүсэлтийг цаг алдалгүй шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;		*Өөрчлөн найруулсан*
1438.	274.2.4.мэргэшлийн сургалтад хамрагдах;	17.1.5.албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, мэргэшлийн түвшингээ тогтмол ахиулах;		*Өөрчлөн найруулсан*
1439.	274.2.5.гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрмийг чанд сахиж ажиллах.			*Хасагдсан*
1440.	274.3. Гаалийн улсын байцаагчийг гаалийн газар, хороодод 2 жил хүртэл хугацаагаар сэлгэн ажиллуулж болно.	**23 дугаар зүйл.Гаалийн улсын байцаагчийг сэлгэн ажиллуулах** 23.1.Гаалийн улсын байцаагчийг ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх болон албан ажлын шаардлага, эрүүл мэндийн байдал, өөрийн хүсэлтийг үндэслэн гаалийн байгууллага хооронд сэлгэн ажиллуулж болно. 23.2.Гаалийн улсын байцаагчийг сэлгэн ажиллуулах журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батлаж, мөрдүүлнэ.		
1441.	274.4. Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрмийг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.			*Хасагдсан*

ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ХҮРЭЭЛЭН
www.legal.gov.mn

1442.		**19 дүгээр зүйл.Гаалийн улсын ерөнхий байцаагч, гаалийн улсын ахлах байцаагчийн бүрэн эрх** 19.1.Гаалийн улсын ерөнхий байцаагч энэ хуулийн 18.1-д заасан эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 19.1.1.Гаалийн бүрдүүлэлтийн дараах аудитын удирдамж батлах; 19.1.2.гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалтын удирдамж батлах 19.1.2.гаалийн улсын ахлах байцаагчийн гаргасан шийдвэр, үйл ажиллагаа, хяналт, шалгалттай холбогдуулан гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх; 19.1.3.гаалийн улсын байцаагчийн тогтоосон акт, дүгнэлт, бусад шийдвэрийг хуулийн хүрээнд хянан үзэж, өөрчлөх хүчихгүй болгох; 19.1.4 19.2.Гаалийн улсын ахлах байцаагч энэ хуулийн 18.1-д заасан эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 19.2.1. 19.2.2 19.2.3.гаалийн улсын байцаагчийн гаргасан шийдвэр, үйл ажиллагаа, хяналт, шалгалттай холбогдуулан гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх		
1443.	**275 дугаар зүйл. Гаалийн улсын байцаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл**	**20 дугаар зүйл.Гаалийн улсын байцаагчид хориглох зүйл**		
1444.	275.1. Гаалийн улсын байцаагч Төрийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлд зааснаас гадна дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 275.1.1. улс төрийн намын гишүүн байх;	20.1.Гаалийн улсын байцаагчид Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хуульд зааснаас гадна дараах зүйлийг хориглоно: 20.1.1.албан үүрэгтэйгээ холбоогүйгээр гаалийн хяналт, бүрдүүлэлт, шалгалт хийх;		*Өөрчлөн найруулсан*
1445.	275.1.2. өөрийн нь гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүмүүсийн гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт, бүрдүүлэлт хийх, эсхүл уг үйл ажиллагаанд оролцох, нөлөөлөх;	20.1.2.өөрийн гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүмүүсийн гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт, бүрдүүлэлт хийх, эсхүл уг үйл ажиллагаанд оролцох, нөлөөлөх;		-
1446.	275.1.3.энэ хуульд зааснаас бусад мэдээлэл шаардах, иргэдэд чирэгдэл учруулах, бусдад давуу байдал олгох зэргээр ялгаварлах; 275.1.4.албан үүрэгтэйгээ холбоогүйгээр гаалийн хяналт тавих, шалгалт хийх.	20.1.3.хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдах; эхэнд 20.1.4.албан тушаал, байгууллагын нэрээр бусдыг эрхшээлдээ оруулах, дарамтлах; 20.1.5.удирдах албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр албаны болон бусдын эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол, нэр төрд хохирол учруулж болзошгүй мэдээ, мэдээллийг нийтэд болон бусдад мэдээлэх; 20.1.6.улс төрийн зорилгоор эвлэлдэн нэгдэх, улс төрийн аливаа үйл ажиллагаа явуулдаг нам, эвсэл, холбоо, үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх, тэдгээрийн үйл ажиллагаа, улс төрийн үзэл баримтлалыг сурталчлах, дэмжлэг үзүүлэх; 20.1.7.ажил хаях, гаалийн албаны хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн бусад арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцох.		*Өөрчлөн найруулсан*

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.legal.mn

1447.	**276 дугаар зүйл. Дүрэмт хувцас, ялгах тэмдэг** 276.1. Гаалийн улсын байцаагч дүрэмт хувцас, ялгах тэмдэг хэрэглэх, эсхүл хувцасны хангамж эдэлнэ. 276.2. Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийн загвар, эдэлгээний хугацаа, хэрэглэх журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална. 276.3.Бусад байгууллага, иргэн гаалийн улсын байцаагчийнхтай ижил загварын дүрэмт хувцас, ялгах тэмдэг хэрэглэхийг хориглоно.	28.1.Гаалийн улсын байцаагч нь албан үүргээ гүйцэтгэхдээ дүрэмт хувцас, ялгах тэмдэг, удирдах төв байгууллагаас олгосон хувийн дугаар бүхий тэмдэг, энгэрийн зүүлт хэрэглэнэ. 28.2.Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийн загвар, эдэлгээний хугацаа, хэрэглэх журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална. 28.3.Бусад байгууллага, иргэн гаалийн улсын байцаагчийнхтай ижил загварын дүрэмт хувцас, ялгах тэмдэг хэрэглэхийг хориглоно.		
1448.	**277 дугаар зүйл. Гаалийн байгууллагын тусгай хэрэгсэл, мэх** 277.1.Гаалийн улсын байцаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ дараахь тусгай хэрэгсэл, мэх хэрэглэж болно: 277.1.1.нэг бүрийн тусгай хэрэгсэл; 277.1.2.тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл; 277.1.3.хамгаалах тусгай хэрэгсэл;	**29 дүгээр зүйл.Тусгай хэрэгсэл, мэх** 29.1.Гаалийн улсын байцаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ дараах тусгай хэрэгсэл, мэх хэрэглэж болно: 29.1.1.нэг бүрийн тусгай хэрэгсэл; 29.1.2.тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл; 29.1.3.хамгаалах тусгай хэрэгсэл;		-
1449.	277.1.4.самбо, каратэ зэрэг зэвсэггүйгээр тулалдах мэх;	29.1.4.бие хамгаалах зэвсэггүйгээр тулалдах мэх;		*“самбо, каратэ зэрэг” гэснийг “бие хамгаалах” гэж өөрчилсөн*
1450.	277.1.5.албаны нохой.	29.1.5.албаны нохой.		
1451.	**278 дугаар зүйл.Тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх** 278.1.Дараахь тохиолдолд тусгай хэрэгсэл, мэх хэрэглэж болно: 278.1.1.гаалийн улсын байцаагчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсон;	**30 дугаар зүйл.Тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх** 30.1.Дараах тохиолдолд тусгай хэрэгсэл, мэх хэрэглэж болно: 30.1.1.гаалийн улсын байцаагчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байдал үүссэн;		*“байдлаар довтолсон” гэснийг “байдал үүссэн” гэж өөрчилсөн*

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nlib.gov.mn

1452.	278.1.2.гаалийн улсын байцаагчийн хууль ёсны шаардлагыг зориуд биелүүлээгүй, эсхүл хүч хэрэглэн эсэргүүцсэн; 278.1.3.хураагдсан, барьцаанд авсан болон гаалийн хяналтад байгаа бараа, тээврийн хэрэгслийг гаалийн нэг байгууллагаас нөгөөд, эсхүл холбогдох бусад байгууллагад хүргэх явцад эсэргүүцэл үзүүлсэн. 278.2.Дараахь тохиолдолд тээврийн хэрэгсэл албадан зогсоох тухай хэрэгсэл хэрэглэж болно: 278.2.1.гаалийн шалгалт дуусаагүй байхад гаалийн байгууллагын зөвшөөрөлгүй хөдлөгөөн; 278.2.2.бараг гаалийн хилээр хууль бусаар нэвтрүүлэх зорилгоор гаалийн хяналтаас зугтсан. 278.3.Тухай хэрэгсэл, мэх хэрэглэснээс хүний амь бие, эрүүл мэндэд гэмтэл учруулсан тохиолдолд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх арга хэмжээ авч, энэ тухай гаалийн байгууллагын даргад, дарга нь прокурор нэн даруй мэдэгдэнэ. 278.4.Энэ хуулийн 277.1-д заасан тусгай хэрэгслийн жагсаалт, хэрэглэх, хадгалах зааврыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн гаалийн байгууллагын дарга батална.	30.1.2.гаалийн улсын байцаагчийн хууль ёсны шаардлагыг зориуд биелүүлээгүй, эсхүл хүч хэрэглэн эсэргүүцсэн; 30.1.3.хураагдсан, барьцаанд авсан болон гаалийн хяналтад байгаа бараа, тээврийн хэрэгслийг гаалийн нэг байгууллагаас нөгөөд, эсхүл холбогдох бусад байгууллагад хүргэх явцад эсэргүүцэл үзүүлсэн. 30.2.Дараах тохиолдолд тээврийн хэрэгсэл албадан зогсоох тухай хэрэгсэл хэрэглэж болно: 30.2.1.гаалийн шалгалт дуусаагүй байхад тээврийн хэрэгслийг гаалийн байгууллагын зөвшөөрөлгүй хөдлөгөөн; 30.2.2.бараг гаалийн хилээр хууль бусаар нэвтрүүлэх зорилгоор гаалийн хяналтаас зугтсан. 30.3.Тухай хэрэгсэл, мэх хэрэглэснээс хүний амь бие, эрүүл мэндэд гэмтэл учруулсан тохиолдолд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх арга хэмжээ авч, энэ тухай гаалийн байгууллагын даргад, дарга нь прокурор нэн даруй мэдэгдэнэ. 30.4.Энэ хуулийн 29.1, 30.2 дахь хэсэгт заасан тусгай хэрэгслийн жагсаалт, хэрэглэх, хадгалах зааврыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.		-
1453.	**279 дүгээр зүйл.Гаалийн улсын байцаагчийн албан тушаалын ангилал**	**26 дугаар зүйл.Гаалийн улсын байцаагчийн албан тушаалын ангилал, зэрэг дэв**		*"ангилал" гэсний дараа ", зэрэг дэв" гэж нэмсэн*

ХУУЛЬ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН
www.legalinfo.gov.mn

1454.	279.1.Гаалийн улсын байцаагчийн албан тушаал дараахь ангилалтай байна: 279.1.1.тэргүүн түшмэл; 279.1.2.эрхэлсэн түшмэл; 279.1.3.ахлах түшмэл; 279.1.4.дэс түшмэл; 279.1.5.туслах түшмэл. 279.2.Тэргүүн түшмэлийн албан тушаалд гаалийн удирдах төв байгууллагын дарга хамаарна. 279.3.Эрхэлсэн түшмэлийн албан тушаалд гаалийн удирдах төв байгууллагын дэд дарга хамаарна. 279.4.Ахлах түшмэлийн албан тушаалд гаалийн удирдах төв байгууллагын бүтцийн нэгжийн дарга, харьяа гаалийн газрын дарга хамаарна. 279.5.Дэс түшмэлийн албан тушаалд гаалийн удирдах төв байгууллагын гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн удирдах төв байгууллагын дэргэдэх байгууллагын дарга, хороо, алба, салбарын дарга хамаарна. 279.6.Туслах түшмэлийн албан тушаалд удирдах төв байгууллагын гаалийн улсын байцаагч, харьяа гаалийн газар, хорооны гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч хамаарна.	26.1.Гаалийн улсын байцаагчийн албан тушаал дараах ангилалтай байна: 26.1.1.тэргүүн түшмэл; 26.1.2.эрхэлсэн түшмэл; 26.1.3.ахлах түшмэл; 26.1.4.дэс түшмэл; 26.1.5.туслах түшмэл. 26.2.Тэргүүн түшмэлийн албан тушаалд гаалийн удирдах төв байгууллагын дарга хамаарна. 26.3.Эрхэлсэн түшмэлийн албан тушаалд гаалийн удирдах төв байгууллагын дэд дарга хамаарна. 26.4.Ахлах түшмэлийн албан тушаалд гаалийн удирдах төв байгууллагын бүтцийн нэгжийн дарга, гаалийн удирдах төв байгууллагын дэргэдэх байгууллагын дарга, харьяа гаалийн газрын дарга хамаарна. 26.5.Дэс түшмэлийн албан тушаалд гаалийн удирдах төв байгууллагын гаалийн улсын ахлах байцаагч, харьяа газрын орлогч дарга, хороо, салбар, албаны дарга хамаарна. 26.6.Туслах түшмэлийн албан тушаалд удирдах төв байгууллагын гаалийн улсын байцаагч, харьяа гаалийн газар, хорооны гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч хамаарна.		
1455.	**280 дугаар зүйл.Гаалийн улсын байцаагчийн зэрэг дэв, шагнал, урамшуулал** 280.1.Гаалийн тэргүүн түшмэл, эрхэлсэн түшмэл, ахлах түшмэл, дэс түшмэл, туслах түшмэлийн албан тушаал нь тус бүртээ тэргүүн, дэд, гутгаар, дөтгөөр гэсэн зэрэг дэвтэй байна. 280.2.Гаалийн тэргүүн түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг Монгол Улсын Ерөнхийлөгч, эрхэлсэн түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг Монгол Улсын Ерөнхий сайд, ахлах түшмэл, дэс түшмэл, туслах түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг гаалийн удирдах төв байгууллагын дарга тус тус олгоно. 280.3.Зэрэг дэв олгохдоо төрийн албанд нийт ажилласан болон тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, мэргэшлийн түвшин, ёс зүйн хэм хэмжээг сахиж буй байдлыг харгалзана. 280.4.Гаалийн улсын байцаагчийн зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална. 280.5.Гаалийн улсын байцаагчид ажлын үр дүнгийн шагнал улирал тутам олгох бөгөөд уг шагналыг олгох журмыг Засгийн газар батална. 280.6.Далд арга хэрэглэж бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлсэн буюу нэвтрүүлэхийг завдсан, эсхүл удаа дараагийн буюу хоорондоо нууцлагдмал холбоо бүхий их хэмжээний зөрчил илрүүлсэн, түүнчлэн зөрчил илрүүлж улсын төсөвт их буюу онц их хэмжээний орлого оруулсан гаалийн улсын байцаагчид мөнгөн урамшуулал олгох бөгөөд уг урамшуулын хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.	26.7.Гаалийн тэргүүн түшмэлийн албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг Монгол Улсын Ерөнхий сайд, эрхэлсэн түшмэлийн албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг гаалийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, ахлах түшмэл, дэс түшмэл, туслах түшмэлийн албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг гаалийн удирдах төв байгууллагын дарга тус тус батална.		*Өөрчлөн найруулсан*

ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ХУРЭЭЛЭН

1456.	**281 дүгээр зүйл.Гаалийн улсын байцаагчийн цол** 281.1. Гаалийн улсын байцаагчид дараахь цол олгож болно: 281.1.1.гаалийн жинхэнэ зөвлөх; 281.1.2.гаалийн итгэмжит зөвлөх; 281.1.3.гаалийн зөвлөх.	**27 дугаар зүйл.Гаалийн улсын байцаагчийн мэргэшлийн цол** 27.1.Гаалийн улсын байцаагчид дараах цол олгож болно: 27.1.1.гаалийн жинхэнэ зөвлөх; 27.1.2.гаалийн итгэмжит зөвлөх; 27.1.3.гаалийн зөвлөх.**2**		*Зүйлийн гарчгийн “байцаагчийн” гэсний дараа “мэргэшлийн” гэж нэмсэн*
1457.	281.3.Гаалийн улсын байцаагчид цол, түүний нэмэгдэл олгох журмыг гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.	27.2.Гаалийн улсын байцаагчид цол, түүний нэмэгдэл олгох журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.**1**		*“гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэснийг “гаалийн удирдах төв” гэж өөрчилсөн*
1458.		**ГУРАВДУГААР ДЭД БҮЛЭГ ГААЛИЙН АЛБА ХААГЧИЙН БАТАЛГАА**		
1459.	**282 дугаар зүйл.Гаалийн улсын байцаагчийн эрхийн баталгаа** 282.1.Гаалийн улсын байцаагч албан үүргээ хараат бусаар, шударгаар биелүүлэх нөхцөл, баталгааг төр хангана. 282.2.Гаалийн байгууллага гаалийн улсын байцаагчаар хуулиар хүлээлгэсэн үүрэгт нь үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.	**33 дугаар зүйл.Гаалийн улсын байцаагчийн эрхийн баталгаа** 33.1.Гаалийн улсын байцаагч албан үүргээ хараат бусаар, шударгаар биелүүлэх нөхцөл, баталгааг төр хангана. 33.3.Гаалийн байгууллага гаалийн улсын байцаагчаар хуулиар хүлээсэн үүрэгт нь үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.		
1460.	282.3.Эрх бүхий байгууллага нь гаалийн улсын байцаагчийг албан үүрэгтэй нь холбогдуулан шалгах бол гаалийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байх үүднээс энэ тухай харьяалах гаалийн байгууллагын даргад урьдчилан мэдэгдэнэ.	33.4.Эрх бүхий байгууллага нь гаалийн улсын байцаагчийг албан үүрэгтэй нь холбогдуулан шалгах бол гаалийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байх үүднээс энэ тухай харьяалах гаалийн байгууллагын даргад урьдчилан мэдэгдэжтохирсон байна.		
1461.	282.4.Хуулиар хүлээлгэсэн албан үүрэгтэй нь холбоотойгоор заналхийлэх, сүрдүүлэх, амь бие, эрүүл мэндэд нь халдах аливаа хууль бус үйлдлээс гаалийн улсын байцаагч, түүний гэр бүлийн гишүүдийг төр хамгаална.	33.2.Хуулиар хүлээсэн албан үүрэгтэй нь холбоотойгоор заналхийлэх, сүрдүүлэх, амь бие, эрүүл мэндэд нь халдах аливаа хууль бус үйлдлээс гаалийн улсын байцаагч, түүний гэр бүлийн гишүүдийг төр хамгаална.		
1462.	282.5.Гаалийн байгууллагад 25-аас дээш жил ажиллаж өндөр насны тэтгэвэр тогтоолгож байгаа гаалийн улсын байцаагчид сүүлийн 3 жилийн албан тушаалын цалингийн хэмжээтэй тэнцэх нэг удаагийн тэтгэмж олгоно.			
1463.		33.5.Гаалийн улсын байцаагчийг ажлын үр дүн, ёс зүй, мэргэшил, ур чадварын түвшинг харгалзан албан тушаал дэвшүүлнэ. 33.6.Гаалийн улсын байцаагчаас хууль тогтоомжийн дагуу тавьсан шаардлагыг гаалийн харилцаанд оролцогч заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд биелүүлээгүй тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. 33.7.Гаалийн улсын байцаагчийн хууль ёсны үйл ажиллагаанд иргэн, албан тушаалтан хэн боловч хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно.		*Шинээр нэмэгдсэн*

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.legal.mn

1464.	282.6.Гаалийн улсын байцаагчид дараахь тусламж олгоно:	**35 дугаар зүйл.Нийгмийн баталгаа** 35.1.Гаалийн албаны алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэнд нь хохирсон тохиолдолд хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмжээс гадна дараах нөхөх төлбөр олгоно:		*Өөрчлөн найруулсан*
1465.	282.6.1.хөдөлмөрийн чадвараа түр алдсан тохиолдолд эмнэлгийн чөлөөтэй байсан хугацааны тэтгэмж, албан тушаалын үндсэн цалингийн зөрүү;			*Хасагдсан*
1466.	282.6.2.тахир дутуу болсон тохиолдолд тахир дутуугийн тэтгэвэр, албан тушаалын үндсэн цалингийн зөрүү;			*Хасагдсан*
1467.	282.6.3.хиймэл эрхтэн хийлгэх тохиолдолд түүний зардал;	35.1.2.хиймэл эрхтэн хийлгэсэн бол түүний зардлыг;		
1468.	282.6.4.эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн тохиолдолд эрүүл мэндийн даатгалын зардлаас хэтэрсэн эмчилгээний зардал;	35.1.3.эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн тохиолдолд эрүүл мэндийн даатгалын зардлаас хэтэрсэн эмчилгээний зардал;		-
1469.	282.6.5.хөдөлмөрийн чадвараа бүрмөсөн алдсан тохиолдолд нэг жилийн албан тушаалын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж;	35.1.1.хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээнээс шалтгаалан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30, 60, 90 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн нөхөх төлбөр;		*Өөрчлөн найруулсан*
1470.	282.6.6.албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан гаалийн улсын байцаагчийн амь насыг хохироосон тохиолдолд түүний ар гэрт 3 жилийн албан тушаалын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж. 282.7.Хил дээр ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчийн гэр бүлийг тэргүүн ээлжинд ажлаар хангах бөгөөд тэднийг ажлаар хангаагүй нөхцөлд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон өндөр насны тэтгэврийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож гаалийн байгууллага төлнө. 282.8.Хил дээр ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчид хилийн нэмэгдэл олгох бөгөөд уг нэмэгдэл олгох журмыг Засгийн газар батална. 282.9.Гаалийн байгууллагад тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажилласан албан хаагчид аминдаа орон сууц барих болон орон сууц, амьдралын нэн тэргүүний хэрэгцээт зүйлс худалдан авах, өөрийн хүсэлтээр суралцах болон хүүхдээ сургахад нь зориулан байгууллагаас нь хөнгөлөлттэй зээл олгож, шаардлагатай тохиолдолд зээлийн баталгаа гаргаж өгнө.	34.4.Гаалийн улсын байцаагчийн суурин бус хилийн боомтод ажилласан нэг жилийг нэг жил гурван сар ажилласанд тооцно 34.5.Хилийн боомтод таваас доошгүй жил ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчид нэг удаагийн мөнгөн урамшууллыг тэдний сарын үндсэн цалингаас суурин бус газар байрладаг хилийн боомтод 50 хувь, нийслэл, аймгийн төв, улсын чанартай хотоос бусад суурин газарт байрладаг хилийн боомтод 35 хувь, нийслэл, аймгийн төв, улсын чанартай хотод байрладаг хилийн боомтод 25 хувиар бодож нэгтгэн таван жил тутамд олгоно.		*Хасагдсан*

хуулийн зүйл хүчингүй хүрээлэн www.mn

1471.		35.2.Энэ хуульд заасан нөхөх төлбөр, тусламж олгох журмыг Засгийн газар батална. 35.3.Гаалийн албанд ажилласан нэг жилийг нэг жил зургаан сар ажилласанд тооцож, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хуульд заасны дагуу тухайн иргэнд өндөр насны тэтгэвэр тогтоож болно. 35.4.Гаалийн улсын байцаагчийн иргэний байгууллагад ажилласан нэг жилийг зургаан сар гаалийн албанд ажиллан шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцож гаалийн алба хаасны тэтгэвэр тогтоож болно. 35.3.Гаалийн улсын байцаагчийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг жил бүр зохион байгуулах бөгөөд зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.		*Шинээр нэмэгдсэн*
1472.		**31 дүгээр зүйл.Гаалийн албаны бусад алба хаагчид** 31.1.Гаалийн алба нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах чиг үүрэг бүхий захиргааны болон үйлчилгээний ажилтантай байж болно. 31.2.Энэ хуулийн 31.1-д заасан ажилтны эрх зүйн байдлыг Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулна.		*Шинээр нэмэгдсэн*
1473.		**32 дугаар зүйл.Гаалийн албанд алба хаах нас** 32.1.Гаалийн албанд алба хаах насны дээд хязгаар нь гүйцэтгэх албан тушаалд эмэгтэй 55 нас, эрэгтэй 60 нас, удирдах албан тушаалд эмэгтэй 60 нас, эрэгтэй 65 нас байж болно. 32.2.Гаалийн алба нь насны дээд хязгаарт хүрч албанаас чөлөөлөгдсөн иргэнийг гаалийн албаны үйл ажиллагаанд туслах үүрэг бүхий ажилд ажиллуулж болно. 32.3.Гаалийн байгууллагад 25 жил ажилласан гаалийн улсын байцаагч өөрөө хүсэлт гаргасан тохиолдолд энэ хуулийн 32.1-д заасан насны хязгаараас өмнө тэтгэвэрт гарах эрх үүснэ.		*Шинээр нэмэгдсэн*
1474.		**36 дугаар зүйл.Гаалийн алба хаасны тэтгэврийн хэмжээ** 36.1.Ггаалийн алба хаасны тэтгэврийг гаалийн улсын байцаагчийн сарын дундаж цалин хөлсний 80 хувиар тогтооно. 36.2.Гаалийн алба хаасны тэтгэврийн доод хэмжээ нь Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас багагүй байна.		*Шинээр нэмэгдсэн*

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМ ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН www.zalgov.mn

1475.	**283 дугаар зүйл. Гаалийн улсын байцаагчийн цалин хөлс** 283.1.Гаалийн улсын байцаагчийн цалин хөлс нь албан тушаалын үндсэн цалин, албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, эрдмийн зэргийн нэмэгдлээс тус тус бүрдэнэ.	**34 дүгээр зүйл.Эдийн засгийн баталгаа** 34.1.Гаалийн улсын байцаагчийн цалин хөлс нь албан тушаалын үндсэн цалин, ажлын үр дүнгийн шагнал, албан ажлын онцгой нөхцөлийн, хилийн, төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, докторын, мэргэшлийн зэргийн нэмэгдлээс тус тус бүрдэнэ.		*“үндсэн цалин,” гэсний дараа “ажлын үр дүнгийн шагнал,” гэж, “нөхцөлийн,” гэсний дараа “хилийн” гэж, тус тус нэмсэн. “эрдмийн” гэснийг “докторын, мэргэшлийн” гэж өөрчилсөн*
1476.	283.2.Энэ хуулийн 283.1-д заасан албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацаагы, эрдмийн зэргийн нэмэгдлийн хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.	34.2.Энэ хуулийн 34.1-д заасан албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, эрдмийн зэргийн нэмэгдлийн хэмжээ, түүнийг олгох журмыг Засгийн газар батална.		-
1477.		34.3.Энэ хуулийн 34.1-д заасан ажлын үр дүнгийн шагнал олгох журмыг Засгийн газар батална. 34.6.Нийгэмд аюултай нөхцөл байдал үүссэн болон онцгой нөхцөлд үүрэг гүйцэтгэсэн тохиолдолд гаалийн албаны алба хаагчид албан тушаалын цалинг ажилласан цаг тутамд хоёр дахин нэмэгдүүлж олгоно. 34.7.Нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод ажиллахаар томилогдсон алба хаагчид уналга, ачаа тээш, зам хоногийн зардал, түүний гэр бүлийн болон асрамжид нь байдаг хүмүүст уналга, ачаа тээшийн зардлыг олгоно. 34.8.Далд арга хэрэглэж бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлсэн буюу нэвтрүүлэхийг завдсан, эсхүл удаа дараагийн буюу хоорондоо нууцлагдмал холбоо бүхий их хэмжээний зөрчил илрүүлсэн, түүнчлэн зөрчил илрүүлж улсын төсөвт их буюу онц их хэмжээний орлого оруулсан гаалийн улсын байцаагчид мөнгөн урамшуулал олгох бөгөөд уг урамшууллын хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.		*Шинээр нэмэгдсэн*
1478.		**24 дүгээр зүйл.Гаалийн улсын байцаагчийн ёс зүй, сахилгын шийтгэл** 24.1.Гаалийн алба нь алба хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчлийн талаар санал дүгнэлт гаргах эрх бүхий ёс зүйн хороотой байна. 24.2.Гаалийн улсын байцаагчийн сахилга, ёс зүйн дүрэм болон Ёс зүйн хорооны ажиллах журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална. 24.3.Ёс зүйн хороонд гаалийн албаны ахмадын хорооны болон олон нийтийн төлөөллийг оролцуулж болно.		*Шинээр нэмэгдсэн*

ХУУЛЬ ЗҮЙН ХУДАЛДАН АВАЛЦАЛЫН ХҮРЭЭЛЭН
www.tuz.gov.mn

1479.	**284 дүгээр зүйл Сахилгын шийтгэл** 284.1.Гаалийн улсын байцаагч албан үүрэгтээ хайнга хандсан, эсхүл энэ хуулийн 60.3-т зааснаас өөр бичиг баримт мэдүүлэгчээс шаардах болон бусад хэлбэрээр бүрэн эрхээ хэтрүүлсэн, түүнчлэн гаалийн хууль тогтоомж, өргөсөн тангарагаа зөрчсөн тохиолдолд дараахь сахилгын шийтгэлийг ногдуулна:	24.4.Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрэм, үйлчилгээний стандартыг зөрчсөн гаалийн улсын байцаагчид гаалийн удирдах төв байгууллагын дарга дор дурдсан сахилгын шийтгэл хүлээлгэнэ:		*Өөрчлөн найруулсан*
1480.	284.1.1.сануулах;	24.4.1.сануулах;		-
1481.	284.1.2.зэрэг дэвийг 1 жил хүртэл хугацаагаар бууруулах;	24.4.3.зэрэг дэв бууруулах;		“дэвийг 1 жил хүртэл хугацаагаар” гэснийг хассан
1482.		24.4.2.албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;		*Шинээр нэмэгдсэн*
1483.	284.1.3.албан тушаалыг 3 сар хүртэл хугацаагаар бууруулах;	24.4.4.албан тушаал бууруулах;		*“тушаалыг 3 сар хүртэл хугацаагаар” гэснийг “тушаал” гэж өөрчилсөн*
1484.	284.1.4.гаалийн улсын байцаагчийн эрхийг хасах;			*Хасагдсан*
1485.	284.1.5.гаалийн албанаас халах.	24.4.5.гаалийн албанаас халах.		*Шинээр нэмэгдсэн*
1486.	284.2.Энэ хуулийн 284.1-д заасан сахилгын шийтгэлийг гаргасан зөрчлийн шинж байдлыг харгалзан ногдуулах бөгөөд сахилгын шийтгэлийг дэс дараалан хэрэглэх шаардлагагүй.	24.5.Энэ хуулийн 24.4-д заасан шийтгэлийг зөрчлийн шинж байдлыг харгалзан хүлээлгэх бөгөөд уг шийтгэлийг дэс дараалан хүлээлгэх шаардлагагүй.		*“ногдуулах” гэснийг “хүлээлгэх” гэж, “хэрэглэх” гэснийг “хүлээлгэх” гэж өөрчилсөн тус тус өөрчилсөн*
1487.	284.3.Гаалийн улсын байцаагчийн сахилгын дүрмийг Засгийн газар батална.			*Хасагдсан*
1488.	284.4.Гаалийн удирдах төв байгууллагын харьяа газар, хорооны болон дэргэдэх байгууллагын дарга энэ хуулийн 284.1.1, 284.1.2-т заасан сахилгын шийтгэл ногдуулж болно.			*Хасагдсан*
1489.		24.6.Гаалийн улсын байцаагч сэлгэн ажиллуулах шийдвэрийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хэрэгжүүлээгүй нь түүнд сахилгын шийтгэл хүлээлгэх, албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно.		*Шинээр нэмэгдсэн*
1490.		**25 дугаар зүйл.Гаалийн албанаас халах** 25.1.Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хуульд зааснаас гадна дор дурдсан тохиолдолд гаалийн улсын байцаагчийг гаалийн албанд эргэж орох эрхгүйгээр хална: 25.1.1.энэ хуулийн 20.1.3, 207.1.4, 20.1.6, 20.1.7-д заасныг зөрчсөн нь нотлогдсон; 25.1.2.Гаалийн улсын байцаагчийн сахилга, ёс зүйн дүрэм, үйлчилгээний стандарт, хөдөлмөрийн дотоод журмыг зөрчиж нэг жилийн дотор хоёр ба түүнээс дээш удаа сахилгын шийтгэл хүлээсэн; 25.1.3.Энэ хуулийн 17.4-т заасан шаардлагыг хангаагүй болох нь сүүлд илэрсэн.		*Шинээр нэмэгдсэн*

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.mi.gov.mn

1491.	**285 дугаар зүйл.Гаалийн байгууллагыг байраар хангах** 285.1.Гаалийн байгууллага нь төрийн өмчийн барилга байгууламжид үйл ажиллагаагаа явуулах ба бусдын эзэмшлийн байрыг гэрээний үндсэн дээр төлбөртэй ашиглаж болно. 285.2.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь өөрийн нутаг дэвсгэрт ажиллах гаалийн байгууллагад хууль тогтоомжийн дагуу эзэмшлийн газар олгож, холбоо, эрчим хүч, дулаанаар саадгүй үйлчилж, үйл ажиллагаагаа явуулах хэвийн нөхцөлөөр хангана.	**15 дугаар зүйл.Гаалийн байгууллагыг байраар хангах** 15.1.Гаалийн байгууллага нь төрийн өмчийн барилга байгууламжид үйл ажиллагаагаа явуулах ба бусдын эзэмшлийн байрыг гэрээний үндсэн дээр үнэ төлбөргүй ашиглана. 15.2.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь өөрийн нутаг дэвсгэрт ажиллах гаалийн байгууллагад хууль тогтоомжийн дагуу эзэмшлийн газар олгож, холбоо, эрчим хүч, дулаанаар саадгүй үйлчилж, үйл ажиллагаагаа явуулах хэвийн нөхцөлөөр хангана.		*“төлбөртэй ашиглаж болно.” гэснийг “үнэ төлбөргүй ашиглана.” гэж өөрчилсөн*
1492.	**286 дугаар зүйл.Гаалийн байгууллагын байршил, ажиллах цагийн хуваарь** 286.1.Гаалийн удирдах төв байгууллагын дарга нь гаалийн байгууллагын байршил, ажиллах цагийн хуваарийг гадаад худалдаанд дэмжлэг үзүүлэх хэрэгцээг харгалзан тогтооно.	**14 дүгээр зүйл.Гаалийн байгууллагын байршил, ажиллах цагийн хуваарь** 14.1.Гаалийн байгууллагын байршил, ажиллах цагийн хуваарийг гаалийн удирдах төв байгууллагын дарга тогтооно.		*Өөрчлөн найруулсан*
1493.	286.2.Хилийн боомт болон олон улсын нисэх буудал дээр байрлаж байгаа гаалийн байгууллагын ажиллах цагийн хуваарийг тухайн хилийн боомтын ажиллах цагийн хуваарьтай нийцүүлэн тогтооно.	14.2.Хилийн боомт болон олон улсын нисэх буудал дээр байрлаж байгаа гаалийн байгууллагын ажиллах цагийн хуваарийг тухайн хилийн боомтын ажиллах цагийн хуваарьтай нийцүүлэн тогтооно.		
1494.	286.3.Гаалийн бүрдүүлэлтийг энэ хуулийн 25.1-д заасан хугацаанд хийх боломжгүй тохиолдолд гаалийн газар, хорооны даргын шийдвэрээр гаалийн улсын байцаагчийг ажлын бус цагаар ажиллуулж болох бөгөөд энэ тохиолдолд гаалийн байцаагчид Хөдөлмөрийн тухай хууль заасан журмын дагуу илүү цагийн хөлс олгоно.	14.3.Гаалийн бүрдүүлэлтийг энэ хуулийн 15.1-д заасан хугацаанд хийх боломжгүй тохиолдолд гаалийн газар, хорооны даргын шийдвэрээр гаалийн улсын байцаагчийг ажлын бус цагаар ажиллуулж болно.		*“болох бөгөөд энэ тохиолдолд гаалийн байцаагчид Хөдөлмөрийн тухай хуульд заасан журмын дагуу илүү цагийн хөлс олгоно.” гэснийг “болно.” гэж өөрчилсөн.*
1495.	**Нэгдүгээр дэд бүлэг Мэдээллийн систем, мэдээллийн технологийг гаалийн үйл ажиллагаанд ашиглах**	**ЗУРГАДУГААР БҮЛЭГ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ ГААЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД АШИГЛАХ**	**7 ДУГААР БҮЛЭГ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ АШИГЛАХ**	
1496.		**23 дугаар зүйл. Мэдээллийн технологийн нэр томъёоны тодорхойлолт**		
1497.		23.1.Энэ бүлэгт хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:		*Шинээр нэмэгдсэн*
1498.		23.1.1.“гаалийн цахим мэдээллийн сан” гэж харилцан уялдаатай, тодорхой бүтэц, дүрмээр бүрдүүлсэн гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгдэх цахим мэдээллийн нэгдлийг;		
1499.		23.1.2.“гаалийн цахим мэдээллийн систем” гэж гаалийн байгууллагын ашиглаж байгаа мэдээллийг хайх, цуглуулах, боловсруулах, хадгалах, авах, дамжуулах, түгээх зориулалттай компьютерийн сүлжээ, програмын цогцыг;		

1500.		23.1.3.“гаалийн цахим сүлжээ” гэж гаалийн үйл ажиллагааг хэвийн тасралтгүй, найдвартай үргэлжлүүлэх зорилгоор цахим мэдээллийг солилцох боломжтой харилцан холбогдсон компьютерийг.		
1501.	**288 дугаар зүйл.Мэдээллийн систем, сүлжээ, технологи ашиглах**	**24 дүгээр зүйл.Гаалийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи ашиглах**	**7.1 Стандарт**	
1502.	288.1.Гаалийн үйл ажиллагаанд мэдээллийг электрон хэлбэрээр солилцох, тэдгээрийн найдвартай байдлыг хангах зорилгоор мэдээллийн систем, сүлжээ, технологи ашиглаж болно.	24.1.Гаалийн байгууллага үйл ажиллагаандаа мэдээллийн технологи ашиглана.	Мэдээллийн технологи нь гаалийн байгууллага болон худалдаанд оролцогчдын хувьд зардал хэмнэсэн, үр ашигтай бол гаалийн байгууллага гаалийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор мэдээллийн технологийг ашиглана. Гаалийн байгууллага нь мэдээллийн технологийг ашиглах нөхцөлийг заасан байна.	*“мэдээллийг электрон хэлбэрээр солилцох, тэдгээрийн найдвартай байдлыг хангах”, “технологи” гэснийг тус тус хассан*
1503.		24.2.Гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай гаалийн цахим мэдээллийн сан үүсгэх, баяжуулах, хадгалах, гаалийн цахим мэдээллийн систем боловсруулах, хөгжүүлэх, тэдгээрийн найдвартай, тасралтгүй, аюулгүй ажиллах нөхцөлийг гаалийн удирдах төв байгууллагын мэдээллийн технологи, аюулгүй байдлын асуудал хариуцсан нэгж хариуцан гүйцэтгэнэ.	**7.2 Стандарт** Гаалийн байгууллага компьютерийн хэрэглээний програм нэвтрүүлэхдээ олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн холбогдох стандартыг хэрэглэнэ. **7.4 Стандарт** Шинээр гарсан, эсхүл шинэчлэн найруулсан үндэсний хууль тогтоомжид	
1504.	288.2.Энэ хуулийн 288.1-д заасан мэдээллийн систем, сүлжээ, технологи нь мэдээлэл харилцааны үндэсний болон олон улсын стандартад нийцсэн байна.	24.3.Гаалийн цахим мэдээллийн систем, гаалийн цахим сүлжээ үндэсний болон олон улсын стандартад нийцсэн байна.	дараах зүйлийг заасан байна: бичиг баримтыг цаасаар бүрдүүлэх шаардлага тавихын оронд цахим	*Өөрчлөн найруулсан*
1505.		24.4.Гаалийн байгууллага гаалийн цахим мэдээллийн системээс үүссэн цахим бичиг баримтыг то он гарын үсэг, нууц үг, хувийн дугаар, цахим үнэмлэх зэрэг дэвшилтэт аргаас аль тохиромжтойг сонгон баталгаажуулна.	худалдааны аргыг ашиглах; баталгаажуулалтыг цахим аргаар болон цаасаар хийх; гаалийн байгууллага мэдээллийг өөртөө ашиглахаар авч үлдэх, боломжтой бол	
1506.		24.5.Энэ хуулийн 24.4-т заасны дагуу баталгаажуулах цахим бичиг баримтад дараах бичиг баримт хамаарна: 24.5.1.гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг; 24.5.2.ачааны манифест; 24.5.3.зөрчлийн тухай тэмдэглэл; 24.5.4.тооцоот хуудас; 24.5.5.төлбөрийн баримт; 24.5.6.статистикийн мэдээлэл; 24.5.7.лавлагаа мэдээлэл; 24.5.8.гаалийн байгууллагын шийдвэр, албан тоот.	тэдгээр мэдээллийг бусад гаалийн байгууллага болон хууль тогтоомжоор зөвшөөрсөн бусад талуудтай цахим худалдааны арга хэрэгслээр солилцох эрхтэй байх.	
1507.		**25 дугаар зүйл.Цахим бичиг баримтын хууль зүйн үйлчлэл**		
1508.		25.1.Энэ хуулийн 24.4-т заасны дагуу баталгаажуулсан цахим бичиг баримтыг албан ёсны, хүчин төгөлдөр бичиг баримт гэж тооцно.		

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ САН
www.legalinfo.mn

1509.		**26 дугаар зүйл.Бусад этгээдийн мэдээллийн санд нэвтрэх**		
1510.		26.1.Хуульд өөрөөр заагаагүй бол эрх бүхий гаалийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ албаны зорилгоор төрийн байгууллагын төвлөрсөн мэдээллийн санд шуурхай нэвтрэх эрхтэй байна.		
1511.		**27 дугаар зүйл.Гаалийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи ашиглах дүрэм, журам, заавар батлах**		
1512.	288.3.Төрийн өмчийн мэдээллийн систем, сүлжээ, технологийг гаалийн үйл ажиллагаанд үнэ төлбөргүй, бусад өмчийнхийг гэрээний үндэсэн дээр ашиглана.			-
1513.	288.4.Гаалийн үйл ажиллагаанд оролцогчийн ашиглах мэдээллийн систем, технологид тавигдах шаардлага, ашиглах журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.	27.1.Гаалийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи ашиглах журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.		*“Гаалийн үйл ажиллагаанд оролцогчийн ашиглах мэдээллийн систем, технологид тавигдах шаардлага, ашиглах журмыг” гэснийг “Гаалийн цахим мэдээллийн сан, систем, сүлжээний асуудлыг зохицуулсан дүрэм, журам, зааврыг” гэж өөрчилсөн*
1514.	**289 дүгээр зүйл. Гаалийн үйл ажиллагааны мэдээллийн сан** 289.1.Гаалийн үйл ажиллагааны мэдээллийн сан нь энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан гаалийн статистикийн мэдээлэл, түүнчлэн мөн хуулийн дагуу мэдүүлэгчээс гаалийн байгууллагад гаргаж өгсөн болон гаалийн байгууллагын өөрөө бүрдүүлсэн мэдээлэл, бичиг баримтаас бүрдэнэ. 289.2.Энэ хуулийн 289.1-д заасан мэдээллийн сан дахь мэдээлэл, бичиг баримт нь бичгийн болон электрон хэлбэртэй байж болно. 289.3.Хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 289.1-д заасан мэдээллийн сангаас хүссэн хэлбэрээр мэдээлэл авч болох бөгөөд ийнхүү мэдээлэл өгөхөд мөн хуулийн 15 дугаар зүйлд заасан журмыг баримтална. 289.4.Гаалийн удирдах төв байгууллага энэ хуулийн 289.1-д заасан мэдээллийн санг үүсгэх, ашиглах, түүнд байгаа мэдээллийг баримтжуулах асуудлыг энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн дотоод журамдаа тусгана.			*Хасагдсан*

Хүний эрхийн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

1515.		**28 дугаар зүйл.Гаалийн цахим мэдээллийн систем, гаалийн цахим сүлжээг ашиглахад хориглох зүйл**		*Шинээр нэмэгдсэн*
1516.		28.1.Гаалийн цахим мэдээллийн систем, гаалийн цахим сүлжээнд нэвтэрсэн хэрэглэгч дараах үйлдэл хийхийг хориглоно:		
1517.		28.1.1.гаалийн цахим мэдээллийн систем, гаалийн цахим сүлжээнээс зөвшөөрөлгүй мэдээлэл хуулбарлах, өөрчлөх ба бусдад тараах зорилгоор хортой код бүхий програм зохиох, хэрэглэх, тараах		
1518.		28.1.2.гаалийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа цахим бичиг баримт, цахим мэдээллийг хуурамчаар зохион хэрэглэх, өөрчлөх, устгах;		
1519.		28.1.3.мэдээллийн санг хуулиар хүлээсэн чиг үүрэгтээ үл хамаарах зорилгоор ашиглах, гаалийн цахим мэдээллийн системд нэвтрэх эрхээ бусдад шилжүүлэх.		
1520.	**YI ХЭСЭГ ХАРИУЦЛАГА**	**YI ХЭСЭГ ГААЛИЙН ЗӨРЧИЛ**		*“ХАРИУЦЛАГА” гэснийг “ГААЛИЙН ЗӨРЧИЛ” гэж өөрчилсөн*
1521.	**АРВАНТАВДУГААР БҮЛЭГ Гаалийн хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**	**АРВАННАЙМДУГААР БҮЛЭГ ГААЛИЙН ЗӨРЧЛИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ, ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ**		*“хууль тогтоомж зөрчигчид” гэснийг “ЗӨРЧЛИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ,” гэж нэмсэн*
1522.		**289 дүгээр зүйл. Гаалийн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа** 289.1.Гаалийн хяналт, шалгалтын явцад илэрсэн гаалийн хууль тогтоомжийн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааг гаалийн улсын байцаагч Хууль сахиулах үйл ажиллагааны тухай, Зөрчлийн тухай хуулийн хүрээнд хэрэгжүүлнэ. 289.2.Гаалийн хууль тогтоомжийн хоёр буюу түүнээс дээш зөрчил үйлдсэн бол зөрчил тус бүрт шийтгэл хүлээлгэнэ. 289.3.Нэг зөрчилд давхардуулан шийтгэл хүлээлгэхийг хориглоно.		*Шинээр нэмэгдсэн*
1523.	**290 дүгээр зүйл.Гаалийн хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**	**290 дүгээр зүйл.Гаалийн хууль тогтоомжийн зөрчил үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлага**		*“тогтоомж зөрчигчид” гэснийг “хууль тогтоомжийн зөрчил үйлдсэн этгээдэд” гэж өөрчилсөн*
1524.	290.1.Гаалийн болон бусад хууль тогтоомж зөрчсөн гаалийн байгууллагын албан тушаалтан, гаалийн улсын байцаагчид сахилгын, захиргааны, эрүүгийн болон бусад хариуцлагыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хүлээлгэнэ.			*Хасагдсан*

www.legalinfo.mn

1525.	290.2.Гаалийн хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:	290.1.Гаалийн хууль тогтоомжийн зөрчил үйлдсэн этгээдэд дор дурдсан хариуцлага хүлээлгэнэ:		*Өөрчлөн найруулсан*
1526.	290.2.1.барааг гаалийн мэдүүлэгт бичээгүй орхих, эсхүл худал бичих, гаалийн хяналтаас гадуур, хилийн боомтгүй газраар нэвтрүүлэх, гаалийн шалгалтаас нуун далдлах, барааны нэр төрөл, хэлбэр дүрс, баглаа боодлыг өөрчлөх, гаалийн бичиг баримтыг засварлах, хуурамчаар үйлдэх зэрэг аргаар хууль бусаар нэвтрүүлсэн бол иргэнийг 10000-30000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-150000 төгрөгөөр торгож, тухайн зөрчилд холбогдох барааг хураах, эсхүл үнийг гаргуулж улсын төсөвт төвлөрүүлэх;	290.1.1.барааг гаалийн мэдүүлэгт бичээгүй орхих, эсхүл худал бичих, гаалийн хяналтаас гадуур, гаалийн шалгалтаас нуун далдлах, барааны нэр төрөл, хэлбэр дүрс, баглаа боодлыг өөрчлөх, гаалийн бичиг баримтыг засварлах, хуурамчаар үйлдэх зэрэг аргаар улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн, эсхүл тийнхүү нэвтрүүлэхийг завдсан бол иргэнийг гурван сая төгрөгөөр, хуулийн этгээдийг арван сая төгрөгөөр торгож, тухайн зөрчилд холбогдох барааг хураах шийтгэл хүлээлгэнэ.		*Өөрчлөн найруулсан*
1527.	290.2.2.тарифын бус хязгаарлалт тогтоосон барааг энэ хуулийн 290.2.1-д заасан аргаар гаалийн хилээр хууль бусаар нэвтрүүлсэн, эсхүл тийнхүү нэвтрүүлэхийг завдсан бол иргэнийг 30000-50000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-250000 төгрөгөөр торгож, тухайн зөрчилд холбогдох барааг хураах, эсхүл үнийг гаргуулж улсын төсөвт төвлөрүүлэх;			
1528.	290.2.3.гаалийн мэдээллийн систем ашиглах журам зөрчсөн иргэнийг 30000-50000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 200000-250000 төгрөгөөр торгон учирсан хохирлыг нөхөн төлүүлэх;	290.1.3.Барааг гаалийн байгууллагад мэдүүлэх журам, гаалийн мэдээллийн системийн ашуулгүй байдлыг хангах журам зөрчсөн иргэнийг нэг зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун мянган төгрөг, гаалийн зуучлагчийг хоёр сая төгрөгөөр торгох шийтгэл хүлээлгэнэ.		*290.2.3, 290.2.4 дэх заалт хуулийн төслийн 290.1.3 дахь заалтад нэгтгэгдэж орсон*
1529.	290.2.4.гаалийн удирдах төв байгууллагаас баталсан барааг мэдүүлэх журам зөрчсөн нь энэ хуулийн 290.2.1, 290.2.2 дахь заалт, 293 дугаар зүйлд заасан зөрчлийн бүрэлдэхүүнгүй бол мэдүүлэгч иргэнийг 10000-30000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-100000 төгрөгөөр торгох;			
1530.	290.2.5.гаалийн хяналтад байгаа барааг гаалийн байгууллагын зөвшөөрөлгүй хөдөлгөсөн, ачсан, буулгасан, шилжүүлэн ачсан нь энэ хуулийн 290.2.1-д заасан зөрчлийн бүрэлдэхүүнгүй бол иргэнийг 10000-30000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-100000 төгрөгөөр торгох;			*хасагдсан*
1531.	290.2.6.гаалийн хяналтад байгаа барааг гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр олгосон, гаалийн хилээр гаргасан бол тухайн бараанд ногдох гаалийн болон бусад татварыг төлүүлж, зөрчил гаргасан ажилтан, албан тушаалтныг 50000-100000 төгрөгөөр торгох;	290.1.5.Гаалийн хяналтад байгаа барааг гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр олгосон, гаалийн хилээр гаргасан бол тухайн бараанд ногдох гаалийн болон бусад татварыг төлүүлж, тавин сая төгрөгөөр торгох шийтгэл хүлээлгэнэ.		*“зөрчил гаргасан ажилтан, албан тушаалтныг 50000-100000 төгрөгөөр торгох;” гэснийг “тавин сая төгрөгөөр торгох шийтгэл хүлээлгэнэ.” гэж өөрчилсөн*

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.mlsov.mn

1532.	290.2.7.энэ хуулийн 38.2-т заасан үүргээ биелүүлээгүй тээвэрлэгчийг 50000-100000 төгрөгөөр торгох;	290.1.13.Тээвэрлэгч, тээвэр зуучлагч гаалийн хууль тогтоомжид заасан үүргээ биелүүлээгүй бол нэг сая төгрөгөөр торгох шийтгэл хүлээлгэнэ. хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр төлбөрийн актаар тавигдсан төлбөрийг төлбөрийг хугацаанд нь барагдуулаагүй			*Өөрчлөн найруулсан*
1533.	290.2.8.гаалийн хууль тогтоомжийг зөрчсөн, эсхүл хууль тогтоомжид заасан эрхээ хэтрүүлсэн гаалийн зуучлагч, мэдүүлэгч иргэнийг 10000-30000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-250000 төгрөгөөр, эсхүл уг зөрчлийг давтан гаргасан бол мэдүүлэгч, гаалийн зуучлагчийг 150000-250000 төгрөгөөр торгох;				*Хасагдсан*
1534.	290.2.9.гаалийн зорилгоор хийх тэмдэглэгээг гэмтээсэн, өөрчилсөн, устгасан, эсхүл гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгслийн хүрээ газрын хаягийг өөрчилсөн нь бараат хууль бусаар нэвтрүүлэхтэй холбогдолгүй бол иргэнийг 10000-30000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-100000 төгрөгөөр торгох;	290.1.6.Гаалийн зорилгоор хийсэн тэмдэглэгээг гэмтээсэн, өөрчилсөн, устгасан, эсхүл гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгслийн хүрээ газрын хаягийг өөрчилсөн нь бараат хууль бусаар нэвтрүүлэхтэй холбогдолгүй бол иргэнийг хоёр зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр сая төгрөгөөр торгох шийтгэл хүлээлгэнэ.			*Өөрчлөн найруулсан*
1535.	290.2.10.гаалийн хяналтын бусийн дэглэмийг зөрчсөн нь бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр хууль бусаар нэвтрүүлэхтэй холбогдолгүй бол иргэнийг 10000-30000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-100000 төгрөгөөр торгох;	290.1.4.Гаалийн бүрдүүлэлтийн горимын шаардлага, гаалийн хяналтын бусийн дэглэмийг зөрчсөн нь бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр хууль бусаар нэвтрүүлэхтэй холбогдолгүй бол иргэнийг нэг зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун мянган төгрөгөөр торгох шийтгэл хүлээлгэнэ.			*Өөрчлөн найруулсан*
1536.	290.2.11.энэ хуулийн 78.1-д заасан гаалийн бүрдүүлэлтийн горимын шаардлага зөрчсөн иргэнийг 10000-30000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-100000 төгрөгөөр торгох;				*Хасагдсан*
1537.	290.2.12.гаалийн болон бусад татвар ногдуулахгүйгээр гаалийн хилээр түр хугацаагаар нэвтрүүлсэн, бараа, тээврийн хэрэгслийг хугацаанд буцаан нэвтрүүлээгүй бол зөрчил илэрсэн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа гаалийн хууль тогтоомж, валютын ханш, тарифыг үндэслэн гаалийн болон бусад татварыг нөхөн төлүүлж, зөрчил гаргасан иргэнийг 30000-50000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-100000 төгрөгөөр торгох;	290.1.7.Гаалийн хилээр түр хугацаагаар нэвтрүүлсэн, бараа, тээврийн хэрэгслийг тогтоосон хугацаанд буцаан нэвтрүүлээгүй бол зөрчил илэрсэн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа гаалийн хууль тогтоомж, валютын ханш, тарифыг үндэслэн гаалийн болон бусад татварыг нөхөн төлүүлж, иргэнийг нэг сая төгрөгөөр торгох шийтгэл хүлээлгэнэ.			*Өөрчлөн найруулсан*
1538.	290.2.13.гаалийн баталгаат бүсэд оруулсан бараа, тээврийн хэрэгсэл алдагдсан, эсхүл гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр устгасан бол зөрчил илэрсэн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа гаалийн хууль тогтоомж, валютын ханш, тарифыг үндэслэн гаалийн болон бусад татварыг нөхөн төлүүлж, зөрчил гаргасан иргэнийг 10000-30000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-100000 төгрөгөөр торгох;				*Хасагдсан*

Хууль зүйн үндэсний хүрээлэн

1539.	290.2.14.гаалийн улсын байцаагчаас албан үүргийнхээ дагуу тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсхүл тогтоосон хугацаанд нь биелүүлээгүй бол иргэнийг 10000-30000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-100000 төгрөгөөр торгох;			*Хасагдсан*
1540.	290.2.15.гаалийн улсын байцаагчийг албан үүргээ гүйцэтгэхэд нь санаатай саад учруулсан, эсэргүүцсэн, доромжилсон, гүтгэсэн, заналхийлсэн, хүч хэрэглэсэн этгээдийг 50000-150000 төгрөгөөр торгох;			*Хасагдсан*
1541.	290.2.16.гаалийн бүрдүүлэлтэд холбогдох бичиг баримтыг засварласан, хуурамчаар үйлдсэн нь энэ хуулийн 290.2.1, 290.2.2 дахь заалт, 293 дугаар зүйлд заасан зөрчлийн бүрэлдэхүүнгүй бол иргэнийг 30000-50000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-250000 төгрөгөөр торгох;			*290.1.1 дэх заалтад нэгтгэгдсэн*
1542.	290.2.17.гаалийн хууль тогтоомжид заасан мэдээ, тайланг буруу гаргасан, эсхүл хугацаанд нь гаргаж өгөөгүй аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-100000 төгрөгөөр торгох;	290.1.12.Гаалийн хууль тогтоомжид заасан мэдээ, тайланг буруу гаргасан эсхүл хугацаанд нь гаргаж өгөөгүй хуулийн этгээдийг таван зуун мянган төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.		*“аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-100000 төгрөгөөр торгох;” гэснийг “хуулийн этгээдийг таван зуун мянган төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.” гэж өөрчилсөн*
1543.	290.2.18.гаалийн болон бусад татварыг хууль бусаар буцаан авах зорилгоор гаалийн үнийг худал мэдүүлсэн бол буцаан авсан татварыг эргүүлэн төлүүлж, иргэнийг 30000-50000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-250000 төгрөгөөр торгох.	290.1.9.Гаалийн болон бусад татварыг хууль бусаар буцаан авах зорилгоор гаалийн үнийг худал мэдүүлсэн бол буцаан авсан татварыг эргүүлэн төлүүлж, иргэнийг арван сая төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун сая төгрөгөөр торгох шийтгэл хүлээлгэнэ.		*“30000-50000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-250000 төгрөгөөр торгох.” гэснийг ”арван сая төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун сая төгрөгөөр торгох шийтгэл хүлээлгэнэ” гэж өөрчилсөн*
1544.		290.1.10.Гаалийн болон бусад татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан барааг зориулалтын бусаар захиран зарцуулсан бол зөрчил илэрсэн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа гаалийн хууль тогтоомж, валютын ханш, тарифыг үндэслэн гаалийн болон бусад татварыг нөхөн төлүүлж, хоёр зуун сая төгрөгөөр торгох шийтгэл хүлээлгэнэ.		*Шинээр нэмэгдсэн*

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

1545.		290.1.14.Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр Бүрдүүлэлтийн дараах шалгалт хийлгэхээс татгалзсан, шалгалтын үйл ажиллагаанд санаатай саад учруулсан, шалгалтад хамрагдах гаалийн болон холбогдох санхүүгийн бичиг баримтыг шалгалтын бүрэлдэхүүнд гаргаж өгөөгүй бол иргэнийг гурван сая төгрөг, хуулийн этгээдийг арван сая төгрөгөөр торгох шийтгэл хүлээлгэнэ.		*Шинээр нэмэгдсэн*
1546.	**290 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага** 290.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэлнь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. 290.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.			*Хасагдсан*
1547.	**АРВАНЗУРГАДУГААР БҮЛЭГ** **Бусад зүйл**			
1548.	**291 дүгээр зүйл. Бараа, тээврийн хэрэгслийг нуувч болгон ашиглах**			
1549.	291.1.Барааг гаалийн хилээр нэвтрүүлэх зорилгоор өөр барааг нуувч болгон ашигласан бол нуувч болгон ашигласан барааг хураах, эсхүл үнийг нь гаргуулж улсын төсөвт төвлөрүүлнэ.	290.1.11.Барааг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх зорилгоор тээврийн хэрэгслийг зориудаар тоноглох, зориулалтыг нь өөрчлөх зэргээр нуувч болгон ашигласан бол уг тээврийн хэрэгслийг хураах, эсхүл үнийг нь гаргуулж улсын төсөвт төвлөрүүлнэ.		*Өөрчлөн найруулсан*
1550.	291.2.Барааг гаалийн хилээр хууль бусаар нэвтрүүлэх зорилгоор тээврийн хэрэгслийг зориудаар тоноглох, зориулалтыг нь өөрчлөх зэргээр нуувч болгон ашигласан бол уг тээврийн хэрэгслийг хураах, эсхүл үнийг нь гаргуулж улсын төсөвт төвлөрүүлнэ.			*Хасагдсан*
1551.	**292 дугаар зүйл.Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний эрхийг цуцлах** 292.1.Энэ хуулийн 290.2.8-д заасан зөрчлийг давтан гаргасан гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний эрхийг цуцална.			
1552.	**293[1] дүгээр зүйл. Гаалийн болон бусад татвар төлөхөөс зайлсхийх**			*“293[1] дүгээр зүйл. Гаалийн болон бусад татвар төлөхөөс зайлсхийх” гэснийг “290 дүгээр зүйл. Гаалийн хууль тогтоомжийн зөрчил үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлага” гэж өөрчилсөн*

www.legal.gov.mn Хуулийн үндэсний хүрээлэн

1553.	293[1].1.Гаалийн үнэ, барааны тоо хэмжээ, гаалийн бүрдүүлэлтийн горим, барааны нэр төрөл, марк, зориулалт, ангилал, гарал үүслийг худал мэдүүлэх, гаалийн бичиг баримтыг солих, засварлах зэрэг аргаар гаалийн болон бусад татвар төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол буруутай этгээдэд Татварын ерөнхий хуулийн 74, 75 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ. 293[1].2.Энэ зүйлийн 2931.1-д заасан зөрчлийг болгоомжгүйгээр үйлдсэн бол буруутай этгээдэд Татварын ерөнхий хуулийн 74, 75 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.	290.1.2.Гаалийн үнэ, барааны тоо хэмжээ,гаалийн бүрдүүлэлтийн горим, барааны нэр төрөл, марк, зориулалт, ангилал, гарал үүслийг худал мэдүүлэх, гаалийн бичиг баримтыг солих, засварлах зэрэг аргаар гаалийн болон бусад татвар төлөхөөс зайлсхийсэн бол буруутай этгээдээр татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлүүлсэн татварыг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгох шийтгэл ногдуулна. 290.1.8.Гаалийн үнэ барааны тоо хэмжээ, гаалийн бүрдүүлэлтийн горим, барааны нэр, төрөл зориулалт, ангилал, гарал үүслийг худал мэдүүлэх, гаалийн бичиг баримтыг солих, засварлах зэрэг аргаар гаалийн болон бусад татвар төлөхөөс зайлсхийсэн бол гаалийн болон бусал албан татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлүүлсэн татварыг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгууль ногдуулна.		*“санаатайгаар зайлсхийсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол буруутай этгээдэд Татварын ерөнхий хуулийн 74, 75 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэснийг “зайлсхийсэн бол буруутай этгээдээр татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлүүлсэн татварыг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгох шийтгэл ногдуулна.” гэж өөрчилсөн*
1554.	293[1].3.Гаалийн болон бусад татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан барааг зориулалтын бусаар захиран зарцуулсан, үрэгдүүлсэн бол улсын хилээр оруулсан өдрийн, хэрэв энэ өдрийг тогтоох боломжгүй бол зөрчил илэрсэн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа гаалийн хууль тогтоомж, валютын ханш, тарифыг үндэслэн гаалийн болон бусад татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлбөл зохих албан татварын дүнгийн 50 хувьтай тэнцэх хэмжээгээр торгууль ногдуулна.	290.1.10.Гаалийн болон бусад татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан барааг зориулалтын бусаар захиран зарцуулсан бол зөрчил илэрсэн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа гаалийн хууль тогтоомж, валютын ханш, тарифыг үндэслэн гаалийн болон бусад татварыг нөхөн төлүүлж, хоёр зуун сая төгрөгөөр торгох шийтгэл хүлээлгэнэ.		*“, үрэгдүүлсэн бол улсын хилээр оруулсан өдрийн, хэрэв энэ өдрийг тогтоох боломжгүй бол зөрчил илэрсэн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа гаалийн хууль тогтоомж, валютын ханш, тарифыг үндэслэн гаалийн болон бусад татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлбөл зохих албан татварын дүнгийн 50 хувьтай тэнцэх хэмжээгээр торгууль ногдуулна.” гэснийг “бол зөрчил илэрсэн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа гаалийн хууль тогтоомж, валютын ханш, тарифыг үндэслэн гаалийн болон бусад татварыг нөхөн төлүүлж, хоёр зуун сая төгрөгөөр торгох шийтгэл хүлээлгэнэ.” гэж өөрчилсөн*

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.mn.gov.mn

1555.	**294[1] дүгээр зүйл.Татварыг хугацаанд нь төлөхгүй байх** 294[1].1.Гаалийн болон бусад татварыг хугацаанд нь төлөөгүй бол төлөгдөөгүй татварын үнийн дүнгээс хугацаа хожимдуулсан хоног тутамд 0.3 хувийн хүү ногдуулах бөгөөд энэ заалтын "хүү" гэсэн ойлголт нь Иргэний хуулийн "анз" гэсэн ойлголтод үл хамаарна. /Энэ хэсгийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/				*294[1] дүгээр зүйл бүхэлдэх хасагдсан*
1556.	**295[1] дүгээр зүйл.Дансны гүйлгээг хаах, эд хөрөнгийг битүүмжлэх** 295[1].1.Гаалийн газар, хорооны даргын шийдвэрээр энэ хуулийн 290.1, 290.2, 291 дүгээр зүйлд заасан барааны үнийг болон 293[1].1, 293[1].2, 294[1] дүгээр зүйлд заасан татвар, торгуулийг үл маргах журмаар 290.1.9 дүгээр зүйлд заасан татвар, торгуулийг үл маргах журмаар холбогдох этгээдийн дансаас нь гаргуулан авч, улсын орлого болгох ба боломжгүй бол дансны гүйлгээг нь хаах буюу татвар, төлбөртэй тэнцэх хэмжээний эд хөрөнгийг нь битүүмжилнэ.	**291 дүгээр зүйл.Дансны гүйлгээг хаах, эд хөрөнгийг битүүмжлэх** 291.1.Гаалийн газар, хорооны даргын шийдвэрээр энэ хуулийн 290.1.1, 290.1.10 дугаар зүйлд заасан барааны үнийг болон 290.1.2, 290.1.4, 290.1.7, 290.1.8, 290.1.9 дугаар зүйлд заасан татвар, торгуулийг үл маргах журмаар холбогдох этгээдийн дансаас гаргуулан авч, улсын орлого болгох ба боломжгүй бол дансны гүйлгээг нь хаах буюу татвар, төлбөртэй тэнцэх хэмжээний эд хөрөнгийг нь битүүмжилнэ.		*"290.1, 290.2, 291 дүгээр зүйлд" гэснийг "290.1.1, 290.1.10 дугаар зүйлд" гэж "293[1].1, 2931.2, 294'1" гэж өөрчилсөн*
1557.	**296 дугаар зүйл.Зөрчлийг хянан шийдвэрлэх** 296.1.Энэ хуульд заасан захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэхдээ энэ хууль болон холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгоно. 296.2.Гаалийн хууль тогтоомжийг нэг үйлдлээр хэд хэдэн удаа зөрчсөн, эсхүл зөрчил давтан үйлдсэн бол зөрчил тус бүрт энэ хуульд заасан хариуцлага ногдуулах боловч нэг зөрчилд давхардуулан шийтгэл ногдуулахыг хориглоно.				*Хасагдсан*
1558.	**297 дугаар зүйл.Бараа, тээврийн хэрэгслийг улсын орлого болгох, буцаан олгох**	**292 дугаар зүйл.Бараа, тээврийн хэрэгслийг улсын орлого болгох, буцаан олгох**			-
1559.	297.1.Гаалийн хууль тогтоомж зөрчсөний улмаас энэ хуулийн дагуу хураагдсан бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллага борлуулах бөгөөд орлогыг нь улсын төсөвт төвлөрүүлнэ.	292.1.Гаалийн хууль тогтоомж зөрчсөний улмаас энэ хуулийн дагуу хураагдсан бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллага борлуулах бөгөөд орлогыг нь улсын төсөвт төвлөрүүлнэ.			-
1560.\	297.2.Энэ хуульд заасны дагуу хураагдсан бараа, тээврийн хэрэгсэл нь гаалийн хууль тогтоомжийн зөрчлөөс холбогдолтой болох нь гаалийн удирдах төв байгуулагын шалгалт, эсхүл шүүхийн шийдвэрээр нотлогдвол тэдгээрийг бүцаан олгох бөгөөд боломжгүй бол үнийг нь эргүүлж олгоно.	292.2.Энэ хуульд заасны дагуу хураагдсан бараа, тээврийн хэрэгсэл нь гаалийн хууль тогтоомжийн зөрчлөөс холбогдолтой болох нь гаалийн удирдах төв байгуулагын шалгалт, эсхүл шүүхийн шийдвэрээр нотлогдвол тэдгээрийг бүцаан олгох бөгөөд боломжгүй бол үнийг нь эргүүлж олгоно.			-
1561.	297.3.Энэ хуулийн 297.2-т зааснаар бараа, тээврийн хэрэгслийг биетээр бүцаан олгох тохиолдолд гаалийн болон бусад татвар, хураамжийг нөхөн төлүүлэх бөгөөд үнийг нь эргүүлж олгохдоо татвар, хураамжийг суутган авна.	292.3.Энэ хуулийн 292.2-т зааснаар бараа, тээврийн хэрэгслийг биетээр бүцаан олгох тохиолдолд гаалийн болон бусад татвар, хураамжийг нөхөн төлүүлэх бөгөөд үнийг нь эргүүлж олгохдоо холбогдох татвар, хураамжийг суутган авна.			*"297.2" гэснийг "292.2" гэж өөрчилсөн*
1562.	297.4. Бараа, тээврийн хэрэгслийг улсын орлого болгох журмыг Засгийн газар батална.	292.4.Бараа, тээврийн хэрэгслийг улсын орлого болгох журмыг Засгийн газар батална.			-

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

1563.	**298 дугаар зүйл.Хадгалах хугацаа дууссан барааг шийдвэрлэх**	**293 дугаар зүйл.Хадгалах хугацаа дууссан барааг шийдвэрлэх**		-
1564.	298.1.Гаалийн түр агуулах, гаалийн баталгаат бүсэд барааг хадгалах хугацаа хэтэрсэн, эсхүл гаалийн бүрдүүлэлтийн явцад мэдүүлэгч нь түүнийг хүлээн авахаас татгалзсан бол гаалийн байгууллага уг барааг улсын орлого болгож борлуулах бөгөөд орлогыг нь улсын төсөвт төвлөрүүлнэ.	293.1.Гаалийн түр агуулах, гаалийн баталгаат бүсэд барааг хадгалах хугацаа хэтэрсэн, эсхүл гаалийн бүрдүүлэлтийн явцад мэдүүлэгч нь түүнийг хүлээн авахаас татгалзсан бол гаалийн байгууллага уг барааг улсын орлого болгож борлуулах бөгөөд орлогыг нь улсын төсөвт төвлөрүүлнэ.		-
1565.	298.2.Энэ хуулийн 298.1-д заасан барааг борлуулснаас хойш 6 сарын дотор эзэмшигч хүсэлт гаргасан тохиолдолд борлуулсан үнээс гаалийн болон бусад татвар, хадгалалтын хөлс зэрэг зардлыг суутгаж, зөрүү үнийг эргүүлэн олгож болно.	293.2.Энэ хуулийн 293.1-д заасан барааг борлуулснаас хойш 6 сарын дотор эзэмшигч хүсэлт гаргасан тохиолдолд борлуулсан үнээс гаалийн болон бусад татвар, хадгалалтын хөлс зэрэг зардлыг суутгаж, зөрүү үнийг эргүүлэн олгож болно.		*“298.1” гэснийг “293.1” гэж өөрчилсөн*
1566.	298.3.Хураагдсан бараа, тээврийн хэрэгслийг борлуулах журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.	293.3.Хураагдсан бараа, тээврийн хэрэгслийг борлуулах журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.		-
1567.	**299 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох** 299.1.Энэ хуулийг 2008 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.	**294 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох** 294.1.Энэ хуулийг 2017 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.		*Дагаж мөрдөх хугацаа өөрчлөгдөнө*
1568.	**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**	Гарын үсэг		

№	Хүчин төгөлдөр дагаж мөрдөж байгаа хууль	Хуулийн төсөл	Тайлбар
1		**ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**	
2		**1 дүгээр зүйл.** Улсын Их Хурлаас 2008 оны 5 дугаар сарын 20-ны өдөр баталсан Гаалийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.	
3		**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Гаалийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.	
4		Гарын үсэг	

---o0o---

Хуулиэлектрон хэлбэрт хөрвүүлэн www.nli.gov.mn

ЯЛ ОНОГДУУЛАХ ОНОЛ, ПРАКТИК: ХАРЬЦУУЛСАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН[1]

Нэг. Удиртгал

1.1. **Судалгааны үндэслэл, асуудал**

Хууль зүйн салбарт тулгамдаж буй асуудлаар мэдээлэл цуглуулах, судалгаа хийх, үүссэн нөхцөл байдлыг сайжруулах талаар санал, зөвлөмж гаргах нь Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Судалгааны төвийн үндсэн чиг үүргүүдийн нэг юм.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс гаргаж буй таслан шийдвэрлэх тогтоол, захирамж давж заалдах шатны шүүхийн магадлалаар хүчингүй болох үзэгдэлийн хувь хэмжээ улсын хэмжээнд өндөр байгааг судлаачид ажигласны үндсэн дээр энэхүү судалгааг хийх болов.

Тухайлбал эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхэд 2015 онд хүлээн авч шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, захирамжийн **35,1** хувь нь хүчингүй болсон талаар ШЕЗ-өөс гаргасан Монгол Улсын шүүхийн 2015 оны шүүн таслах ажиллагааны тайланд дурьджээ. Энэхүү нөхцөл байдал 2016 онд ч хэвээр үргэлжилж буй нь эхний хагас жилийн дүн мэдээнээс харагдаж байгаа ба оногдуулсан ял нь хүчингүй болох үзүүлэлтээр хамгийн өндөр үзүүлэлттэй 5 анхан шатны шүүхийг сонгож судлав .

1.2 Судалгааны зорилго, зорилт

Зорилго:

Энэхүү судалгааны хүрээнд анхан шатны эрүүгийн хэргийн шүүхээс гаргаж байгаа таслан шийдвэрлэх тогтоол, шүүгчийн захирамжийн чанар сул байгаагийн бодит нөхцөл байдлыг тодруулах улмаар хууль тогтоомжийг боловсронгуй болгох, анхан шатны шүүхийн шүүгчдийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх талаар санал, зөвлөмж гаргах нь судалгааны ажлын гол зорилго болно.

Зорилт:

- Бодит нөхцөл байдлыг тодорхойлохын тулд харьяалах эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс гаргасан шийдвэрийг хамгийн ихээр хүчингүй болгож байгаа эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалуудыг түүвэрлэн авч судлав.
- Судалгааны үр дүнд Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зүйл заалтыг боловсронгуй болгох болон эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчидийг мэргэшүүлэх талаар санал болвсруулав.

1.3 Судалгааны хамрах хүрээ

Энэхүү судалгааны ажлыг удирдамжид заасны дагуу дор дурдсан хүрээнд гүйцэтгэв.

1. Дараах анхан шатны шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, захирамж болон тэдгээрийг хүчингүй болгосон давж заалдах шатны шүүхийн магадлалд дүн шинжилгээ хийв.

1.1 Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс гаргасан 10 магадлал, түүнд хамаарах анхан шатны шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, захирамж;

1.2. Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах

[1] Тус судалгааг Хууль зүйн судалгааны төвийн эрдэм шинжилгээний ажилтан Ц.Одгэрэл, Ж.Бариаширсүрэн, Б.Гончигсумлаа, Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн ахлах референт Л.Галбаатар нар хамтран гүйцэтгэв.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nji.gov.mn

шатны шүүхээс гаргасан 10 магадлал, түүнд хамаарах анхан шатны шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, захирамж;

1.3. Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс гаргасан 10 магадлал, түүнд хамаарах анхан шатны шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, захирамж;

1.4. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй болон Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс гаргасан 10 магадлал, түүнд хамаарах анхан шатны шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, захирамж.

1.4 Судалгааны арга зүй

Энэхүү судалгаагаар тавьж буй зорилго, зорилтод хүрэхийн тулд, шинжлэх ухааны ерөнхий аргуудыг суурь болгон, түүний үндсэн дээр эрх зүйн тусгай аргуудыг ашиглав.

АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ТАСЛАН ШИЙДВЭРЛЭХ ТОГТООЛ, ЗАХИРАМЖИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОСОН ТҮГЭЭМЭЛ ШАЛТГААН ТЭДГЭЭРИЙН ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

1.1 Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс гаргасан магадлал, түүнд хамаарах анхан шатны шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, захирамжид хийсэн дүн шинжилгээ.

Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс харьяалах анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож гаргасан 10 магадлал түүвэрлэн авч судалсны 8 нь Баянхонгор аймаг дахь эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг, 1 нь Архангай аймаг дахь эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг, 1 нь Өвөрхангай аймаг дахь эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон магадлал байв.

Судалгаанд бусдын эд хөрөнгийг хулгайлах, санаатайгаар устгах, гэмтээх, бусдын бие махбодид хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл санаатай учруулах, танхайрах, химийн хорт болон аюултай бодисын тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэргийг шийдвэрлэсэн тогтоол, магадлалыг ашиглав.

Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчид анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон хууль зүйн үндэслэл, шалтгаануудыг магадлал тус бүр дээр нэг бүрчлэн дурьдвал:

1. Гэмт хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой нотлох ажиллагааг хариуцан ажиллаж байгаа хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор нь шаардлагатай бүх ажиллагааг гүйцэтгээгүй байхад анхан шатны шүүхийн шүүгч хэргийг эцэслэн шийдвэрлэх үзэгдэл их байгаагаагаас шалтгаалж чанаргүй шийдвэрийн хувь хэмжээ нэмэгддэг ажээ. Ялангуяа ЭБШХ-ийн 16 дугаар зүйлийн 16.1 –д заасан “... хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор нотлохын тулд хуульд заасан бүх арга хэмжээг авч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг яллах ба цагаатгах, эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх ба хөнгөрүүлэх нөхцөл байдлыг бүрэн тогтоох үүрэгтэй” гэснийг анхан шатны шүүгч бүрэн ухамсарлалгүйгээр хэрэг шийдвэрлэж байгаа нь ажиглагдлаа.

2. Хэрэг бүртгэгчийн даалгавраар өөр орон нутагт авагдсан гэрчийн мэдүүлгийг нэг цагдаагийн хэлтсээс нөгөө цагдаагийн хэлтэс рүү факсаар хүлээн авч “хуулбар үнэн” дардсаар давхар баталгаажуулсныг нотлох баримтаар үнэлэхгүйгээр нэмэлт мөрдөн байцаалтад буцааж шийдвэрлэснийг давж заалдах шатны шүүх буруутгасан бөгөөд нотлох баримтад тооцох нь зүйтэй гэжээ. Мөн “гэрчийн мэдүүлэг” ба

“баримт сэлт” хоёрын талаар анхан болон давж заалдах шатны шүүгчид ойлголтын зөрүүтэй байдаг нь ажиглагдлаа. ЭБШХ-ийн 79 дүгээр зүйлийн 79.2-т “... баримт сэлт нь ... гэрчийн мэдүүлгээр тогтоогдно” гэж байгаагаас үзвэл баримт сэлт нь гэрчийн мэдүүлэг байдлаар хэлбэржиж хавтаст хэрэгт нотлох баримтын түвшинд бэхжүүлэгдэх боломжтой байна. Эндээс дүгнэхэд анхан шатны шүүгчийн нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, үнэлэх ажиллагааны талаарх эрх зүйн ухамсар, мэргэшлийн бэлтгэл хангалтгүй байна.

3. Хавтаст хэрэгт бэхжүүлсэн баримт сэлт, мэдээллүүдэд шүүгдэгчийн хувийн байдлын талаар зөрүүтэй тусгагдсан байхад анхан шатны шүүхийн шүүгч үл тоомсорлон шийдвэр гаргасан нь ЭБШХ-ийн 80 дугаар зүйлийн 80.1.4 дэх заалтыг зөрчжээ. Учир нь шүүгдэгчийн хувийн байдал нь түүнд оногдуулах хариуцлагыг хөнгөрүүлэх эсхүл хүндрүүлэхэд нөлөөлөх нэг нөхцөл тул яв цав нотлож байж түүнийгээ үнэлэх хууль зүйн шаардлагатай ажээ.

4. Гэмтлийн зэрэг тогтоосон шинжээчийн дүгнэлт хөнгөн, хүндэвтэр гэж зөрүүтэй гарсан байхад дахин шинжилгээ хийлгэлгүйгээр хэргийг шийдвэрлэсэн нь Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалтыг зөрчсөн байна. Энэ нь нөгөө талаар хэргийн байдлыг бүх талаас нь бүрэн бодитойгоор нотлоогүй байхад шүүх шийдвэрлэсэн тохиолдол болжээ. Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 20.1-д зааснаар *“шинжээчийн дүгнэлт, эсхүл түүний зарим хэсэг үндэслэлгүй буюу үнэн зөв болох нь эргэлзээтэй байвал шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн тогтоол, захирамж, хүсэлтээр дахин шинжилгээ хийнэ”* гэжээ.

5. Хохирогч, иргэний нэхэмжлэгчийг буруу тогтоож, хохирлын тооцоо зөрүүтэй, учирсан гэмтлийг шүүгдэгч учруулсан гэдгийг хангалттай нотлоогүй байхад хэт нэг талыг барьж шүүхийн хэлэлцүүлэг хийсэн гэж давж заалдах шатны шүүх дүгнээд ЭБШХ-ийн 317 дугаар зүйлийн 317.1.1-д заасан *“хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон шүүхийн хэлэлцүүлэг явуулахад нэг талыг барьсан буюу гүйцэд биш хийсэн”* гэдэг үндэслэлээр шийтгэх тогтоолыг хүчингүй болгожээ.

6. Үгсэн тохиролцож үйлдсэн гэмт хэргийн материалаас зарим этгээдийн үйлдлийг үндэслэлгүйгээр тусгаарлан шийдвэрлэснийг давж заалдах шатны шүүх буруутгаж анхан шатны шүүхийн тогтоолыг хүчингүй болгосон байна. Энэ нь мөн шүүх хуралдаан нэг талыг барьж гүйцэд биш хийгдсэн гэсэн үндэслэлийг хангаж байгаа аж.

7. Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.2-т “... гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах” ялыг анхан шатны шүүхийн шүүгч хэрэглэхдээ “... гурав буюу түүнээс дээш 6 сар хүртэл” гэж буруу ойлгон хэрэглэж 3 сар баривчлах ял оноосон нь ЭБШХ-ийн 284.1-д заасан “Шүүхийн тогтоол нь хууль ёсны ба үндэслэлтэй байна” гэх заалтыг зөрчиж гарсан алдаатай шийдвэр болжээ.

8. ЭБШХ-ийн 308 дугаар зүйлийн 308.2-т *“Шүүх давж заалдсан гомдол, эсэргүүцэлд дурдсан зүйлээр хязгаарлахгүй ба бусад шүүгдэгчийн талаар давж заалдах гомдол, эсэргүүцэл бичигдсэн эсэхийг харгалзахгүйгээр бүх шүүгдэгчийн хэргийг бүхэлд нь хянаж үзнэ”* гэсэн заалтыг давж заалдах шатны шүүгчид түгээмэл хэрэглэдэг байна. Энэ явцад бусад шүүгдэгчид хамаарах үйлдлийн нотолгоо, оноосон ялтай холбоотой зөрчил илрүүлсэн тохиолдол түгээмэл байдаг болох нь ажиглагдлаа.

1.2 Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс гаргасан магадлал, түүнд хамаарах анхан шатны шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, захирамжид хийсэн дүн шинжилгээ.

Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс харьяалах анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож гаргасан 10 магадлал түүвэрлэн авч судалсны 6 нь Сүхбаатар аймаг дахь эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг, 4 нь Хэнтий аймаг дахь эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон магадлал байв.

Судалгаанд бусдын эд хөрөнгийг хулгайлах, хээл хахууль авах, насанд хүрээгүй хүнийг хүчиндэх, бусдыг болгоомжгүй, санаатай алах, бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах гэмт хэргийг шийдвэрлэсэн тогтоол, магадлалыг ашиглав.

Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчид анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон хууль зүйн үндэслэл, шалтгаануудыг магадлал тус бүр дээр нэг бүрчлэн дурдвал:

1. Хэрэгт цугларсан нотлох баримтад үндэслэн хянан шийдвэрлэх боломжтой байхад нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаасан нь хууль зүйн үндэслэлгүй бөгөөд хэргийн жинхэнэ байдалтай нийцээгүй тул хэргийг шүүхийн хэлэлцүүлгийн шатанд буцаасан.

2. Таслан шийдвэрлэх тогтоолын тодорхойлох хэсэгт тусгагдах ёстой хуульд заасан мэдээллүүдийг дутуу бичиж тогтоол үйлдсэн нь хэргийн жинхэнэ байдалтай нийцээгүй бөгөөд нотлох баримтаар хангалттай нотлогдоогүй тул анхан шатны шүүх хэргийг нэг талыг барьж шийдвэрлэсэн гэж үзжээ.

3. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон шүүхийн хэлэлцүүлэг явуулахдаа нэг талыг барьсан, гүйцэд биш хийсэн гэж дүгнэсэн.

4. Хэрэгт чухал ач холбогдол бүхий мэдүүлэг өгч болох хүмүүсийг байцаагаагүй, эсхүл зайлшгүй хийвэл зохих шинжилгээг хийлгээгүй, түүнчлэн хэрэгт чухал ач холбогдол бүхий баримт бичиг, эд мөрийн баримтыг шаардан гаргуулж аваагүй тул нэг талыг барьсан, гүйцэд биш хийсэн гэж үзсэн.

5. Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн бөгөөд мэдүүлэг нь шинжээчийн дүгнэлт болон бусад нотлох баримтуудаар нотлогдож тогтоогдоогүй, эрс зөрүүтэй байхад хэргийн талаар үндэслэл муутай дүгнэлт хийж ЭХТА-ийн 94 дүгээр зүйлийн 94.1-д заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, ял оногдуулсан байна.

6. ЭХТА-ийн 94.1-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлснийг анхан шатны шүүх ЭХТА-ийн 183.1 болгон зүйлчлэлийг хүндрүүлэн өөрчилж, шүүгдэгчийн хуулиар хамгаалагдсан эрхийг зөрчин, эрх зүйн байдлыг нь дордуулж, түүнийг гэм буруутайд тооцсон байна. Анхан шатны шүүх ЭБШХ-ийн 320 дугаар зүйлийн 320.1 дэх заалтыг ноцтой зөрчиж гэмт хэргийн улмаас учирсан хохирлын шинж чанар, хэр хэмжээг мөрдөн байцаалтын шатанд гүйцэд тодруулж тогтоогоогүй, яллах дүгнэлтийн хавсралтад хохирогчид хэнээс хэдэн төгрөг гаргуулах талаар дурдаагүй нь хэргийн бодит байдалтай нийцээгүй шийдвэр гаргахад хүргэжээ.

7. Хохирогчийн амь насыг бүлэглэж, санаатай хохироосон үйлдэлд яллагдагчийн оролцоог ялгамжтай тогтоогоогүй, энэ талаар ЭХЕА-ийн 35, 36 дугаар зүйлийг оновчтой зөв хэрэглэж, яллах дүгнэлтэд тусгаагүй нь ЭБШХ-ийн 214, 218-р зүйлд заасан шаардлагыг хангаагүй байх бөгөөд түүнийг шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй гэжээ.

8. Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол хууль ёсны ба үндэслэлтэй байх хуулийн шаардлагыг хангаагүй бөгөөд шүүгдэгчийн үйлдэл гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй талаар хийсэн анхан шатны шүүхийн дүгнэлт нь хэргийн жинхэнэ

байдалтай нийцээгүй. Мөн хэрэгт авагдсан нотлох баримтуудыг бүхэлд нь харилцан хамааралтай байдлаар үнэлээгүй нь ЭБШХ-ийн 296 дугаар зүйлийн 296.1-д заасныг зөрчсөн. Гэмт хэрэг үйлдэгдсэн газар, үйлдсэн арга, гэмт хэрэг эхэлж дууссан цаг хугацаа, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг үнэлж, тогтоолд тодорхойлоогүй ба ЭБШХ-ийн 319 дугаар зүйлийн 319.1.1-д заасны дагуу нотлох баримтаар нотлогдоогүй.

9. Хэрэгт мөрдөн байцаалт явуулахдаа тогтоол гаргахад чухал ач холбогдолтой нөхцөл байдлыг тодруулалгүй орхигдуулж гүйцэд биш хийсэн нь шийтгэх тогтоолыг хүчингүй болгох үндэслэл болжээ. Тухайлбал, шинжээч эмчийн дүгнэлт эргэлзээтэй, дахин бүрэлдэхүүнтэй шинжээчийн дүгнэлт гаргах шаардлагатай байхад анхан шатны шүүх хэргийг шийдвэрлэсэн нь хэт нэг талыг барьсан шийдвэр болжээ. Мөн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны үед чухал ач холбогдол бүхий баримт бичиг, эд мөрийн баримтыг шаардан гаргуулж аваагүй байна.

10. Хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаа бүрэн хийгдсэн бөгөөд хөнгөн гэмтэл учруулсан үйлдлийг тусгаарласан нь хуульд нийцсэн байхад анхан шатны шүүх хэргийг хүлээж аваад шийдвэрлэх ёстой байтал буцаасан нь хэргийн жинхэнэ байдалтай нийцээгүй тогтоол болжээ гэж давж заалдах шатны шүүх дүгнэжээ.

1.3. Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс гаргасан магадлал, түүнд хамаарах анхан шатны шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, захирамжид хийсэн дүн шинжилгээ.

Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс харьяалах анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож гаргасан 9 магадлал түүвэрлэн авч судалсны 7 нь Сэлэнгэ аймаг дахь эрүүгийн хэргийн анхан шатны 20 болон 22 дугаар шүүхийн шийдвэрийг, 2 нь Дархан-Уул аймаг дахь эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон магадлал байв.

Судалгаанд бусдын эд хөрөнгийг хулгайлах, санаатайгаар устгах, гэмтээх, танхайрах, бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэргийг шийдвэрлэсэн тогтоол, магадлалыг ашиглав.

Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчид анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон хууль зүйн үндэслэл, шалтгаануудыг магадлал тус бүр дээр нэг бүрчлэн дурдвал:

1. Эрүүгийн хуулийн 155 дугаар зүйлийн гэмт хэргийн бүх шинжийг агуулж байхад 36.2-г журамлан 145.2-т зааснаар зүйлчилсэн ба шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 1, 2 дугаар зүйлийг зөрчилтэй ойлгомжгүй бичсэн. Таслан шийдвэрлэх тогтоолд дурдсан дүгнэлт нь хэргийн жинхэнэ байдалтай нийцээгүй, эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтойгоор зөрчсөн тул хүчингүй болгожээ.

2. “Шүүхийн тогтоол нь хууль ёсны ба үндэслэлтэй байна” гэснийг зөрчсөн, ял оногдуулахдаа хэргийн бүх нөхцөл байдлыг үндэслээгүй буюу орхигдуулсан. Ялтай байсан этгээд гэмт хэрэг үйлдсэн байхад хүндрүүлэх нөхцөл болгож үнэлээгүй, тогтоох хэсэгт дурьдаагүй байсан тул шийдвэр зөрчилтэй гарсан гэж дүгнэжээ.

3. ЭБШТХ-ийн 317.1.4 “Шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, анхан шатны шүүхэд өөр бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэхээр даалгасан”-г зөрчсөн. Яллагдагч ялтай байх хугацаандаа дахин гэмт хэрэг үйлдсэн байхад шинээр ял оногдуулахдаа хүндрүүлэн авч үзээгүй. Өөрөөр хэлбэл үйлдсэн гэмт хэрэгт нь тохирох ялаас хөнгөн ял оногдуулсан.

4. Ялтай байдлыг байдлыг зүйлчлэлд оруулалгүй орхигдуулсан ба тогтоох хэсэгт дурдаагүй нь шийдвэр зөрчилтэй болгож байна. Ял оногдуулахдаа бүх нөхцөл байдлыг үндэслээгүй буюу орхигдуулсан. ЭБШХ-ийн 2841.1 дэх хэсэг “Шүүхийн тогтоол нь хууль ёсны ба үндэслэлтэй байна.”

5. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 284 дүгээр зүйлийн 284.1 дэх хэсэгт заасан "…шүүхийн тогтоол нь хууль ёсны ба үндэслэл бүхий байна..." 315.1.2, 317 дугаар зүйлийн 317.1.1, 318 дугаар зүйлийн 318.2.1, 322 дугаар зүйлийн 322.1, 325 дугаар зүйл. гэмт хэрэг гарсан шалтгаан нөхцөл, хэргийн оролцогчдын санаа зорилго, сэдэлтийг мөрдөн байцаалтын шатанд нарийвчлан хангалттай сайн тогтоогоогүй. Зарим үйлдлийг бүрэн нарийвчлан шалгалгүй аргагүй хамгаалалт гэж үзсэн.

6. 1.ЭБШХ-ийн 284.1 дэх хэсэгт заасан "...хууль ёсны ба үндэслэлтэй..." 2.ЭБШХ-ийн 124.3-д "Хэргийг байцаан шийтгэх ажиллагааны аль ч үед нэгтгэж болох бөгөөд энэ тухай хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана"заалтыг зөрчсөн 3.315.1.2, 320 дугаар зүйлийн 320.1, 325 дугаар зүйлүүдэд заасныг. 1.Эрүүгийн хэргийг эмх цэгцгүй, ойлгомжгүй, дугаарласан буюу хэргийг буруу нэгтгэсэн. 2.Шийтгэх тогтоол гаргахдаа ЭХ-ийн заалтуудыг буруу бичиж олон тооны техник алдаа гаргасан. 3.ЭБШХ-ийн 124.3-д заасан зохих шийдвэр гараагүй байхад хэргийг нэгтгэсэн.

7. 315.1.2, 317 дугаар зүйлийн 317.1.1, 317.1.2, 317.1.4, 318 дугаар зүйлийн 318.1, 319 дүгээр зүйлийн 319.1.2, 319.1.4, 322 дугаар зүйлийн 322.1, 325 дугаар зүйл. Хэргийн явцад үзлэг хийх, түүнийг битүүмжлэх, хураах зэрэг ажиллагааг гүйцэд хийгээгүй. 2.Оногдуулж буй ялын зүйл ангийн талаар тодорхой танилцуулж байцаагаагүй. 3. шүүх нь шүүгдэгчийн үйлдсэн зарим хэргийг үндэслэлгүйгээр хэрэгсэхгүй болгож дүгнэлт хийсэн.

8. ЭБШХ-ийн 284.1 дэх хэсэгт заасан "...хууль ёсны ба үндэслэлтэй..." байх хуулийн шаардлагыг хангаагүй байна. 2. 42.3.4, 42.3.7 дахь хэсгүүдэд заасан "... хохирогч нь шүүх хуралдаанд оролцох, ...мэдүүлэг өгөх..." зэрэг хохирогчийн хуулиар хамгаалагдсан эрхийг нь зөрчсөн. Шүүх хуралдааны товыг хохирогчид мэдэгдсэн эсэх нь тодорхойгүй байдлын үндсэн дээр шүүх хуралдааныг хийсэн. 2.Шийтгэх тогтоол гаргахдаа ЭХ-ийн заалтуудыг буруу бичиж олон тооны техник алдаа гаргасан 3.ЭБШХ-ийн 124.3-д заасан зохих шийдвэр гараагүй байхад хэргийг нэгтгэсэн.

9. 284.1 дэх хэсэгт заасан "...хууль ёсны ба үндэслэлтэй..." байх хуулийн шаардлагыг хангаагүй. Анхан шатны шүүхээс хэргийн зүйлчлэлийг үндэслэлгүйгээр хөнгөрүүлж зүйлчилсэн.

1.4. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй болон Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс гаргасан магадлал, түүнд хамаарах анхан шатны шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, захирамжид хийсэн дүн шинжилгээ.

Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй болон Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчид анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон хууль зүйн үндэслэл, шалтгаануудыг магадлал тус бүр дээр нэг бүрчлэн дурдвал:

1. Яллагдагчид эрхийг нь тайлбарлан өгч, байцаан шийтгэх ажиллагаа явуулсны дараа гэм буруугийн асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэх. ЭБШХ-ийн 320.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр мөн хуулийг ноцтой зөрсөн гэж үзсэн.

2. Хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хуулийг жинхэнэ агуулгаас зөрүүтэй буруу ойлгож хэрэглэсэн буюу ЭХ-ийн ЕА-ийн 57.1, 57.3 дэх хэсгийн заалтыг зөрчсөн. ЭБШХ-ийн 321.1.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр хуулийг жинхэнэ агуулгаас зөрүүтэй буруу ойлгож хэрэглэсэн гэж үзсэн.

3. Хэргийн мөрдөн байцаалтыг дутуу явуулснаас хэрэгт цугласан нотлох баримтын хүрээнд хэргийг хянан шийдвэрлэх боломжгүй. ЭБШХ-ийн 318.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр мөрдөн байцаалтыг явуулахдаа гүйцэд биш хийсэн гэж үзсэн.

4. ЭБШХ-ийн 80-р зүйлд заасан хэргийн талаар нотолбол зохих асуудлуудыг бүрэн тогтоох шаардлагатай. ЭБШХ-ийн 16.1, 318.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр мөрдөн байцаалтыг явуулахдаа гүйцэд биш хийсэн гэж үзсэн.

5. Мөрдөн байцаалтын ажиллагаа дутуу хийгдсэн бөгөөд ЭБШХ-ийн 80-р зүйлд заасан хэргийн талаар нотолбол зохих асуудлуудыг нарийвчлан шалгаж тогтоогоогүй. ЭБШХ-ийн 16.1, 318.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр мөрдөн байцаалтыг явуулахдаа гүйцэд биш хийсэн гэж үзсэн.

6. Хойшлуулсан буюу ялтай байх хугацаандаа дахин гэмт хэрэг үйлдсэн талаар огт дүгнэлт хийлгүй, түүнчлэн Өршөөл үзүүлэх хуулийг буруу хэрэглэсэн. ЭБШХ-ийн 321.1.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр хуулийг жинхэнэ агуулгаас зөрүүтэй буруу ойлгож хэрэглэсэн гэж үзсэн.

7. Гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан хохирлыг хэн нөхөн төлөх үүрэгтэйг нэг мөр шийдвэрлэх шаардлагатай. ЭБШХ-ийн 318.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр шүүхийн хэлэлцүүлгийг явуулахдаа гүйцэд биш хийсэн гэж үзсэн.

8. Хэргийн зүйлчлэлд нөлөөлөхөөр байхад дүгнэлт гаргасан шинжээчийг шүүх хуралдаанд оролцуулаагүй, дан ганц хохирогчийн мэдүүлгээр шүүгдэгчийг гэм буруутай гэж үзсэн нь учир дутагдалтай. ЭБШХ-ийн 318.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр мөрдөн байцаалт, шүүхийн шатанд хэт нэг талыг барьсан гэж үзсэн.

9. ЭБШХ-ийн 80.1.4, 80.1.5 дахь хэсэгт заасан нотолбол зохих асуудлуудыг нотолж тогтоогоогүй байхад хэргийг эцэслэн шийдвэрлэсэн нь буруу болжээ. ЭБШХ-ийн 318.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр шүүхийн хэлэлцүүлгийг явуулахдаа гүйцэд биш хийсэн гэж үзсэн.

10. Мөрдөн байцаалтын ажиллагаа дутуу хийгдсэн бөгөөд ЭБШХ-ийн 80 дугаар зүйлд заасан хэргийн талаар нотолбол зохих асуудлуудыг нарийвчлан шалгаж тогтоогоогүй. ЭБШХ-ийн 318.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр мөрдөн байцаалт, шүүхийн хэлэлцүүлгийг явуулахдаа гүйцэд биш хийсэн гэж үзсэн.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Анхан шатны шүүхээс гаргасан цагаатгах болон таслан шийдвэрлэх тогтоолыг хүчингүй болгосон шалтгааныг судлан үзэхэд дараах нийтлэг зөрчил гарсан байна. Үүнд:

- Хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хуулийг жинхэнэ агуулгаас зөрүүтэй буруу ойлгож хэрэглэсэн буюу хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд ял оногдуулахтай холбоотой Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 57 дугаар зүйлийн 57.1, 57.3 дэх хэсгийн заалтыг зөрчсөн.[2]

---

[2] 57.1.Энэ хуулийн тусгай ангийн өөр өөр зүйлд болон нэг зүйлийн тус бүрд нь оногдуулж болох өөр өөр хэсгүүдэд заасан хоёр буюу түүнээс дээш гэмт хэрэг үйлдсэн этгээд тэдгээрийн алинд нь ч ял шийтгүүлээгүй бол шүүх гэмт хэрэг тус бүрд нь ял оногдуулж, хөнгөн ялыг хүндэд нь багтаах, эсхүл хэрэг тус бүрт оногдуулсан ялыг хамгийн хүнд ялтай зүйлийн ялын дээд хэмжээний дотор бүгдийг буюу заримыг нэмж нэгтгэн уг этгээдийн биечлэн эдлэх ялыг тогтооно.

57.2.Шүүх гэм буруутай этгээдэд ял оногдуулахдаа энэ хуулийн тусгай ангийн зүйл, хэсэгт заасан нэг буюу хэд хэдэн нэмэгдэл ялыг үндсэн ялтай нь хамт оногдуулж болно.

57.3.Ялтан шүүхээр ял шийтгүүлэхийн өмнө өөр гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн

- Хойшлуулсан буюу ялтай байх хугацаандаа дахин гэмт хэрэг үйлдсэн талаар огт дүгнэлт хийлгүй, түүнчлэн Өршөөл үзүүлэх хуулийг буруу хэрэглэсэн.
- Гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан хохирлыг хэн нөхөн төлөх үүрэгтэйг нэг мөр шийдвэрлээгүй.
- Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 80 дугаар зүйлд заасан хэргийн талаар нотолбол зохих асуудлуудыг бүрэн тогтоогоогүй буюу нотолбол зохих асуудлуудыг нарийвчлан шалгаж нотолж тогтоогоогүй байхад хэргийг эцэслэн шийдвэрлэсэн.
- Мөрдөн байцаалтын шатанд яллагдагчид эрхийг нь тайлбарлан өгч, байцаан шийтгэх ажиллагаа явуулаагүй байхад гэм буруугийн асуудлыг шүүхээр таслан шийдвэрлэсэн.
- Хэргийн мөрдөн байцаалтыг дутуу явуулснаас хэрэгт цугласан нотлох баримтын хүрээнд хэргийг хянан шийдвэрлэх боломжгүй байхад хэргийг шийдвэрлэсэн.
- Хэргийн зүйлчлэлд нөлөөлөхөөр байхад дүгнэлт гаргасан шинжээчийг шүүх хуралдаанд оролцуулаагүй, дан ганц хохирогчийн мэдүүлгээр шүүгдэгчийг гэм буруутай гэж үзсэн.

Иймд дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд дээрх зөрчлийг гаргахгүй байхад анхаарч, Эрүүгийн хуулийг буруу хэрэглэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах асуудалд анхаарал хандуулах шаардлагатай байна. Үүнд:

1. Шүүхийн алдаа зөрчил гарахад нөлөөлж байгаа объектив, субъектив шалтгаан нөхцөлийг судлах;
2. Эрүүгийн хууль тогтоомжийг буруу хэрэглэх асуудлыг судалсан судалгаанд үндэслэн шүүгч нарын дунд хууль хэрэглээний онол практик, хууль тогтоомжийн хэрэглээг сайжруулах, хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтыг үнэлэх, шинжлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зэрэг чиглэлээр шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцэх, харилцан туршлага солилцох хэрэгтэй юм.

---o0o---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ СУРГАЛТЫН www.nlc.edu.mn

шийтгэх тогтоол гарсны дараа тогтоогдвол түүнд энэ зүйлд заасан журмыг баримтлан ял оногдуулна. Ингэж шийдвэрлэхдээ өмнөх шүүхийн шийтгэх тогтоолоор бүрэн буюу хагас эдэлсэн ялыг оруулан тоолно.

ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ, МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ ҮР НӨЛӨӨТЭЙ АРГА ХЭЛБЭР[1]

УДИРТГАЛ

Монгол Улс улс төр, нийгэм, эдийн засгийн шилжилтийн үедээ байгаа орны нэг юм. Энэ нь иргэдийн эрх зүйн ухамсар, соёл төдийлөн төлөвшөөгүй, хууль тогтоомжийн талаарх мэдлэг, ойлголт муу байгаад шууд нөлөөлдөг. Иймээс төрөөс иргэдийн эрх зүйн ерөнхий мэдлэг, ухамсрыг нэмэгдүүлэх үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь нийгэмд шударга ёсыг тогтооход төдийгүй хууль тогтоомжийн хэрэгжилтийг үр дүнтэй хангахад чухал нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Судалгааны зорилт, зорилго: Иргэдийн эрх зүйн боловсролыг нэмэгдүүлэхэд чиглэсэн эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтыг үр дүнтэй явуулах арга замыг тодорхойлох, энэ талаар дотоодын болон гадаад улсын туршлагыг харьцуулан судлах, мөн эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын хүртээмж, чанар, үр нөлөөг сайжруулах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулах зорилготой.

Судалгааны хамрах хүрээ*:* Судалгааны ажлын хүрээнд иргэдийн эрх зүйн мэдлэг, ухамсрыг дээшлүүлэхэд чиглэсэн эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалт явуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх харилцааг зохицуулж буй дотоодын эрх зүйн зохицуулалт болон зарим улсын сайн туршлагыг судлана. Гадаад орнуудаас хөгжингүй орон болох Умард Ирландын Нэгдсэн Вант Улс (цаашид Их Британи гэх), Унгар улс, Бүгд Найрамдах Солонгос (цаашид Солонгос гэх) улсын, шилжилтийн үеийн улс орны төлөөл болгон Оросын Холбооны Улс (цаашид Орос гэх), хөгжиж буй улс орны төлөөлөл болгон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын (цаашид Энэтхэг гэх) туршлагыг тус тус судална.

Судалгааны ажлаар тухайн улс орны онцлог, эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлыг өрнүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлохын зэрэгцээ тухайн улсад хэрэгжүүлж буй эрх зүйн мэдээлэл сурталчилгаа, сургалтыг түгээх арга замыг судална.

Судалгааг хийхдээ баримт бичгийн судалгааны арга, задлан шинжлэх ба нэгтгэн дүгнэх арга, харьцуулалтын арга, хууль тайлбарлах аргуудыг тус тус хэрэглэнэ.

Судалгааны бүтэц*:*

Нэгдүгээр бүлэг: Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалттай холбоотой ерөнхий ойлголт;

Хоёрдугаар бүлэг: Иргэдэд эрх зүйн боловсрол олгоход чиглэсэн арга хэмжээ, туршлагын талаар Монгол Улсын болон гадаад орнуудын харьцуулалт;

Гуравдугаар бүлэг: Дүгнэлт, санал;

Хавсралт №1 Монгол Улсын туршлага

Хавсралт №2 Бүгд найрамдах Энэтхэг Улсын туршлага

Хавсралт №3 Бүгд найрамдах Солонгос Улсын туршлага

Хавсралт №4 Унгар улсын туршлага

[1] Тус судалгааг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан Б.Энх-Амгалан ахлаж, эрдэм шинжилгээний ажилтан Ж.Бариаширсүрэн, Э.Уянга, Ц.Одгэрэл, Б.Гончигсумлаа, Б.Ундрах нар хамтран гүйцэтгэв.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.lri.pmis.gov.mn

Хавсралт №5 Умард Ирландын нэгдсэн вант Улсын туршлага

Хавсралт №6 Оросын Холбооны Улсын туршлага

Хавсралт №7 Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын талаарх Монгол Улсын болон олон улсын эрх зүйн актуудын жагсаалт ба холбогдох зүйл заалтын түүвэр.

I. НЭГ. ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Энэ хэсэгт судалгаатай холбоотой нэр томьёо, сургалт, сурталчилгаа түгээхэд нөлөөлөх хүчин зүйл, түгээгч байгууллага, түгээх арга зам, мэдээлэл түгээх зорилтот бүлгийн талаарх ерөнхий ойлголт, анхаарах асуудлыг авч үзлээ.

1. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалттай холбоотой нэр томьёо

“Эрх зүйн мэдээлэл” гэх ойлголтыг олон улсын хэмжээнд нэгдсэн байдлаар тодорхойлоогүй боловч энэхүү ойлголтын хүрээнд албан ёсны эрх зүйн баримт бичиг болох хууль тогтоомж, олон улсын гэрээ, төрийн байгууллагаас гаргасан дүрэм, журам, шүүхийн шийдвэр болон эрх зүйн ном зохиол, сэтгүүл зэргийг судлаачид нийтлэг байдлаар ойлгож байна.[2]

Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалт нь иргэдийн эрх зүйн ухамсар (*legal awareness*) болон эрх зүйн ерөнхий мэдлэгийг дээшлүүлэн, соён гэгээрүүлэхэд (*legal literacy*) чиглэгддэг. Америкийн Барын Холбоо *(American Bar Association*) эрх зүйн ухамсрыг “хуулийн хэм хэмжээ, процесс, хуулийн эх сурвалжийг ашиглан дүгнэлт хийх мөн соён гэгээрэх чадвар” хэмээн тодорхойлсон. Харин Канадын Барын Холбоо (*Canadian Bar Association*) эрх зүйн ерөнхий мэдлэгийг “хууль эрх зүйн баримт бичгийг ойлгон дүгнэх, үүнийгээ үйлдэл хийхэд, арга хэмжээ авахад ашиглах чадвар” хэмээн тайлбарлажээ.[3]

Иргэдийн эрх зүйн боловсрол, мэдээлэл (*public legal education and information, community legal education, law-related education*)

Гадаад улсуудад эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалттай холбоотой хэрэглэгддэг ерөнхий ойлголтыг авч үзье. Хөгжилтэй улс оронд иргэдийн эрх зүйн ухамсар, мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг ерөнхийд нь иргэдийн эрх зүйн боловсрол (*public legal education*)-ыг дээшлүүлэх болон иргэдэд эрх зүйн мэдээлэл түгээх (*public legal information*) хэмээн ангилдаг.[4]

Тухайлбал, Канад, Их Британи зэрэг хөгжингүй улс орнуудад иргэдийн эрх зүйн боловсрол гэдэгт иргэдийн эрх зүйн ухамсар, ерөнхий мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн мэдээлэл сурталчилгаа, сургалт, соён гэгээрлийн арга хэмжээг ойлгодог.[5] Харин Австрали, АНУ-д нийтийн эрх зүйн боловсрол (*community legal education*) хэмээх нэр томьёог бага орлоготой иргэдэд эрх зүйн ухамсар, ерөнхий мэдлэг түгээх, соён гэгээрүүлэх арга хэмжээний хүрээнд ашигладаг.[6] Түүнчлэн АНУ-д дунд сургууль болон хэвлэл мэдээлэл, бизнесийн чиглэлийн зэрэг зарим их сургуульд эрх зүйн боловсрол олгохыг эрх зүйн хамаарал бүхий боловсрол *(law related-education*) олгох гэж нэрлэдэг. Энэхүү эрх зүйн хамаарал бүхий боловсрол нь тус улсад сургуулиас гадуур иргэдийн эрх зүйн ухамсрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн иргэдийн эрх зүйн боловсролоос ялгаатай ойлголт юм.[7] Гэсэн хэдий ч олон улсын хэмжээнд дээрх нэр томьёонуудыг нэгдсэн байдлаар тодорхойлоогүй учраас улс

---

[2] Rob Richards, What is Legal Information, 2009.

[3] Essay on Legal Awareness, https://en.wikipedia.org/wiki/Legal_awareness

[4] Мөн тэнд.

[5] Мөн тэнд.

[6] ABA Standards, 3.6 on the Provision of Legal Information, American Bar Association.

[7] Essay on Legal Awareness.

бүрийн онцлогоос хамааран харилцан адилгүй агуулга, хүрээтэйгээр ойлгогддог.[8]

Шилжилтийн үеийн буюу пост социалист улсууд, хөгжиж буй Хятад, Энэтхэг, Африк болон Латин Америкийн орнуудад иргэдийн эрх зүйн ухамсар, ерөнхий мэдлэгийг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх ажил дийлэнх тохиолдолд хөгжилтэй улс орны санхүүгийн дэмжлэгтэйгээр өрнөж эхэлсэн.[9] Харин өнөө үед хөгжингүй улс оронтой харьцуулахад хөгжиж буй улс оронд эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажил төрийн бүх шатны байгууллага, иргэний нийгэм, боловсролын байгууллага зэргийн оролцоотойгоор илүү өргөн хүрээнд өрнөж байна.[10] Улмаар хөгжиж буй улс орон эрх зүйн соён гэгээрлийн хөтөлбөр, хууль тогтоомжийг батлан эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлыг иргэдэд эрх зүйн ухамсар, ерөнхий мэдлэг олгох зорилготойгоор өрнүүлж байна.

2. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтыг түгээхэд нөлөөлдөг хүчин зүйлс[11]

Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлыг үр дүнтэй түгээхэд олон хүчин зүйлс нөлөөлдөг. Тухайлбал:[12]

- Нийгэм, эдийн засгийн байдал;
- Ядуурал;
- Эрх зүйн соёл;
- Улс орны эрх зүйн хөгжил;
- Нутаг дэвсгэрийн хэмжээ, газар зүйн байршил;
- Хүн амын нягтаршил;
- Хүн амын боловсролын төвшин;
- Дэд бүтцийн хөгжил;
- Эрх зүйн боловсрол олгох чанар;
- Эрх зүйн боловсрол олгох мэргэжлийн боловсон хүчний чадвар, тоо;
- Бусад хүчин зүйлийг энд дурдаж болох юм.

3. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтыг түгээгч байгууллагууд

Олон төрлийн төрийн болон төрийн бус байгууллага эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлыг явуулдаг. Үүнд голлох үүрэг хүлээдэг Хууль зүйн яам, Хууль зүйн мэдээллийн төв, төрийн бүх шатны байгууллага, хууль хяналтын байгууллагууд, Хуульчдын холбоо, эрх зүйн гэгээрлийн чиглэлээр ажилладаг ТББ-ууд, Олон улсын байгууллагууд, боловсролын бүх шатны сургууль, байгууллагууд, их дээд сургуулийн клиник сургалтын төвүүд болон хэвлэл мэдээллийн байгууллагуудыг дурдаж болох юм. [13]

4. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтыг түгээх зорилтот бүлэг

Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтыг түгээх зорилтот бүлгийг дараах

[8] Developing capable citizens, the role of public legal education, page 16, The report of the PLEAS Task Force, 2007.

[9] Cotula, Lorenzo, Legal Empowerment for Local Resource Control: Securing Local Resource Rights within Foreign Investment Projects in Africa, 2007.

[10] Мөн тэнд.

[11] Батбаярын Оюунцэцэг, Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг орон нутагт зохион байгуулах нь, Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн Хуульчдын сургалт ба давтан сургалт төсөл, 2005. Cotula, Lorenzo, Legal Empowerment for Local Resource Control: Securing Local Resource Rights within Foreign Investment Projects in Africa, 2007.

[12] Мөн тэнд.

[13] Мөн тэнд.

ХУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.mn.gov.mn

байдлаар ангилж болно. Үүнд:[14]

1. Нас, Хүйс /хүүхэд, өндөр настан зэрэг/;
2. Сургагч багш, бизнес эрхлэгчид, хууль сахиулах байгууллагын ажилтан зэрэг;
3. Газар зүйн хүрээгээр /жишээ нь: алслагдмал газар амьдардаг иргэд/;
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд;
5. Хүчирхийлэлд өртсөн хохирогч;
6. Гэмт хэрэгтэн;
7. Бусад.

Үүний зэрэгцээ тодорхой бүлгийн эрэлт хэрэгцээнээс хамааран тодорхой сэдвийн дагуу жишээ нь татвар, зээл, хөдөлмөр эрхлэлт, тэтгэвэр, гэрлэлт зэрэг асуудлын хүрээгээр зорилтот бүлгийг тодорхойлдог.[15]

Үндсэндээ кэйс дээр ажиллах, сонирхолтой түүхээр дамжуулан мэдээлэл түгээх, асуулт хариултын аргыг ашиглах зэргээр харилцан адилгүй эрэлт хэрэгцээ бүхий зорилтот бүлгийн хэрэгцээ, онцлогт нийцүүлэн харилцан адилгүй арга замаар мэдээлэл түгээх нь үр дүнтэй байдаг.[16]

5. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтыг түгээх арга хэрэгсэл[17]

Зорилтот бүлгийн харилцан адилгүй хэрэгцээ шаардлага, онцлогийг харгалзан эрх зүйн мэдээлэл, сурталчилгааг түгээх арга хэрэгсэл нь олон янз байдаг. Үүнд:

- Цахим хэлбэрээр үнэ төлбөргүй хууль эрх зүйн баримт бичиг, ном, сэтгүүл, сонин авах боломжоор олон нийтийг хангах;
- Нийгмийн сүлжээ;
- Ухаалаг утас;
- Ярилцлага, асуулт хариулт;
- Сэдэвчилсэн уралдаан, тэмцээн;
- Өдөрлөг, уулзалт;
- Тоглолт, хошин үзүүлбэр;
- Кино, радио телевизийн нэвтрүүлэг;
- Ном, сонин, сэтгүүл, хэвлэмэл хуудас, мэдээллийн хуудас, товхимол;
- Явуулын видео, аудио, кино;
- Лекц семинар;
- Сэдэвчилсэн түр сургалтууд;
- Олон нийт цугладаг газар эсхүл төрийн байгууллагын өмнө дэлгэцээр шторк, сурталчилгаа, танилцуулга явуулах;
- Бусад арга хэлбэрүүд хамаарна.

Өнөө үед цахим хэлбэрээр мэдээлэл түгээх нь хямд, шуурхай, 24 цагийн турш мэдээлэлтэй танилцах боломжийг сонирхсон иргэнд олгодог давуу талтай хэдий ч уламжлалт буюу хэвлэмэл аргаар мэдээлэл түгээх нь тодорхой бүлгийн

[14] Patricia Byrne, Public legal Education and Information Formats and Delivery Channels, 2014. Developing capable citizens, the role of public legal education, page 16, The report of the PLEAS Task Force, 2007.

[15] Мөн тэнд.

[16] Мөн тэнд, хуудас 15.

[17] Земляченко Л.В., канд. пед. наук, доц. каф. педагогики дошкольного и начального образования, Условия эффективности правового просвещения младших школьников, ГОУ ВПО «Мордовский государственный педагогический институт им. М.Е.Евсевьева», г.Саранск, Республика Мордовия, 2013. Pulikuthiyil, George, "Legal Literacy for Social Empowerment", 2014. jananeethi.org

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

ашиг сонирхлыг илүүтэй хангах үр дүнтэй арга хэлбэр хэвээр байна.[18] Иймд цахим аргаар мэдээлэл авах боломжгүй иргэд болох интернетэд холбогдох боломжгүй эмзэг бүлгийн хүмүүс, өндөр настан зэрэг тодорхой бүлэгт бусад хүртээмжтэй арга хэлбэрээр мэдээлэл түгээх шаардлагатай байдаг.

Видео материал түгээх нь ихээхэн үр дүнтэй ч олон нийтэд видео материалыг түгээхэд өндөр үнэ өртөгтэй гэж тооцогддог байсан. Гэсэн хэдий ч нийгмийн сүлжээ, YouTube зэрэг мэдээллийг хямд, шуурхай түгээх арга дэлгэрснээр видео материалыг түгээх аргыг түлхүү хэрэглэх боломжийг бүрдүүлсэн.

Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан эрх зүйн мэдээллийг түгээх нь нийт иргэдэд хамааралтай хууль эрх зүйн асуудлыг иргэдэд ойлгуулах, таниулахад үр дүнтэй байдаг. Жишээ нь: Их Британид гэр бүлийн эрх зүйн сэдвээр хэвлэл мэдээллийн компанит ажлыг, цахим сайтаар мэдээлэл түгээх аргатай хослуулан явуулжээ. Уг компанит ажлын үеэр өв хөрөнгө, хүүхэд, орон сууц зэрэг хэрэгцээт сэдвээр сэтгүүл, сонин, телевиз, радиогаар мэдээлэл түгээсэн ба дэлгэрэнгүй мэдээлэл, бодит кэйсийг холбогдох цахим сайтад орж үзэх боломжтойгоор хэрэгжүүлсэн нь ихээхэн үр дүнтэй болжээ.[19] Мөн орон нутгийн радио, телевиз нь орон нутгийн асуудалтай холбоотой мэдээлэл түгээхэд илүү үр дүнтэй байдаг.

Дийлэнх хүмүүс тэдний асуудлыг ойлгон, тэдний хэрэгцээнд нийцүүлэн эрх зүйн мэдээллийг өгөх, дэмжлэг үзүүлэх хүнтэй харилцах нь хамгийн үр дүнтэй мэдээлэл авах арга гэж үзсэн нь холбогдох судалгаагаар тогтоогджээ. Иймд олон улсад эрүүл мэндийн ажилтан, нийгмийн ажилтан, хууль сахиулах байгууллагын ажилтан, иргэдтэй ажилладаг төрийн албан хаагч зэрэг мэдээлэл өгөх боломж бүхий хүмүүсийг ‘холбогч’ */intermediary/* ‘албан бус зөвлөгч’ */informal advisers/* зэргээр нэрийдэн иргэдэд эрх зүйн мэдээлэл түгээгч, мэдээллийн ажилтан болгон ашигладаг.[20] Иймд эдгээр хүмүүсийг тэдний чиг үүрэгтэй холбоотой эрх зүйн мэдээллийг иргэдэд зөвлөн түгээгч болгох нь ихээхэн үр дүнтэй, өргөн хэрэглэгддэг арга байна.[21]

Эрх зүйн мэдээлэл зүй ***(legal informatics)***

Мэдээллийн технологи ашиглан дэвшилттэй байдлаар эрх зүйн мэдээллийг түгээх арга замыг эрх зүйн мэдээлэл зүй хэмээн нэрийддэг.[22] Эрх зүйн мэдээллийг хурдан, үнэ төлбөргүй, үр дүнтэй иргэдэд төдийгүй мэргэжлийн хүмүүст түгээх энэхүү арга нь өнөө үед улам боловсронгуй болон хөгжиж буй мэдээллийн шинжлэх ухааны салбар юм.

АНУ-ын Америкийн Номын сангийн холбоо мэдээлэл зүй буюу informatics гэдгийг “мэдээллийн бүтэц, агуулга, зохион байгуулалт, хадгалалт, хайлт, татаж авалт, түгээлтийн судлал” хэмээн тодорхойлсон.[23] Харин *legal informatics* буюу эрх зүйн мэдээлэл зүй гэдэгт эрх зүйн мэдээллийг мэдээллийн технологи ашиглан шинэлэг арга замаар хурдан, үр дүнтэй байдлаар түгээх, ашиглахыг ойлгодог.[24]

Сүүлийн үед мэдээллийн технологийн хөгжилтэй холбоотойгоор эрх зүйн мэдээлэл түгээх төдийгүй хууль зүйн зөвлөгөө өгөх програм, эдийн засгийн хууль тогтоомжийн талаарх мэдээлэл агуулсан хуулийн этгээдэд зориулагдсан програм

---

[18] Better information Handbook, ASA Advicenow, 12, 2009.

[19] Мөн тэнд.

[20] Мөн тэнд, хуудас 13.

[21] Мөн тэнд.

[22] Legal Informatics Blog, https://legalinformatics.wordpress.com

[23] Christopher L. Hinson, Legal Informatics: Opportunities for Information Science, Journal of Education for Library and Information Science, 2005.

[24] Мөн тэнд.

зэрэг олон шинэлэг эрх зүйн мэдлэг, мэдээлэл түгээх арга зам бий болсоор байна.

6. Эрх зүйн мэдээлэл**,** сурталчилгаа, сургалтыг зохион байгуулахад анхаарах асуудал

Мэдээлэл, сурталчилгааны материал түгээхэд дараах зүйлийг анхаарах шаардлагатай байдаг. Үүнд:[25]

- Зорилтот бүлгийн онцлогт тохирсон, тэдний эрэлт хэрэгцээнд нийцүүлэн тохиромжтой хэлбэрээр, нээлттэй, хүртээмжтэй, тасралтгүй түгээх;
- Ойлгомжтой энгийнээр бичих буюу иргэдэд ойлгомжтой, хуулийн бус үг хэллэг ашиглах;
- Мэдээллийн дизайн /текст, зураг, график зэргийн балансыг хангах/;
- Хууль тоочих бус хуулийг тайлбарлах, мөн чанарыг нь ойлгуулах;
- Олон төрлийн арга, хэрэгсэл ашиглан харилцан адилгүй зорилтот бүлэгт мэдээлэл сурталчилгааг түгээх, сургалтыг зохион байгуулах;
- Бусад.

Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтыг үр дүнтэй түгээхэд юуны түрүүнд тухайн зорилтот бүлгийн эрх зүйн мэдээллийн хэрэгцээ шаардлагыг тогтоох, тухайн зорилтот бүлгийн онцлогт /нас, хүйс, хотод эсхүл алслагдмал газар амьдардаг зэрэг/ тохируулан эрх зүйн мэдээллээ боловсруулах, мэдээлэл түгээх арга хэмжээний төлөвлөгөөг гаргах, эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтыг удирдан зохион байгуулах, үнэлэх үе шатыг тодорхой тусгасан эргэх холбоо бүхий тогтолцоо бий болгох асуудлыг анхаарах шаардлагатай байдаг.[26]

Нэгтгэн дүгнэхэд эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажил нь олон төрлийн хүчин зүйлээс хамааран, олон төрлийн арга хэрэгслээр, олон хариуцагч байгууллага мөн харилцан адилгүй зорилтот бүлэгт чиглэгдэн хэрэгждэг байна.

ХОЁР. ХАРЬЦУУЛСАН ДҮН ШИНЖИЛГЭЭ

1. Гадаад орнуудын эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлын арга барилд нөлөөлж буй хүчин зүйлс ба түүний онцлог

Энэ судалгааны хүрээнд хөгжилтэй улсын төлөөлөл болгон Их Британи, Унгар, Азийн өндөр хөгжилтэй улсын төлөөлөл болгон Солонгос, хөгжиж буй улсын төлөөлөл болгон Энэтхэг, шилжилтийн эдийн засагтай улсын төлөөлөл болгон ОХУ-ын туршлагыг тус тус сонгон судалсан болно.

Их Британи**,** Унгар улсад иргэдийн эрх зүйн ухамсар, мэдлэг, боловсрол харьцангуй төлөвшсөн учир хууль дээдлэх, түүнийг дагаж мөрдөх сэтгэлгээ, соёл, ёс суртахууны төлөвшил өндөр орнуудад тооцогддог. Солонгос эдийн засгийн өндөр хөгжилтэй ч нийгмийн эрх зүйн ухамсар, мэдлэгийг цаашид төгөлдөржүүлэх шаардлагатай гэж үздэг орнуудын нэг. Харин Энэтхэг өөрийн улсын нийгмийн онцлогтой холбоотойгоор тодорхой зорилтот бүлэг болох ядуус, алслагдмал газар амьдардаг иргэдэд чиглэсэн өргөн хүрээний эрх зүйн ухамсар нэмэгдүүлэх, чадавхжуулах ажлыг өрнүүлж хэвшсэн улс бол ОХУ нь нийгэм, эдийн засгийн хувьд шилжилтийн үеийн улс бөгөөд үүнтэй холбоотойгоор иргэдийн эрх зүйн мэдлэг ухамсрыг нэмэгдүүлэх, чадавхжуулах олон ажил өрнүүлж буй орон юм.

[25] Мөн тэнд.

[26] *Н.А. Гарашкин,* **Сущность и формы социально-правового просвещение населения,** г. филиал Академии правосудия Воронеж, 2012. Better information Handbook, ASA Advicenow, 2009.

Ийнхүү өөрөөрийн онцлогтой улсорны туршлагыг харьцуулан судалснаар манай улсын нийгэм, эдийн засгийн онцлогт тохирсон эрх зүйн мэдээлэл сурталчилгаа, сургалтын үр нөлөөтэй арга замыг тодорхойлохыг зорьсон. Тухайлбал, Энэтхэгийн ядуус, алсмагдмал газар амьдардаг хүмүүст эрх зүйн мэдлэг, ухамсарыг үр дүнтэй олгох туршлага, Унгар болон Их Британийн эрх зүйн мэдлэг олгох үр дүнтэй арга зам, Солонгосын иргэдийн эрх зүйн боловсролыг төгөлдөржүүлэх бодлого, Оросын үйл ажиллагааг зохион байгуулах арга зам зэргээс манай улс өөрийн улсын онцлогт нийцүүлэн нутагшуулах боломжтой.

2. Гадаад орнуудын эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, эрх зүйн соён гэгээрэл, эрх зүйн ухамсар, соёл, иргэний эрх зүйн боловсролыг дээшлүүлэх талаар хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөр, санаачилга, хууль тогтоомж, төслийн тухайд

Энэтхэг нь өөрийн улсын онцлогтой холбоотойгоор эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, соён гэгээрлийн үйл ажиллагаанд онцгой ач холбогдол өгдөг. Тийм ч учраас тус улс “Хууль зүйн мэдээллийн байгууллагын тухай”[27] дагнасан хуулийг баталсан. Уг хуулийн хүрээнд хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх, эрх зүйн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх үндэсний сүлжээ орон даяар бий болсон байна. Уг сүлжээгээр дамжуулан иргэдийн эрх зүйн мэдлэг, ухамсрыг нэмэгдүүлэн чадавхжуулах, мөн хууль зүйн зөвлөгөөг шаардлагатай иргэдэд нээлттэй, хялбар үзүүлэх замаар төрийн байгууллагуудаас ард иргэдийг хохироох, хуульд заасан эрхийг хязгаарлах асуудлыг шийдвэрлэхийг зорьсон.

Солонгос бүх нийтийн эрх зүйн мэдлэг, ухамсрыг нэмэгдүүлэхэд онцгой ач холбогдол өгөн 2008 онд иргэдийн эрх зүйн мэдлэг, ухамсрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн “Эрх зүйн боловсролыг дэмжих тухай”[28] хуулийг баталсан. Тус хуулийн хүрээнд эрх зүйн мэргэжлийн боловсролоос бусад залуу үе, нийт иргэдэд чиглэсэн эрх зүйн ерөнхий мэдлэг, ухамсрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бүхий л арга хэмжээг эрх зүйн боловсролын хүрээнд ойлгохоор өргөн хүрээнд тодорхойлсон.

Унгар улсад эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, эрх зүйн соён гэгээрэл, эрх зүйн ухамсар, соёл, иргэний эрх зүйн боловсрол олгох ажиллагааг эрх зүйн мэдлэг олгох, хууль зүйн туслалцаа үзүүлэх гэж 2 ангилж үздэг. Эхнийхийг тусгай төсөл, хөтөлбөр боловсруулан тодорхой асуудлын хүрээнд зорилтот бүлэгт чиглүүлэн хэрэгжүүлдэг. Удаахыг нь иргэнийхээ өмнө хүлээсэн төрийн үүрэг гэж үзэн эдийн засаг, нийгмийн эмзэг бүлэгт хамрах иргэдэд үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх хэлбэрээр хэрэгжүүлдэг. Энэ үйлчилгээ хэрэгцээ, шаардлагаа нотолж чадсан эрүү, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч оролцогчид нээлттэй аж. Хууль зүйн туслалцааны үйлчилгээ үзүүлэгч нь өмгөөлөгчийн нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн өмгөөлөгч, энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллага, их сургуулийн багш нар байдаг байна. Тус улс нь шилжилтийн үед олон тооны эрх зүйн мэдлэг, ухамсар нэмэгдүүлэх төрийн хөтөлбөр, бодлогыг батлан хэрэгжүүлж байсныг судалгааны хүрээнд авч үзсэн билээ.

Их Британид эрх зүйн мэдээлэл сурталчилгаа, сургалтын чиглэлээр төрөөс баталсан тодорхой бодлого, хөтөлбөр, хууль байдаггүй.

ОХУ-д 2005 оноос эхлэн иргэдэд эрх зүйн мэдлэг олгох, эрх зүйн соёл эзэмшүүлэх асуудлыг онцгой анхаарч ирсэн. Холбооны Ерөнхий прокурор эрх зүйн соён гэгээрлийн үйлст дэмжлэг үзүүлэх, хувь нэмрээ оруулах талаар тушаалыг 2008 онд гаргаж байсан. Иймд прокурорууд өөрсдийн чиг үүргийн тухайд иргэдэд мэдээлэл түгээх, мэдлэг олгох ажлыг идэвхтэй өрнүүлдэг. 2012 онд эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлыг өрнүүлэх үндсэн чиглэл, арга хэмжээг

[27] Эх сурвалж: Судалгааны ажлын хавсралт 2-оос дэлгэрүүлж үзнэ үү.

[28] Судалгааны ажлын Хавсралт 3-аас дэлгэрүүлж үзнэ үү.

тусгасан “ОХУ-ын Иргэдийн эрх зүйн ерөнхий мэдлэг, ухамсрыг дээшлүүлэх талаарх ОХУ-ын төрийн бодлого”-ыг[29] Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан. Энэ нь эрх тэгш, шударга нийгмийг бий болгоход иргэдээ чадавхжуулах нь нэн чухал асуудал гэж үзсэнтэй холбоотой. Мөн тус улсын иргэдийн эрх зүйн боловсрол хангалтгүй байгаа гэж холбогдох судалгаагаар тогтоогдсонтой ч холбоотой юм. Иймд тус улс нь эрх зүйн мэдээлэл сурталчилгаа, сургалтын ажилд төрийн дээд төвшинд онцгой ач холбогдол өгөн, улс орон даяар мэдээлэл сурталчилгаа, сургалтын ажлыг өргөнөөр өрнүүлдэг.

Манай улсад иргэдийн эрх зүйн боловсролыг нэмэгдүүлэхэд чиглэсэн эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажил нь иргэдийг мэдлэг, мэдээлэл олж авах боломжоор хангах, албан болон албан бус сургалтын тогтолцооны хүрээнд сургах, хууль зүйн зөвлөгөө өгөх зэрэг арга хэлбэрээр хэрэгжиж байна. Ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш цаг үеийн шаардлагад нийцүүлэн иргэдийн эрх зүйн боловсролтой холбоотой олон бодлогын баримт бичгийг төрөөс баталсан байна. Эдгээр баримт бичгүүд нь иргэдийн эрх зүйн боловсролын хүрээнд төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох гол үүрэг гүйцэтгэж байгаа тул цаашдын бодлогыг тодорхойлоход анхааран авч үзэх шаардлагатай юм. Үндсэндээ манай улсад эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалттай холбоотой олон тооны баримт бичиг батлагдсан боловч тэдгээрт эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалттай холбоотой зохион байгуулалт, харилцан уялдаа, арга зүй, арга хэмжээ, санхүүжилт зэрэг олон асуудал тодорхойгүй байна.

3. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа түгээгч байгууллага, чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа

Энэтхэгийн Хууль зүйн мэдээллийн байгууллагын тухай хуулийн дагуу Хууль зүйн үйлчилгээний үндэсний байгууллагыг Дээд шүүхийг түшиглэн, харин мужуудын төвшинд хууль зүйн үйлчилгээний байгууллагыг мужийн/дүүргийн шүүхийг түшиглэн бий болгосон. Шүүхүүдийг түшиглэсэн хууль зүйн үйлчилгээний байгууллагыг тухайн шүүхийн ерөнхий шүүгч/дүүргийн шүүгч удирддаг.

Энэтхэгийн Хууль зүйн үйлчилгээний үндэсний байгууллага нь холбогдох бодлогыг тодорхойлох, улс даяар хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөг удирдан чиглүүлэх, мужийн хууль зүйн үйлчилгээний байгууллагыг нэгдсэн арга зүйгээр хангах, олон нийтийн болон иргэний нийгмийн байгууллагаас санаачилсан тодорхой арга хэмжээг санхүүжүүлэх, эмзэг бүлгийн иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх, хамтын ажиллагааг хангах, тодорхой хөтөлбөр төслийн хэрэгжилтийг үнэлэх, зэрэг өргөн чиг үүрэгтэй. Орон нутгийн хууль зүйн үйлчилгээний байгууллагууд нь тухайн орон нутгийн онцлогт тохирсон эрх зүйн ухамсар, мэдлэг олгох болон зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулдаг.

Үүнээс харахад тус улсад иргэдийг эрх зүйн мэдээллээр хангах, соёл төлөвшүүлэх, зөвлөгөө өгөх дэд бүтэц, сүлжээг тус улсын иргэдэд хамгийн ойлгомжтой, ойр байрлах, иргэдэд хүрч ажиллах боломжтой шат шатны шүүхүүдийг түшиглэн бий болгосон нь онцлог байна. Шүүхүүдийг иргэдэд илүү нээлттэй, хууль зүйн зөвлөн туслах нэгж болгосноор тус улсын төрийн байгууллагуудаас иргэдийг мөлжин, хохироодог асуудлыг үр дүнтэй шийдвэрлэхийг зорьсон байна.

Солонгост бүх төрлийн үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагуудад өөрсдийн чиг үүрэг, харьяалах нутаг дэвсгэрийн хүрээнд эрх зүйн боловсролыг дэмжих, түгээхийг үүрэг болгосон. Мөн эрх зүйн боловсролын бодлогыг тодорхойлох, арга зүйгээр хангах, аливаа арга хэмжээ, төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх, төсвийн үр ашигтай ашиглалтыг хангах эрх зүйн боловсролын асуудлыг зөвлөн

[29] Судалгааны ажлын Хавсралт 6-аас дэлгэрүүлж үзнэ үү.

чиглүүлэх “Эрх зүйн боловсролын хороо”-г[30] төрийн төв байгууллага, төрийн албанд ажилладаггүй гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр Хууль зүйн яамны харьяанд байгуулсан. Энэхүү бодлого тодорхойлох, зөвлөн чиглүүлэх чиг үүрэг бүхий Хорооноос гадна эрх зүйн боловсролын чиглэлээр дагнан мэргэшсэн “Эрх зүйн соёлыг түгээгч төв”-ийг[31] Хууль зүйн сайд байгуулах бүрэн эрхтэй. Хууль зүйн сайдад эрх зүйн боловсролын бодлого, хөтөлбөр тодорхойлох, хэрэгжүүлэх хүрээнд бүхий л төрийн байгууллагын дарга нарт шаардлага хүргүүлэх эрхийг олгосноор төрийн байгууллагуудын үр дүнтэй хамтын ажиллагааг хангах нөхцөлийг бүрдүүлсэн.

Унгарт эрх зүйн мэдлэг, боловсрол олгох, соён гэгээрүүлэх, сурталчлах чиг үүргийг бүхэлд нь хариуцсан нэгдсэн байгууллага, бүтэц байхгүй. Энэ төрлийн үйл ажиллагааг төрийн байгууллага тус бүр өөрийн эрхэлсэн асуудал, чиг үүргийн хүрээнд хариуцан ажилладаг. Төрийн байгууллагаас илүүтэй ТББ, олон улсын байгууллага иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн нийтэд тустай үйл ажиллагааг сайн дурын үндсэн дээр явуулдаг. Иймд төрөөс эдгээр байгууллагын үйл ажиллагаа, санхүүжилтэд анхаарал тавьж, дэмжиж ажилладаг. Нутгийн өөрөө удирдах байгууллагууд орон нутгийн онцлог, иргэдийн эрхэлж буй ажил хөдөлмөр, аж байдал, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд нөлөөлөх, тухайн орон нутагт илүү хамаарах асуудлын хүрээнд эрх зүйн мэдлэг олгох, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулдаг.

Их Британид мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлыг гүйцэтгэх тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн байгууллага байдаггүй. Харин Их Британийн төрийн байгууллагууд өөрийн чиг үүргийн хүрээнд эрх зүйн асуудлаар иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагааг бие даан өрнүүлж хэвшсэн. Их Британийн ТББ, мэргэжлийн холбоод нь чадавхтай, төлөвшсөн учраас тэднийг төрөөс идэвхтэй санхүүжүүлэн олон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Дийлэнх тохиолдолд ТББ нь тодорхой зорилтот бүлэг болон тодорхой хууль зүйн асуудлаар дагнан мэдээлэл сурталчилгаа, сургалтын ажил өрнүүлдэг. Зарим тохиолдолд Хууль зүйн яам болон бусад төрийн байгууллага нь тодорхой асуудлаар зохих арга хэмжээ авч ажиллахыг тухайн асуудлаар мэргэшсэн ТББ-д гэрээлэн даалгадаг.

ОХУ-ын Москва хотын хувьд хотын захирагчийн тушаалаар иргэдийн эрх зүйн ухамсрыг дээшлүүлэх, үйл ажиллагааг зохицуулан холбох зөвлөлийг боловсрол, эрүүл мэнд, соёл, хэвлэл мэдээлэл хариуцсан яамдаас мөн засаг захиргааны удирдлагын болон нэр бүхий төрийн бус байгууллагын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй байгуулан, зөвлөлийн үйл ажиллагааны журмыг баталсан. Улмаар уг зөвлөл нь хотын хэмжээнд иргэдэд эрх зүйн соёл төлөвшүүлэх, мэдлэг олгох үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг баталдаг ба ийнхүү батлахдаа төрийн байгууллагуудын чиг үүргийн дагуу тэдэнд тодорхой төрлийн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажил гүйцэтгэхийг үүрэг болгодог. Улмаар төрийн төв болон шат шатны захиргааны байгууллагууд нь өөрийн чиг үүргийн хүрээнд эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлыг гүйцэтгэдэг төдийгүй төрийн байгууллагууд, мэргэжлийн холбоод, ТББ хамтран мэдээлэл сурталчилгааны ажлыг өрнүүлдэг.

Тухайлбал, Хүний эрхийн комисс эрх зүйн асуудлаар иргэдтэй харилцах, тэдэнд өөрийн чиг үүргийн хүрээнд мэдээлэл өгөхөөс гадна Хуульчдын холбоо, Нотариатчдын холбоо, хорих анги, урьдчилан хорих газар, телевиз, радио, сонин сэтгүүлтэй нягт хамтран ажиллаж эрх зүйн ухамсар, мэдлэг олгох ажлыг өрнүүлдэг. Дотоод хэргийн яам нь иргэдэд зориулсан мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлыг зохион байгуулах үндсэн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлдэг. Хэвлэл мэдээллийн яам өндөр оролцоотой ажилладаг. Тус яам нь олон төрлийн хэвлэмэл

[30] Судалгааны ажлын Хавсралт 3-аас дэлгэрүүлж үзнэ үү.

[31] Мөн тэнд.

бүтээгдэхүүн, телевиз радиогийн нэвтрүүлгийг төрийн байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран эрхлэн гаргадаг. Үүнээс гадна иргэдийн сонирхсон сэдэв, асуултад мэргэжлийн хүмүүс хариулах, зөвлөх боломжийг бүрдүүлэх онлайн конференцийг зохион байгуулдаг нь онцлуушталй юм. Мөн Төрийн Хууль зүйн туслалцааны төв, Нотариатчдын танхим, Хуульчдын холбоо зэрэг мэргэжлийн байгууллагууд нь эрх зүйн мэдээлэл сурталчилгаа, сургалтын ажилд идэвхтэй оролцон өөрсдийн хувь нэмрийг оруулдаг. Үүний зэрэгцээ төрийн байгууллагууд нь өөрийн чиг үүргийн хүрээний эрх зүйн мэдээлэл, зөвлөгөө өгөх ажлыг хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран зохион байгуулдаг.

Монгол Улсын тухайд эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлыг ХЗДХЯ, түүний харьяа Хууль зүйн үндэсний хүрээлэн зохион байгуулж байна. Тус хүрээлэн нь өөрийн чиг үүргийн хүрээнд эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлыг өрнүүлдэг боловч өнөөгийн байдлаар эрх зүйн мэдээлэл сурталчилгаа болон сургалт хариуцсан тус бүр нэг мэргэжилтэнтэй. Иймд тус хүрээлэнгээс улсын хэмжээнд иргэдийн эрх зүйн мэдлэг, ухамсрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх боломжгүй байдалд хүргэж байна. Мөн 2015 онд батлагдсан, 2017 оноос хэрэгжиж эхэлсэн “Хууль тогтоомжийн тухай” хуулийн дагуу хууль тогтоомжийг олон нийтэд таниулах ажлыг нийт төрийн байгууллагууд, засаг дарга нар өөрийн бүрэн эрх, чиг үүргийн дагуу харьяалах салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулахаар зохицуулжээ. Ийнхүү хууль тогтоомжийг сурталчлах ажлыг төвлөрсөн бус байдлаар бүхий л төрийн байгууллагуудад даалгасан нь сайшаалтай юм. Гэсэн хэдий ч иргэдийн эрх зүйн мэдлэг, ухамсрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулахыг бүх шатны төрийн байгууллагуудад хариуцуулаагүй нь учир дутагдалтай байна.

Түүнчлэн төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх Хууль зүйн туслалцааны төв нь өнөөгийн байдлаар зөвхөн эрүүгийн хэрэгт холбогдсон төлбөрийн чадваргүй иргэдэд туслалцаа үзүүлж байгаа учраас төрөөс хүний эрхийг хангах үүргээ зүй ёсоор биелүүлэхийн тулд бусад салбар эрх зүйн асуудлаар төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөлөл, зөвлөгөө авах боломжоор хангах асуудал шийдвэрлэгдээгүй хэвээр байна.

4. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгааг хүлээн авах зорилтод бүлгийг тодорхойлсон байдал, авч хэрэгжүүлдэг арга хэмжээ

Энэтхэг өөрийн улсын онцлогт нийцүүлэн эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ядуус, алслагдмал газар амьдардаг иргэд, хоригдол, халамж асрамжийн газрын хүүхдүүд зэрэг эрх зүйн зохих ёсны мэдлэггүйгээс болж эрх ашиг нь зөрчигдөх магадлалтай зорилтот бүлэгт чиглэсэн эрх зүйн мэдлэг олгох арга хэмжээг түлхүү авч хэрэгжүүлдэг.

Солонгосын тухайд эрх зүйн боловсролыг хүүхэд, залуучуудад албан сургалтын хүрээнд олгохыг “Эрх зүйн боловсролын тухай хууль”-д заасан төдийгүй нийт иргэдэд чиглэсэн эрх зүйн боловсролыг олгох асуудлыг ч уг хуулиар зохицуулсан. Ялангуяа нийт иргэдэд чиглэсэн сургалтыг зохион байгуулдаг эрх зүйн боловсролын байгууллагыг “Насан туршийн боловсролын тухай” хуулийн хүрээнд ажилладаг байгууллагатай ижил төвшинд тодорхойлсон нь эрх зүйн боловсролыг насан туршийн боловсрол хэмээн үзсэнтэй холбоотой болов уу.

Унгар улсад ерөнхий боловсрол олгох сургалтын хөтөлбөрт эрх зүйн мэдлэг олгох хичээлийг бага ангид хүүхдийн эрх, хүний үндсэн эрх сэдвийн хүрээнд, дунд ангид нийгэм, эдийн засаг, эрх зүйн орчны тухай ерөнхий мэдлэг олгох чиглэлээр оруулдаг. Харин мэргэжлийн боловсрол олгох коллеж, сургалтын төв, их сургуулиудад оюутан, сурагчдын эзэмшиж буй мэргэжилтэй холбоотой хууль, эрх зүйн мэдлэг олгох хичээлүүдийн заавал сонгон судлах хичээл болгон оруулдаг

байна. Зорилтот бүлгийн тухайд тухайн орон нутгийн онцлог, иргэдийн эрхэлж буй ажил хөдөлмөр, аж байдал, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд нөлөөлөх, тухайн орон нутагт илүү хамаарах асуудлын хүрээнд эрх зүйн мэдлэг олгох, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулдаг.

Их Британид өсвөр үеийнхний эрх зүйн боловсролд түлхүү анхаардаг. Энэ чиглэлээр дагнан мэргэшсэн ТББ-ууд байдаг. Хүүхдэд эрх зүйн боловсрол олгох арга барилын тухайд мэргэжлийн хүмүүсийг оролцуулан тэдэнд мэдээлэл өгөх, хүүхдийн оролцоог хангасан арга барилаар харилцан яриа өрнүүлэх, мэтгэлцээн уралдаан зохион байгуулах, шүүх байгууллагын үйл ажиллагаатай танилцуулах зэрэг олон төрлийн арга хэлбэрээр, улс төр, эдийн засаг, нийгэм, аюулгүй байдал зэрэг өргөн хүрээний сэдвээр хүүхдэд эрх зүйн боловсрол олгодог.

ОХУ-ын хувьд эрх зүйн мэдээлэл түгээхдээ дараах зорилтот бүлгүүдийг онцгой анхаарч үздэг байна. Үүнд:

- Хүүхэд багачуудад эрх зүйн ерөнхий мэдлэг олгох, эрх зүйн соёлтой иргэн болж төлөвшихөд нь онцлон анхаарах;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настан, эрх чөлөөгөө хязгаарлуулсан этгээд зэрэг тодорхой хууль эрх зүйн асуудлаар мэдлэг шаардлагатай зорилтот бүлэгт онцлон мэдээлэл түгээх зэрэг хамаарна.

Боловсролын яам нь ерөнхий боловсролын сургуулийн төвшинд төдийгүй мэргэжлийн сургалтын төв, коллежид эрх зүйн мэдлэг олгох суурь болон сонгон суралцах хичээлийг өргөнөөр оруулж байна. Үүнээс гадна эрх зүйн тодорхой нэг сэдвээр олимпиад зохион байгуулах; мансуурах бодисын эсрэг, эрүүл амьдралын хэв маягийг дэмжих зэрэг тодорхой чиглэлээр өдөрлөг, тэмцээн, семинар, конференц, мэтгэлцээний уралдаан зохион байгуулах зэрэг олон төрлийн ажлыг хүүхдэд эрх зүйн мэдлэг олгох цогц ажлын хүрээнд гүйцэтгэж байна. Яамд мэргэжлийн хуулийн сургуулиудтай хамтран иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх ажлыг мөн өрнүүлдэг. Мөн сургуулиуд дээр эрх зүйн буланг сургуулийн оюутны холбоо, сурагчдын зөвлөл нь хариуцан эрхлэн гаргадаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настан, гэмт хэрэг үйлдсэн, үйлдэх эрсдэлтэй хүүхдүүдэд зориулсан мэдээлэл сурталчилгаа, сургалтын ажлыг Нийгмийн хамгаллын яам хариуцан зохион байгуулдаг. Нийгмийн хамгаллын яам хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл, халамж үйлчилгээ, хүүхдийг гэмт хэрэг болон бусдад гэм хор учруулахаас урьдчилан сэргийлэх зэрэг хэрэгцээт эрх зүйн мэдээллээр гарын авлага, мэдээллийн хуудас, товхимол, брошюр зэргийг нэгдсэн байдлаар бэлтгэн шат шатны өөрийн харьяа байгууллагуудаар дамжуулан иргэдэд түгээдэг. Хорих анги, урьдчилан хорих газар эрх чөлөөгөө хязгаарлуулж байгаа иргэдэд мэдээлэл, зөвлөгөө өгөх ажлыг хорих анги болон урьдчилан хорих газрын захиргаанаас зохион байгуулдаг. Төрийн байгууллагууд нь өөрсдийн албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулдаг.

Манай улсын тухайд эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтыг онцлон хүргэх тодорхой зорилтот бүлгийг төрийн бодлогын баримт бичигт тусгаагүй байна. Хүүхэд залуучуудад эрх зүйн ерөнхий мэдлэг олгох хичээлийг албан боловсролын тогтолцооны хүрээнд ерөнхий боловсролын болон дээд боловсролын сургуулиудад зааж байна. Гэсэн хэдий ч албан боловсролын тогтолцооны хүрээнд эрх зүйн мэдлэг олгох сургалтаар өнөөгийн нийгэмд залуучууд зохих хэмжээнд зайлшгүй мэдэж байх ёстой хөдөлмөр эрхлэлт, зээл, татвар, ажилгүйдэл, гэр бүл, санхүү, цахим аюулгүй орчин, гэмт хэрэг, зөрчил зэрэг асуудлын талаарх тодорхой ойлголт, мэдлэг чадавхыг олгож байгаа эсэх нь тодорхойгүй байна. Тиймээс эрх зүйн албан сургалтын тогтолцооны хүрээнд тэдэнд өнөөгийн нийгэмд өөрт тулгарсан эрх зүйн асуудлаа бие даан шийдвэрлэх мэдлэгийг, үр өгөөжтэй арга барилаар олгож чадаж

байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, анхаарах, шинэчлэх шаардлагатай асуудлыг тодруулах нь зүйтэй байна.

5. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа түгээх арга зам, хэрэгжүүлэх процесс

Энэтхэгт төрийн хууль зүйн үйлчилгээний байгууллага нь хорих анги, боловсролын байгууллага, асрамжийн газар, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, сайн дурын ажилчидтай хамтран эрх зүйн мэдлэг, ухамсрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн эрх зүйн мэдээлэл сурталчилгаа хийх, зөвлөгөө өгөх, соён гэгээрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Үүнээс гадна утсаар хууль зүйн зөвлөгөө өгдөг онцлогтой байна.

Солонгос “Эрх зүйн боловсролын тухай хууль”-даа эрх зүйн боловсрол олгох чиг үүрэг бүхий байгууллага, хамтын ажиллагаа, зохион байгуулалт, санхүүжилт зэрэг асуудлыг үр дүнтэй шийдвэрлэх тодорхой механизмыг бий болгосон зохицуулалт оруулсан.

Унгарт иргэдийн эрх зүйн мэдлэг, ухамсрын төвшинг тодорхойлох зорилгоор эрх зүйн социологи судалгааг буюу суурь судалгааг дунджаар 10-10 жилийн давтамжтайгаар тогтмол хийж хэвшсэн байна. Судалгаа шинжилгээний ажлыг Унгарын Шинжлэх ухааны академи, ТББ, эрдэмтэн судлаач, багш нар хамтран, эсхүл бие даан гүйцэтгэдэг. Эдгээр судалгаанд суурилсан төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах замаар эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа хийх арга хэлбэрээ тодорхойлдог.

Их Британид мэргэжлийн холбоод Тухайлбал, Хуульчдын холбоо, шүүгчид, хуулийн сургуулийн оюутнууд зэрэг энэ салбарын мэргэжилтнүүдийг иргэдэд эрх зүйн боловсрол олгох ажилд дайчилдаг сайн туршлага байна.

ОХУ нь холбооны төвшинд төрийн бодлогыг тодорхойлон төрийн захиргааны төв болон төрийн шат шатны захиргааны байгууллагуудын хүчийг чиг үүргийн нь хүрээнд дайчлан, нэмэлт чиг үүрэг болгон өгөх замаар эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлыг өргөн цар хүрээнд, харилцан уялдаатайгаар, системтэй, нүсэр байдлаар өрнүүлж байна. Улс орны нөхцөл байдлыг харгалзан цаашид эрх зүйн соён гэгээрлийн үйл ажиллагааг урт хугацааны стратеги, хөтөлбөрийн хүрээнд, төрийн байгууллагуудын хүчийг нэгтгэн, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулан хэрэгжүүлэх нь зүйтэй гэж тус улсын судлаачид үзэж байна.

Манай улсын тухайд үндсэндээ эрх зүйн мэдлэг, ухамсар олгох, эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа түгээх асуудлыг тал бүрийн оролцоог, харилцан уялдаатай, зохион байгуулалттай, нэгдсэн арга зүйтэй, үр дүнтэй, байдлаар шийдвэрлэж чадаагүй байгааг цаашид анхаарах шаардлагатай юм.

ГУРАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

1. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлын арга барилд нөлөөлж буй хүчин зүйл, онцлог

Манай улсад эрх зүйн соёл, иргэдийн эрх зүйн ухамсар төдийлөн төлөвшөөгүй байгаа учраас иргэдийн эрх зүйн мэдлэг, ухамсрыг нэмэгдүүлэх ажлыг төрийн бодлогын төвшинд авч үзэн шат дараатай, зохион байгуулалттай, харилцан уялдаатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь хэрэгтэй байна. Ялангуяа э***рх зүйн мэдээлэл сурталчилгаа, сургалтыг үр дүнтэй өрнүүлэхэд нийгэм, эдийн засгийн байдал, газар нутаг, хүн амын нягтаршил, боловсролын төвшин, эрх зүйн боловсрол олгох боловсон хүчин зэрэг олон асуудлыг анхаарах шаардлагатай бөгөөд эдгээр*** арга хэмжээг бүс нутаг, аймаг, хотуудын онцлогт тохируулан боловсруулдаг байхад анхаарах шаардлага байна.

Гадаад орнуудын туршлагаас харахад юуны түрүүнд иргэдийн эрх зүйн ухамсар, мэдлэгийн төвшнийг судлах /Унгар/ шаардлагатай бөгөөд үүнд тулгуурласан бодлого боловсруулж өөрийн орны онцлогт тохирсон /Энэтхэг/ арга хэмжээг сонгох шаардлагатай юм. Хэрэгжүүлэх арга замыг сонгохдоо төрийн байгууллагуудыг бүх шатанд нь ашиглаж буй ОХУ-ын туршлага болон хууль эрх зүйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллага, мэргэшсэн боловсон хүчин болон энэ чиглэлээр суралцаж буй оюутан сурагчдыг дайчилдаг Их Британий туршлагаас суралцах зүйл их байна гэж үзлээ.

2. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, эрх зүйн соён гэгээрэл, эрх зүйн ухамсар, соёл, иргэний эрх зүйн боловсролын талаарх бодлого, хөтөлбөр, санаачилга, хууль тогтоомж, төсөл

Иргэдийн эрх зүйн мэдлэг, ухамсрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын баримт бичигт эрх зүйн мэдлэг, соёл, ухамсар төлөвшүүлэх арга хэмжээний үндсэн чиглэл, албан болон албан бус сургалтын хүрээнд баримтлах бодлого, төрийн болон ТББ, мэргэжлийн холбоодын чиг үүрэг, тэдний үйл ажиллагааны уялдаа, зохион байгуулалт, санхүүжилтийн асуудал, эрх зүйн мэдлэгийг онцгой анхааран хүргэх зорилтот бүлэг, хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх асуудал зэргийг зөвлөлдөн шийдвэрлэж тусгах нь зүйтэй байна. Энэхүү төрийн бодлогын баримт бичгийг нийгэмд эрх зүйн соёл, мэдлэг, ухамсар төлөвших хүртэл үр дүнтэй, тууштай хэрэгжүүлэх шаардлагатай юм.

3. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа түгээгч байгууллага, чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа

Сонгон судалсан гадаад орнуудад төрийн байгууллагууд өөрсдийн чиг үүрэг, харьяалах нутаг дэвсгэрийн хүрээнд иргэдэд эрх зүйн мэдлэг, мэдээлэл олгох ажлыг өрнүүлж хэвшсэн байна. Хөгжилтэй улс оронд төрийн байгууллагууд нь хөгжлийн явцад эрх зүйн мэдлэг, ухамсар олгох ажлыг хийж хэвшсэн байгаа бол хөгжиж буй, шилжилтийн үеийн орнуудад эрх зүйн мэдлэг, ухамсар нэмэгдүүлэх бодлого, хууль тогтоомжийг батлан гаргаж эрх зүйн мэдлэг, ухамсрыг дээшлүүлэх, соёл төлөвшүүлэх арга хэмжээг харилцан уялдаатайгаар зохион байгуулж байна.

Ийнхүү олон улсын чиг хандлагыг даган тухайн чиг үүргийн төрийн байгууллагуудад нь өөрийн чиг үүрэг, харьяалах нутаг дэвсгэрийн хүрээнд зөвхөн хууль тогтоомжийг таниулах бус харин эрх зүйн мэдлэг олгох, ухамсар хандлага нэмэгдүүлэх арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлэх үүргийг даалгах нь зүйтэй байна. Ингэснээр төрийн байгууллагууд өөрийн чиг үүргийн хүрээнд иргэдэд эрх зүйн мэдлэг олгох ажилд илүүтэй ач холбогдол өгөн, анхааран ажиллах ухамсар хандлага нэмэгдэнэ. Солонгос улсад Эрх зүйн боловсролын хороо нь Хууль зүйн яамны харьяанд, Энэтхэг улсын Хууль зүйн үйлчилгээний үндэсний байгууллага нь Дээд шүүхийн дэргэд, Москвагийн Иргэдийн эрх зүйн ухамсрыг дээшлүүлэх үйл ажиллагааг зохицуулан холбох зөвлөл Москвагийн захирагчийн дэргэд байгуулагдсан байна. Харин манай улсад эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, албан бус сургалтын асуудлыг ХЗДХЯ-нд түшиглэн хэрэгжүүлж ирсэн түүхэн уламжлалыг үндэслэн ХЗДХЯ-нд харьяалуулан иргэдийн эрх зүйн боловсролыг нэмэгдүүлэх бүтцийг бий болгох боломжтой. Бүхий л төрийн байгууллага, ТББ, мэргэжлийн холбоодыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, бодлого чиглэлийг тодорхойлох, уялдуулан зохицуулах, сайн туршлагыг түгээх, сургагч багшийг бэлтгэх, эрх зүйн мэдлэг олгох, ухамсар хандлага нэмэгдүүлэхэд шаардлагатай судалгаа шинжилгээг гүйцэтгэх дэд бүтцийг өнөөгийн бололцоог ашиглан бий болгох шаардлагатай. ХЗДХЯ-ны харьяа эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтаар дагнан үйл ажиллагаа явуулдаг Хууль зүйн үндэсний хүрээлэн нь энэхүү зөвлөн чиглүүлэх, дэмжин туслах чиг үүргийг гүйцэтгэх боломжтой байна.

Үүний зэрэгцээ Энэтхэг улсад шүүхүүдийг түшиглэн эрх зүйн мэдлэг олгох, зөвлөгөө өгөх дэд бүтцийг байгуулсан бол Унгар улсын Хууль зүйн туслалцааны төвүүд нь иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгдөг сайн туршлага байгааг манай улсад мөн хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

4. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгааг хүлээн авах зорилтод бүлгийг тодорхойлсон байдал, авч хэрэгжүүлдэг арга хэмжээ

Бидний судалсан улс орнуудад хүүхдэд эрх зүйн боловсрол олгох, соёл төлөвшүүлэх ажлыг онцлон анхаардаг. Хүүхдэд зөвхөн эрх зүйн ерөнхий мэдлэг олгох хичээл заахаас гадна, тодорхой эрх зүйн сэдвээр өдөрлөг, уралдаан, мэтгэлцээн зохион байгуулах, мэргэжлийн хүмүүсээр чөлөөт ярилцлага хэлбэрээр хичээл заах, шүүх байгууллагын үйл ажиллагаатай танилцуулах, өсвөр үеийн хүүхдэд зориулсан эрх зүйн бүхий л шаардлагатай мэдээллийг агуулсан гарын авлага гаргах, энэ чиглэлээр цахим хуудас ажиллуулах зэрэг цогц арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Энэхүү цогц арга хэмжээг хэрэгжүүлэх нь хүүхдэд эрх зүйн мэдлэг олгох, соёл төлөвшүүлэхэд үр дүнтэй арга барилд тооцогддог. Иймд манай улс зөвхөн ерөнхий боловсролын сургуульд тодорхой эрх зүйн хичээл заахаар хязгаарлагдахгүй олон талт арга хэмжээг сонирхолтой байдлаар зохион байгуулахад анхаарах шаардлагатай. Тухайлбал: мансуурах бодисын эсрэг гүйлтийн уралдаан, тодорхой эрх зүйн сэдвээр мэтгэлцээн уралдаан, хууль эрх зүйн мэргэжлийн хүмүүстэй чөлөөт уулзалт зохион байгуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжтой юм.

Өндөр хөгжилтэй дийлэнх улсад албан боловсролын хүрээнд эрх зүйн суурь мэдлэг, ухамсар олгох асуудлыг нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн бүрэн шийдвэрлэж чадсан байдаг. Иймд төрийн байгууллагууд нь өөрийн чиг үүргийн хүрээний эрх зүйн асуудлаар албан бус сургалтыг зөвхөн тодорхой зорилтот бүлэгт чиглүүлэн эдийн засгийн хувьд хэмнэлттэй, үр дүнтэй байдлаар хэрэгжүүлдэг.

Иймд манай улсын цаашдын чиг хандлага ч албан боловсролын тогтолцоогоор дамжуулан үр дүнтэй, зардал багатай аргаар эрх зүйн суурь мэдлэг олгож эрх зүйн ухамсар, соёл төлөвшсөн иргэдийг бэлтгэхэд чиглэгдэх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл эрх зүйн боловсролыг дангаар биш Монгол Улсын боловсролын тогтолцооны нэг хэсэг болгон албан боловсролын тогтолцооны хүрээнд явуулбал илүү үр дүнтэй. Сурагч бүр хуульч, эрх зүйч болохгүй, харин тэд нийгмийг цогцлоон бүрдүүлэгч ажилтан, эцэг, эх, өмчлөгч, зээлдэгч, зээлдүүлэгч, түрээслэгч, түрээслүүлэгч гэхчлэн алхам тутамдаа эрх зүйн харилцаанд оролцоно. Иймд албан боловсролын хүрээнд олгож буй эрх зүйн мэдлэгийн стандарт, заах арга зүйг онцгой анхааран цаг үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх шаардлага байна.

Түүнчлэн өндөр хөгжилтэй, хууль дээдлэх ёс төлөвшсөн нийгэм бүхий улс орнуудтай харьцуулахад манай улс өөр нөхцөл байдалд байгаа учраас нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн албан бус сургалтыг хэрэгжүүлэх шаардлага байна.

Албан бус сургалтыг тодорхой зорилтот бүлэгт /нэн ядуу, дүрвэгч, цагаач, уугуул иргэд, өндөр настан, ял эдэлж буй хүмүүс зэрэг/ чиглүүлэн зөвхөн төрийн байгууллага гэлтгүй тухайн асуудлаар мэргэшсэн төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлдэг олон улсын жишгийг манай улс ч харгалзах нь зүйтэй. Өнөөгийн байдлаар манай улсад ХЗДХЯ эрх зүйн албан бус сургалтын асуудлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, бодлого чиглэлийг тодорхойлох, уялдуулан зохицуулах чиг үүрэгтэйгээр ажилладаг. Түүний харьяа байгууллага болох Хууль зүйн үндэсний хүрээлэн иргэд, их, дээд сургуулийн багш, төрийн албан хаагчдын эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, чадавхжуулах ажлыг гүйцэтгэх чиг үүрэгтэй ажилладаг. Мөн манай улсад гадаадын байгууллага, олон улсын болон ТББ-ууд иргэдийн төдийгүй төрийн албан хаагчдын эрх зүйн ухамсар мэдлэгийг

нэмэгдүүлэхэд чиглэсэн ажлыг гүйцэтгэхэд ихээхэн хүчин чармайлт гаргаж ирсэн. Иймд энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын үйл ажиллагааг дэмжих, ТББ болон төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг хангах шаардлага байна.

Зохион байгуулалтын тухайд албан бус сургалтыг төрийн байгууллага өөрийн чиг үүрэг, нутаг дэвсгэрийн хүрээнд хариуцахаар зохицуулах нь илүү хүртээмжтэй, үр дүнтэй байх нөхцөлийг хангана. Харин ХЗДХЯ-ны харьяа Хууль зүйн үндэсний хүрээлэн эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын чиглэлээр мэргэшин ажилладаг, туршлагатай байгууллага учраас албан бус сургалт зохион байгуулах мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, бодлого чиглэлийг тодорхойлох, сайн туршлагыг түгээх, иргэдийн эрэлт хэрэгцээнд тохирсон сургалтыг явуулах, хэрэгжилтийн үнэлгээ гүйцэтгэх, сургагч багш бэлтгэх зэрэгт бүхий л төрийн байгууллагуудыг дэмжин туслах боломжтой юм.

5. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа түгээх арга зам, хэрэгжүүлэх процесс (Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа түгээхэд анхаарах бусад асуудал)

1) Албан боловсролын хүрээнд олгогдож буй эрх зүйн мэдлэг олгох, ухамсар төлөвшүүлэх хичээлийн агуулга, заах аргыг үнэлэх замаар асуудлыг тодруулах, шинэчлэх;

2) Иргэдийн эрх зүйн ухамсар, мэдлэгийн төвшинг тогтоох зорилгоор эрх зүйн социологийн судалгааг улсын хэмжээнд зохион байгуулах;

3) Эрх зүйн социологи судалгааны дүнд суурилсан хамгийн үр дүнтэй байж болох эрх зүйн мэдлэг, мэдээлэл түгээх арга зам, төрөл, хэлбэрийг тодорхойлох;

4) Хууль дээдлэх, хуулиа сахих иргэдийн ухамсрыг дээшлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа нь зөвхөн хуулийн байгууллагын хүлээх үүрэг биш юм. Иймд иргэд, олон нийтийн дунд социологи, сэтгэл судлалын чиглэлээр судалгаа хийдэг байгууллагуудтай хамтран иргэдийн сэтгэл зүйд нөлөөлөх чадамжтай, үр нөлөөтэй эрх зүйн мэдээлэл түгээх арга хэрэгслийг сонгодог байх;

5) Эрх зүйн ухамсар, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор хийж буй мэдээлэл, сурталчилгааны ажлыг орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх; /Тухайлбал, аялал жуулчлал, ан агнуур хөгжсөн Хөвсгөл аймагт энэ чиглэлийн хууль тогтоомжийг, уул уурхай түлхүү хөгжсөн аймгуудын иргэд уурхайгаас үүдэн эрүүл мэнд, эд хөрөнгө, мал ахуй, бэлчээрт учирсан хохирлоо хэрхэн барагдуулах, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх зэрэг чиглэлээр эрх зүйн мэдлэг олгодог болох, мөн хэвлэмэл хуудас, телевиз, радио зэрэг онцлог байдалд нь тохирсон эрх зүйн мэдлэг дээшлүүлэх ажлыг өргөжүүлэх боломжийг судлах/;

6) Олон улсад иргэдэд эрх зүйн мэдлэг олгох, ухамсрыг нэмэгдүүлэх арга хэмжээг эрх зүйн боловсрол, иргэдийн эрх зүйн боловсрол, иргэдийн эрх зүйн мэдлэг, ухамсрыг нэмэгдүүлэх арга хэмжээ зэрэг нэрийн дор хэрэгжүүлдэг. Үүнтэй холбоотойгоор олон улсад маш тодорхой зорилгын дагуу, тодорхой эрх зүйн ухамсар хандлага нэмэгдүүлэх арга хэмжээг иргэдэд үр дүнтэй хүргэж байна. Хууль тогтоомжийг сурталчлан таниулахаас илүүтэй хүний нөөц болон хөрөнгийг иргэдийг өөрийн эрх үүргийг ухамсарладаг, нийгэмд эерэг оролцоотой иргэн болгоход чиглэсэн үр дүнтэй арга хэмжээнд зарцуулах нь чухал байна. Эрх зүйн боловсрол гэж юу болох талаар холбогдох төрийн бодлогын баримт бичигт тусгахдаа зорилгын мөн чанар, агуулгыг анхааран тусгах нь зүйтэй;

7) Түүнчлэн хууль зүйн их, дээд сургуулийн төгсөх курсын оюутнуудыг иргэдэд эрх зүйн мэдлэг олгох, зөвлөгөө өгөх ажилд оролцуулах арга нь АНУ-аас гаралтай олон улсад өргөнөөр хэрэглэгддэг эрх зүйн мэдээлэл түгээх, сургалт явуулах арга барил байна. Иймд энэхүү арга барилыг ашигласнаар нэг талаас иргэдэд

шаардлагатай эрх зүйн мэдээлэл, зөвлөгөөг өгөх нөгөө талаас оюутнуудыг практик дээр дадлага ажил хийх боломжоор хангахад ач холбогдолтой юм. Түүнчлэн эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа түгээхэд хуулийн сургуулийн оюутнуудаас гадна мэргэжлийн холбоод, тэтгэвэрт гарсан хуульчид зэрэг мэргэжлийн хүмүүсийн нөөц бололцоог ашиглан эрх зүйн мэдээлэл түгээх, зөвлөгөө өгөх сайн туршлага байгааг хэрэгжүүлэх;

8) Эрх зүйн мэдээллийг харилцан ярих арга барилаар түгээх нь илүү үр дүнтэй болох нь тогтоогдсон учраас хууль эрх зүйн мэдээлэл өгөх боломж бүхий эрүүл мэндийн ажилтан, нийгмийн ажилтан, хууль сахиулах байгууллагын ажилтан, иргэдтэй ажилладаг төрийн албан хаагч зэрэг хүмүүсийг тэдний чиг үүрэгтэй холбоотой эрх зүйн мэдээллийг иргэдэд зөвлөн түгээгч болгох зэрэг асуудлыг анхаарах, боломжит хувилбарыг сонгон бодит амьдралд хэрэгжүүлэх зэрэг санал багтаж байна.

ХАВСРАЛТ I

МОНГОЛ УЛС[32]

/Иргэдэд эрх зүйн боловсрол олгоход чиглэсэн эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтыг түгээх туршлага/

Тухайн улсын талаарх ерөнхий мэдээлэл, үүний дотор эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлын арга барилд нөлөөлөх хүчин зүйл, онцлог

Монгол Улс нь эрх зүйн хөгжил, эрх зүйн соёл төдийлөн төлөвшөөгүй шилжилтийн улс юм. Тийм ч учраас 1990-ээд оноос эхлэн төр засгаас иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх асуудалд онцгой ач холбогдол өгөн, эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалттай холбоотой олон баримт бичгийг баталсан байдаг. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөр” боловсруулах, хэрэгжүүлэх тухай тусгасан.

1. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, эрх зүйн соён гэгээрэл, эрх зүйн ухамсар, соёл, иргэний эрх зүйн боловсролын талаарх бодлого, хөтөлбөр, санаачилга, хууль тогтоомж, төсөл

Монгол Улсын шинэ Үндсэн хууль 1992 онд батлагдсанаар улс төр, нийгмийн тогтолцоонд өөрчлөлт орсон. Үүнтэй холбоотойгоор эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалттай холбоотой нэлээд журам өөрчлөгдөн, шинэчлэгдсэн. Тухайлбал, Улсын Их Хурлын 1992 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсад нийгмийн дэг журам хангах талаар төрөөс явуулах үйл ажиллагааны үндсэн чиглэл”-д нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, хууль сахин биелүүлэх талаар төрөөс явуулах бодлогыг олон түмэнд хүргэх, иргэдийн эрх зүйн соёл, ухамсрыг төлөвшүүлэх зорилгоор эрх зүйн сургалт,[33] сурталчилгаа, мэдээллийн улсын нэгдсэн систем бий болгож, эдийн засаг, боловсон хүчин, зохион байгуулалтын талаарх шаардлагатай арга хэмжээ авах тухай заасан.

Улсын Их Хурлын 1992 оны 29 дүгээр тогтоолын холбогдох заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын “Эрх зүйн сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлыг сайжруулах тухай” 1993 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 57 дугаар тогтоолд албан болон албан бус сургалт, мэдээллийн хэрэгсэл ашиглан хууль тогтоомжийг

[32] ХЗҮХ-ийн Судалгааны төвийн ЭША Б.Ундрах, Э.Уянга нар судалгааны ажлын МУ-тай холбогдох хэсгийг бэлтгэв.

[33] Хууль бүхэн хүний ухамсраар дамжиж, түүний идэвхтэй үйл ажиллагаагаар хэрэгждэг. Тиймээс энэхүү тогтоол болон бусад хууль, тогтоомжид “сургалт, сурталчилгаа, мэдээлэл” нь хамтдаа бичигдсэн байх бөгөөд иргэдийн ухамсар, соёлыг дээшлүүлэхэд чиглэж буй учраас хууль тогтоомжийг мэдээлэх ажлын зэрэгцээ сургалт, сурталчилгааны ажлыг хамтад нь хэрэгжүүлдэг байх нь чухал юм.

сурталчлах, шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх зэрэг олон арга хэмжээ, үйл ажиллагааг явуулах тухай заажээ.

Энэ тогтоол нь Монгол Улсын хэмжээнд хууль зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлыг Монгол Улсын иргэн бүрт хүргэхээр нарийвчлан төлөвлөгдсөн бөгөөд ардчилсан эрх зүйт төрийг бий болгоход томоохон хөдөлгөх хүч болжээ. Ийнхүү шинэ Үндсэн хууль батлагдсантай холбогдуулан хууль тогтоомжийн шинэчлэлийг иргэдэд мэдээлэх, хүргэх, тэдэнд хуулийг ойлгох, сахин биелүүлэх эрх зүйн соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн ажлыг өрнүүлж эхэлсэн байна.

Засгийн газраас дээрх үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах үүднээс "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахтай холбогдсон зарим арга хэмжээний тухай" 1996 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 66 дугаар тогтоол баталжээ. Үүгээр хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, мэдээлэх, нийтэд сурталчлахтай холбогдсон үүргийг төрийн албан хаагч бүрийн ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарьт тодорхой тусган биелэлтийн байдлыг улирал бүр дүгнэж ажиллахыг төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагад даалгасан.

Түүнчлэн "Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр"-ийг 1998 онд Монгол Улсын Их хурлаас баталсан. "Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр"-ийн 39 дэх хэсэгт "Бүх нийтийн эрх зүйн ухамсрыг төлөвшүүлэх, иргэдэд улс төрийн болон эрх зүйн соёлыг эзэмшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг төрийн бүх шатны байгууллагаас явуулна. Үндсэн хуулийн зарчим, үзэл санааг иргэн бүр чанд хэрэгжүүлэх үзлийг бага наснаас нь төлөвшүүлэхийг гол зорилго болгон эрх зүйн сурталчилгаа, мэдээлэл, сургалтыг Үндсэн хууль, бусад хуулийг тууштай биелүүлэхэд чиглүүлж, үүний тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ" хэмээн заасан.

Энэхүү 1998 онд батлагдсан "Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр" хэрхэн хэрэгжиж ирсэн талаар хяналт, шинжилгээ, үнэлгээний ажлыг ХЗДХЯ, Хууль зүйн үндэсний хүрээлэн 2007 онд гүйцэтгэсэн бөгөөд хөтөлбөрийн зорилт "үндсэндээ хэрэгжиж" түүнийг гүнзгийрүүлэх шатанд дэвшин орох шинэ хэрэгцээ тулгарсан[34] хэмээн тайланд дүгнэсэн байна. Түүнчлэн Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2016 онд гүйцэтгэсэн "Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр"-ийн 2008-2016 оны хэрэгжилтийн тайланд эрх зүйн шинэтгэлийн орчин бүрдүүлэх зорилтын хэрэгжилтийг нэгтгэн дүгнэхдээ **"...**бүх нийтийн эрх зүйн ухамсрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохион байгуулалттай арга хэмжээ нэлээд дутмаг байна..." гэжээ "Нийгмийн эрх зүйн ухамсар, соёлыг төлөвшүүлэх ажлыг төрийн бодлогын төвшинд зохион байгуулалттай, харилцан уялдаатай авч үзэн эрх зүйн мэдээллийг үр дүнтэй түгээх, эрх зүйн албан сургалтаар дамжуулан залуу үеийнхээ эрх зүйн мэдлэг ухамсрыг төлөвшүүлэх, албан бус сургалтыг зохион байгуулалттай өрнүүлэх, үр дүнтэй эрх зүйн зөвлөгөө өгөх асуудлыг боловсронгуй болгох зэрэг олон асуудлыг цогц байдлаар төрийн холбогдох бодлогын баримт бичигт тодорхойлох нь зүйтэй." гэсэн саналыг дэвшүүлсэн байна.[35]

2010 оноос эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажилд төр засгаас онцгой ач холбогдол өгч улмаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 67 дугаар тушаалаар "Эрх зүйн сурталчилгааны дунд хугацааны хөтөлбөр", "Эрх зүйн сурталчилгааг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө", Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2011 оны 124 дүгээр тушаалаар "Сум, дүүрэгт эрх зүйн хөтөч /ухуулагч/-ийн ажиллах журам" зэргийг батлан гаргасан. Мөн эрх зүйн сурталчилгааны ажлын хүртээмж, чанарыг дээшлүүлэх чиглэлээр Хууль зүйн сайдын 2016 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн А/50 дугаар тушаалаар "Хууль

[34] Б.Чимид. Төр, нам эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал. 2008 он. УБ., Хоёрдугаар дэвтэр. /40 дэх тал/

[35] Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь, ХЗҮХ, 2016.

зүйн салбарын үйл ажиллагаанд холбогдох мэдээ, мэдээлэл бэлтгэж, олон нийтэд хүргэх журам”-ыг баталсан байна.

Засгийн газрын 2012 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 252 дугаар тогтоолоор “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр” батлагдсан. Хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, шинээр гарч байгаа хууль тогтоомжийг сурталчлах, тайлбарлан таниулах, аливаа гэмт халдлага, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, чадварыг эзэмшүүлэх замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг төрийн байгууллагаас гадна төрийн бус байгууллага, гэр бүл, иргэний оролцоонд түшиглэн зохион байгуулах, зохион байгуулж буй ажлын уялдаа холбоог сайжруулах, иргэдийн нас, хүйс, сонирхол, онцлогт тохируулан сургалт, сурталчилгааны ажлыг үр өгөөжтэй, ойлгомжтой хэлбэрээр тогтмол явуулах, мэдээллийн дэвшилтэт техник, технологийг өргөнөөр ашиглаж, мэдээлэл сурталчилгааг шинэлэг хэлбэрээр зохион байгуулах зэрэг олон арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг энэхүү хөтөлбөрт тусгасан.

Дээр дурдсан Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, болон бусад холбогдох баримт бичгүүд нь иргэдийн эрх зүйн ухамсар, соёлыг дээшлүүлэх талаарх төрийн бодлогыг тусгасан гол баримт бичгүүд юм.

3. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа түгээгч байгууллага, чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа

Монгол Улсын Засгийн газрын 1993 оны 57 дугаар тогтоолоор хууль тогтоомжийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, иргэд, байгууллагад эрх зүйн мэдээллээр үйлчлэх ажлыг нэгтгэн зохицуулж, арга зүйн удирдлагаар хангах үүргийг Хууль зүйн яаманд хариуцуулсан. Мөн “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 28.1.1 дэх, 29.1.6 дахь хэсэгт зааснаар “Аймаг нийслэл, Баг хорооны засаг дарга хуулийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулдаг байх” тухай заасан бөгөөд эдгээр тогтоолууд нь өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байна.

Монгол Улсын Засгийн газрын 1996 оны 265 дугаар тогтоолоор “Төрийн сайд, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга болон төсөвт байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, бүх хэвшлийн аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллагын эрх баригч нар хууль тогтоомж, Засгийн газрын бодлого, шийдвэрийг мэдээлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах, арга зүйн удирдлагаар хангах үүрэг бүхий орон тооны бус мэдээлэл, сурталчилгааны хэсэг байгуулан, байгууллагынхаа хамт олны дунд сард 2-оос доошгүй удаа тус бүр нэг хүртэл цагийн хугацаатай мэдээлэл, сурталчилгааны ажлыг өөрсдийн хүчээр болон улс төрийн зүтгэлтэн, холбогдох байгууллагын удирдах албан тушаалтан, эрдэмтдийн дэмжлэгтэйгээр “Мэдээллийн цаг” сурталчилгаат ажлыг зохион байгуулах” тухай зааж өгчээ.

Монгол Улсын Их Хурлаас 2015 онд баталсан Хууль тогтоомжийн тухай хуулийн[36] 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийг олон нийтэд таниулах ажлыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо Улсын Их Хурлын Тамгын газартай хамтран зохион байгуулж болно”, 46.2 дахь хэсэгт “Ерөнхийлөгчөөс санаачилсан хууль тогтоомжийг олон нийтэд таниулах ажлыг Ерөнхийлөгчийн Тамгын газар зохион байгуулж болно”, 46.3 дахь хэсэгт “Засгийн газар, холбогдох төрийн захиргааны төв байгууллага, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга хууль тогтоомжийг өөрийн бүрэн эрх, чиг үүргийн дагуу харьяалах салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулна” гэх зэрэг зохицуулалтыг хуульчилж өгсөн байна.

[36] Уг хууль нь 2017.01.01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлнэ.

Хууль зүйн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөг сайжруулах зорилгоор “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2006 оны 263 дугаар тогтоолоор баталсан. Харин “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай” хууль 2013 онд батлагдсан. Тус хуулийн дагуу гэмт хэрэгт холбогдсон төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх үндсэн чиг үүрэг бүхий Хууль зүйн туслалцааны төв 2015 онд байгуулагдсан.[37] Хууль зүйн туслалцааны төв нийслэлийн 8 дүүрэг, 21 аймаг болон хүн ам ихтэй зарим сумыг хамруулан нийт 31 салбартайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Дээр дурдсан байгууллагууд нь хууль тогтоомжийг сурталчлах, таниулах болон төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн зөвлөгөө өгөх чиг үүргийг гүйцэтгэж байна.

Иргэдийн эрх зүйн ухамсар, мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг Хууль зүйн яамны харьяа Хууль зүйн үндэсний хүрээлэн авч хэрэгжүүлдэг ба тус байгууллага нь эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалт, судалгааны чиглэлээр дагнан ажилладаг байгууллага юм.

4. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгааг хүлээн авах зорилтод бүлэг /өсвөр үе, ахмад настан, эмзэг бүлэг, орон нутгийн иргэд гэх мэт/-ийг тодорхойлсон байдал, авч хэрэгжүүлдэг арга хэмжээ

Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтыг онцлон хүргэх тодорхой зорилтот бүлгийг төрийн бодлогын баримт бичигт тусгаагүй байна. Харин төрийн байгууллагууд өөрсдийн чиг үүргийн хүрээнд тодорхой зорилтот бүлэгт чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг. Тухайлбал, сүүлийн жилүүдэд Хууль зүйн үндэсний хүрээлэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хууль сахиулах байгууллагын албан хаагч, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад чиглэсэн сургалтуудыг зохион байгуулж байна. Мөн төрөл бүрийн зорилго бүхий ТББ-ууд тодорхой асуудлаар иргэдэд эрх зүйн ухамсар, мэдлэг олгох ажлыг зохион байгуулдаг. Гэсэн хэдий ч эрх зүйн боловсрол олгож буй ТББ-ыг төрөөс хэрхэн дэмжиж, хамтран ажиллах талаар тодорхойгүй байна.

5. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа түгээх арга зам, хэрэгжүүлэх процесс

Иргэдийн эрх зүйн ухамсар, мэдлэгийг нэмэгдүүлэхэд эрх зүйн боловсрол нь өндөр ач холбогдолтой учраас энэ хэсэгт эрх зүйн албан болон албан бус тогтолцооны хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээг авч үзье.

5.1. Эрх зүйн албан бус боловсролын тогтолцооны хүрээнд

Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хуулиудад иргэдийн сурч боловсрох, мэдээлэл авах эрхийн талаар заасан. Тухайлбал, “Боловсролын тухай” хуульд боловсролыг албан, албан бус сургалтаар явуулах тухай заасан байх бөгөөд албан бус сургалтад боловсролын албан тогтолцооноос гадуурх иргэдийн мэдлэг боловсрол, мэдээлэл олж авах, буюу амьдрал орчноос суралцах, мэргэжил боловсролоо бие даан дээшлүүлэх, бүтээлч үйл ажиллагаанд суралцахад чиглэсэн бүхий л үйл ажиллагаа багтсан. Мөн тус хуульд албан бус сургалтыг төрөөс дэмжих тухай дурдсан.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2004 оны 45 дугаар тушаалаар “Эрх зүйн албан бус сургалтын хөтөлбөр”-ийг баталсан. Хөтөлбөрт иргэдэд эрх зүйн боловсролыг нээлттэй, хүртээмжтэй, тохиромжтой хэлбэрээр, тасралтгүй, боломжит хугацаанд нь эзэмшүүлэх талаар заасан. Мөн иргэдэд хууль тогтоомжийг өдөр тутмын амьдралдаа хэрэглэх чадварыг төлөвшүүлэх, эрх зүйн албан бус сургалтын тогтолцоог бүрдүүлэн боловсронгуй болгон бэхжүүлэх, эрх зүйн боловсролын үйлчилгээний чанар, үр өгөөжийг нэмэгдүүлэх, хүн амын эрх зүйн

[37] Хууль зүйн төвийн 2016 оны 7 сарын 8-ний 2/258 тоот албан бичгийн хавсралтаар ирсэн тус төвийн мэдээллийг энд оруулсан болно.

боловсролын эрэлт хэрэгцээг хангах сүлжээг бий болгох зэрэг олон арга хэмжээг тусгасан. Улмаар Засгийн газрын 2006 оны 263 дугаар тогтоолын дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэд эрх зүйн албан бус сургалт, судалгааны бодлого боловсруулах, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий орон тооны бус Үндэсний зөвлөлийг, уг зөвлөлийн салбар зөвлөлийг аймаг, дүүрэг бүрийн Засаг даргын тамгын газрын дэргэд байгуулахаар заасан. Энэ нь бүх нийтийн эрх зүйн сургалтын тогтолцоог бүрдүүлэхэд чухал алхам болсон төдийгүй Монгол Улсын аймгуудын төвшинд "Эрх зүйн албан бус сургалтын хөтөлбөр" батлагджээ. Тухайлбал, Говь-Алтай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 62 дугаар тогтоолын хавсралтаар аймгийн "Эрх зүйн албан бус сургалтын хөтөлбөр"-ийг баталсан нь одоог хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байна.

Түүнчлэн ХЗДХЯ-ны харьяа Хууль зүйн үндэсний хүрээлэн нь 2004 оноос дараах зорилтын хүрээнд эрх зүйн албан бус сургалтыг зохион байгуулж эхэлсэн. Үүнд:

- Эрх зүйн албан бус сургалтын тогтолцоог бүрдүүлэх;
- Эрх зүйн албан бус сургалтад ашиглах ном, гарын авлага бэлтгэх;
- Эрх зүйн албан бус сургалтын сургагч багш бэлтгэх;
- Иргэдэд хууль тогтоомж, олон улсын гэрээг тайлбарлан таниулах, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;
- Эрх зүйн албан бус сургалтын хүртээмжтэй, үр ашигтай мэдээллийн сан бий болгох зэрэг болно.

5.2. Эрх зүйн албан сургалтын тогтолцооны хүрээнд

Ерөнхий боловсролын хүрээнд

Ерөнхий боловсролын сургуульд эрх зүй, ёс суртахуун, ёс зүй, эрх зүй гэсэн хичээлээр дамжуулан суралцагчдад эрх зүйн боловсрол эзэмшүүлж иржээ.[38]

1990 оноос эрх зүйн хичээлийн хуучин агуулгыг зааж, хуучин сурах бичгүүдийг хэрэглэх боломжгүй болсон. Иймээс тухайн үед хичээлийн шинэ агуулга, шинэ сурах бичиг байхгүйгээс болж багш нар шинээр гарсан хуулиудыг цээжлүүлэх төдийхнөөр эрх зүйн сургалтыг явуулж байсан. Энэ байдал нь цаг үрсэн, үр ашиггүй үйл ажиллагаа байсан тул 1997 оноос Гэгээрлийн яамны шийдвэрээр эрх зүйн хичээлийг тогтвортой агуулгаас хасаж, хувьсах агуулгад шилжүүлсэн.

2002 онд батлагдсан Бага, дунд боловсролын тухай хуульд ерөнхий боловсролын сургуульд эрх зүйн боловсрол олгох талаар дараах байдлаар тусгасан. Үүнд: *"5.1 Суурь боловсролын агуулга нь дараах зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ: 5.1.1-д эх хэл болон гадаад хэл, математик, мэдээлэл зүй, шинжлэх ухаан, эрх зүйн зохих шатны мэдлэг,* өөрийн авьяас, чадварт тулгуурласан бие даан амьдрахад шаардлагатай чадвар, дадал эзэмшүүлэх; 5.2.2-т гоо зүй, ёс суртахууны соёлтой, эрүүл чийрэг, иргэний үүргээ ухамсарласан, үнэнч шударга, хамтач, энэрэнгүй, эх оронч, хууль ёсыг дээдлэн сахидаг, үндэсний болон хүн төрөлхтний дэвшилт ёс заншил, соёлын үнэт зүйлсийг хүндлэн хайрладаг болгон төлөвшүүлэх*;"*

2004 онд БСШУЯ "Бага, дунд боловсролын стандарт", мөн түүний бүрэлдэхүүн хэсэг болох "Түүх, нийгмийн ухааны боловсролын стандарт"-ыг шинэчлэн баталжээ. Уг Түүх, нийгмийн ухааны боловсролын стандарт нь суралцагчдад хүний эрхийн мэдлэг, эрхээ эдэлж, зөрчигдсөн эрхээ хамгаалах чадвар суулгаж, хүний эрхийг хүндэтгэдэг "цогц чадамж"-ийг төлөвшүүлэх зорилтыг дэвшүүлсэн юм. Уг стандарт нь агуулгын хувьд "Дүрэм, журам, хууль", "Эрх, үүрэг", "Төрийн байгуулал", "Салбар

[38] Эх сурвалж: http://www.mongoleducation.mn/modules.php?ss=4&id=73 /Бага, дунд боловсролыг прагматчилах зорилтын хэрэгжилт: Эрх зүйн боловсролын шинэчлэл /2006-09-17

эрх зүй” гэсэн агуулгын айтай байна. Агуулгын ай гэдэг нь бага, суурь, бүрэн дунд боловсролын төвшинд үндсэн ойлголт нь хэвээр хадгалагдаж, агуулгын хувьд гүнзгийрэн баяжиж байх мэдлэгийн цөм /хүрээ/ юм. Энэ агуулгын хүрээнд өнөөгийн иргэн хүнд төлөвшсөн байвал зохих хүний эрхийн мэдлэг бүтээх /К1/, хүний эрхийн мэдлэгээ ашиглан хийж сурах /К2/, амьдарч сурах /К3/, нийгэмшин иргэншиж сурах /К4/ зэрэг цогц чадамжийг эзэмшүүлэх зорилтуудыг дэвшүүлж, үүнийг хангах зорилгоор сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сурах бичгүүдийг боловсруулах онол-арга зүйн үндэслэл болж буйд уг стандартын ач холбогдол оршино.

Манай улсын ерөнхий боловсролын тогтолцоог 2005 оноос эхлэн 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэх үйл явц эхэлсэн билээ. Уг зорилтын хүрээнд боловсруулагдсан сургалтын төлөвлөгөө, хичээлийн агуулгын үлгэрчилсэн хүрээнд зааснаар «Нийгэм судлал” хичээл нь 6-9-р ангиудад 1-2 улиралд тус бүр 37 цагийн багтаамжтайгаар, эрх зүй, ёс зүйн болон нийгмийн харилцааны бусад асуудлаар баяжуулагдан орж байна.

Ерөнхий боловсролын сургууль 12 жилийн тогтолцоонд бүрэн шилжиж, улмаар Боловсролын шинэ стандарт хэрэгжиж эхэлсэнтэй холбогдон Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд (БСШУС)-ын 2006 оны 136 дугаар тушаалаар сургалтын шинэ хөтөлбөрийг батлсан. Энэ тушаалын хүрээнд Боловсролын хүрээлэнгийн захирлын 2006 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 15 дугаар тушаалаар хичээлүүдийн агуулгын үлгэрчилсэн хүрээ батлагдсан байдаг. Энэхүү үлгэрчилсэн хүрээний дагуу бага боловсролын төвшинд “Хүн ба орчин”, суурь боловсролын төвшинд “Иргэний боловсрол”, бүрэн дунд боловсролын төвшинд “Нийгмийн ухаан” зэрэг хичээлүүдийн агуулгад хууль, эрх зүйн чиглэлийн мэдлэг багтан судлагдсан хэвээр байна.

Түүнчлэн, ерөнхий боловсролын сургуулийн 6, 7, 8, 9 дүгээр ангийн Түүх, нийгмийн ухааны хичээлийн агуулгын стандартад “Иргэншлийн энгийн ойлголт”, “Ёс зүйн хэм хэмжээ”, “Дүрэм, журам, хууль”, “Эрх, үүрэг”, “Төрийн байгуулал” гэсэн хичээлийн хүрээнд сурагчдад цогц мэдлэг эзэмшүүлэхээр тусгагджээ.

Дээд боловсролын хүрээнд

БСШУС-ын 2002 оны 390 дүгээр тушаалаар “Монгол Улсын Дээд боловсролын стандарт үлгэрчилсэн загвар”-ыг баталж гаргасан бөгөөд энэ загварын дагуу төгсөгчдийн бэлтгэлд тавигдах нийтлэг шаардлагад эрх зүйн хэм хэмжээний тухай ойлголт эзэмшсэн байхаар тусгасан нь хэвээр байна.

Мэргэжлийн дээд боловсролын хүрээнд

Монгол Улсын хуульч бэлтгэх тогтолцоо харьцангуй залуу ч өнөөгийн нийгэм дэх эрх зүйчдийн тооноос үзэхэд эрх зүйчдийг хангалттай бэлтгэж байна гэж хэлэх боломжтой. Харин ч сүүлийн жилүүдэд хуульчдын тоог цөөрүүлэх асуудал хөндөгдөх болсон. Гэвч төрийн захиргааны байгууллагад төрийн захиргааны чиглэл бүрээр /байгаль орчин, үйлдвэр, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, боловсрол, барилга, зам тээвэр гэх мэт/, мөн төр болон хувийн хэвшилд эдийн засгийн /худалдаа, үнэт цаас, банк, санхүү, татвар, гэх мэт/ чиглэлээр мэргэшсэн хуульч салбар бүрээр нийгмийн эрэлт хэрэгцээг хангах шаардлагатай байдаг. Иймд нэгэнт сургууль төгссөн эрх зүйчид эрүүгийн, иргэний, үндсэн хууль, төр захиргааны, олон улсын, бизнесийн гэх мэт чиглэл бүрээр мэргэшин ажилладаг.

Гэсэн хэдий ч нийгмийн эрэлт хэрэгцээг чиглэл бүрээр хангах эрх зүйч бэлтгэх мэргэжлийн салбарын хөгжил үндсэндээ хоцрогдоод байна. Мэргэжлийн боловсрол олгох, мэргэжлийн чиглэлийн индексийг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас “Эрх зүй” гэсэн нэг мэргэжлээр баталсан нь хууль зүйн шинжлэх ухаан, хууль зүйн боловсрол олгох тогтолцоог үндсэндээ хумьсан гэж хэлж болно. Иймд хууль зүйн мэргэжлийн боловсон хүчнийг чанаржуулах асуудлыг цогцоор авч үзэж сайжруулах шаардлагатай байна.

ХАВСРАЛТ II

БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ УЛС[39]
/Иргэдэд эрх зүйн боловсрол олгоход чиглэсэн эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтыг түгээх туршлага/

1. Тухайн улсын талаарх ерөнхий мэдээлэл, үүний дотор эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлын арга барилд нөлөөлөх хүчин зүйл, онцлог

БНЭУ нь Өмнөд Азийн улс бөгөөд Арабын тэнгис, Бенгалын хойгоор далайгаас хязгаарлагдан Пакистан, Бирм, Хятад, Бутан, Шриланк, Бангладеш, Непал улстай хил залган оршдог.

Эрх зүйн тогтолцооны хувьд Англи загварт суурилсан нийтлэг эрх зүйн тогтолцоотой нь манайхаас өөр хэдий ч төвөөс алслагдсан муж, суурин ихтэй, хүн ам нь ядууралтай, дэд бүтэц хангалттай хөгжөөгүй зэрэг зарим талаараа манай улстай төстэй ажээ. Засаг захиргааны 29 муж, 7 холбооны нутаг дэвсгэртэй[40] улс юм.

Нийгэмд тулгамдсан асуудлууд, Тухайлбал, шийдвэрлэж чадахгүй байгаа авилгын нөхцөл байдлыг бууруулахын тулд ард түмний хуулийн мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзээд үүний хүрээнд хууль, ядуурал, соён гэгээрэл, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин болон бусад бүх салбарт байгаа асуудлуудыг олон нийтийн анхаарлын төвд хүргэж төрийн байгууллагууд нь ард түмэнтэйгээ хамтран ажилласнаар нийгмийн сайн сайхан бүрэлдэх нөхцөл бий болно гэсэн бодлогыг Энэтхэгийн төрөөс баримтлан хөгжиж байна.

Ард түмний эрх зүйн мэдлэг, ухамсар нь оршин буй болон өсөн нэмэгдэж буй асуудлуудыг шийдвэрлэхэд нөлөөлөх чухал хүчин зүйл гэж мөн томьёолжээ. Энэтхэгийн хүн ам эрх зүйн мэдлэггүйгээсээ, Тухайлбал, дийлэнх хэсэг нь тэдэнд хуулиар олгосон үндсэн эрхээ ойлгож мэдээгүйгээс болж аливаа асуудал үүсдэг гэж дүгнэсэн аж.

Алслагдсан бүс нутгийн иргэд бүү хэл хот суурин, тосгоны оршин суугчид ч хуульд заасан эрхээ мэддэггүй, мэдэж байсан хэдий ч эрх нь зөрчигдөхөд ямар үйлдэл хийх ёстойгоо мэдэхгүй төөрөлддөг болохыг тогтоожээ. Эндээс үзвэл эрх зүйн мэдлэг, ухамсартай болох, түүнийг зохих ёсоор ойлгож амьдралд үр дүнтэйгээр хэрэглэх зэрэг нь нийгмийн хөгжилд нөлөөлөх бие даасан хүчин зүйлүүд бөгөөд хосолж байж тухайн нийгмийнхээ хөгжилд бодитой хувь нэмэр болох нь харагдаж байна.

Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөө, нэр хүнд, ёс суртахууныг хамгаалсан зарчмууд нь хүүхдийн хөдөлмөр, хүний наймаа, гэр бүлийн хүчирхийлэл, насанд хүрээгүй хүний гэрлэлт гэх мэт сөрөг хүчин зүйлээс олон түмнийг хамгаалан тунхагласан байдаг. Гэтэл эрх зүйн мэдлэггүй байдлыг нь далимдуулж төрийн байгууллагуудаас ард иргэдийг хохироох, хуульд заасан эрх түүнээс хүртэх өгөөжийг замхруулах, дарлал мөлжлөг, хууран мэхлэлтэд өртөхөд хүргэдэг байна.

2. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, эрх зүйн соён гэгээрэл, эрх зүйн ухамсар, соёл, иргэний эрх зүйн боловсролын талаарх бодлого, хөтөлбөр, санаачилга, хууль тогтоомж, төсөл

Энэтхэгийн Барын холбооноос тодорхойлсноор бол “эрх зүйн мэдлэг гэдэг нь хууль зүйн бичвэрт байгаа үгсийг ойлгон дүгнэлт өгч түүнийгээ үйлдэл хийхдээ ашиглах чадвар” гэжээ. Ерөнхийдөө бол анхан шатны хууль, хуулийн процессын

[39] ХЗҮХ-ийн Судалгааны төвийн ЭША Ц.Одгэрэл судалгааны ажлын БНЭУ-тай холбогдох хэсгийг бэлтгэв.

[40] Засаг захиргааны байгууллагаа өөрснөө сонгох эрхтэй, ЗГ-таа харьяалагддаг том хотууд Тухайлбал, Дэли хот нь энэ ангилалд хамаардаг байна.

талаарх мэдээллийг ойлгож байгаагаар нь хүмүүсийг хууль зүйн мэдлэгтэй эсэхийг тогтоож болно. Америкийн Барын холбооноос тодорхойлсноор бол “эрх зүйн ухамсар гэдэг нь хууль доторх бүрдэл хэсэг, процесс, эрх зүйн эх сурвалжид шүүмжит дүгнэлт өгч эрх зүйн тогтолцоог үр өгөөжтэй ашиглах, эрх зүйн мэдлэгийг сайжруулах талаарх хэтийн төлвийг тодорхойлох чадвар юм” гэжээ.

Эрх зүйн мэдлэг болон эрх зүйн ухамсар нь ард түмний эрх зүйн чадавхын суурь болж орших бөгөөд тэд хуулийн зүйл заалт, процессын талаар мэдлэгтэй байснаар хууль ёсны шаардлага нь нэмэгдэж засаглалын бүх төвшинд амьдралд нийцсэн бодлого боловсрогдох, зохих шийдвэр гарахад нөлөөлнө гэж дүгнэжээ. Эдгээр бүх дүгнэлт, хэрэгцээ шаардлагад үндэслэн Энэтхэгийн парламентаас Хууль зүйн мэдээллийн байгууллагын хуулийг 1987 онд баталсан бөгөөд энэ хуулийн дагуу нийгмийн доод хэсгийн сул чадавхтай ард түмэнд ижил тэгш эрх олгох зорилгоор хууль зүйн үнэ төлбөргүй, хангалттай мэдээлэл олгох үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий үндэсний хэмжээний сүлжээ байгуулан 1995 оны 11 дүгээр сарын 9-ны өдрөөс ажиллуулж эхэлжээ.

Хууль зүйн үйлчилгээний үндэсний байгууллага (*National Legal Service Authority*) нь энэ хуулийн хүрээнд үзүүлж буй хууль зүйн үйлчилгээний хэрэгжилтэд үнэлгээ хийж, хяналт тавьж ажилладаг.

Хууль зүйн мэдээллийн байгууллагын хууль нь БНЭУ-ын Үндсэн хуулийн 39А дугаар зүйл дэх төрийн бодлогын үндсэн зарчмуудыг хангах зорилготой ажээ. БНЭУ-ын Үндсэн хуульд эрх зүйн үнэгүй туслалцаа, тэгш эрхийн зарчим тусгагдсан байдаг ба төрийн зүгээс иргэдэд ижил тэгш боломж олгон шударга ёсыг тогтоох эрх зүйн тогтолцоог дэмжиж ялангуяа хууль тогтоомж, хөтөлбөрийн дагуу болон бусад байдлаар эрх зүйн үнэгүй туслалцаа үзүүлдэг. Эдийн засгийн эсхүл бусад боломжгүй байдлаас хамаарч аливаа иргэнд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг тасалдуулж болохгүй гэж хуульчилсан аж.

Энэтхэгийн Үндсэн хуулийн 14, 22(1) дүгээр зүйлд бүх нийтэд ижил боломж олгож шударга ёсыг дэмжин ажиллах эрх зүйн тогтолцоо, хуулийн өмнө ижил тэгш орших нөхцөлөөр хангах үүргийг төр хүлээх талаар заажээ.

Хууль зүйн үйлчилгээний үндэсний байгууллагаас өгсөн бодлого, чиглэлийн дагуу муж бүхэнд Төрийн хууль зүйн үйлчилгээний газар ажиллаж ард түмэнд эрх зүйн үнэгүй туслалцаа үзүүлж, мэдлэг олгох ажил өрнүүлдэг байна. Төрийн хууль зүйн үйлчилгээний газрыг Дээд шүүхийн ерөнхий шүүгч даргалдаг бол орон нутгийн төвшинд дүүргийн шүүгчийн удирдлагад ажиллаж тухайн дүүргийнхээ шүүх дээр байрладаг ажээ.

3. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа түгээгч байгууллага, чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа

Хууль зүйн үйлчилгээний үндэсний байгууллага (төв байгууллага) нь мужийн төвшний Төрийн хууль зүйн үйлчилгээний байгууллагуудыг мэргэжлийн удирдлагаар хангаж улс даяар хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөг удирдан чиглүүлдэг.

Үндэсний хууль зүйн үйлчилгээний байгууллага буюу *the National Legal Services Authority*-ын бүтэц зохион байгуулалт:

(1) Үндэсний хууль зүйн үйлчилгээний байгууллагыг Хууль зүйн мэдээллийн байгууллагын тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газраас байгуулна.

(2) Төв байгууллага нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

(a) БНЭУ-ын Ерөнхий шүүгч нь энэ байгууллагыг удирдана.

(b) Ерөнхий шүүгч нь Ерөнхийлөгчтэй зөвшилцөж дээд шүүхэд ажиллаж байгаа

эсхүл тэтгэвэртээ гарсан хүнийг нэр дэвшүүлж Гүйцэтгэх даргаар томилуулна.

(c) Засгийн газраас тавьсан туршлага, ур чадварын шаардлагын дагуу Засгийн газраас Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн нэр дэвшүүлж бусад гишүүдийг томилно.

(3) Засгийн газраас тавьсан туршлага, ур чадварын шаардлагын дагуу Засгийн газар, ерөнхий шүүгчтэй зөвшилцөн төв байгууллагын гишүүн-нарийн бичгийн даргыг томилох ба энэ нь гүйцэтгэх даргын удирдлага дор ажиллана.

(4) Тухайн багийн ажиллах хугацаа болон бусад нөхцөлийг ерөнхий шүүгч, Засгийн газартай зөвшилцөн тодорхойлно.

(5) Хууль зүйн үйлчилгээний байгууллагын тухай хуульд заасан чиг үүргийг үр өгөөжтэй хэрэгжүүлэхийн тулд ерөнхий шүүгчтэй зөвшилцөн Засгийн газраас тодорхойлсны дагуу төв байгууллага нь ажилтнуудаа томилно.

(6) Төв байгууллагын ажилтнууд нь Засгийн газар, ерөнхий шүүгчээс тогтоосон цалин, урамшуулал авна.

(7) Төв байгууллагын гишүүн-нарийн бичгийн дарга, ажилтнуудад төлөх цалин, урамшуулал, тэтгэвэрийг Энэтхэгийн нэгдсэн сангаас гаргана.

(8) Төв байгууллагаас гарах аливаа шийдвэр нь гүйцэтгэх даргаар баталгаажин гишүүн-нарийн бичгийн дарга эсхүл төв байгууллагын бусад албан хаагчаар дамжин гарна.

Мөн Дээд шүүх нь Хууль зүйн үйлчилгээний хороотой байдаг ба уг хороог Засгийн газраас тогтоосон шалгуур хангасан, тухайн шүүхийн шүүгч даргалан ажилладаг байна. Хорооны нарийн бичгийн даргыг Улсын ерөнхий шүүгч томилох ба бусад ажилтнуудыг хороо бие дааж томилно. Хорооны удирдлага, ажилтнуудын цалин, урамшууллыг төрийн албан хаагчийн нэгэн адил тооцож олгодог ажээ.

Төв байгууллага нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

(a) Хуульд заасан үйлчилгээг үзүүлэх зарчим, бодлого боловсруулах;

(b) Хуульд заасан үйлчилгээ үзүүлэх талаар хамгийн оновчтой, эдийн засгийн ач холбогдолтой хөтөлбөр, төлөвлөгөө гаргах;

(c) Төсөв зарцуулах, муж, дүүргийн хууль зүйн үйлчилгээний газарт төсөв хуваарилах;

(d) Хэрэглэгчийн эрх, хүрээлэн буй орчноо хамгаалах гэх мэтээр нийгмийн сул дорой хэсгийн эрх ашгийг хамгаалах талаар арга хэмжээ авах, энэ чиглэлээр нийгмийн ажилтнуудад хууль зүйн мэдлэг олгох сургалт зохион байгуулах;

(e) Лок адалатаар маргаан шийдвэрлүүлэх үйл ажиллагааг дэмжих, нийгмийн эмзэг бүлэг/хэсгийг соён гэгээрүүлэх зорилгоор хөдөө орон нутаг, ядуусын хороолол эсхүл хөдөлмөрийн колониудад хууль зүйн туслалцаа үзүүлэх түр оффис ажиллуулах;

(f) зөвшилцөл, арбитр, эвлэрлээр маргаан шийдвэрлэх ажиллагааг дэмжих;

(g) зорилтот бүлэгт хүргэх хууль зүйн үйлчилгээний үеэр хийгдэх судалгааны ажлыг дэмжих;

(h) Үндсэн хуульд заасан иргэний үндсэн эрхийг хангах зорилгоор хийгдэх аливаа ажлыг дэмжих;

(i) Хуулийн дагуу санхүүжсэн хууль зүйн туслалцааны хөтөлбөрүүдэд дүн шинжилгээ-хяналт хийх, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн үнэлж дүгнэх;

(j) Хуулийн дагуу олгогдох сангаас муж, дүүргийн хууль зүйн үйлчилгээний байгууллагууд, нийгэмд ажилладаг сайн дурын байгууллагуудад тэтгэлэг олгох;

(k) Энэтхэгийн Барын зөвлөлтэй зөвлөлдөж, хамтран боловсруулсан эрх зүйн боловсролын клиник сургалтын хөтөлбөр, хууль зүйн их, дээд сургуулиудад клиник сургалтын төв нээн ажиллуулахад дэмжлэг үзүүлэх;

(l) Ард түмэнд эрх зүйн мэдлэг, ухамсар түгээх зохистой арга зүй боловсруулах, ялангуяа нийгмийн сул дорой хэсгийн хүмүүст нийгмийн халамж үйлчилгээний талаарх эрх, ач холбогдлыг ойлгуулах, засаг захиргааны зүгээс хэрэгжүүлэх бусад хөтөлбөр, арга зүйг таниулах;

(m) Хот, хөдөөгийн эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, жагсаалтад тусгагдсан овог, каст гэх мэт нийгмийн доод шатны хэсэгт халамж үйлчилгээг хүргэхэд дэмжлэг үзүүлэх;

(n) Муж, дүүргийн хууль зүйн үйлчилгээний байгууллага, дээд шүүхийн хууль зүйн үйлчилгээний хороо, мужийн дээд шүүхийн хууль зүйн үйлчилгээний хороо, Талук хууль зүйн үйлчилгээний хороо, сайн дурын байгууллагуудын үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих, хууль зүйн үйлчилгээний хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд ерөнхий чиглэл өгөх.

Төв байгууллага нь нийгмийн эмзэг, сул дорой бүлэгт хууль зүйн үйлчилгээг хүргэхийн тулд төрийн болон төрийн бус байгууллагууд, их сургуулиуд, бусад байгууллагатай хамтран ажилладаг байна.

Төрийн, мужийн, дүүргийн хууль зүйн үйлчилгээний газар, Талука[41] хууль зүйн үйлчилгээний хороо гэх мэт байгууллагууд дараах хоёр үндсэн чиг үүрэгтэй ажилладаг. Үүнд:

- Зохих этгээдэд Хууль зүйн үнэгүй үйлчилгээ үзүүлэх, соён гэгээрүүлэх,
- Эвлэрэх боломжтой маргаанд Лок Адалат[42] зохион байгуулах.

Хууль зүйн үнэ төлбөргүй үйлчилгээнд дараах зүйлс багтана. Үүнд:

- Шүүхэд төлөх хураамж, үйл ажиллагааны явцад төлбөл зохих бүх төрлийн төлбөрийг төлөх;
- Өмгөөлөгчийн зардал;
- Хууль зүйн үйл ажиллагааны явцад шаардлагатай байгаа тушаал шийдвэр болон бусад баримт бичгийн баталгаажсан хуулбар авах зардал;
- Хууль зүйн үйл ажиллагааны явцад баримт бичиг орчуулах, хэвлэх, давж заалдах баримт бүрдүүлэхэд гарах зардал;
- Хууль зүйн баримт бичиг боловсруулж өгөх гэх мэт.

4. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгааг хүлээн авах зорилтод бүлэг /өсвөр үе, ахмад настан, эмзэг бүлэг, орон нутгийн иргэд гэх мэт/-ийг тодорхойлсон байдал, авч хэрэгжүүлдэг арга хэмжээ

Хуулийн дагуу хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа, үйлчилгээ авах эрх бүхий этгээдэд дараах хүмүүс багтана. Үүнд:

- Хүүхэд, эмэгтэйчүүд;
- Хуваарьт каст[43] болон овгийн[44] гишүүн;
- Үйлдвэрийн ажилчин;
- Нийтийг хамарсан гамшиг, үймээн, үер, ган, газар хөдлөлт, үйлдвэрийн ослын хохирогч;

[41] Дүүргийн доод шатны засаг захиргааны нэгжийн нэр.

[42] Шүүхийн өмнөх шатанд эвлэрүүлэх зарчмаар маргаан хянан шийдвэрлэх тогтолцоо.

[43] Хүн амын 16,6 хувийг эзэлдэг ба Хиндү, Будда, Сик шашинтай ард түмэн.

[44] Хүн амын 8,6 хувийг эзэлдэг ба өмнөд Азийн аборгин угшлын ард түмэн.

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд;
- Асран хамгаалалтад байгаа иргэд;
- Жилд 50,000 рупигээс бага орлоготой иргэн;
- Хүний наймааны хохирогч.

Дээрх үндсэн үйл ажиллагаанаас гадна ард иргэдийн хууль зүйн мэдлэг, ухамсрыг нэмэгдүүлэх зорилготой соён гэгээрүүлэх ажлуудыг зохион байгуулдаг байна.

Энэтхэгт ийнхүү бодлогод үндэслэсэн төлөвлөгөөт ажил хэрэгжүүлж байгаа хэдий ч ард түмний эрх зүйн ухамсар, мэдлэг хомс хэвээр байгаа талаар бичсээр байгаагаас үзвэл нийгэмд чиглэсэн үйл ажиллагааны үр дүн нь богино хугацаанд илрээд байдаггүйг илтгэнэ.

5. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа түгээх арга зам, хэрэгжүүлэх процесс (Харяана мужийн жишээ)**:**

Харяана мужийн хүн амын 70 орчим хувь нь алслагдсан тосгон, хөдөө нутгаар амьдардаг, дэд бүтцээр бүрэн хангагдаагүй зэрэг нөхцөл байдал нь манай улстай төстэй байх тул сонгов. Тус мужийн Төрийн хууль зүйн үйлчилгээний байгууллагаас дээр дурдсан үйл ажиллагаануудыг явуулахаас гадна иргэдийн эрх зүйн ухамсрыг нэмэгдүүлэх, мэдлэгжүүлэх зорилгоор дараах ажил зохион байгуулдаг байна. Үүнд:

1. Алслагдсан орчинд амьдардаг иргэдэд зориулсан эрх зүйн мэдлэг олгох хичээл, сургалтыг долоо хоногт нэг удаа зохион байгуулах;

2. Хоригдлуудад зориулсан сургалт зохион байгуулах;

3. Халамж, асрамжийн газрын хүүхэд, охид, эмэгтэйчүүд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сургалт зохион байгуулах;

4. Мужийн боловсролын газартай хамтран ерөнхий боловсролын дунд, ахлах сургуулийн сурагчид, улсын болон хувийн их дээд сургуулийн оюутнуудын дунд клубууд үүсгэж тэднээр дамжуулан ард иргэдэд эрх зүйн мэдлэг түгээх ажил зохион байгуулах, энэ ажлыг дараах байдлаар хэрэгжүүлдэг ажээ. Үүнд:

- Дэлхийн хүрээлэн буй орчны өдөр, Хүүхдийн хөдөлмөр эрхлэлттэй тэмцэх өдөр, Эмэгтэйчүүдийн өдөр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөр, Сэтгэцийн эрүүл мэндийн өдөр, Хүүхдийн өдөр, Үндэсний хууль зүйн үйлчилгээний өдөр, Тамхины эсрэг өдөр гэх мэт тэмдэглэлт өдрүүдийн зорилго, үйл ажиллагааны талаар иргэдэд мэдээлэл өгөх:

- Иргэдийн гэрээр очиж мэдээлэл өгөх, тэдний дунд уралдаан зохион байгуулах, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, ядуурал бууруулах, нийгмийн халамж үйлчилгээний талаар мэдээлэл бүхий ном, сурах бичиг, гарын авлага, зурагт хуудас тараах;

- Хууль зүйн үнэгүй үйлчилгээ авахад хэрэглэгдэх өргөдлийн маягт тараах, иргэд олноор орж гардаг газруудад байрлуулах;

- Иргэн бүр хөршийнхөө тухай мэдээлэлтэй байж тэдэнд хууль зүйн туслалцаа хэрэгтэй байгаа эсэхэд анхаарал хандуулахад нь туслах;

- Мэтгэлцээн, эссэ бичлэг, зураг, уриа бичлэг, илтгэл, баримтат кино, яруу найраг, уран уншлага гэх мэт төрлөөр шат дараалсан уралдааныг 10, 11, 12 дугаар саруудад сургууль, дүүрэг, мужийн төвшинд зохион байгуулж мөнгөн шагнал, медалиар урамшуулах. Тухайлбал, 2013-2014 онд зарласан уралдааны сэдэв нь дараах байдалтай байсан. Үүнд:

- Хүүхэд, эмэгтэйчүүдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах;
- Инжийг хориглох;

- Хүний эрх;
- Үндсэн үүрэг;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх;
- Мансууруулах бодист дахин донтох;
- Эрүүл ахуй, хүрээлэн буй орчин;
- Бэлгийн хүчирхийлэл;
- Хүүхдийн гэрлэлт;
- Сурч боловсрох эрх;
- Мэдээлэл авах эрх;
- Үндсэн хуулийн үнэ цэнэ;
- Ахмад настны эрх.

Боловсролын байгууллагуудтай хамтран зохион байгуулж буй эдгээр уралдаан, тэмцээн, бусад үйл ажиллагааны зардлыг мужийн Боловсролын газраас гаргадаг.

5. Муж, дүүрэг, дэд-дүүргийн Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх байгууллагаас цаасан болон цахим хэвлэлээр дамжуулан иргэдэд ном, гарын авлага, зарын самбар зэргээр хуулийн мэдлэг түгээдэг. Мөн томоохон сонин, телевиз, радиотой хамтран ажиллаж ярилцлага, нэвтрүүлэг цацдаг байна.

6. Хуульчдад зориулсан сургалт, семинар зохион байгуулдаг.

7. Ард иргэдэд хууль зүйн үнэгүй зөвлөгөөг утсаар өгөх үйлчилгээг өглөөний 9 цагаас шөнийн 12 цаг хүртэл бүх дүүрэгт ажиллуулдаг.

8. Байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэдэд мэдээлэл олгодог.

9. Сайн дурын ажилтнаар дамжуулан иргэдэд эрх зүйн мэдлэг, мэдээлэл олгодог байна.

ХАВСРАЛТ III

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС[45]

/Иргэдэд эрх зүйн боловсрол олгоход чиглэсэн эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтыг түгээх туршлага/

1. Тухайн улсын талаарх ерөнхий мэдээлэл, үүний дотор эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлын арга барилд нөлөөлөх хүчин зүйл, онцлог

Бүгд Найрамдах Солонгос Улс нь Солонгосын хойгийн өмнөд хагаст орших дорнод Азийн улс бөгөөд, 50 сая хүн амтай, 99.392 км2 газар нутагтай. БНСУ нь эдийн засгийн өндөр хөгжилтэй орон бөгөөд өвөрмөц онцлог бүхий соёл, зан заншилтай. Тус улс эрх зүйн боловсролыг сайжруулах ажлын хүрээнд 2008 оноос иргэдийн эрх зүйн ухамсар, мэдлэгийг дээшлүүлэх зорилго бүхий дагнасан хуулийг батлан хэрэгжүүлэх болсон юм. Иймд БНСУ-ын бүх нийтийн эрх зүйн боловсролыг дэмжих бодлого, арга зүй, туршлагыг судлах нь зүйтэй юм.

2. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, эрх зүйн соён гэгээрэл, эрх зүйн ухамсар, соёл, иргэний эрх зүйн боловсролын талаарх бодлого, хөтөлбөр, санаачилга, хууль тогтоомж, төсөл

БНСУ-ын Парламентаас 2008 онд “Эрх зүйн боловсролыг дэмжих тухай” хуулийг (*Legal Education Support Act*) батлан хэрэгжүүлэх болсон. Тус хуулийн зорилгыг “Эрх зүйн боловсролыг системтэйгээр олгох, иргэдийн эрх зүйн мэдлэг, ухамсрыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар ардчиллын үнэт зүйлийг хамгаалан

[45] ХЗҮХ-ийн Судалгааны төвийн ЭША Б.Гончигсумлаа судалгааны ажлын БНСУ-тай холбогдох хэсгийг бэлтгэв.

Хүний эрхийн үндэсний хүрээлэн www.nhri.gov.mn

эрх зүйт ёсны мөн чанар, зарчмыг баталгаажуулахад өөрийн хувь нэмрийг оруулах чадвартай иргэдийг бэлтгэх" хэмээн тодорхойлжээ.[46]

Хуулийн 2 дугаар зүйлд эрх зүйн боловсрол, сургууль болон нийгэм дэх эрх зүйн боловсролын талаарх ойлголтыг тодорхойлсон байна. Эрх зүйн боловсрол гэдэгт иргэдийн хуулийг ойлгох, хуулийн талаар ойлгон эерэг ухамсартайгаар нийгмийн харилцаанд оролцох, нийгмийн хэв журам болон үндсэн хуулийн үнэт зүйлийг ойлгох чадварыг хөгжүүлэх зорилгын хүрээний эрх зүйн талаарх ерөнхий ойлголт, хууль тогтоох процесс, эрх зүйн тогтолцоо, эрх зүйн үнэт зүйл болон зарчмыг залуу үе болон нийт иргэдэд ойлгуулахад чиглэсэн бүхий л хууль, эрх зүйтэй холбоотой боловсролыг ойлгохоор өргөн хүрээнд томьёолон тодорхойлжээ. Дээрхээс үзэхэд эрх зүйн боловсрол гэдэгт эрх зүйн мэргэжлийн боловсролоос бусад эрх зүйн мэдлэг олгох, иргэдийг чадавхжуулах, ухамсар хандлага төлөвшүүлэхэд чиглэсэн бүхий л арга хэмжээг ойлгохоор байна.

Харин сургууль дахь эрх зүйн боловсрол гэдэгт "Дээд боловсролын тухай" (*Higher Education Act*) болон "Бага дунд боловсролын тухай" (*Elementary and Secondary Education, Act*) хуулиудын хүрээнд тодорхойлсон сургуулиуд дахь эрх зүйн боловсрол хамаарна.[47] Боловсролын тухай дээрх хуулиудад хувийн, гадаадын, техникийн, сургалт үйлдвэрлэлийн зэрэг бүхий л төрлийн ерөнхий боловсролын, мэргэжлийн сургалт үйлвэрлэлийн, дээд боловсролын сургуулиудыг сургууль гэсэн тодорхойлолтод багтаасан байна.[48]

Нийгэм дэх эрх зүйн боловсрол гэдэгт "Насан туршийн боловсролын тухай" хуульд (*Lifelong Education Act*) тодорхойлсон насан туршийн боловсролын байгууллага болон иргэдийн эрх зүйн ухамсрыг нэмэгдүүлэх чиглэлээр ажилладаг бусад байгууллагын эрх зүйн боловсролын үйл ажиллагааг ойлгохоор заажээ.[49]

3. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа түгээгч байгууллага, чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа

Тус хуулийн 3 дугаар зүйлд төрийн болон нутгийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлсон. Төрийн болон нутгийн захиргааны байгууллага нь эрх зүйн боловсролын бодлогыг тодорхойлох, хамтын ажиллагааны тогтолцоог бүрдүүлэх болон эрх зүйн боловсрол олгох төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх үүрэгтэй байна. Төрийн болон орон нутгийн байгууллагууд нь эрх зүйн боловсролын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, иргэдийн эрх зүйн боловсролын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, эрх зүйн боловсролыг олгох мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, эрх зүйн боловсролын хөтөлбөрийг судлах, хөгжүүлэх, дэмжих; эрх зүйн боловсрол олгох материаллаг баазыг бүрдүүлэн хөгжүүлэх; эрх зүйн боловсрол олгох сүлжээг бий болгон, ажиллуулах, эрх зүйн боловсролыг дэмжихэд шаардлагатай арга хэмжээг эрх зүйн бодлогод тусгах зорилго, чиг үүрэгтэй байна. Энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд төрийн, хувийн, мэргэжлийн холбоод зэрэг бүх төрлийн байгууллагатай хамтран ажиллах, үр дүнтэй механизмыг төрийн болон нутгийн захиргааны байгууллагууд бүрдүүлэх үүрэгтэй.[50] Энэ хүрээнд хамтын ажиллагааг өрнүүлэх үүднээс төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн захиргааны байгууллага, нийслэлийн болон бусад хотын боловсролын алба, мэргэжлийн холбоодын хооронд хамтын ажиллагааны тогтолцоог бий болгожээ.

---

[46] Legal Education Support Act, Article 1, 2008.

[47] Мөн тэнд, зүйл 2.

[48] Мөн тэнд. Elementary and Secondary Education, Act Higher Education Act.

[49] Мөн тэнд, зүйл 2.

[50] Мөн тэнд.

Хуулийн 4 дүгээр зүйлд Эрх зүйн боловсролын хороог (*The Legal Education Committee)* үүсгэн байгуулах тухай тодорхойлсон байна. Тус хороо нь Хууль зүйн яамны харьяанд байх бөгөөд эрх зүйн боловсролын бодлогыг тодорхойлох, эрх зүйн боловсролын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх болон төсвийн үр дүнтэй ашиглалтыг хангах үүрэгтэй. Хороо нь дараах асуудлаар санал боловсруулах, шийдвэр гаргах үүрэгтэй. Үүнд:

- Эрх зүйн боловсролын бодлогыг тодорхойлох, дэвшүүлэх;
- Эрх зүйн боловсролын үндсэн төлөвлөгөөг боловсруулах, өмнөх жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ;
- Эрх зүйн боловсролын хүрээнд хамтын ажиллагаа болон зохицуулан холбох ажлыг дэмжих;
- Хорооны зорилгыг хангахад чиглэсэн бусад асуудалд санал өгөх, шийдвэр гаргах зэрэг хамаарна.

Хорооны ажиллах журмыг ерөнхийлөгчийн зарлигаар батлах ба журамд тусгагдсанаар төрийн төв байгууллагын төлөөллийг Эрх зүйн боловсролын хорооны гишүүнээр томилно. Ингэхдээ хорооны гишүүдийн талаас илүү хувийг төрийн байгууллагад ажилладаггүй хүмүүсээс сонгодог.[51] Хууль зүйн сайд Хорооны даргыг томилох үүрэгтэй байна.[52]

Хууль зүйн сайд Эрх зүйн боловсрол олгох, эрх зүйн мэдээлэл сурталчилгааг өрнүүлэх үүрэгтэй байгууллагыг Эрх зүйн боловсролын хороотой зөвшилцсөний үндсэн дээр Эрх зүйн соёлыг түгээгч төвөөр (*Legal Culture Promotion Center*) сонгон ажиллуулах боломжтой.[53] Өөрөөр хэлбэл Эрх зүйн боловсролын хорооноос гадна эрх зүйн боловсролын чиглэлээр мэргэшсэн төвийг Хууль зүйн сайд санаачлан байгуулах эрхтэй байна.

Төрийн болон нутгийн захиргааны байгууллагад эрх зүйн боловсролыг хөгжүүлэх судалгааг гүйцэтгэх үүрэг байдаг ч Хууль зүйн сайд зөвхөн эрх зүйн судалгаа гүйцэтгэх дагнасан байгууллагыг бий болгох замаар төрийн захиргааны байгууллагуудыг судалгааны материалаар дэмжин ажиллаж байна.[54]

Онцлон дурдахад Хууль зүйн сайд нь төрийн захиргааны төв, орон нутгийн захиргааны байгууллага, төрийн бусад байгууллагын удирдах албан тушаалтанд эрх зүйн боловсролын хөтөлбөрийг дэмжих болон хэрэгжүүлэхэд хамтран ажиллах талаарх шаардлагыг тавих эрхтэй байна.[55] Хууль зүйн сайдын энэхүү шаардлагыг онц ноцтой байдлаас бусад тохиолдолд төрийн байгууллагууд заавал биелүүлэх үүрэгтэй байна.[56]

4. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгааг хүлээн авах зорилтод бүлэг /өсвөр үе, ахмад настан, эмзэг бүлэг, орон нутгийн иргэд гэх мэт/-ийг тодорхойлсон байдал, авч хэрэгжүүлдэг арга хэмжээ

Тус хуулийн 7, 8, 9 дүгээр бүлэгт сургууль болон нийгэм дэх эрх зүйн боловсролын талаар зохицуулсан.

Сургууль дахь эрх зүйн боловсролыг дэмжих тогтолцоо

Бага, дунд боловсролын тухай хууль болон Дээд боловсролын тухай хуулийн хүрээнд төрийн болон орон нутгийн байгууллага нь сургуулиудын эрх зүйн боловсролын хөтөлбөр, үйл ажиллагааг бүхий л төрлөөр дэмжих боломжтой.

[51] Мөн тэнд, зүйл 4.

[52] Мөн тэнд.

[53] Мөн тэнд, зүйл 6.

[54] Мөн тэнд, зүйл 6.

[55] Мөн тэнд, зүйл 10.

[56] Мөн тэнд, зүйл 10.

Тухайлбал, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, төсөл хөтөлбөрийг дэмжих зэргээр хамтран ажиллах боломжтой байна.[57] Түүнчлэн төрийн болон орон нутгийн байгууллагууд нь эрх зүйн боловсрол олгох боловсон хүчнийг чадавхжуулах, хувийн эрх зүйн боловсролын байгууллагуудыг дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.[58]

Нийгэм дэх эрх зүйн боловсролыг дэмжих тогтолцоо

Насан туршийн боловсролын тухай хуульд (*Lifelong Education Act)* тодорхойлсон насан туршийн боловсролын байгууллага болон иргэдийн эрх зүйн ухамсрыг нэмэгдүүлэх чиглэлээр ажилладаг бусад эрх зүйн боловсролын байгууллагын үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийг төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагууд дэмжиж болдог.[59] Түүнчлэн бүрэн бус боловсролтой, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, Хойд Солонгос улсын иргэд, гадаадын иргэд зэрэг эрх ашиг нь хөндөгдөх магадлалтай зорилтот бүлгийн эрхийг хамгаалах, дэмжихэд чиглэсэн байгууллагын үйл ажиллагааг төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагууд дэмжин ажиллах боломжтойг хуульд зохицуулсан байна.[60]

5. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа түгээх арга зам, хэрэгжүүлэх процесс

Тус улсын эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа түгээлтийн чиг үүргийг төрийн байгууллагууд, орон нутгийн захиргааны байгууллага, эрдэм шинжилгээний хүрээлэн, төвүүд хариуцан ажилладаг. Тэдгээрийн дундаас улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг хууль зүйн судалгааны төвүүдийн үйл ажиллагаа өвөрмөц онцлоготой.

Эрх зүйн мэдээллийг түгээхэд Солонгосын Хууль тогтоомжийн судалгааны хүрээлэн (*Korean Legislation Research Institute*) чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Солонгосын хууль тогтоомжийн судалгааны хүрээлэн нь Засгийн газраас санхүүждэг үндэсний хууль зүйн бодлогын судалгааны хүрээлэн юм. Хууль зүйн үйлчилгээг сайжруулах, хууль тогтоох бодлогыг боловсруулах ажиллагаанд зөвлөх, дэмжлэг үзүүлэх зорилготойгоор 1990 онд байгуулагджээ. Түүнчлэн БНСУ-ын Хууль зүйн яам нь олон нийтийн мэдэх эрхийн баталгааг хангах, эрх зүйн зүйн мэдээлэл түгээлтийн чанарыг сайжруулах зорилгоор интернет орчинд олон төрлийн хайлтын сайтуудыг дэмжин хамтран ажилладаг. БНСУ-ын Үндэсний эрх зүйн мэдээллийн төв нь эрх зүйн бүхий л мэдээллийг хайх боломжтой нэгдсэн цахим хуудас ажиллуулдаг. Тус цахим хуудсанд хүчин төгөлдөр хууль, журам, гэрээ, засгийн газрын шийдвэрүүд, орон нутгийн байгууллагуудын тогтоол, журам, кейс, үндсэн хуулийн шүүхийн шийдвэр, хууль зүйн тайлбар, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, эрх зүйн нэр томьёо болон бусад хууль зүйн мэдээллийг агуулсан нийт 1.6 сая материал байршуулжээ. [61]

Тус мэдээллийн уахим хуудас дараах хэлбэрээр мэдээллээ түгээдэг. Үүнд

- Хууль зүйн мэдээг тухай бүр түргэн шуурхай, бодит үнэнээр мэдээлэх;
- Хүчин төгөлдөр хууль тогтоомжийг төдийгүй бусад эрх зүйн мэдээллийг түгээх;
- Ухаалаг утас ашиглан эрх зүйн мэдээлэл авах үйлчилгээ үзүүлэх;
- Хууль тогтоомж, түүнтэй холбогдон гарсан тогтоол, шийдвэрүүдийг ойлгомжтойгоор хүснэгтлэн системчлэн үзүүлэх хамаарна.

БНСУ нь эрх зүйн мэдээллийг зөвхөн өөрийн улсын иргэдэд түгээгээд зогсохгүй гадаадын иргэдэд таниулах шаардлагатай болсон. Учир нь тус улс нь 51

[57] Мөн тэнд, зүйл 7.

[58] Мөн тэнд.

[59] Мөн тэнд, зүйл 9.

[60] Мөн тэнд.

[61] http://www.moleg.go.kr/english/majorDuties?subId=6

сая хүн амтай бөгөөд 1.74 сая буюу 3.4% нь гадаадын иргэд байна. Тус улсад ажил хийх зорилгоор зүүн өмнөд Азиас болон төв Азийн орнуудаас (Узбекистан, Монгол) гадаадын иргэд ирэх болсноос гадна солонгос иргэнтэй гэр бүл болсон гадаадын иргэд 2005 оны байдлаар нийт гэрлэлтийн 14%-ийг (26000 гаруй) эзэлжээ. Мөн гадаад орнуудын цэргийн хүчин, түүнд ажиллагсад болох 30000 орчим гадаадын иргэд тус улсад амьдарч байна. Иймд эрх зүйн мэдээллийг гадаадын иргэдэд түгээх нь нэн шаардлагатай тулгамдсан асуудлын нэг болжээ.

БНСУ нь эрүүгийн хэргийн нэгдсэн системтэй ба системийн мэдээллийн санд үндэслэсэн портал сайтыг (portal) иргэдэд зориулан ажиллуулдаг. Үүгээр хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааг иргэдэд мэдээлэх, хүргэх, хөнгөн төрлийн хэргийн торгуулийг цахим хэлбэрээр төлөх боломжийг олгох, шүүх хуралдааны зарыг түгээх, иргэд өөрийнхөө хэргийн үйл явц аль үе шатанд явж байгааг мэдэх боломжийг уг портал сайтаар дамжуулан иргэдэд олгожээ.

ХАВСРАЛТ IV

Унгар улс[62]

/Иргэдэд эрх зүйн боловсрол олгоход чиглэсэн эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтыг түгээх туршлага/

1. Тухайн улсын талаарх ерөнхий мэдээлэл, үүний дотор эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлын арга барилд нөлөөлөх хүчин зүйл, онцлог зэрэг мэдээлэл

Унгар улс 10 сая хүн амтай, зүүн Европын орон юм. Дэлхийн хоёрдугаар дайнаас хойших хугацаанд манай улстай нэгэн адил социалист тогтолцоотой байсан ба 1989 онд баруун Германы загварт суурилсан ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжсэн орны нэг юм. Энэ байдлаараа манай улстай ойролцоо улс төр, нийгмийн тогтолцоотой улсуудын нэг гэж дүгнэж болно.

Социалист орнуудаас харьцангуй чөлөөт эдийн засаг, нийгмийн хөгжилтэй байсан энэ улсад ардчилсан нийгмийн үнэт зүйлсийг тусгасан хууль тогтоомжийн шинэчлэл хийгдэж эхэлсэн. Мөн 2004 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Европын Холбооны /цаашид ЕХ гэх/ гишүүн болсноор тус улсын хууль тогтоомжийг ардчилсан нийгмийн суурь зарчим болон ЕХ-ны хууль тогтоомжтой нийцүүлэх үүргийг хүлээсэн бөгөөд энэ нь Унгарын хууль, эрх зүйн орчныг бүхэлд нь шинэчлэх үндэс болсон. Иймд иргэдийн эрх зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, зах зээлийн эдийн засгийн харилцааны эрх зүйн үндсийг бий болгох зэрэг шинэчлэлийн ажлуудыг хууль зүйн суурь судалгааны ажилд үндэслэн хийж иржээ.

Хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд хийгдэж буй ажлуудын үр дүнд бий болсон эрх зүйн орчин, хууль тогтоомжийн өөрчлөлтийн талаарх иргэдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, таниулан сурталчлах ажлыг төр засгийн зүгээс тусгайлан баталсан бодлого, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлдэг байна.

Унгар улсад хэрэгжүүлж буй арга хэмжээг хууль зүйн туслалцаа үзүүлэх, хууль зүйн мэдээлэл өгөх гэсэн үндсэн хоёр ангилалд хамааруулж болохоор байна.

Эхний тохиолдолд иргэний “хууль, шүүхийн өмнө тэгш байх эрх”-ийг хангах үүднээс эрүүгийн, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны болон шүүх хуралдаангүйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хохирогч/нэхэмжлэгч, сэжигтэн/хариуцагч, гэрч гэсэд хэргийн бүхий л оролцогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх адил тэгш нөхцөлийг бүрдүүлэх төрийн үүргийг ойлгож байна. Үүнийг хууль зүйн албаар дамжуулан, хуулийн туслах буюу өмгөөлөгчдийн нэгдсэн

[62] ХЗҮХ-ийн Судалгааны төвийн ЭША Ж.Бариаширсүрэн судалгааны ажлын Унгар улстай холбогдох хэсгийг бэлтгэв.

бүртгэлд бүртгэгдэж, нэрийн жагсаалтад багтсан өмгөөлөгч, хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх бүхий байгууллага, их сургуулийн багш нараар гүйцэтгүүлдэг байна. Энэ харилцааг 2003 оны Хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай LXXX хууль[63], 2007 оны Хууль зүйн сайдын 56/2007 (XII.22) тоот тогтоолоор[64] баталсан "Хууль зүйн туслалцаа авах нарийвчилсан дүрэм"-ээр зохицуулдаг.

Харин хууль зүйн мэдээлэл өгөх ажлын хүрээнд салбар бүр өөрийн чиг үүрэг, үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм журмын талаар таниулах, сурталчлах үйл ажиллагаа явуулдаг. Мөн төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран, эсхүл төрийн бус байгууллага, олон улсын байгууллага бие даан тодорхой нэг эрх, асуудлын хүрээнд эрх зүйн боловсрол олгох төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж иржээ. Тухайлбал, ЕХ-ны санхүүжилтээр 2009-2015 оны хооронд аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажил олгогч, хөдөлмөр эрхлэгчдийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн даатгал, татвар болон бусад энэ төрлийн асуудалтай холбоотой эрх зүйн мэдлэгийн дээшлүүлэх зорилгоор хэрэгжүүлсэн "Хуулийн цэг" хөтөлбөрийг энд дурдаж болох юм.

Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, түүнийг түгээх арга хэлбэрийн тухайд онцлох нэг зүйл бол тус улсад 1960 оны эхэн үеэс 1990 он хүртэлх хугацаанд иргэдийн эрх зүйн ухамсар, хуулийн мэдлэгийн талаар хэд хэдэн суурь судалгаа[65] хийсэн байна. Эдгээр судалгаагаар социалист нийгмийн тогтолцооны үед амьдарч байсан болон энэ тогтолцоонд шилжихээс өмнөх үеийн иргэдийн эрх зүйн ухамсрын төлөвшил болон хуулийн мэдлэгийн төвшинг эрх зүйн социологийн судалгааны аргаар тогтоохыг зорьсон. Уг судалгаанд иргэдийн эрх зүйн ухамсар, хуулийн мэдлэгийг тусдаа ойлголт гэж авч үзсэн байх ба тэдгээрийг уялдаа холбоо ямар төвшинд байгааг тогтоожээ. Мөн боловсролын төвшин, нас, хүйс, амьдарч буй орон нутгийн онцлог, гэмт хэргийн талаар мэдээлж буй арга хэрэгсэл иргэдийн сэтгэлзүй болон, хуулийн мэдлэгт хэрхэн нөлөөлдөг, тэдгээр нь хэрхэн өөрчлөгдөж байгаа талаар ойролцоогоор 10-10 жилийн давтамжтай судалжээ. Үүний үр дүнг ерөнхийд нь тоймловол иргэдийн эрх зүйн ухамсар нь оршин суугаа бүс нутгийн онцлог, эрхэлж буй ажил, түүний мэдээлэл авч буй хэлбэрээс ихээхэн шалтгаалдаг гэх дүгнэлтэд хүргэсэн. Эрх зүйн мэдлэгийн төвшинг хэмжихдээ тодорхой харилцааг зохицуулсан хуулийн зүйл, заалтын тухай мэдлэгээс илүүтэй эрүү, иргэн, төрийн байгуулалтын эрх зүй буюу эрх зүйн салбаруудын талаарх ерөнхий мэдлэгийг хэмжихэд илүү анхаардаг байна.

Үүнээс харахад эрх зүйн ухамсрыг төлөвшүүлэх, хуулийн мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээг эрх зүйн социологийн судалгааны үр дүнд суурилсан, бүс нутаг, зорилтот бүлгийн нийгмийн харилцаанд ороход шаардагдах хууль тогтоомжийг түлхүү сурталчилсан үйл ажиллагааг үндсэн чиг үүргийн хүрээнд зохион байгуулдаг. Ингэхдээ тухайн асуудлыг хариуцсан төрийн болон нутгийн удирдлагын байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлдэг гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

2. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, эрх зүйн соён гэгээрэл, эрх зүйн ухамсар, соёл, иргэний эрх зүйн боловсролын талаарх бодлого, хөтөлбөр, санаачилга, хууль тогтоомж, төсөл

Эрх зүйн боловсрол олгох ажил ерөнхий боловсролын сургалтын нэгдсэн хөтөлбөрт тусгагдсан хэмжээнд эхний ээлжид бага ангийн сурагчдад хүүхдийн эрхийн талаар, ахлах ангийн 9, 10 дугаар ангид "Эдийн засаг болон эрх зүйн орчин"[66]

[63] Эх сурвалж: http://net.jogtar.hu/jr/gen/hjegy_doc.cgi?docid=A0300080.TV

[64] Эх сурвалж: http://net.jogtar.hu/jr/gen/hjegy_doc.cgi?docid=a0700056.irm

[65] Эх сурвалж: http://epa.oszk.hu/02400/02445/00034/pdf/EPA02445_ias_2014_04_01.pdf

[66] Эх сурвалж: Gazdasági és jogi környezetünk I., II. Эх сурвалж: Унгар улсын Засгийн газрын албан ёсны цахим хуудас: http://www.kormany.hu/download/b/1e/50000/kirtkv2015_kozlony_150603.pdf

хичээлээр дамжуулан эрх зүйн ерөнхий мэдлэг олгож байгаа бол мэргэжлийн дунд сургуулиудад сурагчийн эзэмшиж буй мэргэжлийн хүрээнд “Эрх зүй, төрийн захиргааны мэдлэг”[67], “Эрх зүйн мэдлэг-Тээврийн эрх зүй”[68] гэх зэрэг эрх зүйн мэдлэг олгох хичээлүүдээр дамжуулан анхан шатны, ерөнхий мэдлэг олгодог байна. Их дээд сургуулиудад эрх зүйн хичээлүүд заавал сонгон үзэх хичээл болон ордог бөгөөд эдгээр нь тухайн оюутны эзэмшиж буй мэргэжилтэй холбогддог байна.

Унгар улсын хувьд эрх зүйн мэдлэг, мэдээлэл олгох ажлыг ихэвчлэн тодорхой нэг хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд гүйцэтгэдэг ажээ. Төрийн байгууллагууд үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд хууль, эрх зүйн мэдээлэл түгээх үүрэгтэй бөгөөд бүгд өөрийн албан ёсны цахим хуудсаараа дамжуулан мэдээлэл түгээдэг. Тухайлбал, Унгарын Боловсрол судлал, хөгжлийн хүрээлэн[69] нь ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд болон үндэсний хэмжээнд баримтлах үндсэн сургалтын хөтөлбөр, сурах бичигт заавал тусгах хүний эрхийн холбогдолтой олон улсын гэрээ, хэлэлцээр болон дотоодын хууль тогтоомжийн талаар, тэдгээрт тусгагдсан эрх, үүргийн талаар санал, зөвлөмж боловсруулдаг. Үүнээс гадна өөрийн цахим хуудсанд хууль, эрх зүйн, ялангуяа хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр мэдээлэл бэлтгэж байршуулах замаар иргэдийн болон сургуулийн насны хүүхдүүдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх талаар анхаардаг.

Үүнээс гадна бүс нутаг, аймаг, нутгийн өөрөө удирдах байгууллагууд тухайн бүс нутгийн онцлог, хэрэгцээ шаардлагад тулгуурласан эрх зүйн мэдээлэл олгох үр нөлөөтэй бүтэц, хэлбэрийг өөрөө сонгон хэрэгжүүлдэг. Тухайлбал, Будапешт хотын 3 дугаар дүүргийн өөрөө удирдах байгууллага[70] “Хүүхдийн эрхийн стратеги” боловсруулан хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа, санхүүжилтэд оруулах хувь хэмжээг тодорхойлсон байна.[71]

Үүний нэгэн адил Унгар улсын баруун хязгаарт орших Вашмэдьэ /Vasmegye/ нь нутгийн иргэдийн аж амьдралд түлхүү тохиолддог асуудлын хүрээнд хууль, эрх зүйн холбогдолтой мэдээ, мэдээлэл байршуулж, шаардлагатай мэдээлэл хүргэдэг. Тус мужийн хотуудад амьдарч буй иргэдийн дунд Австри, Герман зэрэг хил залгаа болон ойр орших гадаад орнуудад урт, богино хугацаагаар хөдөлмөр эрхлэх, оршин суух асуудал их гардаг аж. Иймд тус мужийн албан ёсны цахим хуудсанд[72] гадаадад хөдөлмөр эрхлэхэд тавигдах шаардлага, анхаарах зүйл, эдлэх эрх, хүлээх үүрэгтэй холбоотой дотоодын, тухайн улсын болон ЕХ-ны эрх зүйн зохицуулалтын талаар дэлгэрэнгүй мэдээлэл байршуулж, иргэдийн хандсан асуултад хариулах байдлаар тухайн хувь хүний нийгмийн харилцаанд тохирсон мэдлэг олгох ажлыг зохион байгуулдаг байна.

Унгар улс ЕХ-ны гишүүн болсноор эдийн засаг, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллага, хөдөлмөр эрхлэгч, ажил олгогчийн эрх зүйн байдалд болон нийгмийн даатгал, татвар, гаалийн хууль тогтоомжид ихээхэн өөрчлөлт орсон. Иймд энэ чиглэлийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, туслалцаа үзүүлэх зорилгоор дунд хугацааны хөтөлбөр боловсруулан ажилласан байдаг. Үүний талаар дэлгэрүүлэн авч үзье.

Хөдөлмөрийн харилцаан дахь үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө. Унгар

[67] Jogi- és államigazgatási ismeretek. Эх сурвалж: мөн тэнд

[68] Jogi ismeretek – Fuvarozásjog, Эх сурвалж: мөн тэнд

[69] Эх сурвалж: http://ofi.hu/tudastar/emberi-jogok

[70] Эх сурвалж http://obuda.hu/

[71] Эх сурвалж: http://obuda.hu/wp-content/uploads/2013/01/Gyermekjogi-strat%C3%A9gia-2016-1.pdf

[72] Эх сурвалж: http://www.vasmegye.hu/vasi-mozaik/183184

улсын Засгийн газар ЕХ-ны санхүүжилтээр 2 жилийн хугацаатай “Хуулийн цэг”[73] хөтөлбөрийг 2009 оноос эхлүүлсэн байна. Төслийн ерөнхий зохицуулагч нь Үндэсний эдийн засгийн яам байсан ба Унгарын мэргэжлийн байгууллагуудын үндэсний холбоо[74], Унгарын үйлдвэрлэлийн холбоо[75], Аж үйлдвэр эрхлэгчдийн үндэсний холбоо[76], Ерөнхий хэрэглээний нэгдлүүд болон Худалдааны байгууллагуудын үндэсний холбоо[77], Худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах үндэсний холбоо[78]-дтой хамтран хэрэгжүүлсэн байна. Уг төслийн үндсэн зорилго нь тус улсад хөдөлмөр эрхлэгч, ажил олгогч болон аж ахуй эрхлэгчдэд хөдөлмөрийн зах зээлд гарах, хөдөлмөрийн, нийгмийн даатгалын тухай хууль болон аж ахуй эрхлэх эрх зүйн орчин, зохицуулалтын талаар үнэ төлбөргүй мэдээлэл олгоход оршино. Унгарын 7 бүс нутагт, 144 нэгжтэйгээр хэрэгжүүлсэн энэхүү хөтөлбөр нь иргэдэд эрх зүйн ерөнхий мэдээллийг цахимаар, утсаар, цахим болон энгийн шуудангаар, биеэр уулзах аргаар түгээдэг. Иргэд 1/ хөдөлмөр эрхлэлт, 2/ нийгмийн даатгал, 3/ компани, аж ахуйн нэгж байгуулах, хувираа хөдөлмөр эрхлэх тухай, 4/ захиргааны эрх зүй, 5/ гэр бүлийн эрх зүй, 6/ санхүү, татварын эрх зүйн зохицуулалтын талаар тодорхой нэг хууль эрх зүйн асуудлаар зөвлөгөө, мэдээлэл авах боломжтой. Хуулийн зөвлөгөө, мэдээлэл өгөх ажлын хүрээнд иргэний тавьсан асуудлаар тухайн хувь хүний асуудалд нийцсэн ерөнхий мэдээлэл өгөх ба тухайн асуудлаар аль байгууллагад, хэрхэн хандах талаар мэдээлэл олгож шаардлагатай тохиолдолд албан бичиг, өргөдөл, гомдол, санал бичих, анкет бөглөх зэрэгт туслалцаа үзүүлдэг байна. Харин энэ үйлчилгээ нь шүүх, төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа, хэрэг бүртгэл болон аж ажуйн нэгжтэй холбоотой мэдүүлэг, тайлан өгөх үүрэгтэй холбоотой үйл ажиллагаанд хамаардаггүй.

“Хуулийн цэг” хөтөлбөр нь 2015 он хүртэл хөдөлмөрийн харилцаанд хамаарах бүхий л чиглэлээр хамтрагч байгууллагууд болон мэргэжлийн шалгалт өгсөн мэргэшсэн хуульч, дадлага туршлагатай хуульчдын оролцоотойгоор хууль зүйн зөвлөгөө өгөх бүтцийг бий болгож чадсан ба тэдгээрийн зүгээс үзүүлж буй мэргэжлийн зөвлөгөөг хүн бүр чөлөөтэй авах боломжтой, мөн албан ёсны цахим хуудсан дахь баримт бичгийн санд байршуулсан 130 гаруй баримт бичгийн загвар, гэрээний төсөл зэргийг ашиглах нөхцөл бүрдсэн байна. Гэвч ЕХ-ны санхүүжилтийн хугацаа дууссантай холбогдуулан 2015 оноос эхлэн дээрх бүтцийн хүрээнд олгох зөвлөгөө мэдээлэл тодорхой тарифтай буюу үнэ төлбөртэй болсон байна[79].

3. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа түгээгч байгууллага, чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа

Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа түгээх үндсэн чиг үүрэг бүхий бие даасан байгууллага, бүтэц тус улсад байхгүй. Харин төрийн байгууллага бүр өөрийн чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд хэрэглэгдэж буй эрх зүйн актуудын талаар иргэдэд мэдээлэл өгч ажилладаг.

Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх зэрэг ажлыг төрийн байгууллагуудаас илүүтэй төрийн бус байгууллага, нийгэмлэг, холбоод идэвх санаачлагатай хэрэгжүүлж хэвшсэн байна.

Унгар улсад аливаа хуульд “сайн – муу” гэх дүнг хууль санаачлагч, хууль тогтоогч болон хэрэгжүүлэгч байгууллага өгдөггүй. Харин үүнээс илүүтэй иргэдээс авсан эрх зүйн социологи судалгааны үр дүнд үндэслэсэн дүн тавьдаг гэж үзэх

[73] http://jogpont.hu/oldal.php?megnyit=1001

[74] Magyar Szakszervezetek Országos Szövetsége

[75] Magyar Iparszövetség

[76] Ipartestületek Országos Szövetsége

[77] Italános Fogyasztási Szövetkezetek és Kereskedelmi Társaságok Országos Szövetsége

[78] Kereskedők és Vendéglátók Országos Érdekképviseleti Szövetsége

[79] Эх сурвалж: http://jogpontplusz.hu/

боломжтой.[80] Үүнээс харахад эрх зүйн социологи судалгааны дүнд үндэслэн аль салбарын хууль тогтоомжийг ямар бүлэгт сурталчлах тухай шийдвэрлэдэг байна. Үүний нэг жишээ бол дээр дурдсан муж/аймгийн өөрөө удирдах байгууллагууд өөрийн нутаг дэвсгэрийн онцлог, иргэдийн аж байдал, хөдөлмөр эрхлэлтэд илүү ихээр хэрэглэгдэх хууль тогтоомжийн талаар мэдээлэл түгээх аргыг дахин дурдаж болох юм.

Эрх зүйн социологи судалгаа буюу суурь судалгааг 1990-ээд оноос хойш Унгарын Шинжлэх ухааны академи, эрдэмтэн судлаачид бие даан эсхүл багаараа бие даасан төсөл болгон гүйцэтгэдэг хандлага тогтсон байна. Тухайлбал, 2012-2015 онд гүйцэтгэсэн “Унгар иргэдийн хуулийн мэдлэг – онолын болон эмпирик судалгаа”[81]-г дурдаж болох юм. Уг судалгааны зорилго нь унгар иргэдийн хуулийн мэдлэгийг шалгах, үүнд хууль тогтоомжтой холбоотой мэдлэг, хуулийн талаарх төсөөлөл[82]-ийг тандан судлах явдал юм. Судалгааны арга зүйн хувьд олон улсад хэрэглэгддэг шинэлэг аргуудаас гадна 1960-1990 онуудад эрх зүйн социологи судалгааг гүйцэтгэж байсан Кулчар Калман /Kulcsбr Kбlmбn/, Шаёо Андраш / Sajy Andrбs/ нарын боловсруулсан аргачлалыг ашигласан нь улс төр, нийгмийн тогтолцооны шилжилтийн үеийн өмнөх ба дараах үеийн иргэдийн эрх зүйн мэдлэгийн төвшинг харьцуулан судлахад үр дүнтэй гэж үздэг.

Төрийн бус байгууллагууд /цаашид ТББ гэх/ үйл ажиллагааны үндсэн чиглэлийнхээ хүрээнд иргэдийн хуулийн мэдлэг, ухамсрыг дээшлүүлэх, шинээр гарч буй хууль тогтоомжийг таниулах арга хэмжээ авч ажилладаг. ТББ-уудын үйл ажиллагааг дэмжих, санхүүжилт олгох зэрэгт төрөөс багагүй анхаарч ажилладаг. Гэхдээ энэ анхаарал, халамж нь тухайн ТББ-ын идэвх, санаачлагатай, үр дүнтэй үйл ажиллагаа, хэр өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа явуулж байгаагаас ихээхэн хамаардаг байна. Тухайлбал, иргэний орлогын албан татварын хуульд зааснаар иргэд татварынхаа 1%-ийг аль нэг ТББ-д нэр зааж өгөх эрхтэй байдаг бол нэр зааж өгөөгүй татварын 1%-иас бүрдсэн татварын нийт орлогыг хамгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ТББ-уудад хуваарилдаг байна.

Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй ТББ-ууд аливаа нэг зорилтот бүлэгт чиглэсэн үйл ажиллагаа эрхэлж, түүгээрээ дагнан мэргэшдэг. Тухайлбал, Унгарын “Хуулийн мэдлэг сан”[83] 1998 онд үүсгэн байгуулагдсан. Үндсэн зорилго нь хуулийн мэдлэгийг түгээх, хууль, эрх зүйн сургалт зохион байгуулах, эрх зүйн мэдээлэл олгох, эрх зүйн чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэх юм. Эдгээр ажлыг юуны өмнө хууль хэрэглэх, хуулийн талаар мэдээлэл авах тал дээр хоцрогдмол орчинд амьдардаг, эсхүл энэ талын мэдээлэл авахад хүндрэлтэй нөхцөлд байдаг нийгмийн эмзэг бүлэгт зориулдаг. Иймд энэ ТББ-ын үйл ажиллагаа нь голчлон нийгмийн ашгийн бус байгууллагууд, бүх нийтийн боловсролын байгууллагууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хүүхдүүдэд чиглэгддэг байна. Ажлын арга барилын хувьд мэргэжлийн хуульчид сайн дурын, нийгмийн хариуцлагын хүрээнд судалгаа шинжилгээ хийх, сургалт зохион байгуулах, эрх зүйн мэдээллийн сүлжээ ажиллуулах, мэдээлэл түгээх материал бэлтгэхэд гар бие оролцох, тараах, соён гэгээрүүлэх лекц унших болон ийм төрлийн арга хэмжээнд оролцож өөрсдийн туршлагаасаа хуваалцах, санал гаргах зэргээр ажлын үр дүнгээ олон нийтэд танилцуулдаг. Уг ТББ нь хүүхдийн эрх, ашгийн бус байгууллагын эрх зүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн байдалтай холбогдуулан нэг сэдвээр дагнасан хөтөлбөр боловсруулан ажилладаг.

[80] Эх сурвалж: Kiss Valéria: Az élő jog koncepciójának empirikus vizsgálata. … Эх сурвалж: http://epa.oszk.hu/02600/02687/00006/pdf/EPA02687_jogi_tanulmanyok_2014_238-248.pdf

[81] A magyar lakosság jogtudata – elméleti és empirikus elemzés. OTKA 105552 sz. projekt (2012-2015) эх сурвалж: http://jog.tk.mta.hu/a-magyar-lakossag-jogtudata

[82] Энэ ойлголт дор хууль тогтоомж иргэдийн сэтгэхүйд болон нийгмийн бодит харилцаанд ямар оролцоотой буюу нөлөөтэй байдаг тухайд хариулт авахыг ойлгоно.

[83] Эх сурвалж: http://www.jogismeret.hu/

ХАВСРАЛТ V

УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ВАНТ УЛС[84]
/Иргэдэд эрх зүйн боловсрол олгоход чиглэсэн эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтыг түгээх туршлага/

1. Тухайн улсын талаарх ерөнхий мэдээлэл, үүний дотор эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлын арга барилд нөлөөлөх хүчин зүйл, онцлог

Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад иргэдийн эрх зүйн соёл харьцангуй төлөвшсөн, иргэний нийгэм нь хариуцлагатай, төрийн байгууллага нь өөрийн чиг үүргийн эрх зүйн асуудлаар иргэддээ мэдээлэл өгөх арга хэлбэр нь тогтворжсон, төрийн албан хаагчид нь чадавхтай өндөр хөгжилтэй улс юм.

2. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, эрх зүйн соён гэгээрэл, эрх зүйн ухамсар, соёл, иргэний эрх зүйн боловсролын талаарх бодлого, хөтөлбөр, санаачилга, хууль тогтоомж, төсөл

Тус улсын хөгжлийн онцлогтой холбоотойгоор тус улсад эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын талаарх үндэсний хэмжээний болон яамдын төвшинд тодорхойлсон төрийн бодлого байдаггүй.

3. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа түгээгч байгууллага, чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа

Их Британийн төрийн байгууллагууд өөрийн чиг үүргийн дагуух эрх зүйн асуудлаар иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагааг бие даан өрнүүлж хэвшсэн.[85] Тухайлбал: Шударга худалдааны газар (*the Office of Fair Trading*) нь хэрэглэгчид боловсрол олгох стратеги хөтөлбөрийн хүрээнд хэрэглэгчдэд бараа, үйлчилгээ худалдан авахад өөрийн эрх үүргийг мэддэг, хариуцлагатай ханддаг болгох ажлыг гүйцэтгэдэг. Мөн Боловсролын яам (*The Department for Education and Skills*) нь хувьсан өөрчлөгдөж буй нийгэмд хүүхдэд зайлшгүй шаардлагатай санхүүгийн боловсрол олгох, эрх үүргээ ухамсарлан өөрсдөө бие даан амьдрах чадвар бүхий иргэн болоход чиглэсэн бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Ажил хөдөлмөр болон тэтгэврийн яам (*The Department for Work and Pensions*) нь тэтгэврийн иргэдийг мэдээллээр хангах, улмаар тэдэнд мэдлэг мэдээлэлтэйгээр тодорхой шийдвэр гаргах чадварыг олгох ажлыг өрнүүлдэг. Энэ мэтчилэн төрийн байгууллагууд нь өөрийн чиг үүргийн асуудлаар тодорхой бүлэг хүмүүс, хүүхдүүдэд эрх зүйн мэдлэг, чадвар олгох үйл ажиллагааг бие даан өрнүүлж хэвшсэн.

Үндсэндээ тус улсад эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтыг өрнүүлэхтэй холбоотой тодорхой төрийн бодлого, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий дагнасан төрийн байгууллага байдаггүй.

Иргэдийн эрх зүйн ерөнхий мэдлэг, ухамсрыг дээшлүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлыг тус улсад иргэний эрх зүйн боловсрол (public legal education) нэрийн дор өрнүүлдэг. Энэхүү ажлыг томоохон ТББ эрхлэн явуулдаг ба тэд тодорхой хөтөлбөр хэрэгжүүлэхэд төрөөс санхүүжилт авах эсхүл үйл ажиллагааны бусад орлогоос санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлдэг.

4. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгааг хүлээн авах зорилтод бүлэг /өсвөр үе, ахмад настан, эмзэг бүлэг, орон нутгийн иргэд гэх мэт/-ийг тодорхойлсон байдал, авч хэрэгжүүлдэг арга хэмжээ

---

[84] ХЗҮХ-ийн Судалгааны төвийн ЭША Б.Ундрах судалгааны ажлын УИНВУ-тай холбогдох хэсгийг бэлтгэв.

[85] Developing capable citizens, the role of public legal education, page 16, The report of the PLEAS Task Force, 2007.

Тус улсын томоохон ТББ-ууд нь тодорхой зорилтот бүлэгт эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтыг явуулахад эсхүл тодорхой арга зүйн болон гарын авлага боловсруулах чиглэлээр дагнан үйл ажиллагаагаа явуулдаг. Тухайлбал: Иргэний сан (*Citizenship Foundation*) ТББ нь хүүхдэд зориулан мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлыг өрнүүлэх туршлагатай бол Өдөр тутмын хууль (*Law for Life*) ТББ нь мэдээлэл, сурталчилгаа, сургалтын материал бэлтгэх, мэдээллээ түгээх арга зүйн болон тодорхой салбар эрх зүйгээр иргэдэд шаардлагатай мэдээлэл бэлтгэхэд мэргэшсэн байдаг. Түүнчлэн ядуус, дүрвэгсэд, цагаачид зэрэг эрх зүйн мэдлэг шаардлагатай тодорхой бүлэгт чиглэсэн эрх зүйн мэдлэг олгох зорилтот ажлууд хийгддэг. Эдгээр арга хэмжээ болон бусад томоохон ТББ-ын үйл ажиллагааг дараах хэсэгт авч үзье.

5. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа түгээх арга зам, хэрэгжүүлэх процесс

Ингээд иргэний эрх зүйн боловсрол олгох чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг дараах байгууллагуудын үйл ажиллагаа болон эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлыг түгээх арга зам, хэрэгжүүлэх процессыг авч үзье.

Өдөр тутмын хууль *(Law for Life)*

Тус байгууллага нь өөрийн хэргийг төлөөлөн шүүхэд өмгөөлөгчийн үйлчилгээ авахгүйгээр бие даан оролцож байгаа иргэдэд зориулан зөвлөгөө өгөх, гарын авлагаар хангах ажлыг хэрэгжүүлдэг ба энэ хүрээнд *http://www.advicenow.org.uk* цахим хуудсыг ажиллуулдаг. Энэ төрлийн үйл ажиллагааг Хууль зүйн яамыг төлөөлөн гэрээгээр гүйцэтгэдэг. Гарын авлагын тухайд Хуульчийн тусламжгүйгээр гэрлэлт дуусгавар болгох нь (How to get a divorce or end a civil partnership without the help of a lawyer), Гэр бүлийн дагнасан шүүхэд өөрийгөө төлөөлөх нь (Representing yourself in family court) зэрэг олон гарын авлагыг гаргасан байдаг.[86]

Тус байгууллага нь нийгмийн халамжийн хуулийн талаарх гарын авлага боловсруулах, болон бусад байгууллагад гарын авлага боловсруулахад арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг гүйцэтгэдэг мэдээлэл, сурталчилгаа, сургалтын чиглэлээр мэргэшсэн байгууллага юм.

Түүнчлэн Хуулийн талаар олж мэдэх нь, хэрхэн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх вэ, Байшин эвдлэх үед, ажил эрхлэлт болон ялгаварлан гадуурхалт зэрэг сэдвээр хууль эрх зүйн мэдлэг олгох сурах бичиг, гарын авлагыг гаргадаг. Эдгээр сургалтын материал нь цахим сургалтын материал хэлбэрээр нээлттэй байрладаг ба ийнхүү цахим сургалтын материал бэлтгэн иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажил нь ихээхэн үр дүнтэй байсан талаар хэрэгжилтийн үнэлгээгээр тогтоогдсон байна. Уг үнэлгээгээр цахим сургалтын материал бэлтгэн, нээлттэй тавих нь иргэдэд тодорхой эрх зүйн асуудлаа өөрсдөө шийдвэрлэх чадварыг олгох төдийгүй тэдэнд эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэхэд үр дүнтэй болох нь тогтоогдсон.

Тус байгууллага иргэний эрх зүйн боловсролын материал бэлтгэн нийтэд түгээхийн өмнө тухайн мэдээллийг түгээх гэж буй зорилтот бүлгийн иргэдээс эрх зүйн материалын тухайд үнэлгээ, зөвлөгөөг авдаг. Улмаар иргэдийн үнэлгээн дээр тулгуурлан мэдээлэл, сурталчилгаа, сургалтын материалыг сайжруулдаг. Бичиг үсэг тайлагдаагүй хүмүүст зориулан мөн эрх зүйн боловсролын материалыг бэлтгэдэг.

Өдөр тутмын хууль ТББ байгууллага эрх зүйн үр дүнтэй, ойлгомжтой мэдээллийг иргэдэд хэрхэн түгээх болон эрх зүйн мэдээллийг түгээхэд баримтлах зарчим зэрэг арга зүйн гарын авлагыг боловсруулж өөрийн цахим сайтаас үнэ төлбөргүй авч хэрэглэх боломжтойгоор байршуулдаг.[87]

[86] Эх сурвалж: http://www.advicenow.org.uk/advicenow-guides

[87] Эх сурвалж: http://www.lawforlife.org.uk/publications/

Биркбэк (Birkbeck) коллежтой хамтран бакалаврын болон магистрын ангийн оюутнуудад иргэний эрх зүйн боловсролын зорилго, ач холбогдол, хүрээ зэргээр хичээл ордог төдийгүй тэдэнтэй хамтран тодорхой иргэдэд эрх зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах замаар оюутнуудад практик дадлага олгодог. Иргэдэд эрх зүйн боловсрол олгох сургах багшийг мөн бэлтгэдэг.

Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлыг сайжруулах, дахин шинэчлэх үүднээс мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлыг үнэлэх шаардлагатай байдаг. Тус байгууллага мөн Хууль зүйн яамны санхүүжилтээр иргэний эрх зүйн боловсрол олгох мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлыг үнэлэх арга зүйн гарын авлагыг гаргасан.[88] Гарын авлагад үнэлгээний төрөл, үнэлгээ явуулахад баримтлах зарчим, шалгуур үзүүлэлтээ тогтоох зэрэг үнэлгээний процессыг хэрхэн явуулах талаарх цогц мэдээллийг тусгасан.

Иргэний сан *(Citizenship Foundation)*

Иргэний сан ТББ нь хүүхдийн эрх зүйн боловсролыг дэмжих чиглэлээр дагнан ажилладаг. Иймд уг байгууллага нь багш нарт зориулсан хууль эрх зүйн сэдвээр гарын авлага бэлтгэн өөрийн цахим хуудсанд байршуулсан байдаг. Англиин ерөнхий боловсролын сургуулийн 80 гаруй хувь нь тус байгууллагын бэлтгэсэн сургалтын гарын авлагыг хичээлдээ ашигладаг. Тус байгууллагаас зөвхөн сургалтын гарын авлага бэлтгээд зогсохгүй багш нарыг хууль эрх зүйн хичээлийг хэрхэн хүүхдэд орох талаарх сургалтыг явуулдаг. Багш нарт гэр бүлийн эрх зүй, хэрэглэгчийн эрх зүй, оюуны өмчийн эрх зүй зэрэг салбар эрх зүйн хичээлийг хэрхэн орох талаар заадаг төдийгүй ямар арга зүйгээр орох нь илүү үр дүнтэй болох талаар зөвлөгөө өгдөг. Тухайлбал: хүүхдүүдийг бүлэг болгон харилцан яриулах, мэтгэлцүүлэх, жүжиглэсэн тоглолтоор дамжуулан тодорхой эрх зүйн асуудлыг ойлгуулах зэрэг сонирхолтой хэлбэрээр багш нарыг эрх зүйн хичээл ороход нь арга зүйн зөвлөгөө өгдөг. Түүнчлэн эрх зүйн хичээлийн хөтөлбөрийг боловсруулан, хэрэгжүүлэхэд 40 гаруй хуулийн фирм, мэргэжлийн холбоод, их дээд сургуулиудтай хамтран ажилладаг.

Эдийн засгийн мэдлэг олгох хичээлийн хүрээнд хүүхдэд өр зээл, ажилгүйдэл, барьцаа цаашлаад санхүүгийн хямрал зэрэг сэдвээр хичээл ордог.

Мөн улс төрийн талаарх ерөнхий мэдлэг, нийгэм дэх хувь хүний оролцоо, төрийн бодлого зэрэг агуулга бүхий хичээл заах гарын авлага, сургалтын материалыг бэлтгэн гаргадаг.

Шүүхийн мэтгэлцээн өрнүүлэх уралдаан тэмцээн нь ихээхэн үр өгөөжтэйд тооцогддог ба 10-13 насны улсын сургуульд суралцдаг хүүхдүүдийн дунд Эрүүгийн эрх зүйгээр шүүхийн мэтгэлцээн өрнүүлэх уралдаан явуулдаг. Мөн 8-9 насны хүүхдүүдийг шүүх дагуулан авч явж эрүүгийн эрх зүйн тогтолцоотой танилцуулах ажлыг өрнүүлдэг.

Мөн тэд хүүхдүүдэд зориулсан хууль эрх зүйн мэдлэг олгох гар утасны апликэйшиныг хуульчид, хүүхдүүд, сурган хүмүүжүүлэгч нартай хамтран хөгжүүлсэн. Энэхүү апликэйшин нь хууль эрх зүйн тогтолцооны талаарх ерөнхий ойлголтыг хүүхдэд олгох мөн тодорхой эрх зүйн асуудлаар хүүхдэд мэдлэг олгох зорилготой. Мөн тэд Залуучуудын үнэмлэх гэдэг нэртэй олон төрлийн эрх зүйн асуудал агуулсан номыг хүүхэд залуучуудад зориулан хямд зардаг. Уг номонд ажил, мөнгө, цагдаа, төр, сонгууль, хүний эрх зэрэг нийтлэг сэдэв агуулагддаг төдийгүй баривчлагдсан үед яах вэ, оюутанд олгодог санхүүгийн дэмжлэг зэрэг чухал асуултын хариултыг хүүхэд залуучууд уг номоос олох боломжтой юм.

Энэ байгууллага нь Оман, Этиоп, ОХУ зэрэг улсын багш нарт хүүхдэд эрх зүйн боловсрол олгох арга зүйн дэмжлэг үзүүлэн тэднийг сургах ажлыг өрнүүлдэг.

[88] Эх сурвалж: http://www.lawforlife.org.uk/evaluation/

Зөвлөх үйлчилгээний холбоо *(Advice Services Alliance)*

Энэхүү холбоо нь төрийн үйлчилгээг хэрхэн сайн түгээх талаар мөн хууль эрх зүйн асуудлаар төрийн болон ТББ-д зөвлөгөө өгөн ажилладаг томоохон байгууллага юм.

Ингээд дээр дурдсан ТББ-уудын оролцоотойгоор үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан ач холбогдолтой, томоохон эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлыг дор онцлон дурдъя. Үүнд:[89]

- Татварын хуульд өөрчлөлт орсонтой холбоотойгоор нийт татвар төлөгчдөд олон төрлийн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын Тухайлбал, телевиз, радиогийн нэвтрүүлэг, үндэсний сонин сэтгүүл, постер, тараах материал, компанит ажил, утасны мессеж, кофе цай сендвичний хайрцаг дээр реклам хэвлэх, тусгайлсан цахим сайт утас ажиллуулах зэрэг байдлаар бүхий л мэдээлэл, сурталчилгааны арга хэрэгсэл ашиглан нийт иргэдэд чиглэсэн эрх зүйн мэдээлэл, сурталчилгааны ажлыг өрнүүлжээ.

- Лондонгийн хуулийн коллежтэй Ламбедын засаг захиргаа хамтран Гудамжны хууль (street law) төслийг хэрэгжүүлжээ. Уг төслийн хүрээнд тус нутаг дэвсгэрийн иргэдийн санал болгосон сэдвийн хүрээнд оюутнууд мөн багш нар танилцуулга хийх, харилцан яриа өрнүүлэх арга барилаар ажилгүйдэл, халамж, маргаан шийдвэрлэх механизм зэрэг сэдвээр мэдээлэл өгсөн байна. Энэхүү хамтарсан хөтөлбөр нь нэг талаас оюутнуудад дадлагын ажил хийх боломжийг олгох нөгөө талаас иргэдэд мэдээлэл хүлээн авах боломжийг олгосон үр дүнтэй төсөл болсон гэж дүгнэгдсэн байна. Энэхүү арга барил нь АНУ-аас гаралтай бөгөөд олон улс оронд өргөнөөр хэрэгждэг.

- Karz Ki Baatein нэртэй өр зээлийн асуудлаарх телевизийн нэвтрүүлгийг үргэлжилсэн дугаар болгон гаргасан байна. Уг нэвтрүүлэг нь 1 дэх өдрийн орой шууд явагддаг ба долоо хоногийн турш 3 удаа давтан гардаг. Уг нэвтрүүлгээр тухайн эрх зүйн асуудлаар мэргэшсэн хуульч иргэдэд мэдээлэл өгөхөөс гадна эфирийн шууд утас ажиллуулан иргэдийн сонирхсон асуултад нь хариулдаг.

- Иргэний сан, Хуульчдын холбоо зэрэг байгууллага мөн шүүгчид хамтран жил бүр шүүх мэтгэлцээний тэмцээн хүүхдүүдийн дунд явуулдаг. Энэхүү хөтөлбөр нь 20 гаруй жилийн турш жил бүр 8000 гаруй хүүхэд, 90 гаруй шүүгч, 200 орчим өмгөөлөгчийг оролцуулан зохион байгуулагддаг.

Зөвлөх үйлчилгээний холбоо ТББ нь хамтран амьдрагчид, залуу хосуудад зориулан өв залгамжлал, байр, татвар, хүүхэд, гэр бүл салалт зэрэг сэдвээр компанит ажил өрнүүлэх, телевиз радиогийн нэвтрүүлэг явуулах ажлыг зохион байгуулсан байна. Үүний дараагаар эдгээр сэдвээр зурагт хуудас бүхий сэтгүүлийг бэлтгэн өөрийн сайтад байршуулсан нь хосуудад эдгээр хууль эрх зүйн асуудлыг эхлээд таниулах, ухуулах үүний дараагаар тэдэнд тодорхой мэдээллийг хүссэн цагтаа авч танилцах боломжоор хангах зорилготой байсан.

- Үндсэндээ иргэний эрх зүйн боловсрол олгох чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг ТББ-ууд иргэний эрх боловсролын чиглэлээр хийгдэж байгаа ажил нь хязгаарлагдмал хүрээнд, тодорхой системчлэлгүй, нэгдсэн бус байдлаар, богино хугацаанд санхүүжигдэн гүйцэтгэгдэж байна гэж дүгнэдэг. Улмаар энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ууд нэгдэн үндэсний стратеги батлах санал гаргасны дагуу 2006 онд Хууль зүйн яам эдгээр ТББ-ын төлөөллийн бүрэлдэхүүнтэй үндэсний хэмжээний стратеги, хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг байгуулсан.[90]

[89] Developing Capable Citizens: the Role of Public Legal Education, the Report of the PLEAS Task Force, 2007.

[90] Developing Capable Citizens: the Role of Public Legal Education, the Report of the PLEAS Task Force, 2007.

Улмаар Зөвлөх үйлчилгээний холбоо, Өдөр тутмын хууль зэрэг нэр бүхий ТББ-ууд хамтран иргэний эрх зүйн боловсрол олгох талаарх үндэсний стратеги шаардлагатай байгаа талаар зөвлөмж бичгийг, холбогдох зөвлөмжийн хамт гаргаж байсан. Зөвлөмжид төрийн болон төрийн бус мөн ТББ-уудын хоорондын хамтын ажиллагаа болон үйл ажиллагааны харилцан уялдааг сайжруулах, Хууль зүйн яамны дэргэд үндэсний хэмжээний зохицуулан холбох зөвлөл байгуулах, сайн туршлагыг бий болгох, брэнд төслийг хэрэгжүүлэх, санхүүжилтийн тогтвортой, үргэлжилсэн байдлыг хангах зэрэг асуудлуудыг дэвшүүлсэн. Гэвч өнөөг хүртэл энэ хүрээнд дорвитой ажил хийгдээгүй байна.

***ХАВСРАЛТ** VI*

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС[91]

/Иргэдэд эрх зүйн боловсрол олгоход чиглэсэн эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтыг түгээх туршлага/

1. Тухайн улсын талаарх ерөнхий мэдээлэл, үүний дотор эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлын арга барилд нөлөөлөх хүчин зүйл, онцлог

ОХУ нь шилжилтийн үеийн улс бөгөөд үүнтэй холбоотойгоор иргэдийн эрх зүйн ухамсар гүйцэд төлөвшөөгүй мөн иргэдийн эрх зүйн ерөнхий мэдлэг төдийлөн хангалттай төвшинд хүрээгүй учраас эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлыг шат дараатай, зохион байгуулах нь тус улсын тухайд цаг үеийн шаардлага хэмээн үздэг. Тийм ч учраас эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалттай холбоотой холбооны болон муж, хотын хэмжээнд батлагдсан олон тооны эрх зүйн баримт бичиг байдаг. Тухайлбал, Холбооны Ерөнхий Прокурорын эрх зүйн соён гэгээрлийн ажлыг зохион байгуулахтай холбоотой тушаал байна. Мөн эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлыг холбооны хэмжээнд өрнүүлэх арга зам, үндсэн чиглэлийг тусгасан ОХУ-ын Иргэдийн эрх зүйн ерөнхий мэдлэг, ухамсрыг дээшлүүлэх талаарх ОХУ-ын төрийн бодлогыг тус улсын ерөнхийлөгчийн зарлигаар 2012 онд баталсан байна.

Тус улс нь өргөн уудам нутаг дэвсгэртэй өөр өөрийн өвөрмөц онцлог бүхий холбооны субъектүүдтэй улс юм. Иймд тус улс нь холбооны төвшинд эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалттай холбоотой үндсэн чиглэл, хэрэгжүүлэх арга замыг тусгасан төрийн бодлогыг тодорхойлж харин төрийн бодлогыг өөрийн муж, хотын онцлог, шаардлагад тохируулан хэрэгжүүлэх бүрэн эрхийг холбооны субъектүүддээ олгосон.

Ингээд юуны түрүүнд Холбооны хэмжээний мэдээлэл, сурталчилгаа, сургалтыг явуулах арга замыг тусгасан баримт бичгийг дараагаар нь Москвагийн иргэдэд эрх зүйн боловсрол олгож буй туршлагыг авч үзье. Учир нь нэг талаас тус хотын засаг захиргааны зохион байгуулалт нь манай улсынхтай тодорхой хэмжээнд төстэй нөгөө талаас авч хэрэгжүүлж буй мэдээлэл, сурталчилгаа, сургалтын арга хэмжээний талаар тодорхой мэдээлэл олдсон учраас тус хотын туршлагыг судалсан болно.

2. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, эрх зүйн соён гэгээрэл, эрх зүйн ухамсар, соёл, иргэний эрх зүйн боловсролын талаарх бодлого, хөтөлбөр, санаачилга, хууль тогтоомж, төсөл

Холбооны Ерөнхий Прокурорын эрх зүйн соён гэгээрлийн ажлыг зохион байгуулахтай холбоотой тушаал

Холбооны Ерөнхий Прокурорын эрх зүйн соён гэгээрлийн ажлыг зохион байгуулахтай холбоотой тушаал (**Приказ Генеральной прокуратуры РФ «Об**

[91] ХЗҮХ-ийн Судалгааны төвийн ЭША Б.Ундрах судалгааны ажлын ОХУ-тай холбогдох хэсгийг бэлтгэв.

организации работы по взаимодействию с общественностью, разъяснению законодательства и правовому просвещению») 2008 онд батлагдсан байдаг.[92] Уг тушаалд эрх зүйн соён гэгээрлийн үйлст прокуроруудын оруулах хувь нэмэр, үүргийг тодорхойлжээ.

Иргэдийн эрх зүйн боловсролыг нэмэгдүүлэх хүрээнд прокурорт хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар лекц унших мөн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хууль тогтоомж, хяналтын талаар сурталчлах үүргийг хүлээлгэсэн. Холбооны, мужийн, хотын, дүүргийн төвшинд хууль тогтоомж, түүний хэрэгжилттэй холбоотой зохион байгуулагдаж буй онол-практикийн хуралд оролцох, бусад эрх зүйн мэдээлэл сурталчилгаа, сургалтын чиглэлээр ажилладаг байгууллагатай хамтран ажиллах, иргэний эрх үүрэг, хууль зөрчих тохиолдолд үүсэх хууль зүйн үр дагавар зэрэг сэдвээр төрөл бүрийн сургалтын болон боловсролын байгууллагатай хамтран ажиллах, хамтран сургалт зохион байгуулах, ***иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах,*** ахмадууд болон тэтгэвэрт гарсан прокуроруудыг эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажилд татан оролцуулах, хамтран ажилласан, зохион байгуулсан үйл ажиллагааг дүгнэх, эрх зүйн мэдээлэл, сурталчилгааны илүү үр дүнтэй арга замыг хэлэлцэх зэрэг олон үйл ажиллагааг хэрэгжүүлэх прокурорын үүргийг тусгажээ.

ОХУ-ын Ерөнхий ***прокурорын*** газрын дэргэдэх ***Академид эрх зүйн соён гэгээрүүлэх арга зүйн болон бусад сургалт, сурталчилгааны материалыг бэлтгэж гаргах үүргийг уг тушаалд тусгасныг онцлон дурдах нь зүйтэй юм.***

Улмаар уг тушаалаар эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалт явуулах прокурорын үүргийг тодорхойлсны сацуу эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтыг өрнүүлэхэд шаардлагатай арга зүйг боловсруулах болон иргэдэд түгээх материалыг бэлтгэх дэд бүтцийг бий болгосон.

Иргэдийн эрх зүйн ерөнхий мэдлэг, ухамсрыг дээшлүүлэх талаарх ОХУ-ын төрийн бодлого

ОХУ-ын Иргэдийн эрх зүйн ерөнхий мэдлэг, ухамсрыг дээшлүүлэх талаарх ОХУ-ын төрийн бодлогыг тус улсын ерөнхийлөгчийн зарилгаар 2012 онд (***Указ Президента*** N 606 “Основы государственной политики Российской Федерации в сфере развития правовой грамотности и правосознания граждан”) баталжээ. Энэ хүрээнд иргэдийн эрх зүйн ерөнхий мэдлэг, ухамсар дээшлүүлэх төрийн бодлогын зарчим, зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл болон агуулгыг тодорхойлсон.

Төрийн бодлого дараах үндсэн чиглэлийн хүрээнд хэрэгжихээр. Үүнд:[93]

- Эрх зүйн соён гэгээрлийн болон мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлыг иргэдэд зориулан өрнүүлэх;
- Сургуульд эрх зүйн ерөнхий мэдлэг олгох хичээл, арга зүйн материалаар дамжуулан хүүхэд болон өсвөр үеийнхний эрх зүйн боловсрол, хүмүүжлийг дээшлүүлэх;
- Хууль тогтоомжийн хийдэл, зөрчлийг арилгах, сайжруулах;
- Эрх зүйн мэдээллийг үр дүнтэй түгээх;
- Эрх зүйч бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох;

---

[92] Приказ Генеральной прокуратуры РФ от 10 сентября 2008 г. № 182 «Об организации работы по взаимодействию с общественностью, разъяснению законодательства и правовому просвещению»

[93] ***Указ Президента Российской Федерации*** от 7 мая 2012 года N 606 «Основы государственной политики Российской Федерации в сфере развития правовой грамотности и правосознания граждан»

- Соёлын арга хэмжээ, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, реклам болон бусад видео материалыг иргэдийн эрх зүйн ерөнхий мэдлэг, боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн хэлбэрээр өөрчлөн сайжруулж зохион байгуулах, ашиглах;
- Төрийн бүх шатны байгууллага, ялангуяа хуулийн хэрэгжилтийг ханган ажилладаг хууль сахиулах байгууллагын ажилчдад иргэдийн эрхийг ханган ажиллах ухамсар, соёл төлөвшүүлэх;
- Эрх зүйн мэргэжлийн зөвлөгөө, ялангуяа иргэдэд эрх зүйн үр дүнтэй, үнэгүй зөвлөгөө өгөх тогтолцоог бий болгох, сайжруулах хамаарна.

Эдгээр үндсэн чиглэлийн хүрээнд авах үндсэн арга хэмжээг мөн тодорхойлсон байна. Үүнд:

1. Хууль тогтоомжийг сайжруулах, хуулийн мэдээлэлтэй танилцах сан бий болгох[94], хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх, холбогдох төрийн ажилтныг чадавхжуулах;
2. Хүүхдэд чиглэсэн арга хэмжээний тухайд сургуулийн өмнөх боловсролоос эхлээд дунд сургууль, их сургуульд эрх зүйн мэдлэг олгох өргөн хүрээний зорилго бүхий үйл ажиллагааг өрнүүлэх;
3. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан дараах үндсэн арга хэмжээг авч ажиллах;

Тухайлбал:

- Цахим болон хэвлэмэл, кабелийн болон бусад телевиз зэрэг бүхий л хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан иргэдийн эрх зүйн ерөнхий мэдлэг, ухамсрыг дээшлүүлэх, хууль дээдэлдэг, хууль хэрэгжүүлдэг иргэн болоход чиглэсэн эрх зүйн мэдээллийг түгээх;
- Энгийн иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар иргэдийн эрх зүйн ухамсар хандлагыг дээшлүүлэх эрх зүйн суурь мэдлэг, олгох мэдээллийг уран сайхны болон бусад төсөл хөтөлбөр хэлбэрээр хэрэгжүүлэх, ийм төрлийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх төрийн тогтолцоог бий болгох, идэвхжүүлэх;
- Хууль дээдлэх соёл, нийгмийн ёс суртахууны эсрэг мэдээлэл олон нийтэд сурталчилсан тохиолдлыг нээлттэй шүүмжлэх, шүүмжлэлт үнэлэмж өгөх механизмыг бий болгох;
- Хууль, эрх зүйн шаардлагатай номоор нийтийн номын сангуудыг хангах, санхүүжилтийг гаргах хамаарна.

4. Эрх зүйн ерөнхий мэдлэг, ухамсар олгох зорилго бүхий иргэний нийгмийн байгууллагыг төрөөс санхүүгийн, эд материалын болон бусад хэлбэрээр дэмжин нягт хамтран ажиллах
5. Зохион байгуулалтын арга хэмжээний тухайд дараах үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх. Үүнд:

- Төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд хамааралтай төрийн бүх шатны байгууллага, иргэний нийгэм болон бусад байгууллагын үйл ажиллагааг зохицуулан холбож ажиллах;
- Төрийн байгууллагын эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлын хүрээнд үзүүлэх үйлчилгээний хэлбэр, зорилгыг тодорхойлох, үйлчилгээнд чанарын стандарт болон хяналт, үнэлгээний механизм тогтоох;

[94] ОХУ-д холбооны хэмжээнд эрх зүйн мэдээллийн нэгдсэн цахим сан болох www.pravo.gov.ru ажилладаг ба энэ манай улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн цахим сан болох www.legalinfo.mn адил юм.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

- Төрийн бодлогыг хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг боловсруулах;
- Төрийн санхүүжилт болон бусад эх үүсвэрийг ашиглах зэрэг хамаарна.

3. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа түгээгч байгууллага, чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа

ОХУ-ын субъектүүд нь өөр өөрийн онцлогийг харгалзан тодорхой зохион байгуулалт болон төлөвлөгөөний дагуу энэхүү төрийн бодлогыг хэрэгжүүлж байгаа бөгөөд уг судалгаанд ОХУ-ын Москва хотын туршлагыг авч үзье.

Москва хотод 2005 оноос эхлэн эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажил өрнөж эхэлсэн. Иргэдэд эрх зүйн соёл төлөвшүүлэхэд чиглэсэн нийт иргэдийг мөн бүхий л насны бүлгийг хамарсан хөтөлбөр 2005 онд батлагдаж байсан.[95]

Москва хотын захирагчийн тушаалаар Москва хотын захирагчийн дэргэдэх иргэдийн эрх зүйн ухамсрыг дээшлүүлэх үйл ажиллагааг зохицуулан холбох зөвлөлийг боловсрол, эрүүл мэнд, соёл, хэвлэл мэдээлэл хариуцсан яам зэрэг яамдаас мөн засаг захиргааны удирдлагын болон нэр бүхий төрийн бус байгууллагын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй 2009 онд бий болгон, зөвлөлийн үйл ажиллагааны журмыг баталсан байна.[96]

Энэхүү зөвлөл нь иргэдийн эрх зүйн ухамсрыг хөгжүүлэхтэй холбоотой төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, холбогдох байгууллагын үйл ажиллагааг уялдуулах, жил бүр зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, мэдээлэл, сурталчилгаа, сургалтын талаарх сайн туршлага түгээх, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, эрх зүйн соён гэгээрлийн холбогдолтой баримт бичиг захирагчид санал болгон түүгээр батлуулах, зохион байгуулагдсан ажлын үр дүнгийн талаар захирагчид тайлагнах үүргийг хүлээдэг.

Ингээд эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлын хүрээнд хотын төрийн байгууллага тус бүрийн “Иргэдэд эрх зүйн соёл төлөвшүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний” дагуу болон өөрсдийн төлөвлөснөөр хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар дэлгэрэнгүй авч үзье.

Хүний эрхийн комисс (*Уполномоченный по правам человека в Московской области)*

Хотын Хүний эрхийн комисс нь эрх зүйн соён гэгээрлийн үйл ажиллагааг идэвхтэй өрнүүлдэг. Тухайлбал: иргэдтэй харилцах, иргэдийг хүлээн авах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл түгээх, интернет сайт ажиллуулах, онол практикийн ач холбогдол бүхий материалыг хэвлэн нийтлэх, жил бүр хүний эрхийн төлөв байдлын талаар тайлан гаргах мөн нийгэмд тулгамдаж буй асуудлыг тодорхойлон илтгэл, тайлан бичих зэргээр эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлыг өрнүүлж байна.

Комисс нь Хуульчдын холбоо болон Нотариатчдын танхимтай мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлын хүрээнд хамтран ажиллах гэрээ байгуулсан. Мөн эрх зүйч бэлтгэдэг хуулийн сургуулиудтай эрх зүйн үнэ төлбөргүй анхан шатны зөвлөгөө иргэдэд өгөх талаар хамтран ажилладаг.

Төрийн бодлогын нэгэн чиглэл болох төрийн албан хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх чиглэлийн хүрээнд Комисс нь төрийн албан хаагчдын эрх зүйн ухамсар, мэдлэгийг сайжруулах үүднээс Москва хотын шинжлэх ухааны “Нахабино” төвд

[95] Распоряжение полномочного представителя Президента Российской Федерации в Центральном федеральном округе от 11 апреля 2005 года” Целевая программа повышения правовой культуры населения”.

[96] Проблемы и перспективы правового просвещения жителей Московской области по вопросам прав и свобод человека и гражданина, форм и методов их защиты, Уполномоченный по правам человека в Московской области, Москва, 2011.

эрх зүйн боловсролын хичээл ордог мөн бусад соён гэгээрүүлэх ажлыг өрнүүлдэг.[97] Тухайлбал: хүүний эрх, хүүхдийн эрх, хотын хүний эрхийг хангах тогтолцоо, хотын шат шатны засаг захиргааны албан хаагчдын мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой хууль зэрэг сэдвээр сургалт, соён гэгээрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Энэхүү үйл ажиллагаа нь төрийн албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх замаар тэднийг хотын иргэдийн эрхийг ханган ажиллах чадвартай болгох зорилготой.

Эрхээ хязгаарлуулж байгаа этгээд Тухайлбал, урьдчилан хорих, шорон, мөрдөн байцаалтад байгаа хүмүүсийг эрх зүйн мэдээллээр хангах, тэдний эрх үүргийг таниулах, хангах асуудлыг дээшлүүлэх ажлыг Комисс нь хотын шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран холбогдох ТББ-ыг оролцуулан /УФСИН/ зохион байгуулдаг.[98]

Хүний эрхийн комисс нь энэ асуудалтай холбоотойгоор “Эрх хязгаарлах эрх бүхий байгууллага дахь хүний эрх” («Права человека в местах принудительного содержания»), “Эрх хязгаарлах эрх бүхий байгууллагаас суллагдсан хүмүүст зориулсан гарын авлага” («Памятка освобождающемуся из мест лишения свободы»), “Эрх хязгаарлах эрх бүхий байгууллагаас гарсан хүмүүсийн нийгэмших асуудал” («Проблемы социальной адаптации (ресоциализации) лиц, освобожденных из мест лишения свободы») гэсэн сэдэвтэй брошюр, гарын авлага гарган хорих анги, урьдчилан хорих газраар тараадаг.[99]

Хүний эрхийн комисс хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрх зүйн мэдээлэл түгээх, эрх зүйн соён гэгээрлийн үйл ажиллагааг өрнүүлэх ажлыг чухалчлан хэрэгжүүлэх үүднээс хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажилладаг.[100] Тухайлбал: Хотын сонин болох “Москвагийн өдөр тутмын мэдээ” (Ежедневные новости. Подмосковье»), “Москвагийн тэтгэврийнхэн” зэрэг сонинд эрх зүйн зөвлөгөөний булан гардаг ба үүнийг Хүний эрхийн комисс сонины редакцтай хамтран эрхэлдэг. Хотын телевиз радиогийн нэвтрүүлгээр эрх зүйн мэдээлэл түгээх хэд хэдэн хөтөлбөр хэрэгждэг ба үүнийг бэлдэхэд мөн хамтран ажилладаг.

Москвагийн Дум (Московская областная Дума)

Москвагийн Дум нь эрх зүйн мэдээлэл түгээх, соён гэгээрүүлэх ажилд хотын иргэдийг эрх зүйн ерөнхий болон хууль тогтоомжтой холбоотой мэдээллээр хангах замаар өөрийн хувь нэмрийг оруулан ажилладаг.[101]

Энэ хүрээнд иргэдийг тэдэнд хандаж мэдээлэл авах боломжоор хангах, хууль тогтоомжид заасан хугацаанд иргэдийн хүсэлтэд хариу өгөх, тэдэнтэй уулзах, мэдээллээр хангах ажлыг Дум гүйцэтгэдэг. Жилд 1500 орчим иргэн ханддаг бөгөөд дийлэнх тохиолдолд орон сууц, тэтгэвэр тэтгэмж, халамж зэрэг сэдвээр мэдээлэл авах хүсэлтэй байдаг. Зөвхөн эрх зүйн мэдээлэл авахыг хүсэхээс гадна хотын иргэд тодорхой хууль тогтоомжийн зохицуулалттай холбоотой санал, хүсэлт илэрхийлэх, тайлбар авах зэрэг ажил мөн өрнөдөг.

Энэ аргаар хотын Дум нь хууль тогтоомж, дүрэм журам, шийдвэрийн талаар иргэдийн санал хүсэлтийг авдаг төдийгүй иргэдэд эрх зүйн зөвлөгөөг бодитоор үзүүлдэг. Дум нь өөрийн эрх хэмжээний хүрээнд батлан гаргасан хууль тогтоомжийг

[97] Проблемы и перспективы правового просвещения жителей Московской области по вопросам прав и свобод человека и гражданина, форм и методов их защиты, Уполномоченный по правам человека в Московской области, Москва, страница 9, 2011.

[98] Мөн тэнд, хуудас 10.

[99] Мөн тэнд.

[100] Мөн тэнд, хуудас 11.

[101] Мөн тэнд, хуудас 16.

мөн холбогдох хууль, журмын төслийг өөрийн цахим хуудсанд байршуулдаг.[102]

Боловсролын яам (**Министерства образования Московской области**)

Боловсролын яам нь дараах эрх зүйн баримт бичгийн дагуу эрх зүйн соёл төлөвшүүлэх, эрх зүйн соён гэгээрлийн үйл ажиллагааг өрнүүлсэн.[103]

- 2005 оны иргэдэд эрх зүйн соёл төлөвшүүлэх зорилтот хөтөлбөр[104]
- 2011 оны Москвагийн иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө[105]
- Иргэдийн эрх зүйн ерөнхий мэдлэг, ухамсрыг дээшлүүлэх талаарх ОХУ-ын төрийн бодлого[106]
- 2004 оны Холбооны Боловсрол, шинжлэх ухааны яамны батлсан Холбооны ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөр хамаарна.[107]

Эрх зүйн соёлыг дээшлүүлэх ажил нь чухал ач холбогдол бүхий ажил учраас тус яамнаас шат дараатай, тодорхой зорилго бүхий ажлыг боловсролын байгууллагуудад зохион байгуулдаг. Түүнчлэн яам нь эрх зүйн соён гэгээрлийн үйл ажиллагаа хамтран өрнүүлэх талаарх гэрээг Хүний эрхийн комисс, Хууль зүйн яам зэрэг холбогдох газартай байгуулан тодорхой арга хэмжээг хамтран зохион байгуулдаг.

Ерөнхий боловсролын сургууль

Ерөнхий боловсролын сургуульд Эрх зүйн боловсролын хичээлийг үндсэн хичээлийн хөтөлбөрт багтаан /за счет учебных часов/ мөн хичээлээс гадуурх үйл ажиллагаанд /часов внеклассной работы/ хамруулан оруулдаг. Үндсэн хичээлийн хөтөлбөрт ордог хичээл нь Холбооны Боловсрол, шинжлэх ухааны яамны батлсан Холбооны ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрийн хүрээнд “Иргэний эрх, үүрэг”, “Эрх зүй”, “Улс төр ба эрх зүй”, “Өдөр тутмын эрх зүйн мэдлэг”, “Хууль, эрх зүйн суурь мэдлэг” зэрэг хичээлийг ордог.[108]

Харин долоо хоногт 1 цагийн эрх зүйн бие даасан хичээлийг 7-11 ангийн сурагчдад ордог. Үүнээс гадна москвагийн ерөнхий боловсролын сургуульд “гэрээ хийж сурцгаая”, “Хүний эрх”, “Хүүхдийн эрх”, “Эрх зүйн суурь мэдлэг” зэрэг тусгай эрх зүйн хичээл заадаг.

Хүүхдийг ирээдүйн эрх үүргээ ухамсарласан хариуцлагатай иргэн болгох үүднээс “Хүн хүнээ хүндэтгэх, саад болохгүй байх”, “Сургууль болон хичээл дээр биеэ зөв авч явах нь”, “Хүмүүстэй харилцах соёл” зэрэг олон хичээл, хөтөлбөр, чөлөөт ярилцлага зэрэг арга хэмжээ хэрэгждэг.

Эрх зүйн соёлыг хүүхдэд төлөвшүүлэх үүднээс эрх зүйн боловсрол олгох асуудлыг цогц байдлаар хэрэгжүүлэхийг зорьдог. Цогц байдлаар хэрэгжүүлэх

---

[102] http://www.mosoblduma.ru/Zakoni/Zakoni_Moskovskoj_oblasti

[103] Мөн тэнд, хуудас 19.

[104] Целевая программа повышения правовой культуры населения (правового всеобуча) в Центральном федеральном округе (утверждена распоряжением полномочного Представителя Президента Российской Федерации в Центральном федеральном округе от 11 апреля 2005 года № 104); план мероприятий по повышению правовой культуры населения Московской области на 2011 год (утвержден постановлением Губернатора Московской области от 29 декабря 2010 года № 1222/61)

[105] План мероприятий по повышению правовой культуры населения Московской области на 2011 год (утвержден постановлением Губернатора Московской области от 29 декабря 2010 года № 1222/61)

[106] Основы государственной политики Российской Федерации в сфере развития правовой грамотности и правосознания граждан;

[107] Базисный учебный план общеобразовательных учреждений Российской Федерации, утвержденный приказом Министерства образования и науки РФ от 9 марта 2004 года № 1312.

[108] Проблемы и перспективы правового просвещения жителей Московской области по вопросам прав и свобод человека и гражданина, форм и методов их защиты, **Уполномоченный по правам человека в Московской области, Москва, страница 20, 2011.**

гэдэгт зөвхөн хичээл заахаас гадна, семинар, дугуй ширээний ярилцлага зохион байгуулах, бага хурал, марафон, асуулт хариултын уралдаан, жүжигт тоглолт, зургийн уралдаан, тэтгэвэрт гарсан хууль эрх зүйн мэргэжилтнүүдээр хүүхдийн эрх, үүргийн талаар хичээл заах зэрэг олон арга хэмжээг зохион байгуулахыг ойлгодог.

Сургуулийн захиргаанаас холбогдох журмыг баталсны үндсэн дээр сургуулийн ахлах ангийн сурагчдын зөвлөл, оюутны холбоо, сургуулийн захиргаа хамтран ерөнхий боловсролын сургуулиуд, мэргэжлийн их дээд сургуулиуд дээр хууль эрх зүйн мэдээлэл бүхий буланг хөтлөн явуулдаг.[109] Жишээ нь сургуулийн эрх зүйн буланд ОХУ-ын төрийн байгуулал, төрийн байгууллагуудын жагсаалт, чиг үүрэг, үйл ажиллагаа, Хүний эрхийн комиссын талаарх мэдээлэл зэрэг мэдээллийг тусгасан байдаг.

Үндсэндээ практикт ерөнхий боловсролын сургуульд эрх зүйн соёл төлөвшүүлэх, боловсрол олгох арга хэмжээ зохион байгуулагддаг. Тухайлбал: “Хүний эрхийн өдөр”, “Урагшаа нэг алх”, “Би ОХУ-ын иргэн”, зэрэг сурагчдын дунд хотын хэмжээний хурал, хүүхдийн зургийн тэмцээн (Тодорхой эрх зүйн нэг сэдэвтэй холбоотойгоор зохион байгуулагддаг. Жишээ нь: мансууруулах бодисын эсрэг, хүчирхийллийн эсрэг), мэтгэлцээн уралдаан, мэргэжлийн хүмүүсээр “Хүүхдийн эрх, үүрэг”, “Хууль зөрчих болон зөрчилд хариуцлага хүлээх”, “Эрүүл зөв амьдрах ухаан” (донтох өвчтөнтэй ажилладаг эмчээр хичээл заалгадаг), “Сэтгэцэд нөлөөт бодисоос урьдчилан сэргийлэх нь”, (хууль сахиулах болон дотоод хэргийн яамны мэргэжилтнээр), “Гэмт хэргийн болон гэм бурууг тогтоох талаарх хичээл” зэрэг арга хэмжээ хамаарна.

Эрх зүйн чиглэлээр улсын хэмжээний олимпиадыг 9-11 дүгээр ангийн хүүхдийн дунд зохион байгуулдаг болсон ба оролцогч хүүхдийн тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байна.[110]

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, коллежийн оюутнуудад 50 багц цагийн “эрх зүйн удиртгал” хичээлийг ордог.[111] Коллежид “эрх зүйн соёл”, “эрх зүй” хичээлийг сонгон суралцах боломжтой.

Яамнаас мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн эрх зүйн соён гэгээрлийн үйл ажиллагаанд байнга хяналт, шалгалт явуулдаг ба үүнтэй холбоотойгоор олон тооны арга зүйн зөвлөмж, зааврыг коллежийн захиргаанд өгдөг. Тухайлбал, яамнаас эрх зүйн соёлыг төлөвшүүлэх цогц арга хэмжээ авах заавар, зөвлөмжийг өгдөг ба үүнд семинар, дугуй ширээний ярилцлага, хурал зэргийг тогтмол оруулах, дотоод хэргийн байгууллагын мэргэжилтнээр лекц уншуулах зэрэг хамаарна.

Эрх зүйн мэргэжлийн боловсрол олгох хүрээнд

Эрх зүйн мэргэжлийн боловсрол олгодог их дээд сургуулийн хичээлийн хөтөлбөрт эрх зүйч болох оюутнуудыг цаашид эрх зүйн соён гэгээрлийн үйл ажиллагаа өрнүүлэх, оролцох, хэрэгжүүлэх мэдлэг, чадвар олгох хичээлийг заадаг.[112] Хуулийн сургуулийн багшийн заавар зөвлөгөөний дагуу төгсөх курсын оюутнууд иргэдэд эрх зүйн мэдээлэл, зөвлөгөө өгөх ажлыг явуулдаг.

Москвагийн нийгмийн ухааны их сургуульд түшиглэн эрх зүйн боловсрол олгох асуудал, багшийн мэргэжил чадварыг сайжруулахтай холбоотой шат дараатай уулзалт, хурлыг багш нар зохион байгуулдаг.

[109] Мөн тэнд, хуудас 21.

[110] Мөн тэнд, хуудас 21.

[111] Мөн тэнд, хуудас 22.

[112] Мөн тэнд, хуудас 23.

Их дээд сургуулийн багшийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг Москвагийн дипломын дараах боловсролын академи болон Холбооны Багшийн мэргэжил дээшлүүлэх академи дээр тулгуурлан системтэйгээр олгодог.

Москвагийн захирагчийн олон нийттэй харилцах алба (***Общественная приемная Губернатора Московской области***)

Москвагийн засаг захиргааны байгуулалтыг хариуцан ажилладаг яам нь (Министерство по делам территориальных образований Московской области) захирагчийн олон нийттэй харилцах албаны ажлын албыг гүйцэтгэдэг. Энэ хүрээнд иргэдийг шат шатны засаг захиргаатай харилцах боломжийг бий болгох зорилготой. Москвагийн харьяаны нийт 71 олон нийттэй харилцах хэлтэс дүүрэг, хороон дээр ажиллаж байна. Жилд ойролцоогоор 2000 гаруй хүн эдгээр олон нийттэй харилцах албанд хандан ямар нэгэн байдлаар хууль эрх зүйн асуудалтай холбоотой мэдээллийг авдаг. Олон нийттэй харилцах хэлтэст ирж буй хууль эрх зүйн асуудалд зөвлөгөө өгөхөд бусад мэргэжлийн холбоод, хуульчидтай хамтран ажилладаг. Олон нийттэй харилцах албанд бага орлоготой иргэдэд зориулсан мэргэжлийн үнэгүй эрх зүйн зөвлөгөө өгөх хөтөлбөр хэрэгждэг. Үүний зэрэгцээ олон нийттэй харилцах алба нь хуулийн сургуулийн төгсөх курсын оюутнуудтай өргөн хүрээнд хамтран ажилладаг.

Москвагийн нийгмийн хамгааллын яам (**Министерства социальной защиты населения Московской области***)*

Тус яам нь иргэдэд эрх зүйн соёл төлөвшүүлэх ажлын хүрээнд нэгдүгээрт өөрийн яам, харьяа агентлагийн ажилтан, албан хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх ажлыг тэдний дунд семинар зохион байгуулах, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах аргаар хэрэгжүүлдэг.

Хоёрдугаарт эрх зүйн соёлыг ирээдүй үеийнхэндээ эзэмшүүлэх нь чухал асуудал гэдэг байр суурийг дэмжин нийгмийн аливаа төрлийн үйлчилгээ, сувилгаа, асрамжид байгаа хүүхдүүдийн эрх зүйн ерөнхий мэдлэгийг дээшлүүлэх үүднээс “Үндсэн хууль дахь хүний эрх”, “Би ОХУ-ын иргэн”, “Үндсэн хуулийн өдөр”, “Эрхээ эдлэх нь”, “Өөрийгөө хамгаалах нь” зэрэг сэдвээр сургалт, зохион бичлэгийн уралдаан, тэмцээн зохион байгуулдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэр бүлд зориулсан “ОХУ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн хамгаалал”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нөхөн сэргээх асуудал”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэр бүлд үзүүлэх халамж үйлчилгээ” сэдэвт уулзалт, семинарыг 2010 онд 4538 гэр бүлийг хамруулан зохион байгуулсан.

Шат шатны яамны харьяа дүүрэг, хорооны нийгмийн хамгааллын ажилтан нь хууль зөрчих эрсдэлтэй хүүхдүүдийн эцэг эхэд зориулан эцэг эхийн үүргийн талаар, гэмт хэрэг болон зөрчил гаргасан насанд хүрээгүй хүүхдэд хүлээлгэх хариуцлагын талаар, нийгмийн халамж үйлчилгээний талаар хууль эрх зүйн мэдээлэл өгөх, иргэдтэй тодорхой сэдвээр харилцан ярилцах байдлаар тэдэнд эрх зүйн мэдлэг олгож байна. Үүний зэрэгцээ шат шатны яамны харьяа дүүрэг, хорооны нийгмийн хамгааллын хэлтэс нь иргэдийн хэрэгцээ шаардлагатай хууль эрх зүйн сэдвээр эрх зүйн буланг гарган ажиллуулдаг. Энэхүү буланд эрх зүйн зөвлөгөөг үнэгүй өгөх боломжтой байгууллага, тус байгууллагын газрын харилцах хаяг, хуулийн дагуу эрх зүйн үнэгүй туслалцаа авах эрх бүхий иргэдийн талаарх мэдээлэл болон тэд хэрхэн үнэгүй эрх зүйн зөвлөгөө авах боломжтой талаарх процессын асуудлыг тусгасан мэдээлэл агуулагдсан байдаг.

Нийгмийн хамгааллын яам нь нэгдсэн байдлаар иргэдэд хэрэгцээтэй хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл, халамж үйлчилгээ, хүүхдийг гэмт хэрэг, бусдад гэм хор учруулахаас урьдчилан сэргийлэх талаар болон бусад эрх зүйн

мэдээллээр гарын авлага, мэдээллийн хуудас, товхимол, брошюр зэргийг бэлтгэн шат шатны өөрийн харьяа байгууллагуудад түгээдэг.

Үүний зэрэгцээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан өөрийн харьяаны хууль эрх зүйн асуудлаар мэдээлэл түгээх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхтэй өрнүүлдэг. Тухайлбал: яамны үйл ажиллагаа, холбоо бүхий эрх зүйн баримт бичиг, үйлчилгээ, ажиллуулдаг шуурхай утас зэргийн талаар өөрийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан мэдээлэл түгээдэг.

“Өдөр тутмын мэдээ” «Ежедневные новости»”, “Москва”, «Подмосковье» сонинд “Нийгмийн хамгаалал” сэдэвт хуудсыг сар болгон гаргадаг. Яамны өөрийн эрхлэн гаргадаг “Москвагийн нийгмийн хамгаалал” сониноор дамжуулан иргэдэд нийгмийн хамгааллын үйл ажиллагаа, арга хэмжээг танилцуулан, эрэлттэй асуугддаг асуудлаар эрх зүйн зөвлөгөө өгөх тусгай буланг ажиллуулдаг.

Өндөр настай иргэдийг компьютер ашиглаж эрх зүйн мэдээлэл авах боломжоор хангах үүднээс тодорхой давтамжтайгаар тэдэнд зориулсан хичээлийг шат шатны салбар хэлтэс дээр зохион байгуулдаг.

Москвагийн Төрийн хууль зүйн туслалцааны төв (**ФГУ «Государственное юридическое бюро по Московской области»**)

Зохих хууль журмын дагуу бага орлоготой иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх зорилгоор Төрийн хууль зүйн туслалцааны төв ажилладаг.[113] Тус төв хууль зүйн туслалцаа үзүүлэхээс гадна эрх зүйн ухамсар хандлага нэмэгдүүлэх ажлыг өрнүүлдэг.

Юуны түрүүнд тус төв өөрийн үйл ажиллагааг иргэдэд сурталчлах үүднээс өөрийн шат шатны харьяа хэлтэс дээр өөрсдийн үйл ажиллагааг таниулах, сурталчлах мэдээллийн булан ажиллуулдаг ба мөн зар сурталчилгаа, маркетингийн байгууллагатай хамтран байрны мэдээллийн самбарт өөрсдийн үйл ажиллагааны талаар мэдээлэл түгээх байдлаар хамтран ажилладаг.

Радио, телевизээр дамжуулан өөрсдийн үйл ажиллагааг сурталчлах ажлыг өрнүүлэхийн хамт нийтлэг, эрэлт хэрэгцээтэй асуудлаар хууль зүйн зөвлөгөө өгдөг. Ийнхүү тогтмол байдлаар харьяа бүхий төвүүд дээр мэдээллийн самбар ажиллуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрх зүйн мэдээлэл түгээх, мэдлэг олгох байдлаар эрх зүйн соён гэгээрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг төдийгүй Хууль зүйн яамны бэлтгэн гаргадаг эрх зүйн мэдээллийг өөрийн дэд бүтцээр дамжуулан түгээдэг. Энэхүү мэдээлэлд жишээ нь “Авлига, түүнтэй тэмцэх нь”, “Иргэн хэрхэн өөрийн эрхийг хөдөлмөрийн хууль тогтоомжийн дагуу хангах вэ”, “Газрын талаарх 100 асуулт” зэрэг товхимол, гарын авлага, брошюр зэрэг иргэний эрхээ хангах, үүргээ биелүүлэх арга замын талаарх мэдээллийг түгээдэг.

Түүнчлэн иргэд процессын шинжтэй асуудлыг ихээхэн асууж ирдэг учраас “Байраа хэрхэн зарах вэ”, “газар яаж өмчлөх вэ” зэрэг асуудлаар мэдээлэл бэлтгэн гаргадаг.

Хорих анги, урьдчилан хорих газар /Управления Федеральной службы исполнения наказаний России по Московской области/

Урьдчилан хорих ангид байгаа хүмүүст тэдний эрх үүргийн талаарх мэдээлэл, мөн гомдол, хүсэлт гаргах талаарх мэдээлэл өгдөг төдийгүй эдгээр мэдээллийг агуулсан буланг ажиллуулдаг. Урьдчилан хориход байгаа хүмүүсийн хүсэлтийн

[113] Федеральным законом от 29 декабря 2012 года № 273-ФЗ «Об образовании в Российской Федерации»; Федеральным законом от 21 ноября 2011 года № 324-ФЗ «О бесплатной юридической помощи в Российской Федерации»

дагуу тэдэнд эрүүгийн хууль, байцаан шийтгэх хууль, урьдчилан хорихтой холбоотой хууль тогтоомжийг уншуулахаар олгодог.

Ийнхүү эрх зүйн мэдээллээр хангах үйл ажиллагаа нь хорих ангиудад мөн хэрэгждэг ба хоёр сард нэгээс багагүй удаа хууль эрх зүйн асуудлаар мэдээлэл өгөх ажиллагаа хийгддэг. Ял эдэлж буй хүмүүсийн амаар болон бичгээр хүсэлт гаргасны дагуу эрх зүйн туслалцаа Тухайлбал, итгэмжлэл бичих зэрэг мэргэжлийн туслалцаа үзүүлдэг.[114]

Ял эдэлж буй хүмүүст хугацаанаас өмнө хэрхэн суллагдах асуудлаар өргөдөл бичих, өршөөл хүсэх өргөдөл бичих зэрэг тодорхой хүсэлтийг гаргахыг жишиг байдлаар үзүүлсэн хүсэлттэй хамт мэдээллийн буланд байршуулдаг. Урьдчилан хорих болон хорих ангид байгаа хүмүүсийг эрх зүйн мэдээллээр хангах, тэдний эрх зүйн ерөнхий мэдлэгийг дээшлүүлэх ажлыг зөвхөн хорих анги, урьдчилан хорих газар гүйцэтгэхээс гадна Хүний эрхийн комисс зэрэг бусад байгууллагуудтай хамтран, тэдний дэмжлэгтэйгээр хэрэгжүүлдэг. Энэ хүрээнд ганцаарчилсан болон нийтийг хамарсан ярилцлага, семинар болдог ба гагцхүү хорих анги дахь хүний эрхээс гадна чөлөөлөгдсөний дараагаар эргээд нийгэмшихэд тулгарах хууль эрх зүйн олон асуудлыг хамардаг.

Нотариатчдын танхим (**Нотариальная Палата на территории Московской области)**

Танхимын нэг үндсэн зорилгод иргэдэд нотариатын үйл ажиллагааны хүрээнд эрх зүйн ерөнхий мэдлэг олгох, эрх зүйн соёл төлөвшүүлэх ажил багтдаг. Энэ хүрээнд Хүний эрхийн комисс, Хуульчдын холбоотой хамтран ажилладаг. Өөрсдийн үйл ажиллагаатай холбоотойгоор телевиз, радиогийн нэвтрүүлэгт оролцох; хууль тогтоомж, тодорхой үйлдэлд хууль эрх зүйн тайлбар хийж сонин, сэтгүүлд мэдээлэл өгөх замаар соён гэгээрлийн үйл ажиллагаанд өөрсдийн хувь нэмрийг оруулдаг. Өмнө дурдсан “Өдөр тутмын мэдээ”, “Москва” зэрэг сонинд өв залгамжлалтай холбоотой, үл хөдлөх хөрөнгө бүртгүүлэхтэй холбоотой зэрэг мэдээллээр асуулт-хариултын хэлбэрээр мэдээлэл бэлтгэхэд туслалцаа үзүүлдэг.

Мэдээллийн технологийн дэвшилттэйгээр хэрэгжиж буй нэгэн шинэлэг арга нь өөрийн албан ёсны сайт болон бусад сайттай хамтран хууль эрх зүйн асуудлаар үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлдэг. Үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх ажиллагаа нь нэг талаас анхан шатны зөвлөгөө иргэнд өгөн туслах нөгөө талаас цаашид тухайн иргэний өмгөөлөгчөөр ажиллах буюу өмгөөлөгч нь үйлчлүүлэгч олж авах гэсэн арга замын дагуу явагддаг.

Дотоод хэргийн яам (*ГУ МВД России по Московской области)*

Тус яамны үндсэн чиг үүрэгт эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажил хамаардаг. Энэ хүрээнд хууль эрх зүйн системчилсэн жагсаалтыг хөтлөхөөс гадна эрх зүйн мэдээлэл хэвлэн түгээх, лекц, семинар, хурал зохион байгуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл өгөх, гарын авлага гаргах; мэдээллийн булан хөтлөх; албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх зэрэг өргөн хүрээний ажил хийгддэг.

Хуулийн дагуу цагдаагийн байгууллага нь өөрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах мөн үйл ажиллагааны талаар иргэдэд мэдээлэх үүргийг хүлээдэг.[115] Иймд цагдаагийн байгууллагаас хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэдэд өөрсдийн үйл ажиллагааны талаар тогтмол мэдээлж байдаг.

---

[114] Проблемы и перспективы правового просвещения жителей Московской области по вопросам прав и свобод человека и гражданина, форм и методов их защиты, **Уполномоченный по правам человека в Московской области, Москва, страница 37, 2011.**

[115] *В главе 2 Федерального закона от 07.02.2011 № 3-ФЗ «О полиции»1 сформулированы принципы деятельности полиции, одним из которых является открытость и публичность (статья 8).*

Яамны ажилтан, албан хаагчдын эрх зүйн мэдлэг, ажлын арга зүйг дээшлүүлэх хүрээнд дараах ажил зохион байгуулагддаг. Үүнд:

- Ажилчдад эрх зүйн мэдлэг олгох, мэдээллээр хангах, ухуулга сурталчилгаа хийх зэргээр тэднийг өөрсдийн үйл ажиллагаагаа хуулийн дагуу хэрэгжүүлэх нөхцөлийг хангах;

- Нийт ОХУ-ын Дотоод хэргийн яамны хэмжээнд хүний эрхийг ханган ажиллахтай холбоотой сайн туршлага, арга зүйн гарын авлага гаргах;

- Албан хаагчдад хууль эрх зүйн болон арга зүйн зөвлөгөө өгөх хамаарна.

Үүний зэрэгцээ Иргэдийн эрх зүйн ерөнхий мэдлэг, ухамсрыг дээшлүүлэх талаарх ОХУ-ын төрийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд иргэдэд дараах тодорхой эрх зүйн туслалцаа үзүүлдэг. Үүнд:

- Тус яамны харьяа бүхий албан хаагч, тэдний гэр бүл;

- Албан үүргээ гүйцэтгэж байгаад амь үрэгдсэн албан хаагчдын гэр бүл;

- Тус яаманд болон харьяа байгууллагад ажиллаж байгаад тэтгэвэрт гарагсад болон тэдний гэр бүл;

- Ахмад дайчид болон тэдний гэр бүлд эрх зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө үзүүлэх хамаарна.

Энэхүү үйлчилгээг хуулийн хэлтэс эсхүл яаманд хуульчаар ажиллаж байсан тэтгэвэрт гарсан албан хаагчид үзүүлдэг.

Тус яам нь иргэдийг хууль эрх зүйн мэдээллээр хангахад чиглэсэн дараах ажлыг гүйцэтгэдэг. Үүнд:

- Нийгмийн хэв журам, аюулгүй байдлыг хангах талаарх төрийн бодлого, түүний хэрэгжилтийн талаар иргэдэд цаг тухайд нь мэдээлэх;

- Тус яамны чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжид орсон өөрчлөлтийг цаг тухайд нь мэдэгдэх;

- Иргэдийн хууль дээдлэх соёлыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах мөн хэв журмыг сахиулахтай холбоотой иргэдийн үүрэг, хувь нэмрийг тэдэнд ойлгуулах;

- Яам, болон түүний харьяа байгууллагын албан хаагчдын ажлын ач холбогдлыг сурталчлах замаар тэдний мэргэжлийн нэр хүндийг өргөх зэрэг хамаарна.

Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалт, ухуулгын ажил нь яамнаас гаргасан олон тооны тушаалын дагуу хэрэгждэг.[116] Үүнээс 2007 онд гаргасан тушаалд тус яамны чиг үүргийн хүрээнд гүйцэтгэх “Эрх зүйн мэдээллийн болон ухуулга сурталчилгааны ажлын үндсэн чиглэлийг” тусгасан.[117] Үүнд:

- Хэвлэмэл бүтээгдэхүүн бэлдэн гаргах, тараах /хууль тогтоомжийн эмхтгэл, шүүх үйл ажиллагаа, яам болон харьяа байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээлэл зэрэг/;

---

[116] Приказ МВД России от 5 января 2007 г. № 5 «Об утверждении основных направлений совершенствования правового обеспечения организации и деятельности системы Министерства внутренних дел Российской Федерации на 2007 – 2017 годы», № 6 «Об утверждении Наставления по организации правовой работы в системе МВД России», которые направлены на разъяснение правовых норм и практики правоприменения в сфере внутренних дел и приказ МВД России от 1 января 2009 г. № 1 «Об утверждении Концепции совершенствования взаимодействия подразделений системы Министерства внутренних дел Российской Федерации со средствами массовой информации и общественными объединениями на 2009 – 2014 годы». Приказом МВД России от 5 января 2007 г. № 5 определены основные направления совершенствования правовой пропаганды.

[117] Приказом МВД России от 5 января 2007 г. № 5 определены основные направления совершенствования правовой пропаганды.

- Семинар, лекц, хурал зохион байгуулах;
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл тараах /олон нийтийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой мэдээлэл тараах ба ингэхдээ гэмт хэргийн мэдээллийн нууцлалыг хангах/;
- Хууль, эрх зүйн булан болон бусад мэдээлэл түгээх арга хэмжээ авах;
- Тодорхой сэдвийн дагуу ажилчдын мэргэжлийг дээшлүүлэх, мэдээллээр хангах;
- Мэдээллийн технологи ашиглан мэдээлэл түгээх хамаарна.

Хэвлэл мэдээллийн яам (*Министерства по делам печати и информации Московской области)*

Хотын төрийн радио, телевиз, сонин, сэтгүүл гэсэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн зорилгын нэгэн хэсэг нь иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх мэдээ, мэдээлэл түгээх юм.

Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлын хүрээнд зөвхөн хотын төдийгүй холбооны хэмжээний төрийн, хувийн хэвшлийн олон сонин сэтгүүл, радио телевиз, мэдээллийн агентлагтай төрийн байгууллагууд, холбоод хамтран ажилладаг.[118]

“Москвагийн өдөр тутмын мэдээ” («Ежедневные новости. Подмосковье») сонинд Хүний эрхийн комисс, Нотариатчдын холбоо зэрэг байгууллагын дэмжлэгтэйгээр тодорхой хуулийн зөвлөгөөг асуулт, хариулт хэлбэрээр сард 1-2 удаа бэлтгэн оруулдаг. Энэхүү эрх зүйн зөвлөгөө өгөх булан иргэдийн талархлыг ихээхэн хүлээж байгаа ба иргэд олон тооны асуулт тавьхаас гадна төрөл бүрийн сэдвээр зөвлөгөө авах хүсэлтээ илгээдэг аж.

Тус сонинд замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой буланг сард нэг удаа хотын замын хөдөлгөөний газрын мэргэжилтний бэлдэж өгсөн мэдээллийн дагуу мөн гаргадаг. “Москвагийн долоо хоног” («Неделя Подмосковье») сонины дугаар болгонд “Криминал”, “Нийгэм”, “Хуулийн дагуу”, “Нөхцөл байдал” зэрэг нэртэй иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн цуврал мэдээллийг мэргэжлийн хуульчдын бэлтгэж өгснөөр гаргадаг. Энэхүү мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст болон өндөр настанд онцгойлон зориулж хүргэдэг.

“Москвагийн зуслангийнхан” («Дачники Подмосковья») сонины “Эрх” буланд Москвагийн газрын харилцааны газрын мэргэжилтэн мэдээлэл бэлтгэж өгөн гаргадаг. “Москвагийн тэтгэврийнхэн” («Пенсионеры Подмосковья») сонины дугаар тутамд “Бидний эрх” нэртэй цуврал мэдээллийг Хүний эрхийн комисс, Нийгмийн хамгааллын яамны бэлтгэж өгснөөр гаргадаг. Тэтгэврийн иргэдэд зориулсан халамж үйлчилгээ, хөнгөлөлт, өндөр настан иргэдийг эм, эмчилгээний бүтээгдэхүүнээр хангах зэрэг асуудлаар мэргэжлийн хүмүүсээс мэдээлэл авснаар сониныг эрхлэн гаргадаг. “Комсомолийн үнэн” («Комсомольская правда»), “Хөдөлмөр” («Труд») зэрэг сонинд хууль эрх зүйн мэдээллийг зөвхөн хуульчдаас мэдээлэл авснаар

[118] Тухайлбал, дараах сонин, сэтгүүл, телевизийн хөтөлбөрийг эрхлэн гаргахад хамтран ажилладаг. Үүнд:
- Холбооны хэмжээний сонин болох «Комсомольская правда», «Московский комсомолец», «Российская газета», «Аргументы и факты», «Известия», «Медицинская газета», «Учительская газета», «Труд») хамаарна.
- Нэр хүнд бүхий хэвлэл мэдээллийн агентлаг «РИА-Новости»; «Интерфакс»
- «Московия» «Издательский дом»
- Хотын хэмжээний «Ежедневные новости. Подмосковье», «Неделя Подмосковье», «Дачники Подмосковья», «Пенсионеры Подмосковья» зэрэг
  - радио «РТВ-Подмосковье»;
  - телевиз «Подмосковье»;
  - Интернэт сайт хамаарна.

гаргах төдийгүй төрийн гүйцэтгэх чиг үүрэг бүхий байгууллагын мэргэжилтнүүдээс мэдээлэл аван гаргадаг.

Түүнчлэн нэр хүнд бүхий хэвлэл мэдээллийн агентлаг «РИА-Новости»; «Интерфакс» эрх зүйн мэдээлэл түгээх, мэдлэг олгох буланг тогтмол хөтлөн явуулдаг.

Эдгээр хэвлэмэл бүтээгдэхүүнээс гадна иргэдийн сонирхсон эрх зүйн асуултад хариулах зорилго бүхий онлайн конференцийг холбогдох яамд, агентлаг, комисс зэрэг байгууллагын мэргэжилтнүүдийг оролцуулан сар бүр зохион байгуулдаг. Конференцийн бичлэгийг мөн асуулт хариултыг бичмэл байдлаар өөрийн албан ёсны цахим хуудсанд байршуулдаг.

Үүний зэрэгцээ хотын захиргааны төв байгууллагууд эрх зүйн мэдээллийн “Хууль” («Закония») порталтай хамтран онлайн хэлбэрээр иргэдийг сард 3-4 удаа хүлээн авч, сонирхсон асуултад нь хариулдаг.

“Москва” («Подмосковье») телевиз эрх зүйн мэдлэг олгох, эрх зүйн соёлыг дээшлүүлэх хүрээнд телевизийн олон тусгай хөтөлбөрийг явуулдаг. Тухайлбал, 2011 оны 1-5 дугаар сарын хооронд “Москвагийн мэдээ” нэвтрүүлгээр эрх зүйн 50 гаруй телевизийн зохиомж гаргасан. «Итоги Подмосковья» нэвтрүүлгээр 2011 оны 1-5 дугаар сарын хооронд 20 гаруй хууль эрх зүйн мэдээлэл бүхий теле зохиомж гаргажээ.

“Итгэлийн индэр” («Область доверия») шууд нэвтрүүлэгт 2011 онд 20 гаруй зээл, санхүү, эрүүл мэндийн даатгал, гэр бүл салалт, газрын татвар, эрүүгийн эрх зүй зэрэг сэдвээр хууль, эрх зүйн ерөнхий мэдлэг олгох нэвтрүүлгийг тусгайлан бэлтгэн гаргасан. Эрх зүйн ерөнхий мэдлэг, боловсрол олгох радиогийн нэвтрүүлгийг өргөнөөр явуулдаг.[119]

Хууль эрх зүйн цаг үеийн шинжтэй мэдээлэл түгээх ажлыг Хэвлэл мэдээллийн яамны олон нийттэй харилцах хэлтэс, мэдээллийн хэлтэс нь Москвагийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай нягт хамтран гүйцэтгэдэг. Энэ нь иргэдэд хүний эрх, үүрэг, нэр хүнд, аюулгүй байдалтай холбоотой мэдээллийг үнэн зөв, зохих ёсны дагуу хүргэхийг зорьдоготой холбоотой.

4. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгааг хүлээн авах зорилтод бүлэг /өсвөр үе, ахмад настан, эмзэг бүлэг, орон нутгийн иргэд гэх мэт/-ийг тодорхойлсон байдал, авч хэрэгжүүлдэг арга хэмжээ

Москва хотын тухайд эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлыг нийт иргэдэд зориулан өрнүүлдэг. Ялангуяа, хүүхэд, өсвөр үе, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, гэмт хэрэг зөрчил үйлдэх магадлалтай хүүхэд, эрхээ хязгаарлуулж буй хорих анги, цагдан хориход байгаа хүмүүс, төрийн албан хаагчид, хууль сахиулах байгууллагын албан хаагчид зэрэг тодорхой зорилтот бүлэг хүмүүст зориулан эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлыг онцгойлон хүргэдэг. Энэ талаар дээрх хэсэгт дэлгэрэнгүй авч үзсэн болно.

5. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа түгээх арга зам, хэрэгжүүлэх процесс

Москва хотын захирагч нь жил бүр “Иргэдэд эрх зүйн соёл төлөвшүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө” баталдаг ба у**г төлөвлөгөөнд зохион байгуулах арга хэмжээг 4 бүлэг асуудлын хүрээнд ангилан, арга хэмжээ бүрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага болон хэрэгжүүлэх хугацааны хамт тодорхойлдог. Үүнд дараах 4 чиглэлээр арга хэмжээ авч ажилладаг. Үүнд**[120]

[119] «РТВ-Подмосковье» «Актуальный разговор», «В блокнот потребителя», «Имею право», «Точка зрения», «Народ и власть», «Депутатский канал», «Перезвон», «Субботняя панорама», «Информация из городов Подмосковья» зэрэг нэвтрүүлэг байдаг.

[120] План мероприятий по повышению правовой культуры населения Московской области на 2011 год (утв. постановлением Правительства Московской области от 29 декабря 2010 г. № 1222/61)

- **Зохион байгуулалтын**
- **Боловсролын**
- **Мэдээллийн**
- **Эрх зүйн туслалцааны үйл ажиллагаа хамаарна.**

Ингээд 2011 онд батлагдсан хотын захирагчийн "Иргэдэд эрх зүйн соёл төлөвшүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг" (**Постановление Правительства Московской области «О Плане мероприятий по повышению правовой культуры населения Московской области на 2011 год») авч үзье.**[121]

Зохион байгуулалтын үйл ажиллагаанаас дурдвал: засаг захиргааны нэгж дээр иргэдийг хүлээн авч, эрх зүйн мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах /Засаг захиргааны байгуулалтыг хариуцсан яам/, төрийн их сургууль болох Москвагийн төрийн нийгэм хүмүүнлэгийн институт дээр клиник төв нээх /Боловсролын яам/ зэрэг үйл ажиллагааг дурдаж болно.

Боловсролын арга хэмжээний хүрээнд төрийн албан хаагчдын эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлыг Москвагийн мэргэжил дээшлүүлэх байгууллагатай хамтран зохион байгуулах /захиргааны байгууллагууд/, эрүүл мэндийн салбарын ажилчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх ялангуяа эрх зүйн мэдээллийн нэгдсэн цахим сайт дээр ажиллаж хүссэн мэдээллээ олох мэдлэг олгох ажлыг зохион байгуулах /Эрүүл мэндийн яам/, нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэгчдэд нийтийн тээврийн үйлчилгээ болон замын аюулгүй байдлын талаарх хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх семинар, конференц, сургалт зохион байгуулах /Зам тээврийн яам/, Сэргээш хэрэглэх талаарх ухуулга сурталчилгааны ажил болон сургалт зохион байгуулах /Москвагийн урлаг, спорт, аялал жуулчлал болон залуучуудад зориулсан үйл ажиллагааг зохион байгуулах комисс/, багш, эцэг эх, сурагчдад мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаарх сургалт зохион байгуулах /Боловсролын яам/, гэрлэлтээ батлуулж байгаа хосууд, бүрэн дунд сургуулийн ахлах ангийн сурагчид, оюутнуудад гэр бүлийн эрх зүй болон гэр бүл төлөвлөлттэй холбоотой лекц, семинар оруулах /Москвагийн гэр бүлийн асуудал хариуцсан байгууллага/; Хүүхдийн зуслан, сувилал зэрэгт "Өсвөр үеийнхэн ба хууль" сэдвээр хичээл оруулах /Нийгмийн хамгааллын яам/, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэр бүлд зориулсан эрх зүйн мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах /Нийгмийн хамгааллын яам/, хөдөлмөрийн эрх зүй, татвар зэрэг асуудлаар жижиг дунд бизнес эрхлэгчдэд сургалт зохион байгуулах /Мэдлэг ТББ-тай гэрээлсний үндсэн дээр/ зэрэг арга хэмжээг боловсролын хүрээнд зохион байгуулах арга хэмжээний тухайд дурдаж болно.

Мэдээ, мэдээлэл түгээх арга хэмжээний хүрээнд телевиз, радиогийн нэвтрүүлэг бэлтгэх, эрх зүйн мэдээлэл хэвлэн тараах, эрх зүйн булан ажиллуулах зэрэг олон ажлыг тухайн чиглэлийн яам, засаг захиргаа нь хариуцан хийхээр төлөвлөдөг байна.

Хууль зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх арга хэмжээний хүрээнд "эрсдэлд өртөх" магадлалтай гэр бүлийн эцэг эх, хүүхдэд зориулан хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх /Нийгмийн хамгааллын яам/, хөдөлмөрийн хууль, хөдөлмөрийн маргаантай холбоотой хууль эрх зүйн зөвлөгөө өгөх /Москвагийн хөдөлмөр эрхлэлтийг хариуцсан комисс/ зэрэг үйл ажиллагаа хамаарна.

[121] Постановление Правительства Московской области от 29 декабря 2010 г. № 1222/61 «О Плане мероприятий по повышению правовой культуры населения Московской области на 2011 год»

ХАВСРАЛТ VII

Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын талаарх Монгол Улсын болон олон улсын эрх зүйн актуудын жагсаалт, холбогдох зүйл заалт

Д/д	ЭРХ ЗҮЙН АКТ	Хамаарах зүйл заалт
	ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ	
1.	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	19
2.	**Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт**	19.2
	ХУУЛЬ	
3.	Монгол Улсын Үндсэн хууль	16.17
4.	Захиргааны ерөнхий хууль	67.5
5.	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай	7.1.4, 7.1.5 бусад
6.	**Хууль тогтоомжийн тухай**	45.3
7.	**Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай**	бүхэлдээ
8.	**Олон нийтийн радио телевизийн тухай**	бүхэлдээ
9.	Монгол Улсын Засгийн газрын тухай	6, 20
10.	**Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай**	11, 28.1.1, 29.1.6
11.	Нийтийн сонсголын тухай	бүхэлдээ
12.	Байгууллагын нууцын тухай	6
13.	Боловсролын тухай	3.1.6, 3.1.7, бусад
14.	Бага дунд боловсролын тухай	5
15.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай	бүхэлдээ
16.	Зар сурталчилгааны тухай	бүхэлдээ
17.	Нийслэлийн эрх зүйн байдлын тухай	-
18.	Хуульчийн эрх зүйн байдлын тухай	45.1.11, 45.1.11.
	УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ	
19.	Монгол Улсад нийгмийн дэг журам хангах талаар төрөөс явуулах үйл ажиллагааны үндсэн чиглэл 1992 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн 29 дүгээр тогтоол	Хоёрт. Нийгмийн дэг журам бэхжүүлэх талаар.
20.	Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр 1998 оны 18 дугаар тогтоол	Зургаа.Эрх зүйн шинэтгэлийн орчин бүрдүүлэх
	ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ	
21.	Эрх зүйн сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлыг сайжруулах тухай 1993 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 57 дугаар тогтоол	бүхэлдээ
22.	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахтай холбогдсон зарим арга хэмжээний тухай 1996 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 66дугаар тогтоол	бүхэлдээ
23.	Журам батлах тухай 2010 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 119 дүгээр тогтоол (Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам)	бүхэлдээ
24.	“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр” 2012 оны 7 дугаар сарын 25-ны өдөр 252 дугаар тогтоол	бүхэлдээ

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРАЛЛЫН www.nli.gov.mn

25.	“Мэдээллийн цаг” сурталчилгаат ажлыг зохион байгуулах тухай 1996 оны 265 дугаар тогтоол	бүхэлдээ
26.	“Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам” 2013 оны 411 дүгээр тогтоолын хавсралт	бүхэлдээ
27.	“Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр” 2006 оны 263 дугаар тогтоол	бүхэлдээ
САЙДЫН ТУШААЛ		
28.	ХЗДХэргийн сайдын 2004 оны 45 дугаар тушаалаар батлагдсан Иргэдийн эрх зүйн мэдлэг, боловсрол эзэмшүүлэх, хууль тогтоомжийг хэрэглэх чадварыг иргэдэд төлөвшүүлэх тухай	Дундговь аймгийн хууль зүйн хэлтсийн үйл ажиллагаандаа мөрдөх эрх зүйн актын жагсаалтад
29.	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 67 дугаар тушаалаар “Эрх зүйн сурталчилгааны дунд хугацааны хөтөлбөр”, “Эрх зүйн сурталчилгааг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”, Хууль зүй, дотоод хэргийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2011 оны 124 дүгээр тушаалаар батлагдсан “Сум, дүүрэгт эрх зүйн хөтөч /ухуулагч/-ийн ажиллах журмын дагуу эрх зүйн хөтөч / ухуулагч/ нарын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, тэдэнд иргэдийн мэдвэл зохих хууль тогтоомжийн мэдлэг олгох, онол арга зүйн зөвлөгөө өгөх .	бүхэлдээ
АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ		
30.	”Эрх зүйн албан бус сургалтын хөтөлбөр” Говь-Алтай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2006 оны 11-р сарын 03-ний өдрийн 62-р тогтоолын хавсралт	бүхэлдээ
31.	“Дархан-Уул аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоол эрх зүйн сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах тухай” 2005 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Дугаар 79	бүхэлдээ

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР
www.nli.gov.mn

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль тогтоомж

1. The Legal Services Authorities Act, India, 1987.

2. Legal Education Support Act, South Korea, 2008.

3. Базисный учебный план общеобразовательных учреждений Российской Федерации, утвержденный приказом Министерства образования и науки РФ от 9 марта 2004 года № 1312.

4. План мероприятий по повышению правовой культуры населения Московской области на 2011 год (утв. постановлением Правительства Московской области от 29 декабря 2010 г. № 1222/61).

5. Постановление Правительства Московской области от 29 декабря 2010 г. № 1222/61 «О Плане мероприятий по повышению правовой культуры населения Московской области на 2011 год».

6. Приказ Генеральной прокуратуры РФ от 10 сентября 2008 г. № 182 «Об организации работы по взаимодействию с общественностью, разъяснению законодательства и правовому просвещению».

7. Приказ МВД России от 5 января 2007 г. № 5 «Об утверждении основных направлений совершенствования правового обеспечения организации и деятельности системы Министерства внутренних дел Российской Федерации на 2007 – 2017 годы», № 6 «Об утверждении Наставления по организации правовой работы в системе МВД России».

8. Приказ МВД России от 1 января 2009 г. № 1 «Об утверждении Концепции совершенствования взаимодействия подразделений системы Министерства внутренних дел Российской Федерации со средствами массовой информации и общественными объединениями на 2009 – 2014 годы».

9. Приказ МВД России от 5 января 2007 г. № 5 определены основные направления совершенствования правовой пропаганды.

10. Распоряжение полномочного представителя Президента Российской Федерации в Центральном федеральном округе от 11 апреля 2005 года “Целевая программа повышения правовой культуры населения”.

11. Указ Президента Российской Федерации от 7 мая 2012 года N 606 «Основы государственной политики Российской Федерации в сфере развития правовой грамотности и правосознания граждан».

12. Целевая программа повышения правовой культуры населения (правового всеобуча) в Центральном федеральном округе (утверждена распоряжением полномочного Представителя Президента Российской Федерации в Центральном федеральном округе от 11 апреля 2005 года № 104).

13. Федеральным законом от 29 декабря 2012 года № 273-ФЗ «Об образовании в Российской Федерации».

14. Федеральным законом от 21 ноября 2011 года № 324-ФЗ «О бесплатной юридической помощи в Российской Федерации».

15. ABA Standards, 3.6 on the Provision of Legal Information, American Bar Association.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Нийтлэл, өгүүллэг

1. Батбаярын Оюунцэцэг, Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг орон нутагт зохион байгуулах нь, Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн Хуульчдын сургалт ба давтан сургалт төсөл, 2005.
2. Better information Handbook, ASA Advicenow, 2009.
3. Christopher L. Hinson, Legal Informatics: Opportunities for Information Science, Journal of Education for Library and Information Science, 2005.
4. Cotula, Lorenzo, Legal Empowerment for Local Resource Control: Securing Local Resource Rights within Foreign Investment Projects in Africa, 2007.
5. Developing capable citizens, the role of public legal education, page 16, The report of the PLEAS Task Force, 2007.
6. Essay on Legal Awareness, https://en.wikipedia.org/wiki/Legal_awareness
7. Patricia Byrne, Public legal Education and Information Formats and Delivery Channels, 2014. Developing capable citizens, the role of public legal education, page 16, The report of the PLEAS Task Force, 2007.
8. Н.А. Гарашкин, Сущность и формы социально-правового просвещение населения, г. филиал Академии правосудия Воронеж, 2012.
9. Уполномоченный по правам человека в Московской области, Проблемы и перспективы правового просвещения жителей Московской области по вопросам прав и свобод человека и гражданина, форм и методов их защиты, 2011.
10. Pulikuthiyil, George, "Legal Literacy for Social Empowerment", 2014.
11. Rob Richards, What is Legal Information, 2009.
12. Susan Edwards and Antonia Fontana, Legal Information Needs of Older People, Law and Justice Foundation of NSW, 2004.
13. Земляченко Л.В., канд. пед. наук, доц. каф. педагогики дошкольного и начального образования, Условия эффективности правового просвещения младших школьников, ГОУ ВПО «Мордовский государственный педагогический институт им. М.Е.Евсевьева», г.Саранск, Республика Мордовия, 2013.

Цахим хуудас

1. Унгар улсын Засгийн газрын цахим хуудас: http://www.kormany.hu/
2. Унгарын Боловсрол судлал, хөгжлийн хүрээлэн: http://ofi.hu/
3. Будапештын III дүүргийн цахим хуудас: http://obuda.hu/
4. "Хуулийн цэг" төслийн цахим хуудас: http://jogpont.hu/
5. "Хуулийн цэг+" төслийн цахим хуудас: http://jogpontplusz.hu/
6. Унгарын Шинжлэх ухааны академийн Хууль зүйн шинжлэх ухааны хүрээлэнгийн цахим хуудас: http://jog.tk.mta.hu/
7. Хуулийн нэгдсэн цахим сан: http://net.jogtar.hu/
8. Вашмэдьэ мужийн цахим хуудас: http://www.vasmegye.hu/
9. Legal Informatics Blog: https://legalinformatics.wordpress.com
10. National Legal Services Authority of India: http://nalsa.gov.in/
11. http://www.advicenow.org.uk/advicenow-guides
12. http://www.lawforlife.org.uk/
13. http://www.citizenshipfoundation.org.uk/
14. http://www.epao.net
15. http://hslsa.nic.in/LL.htm

---o0o---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nlt.gov.mn

“ШҮҮХЭЭС ЭРҮҮГИЙН ХЭРГИЙГ НЭМЭЛТ ХЭРЭГ БҮРТГЭЛТ, МӨРДӨН БАЙЦААЛТ ХИЙЛГЭХЭЭР ПРОКУРОРТ БУЦААХ НЬ” СЭДЭВТ СУДАЛГАА[1]

1. Удиртгал

1.1. Судалгааны зорилго

Монгол Улсын Их Хурлын 2017 оны хаврын чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалт ёсоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг хэлэлцэж байна. Энэ ажлын хүрээнд одоо мөрдөж байгаа Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 225 дугаар зүйлийн 225.1.2 дахь хэсэг болон 230 дугаар зүйлд шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа хийж, хууль тогтоох эрх бүхий субьектын шинэ хуулийн төсөл хэлэлцэн батлах ажилд санал, дүгнэлтээ хүргүүлэхэд оршино.

1.2. Судалгааны арга

Шинжлэх ухааны судалгааны эмпирик түгээмэл арга болон судалгааны судлагдахууны онцлогийг илтгэн гаргах дараах тусгай арга болох.

- Түүхчлэх;
- Харьцуулах;
- Баримт бичиг боловсруулах;
- Социологийн судалгааны санал асуулгын аргыг хэрэглэсэн болно.

1.3. Судалгааны хамрах хүрээ

Судалгаа хийснээр юуны өмнө Монгол Улсад шүүхээс эрүүгийн хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцаахтай холбогдон зохицуулж байсан хуулиуд, одоогийн мөрдөж байгаа “Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль”, тус улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, холбогдох бусад хууль, хууль тогтоомжийн тайлбар, гадаад орнууд өөрийн хууль тогтоомждоо хэрхэн зохицуулж ирсэн байдал, эрдэмтэн судлаачдын өгүүлэл, зэрэг холбогдох эх сурвалжуудад тулгуурлан боловсруулаа.

1.4. Судалгааны бүтэц

Бидний судалгаа 5 үндсэн хэсэг, 12 зүйл, санал-дүгнэлт, хавсралт, ашигласан материал гэсэн бүтэцтэй.

Хоёр. Шүүхээс эрүүгийн хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцаах тухай эрх зүйн зохицуулалтууд, тэдгээрт хийх судалгаа

2.1. Монгол Улсад хэрэгжиж байсан хууль тогтоомжийн түүхэн уламжлал

Монгол Улс үндсэн хуульт төр, нийгмийг байгуулсан тэр цагаас эхлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан хуулиудад “шүүхээс эрүүгийн хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр буцаах”-тай холбогдсон зохицуулалт бүхий заалтуудыг түүхийн он цагийн дараалал ёсоор нягталбал:

1. 1926 онд батлагдсан “МОНГОЛ УЛСЫН ШҮҮН ТАСЛАХ ГАЗРААС АЛИВАА ХЭРГИЙГ БАЙЦААН ШИЙТГЭХ ТУХАЙ ХУУЛЬ”[2]-д “шүүхээс эрүүгийн хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр буцаах”-тай холбогдсон заалт тусгагдаагүй байна.

---

[1] Энэхүү судалгааг УИХ-ын гишүүн Х.Нямбаатарын захиалгаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор, профессор П.Зүмбэрэллхам удирдаж, эрдэм шинжилгээний ажилтан Н.Мичидмаа, Б.Алтангэрэл нар хамтран гүйцэтгэв.

[2] БНМАУ-ын Засгийн газрын албан сэтгүүл. №13, 1926 он.

2. 1929 онд батлагдсан “АЛИВАА ХЭРГИЙГ БАЙЦААН ШИЙТГЭХ ТУХАЙ ХУУЛЬ” (11 дүгээр бүлэг, 123-201 дүгээр зүйл)[3] эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг тусгасан хуульд мөн тухайлан заасан зүйл, заалт үгүй байна**.**

3. 1935 онд батлагдсан “АЛИВАА ХЭРГИЙГ ХЭРХЭН БАЙЦААХ БА ШИЙТГЭХ ТУХАЙ ХУУЛЬ” -ийн “8 дугаар бүлэг 48 дугаар зүйлд:

Шүүн таслах газруудаас аливаа хэргийг байцаах, шийтгэхийн наана гүйцэтгэх хэргийн тухай аливаа байцааж дууссан хэргүүдийг шүүн таслах газар хүлээн авмагц захирах, тушаах хурлыг байгуулан хянаж учир бүрдсэн бол таслан шийтгэх хуралд оруулахаар бэлтгэнэ.

Хэрэв учир бүрдээгүй зүйл байвал дутагдлыг тодорхойлон дахин нэмж байцаан бүрдүүлэхээр эргүүлэн шилжүүлбэл зохино” гэж заажээ.

Дээрх заалт нь эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлсний хойно шүүхээс хавтаст хэрэгтэй танилцаад таслан шийтгэх хурал товлон зарлахаас өмнө хэргийг шүүхийн өмнөх шатанд шилжүүлж, нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаахаар хуульчилсан байна.

4. 1949 онд батлагдсан “БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬ” -ийн Гуравдугаар анги “Анхан шатны шүүхүүдийн шүүх таслах ажиллагааны тухай” хэмээх арван наймдугаар бүлгийн “**260 дугаар зүйл:** Гэмт хэргийн өдүүлсэн тухай мэдээллийг хүлээн авмагц шүүгчээс доор заасан ажлыг дангаар эрхлэн явуулна. **260 дугаар зүйлийн 2** дахь хэсэг: Урьдчилан мөрдөн байцаалт гүйцэтгүүлэхээр прокуророор дамжуулан шийтгүүлнэ”.

“267 дугаар зүйл: Энэ хуулийн 266 дугаар зүйлд дурдсан асуудлуудыг хянан хэлэлцэхдээ бэлтгэл цуглаанаас гүйцэтгэж болох зүйлүүд нь”. “ **267 дугаар зүйлийн 267.2 дахь хэсэг: Хэргийг нөхөн мөрдүүлэхээр прокурорт эргүүлэн өгөх”.**

“336 дугаар зүйл: Шүүх цуглааны үед шүүхээс ялын анхны томьёоллыг өөрчилбөөс зохих шинэ зүйлийг илрүүлэн олсон бөгөөд энэхүү өөрчлөлт нь Эрүүгийн хуулийн илүү хүнд ял ногдох зүйлийг хэрэглэхэд хүрвээс шүүхээс хэргийг сонсох явдлыг түдгэлзэж, уг хэргийг нягтлан мөрдөх, улмаар шүүхэд шилжүүлэх хэргийг эхнээс нь аваад, нийтийн журмаар хянан гүйцэтгүүлэхээр явуулах тухай магадлалыг гаргана”. **384 дүгээр зүйл**: Хоёр дугаар шатны шүүх нь дор дурдсан эрхтэй болох. Үүнд:

“384.2. дугаар зүйл: Шийтгэх тогтоол буюу магадлалыг хүчингүй болгох ба уг хэргийг хянуулахаар анхан шатны шүүхэд явуулах буюу нөхөн мөрдүүлэхээр прокурорт буцаах” гэж тус тус хуульчилсан нь

Дээрх зүйл заалт нь шүүхээс эрүүгийн хэргийг нэмэлтээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа хийлгэхээр эргүүлэн буцаахдаа

1. Шүүхийн өмнөх шатанд **(260.2 болон 267.2 дугаар зүйл)**
2. Анхан шатны шүүхийн шатанд **(336 дугаар зүйл)**
3. Давж заалдах шатны шүүхийн шатанд **(384.2 дугаар зүйл)** гэсэн 3 нөхцөлд шүүхээс эрүүгийн хэргийг нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцааж байсан байна.

Харин хяналтын шатны шүүхээс нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаах тухай зохицуулалт байхгүй байна. Харин энэ шатанд байгаа хэргийг хяналтын журмаар шаардан авах эрхтэй субъектууд байж болно гэж тус хуулийн **404, 419 дүгээр зүйлүүдээр** хуульчилсан байдаг байна. Энэ сонирхолтой зохицуулалтыг тухайн үеийн нийгмийн тогтолцоотой холбон авч үзэхээс өөр тайлбар олдсонгүй.

[3] БНМАУ-ын Засгийн газрын албан сэтгүүл. №50, 1930 он.

5. 1963 онд батлагдсан “БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬ”[4]-Д

III хэсэг “Анхан шатны шүүхийн ажиллагаа” гэсэн “24 дүгээр бүлгийн 231 дүгээр зүйл:

1/ урьдчилсан мөрдөн байцаалт бүрэн биш бөгөөд тэр нь шүүх хурлаар нөхөн гүйцэтгэх боломжгүй бол,

2/ хэрэг бүртгэх буюу урьдчилсан мөрдөн байцаалт явуулах үед эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн байвал,

3/ урьд сонсгосон ял дээр өөр ял нэмж сонсгох, эсхүл ялыг хүндрүүлэх буюу жинхэнэ бодит байдлаар нь ялын төлөвлөгөөнд дурдсанаас онцын ялгаатай болгон өөрчлөх үндэс байвал,

4/ уг хэрэгт холбогдуулан өөр хүмүүсийг эрүүгийн хариуцлагад татах үндэс байгаа бөгөөд тэдний материалыг хэргээс тусгаарлаж болохгүй байвал,

5/ хэргийг буруугаар нэгтгэсэн буюу тусгаарласан тохиолдолд

Шүүх дээр дурдсан тохиолдолд хэргийг буцаахдаа захиран тушаах хурал хийж, хэргийг нэмж мөрдөн байцаалгахаар прокурорт чухам ямар үндэслэлээр буцааж байгаа, юу нэмж тодруулахыг магадлалдаа тодорхой зааж байх үүрэгтэй” байв. Хэргийг нэмж шалгуулахаар буцаахдаа мөрдөн байцаагч, прокурорт чухам юуг, яаж хийхийг зааж сургах энэхүү үүрэг социалист шүүхийн тухайн нийгэмдээ гүйцэтгэж байсан чиг үүрэгтэй нь шууд холбоотой байдаг.

III хэсэг “Хоёр дугаар шатны шүүхийн ажиллагаа” гэсэн хэсгийн “29 дүгээр бүлгийн 339 дүгээр зүйл: Таслан шийдвэрлэх тогтоолыг хүчингүй болгох, хэргийг шинэчлэн хэлэлцүүлэх ба мөрдөн байцаалгахаар буцаах

Хэрэв ялыг хүндрүүлэн сонгох буюу урьд сонсгосон ялаас жинхэнэ байдлаараа онцгой ялгавартай ял сонгохоор таслан шийдвэрлэх тогтоолыг хүчингүй болгосон байвал таслан шийдвэрлэх тогтоол гаргасан шүүхээр дамжуулан нэмж мөрдөн байцаалгахаар прокурорт явуулна.

Хэрэв хэргийг шүүхэд хэлэлцэх үед зөрчил гаргасны улмаас таслан шийдвэрлэх тогтоолыг өөрчилж байгаа бол уг хэргийг таслан шийдвэрлэх тогтоол гаргасан шүүхээр өөр бүрэлдэхүүнтэйгээр буюу өөр шүүхэд шинэчлэн хэлэлцэхээр буцаана” гэж тус тус заажээ.

Дээрхи хуулийн заалтууд нь 1949 оны өмнөх хуулийн холбогдох заалтуудыг ерөнхийд нь хэлбэрийн хувьд уламжлан авсан байна.

Мөн хуулийн **32 дугаар бүлэг “Хяналтын шатны шүүхийн ажиллагаа” хэсгийн “366 дугаар зүйл: Эрүүгийн хэргийг шаардан авах”** тухай үндэслэлүүдийн заан, хуульчилсан байна. Энэ нь 1949 оны өмнөх хуулийн **404, 419 дүгээр зүйлүүдийг уламжлан** нэмж, өөрчлөн найруулж, хуульчилсан байдалтай байдаг.

6. 1994 онд батлагдсан “ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ”[5]-Д

254 дүгээр зүйл: “Мөрдөн байцаалт явуулахдаа нэг талыг барьсан буюу гүйцэт биш хийсэн, эсхүл Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг зөрчсөнөөс шүүгдэгчийн гэм буруутай эсэхийг бүрэн нотолж чадаагүй гэж шүүх хуралдааны явцад үзвэл шүүх хэргийг хянан хэлэлцэхийг 30 хүртэл хоногоор хойшлуулж, нэмэлт мөрдөн байцаалт

[4] БНМАУ-ын хууль дүрэм тогтоолын эмхтгэл. 1 №6, 1963 он.

[5] “Төрийн мэдээлэл” сэтшүүл, №5, 1994 он.

хийлгэх саналыг яллагчид тавьж болно...” гэж томьёолжээ. **Өөрөөр хэлбэл “хэргийн бүрдэл дутуу” гэх үндэслэлээр хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаахыг урьтал болгодог шүүхийн хэвшмэл ажиллагааг хязгаарласан агуулгатай заалт хуульд оруулсан байна.** Гэвч дээрх шинэлэг зохицуулалт бүхий хэм хэмжээг шүүхийн практикт хэрэглэхгүй байсаар ЭБШ хуульд оруулсан дараагийн өөрчлөлтөөр уул заалтыг хуульд “хасалт хийж” дараагийн хуулийг шинэчлэн баталсан байна.

2.2.Монгол Улсын одоо хэрэгжиж байгаа хууль тогтоомжийн зохицуулалт

Монгол Улс “Иргэний болон улс, төрийн эрхийн тухай олон улсын пакт”, “Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт” зэрэг хүний эрхийн талаарх олон улсын гэрээнд өнгөрсөн зууны 70-аад оны дунд үеэс нэгдэн орж, тэдгээрт үндэсний хууль тогтоомжийг бүрнээ нийцүүлэх үүрэг хүлээсэн боловч жинхэнэ утгаар нь энэ ажлыг 1992 оноос буюу Монгол Улсын Үндсэн хуульд хүний баталгаатай эдлэх эрх, эрх чөлөөг тунхаглан хуульчилснаар эхэлжээ.

Шинэ Үндсэн хуулийн хүний эрхийн талаарх заалт, үзэл санаа салбар хуулиуд, түүний дотор хэд хэдэн үе шаттайгаар өөрчилж, нэмэлт оруулсан ЭБШХ, Шүүхийн тухай хууль, Өмгөөллийн тухай хуульд тусгалаа олж, түүнийг хэрэгжүүлэх гол субьект болох шүүх нь хүний эрх, эрх чөлөөг эдлэв халдлагаас хамгаалж, хангах баталгаа болон төлөвших үйл явц 20-иод жил үргэлжилж байна.

2002 онд батлагдсан “ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬ”[6] -ийн 230 дугаар зүйлд:

- Хэргийг буруу нэгтгэсэн, тусгаарласан;
- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг бүрэн биш хийсэн бөгөөд түүнийг шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй бол;
- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахад энэ хуулийг ноцтой зөрчсөн бол;
- Улсын яллагч хэрэгт нэмэлт мөрдөн байцаалт хийлгэх шаардлагатай гэж үзсэн бол хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаахаар шүүх тогтоол, шүүгч захирамж гаргах”-аар заажээ.

Гүчдугаар бүлэг: Давж заалдах шатны шүүхийн үйл ажиллагаа “315 дугаар зүйлийн 315.1.2 дахь хэсэг: Тогтоолыг хүчингүй болгож, **хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт буюу анхан шатны шүүхээр хэлэлцүүлэхээр буцаах”**

Дөчдүгээр бүлэг: Хяналтын шатны шүүхийн үйл ажиллагаа “350 дугаар зүйлийн 350.1.3 дахь хэсэг: Тогтоол, магадлалыг хүчингүй болгож, хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцаах...”-аар тус тус хуульчилжээ.

2002 оны **“ЭРҮҮГИЙ БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬ”**-аар зохицуулахаар заасан дээрх зүйл заалт нь

1. Анхан шатны шүүхээс эрүүгийн хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтанд буцаахаар зохицуулж байсан 1969 оны **“БНМАУ-ЫН ЭРҮҮГИЙ БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬ”-**ийн тодорхой хязгаарлалт тогтоож буцаадаг уламжлалыг хадгалж, шинэчлэн найруулан баталжээ.

2. Давж заалдах шатны шүүхээс эрүүгийн хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтанд буцаахаар зохицуулж байсан 1949, 1969 оны **“БНМАУ-ЫН**

[6] Төрийн мэдээлэл”, №6, 2002 он.

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬ”-ийн зохицуулалтыг шинэчлэн найруулж, орчин цагийн хуулийн хэллэг, томьёололд оруулан баталжээ.

3. Хяналтын шатны шүүхээс эрүүгийн хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтанд буцаахаар оруулсан зохицуулт нь урьд өмнөх хуулийн зохицуулалтуудын уламжлалыг халсан байна. Өмнөх нийгмийн үед прокурор эрүүгийн хэргийн аль ч үе шатанд давуу эрхтэйгээр оролцож эрүүгийн хэргийг татаж авдаг байдлыг халсан байна. Энэ нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч талуудын эрхийг тэгш хангах үндэслэл болжээ.

Гурав. Гадаадын зарим улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зохицуулалт

Дэлхийн эрх зүйн системд монголын үндэсний эрх зүйн хамаарал, эх газрын эрх зүйн системтэй улсуудын хууль тогтоомжийн үндэсний хууль тогтоомжид үзүүлсэн нөлөө, монголын мөрдөн шалгах, шүүн таслах ажиллагааны уламжлалт хэв маяг, түүнчлэн эрх зүйн шинэчлэлийг амжилттай хийсэн зарим улсын хууль тогтоосон туршлага, онцлог зэргийг харгалзан ОХУ, Латви, Казахстан, ХБНГУ, Франц Улсын эрүүгийн байцаан шийтгэх хуулийг харьцуулан судалсныг товчлон танилцуулбал:

3.1. ОХУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд

Оросын Холбооны Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 237 дугаар зүйлд зааснаар “Эрүүгийн хэргийг прокурорт буцаах” тухай ОХУ-ын ЭБШХ-ийн 2013 оны 04 дүгээр сарын 26-нд нэмэлт, өөрчлөлт оруулж, уг хууль нь 2014 оны 05 дугаар сарын 07-оос хүчин төгөлдөр болсон бөгөөд энэ өөрчлөлтийн гол чухал нь шүүхээс хэргийг прокурорт буцаах тухай асуудал байжээ. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд өөрийн уламжлал, эх газрын болон англо-саксоны эрх зүйн уламжлалыг харьцуулан сайтар судалж байна. Нэмэлт өөрчлөлтийн шийдэлд хүрсэн юм байна. ОХУ-ын ЭБШХ-ийн 237 дугаар зүйлдэ оруулсан өөрчлөлтөөр мөрдөн байцаах ажиллагааны дутууг нөхөж гүйцээлгэх зорилгоор буцааж байсныг бүрмөсөн болиулж шүүхээс эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхэд саад учруулж буй нөхцөл байдлыг арилгуулах зорилгоор хэргийг прокурорт буцаах боломжийг хуульчилсан байна. Ингэхдээ буцаах 2 тохиолдлыг дараах байдлаар тодорхойлсон:

1. Шүүхэд хэргийг шилжүүлсний дараа яллагдагчид холбогдох нийгэмд аюултай шинэ үр дагавар үүсч, түүнд нь илүү хүнд ял сонсгох шаардлагатай болсон.

2. Эрүүгийн хэргийн талаар өмнө нь гаргасан шүүхийн тогтоол, магадлал, захирамжийг дээд шатны шүүхээр хүчингүй болгосон бөгөөд хүчингүй болгох шийдвэрийн үндэс болсон шинэ болон дахин үүссэн нөхцөл байдал нь яллагдагчид илүү хүнд ял сонсгох үндэслэл болж байгаа.

Энэ 2 тохиолдолд хэргийн анхан, давж заалдах, хяналтын шатны алинаас нь ч буцааж болохоор шүүхэд заасан.

Өмнө нь ийм үндэслэлүүдээр шүүхээс хэргийг буцааж байгаагүй. Гэхдээ шүүх энд заасан 2 тохиолдолд өөрийн санаачлагаар бус прокурорын хүсэлтээр буцааж болох юм байна. Хэргийг “нэмэлт мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцаах” өнөөдөр манайд мөрдөгдөж байгаа ЭБШХ-ийн ойлголтыг ОХУ-д буцааж болох 2 тохиолдлыг хуульчилсан нь шүүн таслах ажиллагаанд саад болох нөхцөл байдлыг арилгах зорилготой болж шинэчлэгдсэн. Гэхдээ тухайн үндэслэлээр буцаах нь зөвхөн прокурорын хүсэлтээс шалтгаалахаар хуульчилсан байна.

Прокурорын хүсэлтээр буцааж болох дээрх 2 тохиолдлоос гадна, шүүх өөрийн санаачлагаар буцааж болох зарим тохиолдлыг мөн хуульд заасан. Эдгээр нь шүүн

таслах ажиллагааг үргэлжлүүлэн явуулахад саад болох нөхцөл байдлуудтай холбоотой.

- Яллах дүгнэлийг үйлдэхдээ ЭБШХ-ийн заалт зөрчсөн;
- Яллагдагчид яллах дүгнэлтийг гардуулаагүй, эсхүл хуульд заасан хугацаанд гардуулаагүй;
- Хэд хэдэн хэргийг нэгтгэх шаардлагатай болсон гэсэн үндэслэлүүдээр шүүх өөрийн санаачлагаар хэргийг прокурорт буцаах боломжтой болсон.

3.2. ХБНГУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд

ХБНГУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх 1877 онд батлагдсан бөгөөд Европын хамгийн "анхдагч" хуулиудын нэг гэж тооцогддог ба өнөөгийн редакцаар 1987 оноос хойш үйлчилж буй. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны үе шатыг шүүхийн өмнөх, шүүхэд шилжүүлэх, шүүх ажиллагаа гэх зэргээр манайхтай төсөөтэй тоймлон үе шатад хувааж үзэх боломжтой ч зарчмын шинжтэй олон ялгаа байдаг. Тухайлбал, шүүхийн өмнөх үе шатыг эрүүгийн хэрэг үүсгэх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа явуулах гэхчлэн салгадаггүй. Шүүхэд хэрэг очихоос өмнөх ажиллагаанд прокурор голлох үүрэгтэй оролцдог. Гэмт хэрэг гарсан тухай үндэслэл бүхий гомдол, мэдээлэл нь цагдаа, шүүхийн мөрдөн байцаагч, прокурорын хувьд процессын ажиллагааг эхлэх үүргийг үүсгэдэг.

Баримт нотолгоо нь яллахад хангалттай гэж үзвэл прокурор яллагдагчид ял сонсгох ба улмаар мөрдөн шалгах, яллах ажиллагаа хангалттай хийгдсэн бол Германы ЭБШХ-ийн 170.1-д зааснаар харьяалах шүүхэд яллах дүгнэлт бичиж хүргүүлдэг". Бусад бүх тохиолдолд мөн хуулийн 170.2-ыг баримтлан хэргийг хэрэгсэхгүй болгоно. Нэмэлт шалгалт хийлгэхээр хэргийг цагдаад ч юм уу, өөр хэн нэгэнд буцаах тухай зохицуулалт байхгүй.

Шүүхийн шат: прокурор яллахаар эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлсэн бол харьяалах шүүх уул хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх эсэхийг тогтоох ажиллагааг явуулж эхэлдэг. Энэ ажиллагаа нь гэм буруугүй этгээд эрүүгийн хэрэгт яллагдан, шүүх хуралдаанаар шүүгдэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилготой. Энэ шатанд шүүгч яллагдагчийг дуудан ирүүлж, түүнд яллах дүгнэлтийн хувь хуулбарыг танилцуулж, хэрэгт авагдаагүй бусад нотлох баримт цуглуулж авахуулах хүсэлт бий эсэх, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхэд татгалзал бий эсэхийг лавлана. Хуулийн 202 дугаар зүйлд "...хэргийн бодит байдлыг сайтар судалж тогтоох зорилгоор шүүх нэмэлт нотлох баримт цуглуулахаар шийдвэрлэж болох ба түүнд хэн ч гомдол гаргах эрхгүй" гэж заажээ. Үүний дараа шүүх хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх, эс хэлэлцэхээ шийдвэрлэдэг. Эс хэлэлцэх тохиолдолд хэргийг хэрэгсэхгүй болгох, эсхүл түдгэлзүүлэх шийдвэрийн аль нэгийг гаргана. Хэлэлцэхээр бол прокурорын ялласан хэмжээнд, эсхүл сонсгосон ялыг ихэсгэх, багасгах эсэхийг шийдвэрлэдэг. Дүгнэж хэлбэл, шүүхийн шатанд хэргийг дахин шалгуулахаар прокурорт буцаах талаар зохицуулалт огт байхгүй бөгөөд прокурор ялыг нэмэгдүүлэх санал тавьсан тохиолдолд ч хуралдааныг завсарлаж байгаад л хэргийг нэг мөр шийдвэрлэдэг аж.

Эрүүгийн процессийн хууль 160 дугаар зүйл (1) Мөрдөн шалгах процесс "Прокурорын алба нь гэмт хэрэг үйлдэгдсэн талаарх мэдээллийг хүлээн авмагц мөрдөн шалгаж, гэмт этгээдийг яллах эсэх тухай шийдвэрлэнэ".

3.3. БНКУ-ын Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд

БНКУ-ын хуучин ЭБШХ-д хэргийг мөрдөн байцаалтад буцаах тухай 303 дугаар зүйлд шүүгч дараах тохиолдолд талуудын хүсэлтээр хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаана гэсэн байна. Үүнд:

1. Яллагдагч өөр хэрэгт холбогдон шалгагдаж байгаа, эсхүл өөр этгээд хэрэгт хамааралтай бөгөөд хэргийг тусгаарлан шийдвэрлэх боломжгүй гэж үзэх үндэслэлтэй бол;

2. Яллах дүгнэлтэд дурдсан ялыг илүү хүндрүүлэн өөрчлөх, эсхүл анх сонсгосон ялаас өөр ял сонсгох шаардлагатай байгаа бол;

3. Хэргийг буруу нэгтгэсэн, тусгаарласан, эсхүл эрүүгийн хуулийг ноцтой зөрчсөн нь шүүх хуралдаанаар хэргийг хэлэлцэхэд саад учруулахаар байвал шүүх хуралдааныг товлон зарлахын өмнө шүүгч өөрийн санаачлагаар, эсхүл талуудын хүсэлтийн дагуу хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаана.

2015 оны 1 дүгээр сарын 1-ээс нэмэлт, өөрчлөлт оруулсан ЭБШХ-ийн 323 дугаар зүйл “Шүүхээс прокурорт хэргийг буцаах”-д шүүх хуралдааныг хэлэлцэхэд саад учруулахуйц ЭБШХ-ийн бодит зөрчлийг тогтоох, арилгахаар шүүх хэргийг прокурорт буцаана... гэсэн нь БНКУ-ын ЭБШ ажиллагаанд шүүх эрүүгийн хэргийг нэмж шалгуулахаар прокурорт буцаах зохицуулалт байгаа нь манай улсын ЭБШХ-тай мөн адил байдлаар зохицуулагдаж байна.

3.4. Франц Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд

1958 оноос хойш хүчин төгөлдөр үйлчилж байгаа Францын Эрүүгийн байцаан шийтгэх хууль улсын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь бүхэлдээ мөрдөн шалгах тогтолцоотой. Шүүхийн мөрдөн байцаагчийн оролцоо процесс ажиллагаанд их нөлөөтэй. Эрүүгийн процесс нь шүүхийн өмнөх болон шүүхийн гэсэн хоёр шаттай.Хавтаст хэрэгт хангалттай нотлох баримт цугларсан бөгөөд шүүхэд хэргийг шилжүүлснээр шүүхийн өмнөх шат дуусгавар болно.

Энэ хуулийн “Зайлшгүй авах шаардлагатай бус болон онцгой тохиолдолд авах шаардлагатай арга хэмжээ” хэмээх зүйлүүд /283- 287/-эд шүүхийн өмнөх шатанд мөрдөн байцаах ажиллагаа дутуу явагдсан, түүнчлэн хэргийг нэг мөр шийдвэрлэхэд тодорхой үйл баримтыг тогтоох гарцаагүй шаардлагатай гэж үзвэл даргалагч шүүгч захирамж гаргаж мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар заасан байна. Процесс ажиллагааны шүүхийн өмнөх шатруу хэргийг буцаах тухай зохицуулалт энэ хуульд мөн алга байна.

3.5. Латви Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль

Социалист систем, ЗХУ-ын задралын дараа тусгаар тогтносон улсуудын дунд Балтийн тэнгэсийн гэгдэх улсуудын, тухайлбал: Латвийн үндэсний хууль тогтоомжоо Европын холбооны хатуу стандарт, шаардлагад амжилттай нийцүүлсэн туршлагыг дэлхийн олон улсад жишиг болгодог. Иймд дээр товч танилцуулсан ОХУ, ХБНГУ зэрэг эх газрын эрх зүйн өндөр соёл, уламжлалын төлөөлөл болсон улсын ЭБШХ-ийг судлахын сацуу, Латвийн хуулийн бүтэц, онцлогийг харьцуулан судлах нь эрдэм шинжилгээний онол, практикийн ач холбогдолтой байж болно.

Латвид өдгөө мөрдөж буй ЭБШХ-ийг 2005 онд баталсан бөгөөд түүнд шүүхэд шилжүүлсэн хэргийг нэмж шалгуулахаар шүүхийн өмнөх шатанд буюу прокурорт буцаах талаар зохицуулалт огт байхгүй юм. Гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс

үйлдэхүйг дээрх хуулиар эрх олгосон байгууллага, албан тушаалтан прокурорт ирүүлдэг, прокурор уул ажиллагааг хянах шинжтэй чиг үүрэг хэрэгжүүлдэг. Улмаар гэмт хэргийн нөхцөл байдлыг баримт нотолгоогоор хангалттай тодруулсан гэж прокурор үзвэл гэмт хэрэгт сэрдэгдэж буй этгээдэд ял сонсгож, хэргийг шүүхэд шилжүүлдэг. Гэхдээ шүүхийн өмнөх процесс /байцаан шийтгэх/ ажиллагааг явуулах, дуусгавар болгох олон хувилбарыг хуульчилсан /411 дүгээр зүйл/ байна.

Хуульд шүүхийн урьдчилсан хуралдаан, зөвлөгөөн гэх зэрэг тусгайлсан үе шатыг гаргаагүй боловч шүүхийн өмнөх процесс ажиллагаа хэрхэн дуусч байгаагаас шалтгаалж анхан шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа өвөрмөц онцлогтой явагдана.

Латви Улсын ЭБШХ-ын 411 дүгээр зүйлд зааснаар прокурор шүүхийн өмнөх процесс ажиллагааг дор дурдсанаар дуусгавар болгох:

- Эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлэх тогтоол гаргаж, хэргийг харьяалах шүүхэд шилжүүлэх;

- Эрүүгийн хэргийг шүүхэд хойшлуулшгүй ажиллагааны журмаар шилжүүлэх тогтоол гаргах;

- Эрүүгийн хэргийг шүүхэд хялбаршуулсан /хорогдуулсан, богиносгосон/ журмаар шилжүүлэх тогтоол гаргах;

- Эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлэхээр яллагдагчтай тохиролцох журмаар,

- Яллагдагчид ял хэрэглэхээр урьдчилан тохирох;

- Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож, эрүүгийн хариуцлагаас тэнсэж чөлөөлөх журмаар;

- Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг хэргэсэхгүй болгох тогтоол гаргах;

- Эмнэлгийн болон хүмүүжлийн шинжтэй албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шүүхэд эрүүгийн хэргийг шилжүүлэх тогтоол гаргах.

Жишээ болгож эрүүгийн хэргийг шүүхэд хойшлуулшгүй ажиллагааны журмаар шилжүүлэх зохицуулалтын талаар товч дурдвал:

- Тухайн зохицуулалтыг ямар тохиолдолд хэрэглэж болох /гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хэргийн газарт нь баривчилсан, хэргийн ангилал, ажлын 3 хоногт дуусгах боломж г.м./

- Хэрэг гарсан нөхцөл байдал, хохирогч, гэрч, хохирлын хэмжээг тодруулах гэх зэрэг шаардлагатай ажиллагааг маш түргэн гүйцэтгээд материалыг хангалттай болсон гэж прокурор үзвэл шүүхэд хэргийг өгдөг. Тэгэхдээ шүүх хуралдааныг түргэн хийхээр прокурор шүүхтэйгээ зөвшилцдөг ба энэ хугацаа хэрэг хүлээн авснаас хойш 3-10 хоногийн дотор байна. Эрүүгийн хэргийг шүүхэд хойшлуулшгүй ажиллагааны журмаар шилжүүлэх тогтоол нь холбогдох этгээдийг эрүүгийн хариуцлагад татсан шийдвэр болдог ба уул тогтоолыг хэргийн материалын хуулбарын хамтаар яллагдагчид, мөн түүнчлэн хохирогчид прокурор гардуулан өгөх ёстой. Энэ шийдвэрт гомдол гаргахгүй ба шүүхийн ажиллагаа ердийн журмаар явагдана.

Хэрэг хүлээж авсан шүүх мөн хуулийн 486 дугаар зүйлд зааснаар хэргийн харьяалал, яллах шийдвэр нь байгаа эсэх, түүний хувь хуулбарыг яллагдагчид гардуулж өгсөн эсэх, хэргийн материалтай танилцсан эсэх зэрэг асуудлыг тодруулах ба харьяаллын бус бол хэргийг зохих шүүхэд нь шилжүүлж, бусад тохиолдолд “дутагдал”-ыг арилгуулахаар дээд шатны прокурорт хэргийг шилжүүлэн өгдөг. Түүнчлэн 488 дугаар зүйлд зааснаар шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагааг аль болох түргэн эхлэх ёстой ба хэрэг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор хуралдааны товыг тодорхойлсон байх ёстой.

Хууль зүйн яаманд хүргэгдлээ www.zhi.gov.mn

Тус улсын ЭБШХ-д буй манайхаас ялгаатай зохицуулалтын нэг нь шүүх хуралдаанд оролцсон прокурор урьд сонсгосон ялыг багасгаж, нэмэгдүүлж өөрчлөх шаардлагатай бол энэ тухай үндэслэлээ танилцуулж ялыг өөрчлөх үүрэгтэй /461 дүгээр зүйл/. Ял өөрчлөх тохиолдолд:

- хэргийн бодит байдал өөрчлөгдөхгүйгээр ялыг хөнгөрүүлж өөрчилж буй бол шинээр сонсгож буй ялын талаар шүүх хуралдааны тэмдэглэлд тэмдэглэнэ;

- ялыг хүндрүүлсэн буюу сонсгосон ялыг хөнгөрүүлж өөрчилснөөр хэргийн бодит нөхцөл байдал өөрчлөгдсөн бол шүүх, яллагдагч, түүний өмгөөлөгчийн шаардсанаар прокурор нь шинээр ял сонсгох тухай бичгээр мэдэгдэнэ. Ялыг өөрчлөн сонсгоход хугацаа хэрэгтэй бол прокурорын хүсэлтээр хуралдааныг завсарлаж болно.

- хэрэв шүүх хуралдааны явцад хэргийн өөр нөхцөл байдал тогтоогдож, ялыг хүндрүүлэн өөрчлөх шаардлагатай болвол прокурорын хүсэлтээр байцаан шийтгэх зайлшгүй ажиллагаа явуулах боломж олгохоор шүүх хуралдааныг завсарлах ба энэ хугацаа нэг сараас илүү байж болохгүй;

- шинэ ял сонсгож буйтай холбогдож яллагдагч, түүний өмгөөлөгч, хохирогч, түүний төлөөлөгчийн хүсэлтээр шүүх хуралдааныг хойшлуулж, шинээр сонсгож буй ялтай танилцах боломж олгодог байна /462 дугаар зүйл/.

Дөрөв. Социологийн судалгаа, түүний үр дүн

Судалгааны санал асуулгын зорилго:

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчид болон судлаачдын судалж буй асуудлын талаарх санал, байр суурийг тандан тодруулах зорилго тавьсан.

Судалгааны арга зүй:

Судалгаанд бичиг баримт боловсруулах, анкет санал асуулгын болон бичиг баримт судлалын, ажиглалтын, анализ, синтезийн зэрэг аргуудыг хэрэглэн анхдагч мэдээлэлд тоон болон чанарын боловсруулалт хийж, үр дүнг гаргасан болно.

Судалгаанд оролцогчдын хамрах хүрээ:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч субьектүүд болох Улсын дээд шүүхийн шүүгч, Давж заалдах шатны шүүхийн шүүгч, Анхан шатны шүүхийн шүүгч, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч, өмгөөлөгч болон хөндлөнгийн байр сууринаас шинжлэх ухааны онолын судалгаа, шинжилгээ хийдэг эрдэмтэн, судлаачдыг оролцуулаад нийт 186 хүнийг хамруулсан болно.

Санал асуулгын нэгдсэн дүн

Д/д	Судалгаанд оролцсон салбарын төлөөлөл	тоо	Буцаах нь зөв		Буцаах нь буруу	
1	Улсын дээд шүүхийн шүүгч	5	5	100%	0	0%
2	Давж заалдах шатны шүүхийн шүүгч	9	6	66,6%	3	33,4
3	Анхан шатны шүүхийн шүүгч	18	16	88,9%	2	11,1%
4	Прокурор	28	27	96,4%	1	2,3%
5	Мөрдөн байцаагч	43	38	88,4%	5	11,6%
5	Хэрэг бүртгэгч	2	2	100%	0	0%

www.nli.gov.mn Үндэсний хүрээлэн

6	Өмгөөлөгч	38	29	76,3	9	23,6%
7	Эрдэмтэн, судлаач	43	41	95,4	2	4,6
Нийт		186	164	88,1%	22	11,8%

Судалгаанд нийт 186 оролцогч хамрагдсан ба үүнээс 164 оролцогч буюу 88,1% шүүхээс эрүүгийн хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцаах нь зөв гэж үзжээ. Харин 22 оролцогч буюу 11,8% нь шүүхээс эрүүгийн хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцаах нь буруу гэж үзжээ.

Шүүхээс эрүүгийн хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцаах нь зөв гэж үзсэн оролцогчдийн олонх нь дэмжсэн саналыг дор жагсаавал:

1. Аль шатанд буцаах нь зүйтэй вэ? гэсэн асуултанд дараах байдлаар хариулсан байна.

- Бүх шатны шүүхээс 39 %;
- Зөвхөн хэргийг шүүхэд шилжүүлэх шатанд 27,8%;
- Зөвхөн прокурор хүсэлт тавьсан тохиолдолд 15,7%;
- Зөвхөн анхан шатны шүүхээс 14,7%.

2. Ямар шалтгаанаар буцаах нь зөв гэж Та үзэж байна вэ? гэсэн асуултанд дараах байдлаар хариулсан байна.

- Буцаахгүйгээр хэргийн бодит үнэнийг тогтоох боломжгүй 30,4%;
- Буцаахгүй байхаар хуульчлах тохиолдолд шүүгдэгчийн эрх зөрчигдөж, хэлмэгдэх боломж бүрдэнэ 29,3%;
- Буцаахгүй байхаар хуульчлах тохиолдолд шударга ёсны эрх ашиг зөрчигдөж шүүгдэгч ял завших боломж бүрдэнэ. 25%.

- Шүүхээс эрүүгийн хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцаах нь зөв гэж үзсэн оролцогчдийн дийлэнх олонх дэмжсэн саналыг дор жагсаавал:

- Буцаахын оронд шүүх хуралдааны үед нэмэлт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, шийдвэрлэх боломжтой. 24,7,1%;
- Буцааснаар шүүгдэгч ял завших боломж бүрдэнэ. 18,2%;
- Буцааснаар хэргийн шийдвэрлэлт сунжирч чирэгдэл үүснэ. 17,9 %;
- Буцаах нь хөндлөнгийн сонирхлын үүднээс хэргийг шууд шийдвэрлэхээс зайлсхийх боломжийг шүүгчид олгодог. 17.2%.

Тав. Дүгнэлт

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн холбогдох заалтыг түүхчлэн авч үзсэн хэсгээс харахад шүүхээс нэмэлт мөрдөн байцаалтад хэргийг буцаах эрх зүйн зохицуулалт анхны буюу 1926, 1929 оны хуулиудад тусгагдаагүй бөгөөд 1935 оны хуульд анх тусгагдаж, түүнээс хойш одоо хүртэл хэрэглэгдэж байна.

Иймд шүүхээс хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаах эрх зүйн зохицуулалт орчин үеийн Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны түүхэн уламжлалын хувьд анхнаасаа байгаагүй, хожуу буй болжээ. Буй болсон цаг үеийг нь авч үзэхэд шүүхэд нотлох үүрэг давамгайлах хандлагатай болсон социалист эрх зүйн үзэл баримтлалтай холбоотой байж магадгүй.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.ali.gov.mn

2. Бусад зарим улсын харьцуулсан судалгааны байдлаас харахад эх газрын эрх зүйн бүлийн гол төлөөлөгч орон болох Франц болон Герман улсын Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд шүүхээс хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаадаггүй бөгөөд шүүх хуралдааны үед нэмэлт ажиллагаа явуулах боломжтой байна.

Харин социалист эрх зүйн бүлд багтаж байсан БНКУ, ОХУ-ын хувьд нэмэлт мөрдөн байцалтад буцаадаг байсан өмнөх хуулиудын заалтаа өөрчилж, агуулгын хувьд нөхөж мөрдүүлэх бус, шүүн таслах ажиллагаанд саад болох нөхцөл байдлыг арилгах зорилгоор хязгаарлагдмал хүрээнд буцаах байдлаар зохицуулсан байна.

Харин Латви улсад шүүхээс буцаах ойлголтыг хуулиасаа бүрмөсөн хасч, мөрдөн байцаах ажиллагааны шаардлага гарсан үед шүүх ажиллагааг түдгэлзүүлэн шүүхийн шатанд явуулах бололцоог хуульчилсан байна.

Үүнээс харахад хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаахыг эх газрын эрх зүйн бүлийн уламжлал гэж үзэх үндэсгүй бөгөөд манай улсын адил социалист эрх зүйн бүлд багтаж байсан зарим улсууд шүүхээс хэргийг нэмэлт мөрдөн байцаалт хийлгэхээр буцаадаг зохицуулалтаас татгалзах байдлаар Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн шинэчлэлийг хийж байна.

Энэ жишгийг харгалзан манай улсын Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хүрээнд шинэчлэл хийх шаардлага онол, практикийн хувьд бий болсон гэж үзэхээр байна.

3. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, өмгөөлөгч, шүүгч, энэ чиглэлийн судлаачдаас хэсэгчлэн авсан санал асуулгын судалгааны дүнг нэгтгэсэн байдлаас үзэхэд энэхүү санал асуулганд оролцогчдын 88.1 хувь нь буюу дийлэнх нь ямар нэгэн хэмжээнд шүүхээс хэргийг прокурорт буцаах нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилтыг хангахад ач холбогдолтой гэж үзжээ.

Шүүхээс хэргийг буцаахыг дэмжсэн үндэслэлийг харахад ихэнх нь хэргийн бодит үнэнийг тогтооход тустай гэсэн байна. Харин хэргийг буцаахын эсрэг санал өгсөн үндэслэлд хугацаа сунжирч, чирэгдэл үүсдэг, мөн эцэслэн шийдвэрлэхээс зайлсхийх боломжийг шүүгчид олгодог гэсэн үндэслэлүүд давамгайлж байна.

Судалгаанд оролцогчдын саналын нэгдсэн дүн нь ийнхүү хэргийг шүүхээс буцаах талдаа дийлэнх байгаагийн шалтгаан нь одоогийн практикт илүү дасал болсонтой холбоотой байж болох юм.

Санал

1. Шүүхээс Эрүүгийн хэргийг нэмэлт мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцаахаас татгалзах нь шүүх төвийн байр суурьнаас хэргийг хянан шийдвэрлэх зарчимд илүү нийцтэй гэж үзэж байна.

2. Эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлэх шатанд шүүх ажиллагааг явуулахад саад болох нөхцөл байдлыг арилгуулах зорилгоор прокурорт буцаах боломж ба тухайн тохиолдлуудыг хуульд хязгаарлагдмал хүрээнд тодорхой тусгах боломжтой.

3. Шүүх ажиллагааны явцад шинээр илэрсэн нөхцөл байдалд шаардагдах ажиллагааг шүүх ажиллагааны явцад явуулж, эцэслэн шийдвэрлэх бололцоог одоогийнхоос илүү өргөн боломжтойгоор хуульчлах саналтай байна.

--o0o---

ТАВ. ЛАВЛАГАА

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nli.gov.mn

АРД НИЙТИЙН САНАЛ АСУУЛГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА БОЛОН СОНГУУЛИЙН ТУХАЙ, СОНГУУЛИЙН АВТОМАТЖУУЛСАН СИСТЕМИЙН ТУХАЙ, СОНГУУЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛИУДЫН УЯЛДАА ХОЛБОО[1]

Нэг. Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2016 онд баталсан. Энэхүү хууль Сонгуулийн тухай (2015 он), Сонгуулийн автоматжуулсан системийн тухай (2011 он), Сонгуулийн төв байгууллагын тухай (2006 он) хуулиудтай хэрхэн уялдаж байгааг тоймлон авч үзлээ.

1). Ард нийтийн санал асуулгын тухай (шинэчилсэн найруулга) хуульд заасан санал авах ажиллагааг Сонгуулийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд заасны дагуу зохион байгуулахаар тусгасан байна.

2). Уг хуульд заасан санал асуулгыг явуулах нутаг дэвсгэр, сонгуулийн байгууллага, түүний зохион байгуулалт, бүрэн эрхийг Сонгуулийн тухай, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулиудтай уялдуулан зохицуулжээ. Тухайлбал, Хүснэгт 1. Хуулиудын зохицуулалт (дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харна уу).

Хуулийн нэр, он		
Ард нийтийн санал асуулгын тухай хууль /2016/	**Сонгуулийн тухай хууль /2015/**	**Сонгуулийн төв байгууллагын тухай /2006/**
9 дүгээр зүйл. Санал асуулга явуулах нутаг дэвсгэрийн хуваарь	21 дүгээр зүйл. Сонгуулийн нутаг дэвсгэр	
10 дугаар зүйл. Хэсэг, түүнийг байгуулах	23 дугаар зүйл. Сонгуулийн хэсэг	
11 дүгээр зүйл. Санал асуулгыг эрхлэн явуулах байгууллага, түүний зохион байгуулалт	24 дүгээр зүйл. Сонгуулийн байгууллага	7 дугаар зүйл. Хорооны бүрэн эрх
12 дугаар зүйл. Сонгуулийн хороодын зохион байгуулалт бүрэн эрх		7 дугаар зүйл. Хорооны бүрэн эрх

3). Тухайн хуулийн иргэдийн нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах зохицуулалтыг Сонгуулийн тухай хуулийн 61 дүгээр зүйл. Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх, болон Иргэдийн нэрийн жагсаалттай холбогдсон гомдлыг сонгуулийн тухай хуулийн 64 дүгээр зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэхээр тус тус заасан байна.

4). Санал авах, тоолох (санал авах газар, хугацаа, санал асуулгын хуудас, санал авах ажиллагаа, санал асуулгыг ажиглах, санал өгөх) ажиллагааг Сонгуулийн тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулиудтай нийцүүлэн зохицуулжээ.

5). Ард нийтийн санал асуулгын тухай хуульд заасан санал тоолох, санал болон саналын хуудсыг хүчингүйд тооцох, дахин санал хураах, санал асуулгын нэгдсэн дүн гаргах, мэдээлэх ажлыг Сонгуулийн тухай хуулийн 97 дугаар зүйл. санал тоолох, 99 дүгээр зүйл. санал болон саналын хуудсыг хүчингүйд тооцох, 103 дугаар зүйл. хэсэгт явуулсан санал хураалтыг хүчингүйд тооцох 134 дүгээр зүйл. сонгуулийн нэгдсэн дүн мэдээлэх, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйл, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 5 дугаар зүйлд тус тус заасны дагуу явуулахаар зохицуулжээ.

[1] Энэхүү лавлагааг Хууль зүйн судалгааны төвийн эрдэм шинжилгээний ажилтан У.Эрдэнэзаяа гүйцэтгэв.

6). Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль тогтоомж зөрчсөн тухай гомдол, маргааныг шийдвэрлэх харьяалалыг Сонгуулийн тухай хуульд зааснаар шийдвэрлэхээр заасан байна.

Хоёр. Холбогдох хуулиудын нэмэлт өөрчлөлт: Сонгуулийн тухай хууль 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр батлагдсан ба таван удаа (2017.0.2.02, 2016.12.28, 2016.10.07, 2016.05.05, 2015.12.25 онуудад) нэмэлт өөрчлөлт орсон байна. (дэлгэрэнгүйг хавсралт 2-оос харна уу).

2011 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль батлагдсанаас хойш гурван удаа (2016.07.21, 2015.12.25, 2015.11.10 онуудад) нэмэлт өөрчлөлт орсон. (мөн тэнд).

Сонгуулийн төв байгууллагын тухай хууль 2006 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр батлагдсан. Хууль батлагдсанаас хойш хоёр удаа (2015.12.25, 2007.12.26 онуудад) өөрчлөлт оруулсан байна. (мөн тэнд).

Хэдийгээр дээрх хуулиудад нэмэлт, өөрчлөлт орсон боловч Ард нийтийн санал асуулгын тухай (шинэчилсэн найруулга) хуультай холбогдуулж зарчмын шинжтэй өөрчлөлт ороогүй байна.

Ард нийтийн санал асуулгын тухай (шинэчилсэн найруулга) хууль батлагдсанаас хойш дээрх хуулиудад нэмэлт, өөрчлөлт орсныг тодруулж үзэхэд холбогдох хууль шинэчлэгдэн (Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017 он (шинэчилсэн найруулга), Монгол Улсын хилийн тухай хууль, 2016 он (шинэчилсэн найруулга) батлагдсанаар хуулийн нэр томьёоны өөрчлөлт оруулсан, мөн Сонгуулийн хуулийн зарим зүйл заалтыг нэмж, өөрчилж, хүчингүй болгосон нь уг хуулийн мөн чанар, агуулгад нөлөөлөхөөргүй байна.

Дүгнэлт: Ард нийтийн санал асуулгын тухай (шинэчилсэн найруулга) хуулийг Сонгуулийн тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулиудтай уялдуулж гаргасан, ба эдгээр хуульд өөрчлөлт оруулах шаардлага гараагүй байна.

Хуулийн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

Хавсралт 1

АРД НИЙТИЙН САНАЛ АСУУЛГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА БОЛОН СОНГУУЛИЙН ТУХАЙ, СОНГУУЛИЙН АВТОМАТЖУУЛСАН СИСТЕМИЙН ТУХАЙ, СОНГУУЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛИУДЫН УЯЛДАА ХОЛБОО

Ард нийтийн санал асуулгын тухай (шинэчилсэн найруулга) хууль Сонгуулийн тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулиудтай хэрхэн нийцэж байгааг авч үзэв.

Хуулийн нэр, он			
1	2	3	4
Ард нийтийн санал асуулгын тухай хууль /2016/	**Сонгуулийн тухай хууль /2015/**	**Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль /2011/**	**Сонгуулийн төв байгууллагын тухай хууль /2006/**
7 дугаар зүйл. Санал асуулгыг товлон зарлах 7.7.санал асуулгыг улсын их хурлын, ерөнхийлөгчийн болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуультай хамтатган явуулах бол сонгуулийн тухай хуульд заасны дагуу санал асуулгыг санал авах өдрөөс 65-аас доошгүй хоногийн өмнө товлон зарлана.	**Гуравдугаар бүлэг сонгуулийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх үндэс** **16 дугаар зүйл.ээлжит сонгууль, түүний санал авах өдрийг товлон зарлах** 16.1.ээлжит сонгуулийг санал авах өдрөөс 65-аас доошгүй хоногийн өмнө улсын их хурал товлон зарлана.		

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХЭРЭГЛЭЭНИЙ www.nli.gov.mn

8 дугаар зүйл. Санал асуулга явуулахтай холбогдсон зардал 8.1.санал асуулга явуулахтай холбогдсон зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ. 8.2.санал асуулга явуулахтай холбогдсон зардлын төрөл нь сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан зардал байна. 8.3.санал асуулгын зардлын хэмжээг улсын их хурал батална. 8.4.зардлын хэмжээг батлахдаа улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас гаргасан хүн амын тоонд харгалзан тооцсон сонгуулийн төв байгууллагын саналыг үндэслэнэ.	**38 дугаар зүйл.сонгууль зохион байгуулах зардал** 38.2.Улсын их хурал, ерөнхийлөгч, орон нутгийн хурлын сонгуулийн доор дурдсан сонгуулийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ: 38.2.1.сонгуулийн байгууллагын үйл ажиллагааны зардал; 38.2.2.нэр дэвшигчийн үнэмлэх, сонгуулийн штабын ажилтан, менежер, шадар туслагч, ухуулагч болон сонгуулийн ажиглагчийн үнэмлэх хэвлэх, хүргүүлэх зардал; 38.2.3.ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн хамгаалалтын зардал; 38.2.4.саналын хуудас хэвлүүлэх, хамгаалах, хүргүүлэх зардал; 38.2.5.сонгуулийн дүн, мэдээний маягт, бие даан нэр дэвшигчийн дэмжигч-сонгогчийн гарын үсэг цуглуулах маягт, сонгуулийн байгууллагын албан бичгийн хэвлэмэл хуудас хэвлэх, хүргүүлэх зардал; 38.2.6.тамга, тэмдэг, лац, саналын хуудас битүүмжлэн хадгалах уут бэлтгэх зардал; 38.2.7.санал авах, тоолох, дүн гаргах ажиллагаанд хэрэглэх техник, тоног төхөөрөмж, тэдгээрийн сэлбэг хэрэгсэл, программ хангамж, худалдан авах, түрээслэх, ашиглах, хадгалах, хамгаалах, засвар үйлчилгээ хийх, тээвэрлэх болон даатгал, тусгай тэмдэглэл хийх хэрэгсэл, тэдгээрийг худалдан авах, түрээслэх, ашиглах, хамгаалах, хадгалах, засвар үйлчилгээ хийх, хэвлэх, үйлдвэрлэх, тээвэрлэх, хүргэх, татан авах зардал; 38.2.8.санал хураалтын дүнгийн мэдээ дамжуулах зардал; 38.2.9.саналын хайрцаг хийх, хүргэх, санал авах байрын болон санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал; 38.2.10.сонгуулийн хууль тогтоомж болон сонгууль зохион байгуулахтай холбогдсон эрх зүйн бусад акт, гарын авлага, сургалт, сурталчилгааны материал боловсруулах, хэвлэх, хүргэх зардал; 38.2.11.сонгуулийн байгууллагын ажилтан, мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон сургалтын зардал; 38.2.12.сонгуулийн хууль тогтоомжийг сурталчлах болон сонгууль зохион байгуулах, түүний бэлтгэл ажлын явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах арга хэмжээний зардал; 38.2.13.сонгуульд нэр дэвшүүлсэн нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн санхүүжилт, зарцуулалтыг хянан шалгахад гарах зардал; 38.2.14.нэмэлт болон дахин санал хураах, ээлжит, ээлжит бус, нөхөн болон дахин сонгууль явуулах зардал; 38.2.15.сонгуулийн байгууллагын ажилтан, мэдээллийн технологийн багийн болон ажлын хэсгийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал; 38.2.16.сонгуулийн байгууллагын бичиг хэрэг, шуудан, холбоо, унаа, албан томилолтын зардал; 38.2.17.гадаад улсад байгаа иргэдийн санал авахтай холбогдон гарах зардал; 38.2.18.онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардал; 38.2.19.сонгуулийг зохион байгуулахтай холбогдсон бусад зардал. 38.1.сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг хүн амын тоог сонгуулийн нутаг дэвсгэртэй харьцуулан гаргасан сонгуулийн төв байгууллагын саналыг үндэслэн улсын их хурал тухай бүр батална.		

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭН
www.legalinfo.mn

8.5.энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан хэсгийн хороодын ажиллах болон санал авах байрыг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд үнэ төлбөргүй гаргаж өгнө.	**39 дүгээр зүйл.сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд туслах** 39.1.сонгуулийн орон нутгийн байгууллагын ажиллах байр болон санал авах байрыг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд үнэ төлбөргүй гаргаж өгнө.		
8.6.хэсгийн хороодыг ажиллах байр, тээвэр, холбооны болон бусад шаардлагатай хэрэгслээр хангах асуудлыг тухайн шатны засаг дарга хариуцна.	39.2.сонгуулийн орон нутгийн байгууллагыг ажиллах байр, тээвэр, холбоо болон бусад шаардлагатай хэрэгслээр үнэ төлбөргүй хангах асуудлыг тухайн шатны засаг дарга хариуцна.		
8.7.энэ хуулийн 8.1-д заасан зардлын гүйцэтгэлд төрийн аудитын дээд болон орон нутгийн аудитын байгууллага аудит хийж, дүгнэлт гаргана.	39.4.сонгуулийн зардлын гүйцэтгэлд төрийн болон орон нутгийн аудитын байгууллага аудит хийж, дүгнэлт гаргана.		
Хоёрдугаар бүлэг **санал асуулга явуулах нутаг дэвсгэр, сонгуулийн байгууллага, түүний зохион байгуулалт, бүрэн эрх** **9 дүгээр зүйл. Санал асуулга явуулах нутаг дэвсгэрийн хуваарь** 9.1.ард нийтийн санал асуулга явуулах нутаг дэвсгэр нь монгол улсын нутаг дэвсгэр байна.	**Дөрөвдүгээр бүлэг** **сонгуулийн нутаг дэвсгэрийн зохион байгуулалт** **21 дүгээр зүйл.сонгуулийн нутаг дэвсгэр** 21.1.улсын их хурал болон ерөнхийлөгчийн сонгуулийн нутаг дэвсгэр нь монгол улсын нутаг дэвсгэр байна.		
9.2.иргэдийн санал авах зорилгоор санал асуулга явуулах нутаг дэвсгэрийг хэсэгт хуваана.	21.4.сонгогчийн саналыг авах, тоолох зорилгоор сонгуулийн нутаг дэвсгэр нь хэсэгт хуваагдана.		
10 дугаар зүйл. Хэсэг, түүнийг байгуулах 10.3.нэг хэсэг нь суманд 2000-аас, аймгийн төвд 2500-аас, нийслэлийн дүүрэгт 3000-аас дээшгүй санал өгөх иргэнтэй байх бөгөөд нэг хэсэгт байх санал өгөх иргэний тоо 200-аас доошгүй байна.	**23 дугаар зүйл.сонгуулийн хэсэг** 23.2.нэг хэсэг нь суманд 2000-аас дээшгүй, аймгийн төвд 2500-аас дээшгүй, нийслэлийн дүүрэгт 3000-аас дээшгүй сонгогчтой байна.		
10.4.сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид энэ хуулийн 10.1-д заасны дагуу байгуулсан хэсгийн мэдээллийг аймаг, нийслэлийн иргэний бүртгэлийн байгууллагад нэн даруй хүргүүлэх бөгөөд аймаг, нийслэлийн иргэний бүртгэлийн байгууллага нь хүлээн авсан мэдээллийг аймаг, дүүрэг тус бүрийн хэмжээнд нэгтгэн тав хоногт улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.	23.6.хэсгийн талаарх мэдээллийг хүлээн авсан улсын бүртгэлийн байгууллагын аймаг, нийслэл дэх салбар, нэгж нь нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нэгтгэн тав хоногийн дотор улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.		
10.5.энэ хуулийн 10.4-т заасан мэдээллийг үндэслэн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэсгийн дугаарыг тухайн аймаг, дүүргийн хэмжээнд давхардахгүй байхаар тав хоногийн дотор тогтооно.	23.8.хэсгийн талаарх хүлээн авсан мэдээллийг үндэслэн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хэсгийн дугаарыг нэгээс эхлэн давхардахгүй байхаар тогтооно.		

www.nii.gov.mn

11 дүгээр зүйл. Санал асуулгыг эрхлэн явуулах байгууллага, түүний зохион байгуулалт 11.1.санал асуулга явуулах ажлын бэлтгэлийг улсын хэмжээнд сонгуулийн төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд тухайн шатны засаг даргын тамгын газар /цаашид “засаг даргын тамгын газар” гэх/, нутаг дэвсгэрийн нэгжийн хэмжээнд сонгуулийн хэсгийн хороод /цаашид “хэсгийн хороо” гэх/ тус тус эрхлэн зохион байгуулна. 11.2.энэ хуулийн 10.5-д заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас хэсгийн дугаарыг тогтоосноос хойш сум, дүүргийн засаг даргын тамгын газар нь хэсгийн хороог дарга, нарийн бичгийн дарга, тав хүртэл гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр тав хоногт багтаан байгуулна.			**Гуравдугаар бүлэг** **хороо, түүний гишүүний бүрэн эрх, баталгаа** **7 дугаар зүйл. Хорооны бүрэн эрх** 7.1.1.ард нийтийн санал асуулга болон сонгууль бэлтгэн явуулах ажлыг төлөвлөж, зохион байгуулах; 7.1.3.сонгуулийн бүх шатны хороодын үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах; 7.1.4.ард нийтийн санал асуулга болон сонгууль зохион байгуулж явуулах, түүний бэлтгэл ажилтай холбогдсон асуудлаар төрийн зохих байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах; 7.1.14.өөрийн эрх хэмжээнд хамаарах асуудлаар сонгуулийн хороод, сонгууль зохион байгуулж явуулах, түүний бэлтгэл ажлыг хангахад туслах үүрэг бүхий төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, түүнчлэн хууль тогтоомжид заасан асуудлаар холбогдох бусад байгууллагаас шаардлагатай баримт, мэдээ сэлтийг гаргуулж авах, зохих албан тушаалтны мэдээллийг сонсож, хууль биелүүлэх асуудлаар үүрэг даалгавар өгөх;

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

11 дүгээр зүйл. Санал асуулгыг эрхлэн явуулах байгууллага, түүний зохион байгуулалт 11.3.санал асуулгыг Улсын их хурлын, ерөнхийлөгчийн сонгуультай хамт явуулах бол сонгуулийн тухай хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн байгууллага эрхлэн явуулна.	Тавдугаар булэг Сонгуулийн байгууллага **24 дүгээр зүйл.сонгуулийн байгууллага** 24.1.сонгуулийг сонгуулийн байгууллага зохион байгуулж, явуулна. 24.2.сонгуулийн байгууллага нь дараах байгууллага байна: 24.2.1.сонгуулийн төв байгууллага; 24.2.2.аймаг, нийслэлийн сонгуулийн байгууллага /цаашид “аймаг, нийслэлийн сонгуулийн хороо” гэх/; 24.2.3.сум, дүүргийн сонгуулийн байгууллага /цаашид “сум, дүүргийн сонгуулийн хороо” гэх/; 24.2.4.гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах төв комисс / цаашид “төв комисс” гэх/; 24.2.5.гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах салбар комисс / цаашид “салбар комисс” гэх/.		
12 дугаар зүйл. Сонгуулийн хороодын зохион байгуулалт бүрэн эрх 12.1.сонгуулийн ерөнхий хорооны бүрэн эрхтэй холбогдох харилцаанд сонгуулийн төв байгууллагын тухай хуульд заасан журмыг баримтлана.			Гуравдугаар бүлэг хороо, түүний гишүүний бүрэн эрх, баталгаа **7 дугаар зүйл. Хорооны бүрэн эрх**
12.2.тухайн шатны засаг даргын тамгын газар болон хэсгийн хороод санал асуулга явуулахад сонгуулийн тухай хуулийн аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны болон сонгуулийн хэсэг дэх нэгж санал авахтай холбогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.			
Гуравдугаар бүлэг иргэдийн нэрийн жагсаалт **13 дугаар зүйл. Иргэдийн нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах** 13.1.санал асуулгад оролцох иргэдийн нэрийн жагсаалтыг үйлдэх, танилцуулах ажлыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улсын хэмжээнд зохион байгуулж нэгдсэн удирдлагаар хангана.	**Наймдугаар бүлэг сонгогчдын нэрийн жагсаалт** **61 дүгээр зүйл.сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх** 61.1.сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний бүртгэл, мэдээллийн сан дахь сонгогчийн бүртгэлд үндэслэн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхлэн үйлдэнэ.		

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

13.2.иргэдийн нэрийн жагсаалттай холбогдсон гомдлыг сонгуулийн тухай хуулийн 64 дүгээр зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэх бөгөөд энэ хуульд заасан хугацааг баримтлан шийдвэрлэнэ.	**64 дүгээр зүйл.сонгогчдын нэрийн жагсаалттай холбогдсон гомдлыг шийдвэрлэх журам** 64.1.сонгогч өөрийн болон өөрийн гэр бүлийн аль нэг гишүүний нэр сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй буюу буруу бүртгэгдсэн бол өөрийн болон өөрийн гэр бүлийн гишүүний нэрийн өмнөөс гомдлоо улсын бүртгэлийн холбогдох байгууллагад санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө бичгээр гаргана. 64.2.улсын бүртгэлийн холбогдох байгууллага иргэний бүртгэлийн мэдээллийн улсын санг үндэслэн гомдол гаргасан иргэний мэдээллийн талаар лавлагаа гаргах ба уг лавлагааг үндэслэн санал авах байрын дэргэд ажиллах улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан, эсхүл улсын бүртгэгч тухайн сонгогчийн мэдээлэлтэй холбогдсон өөрчлөлтийг гурав хоногийн дотор сонгогчдын нэрийн жагсаалтад оруулна. 64.3.энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг хориглоно. 64.4.санал авах байрын дэргэд ажиллах улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан сонгогчдын нэрийн жагсаалтад “түр хасав” гэсэн нэмэлт тэмдэглэгээ хийлгэсэн иргэний сонгогчдын нэрийн жагсаалтад нэмэлт тэмдэглэгээ хийлгэсэн шалтгаан нь арилсан тохиолдолд санал авах өдрөөс өмнө болон санал авах өдөр тухайн сонгогчийн өөрийнх нь хүсэлт, үндэсний гадаад паспорт, холбогдох бусад нотлох баримтыг үндэслэн сонгогчдын нэрийн жагсаалт дахь зохих тэмдэглэгээг хүчингүй болгон тухайн сонгогчийн бүртгэлийг сэргээж энэ тухай тэмдэглэл үйлдэн санал авах байранд мэдэгдэнэ. 64.5.энэ хуулийн 64.2-64.4-т заасныг зөрчсөн сонгуулийн байгууллагын ажилтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зургаагаас найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.		

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.legal.mn

Дөрөвдүгээр бүлэг санал авах, тоолох **14 дүгээр зүйл. Санал авах газар, хугацаа** 14.1.иргэдээс санал авах газар, хугацаатай холбогдох харилцаанд сонгуулийн тухай хуулийн 87 дугаар зүйлд заасан журмыг баримтлана.	**Арван нэгдүгээр бүлэг санал авах ажиллагаа** **Нэгдүгээр дэд бүлэг санал авах газар, хугацаа** **87 дугаар зүйл.санал авах газар, хугацаа** 87.1.сонгогчдын саналыг улаанбаатарын цагаар санал авах өдрийн 07.00 цагаас 22.00 цаг хүртэл хугацаанд санал авах байранд авна. 87.2.санал авах байр сонгогчдын санал авах өдөр, цаг, байрыг уг өдөр хүртэлх 14 хоногийн турш нийтэд зарлан мэдээлнэ. 87.3.тухайн хэсгийн харьяалагдах сум, дүүргийн засаг дарга санал авахад шаардлагатай дараах зүйлийг сонгуулийн төв байгууллагаас баталсан зааврын дагуу санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө бэлэн болгох үүрэг хүлээнэ: 87.3.1.санал авах байр; 87.3.2.сонгогч саналаа нууцаар өгөхөд шаардагдах санал бэлтгэх бүхээг /300 сонгогч тутамд нэг байхаар тооцож/; 87.3.3.зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаар санал өгөх сонгогч саналаа нууцаар өгөхөд шаардагдах бүхээг; 87.3.4.суурин болон зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг; 87.3.5.сонгогчийн бүртгэл дэх зургийг нийтэд болон ажиглагчид үзүүлэх дэлгэц; 87.3.6.хууль тогтоомжид заасан бусад зүйл. 87.4.харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайль үсэг бүхий хавтас санал авах байр бүрд нэг байна. 87.5.санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчдын тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна. 87.6.санал авах байр нь тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна. 87.7.нэг барилга байгууламж, цогцолборт хэд хэдэн санал авах байр байрлаж болно. 87.8.санал авах байр санал авах өдрөөс арав хоногийн өмнө тухайн хэсэг дэх санал авах байрын дугаар, нэр, хаяг, байршил, орчин тойрны дэвсгэр зураг /план/-ийг нийтэд зарлан мэдээлнэ. 87.9.санал авах байрын байршлыг нийтийн эмх замбараагүй байдал, үер ус, гал түймэр зэрэг давагдашгүй хүчин зүйлийн улмаас өөрчилж болох бөгөөд энэ тухай нэн даруй сонгогчид мэдээлнэ. 87.10.санал авах байрыг бэлтгэх заавар, түүнчлэн саналын хайрцаг, санал өгөх бүхээгийн хэмжээ, загварыг сонгуулийн төв байгууллага батална. 87.11.санал авах байранд саналын хуудас хүлээн авснаас хойш санал авах байрыг цагдаагийн хамгаалалтад авна.		
15 дугаар зүйл. Санал асуулгын хуудас 15.2.сонгуулийн төв байгууллага саналын хуудасны тоо, загвар болон саналын хуудсыг хэвлүүлэх, хадгалах, хүргүүлэх, хамгаалах журмыг батална.	84.11.Тухайн сонгуулийн саналын хуудасны загвар, тоог сонгуулийн төв байгууллага баталж, эрхлэн хэвлүүлнэ.		**7 дугаар зүйл. Хорооны бүрэн эрх**

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.legal.mn

16 дугаар зүйл. Санал авах ажиллагаа 16.1.санал асуулга явуулах өдрийн 07.00 цагт хэсгийн хорооны бүрэлдэхүүн иргэний төлөөлөл, ажиглагчийг байлцуулан дараахь ажиллагааг доор дурдсан дарааллын дагуу гүйцэтгэнэ: 16.1.1.тухайн хэсгийн иргэдийн нэрийн жагсаалтад бичигдсэн нийт иргэний тоо, үүнээс зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгсөн иргэний тоог зарлах; 16.1.2.саналын хуудасны индекс, дугаарыг зарлах; 16.1.3.хүлээн авсан, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авахад зарцуулсан, үүнээс зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авахад иргэн саналаа бүрүү тэмдэглэсэн үндэслэлээр энэ хуульд заасны дагуу дахин нэг саналын хуудас авч саналаа гаргасны улмаас хүчингүй болгосон, түүнчлэн алдагдаж үрэгдсэн, устсан, үлдсэн саналын хуудасны тоог мэдээлэх; 16.1.4.зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаас бусад санал авах бүх хайрцгийг нээж харуулах, санал авах хайрцгийг битүүмжлэх, лацдах, санал авахад бэлэн болгох. 16.2.хэсгийн хороо энэ хуулийн 16.1-д заасан ажиллагааг гүйцэтгэсэн тухай тэмдэглэл хөтөлж, уг тэмдэглэлд бүртгэлийн хуудсыг хавсарган хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн дарга болон бүх гишүүн гарын үсэг зурна. 16.3.санал асуулгад оролцохоор ирсэн иргэн санал авах байранд ажиллах иргэний бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтанд иргэний үнэмлэх, биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-өө шалгуулах бөгөөд иргэний бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан тухайн иргэний мэдээллийг системээс шалгаж зөрчилгүй бол бүртгэлийн хуудас олгоно. 16.4.бүртгэлийн хуудас авсан иргэн уг бүртгэлийн хуудсаа иргэний үнэмлэхийн хамт хэсгийн хорооны гишүүнд шалгуулж саналын хуудас авна. 16.5.санал асуулга явуулах ажиллагаанд ажиглагч болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгч байлцаж болно.	**Хоёрдугаар дэд бүлэг санал авах үйл ажиллагаа** **89 дүгээр зүйл.санал авах байранд санал авах ажиллагаа** 89.1.санал авах өдрийн 07.00 цагт санал авах байрны бүрэлдэхүүн сонгогчдын төлөөлөл, ажиглагчдыг байлцуулан дараах ажиллагааг доор дурдсан дарааллын дагуу гүйцэтгэж тэмдэглэл үйлдэнэ: 89.1.1.тухайн хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоо, үүнээс зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгсөн сонгогчдын тоог мэдээлэх; 89.1.2.саналын хуудасны индекс, дугаарыг мэдээлэх; 89.1.3.хүлээн авсан, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авахад зарцуулсан, үүнээс зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авахад сонгогч саналаа буруу тэмдэглэсэн үндэслэлээр дахин нэг саналын хуудас авч саналаа гаргасны улмаас хүчингүй болгосон, түүнчлэн алдагдаж үрэгдсэн, устгагдсан, үлдсэн саналын хуудасны тоог мэдээлэх; 89.1.4.зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаас бусад санал авах бүх хайрцгийг нээж харуулах, санал тоолох төхөөрөмжийг битүүмжлэх, лацдах, санал авахад бэлэн болгох; 89.1.5.зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгийг нээж, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар саналаа өгсөн сонгогчдын саналын хуудсыг санал тоолох төхөөрөмж /саналын хайрцаг/-д хийхдээ зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгсөн сонгогчийн регистрийн дугаараар сонгогчийн бүртгэлийн хуудсыг улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнаар гарүүлах. 89.2.санал авч эхлэхийн өмнөх ажиллагааг дууссаны дараа сонгогчдын саналыг авч эхэлнэ. 89.3.санал өгөхөөр санал авах байранд ирсэн сонгогч санал авах байранд ажиллах улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын итгэмжлэгдсэн ажилтанд гарын хурууны хээг шалгуулах ба тухайн ажилтан нь иргэний бүртгэлийн мэдээллийн улсын сан дахь сонгогчийн бүртгэл, түүнчлэн тухайн хэсэг дэх сонгогчдын нэрийн жагсаалтын цахим хувилбартай тулган үзэж, зөрчилгүй бол сонгогчийн бүртгэлийн хуудас олгоно. 89.4.гарын хурууны хээ шалгах автомат төхөөрөмж ажиллахгүй буюу ажиллах боломжгүй болсон, түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийн тухайд иргэний үнэмлэхийн мэдээллийг сонгогчдын нэрийн жагсаалттай тулган шалгаж сонгогчийн бүртгэлийн хуудас олгож болно. 89.6.сонгогчийн бүртгэлийн хуудас авсан сонгогчид саналын хуудас олгоно. 89.9.санал авах ажиллагаанд сонгуулийн ажиглагч болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгч байлцаж болно.		
17 дугаар зүйл. Санал асуулгыг ажиглах 17.1.санал асуулгыг иргэний төлөөлөл болон олон улсын байгууллага, гадаад улсын иргэн, гадаад улсын болон дотоодын байгууллага ажиглаж болно. 17.2.санал асуулгыг ажиглах, сурвалжлах журмыг сонгуулийн төв байгууллага батална.	**Арван дөрөвдүгээр бүлэг ажиглагч** 107.6.гадаадын болон олон улсын байгууллага сонгуулийг ажиглахад гадаад улсын иргэн ажиглагч байж болох ба үүнтэй холбогдсон журмыг сонгуулийн төв байгууллага баталж мөрдүүлнэ.		**Гуравдугаар бүлэг хороо, түүний гишүүний бүрэн эрх, баталгаа** **7 дугаар зүйл. Хорооны бүрэн эрх** 7.1.7.ард нийтийн санал асуулгын болон сонгуулийн хууль тогтоомжид заасан дүрэм, журам, заавар, баримт бичгийн загвар маягт батлах;

Дөрөвдүгээр бүлэг санал авах, тоолох **14 дүгээр зүйл. Санал авах газар, хугацаа** 14.1.иргэдээс санал авах газар, хугацаатай холбогдох харилцаанд сонгуулийн тухай хуулийн 87 дугаар зүйлд заасан журмыг баримтлана.	**Арван нэгдүгээр бүлэг санал авах ажиллагаа** **Нэгдүгээр дэд бүлэг санал авах газар, хугацаа** **87 дугаар зүйл.санал авах газар, хугацаа** 87.1.сонгогчдын саналыг улаанбаатарын цагаар санал авах өдрийн 07.00 цагаас 22.00 цаг хүртэл хугацаанд санал авах байранд авна. 87.2.санал авах байр сонгогчдын санал авах өдөр, цаг, байрыг уг өдөр хүртэлх 14 хоногийн турш нийтэд зарлан мэдээлнэ. 87.3.тухайн хэсгийн харьяалагдах сум, дүүргийн засаг дарга санал авахад шаардлагатай дараах зүйлийг сонгуулийн төв байгууллагаас баталсан зааврын дагуу санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө бэлэн болгох үүрэг хүлээнэ: 87.3.1.санал авах байр; 87.3.2.сонгогч саналаа нууцаар өгөхөд шаардагдах санал бэлтгэх бүхээг /300 сонгогч тутамд нэг байхаар тооцож/; 87.3.3.зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогч саналаа нууцаар өгөхөд шаардагдах бүхээг; 87.3.4.суурин болон зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг; 87.3.5.сонгогчийн бүртгэл дэх зургийг нийтэд болон ажиглагчид үзүүлэх дэлгэц; 87.3.6.хууль тогтоомжид заасан бусад зүйл. 87.4.харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайль үсэг бүхий хавтас санал авах байр бүрд нэг байна. 87.5.санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчдын тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна. 87.6.санал авах байр нь тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна. 87.7.нэг барилга байгууламж, цогцолборт хэд хэдэн санал авах байр байрлаж болно. 87.8.санал авах байр санал авах өдрөөс арав хоногийн өмнө тухайн хэсэг дэх санал авах байрын дугаар, нэр, хаяг, байршил, орчин тойрны дэвсгэр зураг /план/-ийг нийтэд зарлан мэдээлнэ. 87.9.санал авах байрын байршлыг нийтийн эмх замбараагүй байдал, үер ус, гал түймэр зэрэг давагдашгүй хүчин зүйлийн улмаас өөрчилж болох бөгөөд энэ тухай нэн даруй сонгогчид мэдээлнэ. 87.10.санал авах байрыг бэлтгэх заавар, түүнчлэн саналын хайрцаг, санал өгөх бүхээгийн хэмжээ, загварыг сонгуулийн төв байгууллага батална. 87.11.санал авах байранд саналын хуудас хүлээн авснаас хойш санал авах байрыг цагдаагийн хамгаалалтад авна. 87.12.энэ хуулийн 87.8, 87.9-д заасныг зөрчсөн сонгуулийн байгууллагын ажилтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зургаагаас найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, 87.3-т заасныг зөрчсөн засаг даргыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зургаагаас найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.		
18 дугаар зүйл. Санал өгөх Иргэн санал авах байранд өөрийн биеэр ирж, саналаа өгнө.	**Гуравдугаар дэд бүлэг сонгогч санал өгөх** **92 дугаар зүйл.санал авах байранд санал өгөх** 92.1.сонгогч санал авах байранд өөрийн биеэр ирж, саналаа биечлэн өгнө.		

ХУУЛЬ ЗҮЙН ЗҮЙЛЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН
www.mlt.gov.mn

18.3.иргэн санал тэмдэглэхдээ алдаа гаргаж буруу тэмдэглэл хийсэн бол саналын хуудсаа саналын хайрцагт хийхээс өмнө энэ тухайгаа хэсгийн хороонд мэдэгдэж, алдаатай саналын хуудсыг хураалгаж, дахин нэг удаа саналын хуудас авч саналаа өгч болно.	92.8.сонгогч санал тэмдэглэхдээ алдаа гаргаж буруу тэмдэглэл хийсэн бол саналын хуудсаа санал тоолох төхөөрөмж /саналын хайрцаг/-д хийхээс өмнө энэ тухайгаа санал авах байранд мэдэгдэж, алдаатай саналын хуудсыг хураалгаж, дахин нэг удаа саналын хуудас авч саналаа өгч болно.		
18.4.хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн байдал, боловсролын түвшингээс шалтгаалан саналаа биечлэн өгөх чадваргүй иргэн өөрийн итгэмжилсэн сонгуулийн эрх бүхий иргэний туслалцаатайгаар санал өгч болох ба сонгуулийн байгууллагын ажилтан, албан тушаалтан, ажиглагч нь итгэмжлэгдсэн хүн байж болохгүй.	92.11.бие эрхтний согог, эрүүл мэндийн байдал, боловсролын түвшингээс шалтгаалан саналаа биечлэн өгөх чадваргүй сонгогч өөрийн итгэмжилсэн сонгуулийн эрх бүхий иргэний туслалцаатайгаар санал өгч болох ба сонгуулийн байгууллагын ажилтан, албан тушаалтан, ажиглагч нь итгэмжлэгдсэн хүн байж болохгүй		
18.5.санал асуулга явуулахад сонгуулийн автоматжуулсан системийг ашиглах эсэхийг Улсын их хурал шийдвэрлэнэ.	3.1.18.“санал тоолох төхөөрөмж” гэж Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасны дагуу Улсын Их Хурлаас зөвшөөрсөн санал авах, тоолох, үр дүнг тооцоолон гаргах, дамжуулах зориулалт бүхий техник хэрэгслийг;	**6 дугаар зүйл. сонгуулийн автоматжуулсан системийг хэрэглэх, ашиглах талаарх Улсын их хурлын бүрэн эрх** 6.1.1.сонгуулийн автоматжуулсан системийг сонгуульд хэрэглэх талаар шийдвэр гаргах;	
18.6.иргэний саналыг зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар авах журмыг сонгуулийн төв байгууллага батална.	**90 дүгээр зүйл.Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах ажиллагаа** 90.10.Сонгогчийн саналыг зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар авах журмыг энэ хуульд нийцүүлэн сонгуулийн төв байгууллага баталж мөрдүүлнэ.	**9 дүгээр зүйл. сонгуулийн автоматжуулсан системийг ашиглах талаарх сонгуулийн ерөнхий хорооны бүрэн эрх** 9.2.1.сонгуулийн автоматжуулсан системийг ашиглахтай холбогдсон дүрэм, журам, зааврыг сонгуулийн тухай хууль тогтоомжтой нийцүүлэн баталж мөрдүүлэх;	
Тавдугаар бүлэг **санал тоолох, дүн гаргах** **19 дүгээр зүйл. Санал тоолох** 19.1.хэсэгт санал тоолох ажиллагааг санал асуулга явуулах өдрийн 22.00 цагт эхэлж, ажиглагч, хэвлэл мэдээллийн байгууллагын болон иргэний төлөөлөгчийг байлцуулан ил тод, нээлттэй явуулна.	**Арван хоёрдугаар бүлэг** **санал хураалтын дүн гаргах, нэгтгэх үйл ажиллагаа** **Нэгдүгээр дэд бүлэг** **санал тоолох** **97 дугаар зүйл.санал тоолох** 97.1.хэсэгт санал тоолох ажиллагааг санал авах ажиллагаа дуусмагц эхэлж, ажиглагч, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчийг байлцуулан ил тод, нээлттэй явуулна.		

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

19.2.хэсгийн хороо санал тоолох бэлтгэл хангагдмагц тухайн хэсгийн хорооны дарга санал тоолох тухай зарлах ба санал тоолох ажиллагааг гүйцэтгэхээс өмнө дараахь ажиллагааг хийн тэмдэглэл үйлдэнэ: 19.2.1.санал авах байранд болон зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар саналаа өгсөн иргэний тоо нь санал авахад олгосон саналын хуудасны тоотой тохирч байгаа эсэхийг тулган шалгаж, эцсийн тооцоо гаргах; 19.2.2.санал авахад зарцуулаагүй үлдсэн болон буруу тэмдэглэл хийснээс хураагдсан саналын хуудсыг тус тусад нь тоолж, баруун дээд өнцгийг нь хайчлан, энэ тухай тэмдэглэлд тусган боож битүүмжлэх. 19.3.хэсгийн хороо энэ хуулийн 19.2-т заасан ажиллагааг гүйцэтгэсний дараа асуултын хариулт бүрд өгсөн саналын тоог хэсгийн хэмжээгээр нэгтгэн тоолж дүнг гаргана. 19.4.санал асуулгын саналыг санал тоолох төхөөрөмжөөр тоолох бөгөөд санал тоолох төхөөрөмжөөс гарсан дүн мэдээ нь тухайн хэсгийн санал асуулгын дүн байна. Санал тоолох төхөөрөмжөөс гарсан дүнг хэвлэж авсны дараа сонгуулийн төв байгууллагын дэргэдэх мэдээллийн технологийн төвд нэн даруй дамжуулна. Санал асуулгын саналыг гар аргаар тоолж, дүнг гаргахаар шийдвэрлэсэн тохиолдолд холбогдох журмыг сонгуулийн төв байгууллага батална. 19.5.иргэн аль ч асуултын хариултад санал өгөөгүй бол аль ч асуудлыг дэмжээгүй санал гэж үзэн тухайн иргэнийг санал өгсөн иргэний тоонд оруулан тоолох ба энэ тохиолдолд уг саналын хуудсыг хүчинтэй саналын хуудаст тооцно. 19.6.санал авахад зарцуулсан болон зарцуулаагүй үлдсэн саналын хуудасны нийлбэр нь тухайн хэсгийн хороо хүлээн авсан нийт саналын хуудасны тооноос зөрвөл хэсгийн хороо шалтгааныг шалгаж тогтоох бөгөөд шаардлагатай гэж үзвэл саналын хуудсыг нэн даруй дахин тоолно. 19.7.хэсгийн хороо энэ хуулийн 19.6-д заасан ажиллагааг гүйцэтгэхдээ зөвхөн саналын хуудсыг тоолно. 19.8.санал тоолох цаг болоогүй байхад саналыг тоолох, түүнчлэн санал тоолох ажиллагааг завсарлахыг хориглоно. 19.9.хэсгийн хороо тухайн хэсгийн санал асуулгын дүнг уншиж сонсгосны дараа, санал асуулгын дүнг нэгтгэсэн тэмдэглэлд хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, нэг хувийг сум, дүүргийн засаг даргын тамгын газарт, сум, дүүргийн засаг даргын тамгын газар нь аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газарт тус тус нэн даруй хүргүүлнэ. 19.10.хэсгийн хороо саналын хайрцгаас гарсан саналын хуудас болон энэ хуульд заасны дагуу хураагдсан саналын хуудсыг тус тусад нь багцлан боож битүүмжлэн, сонгуулийн бусад баримт бичгийн хамт сум, дүүргийн засаг даргын тамгын газарт, сум, дүүргийн засаг даргын тамгын газар нь аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газарт тав хоногт хүргүүлнэ. 19.11.саналын хуудасны мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор энэ хуулийн 19.10-т заасны дагуу битүүмжилсэн саналын хуудасны битүүмжлэлийг задлахгүйгээр холбогдох журамд заасны дагуу аймаг, нийслэлийн архивт хадгална.	97.2.санал авах байр санал тоолох ажиллагааг гүйцэтгэхээс өмнө дараах ажиллагааг хийн тэмдэглэл үйлдэнэ: 97.2.1.санал авах байранд болон зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар саналаа өгсөн сонгогчдын тоо нь сонгогчдод олгосон саналын хуудасны тоотой тохирч байгаа эсэхийг тулган шалгаж, тооцоо гаргах; 97.2.2.санал авахад зарцуулаагүй үлдсэн болон буруу тэмдэглэл хийснээс хураагдсан саналын хуудсыг тус тусад нь тоолж, баруун дээд өнцгийг нь хайчлан, энэ тухай тэмдэглэлд тусган битүүмжилнэ. 97.3.санал авах байр санал тоолохын өмнөх ажиллагааг хийсний дараа саналыг тоолно. 97.4.саналыг санал тоолох төхөөрөмжөөр тоолох бөгөөд санал тоолох төхөөрөмжөөс гарсан дүнгийн хуудас нь тухайн хэсгийн санал хураалтын дүн байна. 97.5.санал авах, тоолох төхөөрөмжид гэмтэл, саатал гарсан тохиолдолд тухайн төхөөрөмжид байгаа саналын хуудсыг хоёр дахь, эсхүл нөөц төхөөрөмжид уншуулж тоолох ба санал авах, тоолох төхөөрөмж байхгүй тохиолдолд сонгуулийн төв байгууллагаас баталсан журмын дагуу гар аргаар тоолно. 97.6.санал авах байр санал тоолох төхөөрөмжөөс санал хураалтын дүнгийн хуудсыг хэвлэж авсны дараа санал хураалтын үр дүнгийн мэдээллийг сонгуулийн төв байгууллагад нэн даруй дамжуулна. 97.7.санал хураалтын дүн мэдээллийг дамжуулах ажиллагаа явуулахгүй байх, саатуулах, зогсоохыг хориглоно. 97.8.санал авах байр санал хураалтын дүнг дараах үзүүлэлтээр гаргана: 97.8.1.тухайн хэсэгт бүртгэгдсэн нийт сонгогчдын тоо; 97.8.2.санал өгсөн нийт сонгогчдын тоо; 97.11.саналын хуудсыг нягтлан тоолоход саналыг тоолохгүй. 97.12.саналын хуудас дахин тоолох үед зөрүү гарвал энэ тухай тэмдэглэл үйлдэж, саналын хуудас тоолоход оролцсон сонгуулийн байгууллагын бүрэлдэхүүн гарын үсэг зурна. 97.13.санал хураалт дууссаны дараа сум, дүүргийн сонгуулийн хороо санамсаргүй сонголт /сугалах/-ын аргаар харьяа хэсгийн хорооноос 50 хүртэл хувийг сонгож 24 цагийн дотор техникийн тооллого хийнэ. Техникийн тооллогод сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн болон сонгогчдын төлөөллийг оролцуулна. 97.14.техникийн тооллого хийх журмыг сонгуулийн төв байгууллага батална. 97.15.санал тоолох цаг болоогүй байхад санал тоолохыг хориглоно. 97.16.санал тоолж эхэлсэн бол завсарлахыг хориглоно.		

хуулийн эрхийн хуулийн хүрээлэн www.mli.gov.mn

20 дугаар зүйл. Санал болон саналын хуудсыг хүчингүйд тооцох 20.1.баталсан загвар, шаардлагыг хангаагүй саналын хуудсыг хүчингүйд тооцно. 20.2.эсрэг утга бүхий хариултын хоёуланг нь тэмдэглэсэн саналыг хүчингүйд тооцно. 20.3.иргэний санал хүчингүй болсон нь саналын хуудсыг хүчингүйд тооцох үндэслэл болохгүй.	**99 дүгээр зүйл.санал болон саналын хуудсыг хүчингүйд тооцох** 99.1.дараах тохиолдолд саналыг хүчингүйд тооцно. 99.3.баталсан загвар, шаардлагыг хангаагүй саналын хуудсыг хүчингүйд тооцно. 99.4.сонгогчийн санал хүчингүй болсон нь саналын хуудсыг хүчингүйд тооцох үндэслэл болохгүй.		
21 дүгээр зүйл. Санал хураалтыг хүчингүйд тооцох, дахин санал хураах 21.1.хэсэгт явагдсан санал хураалтыг доор дурдсан тохиолдолд хүчингүйд тооцно: 21.1.1.гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон зэрэг хүндэтгэн үзэх шалтгаангүй байхад урьд нь зарласнаас өөр байранд, түүнчлэн зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар авснаас бусад тохиолдолд санал авахаар зарласнаас өөр өдөр санал авсан; 21.1.2.санал авсан саналын хайрцаг болон зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгийг алдсан, үрэгдүүлсэн. 21.2.энэ хуулийн 21.1-д заасан үндэслэлээр сум, дүүргийн засаг даргын тамгын газар хэсэгт явуулсан санал хураалтыг хүчингүйд тооцно. 21.3.энэ хуулийн 21.2-т заасны дагуу хэсэгт явуулсан санал хураалтыг хүчингүйд тооцвол энэ тухай шийдвэр гарснаас хойш долоо хоногийн дотор дахин санал хураалт явуулна. 21.4.санал хураалтыг хэсгийн хэмжээгээр хүчингүйд тооцсон бол тухайн хэсгийн нийт иргэнийг, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар авсан саналыг хүчингүйд тооцсон бол уг саналын хайрцагт саналаа өгсөн иргэнийг дахин санал хураалтад оролцуулна.	**Арван гуравдугаар булэг** **Санал хураалт дахин явагдах** **103 дугаар зүйл.хэсэгт явуулсан санал хураалтыг хүчингүйд тооцох** 103.1.доор дурдсан зөрчил сонгуулийн дүнд ноцтойгоор нөлөөлөхөөр бол зөрчил гарсан хэсгийн санал хураалтыг хүчингүйд тооцно: 103.1.1.гамшиг болон аюул тохиолдсон зэрэг хүндэтгэн үзэх шалтгаангүй байхад урьд нь зарласнаас өөр байранд санал авсан; */энэ заалтад 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/* 103.1.2.хуульд зааснаас өөр өдөр санал авсан; 103.1.3.санал авсан зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгийг алдсан, үрэгдүүлсэн, хуульд заасан цагаас өмнө нээсэн; 103.4.дараах байгууллага хэсгийн санал хураалтыг хүчингүйд тооцно: 103.2.санал хураалтыг дараах хэмжээгээр хүчингүйд тооцно: 103.2.1.хэсгийн хэмжээнд бүхэлд; 103.2.2.санал авах байранд авсан саналын хэмжээгээр; 103.2.3.зөөврийн битүүмжилсэн хайрцгаар авсан саналын хэмжээгээр.		
22 дугаар зүйл. Санал асуулгын нэгдсэн дүн гаргах, мэдээлэх 22.1.аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газраас санал асуулгын дүнг ирүүлснээс хойш хоёр хоногийн дотор сонгуулийн төв байгууллага уг дүнг нэгтгэж улсын их хуралд өргөн мэдүүлнэ.	**134 дүгээр зүйл.сонгуулийн нэгдсэн дүн мэдээлэх** */энэ зүйлийн гарчиг 2016 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/* ***(134 дүгээр зүйлийн гарчгийн "гаргах, суудал хуваарилах," гэснийг хассан)***		**7 дугаар зүйл. Хорооны бүрэн эрх** 7.2.5.ард нийтийн санал асуулгын нэгдсэн дүнг гаргаж, улсын их хуралд өргөн мэдүүлэх;

www.zii.gov.mn

Зургадугаар бүлэг **хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага, гомдол, маргаан шийдвэрлэх харьяалал, журам** **23 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль тогтоомж зөрчсөн тухай гомдол, маргааныг шийдвэрлэх харьяалал** 23.1.санал асуулгын тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, маргаан шийдвэрлэх харьяаллыг сонгуулийн тухай хуульд зааснаар шийдвэрлэнэ.	**Арван есдүгээр бүлэг хариуцлага** **165 дугаар зүйл.хариуцлага хүлээлгэх** 165.1.сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн этгээдэд энэ хуульд заасан захиргааны хариуцлага хүлээлгэнэ. 165.2.сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн төрийн албан хаагчид төрийн албаны тухай хуульд заасан сахилгын хариуцлага хүлээлгэнэ. 165.3.сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй бол гэм буруутай этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. 165.4.сонгуулийн хууль тогтоомж зөрчсөний улмаас бусдад эдийн болон эдийн бус хохирол учирсан бол гэм буруутай этгээдэд иргэний хууль, бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. 165.5.энэ хуульд заасан зөрчлийг шалгах, хянан шийдвэрлэх нь тухайн асуудлыг эрүүгийн байцаан шийтгэх журмаар шалгахад саад болохгүй.		

--o0o---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХЭЭЛЭН
www.nli.gov.mn

ГАДААДЫН ЗАРИМ ОРНУУДЫН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТӨРӨЛ

/Харьцуулсан лавлагаа/[1]

УДИРТГАЛ

Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газраас ирүүлсэн захиалгын дагуу Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахтай холбогдуулан “Гадаадын зарим орнуудын хуулийн этгээдийн төрөл” сэдэвт харьцуулсан лавлагаа хийж гүйцэтгэв. Энэхүү лавлагааны хүрээнд ХЗДХЯ-ны захиалга болон судалгааны багийн зүгээс судлах шаардлагатай гэж үзсэн Герман, ОХУ, АНУ, Унгар гэсэн орны эрх зүйн зохицуулалтыг тусгайлан авч үзэв.

Уг харьцуулсан лавлагааг гүйцэтгэхдээ захиалагчаас ирүүлсэн чиглэл буюу 1/ гадаадын улс орнууд ашгийн төлөө болон ашгийн төлөө бус байгууллагадаа ямар хуулийн этгээдийг оруулдаг эсэх талаар судалж, 2/ эдгээр хуулийн этгээдийн төрөлд шашин, хэвлэл мэдээлэл, төрийн бус байгууллага, нийтийн эрх зүйн хуулийн этгээд, соёл, боловсрол, сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн зэрэг байгууллагуудыг аль төрөлд хамааруулж улсын бүртгэлд бүртгэж байгаа эсэхийг харьцуулан судаллаа.

Харьцуулан судлах явцад захиалагчаас ирүүлсэн асуудлын агуулга нь зарим талаар хоорондоо давхцаж байгааг харгалзан захиалгаар ирүүлсэн 2 асуудлыг нэгтгэж гүйцэтгэсэн.

Энэхүү лавлагааг хийж гүйцэтгэхдээ харьцуулан судлах аргыг голлон ашигласан бөгөөд тухайн улсын хуулийн этгээдийн төрөл, хэлбэр, улсын бүртгэлтэй холбогдон үүссэн эрх зүйн зохицуулалтын үр нөлөөний талаар үнэлэлт, дүгнэлт хийгээгүй болно.

НЭГ. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс /цаашид “ХБНГУ” гэх/-ын тухайд ашгийн төлөө хуулийн этгээдийн төрөлд Хувьцаат компани, Хязгаарлагдмал хариуцлагатай компани, Ашгийн төлөө холбоо, Нөхөрлөл гэсэн хуулийн этгээдүүд хамаарч байна. Харин ашгийн төлөө бус хуулийн этгээдүүдэд Холбоо, Сан, Нийтийн эрх зүйн бусад хуулийн этгээдүүд мөн ашгийн бус чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Хязгаарлагдмал хариуцлагатай компани хамаарч байна.

1.1. Ашгийн төлөө байгуулагдсан хуулийн этгээд

Ашгийн төлөө байгуулагдсан хуулийн этгээдүүд гэдэгт ХБНГУ-ын Иргэний хууль болон бусад хуульд нарийвчлан тусгасан журмын дагуу байгуулагдсан төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлж, эрх зүйн чадвар бий болгосон ашгийн төлөө зорилгоор байгуулагдсан хуулийн этгээдийг хамааруулдаг. Ашгийн төлөө байгуулагдсан хуулийн этгээдийн төрөлд нийтлэг шинжээрээ тухайн байгууллагын дүрэмд заасан үйл ажиллагааны чиглэл, зорилгоо ашиг олох гэж тодорхойлсон байхыг ойлгоно.

[1] Тус лавлагааг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Зүмбэрэллхам удирдан, эрдэм шинжилгээний ажилтан Ж.Алтансүх, Б.Алтангэрэл, Ж.Бариаширсүрэн, Б.Сүнжидмаа нар хамтран гүйцэтгэв.

Эдгээр байгуулагад Хувьцаат компани, Хязгаарлагдмал хариуцлагатай компани, Ашгийн төлөө холбоо, Нөхөрлөл зэрэг байгууллагуудыг хамааруулдаг боловч хэвлэл мэдээлэл, соёл, боловсрол, сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн зэрэг хуулийн этгээдийн төрлүүдийн үүсгэн байгуулах баримт бичигт ашгийн төлөө гэж тодорхойлсон бол дээрх байгууллагууд ашгийн төлөө хуулийн этгээдийн төрөлд хамаарч болохоор байна. Ингээд ашгийн төлөө хуулийн этгээдүүдийн төрөл, хэлбэрийг дор товч авч үзье.

Компани

Хувьцаат компани /Aktiengesellschaft/

ХБНГУ-ын Компанийн тухай хуульд /(Aktiengesetz, AktG/ хувьцаат компаний эрх зүйн байдлыг тусгасан. Уг хуульд тусгасанчлан хувьцаат компани байгуулахын тулд үүсгэн байгуулагчид 50 мянган еврогийн нэрлэсэн үнэ бүхий хөрөнгөтэй байх шаардлагатай. Хувьцаа эзэмшигчид компанийн үйл ажиллагаанд өөрийн эзэмшиж байгаа хувьцааны үндсэн дээр оролцдог. Хувьцаат компани Хөрөнгийн биржид бүртгүүлснээр эрх зүйн чадвартай болдог.[2]

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

ХХК гэдэгт хувьцаа эзэмшигчид өөрийн хувь нийлүүлсэн хөрөнгөөрөө хариуцлага хүлээдэг, эрх зүйн чадвар бүхий хуулийн этгээдийг ойлгодог. Энэ нь хуульд заасан баримт бичгийн бүрдлийг хангасны үндсэн дээр харьяа шүүхэд бүртгүүлснээр эрх зүйн чадвартай болдог. ХБНГУ-ын Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн тухай хуульд /GmbH-Gesetz/ зааснаар ХХК байгуулахдаа нэг ба түүнээс дээш үүсгэн байгуулагчид байх бөгөөд доод тал нь 25000 еврогийн анхны хөрөнгө оруулалт хийгдсэн байх шаардлагатай. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн гүйцэтгэх удирдлагыг томилж, чөлөөлөх эсэхийг шийдвэрлэдэг.

Охин компани (Subsidiary)

Охин компани гэдэг нь толгой компаниас тусдаа үйл ажиллагаа явуулдаг. Энэ нь үйл ажиллагаа явуулахдаа менежмент, нягтлан бүртгэлийн тогтолцоо, үйл ажиллагааны тайлан, хөрөнгийн хувьд толгой компаниас тусдаа чиг үүрэг хэрэгжүүлдэг байдлаараа онцлогтой.

Салбар компани Zweigniederlassung (Branch)

Салбар компанийн хувьд толгой компаниас хараат бусаар үйл ажиллагаа явуулах эрхгүй бөгөөд толгой компаний удирдлага, хяналт дор үйл ажиллагаагаа эрхэлдэг. Энэхүү хуулийн этгээд нь охин компаниас гол ялгагдах шинж нь салбар компанид өөрийн гэсэн хөрөнгө байхгүй ба нягтлан бүртгэлийн тогтолцоо байдаггүй. Мөн тухайн компанийг компанийн бүртгэлд бүртгүүлдэггүй зэрэг онцлог шинжээрээ ялгагддаг.[3]

[2] https://www.justlanded.com/english/Germany/Articles/Business/German-company-types

[3] http://www.lawyersgermany.com/types-of-companies-in-germany

Ашгийн төлөө холбоо

ХБНГУ-ын Иргэний хуулийн 22 дугаар зүйлд ашгийн төлөө холбоог байгуулах үндэслэл журмыг тусгасан. Уг зүйлд “ашгийн төлөө холбоо” нь ашиг олох чиглэлээр үйл ажиллагаа явуулах бөгөөд холбооны улсын холбогдох хууль тогтоомжид тусгалаа олоогүй бол төрийн зүгээс тусгайлан эрх олгох замаар эрх зүйн чадамжтай болно. Тусгайлан олгох эрхийг түүний байрлах муж улс олгоно.

Нөхөрлөл

Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл Kommanditgesellschaft (KG) (Limited partnership)

Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл байгуулахын тулд доод тал нь 50 мянган евро бүхий хөрөнгийн эх үүсвэр шаардагддаг. Хуулийн этгээдийн энэхүү төрлийг бүртгэхдээ үүсгэн байгуулах баримт бичгийг нотариатаар батлуулан, Худалдааны бүртгэлд бүртгүүлдэг. Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн онцлог шинж бол нөхөрлөлийн нэг гишүүн нь уг хуулийн этгээдийг бүрэн төлөөлөх эрхтэй ба нөхөрлөлтэй холбогдон үүсэх хариуцлагыг бүрэн хариуцдагаараа онцлогтой.

Бүх гишүүд бүрэн хариуцлагатай нөхөрлөл /General partnership)

Энэхүү хуулийн этгээдийн төрлийн хувьд нөхөрлөлд хамаарах гишүүнд ямар нэгэн хариуцлагын хязгаарлалт тогтоодоггүй. Өөрөөр хэлбэл нөхөрлөлийн гишүүн бүр байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцохын сацуу нөхөрлөлийн үйл ажиллагаанаас гарах хариуцлагыг хамтран хүлээдэг. Нөхөрлөлийг хоёроос доошгүй гишүүнтэйгээр Худалдааны бүртгэл /Commercial Register and the Trade Register/-д бүртгүүлснээр эрх зүйн чадвартай болдог.

Дээрхээс үзэхэд ашгийн төлөө хуулийн этгээдүүд нь нийтлэг шинжээрээ ХБНГУ-ын Иргэний хууль болон бусад хуульд нарийвчлан тусгасан журмын дагуу байгуулагдсан төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлж эрх зүйн чадвар бий болгосон ашгийн төлөө зорилгоор байгуулагдсан хуулийн этгээдийг хамааруулдаг байна. Эдгээр хуулийн этгээдүүдийн бүртгэлийн тухайд харьяа шүүхэд / Хязгаарлагдмал хариуцлагатай компани, Ашгийн төлөө холбоо зэрэг/ бүртгүүлснээр эрх зүйн чадвартай болдог боловч зарим хуулийн этгээдийн онцлог шинжээс нь шалтгаалан Хөрөнгийн биржид бүртгүүлэх /Хувьцаат компани/, Худалдааны бүртгэлд бүртгүүлэх /Нөхөрлөл/ үүргийг хууль тогтоомжид тусгажээ.

1.2. Ашгийн төлөө бус байгуулагдсан хуулийн этгээд

Ашгийн төлөө бус байгуулагдсан хуулийн этгээд гэдэг нь ХБНГУ-ын Иргэний хууль болон бусад холбогдох хуульд тусгасан журмын дагуу байгуулагдсан, төрөөс хараат бусаар үйл ажиллагаагаа явуулдаг, ашиг олох зорилгогүй, өөрийн бие даасан удирдлага зохион байгуулалттай мөн хувийн эрх зүйн хуулийн этгээдүүдийн санхүүжилтээр санхүүжигдэх этгээдийг ойлгоно. Ашгийн төлөө бус чиглэлээр хуулийн этгээд байгуулахын ач холбогдол нь нийтийн сайн, сайхны тусын тулд үйл ажиллагаа явуулах ба төрөөс тавьж буй татвараас чөлөөлөгдөх онцлогтой.[4] Эдгээрийг дор товч авч үзье.

[4] Peter Rawert and Janne Gartner, Nonprofit organization in Germany: Permissible Forms and Legal Framework, 1.

Холбоо

Ашгийн төлөө бус холбоо /Verein/

ХБНГУ-ын Иргэний хуулийн 21 дүгээр зүйлд "Ашгийн төлөө бус холбоо нь анхан шатны шүүхийн дэргэдэх холбооны бүртгэлд бүртгэгдсэнээр эрх зүйн чадамжтай болно." гэж тусгажээ. Энэхүү холбоо нь бүх гишүүдийн хурлаас сонгогдсон гишүүд ба төлөөлөх удирдлагатай байна /27 дугаар зүйл/. Холбоог байгуулахын тулд 1/ доод тал нь 7 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр дүрмээ батлах; 2/ бүх гишүүдийн хурлаар гүйцэтгэх удирдлагаа сонгосон байх; 3/ үүний дараа харьяалах шүүхэд бүртгүүлсэн байх шаардлагатай. Холбооны үйл ажиллагаа явуулах дээрх шалгууraас гадна "арилжаа, бизнесийн чиглэлээр үйл ажиллагаа" явуулахгүй байх шаардлагатай.[5]

Эрх зүйн чадамжгүй холбоо /nicht-eingetragene Vereine/

Эрх зүйн чадамжгүй холбооны хувьд хамтран ажиллах гэрээний зохицуулалт үйлчилнэ. Энэ холбооны нэрийн өмнөөс гуравдагч этгээдтэй хэлцэл хийсэн этгээд хариуцлага хүлээнэ, хэлцлийг хэд хэдэн этгээд хийсэн бол хамтран үүрэг гүйцэтгэгчийн хувиар хариуцлага хүлээнэ. /54 дүгээр зүйл/

Сан

Хуулийн этгээдийн эрхтэй сан

ХБНГУ-ын Иргэний хуулийн 80-88 дугаар зүйлд хуулийн этгээдийн эрхтэй сангийн эрх зүйн байдлыг тусгажээ. Энэ хуульд зааснаар сангийн үйл ажиллагаа ашгийн төлөө бус байх бөгөөд сангийн зорилго нь нийтийн эрх ашигт харшлахгүйгээр үйл ажиллагаа явуулах ба энэ зорилгыг урт хугацаанд тогтвортой явуулах /10 жил/ шалгуурыг хангасан байх гэсэн шаардлагыг тусгажээ. Санг байгуулахад үүсгэн байгуулагчийн суурь хэлцэл, сангийн оршин байх газрын эрх бүхий төрийн байгууллагын хүлээн зөвшөөрсөн акт шаардлагатай /approval by the state supervisory authority/ /80 дугаар зүйл/. Сан байгуулах хэлцлийг бичгээр хийнэ. Үүнд хандивлагчийн зүгээс хөрөнгөө сан байгуулах зорилгоор ашиглах тухай хуулийн хүчин төгөлдөр хүсэл зоригийн илэрхийллийг тусгана. Сан байгуулах хэлцлээр сангийн дүрмийг батлах ба үүнд, 1/ сангийн нэр; 2/ сангийн байрлах газар; 3/ сангийн зорилго; 4/ сангийн хөрөнгө; 5/ сангийн удирдлагыг тодорхойлно. Хуулийн этгээдийн эрхтэй сангийн чиглэлээр сүмийн дэргэд үйл ажиллагаа явуулж байгаа сангууд үйл ажиллагаа явуулж байна.

Хуулийн этгээдийн эрхгүй сан

Хуулийн этгээдийн эрхгүй сангийн эрх зүйн байдлыг хуульд нарийвчлан тодорхойлоогүй. Энэхүү төрлийн харилцаа нь үүсгэн байгуулагч болон бусад этгээдийн хооронд /Rechtstrager/ бэлэглэлийн гэрээний онцлог зохицуулалтаар зохицуулагддаг. Хуулийн этгээдийн эрхгүй санг байгуулахын тулд төрийн эрх бүхий байгууллагын оролцоо /зөвшөөрөл/ шаардагдахгүй бөгөөд анхны хөрөнгө оруулалт /хандив/ шаардагдахгүй.

Хуулийн этгээдийн эрхгүй сангийн эрх зүйн байдлын талаар хуульд тодорхой тусгаагүйн улмаас цаашид энэхүү хуулийн этгээдийн эрх зүй чадварын асуудал мөн гишүүдийн хооронд үүсэх эд хөрөнгийн маргаантай асуудлыг хэрхэн зохицуулах талаар эрх зүйн зохицуулалт дутмаг байдаг.

[5] http://www.usig.org/countryinfo/PDF/Germany.pdf

Сангуудын төрөл хэлбэрийн тухайд гэр бүлийн сан, компанийн дэргэд байгуулагдсан сан, буяны сан зэрэг хэлбэрээр байгуулагдах ба эдгээрийн холимог хэлбэрээр ч бас үйл ажиллагаагаа явуулдаг байна.[6]

Нийтийн эрх зүйн хуулийн этгээд

Иргэний хуулийн 89 дүгээр зүйлд нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд нийтийн эрх зүйн бусад субъектүүд, сан зэрэг байгууллагуудыг хамааруулахаар тусгажээ. Энэхүү хуулийн этгээдийн төрөлд нийтийн эрх ашгийг үйл ажиллагааны зорилгоо болгосон буюу нийтийн эрх зүйн чиглэлээр үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдүүдийг хамруулахаар тусгасан.

Практикт нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй шашны байгууллагуудыг хамруулж байна. Шашны байгууллагуудын бүртгэлийн тухайд шашны үйл ажиллагаа явуулж байгаа этгээдүүдэд заавал бүртгүүлсэн байх шаардлагыг тавьдаггүй боловч шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулахдаа татварын хөнгөлөлт эдлэх зорилгоор Ашгийн төлөө бус хуулийн этгээд болон Нийтийн эрх зүй хуулийн этгээдийн төрөл хэлбэрээр бүртгүүлдэг.[7]

Хязгаарлагдмал хариуцлагатай компани /буяны үйлсэд суурилсан/

Хязгаарлагдмал хариуцлагатай компани /цаашид “ХХК” гэх/ гэдэгт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг эрх зүйн чадвар бүхий хуулийн этгээдийг ойлгодог. Орчин үед энэхүү хандлага өөрчлөгдөж ашгийн төлөө бус чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ХХК-ийн төрөл хэлбэр бий болж байна. Тухайлбал, зарим томоохон аж ахуйн нэгжүүд өөрийн үндсэн үйл ажиллагааны хажуугаар буяны болон нийтийн сайн сайханд чиглэсэн үйл ажиллагаа явуулахын тулд энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулах салбар ХХК байгуулдаг. Практикт дээр гол төлөв буяны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг холбоо, сангийн дэргэд хавсарга байдлаар салбар компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна.[8]

Дээрхээс үзэхэд ашгийн төлөө бус хуулийн этгээдүүд гэдэг нь нийтлэг шинжээрээ ХБНГУ-ын Иргэний хууль болон бусад хуульд тусгасан журмын дагуу байгуулагдсан, төрөөс хараат бусаар үйл ажиллагаагаа явуулдаг, ашгийн төлөө бус зорилготой, өөрийн бие даасан удирдлага зохион байгуулалттай этгээдийг ойлгоно. Түүнчлэн ашгийн төлөө бус чиглэлээр хуулийн этгээд байгуулахын ач холбогдол нь нийтийн сайн, сайхны тусын тулд үйл ажиллагаа явуулдаг онцлогоос хамааран төрөөс тавьж буй татвараас чөлөөлөгддөг онцлогтой байна. Эдгээр хуулийн этгээдүүдийн бүртгэлийн тухайд анхан шатны шүүхийн дэргэдэх холбооны бүртгэлд бүртгэгдсэнээр эрх зүйн чадамжтай болдог.

Хэвлэл мэдээлэл, соёл, боловсрол, сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн зэрэг хуулийн этгээд нь тухайн байгууллагын дүрэмд заасан үйл ажиллагааны зорилго, чиглэлээс хамааран ашгийн төлөө болон ашгийн төлөө бус байгууллагын аль ч төрөлд хамаарч болохоор байна. Харин шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдийн тухайд ашгийн төлөө бус төрөлд хамааруулан бүртгэдэг байна.

---

[6] http://www.corporate-law.eu/en/germany/foundation/

[7] https://www.state.gov/documents/organization/171696.pdf, page 3.

[8] http://www.usig.org/countryinfo/PDF/Germany.pdf

ХОЁР. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

Оросын холбооны улс /цаашид “ОХУ” гэх/-д Хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг “Иргэний хууль” болон бусад салбарын хуульд зохицуулан тусгасан.

ОХУ-ын “Иргэний хууль”-ийн 48 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт зааснаар Хуулийн этгээдийн ойлголт нь “Өөрийн тусгайлсан хөрөнгөтэй, тухайн үйл ажиллагаанаас үүдэх хариуцлагыг өөрийн оруулсан хөрөнгөөрөө хариуцдаг, өөрийн нэрээр эрх олж авч, иргэний эрх эдэлж, үүрэг хүлээдэг, шүүхэд хариуцагч болон нэхэмжлэгчээр оролцох зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд” гэж тодорхойлсон байна.

2.1. Ашгийн төлөө байгуулагдсан хуулийн этгээд

ОХУ-ын Иргэний хуулийн 50 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт тусгаснаар “Хуулийн этгээд өөрийн үйл ажиллагаандаа ашиг олохыг үндсэн зорилго болгосон эрх зүйн этгээдийг ашгийн төлөө байгууллага гэж тодорхолсон. Ашгийн төлөө байгуулагдсан хуулийн этгээдийн төрөлд Компани, Нөхөрлөл, Тариалангийн /фермер/ аж ахуй, Аж ахуйт нөхөрлөл, Үйлдвэрлэлийн хоршоолол, Улсын болон нутгийн захиргааны нэгдмэл аж үйлдвэрийн газар хамаарна /50.2 дугаар хэсэг/. Дээр дурдсан ашгийн төлөө хуулийн этгээдүүдийн төрөл, хэлбэрийг дараах байдлаар авч үзэе.

Компани

Хязгаарлагдмал хариуцлагатай компани /общество с ограниченной ответственностью/

Хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/ гэдэг нь компанийн үйл ажиллагаатай холбогдсон алдагдлыг хөрөнгөөрөө хариуцах чадвартай, нэг болон хэд хэдэн хувь хүн, хуулийн этгээдээр байгуулагдсан байна. Өөрийн оруулсан хувь хэмжээнд ногдох ашиг хүртэх, үйл ажиллагааны үндсэн зорилгоо ашгийн төлөө гэж тодорхойлсон, хуулийн этгээдийн зохион байгуулалтын нэгдлийг хэлнэ гэж заасан байна. ХХК-н доод тал нь 1, дээд тал нь 50 оролцогчдоос хэтрэхгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулах ба түүний оролцогчид нь эрх зүйн чадамжтай байна.

ХХК нь 1 жилийн хугацаанд хувьцаат компаниар өөрчлөн байгуулж болно. Харин энэ хугацаа дуусахаар, заасан гишүүнчлэлийн тооны шаардлагад нийцүүлэхгүй бол шүүхийн журмаар татан буулгана. ХХК нь хувьцаа эзэмшигчдийн нэгдсэн шийдвэрээр сайн дурааараа татан буух, дахин байгуулж болно гэж заасан байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гүйцэтгэх байгууллагын шийдвэрээр эсхүл хууль тогтоомжид заасан эрх бүхий төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагын саналаар шүүхээс татан буулгах эрх зүйн зохицуулалтыг тусгажээ. ХХК-г “Хувиараа бизнес эрхлэгч, хуулийн этгээдийн улсын бүртгэл”/О государственной регистрации юридических лиц и индивидуальных предпринимателей/-ийн тухай хуульд заасны дагуу хуулийн этгээдийн улсын бүртгэлийн эрх бүхий байгууллага /Единый центр регистрации/ бүртгэдэг.

Хувьцаат компани /акционерное общество/

Хувьцаат компанийн эрх зүйн байдал, хувьцаа эзэмшигчдийн эрх үүргийг Иргэний хууль болон хувьцаат компанийн тухай хуулиар тодорхойлно. Хувьцаат компани нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулинд заасан журмын дагуу улсын бүртгэлд оруулсан үеэс эрх зүйн чадамжтай гэж тооцно. Хувьцаат

компани нь аж ахуйт компани /хозейственное общество/ мөн ба түүний дүрэмд заасан хөрөнгийг хувьцааны тодорхой тоонд хувиарладаг_байдлаар тусгасан. Компанийн хувь эзэмшигчид үйл ажиллагаанаас гарсан алдагдлыг хүлээж, харин хариуцлага үүрэхгүй. Хувьцаат компани нь дүрэмдээ хөрөнгийн доод хэмжээг 10000 рубли байхаар тусгасан.[9] Компанийн үүсгэн байгуулагчид нь тухайн компанийн улсын бүртгэлд бүртгэх хүртэл асуудлыг хамтын байдлаар үүрэг хүлээдэг. Энэ талаарх мэдээллээ хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нэгдсэн сан /Единый государственный реестр юридических лиц/-д оруулна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай холбооны хуульд заасан журмын дагуу хуулийн этгээдийн улсын бүртгэл явуулах байгууллага /Единый центр регистрации/ улсын бүртгэл хөтлөн явуулна /Иргэний хуулийн 96-104 дүгээр зүйл/.[10]

Нөхөрлөл /товарищества/

Нөхөрлөл /хамтрал/ нь өөр, өөрсдийн эд хөрөнгө эзэмшигчдийн нэгдмэл харилцаанд суурилсан бизнесийн үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэр юм. Нөхөрлөл байгуулахдаа 2 буюу түүнээс дээш этгээд хөрөнгө оруулах ба үйлдвэрлэл, үйлчилгээгээ хамтран удирдаж, үүсгэн байгуулсан аж ахуйн нэгжээ хамтран эзэмшиж, олсон ашиг орлогоо хуваан, хариуцлагаа хамтран хүлээдэг. Ихэнх тохиолдолд нөхөрлөл нь өөрийн хөрөнгөөсөө шалтгаалан том, жижиг хэмжээний бизнес эрхэлдэг.

Нөхөрлөл нь дотроо бүрэн болон итгэлцлийн нөхөрлөл гэж ангилагдана. Бүрэн нөхөрлөл нь илүү өргөн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг ба татварын хэмжээнээс шалтгаалан фирмийн үйл ажиллагааны хариуцлагыг оролцогчид нь хариуцан, үйлчилгээ явуулах хүрээгээр бүрэн нөхөрлөлийн статус тодорхойлогдоно /хуулийн, аудитор болон анагаахын гэх зэрэг/.[11]

Итгэлцлийн нөхөрлөл нь өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээн, нөхөрлөлийн нэрийн өмнөөс үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулдаг хэд хэдэн оролцогчтой байхаар заасан /Иргэний хуулийн 82 дугаар зүйл/. Бүрэн болон итгэлцлийн нөхөрлөлийн улсын бүртгэлийг Хуулийн этгээдийн улсын нэгдсэн сан /Единый государственный реестр юридических лиц/-д бүртгэнэ.

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл /О средствах массовой информации/

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл гэдэгт олон нийтийн үзэгчдэд зориулан мэдээлэл, түгээх, боловсруулах, цуглуулах өдөр тутмын үйл ажиллагааны хэрэгслийг ойлгодог.

Тогтмол хэвлэх хэвлэл: жилд нэгээс доошгүй удаа сэтгүүл, сонин, радио суваг, нэвтрүүлэг, баримтат кино, хэвлэл зэргийг гаргана. Тус хуулийн 3 дугаар бүлэг “Олон нийтийн мэдээллийг түгээх” гэдэгт төрийн байгууллага, бусад байгууллага, албан газар, аж ахуйн нэгж, эрх бүхий этгээд, иргэний холбоо, иргэдийн зүгээс олон нийтийн мэдээллийн хэрэгслийг хуулийн дагуу түгээн дэлгэрүүлэхэд саад учруулж үл болно гэж заасан. Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тухай хуульд хэвлэл мэдээллийн байгууллага нь ашгийн эсхүл ашгийн бус гэж ялгамжтай заагаагүй байна. Хэрвээ олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэл гаргуулахдаа төлбөр төлсөн бол ашгийн төлөө гэж үзнэ /Тодруулбал: Амьдралд ашгийн бус үйл ажиллагаа явуулдаг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл байхгүй байна/. Олон

[9] http://docs.cntd.ru/document/901702323

[10] http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_8743/9ef980dcd49e7461a063f6d5858a38086e6a52a8/

[11] ГК РФ статья 69-86

нийтийн мэдээллийн хэрэгслийг мэдээлэл, технологи, холбоо, олон нийтийн харилцааг хянах холбооны алба /Федеральная служба по надзору в сфере связи, информационных технологий и массовых коммуникаций [12](Роскомнадзор)/ бүртгэдэг.

2.2. Ашгийн төлөө бус байгуулагдсан хуулийн этгээд

Ашгийн төлөө бус байгууллагыг Иргэний хууль, бие даасан ашгийн төлөө бус байгууллагын тухай хуулиар зохицуулдаг. Ашгийн төлөө бус байгууллага гэдэгт үүсгэн байгуулагчид олсон ашиг, орлогоос хувь оногдуулахгүй ба үйл ажиллагааны үндсэн зорилгоо ашиг орлого олох бус буюу нийтийн сайн сайхан байдлын төлөө үйл ажиллагаа явуулдаг байгууллагыг ойлгоно. Өөрөөр хэлбэл ашгийн бус байгууллагыг нийгмийн сайн сайханд чиглэсэн зорилгоор нийгэм, буяны үйл ажиллагаа, соёл, боловсрол, улс төр, шинжлэх ухаан болон бусад чиглэлээр байгуулж болно.

Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төрөлд Хэрэглэгчдийн хоршоолол, Олон нийтийн байгууллага, Холбоо, Сан, Үл хөдлөх хөрөнгө өмчлөгчдийн нөхөрлөл, Казахын нийгэмлэг, Нутгийн цөөнх уугуул иргэдийн нийгэмлэг, Өөртөө засах / автономная/ ашгийн бус байгууллага, шашны байгууллага, олон нийтийн эрх зүйн компани, өмгөөлөгчдийн танхим, нотариатчдын танхим зэргийг авч үздэг байна.

Холбоо /Ассоциация/

Холбоо гэдэг нь иргэн, хуулийн этгээдийн сайн дурын үндсэн дээр нэгдсэн, ашгийн төлөө бус үйл ажиллагааны зохион байгуулалтын нэгдлийг ойлгодог. Холбооны үйл ажиллагаа Иргэний хууль, Ашгийн төлөө бус байгууллагын тухай хуулиар зохицуулагддаг. Холбооны үүсгэн байгуулагчид нь 2-оос доошгүй байна. Зарим төрлийн холбооны эрх зүйн байдлын онцлогийг тусгасан хуульд холбооны үүсгэн байгуулагчдын тооны хязгаарлалт тогтоосон байж болно /Иргэний хуулийн 123.9 дүгээр хэсэг/

Холбоо нь гишүүдийн шийдвэрээр олон нийтийн байгууллага, бие даасан ашгийн бус байгууллага, сангийн хэлбэрээр дахин байгуулагдаж болно. Холбооны захиргааны дээд байгууллага нь гишүүдийн нийт хурал байна. Холбооны гишүүн нь гишүүнчлэлийн хураамж дүрэмд заасан нөхцөлөөр төлөх үүрэг хүлээх ба холбооны дээд байгууллагын шийдвэрээр нэмэлт эд хөрөнгө хураалгана гэж тусгасан байна. / Иргэний хуулийн 123.11.2 дугаар зүйл/

Сан /Фонд/

Сан гэдэг нь нийтэд ашиг тустай зорилгоор нийгэм, боловсрол, соёл, буяны үйл ажиллагаанд чиглэсэн, хөрөнгийн сайн дурын татварын үндсэн дээр иргэд, хуулийн этгээдийн гишүүнчлэлгүй байгуулсан ашгийн бус нэгдмэл байгууллагыг хэлнэ. Үүсгэн байгуулагчдын санд шилжүүлсэн хөрөнгө нь сангийн өмчлөлд байна. Сангийн дүрмэнд дараах мэдээллийг тусгасан байна. Үүнд: 1. Сангийн нэр, 2. Сангийн байрлах газар, 3. Сангийн үйл ажиллаагааны зорилго, чиглэлийг тодорхой тусгасан байна. Сангийн дүрэмдээ тусгасан зорилгоор эд хөрөнгөө ашиглах ба жил бүр хөрөнгийн тайлан, баланс гаргах үүрэг хүлээнэ гэж заасан байна. Санг татан буулгахдаа гагцхүү сонирхогч этгээдийн өргөдлийн үндсэн дээр шүүх татан буулгах шийдвэр гаргадаг. [13] /Иргэний хуулийн 123.17 дугаар зүйл/

[12] http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_1511/

[13] ОХУ-ын Иргэний хууль, 123.17-123.20 дугаар зүйл

Хэрэглэгчдийн хоршоолол /потребительский кооператив/

Хэрэглэгчийн хоршоолол нь үүсгэн байгуулагчдын дотоод хэрэгцээг хангах зорилгоор иргэн, хуулийн этгээдийн сайн дураараа нэгдсэн гишүүнчлэлийн нэгдлийг ойлгодог /Иргэний хуулийн 123.2 дугаар зүйл/. Хэрэглэгчийн хоршооллын дүрэмд заасанчлан хоршооллын гишүүдийн хувь /ноогдол/, хоршооллын гишүүдийн хувь хүний татварын хэмжээний нөхцөл / условия о размере паевых взносов членов кооператива/, үйл ажиллагааны зорилго, хүлээх хариуцлага, оршин байгаа газар, нэрийг тусгасан байх шаардлагатай. Хэрэглэгчийн хоршоолол нь гишүүдийн шийдвэрээр олон нийтийн байгууллага, холбоо, сан, бие даасан ашгийн бус байгууллагад дахин байгуулагдаж болно. Орон сууц, барилгын хоршоолол нь гишүүдийн шийдвэрээр үл хөдлөх хөрөнгө эзэмшигчдийн нөхөрлөлд дахин байгуулагдаж болно гэж заасан байна.

Олон нийтийн байгууллага /Общественная организация/

Хуульд харшилсан үйл ажиллагаа явуулахгүйгээр нийтийн эрх ашгийг төлөөлөх, хамгаалахад оюун санааны болон бусад материаллаг бус хэрэгцээг хангахаар нийтлэг сонирхлын үндсэн дээр хууль журмын дагуу нэгдсэн иргэний сайн дурын нэгдлийг олон нийтийн байгууллага гэнэ. Олон нийтийн байгууллага нь өөрийн өмчлөлийн эд хөрөнгөтэй байж болно. Олон нийтийн байгууллага нь энэ хуулиар тогтоосон журмын дагуу холбоонд нэгдэх болон тэдний оролцогчдын шийдвэрээр сан эсвэл бие даасан ашгийн бус байгууллагын холбоогоор өөрчлөн байгуулагдаж болно. Олон нийтийн байгууллагын үүсгэн байгуулагчдын тоо гурваас доошгүй байх ба түүний оролцогчдын эрхийг бусад этгээдэд шилжүүлж болохгүй. Олон нийтийн байгууллагын оролцогч өөрийн саналаар энэхүү байгууллагаас гарах эрхтэй ба тус байгууллагад оролцогчийн эрхээ бусдад дамжуулахыг хязгаарладаг. Олон нийтийн ашгийн бус байгууллагыг /Үүнд: олон нийтийн хөдөлгөөн хамаарна/ ОХУ-ын Хууль зүйн яамны дэргэдэх “Бүртгэлийн алба”-д бүртгүүлнэ.[14]

Олон нийтийн хөдөлгөөн **/Общественные движения/** гэдэг нь олон нийтийн оролцогчдын дэмжлэгтэйгээр улс төр, нийгмийн хүрээн дэх олон талын асуудлаар дуу хоолойгоо нэгтгэсэн, гишүүнчлэлгүй иргэний нийгмийн нэгдлийг олон нийтийн хөдөлгөөн гэнэ. /Иргэний хуулийн 123.7 дугаар зүйлд/ ОХУ-ын олон нийтийн хөдөлгөөний эрх зүйн байдлыг “Олон нийтийн нэгдэл”-ийн тухай хуулиар зохицуулна. Энэхүү хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу “Олон нийтийн хөдөлгөөн”-ийг бүртгүүлснээр эрх зүйн чадамжтай болно гэж хуульчилсан /олон нийтийн хөдөлгөөнийг бүртгүүлж бас бүртгүүлэхгүй байж болно/ байна.

Өмгөөллийн танхим /Адвокатские палаты/

Иргэний хуулийн 123.16-1-д Өмгөөллийн танхим гэдэгт өмгөөлөл, өмгөөллийн үйл ажиллагааны тухай хуульд заасан зорилгыг хэрэгжүүлэхэд ОХУ-ын өмгөөллийн холбооны танхим эсхүл субъектийн өмгөөллийн танхимын төрлөөр байгуулагдсан, гишүүнчлэлийн үүрэгтэй, ашгийн бус байгууллагыг хүлээн зөвшөөрнө гэж тусгасан.

ОХУ-ын субъектийн өмгөөллийн танхим нь ОХУ-ын субъектийн бүх өмгөөлөгчдийг гишүүнчлэлийн үүрэг хүлээлгэсэн ашгийн бус байгууллага байна.

ОХУ-ын өмгөөлөгчдийн холбооны танхим нь гишүүнчлэлийн үүрэг хүлээлгэн ОХУ-ын субъектүүдийн өмгөөллийн танхимд нэгдсэн ашгийн бус байгууллага байна гэж тус тус тодорхойлжээ. ОХУ-ын өмгөөллийн холбооны танхим, субъектийн

[14] http://www.barrit.ru/price/10.html

өмгөөллийн танхимын үйл ажиллагааны эрх зүйн байдлыг “Өмгөөлөл, өмгөөллийн үйл ажиллагаа”-ны тухай хуулиар тодорхойлдог.

Өмгөөлөгчдийн танхим нь өөрийн нэрээр өмгөөлийн үйл ажиллагаа явуулахгүй, харин зохион байгуулах үйл ажиллагаа эрхэлнэ.[15] /Адвокатская палата не может осуществлять адвокатскую деятельность от своего имени и заниматься предпринимательской деятельностью/

Өмгөөллийн танхим нь дараах зорилгыг агуулсан байна. Үүнд:

- Мэргэшсэн хууль зүйн туслалцааг иргэдэд хүртээмжтэй, үнэ төлбөргүй үзүүлэхийг зохион байгуулах, хангах,
- Олон нийтийн холбоо, орон нутгийн өөрөө удирдах байгууллага, бусад байгууллага, төрийн эрх бүхий байгууллагын өмгөөлөгчийн ашиг сонирхлыг хамгаалах, төлөөлөх
- Өмгөөллийн үйл ажиллагааг явуулахаар зөвшөөрсөн мэргэжлийн бэлтгэл хүмүүст хяналт хийх.

Өмгөөллийн танхимын дээд байгууллага нь өмгөөлөгчдийн хурал байх ба энэхүү хурал нь эрх зүйн чадамжтай байж жилд нэгээс доошгүй удаа хуралдана.

Өмгөөлөгчдийн танхимыг хуулийн этгээдийн нэгдсэн улсын бүртгэлд бүртгэнэ.

Шашны байгууллага болон сүсэг бишрэлийн эрх чөлөө /о свободе совести и о религиозных объединениях/

Шашны байгууллага болон сүсэг бишрэлийн эрх чөлөөний тухай хууль нь ОХУ-ын Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль, эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад актаар зохицуулна. ОХУ-ын “Иргэний хууль”-ийн хуулийн этгээдийн ангилалд бие даасан ашгийн бус байгууллага байна гэж заажээ.[16] Шашны байгууллагыг хувиараа бизнес эрхлэгч, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар бүртгэнэ.

Шашны байгууллага нь 2 хэлбэрээр байгуулагдана. Үүнд:

1. Шашны бүлэг[17] /улсын бүртгэлд бүртгэгдээгүй, гэхдээ эрх зүйн чадамжтай хуулийн этгээд/
2. Шашны байгууллага /хуулийн этгээдээр бүртгэгдсэн/

Шашны байгууллагын үүсгэн байгуулагч нь шашны байгууллагад шилжүүлсэн эд хөрөнгөндөө өмчлөх эрхээ хадгалахгүй гэж тодорхойлжээ.[18]

Шашны байгууллагыг “Хувиараа бизнес эрхлэгч, хуулийн этгээдийн улсын бүртгэл”-ийн тухай хуулиар зохицуулан Хууль зүйн яам бүртгэж, эрх бүхий гүйцэтгэх байгууллага хяналт тогтоодог.[19]

ГУРАВ. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

Америкийн нэгдсэн улсын Вашингтон мужид хуулийн этгээдийг байгуулж буй зорилго, үйл ажиллагааны чиглэлээс хамаарч ашгийн төлөө /бизнесийн/ болон ашгийн төлөө бус байгууллага гэж авч үзэж байна. Тус мужид ашгийн төлөө хуулийн этгээдийн төрөлд Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани (ХХК), Корпораци, Массачусетсийн Траст, Ерөнхий Нөхөрлөл, Хязгаарлагдмал Нөхөрлөл (ХН),

[15] http://sir35.narod.ru/Legal_agency/Attorney_chamber_22093.html

[16] ОХУ-ын “Иргэний хууль”, 123.27 дугаар зүйл, Орон нутгийн шашны байгууллагын залбирагч 10-аас доошгүй байна.

[17] ОХУ-ын “Шашны байгууллага, сүсэг бишрэлийн эрх чөлөө”-ний тухай хууль, 7 дугаар зүйл,

[18] ОХУ-ын “Иргэний хууль”, 123.28 дугаар зүйл

[19] http://www.jurinfo-gazeta.ru/issues/3168/kak-zaregistrirovat-religioznuyu-organizatsiyu

Хязгаарлагдмал Хариуцлагатай Нөхөрлөл(ХХН), Хязгаарлагдмал Хариуцлагатай Хязгаарлагдмал Нөхөрлөл (ХХХН), Хувираа эрхлэх аж ахуй, Траст, Хамтарсан хөрөнгө оруулалттай үйлдвэр, Хамтын Түрээслэгчид ордог. Харин ашгийн төлөө бус хуулийн этгээдэд ашгийн төлөө бус үйл ажиллагаа явуулдаг хамтын корпораци, ажилчдын хамтарсан корпораци, сүм, хийд болон шашны нийгэмлэгүүд, ахан дүүсийн нийгэмлэг, холбоо, загасны аж ахуй эрхлэгч байгууллага хамаардаг байна.

Хуулийн этгээдийн төрлүүдийг Вашингтон мужийн Нарийн бичгийн даргын ажлын албанаас (Office of the Secretary of State) хөтөлдөг компанийн нэгдсэн бүртгэлд бүртгэдэг. Эдгээр хуулийн этгээдийн төрлүүдийг дор товч авч үзье.

3.1. Ашгийн төлөө байгуулагдсан хуулийн этгээд

Ашгийн төлөө байгууллага нь шатлан захирах удирдлагын бүтэцтэй, ашиг олох зорилгоор үйл ажиллагаа явуулдаг.

Тухайн мужид үйл ажиллагаа эрхэлдэг ашгийн төлөө байгууллагуудын үүсгэн байгуулалт, үйл ажиллагаа болон татан буулгах зэрэг асуудлыг Вашингтоны Ашгийн төлөө бус байгууллагын тухай хуулиар (Washington Business Corporation Act) зохицуулдаг. Ашгийн төлөө байгуулагдсан хуулийн этгээдэд дараах төрлүүд багтдаг. Үүнд:[20]

Компани

Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани (ХХК)

ХХК-г нэг болон түүнээс дээш тооны хувь хүн эсвэл аж ахуй нэгж тодорхой бичигдсэн гэрээний дагуу байгуулдаг. Энэхүү гэрээгээр ХХК–ний үйл ажиллагаатай холбоотой гол асуудлуудыг зохицуулж өгдөг. Үүнд менежментийн тухай заалтууд, ашиг хуваарилах нөхцөл, ашиг ба алдагдлын хуваарилалт зэрэг багтдаг. ХХК нь банкны болон даатгалаас бусад хууль ёсны бусад ашгийн төлөө үйл ажиллагаанд явуулж болдог.

Корпораци (Corporation)

Корпораци нь илүү цогц ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийн төрөл юм. Корпораци нь хувь хүнээс илүү давуу эрх, үүрэгтэй байдаг. Корпорацийн хувиар бизнес эрхлэх нь татвар эсвэл санхүүгийн хувьд ашигтай. Гэхдээ лицензийн төлбөр нэмэгдэх эсвэл дотоод хяналт буурах зэргээр өөр асуудлаар нөхөх боломжтой байдаг. Корпорацийг ашгийн төлөө эсвэл ашгийн төлөө бус гэж байгуулж болно

Массачусетсийн Траст (Massachusetts Trust)

Массачусетсийн Траст гэдэг нь хувьцаа эзэмшигчид итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан эд хөрөнгийг хариуцуулах хувьцаат компани юм.

[20] State of Washington. Business Licensing Service. Accessed 6 April 2017, http://bls.dor.wa.gov/ownershipstructures.aspx.

Нөхөрлөл

Ерөнхий Нөхөрлөл (General partnership)

Ерөнхий Нөхөрлөл нь тухайн аж ахуй эрхлэх хөрөнгө, санхүү, ажиллах хүч зэрэг нөөц бололцоондоо түшиглэн үйл ажиллагаа явуулахыг хүлээн зөвшөөрсөн хоёр ба түүнээс дээш гишүүнээс бүрддэг. Гишүүн бүр бизнесийнхээ ашиг, алдагдал, менежментээ хуваарилж, нөхөрлөлийн нэр дээр үүссэн алдагдал, үүргийг адил тэгш хариуцдаг. Нөхөрлөлийн албан ёсны нөхцөлүүдийг ихэвчлэн нөхөрлөл үүсгэн байгуулах тухай гэрээнд тусгадаг.

Хязгаарлагдмал нөхөрлөл (Limited Partnership)

Хязгаарлагдмал нөхөрлөл нь нэг болон түүнээс дээш тооны ерөнхий болон хязгаарлагдмал гишүүдээс бүрддэг. Ерөнхий гишүүд нь бизнесийг удирддаг бөгөөд ашиг болон алдагдлаа бүхэлд нь хуваадаг. Хязгаарлагдмал гишүүд нь бизнесийн ашгаас хүртдэг. Гэхдээ хөрөнгө оруулалтаа өргөжүүлэх үүднээс алдагдлыг хязгаарладаг. Хязгаарлагдмал гишүүд нь ихэвчлэн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцдоггүй.

Хязгаарлагдмал Хариуцлагатай Нөхөрлөл (Limited Liability Partnership) /ХХН/

ХХН нь өөр нэг гишүүнийхээ хайхрамжгүй байдлаас үүдсэн алдагдалд хариуцлага хүлээдэггүй зэрэг шинжээс бусад нөхцөлийн хувьд Ерөнхий нөхөрлөлтэй ижил. Энэхүү бизнесийн байгууллагыг ихэнхдээ нягтлан бодогч, хуульч зэрэг мэргэжилтнүүд үүсгэн байгуулдаг.

Хязгаарлагдмал Хариуцлагатай Хязгаарлагдмал Нөхөрлөл (Limited Liability Limited Partnership) /ХХХН/

ХХХН нь Хязгаарлагдмал нөхөрлөлийн гэрчилгээн дээр ХХХН-ийг үүсгэн байгуулах талаар мэдэгдлийг оруулсны үндсэн дээр байгуулагдсан нөхөрлөл юм. ХХХН нь үүргийнхээ дагуу ерөнхий гишүүдээ хариуцлагаас тусгаарладаг.

Хувираа эрхлэх аж ахуй *(Sole Proprietorship)*

Хувираа эрхлэх аж ахуй нь хувь хүн эсвэл гэр бүлийн хүрээнд бизнес эрхлэх явдал юм. Энэ нь бизнес нэгжүүдийн ихэнх хувийг бүрдүүлдэг бөгөөд үйл ажиллагаа явуулахад маш энгийн бөгөөд илүү уян хатан менежменттэй байхыг шаарддаг. Гэхдээ хувираа эрхлэх аж ахуйтай холбогдон гарах бүх эрсдэлийг бизнес эрхлэгч өөрөө хариуцдаг.

Траст (Trust)

Траст гэдэгт итгэмжлэгдсэн өмчлөгч болон итгэмжлэгдсэн эд хөрөнгийг эрхлэн хариуцаж, ашиг тус хүртэгч этгээд хоёрын хооронд үүсч буй хууль ёсны харилцаа юм.

Хамтарсан хөрөнгө оруулалттай үйлдвэр (Joint Venture)

Хамтарсан хөрөнгө оруулалттай үйлдвэр нь бизнесийн гүйлгээ болон үйл ажиллагааг гүйцэтгэж явуулахын тулд тодорхой хугацаанд үйл ажиллагаа явуулахаар үүсгэн байгуулагддаг.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nji.gov.mn

Хамтын Түрээслэгчид (Tenants in Common)

Хамтын Түрээслэгчид нь бизнесийн үйл ажиллагаанаас үүдэн гарах хөрөнгө эсвэл хариуцлагын асуудлаар салангид талууд ижил төрлийн бизнесийг 2 ба түүнээс дээш хүмүүс эрхлэх явдлыг хэлнэ.

3.2 Ашгийн төлөө бус байгуулагдсан хуулийн этгээд

Ашгийн төлөө бус байгууллага нь нийтийн сайн сайхан байдал, тодорхой зорилгын төлөө үйл ажиллагаа явуулдаг. Ашгийн төлөө бус байгууллагуудын ихэнх нь олон нийтийн ашиг сонирхлын төлөө ажилладаг. Хэрэв ашгийн төлөө бус байгууллага нь олон нийтийн зүгээс үзүүлж буй хандив, дэмжлэгээс хөрөнгө санхүүгээ бүрдүүлдэг бол Вашингтон мужийн Нарийн бичгийн даргын Буяны Хөтөлбөрт бүртгүүлэх шаардлагатай байдаг. Ашгийн төлөө бус байгуулагдсан эдгээр хуулийн этгээдийн төрлүүдийг Вашингтон мужийн Нарийн бичгийн даргын ажлын албанаас (Office of the Secretary of State) хөтөлдөг компанийн нэгдсэн бүртгэлд бүртгэдэг. Дараах байгууллага ашгийн төлөө бус байгууллагад хамаарагддаг. Үүнд:

Ашгийн төлөө бус байгууллагууд

Ашгийн төлөө бус байгууллагуудын үйл ажиллагаа нь Вашингтон мужийн ашгийн төлөө бус байгууллагуудын хуулиар[21] (Washington Nonprofit Corporation Act) зохицуулагддаг бөгөөд буяны, сайн санааны, боцалтгүй тусламжийн, боловсролын, иргэний, эх оронч үзлийн, улс төрийн, шашны, нийгмийн, ахан дүүсийн, утга зохиолын, соёлын, спортын, шинжлэх ухааны, хөдөө аж ахуйн, цэцэрлэгжүүлэлтийн, мал аж ахуй, болон мэргэжлийн, арилжаа наймааны, аж үйлдвэрийн эсвэл худалдааны зэрэг ашгийн төлөө бус зорилгоор үүсгэн байгуулагдсан төрийн бус байгууллагууд ордог.

Харин хөдөлмөрийн холбоо, хамтын ажиллагааны байгууллага, банкны эсвэл даатгалын тухай хуулийн аль нэг заалтад харъяалагдах байгууллагууд ордоггүй.

Ашгийн төлөө бус үйл ажиллагаа явуулдаг хамтын корпораци

Энэхүү байгууллага нь ашгийн төлөө бус үйл ажиллагаа явуулах зорилгын доор байгуулагдсан хуулийн этгээдүүдийг хамааруулдаг. Эдгээр нь Ашгийн төлөө бус үйл ажиллагаа явуулдаг хамтын корпорацийн тухай хуулийн (Nonprofit Miscellaneous and Mutual Corporation Act) дагуу үйл ажиллагаагаа явуулах бөгөөд эдгээр корпорациудыг ашгийн төлөө үйл ажиллагаа явуулахыг хориглодог байна.[22]

Ажилчдын хамтарсан корпораци

Энэ байгууллагын үйл ажиллагаа нь Ажилчдын хамтарсан байгууллагын тухай хуулиар [23](Employee Cooperative Corporations) зохицуулагддаг.

---

[21] Revised Code of Washington. Chapter 24.03. Accessed 6 April 2017. http://apps.leg.wa.gov/rcw/default.aspx?Cite=24

[22] Revised Code of Washington. Chapter 24.06. Accessed 6 April 2017. http://app.leg.wa.gov/RCW/default.aspx?cite=24.06&full=true

[23] Revised Code of Washington. Chapter 23.78. Accessed 6 April 2017. http://app.leg.wa.gov/rcw/default.aspx?cite=23.78&full=true

Сүм, хийд болон шашны нийгэмлэгүүд

Сүм, хийд болон шашны нийгэмлэгүүдийг “Corporations Sole” гэх хуулиар[24] зохицуулдаг. Энэ хуулийн дагуу шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй сүм, хийдийн шашны хамба, тэргүүлэгч нь АНУ-ын Үндсэн хууль болон тухайн сүм, хийдийн дүрэм, журам, папын хуулийн хүчин чадалтай тогтоол, дэг жаягт нийцүүлэн “Corporation sole” хэлбэрийн хуулийн этгээд байгуулах эрхтэй. Мөн шашны хамба, тэргүүлэгч нь өөрсдийн залгамжлагч нартайгаа хамтран “Body corporate” хэлбэрийн хуулийн этгээд байгуулах боломжтой.

Тодорхой үзэл бодлын нэгдэлд суурилсан нийгэмлэг

Энэхүү хуулийн этгээд нь тодорхой үзэл бодлын нэгдэл дээр суурилсан (Fraternal Society) хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг.[25] Энэ нь хуулийн этгээдийн зохион байгуулалтад орохын тулд конгрессоос баталсан “Chapter 24.24 RCW” хуулийн дагуу доод тал нь 10 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулдаг. [26]

Холбоо (Association)

Холбоо нь нийтлэг ашиг сонирхол, үйл ажиллагаа, эсхүл зорилго бүхий зохион байгуулалттай бүлэг хүмүүс юм.

Хамтарсан холбоо

Холбооны үйл ажиллагааг Хамтарсан холбооны тухай хуулиар[27] (Cooperative Associations) зохицуулагддаг. Энэ хуулийн дагуу хэдэн ч хүмүүс нэгдээд холбоо байгуулах боломжтой байдаг. Тухайлбал, хөдөө аж ахуйн холбоо зэрэг.

Загасны аж ахуй эрхлэгч байгууллага

Энэ нь Загасны аж ахуй эрхлэх аж ахуй нэгжийн тухай хуулиар[28] (Fish Marketing Act) зохицуулдаг. Хамтран ажиллах замаар загас, загасан бүтээгдэхүүн болон загасны аж ахуй эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны менежментийг хариуцах, хог хаягдлыг арилгах, үйлдвэрлэгчээс хэрэглэгчийн гар дээр шууд хүргэх зэрэг зорилгоор байгуулагдсан байгууллага юм.

ДӨРӨВ. УНГАР УЛС

Унгар Улсын Иргэний хуулийн 3 дугаар дэвтэр /2014 оны 3 дугаар сарын 15-наас хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн/-т хуулийн этгээдийн бүртгэл, түүнтэй

[24] Washington State Legislature. Chapter 24.12.010.Accessed 6 April 2017. https://app.leg.wa.gov/rcw/default.aspx?cite=24.12.010.

[25] Washington Nonprofit Corporation Act. Chapter 24.20. Accessed 6 April 2017. http://app.leg.wa.gov/RCW/default.aspx?cite=24.20

[26] Washington Nonprofit Handbook.2009. Page 9. Under Chapter 24.20 RCW, fraternal societies, lodges or chapters may incorporate by filing articles of incorporation with the Secretary of State in accordance with RCW 24.20.010. Members of fraternal societies (there must be at least ten) and fraternal societies themselves may form a separate corporation under Chapter 24.24 RCW to construct, maintain and operate a building for fraternal and social purposes. https://www.sos.wa.gov/_assets/charities/washington%20nonprofit%20handbook.pdf

[27] Revised Code of Washington. Chapter 23.86. Accessed 6 April 2017. http://app.leg.wa.gov/rcw/default.aspx?cite=23.86

[28] Revised Code of Washington. Chapter 24.36. Accessed 6 April 2017. http://app.leg.wa.gov/RCW/default.aspx?cite=24.36&full=true

холбогдох эрх зүйн харилцааг тусгасан.[29] Түүнчлэн Иргэний хуулиас гадна Хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой асуудлыг 2006 оны “Аж ахуйн нэгжийн ил тод байдал, шүүхээс хуулийн этгээдийг бүртгэх үйл ажиллагаа, татан буулгах тухай” хуульд мөн тусгажээ.[30]

Хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийн тухайд Иргэний хуульд заасанчлан Ашгийн төлөө болон ашгийн төлөө бус /иргэний нийгмийн байгууллагын төрөл/ хуулийн этгээдийн төрөлд хуваагдаж байна.

Ашгийн төлөө байгуулагдсан хуулийн этгээд

Ашгийн төлөө үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийг Иргэний хуулийн 10 дугаар бүлгийн 3.88 дугаар зүйлд “Ашгийн төлөөх хуулийн этгээд нь бизнесийн чиглэлээр нэгдсэн эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх, гишүүдийн хувь нийлүүлсэн хөрөнгөөр үүсгэн байгуулагдсан, хуулийн этгээдийн эрхтэй аж ахуйн нэгж байх ба гишүүд хуулийн этгээдийн олсон ашиг, орлогоос хувь авах эрхтэй, хуулийн этгээдэд үүссэн алдагдлыг бүгд хүлээх үүрэгтэй байна”[31] гэж тодорхойлжээ. Ашгийн төлөө үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн төрөлд Нийтийн орлоготой компани, Нэгдэл, Хязгаарлагдмал хариуцлагатай компани, Ганц гишүүнтэй хязгаарлагдмал хариуцлагатай компани, Хувьцаат компани, Ганц гишүүнтэй хувьцаат компани, Компаний нэгдэл, Нөхөрлөл, Хоршоо гэсэн 9 төрлийн хуулийн этгээдийн төрөл багтах бөгөөд эдгээрийн Аж ахуйн нэгжийн шүүх бүртгэж, нэгдсэн бүртгэл хөтөлдөг байна.

Ашгийн төлөө бус байгуулагдсан хуулийн этгээд

Ашгийн төлөө бус хуулийн этгээд буюу иргэний нийгмийн байгууллагын төрөлд холбоо, сан багтаж байна. Эдгээр хуулийн этгээдийг мөн л аж ахуйн нэгжийг шүүх бүртгэж, нэгдсэн бүртгэл хөтөлдөг бөгөөд үйл ажиллагаанд нь хууль ёсны хяналтыг прокурорын байгууллагаас хэрэгжүүлдэг.

Эдгээр хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн орчныг 2011 оны Эвлэлдэн нэгдэх эрх, нийтийн ашгийн статус, болон иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаа, дэмжлэгийн тухай 175 дугаар хууль[32] болон 2011 оны Иргэний нийгмийн байгууллагуудын шүүхийн бүртгэл болон үүнтэй холбогдох ажиллагааны журмын тухай 181 дүгээр хуулиар[33] тус тус зохицуулдаг байна.

Иргэний нийгмийн байгууллага үндсэн зорилго /нийтийн эрх ашиг/-доо нийцсэн ашгийн төлөө, аж ахуйн үйл ажиллагаа явуулж болно.[34] Хэрэв иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагаа нь юуны өмнө ашгийн төлөө, аж ахуйн үйл ажиллагааг явуулахад чиглэгдсэн нь тогтоогдвол татварын байгууллага тухайн байгууллагын эсрэг хууль ёсны хяналт хийлгэх ажиллагааг эхлүүлнэ.[35]

---

[29] 2013. évi V. Törvény a Polgári Törvénykönyvről Эх сурвалж: ttps://net.jogtar.hu/jr/gen/hjegy_doc.cgi?docid=A1300005.TV

[30] 2006. évi V. törvény “a cégnyilvánosságról, a bírósági cégeljárásról és a végelszámolásról” Эх сурвалж: https://net.jogtar.hu/jr/gen/hjegy_doc.cgi?docid=A0600005.TV

31 Унгар Улсын Иргэний хуулийн 3.88 дугаар зүйл

[32] 2011. évi CLXXV. Törvény az egyesülési jogról, a közhasznú jogállásról, valamint a civil szervezetek működéséről és támogatásáról Эх сурвалж: https://net.jogtar.hu/jr/gen/hjegy_doc.cgi?docid=A1100175.TV

[33] 2011. évi CLXXXI. Törvény a civil szervezetek bírósági nyilvántartásáról és az ezzel összefüggő eljárási szabályokról Эх сурвалж: https://net.jogtar.hu/jr/gen/hjegy_doc.cgi?docid=a1100181.tv

[34] Мөн тэнд 18 дугаар зүйл

[35] Мөн тэнд 23 дугаар зүйл

Иргэний нийгмийн байгууллага “нийтийн ашгийн төлөө статус”-тай тохиолдолд ашгийн төлөө бус байгууллага болдог. Энэ статусыг авах нөхцөл, шалгуурыг хуулиар тодорхойлсон байна. Нийтийн ашгийн статустай байгууллагаар Унгар Улсад бүртгэлтэй, нийтийн ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж буй нийт нийгмийн болон хэсэг бүлэг хүний нэгдсэн эрх ашгийг хангахад шаардлагатай хөрөнгө, санхүүтэй, үйл ажиллагаа нь нийтэд дэмжигдсэн байдлыг нь хангалттай тогтоох боломжтой байгууллагыг тодорхойлдог байна.[36]

Үйл ажиллагаа нь нийтэд дэмжигдсэн байдлыг тогтоохдоо дараах хүчин зүйлүүдийн аль нэгийг хангасан байдлыг харгалзан үздэг. Үүнд: шаардлагатай хөрөнгө, санхүүжилт гэдэгт 1/ жилийн дундаж орлого 1 сая форинтоос илүү, 2/ 2 жилийн татвар төлсний дараах үлдэгдэл нь хасах /алдагдалтай/ биш, эсхүл 3/ хүний нөөцийн зардал нь удирдах албан тушаалтны цалин хөлсийг оруулахгүйгээр нийт зарлагын ¼-ийг эзэлдэг байх гэсэн шалгуур тавигддаг.

Харин үйл ажиллагаа нь нийтэд дэмжигдсэн гэдэгт 1/ хувь хүний орлогын албан татварын тодорхой хэсгийг татвар төлөгч ямар нэг санал болгох зохицуулалтын дагуу шилжүүлсэн мөнгөн дүн улсын төсвөөс олгосон санхүүжилтийг оруулахгүйгээр тухайн байгууллагын нийт орлогын 2%-ийг эзэлдэг, 2/ нийтийн эрх ашгийн төлөө хэрэгжүүлсэн үйл ажиллагааны зарцуулсан зардлын хэмжээ нийт зардлын талаас илүү хувийг эзэлдэг, 3/ нийтийн эрх ашгийн төлөө үйл ажиллагаанд доод тал нь 10 сайн дурын ажилтан тусалдаг байх гэх шалгуур үзүүлэлт тавигддаг байна. Хэрэв дээрх шалгуур үзүүлэлтийг хангаагүй, үйл ажиллагааныхаа явцад хангахгүй болсон бол шүүх тухайн байгууллагын нийтийн эрх ашгийн төлөө үйл ажиллагаа эрхлэх статусыг хасдаг ба ингэснээр ашгийн төлөө бус байгууллага байхаа больж ашгийн төлөө байгууллагын төрөлд шилждэг байна.

Шашин, хэвлэл мэдээлэл, төрийн бус байгууллага, нийтийн эрх зүйн хуулийн этгээд, соёл, боловсрол, сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийг ашгийн төлөө болон ашгийн төлөө бус хуулийн этгээдийн аль төрөлд хамааруулж улсын бүртгэлд бүртгэж байгаа эсэх тухайд:

Шашны байгууллага

Унгар Улсад үйл ажиллагаа явуулж буй шашны байгууллагуудын үйл ажиллагааны эрх зүйн орчныг 2011 оны “Итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх эрх, болон сүм хийд, шашны урсгал, шашны төвүүдийн эрх зүйн байдлын тухай” 206 дугаар хууль[37] болон 2013 оны “Сүм, хийдийг хүлээн зөвшөөрөх, сүм хийдийн хуулийн этгээдийн эрх зүйн байдал болон үйл ажиллагааны тусгай журмын тухай” 295/2013.(VII.29) тоот Засгийн газрын тогтоол[38] бүрдүүлдэг.

Шашны байгууллагын үйл ажиллагааны үндсэн зорилго нь шашны зан үйлтэй холбогдсон байх шаардлага тавигдах бөгөөд тухайн байгууллагын зүгээс хэрэгжүүлж буй улс төр, эрх ашиг төлөөлөх, сэтгэлзүй, эмчилгээ, эдийн засаг, аж ахуй, сургалт, хүмүүжил, дээд боловсрол олгох, эрүүл мэнд, сувилахуй, гэр бүл, хүүхэд, өсвөр үеийнхнийг хамгаалах, соёлын, ан амьтан, хүрээлэн буй орчин,

[36] Мөн тэнд 32 дугаар зүйл

[37] 2011. évi CCVI. Törvény “a lelkiismereti és vallásszabadság jogáról, valamint az egyházak, vallásfelekezetek és vallási közösségek jogállásáról1” Эх сурвалж: https://net.jogtar.hu/jr/gen/hjegy_doc.cgi?docid=A1100206.TV

38 295/2013. (VII. 29.) Korm. Rendelet “az egyházi elismerésről és az egyházi jogi személyek jogállásának és működésének sajátos szabályairól”
Эх сурвалж: https://net.jogtar.hu/jr/gen/hjegy_doc.cgi?docid=A1300295.KOR

байгаль хамгаалах, нийгмийн хамгааллын чиглэлээр явуулж буй үйл ажиллагааг шашны үйл ажиллагаанд тооцдоггүй.[39]

Унгар улсад шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудыг бүртгэх 2 хэлбэр байна. Эхнийх нь тодорхой нэг шашны урсгал, сүм хийдийн үйл ажиллагааг улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөх эсэхийг Улсын хурал шийдвэрлэж, төрийн захиргааны байгууллага өөрийн санаачилгаар бүртгэдэг бөгөөд эдгээрийг нутагшсан шашны байгууллага гэж үздэг. Удаах нь шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагын үүсгэн байгуулагчийн хүсэлтээр Аж ахуйн нэгжийн шүүх бүртгэдэг.

Иргэний хууль болон Иргэний нийгмийн байгууллагуудын шүүхийн бүртгэл болон үүнтэй холбогдох ажиллагааны журмын тухай 181 дүгээр хуульд Улсын хурлаас шашны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагыг шашны урсгал буюу сүм гэж хүлээн зөвшөөрсөн тохиолдолд Шашны байгууллагатай харилцаа, холбоо тогтоох асуудал эрхэлсэн сайд Аж ахуйн нэгжийн шүүхэд мэдэгдэл хүргүүлэх бөгөөд шүүх шашны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байсан байгууллагыг улсын бүртгэлээс хасна.[40] Сүм, хийдийг хуулийн этгээдээр бүртгүүлэх хүсэлт гаргаж буй этгээд хүсэлтээ Сүм, хийдийн харилцаа холбоо, координацийн асуудал эрхэлсэн сайдад бичгээр гаргана.[41]

Шашны байгууллагыг бүртгэх, бүртгэлтэй холбоотой бусад асуудал зөвхөн Нийслэлийн шүүхэд харьяалагдана.

Үүнээс харахад шашны байгууллага нь ашгийн төлөө бус үйл ажиллагаа явуулах бөгөөд орлогоо гадаад, дотоодын хувь хүн, хуулийн этгээдээс өгсөн хандив, улсын төсвөөс олгодог санхүүжилт болон эдгээрийн үр өгөөжөөс бүрдүүлдэг. Харин шашны байгууллагын үүсгэн байгуулсан хуулийн этгээдүүд /хоршоо, сан, холбоо, ХХК зэрэг/ нь ашгийн төлөө үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн төрөлд хамаарах боломжтой байна.

Хэвлэл мэдээллийн байгууллага

Хэвлэл мэдээллийн байгууллага нь ашгийн төлөө хуулийн этгээдэд хамаарна. Учир нь эдгээр байгууллагууд ихэнх тохиолдолд нээлттэй/хаалттай хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг. Гэхдээ хэвлэл мэдээллийн байгууллага нийтийн ашгийн төлөө статус авахад тавигдах шаардлага хангасан тохиолдолд ашгийн төлөө бус буюу иргэний нийгмийн байгууллага байх боломжтой хэдий ч өнөөг хүртэл энэ төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл бүртгэгдээгүй.

Төрийн бус байгууллага

Унгар Улсад төрийн бус байгууллага гэх хуулийн этгээдийн төрөл байхгүй, харин иргэний нийгмийн байгууллагын аль нэг төрлөөр бүртгэгддэг. Эдгээр байгууллагууд үйл ажиллагааны үндсэн зорилгоосоо хамааран ашгийн төлөө бус хуулийн этгээдэд тавигдах шалгуур үзүүлэлтийг хангасан бол ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төрөлд, хэрэв хангаж чадахгүй буюу ашгийн төлөө үйл ажиллагаа нь давамгайлж байгаа тохиолдолд ашгийн төлөө хуулийн этгээдийн аль нэг төрөлд хамаарч байна.

[39] 2011. évi CCVI. Törvény “a lelkiismereti és vallásszabadság jogáról, valamint az egyházak, vallásfelekezetek és vallási közösségek jogállásáról” хуулийн 6 дугаар зүйл

[40] 2011. évi CLXXXI. Törvény “a civil szervezetek bírósági nyilvántartásáról és az ezzel összefüggő eljárási szabályokról” хуулийн 71 дүгээр зүйл.

[41] 2013 оны “Сүм, хийдийг хүлээн зөвшөөрөх, сүм хийдийн хуулийн этгээдийн эрх зүйн байдал болон үйл ажиллагааны тусгай журмын тухай” 295/2013.(VII.29) тоот Засгийн газрын тогтоолын 6 дугаар зүйл.

Нийтийн эрх зүйн хуулийн этгээд, соёл, боловсрол, сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн зэрэг байгууллагууд

Эдгээр байгууллагууд нь үйл ажиллагааны үндсэн зорилгоосоо хамааран ашгийн төлөө бус хуулийн этгээдэд тавигдах шалгуур үзүүлэлтийг хангасан бол ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төрөлд, хэрэв хангаж чадахгүй буюу ашгийн төлөө үйл ажиллагаа нь давамгайлж байгаа тохиолдолд ашгийн төлөө хуулийн этгээдийн аль нэг төрөлд хамаарч байна.

ДҮГНЭЛТ

Энэхүү лавлагаагаар Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газраас ирүүлсэн захиалгад дурдсан асуудлын хүрээнд Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Оросын Холбооны Улс, Америкийн Нэгдсэн Улс, Унгар улсуудын эрх зүйн зохицуулалтыг судаллаа. Судлагдсан асуудлуудын хүрээнд дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХБНГУ-д ашгийн төлөө хуулийн этгээдүүд нь нийтлэг шинжээрээ ХБНГУ-ын Иргэний хууль болон бусад хуульд нарийвчлан тусгасан журмын дагуу байгуулагдсан төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлж эрх зүйн чадвар бий болгосон ашгийн төлөө зорилгоор байгуулагдсан хуулийн этгээдийг хамааруулдаг байна. Эдгээр хуулийн этгээдүүдийн бүртгэлийг харьяа шүүхэд /Хязгаарлагдмал хариуцлагатай компани, Ашгийн төлөө холбоо зэрэг/ бүртгэдэг бол зарим хуулийн этгээдийн онцлог шинжээс нь шалтгаалан Хөрөнгийн биржид бүртгүүлэх /Хувьцаат компани/, Худалдааны бүртгэлд бүртгүүлэх /Нөхөрлөл/ үүргийг хууль тогтоомжид тусгажээ.

Харин ашгийн төлөө бус хуулийн этгээдүүдэд нийтлэг шинжээрээ Иргэний хууль болон бусад холбогдох хуульд тусгасан журмын дагуу байгуулагдсан, төрөөс хараат бусаар үйл ажиллагаагаа явуулдаг, ашгийн төлөө бус зорилготой, өөрийн бие даасан удирдлага зохион байгуулалттай этгээдийг ойлгоно. Ашгийн төлөө бус чиглэлээр хуулийн этгээд байгуулахын ач холбогдол нь нийтийн сайн сайхны тусын тулд үйл ажиллагаа явуулж байгаа онцлогоос шалтгаалан төрөөс тавьж буй татварааc чөлөөлөгддөг онцлогтой байна. Эдгээр хуулийн этгээдүүдийн бүртгэлийн тухайд анхан шатны шүүхийн дэргэдэх холбооны бүртгэлд бүртгэгдсэнээр эрх зүйн чадамжтай болдог.

Судалгааны захиалгад ирүүлсэн чиглэл буюу хэвлэл мэдээлэл, соёл, боловсрол, сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн зэрэг хуулийн этгээдийг хуулийн этгээдийн төрлийн аль төрөлд хамаарах тухайд эдгээр байгууллагын дүрэмд заасан үйл ажиллагааны зорилго, чиглэлээс хамааран ашгийн төлөө болон ашгийн төлөө бус байгууллагын аль ч төрөлд хамаарч болохоор тусгагдсан байна. Харин шашны байгууллагын тухайд энэхүү хуулийн этгээдийг байгуулах үндсэн зорилготойгоо уялдуулан гол төлөв ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төрөлд хамааруулан бүртгэдэг байна.

Оросын Холбооны Улс

ОХУ-ын Хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг “Иргэний хууль” болон бусад салбарын хуулиар зохицуулан тусгасан. Ашгийн төлөө хуулийн этгээдийн төрөлд Компани, Нөхөрлөл, Тариалангийн аж ахуй, Төрийн болон орон нутгийн нэгдмэл аж ахуй нэгж, Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл гэсэн хуулийн этгээдийн төрлүүд хамаардаг байна. Харин ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төрөлд Хэрэглэгчдийн хоршоо, Олон нийтийн байгууллага, Олон нийтийн хөдөлгөөн, Сан,

Холбоо, Үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчдийн нөхөрлөл, Өмгөөлөгчдийн танхим, Шашны байгууллага гэх мэт байгууллагууд хамаардаг байна.

ОХУ-ын “Иргэний хууль”-ийн 48 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “Ашгийн төлөө байгууллага нь өөрийн тусгайлсан хөрөнгөтэй, тухайн үйл ажиллагаанаас үүдэх хариуцлагыг өөрийн оруулсан хөрөнгөөрөө хариуцдаг, өөрийн нэрээр эрх олж авч, иргэний эрх эдэлж, үүрэг хүлээдэг, шүүхэд хариуцагч болон нэхэмжлэгчээр оролцох зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд” гэж тодорхойлсон байна.

Ашгийн төлөө бус байгууллага гэдэгт үүсгэн байгуулагчид олсон ашиг, орлогоос хувь оногдуулахгүй ба үйл ажиллагааны үндсэн зорилгоо ашиг орлого олох бус нийтийн сайн сайхан байдлын төлөө үйл ажиллагаа явуулах байгууллагыг ойлгоно. Өөрөөр хэлбэл, ашгийн бус байгууллагыг нийгмийн сайн сайханд чиглэсэн зорилгоор нийгэм, буяны үйл ажиллагаа, соёл, боловсрол, улс төр, шинжлэх ухааны өөр бусад чиглэлээр байгуулж болно.

Эдгээр хуулийн этгээдүүдийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу эрх бүхий төрийн байгууллага /Единый центр регистрации/ нь улсын бүртгэл хөтөлж явуулах ба Олон нийт болон шашны байгууллагыг Хууль зүйн яамны дэргэдэх эрх бүхий гүйцэтгэх байгууллага бүртгэж, хянадаг байна. Хэрвээ эрх бүхий бүртгэлийн байгууллага нь хуулийн этгээдийг бүртгэхээс үндэслэлгүйгээр татгалзаж, зайлсхийсэн тохиолдолд шүүхэд гомдол гаргах эрхийг нээлттэй байдлаар олгожээ.

Америкийн Нэгдсэн Улсын Вашингтон муж

АНУ-ын Вашингтон мужийн хуулийн этгээдийн төрлийг Мужийн Нарийн бичгийн даргын ажлын албаны компанийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлдэг.

Байгууллагын удирдлагын бүтэц, дүрэм, гэрээнд заасан зорилгоос нь хамааруулан ашгийн төлөө болон ашгийн төлөө бус гэж ангилдаг. Ашгийн төлөө хуулийн этгээдийн төрөлд дараах байгууллагууд хамаарч байна. Үүнд: Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани, Корпораци, Массачусетсийн Траст, Ерөнхий Нөхөрлөл, Хязгаарлагдмал Нөхөрлөл, Хязгаарлагдмал Хариуцлагатай Нөхөрлөл, Хязгаарлагдмал Хариуцлагатай Хязгаарлагдмал Нөхөрлөл, Хувираа эрхлэх аж ахуй, Траст, Хамтарсан хөрөнгө оруулалттай үйлдвэр, Хамтын түрээслэгчид зэрэг ордог байна.

Харин ашгийн төлөө бус байгууллагад буяны, сайн санааны, буцалтгүй тусламжийн, боловсролын, иргэний, эх оронч үзлийн, улс төрийн, шашны, нийгмийн, ахан дүүсийн, утга зохиолын, соёлын, спортын, шинжлэх ухааны, хөдөө аж ахуйн, цэцэрлэгжүүлэлтийн, мал аж ахуй, болон мэргэжлийн, арилжаа наймааны, аж үйлдвэрийн эсвэл худалдааны болон ажилчдын хамтарсан байгууллага ашгийн төлөө бус үйл ажиллагаа явуулдаг хамтын корпораци, сүм хийд болон шашны нийгэмлэгүүд, ахан дүүсийн нийгэмлэг, холбоо, хамтарсан холбоо, загасны аж ахуй эрхлэгч байгууллага болон бусад ашгийн төлөө бус байгууллагууд ордог байна.

Вашингтон мужийн хуульд тусгагдсанаар шашны байгууллага болон төрийн бус байгууллага нь ашгийн төлөө бус байгууллагад ордог бол бусад хэвлэл мэдээлэл, нийтийн эрх зүйн хуулийн этгээд, соёл, боловсрол, сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн зэрэг хуулийн этгээдийн үйл ажиллагааны бүтэц, зорилгоос хамааран ашгийн төлөө болон ашгийн төлөө бус байгууллагад хамааруулдаг байна.

Унгар улс

Унгар Улсын Иргэний хуульд хуулийн этгээдийн 11 төрлийг тодорхойлсон бөгөөд үүний 9 нь ашгийн төлөө, 2 нь ашгийн төлөө бус үйл ажиллагаа эрхлэх

боломжтой байдаг байна. Тус улсад хуулийн этгээдийг Аж ахуйн нэгжийн шүүх /сйgbirysбg/ бүртгэдэг бөгөөд хуулийн этгээдийг бүртгэх, мэдээлэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах, хууль ёсны хяналт тавих зэрэг холбогдох асуудлыг хариуцан шийдвэрлэдэг.

Хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэж “Аж ахуйн нэгжийн мэдээлэл” сэтгүүлд бүртгэгдсэн тухай мэдээлэл нийтлэгдсэнээр тухайн хуулийн этгээдэд хууль ёсоор үйл ажиллагаа явуулах эрх үүсдэг.

Иргэний нийгмийн байгууллагууд нийгэм, нийтэд тустай үйл ажиллагаа эрхлэх үндсэн зорилгоор байгуулагддаг ба үйл ажиллагааны онцлогоосоо хамааран ашгийн төлөө бус, нийтийн эрх ашгийг хамгаалах, хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Эдгээр байгууллагуудад үндсэн зорилгодоо нийцсэн ашгийн төлөө бус үйл ажиллагаа эрхлэхээс гадна үйл ажиллагааныхаа чиглэлд нийцсэн ашгийн төлөө үйл ажиллагаа эрхлэхийг хуулиар зөвшөөрдөг. Харин тухайн байгууллагад олгож буй “нийтийн ашгийн төлөө статус” тэдний үйл ажиллагааг дэмжиж төрөөс үзүүлэх хөнгөлөлт, дэмжлэг олгох үндэслэл буюу ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төрөлд хамаатуулах үндэслэл болдог.

Иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааныхаа явцад эхний ээлжид нийтийн ашгийн төлөө үйл ажиллагаа эрхэлж байгаа эсэхэд хууль ёсны хяналтыг прокурорын байгууллага тавьж ажилладаг бол татварын байгууллага тухайн байгууллагын орлого, зарлагын баланс нь нийтийн ашгийн төлөө статуст тавигдах шалгуурыг хангаж байгаа эсэхэд хяналт тавьдаг байна.

Хэрэв иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагаа нийтийн эрх ашгийг хангахад чиглэсэн үйл ажиллагаанаасаа давсан ашгийн төлөө үйл ажиллагаа эрхэлсэн тохиолдолд ашгийн төлөө бус үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын бүртгэлээс хассанаар эдгээр байгууллагууд ашгийн төлөө хуулийн этгээдийн ангилалд шилждэг байна.

Эцэст нь дүгнэхэд хуулийн этгээдийг ашгийн төлөө ашгийн төлөө бус гэж ангилах үндсэн шаардлага нь тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагаа “нийтийн ашгийн төлөө статус”-т тавигдах шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхэд оршиж байна. Ашгийн төлөө үүсгэн байгуулагдаж буй хуулийн этгээдийн төрлийг хуулиар тодорхой зааж өгч байгаа бол иргэний нийгмийн буюу ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төрлийг тэдний үйл ажиллагаа, түүнд зарцуулж буй хөрөнгө, санхүүжилтийн зарцуулалт, сайн дурын буюу нийгэмд тустай үйл ажиллагаа нь нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн зэрэг байдлыг харгалзан үздэг байна. Тухайлбал шашны байгууллага үндсэндээ ашгийн төлөө бус хуулийн этгээд боловч түүний үүсгэн байгуулсан хуулийн этгээд нь ашгийн төлөө хуулийн этгээд байх боломжтой, мөн сургалт, судалгаа, эрүүл мэндийн байгууллага зэрэг нь ялгаагүй нийтийн ашгийн төлөө статуст тавигдах шаардлага хангаагүй бол ашгийн төлөө хуулийн этгээдэд хамаарч байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

1. Герман Улсын Иргэний хууль /1896 он/ https://www.gesetze-im-internet.de/englisch_bgb/

2. ХБНГУ-ын Иргэний хууль /Кодификацийн бүрэн эх/, МУИС-ХЗС, Орчуулсан Б.Буянхишиг

3. German company types your options when setting up a business, *published by Consulting House International,* https://www.justlanded.com/english/Germany/Articles/Business/German-company-types

4. Types of Companies in Germany, http://www.lawyersgermany.com/types-of-companies-in-germany

5. Peter Rawert and Janne Gartner, Nonprofit organization in Germany: Permissible Forms and Legal Framework, 1.

6. Thomas Von Hippel and Dr. Michael Ernst-Pцrksen, Germany http://www.usig.org/countryinfo/PDF/Germany.pdf

7. Meyer-koring, Foundation, http://www.corporate-law.eu/en/germany/foundation/

8. https://www.state.gov/documents/organization/171696.pdf,

Оросын Холбооны Улс

1. ОХУ-ын “Иргэний хууль”, 1994 он, “закон о Гражданский кодекс Российской Федерации, 1994году”, http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_5142/

2. ОХУ-ын “Шашны байгууллага, сүсэг бишрэлийн эрх чөлөө”-ний тухай хууль, 1997 он “закон О свободе совести и религиозных объединениях, 1997 году”

3. “Хувьцаат компани”-ийн тухай хууль, 1995 он, “закон об Акционерных обществах 1995 году” http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_8743/9ef980dcd49e7461a063f6d5858a38086e6a52a8/

4. http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_1511/

5. http://sir35.narod.ru/Legal_agency/Attorney_chamber_22093.html

6. http://docs.cntd.ru/document/901702323

7. http://www.barrit.ru/price/10.html

8. http://www.jurinfo-gazeta.ru/issues/3168/kak-zaregistrirovat-religioznuyu-organizatsiyu

Америкийн Нэгдсэн Улс

1. Washington Nonprofit Handbook. How to Form and Maintain a Nonprofit Corporation in Washington state.(2009 Ed.)

2. Revised Code of Washington. Corporations and Associations (Profit). Title 23. 26 December 2016. Retrieved from http://apps.leg.wa.gov/rcw/default.aspx?Cite=23

3. Revised Code of Washington. Washington Business Corporation Act. Title 23B. 26 December 2016. Retrieved from http://apps.leg.wa.gov/rcw/default.aspx?Cite=23B

4. Revised Code of Washington. Washington Nonprofit Corporation Act. Chapter 24.03.26. (2016). Retrieved from http://apps.leg.wa.gov/rcw/default.aspx?cite=24.03

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН www.nli.gov.mn

Унгар улс

1. Унгар улсын Иргэний хууль

/2013. йvi V. Tцrvйny a Polgбri Tцrvйnykцnyvről/

2. Аж ахуйн нэгжийн ил тод байдал, шүүхээс хуулийн этгээдийн бүртгэх үйл ажиллагаа, татан буулгах тухай" хууль

/2006. йvi V. tцrvйny "A сйgnyilvбnossбgryl, a bнrysбgi сйgeljбrбsryl йs a vйgelszбmolбsryl"/

3. 2011 оны Эвлэлдэн нэгдэх эрх, нийтийн ашгийн статус, болон иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаа, дэмжлэгийн тухай 175 дугаар зүйл

/2011. йvi CLXXV. Tцrvйny "Az egyesьlйsi jogryl, a kцzhasznъ jogбllбsryl, valamint a civil szervezetek műkцdйsйről йs tбmogatбsбryl/

4. 2011 оны Иргэний нийгмийн байгууллагуудын шүүхийн бүртгэл болон үүнтэй холбогдох ажиллагааны журмын тухай 181 дүгээр зүйл

2011. йvi CLXXXI. Tцrvйny "A civil szervezetek bнrysбgi nyilvбntartбsбryl йs az ezzel цsszefьggő eljбrбsi szabбlyokryl"

5. "Итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх эрх, болон сүм хийд, шашны урсгал, шашны төвүүдийн эрх зүйн байдлын тухай" 206 дугаар зүйл

2011. йvi CCVI. Tцrvйny "a lelkiismereti йs vallбsszabadsбg jogбryl, valamint az egyhбzak, vallбsfelekezetek йs vallбsi kцzцssйgek jogбllбsбryl[1]"

6. 2013 оны "Сүм, хийдийг хүлээн зөвшөөрөх, сүм хийдийн хуулийн этгээдийн эрх зүйн байдал болон үйл ажиллагааны тусгай журмын тухай" 295/2013.(VII.29) тоот Засгийн газрын тогтоол

295/2013. (VII. 29.) Korm. Rendelet "az egyhбzi elismerйsről йs az egyhбzi jogi szemйlyek jogбllбsбnak йs műkцdйsйnek sajбtos szabбlyairyl"

7. Milyen szervek ellenőrizhetik a civilszervezeteket?

http://www.nonprofit.hu/tudastar/milyen-szervek-ellenorizhetik-civilszervezeteket

----oOo---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА /Харьцуулсан лавлагаа/[1]

УДИРТГАЛ

Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газраас ирүүлсэн захиалгын дагуу “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа /Харьцуулсан лавлагаа/” сэдвээр харьцуулсан лавлагаа хийж гүйцэтгэв. Энэхүү лавлагааны хүрээнд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг бие даасан хуулиар зохицуулж буй Тажикстан, Беларусь зэрэг орнууд олдсон боловч эдгээр орнуудын хууль тогтоомжууд дэлхийн нийтлэг хэрэглэгддэг хоёрдогч хэлээр орчуулагдан гараагүй, мөн орчуулагдсан зарим орчуулгын хувилбар нь төлбөртэй цахим санд байршсан зэрэг шалтгааны улмаас дээрх орнуудыг судлах боломж гарсангүй. Харин ХЗДХЯ-ны захиалга болон судалгааны багийн зүгээс судлах шаардлагатай гэж үзсэн ОХУ, Казахстан, Унгар, Гүрж гэсэн орны хуулийн зохицуулалтыг тусгайлан авч үзэв.[2]

Уг харьцуулсан лавлагааг гүйцэтгэхдээ захиалагчаас ирүүлсэн чиглэл буюу 1/ Зөрчил шалган шийдвэрлэх тухай бие даасан хуультай орныг судлах; 2/ Зөрчил шалган тогтоох тодорхой ажиллагааг прокурор эсхүл шүүхийн зөвшөөрлөөр хэрэгжүүлдэг журмыг хуульчилсан эсэх; 3/ Зөрчилд шийтгэл оногдуулсан улсын байцаагчийн шийдвэрийг давж заалдах ажиллагаа; 4/ Зөрчилд шийтгэл оногдуулсан шийдвэрийг шүүхэд давж заалдах процесс зэрэг асуудлын хүрээнд харьцуулан судаллаа.

Монгол Улсын өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн зохицуулалтаар зөрчлийн хариуцлагыг цагдаа, гааль, татвар, мэргэжлийн хяналт, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, нийгмийн даатгал зэрэг олон салбарын байгууллага хэрэгжүүлдэг бөгөөд тэдгээрийн үйл ажиллагааны үндэслэл, журмыг Захиргааны хариуцлагын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Өрсөлдөөний тухай, Гаалийн тухай болон Татварын ерөнхий хууль зэрэг салбарын хуулиар зохицуулж байна.

Энэ нь эрх зүйн хэм хэмжээний давхардал, хийдэл, зөрчлийг бий болгож, улмаар салбарын хүрээний дүрэм, журмаар хүний эрхийг хязгаарлаж байгаа нь зөрчил шалган тогтоох болон шийтгэл оногдуулах ажиллагааг харилцан адилгүй, тэнцвэргүй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна.[3] Үүнээс гадна зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа нь хууль зүйн хувьд нэгдсэн стандартаар хуульчлагдаагүйн улмаас дээр дурдсан байгууллагууд өөрийн салбарын онцлог нэрийн дор харьяалах салбар бүр зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны өөр өөр стандартыг тогтоон хэрэгжүүлэх хандлагатай байна. Үүнээс үүдэн дээр дурдсан эрх бүхий байгууллагын албан хаагч /улсын байцаагч/ зөрчлийг шалган тогтоох ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөө, өмчид халдах, хуульд заасан журмаас гадуур хүний эрхийг хязгаарлах нөхцөл бий болгож болзошгүй байдалд хүргэж байна.[4]

Иймд уг лавлагаагаар судалсан орнуудад зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой асуудлуудыг хууль тогтоомждоо хэрхэн тусгасан талаар судалж, харьцуулсан. Энэхүү лавлагааг хийж гүйцэтгэхдээ харьцуулсан

---

[1] Тус судалгааг эрдэм шинжилгээний ажилтан Ж.Бариаширсүрэн, Ж.Алтансүх, Б.Гончигсумлаа, Б.Алтангэрэл,Б.Сүнжидмаа нар хамтран гүйцэтгэв.

[2] Судлагдсан орнуудын хүрээнд зөрчил шалган тогтоох, зөрчлийг шалган шийдвэрлэх бие даасан хуультай орнуудыг аль болох хамруулан судлахыг зорьсон боловч бие даасан хуультай орнуудын талаарх судалгааны эх сурвалж олдоц муутай, өөрийн эх хэлнээс өөр нийтлэг хэрэглэдэг хэлээр орчуулагдаагүй, эсхүл орчуулагдсан хууль тогтоомжууд төлбөртэй цахим санд байсан зэрэг шалтгааны улмаас бие даасан хуультай орнуудыг судлахад хүндрэл учирсан. Хэдийгээр дээрх хүндрэл бэрхшээлүүд учирч байсан боловч уг лавлагааг хийхэд оролцсон судлаачид зөрчил шалган тогтоох, зөрчлийг шалган шийдвэрлэх талаар гаргасан хууль тогтоомжууд нь эрх зүйн бүлийн хувьд Монгол Улстай ойролцоо зохицуулалт бүхий орнуудыг сонгон судалж гүйцэтгэлээ.

[3] Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төслийн үзэл баримтлал, /УБ, 2016/, 1.

[4] Мөн тэнд.

судалгааны аргыг голлон ашигласан бөгөөд тухайн улсын зөрчил хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, одоогийн нөхцөл байдлын талаар үнэлэлт өгөөгүй болно.

НЭГ. УНГАР УЛСЫН ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

1.1. Ерөнхий ойлголт

Унгар улс 2012 онд Зөрчил, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн бүртгэлийн тогтолцооны тухай хууль[5] баталсан байна. Энэ хууль нь 31 бүлэг, 254 зүйлээс бүрдсэн ба уг хуулийн 1-5 дугаар бүлэгт зөрчлийн тухай ерөнхий зохицуулалт, 6-21 дүгээр бүлэгт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны журам, 22 дугаар бүлэгт шийдвэр гүйцэтгэл болон зөрчлийн бүртгэлийн тогтолцооны талаарх зохицуулалт, 23-31 дүгээр бүлэгт бусад зөрчил буюу Зөрчлийн хуулийн тусгай ангийн зохицуулалтуудыг агуулжээ. [6]

Унгар улсын Зөрчил, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн бүртгэлийн тогтолцооны тухай хуульд зааснаар “зөрчил гэж энэ хуулийн дагуу хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.” гэж тодорхойлсон байна. Түүнчлэн энэ хуульд “Үндсэн хуульд заасан төр, нийгэм, эдийн засгийн тогтолцоог, мөн хувь хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн статусгүй байгууллагуудын эрх ашгийг эрүүгийн хариуцлага хүлээлгэх хэмжээнээс бага хэмжээгээр зөрчсөн, эсхүл аюул учруулж болзошгүй нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйд хэрэглэнэ” гэж тусгажээ. [7]

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаан дахь хөөн хэлэлцэх хугацаа 6 сар байна. Зөрчил үйлдсэнээс хойш 2 жил өнгөрсөн бол зөрчил үйлдсэн этгээдэд хариуцлага хүлээлгэхгүй.

Зөрчилд дараах төрлийн шийтгэл оногдуулдаг. Үүнд:

- баривчлах /1-60 хоног/;
- торгууль ногдуулах /5000-150000 форинт, хэрэв баривчлах шийтгэл оногдуулах хэмжээний зөрчил гаргасан бол 300000 форинт хүртэл/;
- нийтэд тустай хөдөлмөр хийлгэх /6-180 цаг/;

Зөрчлийн улмаас оногдуулсан шийтгэлийн ялтай байх хугацаа 2 жил байна. Энэ хугацаа нь давтан үйлдсэн зөрчилд хүндрүүлэх нөхцөл болдог. Үүнээс гадна эрх хасах, эд хөрөнгө хураах, хориглох, сануулах арга хэмжээ авах боломжтой байдлаар зохицуулсан.

Тус хуульд өсвөр насны хүүхэд, цэргийн алба хаагчдад хүлээлгэх шийтгэлийн төрөл, хэмжээг тусгайлан зохицуулсан.[8]

Зөрчил гаргасан этгээдэд шийтгэл хүлээлгэх эрх бүхий байгууллага:[9]

[5] 2012. évi II. törvény A szabálysértésekről, a szabálysértési eljárásról és a szabálysértési nyilvántartási rendszerről Эх сурвалж: http://net.jogtar.hu/jr/gen/hjegy_doc.cgi?docid=A1200002.TV

[6] Зөрчлийн тухай бие даасан хуультай орнуудын дундаас Унгар улсын хуулийг сонгон судлаж, тодорхой асуудлын хүрээнд лавлагаа бэлтгэв.

[7] 1. § (1)[2] Szabálysértés az az e törvény által büntetni rendelt tevékenység vagy mulasztás, amely veszélyes a társadalomra.
(2)[3] E törvény alkalmazásában az a tevékenység vagy mulasztás veszélyes a társadalomra, amely a bűncselekményként történő büntetni rendeléshez szükségesnél kisebb fokban sérti vagy veszélyezteti az Alaptörvény szerinti állami, társadalmi vagy gazdasági rendet, a természetes és jogi személyek, valamint a jogi személyiség nélküli szervezetek személyét vagy jogait.

[8] 26-28 дугаар зүйл.

[9] 38. § (1)[43] Az általános szabálysértési hatóság a fővárosi, megyei kormányhivatal járási (fővárosi kerületi) hivatala (a továbbiakban: járási hivatal).
(2)[44] Az e törvény által a hatáskörébe utalt szabálysértés miatt a szabálysértési hatóság jogkörében a rend őrkapitányság vagy az egyes feladatok ellátására létrehozott rendőri szerv, illetve a Nemzeti Adó- és Vámhivatal feladat- és hatáskörrel rendelkező szerve jár el.
(3)[45] Szabálysértési elzárással is büntethető, valamint e törvényben meghatározott szabálysértés miatt első fokon a járásbíróság jár el.

- Нийслэл, аймгийн Засгийн газрын алба;
- Энэ хуулиар олгосон эрхийн хүрээнд Цагдаагийн байгууллага, Үндэсний татвар, гаалийн алба;
- Захиргааны баривчлах шийтгэл оногдуулах зөрчилд орон нутгийн шүүх;
- Энэ хуулиар зөрчил үйлдсэн этгээдэд газар дээр нь торгууль ногдуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтны жагсаалтад орсон байгууллага, албан тушаалтан багтана.

1.2. Зөрчил шалган тогтоох тодорхой ажиллагааг прокурор эсхүл шүүхийн зөвшөөрлөөр хэрэгжүүлдэг журмыг хуульчилсан эсэх

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаан дахь прокурорын оролцоо

Унгар улсын **Зөрчил, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн бүртгэлийн тогтолцооны тухай** хуулийн 43 дугаар зүйлд зөрчилтэй холбоотой маргааныг шийдвэрлэх ажиллагаан дахь прокурорын оролцоог зохицуулсан байна. Прокурор Зөрчлийн албаны үйл ажиллагаа, авч буй арга хэмжээ хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг шалгах, мөн зөрчлийн бүртгэлийн тогтолцоонд хууль ёсны хяналт тавьж ажилладаг.

Дээрх байгууллага прокуророос тавьсан шаардлага хууль зүйн үндэслэлтэй гэж үзсэн бол хууль тогтоомж зөрчсөн үйлдэл, шийдвэрийг өөрчлөх, буцаах арга хэмжээ авах ба энэ тухай прокурорт мэдэгдэх үүрэгтэй.

Хэрэв Зөрчлийн албa прокурорын шаардлагыг хангаагүй тохиолдолд прокурор 30 хоногийн дотор хүчин төгөлдөр шийтгэвэрийн эсрэг орон нутгийн шүүхэд хандах бөгөөд энэ тухайгаа Зөрчлийн албанд мэдэгдэнэ. Мэдэгдэл хүлээж авсан Зөрчлийн албa 8 өдрийн дотор хэргийн холбогдох материалыг харьяаллын дагуу шүүхэд хүргүүлнэ.

Прокурорын шаардлагын дагуу зөрчилтэй холбоотой үүсгэсэн хэрэгт шүүгч дангаараа, баримт бичгт үндэслэн, 30 хоногийн дотор шийдвэр гаргана. Шүүхийн шийдвэрийг давж заалдах боломжгүй боловч 8 хоногийн дотор шүүх хурал хийлгэх хүсэлт гаргах эрхтэй. Шүүх хурлаар хэлэлцэж гаргасан шүүхийн шийдвэрийн эсрэг давж заалдах боломжгүй.

Зөрчил хянан шалгах ажиллагааны явцад шаардлагатай эд мөрийн баримтыг хураан авах боломжгүй бол зөрчилтэй холбоотой үүссэн шинж тэмдгийг агуулсан, харуулсан баримт бичиг, зураг, эсхүл бусад хэлбэрээр дүрсжүүлсэн хувилбарыг хэргийн материалд хавсаргана.

Шүүх, зөрчлийн албa үл мэдэгдэх газар байгаа, шинж тэмдгийг тодорхойлох, хуулийн дагуу хурааж авах боломжтой эд мөрийн баримтыг эрэн сурвалжлах даалгавар өгч болно. Эрэн сурвалжлах даалгаврыг зөрчил шалгах хугацаа дуусахад, эсхүл зөрчилтэй холбоотой шийдвэр гарсан тохиолдолд хүчингүй болгож, татаж авна.

Зөрчил шалган тогтоох ажиллагааны явцад шаардлагатай үйл ажиллагаа явуулах, эд хөрөнгө хураах асуудлын хүрээнд зөрчил шалгах эрх бүхий байгууллага, хууль тогтоомжийн дагуу үйлдэл дээр нь шууд торгох эрх бүхий албан тушаалтан зөрчлийн эд мөрийн баримт болох эд зүйлийг хурааж авах эрхтэй. Ингэхдээ дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: 1/ Зөрчлийн эд мөрийн баримт байх; 2/ энэ хуулиар хурааж авахыг зөвшөөрсөн эд зүйл байх. Мөн хурааж авсан эд мөрийн баримтыг хэрхэн хадгалах, өмчлөх эрх бүхий этгээдэд буцааж олгох, ийм этгээд байхгүй тохиолдолд улсын өмчид шилжүүлэх, олон өмчлөгчтэй байвал хэнд нь буцааж олгох, хэрэглэх боломжгүй эд мөрийн баримтыг устгах тухай зохицуулалтыг оруулжээ.

Эд мөрийн баримтын төрлүүдээс шуудан, харилцаа холбооны шугам ашиглан илгээсэн эд төрийн баримтыг хүлээн авагчид хүргэхээс өмнө хурааж авах

асуудлаар прокурор тогтоол гаргана. Прокурор тогтоол гаргах хүртэлх хугацаанд тухайн илгээмжийг зөвхөн түр саатуулах талаар арга хэмжээ авч ажиллана.[10]

Эд хөрөнгө хураах, эд хөрөнгө хураахыг зогсоох тухайд заавал тогтоол гаргана.[11] Зөрчил шалган тогтоох ажиллагааны явцад хэрэгцээ шаардлагагүй болсон эд хөрөнгө хураах ажлыг зогсоох тухай тогтоолыг нэн даруй гаргаж, холбогдох этгээдэд мэдэгдэнэ.

Зөрчил үйлдсэн этгээдийг баривчлах тухай шийдвэрийг зөвхөн шүүх гаргана.

1.3. Зөрчилд шийтгэл оногдуулсан улсын байцаагчийн шийдвэрийг давж заалдах ажиллагаа

Хуулийн 35 дугаар зүйлд[12] давж заалдах эрхийн тухай зохицуулсан байна. Үүнд зааснаар зөрчлийн албаны тогтоол, шүүхийн шийдвэр болон зөрчлийн алба, шүүхээс авсан бусад арга хэмжээ, эсхүл авах ёстой байсан хэдий ч аваагүй орхигдуулсан арга хэмжээтэй /эс үйлдэхүй/ холбогдуулан давж заалдах эрхтэй.

Давж заалдах хэлбэр нь санал, давж заалдах өргөдөл, гомдол байна. Бусад хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Зөрчлийн албаны шийтгэвэр, эсхүл арга хэмжээ авах тухай шийдвэрийн эсрэг санал, бусад шийдвэр, арга хэмжээ болон авах ёстой байсан арга хэмжээг авалгүй орхигдуулсан тохиолдолд гомдол, эсхүл шүүхийн шийдвэрийн эсрэг давж заалдах өргөдөл гаргана.

Давж заалдах хугацааны тухайд тухайн шийдвэрийг танилцуулснаар, авах ёстой байсан арга хэмжээг авалгүй орхигдуулсан тохиолдолд энэ тухай мэдээлэл авсан өдрөөс эхлэн 8 хоног байна. Хуулиар хориглосон, давж заалдах эрхгүй хүнээс гаргасан, эсхүл хугацаа хоцорсон, эсхүл давтан нэг асуудлаар гаргасан тохиолдолд зөрчлийн алба, прокурор, шүүх санал, гомдол, давж заалдах өргөдлийг хүлээж авахаас татгалзана.

Хуулиар хориглосон, давж заалдах эрхгүй хүнээс гаргасан, эсхүл хугацаа хоцорсон, эсхүл давтан нэг асуудлаар гаргасан тохиолдолд зөрчлийн алба, прокурор, шүүх санал, гомдол, давж заалдах өргөдлийг хүлээж авахаас татгалзсан шийдвэрийг давж заалдах боломжгүй. Энэ тухай санал, гомдол, өргөдөл гаргасан этгээдэд 5 хоногийн дотор мэдэгдэнэ.

Орон нутгийн /дүүрэг, хотын/ шүүхийн шийдвэрээр оногдуулсан баривчлах шийтгэлийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд давж заалдах шатанд нийслэл,

---

[10] 75§. (3) Postai küldeményt, táviratot - a címzettnek történő kézbesítése előtt - csak az ügyész írásbeli határozata alapján lehet lefoglalni, az ügyészi határozat meghozataláig csak visszatartásuk iránt lehet intézkedni.

[11] 75§. (6) A lefoglalás elrendeléséről és megszüntetéséről határozatot kell hozni.

[12] 25. A jogorvoslati jogosultság: 35. §[41] (1) A szabálysértési hatóság határozata, a bíróság végzése ellen, valamint a szabálysértési hatóság és bíróság egyéb intézkedése ellen, valamint intézkedésének elmulasztása miatt - ha e törvény kivételt nem tesz - jogorvoslatnak van helye. A jogorvoslatra jogosult a jogorvoslati jogáról írásban vagy a tárgyaláson szóban lemondhat.
(2) Jogorvoslatok a kifogás, a fellebbezés és a panasz. E törvény eltérő rendelkezésének hiányában
a) a szabálysértési hatóság büntetést vagy intézkedést megállapító határozata ellen kifogásnak, egyéb határozata vagy intézkedése, illetve az intézkedés elmulasztása ellen panasznak,
b) a bíróság végzése ellen fellebbezésnek
Van helye.
(3) Jogorvoslati kérelem benyújtására - ha e törvény kivételt nem tesz - az jogosult, akire nézve a határozat rendelkezést tartalmaz, vagy akit az intézkedés érint.
(4) A jogorvoslati határidő - e törvény eltérő rendelkezésének hiányában - a közléstől, az intézkedés elmulasztása esetén az erről való tudomásszerzéstől számított nyolc nap.
(5) A törvényben kizárt, az arra nem jogosulttól származó, az elkésett vagy az ismételten azonos tartalommal benyújtott jogorvoslati kérelmet a szabálysértési hatóság, az ügyész vagy a bíróság elutasítja. A törvényben kizárt, az arra nem jogosulttól származó, valamint az ismételten azonos tartalommal benyújtott jogorvoslati kérelmet elutasító határozat vagy végzés ellen további jogorvoslatnak nincs helye; az ilyen jogorvoslati kérelem elbírálását a szabálysértési hatóság, illetve a bíróság mellőzi, és erről a kérelem előterjesztőjét öt napon belül értesíti.

аймгийн шүүхэд хандана.[13] Засгийн газрын тогтоолд заасан тохиолдолд зөрчлийн маргааныг шүүх хурал зарлахгүйгээр, шүүгч, шүүхийн нарийн бичгийн даргын удирдлага, хяналтын дор шүүхийн хэрэг хөтлөгч /манайхаар шүүгчийн туслах/ шийдвэрлэж болно.[14]

1.4. Зөрчилд шийтгэл оногдуулсан шийдвэрийг шүүхэд давж заалдах процесс

Унгар улсад зөрчлийн хэрэг шалган шийдвэрлэх тусгай шүүх байхгүй, харин Засгийн газрын алба, хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд цагдаагийн байгууллага, татвар, гаалийн алба, бусад эрх бүхий байгууллага болон орон нутгийн шүүх /сум, дүүргийн/ харьяаллын дагуу шийдвэрлэдэг. Шүүхэд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг шүүгч дангаараа, шүүгчийн туслах шүүгчийн удирдлага, хяналтын дор явуулж, 30 хоногийн дотор, цугларсан баримт бичигт үндэслэн шийдвэр гаргана.

Баривчлах шийтгэл оногдуулах шаардлагатай зөрчил шалган тогтоох ажиллагааны анхан шатанд орон нутгийн шүүхийн харьяалалд багтана.[15] Харин зөрчилтэй холбоотой хэрэг маргааныг шийдвэрлэх ажиллагаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг өргөн хэрэглэдэг. Хуулийн 82/А зүйлд эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагааны зорилго нь зөрчлийн улмаас үүссэн үр дагаврыг арилгах, зөрчлийн хэрэгт холбогдсон этгээд цаашид дахин зөрчил гаргахгүй байхад, мөн зөрчил гаргагч, хохирогчийг эвлэрүүлэх гэрээ байгуулахад дэмжлэг үзүүлэх явдал гэж тайлбарласан байна.

ХОЁР. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

2.1. Ерөнхий ойлголт

ОХУ-д Захиргааны зөрчил шалган шийдвэрлэх журмыг Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хуулиар[16] зохицуулдаг. Хууль нь 2001 оны 12 дугаар сарын 20-нд төрийн думаар ёсчлогдон 2001 оны 12 дугаар сарын 26-ны өдөр ОХУ-ын зөвлөлөөр батлагдсан байна.

Уг хууль нь ОХУ-ын Үндсэн хууль болон олон улсын хэм хэмжээгээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, олон улсын гэрээнд үндэслэх бөгөөд хэрэв захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хууль олон улсын гэрээ, бусад дүрэмд нийцээгүй бол олон улсын хэм хэмжээ, дүрмийг баримтлана хэрэглэнэ гэж тусгагджээ. ОХУ 2016 онд Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хуульдаа шинэчилсэн найруулга хийж 32 бүлэг, 32 заалттай болсон.

Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хуулийн зорилт нь иргэн, хүний эрх, эрх чөлөө, эрүүл мэнд, эрүүл ахуй, нийтийн ёс суртахуун, байгаль орчныг хамгаалах, төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд тогтоосон журам гаргах, нийгмийн аюулгүй байдал, эд хөрөнгө, төр нийгэм, хуулийн этгээд, хүний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд оршино.

---

[13] 42. § (1) Az első fokú bíróság végzése ellen benyújtott fellebbezést másodfokon a törvényszék tanácsülésen bírálja el.

[14] kormányrendeletben meghatározott esetekben, tárgyaláson kívül, bíró vagy bírósági titkár irányítása és felügyelete mellett bírósági ügyintéző is eljárhat.

[15] Хуулийн 117 дугаар зүйл.

[16] ОХУ-ын Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хууль 2001 он

Уг хуулийн 4 дүгээр зүйлд дараах үндсэн зарчмуудыг тусгажээ.[17] Үүнд:

1. Захиргааны эрх зүйн зөрчил гаргасан этгээдэд хариуцлага оногдуулахдаа Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хуульд заасан журмыг баримтлах;

2. Иргэнд захиргааны шийтгэлийг иргэнд оногдуулахдаа түүний санхүүгийн чадавхи, гэм буруугийн шинж байдал зэргийг харгалзан хариуцлагыг хүндрүүлэх болон хөнгөрүүлэх;

3. Захиргааны зөрчилд оногдуулах шийтгэлийг хуулийн этгээдэд хүлээлгэхдээ хуулийн этгээдийн хөрөнгө болон санхүүгийн байдал, зөрчлийн гэм буруугийн шинжийг харгалзан хариуцлагыг хүндрүүлэх эсхүл хөнгөрүүлэх;

4. Захиргааны эрх зүйн нэг зөрчилд нэг хариуцлага хүлээлгэх.

2.2. Зөрчил шалган тогтоох тодорхой ажиллагааг прокурор эсхүл шүүхийн зөвшөөрлөөр хэрэгжүүлдэг журмыг хуульчилсан эсэх

Захиргааны зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаан дахь прокурорын оролцоог Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.7 дахь заалт болон Прокурорын тухай хуулиар зохицуулсан байна. Прокурорын тухай хууль нь 1992 оны 1 дүгээр сарын 17-нд батлагдсан бөгөөд тус хуульд Прокурор эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан шаардлагыг тогтоосон хугацаанд заавал биелүүлэх үүрэгтэйг онцолсон байна.[18] Прокурорын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3-т заасны дагуу прокурор болон түүний орлогч захиргааны зөрчил үйлдэгдсэн нь тогтоогдсон тохиолдолд дараах арга хэмжээг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Шүүх байгууллагын шийдвэрийн үндсэн дээр бус хууль бусаар захиргааны баривчлагдсан этгээдийг суллах;
- Хуулийн зөрчлийг арилгах тухай санал оруулах гэх мэт.

ОХУ-ын Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хуульд орон нутгийн өөрөө удирдах байгууллага болон төлөөллийн байгууллагууд хариуцагчаар татагдах боломжтой. Дээрх байгууллагуудын шийдвэр, үйл ажиллагаа хууль зөрчсөн бол иргэн прокурорт мэдэгдэх эрхтэй. Прокурор уг асуудлыг шалгаж үзээд үндэслэлгүй нь тогтоогдвол зөрчлийг нэн даруй арилгах шаардлага хүргүүлдэг байна.[19] Уг шаардлагыг биелүүлэх хугацааг прокуророос тогтоох бөгөөд орон нутгийн байгууллага 10 хоногийн дотор прокурорын шаардлагыг хэлэлцэн хариу мэдэгдэнэ. Прокурорын санал гаргасан өдрөөс сарын хугацаанд хуульд заасан зөрчлийг / шалтгаан, нөхцөл/ арилгахаар тодорхой арга хэмжээ авч, түүнийг прокурорт мэдэгдэх үүрэгтэй. Мөн прокурор хуулийн этгээд болон албан тушаалтанд дахин зөрчил гаргахгүй байх талаар бичгээр сануулга өгдөг.

Захиргааны эрх зүйн зөрчилтэй холбоотой хэргийг байгууллага, албан тушаалтны шалгах хугацаа 15 хоног байна.

Шүүхээс захиргааны эрх зүйн зөрчилтэй холбоотой хэргийг хянан шийдвэрлэх хугацаа 2 сар байх бөгөөд оролцогчдоос хүсэлт гаргавал нэмэлт мэдээлэл, нотлох баримт цуглуулах зорилгоор шүүгч 1 сар хүртэл хугацаагаар сунгаж болно.

Хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл зөрчил үйлдэгдсэнээс хойш 60 хоногийн дотор эрх бүхий этгээдийн дээд шатны байгууллага болон шүүхэд хандана.

2.3. Зөрчилд шийтгэл оногдуулсан улсын байцаагчийн шийдвэрийг давж заалдах ажиллагаа

Захиргааны зөрчилд хариуцлага оногдуулах эрх бүхий этгээд нь байцаагч байна.[20]

[17] ОХУ-ын Зөрчлийн эрх зүйн зөрчлийн тухай хуулийн 4 дүгээр заалт

[18] ОХУ-ын Прокурорын тухай хуулийн 9.1, 22, 27, 30, 33 дугаар зүйл

[19] ОХУ-ын Прокурорынтухайхуулийн 22 дугаарзүйлийн3 дахь заалт

[20] https://ru.wikipedia.org/

Байцаагч нь дотроо Замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын байцаагч, Хөдөлмөрийн байцаагч, Замын эргүүлийн алба, Насанд хүрээгүй хүүхдийн хэргийн байцаагч, Байцаагчийн комисс, Москва хотын захиргааны замын байцаагч, Дансны төлөлтийн байцаагч, Улсын галын албаны байцаагч, Ажлын албаны байцаагч гэх мэт үйл ажиллагааны чиглэлээр ажиллана.[21]

Дээрх байцаагч нараас жишээ дурдахад хөдөлмөрийн улсын байцаагч хөдөлмөрийн хэм хэмжээ агуулсан акт, хөдөлмөрийн хуулийг баримтлах холбооны төрийн хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй. Орон нутгийн өөрөө удирдах байгууллага, гүйцэтгэх эрх мэдэлтэй байгууллага, өөр бусад байгууллагын ажил олгогч, түүний төлөөлөгчөөс үнэ төлбөргүйгээр хяналт шалгалтыг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээлэл, бичиг баримт, тайлбар авах эрхтэй.[22]

Хөдөлмөрийн улсын байцаагч хөдөлмөрийн хуулинд заасан эрх зүйн хэм хэмжээний актыг илт зөрчсөн тохиолдолд зөрчлөө нэн даруй арилгах үүргийг ажил олгогчид даалгана. “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн 357 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан.

Ажил олгогч тушаал гарснаас 10 хоногийн дотор шүүхийн журмаар улсын байцаагчийн тушаалд гомдол гаргаж болно. Хууль бус үйлдэл эс үйлдэлдээ хөдөлмөрийн тухай хуулийн 364 дүгээр зүйлд зааснаар улсын байцаагч хариуцлага хүлээнэ.

Хэрэв албаны этгээд хөдөлмөрийн улсын байцаагчийн шийдвэртэй санал нэг байгаа бол тухайн шийдвэрийг гүйцэтгэн тогтоолд заасан тогтоосон хугацаанд захиргааны торгуулийг төлнө. ОХУ-ын захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хуулийн 32.2 дугаар зүйлд зааснаар тогтоол хүчин төгөлдөр болж эхэлсэн өдрөөс 30 хоногоос хэтрэхгүй захиргааны хариуцлагад татагдаж байгаа этгээд захиргааны торгуулиа төлөх ёстой. Захиргааны хариуцлагад татагдаж байгаа хүн хамаарах дээд шатны байгууллага, дээд албан тушаалтан, дүүргийн шүүхэд Захиргааны эрх зүйн зөрчлийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн дагуу гомдол мэдүүлж болно.

Улсын байцаагч болон цагдаагийн албан хаагч тухайн захиргааны зөрчил гаргасан этгээд, хуулийн этгээдэд торгууль бусад албадлагын арга хэмжээ ноогдуулж тус арга хэмжээг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн тохиолдолд дээд шатны байгууллага болон албан тушаалтанд хандаж тус шийтгэвэрийн хуудсыг хэвээр үлдээсэн бол захиргааны хэргийн дагнасан шүүхэд гомдол гаргана. Тус шүүхийн гаргасан тогтоол өмнөх байгууллага, албан тушаалтны процесс ажиллагаатай адил шийдвэр гаргавал харьяалах дээд шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

Прокурор ахлах байцаагчийн гаргасан тогтоол, шийдвэрт захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хууль, бусад хуулийг зөрчсөн эсэхэд ахлах байцаагч, бусад дээд албан байгууллага, анхан шатаар шийдэгдсэн шийдвэрийг давж заалдаж болно.

2.4. Зөрчилд шийтгэл оногдуулсан шийдвэрийг шүүхэд давж заалдах процесс

Зөрчилд шийтгэл оногдуулсан шийдвэрт давж заалдах шатны шүүхэд гомдол гаргахад дараах дарааллыг баримтална. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид уг хуулийн 25.2-25.5 дугаар зүйлд хохирогч, иргэний болон хуулийн этгээдийн төлөөлөгч, өмгөөлөгч, гэрчийн хүсэлтээр прокурор дараах байдлаар давж заалдаж болно. Үүнд:

- Шүүгчийн шийдвэрийг дээд шатны шүүхэд;
- Хамаарал бүхий этгээд (collegiate body) харьяалах дүүргийн шүүхэд дамжуулах;
- Байцаагчийн гаргасан шийдвэрийг дээд албан (superior body) тушаалтан эсхүл харьяалах дүүргийн шүүхэд;

wiki/%D0%98%D0%BD%D1%81%D0%BF%D0%B5%D0%BA%D1%82%D0%BE%D1%80

[21] http://madi.mos.ru/about/polozhenie_o_departamente/

[22] ОХУ-ын Хөдөлмөрийн тухай хуулийн 357 дугаар зүйл

- ОХУ-ын хуультай холбоотой бусад этгээдийн шийдвэрийг тухайн харьяалах шүүхийн шийдвэрийг тус тус давж заалдаж болно гэж заасан.

Тухайлбал байцаагчийн гаргасан шийдвэрийг дүүргийн шүүхэд давж заалдаж болно. Дүүргийн шүүхийн шийдвэрт гомдолтой бол дээд шүүхэд (upper court), бүс нутгийн шүүх болон бусад хамаарагдах шүүхэд заалдаж болно. Харин бүс нутгийн шүүх болон бусад хамаарах шүүхийн шийдвэрийг дахин заалдах боломжийг хуульд нарийвчлан тусгаагүй байна. ОХУ-ын Москва хотын шүүх, Мужийн шүүх, Хязгаарын шүүх, Республикийн дээд шүүхүүдэд Дээд шүүх, Автономит мужийн, Автономит тойргийн шүүх, эсэргүүцэл гаргах, гомдол өгч болно.

Албаны этгээд /байцаагч/, дээд шатны албан тушаалтны гаргасан тогтоолыг зөрчил гаргагч хүн зөвшөөрөхгүй бол харъяалагдах шүүх, дээд шатны шүүхэд гомдлоо гаргаж болно. Шүүхэд гаргасан гомдлыг шүүхэд ирсэн өдрөөс 1 сарын дотор хянаж шийдвэр гаргана.

Зөрчлийн хуулийн 30.2 дугаар хэсэгт зааснаар зөрчлийн хэргийн шийдвэрийг дээд шүүх, ахлах байцаагч, болон зөрчил хянан шийдвэрлэх шүүхээр давж заалдана. Шүүгчийн зөрчлийн шийтгэл оногдуулсан шийдвэрийг тухайн давж заалдах өдөртөө дээд шүүхэд өргөн барьж болно. Зөрчлийн шийтгэл оногдуулсан шийдвэрийг Зөрчлийн 30.5 дугаар зүйлд заасан хугацаан дотор давж заалдана. Иргэн, хуулийн этгээд зөрчлийн шийдвэрийг хүлээн авсан хоногоос 10 хоногийн дотор давж заалдаж болно.

ГУРАВ. БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛСЫН ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

3.1. Ерөнхий ойлголт

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан хуультай орнуудын дундаас Бүгд Найрамдах Казахстан Улсыг /цаашид БНКУ гэх/ сонгон, ХЗДХЯ-наас ирүүлсэн асуудлын хүрээнд тухайн улсын зохицуулалтаас судаллаа. БНКУ нь 2014 оны 07 дугаар сарын 05-ны өдөр 53 бүлэг, 920 зүйл анги бүхий “Захиргааны эрх зүйн зөрчил”-ийн тухай хуулийг баталж, 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан.

БНКУ-ын “Захиргааны эрх зүйн зөрчил”-ийн тухай хуулийн 6 дугаар зүйлд энэ хуулийн зорилгыг тодорхойлсон байх ба “Иргэн, хувь хүний хууль ёсны ашиг сонирхол, эрх, эрх чөлөө, эрүүл мэнд, эрүүл аюулгүй орчинд амьдрах баталгааг хангах, байгаль орчин, нийгмийн ёс суртахуун, хуулийн этгээдийн ашиг сонирхол, хуулиар баталгаажуулсан эрхийг хамгаалах, төрийн байгууллага, эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм журмыг дагаж мөрдүүлэх, нийгмийн аюулгүй байдлыг хангах, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд оршино.

Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хуулиар захиргааны хариуцлагад тооцох үндэслэл, зарчмыг тогтоох, ямар үйлдлийг зөрчилд тооцох, зөрчил гаргасан этгээдэд ямар төрийн байгууллага, албан тушаалтан, ямар шийтгэлийг, ямар журмаар оногдуулах асуудлыг зохицуулдаг. Тухайлбал уг хуулийн 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт[23] “Захиргааны шийтгэл гэж зөрчил гаргасан этгээдийн эрх, эрх чөлөөг хязгаарлах болон зарим эрхийг хасах тухай хууль тогтоомжоор олгогдсон эрх бүхий байгууллага, албан тушаалтан, шүүхийн зүгээс авч хэрэгжүүлж буй албадлагын арга хэмжээ мөн” гэж заасан. Мөн захиргааны шийтгэл нь зөрчил гаргасан этгээдийг хүмүүжүүлэх, хууль журмыг сахих, хүндэтгэх байдлыг дээшлүүлэх, зөрчил гаргагч болон бусад этгээдийг зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн байх ба хувь хүн, хуулийн этгээдийн нэр хүндэд халдах, доромжлох, бие махбодь, сэтгэл санааны хохирол учруулах зорилго агуулахгүй гэж заажээ.

Тус улсын Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хууль дахь зарим онцлог заалтаас дурдахад, энэ хуулийн 74 дүгээр зүйлд Бүгд Найрамдах Казахстан улсын

[23] БНКУ-ын Захиргааны эрх зүйн зөрчилийн тухай хуулийн 40 дүгээр заалтын 1-5 дахь хэсэг

иргэншлийг авахад саад учруулсан албан тушаалтан хуулийн этгээдийн хууль бус үйлдэл, эс үйлдэлд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний тенгегээр торгууль ногдуулдаг. Харин энэ үйлдлээ 1 жилийн хугацаанд давтан үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 60 дахин нэмэгдүүлэх хэмжээний тенгегээр торгодог. Харин хуулийн 73 дугаар зүйлд гэр бүлийн харилцаан дахь зарим хууль бус үйлдлийг зөрчилд тооцохоор тусгасан бөгөөд тухайлбал "хүнийг зүй бусаар хараах, басамжлан доромжлох, гэрийн эд хогшлыг эвдэж сүйтгэсэн, гэр бүл ахуйн харилцаанд гарсан, тэдний амгалан тайван байдлыг алдагдуулсан, хүндэтгэлгүй хандсан зэрэг эрх зүйн зөрчил гаргасан этгээдэд, хэрэв энэ үйлдэл нь гэмт хэргийн шинж агуулаагүй 3 хүртэлх хоногийн хугацаанд захиргааны баривчилгаанд татдаг, хэрэв энэ үйлдлээ 1 жилийн дотор давтан үйлдвэл 10 хоног баривчилдаг бол 2-оос дээш удаа энэ төрлийн зөрчил гаргасан этгээдэд хөдөлмөрийн хөлсний сарын доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү тенгегээр торгууль ногдуулах шийтгэл оногдуулдаг байна.

Захиргааны зөрчилтэй холбогдуулан гаргасан шийдвэр хувь хүн, хуулийн этгээдийн Бүгд Найрамдах Казахстан улсын Үндсэн хууль болон бусад хуулиар баталгаажсан хууль ёсны ашиг сонирхол, эрхийг зөрчсөн гэж үзвэл тухайн шийдвэрийн аль нэг хэсгийг эсхүл бүхэлд нь давж заалдах боломжтой ба өргөдлөө шүүхэд гаргана.

Захиргааны зөрчил гаргасан этгээдэд хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу дараах төрлийн шийтгэл оногдуулахаар хуульчилсан байна. Үүнд:

1. Сануулах;

2. Торгох /хувь хүнд нэг өдрийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг[24] 500 дахин, албан тушаалтанд 700 дахин, аж ахуйн нэгжид 1000 дахин, томоохон хуулийн этгээдэд 2000 дахин нэмэгдүүлсэн хэмжээтэй дүйцэхүйц хэмжээний торгууль ногдуулдаг/;

3. Зөрчил үйлдсний үр дүнд олж авсан эд хөрөнгө, эд мөрийн баримт эсхүл зөрчил үйлдсэн зүйлийг хураан авах;

4. Зөрчил гаргахад хэрэглэсэн эд зүйл, багаж хэрэгслийг хураан авах;

5. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх хасах /1 сараас 2 жил хүртэл/;

6. Тусгай зөвшөөрөл хураах, тодорхой үйл ажиллагаа явуулахыг зогсоох /6 сар хүртэл хугацаагаар/, данс битүүмжлэх;

7. Үйл ажиллагаа эрхлэхийг хориглох эсхүл зогсоох /10 хоног хүртэл/;

8. Хууль бусаар барьсан болон баригдаж байгаа барилгыг албадан буулгах;

9. Захиргааны баривчилгаа /30 хоног хүртэл/, баривчилгааны хугацааг 3 цагаас хэтрэхгүй хугацаагаар сунгаж болно гэж заасан.

Үүнээс үзэхэд захиргааны эрх зүйн зөрчил гаргасан этгээдэд оногдуулсан хамгийн хүнд шийтгэл нь захиргааны баривчилгаа бол хуулийн этгээдийн хувьд их хэмжээний торгууль ногдуулах эсхүл үйл ажиллагааг нь зогсоох, зарим тохиолдолд тодорхой үйл ажиллагаа явуулах лиценз, эд хөрөнгө хураах зэрэг зохицуулалт оруулсан байна.[25]

3.2. Зөрчил шалган тогтоох тодорхой ажиллагааг прокурор эсхүл шүүхийн зөвшөөрлөөр хэрэгжүүлдэг журмыг хуульчилсан эсэх

Прокурорын оролцоо

Прокурор нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх ажиллагаа хуулийн тогтоомжийн хүрээнд хийгдэж байгаа эсэхийг шалгадаг. Прокурор зөрчил илрүүлээд протокол /тогтоол/ үйлдсэний дараа 3 хоногийн

[24] БНКУ-д хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1 өдрийн ажилд олгох цалингаар тооцдог. 1 өдрийн ажлын хөлс нь 2017 онп дунджаар 2100 тенге /ойролцоогоор 21000 төгрөг/ байна.

[25] http://vko.kgd.gov.kz/ru/news/news/pravo-na-zashchitu-poryadok-obzhalovaniya-postanovleniya-o-privlechenii-k-administrativnoy

хугацаанд, байгууллага, албан тушаалтай хүнд, шүүх бичгээр авч үзэж хянуулах, зөрчлийг арилгуулахаар явуулна. Захиргааны эрх зүйн зөрчил гаргасан этгээдийн гэм буруутай үйлдлийн тухай өөрийн саналаа эрх бүхий байгууллага, шүүхэд бичнэ.

Прокурор өөрийн санаачилгаар захиргааны эрх зүйн зөрчил гаргасан хувь хүн, хуулийн этгээдэд хэрэг үүсгэдэг. Прокурорт гомдлоо тогтоосон хугацаанд гаргаж прокурорын хяналтын ажиллагааны үед захиргааны шийтгэл оногдуулах үйл ажиллагааг түр түдгэлзүүлнэ. Зөрчлийн хэрэгт нэмэлт шалгалт явуулах зорилгоор тусгай эрх бүхий албан тушаалтан, байгууллагад бичгээр хандах, прокурорын хууль ёсны шалгалтын үед захиргааны шийтгэл оногдуулах тухай тогтоол гүйцэтгэх ажиллагааг зогсоох эрхтэй байдаг.[26] Шалгалтын үр дүнгээр зохих байгууллагад эсэргүүцэл бичих, тогтоолыг цуцлах, өөрчлөх зэрэг эрх хэмжээтэй байна.

Захиргааны эрх зүйн зөрчилтэй холбоотой прокурорын гаргасан тогтоолыг эс зөвшөөрвөл дээд шатны прокурорт 3 хоногийн дотор гомдол гаргадаг. Захиргааны эрх зүйн зөрчлийн хэрэгт БНКУ-ын Ерөнхий прокурор, түүний орлогч, аймгийн прокурор, түүнтэй адилтгах прокурор хяналтын журмаар шалгалт явуулахаар шүүгчид шаардлага хүргүүлж болно.

3.3. Зөрчилд шийтгэл оногдуулсан улсын байцаагчийн шийдвэрийг давж заалдах ажиллагаа

Захиргааны эрх зүйн зөрчлийн (827 дугаар зүйл) хэргийг хөтөлж, шийдвэр гаргах байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэлд дээд шатны байгууллага, албан тушаалтан, дүүргийн болон түүнтэй адилтгах захиргааны дагнасан шүүхэд гомдол мэдүүлж болно. Эрх бүхий албан тушаалтан гаргасан шийдвэрийнхээ үндэслэл, баримтыг нотлох үүрэг хүлээнэ. Шийдвэр гаргасан албан тушаалтанд өөрийн гаргасан шийдвэрт холбогдох гомдлыг авч хянуулахаар даалгахыг хориглоно.

Хууль ёсны ашиг сонирхол, эрх зөрчигдсөн өдрөөс хойш 2 сарын дотор гомдлоо дээд шатны байгууллага, шүүхэд хандах эрхтэй.[27] Захиргааны эрх зүйн зөрчилд татагдсан этгээдийг баривчлах, прокурор хэрэг үүсгэх тогтоол гаргах, хэргийн оролцооны үеэс өмгөөлөгч ямар ч шатанд хууль ёсны эрхийг хамгаалах зорилготой орж болно.

Хүний гэм буруутай үйлдлийг нь нотолж чадаагүй байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийн улмаас учирсан хохирлоо барагдуулах асуудлаар албан ёсны уучлал /извинение/ бичгээр гуйж шийдвэр гаргана. Сэтгэл санааны хохирол учруулсан тохиолдолд хохирлыг мөнгөн хөрөнгөөр нөхөн төлөх бөгөөд энэ тухай нэхэмжлэлийг иргэний хэрэг шүүн таслах ажиллагааны журмаар явуулна. Шүүх, байгууллага, албан тушаалтны гэм буруутай үйлдлээс болж учирсан хохирлыг БНКУ-ын төсвөөс гаргана.

Төрийн байгууллага, албан тушаалтны үйлдэл, шийдвэр Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, хэм хэмжээний эрх зүйн актыг зөрчсөн гэж үзвэл түүнд эсэргүүцэл бичнэ. Прокурорын эсэргүүцлийг календарны өдрийн 10 хоногийн хугацаанд байгууллага, албан тушаалтан хянаж үзэх ёстой. Тогтоосон хугацаанд прокурорын тогтоолыг гүйцэтгээгүй бол хуулиар заасан хариуцлага хүлээнэ[28]. Прокурор хуульд заасан бусад тохиолдолд захиргааны эрх зүйн зөрчлийг арилгах хэрэг үүсгэн шалгалт явуулж болно.

3.4. Зөрчилд шийтгэл оногдуулсан шийдвэрийг шүүхэд давж заалдах процесс

Дүүргийн, түүнтэй адилтгах захиргааны хэргийн төрөлжсөн шүүгч захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хэргийг шалгаж хянадаг.

---

[26] БНКУ-ын Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хуулийн 834 дүгээр заалт

[27] БНКУ-ын Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хуулийн 828 дугаар зүйл

[28] БНКУ-ын Прокурорын байгууллагын тухай хуулийн 19-20 дугаар зүйл

Дүүрэг хоорондын төрөлжсөн шүүхийн шүүгч насанд хүрээгүй хүүхдийн хэргийг энэ хуулийн 435, 436.3, 438.3, 440.4.5, 442.3, 448 заалтуудаар хянадаг. Төрийн байгууллага, албан тушаалтан шүүгчийн тогтоолд заасан хугацаанаас илүү хууль бусаар баривчилсан этгээдийг нэн даруй суллах үүрэгтэй. Захиргааны эрх зүйн зөрчлийн оролцогчдын хэнийг ч гутаан доромжлох, эрүү шүүлт тулгаж болохгүй.

Байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг эс зөвшөөрч шүүхэд гомдол гаргаж болно. Тус шүүхийн шийдвэр мөн адил гарсан тохиолдолд давж заалдах шатны шүүхэд хандах эрх нь нээлттэй. Захиргааны баривчилгаа 30 хоног хүртэлх хугацаатай байна. Мөн онц байдал зарласан үед 45 хоног хүртэлх хугацаагаар баривчилж болно. Захиргааны баривчилгааг 14 нас хүрээгүй хүүхэдтэй эх, жирэмсэн эмэгтэй, 18 нас хүрээгүй хүүхэд, 1-2 зэрэглэлийн хөгжлийн бэрхшээлтэй хүн, 58 наснаас дээш насны эмэгтэй хүн, 60 настай эрэгтэй хүнд хэрэглэж болохгүй. Захиргааны түр саатуулах хугацааг захиргааны баривчилгааны хугацаанд тооцно.

ДӨРӨВ. ГҮРЖ УЛСЫН ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

4.1. Ерөнхий ойлголт

Гүрж улсын парламентаас Захиргааны зөрчлийн тухай хуулийг 1985 онд баталжээ. Уг хууль нь 5 хэсэг, 32 бүлэг, 314 зүйлээс бүрдэнэ. Захиргааны зөрчлийн тухай хуулийн зорилт нь эд хөрөнгө, нийгэм, эдийн засаг, улс төрийн болон иргэдийн эрх ашиг, эрх чөлөө, аж ахуйн нэгж, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад нийгмийн хэв журмыг сахих, иргэний эрх ашгийг хүндэтгэх явдал болно.

Олон улсын байгууллагын зүгээс Гүрж улсын Захиргааны зөрчлийн тухай хуулийн зарим зохицуулалтад ихээхэн шүүмжлэлтэй ханддаг байна. Энэ нь Хүний эрхийн тухай европын конвенцийн 6 дугаар зүйлд заасан “шударгаар шүүлгэх эрх”-ийн талаар хуульд тодорхой тусгаагүйтэй холбоотой.

Зөрчил гаргасан болон гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шалган шийдвэрлэх процесс ижил төстэй хуульчлагдсан нь ял оногдуулах ажиллагааны процессын ялгамжтай байх зарчимд үл нийцсэн гэж үзэж байжээ. Өөрөөр хэлбэл жижиг зөрчил үйлдсэн этгээдийг эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн этгээдтэй ойролцоо түвшинд шалгах явдал[29] нь зөрчил гаргагчийн эрхийг дордуулж байгаа гэж тайлбарласан байна.

Гүрж улс 2014 онд Захиргааны зөрчлийн тухай хуульдаа шинэчлэл хийж олон шинэлэг зохицуулалтыг нэвтрүүлсэн байна. Энэ хүрээнд өмнө зөрчил гаргасан этгээдэд цагдан хорих хугацаа 90 хоног байсныг 15 хоног болгон өөрчилсөн зэрэг олон улсын эрх зүйн зарчимд нийцсэн эерэг хандлагатай хууль болсон гэж үнэлэгдэх болжээ.

4.2. Зөрчил шалган тогтоох тодорхой ажиллагааг прокурор эсхүл шүүхийн зөвшөөрлөөр хэрэгжүүлдэг журмыг хуульчилсан эсэх

Захиргааны зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд прокурорын оролцоо ямар байх талаар хуульчилсан. Захиргааны зөрчлийн тухай хуулийн 238 дугаар зүйлд зааснаар прокурор захиргааны зөрчлийн хэрэг бүртгэлтэд хяналт тавих[30] бөгөөд хэргийн материалтай танилцах, эрх бүхий албан тушаалтны оногдуулсан арга хэмжээнд хуулийн дагуу хяналт тавих, захиргааны зөрчлийн талаарх шүүхийн шийдвэрт гомдол гаргах, эсэргүүцэл бичих зэрэг хуульд заасан бусад үүргийг хэрэгжүүлнэ. Мөн захиргааны зөрчлийг шалгах явцад гэмт хэргийн шинжтэй болох нь тогтоогдвол холбогдох материалыг прокурорын байгууллага болон мөрдөн байцаах байгууллагад шилжүүлнэ.[31]

[29] Зөрчил гаргасан этгээдийг 90 хүртэл хоног цагдан хорих эрхтэй байна.

[30] Administrative Offences of Code of Georgia, Article 238

[31] Administrative Offences of Code of Georgia, Article 238

4.3. Зөрчилд шийтгэл оногдуулсан улсын байцаагчийн шийдвэрийг давж заалдах ажиллагаа

Гүрж улсын Захиргааны зөрчлийн тухай хуулийн 272 дугаар зүйлийн 272.1 дэх хэсэгт эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг давж заалдах журмууд доорх байдлаар тусгасан.[32] Үүнд:

- Иргэн захиргааны зөрчил оногдуулсан шийдвэр давж заалдах гомдол, прокурор эсэргүүцэл бичиж болно. Гомдол, эсэргүүцлийг шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор тухайн эрх бүхий албан тушаалтнаар дамжуулан дээд шатны албан тушаалтанд гаргана.
- Эрх бүхий албан тушаалтан захиргааны шийтгэлийг өөрчилсөн тохиолдолд уг шийдвэрийг дээд албан тушаалтанд эсхүл дүүргийн (хотын) шүүхэд давж заалдаж болох ба тухайн шийдвэр эцсийн байна.
- Эрх бүхий албан тушаалтан захиргааны шийтгэлийг анхааруулах хэлбэрээр мөн илтгэх хуудас бичилгүйгээр оногдуулсан тохиолдолд дээд шатны албан тушаалтанд давж заалдаж болно. Эрх бүхий албан тушаалтан захиргааны шийтгэлийг өөрчилсөн тохиолдолд уг шийдвэрийг дээд албан тушаалтанд эсхүл дүүргийн (хотын) шүүхэд давж заалдаж болох ба тухайн шийдвэр эцсийн байна.
- Захиргааны зөрчилтэй холбоотой гаргасан шийдвэрийг тухайн шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргаж болно. Энэ тохиолдолд 3 хоногийн дотор тухайн давж заалдаж буй албан тушаалтанд шийдвэрийг бусад бичиг баримтын хамт илгээх үүрэгтэй.
- Хэрэв захиргааны торгууль оногдуулсан шийдвэрийг давж заалдаж байгаа тохиолдолд төлбөр авах зохицуулалттай. Торгох шийтгэлийн хувьд захиргааны зөрчлийн шийдвэр гарснаас хойш 10 хоногийн дотор давж заалдаж болно.[33]

Гомдол, эсэргүүцэл бичих явцад эрх бүхий албан тушаалтнаас шалтгаалан хуулиар тогтоосон хугацаа хэтэрсэн бол хугацааг дахин сэргээж тогтоодог байна. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 251 дүгээр зүйлд баримт бичиг хураах, нэгжлэг хийх, баривчлан саатуулсан тохиолдолд энэ талаар эрх ашиг нь зөрчигдсөн этгээд прокурор, эсхүл удирдах албан тушаалтанд давж заалдах гомдол гаргаж болдог.[34]

Прокурорын эсэргүүцлийг шүүх хуралд авч хэлэлцэх хүртэл захиргааны зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг түр түдгэлзүүлнэ. Прокурорын эсэргүүцлийг хэлэлцсэний дараа захиргааны зөрчлийн шийдвэрийг 7 хоногийн дотор хохирогч болон прокурорт мэдэгдэнэ.

4.4. Зөрчилд шийтгэл оногдуулсан шийдвэрийг шүүхэд давж заалдах процесс

Гүрж улсад захиргааны зөрчлийг дүүргийн захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэнэ. Гүржийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн дагуу дүүрэггүй зохион байгуулалттай хотод хотын шүүх, дүүрэгтэй хотод дүүргийн шүүх байна.[35] Давж заалдах шатны шүүх нь дүүргийн, мужийн шүүхийн шийдвэртэй холбогдсон гомдлыг давж заалдах шатны журмаар хянан хэлэлцэнэ. Мөн зөрчлийн хэрэг зохицуулах дотоод хэргийн байгууллагууд (agencies of internal affairs), улсын мэргэжлийн хяналтын байгууллага (state inspection agencies) болон эрх бүхий албан тушаалтан (officials) тухайн зөрчлийг шийдвэрлэнэ.

Захиргааны зөрчлийн хэрэг болох Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, Аж үйлдвэр, Эрчим хүчний үйлдвэр, Аж ахуй нэгжийн үйл ажиллагааны захиргааны зөрчлийн хэрэг Дүүргийн (хот) шүүхэд хамаарна.

---

[32] Administrative Offences of Code of Georgia, Article 272.1

[33] Administrative Offences of Code of Georgia, Article 273

[34] Administrative Offences of Code of Georgia, Article 271

[35] Ж.Амарсанаа нар, Дэлхийн Улсуудын Шүүхийн тогтолцоо, УБ; 2005, 9.

Тээврийн хэрэгслийн жолооч замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм зөрчих, Тусгай хамгаалалттай газрын захиргааны зөрчлийг дотоод хэргийн байгууллагад хэлэлцдэг. Нутгийн өөрөө удирдах газрын нийтийн тав тухтай байдлыг хангах, барилгын материал хог хаягдлыг устгах, далайн боомтын ачаа ачих, буулгах, хадгалахтай холбоотой захиргааны зөрчлийг Нутгийн өөрөө удирдах байгууллага тус тус хэлэлцдэг.[36]

Захиргааны зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 279 дүгээр зүйлд захиргааны зөрчил шалган шийдвэрлэх шүүх болон удирдах албан тушаалтанд (superior agency of internal affairs) давж заалдах бүрэн эрхтэй байхаар тусгажээ.[37]Прокурорын эсэргүүцлээр эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг дээд шатны албан тушаалтанд давж заалдаж болно.

Дээд шатны албан тушаалтны шийдвэрийг дүүргийн шүүхэд, дүүргийн шүүх хэлэлцсэн шийдвэрийг давж заалдах шатны шүүхэд гаргах бөгөөд анхан шатны шүүхийн шийдвэр хууль ёсны дагуу эсэхийг шалгаж дараах шийдвэрийн аль нэгийг гаргана. Үүнд: Зөрчил оногдуулсан шийдвэрийг хүчингүй болгох, хэвээр үлдээх, өөрчлөх зэрэг багтана. Дүүргийн шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол 30 хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд хандана. Давж заалдах шатны шүүхийн шийдвэр эцсийн байна.

ДҮГНЭЛТ

Энэхүү лавлагаагаар Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газраас ирүүлсэн захиалгад дурдсан асуудлаар Бүгд Найрамдах Унгар улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, Гүрж улсуудын хүрээнд судаллаа. Энэхүү лавлагаагаар дээрх орнуудын эрх зүйн зохицуулалтад үнэлэлт дүгнэлт өгөхийг зориогүй бөгөөд харин эдгээр орнуудыг эрх зүйн зохицуулалтын зарим онцлог шинжийг илрүүлэхийг зорьсон.

1. Унгар улс зөрчил хянан шийдвэрлэх ажиллагааг зөрчлийн хуулийн хамт зохицуулсан хуулийг 2012 онд баталсан. Энэ хуулиар Зөрчил, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн бүртгэлийн тогтолцооны тухай хууль нь материаллаг болон процессын эрх зүйн зохицуулалтыг нэг дор багтаасан байхаас гадна зөрчлийн нэгдсэн бүртгэлтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг мөн агуулсан эрх зүйн акт юм. Унгар улсад зөрчлийн хэрэг маргааныг шалган тогтоох дагнасан шүүх байхгүй, харин хуульд нэр зааж оруулсан төрийн байгууллага, албан тушаалтан хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд зөрчил шалган тогтоох, хариуцлага оногдуулах эрхтэй байна.

Зөрчил гаргасан этгээдийн эрх чөлөөнд халдах буюу баривчлах шийтгэл оногдуулах асуудлыг зөвхөн шүүх шалган тогтоох, шийдвэр гаргах эрхтэй бол бусад зөрчлийн тухайд давж заалдах шатанд асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэдэг байна. Прокурор зөрчилтэй холбоотой гаргасан шийдвэрт ерөнхий хяналт тавих, шаардлагатай тохиолдолд зөрчлийн албанаас гаргасан шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөх асуудлаар давж заалдах шатны байгууллагад мэдэгдэл, хүсэлт гаргах эрхтэй. Үүнээс гадна зөрчлийн бүртгэлийн тогтолцоонд хяналт тавих үүрэгтэй, мөн шуудан, харилцаа холбооны хэрэгслээр дамжуулан илгээсэн илгээмж, захидал хураан авах зөвшөөрөл олгох эрхтэй байна.

[36] Administrative Offences of Code of Georgia, Article 209.1

[37] Administrative Offences of Code of Georgia, Article 279

2. Оросын Холбооны Улсын Захиргааны зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль гэж тусгайлан нэрлэсэн хууль хэрэгждэггүй боловч 2001 онд батлагдсан бөгөөд 2016 онд нэмэлт, өөрчлөлт оруулж батлагдсан "Захиргааны эрх зүйн зөрчил" гэсэн хуулиар захиргааны зөрчилтэй холбоотой асуудлыг шийдвэрлэдэг. Энэ хуулиар Захиргааны эрх зүйн зөрчил шийдвэрлэх, холбогдох шийдвэр гаргах эрхийг харьяалах байгууллагын улсын байцаагчид олгосон бөгөөд хэрэг маргааныг шийдвэрлэх анхан шатны байгууллага /улсын байцаагч/ байна.

Захиргааны эрх зүйн зөрчлийн оролцогч этгээд шүүх эсхүл дээд шатны албан тушаалтан, байгууллага /албан тушаалтан/-д гомдол мэдүүлнэ. Прокурор захиргааны эрх зүйн зөрчлийн оролцогчдод хуулиар олгогдсон эрхийнхээ хүрээнд хяналт тавьж ажиллана. Шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдоос үл хамааран хууль бус үйлдэл гаргасан гэж үзвэл прокурор нь дээд шатны шүүхэд эсэргүүцэл бичих эрхтэй.

Анхан шатны шүүхийн шүүгч болон дүүргийн шүүхийн шүүгчийн шийдвэрийг зөрчлийн хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 – 30.8 дугаар зүйлд заасны дагуу зөвхөн дээд шатны шүүхэд давж заалдаж болно. Автономит мужийн, Автономит тойргийн шүүх, Москва болон Санкт-Петербург хотын шүүх, Мужийн шүүх, Хязгаарын шүүх, Республик улсуудын дээд шүүхээс гаргасан хүчин төгөлдөр болсон тогтоолын эсэргүүцэл, гомдлыг ОХУ-ын Дээд шүүх хянаж тогтоол нь эцсийн байна.

3. Бүгд Найрамдах Казахстан Улс 2014 онд батлагдсан "Захиргааны эрх зүйн зөрчил"-ийн тухай хуулиа баталж, 2016 онд нэмэлт өөрчлөлт хийсэн. Энэ хуулиар захиргааны хариуцлагын үндэслэл, зарчмыг тогтоох, ямар үйлдэл, эс үйлдэл захиргааны эрх зүйн зөрчил байх, ямар төрийн байгууллага (албан тушаалтны) захиргааны эрх зүйн зөрчил үйлдсэн этгээдэд ямар журмаар шийтгэл оногдуулах зэрэг харилцааг зохицуулдаг. Казахстан Улсад энэ зөрчлийн хэрэг маргааныг шийдвэрлэхэд чиглэсэн захиргааны хэргийн шүүх байгуулсан нь энэ төрлийн зөрчил гарахад таслан сэргийлэх, урьдчилан сануулахаар төрийн байгууллага, албан тушаалтан хариуцлага оногдуулах эрхтэй зохицуулсан. Харин дээрх хүн, хуулийн этгээдийн хууль бус үйлдлийг прокурорын байгууллагаас хянан шалгах, гаргасан тушаал, шийтгэвэрийг хүчингүй болгох, өөрчлөх асуудлаар дээд шатны байгууллага, шүүхэд санал, эсэргүүцэл бичих эрхийг тусгасан.

4. Гүрж улс нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг Зөрчлийн хэрэг шалган шийдвэрлэх тухай бие даасан хуулиар зохицуулдаг байна. Тус хуульд заасны дагуу прокурорын оролцоо ямар байх талаар зохицуулсан бөгөөд прокурор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуулийн дагуу явагдаж буй эсэх, эрх бүхий байгууллагын шийдвэр хууль зүйн үндэслэлтэй эсэхэд хяналт тавьж ажилладаг байна. Түүнчлэн прокурор тухайн шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл эсэргүүцэл бичдэг байна. Гүрж улсад захиргааны зөрчлийн хариуцлагыг эрх бүхий албан тушаалтан оногдуулдаг бөгөөд иргэн тэрхүү шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл хэрэг маргааны онцлогоос хамааран дээд шатны байгууллага болон дүүргийн шүүхэд гомдол гаргах эрхтэй. Захиргааны зөрчлийн хэргийг дүүргийн захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэж байна.

Шүүхэд гомдол гаргах журмын дагуу эрх бүхий албан тушаалтны иргэнд зөрчил ногдуулсантай холбогдох гомдлыг шүүх хянан шийдвэрлэж байгаа бол эхлээд дүүргийн шүүхээр хянан шийдвэрлэнэ. Хэрэв иргэн дүүргийн шүүхээс гаргасан шийдвэрийг давж заалдах бол гомдлоо давж заалдах шатны шүүхэд гаргана. Давж заалдах шатны шүүхийн шийдвэр эцсийн байх буюу давж заалдах шатны шүүхээс дээш хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагддаггүй онцлогтой.

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Унгар улсын зөрчил, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн бүртгэлийн тогтолцооны тухай хууль
Хавсралт 2. ОХУ-ын 2001 оны захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хууль
Хавсралт 3. Бүгд найрамдах Казахстан улсын захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хууль
Хавсралт 4. Гүрж улсын зөрчил, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн бүртгэлийн тогтолцооны тухай хууль

Хавсралт 1. Унгар улс
Зөрчил, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа,
зөрчлийн бүртгэлийн тогтолцооны тухай хууль

№	Судлуулахаар захиалсан асуудлын агуулга	Хуулийн зохицуулалт	Хуулийн зүйл, заалт
1.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай бие даасан хуультай орныг судлах	Унгар улс зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг бие даасан хуулиар зохицуулаагүй. Харин 2012 онд батлсан **“Зөрчил, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн бүртгэлийн тогтолцооны тухай хууль”-иар энэ төрлийн харилцааг зохицуулсан байна.**	
2.	Зөрчил шалган тогтоох ажиллагааг прокурор эсхүл шүүхийн зөвшөөрлөөр хэрэгжүүлдэг журмыг хуульчилсан эсэх. Тухайлбал эд хөрөнгө хураан авах, эсхүл үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох гэх мэт.	Энэ хуулиар зөрчил шалган шийдвэрлэх, шийдвэр гаргах эрхийг “Засгийн газрын алба” гэх нэртэй субьектэд олгосон бөгөөд уг алба нь зөрчлийн хэрэг маргааныг шийдвэрлэх анхан шатны байгууллага /цаашид Зөрчлийн алба гэх/ юм. Эдгээр албаны эрх бүхий улсын байцаагч нар эд хөрөнгө хураах, үйл ажиллагааг зогсоох талаар бие даан шийдвэр гаргадаг. Энэ тухай тогтоол үйлдэхдээ шүүх, эсхүл прокуророос зөвшөөрөл авах талаар уг хуульд заагаагүй байна. Харин шуудан, харилцаа холбооны хэрэгслээр дамжуулан илгээсэн илгээмж, захидал хураан авах тухай шийдвэрийг зөвхөн прокурор гаргадаг.	**Хуулийн 75 дугаар зүйл.**

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.legal.mn

	Зөрчилд шийтгэл оногдуулсан улсын байцаагчийн шийдвэрийг шүүхэд давж заалдах процесс. Үүнд прокурорт давж заалдах шат байгаа эсэх.	Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд прокурорт давж заалдах тухай уг хуульд тодорхой зохицуулалт тусгаагүй. Зөрчлийн албаны улсын байцаагчийн гаргасан шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд тухайн асуудлыг хариуцсан дээд шатны эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргана. Тухайлбал албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийг эс зөвшөөрч, гаргасан гомдол үндэслэлтэй бол Зөрчлийн алба 3 хоногийн дотор шийдвэрийг өөрчилнө. Харин өөрчлөх үндэслэлгүй гэж үзсэн бол уг зөрчлийн хэргийн материалыг 3 хоногийн дотор прокурорт шилжүүлэхээр зохицуулсан байна. Захиргааны зөрчил гаргасан этгээдэд баривчлах шийтгэлийг зөвхөн орон нутгийн шүүхийн шийдвэрээр оногдуулдаг. Шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд аймаг, нийслэлийн шүүхэд давж заалдах гомдол гаргадаг байна. Зөрчлийн албанаас гаргасан шийдвэрт прокурор хууль ёсны ерөнхий хяналт тавьж ажиллах ба Зөрчлийн албанаас гаргасан хууль тогтоомж зөрчсөн шийдвэрийг эс зөвшөөрч шүүхэд давж заалдах эрхтэй.	Хуулийн 35 дугаар зүйл. Хуулийн 98 дугаар зүйл Хуулийн 42 дугаар зүйл. Хуулийн 43 дугаар зүйл.
4.	Зөрчилд шийтгэл оногдуулсан шийдвэрийг шүүхэд давж заалдах процесс болон шүүхийн төрөл /ямар төрлийн шүүх уг асуудлыг шийдвэрлэж байна. Эрүүгийн шүүх үү эсхүл жижиг хэргийн шүүх гэсэн дагнасан шүүх байна уу, Энэхүү шүүх нь манай Захиргааны хэргийн шүүхийн хэрэг, маргаан шийдвэрлэх процессоос ялгаатай эсэх/	Унгар улсад зөрчлийн хэрэг шалган шийдвэрлэх тусгай шүүх байхгүй. Захиргааны зөрчилд тооцогдох хэрэг маргааныг харьяалах асуудлынхаа хүрээнд Засгийн газрын алба, цагдаагийн байгууллага, татвар, гаалийн алба, эрх бүхий бусад байгууллага шалган шийдвэрлэдэг. Харин баривчлах шийтгэлийг орон нутгийн шүүхээр шүүхээр шийдвэрлэдэг байна.	Хуулийн 38 дугаар зүйл.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Хавсралт 2. Оросын Холбооны Улс
Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хууль

№	Судлуулахаар захиалсан асуудлын агуулга	Хуулийн зохицуулалт	Хуулийн зүйл, заалт
1.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай бие даасан хуультай орныг судлах	Оросын Холбооны Улс зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг бие даасан хуулиар зохицуулаагүй. Харин 2001 онд баталсан “Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хууль”-иар энэ төрлийн харилцааг зохицуулсан байна.	
2.	Зөрчил шалган тогтоох ажиллагааг прокурор эсхүл шүүхийн зөвшөөрлөөр хэрэгжүүлдэг журмыг хуульчилсан эсэх. Тухайлбал эд хөрөнгө хураан авах, эсхүл үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох гэх мэт.	Эрх бүхий байгууллагын улсын байцаагч /государственный инспектор/ эд хөрөнгө хураах, үйл ажиллагаа зогсоох тухай шийдвэр гаргахдаа шүүх болон прокуророос зөвшөөрөл авдаггүй. Эдгээр асуудлаар тогтоол үйлдэхдээ шүүх, эсхүл прокуророос зөвшөөрөл авах талаар уг хуульд тусгагдаагүй байна. Жишээ нь: Замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын байцаагч / Государственная инспекция безопасности дорожного движения/ тээврийн хэрэгсэл жолоодож явсан жолоочийг тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхээ биедээ авч яваагүй шалтгаанаар авто машиныг нь 1 хоногийн хугацаагаар журмын хашаанд хийх, жолоочийг 10 цаг хүртэлх хугацаагаар түр саатуулах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд прокурор, эсхүл шүүхийн зөвшөөрөл авдаггүй байна.	Хуулийн 12.3 дугаар заалт
3.	Зөрчилд шийтгэл оногдуулсан улсын байцаагчийн шийдвэрийг шүүхэд давж заалдах процесс. Үүнд прокурорт давж заалдах шат байгаа эсэх.	Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг эс зөвшөөрч прокурорт давж заалдах тухай хуулийн зохицуулалт уг хуульд байхгүй байна. Энэ хуулиар захиргааны эрх зүйн зөрчил шийдвэрлэх, холбогдох шийдвэр гаргах эрхийг тухайн асуудлыг хариуцсан байгууллагын улсын байцаагчид олгосон бөгөөд энэ нь захиргааны зөрчлийг шийдвэрлэх анхан шатны байгууллага/ улсын байцаагч/ байна. Прокурор захиргааны эрх зүйн зөрчлийг шийдвэрлэсэн шийдвэрт хуулийн дагуу ерөнхий хяналт тавина.	Хуулийн 25 дугаар зүйл Хуулийн 24.4 дүгээр заалт
4.	Зөрчилд шийтгэл оногдуулсан шийдвэрийг шүүхэд давж заалдах процесс болон шүүхийн төрөл / ямар төрлийн шүүх уг асуудлыг шийдвэрлэж байна. Эрүүгийн шүүх үү эсхүл жижиг хэргийн шүүх гэсэн дагнасан шүүх байна уу, Энэхүү шүүх нь манай Захиргааны хэргийн шүүхийн хэрэг, маргаан шийдвэрлэх процессоос ялгаатай эсэх/	ОХУ-д зөвхөн захиргааны зөрчил шалган шийдвэрлэдэг бие даасан шүүх байхгүй. Харин Захиргааны хэргийн шүүх захиргааны зөрчилтэй холбоотой хэрэг маргааныг шийдвэрлэдэг. Зөрчил гаргасан этгээд захиргааны зөрчлийг шийдвэрлэсэн улсын байцаагчийн тогтоолыг дээд шатны албан тушаалтанд, анхан шатанд хэргийг хэлэлцсэн шүүхийн шийдвэрийг дээд шатны шүүхэд давж заалдах боломжтой.	Хуулийн 30.13 дугаар заалт Хуулийн 30.9 дугаар заалт Хуулийн 30.16 дугаар заалт

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Хавсралт 3.

Бүгд найрамдах Казахстан Улс Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хууль

№	Судлуулахаар захиалсан асуудлын агуулга	Зохицуулсан байдал	Хуулийн зүйл, заалт
1.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай бие даасан хуультай орныг судлах	Бүгд найрамдах Казахстан Улс зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг бие даасан хуулиар зохицуулаагүй. Харин 2016 онд баталсан “Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хууль”-иар энэ төрлийн харилцааг зохицуулсан байна.	
2.	Зөрчил шалган тогтоох ажиллагааг прокурор эсхүл шүүхийн зөвшөөрлөөр хэрэгжүүлдэг журмыг хуульчилсан эсэх. Тухайлбал эд хөрөнгө хураан авах, эсхүл үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох гэх мэт.	Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллагын улсын байцаагч / государственный инспектор/ эд хөрөнгө хураах, үйл ажиллагаа зогсоох тухай шийдвэрийг бие даан гаргадаг. Энэ тухай тогтоол үйлдэхдээ шүүх, эсхүл прокуророос зөвшөөрөл авах тухай зохицуулалт уг хуульд тусгагдаагүй байна.	Прокурорын тухай хуулийн 19, 20 дүгээр зүйл Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хуулийн 687 дугаар зүйл
3.	Зөрчилд шийтгэл оногдуулсан улсын байцаагчийн шийдвэрийг шүүхэд давж заалдах процесс. Үүнд прокурорт давж заалдах шат байгаа эсэх.	Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг эс зөвшөөрч прокурорт давж заалдах тухай зохицуулалт уг хуульд байхгүй байна. Эрх бүхий улсын байцаагчийн гаргасан шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд 2 сарын дотор тухайн асуудлыг эрхэлсэн дээд шатны байгууллага, албан тушаалтанд, дүүргийн шүүхэд гомдол мэдүүлнэ. Гомдлыг 10 хоногийн дотор хянаж үзээд гомдлыг хангасан, эсхүл хангахаас татгалзсан тогтоол гаргадаг. Анхан шатны шүүх, эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан захиргааны шийтгэл оногдуулах тухай тогтоолыг эс зөвшөөрсөн прокурор дээд шатны шүүхэд давж заалдаж, эсэргүүцэл бичиж болно.	Хуулийн 827 дугаар зүйл Хуулийн 829 дүгээр зүйл Хуулийн 830 дугаар зүйл
4.	Зөрчилд шийтгэл оногдуулсан шийдвэрийг шүүхэд давж заалдах процесс болон шүүхийн төрөл /ямар төрлийн шүүх уг асуудлыг шийдвэрлэж байна. Эрүүгийн шүүх үү эсхүл жижиг хэргийн шүүх гэсэн дагнасан шүүх байна уу, Энэхүү шүүх нь манай Захиргааны хэргийн шүүхийн хэрэг, маргаан шийдвэрлэх процессоос ялгаатай эсэх/	Бүгд Найрамдах Казахстан улсад захиргааны зөрчил шалган шийдвэрлэдэг бие даасан шүүх байхгүй. Захиргааны зөрчил шалган шийдвэрлэх асуудлыг харьяалах асуудлын хүрээнд улсын байцаагч, дотоод хэргийн байгууллага /цагдаа/, цагаачлалын алба, санхүүгийн яамны алба, цэргийн цагдаагийн алба гэх мэт хуулиар эрх олгогдсон бусад байгууллагууд, захиргааны шүүх, насанд хүрээгүйчүүдийн төрөлжсөн шүүх шийдвэрлэдэг байна.	Хуулийн 684,685,696, 699,722 дугаар зүйлүүд

ХУУЛЬ ЗҮЙН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ www.num.edu.mn

Хавсралт 4. Гүрж Улс

Захиргааны зөрчлийн тухай хууль

№	Судлуулахаар захиалсан асуудлын агуулга	Хуулийн зохицуулалт	Хуулийн зүйл, заалт
1.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай бие даасан хуультай орныг судлах	Гүрж Улс зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг бие даасан хуулиар зохицуулаагүй. Харин 1985 онд баталсан “Захиргааны зөрчлийн тухай хууль”-иар энэ төрлийн харилцааг зохицуулсан байна.	
2.	Зөрчил шалган тогтоох ажиллагааг прокурор эсхүл шүүхийн зөвшөөрлөөр хэрэгжүүлдэг журмыг хуульчилсан эсэх. Тухайлбал эд хөрөнгө хураан авах, эсхүл үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох гэх мэт.	Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан /улсын байцаагч/ эд хөрөнгө хураан авах, эсхүл үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох ажиллаагаа явуулахдаа бие даан шийдвэр гаргах эрхтэй бөгөөд үүнд прокурор, эсхүл шүүхийн зөвшөөрөл авахыг шаардсан зохицуулалт энэ хуульд тусгагдаагүй.	**Хуулийн 249 дүгээр зүйлийн нэгдүгээр хэсэг**
3.	Зөрчилд шийтгэл оногдуулсан улсын байцаагчийн шийдвэрийг шүүхэд давж заалдах процесс. Үүнд прокурорт давж заалдах шат байгаа эсэх.	Захиргааны зөрчилд шийтгэл оногдуулсан улсын байцаагчийн шийдвэрийг прокурорт давж заалдах тусгай зохицуулалт байхгүй. Захиргааны торгууль оногдуулсан улсын байцаагчийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд дээд шатны байгууллагад эсхүл дүүргийн шүүхийн аль нэгэнд давж заалдах гомдол гаргах боломжтой. Харин захиргааны торгуулиас бусад шийдвэрийг зөвхөн дээд шатны байгууллагад давж заалдана. Дээд шатны байгууллагаас гаргасан шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд дүүргийн шүүхэд давж заалдах эрхтэй байна.	Хуулийн 272 зүйлийн нэгдүгээр хэсэг Хуулийн 279 зүйлийн хоёрдугаар хэсэг
4.	Зөрчилд шийтгэл оногдуулсан шийдвэрийг шүүхэд давж заалдах процесс болон шүүхийн төрөл /ямар төрлийн шүүх уг асуудлыг шийдвэрлэж байна. Эрүүгийн шүүх үү эсхүл жижиг хэргийн шүүх гэсэн дагнасан шүүх байна уу, Энэхүү шүүх нь манай Захиргааны хэргийн шүүхийн хэрэг, маргаан шийдвэрлэх процессоос ялгаатай эсэх/	Гүрж улсад захиргааны зөрчлийг шийдвэрлэдэг тусгай, бие даасан шүүх байхгүй. Захиргааны зөрчилд холбогдох хэрэг маргааныг харьяаллын дагуух дүүргийн шүүхэд давж заалдана. Харин баривчлах шийдвэрийг давж заалдах шүүхийн захиргааны хэргийн танхим шийдвэрлэнэ.	Хуулийн 281 дүгээр зүйл

ХУУЛЬ ЗҮЙЛИЙН УНИВЕРСИТЕТИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Ж.Амарсанаа нар, Дэлхийн Улсуудын Шүүхийн Тогтолцоо, ХЗҮХ, Улаанбаатар хот, 2005 он

Унгар улсын Зөрчил, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн бүртгэлийн тогтолцооны тухай 2012 оны 2 дугаар хууль /2012. йvi II. tцrvйny A szabбlysйrtйsekről, a szabбlysйrtйsi eljбrбsryl йs a szabбlysйrtйsi nyilvбntartбsi rendszerről/ Цахим хуудас: http://net.jogtar.hu/jr/gen/hjegy_doc.cgi?docid=A1200002.TV

2. Administrative Offences Code of Georgia. https://matsne.gov.ge/en/document/download/28216/339/en/pdf

3. Responses of the Government of Georgia to the issues raised by UN Human Rights Committee on Examination of the 4th Periodic Reports of Georgia on Implementation ICCPR. 2014.

4. ОХУ-ын захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хууль-/Кодекс Российской федерации об административных правонарушениях/

http://www.consultant.ru/document/cons_doc_law_34661/

5. ОХУ-ын прокурорын байгууллагын тухай хууль / Кодекс российской федерация об прокуратуре рф/

http://pravo.gov.ru/proxy/ips/?docbody=&nd=102014157

6. БНКУ-ын Захиргааны эрх зүйн зөрчлийн тухай хууль /Кодекс об административных правонарушениях республики Казахстана/ https://online.zakon.kz/document/?doc_id=31577399

7. БНКУ-ын Прокурорын байгууллагын тухай хууль

http://prokuror.gov.kz/rus/o-prokurature/normativnye-pravovye-akty/zakon-o-prokurature

---o0o---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

АРИЛЖААНЫ ТҮРЭЭСИЙН ХАРИЛЦААН ДАХЬ ТҮРЭЭСЛЭГЧИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТАЛААРХ ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ[1]

Удиртгал

Монгол Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалангийн хүсэлтийн дагуу Түрээслэгчдийн эрх ашгийг хамгаалсан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг цуглуулж, түрээслэгчийн эрх ашгийг хамгаалах асуудлыг Газрын тухай болон бусад хуультай хэрхэн уялдуулж талаарх саналыг энэхүү лавлагаа мэдээлэлд тусгасан болно.

Лавлагаа мэдээллийг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвөөс Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд 2017 оны 12 дугаар сард хийж гүйцэтгэв.

Нэг. Ерөнхий ойлголт

Манай улсын хувьд түрээслэгчид хамаарах эрх зүйн суурь зохицуулалт нь түрээсийн обьектийн төрөл, өмчлөгч, эзэмшигчийн эрхийн байдлаас хамаарч Иргэний хуульд, мөн Газрын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, түүнчлэн Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, мөн Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Төр өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам болон барилга байгууламж хувьчлах, төрийн өмчийг түрээсийн гэрээгээр эзэмших, тэдгээрийг худалдах, Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр” зэрэг холбогдох зохицуулалтууд тусгагдсан байна.

Эдгээрээс судалж буй сэдэвтэй голлон холбогдох эрх зүйн зохицуулалт нь Иргэний хуулийн 27 болон 28 дугаар бүлэгт түрээсийн гэрээ, төлбөр, хугацаа, газар, үйлдвэр түрээслэх, дамжуулан түрээслэх зэрэг тусгайлсан хэм хэмжээ болон хуульчлагджээ. Ингэхдээ түрээсийн гэрээний үндсэн агуулга болох түрээслэгч нь түрээслүүлэгчийн эд зүйлийг ашигласны төлөө төлбөр төлөх, тэрхүү төлбөрийг талууд харилцан тохиролцсон байх гэсэн утгаар зохицуулсан байдаг.

Түрээсийн зүйлийн зонхилох хэсгийг үл хөдлөх эд хөрөнгө эзлэх ба тухайн эд хөрөнгийн өмчлөгч болон зориулалтаас хамаарч түрээсийн төрлийг төрийн болон хувийн өмчийн түрээс гэж ангилдаг бол хүнс, бараа болон бусад төрлийн бүтээгдэхүүнийг худалдан борлуулах, үйлчилгээний зориулалтаар лангуу, талбай, байр, газрыг түрээслэх үйл ажиллагаа нь “Арилжааны түрээс”[2] гэх ангилалд хамаарч байна.

Хоёр. Өнөөгийн нөхцөл байдал

Хүнс, бараа болон бусад төрлийн үйлчилгээ эрхлэх, үйл ажиллагаа явуулахад голдуу арилжааны, бизнесийн зорилгоор хүнс, бараа болон бусад төрлийн бүтээгдэхүүнийг худалдан борлуулах, үйлчилгээний лангуу, талбай, байр, газар зэргийг түрээсэлдэг.

[1] Тус лавлагааг УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалангийн захиалгаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор Х.Эрдэм-Ундрах удирдан, эрдэм шинжилгээний ажилтан Б.Сүнжидмаа гүйцэтгэв.

[2] Улсын Их Хурлын Тамгын газар. Түрээсийн татварын талаарх зарим улсын эрх зүйн зохицуулалт (харьцуулсан судалгаа). УБ., 2013 он.

Дээрх үйл ажиллагааны төрөл, онцлогоос шалтгаалан түрээсийн харилцаанд нэг талаас түрээслэгч, түрээслүүлэгч, дам түрээслэгч, өмчлөгч, хэрэглэгч, нөгөө талаас үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хяналт шалгалт явуулах, татвар ногдуулах, хураах эрх бүхий төрийн байгууллага тус харилцаанд оролцож байна.

Үйл ажиллагаа эрхлэх эрх авах ажиллагаанд хамаарах хуулийн зохицуулалт цөөнгүй байх бөгөөд үүний дагуу бүрдүүлэх материал, хандах эрх бүхий байгууллага, тэдгээрийн зүгээс явуулах хяналт шалгалтын асуудалд холбогдох эрх зүйн зохицуулалт олон байна.

Харин түрээслэгч, түрээслүүлэгч талын эрх ашгийг хамгаалсан зохицуулалт бүхий нэгдсэн нэг эрх зүйн акт байхгүй. Энэ харилцаа нь өмнө дурдсанчлан Иргэний хуулиар аль эсхүл талуудын хооронд байгуулсан Түрээсийн гэрээнд заасан хүрээгээр тодорхойлогдож байгаа ба Иргэний хуулийн 319 болон 320 дугаар зүйлд зааснаар түрээсийн төлбөр, хугацааг өөрчлөх боломж нь зөвхөн “талуудын тохиролцоо”-нд үндэслэсэн байхаар хуульчлагдсан. Гэвч бодит байдал дээр түрээслүүлэгч тал үндэслэлгүйгээр түрээсийн үнэ нэмэх, түрээслэгч тал аргагүй байдлаас шалтгаалан үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх, зарим тохиолдолд маргах[3] байдлаар энэ харилцаа үргэлжилсээр иржээ.

Мөн арилжааны түрээсийн үйл ажиллагаанд түрээслэгч, түрээслүүлэгч талаас гадна уг үйл ажиллагааны онцлогоос хамааран нийтийн эрх ашиг давхар хөндөгддөг тул төрөөс сүүлийн жилүүдэд нийтийн эрх ашгийн хамгаалах зорилгоор холбогдох эрх зүйн актыг батлан гаргасны нэг нь “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр” бөгөөд уг хөтөлбөрт “арьс шир, ноос, ноолуур боловсруулах үйлдвэр, авто техникийн болон барилгын материалын захыг нийслэлээс үе шаттай нүүлгэн шилжүүлэх” талаар тусгасан байна.

Бидний судалсан эх сурвалжийн хүрээнд түрээсийн харилцаанд холбогдох тусгайлсан судалгаа-2, магистрын зэрэг горилсон бүтээл-4, ном, гарын авлага-1, эрдэм шинжилгээний өгүүлэл-5 бичигдэн гарчээ.[4]

Гурав. Эрх зүйн зохицуулалт

3.1. Түрээслэгчдийн эрх ашгийг хамгаалсан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Түрээсийн харилцаанд холбогдох хууль тогтоомжийн түүхэн хөгжлийг судлан үзэхэд мал адгуулах болон хадлан, тариалангийн газрыг түрээслүүлэх мөн түүнчлэн “худалдаа хийх зорилгоор байшин барьж, худалдаачдад түрээслүүлэх” зэрэг харилцааг тодорхой хэмжээнд зохицуулж байсан талаар эх сурвалжуудад тэмдэглэгдсэн байна[5].

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиудад түрээсийн холбогдох харилцааг дараах байдлаар зохицуулж байна.

Иргэний хуулийн 27, 28 дугаар бүлгээр түрээсийн харилцааг зохицуулсан. Ингэхдээ уг хуулийн 318 дугаар зүйлд заасан түрээсийн гэрээ нь гагцхүү эд юмсын эрхээр хязгаарлагдахгүй бүх эд зүйлд хамаатай байх бол 321 дүгээр зүйлээр зөвхөн хөдөө аж ахуйн зориулалттай газар бус үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай газарт мөн хамаарах өргөн агуулгаар зохицуулж өгсөн.

---

[3] УДШ-ийн хяналтын шатны шүүх хуралдааны шүүгчийн тусгай санал. “Хүчит шонхор” ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэргийн тухай. 2014 оны 6 дугаар сарын 16-ны өдөр.

[4] Дэлгэрэнгүйг хавсралт №1-ээс харна уу.

[5] Б.Баярсайхан. *Төмөр утасны дүрэм, айлтгалын эх, байшин барьж худалдаачдад түрээслүүлэх саналыг дахин хянан хэлэлцүүлэхээр Гадаад яаманд илгээсэн бичиг” Монгол Улсын Хууль тогтоомжийн түүхэн товчоо. УБ. 2011* (Улсын хурлын газраас)

Иргэний хуулийн 318.5-д зааснаар түрээсийн гэрээнд эд хөрөнгө хөлслөх гэрээний журам нэг адил үйлчлэх, 294 дүгээр зүйлд Эд хөрөнгө хөлслөх гэрээг дуусгавар болгох талаар зохицуулахдаа 294.2.3-т "хөлслүүлэгчийн санал болгосон зах зээлийн үнэд тохирсон нэмэгдэл хөлс төлөхөөс хөлслөгч татгалзсан" бол гэрээг цуцлах талаар хуульчилсан байна.

Газрын тухай хуулиар газар эзэмших, ашиглах харилцааг голлон зохицуулсан бол Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиар Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх зориулалт, болзол, шаардлага, хуульд заасан журам нөхцөлийн талаар зохицуулсан байдаг. Харин судалж буй сэдэвтэй шууд холбогдох асуудлаар нарийвчилсан зохицуулалт эдгээр хуульд тусгагдаагүй ч Газрын тухай хуулийн 7 дугаар зүйлд зааснаар "газрыг эзэмшиж, ашиглаж байгаа этгээд газрын төлбөрийг төлөх", Газрын төлбөрийн тухай 1997 оны хуульд төрийн өмчийн газрыг эзэмшиж, ашигласны төлөө төлбөр ногдуулах, уг төлбөрийг төсөвт төлөх тухай зохицуулсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 1996 онд батлагдсан бөгөөд уг хуулийн 28 дугаар зүйлд "төр өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журмыг иргэний хуульд нийцүүлэн Засгийн газар тогтооно, журамласнаас бусад үл хөдлөх хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг төрийн өмчит хуулийн этгээд эдлэх, мөн түрээсийн гэрээнд заавал тусгах нөхцөл" зэргийг хуульчлан зохицуулсан.

2003 онд **Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль**, 2009 онд **Улсын бүртгэлийн ерөнхий хууль**, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль тус тус батлагдсан. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 32 дугаар зүйлд түрээсийн эрхийн улсын бүртгэлийн талаар зохицуулсан бөгөөд уг хуулийн 32.4.2-т "түрээслүүлэх үл хөдлөх эд хөрөнгийн хэмжээ, байршил, **гэрээний үнэ, нөхцөл, хугацаа**"-г улсын бүртгэлд тусгахаар заасан байдаг. Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 5.5.6-д зааснаар түрээсийн бүртгэл нь эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нэг төрөл болон хуульчлагдсан.

2010 онд Өрсөлдөөний тухай хууль батлагдаж аж ахуй эрхлэгчийг энэхүү хуулийн үйлчлэх хүрээнд хамааруулсан. Хуулийн 4.1.3-т ""аж ахуй эрхлэгч" гэж Монгол Улсад бүртгэлтэй, аж ахуй эрхэлж байгаа ашгийн төлөө болон ашгийн төлөө бус хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, хувь хүнийг" ойлгохоор зааж, аж ахуй эрхлэгчийг зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилт тавьсан.

Төр өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх журам 2001 онд батлагдаж, өөрийн өмчийн түрээсийн гэрээ байгуулах, цуцлах, түрээсээр эзэмшүүлэхтэй холбогдсон маргаан шийдвэрлэх харилцааг зохицуулсан. Журмын 11-д "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авч Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тогтооно" гэж заасан.

Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор "**Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр"** батлагдсан. Уг хөтөлбөрийн 4.1.11-т "арьс шир, ноос, ноолуур боловсруулах үйлдвэр, авто техникийн болон барилгын материалын захыг нийслэлээс үе шаттай нүүлгэн шилжүүлж, инновацид тулгуурласан ногоон технологи бүхий үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх" ажлыг хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ болгон тусгасан байна.

Судалж байгаа сэдэвтэй холбогдуулан "Хүчит шонхор" захын нэхэмжлэлтэй захиргааны хэрэг[6]-ийг шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэр, давж

[6] "Хүчит шонхор" ХХК-ний нэхэмжлэлтэй захиргааны хэргийн Анхан шатны шүүхийн шийдвэр, Давж заалдах шатны шүүхийн магадлал, Монгол Улсын Дээд шүүхийн Хяналтын шатны шүүх хуралдааны

заалдах шатны шүүхийн магадлал болон хяналтын шатны шүүхийн шүүгчийн тусгай саналаас харахад ШӨХТГ-т түрээслэгчдээс “захын түрээсийн төлбөрийг гэнэт нэмсэн” гэх гомдол ирсний дагуу байцаагч энэхүү нөхцөл байдлыг тогтоохоор хяналт шалгалт хийж зөрчлөө арилгахыг “Хүчит шонхор” ХХК-аас шаарджээ. Улсын байцаагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй учраас байцаагч шийтгэвэр гаргаж ХХК-г торгосон, харин ХХК уг торгууль оногдуулсан шийтгэврийг эс зөвшөөрч захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан байна. Анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн боловч уг хэрэгт холбогдуулан УДШ-ийн хяналтын шатны шүүх хуралдааны шүүгчийн тусгай санал гарсан бөгөөд уг тусгай саналын дүгнэлт хэсэгт “Дээрхээс нэгтгэн үзэхэд, Өрсөлдөөний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан ноёлох үйл ажиллагаанд бусад аж ахуй эрхлэгчийг зах зээлд гарч ирэх нөхцөлийг хаан боогдуулах, зах зээлээс шахан гаргах зорилготой үйл ажиллагаа хамаарахын зэрэгцээ хэрэглэгчийг хясан боогдуулахад чиглэсэн үйл ажиллагаа хамаардаг бөгөөд мөн хуулийн 7.1.3-т заасан зохицуулалт нь хэрэглэгчийн эсрэг үйлдэгддэг ноёлох үйл ажиллагааны төрөл мөн. Мөн маргаан бүхий чингэлгүүд нь 7 дугаар зүйлийн 7.1.3-т зааснаар **ижил төрлийн бараа бүтээгдэхүүн төдийгүй эдгээр чингэлгүүдэд зардлаас хамаарсан ялгаатай үнэ тогтоох үндэслэл байхгүй** байна. Шонхор худалдааны төв нь махны бөөний борлуулалтаар дагнасан, бөөний болон жижиглэн худалдаа эрхлэгчдэд уг төвөөс мах худалдан авч Улаанбаатар хотын бусад зах, дэлгүүрийг хангадаг учир махны нийлүүлэлтэд ихээхэн үүрэг гүйцэтгэдэг. Энэ утгаараа **зардал нь ижил мах худалдах зориулалттай чингэлгүүдийг адил үнээр буюу 500,000 төгрөгөөр түрээслэх боломж байхад зардлаас үл хамаарах үндэслэлээр зарим чингэлгийн үнийг 900,000 хүртэл нэмэгдүүлж, махны худалдаа эрхлэгч нарт тэгш өрсөлдөх нөхцөлийг хангасангүй**. Нөгөө талаас, Өрсөлдөөний тухай хуулийн зохицуулалт нь уг хуулийн зохицуулалтад хамрагдаж буй аж ахуй эрхлэгчдэд нэг мөр үйлчлэх учиртай. **Аж ахуй эрхлэгч цахилгаан эрчим хүч, дулаан, харилцаа холбоо болон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний импорт, нийлүүлэлт зэрэг ямар төрлийн бараа бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлж байгаагаас үл хамааран давамгай байдалтай аж ахуйн нэгж мөн бол нийлүүлж буй бараа бүтээгдэхүүнийг зардлаас хамаарахгүй бусад үндэслэлээр дур мэдэн өөр өөр үнэ тогтоож, хувийн үнэлэмжээр хэрэглэгчийг ялгаварлах үндэс байхгүй**” гэж дурдсан байна.

Арилжааны түрээсийн харилцаатай холбоотой түрээслэгчийн эрх ашиг хөндөгдсөн дээрх тохиолдлоос гадна худалдаа, үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагаанд холбогдуулан олон нийтийн зүгээс санал, шүүмж багагүй гардаг. Тухайлбал, барилгын материал, автомашины худалдааны төвүүдийн үйл ажиллагаа иргэдийн эрүүл мэнд, аюулгүй орчинд амьдрах эрхэд сөргөөр нөлөөлж байгаа талаар ихээхэн яригддаг.

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас “Давамгай болон зүй ёсны монополь байдалтай аж ахуйн нэгжүүдийн жагсаалт”[7]-ыг гаргасан бөгөөд үүнд Улаанбаатар хотын хэмжээнд 8, орон нутгийн хэмжээнд 34 аж ахуйн нэгж тус тус хамаарч байна.

2014 онд Нийслэлийн Засаг даргын А/505 дугаартай захирамж[8]-аар олон нийтийн зүгээс ирсэн санал, хүсэлтийг үндэслэн Нийслэлийн замын хөдөлгөөний

шүүгчийн тусгай саналыг бүрэн эхээр нь хавсралт №5-аас харна уу.

[7] Жагсаалтыг хавсралт №4-өөс харна уу,

[8] Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. http://www.legalinfo.mn/law/details/10709.

ачааллыг тэнцвэржүүлэх, түгжрэл саатлыг бууруулах зорилгоор худалдааны төв, зах болон автозамын дагуу байрлах худалдаа, үйлчилгээний газар /нүүрс, түлээ, мод, барилгын материал, автомашин, техникийн худалдаа, үйлчилгээ, засвар/-ын ажиллах цагийн хуваарьт өөрчлөлт оруулжээ.

Эдгээрээс харахад арилжааны түрээсийн харилцаанд түрээслэгчийн эрх ашгийг хамгаалсан тусгайлсан хууль, бие даасан зохицуулалт одоогоор байхгүй байна. Мөн арилжааны түрээсийн үйл ажиллагаанд түрээслэгч, түрээслүүлэгч талаас гадна уг үйл ажиллагааны онцлог болох арилжааны /олон нийтийг хамарсан/ гэх үндсэн шинжээс хамааран нийтийн эрх ашиг давхар хөндөгддөг болохыг дээрх захирамж болон хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнээс харж болно. Түүнчлэн арилжааны түрээсийн үйл ажиллагаанд шууд холбогдох суурь хүчин зүйлийн нэг нь тухайн үйл ажиллагааг эрхлэн явуулах “Газар”-ын асуудал байдаг.

3.2.“Түрээслэгчдийн эрх ашгийг хамгаалах талаарх эрх зүйн зохицуулалтыг Газрын тухай болон бусад хуультай уялдуулах талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлд газрыг өмчлүүлэх, өмчлөгч газраа бусдад эзэмшүүлэх, ашиглуулах харилцаанд талуудын хооронд үүсэх эрх, үүргийн талаар суурь зохицуулалтуудыг хуульчилсан байдаг.

Мөн Улсын тусгай хэрэгцээг үндэслэн газрыг солих буюу эргүүлэн авах, нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газрыг дайчлан авахаар тус тус заасан. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн талаар “16.3 нь 6.4-т заасан газартай холбогдон авах нөхөх олговрыг дэлгэрүүлж бусад хувийн өмчийг (байшин барилга зэрэг бусад үл хөдлөх хөрөнгө) дайчлан авбал мөн нөхөх олговор төлөхөөр хуульчилсан[9] бөгөөд нөхөх олговор нь “урьдчилсан шударга нөхөх олговор байх” талаар мөн практик дээр нөхөх олговрын хэмжээ нь зах зээлийн үнэлгээнээс хэт доогуур тогтоогдсон талаарх жишээ баримтыг дурдсан байна.

2002 онд Газрын тухай хууль болон Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль батлагдаж дээр дурдсан суурь зохицуулалтуудыг нарийвчлан зохицуулахдаа түрээстэй шууд холбоотойгоор Газрын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2-т “гадаад улс, олон улсын байгууллага, гадаадын хуулийн этгээдэд газрыг тодорхой хугацаагаар түрээс, концессын гэрээгээр ашиглуулах талаар шийдвэр гаргах”-ыг УИХ-ын бүрэн эрхэд хамааруулж, МУИГӨтХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.9-т “Иргэний өмчийн газрыг гэрээний үндсэн дээр хөлсөлж, түрээсэлж байгаа гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүн уг газрыг бусдад дамжуулан хөлслөх, дамжуулан түрээслэхийг хориглоно” хэмээн хуульчилсан.

Засгийн газраас 2017 онд “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр” баталсан бөгөөд уг хөтөлбөрт “**арьс шир, ноос, ноолуур боловсруулах үйлдвэр, авто техникийн болон барилгын материалын захыг** нийслэлээс үе шаттай нүүлгэн шилжүүлэх” арга хэмжээ тусгагджээ.

Уг хөтөлбөр нь 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан бөгөөд уг хөтөлбөрийг баталсан ЗГ-ын тогтоолын 2-т “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г 2017 оны 4 дүгээр сард багтаан батлан хэрэгжүүлэхээр заасан хэдий ч хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан эсэх нь тодорхойгүй, дээр дурдсан “нүүлгэн шилжүүлэх” ажил хэзээ, хэрхэн хийгдэх нь одоогоор тодорхойгүй байна.

Хөтөлбөр нь 2017-2025 он хүртэл хэрэгжихээр төлөвлөгдсөн тул цаашид төрөөс агаар, орчны бохирдлыг бууруулах зорилгоор ийнхүү нүүлгэн шилжүүлэх ажил тодорхой үе шаттайгаар хэрэгжих төлөвтэй байна.

[9] Ж.Сайнхишиг. Монгол Улсын Үндсэн хуулийн хувийн өмчийг дайчлан авах эрх зүйн зохицуулалтын тулгамдсан асуудал. ХЗҮХ. 2012.

Дүгнэлт

Арилжааны түрээсийн харилцаанд оролцогч талуудын эрх ашиг хөндөгдөх тул тэдгээрийн эрх ашгийг хамгаалах, тэдний саналыг сонсох, түүнчлэн Захиргааны ерөнхий хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, Хөрс, хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулиудын холбогдох зохицуулалтыг анхаарах мөн нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой зардал, нөхөх олговор олгоход баримтлах зарчим, журмыг мөрдөх нь төрөөс түрээслэгчийн эрх ашгийг хамгаалах талаар цаашид авч хэрэгжүүлэх ажилд чухал нөлөөтэй.

Санал, Зөвлөмж

Түрээсийн эрх ашгийг хамгаалах тухай хуулийн төсөл боловсруулахад дараах асуудлыг анхаарах шаардлагатай.

Үүнд:

Нэг. Түрээсийн харилцаанд оролцогчдыг, тухайлбал, төр-иргэн, иргэн-иргэний хооронд үүсэх харилцаа,

Хоёр. Түрээсийн харилцааны обьектийн төрөл ялгаатай байдлыг харгалзан үзэх. Үүнд:

- Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө (газар, барилга, талбай);
- Хувийн өмчийн үл хөдлөх хөрөнгө;
- Дамжуулан түрээслэх харилцаа.

Гурав. Түрээсийн төрлийн ялгаатай байдлыг харгалзан үзэх. Үүнд:

- Үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар газар, байр түрээслэх;
- Хөдөө, аж ахуйн зориулалтаар газар түрээслэх.

Дөрөв. Үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах зөвшөөрөл, хяналт шалгалт, татвар, төлбөртэй холбоотой асуудлууд холбогдох хууль тогтоомжоор зохицуулагдсан байна.

Тав. Судалж буй сэдэвтэй холбоотойгоор түрээслэгчийн эрх ашгийг хамгаалсан тусгайлсан зохицуулалт Монгол Улсын Үндсэн хууль болон Газрын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд тусгагдаагүй тул эдгээр хуулийн холбогдох заалтуудад нийцүүлэн түрээслэгчийн эрх ашгийг хамгаалсан эрх зүйн зохицуулалтыг нэмж хуульчлах боломжтой юм.

Зургаа. Харин бусад хуулийн хувьд энэхүү Лавлагаа мэдээллийн 3.1 дэх дэд хэсэгт дурдсанчлан Иргэний хууль болон Өрсөлдөөний тухай хуулийн холбогдох заалтуудаар түрээслэгчийн эрх ашгийг тодорхой хэмжээнд хамгаалсан, ялангуяа арилжааны түрээсийн харилцаанд түрээслүүлэгч тал үндэслэлгүйгээр түрээсийн төлбөрөө нэмсэн тохиолдолд Өрсөлдөөний тухай хуулийн холбогдох зохицуулалтыг ашиглан түрээслэгчийн эрх ашгийг хамгаалж болох зохицуулалтууд хуульчлагдсан байна.

Долоо. Цаашид төрөөс түрээслэгчийн эрх ашгийг хамгаалсан хуулийн зохицуулалтыг өргөжүүлэх, тусгайлан зохицуулах тохиолдолд арилжааны түрээсийн харилцаан дахь талуудыг зөвхөн түрээслэгч, түрээслүүлэгч тал гэж үзэхээс гадна энэ харилцаанд нийтийн эрх ашиг давхар хөндөгдөж байгааг анхааран үзэж, түүнд нийцүүлэх бодлого баримтлах нь чухал юм.

Найм. Мөн Эдийн засгийн хөгжлийн яамны захиалгаар Мирим Консалтинг ХХК “Түрээсийн харилцаа болон үйл ажиллагааны нийгэм, эдийн засаг, эрх зүйн орчин” сэдэвт судалгаа ба бодлогын зөвлөмж боловсруулсан учраас энэ талаарх судалгаа хийх шаардлагагүй гэж үзэж байна[10].

[10] Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт №2-оос харна уу.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Иргэний хууль, 2002.
3. Газрын тухай хууль, 2002.
4. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай, 2002.
5. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, 2006.
6. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, 1996.
7. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, 2009.
8. Улсын бүртгэлийн ерөнхий хууль, 2009.
9. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай, 2003.
10. Өрсөлдөөний тухай, 2010.
11. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам 2001 оны №134.
12. Засгийн газрын тогтоол (захирамж). Барилга шилжүүлэх тухай. 2002.12.25, №271.
13. Засгийн газрын тогтоол, Иргэдийг орон сууцжуулах талаар авах зарим арга хэмжээний тухай. 2013, №136.
14. Засгийн газрын тогтоол, “Түрээсийн орон сууц” хөтөлбөр 2015, №248.
15. Засгийн газрын тогтоол. “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр” 2017, №98.
16. Б.Баярсайхан.Төмөр утасны дүрэм, айлтгалын эх, байшин барьж худалдаачдад түрээслүүлэх саналыг дахин хянан хэлэлцүүлэхээр Гадаад яаманд илгээсэн бичиг” Монгол Улсын хууль тогтоомжийн түүхэн товчоо. УБ. 2011.
1. Ном, сурах бичиг, өгүүлэл
17. Улсын Их Хурлын Тамгын газар. Судалгааны эмхэтгэл. УБ., 2014.
18. Монгол Улсын иргэний хуулийн тайлбар. УБ., 2010.
19. Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн тусгай анги. Анхны хэвлэл. УБ., 2010.

2. Судалгааны ажил, Улсын дээд шүүхийн тайлбар, зөвлөмж, шүүгчийн тусгай санал
20. Улсын Их Хурлын Тамгын газар. Түрээсийн татварын талаарх зарим улсын эрх зүйн зохицуулалт (харьцуулсан судалгаа). УБ., 2013.
21. Түрээсийн харилцаа болон үйл ажиллагааны нийгэм, эдийн засаг, эрх зүйн орчны судалгаа ба бодлогын зөвлөмж боловсруулах төсөл. УБ., 2014.
22. Монгол улсын дээд шүүхийн зөвлөмж. Гэрээний зарим эрх зүйн маргааны хууль хэрэглээ болон гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахад анхаарах асуудлууд. 2016.09.05, №3.
23. Ж.Сайнхишиг. Монгол Улсын Үндсэн хуулийн хувийн өмчийг дайчлан авах эрх зүйн зохицуулалтын тулгамдсан асуудал. 2012. ХЗҮХ. http://nli.gov.mn/?p=2037
24. Монгол улсын дээд шүүхийн тогтоол. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зарим зүйл, хэсгийг тайлбарлах тухай. 1999.03.08, №79.
25. Улсын Дээд Шүүхийн тогтоол, Түрээсийн гэрээгээр эзэмшиж байгаа зарим барилгын тухай 1999.02.24, №33.
26. Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдааны шүүгчийн тусгай санал. “Хүчит шонхор” ХХК”-ний нэхэмжлэлтэй захиргааны хэргийн тухай. 2014.06.16. http://www.supremecourt.mn/tusgaisanal/view?id=1.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

Хавсралт 1

Түрээсийн харилцаанд хамаарах ном зүйн түүвэр жагсаалт

д/д	Баримт бичгийн төрөл	Боловсруулсан байгууллага, хүний нэр	Утга
1	Судалгааны ажил	УИХ-ын тамгын газрын судалгааны төв	Түрээсийн татварын талаарх зарим улсын эрх зүйн зохицуулалт /харьцуулсан судалгаа/ Уб., 2013.
2		Захиалагч: Эдийн засгийн хөгжлийн яам, Хамтрагч: МИРИМ Консалтинг ХХК	Түрээсийн харилцаа болон үйл ажиллагааны нийгэм, эдийн засаг, эрх зүйн орчны судалгаа ба бодлогын зөвлөмж боловсруулах төсөл. Уб., 2014.
4	Магистрын зэрэг горилсон бүтээл	Д.Пүрэвдулам	Үл хөдлөх эд хөрөнгө түрээслэх гэрээний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал. Уб., 2006.
5		Д.Солонго	Түрээсийн гэрээний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал. Уб., 2011.
7		С.Мандухай	Үл хөдлөх эд хөрөнгө түрээслэх гэрээний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал. Уб., 2010.
10		Н.Хишигсүх	Түрээсийн гэрээний эрх зүйн зохицуулалт, тулгамдсан асуудал. Уб., 2009.
11	Ном, гарын авлага	С.Лувсандорж	Хөдөө аж ахуй дахь түрээсийн харилцаа. Уб., 1989.
12	Эрдэм шинжилгээний өгүүлэл	О.Адъяа	Хоршоолол, нөхөрлөл, гэрээ түрээсийн хэлбэр. Ардын төр. 1989. №1. 43-44 дэх тал.
13		Г.Дашаа	Гэрээ, түрээс түүнийг боловсронгуй болгох шаардлага. Ардын төр. 1989. №3. 16-18 дахь тал.
15		З.Сүхбаатар	Түрээсийн гэрээний хэлбэр. “Өмгөөлөгч” мэдээлэл, танин мэдэхүйн сар тутмын сэтгүүл. 2009. №3 (29). 27-29 дэх тал.
17		Б.Цогням, А.Энхбат	Гэрээ, түрээсээс үүссэн маргааныг шийдвэрлэх нь. Социалист хууль ёс. 1990. №1. 32-35 дахь тал.
18		Н.Чинбат	Түрээстэй гэрээлэх харилцааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгоё. Ардын төр. 1989. №2. 28-29 дэх тал.
19	Бусад		Бэлчээрийн түрээс хураах дүрэм. хотгүй., 1925. /монгол бичгээр/.
20	Гадаад монголын хязгаарын дотор худалдаа ба үйлдвэрийн учир суух оросын харьяат нарт орон байшин байгуулах хэсэг газар түрээслэн олгох учир хэлэлцэн тогтоосон гэрээ бичиг. Уб., 1917. /монгол бичгээр/. Ногооны газар түрээслэн олгох түр дүрэм. Уб., 1926. /монгол бичгээр/. Хадланг түр түрээслэх дүрэм. Уб. / Монгол бичгээр/.		
21			
22			

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nii.gov.mn

Хавсралт 2

ТҮРЭЭСИЙН ХАРИЛЦААНЫ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ ЭРХЗҮЙН ОРЧНЫ БОДЛОГЫН СУДАЛГАА, /БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ/ /PHASE II/[11]

Эхэлсэн хугацаа: 2014.09 сар

Гэрээний дуусах хугацаа: 2014.12 сар

Захиалагчийн нэр: Эдийн засгийн хөгжлийн яам

Төсөл хэрэгжсэн газар: Монгол улс

Төслийн үндсэн зорилго:

Монголын нийгэм эдийн засаг өсөн нэмэгдэхийн хэрээр түрээсийн харилцаа өргөжиж байгаа нь төрөөс тусгайлсан зохицуулалт хийх зайлшгүй шаардлага байгааг илэрхийлж байгаа юм. Тэр дундаа үйл ажиллагааны түрээсийн хувьд одоогийн иргэний хуулиар зохицуулагдаж байгаа нь “түрээслүүлэгч тал”-д давуу талыг бий болгох нөхцөл бий болгож байна. Тиймээс Иргэний хууль болон бусад хуулиар зохицуулалтгүй орхисон, зохицуулах боломжгүй үйл ажиллагааны харилцааг зохицуулаг түрээсийн хуулийн төслийг боловсруулах нь энэ төслийн гол зорилго болно.

Бодит хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тодорхойлолт:

Үйл ажиллагааны түрээсийн хуулийн төслийг боловсруулахдаа цаашид түрээсийн харилцаанд үүсэх эрсдлийг бууруулах, түрээсийн харилцааны далд хэлбэрийг эдийн засгийн тооцоо судалгаанд оруулах, түрээслэгч түрээслүүлэгчийн эрх ашгийг адил тэгш хамгаалах, аль нэг талд давамгай үйлчлэхгүй байх нөхцлийг бий болгох зарчмыг хангаж ажилласан. Үйл ажиллагааны түрээсийн хуулийн төсөлд дараах боловсруулалтыг хийсэн.

- Иргэний хуулийн түрээсийн харилцааны тодорхойлоогүй орхисон хийдлийг нөхөж үйл ажиллагааны түрээсийн хуульд шинээр 15 ойлголтын тодорхойлолтыг оруулж өгсөн.
- 8 төрлийн үйл ажиллагааны түрээсийг тодорхойлж өгсөн ба үүнд газрын болон уул уурхайн түрээсийн харилцааг зохицуулахгүй байхаар боловсруулсан.
- Үйл ажиллагааны түрээсийн депозит, түрээсийн чадамжийн үнэлгээний зохицуулалт болон даатгалын харилцааг шинээр оруулж өгсөн.
- Түрээсийн төлбөрийг үндэслэлтэй тогтоох, урьдчилгаа төлбөр авахыг хориглох, түрээслүүлэгчийн хохирлыг барагдуулах депозитийн харилцааг шинээр оруулж өгсөн.
- Түрээслүүлэгч болон түрээслэгчийн харилцааг иргэний нийгмийн байгууллагаар дамжуулан зохицуулах, төрийн оролцоог тодорхой болгох, түрээсийн гэрээг заавал бүртгэх зохицуулалт зэргийг тодорхой болгосон.
- Давхар болон дамжуулан түрээслэх үйл ажиллагааг дамлан түрээслэхээс ялган хуульчилж, дамлан түрээслэхийг хориглосон.
- Мөн түрээсийн харилцааны эрсдлийг бууруулах даатгалын хэлбэрийг бий болгосноос гадна гүүдвилийн харилцааг зохицуулж өгснөөр түрээслэгчийн өөрийн бий болгосон бизнесийг түрээслүүлэгч болон түүний хамсаатанд алдах магадлалыг бууруулсан.

[11] Мирим Консалтинг ХХК-аас хийсэн судалгаа.2014.УБ. http://mirim.mn/project/39

Бодит үр дүн/ Амжилтууд:

Үйл ажиллагааны түрээсийн харилцааг зохицуулах энэ хуулийн төслийг боловсруулснаар түрээслэгч болон түрээслүүлэгч нарын хооронд үл ойлголцох байдал гарах, нийгмийн бухимдал үүсэх, эдийн засгийн нөөцийг буруу зарцуулах зэрэг эрсдлийг бууруулах бодит нөхцлийг бүрдүүлэх боломжтой болж байгаа бөгөөд цаашлаад энэ хууль батлагдсанаар Иргэний хуулиар зохицуулалтгүй орхисон үйл ажиллагааны түрээсийн бусад харилцааг хуульчлан зохицуулалт хийх боломжтой болж байгаа юм.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

Хавсралт 3

Түрээсийн харилцаанд хамаарах эрх зүйн зохицуулалтын түүвэр жагсаалт

д/д	Хууль, тогтоомжийн нэр	Утга
Хууль		
1	**Иргэний хууль**	**318 дугаар зүйл. Түрээсийн гэрээ** 318.1.Түрээсийн гэрээгээр түрээслүүлэгч нь түрээслэгчийн эзэмшил, ашиглалтад аж ахуйн үйл ажиллагаа явуулах болон дүрэмд заасан зорилгоо биелүүлэхэд нь зориулж тодорхой хөрөнгө шилжүүлэх, түрээслэгч нь гэрээгээр тохирсон түрээсийн төлбөрийг төлөх үүргийг тус тус хүлээнэ. 318.2.Түрээслэгч нь гэрээнд заасан хугацааны туршид тухайн хөрөнгийг зориулалтын дагуу ашигласны үр дүнд бий болсон үр шимийг олж авах эрх эдэлнэ. 318.3.Хуульд өөрөөр заагаагүй бол түрээсийн гэрээг бичгээр байгуулах бөгөөд үл хөдлөх эд хөрөнгө түрээслэх гэрээг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгүүлнэ. */Энэ хэсэгт 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/* 318.4.Энэ хуулийн 318.3-т заасан шаардлагыг хангаагүй гэрээ хүчин төгөлдөр бус байна. 318.5.Энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол түрээсийн гэрээнд эд хөрөнгө хөлслөх гэрээний журам нэгэн адил үйлчилнэ. **319 дүгээр зүйл. Түрээсийн төлбөр** 319.1.Түрээсийн төлбөрийг мөнгө, эсхүл өөр хэлбэрээр төлөхөөр тохиролцож болно. 319.2.Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас түрээсэлсэн эд хөрөнгийн чанар байдал алдагдвал талууд харилцан тохиролцож түрээсийн төлбөрийн хэмжээг өөрчилж болно. **320 дугаар зүйл. Түрээсийн гэрээний хугацаа** 320.1.Түрээсийн гэрээний хугацааг талууд тохиролцож тогтооно. 320.2.Түрээсийн гэрээг арваас дээш жилийн хугацаатай хийсэн бол арван жил өнгөрмөгц аль нэг талын санаачилгаар, хуульд заасан журмаар гэрээг цуцалж болно. 320.3.Газар буюу эрх түрээслэх гэрээний хугацааг талууд тогтоогоогүй бол гэрээг түрээсийн жилийн эцэст буюу түрээсийн жил дууссанаас хойш нэг сарын дотор цуцалж болно. 320.4.Түрээсийн гэрээг хугацаанаас өмнө цуцлахад энэ хуулийн 320.3-т заасан журмыг баримтална. **321 дүгээр зүйл. Газрыг хэрэглэгдэхүүний хамт түрээслэх** 321.1.Газрыг хэрэглэгдэхүүний хамт түрээсэлсэн түрээслэгч хэрэглэгдэхүүн тус бүрийг арчлан хамгаалах үүрэгтэй. 321.2.Түрээслэгчээс үл хамаарах шалтгаанаар хэрэглэгдэхүүн устах буюу гэмтсэн бол түрээслүүлэгч сольж өгөх үүрэгтэй. 321.3.Газар түрээслэгч хэрэглэгдэхүүнийг түрээслэхдээ тус тусад нь үнэлж, түрээсийн гэрээ дуусгавар болоход түрээслүүлэгчид эргүүлэн өгөхөөр гэрээнд тохиролцсон бол гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлаас хэрэглэгдэхүүн устсан буюу гэмтсэний үр дагаврыг хариуцна. 321.4.Гэрээнд заасан бол түрээслэгч нь түрээсэлж байгаа хэрэглэгдэхүүний зарим хэсгийг аж ахуйн зориулалтаар нь захиран зарцуулж болно. 321.5.Түрээслэгч түрээсэлсэн газрын хэрэглэгдэхүүнийг аж ахуйн зориулалтаар ашиглах шаардлагад нийцсэн хэмжээнд байлгах үүрэгтэй. 321.6.Түрээсийн гэрээ дууссаны дараа түрээсэлсэн хэрэглэгдэхүүнд нийлүүлсэн салгаж үл болох эд юмс түрээслүүлэгчийн өмчлөлд шилжинэ. 321.7.Түрээсийн гэрээ дуусгавар болсноор түрээслэгч түрээсэлсэн хэрэглэгдэхүүнийг түрээслүүлэгчид буцаан өгөх үүрэгтэй. 321.8.Хэрэв хэрэглэгдэхүүнийг түрээслэгчид шилжүүлсэн үеийн үнэ, түрээслэгчээс түрээслүүлэгчид буцаан өгөх үеийн үнийн хооронд зөрүү гарсан бол энэ зөрүүг түрээслэгч нөхөн төлнө. Хэрэглэгдэхүүний үнийг түрээсийн гэрээ дуусгавар болох үеийн ханшаар тогтооно. 321.9.Түрээслүүлэгч нь түрээслэгчийн нийлүүлсэн, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд ач холбогдолгүй, эсхүл хэт их үнэтэй хэрэглэгдэхүүнийг хүлээн авахгүй байх буюу төлбөр төлөхөөс татгалзах эрхтэй. 321.10.Түрээслэгч нь түрээсэлсэн газрын хэрэглэгдэхүүний талаар гаргасан шаардлагаа хангуулах үүднээс түрээсээр эзэмшиж байгаа газрын хэрэглэгдэхүүнээс барьцаалах эрхтэй. Түрээслүүлэгч шаардлагыг өөр байдлаар хангах болсон бол түрээслэгч барьцаалах эрхээсээ татгалзах, харин шаардлагын зохих хэсгийг мөнгөн хэлбэрээр хангасан бол түрээслэгч барьцаанд байгаа хэрэглэгдэхүүний аль нэг хэсгийг барьцаанаас чөлөөлнө. **322 дугаар зүйл. Үйлдвэр, аж ахуйг түрээслэх** 322.1.Үйлдвэр, аж ахуйг хэрэглэгдэхүүний хамт түрээсэлж болно. 322.2.Хэрэглэгдэхүүнд хамаарах мал, тэжээвэр амьтан устсан буюу гэмтсэн бол түрээслэгч аж ахуйн үйл ажиллагааг зохих ёсоор эрхэлсэн эсэхээс үл хамааран түрээслүүлэгчид учирсан гэм хорыг арилгах үүрэгтэй. 322.3.Үйлдвэр, аж ахуйг түрээслэхэд энэ хуулийн 321 дүгээр зүйлд заасан журам нэгэн адил үйлчилнэ.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.mli.gov.mn

323 дугаар зүйл. Дамжуулан түрээслэх

323.1.Гэрээнд өөрөөр заагаагүй бол түрээслэгч түрээсэлсэн эд хөрөнгийг гагцхүү түрээслүүлэгчийн зөвшөөрөлтэйгээр дамжуулан түрээсэлж болно.

324 дүгээр зүйл. Түрээслэгч солигдох

324.1.Түрээслэгч нь түрээсийн гэрээний хугацаа дуусахаас өмнө түрээсэлсэн эд хөрөнгийг түрээслүүлэгчид буцаан өгсөн тохиолдолд гэрээний хугацаа дуусах хүртэл түрээсийн төлбөрөөс чөлөөлөгдөхгүй.

324.2.Түрээслэгч өөрийнхөө оронд түрээсийн гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн, төлбөрийн чадвар бүхий өөр түрээслэгчийг санал болгосныг түрээслүүлэгч хүлээн зөвшөөрсөн нөхцөлд түрээслэгч энэ хуулийн 324.1-д заасан үүргээс чөлөөлөгдөнө.

325 дугаар зүйл. Түрээслэгч нас барсны дараа түрээсийн гэрээ үргэлжлэх

325.1.Түрээслэгч нас барсан тохиолдолд түүний өвлөгч буюу түрээслүүлэгч хуанлийн жилийн тухайн улирал дуусанаас хойш 6 сарын дотор түрээсийн гэрээг цуцалж болно.

325.2.Түрээслэгчийн өвлөгч өөрөө, эсхүл гуравдагч этгээдээр дамжуулан түрээсэлсэн эд хөрөнгийг аж ахуйн зориулалтаар ашиглаж чадна гэж үзвэл түрээсийн гэрээг цуцлахаас татгалзаж, гэрээг үргэлжлүүлэхээр түрээслүүлэгчээс шаардаж болно.

326 дугаар зүйл. Түрээслэгчийн хариуцлага

326.1.Түрээслэгч түрээсийн гэрээ дуусгавар болсны дараа ердийн буюу гэрээгээр тохиролцсон элэгдлийг тооцож түрээсэлсэн эд хөрөнгийг бүцаан өгөх үүрэгтэй.

326.2.Түрээслүүлэгч өөрт учирсан хохирол, хэтэрсэн хугацааны түрээсийн төлбөрийг нөхөн төлөхийг шаардаж болно.

ХОРИН НАЙМДУГААР БҮЛЭГ
Хөдөө аж ахуйн зориулалттай газрын түрээс

327 дугаар зүйл. Хөдөө аж ахуйн зориулалттай газрын түрээсийн гэрээ

327.1.Хөдөө аж ахуйн зориулалттай газрыг уг зориулалтаар ашиглуулахаар сууцны болон аж ахуйн зориулалтаар ашиглагдах байгууламжийн хамт, эсхүл тийм байгууламжгүйгээр түрээсэлж болно.

327.2.Энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол хөдөө аж ахуйн зориулалттай газрыг түрээслэхэд түрээсийн гэрээний журам нэгэн адил үйлчилнэ.

328 дугаар зүйл. Гэрээгээр шилжүүлэх эд хөрөнгө

328.1.Түрээслүүлэгч нь газрыг гэрээнд заасан зориулалтаар ашиглах шаардлага хангасан эд хөрөнгийн хамтаар түрээслэгчид шилжүүлэх үүрэгтэй.

328.2.Гэрээнд өөрөөр заагаагүй бол түрээслэгч түрээсээр шилжүүлсэн сууцны болон аж ахуйн зориулалттай барилга байгууламж, зам, хашаа зэрэг эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангахтай холбогдсон урсгал засварыг өөрийн зардлаар хийх, түрээсэлж авсан эд хөрөнгийг аж ахуйн зориулалтаар нь ашиглах үүрэг хүлээнэ.

328.3.Түрээсийн гэрээний харилцаа үүсэх, дуусгавар болох үед талууд гэрээгээр шилжүүлбэл зохих эд хөрөнгийн тоо хэмжээ, үнэ, шилжүүлэх үеийн чанарын байдал зэргийг заасан жагсаалтыг хамтран үйлдэж, гарын үсэг зурж баталгаажуулна.

329 дүгээр зүйл. Түрээслүүлэгчийн барьцааны эрх

329.1.Түрээслүүлэгч нь түрээсийн гэрээгээр түрээслэгчид гаргах шаардлагаа хангуулахын тулд түрээслэгчийн түрээсэлж авсан эд хөрөнгийг ашигласны үр дүнд олж авсан эд юмс, үр шимийг барьцаалах эрхтэй.

330 дугаар зүйл. Гэрээний хугацааг сунгах

330.1.Хөдөө аж ахуйн зориулалттай газрын түрээсийн гэрээг хоёр жилээс дээш хугацаагаар, бичгээр хийх бөгөөд энэ журмыг баримтлаагүй байгуулсан гэрээг тодорхой бус хугацаагаар байгуулсан гэж үзэж уг гэрээ үйлчилж эхэлснээс хойш нэг жил өнгөрснөөр дуусгавар болгоно.

330.2.Гурван жилээс дээш хугацаагаар байгуулсан гэрээг сунгах тухай гэрээний нэг талын саналыг ирснээс хойш 3 сарын дотор нөгөө тал татгалзаж байгаа тухай мэдэгдээгүй бол түүнийг тодорхой бус хугацаагаар байгуулсанд тооцно.

330.3.Гэрээг сунгах тухай санал болон татгалзлыг бичгээр үйлдэнэ.

331 дүгээр зүйл. Зайлшгүй зардал төлөх үүрэг

331.1.Түрээслүүлэгч түрээслэгчид түрээслэн авсан эд хөрөнгөтэй холбогдон гарсан зайлшгүй зардлыг нөхөн төлөх үүрэгтэй.

331.2.Энэ хуулийн 331.1-д зааснаас бусад зардлыг түрээслүүлэгч нөхөн төлөхөөр зөвшөөрсөн бол түрээсийн харилцаа дуусгавар болох үед төлнө.

332 дугаар зүйл. Гэрээ дуусгавар болох үеийн талуудын эрх, үүрэг

332.1.Аж ахуйн үйл ажиллагааг зохих ёсоор явуулсны үр дүнд бий болсон ургацаа хураан аваагүй байхад түрээсийн гэрээ дуусгавар болсон бол түрээслэгч түрээсийн гэрээг сунгахыг түрээслүүлэгчээс шаардах, эсхүл хураан аваагүй байгаа ургацын өртгийг түрээслүүлэгч түрээслэгчид төлөх үүрэгтэй.

332.2.Хөдөө аж ахуйн зориулалттай газрын түрээсийн хугацаа дуусахад түрээслэгч нь түрээслүүлэгчид газар, барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ердийн буюу гэрээгээр тохиролцсон элэгдлийг тооцож аж ахуйн хэвийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх шаардлагад тохирохоор бүрэн бүтэн хүлээлгэн өгөх үүрэгтэй.

332.3.Түрээслэгч нь түрээслэн авсан эд хөрөнгийг анх хүлээн авах үеийнхээс илүү чанаржуулан үлдээхээр бол түрээслүүлэгчээс нөхөн төлбөр шаардах эрхтэй.

332.4.Түрээсийн гэрээ дуусгавар болоход түрээслэгч нь салгаж болох засан сайжруулалтыг салгаж авах буюу түрээслүүлэгч нь зохих үнийг төлж өөртөө авч болно.

ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ
WWW.LEGALINFO.MN

2	**Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай**	13 дугаар зүйл. Элэгдэл, хорогдлын шимтгэл тооцох 13.8.Санхүүгийн түрээсийн гэрээгээр түрээслэсэн хөрөнгийг түрээслүүлэгч, түрээслэгч харилцан тохиролцож аль нэг талын санхүүгийн тайлан балансад бүртгэнэ.
6	**Төрийн болон орон нутгийн өмчийн тухай**	28 дугаар зүйл. Төрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх 1. Төрийн нийтийн зориулалттай өмчийг түрээслүүлэх журмыг Улсын Их Хурал, төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журмыг Иргэний хуульд нийцүүлэн Засгийн газар тогтооно 2. Засгийн газраас тусгайлан журамласнаас бусад үл хөдлөх хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг төрийн өмчит хуулийн этгээд эдэлнэ. 3. Түрээсийн гэрээнд Иргэний хуулийн 105 дугаар зүйлд заасан нөхцөлөөс гадна эд хөрөнгө түрээслүүлэх хугацаа, төлбөр, нөхцөл, хугацаанаас өмнө цуцлах үндэслэл, үүсэх үр дагавар, түүнийг арилгах журмыг заавал тусгана. /Энэ хэсэгт 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/ 4. Түрээсэлсэн эд хөрөнгийг худалдах тохиолдолд түрээслэгчид Иргэний хуулийн 105 дугаар зүйлд заасан эрх /тэргүүн ээлжинд худалдан авах/ эдлүүлэх эсэхийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шийдвэрлэнэ.
7	**Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай**	9 дүгээр зүйл.Үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг барьцаалуулах 9.3.Үүрэг гүйцэтгэгч /түрээслэгч, хөлслөгч/ нь үл хөдлөх эд хөрөнгийг түрээслэх, хөлслөх эрхийг гагцхүү үүрэг гүйцэтгүүлэгч /түрээслүүлэгч, хөлслүүлэгч/-ийн бичгээр өгсөн зөвшөөрөлтэйгээр барьцаалуулж болно.
8	**Улсын бүртгэлийн ерөнхий хууль**	5.5.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл дараахь төрөлтэй байна: 5.5.6.түрээсийн;
9	**Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай**	32 дугаар зүйл.Үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн бүртгэл32.4.Түрээсийн эрхийн улсын бүртгэлд дараахь зүйлийг тусгана: 32.4.1.түрээслэгчийн овог, эцэг/эх/-ийн нэр, нэр, оршин суугаа хаяг, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, түрээслэгч нь хуулийн этгээд бол түүний нэр, оршин байгаа газар, улсын бүртгэлийн дугаар, түүнийг төлөөлөн түрээсийн гэрээ байгуулах этгээдийн эцэг/эх/-ийн нэр, нэр, оршин суугаа хаяг, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар; 32.4.2.түрээслүүлэх үл хөдлөх эд хөрөнгийн хэмжээ, байршил, гэрээний үнэ, нөхцөл, хугацаа. 32.5.Газар түрээсэлж байгаа бол мэдүүлэгт түрээслэх газрын кадастрын зургийг хавсаргана.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

10	**Өрсөлдөөний тухай**	3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ3.1.Энэ хуулийн үйлчлэлд аж ахуй эрхлэгч, төрийн, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага хамаарна. 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт 4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: 4.1.5.“ноёлох үйл ажиллагаа” гэж давамгай байдлаа хууль бусаар ашиглаж бусад аж ахуй эрхлэгчийг зах зээлд гарч ирэх нөхцөлийг хаан боогдуулах, зах зээлээс шахан гаргах зорилгоор зах зээлд борлуулж байгаа тухайн бараа бүтээгдэхүүний тоо, хэмжээ, үнэ зэргийг хязгаарлан өрсөлдөөнийг бодитоор хязгаарлах, хэрэглэгчийг хясан боогдуулахыг; 6 дугаар зүйл.Зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгчийн үйл ажиллагааг зохицуулах 6.1.Энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар нь зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгчийн үйл ажиллагаанд дараахь зохицуулалт хийнэ: 6.1.2.бодит зардлыг нь харгалзан тухайн бараа бүтээгдэхүүнийг борлуулах үнийн өөрчлөлтийг хянан зөвшөөрөл олгох. 7 дугаар зүйл.Давамгай байдлаа хууль бусаар ашиглах 7.1.Давамгай байдалтай аж ахуй эрхлэгч дараахь ноёлох үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 7.1.2.бараа бүтээгдэхүүнд үндэслэлгүйгээр хэт өндөр үнэ тогтоох; 7.1.3.аж ахуй эрхлэгчээс борлуулалтын нэмэлт нөхцөлийг шаардах, зах зээлд ижил төрлийн бараа бүтээгдэхүүнийг ялгавартай үнээр борлуулах, үндэслэлгүйгээр борлуулалт хийхээс татгалзах. Энэ нь бүс нутгийн байршлаас хамаарсан тээврийн бодит зардлыг тооцсон бараа бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт, үйлдвэрлэгч, нийлүүлэгчээс бөөний болон жижиглэнгийн худалдан авагчид өгч байгаа урамшуулалд хамаарахгүй;
УДШ-ийн тогтоол		
11	Монгол улсын дээд шүүхийн зөвлөмж 2016.09.05 №3 гэрээний зарим эрх зүйн маргааны хууль хэрэглээ болон гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахад анхаарах асуудлууд	**Түрээсийн гэрээ болон эд хөрөнгө хөлслөх гэрээний харилцааг тодорхойлохдоо хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн** Түрээсийн болон эд хөрөнгө хөлслөх гэрээгээр бусдын эзэмшил ашиглалтад эд хөрөнгө шилжүүлдэг адил шинж бий боловч түрээсийн гэрээний хувьд гэрээгээр шилжүүлсэн эд хөрөнгийг түрээслэгч зориулалтын дагуу ашиглаж, үр шимийг олж авах эрхтэй байдаг бол эд хөрөнгө хөлслөх гэрээгээр хөлслөгч нь эд хөрөнгийг ашиглах эрхтэй байна. Эд хөрөнгө хөлслөх гэрээний зүйл нь хөлслөгчийн ашиглах хэрэгцээг хангах зорилготой байдаг. Хэрэв тухайн эд хөрөнгийг тодорхой зориулалтаар шилжүүлсэн бол түүнээс гарах үр шимийг түрээслэгч олж авах эрхтэй, тийм учраас түрээсийн зүйлийн зориулалт эд хөрөнгө хөлслөх гэрээнээс ялгаатай нь анхнаасаа тодорхой байдаг байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.ntt.gov.mn

12	Монгол улсын дээд шүүхийн тогтоол 1999.03.08 №79 төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зарим зүйл, хэсгийг тайлбарлах тухай	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн /цаашид «хууль» гэх/ 28 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг дор дурдсанаар тайлбарласугай. 1.Хуулийн 28 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Түрээслэсэн эд хөрөнгийг худалдах тохиолдолд түрээслэгчид Иргэний хуулийн 274 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан эрх /тэргүүн ээлжинд худалдан авах/ эдлүүлэх эсэхийг Төрийн өмчийн хороо шийдвэрлэнэ” гэдгийн “тэргүүн ээлжинд худалдан авах эрх” гэдэгт түрээсийн гэрээний үүргээ зохих ёсоор гүйцэтгэдэг түрээслэгч нь уг эд хөрөнгийг түрээслүүлэгчээс санал болгосон худалдах нөхцөл, үнээр тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй гэж ойлгоно. Хэрэв түрээслэгч түрээслүүлэгчийн санал болгосон худалдах нөхцөл болон үнийг хүлээн зөвшөөрөөгүй бол тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ алдах бөгөөд худалдааг хуульд заасан нийтийн журмаар явуулна. 2.Хууль буюу түрээсийн гэрээнд түрээслэгч нь түрээслэсэн эд хөрөнгөө тэргүүн ээлжинд худалдан авах эрх эдлэхгүй байхаар заасан бол тухайн хууль буюу гэрээнд заасан журмыг баримтлана. 3.”Хуулийн мөн зүйл, хэсгийн “Түрээслэсэн эд хөрөнгийг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэх эсэхийг Төрийн өмчийн хороо шийдвэрлэнэ” гэдгийг төрийн өмчийн түрээслүүлсэнэд хөрөнгийг хувьчлах журмаар буюу хувьчлалаас гадуур худалдах тохиолдолд уг эд хөрөнгийг тэргүүн ээлжинд худалдан авах эрх эдлэхээр түрээсийн гэрээнд заагаагүй түрээслэгч нь Иргэний хуулийн 274 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу эд хөрөнгийг тэргүүн ээлжинд худалдан авах тухай хүсэлт гаргавал түүнд түрээслүүлсэн эд хөрөнгийг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэх эсэхийг Төрийн өмчийн хороо тухай бүрт нь шийдвэрлэх эрхтэй гэж ойлгоно. 4.Эд хөрөнгө түрээслэх гэрээг эрх бүхий байгууллагатай байгуулсан бөгөөд гэрээндээ уул эд хөрөнгийг тэргүүн ээлжинд худалдан авах эрх эдлэхээр заасан, гэрээний үүргээ зохих ёсоор гүйцэтгэдэг түрээслэг чнь гэрээний нөхцлийн дагуу түүнийг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй. Хэрэв ийм тохиолдолд түрээслүүлэгч нь гэрээнийхээ заалтыг зөрчиж уг эд хөрөнгийг өөр этгээдэд худалдах гэрээ байгуулсан байвал түрээслэгч уул эд хөрөнгийн гэрээнд заасан нөхцөл болон үнээр эд хөрөнгийг өөртөө шилжүүлэхийг шаардах эрхтэй байна.
Засгийн газрын тогтоол		
13	Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам 2001 оны №134	4. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээсээр эзэмшигч, ашиглагч нь эд хөрөнгийн баталгаа, төлбөрийн чадвартай Монгол улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд (цаашид “түрээслэгч” гэнэ) байна. 7. Түрээслүүлэгч болон түрээслэгчийн хоорондын харилцааг хууль тогтоомж, энэ журамд заасны дагуу байгуулсан түрээсийн гэрээгээр зохицуулна. 8. Төрийн өөрийн өмчийн тухайн эд хөрөнгийг хоёр буюу түүнээс дээш этгээд түрээслэх бол түрээсийн гэрээний нөхцөлийг түрээслэгч, түрээслүүлэгч харилцан тохиролцоно. Харин төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг зөвхөн нэг этгээдэд түрээслүүлэх бол түрээслэгчийг сонгон шалгаруулна. 9. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслэгч нь түрээсээр эзэмшиж буй төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг дамжуулан түрээслүүлэх, хамтран түрээслэх, эрх залгамжлан түрээслэх бол Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрөл авна. 10. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар, түрээслэгчийг сонгон шалгаруулах журмыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар батална. 11. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авч Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тогтооно.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.mlt.gov.mn

14	Барилга шилжүүлэх тухай 2002.12.25 №271	2. Төрийн өмчийн 15 дугаар байрын барилгад оруулсан 59945686.0 (тавин есөн сая есөн зуун дөчин таван мянга зургаан зуун наян зургаан) төгрөгийн хөрөнгө оруулалтаас уг байрын түрээсийн төлбөрийн үлдэгдэл, эзэмшүүлж байсан үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлыг хасч түрээслэгч “Цаст-У” ХХК-тай тооцоо хийхийг Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг нь шийдвэрлэх арга хэмжээ авахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд тус тус даалгасугай.
15	Жагсаалт батлах тухай / хувьчлагдах барилга байгууламжийн жагсаалт/ 1999.08.25 №133	1.Хувьчлагдах барилга байгууламжийн жагсаалтыг хавсралтын ёсоор баталсугай. 2.Иргэний хуулийн 274 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу жагсаалтад дурдагдсан барилга байгууламжийг түрээсийн гэрээгээр эзэмшиж байгаа түрээслэгчдэд тэргүүн ээлжинд санал болгож, тогтоосон хугацаанд барилгын үнийг төлөөгүй тохиолдолд нийтийн дуудлага худалдаагаар худалдахыг Төрийн өмчийн хорооны дарга Д.Зоригтод үүрэг болгосугай.
16	Түрээсийн гэрээгээр эзэмшиж байгаа зарим барилгын тухай 1999.02.24 №33	1.Түрээсийн гэрээгээр эзэмшиж байгаа түрээслэгч нарт түрээсийн давуу эрхээр худалдах төрийн өмчийн барилгын жагсаалтыг хавсралтын ёсоор баталсугай. 2.Түрээсийн давуу эрхээр худалдахаар санал болгох барилгын үнэлгээг гаргаж, түрээслэгч нарт санал өгсөн өдрөөс хойш 14 хоногийн дотор барилгын үнийг төлөөгүй тохиолдолд тухайн барилгыг нийтийн дуудлага худалдаагаар худалдахыг Төрийн өмчийн хорооны дарга З.Энхболдод даалгасугай.
17	Түрээсэлсэн эд хөрөнгийг худалдах тухай 2000.07.06 №103	Их шавийн дээд сургуулийн түрээсийн гэрээгээр эзэмшиж байгаа байрыг түрээслэгчид нь тэргүүн ээлжинд худалдахыг Төрийн өмчийн хорооны дарга Д.Зоригтод зөвшөөрсүгэй.
18	Хилийн цэргийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2001.06.11 № 126	2. Төрийн өмчийн 13 дугаар байрыг Хилийн цэргийн дээд сургуулийн эзэмшилд шилжүүлэхийг Төрийн өмчийн хорооны дарга Л.Пүрэвдоржид, уг байрны засварт зарцуулсан 20.5 (хорин сая таван зуун мянган) сая төгрөгийг 2001 оны төсөвтөө багтаан түрээслэгчдэд нь нөхөн олгохыг Хилийн цэргийг удирдах газрын дарга П.Сүндэвт тус тус даалгасугай.
19	**Түрээсийн гэрээний заалтад нэмэлт оруулах тухай 2009.01.21** №12	“...Түрээслэгч өөрчлөгдөөгүй тохиолдолд анх байгуулсан гэрээг үргэлжлүүлэн мөрдөх бөгөөд гэрээний нөхцөлийн талаар тохиролцож протокол үйлдэж сунгалтын хамт гэрээнд хавсаргана. Энэхүү протокол нь гэрээний салшгүй хэсэг байна.
20	Иргэдийг орон сууцжуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2013 №136	Улсын Их Хурлын 2010 оны 36 дугаар тогтоол, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь: 3. Ипотекийн зээлээр орон сууц худалдан авах боломжгүй иргэдэд зориулсан “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг боловсруулан батлуулж, эхний ээлжинд 1300 айлын түрээсийн орон суущыг 2013 онд барих ажлыг зохион байгуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр нарт даалгасугай.
21	“Түрээсийн орон сууц” хөтөлбөр 2015 №248	Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн чиглэл 3.1.5. төрийн болон орон нутгийн түрээсийн орон сууцыг түрээслэгчээс энэхүү хөтөлбөрийн 4.1.4-т заасан түрээсийн төлбөрийг хуримтлуулж улс, орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлнэ. Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа 4.1.1. Орон сууцны тухай хуульд түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх, ашиглах, түрээслэгч, түрээслүүлэгчийн эрх ашиг, үүрэг хариуцлага, түрээсийн төлбөртэй холбогдсон нэмэлт, өөрчлөлт оруулах;

www.legalinfo.mn

22	“Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр” 2017 оны 98 дугаар тогтоол	4.1.11. арьс шир, ноос, ноолуур боловсруулах үйлдвэр, авто техникийн болон барилгын материалын захыг нийслэлээс үе шаттай нүүлгэн шилжүүлж, инновацид тулгуурласан ногоон технологи бүхий үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх;
Нийслэлийн Засаг даргын захирамж		
23	Цагийн хуваарь батлах тухай 2014.06.17 №А/505	1. Цагийн хуваарьт өөрчлөлт оруулах талаар байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс ирүүлсэн санал, хүсэлтийн дагуу Нийслэлийн замын хөдөлгөөний ачааллыг тэнцвэржүүлэх, түгжрэл саатлыг бууруулах зорилгоор худалдааны төв, зах болон автозамын дагуу байрлах худалдаа, үйлчилгээний газар /нүүрс, түлээ, мод, барилгын материал, автомашин, техникийн худалдаа, үйлчилгээ, засвар/-ын ажиллах цагийн хуваарийг хавсралтад заасны дагуу шинэчлэн баталж 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГ
www.nli.gov.mn

Хавсралт 4

Давамгай болон зүй ёсны монополь байдалтай аж ахуйн нэгжүүдийн жагсаалт[12]

д/д	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Бараа бүтээгдэхүүний хүрээ	Зах зээлийн газар зүйн хил хязгаар
Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй худалдааны төв, захын түрээсийн зах зээл			
1	Нарантуул ОУХТ	Худалдааны захын түрээс	Улаанбаатар хотын хэмжээнд
2	Хархорин ХТ		
3	Барс ХТ		
4	Бөмбөгөр ХТ		
5	Хүчит шонхор ХТ		
6	Меркури ХТ		
7	Бүрд ХТ		
8	Саруул ХТ		
Аймгуудад үйл ажиллагаа явуулж буй худалдааны төв, захын түрээсийн зах зээл			
9	Хасу худалдааны төв	Худалдааны захын түрээс	Орон нутагт
10	Есөн эрдэнэ зах		
11	Баясуулагч зах		
12	“Балдан засаг” зах		
13	“Тогтох мандал” зах		
14	Гурван мэргэд зах		
15	Алтан эх худалдааны төв		
16	Тирлик зах		
17	Шинэ-Алтай зах		
18	Шүр зах		
19	Шинэ-Дархан ОУХТ		
20	Арвайхээр зах		
21	Цэцэн харцага зах		
22	Баруун бүсийн худалдааны төв		
23	Хангайн бүс худалдааны төв		
24	Гандирс худалдааны төв		
25	Дээж зах		
26	Эргэл зах		
27	Мөнхдүүрэн зах		
28	Алтан булаг зах		
29	хурх зах		
30	Хан-Орд зах		
31	Их буян худалдаа үйлчилгээний төв		
32	Хөвсгөл эх худалдаа үйлчилгээний төв		
33	Увс зах		
34	Итгэлт зах		

[12] Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар. Зүй болон давамгай жагсаалт.xlsx. https://www.dropbox.com/s/cihp7q6stiww46p/.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Нийслэлийн Засаг даргын 2014 оны 06 сарын 17 -ний өдрийн А/505 дугаар захирамжийн хавсралт

Худалдааны төв, зах болон автозамын дагуу байрлах худалдаа, үйлчилгээний газрын ажиллах цагийн хуваарь

д/д	Худалдаа, үйлчилгээний газрын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Байршил	Амрах өдөр / гариг/	Ажлын өдөр	
				Ажил эхлэх цаг	Ажил дуусах цаг	
Баянзүрх дүүрэг						
1	Нарантуул худалдааны төв	Нарантуул трейд ХХК	Баянзүрх дүүрэг 14 дүгээр хороо	Мягмар	10.00	20.00
2	Дүнжингарав худалдааны төв	Дүнжингарав ХХК	Баянзүрх дүүрэг 26 дугаар хороо	Даваа	10.00	20.00
3	Өгөөмөр техникийн зах	Собу ХХК	Баянзүрх дүүрэг 14 дүгээр хороо	Лхагва	10.00	19.00
4	Да хүрээ худалдааны төв	Да хүрээ трейд ХХК	Баянзүрх дүүрэг 17 дугаар хороо	Даваа	08.00	18.00
5	Сандэй плаза худалдааны төв	Сандэй плаза ХХК	Баянзүрх дүүрэг 14 дүгээр хороо	Даваа	10.00	22.00
6	Шөнийн зах	Нармон ХХК	Баянзүрх дүүрэг 14 дүгээр хороо	Пүрэв	12.00	00.00
7	Цайз, Цолмонбадрах, Доной модны зах болон түүний ойр орчмын түлээ, нүүрсний цэгүүд	Цайз ХХК Цолмонбадрах ХХК Доной трейд ХХК	Баянзүрх дүүрэг 19 дүгээр хороо	Лхагва	10.00	19.00
8	Цайз захын уулзвараас Да хүрээ зах хүртэл Шар хадны зам дагуух бүх авто худалдаа, үйлчилгээ, засварын газрууд		Баянзүрх дүүрэг 17, 19 дүгээр хороо	Даваа	08.00	18.00
9	Баянзүрх худалдааны төв	Хан талст ХХК	Баянзүрх дүүрэг 6 дугаар хороо	Пүрэв	09.00	19.00
10	Баянзүрх худалдааны төв-2	Маркет плейс менежмент ХХК	Баянзүрх дүүрэг 6 дугаар хороо	Лхагва	09.00	19.00
Сүхбаатар дүүрэг						
1	100 айл орчмын барилгын материалын бүх дэлгүүр		Сүхбаатар дүүрэг 10,11 дүгээр хороо	Пүрэв	07.00	18.00
2	Меркури худалдааны төв	Гурван эвтэн ХХК	Сүхбаатар дүүрэг 3 дугаар хороо	Даваа	10.00	19.00
Баянгол дүүрэг						
1	Барс худалдааны төв	Барс импекс ХХК	Баянгол дүүрэг 3 дугаар хороо	амралт-гүй	07.00	17.00

www.nlis.gov.mn

2	Хар хорин худалдааны төв	Чингэс трейд ХХК	Баянгол дүүрэг 20 дугаар хороо	Даваа	10.00	19.00
3	Барс-2 худалдааны төв	МВС групп ХХК	Баянгол дүүрэг 20 дугаар хороо	Мягмар	10.00	19.00
4	Хялганат модны зах	Дата төв ХХК	Баянгол дүүрэг 20 дугаар хороо	Пүрэв	09.00	19.00
5	Гурвалжин-44 модны зах	УБТЗ-ын АБТЭМА	Баянгол дүүрэг 20 дугаар хороо	Пүрэв	09.00	19.00
Хан-Уул дүүрэг						
1	Мишээл экспо худалдааны төв	Мишээл групп ХХК	Хан-Уул дүүрэг 2 дугаар хороо	Лхагва	10.00	20.00
Чингэлтэй дүүрэг						
1	Бөмбөгөр-1 худалдааны төв	Эрдэнэбулган ХХК Юмт бөмбөгөр ХХК	Чингэлтэй дүүрэг 2 дугаар хороо	Даваа	10.00	20.00
2	Бөмбөгөр-2 “Содон” худалдааны төв	Эрдэнэбулган ХХК	Чингэлтэй дүүрэг 2 дугаар хороо	Лхагва	09.00	19.00
3	Алтжин бөмбөгөр худалдааны төв	Даян-Өндөр ХХК	Чингэлтэй дүүрэг 2 дугаар хороо	Пүрэв	11.00	20.00
4	Шонхор зах	Хүчит шонхор ХХК	Чингэлтэй дүүрэг 11 дүгээр хороо	Пүрэв	05.00	19.00
5	Нарантуул-2 худалдааны төв	Анко ХХК	Чингэлтэй дүүрэг 12 дугаар хороо	Даваа	05.00	19.00
6	Гялгар модны зах	Шинэ үйлс ХХК	Чингэлтэй дүүрэг 13 дугаар хороо	Мягмар	09.00	19.00
Сонгинохайрхан дүүрэг						
1	Хангай модны зах	Мөстийн гол ХХК	Сонгинохайрхан дүүрэг 6 дугаар хороо	Даваа	09.00	19.00
2	Сонсголон модны зах	Сонсголон ХХК	Сонгинохайрхан дүүрэг 20 дугаар хороо	Лхагва	09.00	19.00

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ШИЙДВЭР МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

2014 оны 01 сарын 06 Дугаар 0025 Улаанбаатар хот

Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхийн шүүх хуралдааныг шүүгч О.Оюунгэрэл даргалж, тус шүүхийн “В” танхимд нээлттэй хийсэн хуралдаанаар Нэхэмжлэгч: “Хүчит шонхор” ХХК, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 11 дүгээр хороо, Дэнжийн мянга, Шонхор худалдааны төв. Хариуцагч: Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын ахлах байцаагч Г.Энхманлайд холбогдох, Нэхэмжлэлийн шаардлага: “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагчийн 2013 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 0000109 дүгээр шийтгэврийг хүчингүй болгуулах” шаардлага бүхий нэхэмжлэлтэй захиргааны хэргийг хянан хэлэлцэв. Шүүх хуралдаанд нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ж. Отгонжаргал, нэхэмжлэгчийн өмгөөлөгч П.Одгэрэл, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ж.Очирхуяг, гэрч н.Дамдинсүрэн, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Б.Цэцэгмаа нар оролцов. ТОДОРХОЙЛОХ нь: Нэг. Нэхэмжлэгч “Хүчит шонхор” ХХК-ийн гүйцэтгэх захирал Т.Сайнхүү шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ: “Шонхор” худалдааны төв 1992 онд байгуулагдаж 21 дэх жилдээ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тус төвийн захиргаанаас худалдаа үйлчилгээний салбарт мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, зохих стандартын шаардлагыг хангасан чанартай, эрүүл хүнсээр хэрэглэгчдэд үйлчлэхийн төлөө 800 гаруй түрээслэгчидтэй идэвхи санаачлагатай хамтран ажилласаар байна. Тус худалдааны төв нь бусад хүнсний зах, төвүүдэд үлгэр дуурайлал болж 2010 онд улсын хэмжээнд шалгарч ХХААХҮЯ, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, МҮХАҮТ-ын “Шилдэг худалдааны төв” өргөмжлөл цомоор шагнагдаж байсан. ШӨХТГ-ын улсын ахлах байцаагч Г.Энхманлай болон Улсын байцаагч Ж.Очирхуяг нарын гарын үсэг бүхий 2013 оны 5-р сарын 23-ны өдрийн 5/132 албан тоот бүхий шаардлагыг “Хүчит Шонхор” ХХК-нийн гүйцэтгэх захирал Т.Сайнхүүд ирүүлсэн байна. Уг албан шаардлагад тус захын түрээслэгчдээс “энэ оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 250 мянган төгрөгөөс 330 мянган төгрөгийн хооронд байсан түрээсийн төлбөрийг 1 сая төгрөг болгон гэнэт нэмсэн” тухай өргөдөл ирсний дагуу шалгаж байгаа бөгөөд 1/ “Шонхор” худалдааны төвийн түрээсийн төлбөрийг нэмсэн эсэх талаар тайлбар, 2/ Нэмсэн бол түрээсийн төлбөр нэмсэн тушаал, шийдвэрийн баталгаат хуулбар / обьект түрээс/, 3/ Түрээсийн төлбөр нэмсэнтэй холбогдуулан түрээслэгчидтэй байгуулсан гэрээний баталгаат хуулбар, 4/ Түрээсийн төлбөр нэмэх болсон шалтгаан, үндэслэл, тооцоо, судалгааг 2013 оны 5-р сарын 27-ны өдрийн дотор гаргаж ирүүлэхийг мэдэгдсэн. Уг шаардлагын дагуу “Хүчит шонхор” ХХК-аас 2013 оны 5-р сарын 27-ны өдрийн 79 тоотоор ШӨХТГ-т зохих судалгаа, үндэслэл бүхий хариу тайлбарыг албан ёсоор хүргэж өгсөн байна. ШӨХТГ-ын улсын ахлах байцаагч Г.Энхманлай болон улсын байцаагч Ж.Очирхуяг нар нөхцөл байдлыг хянаж үзээд

ХУУЛЬ ЗҮЙН ШИЙДВЭРИЙН САН
www.legalinfo.mn

2013 оны 6-р сарын 3-ны өдөр зөрчил арилгуулах тухай 5/137 тоот албан шаардлагыг “Хүчит Шонхор” ХХК-д хүргүүлсэн байна. Уг шаардлагаар “ижил хэмжээ бүхий талбайтай обьектод ялгавартай түрээсийн төлбөр тогтоосон нь Өрсөлдөөний тухай хуулийн 7.1,3 -ийг зөрчиж байгаа тул ялгавартай түрээсийн төлбөр тогтоохгүй байхыг шаардаж байна” хэмээн мэдэгджээ. “Хүчит шонхор” ХХК-ниас 2013 оны 6-р сарын 3-ны өдөр 5/137 тоотоор Өрсөлдөөний тухай хуулийн 7.1.3-ийг зөрчөөгүй талаар 4 үндэслэл бүхий хариу тайлбарыг ШӨХТГ-т өгсөн. Гэтэл ШӨХТГ-ын улсын ахлах байцаагч Г.Энхманлай болон улсын байцаагч Ж. Очирхуяг нараас 2013 оны 7-р сарын 4-ний өдөр 5/154 тоот албан шаардлагыг дахин давтаж ирүүлсэн учир “Хүчит шонхор” ХХК-ийн гүйцэтгэх захирал Т.Сайнхүү болон олон нийттэй харилцах албаны дарга Ш.Нямхүү нар 2013 оны 7-р сарын 5-ны өдөр улсын ахлах байцаагч Г.Энхманлайгийн ажил дээр очиж биечлэн уулзаж, тайлбарыг бичгээр хүргэж өгсөн болно. Уулзалтын явцад өөрсдийн дотоод зохион байгуулалтад хийсэн өөрчлөлт, гарсан үр дүнгийн талаар улсын ахлах байцаагч Г.Энхманлайд сайтар тайлбарлаж танилцуулсанд нөхцөл байдлыг маш сайн ойлголоо гэж хэлсэн. Түрээсийн гэрээ нь гэрээний талуудын харилцан тохиролцоо байдаг тул захын захиргаанаас бие даагаад шийдчих боломжгүй. Иймд түрээслэгч нарт ШӨХТГ-аас тавьж буй лангууны түрээсийн үнийг бүгдийг ижил болгох шаардлагыг танилцуулж гэрээнд өөрчлөлт оруулах болсныг мэдэгдсэн. Гэтэл түрээслэгчид гэрээнд өөрчлөлт оруулахыг үл зөвшөөрч эсэргүүцлээ бичгээр илэрхийлж гарын үсэг зурцгаасан байна. Анхнаасаа л захын захиргааны зүгээс бүх лангуунд нэг ижил түрээсийн төлбөр санал болгоход түрээслэгч нар ажлын байрны байршил харилцан адилгүй байгааг илэрхийлж, лангууны түрээсийн төлбөрийг ялгаатай байх санал гаргасныг хүлээн авч харилцан тохиролцож түрээсийн төлбөрөө тогтоож гэрээгээ хийсэн байдаг. Нэгэнт түрээслэгчидтэй хийсэн гэрээнд дахин өөрчлөлт оруулахыг түрээслэгч нар зөвшөөрөөгүй учир захиргааны санаачилгаар дангаар түрээсийн гэрээнд өөрчлөлт оруулах нь хууль зүйн хувьд боломжгүй юм гэдгийг тайлбарлахад улсын ахлах байцаагч Г.Энхманлай нөхцөл байдалтай танилцан ойлгож торгууль шийтгэл тавих үндэслэлгүй юм байна, бид энэ асуудлыг үүгээр цэглэе хэмээн хариу хэлсэн. Харин түрээсийн үнийг буулгах боломжтой эсэх талаар асуухад Т.Сайнхүү захирал “түрээсийн төлбөрийг түрээслэгч нартайгаа харилцан тохиролцож” буулгаж болох талаар санал бодлоо хэлсэн байдаг. ШӨХТГ-т болсон уулзалт, ярилцлагын дараа Т.Сайнхүү захирал 2013 оны 07-р сарын 06-ны өдөр түрээслэгч нартай уулзаж түрээсийн үнийг бууруулахаар харилцан тохиролцсон болно. Гэтэл ШӨХТГ-ын улсын ахлах байцаагч Г.Энхманлайн гарын үсэг бүхий 2013 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 0000109 дугаар шийтгэврээр “Хүчит шонхор” ХХК нь улсын байцаагчийн албан шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй зөрчил гаргасан тул ШӨХТГ-аас Өрсөлдөөний тухай хуулийн 27.2 дахь заалтаар 110 646 850 төгрөгөөр торгосон байна. Энэхүү шийтгэврийг эс зөвшөөрч “Хүчит шонхор” ХХК-иас 2013 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 101 албан тоотоор ШӨХТГ-ын дарга О.Магнайд гомдол гаргасан бөгөөд уг гомдолд улсын ерөнхий байцаагч О.Магнай 2013 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 1/829 албан тоотоор гомдлын шаардлагыг хангах үндэслэлгүй гэсэн хариу өгсөн байна. Улсын ахлах байцаагч Г.Энхманлайгийн 2013 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 0000109 дугаар шийтгэврийг дараах үндэслэлээр хууль зөрчсөн хэмээн үзэж байна. Нэг. Өрсөлдөөний тухай хуулийн 7.1.3-ийг буруу тайлбарлаж хэрэглэсэн. “Хүчит шонхор” ХХК нь худалдааны төв дээрээ 320 орчим ажлын байр /лангуу, павилон/ түрээслүүлж түрээсийн үйл ажиллагаа эрхэлж байна. Лангууны түрээсийн үнэ нь 188,000-800,000 төгрөгийн хооронд байхаар түрээслэгч

нартай тохиролцож түрээсийн гэрээ байгуулсан байна. Лангууны түрээсийн үнэ дараахь үндэслэлийн улмаас ялгаатай байна. Үүнд: 1. Түрээслэгч нар махны, хүнсний ногооны, гурил будааны, гэр ахуйн өргөн хэрэглээний барааны гэсэн төрлөөр худалдаа явуулдаг тул борлуулж буй барааны төрлөөс хамааран лангууны түрээсийн төлбөр өөр өөр байна. 2. Лангууг 3-5 түрээслэгч хамтран түрээсэлдэг бөгөөд мөн лангууг ажиллуулах цаг харилцан адилгүй байна. 3. Лангуунууд байршлын хувьд зарим нь дулаан байранд, зарим нь гадна талбайд, зарим нь худалдан авагч ихтэй зорчдог хэсэгт байхад, зарим нь худалдан авагч харьцангуй цөөн очдог хэсэгт байрладаг учир борлуулалтын байдлаас хамааран лангууны түрээс ялгаатай байна. Тухайлбал гадна байрлах лангууг түрээслэгч нарын тавьсан хүсэлтийн дагуу байршлаар 3 хэсэгт хуваан түрээсийн төлбөрөө тогтоосон. а/ Төв хаалганд ойрхон үйлчлүүлэгчийн орох, гарах зам дээр байрлалтай хэсэг, б/ Хойд тал руу сунаж байрласан хэсэг, в/ Үйлчлүүлэгчийн автомашины зогсоолын ар талд байрлалтай хэсэг гэх мэт. Эдгээр үндэслэл бүхий шаардлагууд байгаа гэдгийг лангуу түрээслэгчдийн мэдүүлэг болон бусад нотлох баримтаас тодорхой харж болно. Ер нь лангууны байршлаас хамааран түрээсийн үнэлгээ ялгаатай байх нь хэнд ч ойлгомжтой. Тэгээд ч “лангуу түрээслэх” нь “бараа бүтээгдэхүүн худалдан борлуулах”-аас утга агуулга болон гарах эрх зүйн үр дагаврын хувьд харилцан адилгүй ялгаатай ойлголт юм. Мөн “Хүчит шонхор” ХХК нь лав л түрээсийн үйл ажиллагаа эрхэлдгийн хувьд “давамгай байдалтай аж ахуй эрхлэгч” биш Улаанбаатар хотод тус компаниас ихээр лангуу түрээслэдэг аж ахуй эрхлэгчид олон байгаа бөгөөд одоогоор манай компанийг “давамгай байдалтай аж ахуй эрхлэгч” гэж бүртгэсэн албан ёсны эрх зүйн акт байхгүй /бидэнд албан ёсоор мэдэгдээгүй/ байна. Дээрх нөхцөл байдлуудаас дүгнэвэл “Хүчит шонхор” ХХК-ний лангуугаа ялгаатай үнээр түрээсэлснийг Өрсөлдөөний тухай хуулийн 7.1.3-ыг зөрчсөн гэж үзээд бүх лангуугаа ижил үнээр түрээслэх шаардлага бүхий улсын ахлах байцаагчийн 2013 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 0000109 дугаар шийтгэвэр нь /Өрсөлдөөний тухай хуулийн 7.1.3-ыг/ хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн байна. Хоёр: Өрсөлдөөний тухай хуулийн 27.2-ийг хэрэглэх ёсгүй байсан. Хэрэв “Хүчит шонхор” ХХК-ийг Өрсөлдөөний тухай хуулийн 7.1.3-ыг зөрчсөн гэж үзвэл Өрсөлдөөний тухай хуулийн 27.1.2-ыг хэрэглэх ёстой. Гэтэл “өмнөх жилийн орлогыг тооцох боломжгүй” гэж үзээд Өрсөлдөөний тухай хуулийн 27.2-ыг хэрэглэсэн нь үндэслэлгүй байна. Учир нь “Хүчит Шонхор” ХХК-нийн орлого болон татвартай холбоотой албан ёсны мэдээллийг татварын байгууллагаас авах бүрэн боломжтой. Гурав: Өрсөлдөөний тухай хуулийн 13.2.4 болон 13.2.5-ыг тус тус зөрчсөн байна. Өрсөлдөөний тухай хуулийн 14.1-д “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар нь өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, өрсөлдөөний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх, аж ахуй эрхлэгч, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн.” гэж заасан байдаг. ШӨХТГ-аас лангууны түрээсийн үнийг бууруулж, ижил болгох шаардлага тавьсан нь, мөн “Хүчит Шонхор” ХХК-нийг давамгай байдалтай аж ахуй эрхлэгч гэж үзэж зах зээлийг хууль бусаар хуваарилж байгаа нь төрийн захиргааны байгууллагад хуулиар хориглосон үйлдэл юм. Иймд улсын байцаагчийн 2013 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 0000109 дугаар шийтгэвэр нь Өрсөлдөөний тухай хуулийн 13.2.4, 13.2.5-д заасныг тус тус зөрчсөн байна. Дөрөв: Өрсөлдөөний тухай хуулийн 7.1.3-ийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, өөрөөр хэлбэл хуулийн зөрчил гаргаагүй байхад торгож ЗХХШтХ 9.1.7-д заасан “‹захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэл байгаагүй” гэсэн нөхцөлийг хангасан, хуулиар хориглосон шийдвэр гаргаж Өрсөлдөөний тухай хуулийн 13.2.4, 13.2.5-ыг

тус тус зөрчсөн. Мөн Өрсөлдөөний тухай хуулийн 27.2-ийг хэрэглэж хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэснээр ЗХХШтХ 9.1.9-д заасан “бусад холбогдох хууль зөрчсөн” гэсэн нөхцөлийг хангасан. Иймд 0000109 дугаар шийтгэвэр болох захиргааны актыг ЗХХШтХ 9.1.7, ЗХХШтХ 9.1.9-д заасан захиргааны акт илт хууль бус байх нөхцөлийг хангасныг тогтоож ЗХХШтХ 70.2.3 дагуу илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрсөн шийдвэр гаргаж өгнө үү.” гэжээ. Хоёр. Хариуцагч Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын улсын ахлах байцаагч Г.Энхманлай шүүхэд ирүүлсэн хариу тайлбартаа: “.....“Хүчит шонхор” ХХК-иас гаргасан Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагчийн 2013 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 0000109 тоот шийтгэврийг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй байна. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар /ШӨХТГ/-аас тус газрын дэд даргын 2013 оны 5 дугаар сарын 30-ны өдөр баталсан 1/37 тоот удирдамжийн дагуу “Хүчит шонхор” ХХК-ийн үйл ажиллагаа нь Өрсөлдөөний тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд хяналт шалгалтын ажлыг хийсэн. Хяналт шалгалтыг ШӨХТГ-ийн Өрсөлдөөний зохицуулалтын хэлтсийн улсын ахлах байцаагч Э.Энхманлай, улсын байцаагч Ж.Очирхуяг, К.Жархынбек нарын бүрэлдэхүүнтэйгээр хийж гүйцэтгэсэн. Хяналт шалгалтын ажлын хэсэг хяналт шалгалтын явцад цугларсан баримт материал, хяналт шалгалтад хамрагдсан болон холбогдох бусад этгээдүүдийн тайлбар, мэдээ, мэдээллийг судлан шалгасан. Улсын байцаагчид “Хүчит шонхор” ХХК-ийг өөрийн Шонхор худалдааны төвийн ижил хэмжээ бүхий талбайтай объектод ялгавартай түрээсийн төлбөр тогтоож түрээслэгч нараас хураан авч Өрсөлдөөний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “Давамгай байдалтай аж ахуй эрхлэгч дараах ноёлох үйл ажиллагаа явуулахыг хориглоно, 7.1.3....зах зээлд ижил төрлийн бараа бүтээгдэхүүнийг ялгавартай үнээр борлуулах, үндэслэлгүйгээр борлуулалт хийхээс татгалзах...” гэж заасныг зөрчсөн болохыг тогтоосон байна. Улмаар уг зөрчлийг арилгахыг “Хүчит шонхор” ХХК-д 2013 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 5/137 дугаартай, 2013 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 5/154 дугаартай улсын байцаагчийн албан шаардлагаар тус тус үүрэг болгосон байдаг. Мөн улсын ахлах байцаагч Г.Энхманлай Өрсөлдөөний тухай хуулийн 7.1.3 дахь заалтыг зөрчсөн “Хүчит шонхор” ХХК-д мөн хуулийн 27.2 дахь хэсэгт заасны дагуу 110,646,850.00 /нэг зуун жаран зургаан сая дөчин зургаан мянга найман зуун тавь/ төгрөгийн торгуулийг 2013 оны 7 дугаар сарын 15-ны өдөр 0000109 дугаартай шийтгэврээр ногдуулсан. “Хүчит шонхор” ХХК-ийн зүгээс 0000109 дугаартай шийтгэврийг хүчингүйд тооцуулахаар 2013 оны 7 дугаар сарын 22-ны өдөр гомдол гаргасныг ШӨХТГ-ын дарга, улсын ерөнхий байцаагч хянаад улсын байцаагчийн шийтгэврийг хүчингүй болгох болон гомдлын шаардлагыг хангах боломжгүй болохыг 2013 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 1/829 дугаартай албан бичгээр мэдэгдсэн байдаг. Тайлбар 1. “Хүчит шонхор” ХХК-ийн нэхэмжлэлийн 1 дэх үндэслэлийн хувьд үндэслэлгүй болох нь дараах байдлаар нотлогдож байна. Үүнд: а/ Өрсөлдөөний тухай хуулийн 7 дугаар зүйлд тухайн зах зээлд давамгай байдалтай аж ахуй эрхлэгч ноёлох үйл ажиллагаа явуулахыг хориглосон тохиолдлуудыг хуульчилсан байдаг. Гэтэл “Хүчит шонхор” ХХК Өрсөлдөөний тухай хуулийн 7.13 дахь заалтыг зөрчин Шонхор худалдааны төвийн объект /лангуу, павильон, чингэлэг гэх.мэт/-ыг түрээслүүлэхдээ тухайн объектыг эзлэхүүн, хэмжээнээс нь үл хамаарч, ялгавартай байдлаар түрээсийн төлбөрийг тогтоож түрээслэгч нараас авдаг байна. Ийнхүү давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийн зүгээс тухайн түрээслэгч аж ахуй эрхлэгчдийн дунд ялгавартай байдлыг бий болгож, өрсөлдөх нөхцөлийг нь хязгаарласан үйлдэл гаргах явдлыг эдийн засгийн

өрсөлдөөний онолоор болон хуулиар хориглодог билээ. ШӨХТГ-аас хийсэн хяналт шалгалтаар “Хүчит шонхор” ХХК Өрсөлдөөний тухай хуулийн 7.1.3 дахь заалтыг зөрчсөн болох нь дараах зүйлүүдээр нотлогддог. Үүнд “Хүчит шонхор” ХХК-ийн 2013 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 79 дугаартай албан бичиг болон түүний хавсралтууд, “Хүчит шонхор” ХХК-ийн 2013 оны 6 дугаар сарын 11-ны өдрийн 85 дугаартай албан бичгээр өгсөн тайлбар, төлбөрийн баримт. Нэхэмжлэлийн үндэслэлийн нэг дэх хэсэгт бичсэнээс мөн нэхэмжлэгчийн Өрсөлдөөний тухай хуулийн 7.1.3 дахь заалтыг зөрчсөн үйлдэл нотлогдохоор байна. Тухайлбал “1. ... борлуулж буй барааны төрлөөс хамааран лангууны түрээсийн төлбөр өөр өөр байна.” гэсэн тайлбарын хувьд үндэслэлгүй болжээ. Учир нь Шонхор худалдааны төвд гадаа байрлалтай мах худалдаалдаг нэг чингэлэгт хэдэн хүн худалдаа хийж байгаагаас нь хамаарч нэг чингэлгийн түрээсийн төлбөрийг 6 дугаар сар хүртэл хугацаанд 150 000-470 000 хүртэл төгрөгөөр, 6 дугаар сараас 350 000 - 900 000 хүртэл төгрөгөөр тогтоож хураан авсан байна. “2. Лангууг 3-5 түрээслэгч хамтарч түрээслэдэг бөгөөд мөн лангууг ажиллуулах цаг харилцан адилгүй байна.» гэсэн байх боловч энэ нь нэг ижил хэмжээ бүхий лангуунд ялгавартай түрээсийн төлбөр тогтоох үндэслэл болохгүй юм. “3. Лангуунууд нь байршлын хувьд ... зарим нь худалдан авагч ихээр зорчдог хэсэгт байхад, зарим нь худалдан авагч харьцангуй цөөн очдог хэсэгт байрладаг учир борлуулалтын байдлаас хамааран лангууны түрээс ялгаатай байна. Тухайлбал гадна байрлах лангууг түрээслэгч нарын тавьсан хүсэлтийн дагуу байршлаар нь 3 хэсэгт хуваан түрээсийн төлбөрөө тогтоосон: ... Ер нь лангууны байршлаас хамааран түрээсийн үнэлгээ ялгаатай байх нь хэнд ч ойлгомжтой” гэсэн зэрэг нь мөн л ижил хэмжээ бүхий лангуунд ялгавартай түрээсийн төлбөр тогтоох үндэслэл болохгүй юм. Иймд «Хүчит шонхор» ХХК нь түрээсийн төлбөрийг дээрх үндэслэлүүдээр ялгавартай байдлаар тогтоосон нь Өрсөлдөөний тухай хуулийн 7.1.3 дахь заалтыг зөрчсөн болох нь мөн нотлогдохоор байна. б/ Нэхэмжлэлийн 1 дэх хэсэгт “Тэгээд ч лангуу түрээслэх нь “бараа бүтээгдэхүүн борлуулахаас утга агуулга болон гарах эрх зүйн үр дагаврын хувьд харилцан адилгүй ялгаатай ойлголт” гэсэн нь үндэслэлгүй юм. Учир нь Өрсөлдөөний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т “Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно: 4.1.1. «бараа бүтээгдэхүүн» гэж зах зээлд худалдах, солилцох, эргэлтийн өөр нэг хэлбэрт оруулах зориулалттай бүх төрлийн эд юмс, төлбөрийн хэрэгсэл, ажил, үйлчилгээ, шилжүүлж болох эрх зэргийг;” гэж заасны дагуу Өрсөлдөөний тухай хуулийн зохицуулалт нь түрээсийн үйлчилгээний зах зээлд мөн нэгэн адил хамаарах юм. в/ Нэхэмжлэлийн 1 дэх хэсэгт “Мөн “Хүчит шонхор” ХХК нь лав л түрээсийн үйл ажиллагаа эрхэлдэгийн хувьд “давамгай байдалтай аж ахуй эрхлэгч” биш Улаанбаатар хотод тус компаниас ихээр лангуу түрээслэдэг аж ахуй эрхлэгчид олон байгаа бөгөөд одоогоор манай компанийг “давамгай байдалтай аж ахуй эрхлэгч” гэж бүртгэсэн албан ёсны эрх зүйн акт байхгүй /бидэнд албан ёсоор мэдэгдээгүй/ байна.” гэсэн нь үндэслэлгүй юм. Учир нь ШӨХТГ-ын 2012 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 12 дугаартай “Давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийг тогтоох тухай” тогтоолоор “Хүчит шонхор” ХХК-ийг Чингэлтэй дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй түрээсийн үйлчилгээний зах зээлд давамгай байдалтай аж ахуй эрхлэгчээр тогтоон бүртгэсэн байдаг. Энэ тухай ШӨХТГ-ын 2012 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 1/1248 дугаартай албан бичгээр болон тус газраас “Хүчит шонхор” ХХК-д 2013 оны 1 дүгээр сард хийсэн хяналт шалгалтын явцад удаа дараа мэдэгдсэн байдаг. Тайлбар 2. “Хүчит шонхор” ХХК-ийн нэхэмжлэлийн 2 дахь үндэслэлийн хувьд үндэслэлгүй болох нь дараахь байдлаар нотлогдож байна. Үүнд: Нэхэмжлэлийн 2 дахь хэсэгт “Өрсөлдөөний

тухай хуулийн 27.2-ийг хэрэглэх ёсгүй байсан” гэсэн нь үндэслэлгүй юм. Учир нь хяналт шалгалтын явцад тус газраас “Хүчит шонхор” ХХК-ийн 2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан балансыг гаргуулан авч судлан үзэхэд уг компанийн түрээсийн үйлчилгээний борлуулалтын орлого тогтоогдох боломжгүй байсан. Иймд Өрсөлдөөний тухай хуулийн 27.2-т «Энэ хуулийн 27.1.1, 27.1.2, 27.1.4-т заасан шийтгэл ногдуулахад аж ахуй эрхлэгчийн тухайн бараа бүтээгдэхүүний өмнөх жилийн болон тухайн жилийн тухайн бараа бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг тооцох боломжгүй, эсхүл борлуулалт хийгдээгүй тохиолдолд энэ хуулийн 27.1.1, 27.1.2, 27.1.4-т заасан аж ахуй эрхлэгчийг өөрийн хөрөнгийн тав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.» гэж заасныг үндэслэн “Хүчит шонхор” ХХК-ийн 2012 оны 4-р улирлын санхүүгийн тайлангийн баланс хэсгийн 2.3.20-т тэмдэглэгдсэн Эзэмшигчийн өмчийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийн торгуулийг шийтгэврээр ногдуулсан. Тайлбар 3. “Хүчит шонхор” ХХК-ийн нэхэмжлэлийн 3-т “Өрсөлдөөний тухай хуулийн 13.2.4 болон 13.2.5-ыг тус тус зөрчсөн” гэх үндэслэлийн хувьд үндэслэлгүй болох нь дараахь байдлаар нотлогдож байна. ШӨХТГ-ын улсын байцаагч нар нь “Зөрчлийг арилгуулах тухай” 2013 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 5/137 дугаартай, 2013 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 5/154 дугаартай улсын байцаагчийн албан шаардлагаар ижил хэмжээ бүхий талбайтай объектод ялгавартай түрээсийн төлбөр тогтоохгүй байхыг, Өрсөлдөөний тухай хуулийн 7.1.3-т заасныг зөрчихгүй байхыг “Хүчит шонхор” ХХК-иас тус тус шаардсан нь Өрсөлдөөний тухай хуулийн 20.2 дахь хэсэг, 20.3.1 хэсэгт үндэслэсэн байдаг. Тайлбар 4. “Хүчит шонхор” ХХК-ийн нэхэмжлэлийн 4-т “Өрсөлдөөний тухай хуулийн 7.1.3-ыг буруу тайлбарлаж хэрэглэсэн, өөрөөр хэлбэл хуулийн зөрчил гаргаагүй байхад торгож ЗХХШТХ 9.1.7-д заасан “захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэл байгаагүй” гэсэн нөхцөлийг хангасан, хуулиар хориглосон шийдвэр гаргаж Өрсөлдөөний тухай хуулийн 13.2.4 болон 13.2.5-ыг тус тус зөрчсөн мөн Өрсөлдөөний тухай хуулийн 27.2-ыг хэрэглэж хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэснээр ЗХХШТХ 9.1.9-д заасан “бусад холбогдох хууль зөрчсөн” гэсэн нөхцөлийг хангасан.” гэсэн үндэслэлүүд нь мөн үндэслэлгүй болох нь нэхэмжлэлд өгч буй энэхүү хариу тайлбарын 1, 2, 3 дахь тайлбар үндэслэлүүдээр нотлогдохоор байна. Иймд “Хүчит шонхор” ХХК-иас гаргасан “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагчийн 2013 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 0000109 тоот шийтгэврийг хүчингүй болгуулах тухай” нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон, ШӨХТГ-ын улсын байцаагчийн 0000109 дугаартай шийтгэврийг хэвээр үлдээн шийдвэрлэж өгнө үү” гэжээ. ҮНДЭСЛЭХ нь: Нэхэмжлэгч нь шүүхэд хандаж Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч Г.Энхманлайд холбогдуулан “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагчийн 2013 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 0000109 дүгээр шийтгэврийг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийн шаардлага гаргажээ. Шүүх хэрэгт авагдсан бичгийн нотлох баримт болон нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгчийн шүүхэд болон шүүх хуралдаанд гаргасан тайлбарыг хянаад дараах хууль зүйн үндэслэлээр нэхэмжлэгч “Хүчит шонхор” ХХК-ийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэлээ. Хүчит шонхор худалдааны төв нь 1992 онд байгуулагдаж тус худалдааны төвд 320 орчим ажлын байр /лангуу, павильон/ түрээслүүлж түрээсийн үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд лангууны түрээсийн үнэ нь 188,000-800,000 төгрөгийн хооронд байхаар түрээслэгч нартай тохиролцож түрээсийн гэрээ байгуулан ажилладаг болох нь нэхэмжлэгч, хариуцагч тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тайлбар, гэрчийн мэдүүлгээр нотлогдож байна. Дээрх лангууны түрээсийн үнэ нь дараах үндэслэлийн улмаас ялгаатай

байсан байна. Үүнд: Түрээслүүлэгч нар махны, хүнсний ногооны, гурил будааны, гэр ахуйн өргөн хэрэглээний барааны гэсэн төрлөөр худалдаа явуулдаг тул борлуулж буй барааны төрлөөс хамааран лангууны түрээсийн төлбөр өөр өөр, лангууг 3-5 түрээслэгч хамтран түрээслэдэг, мөн лангууг ажиллуулах цаг харилцан адилгүй, лангуунууд байршлын хувьд зарим нь дулаан байранд, зарим нь гадна талбайд, зарим нь худалдан авагч ихээр зорчдог хэсэгт байхад, зарим нь худалдан авагч харьцангуй цөөн очдог хэсэгт байрладаг учир борлуулалтын байдлаас хамааран лангууны түрээс ялгаатай байдаг. Тухайлбал гадна байрлах лангууг түрээслэгч нарын тавьсан хүсэлтийн дагуу байршлаар нь 3 хэсэгт хуваан түрээсийн төлбөрөө тогтоосон байна "төв хаалганд ойрхон үйлчлүүлэгчийн орох, гарах зам дээр байрлалтай хэсэг, хойд тал руу сунаж байрласан хэсэг, үйлчлүүлэгчийн автомашины зогсоолын ар талд байрлалтай хэсэг" гэж эдгээрийн байршлаас хамаарч лангууны түрээсийн үнэлгээ ялгаатай байдаг байна. "Хүчит шонхор" ХХК-нь түрээслэгч нартай гэрээ байгуулахдаа "харилцан тохиролцож хийх" гэсэн Иргэний хуулийн заалтыг баримталсан байна. Нэхэмжлэгчийн дээрх тайлбараас үзвэл Өрсөлдөөний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3-т зааснаар "Хүчит шонхор" ХХК-ыг лангууны түрээсийн үнийг ноёлох үйл ажиллагаа явуулах зорилгоор лангууны түрээсийн төлбөрийг ялгавартай тогтоосон гэж үзэх үндэслэлгүй байна. Өөрөөр хэлбэл "Хүчит шонхор" ХХК-нь ноёлох үйл ажиллагаа явуулах зорилготой байсан гэдэг нь тогтоогдохгүй байна. Ер нь чөлөөт зах зээл дээр аж ахуйн нэгж нь өөрсдийн бизнес төлөвлөгөө, бизнесийн зорилго, маркетингийнхээ дагуу үйл ажиллагаа явуулж байгааг ноёлох үйл ажиллагаа явуулсан гэж үзэх үндэслэлгүй байна. Түүнчлэн түрээслэгч нар нь өөрсдийн хүсэл зоригийн дагуу "Хүчит шонхор" худалдааны төвтэй гэрээний нөхцөлийг зөвшөөрч түрээсийн гэрээг байгуулах, байгуулахгүй байх, татгалзах эрхтэй байхад төрийн захиргааны байгууллага хөндлөнгөөс оролцож аж ахуй эрхлэгчээс борлуулалтын нэмэлт нөхцөлийг шаардах, зах зээлд ижил төрлийн бараа бүтээгдэхүүнийг ялгавартай үнээр борлуулах, үндэслэлгүйгээр борлуулалт хийхээс татгалзах, бүс нутгийн байршлаас хамаарсан тээврийн бодит зардлыг тооцсон бараа бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт, үйлдвэрлэгч, нийлүүлэгчээс бөөний болон жижиглэнгийн худалдан авагчид өгч байгаа урамшуулалд хамаарахгүй асуудлаар шаардаж байгаа нь хууль бус байна. Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т "Төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага хуульд зааснаас бусад тохиолдолд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Мөн хуулийн 13.2.4-т бараа бүтээгдэхүүний үнийг бууруулахад, эсхүл нэг хэмжээнд барихад чиглэсэн, 13.2.5-т зах зээлийг нутаг дэвсгэр, эсхүл үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ, барааны нэр, төрөл, худалдагч, худалдан авагчийн хүрээгээр хуваарилахдаа чиглэсэн үйл ажиллагаа явуулахыг хориглоно гэж заасан байхад дээрх хуулийг зөрчиж Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас лангууны түрээсийн үнийг бууруулж, ижил болгох шаардлага тавьж байгаа нь хууль бус юм. Мөн "Хүчит шонхор" ХХК-ын олж байгаа орлогыг тодорхойлох "Хүчит шонхор" ХХК-ны захирлын түрээсийн төлбөрийг шинэчлэн тогтоосон 2013 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 05 тоот тушаал, сүүлийн 10 жилд оруулсан хөрөнгө оруулалт, ашиглалттай холбоотой гарсан зардал, зардлын өсөлт, ажиллагсдын дундаж цалингийн өсөлтийн хуваарь, "Хүчит шонхор" ХХК-ийн 2013 оны эхний 5 сард мөрдөгдөж байгаа түрээсийн үнэ, "Хүчит шонхор" ХХК-ийн 4-р улирлын санхүүгийн тайлан, орлогын мэдүүлэг, ажлын байр түрээслэх гэрээ, зэргээр тус компанийн борлуулалтын орлогыг тооцох боломжтой байхад орлого тооцох боломжгүй гэх үндэслэлээр 110.646.850 төгрөг төлүүлэхээр шийтгэвэр оногдуулсан

нь үндэслэлгүй байна. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1, 70.2.1, дэх хэсэгт заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь: 1. Өрсөлдөөний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т заасныг баримтлан Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагчийн 2013 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 0000109 дүгээр шийтгэврийг хүчингүй болгосугай. 2. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт заасны дагуу нэхэмжлэгчээс улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 70200 улсын орлогод хэвээр үлдээж, нэхэмжлэлийг бүхэлд нь хангасантай холбогдуулан хариуцагчаас 70200 төгрөгийг гаргуулж нэхэмжлэгчид олгосугай. 3. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2 дахь хэсэгт зааснаар шүүхийн шийдвэр нь танилцуулан сонсгосноор хүчинтэй болох бөгөөд хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.3 дахь хэсэгт заасан хугацаа өнгөрснөөс хойш 14 хоногийн дотор тус шүүхэд хүрэлцэн ирж, шүүхийн шийдвэрийг өөрөө гардан авах үүрэгтэй болохыг дурьдсугай. Энэхүү шийдвэрийг эс зөвшөөрвөл Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1 дэх хэсэгт зааснаар шүүхийн шийдвэрийг гардан авснаас хойш хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

ШҮҮГЧ О.ОЮУНГЭРЭЛ

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ САН
www.nli.gov.mn

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ ХУРАЛДААНЫ МАГАДЛАЛ

2014 оны 04 сарын 09 Дугаар 0148 Улаанбаатар хот

“Хүчит шонхор” ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэргийн тухай

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааныг шүүгч Б.Мөнхтуяа даргалж, шүүгч Д.Батбаатар, шүүгч Ц.Цогт нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн дарга Г.Урангуа, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ж.Отгонжаргал, нэхэмжлэгчийн өмгөөлөгч П.Одгэрэл, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ж.Очирхуяг нарыг оролцуулан хийж, Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхийн 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 25 дугаар шийдвэрийг эс зөвшөөрч гаргасан хариуцагчийн давж заалдах гомдлоор, “Хүчит шонхор” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын ахлах байцаагч Г.Энхманлайд холбогдох захиргааны хэргийг шүүгч Ц.Цогтын илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь: Нэхэмжлэгч “Хүчит шонхор” ХХК-иас шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ: “... “Хүчит шонхор” ХХК-ийг улсын байцаагчийн албан шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй зөрчил гаргасан хэмээн Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын ахлах байцаагч Г.Энхманлайн 2013 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 0000109 тоот шийтгэврийг хүчингүй болгуулах” гэжээ. Хариуцагч Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын ахлах байцаагч Г.Энхманлай шүүхэд ирүүлсэн хариу тайлбартаа: “... “Хүчит шонхор” ХХК-иас гаргасан Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагчийн 2013 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 0000109 тоот шийтгэврийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй байна. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар удирдамжийн дагуу “Хүчит Шонхор” ХХК-ийн үйл ажиллагаа нь Өрсөлдөөний тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд хяналт шалгалтын ажлыг хийж, Шонхор худалдааны төвийн ижил хэмжээ бүхий талбайтай объектод ялгавартай түрээсийн төлбөр тогтоож түрээслэгч нараас хураан авч Өрсөлдөөний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.1.3-т заасныг зөрчсөн болох нь тогтоогдсон. Тайлбар 1. “... борлуулж буй барааны төрлөөс хамааран лангууны түрээсийн төлбөр өөр өөр байна” гэсэн тайлбарын хувьд үндэслэлгүй болжээ. Учир нь Шонхор худалдааны төвд гадаа байрлалтай мах худалдаалдаг нэг чингэлэгт хэдэн хүн худалдаа хийж байгаагаас нь хамаарч нэг чингэлгийн түрээсийн төлбөрийг 6 дугаар сар хүртэл хугацаанд 150 000-470 000 хүртэл төгрөгөөр, 6 дугаар сараас 350 000 - 900 000 хүртэл төгрөгөөр тогтоож хураан авсан байна. “Лангууг 3-5 түрээслэгч хамтарч түрээсэлдэг бөгөөд мөн лангууг ажиллуулах цаг харилцан адилгүй байна, лангуунууд нь байршлын хувьд ... зарим нь худалдан авагч ихээр зорчдог хэсэгт байхад, зарим нь худалдан авагч

харьцангуй цөөн очдог хэсэгт байрладаг учир борлуулалтын байдлаас хамааран лангууны түрээс ялгаатай байна” гэсэн байх боловч энэ нь нэг ижил хэмжээ бүхий лангуунд ялгавартай түрээсийн төлбөр тогтоох үндэслэл болохгүй юм. Иймд “Хүчит шонхор” ХХК нь түрээсийн төлбөрийг дээрх үндэслэлүүдээр ялгавартай байдлаар тогтоосон нь Өрсөлдөөний тухай хуулийн 7.1.3 дахь заалтыг зөрчсөн болох нь мөн нотлогдохоор байна. Тайлбар 2. Нэхэмжлэлийн 2 дахь хэсэгт “Өрсөлдөөний тухай хуулийн 27.2-ийг хэрэглэх ёсгүй байсан” гэсэн нь үндэслэлгүй юм. Учир нь хяналт шалгалтын явцад тус газраас “Хүчит шонхор” ХХК-ийн 2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан балансыг гаргуулан авч судлан үзэхэд уг компанийн түрээсийн үйлчилгээний борлуулалтын орлого тогтоогдох боломжгүй байсан тул Өрсөлдөөний тухай хуулийн 27.2-т заасныг үндэслэн “Хүчит шонхор” ХХК-ийн 2012 оны 4-р улирлын санхүүгийн тайлангийн Баланс хэсгийн 2.3.20-т тэмдэглэгдсэн Эзэмшигчийн өмчийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийн торгуулийг шийтгэврээр ногдуулсан. Тайлбар 3. “Хүчит шонхор” ХХК-ийн нэхэмжлэлийн 3-т “Өрсөлдөөний тухай хуулийн 13.2.4 болон 13.2.5-ыг тус тус зөрчсөн” гэх үндэслэлийн хувьд үндэслэлгүй болох нь дараах байдлаар нотлогдож байна. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч нар нь “Зөрчлийг арилгуулах тухай” 2013 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 5/137 дугаартай, 2013 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 5/154 дугаартай улсын байцаагчийн албан шаардлагаар ижил хэмжээ бүхий талбайтай объектод ялгавартай түрээсийн төлбөр тогтоохгүй байхыг, Өрсөлдөөний тухай хуулийн 7.1.3-т заасныг зөрчихгүй байхыг “Хүчит шонхор” ХХК-иас тус тус шаардсан нь Өрсөлдөөний тухай хуулийн 20.2 дахь хэсэг, 20.3,1 дэх хэсэгт үндэслэсэн байдаг. Иймд “Хүчит шонхор” ХХК-иас гаргасан “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагчийн 2013 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 0000109 тоот шийтгэврийг хүчингүй болгуулах тухай” нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагчийн 0000109 дугаартай шийтгэврийг хэвээр үлдээн шийдвэрлэж өгнө үү” гэжээ. Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхийн 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 25 дугаар шийдвэрээр: Өрсөлдөөний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т заасныг баримтлан Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагчийн 2013 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 0000109 дүгээр шийтгэврийг хүчингүй болгож шийдвэрлэжээ. Хариуцагч шүүхэд гаргасан давж заалдах гомдолдоо: “... Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхийн шүүгч “Хүчит шонхор” ХХК-иас гаргасан, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагчийн 2013 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 0000109 тоот шийтгэврийг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж уг захиргааны актыг бүхэлд нь хүчингүй болгон 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 25 дугаартай шийдвэр гаргасан. Шүүгчийн гаргасан дээрх шийдвэрийг дараах үндэслэлүүдээр хүлээн зөвшөөрөхгүй байна. Нэг. Шүүхийн шийдвэрийн үндэслэх нь хэсэгт “Дээрх лангууны түрээсийн үнэ нь дараах үндэслэлийн улмаас ялгаатай байсан байна. Үүнд: Түрээслүүлэгч нар махны, хүнсний ногооны, гурил будааны, гэр ахуйн өргөн хэрэглээний барааны гэсэн төрлөөр худалдаа явуулдаг тул борлуулж буй барааны төрлөөс хамааран лангууны түрээсийн төлбөр өөр өөр, лангууг 3-5 түрээслэгч хамтран түрээсэлдэг, мөн лангууг ажиллуулах цаг харилцан адилгүй, лангуунууд байршлын хувьд зарим нь дулаан байранд, зарим нь гадна талбайд, зарим нь худалдан авагч ихээр зорчдог хэсэгт байхад, зарим нь худалдан авагч харьцангуй цөөн очдог хэсэгт байрладаг учир борлуулалтын байдлаас хамааран лангууны түрээс ялгаатай байдаг” гэснийг үндэслэн Өрсөлдөөний тухай хуулийн 7 дугаар

зүйлийн 7.1-т “Давамгай байдалтай аж ахуй эрхлэгч дараах ноёлох үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 7.1.3 ... зах зээлд ижил төрлийн бараа бүтээгдэхүүнийг ялгавартай үнээр борлуулах, үндэслэлгүйгээр борлуулалт хийхээс татгалзах...;” гэж зааснаар Хүчит шонхор ХХК-ийг лангууны түрээсийн үнийг ноёлох үйл ажиллагаа явуулах зорилгоор лангууны түрээсийн төлбөрийг ялгавартай бүтээгдэхүүнийг ялгавартай үнээр борлуулах, үндэслэлгүйгээр борлуулалт хийхээс татгалзах ...” гэж зааснаар Хүчит шонхор ХХК-ийг лангууны түрээсийн үнийг ноёлох үйл ажиллагаа явуулах зорилгоор лангууны түрээсийн төлбөрийг ялгавартай тогтоосон гэж үзэх үндэслэлгүй байна гэсэн нь Өрсөлдөөний тухай хуулийг буруу тайлбарлан, нэхэмжлэгч талыг илтэд хамгаалсан шийдвэр болсон байна. Учир нь Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас хийсэн шалгалтаар Хүчит шонхор ХХК-ийн зүгээс өөрийн Шонхор худалдааны төвд гадаа байрлалтай мах худалдаалдаг 20 тоннын багтаамжтай ижил зориулалт бүхий чингэлгүүдийн түрээсийн төлбөрийг 6 дугаар сар хүртэл хугацаанд 150 000-470 000 хүртэл төгрөгөөр, 6 дугаар сараас 350 000 - 900 000 хүртэл төгрөгөөр тогтоож хураан авсан нь Өрсөлдөөний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “Давамгай байдалтай аж ахуй эрхлэгч дараах ноёлох үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 7.1.3. ... зах зээлд ижил төрлийн бараа бүтээгдэхүүнийг ялгавартай үнээр борлуулах, үндэслэлгүйгээр борлуулалт хийхээс татгалзах ...” гэж заасныг зөрчсөн гэж дүгнэсэн байдаг. Харин бусад төрлийн буюу хүнсний ногооны, гурил будааны, гэр ахуйн өргөн хэрэглээний барааны гэсэн төрлөөр худалдаа явуулдаг лангуунуудын түрээсийн төлбөрийг тогтоосон байдал нь Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийг зөрчсөн гэж үзээгүй юм. Гэтэл шүүгч Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас Шонхор худалдааны төвийн бух төрлийн худалдаа хийдэг лангууны түрээсийг ялгавартай тогтоосон гэх үндэслэлээр хууль зөрчсөн гэж үзсэн мэтээр тайлбарлаж, үүнийг үндэслэл болгон шийдвэрээ гаргасан нь нөхцөл байдал, хариуцагч талын тайлбар, нотлох баримтуудыг үнэн зөвөөр үнэлээгүй гэх үндэслэл болсон. Өрсөлдөөний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1,”бараа бүтээгдэхүүн” гэж зах зээлд худалдах, солилцох, эргэлтийн өөр нэг хэлбэрт оруулах зориулалттай бүх төрлийн эд юмс, төлбөрийн хэрэгсэл, ажил, үйлчилгээ, шилжүүлж болох эрх зэргийг; гэж тодорхойлсон бөгөөд Хүчит шонхор ХХК-ийн бараа бүтээгдэхүүн нь “түрээсийн үйлчилгээ” болж байна. Харин Өрсөлдөөний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-7 “бараа бүтээгдэхүүний хүрээ харилцан орлох бараа бүтээгдэхүүний бүлгийг” гэж тодорхойлсны дагуу Хүчит шонхор ХХК-ийн уг хэрэгт холбогдож буй түрээсийн үнийг нь ялгавартай тогтоосон бараа бүтээгдэхүүний хүрээ нь мах худалдаалах зориулалт бүхий 20 тоннын чингэлэг байна. Учир нь мах худалдаалдаг нэг аж ахуй эрхлэгчийн хувьд бараагаа борлуулах үйл ажиллагааг Хүчит шонхор худалдааны төвд байрлалтай мах худалдаалах зориулалттай аль ч чингэлэгт явуулах боломжтой тул эдгээр чингэлгүүд нь харилцан орлох бараанууд болж байна. Хоёр. Шүүхийн шийдвэрийн үндэслэх нь хэсэгт “Ер нь чөлөөт зах зээл дээр аж ахуйн нэгж нь өөрсдийн бизнес төлөвлөгөө, бизнесийн зорилго, маркетингийн дагуу үйл ажиллагаа явуулж байгааг ноёлох үйл ажиллагаа явуулсан гэж үзэх үндэслэлгүй байна” гэжээ. Гэтэл Монгол Улсын Иргэний хууль болон Өрсөлдөөний тухай хуулиар тухайн зах зээлд давамгай байдалтай аж ахуй эрхлэгчдийг жирийн бусад аж ахуй эрхлэгчдээс онцгойлон авч үзэн тэдгээрийн зүгээс чөлөөтэй хийж болохгүй үйлдэл, эс үйлдэхүй, үйл ажиллагааг хуульчилж өгсөн байдаг. Тухайн тохиолдлын хувьд Иргэний хуулийн 189.4-т “Тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил, үйлчилгээ эрхлэх талаар тухайн зах зээлд давамгайлж байгаа этгээд энэхүү үйл ажиллагааны хүрээнд түүнд хандсан этгээдтэй гэрээ байгуулах

үүрэгтэй бөгөөд нөгөө талдаа тэгш бус нөхцөл тулган санал тавих буюу гэрээ байгуулахаас татгалзах эрхгүй", Өрсөлдөөний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т "Давамгай байдалтай аж ахуй эрхлэгч дараах ноёлох үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 7.1.3, ... зах зээлд ижил төрлийн бараа бүтээгдэхүүнийг ялгавартай үнээр борлуулах, үндэслэлгүйгээр борлуулалт хийхээс татгалзах ..." гэж заасны дагуу давамгай байдалтай аж ахуй эрхлэгч болох Хүчит шонхор ХХК-д өөрийн бараа бүтээгдэхүүн буюу ижил төрлийн объектын түрээсийн төлбөрийг ялгавартай тогтоохыг хориглосон байна. Гурав. Шүүхийн шийдвэрийн үндэслэх нь хэсэгт "... Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас Өрсөлдөөний тухай хуулийн 13.2.4, 13.2.5-т заасныг зөрчин лангууны түрээсийн үнийг бууруулж, ижил болгох шаардлага тавьж байгаа нь хууль бус болсон юм." гэсэн нь мөн л нотлох баримтад тулгуурлаагүй үндэслэлгүй байна. Учир нь Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас "лангууны түрээсийн үнийг бууруул" гэсэн шаардлагыг Хүчит шонхор ХХК-д тавиагүй бөгөөд энэ талаар шаардлага тавьсан болох нь баримтаар нотлогддоггүй, ийм шаардлага тавьсан талаар зөвхөн нэхэмжлэгч талын аман тайлбар байдаг, нэхэмжлэгч үүнийгээ баримтаар нотолж чадаагүй болно. Харин лангууны түрээсийн төлбөрийг ижил болгох шаардлагын хувьд энэхүү гомдлын агуулга хэсгийн нэг дэх үндэслэлд дурдсанчлан Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас зөвхөн ижил төрлийн бараа бүтээгдэхүүн буюу мах худалдаалах зориулалттай, гадна байрлалтай, 20 тоннын багтаамжтай, ижил хэмжээтэй чингэлгүүдийн түрээсийн үнийг ижил болгож, тухайн объектыг түрээслэн ижил төрлийн бараа бүтээгдэхүүн борлуулж буй этгээдүүдийн зах зээлд өрсөлдөх боломжийг хязгаарлахгүй байхыг улсын байцаагчийн албан шаардлагаар Хүчит шонхор ХХК-д үүрэг болгосон нь Өрсөлдөөний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т "Давамгай байдалтай аж ахуй эрхлэгч дараах ноёлох үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 7.1.3... зах зээлд ижил төрлийн бараа бүтээгдэхүүнийг ялгавартай үнээр борлуулах, үндэслэлгүйгээр борлуулалт хийхээс татгалзах...;" гэсэн заалтад үндэслэсэн байдаг. Иймд дээр дурдсанчлан Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын албан шаардлага нь хуульд үндэслэсэн, хууль ёсны шаардлага байх тул 13.2-т "Төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага хуульд зааснаас бусад тохиолдолд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 13.2.4.бараа бүтээгдэхүүний үнийг бууруулахад, эсхүл нэг хэмжээнд барихад чиглэсэн; 13.2.5.зах зээлийг нутаг дэвсгэр, эсхүл үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ, барааны нэр, төрөл; худалдагч, худалдан авагчийн хүрээгээр хуваарилахад чиглэсэн" гэсэн заалтыг зөрчөөгүй юм. Дөрөв. Шүүгч шийдвэртээ "Хүчит шонхор ХХК-ийг ноёлох үйл ажиллагаа явуулах зорилгоор лангууны түрээсийн үнийг ялгавартай тогтоосон гэж үзэх үндэслэлгүй байна" гэсэн нь үндэслэлгүй байна. Гэтэл Өрсөлдөөний тухай хуулийн дугаар зүйлийн 7.1-т "Давамгай байдалтай аж ахуй эрхлэгч дараах ноёлох үйл ажиллагаа явуулахыг хориглоно:" гэж заасан бөгөөд энэхүү хэсэгт заасан заалтуудаар хуульчилсан, давамгай байдалтай аж ахуй эрхлэгчдийн зүгээс чөлөөтэй хийж болохгүй үйлдэл, эс үйлдэхүй, үйл ажиллагааг бүгдийг ноёлох үйл ажиллагаа гэж үзэн хориглосон байна, Тухайн хэргийн хувьд хуулийн энэ хэсэгт заасан үйлдлийг гаргасан өөрөө ноёлох үйл ажиллагаа болох юм. Шүүгчийн зүгээс хуулийн энэхүү заалтыг нэхэмжлэгч талд ашигтайгаар, буруу тайлбарлан хэрэглэсэн нь "хуулийн зүйл, заалтыг шууд утгаар нь ойлгон хэрэглэх" зарчмыг алдагдуулж байна. Тав. Шүүгч Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагчийн шийтгэврээр ногдуулсан торгуулийн хэмжээг тогтооход Хүчит шонхор ХХК-ийн борлуулалтын орлогыг тодорхойлох боломжтой байхад орлого тооцох боломжгүй гэх үндэслэлээр 110.646.850 төгрөг

төлүүлэхээр шийтгэвэр оногдуулсан нь үндэслэлгүй байна гэсэн нь үндэслэлгүй болсон. Учир нь Өрсөлдөөний тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2-т “энэ хуулийн 6.2, 7.1-д заасныг зөрчсөн аж ахуй эрхлэгчийг тухайн бараа бүтээгдэхүүний өмнөх жилийн борлуулалтын орлогын дөрөв хүртэл хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хууль бусаар олсон орлого, эд зүйлийг хураах;” гэж заасны дагуу зөрчил * гаргасан Хүчит шонхор ХХК-ийн тухайн зөрчилд холбогдох бараа бүтээгдэхүүнээс олсон орлогын хэмжээг албан ёсны үнэн зөв бодитой баримтаар нотлох боломжгүй бөгөөд аливаа аж ахуй эрхлэгчийн тухайн жилийн борлуулалтын орлогын хэмжээг албан ёсоор санхүүгийн тайлан, балансаар гаргадаг. Гэвч энэхүү санхүүгийн тайлан, балансаас тухайн аж ахуй эрхлэгчийн борлуулж буй олон төрлийн бараа бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг бараа бүтээгдэхүүн тус бүрээр тодорхойлоогүй байдаг. Иймээс улсын байцаагч нь Хүчит шонхор ХХК-ийн уг зөрчилд холбогдох бараа бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг албан ёсны үнэн зөв, бодитой баримтаар тооцох боломжгүй гэж үзэн Өрсөлдөөний тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т “Энэ хуулийн 27.1.1, 27.1.2, 27.1.4-т заасан шийтгэл ногдуулахад аж ахуй эрхлэгчийн тухайн бараа бүтээгдэхүүний өмнөх жилийн болон тухайн жилийн тухайн бараа бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг тооцох боломжгүй, эсхүл борлуулалт хийгдээгүй тохиолдолд энэ хуулийн 27.1.1, 27.1.2, 27.1.4-т заасан аж ахуй эрхлэгчийг өөрийн хөрөнгийн тав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасны дагуу Хүчит шонхор ХХК-ийн 2012 оны 4-р улирлын санхүүгийн тайлангийн Баланс хэсгийн 2.3.20-т тэмдэглэгдсэн Эзэмшигчийн өмчийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний /төгрөгийн/ торгуулийг шийтгэврээр ногдуулсан. Иймд дээр дурдсан үндэслэлүүдээр Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхийн 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 25 дугаартай шийдвэр нь үндэслэлгүй, хууль бус гэж үзэж байгаа тул хүчингүй болгож, нэхэмжлэлийг буюу хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү” гэжээ. ХЯНАВАЛ: Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 85 дугаар зүйлийн 85.3 дахь хэсэгт зааснаар хэргийг бүхэлд нь хянан үзэхэд нэхэмжлэгчийн “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын ахлах байцаагчийн 2013 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 0000109 тоот шийтгэврийг хүчингүй болгуулах” нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн нь үндэслэлтэй байх тул шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэв. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагчийн 2013 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 0000109 дүгээр шийтгэврээр “улсын байцаагчийн 2013 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 5/154 тоот албан шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй” гэсэн үндэслэлээр Өрсөлдөөний тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийг баримтлан торгох захиргааны шийтгэл ногдуулсан бөгөөд 5/154 тоот албан шаардлагаар “Хүчит шонхор” ХХК нь Өрсөлдөөний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т заасныг зөрчсөн гэж үзэн уг зөрчлийг арилгахыг шаардсан байна. Өрсөлдөөний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийг ноёлох үйл ажиллагаа явуулахыг хориглосон ба мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтад ноёлох үйл ажиллагаа гэдгийг давамгай байдлаа хууль бусаар ашиглаж бусад аж ахуй эрхлэгчийг зах зээлд гарч ирэх нөхцөлийг хаан боогдуулах, зэх зээлээс шахан гаргах зорилгоор зах зээлд борлуулж байгаа тухайн бараа, бүтээгдэхүүний тоо, хэмжээ, үнэ зэргийг хязгаарлан өрсөлдөөнийг бодитоор хязгаарлах, хэрэглэгчийг хясан боогдуулахыг ойлгоно гэж тодорхойлжээ. Үүнээс үзвэл давамгай байдалтай аж ахуй эрхлэгч нь тус хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т зааснаар ижил төрлийн бараа бүтээгдэхүүнийг ялгавартай үнээр борлуулахдаа бусад аж ахуй эрхлэгчийг зах зээлд гарч ирэх нөхцөлийг хаан боогдуулах зорилготой

бол энэ нь хуулиар хориглосон ноёлох үйл ажиллагаанд хамаарах бөгөөд харин өөрийн түрээсийн зүйл болох лангууны байршил, ажиллах цаг зэрэг ялгаатай нөхцөл байдалтай нь уялдуулан түрээсийн төлбөрийг ялгавартай тогтоосныг Өрсөлдөөний тухай хуулиар хориглосон ноёлох үйл ажиллагаа гэж үзэх боломжгүй бөгөөд дээр дурдсан зөрүүтэй нөхцөл байдлаас үүдэн ийнхүү ялгавартай төлбөр тогтоосон нь түрээслэгч буюу хэрэглэгчийн хүсэл зоригт нийцсэн үйл ажиллагаа байна. Хэргийн оролцогчдын тайлбар болон гэрч Г.Ганхуягийн “байрлал янз бүр байдаг, хойд эгнээний урдуур машинтай хүмүүс ирээд махаа зардаг”, гэрч Ё. Отгонцэцэгийн “урд, хойд эгнээний байрлалаас болж лангууны түрээс ялгаатай байдаг. Манай эгнээний байрлал ашигтай байрлал. Хойд эгнээний урдуур мах зардаг машин зогсдог” гэх мэдүүлэг болон хурлын протокол зэрэгт лангууны байршлаас шалтгаалан ажиллах цаг, түүнтэй уялдан ашиг орлого ялгаатай байдаг талаар дурдсан байна. Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа “лангуунуудын гаргаж буй зардал ижил байдаг бөгөөд түрээсийн төлбөр ялгаатай байгаагаас үүдэн өндөр түрээсийн төлбөртэй түрээслэгч нь бага төлбөртэй түрээслэгчидтэй шударгаар өрсөлдөх боломжгүй болох ба улмаар тус зах зээлд шинээр аж ахуй эрхлэгчид орох боломжгүй болно” гэх боловч Өрсөлдөөний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д тодорхойлсон ноёлох үйл ажиллагаа гэдэгт түрээсийн үйлчилгээ үзүүлж буй давамгай байдалтай аж ахуйн нэгж болох “Хүчит шонхор” ХХК-иас ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг бусад аж ахуй эрхлэгчийг зах зээлд гарч ирэх нөхцөлийг хаан боогдуулах, шахан гаргахад чиглэсэн үйл ажиллагааг ойлгохоос бус өөрийн үйлчилгээг авч буй аж ахуй эрхлэгч болох түрээслэгчид ялгавартай төлбөр тогтоосон тохиолдлыг хориглосон заалт гэж үзэхээргүй байна. Хариуцагч нь давж заалдах гомдолдоо Өрсөлдөөний тухай хуулийн 7.1 дэх хэсэгт хуульчилсан үйл ажиллагааг бүгдийг ноёлох үйл ажиллагаа гэж үзэн хориглосон бөгөөд нэхэмжлэгч нь энэ хэсэгт заасан үйлдлийг гаргасан тул ноёлох үйл ажиллагаа явуулсан гэж маргажээ. Нэхэмжлэгч хуулийн этгээдийн зүгээс ижил талбай бүхий объектуудыг ялгавартай үнээр түрээслүүлсэн зорилго нь ноёлох үйл ажиллагаа гэж үзэхээргүй байх ба түрээслүүлэгчийн борлуулж буй бараа бүтээгдэхүүн болох лангуу нь талбай, зориулалтын хувьд ижил ч гэсэн байршил, ажиллах цаг, нөхцөл боломжийн хувьд ялгаатай байгаагаас үзвэл эдгээр лангуунуудыг ижил төрлийн бараа гэж үзэхэд учир дутагдалтай байх тул “байршлаас хамаарч лангууны түрээсийн үнэлгээ ялгаатай байдаг, ... ноёлох үйл ажиллагаа явуулах зорилгоор лангууны түрээсийн төлбөрийг ялгавартай тогтоосон гэх үндэслэлгүй” гэж үзсэн шүүхийн дүгнэлт зөв байна. Хариуцагч нь давж заалдах гомдолдоо Иргэний хуулийн 189 дүгээр зүйлийн 189.4 дэх хэсэгт “... тухайн зах зээлд давамгайлж байгаа этгээд ... түүнд хандсан этгээдтэй гэрээ байгуулах үүрэгтэй бөгөөд нөгөө талдаа тэгш бус нөхцөл тулган санал тавих эрхгүй” гэснийг дурдсан байх бөгөөд маргаан бүхий захиргааны актын хууль зүйн үндэслэлийг хянан шийдвэрлэхэд уг зохицуулалт хамааралгүй, өөрөөр хэлбэл түрээслүүлэгч “Хүчит шонхор” ХХК нь тухайлсан аж ахуй эрхлэгчтэй гэрээ байгуулахдаа илт тэгш бус нөхцөл тулган өөртөө давуу байдал олгохыг хориглох нөхцөл байдлыг тус зүйлээр зохицуулснаас биш гэрээ байгуулж буй нийт этгээдтэй яг ижил нөхцөлөөр гэрээ байгуулах тухай зохицуулалт биш байх тул уг гомдол үндэслэлгүй байна. Харин аж ахуй эрхлэгч нар өөрийн үйл ажиллагааг явуулахдаа тухайн харилцаанд үйлчлэх хууль, тогтоомжийг дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд ийнхүү ажиллахдаа ноёлох болон өрсөлдөөнд харшлах аливаа үйл ажиллагаа хийхийг хуулиар хориглох бөгөөд шүүхийн шийдвэрт “Ер нь чөлөөт зах зээлд аж ахуйн нэгж өөрийн бизнес төлөвлөгөө, зорилго, маркетингийн дагуу үйл ажиллагаа явуулж байгааг

ноёлох үйл ажиллагаа явуулсан гэж үзэх үндэслэлгүй” гэж дүгнэсэн нь шүүхийн шийдвэрт тухайн захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талуудын маргаж буй захиргааны актын хууль зүйн үндэслэлийн хүрээнд шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж, хэргийг шийдвэрлэхэд үндэслэл болсон нотлох баримтыг үнэлж дүгнэсэн байдал тусгагдах ёстой гэсэнтэй нийцээгүй байна. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагчийн 2013 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 5/154 тоот албан шаардлагаар нэхэмжлэгч хуулийн этгээдийг дурдсан зөрчлийг арилгаж, ижил хэмжээ бүхий талбайтай объектод ялгавартай түрээсийн төлбөр тогтоохгүй байхыг шаардсанаас биш үнийг бууруулах шаардлага тавиагүй байхад шүүх “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас лангууны түрээсийн үнийг бууруулж, ижил болгох шаардлага тавьж байгаа нь хууль бус” гэсэн нь маргаан бүхий захиргааны актад хамааралгүй зүйлийг буруу дүгнэсэн байхаас гадна Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.4-т заасныг хариуцагч зөрчсөн гэсэн нь үндэслэлгүй байна. Түүнчлэн шүүх ямар үндэслэлээр, ямар нотлох баримтад тулгуурлан Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.5 дахь заалтыг хариуцагч зөрчсөн гэж дүгнэсэн нь ойлгомжгүй байна. Нэхэмжлэгч “Хүчит шонхор” ХХК түрээсийн төлбөрийг ялгавартай тогтоосон нь Өрсөлдөөний тухай хуулийн зохицуулалтыг зөрчсөн гэж үзэхээргүй, өөрөөр хэлбэл тус хуулийн этгээдээс хууль зөрчсөн үйлдэл гаргаагүй байх тул мөн хуульд заасан захиргааны арга хэмжээ авах үндэслэлгүй байх бөгөөд торгуулийн хувь тооцсон аргачлалын талаарх маргаанд шүүх дүгнэлт хийх шаардлагагүй. Хэдийгээр шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт маргааны зарим нөхцөл байдлыг буруу дүгнэсэн боловч шийдвэрт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох нөхцөл тогтоогдохгүй байх тул Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагчийн 0000109 дүгээр шийтгэврийг хүчингүй болгож шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх нь зүйтэй гэж үзлээ. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.1, 87 дугаар зүйлийн 87.1 дэх хэсгийг удирдлага болгон ТОГТООХ НЬ: 1. Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхийн 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 25 дугаар шийдвэрийг хэвээр үлдээж, хариуцагчийн давж заалдах гомдлыг хангахгүй орхисугай. 2. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.3-т зааснаар хариуцагч нь улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдсөн болохыг дурдсугай. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.5 дахь хэсэгт зааснаар давж заалдах шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн, хууль буруу хэрэглэсэн гэж нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч үзвэл магадлалыг гардан авсан, эсхүл хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй.

ШҮҮХ БҮРЭЛДЭХҮҮН:
ШҮҮГЧИД Б.МӨНХТУЯА
Д.БАТБААТАР
Ц.ЦОГТ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХ ХУРАЛДААНЫ ШҮҮГЧИЙН ТУСГАЙ САНАЛ

2014 оны 06 дугаар сарын 16 -ны өдөр Улаанбаатар хот

“Хүчит шонхор” ХХК-ний нэхэмжлэлтэй захиргааны хэргийн тухай

Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн М.Батсуурь би “Хүчит шонхор” ХХК-ний нэхэмжлэлтэй, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын ахлах байцаагч Г.Энхманлайд холбогдох, “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагчийн 2013 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 0000109 дүгээр шийтгэврийг хүчингүй болгох” нэхэмжлэлийн шаардлагатай, Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхийн 2014 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн 25 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2014 оны 4 дүгээр сарын 9-ны өдрийн 148 дугаар магадлалтай захиргааны хэргийг хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гаргасан гомдлоор Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн танхимын шүүх хуралдаанаар хэлэлцэх явцад анхан болон давж заалдах шатны шүүх хэргийг шийдвэрлэхдээ холбогдох хуулийн заалтыг буруу тайлбарласан талаар санал гаргасан ч шүүх бүрэлдэхүүний олонхи анхан шатны шүүхийн шийдвэр, магадлалыг тус тус хэвээр үлдээхээр шийдвэрлэсэн тул “Өрсөлдөөний тухай хууль”-ийн холбогдох заалтыг буруу тайлбарласан гэсэн үндэслэлээр тусгай санал бичив.

Хэргийн тухайд хураангуй

“Шонхор” Худалдааны төв (“Хүчит шонхор” ХХК) нь Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 11 дүгээр хороо, Дэнжийн 1000-д байрлалтай бөгөөд 1992 оноос хойш хүнсний барааны зах ажиллуулах, хүнсний барааны лангуу түрээслэх зэрэг үйл ажиллагаа явуулж байна.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар(ШӨХТГ)-т “Хүчит шонхор” ХХК-ийн захын түрээслэгчдээс “захын түрээсийн төлбөрийг гэнэт нэмсэн” гэх гомдол ирснийг үндэслэн ШӨХТГ-ын улсын байцаагчид дээрх нөхцөл байдлыг тогтоохоор хяналт шалгалт хийж, Өрсөлдөөний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т заасан “...зах зээлд ижил төрлийн бараа, бүтээгдэхүүнийг ялгавартай үнээр борлуулах, үндэслэлгүйгээр борлуулалт хийхээс татгалзах...” хориглоно гэсэн заалтыг зөрчсөн гэсэн үндэслэлээр 2013 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 5/137, 2013 оны 7 дугаар сарын 4-ны өдрийн 5/154 дугаартай албан шаардлагаар уг зөрчлөө арилгахыг шаарджээ.

Хүчит шонхор ХХК-ний хүрээлэн www.huchit.com

Нэхэмжлэгчээс “түрээсийн төлбөрийг ижил болгох саналыг түрээслэгч нар зөвшөөрөөгүй” гэсэн үндэслэлээр уг шаардлагыг биелүүлэх боломжгүй талаар хариу хүргүүлсэн боловч ШӨХТГ-ын улсын байцаагчийн 2013 оны 7 дугаар сарын 13-ны өдрийн 0000109 дугаар шийтгэвэрээр 110,646.850 мянган төгрөгөөр торгохоор шийдвэрлэсэн тул үүнийг эс зөвшөөрч шүүхэд нэхэмжлэл гаргасан байна.

Нэхэмжлэгч “Хүчит шонхор” ХХК нь Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2012 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 12 дугаар тогтоолоор захын түрээсийн үйлчилгээний зах зээлд **“давамгай байдалтай аж ахуйн нэгж”** гэж зарласан бөгөөд нэхэмжлэгч энэ талаар маргаагүйг дурдах нь зүйтэй.

Холбогдох хуулийн зохицуулалт болон түүнийг тайлбарлаж хэрэглэсэн тухайд

Монгол улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1-т “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна”, мөн зүйлийн 4-т “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж заасанд нийцүүлэн Улсын Их Хурлаас Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2010 оны 6 дугаар сарын 10-ны өдөр баталж мөрдүүлсэн.

Өрсөлдөөний тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “энэ хуулийн зорилт нь ... зах зээлд ноёлох ... аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, хориглон хязгаарлах, ... тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино”, 5 дугаар зүйлийн 5.2-т “Тодорхой бараа бүтээгдэхүүний зах зээлд дангаараа буюу бусад этгээдтэй хамтран, эсхүл харилцан хамаарал бүхий этгээд үйлдвэрлэл, борлуулалтын, эсхүл худалдан авалтын гуравны нэг буюу түүнээс дээш хувийг эзэлж байвал давамгай байдалтай аж ахуй эрхлэгч гэж үзнэ”, 7 дугаар зүйлийн 7.1-д “Давамгай байдалтай аж ахуй эрхлэгч дараахь ноёлох үйл ажиллагаа явуулахыг хориглоно:” хэмээн зааснаар Өрсөлдөөний тухай хууль нь аж ахуй эрхлэгчдийн тэгш өрсөлдөх нөхцлийг хангахаас гадна өрсөлдөөний бус, эсхүл өрсөлдөөний хязгаарлагдмал нөхцөлд үйл ажиллагаагаа явуулдаг давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийн ноёлох үйл ажиллагааг тодорхойлж, уг үйл ажиллагаа явуулахаас урьдчилан сэргийлэх, ийм үйл ажиллагаа явуулсан бол төрөөс хариуцлага хүлээлгэх зорилттой.

Энэ утгаараа Өрсөлдөөний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан хориглосон зохицуулалт нь “давамгай байдалтай аж ахуй эрхлэгч” гэсэн эрх зүйн статус авсан бүхий л аж ахуй эрхлэгчид ямар зах зээлд ямар төрлийн бараа бүтээгдэхүүн нийлүүлж байгаагаас үл хамааран хориглогдох учиртай.

Тухайн тохиолдолд “Хүчит шонхор” ХХК нь ШӨХТГ-ын тогтоолоор захын түрээсийн үйлчилгээний зах зээлд **“давамгай байдалтай аж ахуйн нэгж”** гэдэг нь тогтоогдсон бөгөөд харин түрээслэгчид нь уг харилцаандаа хэрэглэгч болохоос уг зах зээлд өрсөлдөгч биш гэдэг нь илэрхий. Хуулийн энэхүү зохицуулалтад буй хэрэглэгчийг тухайн харилцаанд хамааруулан ойлгох бөгөөд бүтээгдэхүүнийг хэрэглэх эцсийн хэрэглэгчийг илэрхийлсэн заалт гэж үзэх боломжгүй. Тиймээс давамгай байдалтай аж ахуй эрхлэгчээс тухайн харилцаанд хэрэглэгч болох “түрээслэгчид”-ийн эсрэг “хэрэглэгчийг хясан боогдуулсан” шинж бүхий хуулийн 7.1-д заасан хориглосон үйл ажиллагааг хэрэгжүүлсэн эсэх талаас хууль тайлбарлах замаар дүгнэлт хийж, хэргийг шийдвэрлэх байжээ.

Гэтэл шүүхүүд Өрсөлдөөний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5, 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтыг тус тус буруу тайлбарлаж хэрэглэсэн байх тул тус бүрт нь үндэслэл гаргах нь зүйтэй.

1. Өрсөлдөөний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан “ноёлох үйл ажиллагаа” гэдгийг мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д заасан “бусад аж ахуй эрхлэгчийг зах зээлд гарч ирэх нөхцөлийг хаан боогдуулах, зах зээлээс шахан гаргах зорилгоор” явуулсан бол ноёлох үйл ажиллагаанд хамааруулна гэсэн тайлбарыг шүүх хийжээ. Энэ нь дараахь байдлаар үндэслэлгүй байна:

a. Өрсөлдөөний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д “ноёлох үйл ажиллагаа” гэж давамгай байдлаа хууль бусаар ашиглаж бусад аж ахуй эрхлэгчийг зах зээлд гарч ирэх нөхцөлийг хаан боогдуулах, зах зээлээс шахан гаргах зорилгоор зах зээлд борлуулж байгаа тухайн бараа бүтээгдэхүүний тоо, хэмжээ, үнэ зэргийг хязгаарлан өрсөлдөөнийг бодитоор хязгаарлах, хэрэглэгчийг хясан боогдуулахыг;” ойлгохоор заасан бөгөөд хуулийн энэхүү тодорхойлолтод хоёр үндсэн нөхцлийг таслалаар зааглаж тусгасан байна. Тодруулбал, **нэгдүгээрт, давамгай байдлаа хууль бусаар ашиглаж бусад аж ахуй эрхлэгчийг зах зээлд гарч ирэх нөхцөлийг хаан боогдуулах, зах зээлээс шахан гаргах зорилгоор зах зээлд борлуулж байгаа тухайн бараа бүтээгдэхүүний тоо, хэмжээ, үнэ зэргийг хязгаарлан өрсөлдөөнийг бодитоор хязгаарлах, хоёрдугаарт, мөн давамгай байдлаа хууль бусаар ашиглаж хэрэглэгчийг хясан боогдуулахыг ноёлох үйл ажиллагаа** хэмээн тодорхойлжээ.

Гэтэл шүүхүүд дээрх хоёр ялгаатай нөхцөл заасан хууль тогтоогчийн хүсэл зоригийг анхааралгүй, тодорхойлолтод байгаа зарим хэсгийг таслан авч, гагцхүү бусад аж ахуй эрхлэгчийг зах зээлд гарч ирэх нөхцөлийг хаан боогдуулах, зах зээлээс шахан гаргах зорилго агуулсан бол ноёлох үйл ажиллагаанд хамаарах мэтээр хууль тогтоогчийн аутентик тайлбарт өрөөсгөл дүгнэлт хийсэн байна.

Хэрвээ дээрх байдлаар уг зохицуулалтын агуулгыг авч үзэх ёстой бол “бусад аж ахуй эрхлэгчийг зах зээлд гарч ирэх нөхцлийг хаан боогдуулах, зах зээлээс шахан гаргах зорилгоор...хэрэглэгчийг хясан боогдуулах” гэсэн утга гарч ирэх болно. Хуулийн логик болон бодит байдлын хувьд ч гэсэн аж ахуй эрхлэгчийг зах зээлд гарч ирэх нөхцөлийг хаан боогдуулах, эсхүл зах зээлээс шахан гаргах зорилгоор хэрэглэгчийг хясан боогдуулах тухай ойлголт байх боломжгүй юм. Хэрэглэгчийг хясан боогдуулах нь давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийн өөр шалтгаанаар хэрэгждэг ноёлох үйл ажиллагаа юм.

b. Улсын Их Хурлын 2010 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сарын 7-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар “Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-ийг хэлэлцсэн бөгөөд уг төслийн үзэл баримтлалын талаар хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Д.Ганхуяг танилцуулж, гишүүдийн асуусан асуултад хариулсан байна.

Уг хэлэлцүүлгийн явцад Н.Ганбямба гишүүний асуусан асуултад хууль санаачлагч “...Ер нь бол зах зээлд зүй ёсны монополь, давамгай байдалтай аж ахуйн нэгж аль нэг нь байж болно. Гэхдээ нэг зүйлийг хориглож байгаа юм. Тэр нь ноёлох үйл ажиллагаа. Тэр**ноёлох үйл ажиллагаа нь юу байна вэ гэхээр зах зээлд бусад өрсөлдөгчийг хаан боогдуулах, бусад өрсөлдөгчийг хуйвалдан гаргах, нөгөө талаас хэрэглэгчийг хясан боогдуулах гэсэн ийм зах зээлийн тодорхойлолт байгаа**” хэмээн ноёлох үйл ажиллагаа нь зөвхөн өрсөлдөгчийг хаан боогдуулах, бусад өрсөлдөгчийг хуйвалдан гаргахад чиглэгдэх бус, мөн хэрэглэгчийг хясан боогдуулахад чиглэж болох тухай төслийн 4 дүгээр зүйлд тодорхойлолтын үзэл баримтлалыг хууль санаачлагч хоёрдмол санаагүйгээр

илэрхийлж, энэ талаар хэлэлцүүлгийн явцад улам тодруулж тайлбарласан бөгөөд байнгын хорооны болон хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт уг заалттай холбоотой зарчмын зөрүүтэй санал гараагүй учир хууль санаачлагчийн анхны үзэл баримтлалаар дээрх хуулийн заалт батлагдсан байна.

с. Өрсөлдөөний тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан ноёлох үйл ажиллагааны төрлүүдийг авч үзвэл 7.1.4-т “бусад аж ахуй эрхлэгч зах зээлд гарч ирэхэд саад учруулах, тэдгээрийг зах зээлээс шахан гаргах зорилгоор бараа бүтээгдэхүүнээ бодит зардлаас доогуур үнээр борлуулах;”, 7.1.10-т “өрсөлдөгчөө өөртөө нэгтгэх, хуваах, тусгаарлах замаар өөрчлөн байгуулахыг шаардах” зэрэг бусад аж ахуй эрхлэгчийг зах зээлд гарч ирэх нөхцөлийг хаан боогдуулах, зах зээлээс шахан гаргах зорилгоор үйлдэгдэж болох ноёлох үйл ажиллагааг хориглосны зэрэгцээ 7.1.2-т “бараа бүтээгдэхүүнд үндэслэлгүйгээр хэт өндөр үнэ тогтоох”, 7.1.3-т “аж ахуй эрхлэгчээс борлуулалтын нэмэлт нөхцөлийг шаардах, зах зээлд ижил төрлийн бараа бүтээгдэхүүнийг ялгавартай үнээр борлуулах, үндэслэлгүйгээр борлуулалт хийхээс татгалзах”, 7.1.12-т “бараа бүтээгдэхүүн борлуулахдаа иж бүрдэлд ороогүй бараа дагалдуулах” зэрэг хэрэглэгчийг хясан боогдуулахад чиглэсэн ноёлох үйл ажиллагааны төрлийг тус бүрт нь зааж, хориглосон байна.

Учир нь эдгээр ноёлох үйл ажиллагааны төрлүүд нь өрсөлдөгчийг зайлуулах, өрсөлдөөнийг хязгаарлахаас гадна хэрэглэгчийн сонголтгүй, эсхүл сонголт хязгаарлагдмал байгаа байдлыг далимдуулж давамгай байдлаа буруугаар ашиглан хэрэглэгчийг хясан боогдуулахаас сэргийлсэн зохицуулалтууд юм. Ялангуяа монополь аж ахуйн нэгжийн хувьд өрсөлдөгчийг шахан зайлуулах тухай ойлголт байхгүй учир ийм төрлийн давамгай байдалтай аж ахуйн нэгжээс хэрэглэгчийг хамгаалах зорилгоор энэ төрлийн ноёлох үйл ажиллагааг хууль тогтоогч тусгайлан заажээ.

Эдгээр зохицуулалт нь ШӨХТГ-т иргэн, аж ахуй эрхлэгчдийн бүхий л гэрээ, хэлцэлд хөндлөнгөөс оролцож, хянах эрхийг олгож буй бус, харин давамгай байдалтай аж ахуй эрхлэгчээс энэхүү байдлаа урвуугаар ашиглаж бусад аж ахуй эрхлэгчийг шахах, эсхүл хэрэглэгчийг хохироох үйл ажиллагаа явуулахаас урьдчилан сэргийлэх зорилготой. Тиймээс хуулийн 7 дугаар зүйлд заасан ноёлох үйл ажиллагааг зөвхөн “бусад аж ахуй эрхлэгчийг зах зээлд гарч ирэх нөхцлийг хаан боогдуулах, зах зээлээс шахан гаргах зорилгоор” хийж гэмээ нь ноёлох үйл ажиллагаа гэж үзвэл “хэрэглэгчийг хясан богдуулах” зорилготой ноёлох үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтууд хэрэгжих боломжгүй болж, хуулийн үр нөлөөнд сөргөөр нөлөөлөх болно.

Иймд, Өрсөлдөөний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан “ноёлох үйл ажиллагаа”-г мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д заасан “бусад аж ахуй эрхлэгчийг зах зээлд гарч ирэх нөхцөлийг хаан боогдуулах, зах зээлээс шахан гаргах зорилгоор” хийгдсэн тохиолдолд ноёлох үйл ажиллагаа гэж үзэх талаарх шүүхүүдийн тайлбар үндэслэлгүй гэж үзэж байна.

2. Өрсөлдөөний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т заасан нөхцлийг шүүхүүд анхаарсангүй, буруу тайлбарлаж хэрэглэсэн байна. Тодруулбал, хариуцагчаас “гадна талбайд нэг эгнээнд зэрэгцээ оршиж буй мах зардаг чингэлэгт өөр өөр үнэ тогтоосон” хэмээн маргасан байхад шүүхүүд “ижил төрлийн бараа биш” хэмээн тайлбарлажээ.

а. Өрсөлдөөний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т заасан “...ижил төрлийн бараа бүтээгдэхүүнийг ялгавартай үнээр борлуулах...” гэсэн зохицуулалтын ерөнхий агуулгыг авч үзвэл үйлдвэрлэгч, нийлүүлэгч зэрэг давамгай байдалтай аж ахуйн нэгжээс зардлын ялгаа байхгүй, нэг төрлийн бараа бүтээгдэхүүнд өөрийн хувийн

үнэлэмжээр хэрэглэгчийг ялгаварлаж, өөр өөр үнэ тогтоохоос сэргийлжээ. **Давамгай байдалтай аж ахуй эрхлэгчээс бараа бүтээгдэхүүн авч буй хэрэглэгчийн хувьд сонголтгүй, эсхүл сонголт хязгаарлагдмал байдаг учир аж ахуй эрхлэгч энэ харилцаанд давуу байдлаа ашиглаж, өөрийн субъектив үнэлэмжээр бараа бүтээгдэхүүнд зардлаас үл хамаарах шалтгаанаар ялгамжтай үнэ тогтоож, үндэслэлгүй хэрэглэгчийг хохироохоос хамгаалахад энэхүү зохицуулалтын ач холбогдол оршино**. Үүгээрээ уг зүйлийн 7.1.2-т заасан "үндэслэлгүй хэт өндөр үнэ тогтоох" буюу хэрэглэгчийг ялгаварлалгүйгээр, үндэслэлгүй хэт өндөр үнэ тогтоох заалтаас хэрэглэгчийг ялгаварлаж, зарим хэрэглэгчийг үндэслэлгүй илүү үнэ төлүүлэхээс сэргийлдгээрээ энэ заалт онцлогтой.

b. Уг заалтад "ижил төрлийн бараа бүтээгдэхүүн" гэсэн нөхцөлийг заасан бөгөөд өрсөлдөөний эрх зүйн онолд "тухайн бараа бүтээгдэхүүнийг орлох боломжтой, зориулалт нь нэг байх бараа бүтээгдэхүүн"-ийг үүнд хамааруулан ойлгодог. Тодруулбал,**хэрэглэгчийн хүссэн бараа байхгүй тохиолдолд зориулалтын дагуу орлуулах боломжтой буюу сонголттой, нэг бүлэгт багтдаг, төрлийн хувьд адил бараа бүтээгдэхүүнийг "ижил төрлийн бараа" бүтээгдэхүүн** гэж үздэг.

Тухайн тохиолдолд Шонхор худалдааны төвийн хашаан дотор, гадна талбайд байрлалтай, зориулалт нь нэг буюу махны чиглэлээр үйл ажиллагаа явуулах зориулалттай, нэг эгнээнд зэрэгцэн болон өөд өөдөөс харан орших 20 тонны 50 ширхэг чингэлэг байх тул эдгээрийг "ижил төрлийн бараа бүтээгдэхүүн" биш гэж үзэх үндэслэл байхгүй юм.

c. Мөн хуулийн энэхүү заалтад "Энэ нь бүс нутгийн байршлаас хамаарсан тээврийн бодит зардлыг тооцсон бараа бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт, үйлдвэрлэгч, нийлүүлэгчээс бөөний болон жижиглэнгийн худалдан авагчид өгч байгаа урамшуулалд хамаарахгүй" гэсэн нэмэлт тайбарыг хууль тогтоогчоос хийжээ. Тодруулбал, ижил төрлийн бараа бүтээгдэхүүнд ялгавартай үнэ тогтоож болох нөхцөл нь бүс нутгийн байршлаас хамааран тээвэрлэлтэд гарах зардал юм.

Гэтэл хяналтын шатны шүүхийн тогтоолд "түрээсийн үйлчилгээний гол зүйл нь ашигтай байршил...худалдааны төв захуудад түрээслүүлж буй лангуу, тавиур, чингэлэг, павильон нь байршлаасаа хамаарч үнэлэгдэх боломжтой" хэмээн хуулийн зохицуулалтын агуулгад нийцээгүй тайлбар хийжээ.

Улаанбаатар хотод байгаа газар байршлаасаа хамаарч үнэлэгдэх нь илэрхий. Маргаан бүхий чингэлэгийн хувьд нэг бүс нутагт төдийгүй нэг хашаан дотор зэрэгцээ байрлалтай юм. Тиймээс бүс нутгийн хувьд өөр өөр байршилд гэж үзэх боломжгүй.

Мөн нэг хашаан дотор байгаа лангуу, тавиур, чингэлэг, павильон нь ч өөр өөр үнэлэгдэх боломжтой бөгөөд харин ингэж үнэлэх нөхцөл нь давамгай байдалтай аж ахуйн нэгжийн хувьд зардлын ялгаатай байдал гэдгийг хуулийн энэхүү зохицуулалтад заасан, өрсөлдөөний эрх зүйн онолд мөн ингэж тайлбарладаг.

Хариуцагчаас худалдааны төвийн гадна хашаанд байрших чингэлэг болон байшин дотор байрлах лангууг ялгаатай үнээр түрээслэсэн гэж маргаагүй, байшинд байрлах лангууны хувьд барилгын өртөг, цахилгаан, дулаан гээд зардлын хувьд ялгаатай байхын зэрэгцээ лангуу, чингэлэг хоёрыг бүтээгдэхүүний хувьд нэг гэж үзэх боломжгүй. Мөн гэр ахуйн жижиглэн барааны болон гурил, хүнсний ногооны зэрэг бусад зориулалт бүхий чингэлэгт тогтоосон үнийг энд авч үзээгүй, гагцхүү махны зориулалтаар түрээслэдэг нэг эгнээнд зэрэгцэн ба өөд өөдөөс харан орших 50 чинлэгүүдийг ялгаатай үнээр түрээслэж буйг буруутгасан бөгөөд энд зардлын ялгаа байхгүй гэдэг нь хавтаст хэрэгт авагдсан баримтаар тогтоогдсон, мөн өмнө тэмдэглэснээр нэг хашаанд зэрэгцэн оршиж буй учир "бүс нутгийн байршлаас

хамаарсан үнийн зардал” байгаа гэж үзэх боломжгүй, ялгаатай үнээр түрээслэх эрх зүйн үндэслэл байхгүй.

Дүгнэлт

Дээрхээс нэгтгэн үзэхэд, Өрсөлдөөний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан ноёлох үйл ажиллагаанд бусад аж ахуй эрхлэгчийг зах зээлд гарч ирэх нөхцөлийг хаан боогдуулах, зах зээлээс шахан гаргах зорилготой үйл ажиллагаа хамаарахын зэрэгцээ хэрэглэгчийг хясан боогдуулахад чиглэсэн үйл ажиллагаа хамаардаг бөгөөд мөн хуулийн 7.1.3-т заасан зохицуулалт нь хэрэглэгчийн эсрэг үйлдэгддэг ноёлох үйл ажиллагааны төрөл мөн. Мөн маргаан бүхий чингэлэгүүд нь 7 дугаар зүйлийн 7.1.3-т зааснаар ижил төрлийн бараа бүтээгдэхүүн төдийгүй эдгээр чингэлэгүүдэд зардлаас хамаарсан ялгаатай үнэ тогтоох үндэслэл байхгүй байна.

Шонхор худалдааны төв нь махны бөөний борлуулалтаар дагнасан, бөөний болон жижиглэн худалдаа эрхлэгчэд уг төвөөс мах худалдан авч Улаанбаатар хотын бусад зах, дэлгүүрийг хангадаг учир махны нийлүүлэлтэд ихээхэн үүрэг гүйцэтгэдэг. Энэ утгаараа зардал нь ижил мах худалдах зориулалттай чингэлэгүүдийг адил үнээр буюу 500,000 төгрөгөөр түрээслэх боломж байхад зардлаас үл хамаарах үндэслэлээр зарим чингэлэгийн үнийг 900,000 хүртэл нэмэгдүүлж, махны худалдаа эрхлэгч нарт тэгш өрсөлдөх нөхцлийг хангасангүй.

Нөгөө талаас, Өрсөлдөөний тухай хуулийн зохицуулалт нь уг хуулийн зохицуулалтад хамрагдаж буй аж ахуй эрхлэгчдэд нэг мөр үйлчлэх учиртай. Аж ахуй эрхлэгч цахилгаан эрчим хүч, дулаан, харилцаа холбоо болон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний импорт, нийлүүлэлт зэрэг ямар төрлийн бараа бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлж байгаагаас үл хамааран давамгай байдалтай аж ахуйн нэгж мөн бол нийлүүлж буй бараа бүтээгдэхүүнийг зардлаас хамаарахгүй бусад үндэслэлээр дур мэдэн өөр өөр үнэ тогтоож, хувийн үнэлэмжээр хэрэглэгчийг ялгаварлах үндэс байхгүй. Энэ төрлийн маргаан үүсвэл хуулийн өрсөлдөх тайлбар байлгах үүднээс тусгай санал бичив.

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ТАНХИМЫН ТЭРГҮҮН М.БАТСУУРЬ

ХУУЛЬ ЗҮЙН ИНСТИТУТ
www.ilaw.mn

ТЭМДЭГЛЭЛ

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn